УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
ПАРЛАМЕНТЫН СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭН

# “ПАРЛАМЕНТ”

*(Судалгааны эмхэтгэл)*




**НИЙГМИЙН СУДАЛГААНЫ СЕКТОР**

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

УЛААНБААТАР ХОТ, 2022

ННА*- 60
ДАА**-300
П-183

“Парламент” судалгааны эмхэтгэл (XXXVII боть)-ийг
Улсын Их Хурлын Тамгын газрын Парламентын судалгааны
хүрээлэнгээс эрхлэн гаргав.

Хянасан: Ц.Цогзолмаа
Ц.Норовдондог (Ph.D)

Эмхэтгэсэн: Д.Жигваагүнсэл
Ц.Оргилмаа

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Т.Цэнд-Аюуш

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

УИХ-ын Тамгын газар ©
“ПАРЛАМЕНТ” СУДАЛГААНЫ ЭМХЭТГЭЛ - XXXVII БОТЬ

**ISBN 978-9919-9806-6-5**

# ГАРЧИГ

## БҮЛЭГ. НИЙГЭМ


**1.1 Эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцоо ба цалин хөлсний систем: олон улсын туршлага, зөвлөмж (АНУ, Израил, БНСУ, Шинэ Зеланд, Япон, Перу, Казахстан, Монгол) (СТ-21/225)**........ 6

*Ц.Норовдондог (Ph.D), Д.Амаржаргал (Ph.D), О.Нарантуяа, Р.Оргилмаа, Б.Батцэцэг, Р.Нургүл*

**1.2 Монгол Улсын сэтгэл судлалын салбарын өнөөгийн байдал, мэргэжилтэн бэлтгэх тогтолцоо ба гадаадын зарим орны туршлага, эрх зүйн зохицуулалт (СТ-21/239)**............................... 95

*Э.Энхтүвшин, П.Уранчимэг, С.Золжаргал, Б.Туул*

**1.3 Хүний эрхийн боловсрол олгох тогтолцоо ба парламентын оролцооны талаарх харьцуулсан судалгаа (СТ-21/234)**............. 141

*Ц.Норовдондог (Ph.D), Д.Жигваагүнсэл, Д.Амаржаргал (Ph.D), Б.Батцэцэг*

**1.4 Ерөнхий боловсролын сургуулийн ёс зүйн кодекс ба сургуулийн орчин дахь хүчирхийлэл, дээрэлхэлтийн хариу арга хэмжээний талаарх бусад орнуудын туршлага**................ 170

*Ц.Норовдондог (Ph.D), Д.Аюуш, Д.Амаржаргал (Ph.D), Б.Батцэцэг, Д.Жигваагүнсэл, Р.Оргилмаа, О.Нарантуяа*

**1.5 Нийгмийн даатгал төлөлтөд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хамрагдалт: Монгол Улсын нөхцөл байдал (СТ-21/413)**............ 214

*Ц.Норовдондог (Ph.D), О.Нарантуяа*

**1.6 Жирэмсэн болон амаржсан эхийн тэтгэмж, хүүхэд асрах чөлөөний талаарх гадаадын зарим орны туршлага (СТ-21/237)**.......................................................................................... 224

*Ц.Норовдондог (Ph.D), Д.Аюуш, Д.Амаржаргал (Ph.D), Б.Батцэцэг, Д.Жигваагүнсэл, Р.Оргилмаа, О.Нарантуяа*

**1.7 Тэтгэврийн хуримтлалын тогтолцооны талаарх гадаадын зарим орны туршлага (СТ-21/238)**.................................................. 263

*Ц.Норовдондог (Ph.D), Р.Нургүл, Ц.Ариунаа, И.Жаргалзаяабямба, П.Уранчимэг*

**1.8 Нийтийн мэдээллийн эрх зүйн зохицуулалт (СТ-21/231)**........... 317

*Г.Алтан-Оч (Ph.D)*


UIH.MN СУДАЛГААНЫ САН

**1.9** **Хүний хувийн мэдээлэл хамгаалах талаарх олон улсын эрх зүйн зохицуулалт (CT-21/242)**................................................ 327

*С.Золжаргал*

**1.10** **Цахим гарын үсгийн эрх зүйн зохицуулалтын олон улсын чиг хандлага: Монгол Улс болон гадаадын зарим орны туршлага (CT-21/243)**....................................................................... 349

*Г.Уянга*

**1.11** **Кибер гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын туршлага ба эрх зүйн орчин (CT-21/230)**................................................................... 369

*О.Билгүүтэй, Б.Батцэцэг, Р.Оргилмаа*

**1.12** **Монгол Улсын нийгэм-эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдлын талаарх олон нийтийн шүүмж ба тулгамдсан асуудлууд: Олон нийтийн санаа бодлыг тандах судалгаа**..... 425

*Парламентын судалгааны хүрээлэн*

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

# НИЙГЭМ

## ТОЙМ АГУУЛГА

- **Эрүүл мэнд**
- **Боловсрол**
- **Даатгал, тэтгэвэр, тэтгэмж**
- **Цахимжилт**
- **Олон нийтийн мэдээлэл**

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

# ЭРҮҮЛ МЭНДИЙН САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦОО БА ЦАЛИН ХӨЛСНИЙ СИСТЕМ: ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА, ЗӨВЛӨМЖ

*Ц.Норовдондог (Ph.D), Д.Амаржаргал (Ph.D),*
*О.Нарантуяа, Р.Оргилмаа, Б.Батцэцэг, Р.Нургүл*

## АГУУЛГА

УДИРТГАЛ
СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ
БҮЛЭГ I. ЭРҮҮЛ МЭНДИЙН ТОГТОЛЦОО БА САНХҮҮЖИЛТИЙН ОЛОН УЛСЫН ЗАГВАРУУД, ТЭДГЭЭРИЙН ОНЦЛОГ
1.1. Эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх хүчин зүйлс
1.2. Эрүүл мэндийн тогтолцоо ба түүний санхүүжилтийн загварууд
1.3.Шилжилтийн эдийн засагтай орнууд дахь эрүүл мэндийн тогтолцоо, шинэчлэлийн асуудал
1.4.Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн арга, механизмууд
1.5.Дэлхийн зарим орнуудын эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцооны онцлог
1.6.Эрүүл мэндийн санхүүжилтийн ялгаатай тогтолцоон дахь эрүүл мэндийн салбарын үр дүнгийн үзүүлэлтүүдийн харьцуулалт
1.7.Олон улсын эрүүл мэндийн тогтолцооны үр нөлөөг хэмжих үзүүлэлтүүд
1.8.Дэлхийн улс орнуудын эрүүл мэндийн салбарын ерөнхий үзүүлэлт ба Монгол Улсын нөхцөл байдал
1.9.Дэлхий дахины эрүүл мэндийн санхүүжилтийн зарцуулалт
БҮЛЭГ II. ЭРҮҮЛ МЭНДИЙН САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦООНЫ ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА, ЭРХ ЗҮЙН ОРЧИН
2.1.АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС
Хууль эрх зүйн зохицуулалт
Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн тогтолцоо
Эрүүл мэндийн даатгал
2.2.ИЗРАИЛ УЛС
Хууль эрх зүйн зохицуулалт:
Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн тогтолцоо
Эрүүл мэндийн салбар дахь шинэчлэл
2.3.БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС
Хууль эрх зүйн орчин
Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн тогтолцоо
Эрүүл мэндийн даатгал
2.4.ШИНЭ ЗЕЛАНД УЛС
Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн тогтолцоо
Ковид-19 цар тахлын эсрэг төсөвлөсөн төсөв
Эрүүл мэндийн даатгал
Эмнэлгийн санхүүжилт
2.5.ЯПОН УЛС
Хууль эрх зүйн зохицуулалт
Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн тогтолцоо
Эрүүл мэндийн байгууллагын санхүүжилт
Эрүүл мэндийн даатгал
2.6.ПЕРУ УЛС
Хууль эрх зүйн зохицуулалт
Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн тогтолцоо
2.7. БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН УЛС
Эрх зүйн зохицуулалт
Эрүүл мэндийн санхүүжилтийн зарцуулалт

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Ковид-19 үеийн эрүүл мэндийн санхүүжилт
2.8.МОНГОЛ УЛС
Эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцоо ба онцлог, хууль эрх зүйн орчин
Эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцоо
Монгол улсын эрүүл мэндийн санхүүжилтийн бүрдүүлэлт
Монгол улсын эрүүл мэндийн санхүүжилтийн хуваарилалт
Эрүүл мэндийн байгууллагуудын санхүүжилт
Ковид-19 цар тахлын үед эрүүл мэндийн санхүүжилтийн талаар авч буй арга хэмжээ
БҮЛЭГ III. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ЦАЛИН ХӨЛСНИЙ СИСТЕМ, ОЛОН УЛСЫН ЖИШИГ
3.1. Эрүүл мэндийн салбарын цалин хөлсний олон улсын систем, арга хэлбэрүүд ба харьцуулалт
3.2. Шилжилтийн эдийн засагтай зарим орнуудын эмч, эмнэлгийн ажилтнуудын цалин хөлсний систем, шинэчлэлийн явц
3.3.Эрүүл мэндийн байгууллагын цалин, урамшууллын стратеги
3.4.Эрүүл мэндийн салбарын цалин хөлсний системд нөлөөлөх хүчин зүйлс
3.5. ДЭМБ-ын гишүүн орнуудын эрүүл мэндийн салбарын цалин хөлсний байдал
3.6. ДЭМБ-ын эрүүл мэндийн салбарын цалин хөлс, урамшууллын стратеги
3.7. Дэлхийн банкны зөвлөмж: Эрүүл мэндийн ажилтны цалин урамшууллыг нэмэгдүүлэхэд баримтлах зарчим, анхаарах зүйлс
БҮЛЭГ IV. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ЦАЛИН ХӨЛСНИЙ СИСТЕМ: БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА, ЭРХ ЗҮЙН ОРЧИН
4.1. АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС
Цалингийн тогтолцооны эрх зүйн зохицуулалт
Дундаж цалин, шатлал
4.2. ИЗРАИЛ УЛС
Эрүүл мэндийн ажилтан, албан хаагч
Цалин хөлсний систем
4.3. ШИНЭ ЗЕЛАНД УЛС
Эрүүл мэндийн байгууллагын ажилтан, албан хаагч:
Цалин хөлсний систем
4.4. ЯПОН УЛС
Эрх зүйн зохицуулалт
Цалин хөлсний систем
4.5. ПЕРУ УЛС
Эрүүл мэндийн салбарын цалин хөлсний бодлого, эрх зүйн орчин, тогтолцоо
Цалин хөлсний бүтэц
4.6. БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН УЛС
Эрүүл мэндийн салбарын цалин хөлсний бодлого, эрхзүйн орчин, тогтолцоо
ЭМС цалин хөлсний бүтэц, бүрэлдэхүүн
4.7. МОНГОЛ УЛС
Эрүүл мэндийн салбарын цалин хөлсний бодлого, тогтолцоо
Цалин хөлсний талаарх эрх зүйн зохицуулалт
Эрүүл мэндийн ажиллагсдын цалингийн дундаж
Эрүүл мэндийн ажиллагсдын дундаж цалингийн хэмжээ
Цалингийн бүрэлдэхүүн
АШИГЛАСАН МАТЕРИАЛ

UIH.MN СУДАЛГААНЫ САН

## УДИРТГАЛ

Судалгааны захиалгын дагуу “Эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцоо ба цалин хөлсний систем: Олон улсын туршлага, зөвлөмж” сэдэвт харьцуулсан судалгааны ажлыг УИХ-ын Тамгын газрын Парламентын судалгааны хүрээлэнд гүйцэтгэв.

**Судалгааны хамрах хүрээ:**

Судалгааны ажлыг захиалагчаас ирүүлсэн хүсэлтийн дагуу эрүүл мэндийн салбарын ажилтнуудын цалин, урамшууллыг нэмэх боломжийг судлах зорилгоор гүйцэтгэлээ. Сэдвийн хүрээнд дараах 2 бүлэг асуудлыг гүнзгийрүүлэн судалж, харьцуулсан шинжилгээ хийсэн болно. Үүнд:

1) Эрүүл мэндийн тогтолцоон дахь олон улсын санхүүжилтийн загварууд, тэдгээрийн онцлог, давуу болон сул талууд, шилжилтийн эдийн засагтай орнуудын эрүүл мэндийн санхүүжилтийн загвар ба түүний шинэчлэл, олон улсын байгууллагуудаас гаргасан эрүүл мэндийн санхүүжилтийн талаарх зөвлөмж болон бусад орнуудын эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцооны загвар, бодлого-эрх зүйн орчин, санхүүжилтийн арга, механизмын талаарх практик туршлага
2) Эрүүл мэндийн тогтолцоон дахь эмч, эрүүл мэндийн ажилтнуудын цалин хөлсний систем, тэдгээрийн онцлог, давуу болон сул талууд, шилжилтийн эдийн засагтай орнуудын эрүүл мэндийн салбарын цалин хөлсний шинэчлэлийн бодлого, эрх зүйн орчин, цалин, урамшууллын механизмын талаарх практик туршлагуудыг харьцуулан судаллаа.

Судалгаанд эрүүл мэндийн санхүүжилтийн олон улсад түгээмэл хэрэглэгдэж байгаа загваруудыг нутагшуулсан орнуудын төлөөллүүд, мөн эрүүл мэндийн ажилтнуудын цалин хөлсний дэвшилтэт системийг нэвтрүүлсэн, манайхтай ижил шилжилтийн эдийн засагтай орнуудын төлөөллүүд болох АНУ, Израил, БНСУ, Шинэ Зеланд, Япон, Перу, ОХУ Казахстан, Монгол зэрэг орнуудыг хамруулав.

Судалгааны тайлан 4 бүлэгтэй:

*__Нэгдүгээр бүлэгт,__* дэлхий дахинд бүрэлдэн бий болсон эрүүл мэндийн тогтолцоо ба санхүүжилтийн загварууд, тэдгээрийн онцлог, давуу болон сул талууд, эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцоо бүрдэхэд нөлөөлөх хүчин зүйлс зэрэг асуудлуудыг хамруулснаас гадна дээрх тогтолцооны жишгийг тогтоосон сонгодог загвартай Герман, Канад, Франц, Их Британи, АНУ, Япон орнуудын туршлага, шилжилтийн эдийн засагтай орнуудад явагдаж буй эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцооны шинэчлэл зэрэг асуудлуудыг хөндөн судалсан. Мөн улс орнуудын орлогын түвшинд эрүүл мэндийн салбарын үр нөлөөг хэмжих үзүүлэлтүүд ямар байгааг гарган, Монгол Улстай харьцуулан харуулсан болно.

*__Хоёрдугаар бүлэгт__*, эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцооны олон улсын практик туршлагуудыг харьцуулан судалсан. Судалгаанд АНУ, Израил, БНСУ, Шинэ Зеланд, Япон, Перу, Казахстан, Монгол зэрэг орнуудыг хамрууллаа.

*__Гуравдугаар бүлэгт,__* дэлхий дахинд бүрэлдэн бий болсон эрүүл мэндийн салбарын цалин хөлсний системийн олон улсын жишиг, аргачлал, давуу болон сул талууд, цалин хөлсний санхүүжилтийн эх үүсвэр ба олгох механизм, ДЭМБ, Дэлхийн банкнаас эрүүл мэндийн салбарын ажилтнуудын цалин хөлстэй холбоотой гаргасан зөвлөмж, олон улсад нийтлэг дагаж мөрдөх стратеги болон баримтлах зарчмуудын талаарх мэдээллийг оруулсан.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

*Дөрөвдүгээр бүлэгт* судалгаанд авагдсан орнуудын эрүүл мэндийн салбарын цалин хөлсний систем, бодлого, эрх зүйн зохицуулалт, цалин хөлсний системийн бүтэц, урамшууллын механизмтай холбоотой практик туршлагуудыг харьцуулан судлав.

***Түлхүүр үг:*** *Эрүүл мэндийн тогтолцооны санхүүжилт, эрүүл мэндийн ажилтны цалин, урамшуулал, эмнэлгийн ажилтны цалингийн бодлого, цалингийн стратеги, цалингийн нөхцөл байдал, цалинд нөлөөлөх хүчин зүйлс*

***Keywords:*** *Healthcare system financing, health workforce renumeration, health workers salary policy, total gross wages of health worker, renumeration and incentive strategy, factors of health workers' salary*

## СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

### 1) Эрүүл мэндийн тогтолцооны санхүүжилтийн загварын харьцуулалт

Судлаачид дэлхийн улс орнуудын эрүүл мэндийн тогтолцооны загваруудыг олон ургальч байдлаар ангилсан судалгаа, үзэл хандлагууд түгээмэл байна. Тухайлбал,

***Нэг. Нийгэм-улс төрийн тогтолцооны үзэл хандлага талаас*** *нь* классик тогтолцоо, плюрал тогтолцоо, даатгалын тогтолцоо, үндэсний тогтолцоо, социалист тогтолцоо гэж ангилахаас гадна утилитар, коммунатор, либерал тогтолцоо ч гэж нэрлэдэг.

Орчин үед ДЭМБ-ын экспертүүдийн[1] тогтоосон эрүүл мэндийн тогтолцооны дараах үндсэн 3 ангиллыг түгээмэл ашиглаж байна.

- Төрийн оролцоотой тогтолцоо (Бевериджийн систем)
- Бүх нийтийг хамарсан эрүүл мэндийн даатгалын тогтолцоо (Бисмаркийн систем)
- Зах зээлийн буюу хувийн эрүүл мэндийн тогтолцоо

Олон улсын судлаачдын ангиллыг өргөн хүрээнд авч үзвэл ерөнхий тогтолцооны шинж байдал, ангиллаас хамааруулан дэлхий дээр эрүүл мэндийн тогтолцооны дараах загварууд бий болсон гэж үздэг:

1. Универсал загвар (Бевериджийн загвар)
2. Нийгмийн даатгалын тогтолцооны загвар (Бисмаркийн загвар)
3. Өмнөдийн загвар (Испани, Португал, Грек, Италийн зарим хэсэг)
4. Скандинавын загвар буюу институциональ загвар (социал демократ загвар)
5. Либераль загвар
6. Корпоратив-консерватив загвар (Япон)
7. Латин-америкийн загвар
8. Зүүн Азийн аж үйлдвэржсэн орнуудын эрүүл мэндийн тогтолцооны загвар
9. Шилжилтийн эдийн засагтай орнуудын эрүүл мэндийн тогтолцооны загвар хэмээн ангилж байна.

***Хоёр. Эдийн засаг-санхүүжилтийн арга механизм талаас нь,*** эрүүл мэндийн салбарын тогтолцоо, үйл ажиллагаанд төрөөс хэрхэн оролцож байгааг чухалчлан авч үздэг бөгөөд орчин үед эрүүл мэндийн тогтолцооны санхүүжилтийн дараах 3 загварыг түгээмэл ашиглаж байна:

1. Зах зээлийн систем буюу хувийн эрүүл мэндийн даатгалын системд суурилсан төлбөртэй эмнэлгийн үйлчилгээний загвар

[1] (S. Hakansson, B. Majnoni, D'Intignano, G.H. Mooney, J.L. Roberts, G.L. Stoddart, K.S. Johansen, H. Zollner)

2. Төсвийн санхүүжилтэнд суурилсан төрийн эрүүл мэндийн үйлчилгээний загвар
3. Нийгмийн даатгал болон зах зээлийн санхүүжилтийн олон сувгуудыг нэгтгэсэн эрүүл мэндийн үйлчилгээний загвар

Дээрх 3 загвар өөрийн гэсэн давуу болон сул талуудтай бөгөөд дэлхийн улс орнууд санхүүжилтийн үндсэн арга механизм болгон ашиглаж байна.

*Загвар 1-ийн хувьд*, төрийн эрүүл мэндийн даатгалын нэгдсэн тогтолцоо үйлчлэхгүй бөгөөд эмнэлгийн үйлчилгээний төлбөрийг иргэд хувиасаа гаргадаг. *(сонгодог жишээ АНУ)*

*Загвар 2-ын хувьд*, төрийн оролцоо чухал үүрэгтэй. Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг үндсэндээ улсын төсвөөс бүрэн санхүүжүүлэх бөгөөд иргэд эрүүл мэндийн үйлчилгээг үнэ төлбөргүй авах эрхтэй. *(сонгодог жишээ Куба, Их британи)*

*Загвар 3-ын хувьд*, нийгмийн даатгал буюу эрүүл мэндийн даатгалын систем чухал үүрэгтэй. Эрүүл мэндийн тогтолцооны энэхүү загвар нь эдийн засгийн холимог тогтолцоон дээр тулгуурлана. Өөрөөр хэлбэл, нийгмийн янз бүрийн бүлгийн хүн амыг эрүүл мэндийн үйлчилгээнд бүрэн хамруулах зорилготой, эрүүл мэндийн үйлчилгээний зах зээлийн тогтолцоо болон нийгмийн даатгалын баталгааг хослуулсан, төрийн зохицуулалтын хөгжингүй систем буюу холимог загвар юм.

Энэхүү загварыг орчин үед дэлхийн улс орнууд түгээмэл ашиглаж байгаа бөгөөд тогтолцооны гол онцлог нь хүн амыг эрүүл мэндийн заавал даатгалд бүрэн хамруулах, эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтэнд төрөөс тодорхой хэмжээгээр оролцох шаардлагатай болдог. Учир нь төрийн үүрэг нь эрүүл мэндийн салбарын зах зээлийн төлбөртэй зарчмыг хөндөхгүйгээр, иргэдийн амьжиргааны ялгаатай байдлыг харгалзан эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд бүрэн хамруулах баталгааг хангахад чиглэгдэнэ. Түүнчлэн эрүүл мэндийн салбарын үүрэг нь иргэд эрүүл мэндийн үйлчилгээ авах байгууллагаа бие даасан байдлаар сонгох, эмнэлгийн тусламж үйлчилгээг баталгаат түвшинд чанартай авах боломжийг бүрдүүлэхэд чиглэнэ.

Санхүүжилтийн олон урсгал бүхий энэхүү загвар нь (хөрөнгийн эх үүсвэрийг Улсын төсөв, ЭМД-ийн шимтгэл, Даатгалын сангийн ашгаас бүрдүүлдэг) эрүүл мэндийн салбарын нийгмийн даатгалд суурилсан, уян хатан, тогтвортой систем гэдгээрээ давуу талтай. Энэ загварыг хэрэгжүүлсэн орнуудын сонгодог жишээ нь, Финланд, Франц, Нидерланд, Австри, Бельги, Голланд, Швейцар, Канад, Япон зэрэг орнууд юм. Монгол улсын эрүүл мэндийн тогтолцооны хувьд төрийн оролцоо чухал үүрэгтэй боловч эрүүл мэндийн даатгалын тогтолцоо системийн онцлогоос шалтгаалж байгаа тул холимог загвартай байна.

Нийгмийн даатгалын санхүүжилтийн гол шинж нь төрийн оролцоо болон зах зээлийн загварыг хослуулснаараа онцлогтой. Аль параметр нь илүү давамгайлж байгаагаас шалтгаалан төрийн оролцоо давамгайлсан, зах зээлийн загвар давамгайлсан гэж тодорхойлогдоно. Жишээ нь, Скандинавын орнууд болон Канадад төрийн оролцоо түлхүү байдаг бол Францад зах зээлийн загвар давамгайлдаг байна.

***Эрүүл мэндийн тогтолцоог үйлчилгээний нийгмийн шинж чанар талаас нь*** авч үзвэл, иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэгш, хүртээмжтэй үзүүлэх нь төрийн бодлогын гол асуудал учраас төрөөс заавал оролцох шаардлагатай болдог.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Иймд төрөөс эрүүл мэндийн салбарыг нэгдсэн удирдлагаар хангаж, хяналт тавих тогтолцоо буюу улсын төсвөөс давамгай санхүүжүүлэх зарчим (Беверидж систем) бий болсон. Жишээ нь, Их Британид Үндэсний эрүүлийг хамгаалах систем үйлчлэх бөгөөд гол үзэл санаа нь эв санааны нэгдлийн зарчим буюу баян нь ядуудаа, эрүүл нь өвчтэй хүмүүстээ туслах зарчим буюу төвлөрсөн тогтолцоо бүхий төлөвлөлт-хуваарилалтын шинжийг агуулна. Энэ загвар нь өөрийн гэсэн давуу болон сул талтай. Тухайлбал,

- өрсөлдөөн үгүй тул эрүүл мэндийн салбарын жам ёсны хөгжлийг идэвхжүүлэх хөшүүрэг бага, улмаар энэ нь эрүүл мэндийн үйлчилгээний чанарт нөлөөлөх сөрөг талтай, түүнчлэн салбарын бүтэц тогтолцоо уян хатан биш байдгаас шалтгаалж удирдлагын үр ашиггүй стратеги баримтлах, техник технологийн шинэчлэл удаашрах зэрэг сул талтай бол өвчнөөс урьдчилан сэргийлэх бодлого, тогтолцоо сайн учраас өвчлөл харьцангуй буурах, өртөг зардал багасах давуу талтай.

Эрүүл мэндийн үйлчилгээний нийгмийн даатгалын (Бисмарк) загварын үед хүний эрүүл мэндийг “капитал” гэж авч үздэг. Энэ загварын гол зарчим нь эрүүл мэнд бол хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх нийгмийн үнэт капитал гэх үзэлд тулгуурласан.

Энэ загварын онцлог нь төрийн эрүүл мэндийн даатгалын системээр дамжуулан орлогын дахин хуваарилалт хийдэгт оршино. Даатгалын тогтолцоо нь ядуу иргэд, хөдөлмөрийн чадвар алдсан хүмүүсийн нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд ихээхэн дэм болж байдгаараа онцлогтой.

Шилжилтийн эдийн засагтай орнуудад хүн амын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эрэлт хэрэгцээ их байгаа хэдий ч эрүүл мэндийн тусламж үйлчилгээний байгууллагууд хэвийн ажиллахын тулд юуны өмнө санхүүжилтийн уян хатан, тасралтгүй механизмыг бүрдүүлэх шаардлага тулгамдсан асуудал болж байна.

Гэвч төсвийн хомсдолд байнга орж байдаг эдгээр орнуудын хувьд эрүүл мэндийн тогтолцооны төрийн санхүүжилтийн загварт найдахад хэцүү. Нөгөө талаас иргэдийн орлогын түвшин, төлбөрийн чадвар муу байх тул эмнэлгийн үйлчилгээг төлбөртэй үзүүлэх боломж хязгаарлагдмал байдаг.

Ийм учраас шилжилтийн эдийн засагтай орнуудад эрүүл мэндийн тогтолцооны зах зээлийн санхүүжилтийн загвар дангаараа төдийлөн тохиромжтой биш бөгөөд нийгмийн эмзэг бүлгийн гишүүдийн эрүүл мэндийн үйлчилгээний хэрэгцээг хангахад төрийн оролцоо чухал хэвээр байсаар байна. Шилжилтийн эдийн засгийн хүндрэл бэрхшээл, улс төр-эдийн засгийн нөхцөл байдал, нийгмийн бүлгүүдийн орлогын ялгаа улам нэмэгдсэнтэй холбогдуулан шилжилтийн эдийн засагтай орнууд хүн амыг эрүүл мэндийн үйлчилгээнд тэгш хамруулах боломжийг хангасан оновчтой тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай тулгарч байна. Өнөө цаг үед шилжилтийн эдийн засагтай орнуудын хувьд хөрөнгийн боломжит эх үүсвэрүүдийг эрүүл мэндийн салбарт татан төвлөрүүлэх бүх боломжуудыг судлан ашиглах ёстой гэж экспертүүд зөвлөж байна.

UILI.MN СУДАЛГААНЫ САН

Шилжилтийн эдийн засагтай орнуудад дээрх загваруудаас хамгийн тохиромжтой нь ***санхүүжилтийн олон сувгууд бүхий нийгмийн даатгалын тогтолцооны загвар*** байх болно. Өөрөөр хэлбэл, эрүүл мэндийн салбарыг санхүүжилтийн олон эх үүсвэрт тогтолцоонд шилжүүлж, улсын төсвийн хөрөнгө, нийгмийн даатгалын шимтгэл болон даатгалын компанийн ашгийн хувиар санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх нь оновчтой гэж олон улсын шинжээчид зөвлөж байна.

**2) Эрүүл мэндийн салбарын цалин хөлсний системийн харьцуулалт**

Дэлхийн эрүүл мэндийн салбарт тулгамдаж буй гол асуудал бол санхүүжилтийн асуудал. Санхүүжилтийн хүндрэлтэй нөхцөлд эрүүл мэндийн салбарын ажилтнуудын цалин хөлсний системийг оновчтой тогтоох, хязгаарлагдмал нөөц боломжийг үр ашигтай ашиглах асуудал эрүүл мэндийн цалин хөлсний системийн тулгамдсан асуудал болж байна.

Судалгаанаас үзэхэд, эрүүл мэндийн салбарын ажилтнуудын цалин хөлсний нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн тогтолцоо дэлхийн практикт үгүй боловч сайн туршлага бүхий орнуудын жишгээр аль болох бага зардлаар чанартай эмнэлгийн үйлчилгээ үзүүлэхийн тулд улс орон бүр өөр өөрийн орны онцлогт тохирсон үр ашигтай цалин хөлсний систем бий болгосон байна.

Эрүүл мэндийн үйлчилгээний чанар, үр нөлөө нь эрүүл мэндийн салбарын эмч ажилтнуудын цалингаас шууд хамааралтай тул 1) эмнэлгийн байгууллагуудын бие даасан байдал, эрх мэдлийг нэмэгдүүлэх, 2) санхүүжилтийг нэмэгдүүлэхэд анхаарах шаардлагатай болж байна. Өөрөөр хэлбэл, эрүүл мэндийн байгууллага эмч, ажилтнуудынхаа цалин хөлсийг ажлын гүйцэтгэл болон чанарт тулгуурлан коэффициентоор өсгөх боломжтой байх, мөн шийдвэр гаргах бие даасан байдлаа хадгалах явдал чухал юм.

Эдийн засгийн өндөр хөгжилтэй орнууд, тухайлбал, Шведэд эмч нарын цалин бусад салбарын цалингийн дунджаас 1,65 дахин, АНУ-д 7,2 дахин, Германд 6 дахин өндөр байдаг гэсэн судалгаа байна. Баруун Европын ихэнх орнуудад, тухайлбал, Герман, Бельги, Люксембург, Голланд, Швейцар, Франц зэрэг орнуудад эрүүл мэндийн даатгалын систем өндөр хөгжсөн байдаг учраас урамшуулалт (гонорар) цалингийн системийг хэрэглэдэг бол, төсвийн санхүүжилтийн загварыг ашиглаж байгаа орнуудад энэхүү системийг хэрэглэх боломжгүй ба зөвхөн амбулторын эмч нарт нэмэгдэл олгоход ашигладаг байна.

Их Британи, Испани, Ирланд, Итали гэх мэтийн орнуудад нэг хүнээр тооцсон цалингийн системийг хэрэглэдэг бөгөөд энэ аргыг хэрэглэх үед эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд зарцуулах зардлын өсөлт хязгаарлагддаг учраас эмч, эмнэлгийн ажилтнууд аль болохоор өвчтөнд үзлэг, эмчилгээ хийхээс зайлсхийж урьдчилан сэргийлэх үзлэг олноор хийхийг илүүд үздэг сөрөг талтай.

Нэг иргэнээр тооцсон цалин хөлсний систем нь дараах 2 хэлбэртэй байна.

1) Ерөнхий нормативт цалингийн систем (Дани, Нидерланд)
2) Харьяаллын хүрээний хүн амын нас, хүйсэнд суурилсан нормативт цалингийн систем (Их Британи, Итали)

Дани, Их Британи, Норвеги, Герман зэрэг орнуудад нэг иргэнээр тооцсон тогтмол цалингийн систем давамгайлах боловч урамшуулалт цалингийн систем мөн үйлчилдэг тул холимог системтэй. Энэхүү холимог систем нь эмнэлгийн тусламж үйлчилгээг идэвхжүүлэх хөшүүрэг болдог байна.

Иргэд нь эмнэлгийн үйлчилгээнд сэтгэл хангалуун байдаг гэж судалгаагаар тогтоогдсон зарим орнуудад, тухайлбал, Нидерланд, Франц, Германд – урамшуулалт цалингийн систем үйлчилдэг. Иргэдийн сэтгэл ханамж муутай Испани гэх мэтийн улс орнууд нэгжийн нормативт суурилсан цалингийн системтэй байна.

UIH.MN СЭДЭВ ХАНЫ САН

Олон улсын туршлагаас үзэхэд, эрүүл мэндийн цалин хөлсний дараах үндсэн системүүд бүрэлдэн бий болсон байна. Үүнд:

- <u>*Тогтмол цалингийн систем*</u> - шилжилтийн эдийн засагтай ихэнх орнууд энэ хэлбэрийг ашиглаж байгаа бөгөөд эмч, эмнэлгийн ажилтны ажлын үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт байхгүй учраас ажил үйлчилгээний чанарыг сайжруулах, идэвхжүүлэх хөшүүрэг болж чаддаггүй. Нэгжийн үнэлгээнд суурилсан цалин хөлсний системийн үед эмнэлгийн ажилтнууд зөвхөн өөрийн хариуцсан бүртгэлтэй хүмүүст эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх бөгөөд тоон болон чанарын үзүүлэлтэнд онцгойлон ач холбогдол өгдөггүйгээрээ сул талтай.
- <u>*Урамшуулалт цалингийн систем*</u> -энэ систем нь ихэвчлэн гэр бүлийн буюу өрхийн эмнэлэг давамгайлсан сайн тогтолцоотой орнуудад үйлчлэх бөгөөд эмч, эмнэлгийн ажилтнуудын ажлын үр дүнг тоон болон чанарын шалгуур үзүүлэлтээр үнэлж олгодог, санхүүгийн нэмэлт эх үүсвэр татан төвлөрүүлэх боломжтой дэвшилтэт урамшууллын цалин хөлсний системд тооцогддог. Энэ системийн үед эмч, эмнэлгийн ажилтнууд тооны араас хөөцөлдөж аль болох өндөр үнэтэй эм тариа, үйлчилгээг өвчтөнүүдэд санал болгох сонирхол бий болдогоороо сул талтай.

Урамшуулалт цалин хөлсний системийг нэвтрүүлэхэд тодорхой хүндрэл бэрхшээлүүд тулгарч байна. Тухайлбал, хуучин социалист орнууд буюу шилжилтийн эдийн засагтай орнуудад 1) төсөв-санхүүгийн нөөц хүрэлцээгүй, 2) эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцооны тасралтгүй, уян хатан байдал хангагдаагүй зэрэг шалтгаануудын улмаас энэ системийг нэвтрүүлэхэд хүндрэлтэй байна гэж олон улсын экспертүүд үзсэн байна. Тиймээс одоогийн цалин хөлсний систем нь эмч, эмнэлгийн ажилтнуудын ажлын үр дүнг бодитой үнэлэх, ажил үйлчилгээний чанар, стандартыг сайжруулах хөшүүрэг болж чадахгүй байгаа учраас шилжилтийн эдийн засагтай олон улс орнууд эмч нарын ажлын үр дүн болон эдийн засгийн хөшүүргийн тэнцвэрийг хадгалсан байдлаар дэвшилтэт системийг нэвтрүүлэхийг зорьж байна.

Дэлхийн банкнаас, цар тахал гэх мэт эрүүл мэндийн ажилтнууд ачаалалтай ажилладаг онцгой нөхцөл байдлын үед эрүүл мэндийн ажилчдыг Засгийн газраас дэмжих үндсэн хэлбэр бол тэдний цалин, урамшууллыг нэмэгдүүлэх хэлбэр гэж үзсэн. Тиймээс эхний ээлжинд нэмэлт цалингийн хэмжээг зөв тодорхойлж, эрүүл мэндийн ажилтны цалингийн түвшин, бүтцийг сайтар үнэлэх шаардлагатай хэмээн зөвлөсөн.

Дэлхийн банкны гишүүн орнуудад эрүүл мэндийн ажилчдын цалин хөлс нийтлэг байдлаар дараах бүтэцтэй байна:

- <u>*Үндсэн цалин*</u>. Үүнийг төрийн албаны цалин хөлсний тухай хууль, тогтоомж болон эрүүл мэндийн ажилтны цалингийн шатлалд үндэслэн тогтооно.
- <u>*Илүү цагийн нэмэгдэл*</u>. Үүнийг хуулиар тогтоосон ажлын цагаас хэтрүүлэн ажилласан тохиолдолд нэмэгдүүлж олгоно.
- <u>*Хөдөлмөрийн хортой нөхцөлийн нэмэгдэл.*</u> Энэ нь эрсдэлтэй гэж тооцогдох хөдөлмөрийн нөхцөлд ажилласан тохиолдолд нэмж олгодог нөхөн олговор юм.
- <u>*Бусад нэмэгдэл*</u>. Үүнд ихэвчлэн ажилласан жилийн, ур чадварын, боловсролын, мэргэшлийн зэргийн, орон нутагт буюу алслагдсан газарт ажилласны нэмэгдэл гэх мэт нэмэгдлүүд орно.
- <u>Гүйцэтгэлийн үр дүнгээр цалинжуулах</u>. Энэ нь орц (ажлын цаг гэх мэт), гарц (эмчлүүлсэн өвчтөний тоо гэх мэт), үр дүн (өвчтөний сэтгэл ханамж) гэх мэт үзүүлэлтээр тодорхойлогддог нэмэлт төлбөр юм.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

- *Томилолтын мөнгө*. Энэ нь ихэвчлэн сургалт, семинарт хамрагдахад зориулан олгогддог.

Дэлхийн банкнаас, эмнэлгийн ажилтны цалин хөлсийг нэмэгдүүлэхдээ дараах нөхцөл байдлуудыг анхаарах шаардлагатай гэж зөвлөсөн.[2]

- Эрүүл мэндийн салбарын ажилчид нь төрийн үйлчилгээний албан хаагчдын томоохон хэсгийг бүрдүүлдэг. Тиймээс хөгжиж буй орнуудад эрүүл мэндийн ажилчдын цалинг нэмэх нь эм, эмнэлгийн хэрэгсэл зэрэг бусад чухал зардлын санхүүжилтийг бууруулж болзошгүй.
- Үйлдвэрчний эвлэл нь идэвх сайтай орнуудад нэг салбарын ажилчдын цалинг нэмэхэд нөгөө салбарын ажилчид цалингийн өсөлтийг шаардах явдлыг эрчимжүүлэх магадлалтай.
- Цалинг түр хугацаанд нэмсэн ч энэ өсөлт цаашид хадгалагдан үлдсэнээс үүдэн төсвийн тогтвортой байдалд нөлөөлөх, урт хугацааны гажуудал, бэрхшээлийг үүсгэх эрсдэлтэй байж болзошгүй.

Түүнчлэн хямралын болон цар тахлын идэвхтэй тархалтын үед эмнэлгийн ажилтнуудын цалинг нэмэгдүүлэхэд дараах зарчмуудыг баримтлахыг зөвлөсөн:

1) Засгийн газраас энэ асуудалд албан ёсоор анхаарал хандуулах. Засгийн газрын зүгээс цалинг нэмэх шаардлага хангасан эрүүл мэндийн ажилтны ангиллыг гаргаж, илүү цагаар ажиллаж, нэмэлт эрсдэлд орох магадлалтай бүх ажилтнуудыг хамруулах шаардлагатай.
2) Онцгой байдлын үеийн түр хугацааны нэмэгдэл олгох. Энэхүү нэмэгдэл нь нэг удаагийн “тусгай тэтгэмж” хэлбэртэй байх ба хямрал дуусахад цуцлагдана. Нэмэгдлийг цалингийн хувиар бус тогтсон хэмжээгээр олгох, ингэснээр хянаж, удирдах, нэр бүхий эрүүл мэндийн бүх ажилчдыг хамруулах боломжтой болно. Засгийн газрууд төрийн албан хаагчдын цалингийн тухай хууль тогтоомжид өөрчлөлт оруулахаас аль болох зайлсхийх хэрэгтэй. Онцгой байдлын үеийн нэмэлт цалин хөлсийг сар бүр эсвэл улирал тутамд нөхцөл байдалтай уялдуулан олгож, уян хатан хандах ёстой.
3) Хяналтыг хэрэгжүүлэхэд төвөг багатай байх. Цар тахал гэх мэт хүнд нөхцөл үүссэн үед өндөр өртөгтэй хяналт, шалгалт шаардах цалингийн нэмэгдлээс аль болох зайлсхийх хэрэгтэй. Тухайлбал, гүйцэтгэлд суурилсан урамшууллыг олгох тохиолдолд гүйцэтгэлийн орц, гарц, үр дүнг хянаж шалгах нүсэр ажиллагаа шаардлагатай болно.
4) Тэгш хандах. Цалин хөлсийг субъектив шалгуураар олгодог, ижил ур чадвар, туршлагатай эмнэлгийн ажилтнуудад ялгавартай цалин олгодог тэгш бус практикийг аль болох багасгах, цалингийн нэмэгдлийг тооцоо судалгаанд үндэслэн тогтоох, ил тод болгох шаардлагатай. Бусад орнуудын практикаас харахад Ковидын хямралын үеийн эмч нарын нэмэгдэл цалинг үндсэн цалингийн 20-иос доошгүй хувиар тогтоох нь тохиромжтой байх тул нэмэгдлийн хэмжээ хязгаарыг тухайн орон өөрийн орны төсвийн боломжиндоо тулгуурлан тогтоох ёстой хэмээн зөвлөсөн байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[2] https://blogs.worldbank.org/governance/how-increase-compensation-health-workers-during-Ковид-19

**Судалгаанд авагдсан зарим орнуудын туршлага:**

Израил Улс

- Израил Улс бүх нийтийн үндэсний эрүүл мэндийн даатгалын системтэй бөгөөд төрийн оролцоо ихтэй. Үндэсний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд зааснаар тус улсад оршин суугаа хүн бүр эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах эрхтэй. Эрүүл мэндийн даатгалын зардлын 63 хувийг төсвийн хөрөнгөөр, 37 хувийг хувийн даатгалын эх үүсвэрээс санхүүжүүлдэг. Эрүүл мэндийн зардал нь улсын нэгдсэн төсвийн зардлын 12.1%-ийг эзэлдэг. Харин Засгийн газраас гаргаж буй зардал нь эрүүл мэндийн нийт зардлын 64.7 хувийг эзэлдэг бол хувь хүнээс гарч буй зардал 21.1% байна. Хувийн даатгалын эх үүсвэрт хувь хүнээс гарах зардал, сайн дурын эрүүл мэндийн даатгал болон бусад гадны тусламж, дэмжлэг хамаарна.
- Израил Улсад эрүүл мэндийн ажилтнууд нэг эмчид ногдох өвчтөний тооноос хамаарч цалинждаг. Энэ нь 2 янз байх бөгөөд идэвхтэй болон идэвхгүй өвчтөн буюу үйлчилгээ авсан, аваагүйгээс хамаарч нэг даатгуулагчид ногдох төлбөрийг улирал тутам авдаг. Харин улсын болон ашгийн бус эмнэлгийн эмч нар тогтмол цалинтай байх ба цалин хөлсийг хамтын гэрээгээр зохицуулдаг. Илүү цагийн хөлс олгож болох бөгөөд цагаар эсвэл ажилбарын процесс бүрээр тооцож олгоно. Хөдөө, орон нутагт ажиллаж, амьдарч байгаа эмч нарыг урамшуулах, дэмжих зорилгоор хязгаар нутгийн нэмэгдлийг 25 хувиар олгож байна. Мөн мэргэшлийн болон бусад нэмэгдлүүдийг тогтсон журмын дагуу олгодог.

БНСУ

- Солонгос Улс нь хөгжиж буй орноос өндөр хөгжилтэй орон руу шилжиж буй улс бөгөөд нийгмийн эрүүл мэндийн заавал даатгалын тогтолцоотой. Эрүүл мэндийн санхүүжилтэд хувийн хэвшил давамгайлдаг. Солонгос Улс 1989 онд Үндэсний эрүүл мэндийн даатгалын тогтолцоонд шилжсэн. 2018 оны байдлаар дотоодын нийт бүтээгдэхүүний 8 орчим хувийг эрүүл мэндийн салбарт зарцуулж байна. Жилд нэг хүнд ногдох эрүүл мэндийн үйлчилгээний зардал 2542 ам доллар байна. Солонгосын үндэсний эрүүл мэндийн даатгалын санхүүжилт нь эрүүл мэндийн даатгалын шимтгэл (83%), засгийн газрын татаас (12%) болон бусад эх үүсвэр буюу тамхины татвар (5%)-аас бүрддэг. Зардлын санхүүжилт нь Нийгмийн эрүүл мэндийн даатгалаас 42.8%, татвар, төсвөөс 11.5%, хувь хүнээс 35.2%, хувийн эрүүл мэндийн даатгалаас 6.2%, бусад эх үүсвэрээс 4.3% байна. Солонгосын эрүүл мэндийн санхүүжилтэнд хувь хүнээс гарах зардал өндөр тул хүн амын 70-аас дээш хувь нь хувийн эрүүл мэндийн даатгалд хамрагддаг байна.

Япон Улс

- Япон Улсын эрүүл мэндийн Беверидж загварын тогтолцоотой. 2020 оны байдлаар улсын төсвөөс 84%-ийг санхүүжүүлсэн. Үүнээс[3] 42%-ийг татварын орлогоор, 42%-ийг эрүүл мэндийн даатгалын шимтгэлээс, 16%-ийг өвчтөний үйлчилгээний төлбөрөөс бүрдүүлсэн. Эрүүл мэндийн салбарт ДНБ-ний 11%-ийг зарцуулдаг. Тодруулбал, жилд нэг хүнд ногдох эмнэлгийн үйлчилгээний дундаж зардал нь 4,267 ам.доллар байна. Япон Улсын дундаж наслалт 84,21 байгаа нь эрүүл мэндийн зардлын өсөлтөд нөлөөлж байна.

Шинэ Зеланд

- Шинэ Зеланд Улс төсвийн санхүүжилтэнд суурилсан төрийн эрүүл мэндийн үйлчилгээний загвартай. Тус улсад эрүүл мэндийн үйлчилгээг улс орон даяар байгуулсан 20 дүүргийн эрүүл мэндийн төвүүдээр дамжуулан үзүүлж байна.

[3] https://www.commonwealthfund.org/international-health-policy-center/countries/japan

Эрүүл мэндийн зардлын 80 орчим хувийг улсын төсвөөс, 5 хувийг хувийн даатгалаас, 15 орчим хувийг төлбөр хуваах болон хувь хүн, айл өрхөөс гарч байгаа зардал эзэлсэн байна. Дүүргийн эрүүл мэндийн зөвлөлд хуваарилагдсан төсөвт эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардлаас гадна эмч, эмнэлгийн ажилтнуудын цалин хөлс багтдаг. 2021 оны төсөвт эрүүл мэндийн санхүүжилт нэлээдгүй хувь (24 тэрбум ам доллар)-ийг эзлээд байна.

АНУ

- АНУ нь эрүүл мэндийн санхүүжилтийн зах зээлийн буюу хувийн эрүүл мэндийн даатгалын тогтолцоотой. Тиймээс эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өртөг тэр хэрээр өндөр байна. Эрүүл мэндийн салбарын санхүүжилт нь хувийн даатгал, засгийн газрын санхүүжилт, хувь хүнээс гарч буй зардлаас бүрдэж байна. Хувь хүнээс гарч буй зардал нь Холбооны засгийн газрын санхүүжилттэй бараг тэнцүү байна. Нийт иргэдийн 92 орчим хувь нь эрүүл мэндийн даатгалд хамрагдсанаас 2019 оны байдлаар иргэдийн 67.2% нь хувийн сайн дурын эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байна. Үүнээс 55.7% нь ажил олгогчоос төлж буй даатгалд, 11.3% нь хувиараа даатгалд хамрагдсан байна. Нэг хүнд ногдох эрүүл мэндийн үйлчилгээний зардлаараа дэлхийд тэргүүлж буй орнуудын нэгд ордог.
- Холбооны засгийн газрын харьяа Хөдөлмөрийн статистикийн товчоо улсын болон хувийн хэвшлийн байгууллагад ажиллагсдын цалинг улсын хэмжээнд жил бүр харьцуулан гаргадаг. Үндэсний цалин хөлсний судалгаанд суурилан улсын байгууллагад ажиллаж буй ажилтанд тухайн жилийн цалингийн зөрүүгийн дунджаар үндсэн цалин дээр нэмэгдлийг тооцон олгодог онцлогтой байна.

Монгол Улс

- Монгол Улсын ДНБ-д эрүүл мэндийн зардлын эзлэх хувь бусад бага дунд орлоготой орнуудтай (4.2 хувь) харьцуулахад маш бага буюу 2.2 хувь байна. Гэсэн хэдий ч эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж бусад бага дунд орлоготой орнуудтай харьцуулахад илүү сайн үзүүлэлттэй байгаа ба их эмчийн 10 мянган хүнд ногдох тоогоор (36.8) өндөр орлоготой орнуудаас (28.7) ч илүү үзүүлэлттэй байна. Мөн хүн амын эрүүл мэндийн үзүүлэлтээр бага дунд орлоготой орнуудыг бодвол харьцангуй сайн байгаа ч өндөр орлоготой оронтой харьцуулахад их эмчийн тооноос бусад бүх үзүүлэлтээр дор байна.

  Эрүүл мэндийн санхүүжилтийг бүрдүүлж буй үндсэн гурван эх үүсвэрийг авч үзвэл 1) улсын төсөв, 2) заавал төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэл, 3) иргэдээс шууд төлөх төлбөр багтаж байна. Эдгээр эх үүсвэрээс улсын төсөв хэмжээний хувьд давамгайлж байна. Одоогоор эрүүл мэндийн салбарын үндсэн санхүүжилтийг улсын төсөв, ЭМДС гэсэн хоёр эх үүсвэрээр тусдаа хоёр санд төвлөрүүлж байгаа бөгөөд эрүүл мэндийн салбарт улсын бүх эх үүсвэрийг нэг санд төвлөрүүлэх тогтолцоог хараахан бий болгож чадаагүй байна.
- Манай улсын цалин хөлсний системийн хувьд нэгжийн үнэлгээнд суурилсан нормативт цалингийн систем буюу тогтмол цалингийн систем зонхилж байна. Харин 2021 оноос гүйцэтгэлд суурилсан цалингийн тогтолцоог аажмаар нэвтрүүлж эхэлсэн. Үүнтэй холбоотойгоор салбарт нөөцийг хуваарилахдаа микро удирдлагын хандлагыг халж стратегийн хувьд нөөцийг тогтвортой байлгах арга зам руу шилжин, эрүүл мэндийн байгууллагуудын төлбөрийн механизм ба эрүүл мэндийн ажилтнуудын цалин хөлсний тогтолцооны заагийг арилгаж, гүйцэтгэлийг сайжруулах нэгдмэл сонирхлыг аль аль түвшинд бий болгох хэрэгтэй байна гэж Азийн Хөгжлийн Банкнаас гаргасан судалгаанд зөвлөсөн байна.

(Дэлгэрэнгүй мэдээллийг судалгааны хэсгээс үзнэ үү)

UIH.MN СУДАЛГААНЫ САН

## СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

## БҮЛЭГ I. ЭРҮҮЛ МЭНДИЙН ТОГТОЛЦОО БА САНХҮҮЖИЛТИЙН ОЛОН УЛСЫН ЗАГВАРУУД, ТЭДГЭЭРИЙН ОНЦЛОГ

### 1.1. Эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх хүчин зүйлс

Дэлхийн улс орнуудын эрүүл мэндийн салбарын тогтолцооны шинж чанарыг тогтолцооны олон хэлбэр, энэ салбар дахь эдийн засгийн харилцааны онцлогоос нь хамааруулан дараах хэд хэдэн параметруудаар тодорхойлдог. Үүнд:

- Өмчийн хэлбэр
- Санхүүжилтийн хэлбэр (эх үүсвэр)
- Эмч, эмнэлгийн ажилтнууд (үйлчилгээ үзүүлэгч) болон иргэд (үйлчилгээ авагч)-ийг урамшуулах механизм
- Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүртээмж болон чанарт хяналт тавих арга хэлбэр

Улс орон бүр өөрийн орны нөөц боломж, уламжлалт тогтолцоонд суурилсан эрүүл мэндийн тогтолцоотой. Үүнээс шалтгаалан эрүүл мэндийн салбарт хөрөнгө нөөцийг татан төвлөрүүлэх, эрүүл мэнд хамгааллын бодлого хэрэгжүүлэх аргууд төлөвшин бүрдсэн байдаг. Эрүүл мэндийн салбарт зарцуулж буй хөрөнгийн тоо хэмжээ, чанар, хөрөнгө бүрдүүлэлт, санхүүжилтийн механизм нь тухайн орны улс төр, ёс суртахууны хандлага болон бүрэлдэн бий болсон тогтолцоо, түүний төлөвшлөөс ихээхэн хамааралтай байгааг судлаачид тогтоосон.

### 1.2. Эрүүл мэндийн тогтолцоо ба түүний санхүүжилтийн загварууд

Судлаачид дэлхийн улс орнуудын эрүүл мэндийн салбарын тогтолцооны загваруудыг олон ургалч байдлаар ангилсан судалгаа, үзэл хандлагууд түгээмэл байдаг. Тухайлбал,

***Нэг.***Нийгэм-улс төрийн тогтолцооны үзэл хандлага талаас нь авч үзвэл: классик тогтолцоо, плюрал тогтолцоо, даатгалын тогтолцоо, үндэсний тогтолцоо, социалист тогтолцоо гэж ангилдаг бол эрүүл мэндийн системийн мөн чанар талаас нь Оросын эрдэмтэн О.П. Шепин, В.Б.Филатов нар утилитар, коммунатор, либерал гэсэн 3 үндсэн тогтолцоонд ангилж авч үзсэн байдаг.

Орчин үед ДЭМБ-ын экспертүүдийн[4] тогтоосон эрүүл мэндийн тогтолцооны дараах үндсэн 3 ангиллыг түгээмэл ашиглаж байна.

1. Төрийн оролцооны тогтолцоо (Беверидджийн систем)
2. Бүх нийтийг хамарсан эрүүл мэндийн даатгалын тогтолцоо (Бисмаркийн систем)
3. Төрийн оролцоогүй, зах зээлийн болон хувийн эрүүл мэндийн тогтолцоо

Судлаачдын ангиллыг өргөн хүрээнд авч үзвэл эрүүл мэндийн тогтолцооны дараах загваруудыг тодорхойлсон байдаг. Үүнд:

1. Универсал загвар (Беверидджийн загвар)
2. Нийгмийн даатгалын тогтолцооны загвар (Бисмаркийн загвар)
3. Өмнөдийн загвар (Испани, Португал, Грек, Италийн зарим хэсэг)
4. Скандинавын загвар буюу институциональ загвар (социал демократ загвар)
5. Либераль загвар
6. Корпоратив-консерватив загвар (Япон)

[4] (S. Hakansson, B. Majnoni, D'Intignano, G.H. Mooney, J.L. Roberts, G.L. Stoddart, K.S. Johansen, H. Zollner)

UIH.MN СУДАЛГААНЫ САН

7. Латин-Америкийн загвар
8. Зүүн Азийн аж үйлдвэржсэн орнуудын эрүүл мэндийн тогтолцооны загвар
9. Шилжилтийн эдийн засагтай орнуудын эрүүл мэндийн тогтолцооны загвар

***Хоёр***. Эдийн засгийн загвар талаас нь авч үзвэл, дэлхийн улс орнуудад эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаа, процесст төр ямар үүрэг роль гүйцэтгэж байгааг чухалчлан авч үздэг.

Орчин үеийн эрүүл мэндийн салбарын тогтолцооны бүх хэлбэрийг бүхэлд нь авч үзээд судлаачид 3 янзын эдийн засгийн загварыг олж тогтоосон. Эдгээр загваруудад оноосон тодорхой нэршил үгүй боловч мэргэжилтнүүд загварыг ангилж болохуйц параметрууд болон шинж байдлыг тодорхойлж дараах 3 загварыг тогтоосон:

1. Зах зээлийн систем буюу хувийн эрүүл мэндийн даатгалын системд суурилсан төлбөртэй эмнэлгийн үйлчилгээний загвар
2. Төсвийн санхүүжилтэд суурилсан төрийн эрүүл мэндийн үйлчилгээний загвар
3. Нийгмийн даатгал болон зах зээлийн санхүүжилтийн сувгуудыг нэгтгэсэн эрүүл мэндийн үйлчилгээний загвар

***Загвар 1-ийн хувьд***, төрийн эрүүл мэндийн даатгалын нэгдсэн тогтолцоо үйлчлэхгүй бөгөөд эмнэлгийн үйлчилгээний төлбөрийг иргэд хувиасаа гаргадаг. Эрүүл мэндийн үйлчилгээг иргэд зах зээлийн зарчмаар авах ба ийм зарчмаар үйлчилгээ авах боломжгүй иргэд (бага орлоготой иргэд, тэтгэврийн хөгшчүүд, ажилгүйчүүд)-ийн эрүүл мэндийн үйлчилгээг төрөөс Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хөтөлбөр хэрэгжүүлэх замаар шийдвэрлэж, тусгайлан санхүүжүүлдэг. Тухайлбал, АНУ бол энэ загварын сонгодог жишээ юм. АНУ-д эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чөлөөт зах зээлийн тогтолцоо үйлчилдэг. Нэмэлтээр эмзэг, ядуу бүлэгт зориулсан “Medicade” хөтөлбөр, тэтгэврийн насныханд зориулсан “Medicare” хөтөлбөрүүдийг төрөөс хэрэгжүүлэх замаар зорилтот бүлгийн эрүүл мэндийн үйлчилгээний төлбөрийг төрөөс зохицуулдаг. Энэхүү загварыг “төлбөртэй”, “зах зээлийн”, “Америкийн” мөн заримдаа “хувийн даатгалын” гэх мэтээр нэрлэдэг.

***Загвар 2-ын хувьд***, төрийн оролцоо чухал үүрэгтэй. Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг үндсэндээ улсын төсвөөс бүрэн санхүүжүүлэх бөгөөд иргэд эрүүл мэндийн үйлчилгээг үнэ төлбөргүй (зарим нэг цөөн тооны үйлчилгээнээс бусад) авах эрхтэй. Энэ тогтолцооны үед эрүүл мэндийн үйлчилгээг худалдан авах, иргэдийн эрүүл мэндийн хэрэгцээг хангах нь төрийн үүрэг байдаг. Эрүүл мэндийн салбарт чөлөөт зах зээлийн асуудал хоёрдогч асуудал байх ба хэрэв зөвшөөрсөн тохиолдолд төрийн хяналтан дор хэрэгжүүлнэ. Энэхүү загварыг 1948 оноос хойш Их Британид хэрэглэж байгаа бол Ирланд (1971), Дани (1973), Португал (1979), Итали(1980), Грек (1983), Испани (1986) зэрэг орнуудад мөн төлөвшин бий болсон загвар юм. Энэ загварыг “төрийн”, “төсвийн”, “улсын төсвийн” гэх мэтээр нэрлэдэг.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

***Загвар 3-ын хувьд***, нийгмийн даатгал буюу эрүүл мэндийн даатгалын систем чухал үүрэгтэй. Эрүүл мэндийн тогтолцооны энэхүү загвар нь эдийн засгийн холимог тогтолцоон дээр тулгуурлана. Өөрөөр хэлбэл, нийгмийн янз бүрийн бүлгийн хүн амыг эрүүл мэндийн үйлчилгээнд бүрэн хамруулах зорилготой, эрүүл мэндийн үйлчилгээний зах зээлийн тогтолцоо болон нийгмийн даатгалын баталгааг хослуулсан, төрийн зохицуулалтын хөгжингүй систем буюу холимог загвар юм. Энэ тогтолцооны үед хүн амыг эрүүл мэндийн заавал даатгалд бүрэн хамруулах бөгөөд эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтэд төрөөс тодорхой хэмжээгээр оролцох шаардлагатай болдог. Учир

нь төрийн үүрэг нь эрүүл мэндийн салбарын зах зээлийн төлбөртэй зарчмыг хөндөхгүйгээр, иргэдийн амьжиргааны ялгаатай байдлыг харгалзан эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд бүрэн хамруулах баталгааг хангахад чиглэгдэнэ. Эрүүл мэндийн салбарын үүрэг нь иргэд эрүүл мэндийн үйлчилгээ авах байгууллагаа бие даасан байдлаар сонгох, эмнэлгийн тусламж үйлчилгээг баталгаат түвшинд чанартай авах боломжийг бүрдүүлэхэд чиглэнэ. Санхүүжилтийн олон урсгал бүхий энэхүү загвар нь (хөрөнгийн эх үүсвэр нь Улсын төсөв, ЭМД-ийн шимтгэл, Даатгалын сангийн ашгаас бүрдэнэ) эрүүл мэндийн салбарын нийгмийн даатгалд суурилсан, уян хатан, тогтвортой систем гэдгээрээ давуу талтай. Энэ загварыг хэрэгжүүлсэн орнуудын сонгодог жишээ нь, Финланд, Франц, Нидерланд, Австри, Бельги, Голланд, Швейцар, Канад, Япон зэрэг орнууд юм.

Нийгмийн даатгалын санхүүжилтийн гол шинж нь төрийн оролцоо болон үйлчилгээний зах зээлийн загварыг хослуулснаараа онцлогтой. Аль параметр нь илүү давамгайлж байгаагаас шалтгаалан төрийн оролцоо давамгайлсан, зах зээлийн загвар давамгайлсан гэж тодорхойлогдоно. Жишээ нь, Скандинавын орнууд болон Канадад төрийн оролцоо түлхүү байдаг бол Францад зах зээлийн загвар давамгайлдаг.

Эрүүл мэндийн тогтолцооны дээрх загваруудын хувьд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг ***“товар”*** гэж үзэх үү гэдэг асуудал төрийн оролцоо чухал уу гэдэгтэй адил чухал асуудал юм. Хэрэв товар гэж үзвэл үнэ цэнэ, эрэлт-нийлүүлэлтийг хэрхэн тодорхойлох вэ, бусад товараас юугаараа онцлогтой вэ гэх мэтийн олон асуудал гарч ирэх бөгөөд судлаачид үүн дээр олон ургалч үзэл бодол, тайлбар өгдөг. Жишээ нь, ***“зах зээлийн загвар”-***ын үед эрүүл мэндийн үйлчилгээний үнэ өртөг, чанар нь бусад товарын нэгэн адил эрэлт нийлүүлэлт, зах зээлийн зарчмаар тодорхойлогдоно. Жишээ нь, энэ системийн үед хувийн эрүүл мэндийн байгууллагууд болон эрүүл мэндийн даатгалын ашгийн төлөө байгууллагууд хөгжсөн байх ба эмнэлгийн байгууллагууд нь бэлтгэн нийлүүлэгч, үйлчлүүлэгчид худалдан авагчид байна. Гэвч загвар бүхэн давуу болон сул талтай. Жишээ нь, зах зээлийн загварын үед өрсөлдөөн их байх тул эмнэлгийн үйлчилгээний чанар, техник технологи сайжрах, удирдлагын стратеги, байгууллагын үр ашиг сайжрах ч гэлээ дараах сөрөг талууд бий болно. Тухайлбал:

- эмнэлгийн тусламж үйлчилгээний зардал хяналтгүй өсөх;
- төрөөс үүнд хяналт тавих боломжгүй байх тул эрүүл мэндийн салбарын бодлого бусад салбарын бодлого, төлөвлөлттэй уялдуулах боломжгүй болох;
- үйлчилгээний илүүдэл бий болсноор хууль бус үйлчилгээ бий болох нөхцөлийг бүрдүүлэх;
- шударга бус өрсөлдөөн, үйлчлүүлэгчдийг татах өрсөлдөөн, реклам, зар сурталчилгаа ихээр хийх;
- эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тэгш бус хүртээмж, ялгавартай байдал бий болох;
- ашгийн төлөө сонирхолтой даатгалын байгууллагууд олноор бий болсноор эрүүл мэндийн үйлчилгээний цар хүрээ, үнэ өртөг буурах, улмаар үйлчлүүлэгч өөрөө төлбөр төлөх хэмжээнд хүргэх гэх мэт.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Зах зээлийн эрүүл мэндийн тогтолцооны үед иргэд мөнгөн хуримтлалаа санхүүгийн хөрөнгө оруулалтад хийх үү, эрүүл мэндийн даатгалын санд оруулах уу гэдэг сонголттой тулгардаг. Энэхүү сонголтыг шийдвэрлэх нь тухайн хүний өвчлөх эрсдэл болон хөрөнгө оруулалтын өгөөжөөс шалтгаална. Энэ тогтолцоо нь эрүүл мэндийн тогтолцооны хамгийн чанартай боловч өртөг өндөртэй загварт тооцогддог учир хамгийн үр ашиг багатай, иргэдэд хүртээмж багатай, ялгавартай тогтолцоонд тооцогддог.

Хэрвээ ***эрүүл мэндийн үйлчилгээний нийгмийн шинж чанарыг*** онцгойлон авч үзэж байгаа бол иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэгш, хүртээмжтэй үзүүлэхэд төрөөс заавал оролцох шаардлагатай болдог. Энэ тохиолдолд төрөөс эрүүл мэндийн салбарыг нэгдсэн удирдлагаар хангаж, хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх бөгөөд улсын төсвөөс санхүүжүүлэх зарчим Беверидж систем) үйлчилдэг. Жишээ нь, Их Британийн Үндэсний эрүүлийг хамгаалах систем үйлчлэх бөгөөд гол үзэл санаа нь эв санааны нэгдлийн зарчим буюу баян нь ядуудаа, эрүүл нь өвчтэй хүмүүстээ туслах зарчим үйлчлэх тул төвлөрсөн тогтолцоо бүхий төлөвлөлт-хуваарилалтын шинжийг агуулна. Энэ загвар нь өөрийн гэсэн давуу болон сул талтай. Тухайлбал,

- өрсөлдөөн үгүй тул эрүүл мэндийн салбарын жам ёсны хөгжлийг идэвхжүүлэх хөшүүрэг бага, улмаар энэ нь эрүүл мэндийн үйлчилгээний чанарт нөлөөлөх сөрөг талтай, түүнчлэн салбарын бүтэц тогтолцоо уян хатан биш байдлаас шалтгаалж удирдлагын үр ашиггүй стратеги баримтлах, техник технологийн шинэчлэл удаашрах зэрэг сул талтай бол,
- өвчнөөс урьдчилан сэргийлэх бодлого, тогтолцоо сайн учраас өвчлөл харьцангуй буурах, өртөг зардал багасах давуу талтай.

Эрүүл мэндийн үйлчилгээний нийгмийн даатгалын (Бисмарк) загварын үед хүний эрүүл мэндийг “капитал” гэж авч үздэг. Энэ загварыг анх хэрэгжүүлсэн Германы канцлер Отто Бисмаркийн үеэс (1883-1889) ажилчин ангийг өвчлөх, золгүй тохиолдолд өртөх, тахир дутуу болох, хөгшрөх энэ бүх таагүй нөхцөлөөс хамгаалах зорилгоор олон янзын даатгалын хуулийг баталж мөрдүүлсэн. Энэ загварын гол зарчим нь эрүүл мэнд бол хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх үнэт капитал гэх үзэлд тулгуурласан.

Энэ загварын бас нэг онцлог нь төрийн эрүүл мэндийн даатгалын системээр дамжуулан орлогын дахин хуваарилалт хийдэгт оршино. Даатгалын тогтолцоо нь ядуу буурай иргэд, хөдөлмөрийн чадвар алдсан хүмүүсийн нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд ихээхэн дэм болж байдгаараа онцлогтой.

Дээр дурдсан зах зээлийн, төрийн, нийгмийн даатгалын эрүүл мэндийн тогтолцооны үр нөлөө, тэдгээрийн давуу болон сул талуудыг тодорхой орнуудын жишээн дээр харьцуулан үзүүлэв.

**Нийгмийн даатгалын санхүүжилтийн загвар бүхий зарим орнуудын харьцуулалт**

| **Загварын төрөл** | Нийгмийн даатгалын | Нийгмийн даатгалын | Нийгмийн даатгалын |
|---|---|---|---|
| **Орнууд** | **Герман** | **Япон** | **Канад** |
| **Загварын үндсэн зарчим** | Эрүүл мэнд бол “хүний капитал”-ын чанарыг тодорхойлох үндсэн фактор. Эмнэлгийн үйлчилгээ- хүний эрүүл мэндийг хэвийн хэмжээнд байлгах зардлаар хэмжигдэнэ. | Эрүүл мэндийн үйлчилгээ нь квази нийгмийн баялаг мөн. Эрүүл мэндийн заавал даатгал (ЭМЗД)-ын хөтөлбөр нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тодорхой хэсгийг санхүүжүүлнэ. | Эрүүл мэндийн үйлчилгээ нь нийгмийн баялагт чиглэнэ. Эрүүл мэндийн системийг төрөөс хянах ёстой. |
| **ДНБ-д эрүүл мэндийн зардлын эзлэх хувь** | 8.1% | 6.6% | 8.7% |
| **Санхүүжилтийн эх үүсвэр** | Эрүүл мэндийн заавал даатгал-60%<br>Эрүүл мэндийн сайн дурын даатгал-10%<br>Улсын төсвийн санхүүжилт-15%<br>Хувийн эх үүсвэр-15% | Эрүүл мэндийн заавал даатгал-60%<br>Улсын төсвийн санхүүжилт-10%<br>Олон нийтийн сангууд-10%<br>Хувийн эх үүсвэр-20% | Холбооны улс болон муж улсуудын төсвийн санхүүжилт-90%<br>Хувийн даатгалын сангууд болон сайн дурын хандив-10% |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | | |
|---|---|---|---|
| **Хөрөнгийн зарцуулалтын үр ашгийг хянах** | Хяналтыг хувийн болон улсын даатгалын сангууд хэрэгжүүлнэ. | Хяналтыг даатгалын фирмүүд болон хувийн даатгагчид хэрэгжүүлнэ. | Хяналтыг төрөөс хэрэгжүүлнэ. |
| **Эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдалт** | Хүн амын 90% нь ЭМЗД-д, 10% нь ЭМСДД-д хамрагдах ба үүнээс ЭМЗД-д хамрагдсан иргэдийн 3% нь ЭМСДД-д давхар хамрагдсан. | Хүн амын 40% нь Үндэсний даатгалд, 60% нь мэргэжлийн үйлдвэрлэлийн даатгалд хамрагдсан. | Хүн амын 98-99% нь Эрүүл мэндийн заавал даатгал (ЭМЗД)-д хамрагдсан. |
| **Боломжит эмнэлгийн үйлчилгээний төрлүүд** | ЭМЗД, ЭМСДД-ийг хослуулах хөтөлбөр хэрэгжүүлснээр өргөн хүрээтэй эмнэлгийн үйлчилгээ авах боломжтой болсон | ЭМЗД, ЭМСДД-ийг хослуулах хөтөлбөр хэрэгжүүлснээр өргөн хүрээтэй эмнэлгийн үйлчилгээ авах боломжтой болсон. | ЭМЗД-ийн хөтөлбөрийн хүрээнд зайлшгүй үзүүлэх үйлчилгээгээр хязгаарлаж, шинэ арга технологи нэвтрүүлэх боломж хязгаарлагдсан |
| **Шинэ технологи нэвтрүүлэлт** | Эрүүл мэндийн төрөл бүрийн үйлчилгээ үзүүлэх шаардлага нь шинэ техник, технологи нэвтрүүлэх хөшүүрэг болдог | Эрүүл мэндийн төрөл бүрийн үйлчилгээ үзүүлэх шаардлага нь шинэ техник, технологи нэвтрүүлэх хөшүүрэг болдог. | Шинэ техник, технологи нэвтрүүлэхэд маш их саад тотгор учирдаг |
| **Эрүүл мэндийн үйлчилгээний үнийн зохицуулалт** | “нүдний шил” зарчмаар үнэ тогтоно. Эдийн засгийн нөхцөл байдал өөрчлөгдвөл үнийг дахин авч үзнэ. | Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамнаас үнэ тогтооно. | Үнийг Засгийн газраас зохицуулна, жил бүр хянана, гэвч өөрчлөлт оруулах нь удаан. |

### Төрийн болон зах зээлийн санхүүжилтийн загвар бүхий зарим орнуудын харьцуулалт

| **Загварын төрөл** | Төрийн | Төрийн | Зах зээлийн |
|---|---|---|---|
| **Орнууд** | **Франц** | **Их Британи** | **АНУ** |
| **Загварын үндсэн зарчим** | Эрүүл мэндийн үйлчилгээ нь квази нийгмийн баялаг мөн. ЭМЗД-ийн хөтөлбөр нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тодорхой хэсгийг санхүүжүүлнэ. | Эрүүл мэндийн үйлчилгээ нь нийгмийн баялагт чиглэнэ. Баян нь ядуу, эрүүл нь өвчтэй хүмүүсийнхээ өмнөөс төлнө. | Эрүүл мэндийн үйлчилгээ нь хүний хувийн баялагт чиглэнэ. Өөрөөр хэлбэл, ЭМҮ бол худалдаж, худалдан авч болдог товар юм. |
| **ДНБ-д эрүүл мэндийн зардлын эзлэх хувь** | 8.5% | 6.0% | 14% |
| **Санхүүжилтийн эх үүсвэр** | Эрүүл мэндийн заавал даатгал-50%<br>Эрүүл мэндийн сайн дурын даатгал-20%<br>Улсын төсвийн санхүүжилт-10%<br>Хувийн эх үүсвэр-20% | Улсын төсвийн санхүүжилт-100% | Хувийн даатгал-40%<br>Хувийн эх үүсвэр-20%<br>Өндөр настан болон баг орлоготой иргэдийн хөтөлбөрүүд- 40% |
| **Хөрөнгийн зарцуулалтын үр ашгийг хянах** | Хяналтыг даатгалын сангууд, хувийн даатгалын фирмүүд, улсын даатгалын байгууллага хэрэгжүүлнэ. | Хяналтыг төрийг төлөөлж Эрүүл мэндийн яам хэрэгжүүлнэ. | Хяналтыг даатгалын фирмүүд, хувийн даатгалын сангууд хэрэгжүүлнэ. |
| **Эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдалт** | Хүн амын 80% нь ЭМЗД-д хамрагдаж өргөн хүрээтэй эрүүл мэндийн үйлчилгээ авна | Бүх нийтээрээ эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдана. | Үйлчлүүлэгчийн төлбөрийн чадвараар хязгаарлана. Өндөр настан болон бага орлоготой хүссэн хүн бүхэн хөтөлбөрт хамрагдах боломжгүй. |
| **Боломжит эмнэлгийн үйлчилгээний төрлүүд** | ЭМЗД, ЭМСДД-ийг хослуулснаар өргөн хүрээтэй эмнэлгийн үйлчилгээ авах боломжтой. | Урьдчилан сэргийлэх өргөн хүрээтэй үйл ажиллагаа, эмчилгээний багц нь үйлчилгээний боломжоор хязгаарлагдана. | Хамгийн олон янзын эмчилгээ болон урьдчилан сэргийлэх үйлчилгээ авах боломжтой. |

| | | | |
|---|---|---|---|
| **Шинэ технологи нэвтрүүлэлт** | Эрүүл мэндийн төрөл бүрийн үйлчилгээ үзүүлэх шаардлага нь шинэ техник, технологи нэвтрүүлэх хөшүүрэг болдог | Урамшууллын хөшүүрэг байхгүй учраас шинэ техник, технологи нэвтрүүлэхэд удаан | Эрүүл мэндийн салбарт хамгийн өндөр техник, технологи нэвтрүүлэх боломжтой |
| **Эрүүл мэндийн үйлчилгээний үнийн зохицуулалт** | Засгийн газраас үнийг зохицуулна, жилд 2 удаа хянаж үзнэ. | Хүн амын хүйс, насны ангиллаас хамааруулан тогтоосон нормативт суурилан төсөв хөрөнгийг хуваарилна | Үнийн зохицуулалт байхгүй. Үнийг үйлчлүүлэгч, даатгалын компани болон эрүүл мэндийн байгууллага 3 зөвшилцөж тохирно. |

### 1.3.Шилжилтийн эдийн засагтай орнууд дахь эрүүл мэндийн тогтолцоо, шинэчлэлийн асуудал

Дээрх эрүүл мэндийн тогтолцооны сонгодог загваруудыг шилжилтийн эдийн засагтай орнуудад нэвтрүүлэхэд дараах хүндрэл бэрхшээлүүд тулгарч байна.

1) Төсвийн хомсдол
2) Үйлдвэрлэлийн салбарын уналт
3) Ажилгүйдэл, ядуурал, хүн амын орлого
4) Өндөр инфляц

Шилжилтийн үеийн эдийн засгийн хүндрэл бэрхшээлүүд нийт хүн амын амьдралын чанарт нөлөөлж эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эрэлт хэрэгцээг нэмэгдүүлж байна. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний байгууллагууд хэвийн ажиллахын тулд юуны өмнө тасралтгүй санхүүжилтийн механизмыг бүрдүүлэх шаардлагатай тулгарч байна.

Гэвч төсвийн хомсдолд байнга орж байгаа шилжилтийн эдийн засагтай улс орнуудын хувьд эрүүл мэндийн тогтолцооны төрийн санхүүжилтийн загварт найдахад хэцүү. Нөгөө талаас иргэдийн орлогын түвшин доогуур, инфляцын хурд өндөр байгаа тохиолдолд иргэдийн төлбөрийн чадвар муу байх тул эмнэлгийн үйлчилгээний төлбөрийн чадвар хязгаарлагдмал байна. Ийм учраас шилжилтийн эдийн засагтай орнуудад эрүүл мэндийн тогтолцооны зах зээлийн санхүүжилтийн загвар төдийлөн тохиромжтой биш бөгөөд нийгмийн эмзэг бүлгийн гишүүд харьцангуй эрүүл мэндийн үйлчилгээний эрэлт ихтэй боловч эрүүл мэндийн үйлчилгээнд төдийлөн хамрагдах боломжгүй нөхцөл байдал үүсдэг байна. Шилжилтийн эдийн засгийн хүндрэл бэрхшээл, улс төр-эдийн засгийн шинэчлэл, нийгмийн бүлгүүдийн орлогын ялгаатай байдал зэрэг олон нөхцөл байдлын улмаас эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотой маш их бэрхшээлүүд тулгарч байна. Тэр тусмаа эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хэрэгцээ улам бүр өсөн нэмэгдэж байгаа өнөө цаг үед шилжилтийн эдийн засагтай орнуудын хувьд хөрөнгийн боломжит эх үүсвэрүүдийг эрүүл мэндийн салбарт татан төвлөрүүлэх бүх боломжийг ашиглах ёстой гэж судлаачид зөвлөж байна.

Иймээс төсвийн хөрөнгө хүрэлцээгүй, төрөөс эрүүл мэндийн салбарыг бүрэн санхүүжүүлэх боломжгүй шилжилтийн эдийн засагтай орнуудад дээрх загваруудаас хамгийн тохиромжтой нь ***санхүүжилтийн олон сувгууд бүхий нийгмийн даатгалын тогтолцооны загвар*** байх болно. Өөрөөр хэлбэл, эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг олон эх үүсвэрт тогтолцоонд шилжүүлж, улсын төсвийн хөрөнгө, нийгмийн даатгалын шимтгэл болон даатгалын компанийн ашгийн хувиар санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх нь зүйтэй гэж олон улсын шинжээчид зөвлөсөн байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

### 1.4.Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн арга, механизмууд

Эрүүл мэндийн салбарын санхүүжилттэй холбоотой хүндрэл бэрхшээл нь хөгжингүй болон хөгжиж буй орнуудад аль алинд нь түгээмэл тулгардаг асуудал боловч эрүүл мэндийн салбарын тогтолцоо, санхүүжилтийн арга, тухайн орны хөгжлийн түвшингээс хамаарч эдийн засгийн үр дагавар нь улс орон бүрд харилцан адилгүй байдаг.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилтийн ***шууд ба шууд бус*** санхүүжилтийн 2 арга байдаг.

*Шууд санхүүжилтийн арга* гэдэг нь эрүүл мэндийн үйлчилгээний төлбөрийг үйлчилгээг худалдан авагч хувиасаа төлөхийг хэлнэ.

*Шууд бус санхүүжилтийн арга* гэдэг нь эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч болон үйлчилгээг худалдан авагчийн дунд гуравдагч этгээд оролцох хэлбэрийг хэлнэ.

Эрүүл мэндийн тогтолцоог ***улсын төсвийн эх үүсвэр***, ***даатгалын сангийн эх үүсвэр*** (заавал даатгал болон сайн дурын даатгал), ***үйлчлүүлэгчийн төлбөр*** болон ***хандивын*** эх үүсвэрээр санхүүжүүлдэг гэдгийг өмнөх хэсгүүдэд тайлбарласан.

АНУ, Их Британи, Герман, Франц, Куба, Турк улсуудын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилтийн загвар, эдгээр орнуудын эрүүл мэндийн тогтолцооны ялгаатай байдлыг дараах судалгаагаар харьцуулан харуулсан байна. [5]

***Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилтийн*** Beveridge загвар, Bismarck загвар болон Хувийн эрүүл мэндийн даатгалд суурилсан загварууд нь санхүүгийн эх үүсвэр, шийдвэр гаргах механизм, үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын хувьд зарчмын ялгаатай болохыг энэхүү судалгаанаас харж болно.

**Зарим орны эрүүл мэндийн тогтолцооны загварууд**

| **Санхүүжилтийн загвар** | **Беверiджийн загвар (Англи)** | **Бисмарк загвар (Герман)** | **Хувийн эрүүл мэндийн даатгалын загвар (АНУ)** | **Социалист загвар (Куба)** |
|---|---|---|---|---|
| Шийдвэр гаргах механизм | ЗГ шийдвэр гаргаж, менежмент хийнэ. | Даатгалын сан болон Эмч нарын холбоо шийдвэр гаргаж менежмент хийнэ. | Хувийн бизнесийн зарчмаар ажиллана. | ЗГ шийдвэр гаргаж, менежмент хийнэ. |
| Эх үүсвэр (нөөц) | Төсөв(татвар) | Ажилтан ба ажил олгогчийн шимтгэл | Хувийн санхүүжилт | Улсын төсөв |
| Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч | Улсын | Улсын/хувийн | Хувийн | Улсын |

*Эх сурвалж: Isik 2015*

Санхүүжилтийн зарчим, арга механизмаас хамааруулан эрүүл мэндийн тогтолцоог дараах түгээмэл 4 ангилалд хуваан авч үзсэн байна.[6]

1. Бизнесийн буюу чөлөөт эрүүл мэндийн тогтолцоо

Чөлөөт зах зээлийн эрүүл мэндийн тогтолцоотой орнуудад хувийн хэвшлийн зүгээс эрүүл мэндийн үйлчилгээний эрэлт, нийлүүлэлтийн аль алинд оролцдог, тогтолцооны

[5] Mustafa, I. S. İ. K., Fikriye, I. S. İ. K., & Kiyak, M. (2015). Analyzing financial structure of Turkish healthcare system in comparison with us, German, British, French and Cuban healthcare systems. Journal of Economics Finance and Accounting, 2(4).

[6] Milton I. Roemer-ийн арга

UIH.MN СУДАЛГААНЫ САН

үндсэн хэсэг нь болдог. Эрүүл мэндийн үйлчилгээний төлбөрийг хувь хүн өөрөө гаргах, эсхүл хувийн даатгалаас санхүүжүүлэх боломжтой байдаг тул ихэвчлэн чинээлэг давхаргын хүмүүс эрүүл мэндийн үйлчилгээнд бүрэн хамрагдах, чанартай үйлчилгээ авах боломжтой байдаг байна. Энэхүү загварыг нэвтрүүлсэн орнуудын сонгодог жишээ нь АНУ болон Бразил улс юм.

2. Нийгмийн хамгааллалд суурилсан эрүүл мэндийн тогтолцоо

Энэ тогтолцооны санхүүжилтийн механизм нь Бисмарк загвартай дүйцдэг. Бисмарк загварыг анх Германд нэвтрүүлсэн бөгөөд Австри, Бельги, Франц, Нидерланд зэрэг Европын орнууд, түүнчлэн дэлхийн хөгжингүй ба хөгжиж буй орнуудад түгээмэл ашиглаж байна. Энэхүү загвар нь 1990 оноос хойш хэрэгжүүлсэн Дэлхийн банкны эрүүл мэндийн бодлогын шинэчлэлийн хүрээнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилтийн хамгийн түгээмэл хэрэглэгддэг арга болсон байна. Энэ тогтолцооны санхүүжилтийн эх үүсвэр нь шимтгэлийн орлого байх ба эрүүл мэндийн үйлчилгээнд төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд аль аль нь оролцдог. Санхүүжилтийн үндсэн зарчим нь бүх иргэдийг эрүүл мэндийн даатгалд заавал хамруулахад оршдог.

3. Ерөнхий ба хүртээмжтэй эрүүл мэндийн тогтолцоо

Энэ тогтолцооны санхүүжилтийн механизм нь Бевериджийн загвартай дүйцдэг ба төрөөс удирдлагыг хэрэгжүүлнэ. Бевериджийн загвар нь Их Британид анх үүссэн бөгөөд өнөөдөр энэхүү загварыг Дани, Финланд, Ирланд, Испани, Швед, Итали, Норвеги, Португал, Грект ашиглаж байна. Эрүүл мэндийн үйлчилгээний санхүүжилтийн гол эх үүсвэр нь татвар (төсөв)-ын эх үүсвэр байна. Засгийн газрын зүгээс эрүүл мэндийн тогтолцооны санхүүжилтийг төсвөөр дамжуулан хянах ба бүх иргэд даатгалын шимтгэл төлснөөр эрүүл мэндийн үйлчилгээнд үнэ төлбөргүй хамрагддаг. Эмч нарыг нэг өвчтөнийг эмчлэх үнэлгээний системээр (fee per patient) цалинжуулдаг ба эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас эрүүл мэндийн салбарт зарцуулах төсвийг тогтоодог. Хувийн хэвшлийнхэн эрүүл мэндийн үйлчилгээнд оролцож болох ба үнээс үүдэн гарах сөрөг үр дагаврыг сайтар хянан зохицуулах аудитын системтэй байдаг.

4. Социалист буюу төвлөрсөн төлөвлөгөөт эрүүл мэндийн тогтолцоо

Социалист хэлбэрийн эрүүл мэндийн тогтолцоо нь урьдчилан сэргийлэх үзлэг болон эрүүл мэндийн үйлчилгээ, эмчилгээг бүх иргэнд үнэ төлбөргүй үзүүлдгээрээ онцлогтой юм. Эрүүл мэндийн үйлчилгээнд хувийн хэвшил оролцдоггүй бөгөөд төрөөс бүрэн хянаж зохицуулдаг. Куба Улс нь энэ системийн гол төлөөлөгч болдог.

### 1.5.Дэлхийн зарим орнуудын эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцооны онцлог

***Америкийн Нэгдсэн Улс***

АНУ-ын эрүүл мэндийн тогтолцоо хувийн хэвшлийн эрүүл мэндийн даатгалын байгууллагууд дээр суурилсан байдаг. Ихэнх иргэд хувийн эрүүл мэндийн даатгалтай байдаг. Үйлчилгээг ихэвчлэн хувийн эрүүл мэндийн байгууллагууд болон хувийн эмнэлэгтэй эмч нар үзүүлдэг. Эрүүл мэндийн анхан шатны тусламж үзүүлэгч байгууллага төдийлөн хүчтэй биш бөгөөд нэг хүнд ногдох эрүүл мэндийн зардал ихээхэн өндөр байна. Эрүүл мэндийн салбарын зардлын ҮНБ-д эзлэх хувь өндөр буюу 16.5 хувьтай байдаг. Энэ хэмжээ нь OECD орнуудын дундаж түвшнээс ойролцоогоор хоёр дахин илүү байна. Ийнхүү эрүүл мэндэд зарцуулах зардал нь их боловч эрүүл мэндийн үзүүлэлтүүд нь сайн биш, дэлхийн нэр хүнд бүхий оношилгоо, эмчилгээний төвүүд, судалгааны байгууллагууддаа маш их ач холбогдол өгч, хөрөнгө оруулдаг. Мөн хүн амын

UIH.MN СУДАЛГААНЫ САН

нэлээд хэсэг нь эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүйн улмаас эрүүл мэндийн анхан шатны зохих тусламж үйлчилгээг авч чаддаггүй. Энэ бэрхшээлийг даван туулахын тулд АНУ-ын засгийн газар Medicare, Medicaid хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж эхэлсэн ба тэтгэврийн насныхан болон бага орлоготой иргэдийн эрүүл мэндийн зардлыг нөхөх зорилготой юм. Эдгээр хөтөлбөрийн сул тал нь эрүүл мэндийн бүх зардлыг хамруулж чадаагүйд оршино.

АНУ-ын загварын онцлог бол туйлын өндөр өртөгтэй боловч эрүүл мэндийн үзүүлэлтүүд нь тэр хэмжээгээрээ сайн байж чадахгүй байгаа явдал юм. Эрүүл мэндийн зардлыг өндөр өртөг бүхий хоёрдогч, гуравдугаар шатлалын эмчилгээ, үйлчилгээнд хуваарилдаг тул ашиг багатай анхан шатны тусламж үйлчилгээний байгууллагууд хувийн хэвшлийн сонирхлыг төдийлөн татаж чаддаггүй байна. Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний удирдлагыг төрийн байгууллагууд нь сайтар зохион байгуулж чаддаггүй тул өндөр өртөг бүхий хоёрдогч, гуравдагч шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах боломж муутай иргэд эрүүл мэндийн үйлчилгээг хангалттай хэмжээнд авч чадахгүй байгаа нь асуудал болж байна.

***Их Британи***

NHS нь Их Британид амьдардаг бүх хүмүүст үнэ төлбөргүй эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг. NHS-ийн санхүүгийн гол эх үүсвэр нь татварын орлого бөгөөд улсын төсвөөс эрүүл мэндийн үйлчилгээнд ихээхэн зардал гаргадаг. Эрүүл мэндийн салбарын нийт санхүүжилтийн 82.2% нь төсвөөс, 10% нь өргөн хэрэглээний барааны татварын эх үүсвэрээс, 7.8% нь өвчтөний зүгээс төлөх шимтгэлийн эх үүсвэрээс тус тус бүрддэг. Эрүүл мэндийн энэ тогтолцооны талаарх иргэдийн хүлээлт болон сөрөг хандлага их байдаг ч Их Британийн эрүүл мэндийн зардал Европын Холбоо болон OECD-ийн гишүүн бусад орнуудын дунджаас доогуур, хэмнэлт сайтай байж чаддаг байна.

***Герман Улс***

Германы эрүүл мэндийн систем нь иргэдэд хамгийн өргөн хүрээтэй эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдгээрээ онцлогтой. Эрүүл мэндийн үйлчилгээг ихэвчлэн төрийн эрүүл мэндийн байгууллагууд үзүүлдэг ба нийгмийн даатгалын тогтолцоогоор санхүүжүүлдэг. Одоогоор дэлхийн 100 гаруй улс эрүүл мэндийн тогтолцоондоо энэ системийг нэвтрүүлээд байна.

Энэ тогтолцоонд иргэдээс эрүүл мэндийн даатгалын шимтгэл авдаг ба иргэдийн орлогын байдалтай шууд хамааралтай байна. Ажил олгогч нь мөн давхар шимтгэл төлдөг. Эрүүл мэндийн суурь үйлчилгээний хамрах хүрээ хязгаарлагдмал ба нэмэлт даатгалын багцыг худалдаж авах боломжтой байдаг.

Герман Улс эрүүл мэндийн холимог санхүүжилтийн тогтолцоотой бөгөөд өвчний даатгалын санг хараат бус бие даасан байгууллагууд удирддаг. Германд бараг бүх иргэд эрүүл мэндийн даатгалд хамрагддаг.

Герман Улс нь дэлхийд хамгийн хүчтэй эрүүл мэндийн тогтолцоотой орнуудын тоонд ордог бөгөөд нийтийн эрүүл мэндийн даатгалын бизнес сайн хөгжсөн байдаг. Хүн бүр эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах боломжтой. Нийт иргэдийн 90 хувь нь нийгмийн даатгалд хамрагдсан байдаг ба сар бүр тогтмол шимтгэл төлдөг. Хүн амын зарим хэсэг нь улсын даатгалын хөтөлбөрөөс гадна хувийн даатгалд нэмж хамрагддаг. Гэхдээ Германы эрүүл мэндийн санхүүжилтийн өрийн хэмжээ насжиж буй хүн амын бүтэцтэй холбоотойгоор нэмэгдэж байна.

Герман Улс эрүүл мэндийн зардалдаа ҮНБ-ний 10.8%-ийг зарцуулдаг ба энэ нь OECD орнуудын дунджаас дээгүүр (7.9%) байна. Эрүүл мэндийн нийт зардлын улсын төсвөөс



UIH.MN СУДАЛГААНЫ САН

(public share) гаргах хувь 74.9% ба 16.6 хувийг төвлөрсөн төсвөөс (central share), үлдсэн хэсгийг нийгмийн хамгааллын сангаас (social security fund) санхүүжүүлдэг. Нийт эрүүл мэндийн зардлын 97 хувийг урсгал зардалд зарцуулах ба зөвхөн 3%-ийг хөрөнгө оруулалтад зориулдаг. Тиймээс төрөөс эрүүл мэндийн салбарт томоохон хөрөнгө оруулалт бараг хийдэггүй. Хувийн салбарын зардал нийт эрүүл мэндийн зардлын 25.1%-ийг эзлэх ба хувь хүнээс гарч буй зардал нь хувийн салбарын эрүүл мэндийн зардлын 42.4%-ийг эзэлж байна. Эрүүл мэндийн нийт зардалд хувийн эрүүл мэндийн даатгалын зардал 7%, хувь хүнээс гарах зардал 7%, нийгмийн хамгааллын хөтөлбөрийн зардал 3%-ийг эзэлж байна.

***Франц Улс***

Францын эрүүл мэндийн тогтолцооны зардал нь улсын нийгмийн даатгалаас гардаг ба өвчний сайн дурын даатгал нэмэгддэг. Францад оршин суух зөвшөөрөлтэй бүх хүн нийгмийн эрүүл мэндийн даатгалд хамрагддаг. Хүн амын 74% нь эрүүл мэндийн даатгалын үндэсний сан, 7% нь хөдөө аж ахуйн ажилчдын даатгалын сан, 9% нь ажил олгогчдын сан, 6% нь ЭМЯ-ны сан, 2% нь хувийн байгууллагын санд хамрагддаг. Эхлээд эрүүл мэндийн үйлчилгээ авагч нь бүх төлбөрөө төлсний дараа төлбөрийн 75%-ийг холбогдох сангаас нөхөн олгодог.

Үндсэн зарчим нь нийгмийн даатгалд хамрагдсан иргэний эрүүл мэндийн бүх зардлыг Нийгмийн хамгааллын алба ба Эрүүл мэндийн үндэсний даатгалын хөтөлбөрийн дагуу нөхөн төлдөг явдал юм. Эрүүл мэндийн тогтолцоон дахь даатгалын сангууд нийтлэг зарчимтай бөгөөд даатгуулагч ажилтан, ажил олгогчийн заавал төлөх шимтгэлд үндэслэн нөөцөө бүрдүүлдэг. Энэхүү заавал төлөх шимтгэлийн хэмжээ нь даатгуулагч ажилтны сонгосон үйлчилгээний хүрээгээр шийдэгдэнэ.

Эрүүл мэндэд зарцуулж буй ҮНБ-ний эзлэх хувь хэмжээ 9% байна. Европын Холбооны бусад орнуудаас ялгаатай нь эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх зардалд их зардал, урьдчилан сэргийлэх эмчилгээнд бага зардал хуваарилдгаараа онцлог. ДЭМБ-аас Францын эрүүл мэндийн системийг 2000 оны шилдэг эрүүл мэндийн системээр шалгаруулсан байна. Либерализм ба үүрэг хариуцлага, аудит ба хүлээцтэй байдал, төвлөрөл ба бие даасан байдлууд нь тэнцвэртэй, дэлхийн сайн жишиг хэмээн тодорхойлсон байна. Засгийн газар нь жил бүр Нийгмийн хамгааллын санхүүгийн тухай хуулийн төслийг парламентад өргөн барьдаг ба ирэх жилийн эрүүл мэндийн даатгалын зардлынхаа зорилтыг тодорхойлдог байна. Энэхүү зохицуулалтад Эрүүл мэндийн яам ихээхэн үүрэг гүйцэтгэдэг.

ДЭМБ ба Дэлхийн банкны мэдээллээр Францын нийт эрүүл мэндийн зардлын 79% нь улсын төсвөөс гарч байгаа нь Герман, Бельги улсын эрүүл мэндийн зардлаас дээгүүр үзүүлэлт юм.

***Куба Улс***

Эрүүл мэндийн социалист, төвлөрсөн төлөвлөгөөт тогтолцоотой орнуудад дараах зарчмуудыг голчлон баримталдаг. Эрүүл мэндийн үйлчилгээний тэргүүлэх чиглэл нь нийтийн эрх ашигт суурилдаг ба хүн бүр нийгмийн даатгалд хамрагдан үнэ төлбөргүй эрүүл мэндийн үйлчилгээ авах боломжтой.

Эрүүл мэндийн зардалд хуваарилсан ҮНБ-ний хувь 10.1% буюу харьцангуй өндөр байна Эрүүл мэндийн үйлчилгээг зөвхөн төрийн эрүүл мэндийн байгууллага хариуцах ба хувийн хэвшлийн оролцоо байхгүй. Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээнд суурилсан байдаг ба урьдчилан сэргийлэх тусламж үйлчилгээнд тэргүүлэх ач холбогдол өгч бүх түвшний эмчилгээ үйлчилгээг нэгдсэн байдлаар зохион байгуулдаг.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Эрүүл мэндийн нийт зардлын 92.6 хувийг төсвийн хөрөнгөөр санхүүжүүлдэг. Куба бол хөгжиж буй орон боловч эрүүл мэндийн салбарын хөгжил маш сайн байгаа нь ажиглагддаг. Сүрьеэгийн өвчлөл бага, вакцинжуулалт (дархлаажуулалт) өндөр, нялхсын эндэгдэл бага байгаа нь эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний системийг үр дүнтэй явуулж байгааг илэрхийлэх үндсэн үзүүлэлт юм. Цэвэр ус, ариун цэврийн байгууламжаар хангахад хөрөнгө оруулалт их хийсэн нь халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхэд ихээхэн хувь нэмэр оруулсан. Куба бол дэлхийн 180 орноос эрүүл мэндийн тусламж үйлчилгээний үзүүлэлт сайтай эхний 30 орны нэг юм.

Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн талаас нь авч үзвэл эрүүл мэндийн ихэнх үйлчилгээ үнэ төлбөргүй бөгөөд бүх нийтийг хамардаг. Засгийн газрын нөөц бололцоо хязгаарлагдмал байдаг ч урьдчилан сэргийлэх эм, оношилгоо, шинжилгээ, хэвтүүлэн эмчлэх эмэнд ямар ч төлбөр авдаггүй. Хувь хүнээс гарах зардал маш бага байна. Тухайлбал амбулторын эм, сонсголын аппарат, шүд, ортопедийн протез, дугуй сандал зэргийг хувиасаа гаргадаг. Эдгээр үйлчилгээ нь бага орлоготой иргэдийн хувьд үнэгүй байдаг. Эрүүл мэндийн байгууллагууд нь улсынх бөгөөд эрүүл мэндийн бүх ажилчид тогтмолоор цалинждаг.

***Турк Улс***

Туркийн эрүүл мэндийн үйлчилгээг харилцан уялдаа холбоо муутай санхүүгийн янз бүрийн эх үүсвэрээр удаан хугацаанд санхүүжүүлж ирснийг 2006 оноос эрүүл мэндийн ерөнхий даатгалын тогтолцоо руу шилжүүлснээс хойш санхүүгийн ялгаатай эх үүсвэрүүдийг хянах боломж бүрдсэн. Энэхүү загварт эрүүл мэндийн тусламж үйлчилгээг эрүүл мэндийн үйлчилгээний хэрэглэгчдээс шууд болон шууд бусаар авдаг даатгалын шимтгэлээр санхүүжүүлдэг.

Эрүүл мэндийн санхүүжилтэд тодорхой үүрэг гүйцэтгэдэг нийгмийн эрүүл мэндийн даатгалын бүх байгууллагыг Эрүүл мэндийн ерөнхий даатгалын дор удирдан зохион байгуулдаг. Эрүүл мэндийн ерөнхий даатгалын тогтолцооны хүрээнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг дараах 4 эх үүсвэрээр санхүүжүүлдэг.

- Нийгэм хамгааллын албанаас хуваарилсан нөөц буюу ажилтан, ажил олгогчдын төлсөн татвар.
- Төсвөөс хуваарилсан нөөц буюу татвар
- Хувь хүнээс гарах зардал
- Эрүүл мэндийн даатгалд хувийн байгууллагаас орж ирэх нөөц буюу хувийн эрүүл мэндийн даатгалын шимтгэл.

Эрүүл мэндийн нийт зардлын төсвөөс гарах хувь 75.5% ба нийт эрүүл мэндийн зардлын зөвхөн 5.9%-ийг эрүүл мэндийн хөрөнгө оруулалтад хуваарилдаг байна. Энэхүү эрүүл мэндийн хөрөнгө оруулалтын зардлын 57.4% нь Эрүүл мэндийн яамнаас, 12% нь их дээд сургуулиас, 7% нь бусад эрүүл мэндийн байгууллагаас, 23.5% нь хувийн эрүүл мэндийн байгууллагуудаас гарч байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

## 1.6.Эрүүл мэндийн санхүүжилтийн ялгаатай тогтолцоон дахь эрүүл мэндийн салбарын үр дүнгийн үзүүлэлтүүдийн харьцуулалт

**Эрүүл мэндийн зардал ба эрүүл мэндийн үзүүлэлтүүдийг харьцуулсан байдал**

| Улс | Нэг хүнд ногдох эрүүл мэндийн зардал ($) | ҮНБ-д эрүүл мэндийн зардлын эзлэх хувь (%) | Дундаж наслалт | Нялхсын эндэгдэл | Эмнэлэгт тухайн өдрөө үзүүлэх цаг авч чадахгүй байх хувь (%) | Эрүүл мэндийн үйлчилгээний төлбөрийн чадамжгүй байдал (%) |
|---|---|---|---|---|---|---|
| Беверидж загвартай улс | 3401 | 9,5 | 79,9 | 3,2 | 48,5 | 9,5 |
| Бисмарк загвартай улс | 3345 | 9,1 | 80,7 | 3,4 | 44,0 | 15,5 |
| АНУ | 8505 | 17,7 | 78,6 | 6,0 | 70,0 | 33,0 |
| Турк | 984 | 5,4 | 74,6 | 7,4 | - | - |

*Эх сурвалж: OECD 2014*

Дээрх хүснэгтэд Беверидж ба Бисмарк загвартай орнуудыг хувийн даатгалын тогтолцоотой АНУ болон холимог тогтолцоотой Турк Улстай харьцуулж үзэхэд:

- Беверидж ба Бисмарк загвартай орнуудын үзүүлэлт ерөнхийдөө аль аль талдаа ачаалал багатай дундаж түвшинд байгаа нь харагдаж байна. 1 хүнд ногдох ЭМ-ийн зардал амьжиргааны түвшинтэй харьцуулахад боломжийн, дундаж наслалт өндөр, нялхсын эндэгдэл бага байхаас гадна эмнэлгийн үйлчилгээ хүртээмжтэй, иргэдэд төлбөрийн хүндрэл харьцангуй бага гардаг нь харагдаж байна.
- тэгвэл зах зээлийн загвартай АНУ-д нэг хүнд ногдох эрүүл мэндийн зардал өндөр хэдий ч эмнэлгийн үйлчилгээ хүртээмжгүй, иргэдэд төлбөрийн ачаалал их ирдэг нь харагдаж байна.

## 1.7.Олон улсын эрүүл мэндийн тогтолцооны үр нөлөөг хэмжих үзүүлэлтүүд

Эрүүл мэндийн салбарт шинэчлэл хийж, үр өгөөжийг сайжруулахын тулд эхлээд улс орнуудын эрүүл мэндийн тогтолцооны гүйцэтгэлийн үр дүнг тодорхойлох шаардлагатай болдог. 2000 онд ДЭМБ-аас 191 орныг хамруулан энэ асуудлыг судалж, эрүүл мэндийн салбарын гүйцэтгэлийг үнэлэх аргачлал боловсруулсан байна.

Эрүүл мэндийн тогтолцооны үр нөлөөг үндсэн 5 үзүүлэлтийг багтаасан эрүүл мэндийн үр дүнгийн индекс (health system performance composite index)-ээр тооцоолсон байна.[7] Эдгээр 5 үзүүлэлт нь:

1. Хүн амын эрүүл мэндийн сайжрах байдлын хүрсэн түвшин
2. Хүн амын эрүүл мэндийн сайжрах байдлын тархалт жигд байх
3. Эрүүл мэндийн тогтолцооны хариу үйлдэл хүн амын хүлээлтийн түвшинд хүрсэн байх
4. Эрүүл мэндийн тогтолцооны хариу үйлдэл жигд хүртээмжтэй байх
5. Эрүүл мэндийн санхүүжилт буюу хүн амыг санхүүгийн эрсдэлээс хамгаалах тэгш зарчим

[7] Tandon, A., Murray, C. J., Lauer, J. A., & Evans, D. B. (2000). Measuring overall health system performance for 191 countries. *Geneva: World Health Organization*.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Дээрх 5 үзүүлэлтэд үндэслэн улс орнуудын эрүүл мэндийн тогтолцооны гүйцэтгэлийн индексийг тодорхойлоход 2000 оны байдлаар Франц, Итали тэргүүлж, Япон 10, Норвеги 11, Шинэ Зеланд 41-р байранд тус тус орж байсан ба Монгол Улс эрүүл мэндийн тогтолцооны гүйцэтгэлийн үзүүлэлтээр 145-д жагсаж байжээ. Харин 2021 оны байдлаар эдгээр орнууд тэргүүлэх байр сууриа хадгалсаар байгаа ба Монгол орны үзүүлэлт энэ жилийн тооцоололд судлагдаагүй байна.[8]

Мөн түүнчлэн Жонс-Хопкинсын Их Сургууль болон Олон улсын цөмийн аюулгүй байдлыг хамгаалах байгууллага хамтран 2019 онд дэлхийн 195 орныг хамруулсан Глобал эрүүл мэндийн аюулгүй байдлын индексийг (Global health security index) боловсруулсан ба үүнд доорх үндсэн 6 категор ба түүнээс салбарлах 34 үзүүлэлтийг нэгтгэн тооцоолсон байна.[9] Үүнд:

1. Урьдчилан сэргийлэлт- антибиотикт тэсвэрт чанар, зоонозын өвчнүүд, биологийн аюулгүй байдал, биологийн аюулгүй байдлын хамгаалалт, хариуцлагатай шинжлэх ухаан, дархлаажуулалт
2. Илрүүлэг-лабораторын тогтолцоо, шуурхай хяналт, мэдээлэл, тархвар судлалын боловсон хүчин, хүн, амьтан, орчны өгөгдлийг нэгтгэж дүгнэх байдал
3. Хариу арга хэмжээ авах-онцгой байдлын үеийн бэлэн байдал, төлөвлөгөөтэй байдал, онцгой байдалд үзүүлэх үйл ажиллагаа, нийгмийн эрүүл мэнд ба аюулгүй байдлын уялдаа холбоо, эрсдэлийг үнэлэх, харилцаа холбооны дэд бүтэц, аялал жуулчлал ба худалдааны хязгаарлалт
4. Эрүүл мэнд- эмнэлгийн хүчин чадал, эрүүл мэндийн ажилчдын хуваарилалт, эрүүл мэндийн хүртээмжтэй байдал, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед эрүүл мэндийн ажилтантай холбоо харилцаатай байх боломж, халдварт өвчнийг хянах туршлага, тоног төхөөрөмжийн хүрэлцээтэй байдал, анагаах ухааны шинэ аргачлалыг турших, зөвшөөрөл гаргах чадамж
5. Нормативууд- нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед олон улсад мэдээлэх нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын арга хэмжээг авахдаа олон улсын гэрээнд нэгдэх, олон улсын амлалт, олон улсын хүн ба амьтны эрүүл мэндийн аюулгүй байдлын судалгаанд нэгдэх, уг судалгаанд зориулж төсвөөс санхүүжилт гарсан эсэх, генийн ба биологийн өгөгдөл, дээжээ хуваалцах эсэх
6. Эрсдэл- улс төрийн ба аюулгүй байдлын эрсдэл, нийгэм эдийн засгийн эрсдэл, дэд бүтцийн чадавх, орчны эрсдэл, нийгмийн эрүүл мэндийн эмзэг байдал (дундаж наслалт, эрүүл мэндийн үйлчилгээний чанар, шаардлага хангасан ундны ус, ариун цэврийн байгууламжийн хангамж, нэг хүнд ногдох эрүүл мэндийн төсвийн зарцуулалт)

Дээрх үзүүлэлтүүдийг нэгтгэн Глобал эрүүл мэндийн аюулгүй байдлын индексийг тооцоолон гаргахад АНУ, Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хаант улс (ИБУИНХУ) тэргүүлж, Норвеги 16, Япон 21, Шинэ Зеланд 35-д жагссан бол Монгол Улс 46-д жагссан байна.

### 1.8.Дэлхийн улс орнуудын эрүүл мэндийн салбарын ерөнхий үзүүлэлт ба Монгол Улсын нөхцөл байдал

Дэлхий дахинаа эрүүл мэндийн тогтолцоог үнэлж дүгнэхдээ эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, эрүүл мэндийн салбарт зарцуулах зардал, хүн амын эрүүл

[8] https://worldpopulationreview.com/country-rankings/best-healthcare-in-the-world
[9] https://www.ghsindex.org

UIH.MN СУДАЛГААНЫ САН

мэндийн үндсэн үзүүлэлтүүдийг ашигладаг. Өндөр орлоготой орнуудад эрүүл мэндийн зардлын зарцуулалт өндөр байхын хэрээр эрүүл мэндийн тогтолцоо хүртээмж ихтэй, хүн амын үзүүлэлт сайн байна.[10]

**Эрүүл мэндийн салбарын ерөнхий үзүүлэлтийг Монгол Улстай харьцуулсан байдал**

| Үзүүлэлт | Дэлхийн дундаж | Өндөр орлоготой орнуудын дундаж | Бага дунд орлоготой орнуудын дундаж | Монгол Улс (2019 оны жилийн эцсийн байдлаар) |
|---|---|---|---|---|
| **Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжтэй байдал** | | | | |
| Эмнэлгийн ор (1000 хүнд ногдох) | 2.8 | 5.2 | 0.7 | 8.0 |
| Их эмч (10000 хүнд) | 13.9 | 28.7 | 7.9 | 36.8 |
| Сувилагч, эх баригч (10000 хүнд) | 28.6 | 88.2 | 18.0 | 43.2 |
| Эм зүйч (10000 хүнд) | 4.5 | 10.1 | 4.2 | 7.8 |
| Шүдний эмч (10000 хүнд) | 2.8 | 6.5 | 1.2 | 4.4 |
| **Эрүүл мэндийн салбарын зардлын үзүүлэлт** | | | | |
| ДНБ-д эрүүл мэндийн зардлын эзлэх хувь | 8.6 | 11.6 | 4.1 | 2.2 |
| Улсын төсөвт эрүүл мэндийн зардлын эзлэх хувь | 14.1 | 16.8 | 6.2 | 7.2 |
| Нэг хүнд ногдох эрүүл мэндийн зардал (ам.доллар) | 615 | 2857 | 32 | 92 |
| **Хүн амын эрүүл мэндийн үзүүлэлт** | | | | |
| Дундаж наслалт | 71 | 79 | 68 | 70 |
| Нялхсын эндэгдэл (1000 амьд төрөлтөнд) | 33.6 | 5.3 | 44 | 13.3 |
| 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл (1000 амьд төрөлтөнд) | 45.6 | 6.3 | 59 | 16.1 |
| Эхийн эндэгдэл (100000 амьд төрөлтөнд) | 210 | 17 | 240 | 23 |

*Эх сурвалж: ДЭМБ 2015, Дэлхийн банк 2021, Үндэсний Статистикийн Хороо 2020*

Хүснэгтээс харахад бусад бага дунд орлоготой орнуудтай харьцуулахад Монгол Улсын ДНБ-д эрүүл мэндийн зардлын эзлэх хувь маш бага 2.2 хувь, улсын төсөвт эрүүл мэндийн зардлын эзлэх хувь, нэг хүнд ногдох эрүүл мэндийн зардлын хувиараа арай өндөр байна. Мөн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж бусад бага дунд орлоготой орнуудаас илүү, их эмчийн 10 мянган хүнд ногдох тоогоор өндөр орлоготой орнуудаас ч илүү байгаа нь харагдаж байна. Мөн хүн амын эрүүл мэндийн үзүүлэлтээр бага дунд орлоготой орнуудыг бодвол харьцангуй сайн байгаа ч өндөр орлоготой оронтой харьцуулахад их эмчийн тооноос бусад бүх үзүүлэлтээр дор байгаа нь уг хүснэгтээс харагдаж байна.

### 1.9.Дэлхий дахины эрүүл мэндийн санхүүжилтийн зарцуулалт

ДЭМБ-аас 2020 онд гаргасан Дэлхий дахины эрүүл мэндийн зарцуулалтын тайланд өндөр, өндөр дунд, бага дунд, бага орлоготой орнуудын эрүүл мэндийн санхүүжилтийн зарцуулалтыг харьцуулсан байна.[11] Энэ тайланд дурдсанаар КОВИД-19 цар тахлаас өмнө дэлхийн хэмжээнд эрүүл мэндэд зарцуулах зардал тасралтгүй өссөөр байжээ.

[10] https://data.worldbank.org/
https://apps.who.int/iris/bitstream/handle/10665/332070/9789240005105-eng.pdf

[11] Vrijburg, K. L., & Hernández-Peña, P. (2020). Global spending on health: Weathering the storm 2020. *World Health Organization Working paper*, (19.4).

2018 онд дэлхий дахинаа эрүүл мэндийн зардал 8.3 их наяд доллар буюу дунджаар улс орнуудын дотоодын нийт бүтээгдэхүүний 10%-ийг эзэлж байв. Гэхдээ энэ нь сүүлийн таван жилд анх удаа эрүүл мэндийн салбарын зарцуулалт ДНБ-ний өсөлтөөс удаашралтай байсныг харуулдаг. 2000-2018 онд улс орнуудын нэг хүнд ногдох эрүүл мэндийн зарцуулалт тогтмол өсөж байсан ба 2008-2009 оны эдийн засгийн хямралын дараах эрүүл мэндийн зарцуулалтын өсөлт удаашралтай байжээ.

**Дэлхийн эрүүл мэндийн зарцуулалтын дийлэнх хэсгийг эзэлж буй бүсүүд ба орнууд**




*Эх сурвалж: ДЭМБ 2020*

Бага, дунд орлоготой орнуудын эрүүл мэндийн нийт зардалд хувь хүнээс гарч буй зардлын эзлэх хувь 40%-иас дээш хэвээр байна. Эдгээр орнуудын эрүүл мэндийн зардалд зориулсан гадны тусламж оргил үедээ хүрч байсан ба сүүлийн жилүүдэд дундаж орлоготой орнуудын хүлээн авсан гадны тусламжийн эзлэх хувь нэмэгдэж, бага орлоготой орнуудынхаас давсан байна. Энэхүү эрүүл мэндэд үзүүлэх гадны тусламж нь бага, дунд орлоготой орнуудад голчлон халдварт ба шимэгчийн өвчний хөтөлбөрийг санхүүжүүлэхэд ашиглагдсан бол эдгээр орнуудын дотоодын төсөв ихэвчлэн халдварт бус өвчинтэй тэмцэхэд төвлөрч байна.

Бага орлоготой орнуудад халдварт өвчинд зарцуулах зардал нийт эрүүл мэндийн зардлын тал хувийг эзэлж байсан бол дунд орлоготой орнуудын гуравны нэгийг эзэлж байна. Харин халдварт бус өвчинд зарцуулах зардал дунд орлоготой орнуудын эрүүл мэндийн зардлын 30 орчим хувийг, бага орлоготой орнуудын 13 орчим хувийг эзэлж байна. Бага, дунд орлоготой орнуудад эрүүл мэндэд чиглэсэн гадны тусламжийн гуравны хоёр нь халдварт өвчинд зарцуулагдаж байгаа ба дундаж орлоготой орнуудад ХДХВ-ийн халдварын эсрэг тэмцэх зардал дангаараа эрүүл мэндийн гадны тусламжийн бараг тэн хагасыг эзэлж байна. Бага орлоготой орнуудад халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэхэд зарцуулах зардлын 37% нь дотоодын сангаас орж ирдэг бол 15% нь гадны тусламжаар орж ирдэг байна. Дундаж орлоготой орнууд энэ зардлынхаа 59%-ийг дотоодын төсвийн хөрөнгөөс бүрдүүлж, 2% нь гадны тусламжаас бүрдэж байна.

**Улс орнуудын нэг хүнд ногдох эрүүл мэндийн зардал (ам.доллар)**




*Эх сурвалж: ДЭМБ 2020*

Бага орлоготой гэж тооцогддог нийт 32 оронд эрүүл мэндийн санхүүжилт бэрхшээлтэй байдаг тул эрүүл мэндийн аюулгүй байдал, бүх нийтийн эрүүл мэндийн хамралтын явц удаашралтай байна. Эдгээр орнуудад нэг хүнд ногдох эрүүл мэндийн жилийн зардал 34 ам.доллар байдаг ба энэ нь ДНБ-ний 4.4% орчим бөгөөд үүнээс бараг 60%-ийг хувь хүн өөрөө төлдөг байна. Үүнээс төсвөөс гаргадаг зардал нь дунджаар 9 ам.доллар л байдаг ба энэ нь ДНБ-ний 1.2%-ийг эзэлж байна. Тиймээс эрүүл мэндийн чиглэлийн гадны тусламж өнгөрсөн арван жилийн хугацаанд хоёр дахин нэмэгдэж байна. Монгол Улсад нэг хүнд ногдох эрүүл мэндийн зардал 2020 онд 244 мянган төгрөг буюу 87,14 ам.доллар байна. Доорх зурагт өндөр орлоготой байх тусам төсвөөс гарах эрүүл мэндийн зардлын эзлэх хувь ихэсч байгааг харуулж байна.

КОВИД-19 цар тахлаас үүдэлтэй эрүүл мэнд, эдийн засгийн цочрол нь эрүүл мэндийн зардалд шууд болон шууд бус үр дагавар авчирч, бүх нийтийн эрүүл мэндийн хамралтыг улам удаашруулах хандлагатай байна. Бүх улс орон цар тахлаас үүдсэн эдийн засгийн хямралыг даван туулахын тулд төсвийн хуваарилалт хийж байгаа ч үүнээс эрүүл мэндийн салбарт очих хувь харьцангуй бага байна. Энэ дундаа бага орлоготой улс орнуудын цар тахлын эсрэг эрүүл мэндийн хариу арга хэмжээнд хүнд туссан. Дэлхийн эдийн засгийн гүнзгий хямралыг дагаж гарсан эрүүл мэндийн хямрал нь удаан хугацаанд хадгалагдаж болзошгүй байна. Учир нь улс орнууд эдийн засгийн хямралаа бууруулах гэж нэмэлт өр тавьсаар байна. Тиймээс КОВИД-19-ийн хямралын дунд болон урт хугацааны эрүүл мэндийн зардалд үзүүлэх нөлөө нь макро эдийн засгийн үзүүлэлтүүд, эрүүл мэндийн үйлчилгээний эрэлт, нийлүүлэлтийн хэв маягаас хамаарах юм. Мөн түүнчлэн цар тахал гарахаас өмнө үүссэн эрүүл мэндийн санхүүжилтийн эмзэг байдал нь ойрын жилүүдэд хадгалагдсаар байх болно. Ийнхүү өр төлбөрийн сүлжээнд автсаар

байх нь нийгмийн салбарууд, түүн дотор эрүүл мэндэд зарцуулах төсвийн зардлыг бууруулж, эрүүл мэндийн бүх нийтийн хамралтыг удаашруулах эрсдэлтэй байна. Тиймээс эрүүл мэндийн салбарт ихээхэн анхаарч санхүүжүүлэх бодлого хэрэгжүүлэх нь цар тахлаас үүдэлтэй үр дагаврыг хөнгөвчлөх юм. Харин эрүүл мэндийн санхүүжилтийн сул тогтолцоотой улс орнууд цар тахлын хямралыг ашиглан, шинэчлэл хийх замаар эрүүл мэндийн бүх нийтийн хамралтын хүрээг ахиулж болох юм.

Энэхүү цар тахал дэлхий дахинд эрүүл мэндэд илүү их хэмжээгээр тогтвортой төсвийн санхүүжилт шаардлагатай байгааг батлан харуулж байна. ДЭМБ энэ нөхцөл байдалд үндэслэн дараах зөвлөмжийг хүргэж байна. Үүнд:

1.Нийгэм-эдийн засгийн тэргүүлэх чиглэлд эрүүл мэндэд зарцуулах төсвийн зардлыг багтаах;
2.Нийтийн эрүүл мэндийн хамралтыг сайжруулах, ингэхдээ эхний ээлжид эрүүл мэндийн нийтлэг хэрэглээ болох тархвар судлалын хяналт, лабораторын тогтолцоо, дархлаажуулалтын санхүүжилтийг нэмэгдүүлэх;
3.Дэлхий дахин эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангах нийтлэг зорилгод тэмүүлж байгаа тул эрүүл мэндийн салбарыг хөрөнгө оруулалтын тэргүүлэх чиглэл болгох;
4.Анхан шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, тэгш байдлыг хангахад чиглэсэн төсвийн санхүүжилтийг нэн тэргүүнд тавих;
5.Орлого багатай улс орнуудад чиглэсэн тусламжийг зохих чиглэлд нэмэгдүүлэх;
6.Үндэсний болон дэлхийн түвшинд эрүүл мэндийн зардлын ил тод байдалд хяналт тавих байгууллагуудыг дэмжиж санхүүжүүлэх.

## БҮЛЭГ II. ЭРҮҮЛ МЭНДИЙН САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦООНЫ ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

### 2.1.АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС

Хууль эрх зүйн зохицуулалт

АНУ-д эрүүл мэндийн салбарын санхүүжилт, эрүүл мэндийн даатгалтай холбогдон гарах харилцааг “Нийгмийн халамжийн тухай” (Social Security Act 1965) “Нийтийн эрүүл мэндийн үйлчилгээний тухай” (Public Health Service Act), “Өвчтөнийг хамгаалах, боломжит эрүүл мэндийн үйлчилгээний тухай” (The Patient Protection and Affordable Care Act 2010 (Obamacare))[12] болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулж байна.

“Өвчтөнийг хамгаалах, боломжит эрүүл мэндийн үйлчилгээний тухай” хууль нь 2010 онд батлагдсан бөгөөд тус хуулиар Америкийн иргэн бүр хямд, чанартай эрүүл мэндийн даатгалд хамрагдахад засгийн газар, ажил олгогчид болон иргэдийн хүлээх үүрэг, хариуцлагыг тус тус заасан байна. Энэхүү хуулиар эрүүл мэндийн даатгалд хамрагдах боломжийг нэмэгдүүлэх, хэрэглэгчдийн эрхийг хамгаалах, өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд голлон анхаарах, үйл ажиллагааны гүйцэтгэл, чанарыг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн салбарын ажиллах хүчийг нэмэгдүүлэх, өсөн нэмэгдсээр байгаа эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний үнэ төлбөрийг бууруулах зэрэг зорилгыг тавьсан байна. Эрүүл мэндийн яамны харьяа Хэрэглэгчийн мэдээлэл, даатгалын хяналтын төв (Center for Consumer Information and Insurance Oversight) нь тус хуулийн хэрэгжилтэд, тодруулбал, хувийн эрүүл мэндийн даатгалд хяналт тавьж ажилладаг байна.

[12] https://www.hhs.gov/sites/default/files/ppacacon.pdf

### Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн тогтолцоо

АНУ нь эрүүл мэндийн санхүүжилтийн зах зээлийн буюу хувийн эрүүл мэндийн даатгалын загварт хамрагдаж байна.

**Эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцооны загвар**[13]




АНУ-ын нийт хүн ам 332.981.960 гаруй бөгөөд Дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ ойролцоогоор 17.7%-ийг эрүүл мэндийн салбарт зарцуулж байна. Жилд нэг хүнд ногдох эрүүл мэндийн үйлчилгээний зардал 11.172 ам доллар байна.

**Эрүүл мэндийн салбарын ерөнхий үзүүлэлт**

| Үзүүлэлт | 2019 оны эцсийн байдлаар |
|---|---|
| **Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжтэй байдал** | |
| Эмнэлгийн ор (1000 хүнд ногдох) | 2.87 |
| Их эмч (10000 хүнд) | 26.1 |
| Шүдний эмч (10000 хүнд) | 6.1 |
| Эрүүл мэндийн салбарын зардлын үзүүлэлт | |
| ДНБ-д эрүүл мэндийн зардлын эзлэх хувь | 17.7% |
| Улсын төсөвт эрүүл мэндийн зардлын эзлэх хувь | 3.81 их наяд $ |
| Нэг хүнд ногдох эрүүл мэндийн зардал (ам.доллар) | 11.172$ |

UIH MN СУДАЛГААНЫ САН

13 https://www.commonwealthfund.org/international-health-policy-center/countries/united-states

| Хүн амын эрүүл мэндийн үзүүлэлт | |
|---|---|
| Дундаж наслалт | 79 |
| Нялхсын эндэгдэл (1000 амьд төрөлтөнд) | 4 |
| 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл (1000 амьд төрөлтөнд) | 7 |
| Эхийн эндэгдэл (100000 амьд төрөлтөнд) | 19 |

Эрүүл мэндийн салбарын санхүүжилт нь засгийн газрын санхүүжилт, хувийн даатгал, хувь хүнээс гарч буй зардлаас бүрдэж байна. 2019 оны байдлаар эрүүл мэндийн зардлын 29%-ийг Холбооны засгийн газар, 28.4%-ийг өрх буюу хувь хүний зардал, 19.1%-ийг хувийн даатгал, 16.1%-ийг муж болон орон нутгийн засгийн газар, 7.5%-ийг бусад хувийн орлогоос санхүүжүүлсэн байна. Эрүүл мэндийн санхүүжилт нь эмнэлэг, эмч, ажилтнууд, эм хангамж, асрах, сувилах үйлчилгээ болон эмчилгээний тоног төхөөрөмжинд зарцуулагдаж байна.

2019 оны эцсийн байдлаар 3.8 их наяд ам долларыг эрүүл мэндийн санхүүжилтэнд зарцуулсан байна. Үүнээс:

- 21%-Medicare улсын даатгалд
- 16%-Medicaid улсын даатгалд
- 31%-хувийн эрүүл мэндийн даатгалд
- 11%-хувь хүнээс гарч буй зардал
- 4.2%-эмнэлгийн зардал
- 4.6%-эмч, эмнэлгийн үйлчилгээний зардал
- 5.7%-жороор олгох эмийн зардалд тус тус зарцуулсан байна.[14]

**Эрүүл мэндийн даатгал**

АНУ-д улсын болон хувийн эрүүл мэндийн даатгалын байгууллагууд үйл ажиллагаа явуулж байна. Нийгмийн халамжийн тухай хуулиар засгийн газрын санхүүжилттэй Medicare болон Medicaid даатгалуудыг анх 1965 онд бий болгожээ. Нийт иргэдийн 92 орчим хувь нь эрүүл мэндийн даатгалд хамрагдсанаас 2019 оны байдлаар АНУ-ын иргэдийн 67.2% нь хувийн сайн дурын эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байна. Үүнээс 55.7% нь ажил олгогчоос төлж буй даатгалд, 11.3% нь хувиараа даатгалд хамрагдсан байна. Холбооны засгийн газраас хэрэгжүүлж буй эрүүл мэндийн даатгалын хөтөлбөрүүдэд иргэдийн 34%, үүнээс, Medicare даатгалд 16.1%, Medicaid даатгалд 17.9% хамрагдсан байна. 2016 оны эхний улирлын байдлаар 27.5 сая иргэн буюу нийт хүн амын 8.5% нь эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй үлдсэн байна. Энэ нь “Өвчтөнийг хамгаалах, боломжит эрүүл мэндийн үйлчилгээний тухай” хууль хэрэгжиж эхэлснээс хойш даруй 2 дахин буурсан дүн юм.

*Улсын эрүүл мэндийн даатгал:* Холбооны засгийн газраас санхүүжүүлдэг Medicare даатгалд 65-аас дээш насны ахмад настнууд болон зарим хөгжлийн бэрхшээлтэй иргэд хамрагддаг байна. Холбооны засгийн газар нь дангаараа, зарим мужид мужийн засгийн газартай хамтран Medicaid болон “Хүүхдийн эрүүл мэндийн даатгалын хөтөлбөр” (Children’s Health Insurance Program)-үүдийг тодорхой түвшний бага орлоготой иргэдэд зориулан хэрэгжүүлдэг байна. Олон тооны мужуудад Medicaid хөтөлбөрөөр дамжуулан бага орлоготой насанд хүрсэн иргэдийн даатгалд хамрагдах хүрээг нэмэгдүүлсээр байна. “Хүүхдийн эрүүл мэндийн даатгалын хөтөлбөр”-т 2019 оны байдлаар бага орлоготой өрхийн 9 сая хүүхэд хамрагдан даатгуулсан байна.

[14] https://www.cms.gov/Research-Statistics-Data-and-Systems/Statistics-Trends-and-Reports/NationalHealthExpendData/NHE-Fact-Sheet

UIH.MN СУДАЛГААНЫ САН

*Хувийн эрүүл мэндийн даатгал:* Хувийн эрүүл мэндийн даатгал нь ихэвчлэн мужийн түвшинд хэрэгждэг. Нийт Америкчуудын 2/3 хувь нь хувийн эрүүл мэндийн даатгалд даатгуулсан байна. Ажил олгогчид нь хувийн даатгалын компаниудтай гэрээ хийн ажилтнуудаа даатгалд хамруулах бөгөөд энэ төрлийн даатгалд ихэвчлэн дан ганц ажилтныг бус гэр бүлийнх нь гишүүдийг давхар хамруулдаг байна. Ажил олгогч болон ажилтан аль аль нь даатгалын шимтгэлийг хуваан төлөх бөгөөд цөөн тохиолдолд ажил олгогч нь шимтгэлийг бүтэн төлдөг байна.

*Хувь хүнээс гарч буй зардал:* 2019 оны байдлаар эрүүл мэндийн нийт зардлын 28.4%-ийг өрхөөс төлсөн зардал эзэлсэн байна. Энэ нь холбооны засгийн газраас төлсөн дүн (29%)-тэй бараг тэнцэж байна. Хувь хүнээс гарч буй зардал үүний 1/3-тэй тэнцэж байгаа бөгөөд ихэвчлэн эрүүл мэндийн үйлчилгээний төлбөр нь даатгалд төлсөн төлбөрөөс илүү гарсан тохиолдолд даатгалд төлсөн төлбөрийг бүтнээр нь суутгуулна. Эрүүл мэндийн үйлчилгээний хувь хүнээс гарах зардлын дундаж өртөг жилд 1 хүнд 1846 ам доллар байна.

**Нийт хүн амын даатгалд хамрагдсан байдал (2019 оны байдлаар)**




***Эмнэлгийн санхүүжилт***

Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч эмнэлгийн байгууллагыг улсын болон хувийн эрүүл мэндийн даатгал, хувь хүнээс төлж буй төлбөрөөр санхүүжүүлнэ. Эмнэлгүүд даатгалын сангийн санхүүжилтээ чөлөөтэй сонгох эрхтэй. Санхүүжилтийн хэлбэрүүд нь холимог байна.

- Medicare даатгал нь оношийн хамааралтай бүлгээр төлбөр хийнэ. Үүнд эмчийн цалин орохгүй.
- Medicaid даатгал нь оношийн хамааралтай бүлэг болон нэмэлтээр, түр хугацаагаар ажилласан ажилтны зардал түүнчлэн нөхөн төлбөр дээр үндэслэн төлбөр хийнэ.
- Хувийн даатгал нь ихэвчлэн эмнэлэг бүртэй жилийн гэрээ байгуулан, нэмэлтээр, түр хугацаагаар ажилласан ажилтны зардалд үндэслэн төлбөр хийнэ.[15]

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[15] https://www.commonwealthfund.org/international-health-policy-center/countries/united-states

## 2.2.ИЗРАИЛ УЛС

Израил Улс нь газар дундын тэнгисийн зүүн эрэгт орших баруун Азийн хөгжингүй, парламентын засаглалтай бүгд найрамдах улс (developed country) юм.

Хууль эрх зүйн зохицуулалт: Израил Улсын эрүүл мэндийн тогтолцоо нь 1995 онд батлагдсан Үндэсний эрүүл мэндийн даатгалын тухай хууль (NHI Law)-д үндэслэдэг бөгөөд Хамтын урт хугацааны тусламжийн даатгалын тухай хууль (The Community Long-term Care Insurance Law), Өвчтөний эрх зүйн байдлын тухай хууль (Patient’s rights law)-аар тус тус зохицуулдаг. Хуульд зааснаар эрүүл мэндийн даатгал нь шударга ёс, тэгш байдал, харилцан туслалцааны зарчимд үндэслэх бөгөөд тус улсад оршин суугаа хүн бүр эрүүл мэндийн үйлчилгээ авах эрхтэй.

Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн тогтолцоо: Израил Улс нь 2019 оны дэлхийн эрүүл мэндийн үзүүлэлтээр 169 орноос 10[16] дугаар байр эзэлсэн бөгөөд хүн амын дундаж наслалт (82.8) өндөртэй улс юм.

Нийт хүн ам 9.3 сая бөгөөд 2018 оны байдлаар дотоодын нийт бүтээгдэхүүний 7.6%-ийг[17] эрүүл мэндийн салбарт зарцуулж байна. Нэг хүнд ногдох эрүүл мэндийн үйлчилгээний зардал 3323 ам доллар байна.

**Эрүүл мэндийн салбарын ерөнхий үзүүлэлт**[18]

| Үзүүлэлт | 2018 оны байдлаар |
|---|---|
| **Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжтэй байдал** | |
| Эмнэлгийн ор (1000 хүнд ногдох) | 3,0 |
| Их эмч (1000 хүнд) | 4.6 |
| Сувилагч, эх баригч (1000 хүнд) | 5.7 |
| Эм зүйч (1000 хүнд) | 0.87 |
| Шүдний эмч (1000 хүнд) | 0.77 |
| **Эрүүл мэндийн салбарын зардлын үзүүлэлт** | |
| ДНБ-д эрүүл мэндийн зардлын эзлэх хувь | 7.6% |
| Улсын төсөвт эрүүл мэндийн зардлын эзлэх хувь | 64.7% |
| Нэг хүнд ногдох эрүүл мэндийн зардал (ам.доллар) | 3323 |
| **Хүн амын эрүүл мэндийн үзүүлэлт** | |
| Дундаж наслалт | 82.8 |
| Нялхсын эндэгдэл (1000 амьд төрөлтөнд) | 3 |
| 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл (1000 амьд төрөлтөнд) | 4 |
| Эхийн эндэгдэл (100000 амьд төрөлтөнд) | 3 |

Израилийн эрүүл мэндийн тогтолцоог төсвийн санхүүжилт болон татвар буюу Үндэсний эрүүл мэндийн даатгалын шимтгэл, хувийн эх үүсвэр (VHI and OOP)-ээс санхүүжүүлдэг. Эрүүл мэндийн системийг санхүүжүүлэхдээ эрүүл мэндийн салбарын онцлоготой холбоотойгоор Засгийн газар эрүүл мэндийн төлөвлөгөө (Health plan) тус бүрийн гишүүдийн тоо, тэдгээрийн насны байдал, хүйс, оршин суугаа газрыг харгалзан үзсэн томьёоны дагуу Эрүүл мэндийн санд хуваарилдаг.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[16] https://www.internations.org/go/moving-to-israel/healthcare
[17] https://www.commonwealthfund.org/international-health-policy-center/countries/israel
[18] https://www.theglobaleconomy.com/Israel/

**Эрүүл мэндийн даатгал**

Израил Улс нь бүх нийтийн даатгалд хамрагдах үндэсний эрүүл мэндийн даатгал (NHI)-ын системтэй бөгөөд тус улсын иргэд болон байнга оршин сууж буй бүх иргэд эрүүл мэндийн төлөвлөгөө (HP) хэмээх ашгийн бус дөрвөн эрүүл мэндийн төлөвлөгөөнөөс сонгох эрхтэй. Энэхүү эрүүл мэндийн дөрвөн төлөвлөгөө нь 1920-1940 оны хооронд анх бий болсон. Даатгуулагч нь төсвийн болон хувийн санхүүжилтээр дамжуулан эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авна.

**Санхүүжилтийн урсгал**[19]




Израилийн эрүүл мэндийн даатгалын зардлын 63 хувийг төсвийн хөрөнгөөр санхүүжүүлдэг бол 37 хувийг хувийн даатгалын эх үүсвэрээс санхүүжүүлдэг.

Хувийн санхүүжилтэд хувь хүнээс гарах зардал (OOP) болон сайн дурын эрүүл мэндийн даатгал (VHI) бусад гадны тусламж хамаарна.

Үндэсний эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийг ерөнхийдөө эрүүл мэндийн татвар болон ерөнхий татвараас санхүүжүүлдэг.

Эрүүл мэндийн татвар гэдэг нь 18-аас дээш насны бүх иргэн, оршин суугчдын төлж буй Үндэсний эрүүл мэндийн даатгалын шимтгэл бөгөөд Үндэсний даатгалын байгууллагад (NII) цуглардаг. Эрүүл мэндийн татварт дундаж цалингийн 60 хувь хүртэл цалинтай ажилчдын цалингийн 3%, түүнээс дээш хэмжээтэй цалинтай ажилчдын цалингийн 5-11 хувийн шимтгэл төлдөг. Хувиараа хөдөлмөр эрхлэгч нийт орлогоосоо, тэтгэвэрт гарсан хүмүүс тэтгэврээсээ ижил хувь хэмжээгээр эрүүл мэндийн татвар төлнө. Цалинтай ажил хийдэггүй, гэр бүлтэй эмэгтэйчүүд энэхүү татварыг төлөхөөс чөлөөлөгдөнө. Оюутнууд

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[19] https://www.euro.who.int/__data/assets/pdf_file/0009/302967/Israel-HiT.pdf 83 дахь тал

болон ажилгүй иргэд орлого эсвэл бэлэн мөнгөний шилжүүлгээс 5 хувийг төлөх ёстой. Тухайлбал, ажилгүйдлийн тэтгэмж, орлогын дэмжлэг, үндэсний даатгалын байгууллагын тэтгэмж, тэтгэлэг гэх мэт.

Эрүүл мэндийн зардал нь улсын нэгдсэн төсвийн зардлын 12.1%-ийг эзэлдэг. Харин Засгийн газраас гаргаж буй зардал нь эрүүл мэндийн нийт зардлын 64.7 хувийг эзэлдэг бол хувь хүнээс гарч буй зардал 21.1% байна.

Нэг хүнд ногдох ДНБ 44215 ам доллар байгаа бол нэг хүнд ногдох эрүүл мэндийн зардал 3323 ам доллар байна.

**Шигтгээ:** Эрүүл мэндийн төлөвлөгөө буюу план

**Клалит (Clalit)**-буцаж ирсэн оршин суугчид, жуулчид болон оюутнуудад Израил иргэдтэй адил эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх бөгөөд жирэмсэн үе хамаарах боловч эмнэлэгт хэвтэх, төрөх хамаарахгүй.

**Дарконайм (Darconaim)**-Маккаби эрүүл мэндийн сан-буцаж ирсэн оршин суугчид, жуулчид, оюутнуудад эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх бөгөөд жирэмсэн үе хамаарах боловч эмнэлэгт хэвтэх, төрөх хамаарахгүй.

**Мэүхэдит (Meuhedet)**-гадаад оршин суугчдад зориулсан төлөвлөгөө. Буцаж ирсэн оршин суугчид, жуулчид, оюутнуудад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг.

**Шилоэч (Shiloach)**-жуулчид болон оюутнуудад эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг.

*Эх сурвалж:* https://www.internations.org/go/moving-to-israel/healthcare

*Хувь хүнээс гарах зардал:* Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авч буй иргэдээс анхан шатны тусламж, урьдчилан сэргийлэх үзлэг, хорт хавдрын үзлэг, эмнэлэгт хэвтэн эмчлүүлэхээс бусад эмчилгээ, үйлчилгээнд нэмэлт төлбөр авахыг зөвшөөрдөг. 2016 онд хувь хүнээс гарсан зардал нь улсын эрүүл мэндийн зардлын 22 хувийг эзэлсэн байна. Үүний дийлэнх нь сайн дурын эрүүл мэндийн даатгал (38%), насанд хүрэгчдийн шүдний эмчилгээ (22.5%), эм бэлдмэл (15%)-д зарцуулагджээ.

*Хувийн эрүүл мэндийн даатгал:* Израил Улсын иргэд эрүүл мэндийн дөрвөн сангаас гадна нэмэлт даатгал буюу хувийн эрүүл мэндийн даатгал сонгох боломжтой. Хувийн эрүүл мэндийн даатгалын давуу тал нь илүү олон үйлчилгээ авах боломжтой бөгөөд 2016 онд улсын эрүүл мэндийн зардлын 14%-ийг хувийн эрүүл мэндийн даатгалаас санхүүжүүлжээ. Хувийн эрүүл мэндийн даатгал нь насанд хүрэгчдэд зориулсан шүдний эмчилгээ, зарим эм, эмийн бүтээгдэхүүнийг хамарсан нэмэлт үүрэг гүйцэтгэдэг.

Эрүүл мэндийн салбар дахь шинэчлэл:

Израил Улс нь эрүүл мэндийн салбарт дараах шинэчлэлийг нэвтрүүлж байна. Үүнд:

- Эрүүл хооллолтыг дэмжих орчныг бүрдүүлэх. Эрүүл мэндийн яамнаас хүнсний бүтээгдэхүүний заавал шошголох, хүүхдийн эрүүл мэндэд хортой хүнсний сурталчилгааг хязгаарлах зэрэг арга хэмжээ авчээ. Мөн сургууль цэцэрлэг гэх мэт улсын байгууллагаас гаргаж буй хоолны тэжээллэг чанарыг сайжруулж, эрүүл хооллолтын талаарх боловсролыг бага насны хүүхдүүдийн сургуулийн хөтөлбөрт багтаажээ.
- Олон нийтийн дунд сувилагчийн үүргийг өргөжүүлэх. Эрүүл мэндийн яам 2018 онд

UIH.MN СУДАЛГААНЫ САН

анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлдэг эмч нарт үзүүлэх зарим дарамтыг арилгах зорилгоор орон нутаг дахь нарийн мэргэжлийн сувилагчдын үүрэг, үйл ажиллагааны цар хүрээг өргөтгөсөн. Мэргэшсэн сувилагчид одоо цочмог өвчний хөнгөн хэлбэр, яаралтай боловч эмчлэхэд хялбар өвчнийг эмчлэх, хянах боломжтой болсон.

- Тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг сайжруулах
- Шүдний эмчилгээний хамрах хүрээг цаашид өргөжүүлэх. Эрүүл мэндийн яамны төсөвт эрүүл мэндийн сагсыг өргөжүүлэх зорилгоор 2018 оны туршид 75-аас дээш насны хүмүүст, 2019 оны туршид 18 хүртэлх насны хүүхдийн шүдний эмчилгээнд хамруулахаар төсөвлөжээ.
- Ахмад настнуудад үзүүлэх үйлчилгээний цар хүрээг нэмэгдүүлэх. Израилийн хүн амын насжилт нэмэгдэж байгаатай холбогдуулан Эрүүл мэндийн яам нь урт хугацааны тусламж үйлчилгээнд хамрагдах боломжийг өргөжүүлж байна.

*Тулгамдаж буй зарим асуудал[20]:*

- Эрүүл мэндийн тогтолцоо нь өсөн нэмэгдэж буй эрэлт, эрүүл мэндэд чиглэсэн төсвийн хатуу санхүүжилтийн дарамтанд байдаг.
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаар нийгэм, эдийн засгийн янз бүрийн бүлгүүдийн хоорондын тэгш бус байдлын асуудал хэвээр байна.
- Эрүүл мэндийн даатгалын дөрвөн сан, үйлчилгээ эрхлэгчдийн байнгын алдагдал нь төрийн тогтолцоог дутуу санхүүжүүлж болзошгүйг харуулж байна.

Засгийн газар 2014 оноос хойш эмнэлгүүдийн санхүүжилтэд тавих хяналтаа чангатгаж, сангийн санхүү, төсвийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, алдагдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан боловч өртөг нэмэгдэж байгаатай холбогдуулан сангууд болон үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын алдагдал ирээдүйд хэвээр байх хандлагатай байна.

## 2.3.БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС

Солонгос Улс нь хөгжиж буй орноос өндөр хөгжилтэй орон руу шилжиж буй парламентын засаглалтай бүгд найрамдах улс юм. Эдийн засгийн үзүүлэлтийн хувьд нэг хүнд ногдох ДНБ 33,624 ам доллар бөгөөд дундаж наслалт 83 байна.

Хууль эрх зүйн орчин*:* Солонгос Улс нь эрүүл мэндийн даатгалын тогтолцооны хувьд нийгмийн бүхий л гишүүд заавал даатгуулах ёстой нийгмийн эрүүл мэндийн даатгалын тогтолцоотой. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын хувьд хувийн хэвшил давамгайлсан, бүх эмнэлгүүдийн 90 хувь хувийн хэвшил, клиник эмнэлгүүдийн хувьд бүгд хувийн эмнэлгүүд байдаг.

Эрүүл мэндийн санхүүжилттэй холбоотой харилцааг Үндэсний эрүүл мэндийн даатгалын тухай хууль (National health insurance act), Эрүүл мэндийн даатгалын тухай хууль (Medical insurance act), Урт хугацааны тусламж, үйлчилгээний даатгалын тухай хууль (Long-term care insurance act), Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төлөвлөгөө (Medical Aid Programme) болон бусад дүрэм, журмаар зохицуулдаг.

Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн тогтолцоо*:* БНСУ-ын нийт хүн ам 51.3 сая бөгөөд 2018 оны байдлаар дотоодын нийт бүтээгдэхүүний 8 орчим хувийг эрүүл мэндийн салбарт зарцуулж байна. Жилд нэг хүнд ногдох эрүүл мэндийн үйлчилгээний зардал 2542 ам доллар байна.

[20] https://www.oecd.org/policy-briefs/israel-securing-adequate-resources-for-health-system.pdf

**Эрүүл мэндийн салбарын ерөнхий үзүүлэлт**[21]

| Үзүүлэлт | 2018 оны байдлаар |
|---|---|
| **Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжтэй байдал** | |
| Эмнэлгийн ор (1000 хүнд ногдох) | 12.4 |
| Их эмч (10000 хүнд) | 2.4 |
| Сувилагч, эх баригч (10000 хүнд) | 7.3 |
| Эм зүйч (10000 хүнд) | 0.73 |
| Шүдний эмч (10000 хүнд) | 0.5 |
| **Эрүүл мэндийн салбарын зардлын үзүүлэлт** | |
| ДНБ-д эрүүл мэндийн зардлын эзлэх хувь | 7% |
| Улсын төсөвт эрүүл мэндийн зардлын эзлэх хувь | 14% |
| Нэг хүнд ногдох эрүүл мэндийн зардал (ам.доллар) | 2542 |
| **Хүн амын эрүүл мэндийн үзүүлэлт** | |
| Дундаж наслалт | 83.23 |
| Нялхсын эндэгдэл (1000 амьд төрөлтөнд) | 3 |
| 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл (1000 амьд төрөлтөнд) | 3 |
| Эхийн эндэгдэл (100000 амьд төрөлтөнд) | 43 |

**Эрүүл мэндийн даатгал**

Солонгос улс 1989 онд Үндэсний эрүүл мэндийн даатгалын тогтолцоонд шилжсэн бөгөөд ашгийн бус олон даатгалын сангаас бүрддэг байсан. 2000 онд эрүүл мэндийн салбарт хийсэн шинэчлэлээр дээрх олон сангуудыг нэгтгэн нэг даатгагч буюу Үндэсний эрүүл мэндийн даатгалын сан болгож өөрчилсөн.

Солонгос улсын эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцоонд хувийн хэвшил давамгайлан оролцдог бөгөөд Эрүүл мэндийн яам нь бодлого боловсруулагч, зохицуулагчийн үүрэг гүйцэтгэдэг.

Стратеги, сангийн яам нь Үндэсний эрүүл мэндийн даатгалын системд Засгийн газраас татаас олгож, тамхины татварыг тодорхойлох буюу санхүүжилтэд чиглэсэн чухал үүргийг гүйцэтгэдэг. Эрүүл мэндийн даатгалын бодлогыг Үндэсний эрүүл мэндийн даатгалын байгууллага (NHIS), эрүүл мэндийн даатгалын хяналт, үнэлгээний байгууллага гэсэн хоёр байгууллагаар дамжуулан хэрэгжүүлдэг. Харин орон нутгийн засаг захиргааны нэгжийн зүгээс эрүүл мэндийн салбарт оролцох оролцоо, үүрэг хязгаарлагдмал байдаг. Улсын болон хувийн хэвшлийн эмнэлгүүд нь ижил тэгш эрхтэйгээр Үндэсний эрүүл мэндийн даатгалын сантай гэрээ байгуулж, даатгалын сангаас санхүүжилт авдаг. Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчид нь сангийн нөхөн олговрын үйлчилгээ болон эрүүл мэндийн даатгалын тэтгэмжийн багц дахь үйлчилгээнд нэхэмжлэл гаргадаг.

Солонгосын эрүүл мэндийн зардлын ихэнх хувийг Үндэсний эрүүл мэндийн даатгалд оруулсан шимтгэл ээлдэг бөгөөд Засгийн газрын төсвийн хуваарилалтын гүйцэтгэх үүрэг харьцангуй бага байдаг. Үндэсний эрүүл мэндийн даатгал нь бүх нийтийг хамардаг боловч эрүүл мэндийн зардал дахь хувь хүнээс гарах зардлын хувь хэмжээ их байдаг. Энэ нь өндөр техник технологи шаардсан эмчилгээ, үйлчилгээ, даатгуулсан үйлчилгээний багц болон тэтгэмжийн багцад ороогүй үйлчилгээ авах тохиолдолд иргэд өөрсдөө төлбөрөө төлдөг. ЭМД-д хамрагдсан иргэд эрүүл мэндийн нэгдсэн үзлэгт үнэ төлбөргүй хамрагдах бөгөөд даатгуулагчийн насны байдлаар хамаарч үзлэг, шинжилгээний нэр төрөл өөр өөр байдаг. Даатгалд хамрагдсан гадаадын иргэдийн хувьд Солонгос иргэний нэгэн адил хөнгөлөлт эдлэх боловч эмнэлэгт үзүүлэх, хэвтэж эмчлүүлэх үед 20-50 хувь, эмийн сангаар

[21] https://www.theglobaleconomy.com/South-Korea/Health_spending_per_capita/

үйлчлүүлэх үед 30 хувийг даатгуулагч төлөх бөгөөд үлдсэн хувийг ЭМ-ийн даатгалын сангаас гаргана.

Солонгосын эрүүл мэндийн зардал[22] нь Нийгмийн эрүүл мэндийн даатгалаас 42.8%, Татвар 11.5%, хувь хүнээс гарах зардал 35.2%, хувийн эрүүл мэндийн даатгал 6.2%, бусад зардал 4.3% байна.




Харин үндэсний эрүүл мэндийн даатгалын санхүүжилт нь эрүүл мэндийн даатгалын шимтгэл, засгийн газрын татаас болон бусад эх үүсвэр буюу тамхины татвараас бүрддэг.




*Хувь хүнээс гарах зардал:* Эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд нь үндэсний эрүүл мэндийн даатгал болон эрүүл мэндийн даатгалын тэтгэмжийн багцад ороогүй үйлчилгээг авахдаа хувиасаа мөнгө төлдөг. Даатгуулсан үйлчилгээний төлбөрийг Үндэсний эрүүл мэндийн даатгалын байгууллага хатуу хянаж, зохицуулалт хийдэг. Харин шинэ техник, технологид суурилсан эмчилгээ үйлчилгээ нь өндөр өртөгтэй байх бөгөөд хувийн хэвшлийн эмнэлгүүд энэхүү эмчилгээ, үйлчилгээг санал болгох, нөгөө талаас илүү үр дүнтэй байх магадлалтай байдаг тул иргэд тус үйлчилгээг өөрийн зардлаар авах хандлагатай байдаг.

[22] https://documents1.worldbank.org/curated/en/418791516185685994/pdf/Advancing-universal-health-coverage-what-developing-countries-can-learn-from-the-Korean-experience.pdf

*Хувийн эрүүл мэндийн даатгал:* Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилтэд сайн дурын буюу хувийн эрүүл мэндийн даатгалын гүйцэтгэх үүрэг нэмэгдэж байгаа бөгөөд эрүүл мэндийн нийт зардлын 5 хувийг эзэлж байна. Хувийн эрүүл мэндийн даатгалын үйлчилгээг ихэвчлэн бусад даатгалын байгууллагаар дамжуулдаг бөгөөд нөхөн олговрыг үйлчилгээ үзүүлэгчид бус даатгуулагчид олгодог тул нэгдсэн мэдээлэл хомс байдаг. Солонгосын эрүүл мэндийн нийт зардлын хувь хүнээс гарах зардлын хэмжээ өндөр байгаа тул хүн амын 70-аас дээш хувь нь тус зардлыг төлөх зорилгоор хувийн эрүүл мэндийн даатгалд хамрагддаг байна.

## 2.4.ШИНЭ ЗЕЛАНД УЛС

*Хууль эрх зүйн зохицуулалт:* Шинэ Зеланд Улсад эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг Нийгмийн хамгааллын тухай (Social Security Act 1938), Эрүүл мэндийн тухай (Health Act 1956) Шинэ Зеландын Нийтийн эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлийн тухай (New Zealand Public Health and Disability Act 2000) хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулж байна.[23]

Нийгмийн хамгааллын тухай хуулиар Шинэ Зеланд улсын засгийн газар нь хүн амын эрүүл мэндийг сахин хамгаалахад үндсэн үүрэг гүйцэтгэнэ. Засгийн газар нь мөн хувийн эрүүл мэндийн байгууллагуудад байнга дэмжлэг үзүүлж ажиллах үүрэг хүлээдэг байна. Шинэ Зеланд Улсын Эрүүл мэндийн талаар баримтлах бодлого (New Zealand Health Strategy)-ын дагуу засгийн газар нь эрүүл мэндийн бодлогын хөтөлбөрийг боловсруулах, үйлчилгээний хэрэгцээ, шаардлага болон улсаас санхүүжүүлдэг жил бүрийн эрүүл мэндийн төсвийг тодорхойлоход гол үүрэг гүйцэтгэнэ. Эрүүл мэндийн яам нь бодлогын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах бөгөөд хэрэгжилтийг парламентад тайлагнана. 2021 оны байдлаар дөрвөн чухал бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Шинэ Зеландын эрүүл мэндийн талаар баримтлах бодлого 2016
- Шинэ Зеландын хөгжлийн бэрхшээлийн талаар баримтлах бодлого
- Маори үндэстний эрүүл мэндийн талаар баримтлах бодлого
- Эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээнд баримтлах бодлого зэрэг болно.[24]

Шинэ Зеландын Нийтийн эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлийн тухай (New Zealand Public Health and Disability Act 2000)[25] хуулиар эрүүл мэндийн салбарт төсвөөс үзүүлж буй санхүүжилт болон эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлийн үйлчилгээний зохион байгуулалтын бүтцийг зохицуулсан байна. Тус хуулиар Дүүргийн эрүүл мэндийн зөвлөл (District Health Boards)-үүдийг байгуулсан бөгөөд Эрүүл мэндийн яам, яамны харьяа хороод, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын үүрэг, хариуцлагыг тодорхой зохицуулсан байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[23] https://www.health.govt.nz/new-zealand-health-system/overview-health-system/statutory-framework
[24] https://www.health.govt.nz/new-zealand-health-system/overview-health-system/statutory-framework
[25] https://www.legislation.govt.nz/act/public/2010/0118/latest/DLM2901004.html?search=sw_096be8ed806b12cd_funding_25_se&p=1#DLM2901010

**Шинэ Зеланд Улсын эрүүл мэндийн тогтолцооны загвар**[26]




Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн тогтолцоо***:*** Шинэ Зеланд улсын эрүүл мэндийн санхүүжилт нь төсвийн санхүүжилтэнд суурилсан төрийн эрүүл мэндийн үйлчилгээний загварт багтдаг байна.

Шинэ Зеланд Улсын нийт хүн ам 4.861.700 гаруй бөгөөд Дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ ойролцоогоор 7%-ийг[27] эрүүл мэндийн салбарт зарцуулж байна. Жилд нэг хүнд ногдох эрүүл мэндийн үйлчилгээний зардал 4.037 ам доллар байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

---

[26] https://www.health.govt.nz/new-zealand-health-system/new-zealand-health-strategy-future-direction/turning-strategy-action
[27] https://www.stats.govt.nz/information-releases/gross-domestic-product-march-2021-quarter

**Эрүүл мэндийн салбарын ерөнхий үзүүлэлт**

| Үзүүлэлт | 2019 оны эцсийн байдлаар |
|---|---|
| **Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжтэй байдал** | |
| Эмнэлгийн ор (1000 хүнд ногдох) | 2.57 |
| Их эмч (10000 хүнд) | 33.5 |
| Сувилагч, эх баригч (10000 хүнд) | 103.4; 5.6 |
| Эм зүйч (10000 хүнд) | 7.1 |
| Шүдний эмч (10000 хүнд) | 6.3 |
| **Эрүүл мэндийн салбарын зардлын үзүүлэлт** | |
| ДНБ-д эрүүл мэндийн зардлын эзлэх хувь | 7% |
| Улсын төсөвт эрүүл мэндийн зардлын эзлэх хувь | 19.8 тэрбум $ |
| Нэг хүнд ногдох эрүүл мэндийн зардал (ам.доллар) | 4.037$ |
| **Хүн амын эрүүл мэндийн үзүүлэлт** | |
| Дундаж наслалт | 81 |
| Нялхсын эндэгдэл (1000 амьд төрөлтөнд) | 3 |
| 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл (1000 амьд төрөлтөнд) | 6 |
| Эхийн эндэгдэл (100000 амьд төрөлтөнд) | 9 |

Эрүүл мэндийн салбарыг гол төлөв татварын орлогоос санхүүжүүлдэг. Ослын нөхөн олговрын холбоо (Accident Compensation Corporation)-ны шимтгэл, хураамж нь санхүүжилтийн нэлээдгүй хувийг эзэлдэг байна. Бусад чухал санхүүжилтийн эх үүсвэрүүдэд засгийн газрын бусад агентлагууд, орон нутгийн засаг захиргааны байгууллагууд болон эрүүл мэндийн даатгал, хувь хүнээс гарч буй зардал зэрэг орно.

Төсвийн санхүүжилтийг “Vote Health” гэж нэрлэдэг байна. Эрүүл мэндийн яам нь батлагдсан төсвийн ¾-аас илүү хувийг Дүүргийн эрүүл мэндийн зөвлөл (District Health Board)-үүдэд хуваарилдаг. Улсын хэмжээнд 20 Дүүргийн эрүүл мэндийн зөвлөлүүд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд хуваарилагдсан хөрөнгийг харьяа нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийн үйлчилгээнд зарцуулдаг. Үүнд улсын эмнэлгийн зардал болон эмч, ажилтнуудын цалин хөлсний зардал багтана.

*Зураг 1. Эрүүл мэндийн “Vote Health” төсвийн хуваарилалт.*




Төсвийн ойролцоогоор 19%-ийг улсын хэмжээнд шаардлагатай байгаа эрүүл мэндийн үйлчилгээнд, тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих үйлчилгээ, нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээ, урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээний тодорхой хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээ, “Эрүүл хүүхэд” эх хүүхдийн эрүүл мэндийн үйлчилгээ, анагаахын сургууль төгсөгчдийг дадлагажуулах хөтөлбөр зэрэгт зарцуулдаг байна. Төсвийн 1 орчим хувийг эрүүл мэндийн салбарыг дэмжих, хөгжүүлэх, хяналт тавьж, удирдах үүрэг бүхий Эрүүл мэндийн яамны үйл ажиллагаанд зориулан зарцуулдаг байна. 2021 оны төсөвт эрүүл мэндийн салбарт 24 тэрбум ам долларыг төсөвлөсөн байна. Үүнээс 4.7 тэрбум ам долларыг үйл ажиллагааны зардалд төсөвлөжээ.[28]

[28] https://www2.deloitte.com/nz/en/pages/2021-government-budget/articles/health.html

Ковид-19 цар тахлын эсрэг төсөвлөсөн төсөв*:* Ковид-19 цар тахал өвчний эсрэг хариу арга хэмжээ авах, нөхөн сэргээх сан (КОВИД-19 Response and Recovery Fund) байгуулагдан ажиллаж байгаа бөгөөд КОВИД-19 цар тахал өвчний улмаас доройтсон эдийн засгийг сэргээх, хүн амын эрүүл мэндийг сахин хамгаалахад санд хуримтлагдсан хөрөнгийг зарцуулж байна. 2021 онд КОВИД-19 цар тахлын эсрэг хүн амаа үнэгүй вакцинжуулах хөтөлбөрт 1.5 тэрбум ам долларыг Ковид-19 сангаас хуваарилсан. Энэ нь нийт иргэдийг сайн дурын үндсэн дээр Pfizer вакцины 2 тунд хамруулахад зориулж буй төсөв юм. Ковид-19 санд 5.1 тэрбум ам долларыг цар тахлын дэгдэлт дахин гарсан тохиолдолд хариу арга хэмжээ авах болон эдийн засгийн шаардлагатай сэргээн босголтын ажилд зориулан байршуулаад байна.[29]

**Эрүүл мэндийн даатгал**

*Улсын эрүүл мэндийн даатгал:* Бүх байнгын оршин суугчид улсын санхүүжилттэй эрүүл мэндийн даатгалд хамрагддаг. Даатгалын санхүүжилтийн дийлэнх хэсэг нь татварын орлогоос бүрддэг байна. Гэвч байнгын бус оршин суугчдын хувьд улсын эмнэлгээр үйлчлүүлсэн ч эмчилгээний төлбөрийг өвчтөн өөрөө төлөх үүрэгтэй. Харин тухайн өвчтөн өөрөө буруугүйн улмаас осолд өртсөн бол даатгалын нөхөн олговорт хамрагдана. Нийт эрүүл мэндийн зардлын 80 орчим хувийг улсын төсвөөс санхүүжүүлж байна.

*Хувийн эрүүл мэндийн даатгал:* Хувийн эрүүл мэндийн даатгалын үйлчилгээг ашгийн бус болон ашгийн төлөө янз бүрийн байгууллага, компаниуд санал болгодог бөгөөд нийт эрүүл мэндийн зардлын 5%-ийг хувийн даатгалаас бүрдүүлж байна. Эмчилгээний зардлыг хуваах, хувийн эмнэлэгт мэс засал хийлгэх, хувийн эмнэлэгт үзүүлж зөвлөгөө авах болон яаралтай бус эмчилгээ, үйлчилгээнд хурдан шуурхай хамрагдахад хувийн даатгалыг түлхүү ашиглаж байна. Нийт хүн амын ойролцоогоор 1/3 хувь нь хувийн даатгалд хамрагдаж байгаа бөгөөд ихэвчлэн хувь хүмүүс даатгуулдаг байна.

*Төлбөр хуваах болон хувь хүнээс гарч буй зардал.* Төлбөр хуваах болон хувь хүн, айл өрхөөс шууд төлөгдөж байгаа зардал нь 2014 оны байдлаар эрүүл мэндийн нийт зардлын 13 орчим хувийг эзэлсэн байна.

**Эмнэлгийн санхүүжилт**

Шинэ Зеланд Улсад улсын болон хувийн эмнэлгүүд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлдэг. Улсын эмнэлгүүд дийлэнх хувийг эзэлдэг байна. Улсын эмнэлгүүд Дүүргийн эрүүл мэндийн төвүүдээр дамжуулан улсын төсвөөс санхүүжигдэнэ. Санхүүжилтэд эмч, эмнэлгийн ажилтнуудын цалин хөлсийг багтаасан байдаг.

## 2.5.ЯПОН УЛС

Япон Улсын эрүүл мэндийн тогтолцоо Беверiджийн загвартай. 2020 оны байдлаар улсын төсвөөс эрүүл мэндийн санхүүжилтийн 84%-ийг санхүүжүүлдэг. Санхүүжилтийн[30] 42%-ийг татварын орлого, 42%-ийг эрүүл мэндийн даатгалын шимтгэлээс, 16%-ийг өвчтөний үйлчилгээний төлбөрөөс бүрдүүлдэг байна. Эрүүл мэндийн салбарт ДНБ-ний 11%-ийг зарцуулдаг. Тодруулбал, жилд нэг хүнд ногдох эмнэлгийн үйлчилгээний дундаж зардал нь 4,267 ам.доллар байна. Япон Улсын дундаж наслалт 84,21 байгаа нь хүн амын хөгшрөлт эрүүл мэндийн зардлын өсөлтөд нөлөөлж байна.

[29] https://www.treasury.govt.nz/sites/default/files/2021-05/b21-at-a-glance.pdf
[30] https://www.commonwealthfund.org/international-health-policy-center/countries/japan

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Хууль эрх зүйн зохицуулалт*:* Япон Улсын Үндсэн хуульд [31] “Иргэд эрүүл мэндээ хамгаалуулах эрхтэй бөгөөд нийгмийн халамж, нийгмийн хамгаалал, нийгмийн эрүүл мэндийг сайжруулах, дэмжих нь Засгийн газрын үүрэг мөн” гэж хүний эрхийг баталгаажуулсан байна. Эрүүл мэндийн салбарын харилцааг Эрүүл мэндийн даатгалын хууль (Health Insurance Law)[32], Үндэсний эрүүл мэндийн даатгалын тухай хууль (National Health Insurance Law)[33], Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн тухай хууль (Health Care Reform Act)[34], Урт хугацааны тусламж үйлчилгээний даатгалын тухай хууль (Long-Term care Insurance Act)[35]-аар тус тус зохицуулж байна.

Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн тогтолцоо*:* Эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцоо нь нийгмийн эрүүл мэндийн даатгалын систем дээр суурилдаг бөгөөд татвар болон үйлчилгээний төлбөрөөс санхүүждэг. Төрийн захиргааны байгууллагууд нь Засгийн газар болон эрүүл мэндийн байгууллагын хооронд байгуулсан даатгалын гэрээнд хяналт тавьдаг. Сангийн яамнаас улсын төсвөөр дамжуулан Үндэсний эрүүл мэндийн даатгалд татаас өгдөг. Япон Улс нь Дотоодын Нийт Бүтээгдэхүүн (ДНБ)-ийхээ 11 орчим хувьтай тэнцэх хэмжээний зардлыг Эрүүл мэндийн салбартаа зарцуулдаг. Тодруулбал, жилд нэг хүнд ногдох эмнэлгийн үйлчилгээний дундаж зардал нь 4,267 ам.доллар байна.




[31] https://japanhpn.org/en/section-3-1/
[32] http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail_main?re=&vm=02&id=3266
[33] https://www.ilo.org/dyn/travail/docs/2064/National%20Health%20Insurance%20Law%201938.pdf
[34] http://www.ilcjapan.org/linksE/doc/Reform_of_the_health_care_system_in_Japan.pdf
[35] http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?id=94&vm=2&re=02

**Эрүүл мэндийн салбарын ерөнхий үзүүлэлт**

| Үзүүлэлт | 2017 оны байдлаар |
|---|---|
| **Эрүүл мэндийн тогтолцооны үзүүлэлт** | |
| Эмнэлгийн ор (1000 хүнд ногдох) | 1222 |
| Их эмч(10000хүнд ногдох) | 256 |
| Сувилагч, эх баригч(10000 хүнд ногдох) | 12.1 |
| Эм зүйч(10000 хүнд ногдох) | 294.000 |
| Шүдний эмч(10000 хүнд ногдох) | 105.000 |
| **Эрүүл мэндийн салбарын зардлын үзүүлэлт**[36] | |
| ДНБ-д эрүүл мэндийн зардлын эзлэх хувь | 11% |
| Улсын төсөвт эрүүл мэндийн зардлын эзлэх хувь | 24% |
| Нэг хүнд ногдох эрүүл мэндийн зардал (ам.доллар) | 4267 ам.доллар |
| **Хүн амын эрүүл мэндийн үзүүлэлт** | |
| Дундаж наслалт | 84.21 жил |
| Нялхсын эндэгдэл (1000 амьд төрөлтөнд) | 0.8 |
| 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл (1000 амьд төрөлтөнд) | 2.3 |
| Эхийн эндэгдэл (100000 амьд төрөлтөнд) | 4 |

*Эрүүл мэндийн зардлыг санхүүжилтийн эх үүсвэрээр (2014 он)*




Эрүүл мэндийн байгууллагын санхүүжилт [37] 2020 оны байдлаар эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтийн 84 хувийг улсын төсвөөс санхүүжүүлж, үүнээс 42 хувийг нь татварын орлогоос, 42 хувийг нь эрүүл мэндийн даатгалын шимтгэлээс, үлдсэн 16 хувийг эмнэлгийн үйлчилгээний төлбөрөөс тус тус бүрдүүлж байна. Засгийн газраас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээг тогтоож, орон нутгийн засаг захиргаа, даатгагч, үйлчилгээ үзүүлэгч нь тогтоосон журмыг дагаж мөрддөг. Эрүүл мэнд, хөдөлмөр халамжийн яам тус журмын хэрэгжилтэд хяналт тавьж, Япон Улсын 47 муж нь

[36] https://p4h.world/en/universal-object-country/japan
[37] https://www.commonwealthfund.org/sites/default/files/documents

бүс нутгийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг уг журмын дагуу орон нутгийн төсөвт суулгасан хөрөнгөөр хэрэгжүүлдэг. 1,700 гаруй хотын захиргаа нь Эрүүл мэндийн даатгалын тогтолцооны бүрэлдэхүүн хэсгүүдийг ажиллуулж, орон нутагтаа эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулдаг.

Эрүүл мэндийн зардлыг эмчилгээний төрлөөр эрэмбэлэхэд хэвтэн эмчлүүлэгчдийн зарлага хамгийн өндөр буюу 37%-ийг эзэлж байна. Энэ нь бусад оронтой харьцуулахад Япон Улсад хэвтэн эмчлүүлэх дундаж хугацаа нь их байна.

**Эрүүл мэндийн зардлыг эмчилгээний төрлөөр** *(2014 он)*




*Эх сурвалж: http://japanhpn.org/wp-content/uploads/2019/10/Section7_JHPN_ENG.pdf*

## Эрүүл мэндийн даатгал[38]

Эрүүл мэндийн даатгалын хуульд зааснаар даатгуулагч нь ажилчдын эрүүл мэндийн даатгал, үндэсний эрүүл мэндийн даатгал, 75 ба түүнээс дээш ахмад настны эрүүл мэндийн даатгал гэсэн гурван төрлийн даатгалд хамрагддаг. 75 ба түүнээс дээш насны хүмүүсийн эрүүл мэндийн даатгалыг улсын төсвөөс, харин ажилчдын болон үндэсний эрүүл мэндийн даатгалыг даатгалын шимтгэлээр санхүүжүүлдэг. Япон Улсын хүн амын 98,3 хувь нь эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байдаг. Эрүүл мэндийн даатгалын санд 30 хувийг иргэн, 70 хувийг улсаас төлдөг. Үндэсний эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг тооцох арга нь бүс нутгаас хамаарч өөр өөр байдаг. Тухайн бүс нутгийн шимтгэлийн орлого (өрхийн орлогод ногдуулах), хөрөнгө (өрхийн хөрөнгөд ногдуулах), тэгш байдал (нэг хүнд ногдох), өмч (өрх бүрт тооцох) гэсэн дөрвөн хүчин зүйл дээр үндэслэсэн байдаг. Сард дунджаар 35,00-40,000 иен (330-370 ам.доллар) байдаг.

*Хувь хүнээс гарах зардал:* Эмнэлгийн үйлчилгээ авч буй 6-аас дээш насны хүүхдүүд эмчилгээний төлбөрийн 20 хувийг, 70-74 настай болон бага орлоготой насанд хүрэгчид 20 хувийг, 70 хүртэлх насны даатгуулагчид 30 хувийг, 75 ба түүнээс дээш настай иргэд 10 хувийг өөрсдөө төлөх ёстой. Харин 6 хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн үйлчилгээний төлбөрийг орон нутгийн засаг захиргааны татаасаар бүрэн хариуцдаг.

*Хувийн эрүүл мэндийн даатгал:* Хувийн эрүүл мэндийн даатгал нь амь насны даатгалд нэмэлт хэлбэрээр хөгжиж, өвчилсөн тохиолдолд нэмэлт төлбөр олгодог бөгөөд даатгуулагчид эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх эсхүл хорт хавдар болон бусад архаг өвчин туссан тохиолдолд өдөр бүр мөнгө төлөх замаар тогтоосон хугацаанд нөхөн төлбөр хэлбэрээр олгодог. Ашгийн төлөө болон ашгийн бус байгууллагууд хувийн эрүүл мэндийн даатгалыг эрхэлдэг бөгөөд хувийн хөрөнгөөр эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх нь

[38] file:///C:/Users/irmuu/Downloads/9789290226260-eng.pdf

зөвхөн гажиг заслын эмчилгээ гэх мэт тодорхой төрлийн үйлчилгээгээр хязгаарлагддаг онцлогтой. Улсын болон хувийн эмнэлгүүд үндэсний эрүүл мэндийн даатгалаар үйлчилгээ үзүүлдэг тул хувийн эрүүл мэндийн даатгал төдийлөн хөгжихгүй байна.

## 2.6.ПЕРУ УЛС

Перу Улс 32 сая хүн амтай хөгжингүй орон бөгөөд нэг хүнд ногдох ДНБ нь 13,300 ам.доллар, дундаж наслалт 74 жил бөгөөд 224 орноос 126-д орж байна. Эрүүл мэндийн зардлын хэмжээ ДНБ-ний 5.6 хувьтай тэнцэж байна. Эрүүл мэндийн тогтолцоо нь универсал (Бевериджийн) загвартай орон юм. Нийт хүн амын 60%-д Эрүүл мэндийн яам, 30%-д Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, 10%-д Зэвсэгт хүчин, цагдаа, хувийн хэвшил эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг. 2016 оны байдлаар эрүүл мэндийн даатгалын орлого 10,7 тэрбум ам.долларт хүрч түүний 65,3%-ийг шимтгэл, татвараас үлдсэн хувийг бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн байна.

Хууль эрх зүйн зохицуулалт*:* Үндсэн хуулийн[39] 9 дүгээр зүйлд Төр нь эрүүл мэндийн гол үйлчилгээ үзүүлэгч бөгөөд "Төрөөс эрүүл мэндийн бодлогыг тодорхойлж хүн бүрийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг өргөжүүлэх олон талт болон төвлөрсөн бус хэрэгжилтийг хариуцах" үүрэгтэй. 6 дугаар зүйлд “Төр эрүүл мэндийн үйлчилгээг үнэ төлбөргүй авах баталгаа өгдөг” 7 дугаар зүйлд “хүн бүр эрүүл мэндээ хамгаалах эрхтэй” гэж хүний эрхийг баталгаажуулсан байна. Эрүүл мэндийн санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын хууль (Universal Health Insurance Act), Үндсэн хууль (Constitution of the Republic of Peru)[40]-аар тус тус зохицуулж байна.

Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн тогтолцоо**:** Перу Улс Дотоодын нийт бүтээгдэхүүний (ДНБ) 5,6%-ийг эрүүл мэндийн салбартаа зарцуулдаг. Тодруулбал, жилд нэг хүнд ногдох эмнэлгийн үйлчилгээний дундаж зардал нь 369 ам.доллар байна. Эрүүл мэндийн санхүүжилтийн 54%-ийг улсын төсвөөс, 39%-ийг хувь хүний үйлчилгээний төлбөрөөс, 7%-ийг бусад эх үүсвэрээс бүрдүүлдэг.

**Эрүүл мэндийн салбарын ерөнхий үзүүлэлт**

| Үзүүлэлт | 2017оны байдлаар |
|---|---|
| **Эрүүл мэндийн тогтолцооны үзүүлэлт** | |
| Эмнэлгийн ор (1000 хүнд ногдох) | 1.5 |
| Их эмч (10000 хүнд ногдох) | 1.3 |
| Сувилагч, эх баригч (10000 хүнд ногдох) | 2.4 |
| Эм зүйч (10000 хүнд ногдох) | |
| Шүдний эмч (10000 хүнд ногдох) | 0.1 |
| **Эрүүл мэндийн салбарын зардлын үзүүлэлт** | |
| ДНБ-д эрүүл мэндийн зардлын эзлэх хувь | 5.6% |
| Улсын төсөвт эрүүл мэндийн зардлын эзлэх хувь | 15% |
| Нэг хүнд ногдох эрүүл мэндийн зардал (ам.доллар) | 369 ам.доллар |
| **Хүн амын эрүүл мэндийн үзүүлэлт** | |
| Дундаж наслалт | 76.52 жил |
| Нялхсын эндэгдэл (1000 амьд төрөлтөнд) | 10.3 нас баралт |
| 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл (1000 амьд төрөлтөнд) | 13.2 нас баралт |
| Эхийн эндэгдэл (100000 амьд төрөлтөнд) | 88 нас баралт |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[39] https://www.constituteproject.org/constitution/Peru_2009?lang=en
[40] https://www.socialprotection-toolbox.org/practice/perus-legal-framework-rights-health-care

***Эрүүл мэндийн санхүүжилт, зарцуулалт***

Эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтийн 79 хувийг татвараас, 15 хувийг нөхөн төлбөр, 6 хувийг хандив тусламжаар бүрдүүлдэг. Эрүүл мэндийн яамны төсвийн зарцуулалтын 37 орчим хувийг боловсон хүчний зардал (амралт, нөхөн олговор, шагнал урамшуулал, гэр бүлийн тэтгэмж, бусад), 6.2%-ийг нийгмийн даатгалын зардал (ажил олгогч, ажилчдын эрүүл мэндийн нийгмийн даатгал, тэтгэвэр) ба 46%-ийг бараа, үйлчилгээний зардал, 11%-ийг бусад хөрөнгийн зардалд зарцуулдаг. Нийгмийн хамгааллын алба нь 21%-ийг бараа худалдан авахад, 55%-ийг цалин хөлс, 6.8%-ийг бусад менежментийн зардалд, 1.3%-ийг гуравдагч этгээдэд үзүүлэх үйлчилгээнд, 2.3%-ийг бусад хүмүүст зарцуулдаг байна.

Эрүүл мэндийн даатгал[41]

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг Эрүүл мэндийн яам нь төвлөрүүлэн удирдаж Нийгмийн хамгааллын алба, Зэвсэгт хүчин тодорхой үүрэг гүйцэтгэдэг. Перугийн Ерөнхий сайд, яамдын зөвлөл хамтран улс орны эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, дүрэм журам, стратеги боловсруулж, бодлогыг Конгресст өргөн барьдаг. Эдгээр хуулийг хэрэгжүүлэх үүрэг хариуцлагыг Перугийн засаг захиргааны 25 бүсийн удирдагчдад шилжүүлдэг. 2009 онд Эрүүл мэндийн яамнаас үндэсний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийг баталсан. Уг хуулиар эрүүл мэндийн даатгалын тогтолцоог нэвтрүүлж, эрүүл мэндийн даатгалд нэн ядуу амьдарч буй хүмүүсийг наснаас үл хамааран автоматаар бүртгэдэг болсон. Одоогоор хүн амын 80 орчим хувь энэ даатгалд үнэгүй хамрагдаж, 20 хувь нь эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлдөг. Эрүүл мэндийн даатгалын орлогын 65.3% нь шимтгэл, татвараас, үлдсэн хувийг бусад эх үүсвэрээс бүрдүүлдэг. Эрүүл мэндийн даатгалын 43%-ийг тэтгэмжид, 33%-ийг цалин, тэтгэвэрт зарцуулсан байна.

*Хувийн даатгал:* Хувийн даатгал буюу урьдчилж төлбөр төлөх үйлчилгээ нь хүн амын 2%-аас бага хувийг хамардаг. Перу улсад захиалагч нь хувийн даатгалын тогтолцоо эсвэл хувийн даатгалтай холбоотой EPS-т хамрагдаагүй тохиолдолд хамтарсан төлбөр хийхгүй.

## 2.7. БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН УЛС

### Эрх зүйн зохицуулалт

Казахстан Улсад эрүүл мэндийн тогтолцооны санхүүжилтийг Иргэдийн эрүүл мэнд ба эрүүл мэндийг хамгаалах тогтолцооны тухай хуулиар зохицуулсан. Хуулийн 67 дугаар зүйлд заасны дагуу дараах эх үүсвэрээс санхүүжүүлж байна. Үүнд:[42]

- төсвийн хөрөнгө;
- нийгмийн эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгө;
- сайн дурын эмнэлгийн даатгалын хэрэгсэл;
- төлбөртэй үйлчилгээгээр олсон хөрөнгө;
- нэмэлт төлбөрөөс хүлээн авсан хөрөнгө;
- хувь хүн, хуулийн этгээдээс сайн дурын хандив хэлбэрээр авсан хөрөнгө;
- Бүгд Найрамдах Казахстан Улсын хууль тогтоомжид харшлахгүй бусад эх сурвалж.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[41] https://www.pacificprime.com/country/americas/peru-health-insurance-pacific-prime-internationa/
[42] О здоровье народа и системе здравоохранения, https://adilet.zan.kz/rus/docs/K2000000360

Үнэгүй эмнэлгийн тусламжийн баталгаат хэмжээ болон нийгмийн эрүүл мэндийн заавал даатгалын тогтолцооны хүрээнд үзүүлэх эмнэлгийн үйлчилгээний тарифыг Казахстан Улсын Эрүүл мэндийн яам баталдаг. Мөн энэхүү тарифыг тогтоох журам, аргачлалыг бас тус яам тогтооно.

Үнэгүй эмнэлгийн тусламж үзүүлэх эрүүл мэндийн субъектүүдийн санхүүжилтийг дараах байдлаар олгодог.

- улсын эрүүл мэндийн субъектүүдийн хувьд тусдаа санхүүжилтийн төлөвлөгөөний /индивидуальный план/ дагуу;
- бусад эрүүл мэндийн субъектүүдэд төсвийн хөтөлбөрийн захирагч, эсхүл нийгмийн эрүүл мэндийн даатгалын сантай хийсэн гэрээний үндсэн дээр олгоно.

*Жич: Эрүүл мэндийн субъектүүд – эрүүл мэндийн байгууллагууд, мөн эрүүл мэндийн болон эмийн үйл ажиллагаа тогтмол явуулдаг хувь хүмүүсийг хэлнэ.*[43]

Эрүүл мэндийн санхүүжилтийн зарцуулалт: Санхүүжилтийг дараах чиглэлээр зарцуулдаг.[44]

- үнэ төлбөргүй эмнэлгийн тусламжийн баталгаат хэмжээний хүрээнд эрүүл мэндийн субъектийн үйлчилгээний төлбөр;
- эрүүл мэндийн байгууллагын материал, техникийн тоног төхөөрөмж;
- эм, ховор эм, цус, түүний бүрэлдэхүүн хэсэг, вакцин болон иммунобиологийн бусад эм, түүнчлэн эмнэлгийн бүтээгдэхүүн болон техник хэрэгсэл худалдан авах;
- халдварт өвчний тохиолдол, тархалтыг арилгах;
- эрүүл мэндийн салбарын боловсон хүчнийг сургах, мэргэжил дээшлүүлэх, давтан сургах;
- анагаах ухааны, шинжлэх ухааны ололт амжилтыг хөгжүүлэх, нэвтрүүлэх;
- Казахстан Улсын хууль тогтоомжоор хориглоогүй бусад зардал.

Эрүүл мэндийн субъектүүдийн үйлчилгээний төлбөрийг эмнэлгийн үйлчилгээний чанар, хэмжээний хувьд гэрээт үүргийн биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээний үр дүнг харгалзан Эрүүл мэндийн яамнаас тогтоосон журмаар төлдөг.

Эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн хэрэгслийн эргэлтэд хамрагдах субъектүүдэд эмийн үйлчилгээний зардлын төлбөрийг Эрүүл мэндийн яамнаас тогтоосон журмаар төсвийн хөтөлбөрийн захирагчид эсвэл, нийгмийн эрүүл мэндийн даатгалын сангаас олгодог байна.

Ковид-19 үеийн эрүүл мэндийн санхүүжилт:[45] Коронавирусийн халдвар үүсэх, тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор тус улсын эрүүл мэндийн байгууллагуудыг тусгай хамгаалалтын хэрэгслээр хангах ажлын хүрээнд Казахстан Улсын засгийн газрын нөөц хөрөнгөөс нийт 17 тэрбум тенге төсөвлөсөн.

2020 оны 1-р сарын 29-нд (эхний ээлж) 1 609 616.50 мянган тенге;
2020 оны 2-р сарын 21-нд (хоёр дахь ээлж) 428,227.18 мянган тенге;
2020 оны 2-р сарын 11-нд (гурав дахь ээлж) 38,899.31 мянган тенге;

[43] Об утверждении правил ведения учета субъектов здравоохранения, оказывающих медицинскую помощь в рамках гарантированного объема бесплатной медицинской помощи и (или) в системе обязательного социального медицинского страхования, https://adilet.zan.kz/rus/docs/V2000021619
[44] https://egov.kz/cms/ru/articles/Health-care-financing
[45] 2020 оны 8-р сарын 11-ний байдлаар, https://www.Ковид19healthsystem.org/countries/kazakhstan/livinghit.aspx?Section=4.1%20Health%20financing&Type=Section

UILMN СУДАЛГААНЫ САН

2020 оны 3-р сарын 25-нд (дөрөв дэх ээлж) 21 430 635.41 мянган тенге хуваарилагдсан.

Эхний ээлжийн хүрээнд Эрүүл мэндийн яамны харьяа байгууллагуудад зориулан нэг дистрибьютерээр дамжуулан тусгай хамгаалалтын хэрэгсэл болон эмийн зүйл (гурван давхар эмнэлгийн маск, амьсгалын баг, эмнэлгийн нэг удаагийн бээлий, коронавирусийн халдварыг оношлох ПГУ шинжилгээний систем, тахлаас хамгаалах 1-р төрлийн хувцас (дахин ашиглах боломжтой), эмнэлгийн хувцас ба эмийн зүйл) худалдан авахад 423.9 сая тенге, хоёр дахь ээлжид 138.9 сая тенге, дөрөв дэх ээлжид 6,718.0 сая тенге тус тус хуваарилжээ.

Гурав дахь ээлжийн санхүүжилтээс БНХАУ-д КОВИД-19-тэй тэмцэхэд зориулж хүмүүнлэгийн тусламж 38.899.31 мянган тенгег илгээсэн байна.

Түүнчлэн 5.3 тэрбум тенгег цэргийн эрүүл мэндийн нэгж, Дотоод хэргийн яам, Батлан хамгаалах яам, бусад төрийн байгууллагад тусгай хамгаалах хэрэгсэл худалдан авахад зарцуулсан байна. Нэмэлт хөрөнгийг Казахстан улсын Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргасан.

## 2.8.МОНГОЛ УЛС

Эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцоо ба онцлог, хууль эрх зүйн орчин

Монгол Улсын эрүүл мэндийн тогтолцоо захиргааны бүтцийн дагуу зохион байгуулалттай бөгөөд баг, сумын түвшинд анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагууд ба аймаг, нийслэлийн түвшинд хоёрдогч, гуравдагч шатлалын төрөлжсөн үйлчилгээ үзүүлж байгаа гурван шатлал бүхий тогтолцоо юм.[46]

Монгол Улс 1994 онд эрүүл мэндийн үндэсний албан журмын даатгалыг нэвтрүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилтийг зөвхөн зардлын зүйл ангиар хийж байсан бол одоо анхан шатны тусламж үйлчилгээг нэг хүнд ногдох төлбөрийн аргаар, харин эмнэлгийн тусламж үйлчилгээг өртөг ойролцоо оношийн бүлгээр тооцох тогтолцоог нэвтрүүлээд байна.[47]

Өнөөг хүртэл эрүүл мэндийн санхүүжилтийг бүрдүүлж байсан үндсэн гурван эх үүсвэрийг авч үзвэл 1) улсын төсөв (төв засгийн газраас бий болгосон татвар), 2) заавал төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэл, 3) иргэдээс шууд төлөх төлбөр багтаж байна. Эдгээр эх үүсвэрээс хэмжээний хувьд улсын төсөв давамгайлж байна.

**Монгол Улсын эрүүл мэндийн санхүүжилт 2016-2020 он**

| Үзүүлэлт | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 |
|---|---|---|---|---|---|
| Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага, сая төгрөг | 9 495 332.9 | 9 017 318.6 | 9 222 928.5 | 11 429 391.8 | 13 960 787.5 |
| Эрүүл мэндийн нийт зардал[1], сая төгрөг | 657 478.1 | 674 899.7 | 737 723.7 | 823 888.9 | 787 067.4 |
| Улсын нэгдсэн төсвийн зарлагад эрүүл мэндийн зардлын эзлэх хувь | 6.9 | 7.5 | 8.0 | 7.2 | 5.6 |
| Нэг хүнд ногдох эрүүл мэндийн зардал, мянга.төгрөг | 216. 4 | 217. 9 | 233. 5 | 258. 3 | 244.0 |

*Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо 2021 он*

[46] https://www.1212.mn/BookLibraryDownload.ashx?url=eruul_mend_2019.pdf&ln=Mn
[47] https://www.adb.org/sites/default/files/publication/352706/health-fs-mongolian.pdf



UIH.MN СУДАЛГААНЫ САН

Өнгөрсөн таван жилийн хугацаанд эрүүл мэндийн салбарт улсаас хуваарилсан төсөв 1.5 дахин өссөн боловч ДНБ-д эзлэх хувь хэмжээ нь 2019 оны жилийн эцэст дөнгөж 2.2 хувьд хүрч, энэ нь 2000 оны эхний арваад жилээс доогуур түвшинд байна. Эрүүл мэндийн салбарын улсын санхүүжилт ийм түвшинд байх нь төр болон эрүүл мэндийн даатгалын багцын санхүүжилтээр бүх хүн амыг тусламж, үйлчилгээнд бүрэн хамруулах хэрэгцээг хангах боломжгүй бөгөөд, багцуудын санхүүжилт нь тусламж. үйлчилгээний үйлдвэрлэлийн зардлаас бага байж болзошгүй. Тиймээс эрүүл мэндийн салбар нь Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого 2017-2026-д тодорхойлсны дагуу Засгийн газраас улсын санхүүжилтийг ДНБ-ний 5%-иас доошгүй түвшинд авах шаардлагатай гэж үзсэн.[48]

***Хууль эрх зүйн орчин:*** Монгол Улсын эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцоог дараах хуулиар зохицуулж байна.

- Эрүүл мэндийн тухай хууль
- Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль
- Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
- Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Засгийн газрын тусгай сангийн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль

Эрүүл мэндийн санхүүжилтийн бодлогын хүрээнд Засгийн газар Алсын хараа-2050 урт хугацааны хөгжлийн бодлого, төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, эмийн талаар төрөөс баримтлах бодлогуудыг баталсан.

Эрүүл мэндийн санхүүжилтийн асуудлаарх стратегийн баримт бичигт[49] худалдан авагч (ЭМДЕГ)-ийг илүү бие даасан болгох, нэг сан, нэгдсэн тусламж, үйлчилгээний багцад шилжих, илүү үр дүнтэй худалдан авалт, гүйцэтгэлд тулгуурласан санхүүжилт, гэрээлэлтийг нэвтрүүлэх талаар дурдсан байдаг. ЭМДЕГ одоогоор улсын болон хувийн хэвшлийн байгууллагуудыг сонгон шалгаруулж, худалдан авах гэрээ байгуулдаг. [50]

Эмнэлгийн түсламж, үйлчилгээний тухай хууль (21.2-р зүйл)-ийн дагуу тусламж, үйлчилгээг худалдан авах гэрээгээр үзүүлнэ гэж заасан.[51] Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд (16.2-р зүйл) ЭМДЕГ-аар дамжуулж ЭМЯ-ны нэрийн өмнөөс улсын төсвөөс санхүүждэг тусламж, үйлчилгээг худалдан авах боломжийг олгосон бөгөөд Засгийн газрын 2017 оны 156 тоот тогтоолоор зохицуулалтыг баталсан нь худалдан авалтын үйл ажиллагаа нэг худалдан авагчийн загвар руу шилжиж буй эхний алхам юм.

Одоогоор эрүүл мэндийн салбарын үндсэн санхүүжилтийг улсын төсөв, ЭМДС гэсэн хоёр эх үүсвэрээр тусдаа хоёр санд төвлөрүүлж байгаа бөгөөд Төсвийн тухай хуульд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг улсын төвлөрсөн төсвөөс санхүүжүүлэхээр заасан байдаг бол Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд үндэсний хэмжээнд нэг ЭМД-ын сантай байна гэдэг. Тиймээс эрүүл мэндийн салбарт улсын бүх эх үүсвэрийг нэг санд төвлөрүүлэх тогтолцоог хараахан бий болгож чадаагүй байна.

[48]https://mohs.gov.mn/uploads/userfiles/files/TA%209386_Technical%20Report_1_MON_LAST%2016022019.pdf
[49] https://www.legalinfo.mn/law/details/5690
[50]https://mohs.gov.mn/uploads/userfiles/files/TA%209386_Technical%20Report_1_MON_LAST%2016022019.pdf
[51] https://www.legalinfo.mn/law/details/11929

Төсвийн тухай хуулиар эрүүл мэндийн салбарт төсвийн төлөвлөлт, санхүүжилттэй холбоотой олон асуудлууд өөрчлөгдсөн. Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэгчдэд зориулж төсвийн төлөвлөлт, төсөв батлах, төсвийн гүйцэтгэлийн журамд өөрчлөлт орсон. Төсвийн тухай хууль орон нутгийн засаг захиргаа, байгууллагуудад төсөвтэй холбоотой шийдвэр гаргах орон зайг нэмэгдүүлсэн байна.

Одоогоор үр дүнд суурилсан төсөвлөлт (ҮДСТ)-ийг эрүүл мэндийн анхан шатны тусламжид болон ЭМДС-аас санхүүжүүлдэг эмнэлгийн тусламж, үйлчилгээнд хэрэгжүүлж байна. Мөн цар тахалтай холбоотойгоор Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 03 дугаар тогтоолын дагуу Ковид-19-ийн эсрэг тусламж үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн байгууллагуудад санхүүжилт олгож байна.[52]

**Эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцоо**

**Эрүүл мэндийн даатгал**

ЭМДЕГ нь ЭМЯ-ны харьяанд 2017 оны 12-р сард Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг байдлаар байгуулагдсан. Одоогийн байдлаар Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг НДЕГ цуглуулж, ЭМДЕГ-т шилжүүлснээр ЭМД-ын зардлыг тусламж, үйлчилгээ үзүүлэгчдэд хуваарилдаг. Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд Засгийн газар ЭМД-ын хураамжийн хэмжээг жил бүр батлах ёстой гэж заасан.[53] Иргэдийн төлж буй нийгмийн даатгалын шимтгэлийн дүн 12,5 хувь бөгөөд үүнээс 2 хувийг эрүүл мэндийн даатгалын шимтгэлд зарцуулдаг.[54] Төрөөс шимтгэлийг нь хариуцдаг даатгуулагчид нь 50 хувиас илүүг эзэлж байгаа хэдий ч ЭМДС-ийн орлогын зөвхөн 15 хувийг бүрдүүлж байна.

Эрүүл мэндийн даатгалын хүн амын хамралт 2014 онд 86% байсан бол 2016 оны эцэс гэхэд 76% болж буурсан гэж Азийн Хөгжлийн Банк (АХБ)-ны дэмжлэгтэй хэрэгжүүлсэн төслийн 2017 оны ЭМД-ын орлого, зардлын дүн шинжилгээ тайланд дурдсан байна. Хамралт буурсан нь 2015-2016 оны эдийн засгийн хямралын нөлөөгөөр бий болсон ажилгүйдэл, санхүүгийн тогтворгүй байдал, 2015 оны Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиар хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн шимтгэлийг нэмэгдүүлсэн зэрэгтэй холбоотой.

2010-2017 онд ЭМДС-ийн орлого нэрлэсэн дүнгээрээ гурав дахин өссөн байна.




*Эх сурвалж: Эрүүл мэндийн үзүүлэлтүүд 2017 (ЭМХТ, 2018)*

...MN СУДАЛГААНЫ САН

[52] Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, 2021 http://www.emd.gov.mn
[53] ttps://mohs.gov.mn/uploads/userfiles/files/TA%209386_Technical%20Report_1_MON_LAST%2016022019.pdf
[54] Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээний талаарх харьцуулсан лавлагаа мэдээлэл : Монгол Улс болон гадаадын зарим орны мэдээлэл СТ-21/407

2020-2021 онд ЭМД-ын сангийн шимтгэлийн орлого 130.6 тэрбум болсон ба шимтгэл төлөгчдийн тушаасан орлогын хэмжээ 2021 оны эхний хагаст өнгөрсөн оныхоос ихэссэн үзүүлэлттэй байна.

**2020, 2021 оны 5 сарын байдлаарх Эрүүл мэндийн даатгалын сангийн шимтгэлийн орлого**

| ЭМД-ЫН САНГИЙН ШИМТГЭЛИЙН ОРЛОГО | 2020 I-V сар | 2021 I-V сар |
|---|---|---|
| Эрүүл мэндийн даатгалд даатгуулагчид | 3.124.263 | 3.142.862 ↑ |
| Шимтгэлийг ажил олгогч, даатгуулагч хариуцан төлсөн иргэд | 780.517 | 799.274 ↑ |
| Төсөвт байгууллагын ажилтан | 244.619 | 249.591 ↑ |
| Аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан | 535.898 | 549.683 ↑ |
| Шимтгэлийг өөрөө хариуцан төлсөн иргэд | 161.625 | 118.868 ↓ |
| Малчин | 42.189 | 32.911 ↓ |
| Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн | 32.911 | 77.117 ↑ |
| Их, дээд сургууль, коллеж, МСҮТ-ийн суралцагч | 15.349 | 8.726 ↓ |
| Бусад даатгуулагч | 114 | 114 |
| Шимтгэлийг улсын төсвөөс хариуцсан иргэд | 2.182.121 | 2.224.720 ↑ |

тэрбум.төгрөгөөр

*Эх сурвалж: ЭМДЕГ, 2021*

*Монгол Улсын эрүүл мэндийн санхүүжилтийн бүрдүүлэлт*

Монгол Улсын эрүүл мэндийн санхүүжилтийг улсын төсөв, ЭМД, олон улсын байгууллагын хандив, тусламж, зээл болон хувь хүний төлбөр бүрдүүлнэ. Эрүүл мэндийн салбарын төсвийн саналыг ЭМЯ боловсруулж, СЯ нь төсвийг УИХ-д батлуулахаар оруулдаг.[55] 2006 онд Эрүүл мэндийг дэмжих тусгай санг байгуулсан нь эрүүл мэндийн салбарын төсвийн санхүүжилтийг өргөжүүлж, тамхи, архины онцгой татвар, импортын эмийн гаалийн татвараас тодорхой хувиар нэмэлт эх үүсвэрийг бүрдүүлэх болсон. Эрүүл мэндийг дэмжих сан нь дараах эх үүсвэрээс бүрдэж байна. Үүнд:

- Архи, согтууруулах ундааны онцгой албан татварын 1 хувь
- Эмийн импортын гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын 2 хувь
- Тамхины онцгой албан татварын 2 хувь

2018 онд Эрүүл мэндийг дэмжих сангийн санхүүжилтийг эрүүл мэндийн салбарын улсын төсвийн 1 хувиас бага байхаар баталсан. Сангийн хөрөнгийг халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэхэд зарцуулдаг. Хэдийгээр сангийн эх үүсвэрийг хуулийн дагуу бүрдүүлж байгаа ч хэмжээ нь хэт бага учраас эрүүл мэндийн нийт зардалд улсын санхүүжилтийн эх үүсвэрийн эзлэх хувийг нэмэгдүүлэхэд нөлөө үзүүлэхгүй байна.[56]

ДЭМБ-аас олон улсын эрүүл мэндийн санхүүжилтийн талаар гаргадаг мэдээллээс[57] харвал Монгол Улсын эрүүл мэндийн нийт зардлыг улсын төсөв, нийгмийн эрүүл мэндийн даатгал, гадны тусламж бүрдүүлж байгаа ба үлдсэн зардлын дийлэнхийг хувь хүн гаргаж байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[55] ttps://mohs.gov.mn/uploads/userfiles/files/TA%209386_Technical%20Report_1_MON_LAST%2016022019.pdf
[56]https://mohs.gov.mn/uploads/userfiles/files/TA%209386_Technical%20Report_1_MON_LAST%2016022019.pdf
[57] Global health expenditure database. WHO. https://apps.who.int/nha/database/country_profile/Index/en

**Эрүүл мэндийн улсын зардлын бүрдүүлэлт 2000-2018 он**




*Эх сурвалж: ДЭМБ 2019*

Эрүүл мэндийн даатгалын орлого эрүүл мэндийн улсын зардалд эзлэх хувиараа 30%-аас бага байсаар ирсэн, тухайлбал 2011 онд 20% байсан бол 2017 он гэхэд 27% болж өссөн байна. 2017 онд улсын төсвийн санхүүжилт ЭМУЗ-ын 64,4%-ийг эзэлж байсан байна.

Эрүүл мэндийн нийт зардлын ДНБ-д эзлэх хувь 2001 онд 3.8 хувь байсан бол эрүүл мэндийн салбарт Засгийн газраас хуваарилсан улсын төсвийн хөрөнгийн урсгал хангалттай хэмжээнд нэмэгдэж ороогүйгээс эрүүл мэндийн нийт зардлын ДНБ-д эзлэх хувь буурсаар байна.

**Эрүүл мэндийн улсын зардал, ДНБ-д эзлэх хувь (2000-2017 он)**




Улбар шар – Эрүүл мэндийн улсын зардал, ДНБ-д эзлэх %.
Эх сурвалж: Эрүүл мэндийн үзүүлэлтүүд 2017 (ЭМХТ, 2018)

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**Монгол Улсын эрүүл мэндийн салбарын зарцуулалт:** Үндэсний статистикийн хорооны 2020 оны тайланд эрүүл мэндийн салбарын нийт зардал 2019 оны урьдчилсан гүйцэтгэлээр 823.9 тэрбум төгрөг болж, сүүлийн 10 жилийн дунджаас 1.5 дахин, өмнөх оныхоос 1.1 дахин өссөн байна. Харин улсын төсвийн зардалд эрүүл мэндийн зардлын эзлэх хувь 2019 оны урьдчилсан гүйцэтгэлээр 7.2 хувь болж, сүүлийн 10 жилийн дунджаас 0.2 пунктээр, өмнөх оноос 0.8 пунктээр тус тус буурсан байна. [58]

[58] https://www.1212.mn/BookLibraryDownload.ashx?url=eruul_mend_2019.pdf&ln=Mn

**Эрүүл мэндийн салбарын зардал, 2010-2019 он**




*Эх сурвалж: Статистикийн үндэсний хороо, 2020*

Нэг хүнд ногдох эрүүл мэндийн зардал 2019 онд 258.3 мянган төгрөг болж, сүүлийн 10 жилийн дунджаас 73.9 мянга буюу 40.1 хувь, өмнөх оноос 24.8 мянга буюу 10.6 хувиар тус тус өсжээ. Харин ДНБ-д эрүүл мэндийн зардлын эзлэх хувь 2019 онд 2.2 болж, сүүлийн 10 жилийн дунджаас 0.3 пунктээр, өмнөх оноос 0.1 пунктээр тус тус буурсан байна. ”Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого”-ын хүрээнд “Улсын нэгдсэн төсвөөс эрүүл мэндийн салбарт зарцуулах зардлыг 12 хувь, ДНБ-нд эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн эзлэх хэмжээг 2021 он гэхэд 3.7 хувьд хүргэх” зорилт тавьсан бөгөөд энэ зорилтдоо хүрээгүй байна.[59]

Монгол Улсын эрүүл мэндийн санхүүжилтийн хуваарилалт

ДЭМБ-аас 6 жил тутамд улс орнуудын эрүүл мэндийн зардлыг гаргадаг ба дараагийн үзүүлэлт нь 2024 онд гарах юм. Доорх хүснэгтээс харахад улсын нэгдсэн төсвийн зарлагад эрүүл мэндийн зардлын эзлэх хувь 2000 оноос 2018 онд 12.3%-аас 7.7% хүртэл тогтмол буурсан байна. Үүнтэй зэрэгцэн эрүүл мэндийн нийт зардалд улсын төсвөөс гаргаж буй зардлын эзлэх хувь багассан, хувь хүнээс өөрөөс нь гарч буй эрүүл мэндийн зардал тогтмол өссөн байна.[60]

**Эрүүл мэндийн зардал 2000-2018 он**

| Үзүүлэлт | 2000 | 2006 | 2012 | 2018 |
|---|---|---|---|---|
| Нэг хүнд ногдох эрүүл мэндийн зардал (ам.доллар)[61] | 27.0 | 50.0 | 167.8 | 155.1 |
| Эрүүл мэндийн нийт зардалд улсын төсвөөс гаргаж буй зардлын эзлэх хувь[62] | 74.3 | 66.4 | 60.8 | 58.7 |
| Эрүүл мэндийн нийт зардалд хувь хүнээс гарч буй зардлын эзлэх хувь[63] | 19.7 | 25.6 | 31.5 | 32.4 |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

59 https://www.1212.mn/BookLibraryDownload.ashx?url=eruul_mend_2019.pdf&ln=Mn
60 Global health expenditure database. WHO. https://apps.who.int/nha/database/country_profile/Index/en
61 CHE- current health expenditure per capita
62 GGHE-D%CHE -Domestic general government health expenditure (*GGHE-D*) as percentage of current health expenditure
63 OOPS%CHE- Out-of-pocket (*OOPS*) as % of Current Health Expenditure

| | | | | |
|---|---|---|---|---|
| Улсын нэгдсэн төсвийн зарлагад эрүүл мэндийн зардлын эзлэх хувь[64] | 12.3 | 9.5 | 6.5 | 7.7 |
| Нэг хүнд ногдох ДНБ (ам.доллар)[65] | 554 | 1334 | 4352 | 4094 |

Эх сурвалж: :ДЭМБ 2019

Улмаар Үндэсний Статистикийн Хорооны мэдээллээр 2020 оны жилийн эцэст улсын нэгдсэн төсвийн зарлагад эрүүл мэндийн зардлын эзлэх хувь үргэлжлэн буурч 5.6% болсон байна.

**Эрүүл мэндийн зардал 2020 оны жилийн эцсийн байдлаар**

| Үзүүлэлт | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 |
|---|---|---|---|---|---|
| Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага, сая төгрөг | 9 495 332.9 | 9 017 318.6 | 9 222 928.5 | 11 429 391.8 | 13 960 787.5 |
| Эрүүл мэндийн нийт зардал[1], сая төгрөг | 657 478.1 | 674 899.7 | 737 723.7 | 823 888.9 | 787 067.4 |
| Улсын нэгдсэн төсвийн зарлагад эрүүл мэндийн зардлын эзлэх хувь | 6.9 | 7.5 | 8.0 | 7.2 | 5.6 |
| Нэг хүнд ногдох эрүүл мэндийн зардал, мянга.төгрөг | 216. 4 | 217. 9 | 233. 5 | 258. 3 | 244.0 |

*Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, 2021 он.*

2021 оны байдлаар ЭМДС-ийн зардал одоогоор эмнэлгийн тусламж үйлчилгээ, сувиллын тусламж үйлчилгээ, эмийн үнийн хөнгөлөлтийн зардалд зарцуулагдаж байна.

**2020, 2021 оны 5 сарын байдлаарх Эрүүл мэндийн даатгалын сангийн тусламж, үйлчилгээний зардал**



| ЭМД-ЫН САНГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2020 I-V сар | 2021 I-V сар |
|---|---|---|
| Эрүүл мэндийн даатгалын сангийн тусламж үйлчилгээний зардал | 152.978.3 | 388.649.6 |
| Эмнэлгийн тусламж, үйлчилгээний зардал | 135.272.7 | 363.182.3 |
| Сувиллын тусламж үйлчилгээний зардал | 3.760.2 | 1.483.9 |
| Эмийн үнийн хөнгөлөлтийн зардал | 13.945.4 | 23.483.4 |

*Эх сурвалж: ЭМДЕГ, 2021*

## Эрүүл мэндийн байгууллагуудын санхүүжилт

Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний техникиийн тайлангийн дагуу [66] эрүүл мэндийн анхан шатны санхүүжилтийн хуваарилалт нь тоо хэмжээ ба норматив зардалд суурилдаг (өрхийн болон сумын эрүүл мэндийн төв) хэдий ч дийлэнх төсвийн хуваарилалт лавлагаа шатлалын эмнэлгүүд, тэдгээрийн нүсэр дэд бүтцийн зардалд зориулагдсан хэвээр

[64] GGHE-D%GGE- Domestic general government health expenditure (*GGHE-D*) as percentage of general government expenditure
[65] GDP per capita- Per capita gross domestic product
[66]https://mohs.gov.mn/uploads/userfiles/files/TA%209386_Technical%20Report_1_MON_LAST%2016022019.pdf

байна. Энэ байдал нь эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн бууралтад мөн нөлөөлж байна. Эрүүл мэндийн салбарын төсвийн өсөлт ДНБ-ий өсөлтөөс хоцорч байна. Сангийн яамны зүгээс эрүүл мэндийн салбарын төсвийн хуваарилалтад хэт оролцож, микро түвшинд удирдаж байгаа нь ЭМЯ-нд шатлал болон байгууллага хооронд төсвийг хуваарилах, төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах уян хатан байдлыг олгохгүй байна.

**Төлбөрийн үндсэн аргууд.** Эрүүл мэндийн салбарын хууль эрх зүйн орчин шинэчлэгдэж, тусламж, үйлчилгээний төлбөрийн аргуудыг хуулиудад тодорхой тусгасан. Одоо мөрдөж буй төлбөрийн үндсэн аргуудад зардлын зүйл анги, эрсдэлээр ангилсан нэг иргэнд тооцсон төлбөр, тохиолдолд суурилсан өртөг ойролцоо оношийн бүлэг тооцсон төлбөр, иргэн шууд төлөх үйлчилгээний төлбөр зэрэг багтаж байна.

Тусламж, үйлчилгээ үзүүлэгчийг санхүүжүүлэх төлбөрийн одоогийн тогтолцооны давуу талууд:

- Төсвийн хязгаар тогтоох нь зардлыг хязгаарлаж, тогтвортой санхүүжилтийг хангадаг.
- Газарзүйн болон хүн амын ялгаатай байдлыг анхан шатны тусламжийн төлбөрт харгалзан үздэг.
- Төлбөрт үйлчилгээг тодорхой журмаар зохицуулж, төсвийн нийт дүнд оруулж, дээд хязгаарт хамруулж байгаа нь өртөг өндөртэй үйлчилгээний хэт ашиглалтаас сэргийлж, нийт эрүүл мэндийн зардлыг өсгөхөд хүргэдэггүй.

Сул талууд:

- Одоогийн төлбөрийн аргууд нь гүйцэтгэл, үр ашгийг дээшлүүлэх, анхан шатны тусламж болон урьдчилан сэргийлэлтийг дэмжихгүй байна.
- Шаардлагагүй тусламж үйлчилгээг өөгшүүлдэг.
- Улсын эмнэлгүүдэд хатуу төсвийн хязгаар тогтоож, давсан орлогыг суутгаж, зардлын зүйл анги, орцоор төсвийг төлөвлөж байгаа нь үр дүн болон үр ашигтай байдлыг дэмжихгүй байна.
- Улсын эмнэлгүүд, өрхийн эрүүл мэндийн төвүүд дунд үйлчилгээ үзүүлэгчээ чөлөөтэй сонгох эрх байхгүй байгаа нь өрсөлдөөнийг хязгаарладаг.
- Хувийн болон улсын эмнэлгүүдэд шаардлагагүй хэвтэлт, үзлэгийг байлгах сонирхол үүсгэж байна.
- Гүйцэтгэлийг (тусламж үйлчилгээний чанар) сайжруулах хөшүүрэг болж чадахгүй байна.
- Өртөг ойролцоо оношийн бүлгийн санхүүжилт нь хавсарсан өвчлөлийг тооцохгүй байна.
- Хэмнэлтийн зөвхөн 60 хүртэлх хувийг зарцуулахыг зөвшөөрдөг тул эмнэлгүүдэд хэмнэлтийг үр өгөөжтэй ашиглах сонирхол төрүүлэхгүй байна.

Төлбөрийн аргыг сайжруулахад дараах зүйлсийг анхаарвал зохино. Үүнд: 1) төлбөрийн аргуудын урамшууллын зохицуулалтыг тусламж үйлчилгээний төрөл, хэлбэр, түвшинд уялдуулж, хэрэгжүүлэх; 2) гүйцэтгэлийн урамшууллыг дэмжих болон 3) төлбөрийн аргыг уян хатан тогтмол шинэчлэх боломжтой байх. Мөн хуулинд төлбөрийн аргуудыг тодорхойлж зааж өгөхөөс зайлсхийх, харин тухай бүрд үр ашиг, чанарыг сайжруулах үр дүнтэй төлбөрийн аргуудыг хослуулан хэрэглэх боломжийг бүрдүүлэх шаардлагатай. [67]

[67] ttps://mohs.gov.mn/uploads/userfiles/files/TA%209386_Technical%20Report_1_MON_LAST%2016022019.pdf

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Ковид-19 цар тахлын үед эрүүл мэндийн санхүүжилтийн талаар авч буй арга хэмжээ

Коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх журам, тусламж үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээг батлах тухай Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан тушаал энэ оны 4 дүгээр сарын 30-ны өдөр батлагдан гарсан.

Эрүүл мэндийн даатгалын сангаар дамжуулан тусламж үйлчилгээний зардлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу санхүүжүүлэх ажлыг ЭМДЕГ-аас хэрэгжүүлэн ажиллаж байгаа ба Ковид-19-ийн эсрэг тусламж үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн байгууллагаас ирүүлсэн нэхэмжлэлийг хянасны үндсэн дээр санхүүжилт олгож байна.

Тухайлбал, 3 сарын 01-нээс 5 сарын 10-ны хүртэлх хугацаанд дархлаажуулалт хийсэн нийслэлийн 38 эрүүл мэндийн байгууллагад 4,6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. 4,2 тэрбум төгрөг буюу 91,3 хувь нь 8 дүүргийн Эрүүл мэндийн төвүүдэд хуваарилагдсан. 2021 оны 5 сарын 11-нээс 6 сарын 15-ны хугацаанд дархлаажуулалт хийсэн нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудаас гүйцэтгэлийн нэхэмжлэлд суурилан 4.2 тэрбум төгрөгийн санхүүжилт нэмж олгохоор байна.[68]

## БҮЛЭГ III. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ЦАЛИН ХӨЛСНИЙ СИСТЕМ, ОЛОН УЛСЫН ЖИШИГ

### 3.1. Эрүүл мэндийн салбарын цалин хөлсний олон улсын систем, арга хэлбэрүүд ба харьцуулалт [69]

Дэлхий дахинд эрүүл мэндийн салбарт тулгамдаж буй гол асуудал бол санхүүжилтийн асуудал юм. Дэлхийн улс орнууд хөгжлийн түвшнээс үл хамааран эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцооны шинэчлэлийг идэвхтэй өрнүүлж байгаа хэдий ч аль ч улсын төр засгаас эмнэлгийн байгууллагуудыг хангалттай санхүүгийн эх үүсвэрээр хангаж чадаагүй, хөрөнгийн эх үүсвэр дутагдалтай хэвээр байна. Ийм нөхцөлд эрүүл мэндийн салбарын ажилтнуудын цалин хөлсний системийг оновчтой тогтоох, хязгаарлагдмал нөөц боломжийг үр ашигтай ашиглах асуудал дэлхийн улс орнуудад тулгарч байна.

Судалгаанаас үзэхэд, эрүүл мэндийн салбарын ажилтнуудын цалин хөлсний универсал тогтолцоо дэлхийн практикт үгүй боловч сайн туршлага бүхий орнуудын жишгээр аль болох бага зардлаар чанартай эмнэлгийн үйлчилгээ үзүүлэхийн тулд улс орон бүр өөр өөрийн гэсэн цалин хөлсний систем тогтоохын төлөө тэмүүлж байна. Орчин үед дэлхий дахинд явагдаж байгаа эрүүл мэндийн салбарын шинэчлэл нь эрүүл мэндийн салбарын эмч, мэргэжилтнүүдийн нөхцөл байдлыг сайжруулах, цалин хөлсийг нэмэгдүүлэх, мэргэжлийн нэр хүндийг өсгөх, санхүүжилтийн механизмыг боловсронгуй болгоход чиглэгдэж байна.

Эрүүл мэндийн үйлчилгээний чанар нь эрүүл мэндийн салбарын эмч ажилтнуудын цалингаас шууд хамааралтай тул 1) эмнэлгийн байгууллагуудын бие даасан байдал, эрх мэдлийг нэмэгдүүлэх 2) санхүүжилтийг нэмэгдүүлэхэд анхаарах шаардлагатай болж байна. Өөрөөр хэлбэл, эрүүл мэндийн байгууллага эмч, ажилтнуудынхаа цалин хөлсийг ажлын гүйцэтгэл болон чанарт тулгуурлан коэффициентоор өсгөх боломжтой байх, шийдвэр гаргах буюу бие даасан байдлаа хадгалах явдал чухал юм.

[68] http://www.emd.gov.mn
[69] https://cyberleninka.ru/article/n/sravnitelnyy-analiz-oplaty-truda-meditsinskih-rabotnikov-obzor-literatury/viewer

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Эдийн засгийн өндөр хөгжилтэй орнууд, тухайлбал, Шведэд эмч нарын цалин бусад салбарын цалингийн дунджаас 1,65 дахин, АНУ-д 7,2 дахин, Германд 6 дахин өндөр байдаг гэсэн судалгаа байна. Өнөөгийн эмч нарын цалингийн түвшин эмнэлгийн мэргэжилтнүүдийг бэлтгэхэд зарцуулсан хөрөнгө болон цаг хугацаа, тэдний хүлээлт буюу алдагдсан боломж, мэргэжлийн нэр хүндийг өсгөх хэмжээнд хүрээгүй, урамшууллын хөшүүрэг болж чадахгүй байгаа талаар судлаачид олонтоо дүгнэсэн байдаг.

Баруун Европын ихэнх орнуудад, тухайлбал, Герман, Бельги, Люксембург, Голланд, Швейцар, Франц зэрэг орнуудад эрүүл мэндийн даатгалын систем өндөр хөгжсөн байдаг учраас урамшуулалт (гонорар) цалингийн системийг хэрэглэдэг бол, төсвийн санхүүжилтийн загварыг ашиглаж байгаа орнуудад энэхүү системийг хэрэглэх боломжгүй бөгөөд зөвхөн амбулторын үйлчилгээний эмч нарт нэмэгдэл олгоход ашигладаг байна.

Их Британи, Испани, Ирланд, Итали гэх мэтийн орнуудад нэг хүнд ногдох цалингийн системийг хэрэглэдэг бөгөөд энэ аргыг хэрэглэх үед эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд зарцуулах зардлын өсөлт хязгаарлагддаг учраас эмч, эмнэлгийн ажилтнууд аль болохоор өвчтөнд үзлэг, эмчилгээ хийхээс зайлсхийж урьдчилан сэргийлэх үзлэг олноор хийхийг илүүд үздэг сөрөг талтай.

Энэхүү цалин хөлсний арга нь дараах 2 хэлбэртэй байна.

3) Ерөнхий нормативт суурилсан цалингийн систем (Дани, Нидерланд)
4) Харьяалал бүхий хүн амын нас, хүйст суурилсан нормативт цалингийн систем (Их Британи, Итали)

Энэ аргыг хэрэглэх үед цалингийн зардлын өсөлтийн түвшинг тодорхойлох боломжтой учраас эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хэмжээ нэмэгдүүлэх хөшүүрэг болж чаддаг гэж үздэг. Гэвч ажил үйлчилгээгээ максимум хэмжээнд үзүүлсэн эмчид энэ нэмэгдэл олгогдохгүй буюу эсхүл маш бага хэмжээтэй олгогддог байна.

Дани, Их Британи, Норвеги, Герман зэрэг орнуудад нэгжийн үнэлгээнд суурилсан тогтмол цалингийн систем давамгайлах боловч холимог системтэй. Энэхүү холимог систем нь тэргүүлэх ач холбогдол бүхий эмнэлгийн тусламж үйлчилгээг идэвхжүүлэх хөшүүрэг болдог байна.

Холимог цалин хөлсний системтэй орнуудаас Их Британийн туршлага нэлээд сонирхолтойд тооцогддог. Финланд, Швед, Грек, Португал зэрэг орнуудад амбулторын эмч, ажилтнуудын цалинг тодорхой түвшинд хатуу тогтоох бөгөөд эмч ажилтнууд нэг ёсондоо улсын эмнэлэгт ажиллаж буй хөлсний ажилтнууд юм. Барууны орнуудын туршлагаас үзэхэд, хэрэв амбулторын үйлчилгээ тутамд үнэлгээ тогтоовол нийт үйлчилгээний хэмжээ илтэд өсөх ба энэ нь нэгжийн норматив үнэлгээнд суурилсан систем болон улсын эмнэлгүүдийн үзүүлэлттэй харьцуулахад харьцангуй өндөр байх боломжтой.

Хамгийн сайн туршлагатай, иргэд нь эмнэлгийн үйлчилгээнд сэтгэл хангалуун байдаг гэж судалгаагаар тогтоогдсон зарим орнуудад, тухайлбал, Нидерланд, Франц, Германд – урамшуулалт цалингийн систем үйлчилдэг. Иргэдийн сэтгэл ханамж муутай Испани гэх мэтийн улс орнууд нэгжийн нормативт суурилсан цалингийн системтэй байна.

Олон улсын туршлагаас үзэхэд, эрүүл мэндийн цалингийн универсал хэлбэр хараахан бий болоогүй байгаа бөгөөд дараах хэлбэрүүдийг ашиглаж байна. Үүнд:

***Тогтмол цалингийн систем*** - шилжилтийн эдийн засагтай ихэнх орнууд энэ хэлбэрийг ашиглаж байгаа бөгөөд эмч, эмнэлгийн ажилтны ажлын үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт байхгүй учраас ажил үйлчилгээний чанарыг сайжруулах, идэвхжүүлэх хөшүүрэг болж чаддаггүй. Нэгжийн үнэлгээнд суурилсан цалин хөлсний системийн үед эмнэлгийн ажилтнууд зөвхөн өөрийн хариуцсан бүртгэлтэй хүмүүст эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх бөгөөд тоон болон чанарын үзүүлэлтэд онцгойлон ач холбогдол өгдөггүйгээрээ сул талтай.

***Урамшуулалт цалингийн систем*** - энэ систем нь ихэвчлэн гэр бүлийн буюу өрхийн эмнэлэг давамгайлсан сайн тогтолцоотой орнуудад үйлчлэх бөгөөд эмч, эмнэлгийн ажилтнуудын ажлын үр дүнд суурилсан тоон болон чанарын шалгуур үзүүлэлтээр олгогддог, санхүүгийн нэмэлт эх үүсвэрийг татан төвлөрүүлэх боломжтой дэвшилтэт, урамшууллын цалин хөлсний систем юм. Энэ системийн үед эмч, эмнэлгийн ажилтнууд тооны араас хөөцөлдөж аль болох өндөр үнэтэй эм тариа, үйлчилгээг өвчтөнүүдэд санал болгох сонирхол бий болдгоороо сул талтай.

Олон улсын түвшинд урамшуулалт цалин хөлсний систем харьцангуй дэвшилтэт аргад тооцогддог боловч энэхүү системийг нэвтрүүлэхэд тодорхой хүндрэл бэрхшээлүүд тулгардаг байна. Тухайлбал, хуучин социалист орнууд буюу шилжилтийн эдийн засагтай орнуудад энэхүү системийг нэвтрүүлэхэд 1) төсөв-санхүүгийн нөөц хүрэлцээгүй, 2) эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцооны тасралтгүй, уян хатан байдал хангагдаагүй зэрэг шалтгаанууд нөлөөлдөг учраас нэвтрүүлэхэд хүндрэлтэй гэж олон улсын экспертүүд үзсэн байна. Гэсэн хэдий ч одоогийн цалин хөлсний систем нь эмч, эмнэлгийн ажилтнуудын ажлын үр дүнг бодитой үнэлэх, ажил үйлчилгээний чанар, стандартыг сайжруулах хөшүүрэг болж чадахгүй байгаа учраас шилжилтийн эдийн засагтай олон улс орнууд эмч нарын ажлын үр дүн болон эдийн засгийн хөшүүргийн тэнцвэрийг хадгалсан байдлаар дэвшилтэт системийг нэвтрүүлэхийг зорьж байна.

**Эрүүл мэндийн салбар дахь цалин хөлсний систем ба тэдгээрийн эдийн засгийн үр нөлөөний харьцуулалт**

| Эрүүл мэндийн салбар дахь цалин хөлсний систем | Хэлбэр | Эдийн засгийн үр нөлөө | | |
|---|---|---|---|---|
| | | Идэвх санаачилгыг дэмждэг эсэх | Идэвх санаачилгыг бууруулдаг эсэх | Ажиллах хүчний зардлын өсөлтийг хязгаарладаг эсэх |
| Урамшуулалт цалингийн систем (fee for service) | Гүйцэтгэлээр | Тийм | Үгүй | Үгүй |
| Тогтмол цалингийн систем (salary) | Цагаар | Үгүй | Тийм | Тийм |
| Нэг өвчтөнд ногдох тогтмол зардалд суурилсан цалингийн систем (capitation fee) | Тогтмол гүйцэтгэлээр | Үгүй | Тийм | Тийм |

*Эх сурвалж: https://www.krasmed.ru/docs/opmspvupf/05_11.pdf*

### 3.2. Шилжилтийн эдийн засагтай зарим орнуудын эмч, эмнэлгийн ажилтнуудын цалин хөлсний систем, шинэчлэлийн явц

Шилжилтийн эдийн засагтай орнуудын хувьд гадаадын бусад оронд дэвшилттэйд тооцогдож буй ЭМ-ийн ажилтнуудын цалин хөлсний системээр баримжаалан өөрийн орны уламжлалт цалин хөлсний систем, улс орныхоо эдийн засгийн хүчин чадал, нөөц боломждоо тулгуурласан цалин хөлсний системийг эрүүл мэндийн салбарт мөрдүүлж байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Тухайлбал, ОХУ-д, эрүүл мэндийн заавал даатгалын хүрээнд эмнэлгийн тусламж үйлчилгээний цалин хөлсний тогтолцоог боловсронгуй болгох хөтөлбөр хэрэгжүүлж байгаа бөгөөд нэгжид суурилсан тогтмол цалингийн системд үндэслэсэн үйл ажиллагааны үр дүнгээр нэмэлт урамшуулал олгох журам тогтоон хэрэгжүүлж байна. Энэхүү систем нь ялангуяа амбултор-поликлиникийн нэгжүүдэд илүү үр дүнтэй байгаа нь тогтоогдсон. Санхүүжилтийн зарчим нь суурь тариф дээр поликлиникийн санхүүжилтийг нэмж тооцно.

ОХУ-д одоогоор эмнэлгийн байгууллага хэдий чинээн том байна төдий чинээ их төсөв авна гэсэн төсвийн хуваарилалтын уламжлалт тогтолцоо болон эрүүл мэндийн байгууллагын хэмжээ, орон тооноос үл хамаарах ажлын үр дүнд, эрүүл мэндийн даатгалд суурилсан эмнэлгийн тусламж үйлчилгээний санхүүжилт бүхий цалин хөлсний систем зэрэгцэн оршиж, тодорхой хэмжээнд зөрчилтэй асуудлуудыг бий болгож байна.

Казахстан Улс өмнө нь орон тоонд суурилсан төсвийн санхүүжилт бүхий цалин хөлсний тогтолцоотой байсан бол 2000 онд нэгжид суурилсан нормативт санхүүжилт бүхий цалин хөлсний системд шилжсэн. Одоогийн байдлаар Казахстан Улс *эрүүл мэндийн үйлчилгээний чанар, стандартад суурилсан нэмэлт урамшуулал бүхий нэгжид суурилсан нормативт санхүүжилттэй цалин хөлсний тогтолцоог* нэвтрүүлээд байна.

Дүгнэж хэлэхэд, эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн хүрээнд эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулахад зайлшгүй шаардлагатай хүчин зүйлс нь 1) санхүүжилтийн нөөц хангалттай байх; 2) эрүүл мэндийн салбарын ажилтнуудын цалин хөлсний оновчтой тогтолцоог нэвтрүүлэх; 3) эмч, эмнэлгийн ажилтны цалин хөлсийг ажлын үр дүнтэй уялдуулах шаардлага бий болж байна.

### 3.3.Эрүүл мэндийн байгууллагын цалин, урамшууллын стратеги

Аливаа байгууллага цалин хөлсний урамшууллын бодлогыг үйл ажиллагаагаа тодорхой зорилгод хүрэх стратегийн хэрэгсэл гэж үзэх нь байгууллагуудын хувьд харьцангуй шинэ хандлага юм.

‘Стратегийн цалин’ гэх санаа нь байгууллагын тодорхой зорилтыг дэмжсэн шагнал урамшууллын багцыг нэвтрүүлэх боломжид суурилдаг. Жишээлбэл, эрүүл мэндийн ажилтны ур чадварыг нэмэгдүүлэхийг эрмэлзэж буй байгууллага ур чадварт суурилсан цалингийн системийг нэвтрүүлж болно.

Стратегийн цалин хөлсний тухай ойлголтын гол цөм нь цалин хөлсөнд нөлөөлөх тогтмол болон хувьсах хүчин зүйлс юм. Тухайн байгууллага хүрэхээр зорьж буй зорилго, алсын хараагаа тодорхой болгож, шагнал урамшууллын стратеги тодорхойлох ба үүнд нийцсэн арга хэлбэр, тогтолцоог бий болгож эхэлсэн. Энэ нь үндсэндээ *зөөлөн ур чадварт суурилсан урамшуулал, өрсөлдөх чадварт суурилсан урамшуулал, багаар тооцсон цалин урамшуулал* хэлбэртэй байна.

Олон улсын хэмжээнд авч үзвэл, эрүүл мэндийн байгууллагууд цалин хөлсний одоогийн тогтолцоогоо хянан үзэж, шинэ хандлага, арга хэлбэрүүдийг нэвтрүүлэх болсон дараах шалтгаанууд байна гэж үздэг. Үүнд:

- Эрүүл мэндийн тогтолцоонд цалин хөлсний зардал урсгал зардлын 70% ба түүнээс дээш хувийг эзэлдэг тул хөдөлмөрийн өртгийг хянах, үр ашгийг дээшлүүлэх шаардлага бий болсон
- Үндэсний түвшинд, мөн байгууллагын түвшинд гүйцэтгэлийн менежментийн системчилсэн хандлагыг хөгжүүлж байна. Тухайлбал эрүүл мэндийн тогтолцоонд

УИХ-ЫН СУДАЛГААНЫ САН

“худалдан авагч-үйлчилгээ үзүүлэгч”-ийн гэрээт харилцааг нэвтрүүлэх болсон байна

- Эрүүл мэндийн ажилчдыг сонгон шалгаруулах, тогтвор суурьшилтай ажиллуулах, газарзүйн хуваарилалтаар байршуулахын тулд цалин урамшууллын механизмыг ашиглаж байна.
- Хувь хүн, байгууллагын түвшинд хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулахын тулд цалин урамшууллын шинэ стратегийг ашиглаж байна.
- Байгууллагын бүтцийн өөрчлөлт шинэчлэлт, байгууллагын соёл, менежментийг өөрчлөх зорилгоор цалин урамшууллын шинэ стратегийг ашиглаж байна.
- Эрүүл мэндийн ажилтны ажлын цаг ашиглалт, хандлага, зан төлөвийн уян хатан байдлыг сайжруулах механизм болгон ашиглаж байна.
- Эрүүл мэндийн ажилтнуудыг олон талт хамтын ажиллагаа, багаар ажиллах чадварыг дэмжих хөшүүрэг болгон ашиглаж байна.
- Эрүүл мэндийн ажилтнууд ур чадвараа тасралтгүй дээшлүүлж, шинэ чадвар эзэмшихэд уриалах буюу тэдний “насан туршийн боловсрол”-ыг дэмжих асуудлыг цалин урамшууллыг бодлогоор зохицуулж байна.

Цалин хөлс, урамшууллын стратегийг боловсруулах, шинэчлэхэд дээр дурдсан харилцан уялдаа бүхий олон үндэслэлүүдийг авч үзэх шаардлагатай. Түүнчлэн цалин хөлс, урамшууллын стратегийг үр дүнтэй хэрэгжүүлэх үндсэн нөхцөл нь тухайн байгууллагын ерөнхий стратеги, байгууллагын тодорхой зорилго, үйл ажиллагааны нөхцөл байдалд тохирсон байхад оршино.

Эрүүл мэндийн салбарын цалин урамшууллын системд өөрчлөлт шинэчлэл хийх явцад эрүүл мэндийн салбарт ажиллагсдад урьдчилан төлөвлөөгүй, хүсээгүй олон үр дагавартай учирч болзошгүй. Тиймээс тухайн улс, орон байгууллага бүр өөрсдийн нөөц боломж, онцлогт тохирсон цалин хөлсний стратеги боловсруулах нь эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн явцад эерэг өөрчлөлт авчрахаас гадна ажиллагсдын зүгээс гарч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах сайн талтай.

### 3.4.Эрүүл мэндийн салбарын цалин хөлсний системд нөлөөлөх хүчин зүйлс

Эрүүл мэндийн ажилтны салбарын цалин хөлс, урамшууллын системд олон хүчин зүйлс нөлөөлдөг. Тиймээс эрүүл мэндийн тусламж үйлчилгээг ямарч нөхцөлд үзүүлж болохуйц түгээмэл бодлого, үйл ажиллагааны чиглэлийг тогтоох шаардлагатай.

Эрүүл мэндийн салбарын цалин хөлс, урамшууллын системийг бүрдүүлэхэд чухал ач холбогдол бүхий шууд нөлөөлөх хүчин зүйлс болон бодлогын хүчин зүйлсийг дараах байдлаар авч үзлээ. [70,71]

Шууд нөлөөлөх хүчин зүйлс:

- *Газар зүйн байршил*- тухайн ажилтны цалин, амьжиргааны өртөг нь хүн амын төвлөрөл ихтэй томоохон хотуудад сийрэг хүн амтай орон нутгийнхнаас өндөр байх хандлагатай. Иймд хот, хөдөөгийн эмнэлгийн ажилтны цалин хөлсний ялгаа тай байдлыг анхаарч үзэх шаардлагатай.
- *Ажиллаж буй салбар*- ижил мэргэжилтэй боловч ямар салбарт ажиллаж байгаагаас тухайн ажилтны цалин, хөлс хамаарна. Тухайлбал, улсын болон хувийн эмнэлгт ажиллаж буй эмнэлгийн ажилтны цалин, хөлс ялгаатай байдаг.

[70] https://www.careerprofiles.info/salary-factors.html
[71] https://www.salary.com/articles/eight-factors-that-can-affect-your-pay/

- *Боловсрол-* Боловсрол, эрдмийн зэрэг цолноос хамааран цалин хөлсний хэмжээ харилцан адилгүй байдаг.
- *Ажлын туршлага-* ажилласан жилээс шалтгаалж эрүүл мэндийн ажилтны цалин хөлс ялгаатай байна.
- *Гүйцэтгэлийн үр дүн* - ажлын гүйцэтгэлийн үр дүнгээс хамааран цалин хөлс ялгаатай тогтоно. Ялангуяа эрүүл мэндийн салбар дахь гүйцэтгэлд суурилсан цалингийн тогтолцоотой үед.
- *Удирдлагын нэмэгдэл* - удирдах албан тушаалд ажиллаж буй этгээд өөрийн хариуцаж буй газар хэлтсийнхээ амжилтаас хамаарч цалин, урамшуулал авна. Тухайлбал эмнэлгийн тасгийн эрхлэгчийн нэмэгдэл нь тухайн тасгийн ажлын үр дүн, амжилттай шууд хамааралтайгаар өөрчлөгдөж болно.
- *Мэргэжлийн холбооны гишүүнчлэл* - мэргэжилтэй холбооны гишүүнчлэл, мэргэжлийн сертификат авсан байдал зэрэг нь цалин хөлсөд нөлөөлөх тохиолдол бий. Тухайлбал яаралтай тусламж үзүүлэх ур чадварын сертификат эсвэл хүүхдийн хөгжлийг алтан стандартаар үнэлж, оношлох ур чадварын сертификатыг зохих мэргэжлийн нийгэмлэгээс нь авсан бол цалин нэмэгдэх жишиг байдаг.
- *Хөдөлмөрийн хүнд нөхцөл-* ажлын байрны орчны сөрөг нөлөөлөл, эрсдэлт хүчин зүйлс зэрэг нь цалин хөлсийг нэмэх шалтгаан болно. Тухайлбал химийн тариа найруулдаг сувилагч, туяа эмчилгээний эмч гэх мэт
- *Илүү ажлын гүйцэтгэл* - илүү цагаар, эсхүл гадаа олон цагаар ажиллаж байгаа ажилтан нийгэм-эрүүл мэндийн хувьд ахиу зардал гаргасанд тооцогддог тул илүү цалин авах шаардлагатай болдог.
- *Цалингийн ангилал, шатлал-* гарааны цалин, дундаж цалин, хамгийн их цалин гэх зэрэг шатлалууд байж болох бөгөөд улсын байгууллагад ажиллагсдын цалин хувийн байгууллагатай харьцуулахад харьцангуй уян хатан бус байдлаар тогтоогддог.
- *Ажил, мэргэжлийн зэрэг* - туслах мэргэжилтэн, мэргэжилтэн болон ахлах мэргэжилтнүүдийн цалин харилцан ялгаатай байна.
- *Хөдөлмөрийн зах зээл дэх эрэлт, нийлүүлэлт-* ажиллах хүчний хомсдол байна гэж үзвэл ажил олгогчид чадвар сайтай ажилтныг татахын тулд гарааны сайн цалинг санал болгож болно. Тухайлбал алслагдмал нутагт эмч нарыг татахын тулд цалин урамшууллыг нэмэгдүүлэх бодлого баримтална.
- *Засгийн газрын бодлого, эрх зүйн зохицуулалт-* цалин, хөлстэй холбоотой хууль, журам, бичиг баримтууд нь цалин хөлсийг тогтоох үндэслэл болно. Жишээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, төр захиргааны байгууллагад ажиллагсдын цалингийн итгэлцүүр гэх мэт.
- *Хөдөлмөрчдийн эрх ашгийг хамгаалах байгууллага* - Хөдөлмөрчдийн эрх ашгийг хамгаалах байгууллага цалин хөлсийг нэмэгдүүлэх чиглэлээр санал, санаачилга гарган идэвхтэй ажиллаж болно.

Бодлогын хүчин зүйлс:

- *Төсвөөс олгож буй эрүүл мэндийн салбарын зардлын улсын нэгдсэн төсвийн зардалд эзлэх хувь* - тухайн улс эрүүл мэндийн салбартаа хэр анхаарч байгаа вэ гэдгийг энэхүү үзүүлэлтээр тодорхойлно.
- *Улсын эмнэлгийн салбарт ажиллагсдын тоо-* нэг ажилтанд ногдох зардлын хэмжээг үгээр тогтооно.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

- *Улсын эмнэлгийн эмч, ажилчдын цалинд төсвөөс хуваарилж буй мөнгөн хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр-* үүнд олон эх үүсвэр хамаарах бөгөөд ЭМДС-аас гарч байна уу, төсвөөс гарч байна уу гэдгээс шалтгаална.
- *Иргэдээс ЭМДС-д төлж буй шимтгэлийн хэмжээ-* ЭМДС-аас санхүүжилт авч байгаа тохиолдолд энэ хувь хэмжээ чухал.
- *Хувийн эрүүл мэндийн даатгалын сангийн хөгжил-* хувийн даатгалын сангийн үйлчилгээ сайн хөгжсөн бол хувийн эмнэлэгт хандах нь ихэсч, улсын эмнэлгийн ачаалал багасах сайн талтай.
- *Улсын эмнэлгийн эмчийн цалин-* улсын эмнэлгийн эмчийн цалинг зөвхөн төсвийн эх үүсвэрээр олгож байна уу, эсхүл эмнэлгийн өөрийн орлогын эх үүсвэрийг ашиглаж байна уу гэдгээс эмчийн цалин хамаарч хэлбэлзэнэ.
- *Улсын эмнэлгийн эмчийн цалинг тогтоох аргачлал-*Улсаас тогтоосон эрүүл мэндийн ажилтны цалинг тогтоох нэгдсэн аргачлал, журмууд хамаарна.

### 3.5. ДЭМБ-ын гишүүн орнуудын эрүүл мэндийн салбарын цалин хөлсний байдал

Бүх нийтийн эрүүл мэндийг сайжруулах үндсэн нөхцөл нь идэвх чармайлттай эрүүл мэндийн ажилчдын тоо хангалттай байхад оршино. Эрүүл мэндийн ажилчдын цалин хөлс нь Засгийн газраас олгож буй эрүүл мэндийн зардал болон эрүүл мэндийн нийт зардлаас шууд хамааралтай.

- Засгийн газрын эрүүл мэндийн зардалд хүн амын эрүүл мэндийг хамгаалах, нөхөн сэргээх, сайжруулах зорилгоор төсвөөс хуваарилсан урсгал болон хөрөнгийн зардлууд багтана.
- Эрүүл мэндийн нийт зардалд хүн амын эрүүл мэндийг хамгаалах, нөхөн сэргээх, сайжруулах зорилгоор хувийн сектор болон Засгийн газраас гаргасан бүх зардлыг хамруулж ойлгоно.

ДЭМБ-аас эрүүл мэндийн ажилтанд зарцуулж буй зардлын мэдээллээ гаргах боломжтой дэлхийн 179 орныг хамруулан судалгаа хийхэд эрүүл мэндийн ажилтны цалин хөлсөнд дунджаар нийт эрүүл мэндийн зардлын 33.6%-ийг зарцуулж байгаа нь тодорхой болжээ. Эрүүл мэндийн ажилтны цалин хөлсөнд зарцуулж буй зардлын дундаж хэмжээ нь улс орны орлогын түвшин нэмэгдэх тусам ихэсч байна. Хамгийн өндөр орлоготой орны хувьд энэ үзүүлэлт 38.1%-тай байгаа бол хамгийн бага орлоготой оронд 28.7% байна.

| Улс орны орлогын түвшин | Судалгаанд хамрагдсан орон | Нийт эрүүл мэндийн зардалд эрүүл мэндийн ажилтны цалингийн эзлэх хувь | Нийт эрүүл мэндийн зардалд улсын эмнэлэгт ажиллагсдын цалингийн хувь | Засгийн газрын эрүүл мэндийн зардалд улсын эмнэлэгт ажиллагсдын цалингийн хувь | Эрүүл мэндийн ажилтны дундаж цалин (ам.дол) | Эрүүл мэндийн ажилтны худалдан авах чадварын тэгш байдалд суурилсан дундаж цалин |
|---|---|---|---|---|---|---|
| Өндөр | 48 | 38.1 | 18 | 31.2 | 28298 | 28063 |
| Өндөр дунд | 51 | 33.2 | 23.4 | 38.2 | 8037 | 14667 |
| Бага дунд | 48 | 30.5 | 18.7 | 34.7 | 3079 | 5927 |
| Бага | 32 | 28.7 | 9.9 | 26.2 | 473 | 1347 |
| Бүгд | 179 | 33.6 | 18.1 | 33.2 | 15352 | 18102 |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Хүснэгтээс үзэхэд, улсын эмнэлгийн ажилчдын цалин хөлс нь эрүүл мэндийн нийт зардлын бараг 20%, Засгийн газрын эрүүл мэндийн зардлын 33.2%-ийг эзэлж байна. Мөн

бага орлоготой орнуудын улсын эмнэлгийн ажилчдын цалингийн зардал өндөр орлоготой орнуудынхаас хавьгүй бага хэвээр байна. Улсын байгууллагын эрүүл мэндийн ажилтнуудын цалингийн хэмжээ ерөнхийдөө улс орны орлогын түвшинтэй шууд хамааралтай байна.

Сүүлийн жилүүдэд эрүүл мэндийн ажилтны цалингийн зардлын ДНБ-д эзлэх хувь хэмжээ өссөөр байна. Сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд энэ хандлага хадгалагдсаар ирсэн ба үүнд эрүүл мэндийн ажилтнуудын тооны өсөлт нөлөөлсөн гэж үзэж болно.

Эрүүл мэндийн салбарын бусад зардлуудтай харьцуулахад эрүүл мэндийн ажилчдын цалин хөлсний зардал харьцангуй удаан өссөн нь эрүүл мэндийн салбарын ихэнх зардлыг технологи ба хөрөнгө оруулалтад зарцуулсантай холбоотой.

Бүх нийтийн эрүүл мэндийг сайжруулах зорилтыг зөвхөн зайлшгүй үйлчилгээгээр хязгаарлах боломжгүй юм. Иймээс эрүүл мэндийн санхүүжилтийг эрүүл мэндийн салбарын ажилтнуудын цалин хөлсийг нэмэгдүүлэх болон эрүүл мэндийн тогтолцооны бусад бүрэлдэхүүн хэсэг болох эм, дэд бүтэц, мэдээллийн технологид хөрөнгө оруулалт хийхэд зарцуулах шаардлагатай гэж ДЭМБ-аас зөвлөсөн байна. Хязгаарлагдмал санхүүгийн нөөцийн хэчнээн хувийг эрүүл мэндийн салбарын боловсон хүчиндээ зориулах вэ гэдэг нь засгийн газруудад тулгарч буй тулгамдсан асуудал, бэрхшээл болж байна.

### 3.6. ДЭМБ-ын эрүүл мэндийн салбарын цалин хөлс, урамшууллын стратеги

Эрүүл мэндийн ажилтны цалин хөлсний бүтэц, стратегийг дараах 4 хэлбэрээр тодорхойлж байна.[72]

- ***Багцлан олгох*** (capitation fee) Бүртгэлтэй нэгж өвчтөнд ногдох зардалд суурилсан тогтмол хэмжээний мөнгийг багцлан хуваарилдаг тогтолцоог хэлнэ.
- ***Санхүүгийн эрсдэл хуваалцах*** (shared financial risk). Санхүүгийн нэг эх үүсвэрт хамруулдаг хэлбэр бөгөөд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардлыг хэмнэвэл ашигтай, хуваарилагдсан зардлаас хэтэрсэн үйлчилгээ үзүүлбэл алдагдалд ордог. Энэ системийг ихэвчлэн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад ашигладаг.
- ***Үйлчилгээний төлбөрийн систем*** (fee-for-service). Эмч нар үзүүлсэн үйлчилгээгээрээ цалинждаг. Хэдий чинээ их үйлчилгээ үзүүлнэ, төдий чинээ өндөр цалин авна.
- ***Тогтмол цалингийн систем*** (salary). Эмч нарын цалинг тэдний туршлага, ур чадварт суурилан олгодог. Энэ систем нь хувь хүн өөрийн арга барилыг шинэчлэх санхүүгийн хөшүүрэг болохгүй.

**Урамшуулал** гэдэг нь зан үйлийн тодорхой өөрчлөлтийг бий болгох зорилготой хөшүүргийг хэлнэ. Урамшуулал нь янз бүрийн хэлбэртэй байх бөгөөд мөнгөн ба мөнгөн бус хэлбэртэй байж болно.

Мөнгөн урамшуулал:
- Мөнгөн төлбөр
- Санхүүгийн шууд ашиг тус бүхий:
  - Тэтгэвэр
  - Өвчин/ эрүүл мэнд/ осол/ амьдралын даатгал

[72] Health workforce incentive and remuneration strategies, a research review, Evidence and Information for Policy, Department of Organization of Health Services Delivery, World Health Organization, Geneva 2000

UIH.MN СУДАЛГААНЫ САН

- Хувцас/байрны мөнгө
- Томилолтын мөнгө
- Хүүхэд асрах тэтгэмж

- Санхүүгийн шууд бус үр ашиг бүхий:
  - Хөнгөлөлттэй хоол/ хувцас/байр
  - Хөнгөлөлттэй зорчих
  - Хөнгөлөлттэй хүүхэд харах үйлчилгээ

Мөнгөн бус урамшуулал:

- Баярын амралт
- Уян хатан ажлын цаг
- Сургалтанд хамруулах/ боловсрол эзэмшихэд нь дэмжлэг үзүүлэх
- Амралтын/ сургалтын чөлөө
- Төлөвлөгөөт амралт
- Хөдөлмөрлөх нөхцөлийн эрүүл мэндийн зөвлөгөө
- Амралт зугаалгын байгууламжаар хангах

Эрүүл мэндийн ажилтанд олгох цалин, урамшууллын стратегийг хувь хүн болон хамтын ажиллагааны хүрээнд орц, гарцын үндсэн хэмжигдэхүүнээр тодорхойлдог.

Хувь хүнд чиглэсэн цалин, урамшууллын стратеги нь тухайн эрүүл мэндийн ажилтанд зан үйлийн ээрэг өөрчлөлт авчрахад чиглэдэг бол хамт олны цалин, урамшууллын схемийг байгууллагын болон багийн түвшинд 2 янзаар олгодог.

**Гүйцэтгэлийн урамшууллын схем**

| Гүйцэтгэлийн хэлбэр | Гүйцэтгэлийн урамшууллын үнэлгээний нэгж | | |
|---|---|---|---|
| | Хувийн | Багийн | Байгууллагын |
| Гарц | Нэгж ажлын хэмжээ (piecework) | Багийн бонус (team bonus) | Хэмнэсэн зардлаа хуваах (gainsharing) |
| | Нийт орлогоос хувь авах (commision) | | |
| | Хувийн бонус (individual bonuses) | Хэмнэсэн зардлаа хувааж авах (team gainsharing) | Ашгаа хувааж авах (profit sharing) |
| | Хувийн гүйцэтгэлд суурилсан урамшуулал (individual performance-related pay) | | |
| Орц | Мэргэжлийн ур чадварт суурилсан урамшуулал/ ур чадварт суурилан тушаал дэвших (skill based/clinical ladders) | | Ажилтан хувьцаа эзэмших (share ownership) |
| | Зан төрх буюу зөөлөн ур чадварт суурилсан урамшуулал / албан тушаал шатлан дэвшүүлэх (merit pay) | | |
| | Өрсөлдөх чадварт суурилсан урамшуулал (дээрх 2 урамшууллын аль алиныг нь нэгтгэсэн урамшуулал) (competence-based) | | |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**3.7. Дэлхийн банкны зөвлөмж: Эрүүл мэндийн ажилтны цалин урамшууллыг нэмэгдүүлэхэд баримтлах зарчим, анхаарах зүйлс**

Цар тахал гэх мэт эрүүл мэндийн ажилтнууд ачааллалтай ажилладаг онцгой нөхцөл байдлын үед эрүүл мэндийн ажилчдыг Засгийн газраас дэмжих үндсэн хэлбэр бол тэдний цалин, урамшууллыг нэмэгдүүлэх хэлбэр юм.

Тиймээс эхний алхам нь нэмэлт цалингийн хэмжээг зөв тодорхойлж, эрүүл мэндийн ажилтны цалингийн түвшин, бүтцийг сайтар үнэлэх шаардлагатай. Дэлхийн банкны гишүүн орнуудад эрүүл мэндийн ажилчдын цалин хөлс нийтлэг байдлаар дараах бүтэцтэй байна:

- ***Үндсэн цалин***. Үүнийг төрийн албаны цалин хөлсний тухай хууль, тогтоомж болон эрүүл мэндийн ажилтны цалингийн шатлалд үндэслэн тогтооно.
- ***Илүү цагийн нэмэгдэл***. Үүнийг хуулиар тогтоосон ажлын цагаас хэтрүүлэн ажилласан тохиолдолд нэмэгдүүлж олгоно.
- ***Хөдөлмөрийн хортой нөхцөлийн нэмэгдэл***. Энэ нь эрсдэлтэй гэж тооцогдох хөдөлмөрийн нөхцөлд ажилласан тохиолдолд нэмж олгодог нөхөн олговор юм.
- ***Бусад нэмэгдэл***. Үүнд ихэвчлэн ажилласан жилийн, ур чадварын, боловсролын, мэргэшлийн зэргийн, орон нутагт буюу алслагдсан газарт ажилласны нэмэгдлүүд орно.
- ***Гүйцэтгэлийн төлбөр***. Энэ нь орц (ажлын цаг гэх мэт), гарц (эмчлүүлсэн өвчтөний тоо гэх мэт), үр дүн (өвчтөний сэтгэл ханамж) гэх мэт үзүүлэлтээр тодорхойлогддог нэмэлт төлбөр юм.
- ***Томилолтын мөнгө***. Энэ нь ихэвчлэн сургалт, семинарт хамрагдахад зориулан олгогддог.

Эдгээр цалингийн нэмэгдлүүдийг төсөвлөхдөө дараах зүйлсийг анхаарах шаардлагатай гэж дэлхийн банкнаас зөвлөсөн.[73]

- Эрүүл мэндийн салбарын ажилчид нь төрийн албан хаагчдын томоохон хэсгийг бүрдүүлдэг. Тухайлбал, Латин Америк, Европын Холбоонд эрүүл мэндийн ажилчдын 12-37 хувь нь төсвийн байгууллагын ажилтнууд байдаг. Тиймээс хөгжиж буй орнуудад эрүүл мэндийн ажилчдын цалинг нэмэх нь эм, эмнэлгийн хэрэгсэл зэрэг бусад чухал зардлын санхүүжилтийг бууруулж болзошгүй.
- Үйлдвэрчний эвлэл нь идэвх сайтай орнуудад нэг салбарын ажилчдын цалинг нэмэхэд нөгөө салбарын ажилчид цалингийн өсөлтийг шаардах явдлыг эрчимжүүлэх магадлалтай.
- Цалинг түр хугацаанд нэмсэн ч энэ өсөлт цаашид хадгалагдан үлдсэнээс үүдэн төсвийн тогтвортой байдалд нөлөөлөх, урт хугацааны гажуудал, бэрхшээлийг үүсгэх эрсдэлтэй байж болзошгүй.

Дэлхийн банкнаас гаргасан судалгаагаар, Латин Америкийн 10 орон, Европын Холбооны 27 оронд эрүүл мэндийн ажилтнууд бусад салбарын ажилчдаас илүү цалингийн нэмэгдэл авч байгаа ба улс орны орлогын түвшингээс хамаарч эрүүл мэндийн салбарын нэмэгдэл буурдаг гэжээ.

Дэлхийн банкнаас хямралын үед болон цар тахлын идэвхтэй тархалтын үед эмнэлгийн ажилтнуудын цалинг нэмэгдүүлэхэд баримтлах зарчмуудын талаар дараах зөвлөмжийг гаргажээ.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

***Хямралын үед эрүүл мэндийн ажилтны цалин, урамшууллыг нэмэгдүүлэх зарчмууд***

1) Албан ёсны байх

Засгийн газрын зүгээс цалинг нэмэх шаардлага хангасан эрүүл мэндийн ажилтны ангиллыг тодорхой мэдээлэх хэрэгтэй. Эрүүл мэндийн байгууллагын бүх ажилчид илүү цагаар ажиллаж, нэмэлт эрсдэлд орох магадлалтай тул эрүүл мэндийн салбарт ажиллаж буй эмнэлгийн болон эмнэлгийн бус бүх ажилтнуудыг хамруулах явдал чухал

[73] https://blogs.worldbank.org/governance/how-increase-compensation-health-workers-during-Ковид-19

юм. Төсвийн хязгаарлагдмал байдлаас үүдэн засгийн газрууд эмнэлгийн бус ажилтнуудын цалинг нэмэхгүй үлдээх тохиолдол ажиглагддаг. Ийм нөхцөл байдал байгууллага доторх дургүйцэл, эвгүй байдлыг бий болгож болзошгүй юм.

2) Онцгой байдлын үеийн түр нэмэгдэл

Онцгой байдлын үеийн нэмэлт цалин нь Засгийн газрын тогтоолоор баталсан түр хугацааны “тусгай тэтгэмж” хэлбэртэй байх ёстой бөгөөд хямрал дуусахад цуцлагдана. Энэ төрлийн нэмэгдэл нь цалингийн хувиар бус тогтсон хэмжээгээр олгогдох ёстой бөгөөд ингэснээр хянаж, удирдахад амар болж, нэр заасан эрүүл мэндийн бүх ажилчдыг хамруулах боломжтой болно. Засгийн газрууд төрийн албан хаагчдын цалингийн тухай хууль тогтоомжид өөрчлөлт оруулахаас аль болох зайлсхийх хэрэгтэй. Онцгой байдлын үеийн нэмэлт цалин хөлсийг сар бүр эсвэл улирал тутамд нөхцөл байдалтай уялдуулан олгож шинэчлэн, уян хатан байдлыг хангах ёстой.

3) Шалгахад хялбар байх

Цар тахал гэх мэт Засгийн газрын чадавх хязгаарлагдмал байдалд орсон үед өндөр өртөгтэй хяналт, шалгалт шаардах цалингийн нэмэгдлээс аль болох зайлсхийх хэрэгтэй. Үүнд гүйцэтгэлд суурилсан урамшуулал орох ба учир нь гүйцэтгэлийн орц, гарц, үр дүнг хянаж шалгах нүсэр ажиллагаа шаардлагатай болдог.

4) Тэгш хандах

Дэлхийн банкны гишүүн орнуудад цалин хөлсний бүтэц тэгш бус байдгаас гадна олон оронд энэ нь ил тод бус байна. Ихэнх тохиолдолд ижил ур чадвар, туршлагатай эмнэлгийн ажилтнуудыг субъектив шалгуураар үндэслэн өөр өөрөөр цалинжуулдаг. Хямралын үед энэ ялгааг аль болох багасгахад анхаарах хэрэгтэй бөгөөд эрүүл мэндийн ажилчдад цалингийн хувиар бус нэг удаагийн тэтгэмж хэлбэрээр олговол удирдахад хялбар болдог. Цалингийн нэмэлт хэмжээг тогтоохдоо тооцоо судалгаанд суурилан тогтоох шаардлагатай боловч ихэвчлэн үндсэн цалингийн 20-иос доошгүй хувиар тогтооход тохиромжтой байдаг. Гэсэн хэдий ч ийм нэмэгдлийн хэмжээ хязгаарыг тухайн улс орон төсвийн нөөц бололцоондоо тулгуурлан тодорхойлох ёстой.

## БҮЛЭГ IV. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ЦАЛИН ХӨЛСНИЙ СИСТЕМ: БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

### 4.1. АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС

**Цалингийн тогтолцооны эрх зүйн зохицуулалт**

Эрүүл мэндийн ажилтнуудын цалин хөлс, түүнтэй холбогдон гарах харилцааг “Шударга хөдөлмөрийн стандартын тухай” (Fair Labor Standards Act), “Тэгш цалингийн тухай” (Equal pay Act) болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулж байна.

2019 оны байдлаар АНУ-ын эрүүл мэндийн салбарт 22 сая эмч, ажилтнууд ажилласан байна. Эдгээрээс 9.8 сая нь эмч, хагалгааны эмч болон сувилагчид байна. Эмч нарын цалин хөлсийг хувийн даатгал, улсын даатгал, хувь хүнээс шууд гарах зардлаас санхүүжүүлж байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**Дундаж цалин, шатлал**

Хувийн эмнэлэгт ажиллаж буй эмч нарын дундаж цалин жилд 209.000 ам доллар байна. Энэ нь өмнөх жилтэй харьцуулахад 4.6%-аар нэмэгдсэн дүн юм. Эмчийн цалин байршил болон мэргэшил зэрэг хүчин зүйлсээс шалтгаалан харилцан адилгүй байх ба хамгийн өндөр цалин жилд 616.000 ам доллар байсан байна.

Улсын эмнэлэгт ажиллаж буй эмч нарын цалинг Холбооны засгийн газрын цалингийн сүлжээний Ерөнхий ангилал (General Schedule)-аар цалинжуулах бөгөөд дотроо 15 ангилалтай, ангилал тус бүр 10 шатлалтай байна. Анх ажилд орж буй ажилтан GS-11 ангиллын эхний шатлалаар цалинжих ба 55756 ам долларын үндсэн цалин авч байна. Улсын эмнэлэгт ажиллаж буй эмчийн хамгийн дээд шатлалын үндсэн цалин 143598 ам доллар байна.

Тухайн ажилтныг тогтвор суурьшилтай ажиллуулахын тулд тодорхой хугацаагаар ажиллуулах гэрээ байгуулах бөгөөд 24 сар хүртэл ажилласан ажилтанд үндсэн цалин дээр нэмэлтээр 14000 ам доллар хүртэлх урамшуулал жилд 1 удаа, 24-өөс дээш сар ажилласан ажилтанд 30000 ам доллар хүртэлх урамшууллыг жилд 1 удаа олгоно.[74]

Улсын эмнэлэгт ажиллаж буй сувилагчийн жилийн дундаж цалин 78133 ам доллар байна. Энэ нь өмнөх жилтэй харьцуулахад 3.7%-аар өссөн үзүүлэлт юм. Харин асрагч нарын дундаж цалин 36421 ам доллар байна.[75]

Холбооны засгийн газрын харьяа Хөдөлмөрийн статистикийн товчоо нь тодорхой салбарын улсын болон хувийн хэвшлийн байгууллагад ажиллагсдын цалинг улсын хэмжээнд жил бүр харьцуулан гаргадаг Үндэсний цалин хөлсний судалгаан дээр үндэслэн улсын байгууллагад ажиллаж буй ажилтанд тухайн жилийн цалингийн зөрүүгийн дунджаар үндсэн цалин дээр нэмэгдлийг тооцон олгодог байна.[76]

**Холбооны засгийн газрын цалингийн сүлжээний Ерөнхий ангилал 11-15 (2021 он)**

| Grade | Step 1 | Step 2 | Step 3 | Step 4 | Step 5 | Step 6 | Step 7 | Step 8 | Step 9 | Step 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 11 | 55756 | 57615 | 59474 | 61333 | 63192 | 65051 | 66910 | 68769 | 70628 | 72487 |
| 12 | 66829 | 69057 | 71285 | 73513 | 75741 | 77969 | 80197 | 82425 | 84653 | 86881 |
| 13 | 79468 | 82117 | 84766 | 87415 | 90064 | 92713 | 95362 | 98011 | 100660 | 103309 |
| 14 | 93907 | 97037 | 100167 | 103297 | 106427 | 109557 | 112687 | 115817 | 118947 | 122077 |
| 15 | 110460 | 114142 | 117824 | 121506 | 125188 | 128870 | 132552 | 136234 | 139916 | 143598 |

**Холбооны засгийн газрын цалингийн сүлжээний Ерөнхий ангилал 11-15 дээр орон нутгийн нэмэгдлийг 15.95%-аар нэмж тооцсон дүн (2021 он)**

| Grade | Step 1 | Step 2 | Step 3 | Step 4 | Step 5 | Step 6 | Step 7 | Step 8 | Step 9 | Step 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 11 | 64649 | 66805 | 68960 | 71116 | 73271 | 75427 | 77582 | 79738 | 81893 | 84049 |
| 12 | 77488 | 80072 | 82655 | 85238 | 87822 | 90405 | 92988 | 95572 | 98155 | 100739 |
| 13 | 92143 | 95215 | 98286 | 101358 | 104429 | 107501 | 110572 | 113644 | 116715 | 119787 |
| 14 | 108885 | 112514 | 116144 | 119773 | 123402 | 127031 | 130661 | 134290 | 137919 | 141548 |
| 15 | 128078 | 132348 | 136617 | 140886 | 145155 | 149425 | 153694 | 157963 | 162233 | 166502 |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[74] https://www.federaljobs.net/salarybase.htm#Physicians_Comparibility_Allowan
https://www.law.cornell.edu/uscode/text/5/5948
[75] https://www.federaljobs.net/Occupations/gs-0600-nursing-jobs.htm
https://www.ziprecruiter.com/Jobs/Federal-Government-Nursing
[76] https://federalnewsnetwork.com/all-news/2018/01/better-understand-locality-pay-how-it-works-and-what-it-means-for-your-salary/

**Холбооны засгийн газрын цалингийн сүлжээний Ерөнхий ангилал 11-15-ын үндсэн цагийн хөлс (Basic rates-B) болон илүү цагийн нэмэгдэл хөлс (Overtime-O)**

| Grade | B/O | Step 1 | Step 2 | Step 3 | Step 4 | Step 5 | Step 6 | Step 7 | Step 8 | Step 9 | Step 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 11 | B | 26.72 | 27.61 | 28.50 | 29.39 | 30.28 | 31.17 | 32.06 | 32.95 | 33.84 | 34.73 |
| | O | 36.48 | 36.48 | 36.48 | 36.48 | 36.48 | 36.48 | 36.48 | 36.48 | 36.48 | 36.48 |
| 12 | B | 32.02 | 33.09 | 34.16 | 35.22 | 36.29 | 37.36 | 38.43 | 39.49 | 40.56 | 41.63 |
| | O | 36.48 | 36.48 | 36.48 | 36.48 | 36.48 | 37.36 | 38.43 | 39.49 | 40.56 | 41.63 |
| 13 | B | 38.08 | 39.35 | 40.62 | 41.89 | 43.15 | 44.42 | 45.69 | 46.96 | 48.23 | 49.50 |
| | O | 38.08 | 39.35 | 40.62 | 41.89 | 43.15 | 44.42 | 45.69 | 46.96 | 48.23 | 49.50 |
| 14 | B | 45.00 | 46.50 | 48.00 | 49.50 | 51.00 | 52.49 | 53.99 | 55.49 | 56.99 | 58.49 |
| | O | 45.00 | 46.50 | 48.00 | 49.50 | 51.00 | 52.49 | 53.99 | 55.49 | 56.99 | 58.49 |
| 15 | B | 52.93 | 54.69 | 56.46 | 58.22 | 59.98 | 61.75 | 63.51 | 65.28 | 67.04 | 68.81 |
| | O | 52.93 | 54.69 | 56.46 | 58.22 | 59.98 | 61.75 | 63.51 | 65.28 | 67.04 | 68.81 |

## 4.2. ИЗРАИЛ УЛС

### Эрүүл мэндийн ажилтан, албан хаагч

2018 оны байдлаар 38.523 тусгай зөвшөөрөлтэй эмчээс 5,052 нь (13%) ерөнхий мэргэжлийн эмч байна. Энэ нь Израилийн нэг хүнд ногдох ерөнхий эмчийн тоо дунджаар 1000 хүнд 0.6 эмч ногдох бөгөөд бүс нутаг, эрүүл мэндийн төлөвлөгөөнөөс хамаарч харилцан адилгүй байдаг. Израилийн эмч, сувилагч нь эрүүл мэндийн план буюу тус сангаас цалинждаг бөгөөд өвчтөнөөс нэмэлт төлбөр авдаггүй.

### Цалин хөлсний систем

Олон нийтэд түшиглэсэн үйлчилгээ (Community-based services): Клалит (Clalit) клиникт суурилсан эмч нарын цалинг Израилийн эрүүл мэндийн нийгэмлэг (Israel Medical Association)-тэй байгуулсан хамтын хэлэлцээрээр тогтоодог бөгөөд эрүүл мэндийн планд хамрагдаж буй нэг эмчид ногдох өвчтөний тооноос хамаарч цалинждаг.

Клалит, Леймит нар нь идэвхгүй өвчтөн (passive capitation) буюу тухайн эрүүл мэндийн планд хамаарч байгаа даатгуулагч нь тухайн улиралд ерөнхий эмчид үзүүлсэн эсэхээс үл хамааран нэг даатгуулагчид ногдох төлбөрийг улирал бүр авдаг.

Маккаби, Меухедит нар нь идэвхтэй өвчтөн (active capitation) буюу улиралд дор хаяж нэг удаа ерөнхий эмчид үзүүлсэн даатгуулагчийн тоогоор төлбөрийг улирал тутам авна. Бие даан үйлчилгээ үзүүлдэг эмч нарын хувьд тодорхой журмын дагуу үйлчилгээний төлбөрийн хязгаарлагдмал төлбөр авах бөгөөд гэрээгээр зохицуулдаг. Эрүүл мэндийн үйлчилгээний чанартай холбоотой санхүүгийн урамшууллын систем ашигладаггүй.

*Эмнэлгийн үйлчилгээ:* Улсын эмнэлэг болон ашгийн бус эмнэлгүүдэд (non-profit-making hospitals) эмч нар тогтмол цалинтай ажилладаг бөгөөд ихэнх эмнэлгүүдийн хувьд цалин хөлсний нөхцөлийг хамтын гэрээгээр зохицуулдаг. Цалингийн түвшин нь албан тушаал (resident, board-certified specialist, department chair, etc.)-ын болон ажилласан жилээс хамаардаг.

Эрүүл мэндийн яамны зарим эмч (ихэвчлэн мэс засалч) нар илүү цагийн хөлс олгож болох бөгөөд илүү цагийн хөлсийг цагаар эсвэл ажилбарын процесс бүрээр тооцож олгоно. Клалит түвшний эмнэлэгт мөн төстэй зохицуулалт байдаг.

*Нэмэгдэл, урамшуулал:* 2011 онд хөдөө, орон нутагт ажиллаж, амьдарч байгаа эмч нарыг урамшуулах, дэмжих зорилгоор хязгаар нутгийн (алслагдсан хөдөө, орон нутагт ажиллаж байгаа эмч, эмнэлгийн ажилтнуудад олгох нэмэгдэл) нэмэгдлийг олгохоор шийдвэрлэсэн бөгөөд 2013 оноос 25 хувийн нэмэгдэл олгож байна. Мөн зөвлөлийн гэрчилгээтэй эмч нар 17 хувийн нэмэгдэл авна.

Мөн хязгаар нутагт ажиллаж буй эмч нарт нэг удаагийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх бөгөөд энэ нь хүүгүй зээлийн хэлбэртэй байх ба тодорхой хугацаанд хязгаар нутагт ажилласан нөхцөлд буцааж төлөхгүйгээр буцалтгүй тусламж болгон хувиргадаг. Энэхүү тусламжийн хэмжээ нь мэргэжлээс хамаарч харилцан адилгүй байх бөгөөд ойролцоогоор 75-125.000 мянган евро байдаг.

### 4.3. ШИНЭ ЗЕЛАНД УЛС

Эмч, эрүүл мэндийн ажилтнуудын цалин хөлс, түүнтэй холбогдон гарах харилцааг Хөдөлмөрийн харилцааны тухай (Employment Relations Act 2000), Цалин хөлсийг хамгаалах тухай (Wages Protection Act 1983), Эмнэлгийн асрамж, үйлчилгээ үзүүлэх ажилтнуудын цалин хөлс тогтоох тухай (Care and Support Worker (Pay equity) Settlement Act 2017)[77] хууль болон холбогдох бусад хууль тогтоомжуудаар зохицуулж байна.

***Эрүүл мэндийн байгууллагын ажилтан, албан хаагч:***

Эрүүл мэнд, нийгмийн тусламжийн салбарт одоогийн байдлаар 253.000 гаруй ажилтнууд алба хааж байна. Энэ нь 2011 онд 209.000 орчим байснаас хойш тогтмол өссөн үзүүлэлт юм. 2019 оны байдлаар 100.000 хүнд 6371 эрүүл мэндийн ажилтан, 344.7 эмч ногдож байна.

**Цалин хөлсний систем**

Дүүргийн эрүүл мэндийн зөвлөлүүдэд хуваарилагдсан төсвийн ойролцоогоор тэн хагасыг ажилчдын цалинд зарцуулдаг байна. 2019 оны байдлаар эрүүл мэнд, нийгмийн тусламжийн ДНБ-ний 45%, нийт ДНБ-ний 2%-ийг Дүүргийн эрүүл мэндийн зөвлөлийн харьяа эмнэлгийн эмч, ажилтнуудын цалинд зарцуулсан байна.[78]

*Эмчийн цалин:* Дүүргийн эрүүл мэндийн зөвлөл, Эмнэлгийн мэргэжилтнүүдийн холбооноос хамтран гаргасан гэрээнд зааснаар 1 (доод)-ээс 15 (дээд) хүртэлх цалингийн шатлалаар жилийн үндсэн дундаж цалин эхний шатлалд 163.000 NZD-оос эхлэх ба 15 дугаар шатлалд 240.000 NZD байна. Суурь цалин дээр мэргэшил, ажлын туршлага буюу ажилласан жил, ур чадвар, бүсийн нэмэгдэл болон гүйцэтгэлийн нэмэгдэл зэрэг нэмэгдлүүдийг тооцож олгоно. Бүсийн нэмэгдэл нь тухайн орон нутгаасаа хамааран жилийн 7.383 NZD-аас 15.408 NZD байна. Мэргэшил дээшлүүлэх сургалтанд хамрагдсан тохиолдолд сургалтын зардалд жилийн 16.000 NZD хүртэлх хөнгөлөлтийг үзүүлнэ.[79]

[77] https://www.health.govt.nz/new-zealand-health-system/pay-equity-settlements/care-and-support-workers-pay-equity-settlement
[78] https://www.health.govt.nz/system/files/documents/publications/cost-value-employment-health-disability-sector-25nov2020.pdf
[79] https://www.asms.org.nz/wp-content/uploads/2019/11/BERL-Report-Final-November.pdf

**Эмч нарын үндсэн дундаж цалин (шатлалаар)**

| ***Шатлал*** | ***Цалин (NZD)*** |
|---|---|
| ***1*** | *163.598* |
| ***2*** | *167.902* |
| ***3*** | *173.283* |
| ***4*** | *178.665* |
| ***5*** | *184.047* |
| ***6*** | *189.428* |
| ***7*** | *194.809* |
| ***8*** | *200.192* |
| ***9*** | *205.573* |
| ***10*** | *210.957* |
| ***11*** | *216.536* |
| ***12*** | *224.143* |
| ***13*** | *230.735* |
| ***14*** | *236.820* |
| ***15*** | *243.412* |

*Сувилагч, эх баригч сувилагчийн цалин*[80]

Шинэ Зеланд Улсад энгийн сувилагч нар 1 (доод)-ээс 7 (дээд) хүртэл шатлалаар цалинжиж байна. Сургуулиа төгсөөд Дүүргийн эрүүл мэндийн зөвлөлийн харьяа эмнэлэгт шинээр ажилд орж буй сувилагч эхний жилдээ жилийн 54.034 NZD-ийн 1-р шатлалын үндсэн цалин авна. Шатлал ахисаар 7-р шатлалд хүрсэн сувилагч жилийн 77.386 NZD-ийн үндсэн цалингаар цалинжина. Сувилагч шатлал ахихад сувилагч, эх баригчийн ажлын туршлага, тухайн мэргэшлийн ур чадвар нөлөөлнө. 5-7 дугаар шатлал руу ахихад дээрх шаардлагуудыг хангасан байх шаардлагатай хийгээд өмнөх шатлалдаа доод тал нь 12 сар ажилласан байх шаардлагатай байна. (Хүснэгт 2)

**Сувилагч, эх баригчийн үндсэн цалин** *(NZD)*

| Шатлал | Үндсэн цалин |
|---|---|
| 7 | 77.386 |
| 6 | 75.132 |
| 5 | 72.945 |
| 4 | 65.652 |
| 3 | 62.138 |
| 2 | 58.491 |
| 1 (Шинээр ажилд орсон) | 54.034 |

**Асрагчийн үндсэн цалин (NZD)**

| Шатлал | Үндсэн цалин |
|---|---|
| 5 | 48.003 |
| 4 | 46.605 |
| 3 | 45.779 |
| 2 | 42.910 |
| 1 | 40.382 |

**Ахлах сувилагчийн үндсэн цалин (NZD)**

| Зэрэглэл | Үндсэн цалин |
|---|---|
| 2 | 79.760<br>81.322<br>85.375 |
| 3 | 86.887<br>90.230<br>96.378 |
| 4 | 91.899<br>95.241<br>101.541 |
| 5 | 96.910<br>100.256<br>106.703 |
| 6 | 100.256<br>103.596<br>110.146 |
| 7 | 103.596<br>106.938<br>112.389 |
| 8 | 109.116<br>115.026<br>1206938<br>1306653 |

UIH MN СУДАЛГААНЫ САН

Ахлах сувилагч болон эх баригч сувилагчийн цалин нь 2 (доод)-оос 8 (дээд) хүртэлх зэрэглэлтэй. Зэрэглэл бүр дотроо 3 шатлалт цалинтай байна. 2-р зэрэглэлийн сувилагчийн эхний шатлалын жилийн үндсэн цалин 79.760 NZD, хамгийн өндөр буюу

[80] https://careers.adhb.govt.nz/assets/Documents/MECAs/NZNO-Nursing-and-Midwifery-Multi-Employer-Agreement.pdf

8-р зэрэглэлийн Ахлах сувилагчийн дээд шатлалын жилийн үндсэн цалин 130.653 NZD байна. Зэрэглэл ахихад ажилтны ур чадвар, ажлын гүйцэтгэлийг харгалзахын сацуу өмнөх зэрэглэлд доод тал нь 1 жилийн хугацаатай ажилласан байх шаардлагатай байна. (Хүснэгт 3)

*Асрагчийн цалин* (Health Care Assistant and Hospital Aid)

Асрагч нар 1 (доод)-ээс 5 (дээд) хүртэл шатлалаар цалинжиж байна. 1-р шатлалын жилийн үндсэн цалин 40.382 NZD байгаа бол хамгийн дээд буюу 5-р шатлалын цалин жилдээ 48.003 NZD байна. 5 дугаар шатлал руу ахихад тухайн асрагч өмнөх 4 дүгээр шатлалдаа доод тал нь 12 сар ажилласан байх шаардлагатай байна. (Хүснэгт 4)

*Сувилагч, асрагчийн үндсэн цалин дээр тооцож олгох нэмэгдэл:* Үндсэн цалин дээр илүү цагийн хөлс, ээлжинд гарсны нэмэгдэл, хоол, унааны төлбөр зэргийг нэмж тооцож байна.

Энгийн өдөр илүү цагаар ажилласан бол тухайн ажилтны цагийн хөлсийг эхний 3 цагт 1.5-аар үржүүлж тооцно. 4 дэх цагаас эхлэн цагийн хөлсийг 2-оор үржүүлж тооцно. Амралтын өдөр болон баярын өдрүүдээр ажилласан бол цагийн хөлсийг 2-оор үржүүлж тооцно. Сувилагч нар ээлжиндээ 8-10 цаг ажилладаг бөгөөд үргэлжлүүлэн ажиллуулах шаардлагатай тохиолдолд дараалсан 12 цагаас илүү цаг ажиллуулж болохгүй.

Ажилтан дуудагдаж ажилласан тохиолдолд энгийн өдөр цагийн 8 NZD, баяр ёслолын өдрүүдэд цагийн 10 NZD үндсэн цалин дээр нэмж тооцогдоно.

Өөрийн хариуцсан ажлаас дээд шатлалын ажил гүйцэтгэсэн тохиолдолд одоогийн байгаа шатлал болон дээд шатлалын 1 цагийн цалингийн зөрүүг үндсэн цалин дээр нэмж тооцно.

Ээлжээ дуусcаны дараа 1-ээс илүү цаг ажилласан тохиолдолд 7.95 NZD-ыг хоолны мөнгөнд тооцож олгох ба эсхүл эмнэлгээс хоол олгоно. Ажлын журмаар гадуур ажилласан тохиолдолд унааны зардлыг олгоно.

## 4.4. ЯПОН УЛС

### Эрх зүйн зохицуулалт

Япон Улсын төрийн албаны хуульд зааснаар төрийн албан хаагчийг ерөнхий болон тусгай гэж хоёр ангилдаг бөгөөд Улсын эмнэлгийн ажилтнууд нь төрийн ерөнхий албан хаагчид хамаарч байна. Эмнэлгийн ажилтнуудын цалин хөлсний харилцааг Хөдөлмөрийн стандартын хууль (Labor Standards Act)[81], Төрийн албаны хууль (National Public Service Act)[82], Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хууль (Minimum Wage Act)[83]-аар тус тус зохицуулжээ.

*Эрүүл мэндийн байгууллагын ажилтан, албан хаагч:* Япон Улсын нийт төрийн албан хаагчдын 641,000 нь улсын, 2,860,000 нь орон нутгийн төрийн байгууллагад ажиллаж байна. Үүнээс 327,000 гаруй нь эмч ажиллаж байгаа бөгөөд 100,000 хүн тутамд 256 эмч ногдож байна. Нийт эмнэлгийн 15 хувь нь улсын болон орон нутгийн төсөвт, харин үлдсэн нь хувийн болон ашгийн бус эмнэлгийн байгууллага байдаг. Ашгийн бус эмнэлгийн байгууллагын зарим нь олон нийтийн үүрэг гүйцэтгэгчээр томилогдсон байдаг тул төсвөөс татаас авдаг. Тус улсад одоогийн байдлаар 8,300 эмнэлэг үйл ажиллагаа явуулж байна.

[81] https://www.ilo.org/dyn/natlex/docs/WEBTEXT/27776/64846/E95JPN01.htm
[82] http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail_main?re=&vm=02&id=2713
[83] http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?id=2420&vm=2&re=02

*Цалингийн талаар зөвлөмж гаргадаг байгууллага*[84]

Япон Улсын Үндэсний боловсон хүчний газар (National Personnel Authority) нь Парламентын зөвшөөрөл болон Засгийн газрын тогтоолоор байгуулагддаг бие даасан хараат бус байгууллага юм. Тус байгууллага нь төрийн албан хаагчдын цалин хөлсний талаар зөвлөмж хүргүүлэн уг зөвлөмжийн дагуу цалин хөлсний хууль, журамд нэмэлт өөрчлөлт оруулдаг болно.

**Цалин хөлсний систем**

Хөдөлмөрийн стандартын хуульд зааснаар цалин хөлс нь ажил олгогчоос ажилтанд олгосон цалин, тэтгэмж, урамшуулал болон бусад нэмэлт төлбөрийг хэлнэ. Эмнэлгийн ажилчид үндсэн цалин, нэмэгдэл, урамшуулал авдаг.

*Тооцох арга:* [Үндсэн цалин + тогтмол тэтгэмж + гүйцэтгэлд суурилсан урамшуулал (Шагналаас бусад)] - [нийгмийн даатгалын шимтгэл ] - [татвар (орлогын албан татвар, байнгын оршин суугчийн албан татвар)].

*Цалингийн бүтэц:*[85] үндсэн цалин + тогтмол тэтгэмж + гүйцэтгэлийн урамшуулал

*Тогтмол тэтгэмж:*

- Амьжиргааны зардалд туслах тэтгэмж: Гэр бүлийн тэтгэмж, орон сууцны тэтгэмж, унааны тэтгэмж, гэр бүлийн хараа хяналтгүйн тэтгэмж;
- Ажиллах газрын тэтгэмж: өөр газар шилжүүлэн ажиллуулах тэтгэмж, алсын бүсийн тэтгэмж, ажлын хүнд нөхцөлийн тэтгэмж;
- Үүрэг хариуцлагын тэтгэмж: Удирдлагын тэтгэмж, удирдах ажилтнуудад зориулсан баярын тусгай тэтгэмж;
- Илүү цагаар ажилласны тэтгэмж: Илүү цагийн тэтгэмж, өдөр / шөнийн жижүүрийн тэтгэмж;
- Бусад тэтгэмж.

*Гүйцэтгэлийн урамшуулал:*

- *Хувь хүний гүйцэтгэлд суурилсан урамшуулал*
- *Баярын / жилийн төгсгөлийн урамшуулал зэрэг орно.*

*Эмч, сувилагчийн цалин 2021 оны байдлаар*[86] Үүнд орон сууц, унаа болон бусад тэтгэмжийг багтаасан болно. Эрүүл мэндийн салбарын цалин хөлс бусад ажлын байрны цалин хөлснөөс 49%-аар илүү байна.

| Цалин хөлсний хэмжээ | Доод цалин (иен) | Дундаж цалин (иен) | Өндөр цалин (иен) |
|---|---|---|---|
| Эмч | 495,000 | 1,350,000 | 2,280,000 |
| Сувилагч | 189,00 | 403,000 | 636,00 |

*Ажилласан жилийн нэмэгдэл*

- 2-5 жил ажилласан бол 34%
- 5-10 жил ажилласан бол 36%
- 10-15 жил ажилласан бол 21%
- 15-20 жил ажилласан бол 14%
- 20-оос дээш жил ажилласан бол 9%-аар тус тус өмнөх жил дээрээ нэмэгдэнэ.

84 https://www.jinji.go.jp/en/
85 https://www.oecd.org/gov/pem/48668483.pdf
86 http://www.salaryexplorer.com/salary-survey.php?loc=1212&loctype=3&job=13&jobtype=2

UIH.MN СУДАЛГААНЫ САН

*Эмнэлгийн ажилтны цагийн дундаж цалин*

Цагийн цалин = жилийн цалин ÷ (52(долоо хоног) x 5(ажлын өдөр) x 8(ажлын цаг)) энэ аргаар бодож гаргана. Эмнэлгийн ажилтны цалин хөлс бусад ажлын байрны цалин хөлснөөс 49%-р илүү байна.

### 4.5. ПЕРУ УЛС

**Эрүүл мэндийн салбарын цалин хөлсний бодлого, эрх зүйн орчин, тогтолцоо**

Эмнэлгийн байгууллагын ажилчдын цалин хөлсийг Хөдөлмөр эрхлэлтийн тухай хууль (Employment Law)[87], Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хууль(Minimum Wage Act)[88], Эрүүл мэндийн даатгалын хууль(Universal Health Insurance law)-аар тус тус зохицуулж байна.

*Эрүүл мэндийн байгууллагын ажилтан албан хаагч:* Эрүүл мэндийн байгууллагуудын 97 орчим хувь нь хот суурин газарт, 3 хувь нь хөдөө орон нутагт байрладаг. Нийт эмнэлгийн орны 50% нь ЭМЯ-ны эмнэлгүүдэд, 20.7% нь зэвсэгт хүчинд, 21.6% нь хувийн хэвшилд харьяалагддаг байна. Нийт 180,000 эрүүл мэндийн ажилтнаас эмч нар 17%, сувилагч 16%, эх баригчид 3%, шүдний эмч 7%, техникч ба туслахууд 36%, администраторууд 16%-ийг эзэлж байна. 10,000 хүн тутам 11 эмч, 14 сувилагч ногдож байна.

Цалин хөлсний бүтэц[89]

Эмнэлгийн ажилчдын цалин хөлс нь үндсэн цалин, тэтгэмж, урамшууллаас бүрдэнэ.

Тэтгэмж

- Хоол унааны мөнгө
- Боловсролын тэтгэмж
- Гэр бүлийн тэтгэмж
- Онцгой тэтгэмж (ур чадвараас хамаарч авсан шагнал урамшуулал)

Урамшуулал

- Баярын өдөр
- Шөнийн ээлж
- Ням гаригийн амралтын өдрийн ээлж
- Ням гаригийн амралтын шөнийн ээлжинд гарснаас хамаарч урамшуулал олгодог.

*Ажилласан жилийн нэмэгдэл*[90]

Эмчийг ажилласан жилээр нь 5 түвшинд хуваадаг.

- 1-р түвшин - 5 хүртэлх жил ажилласан бол 29%
- 2-р түвшин - 5 жил, 1 өдрөөс 10 жил хүртэл ажилласан бол 38%
- 3-р түвшин - 10 жил, 1 өдрөөс 15 жил хүртэл ажилласан бол 24%
- 4-р түвшин - 15 жил, 1 өдрөөс 20 жил хүртэл ажилласан бол 7%
- 5-р түвшин - 20 гаруй жил ажилласан бол 7%-аар өмнөх жил дээрээ нэмэгдэнэ.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

[87] https://www.bizlatinhub.com/what-are-the-employment-laws-in-peru/
[88] https://tusalario.org/peru/ley-laboral/trabajo-y-salarios
[89]https://www.who.int/alliancehpsr/projects/alliancehpsr_healthworkersalaries_bitran_finalreport.pdf
[90] https://www.salaryexpert.com/salary/job/medical-doctor/peru/lima

*Эмчийн цалин*

| | Жил (доллар) | Сар (доллар) | Цаг (доллар) |
|---|---|---|---|
| Өндөр цалин | 162,207 | 11,485 | 69,99 |

*Сувилагчийн цалин*[91]

2021 оны 6-р сарын 28-ны байдлаар Перуд нэг сувилагчийн жилийн дундаж цалин жилд 47630 доллар байна. Цагт ойролцоогоор 22.90 долларын цалинтай болно. Энэ нь долоо хоногт 916 доллар буюу сард 3,969 доллартай тэнцэх юм.

| | Жил (доллар) | Сар (доллар) | Цаг (доллар) |
|---|---|---|---|
| Өндөр цалин | 74,882 | 6240 | 36 |
| Цалингийн 75 хувь | 60,250 | 5,020 | 29 |
| Дундаж цалин | 47,630 | 3,969 | 23 |
| Цалингийн 25 хувь | 37,441 | 3,120 | 18 |

## 4.6. БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН УЛС

### Эрүүл мэндийн салбарын цалин хөлсний бодлого, эрхзүйн орчин, тогтолцоо

Казахстан Улсын эрүүл мэндийн салбар /ЭМС/ нь 2018 оноос эхлэн заавал даатгуулах эрүүл мэндийн даатгалын тогтолцоог нэвтрүүлж, эрүүл мэндийн салбарын байгууллагуудад олгох санхүүжилтийг тухайн байгууллагын үзүүлсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд ногдох тарифт тулгуурлан Нийтийн эрүүл мэндийн даатгалын сангаас олгодог болсон. Ингэснээр ЭМС-ын байгууллагуудыг аж ахуйн тооцоонд шилжүүлж эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, салбарын ажилтнуудын цалин хөлс, урамшууллыг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн.

Казахстан Улсын “Эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх төрийн бодлого 2020-2025” хөтөлбөрийн хүрээнд эрүүл мэндийн салбарын ажилтны цалин хөлсний талаарх дор дурдсан бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тусгажээ.

1. ЭМС-ын үйлчилгээний чанарыг дээшлүүлэх бодлогын хүрээнд эмч, мэргэжилтнүүдийн цалинг 2023 онд эдийн засаг дахь дундаж цалингийн 180%-д хүргэх. (өөрөөр хэлбэл эдийн засаг дахь дундаж цалингаас 80% өндөр байх).
2. ЭМС-ын хүний нөөцийг сайжруулах бодлогын хүрээнд ЭМС-ын мэргэжлийн нэр хүндийг өсгөн, ажилтнуудын цалингийн хэмжээг нэмэх. 2025 онд ЭМС-ын цалинг 550,000 тенгед хүргэх.
3. Заавал даатгах эрүүл мэндийн даатгалын системийг улам гүнзгийрүүлэн нэвтрүүлэх, сайн дурын эрүүл мэндийн даатгалыг урамшуулах бодлогын хүрээнд эрүүл мэндийн даатгалын сангаас олгох санхүүжилтийн тарифын тооцоонд ЭМС-ын ажилтнуудын цалингийн өсөлтийн зардлыг нэмж тусгах.
4. ЭМ-ийн байгууллагуудыг аж ахуйн тооцоонд шилжүүлэн сайн засаглалыг хэрэгжүүлснээр ЭМС-ын ажилтнуудын цалингийн тогтолцоог ил тод, шилэн болгох. Эрүүл мэндийн байгууллагуудад ажилтнуудынхаа цалин, урамшууллыг хамтын хэлэлцээрийн хүрээнд тогтоох эрхийг олгоно.

Казахстаны ЭМС-ын цалингийн хэмжээг тогтоохдоо дор дурдсан эрх зүйн актыг баримталдаг.

[91] https://www.ziprecruiter.com/Salaries/Nurse-Salary-in-Peru,IN

UIH.MN СУДАЛГААНЫ САН

- Засгийн газрын 2015 онд баталсан “Төсвийн байгууллага болон төсвөөс санхүүждэг аж ахуйн нэгжүүдийн ажилтны хөдөлмөрийн хөлсний тогтолцооны тухай” 1193 тоот тогтоол.
- Хөдөлмөрийн тухай хууль
- Төрийн өмчийн тухай хууль
- Засгийн газрын 1999 оны 1930 тоот тогтоол (Хөдөлмөрийн хүнд болон хортой нөхцөл шаардсан ажил мэргэжлийн жагсаалт)
- 2021 онд байгуулагдсан 2020-2022 онд мөрдөгдөх Эрүүл мэндийн яам, ЭМС-ын ҮЭ, Үндэсний эрүүл мэндийн танхимын хамтарсан нэмэлт хэлцэл.
- 2020 онд гарсан Эрүүл мэндийн сайдын тушаал (Эрүүл мэндийн салбар дахь төрийн байгууллагуудын ажилтнуудын хөдөлмөрийн хөлсийг тооцох тухай)
- Байгууллагын хамтын гэрээ
- Ажил олгогчоос тогтоосон бусад эрх зүйн акт

ЭМС-ын цалинг тогтоохдоо тус салбарын мэргэжилтнүүдийг 3 бүлэгт ангилах бөгөөд ангилал бүр нь 4 зэрэгтэй.

1. Нэгдүгээр ангилал буюу **B2** – Энэ ангилалд үндсэн орон тооны мэргэжилтэн болох дээд боловсролын мэргэшсэн мэргэжилтэн буюу мэргэшсэн их эмч нар хамрагдана. Дотроо “дээд зэрэглэл”, “I зэрэглэл”, “II зэрэглэл ” болон “зэрэглэлгүй” гэсэн 4 зэрэгт хуваагдана.
2. Хоёрдугаар ангилал буюу **B3** – Энэ ангилалд үндсэн орон тооны мэргэжилтэн болох дээд боловсролын дунд түвшний мэргэшсэн мэргэжилтэн буюу ердийн эмч болон мэргэшилтнүүд хамрагдана. Дотроо “дээд зэрэглэл”, “I зэрэглэл”, “II зэрэглэл ” болон “зэрэглэлгүй” гэсэн 4 зэрэгт хуваагдана.
3. Гуравдугаар ангилал буюу **B4** – Энэ ангилалд үндсэн орон тооны дунд түвшний эрүүл мэндийн ажилчид (сувилагч г.м) хамрагдана. Дотроо “дээд зэрэглэл”, “I зэрэглэл”, “II зэрэглэл ” болон “зэрэглэлгүй” гэсэн 4 зэрэгт хуваагдана.

ЭМС-ын цалин хөлс нь ажилтны мэргэжлийн түвшин, ур чадвар, ажилласан жил, хийсэн ажлын үр дүн, сахилга бат, албан тушаал зэргээс хамааран тогтоогддог.

Цалингийн хэмжээ нь тухайн мэргэжлийн цалингийн доод хэмжээнээс багагүй байх ба энэ цалингийн доод хэмжээг БНКазУ-ын муж бүр харилцан адилгүй хэмжээгээр тогтоодог.

Аж ахуйн тооцоонд шилжсэн ЭМС-ын байгууллагууд нь Засгийн газраас тогтоосон цалингийн хэмжээг мөрдөлгүйгээр өөрсдөө бие дааж цалин хөлс, урамшууллаа тогтоох боломжтой.

**ЭМС-ын цалин хөлсний бүтэц, бүрэлдэхүүн**

Казахстан Улсын ЭМС-ын эмч мэргэжилтнүүдийн цалингийн дундаж хэмжээ нь мэргэжлээсээ шалтгаалан 101,0 –117,0 мянган тенге байна. Харин сувилагч нарын цалингийн хэмжээ нь 76,3 мянган тенге болж байна. Засгийн газын шийдвэрээр 2021 оны 7-р сараас эхлэн ЭМС-ын ажилтнуудын цалинг нэмэх шийдвэр гаргасан бөгөөд ингэснээр эмч нарын цалин 131,2 – 152,0 мянган тенге, сувилагч нарын цалин 99,3 мянган тенге болохоор байна.

Эмч нараас мэс заслын эмч нар хамгийн өндөр цалинтай буюу дунджаар 200,0 – 446,0 мянган тенге байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

ЭМС-ын цалин хөлс нь дор дурдсан 3 бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ.

- үндсэн цалин
- цалингийн нэмэгдэл
- урамшууллаас бүрдэнэ.

1. <u>Үндсэн цалин хөлс</u>

Үндсэн цалинг “хөдөлмөрийн хөлсний суурь үнэлгээ” болон “ажил мэргэжлийн коэффициент” гэсэн 2 үзүүлэлтэнд тулгуурлан тогтооно.

**Үндсэн Цалин** = **Хөдөлмөрийн хөлсний суурь үнэлгээ** x **Коэффициент**

**Хөдөлмөрийн хөлсний суурь үнэлгээг** Засгийн газар тогтоох ба өнөөдрийн байдлаар **17’697** тенгетэй тэнцүү байна.

**Ажил мэргэжлийн коэффициентийг** Эрүүл мэндийн салбарын мэргэжилтнүүдийн ангилал, зэрэг, ажилласан жилээс хамааруулан тогтохх бөгөөд үүнийг “Төсвийн байгууллага болон төсвөөс санхүүждэг аж ахуйн нэгжүүдийн ажилтны хөдөлмөрийн хөлсний тогтолцооны тухай” Засгийн газрын тогтоолын хавсралт 5-д заасан байдаг.

| | Зэрэг | Мэргэжлээрээ ажилласан жил | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 0-1 | 1-2 | 2-3 | 3-5 | 5-7 | 7-10 | 10-13 | 13-16 | 16-20 | 20-25 | 25-аас дээш |
| B2 | 1 | 4,67 | 4,74 | 4,81 | 4,88 | 4,95 | 5,01 | 5,08 | 5,16 | 5,24 | 5,32 | 5,41 |
| | 2 | 4,39 | 4,50 | 4,57 | 4,65 | 4,72 | 4,79 | 4,86 | 4,95 | 5,03 | 5,12 | 5,20 |
| | 3 | 4,36 | 4,44 | 4,51 | 4,59 | 4,66 | 4,74 | 4,81 | 4,90 | 4,99 | 5,08 | 5,16 |
| | 4 | 4,10 | 4,14 | 4,19 | 4,23 | 4,27 | 4,33 | 4,38 | 4,49 | 4,59 | 4,67 | 4,73 |
| B3 | 1 | 4,13 | 4,18 | 4,24 | 4,29 | 4,36 | 4,42 | 4,49 | 4,55 | 4,62 | 4,69 | 4,75 |
| | 2 | 3,85 | 3,91 | 3,97 | 4,03 | 4,09 | 4,16 | 4,23 | 4,30 | 4,37 | 4,44 | 4,51 |
| | 3 | 3,82 | 3,88 | 3,94 | 4,00 | 4,07 | 4,14 | 4,21 | 4,28 | 4,36 | 4,43 | 4,50 |
| | 4 | 3,52 | 3,58 | 3,64 | 3,71 | 3,78 | 3,85 | 3,94 | 4,00 | 4,06 | 4,12 | 4,19 |
| B4 | 1 | 3,95 | 3,99 | 4,05 | 4,11 | 4,16 | 4,22 | 4,28 | 4,34 | 4,40 | 4,45 | 4,52 |
| | 2 | 3,73 | 3,79 | 3,85 | 3,92 | 3,97 | 4,04 | 4,10 | 4,17 | 4,25 | 4,32 | 4,39 |
| | 3 | 3,67 | 3,73 | 3,79 | 3,85 | 3,91 | 3,97 | 4,03 | 4,09 | 4,16 | 4,22 | 4,29 |
| | 4 | 3,32 | 3,36 | 3,41 | 3,45 | 3,49 | 3,53 | 3,57 | 3,61 | 3,65 | 3,69 | 3,73 |

Засгийн газрын тогтоолоор эрүүл мэндийн салбарын ажилтнуудын цалинг нэмэгдүүлэх зорилгоор цалингийн нэмэгдлийн коэффициентийг тогтоож өгсөн.

| | **B2 ангилалд** | **B3 ба B4 ангилалд** |
|---|---|---|
| **2021.01.01-ээс** | 2,02 | 1,63 |
| **2022.01.01-ээс** | 2,63 | 1,95 |
| **2023.01.01-ээс** | 2,73 | 2,05 |

Жишээ :

A. 15 жил ажилласан I зэрэглэлийн дээд боловсролын мэргэшсэн эмчийн үндсэн цалин (B2 ангиллын 2 зэрэг)
Хөдөлмөрийн хөлсний суурь үнэлгээ - 17 697 тенге
Цалингийн доод хэмжээ - 42 500 тенге
Ажил мэргэжлийн коэффициент - 4.95
Үндсэн цалин - 17697 x 4.95 = 87 600

UIH.MN СУДАЛГААНЫ САН

2021 оны цалингийн нэмэгдэл коэффициент - 2.02
2021 оны үндсэн цалин нь 87600 x 2.02 = **176 952 тенге**

B. 11 жил ажилласан дээд зэрэглэлийн дунд түвшний эрүүл мэндийн ажилтан болох сувилагчийн үндсэн цалин (В4 ангилалын 1 зэрэг)
Хөдөлмөрийн хөлсний суурь үнэлгээ - 17 697 тенге
Ажил мэргэжлийн коэффициент - 4.28
Үндсэн цалин - 17697 x 4.28 = 75743
2021 оны цалингийн нэмэгдэл коэффициент - 2.02
2021 оны үндсэн цалин нь 75743 x 1.63 = **123 461** тенге

2. <u>Цалингийн нэмэгдэл</u>

Эрүүл мэндийн ажилтнууд нь Засгийн газар, тухайн эрүүл мэндийн байгууллагын хүрээнд тогтоосон цалингийн нэмэгдэл авдаг. Эрүүл мэндийн ажилтнуудын цалингийн нэмэгдлийг “Төсвийн байгууллага болон төсвөөс санхүүждэг аж ахуйн нэгжүүдийн ажилтны хөдөлмөрийн хөлсний тогтолцооны тухай” Засгийн газрын тогтоолын хавсралт 5, 18, 19, 21-д заасан. Дор дурдсан цалингийн нэмэгдлүүд байдаг.

- Албан тушаалтай хавсран гүйцэтгэсэн ажлын нэмэгдэл
- Хортой, хүнд нөхцөлтэй ажлын байрны болон биеийн хүч шаардсан ажлын нэмэгдэл
- Онцгой нөхцөлийн нэмэгдэл
- Орон нутагт ажилласны нэмэгдэл (цалингийн 25%-аас доошгүй)
- Сэтгэлзүйн дарамт болон биеийн ачааллалтай ажилласны нэмэгдэл
- Салбар нэгжид ажилласны нэмэгдэл
- Оройн цаг, амралтын өдөр, бүх нийтийн амралтын өдөр ажилласны нэмэгдэл
- Бусдын ажлыг хавсран гүйцэтгэсний нэмэгдэл
- Албан тушаалын зэрэглэлийн (ахлах сувилагч г.м)
- Эрдмийн зэргийн нэмэгдэл
- Төрийн одон, шагналын нэмэгдэл
- Бусад нэмэгдэл

Цалингийн нэмэгдлийг дор дурдсан цалин хөлснөөс тодорхой хувь хэмжээгээр бодож олгоно.

- Үндсэн цалин эсвэл тооцсон цагийн хөлс – 20%-аас 60%
- Хөдөлмөрийн хөлсний үнэлгээ – 20%-аас 220% хүртэл
- Сарын тэтгэмж тооцох үнэлгээ – 1.25-аас 34 дахин нэмэгдүүлсэн хэмжээгээр

3. <u>Урамшуулал</u>

Казахстаны хөдөлмөрийн хууль болон бусад хууль тогтоомжид заасны дагуу Эрүүл мэндийн байгууллага нь дотооддоо мөрдөх нэмэлт цалин болон ажилчдын ажлын идэвхийг сайжруулах үүднээс урамшуулал олгож болдог. Нэмэлт цалин болон урамшууллыг тогтоохдоо Засгын газрын түвшин гэхээсээ илүү тухайн ЭМ-ийн байгууллагууд үйл ажиллагааныхаа онцлогтой уялдуулан бие дааж уян хатнаар зохицуулдаг.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Нэмэлт цалин болон урамшууллыг олгох эрх зүйн акт нь дор дурдсан хэлбэртэй байж болдог.

- Байгууллагын хөдөлмөрийн хөлс, шагнал урамшууллын тухай журам
- Байгууллагын хамтын гэрээ
- Удирдах албан тушаалтны тушаал захирамж г.м.

Нэмэлт цалин болон урамшууллыг олгох эрх зүйн актыг боловсруулахдаа удирдлага, үйлдвэрчний эвлэл, ажилчдын төлөөллийг оролцуулсан тусгай комисс байгуулах бөгөөд энэ комисс нь ил тод байх зарчим дээр үндэслэн нэмэлт цалин, урамшууллыг ямар шалгуураар хэнд яаж олгох зэргийг нарийвчлан тусгаж тогтоодог. Энэ эрх зүйн актанд дараах зүйл заалтыг тусгаж өгдөг.

- Цалингийн нэмэгдэл олгох албан тушаал, ажил мэргэжлийн жагсаалт
- Ажилтнуудын ажлын үр дүнг үнэлэх үнэлгээ
- Цалингийн нэмэгдлийг тооцох коэффициент
- Цалингийн нэмэгдэл урамшууллыг олгох нөхцөл, хугацаа, хэлбэр
- Цалингийн нэмэгдэл, урамшууллыг олгох шалгуур

Нэмэлт цалин, урамшууллыг олгохдоо ажилтнуудад ижил хувь хэмжээгээр эсхүл ажилтан тус бүрээр тооцож гаргасан коэффициентэд үндэслэн олгож болно.

## 4.7. МОНГОЛ УЛС

### Эрүүл мэндийн салбарын цалин хөлсний бодлого, тогтолцоо

Эрүүл мэндийн салбарт 2019 оны жилийн эцсийн байдлаар нийт 54687 ажиллагсад ажиллаж байгаа нь сүүлийн 10 жилийн дунджаас 7.8 мянга (16.7%)-аар, өмнөх оноос 2.4 мянга (4.6%)-аар тус тус нэмэгдсэн байна. 10000 хүнд ногдох эрүүл мэндийн салбарын ажиллагсад 2019 оны жилийн эцсээр 171 болж, сүүлийн 10 жилийн дундаж болон өмнөх оноос 6-11-ээр нэмэгджээ. Үүнээс их эмч, сувилагчийнх 2019 онд 37-40 болж, сүүлийн 10 жилийн дундаж болон өмнөх оноос мөн 1-4-өөр нэмэгдсэн байна. [92]

**Эрүүл мэндийн ажилтны тоо (10000 хүнд ногдох), 2010-2019 он**




Эрүүл мэндийн салбарын төсвийн гол зардал нь цалин байдаг боловч эрүүл мэндийн салбарын ажиллагсдын цалин бага түвшинд байсаар байна. Улсын эрүүл мэндийн байгууллагын ажилтнууд төрийн албан хаагчид учраас төрөөс цалинг зохицуулж байна. Эмч, сувилагч нар төрийн үйлчилгээний албан хаагч тул төрийн албан хаагчдын цалингийн хуваарийн дагуу цалинждаг. Цалин хөлсний хэмжээ нь ажил эрхлэлтийн үргэлжлэх хугацаа, албан тушаал, мэргэшсэн байдлаас хамааран харилцан адилгүй байна.

*Улсын эмнэлгийн салбарт ажиллагсдын тоо.* Улсын эмнэлгүүдэд 25739 албан хаагч ажиллаж байгаа нь улсын хэмжээнд нийт ажиллаж буй 205011 төрийн албан хаагчийн 13 хувийг эзэлж байна. Харин нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд хамрагдсан нийт даатгуулагчдын 44.4 мянга (6.5%) нь хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбарын ажилчид байна.[93]

[92] https://www.1212.mn/BookLibraryDownload.ashx?url=eruul_mend_2019.pdf&ln=Mn
[93] Ажилчдын сарын дундаж цалингийн статистикийн мэдээ, 2021. Үндэсний Статистикийн хороо

*Улсын эмнэлгийн эмчийн цалинд зориулж төрөөс хуваарилж буй мөнгөн хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр:* Албан хаагчдын цалин, урамшууллыг улсын төсөв, эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, төсөвт байгууллагын өөрийн орлого зэргээс санхүүжүүлж байна. 2020 оны байдлаар 747,4 тэрбум төгрөгийн цалин хөлсний зардал эрүүл мэндийн ажилтнуудад зориулж батлагдсан байна. Харин 2021 оны эхний улирлын байдлаар хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбарт ажиллагсдын сарын дундаж цалин өмнөх улирлаас 139.1 (11.2%) мянган төгрөгөөр буурсан байна. [94]

Цалин хөлсний талаарх эрх зүйн зохицуулалт: Эмч нарын цалингийн эрх зүйн зохицуулалтын хувьд нийт 13 эрх зүйн баримт бичиг үйлчилж байгаа ба нийтлэг байдлаар цалин, нэмэгдэл, мөнгөн урамшуулал, мөнгөн бус урамшууллын хэлбэрээр олгохоор зохицуулалт хийсэн байна.

**Монгол Улсын эрүүл мэндийн ажилтны цалин хөлсний талаар зохицуулсан эрх зүйн зохицуулалт**

<table>
<tr><th>Цалин урамшууллын хэлбэр</th><th>Зохицуулж буй эрх зүйн акт</th><th>Эрх зүйн зохицуулалт</th><th>Хариуцах нэгж</th></tr>
<tr><td colspan="4">5. ЦАЛИН</td></tr>
<tr><td>Цалин</td><td>Эрүүл мэндийн тухай хууль 2011.05.05 https://www.legalinfo.mn/law/details/49</td><td>29.1. Эрүүл мэндийн ажилтны цалингийн тусгай сүлжээний доод жишгийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төрөл, онцлогийг харгалзан хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.</td><td>29.1. Засгийн газар</td></tr>
<tr><td>Цалингийн сан</td><td>Эрүүл мэндийн тухай хууль 2011.05.05 https://www.legalinfo.mn/law/details/49</td><td>17.10.4.төсвийн хязгаарт нийцүүлэн эмнэлгийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаар, цалингийн санг тогтоох;</td><td>17.10. Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшл-ийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөл</td></tr>
<tr><td>Үндсэн цалин</td><td>Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай тогтоол Дугаар 472, Хавсралт 7 2019.12.25 https://www.legalinfo.mn/annex/details/10385?lawid=14892</td><td>Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээ<br>ТҮЭМ- эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаал
<table>
<tr><th>Шатлал</th><th>Албан тушаалын жишээ</th><th>1</th><th>2</th><th>3</th><th>4</th><th>5</th></tr>
<tr><td>ТҮЭМ-1</td><td>шил угаагч</td><td>547509</td><td>551533</td><td>561756</td><td>587693</td><td>616629</td></tr>
<tr><td>ТҮЭМ-2</td><td>туслах сувилагч</td><td>587385</td><td>591811</td><td>603058</td><td>631589</td><td>663419</td></tr>
<tr><td>ТҮЭМ-3</td><td>сувилагч</td><td>653181</td><td>658271</td><td>671205</td><td>704015</td><td>740619</td></tr>
<tr><td>ТҮЭМ-4</td><td>резидент эмч</td><td>703623</td><td>709224</td><td>723450</td><td>759541</td><td>799806</td></tr>
<tr><td>ТҮЭМ-5</td><td>ерөнхий мэргэжлийн эмч</td><td>731369</td><td>737248</td><td>752185</td><td>790081</td><td>832357</td></tr>
<tr><td>ТҮЭМ-6</td><td>сумын эмнэлгийн дарга</td><td>818762</td><td>825523</td><td>842702</td><td>886282</td><td>934899</td></tr>
<tr><td>ТҮЭМ-7</td><td>аймгийн нэгдсэн эмнэлгийн дарга</td><td>885763</td><td>893200</td><td>912097</td><td>938498</td><td>964899</td></tr>
<tr><td>ТҮЭМ-8</td><td>Төрөлжсөн мэргэшлийн</td><td>945093</td><td>953058</td><td>973165</td><td></td><td></td></tr>
</table></td><td>2. Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтооход шаардагдах хөрөнгийг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны батлагдсан төсөвт багтаан хэрэгжүүлэхийг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.</td></tr>
</table>

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[94] Ажилчдын сарын дундаж цалингийн статистикийн мэдээ, 2021. Үндэсний Статистикийн хороо

<table>
<tr>
<td></td>
<td></td>
<td>
<table>
<tr><td></td><td>эмнэлг-ийн дэд дарга</td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td>ТҮЭ М-9</td><td>Төрөлж-сөн мэргэшл-ийн эмнэлг-ийн захирал</td><td>1008801</td><td>1017401</td><td>1039119</td><td></td><td></td></tr>
</table>
</td>
<td></td>
</tr>
<tr>
<td>Үндсэн цалин</td>
<td>Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай тогтоол Дугаар 472, Хавсралт 10. Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээ 2019.12.25 https://www.legalinfo.mn/annex/details/10388?lawid=14892</td>
<td>
Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн сүлжээ<br>
ТҮ-Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаал
<table>
<tr><th colspan="2">Шатлал</th><th>Албан тушаалын жишээ</th><th>1</th><th>2</th><th>3</th></tr>
<tr><td rowspan="12">Албан тушаалын зэрэглэл</td><td>ТҮ-1</td><td>жижүүр</td><td>487695</td><td>491079</td><td>499556</td></tr>
<tr><td>ТҮ-2</td><td>асрагч</td><td>510435</td><td>514086</td><td>523359</td></tr>
<tr><td>ТҮ-3</td><td>эмнэлгийн тогооч</td><td>528520</td><td>532353</td><td>542089</td></tr>
<tr><td>ТҮ-4</td><td>лаборант</td><td>547509</td><td>551533</td><td>561756</td></tr>
<tr><td>ТҮ-5</td><td>техникч</td><td>587385</td><td>591811</td><td>603058</td></tr>
<tr><td>ТҮ-6</td><td>Нийгмийн ажилтан</td><td>653181</td><td>658271</td><td>671205</td></tr>
<tr><td>ТҮ-7</td><td>Нягтлан бодогч</td><td>703623</td><td>709224</td><td>723450</td></tr>
<tr><td>ТҮ-8</td><td>Ерөнхий нягтлан бодогч</td><td>731369</td><td>737248</td><td>752185</td></tr>
<tr><td>ТҮ-9</td><td>Лабораторын эрхлэгч</td><td>818762</td><td>825523</td><td>842702</td></tr>
<tr><td>ТҮ-10</td><td>агентлагийн хэлтсийн дарга</td><td>885763</td><td>893200</td><td>912097</td></tr>
<tr><td>ТҮ-11</td><td>Яамны хэлтсийн дарга</td><td>945093</td><td>953058</td><td>973165</td></tr>
<tr><td>ТҮ-12</td><td>Яамны газрын дарга</td><td>1008801</td><td>1017401</td><td>1039119</td></tr>
</table>
</td>
<td>Төсвийн ерөнхийлөн захирагч</td>
</tr>
<tr><td colspan="4">6. НЭМЭГДЭЛ</td></tr>
<tr>
<td>Мэргэшлийн зэргийн нэмэгдэл</td>
<td>Засгийн газрын 2018 оны 382 дугаар Тогтоол. Хавсралт 5. Төрийн үйлчилгээний албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох нийтлэг журам https://www.legalinfo.mn/annex/details/9074?lawid=13946</td>
<td>
2. Төрийн үйлчилгээний албан хаагчийг мэргэжлийнхээ дагуу тухайн албан тушаал эрхэлж байх хугацаанд мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийг үндэслэн албан тушаалын сарын үндсэн цалингаас доор дурдсан хувиар бодож сар бүр олгоно:
<table>
<tr><th>Мэргэшлийн зэрэг тогтоогдсон төрийн үйлчилгээний албан тушаал</th><th>Эмнэлгийн мэргэжилтэн</th><th>Албан тушаалын сарын үндсэн цалингаас бодох хувь</th></tr>
<tr><td>I зэрэг- зөвлөх</td><td>Зөвлөх</td><td>20</td></tr>
<tr><td>II зэрэг- тэргүүлэх</td><td>Тэргүүлэх</td><td>15</td></tr>
<tr><td>III зэрэг- ахлах</td><td>Ахлах</td><td>10</td></tr>
</table>
</td>
<td>3. Төрийн үйлчилгээн-ий албан хаагчид мэргэшлийн зэрэг, зэргийн нэмэгдэл олгох асуудлыг тухайн байгууллагын төсвийн шууд захирагч шийдвэрлэнэ.</td>
</tr>
<tr>
<td>Ажилласан жилийн нэмэгдэл</td>
<td>Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол, Хавсралт 1. Төрийн захиргааны болон үйлчилгээний</td>
<td>Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг тухайн төрийн албан хаагчийн төрийн байгууллагад ажилласан хугацааг харгалзан түүний албан тушаалын сарын үндсэн цалингаас дор дурдсан хувиар бодож олгоно:<br>
6-10 жилд (61-120 сар)-5 хувь<br>
11-15 жилд (121-180 сар)-10 хувь<br>
16-20 жилд (181-240 сар)-15 хувь<br>
21-25 жилд (241-300 сар)-20 хувь<br>
26 ба түүнээс дээш (301 ба түүнээс дээш сар)-25 хувь</td>
<td>6. Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг тухайн байгууллага жил бүрийнхээ төсөвт тусгаж олгоно.</td>
</tr>
</table>

UIH.MN СУДАЛГААНЫ САН

<table>
<tr><td></td><td>албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам 2018.12.19 https://www.legalinfo.mn/annex/details/9070?lawid=13946</td><td></td><td></td></tr>
<tr><td>Орон нутгийн нэмэгдэл</td><td>Засгийн газрын 2018 оны 382 дугаар Тогтоол. Хавсралт 6. Төрийн үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам https://www.legalinfo.mn/annex/details/9075?lawid=13946</td><td>2. Орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны нэмэгдлийг дараах албан тушаал эрхэлж байгаа эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингаас дор дурдсан хувиар бодож сар бүр олгоно:
<table>
<tr><th>Албан тушаал</th><th>Хувь</th></tr>
<tr><td>Аймгийн нэгдсэн эмнэлэг/бүсийн оношилгоо, эмчилгээний төв, эрүүл мэндийн бусад байгууллагын:<br>1.Захирал/дарга 2.Дэд захирал/орлогч дарга<br>3.Чанарын менежер 4.Хүний их эмч<br>5.Сувилахуйн/эх барихуйн мэргэжилтэн<br>6.Эрүүл мэндийн бусад мэргэжилтэн<br>7.Эмнэлгийн бусад мэргэжилтэн 8.Анагаахын болон эм зүйн техникч<br>9.Сувилахуйн болон эх барихуйн туслах/дэд мэргэжилтэн<br>10. Эрүүл мэндийн бусад туслах/дэд мэргэжилтэн</td><td>10</td></tr>
<tr><td>Сум (сум дунд), тосгоны эрүүл мэндийн төвийн:<br>1.Сувилахуйн/эх барихуйн мэргэжилтэн<br>2.Эмчилгээ оношилгооны тоног төхөөрөмжийн техникч, лаборант<br>3.Эрүүл мэндийн бусад мэргэжилтэн<br>4.Эм зүйн мэргэжилтэн<br>5.Түргэн тусламжийн жолооч</td><td>15</td></tr>
<tr><td>Сум (сум дунд), тосгоны эрүүл мэндийн төвийн:<br>1.Дарга 2.Хүний их эмч 3.Хүний бага эмч, багийн бага эмч</td><td>20</td></tr>
</table></td><td>4. Орон нутагт ажилласны нэмэгдлийг тухайн байгууллага жил бүрийнхээ төсөвт тусгаж олгоно.</td></tr>
<tr><td>Ур чадварын нэмэгдэл</td><td>Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол. Хавсралт 4.Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам https://www.legalinfo.mn/annex/details/9073?lawid=13946</td><td>3. Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно.</td><td>Ур чадварын нэмэгдлийг тухайн байгууллага жил бүрийнхээ төсөвт тусгаж олгоно.</td></tr>
<tr><td>Эрдмийн зэрэг цолны нэмэгдэл</td><td>Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол. Хавсралт 3. https://www.legalinfo.mn/annex/details/9072?lawid=13946</td><td>Их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль тогтоомжоор заасан байгууллагад сургалт, эрдэм шинжилгээ, туршилтын ажил эрхэлдэг, эрдэм шинжилгээний байгууллагад болон судалгаа шинжилгээ, туршилтын үндсэн үйлдвэрлэл дээр ажилладаг эрдмийн зэрэг, цолтой төрийн албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингаас дор дурдсан хувиар бодож сар бүр нэмэгдэл олгож байна:<br>Шинжлэх ухааны доктор зэрэг-20 хувь<br>Профессор цол-10 хувь<br>Боловсролын доктор зэрэг-15 хувь<br>Дэд профессор цол-5 хувь</td><td>7. Докторын зэрэг, профессор цолны нэмэгдлийг тухайн байгууллага жил бүрийнхээ төсөвт тусгаж олгоно.</td></tr>
<tr><td>Дуудлагын нэмэгдэл</td><td>Засгийн газрын тогтоол 2018 оны 382 дугаар тогтоол. Хавсралт 2. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам https://www.legalinfo.mn/annex/details/9071?lawid=13946</td><td>4.2. Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч алсын болон төрөлжсөн мэргэжлийн дуудлагаар явж эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлсэн бол түүний албан тушаалын сарын үндсэн цалингийн 5 хүртэл хувиар тооцож дуудлагаар явсан тохиолдол бүрт нэмэгдэл хөлс олгоно.</td><td>4.2. Алсын болон төрөлжсөн мэргэжлийн дуудлагаар явж эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлсэн үед тооцох нэмэгдэл хөлсийг дуудлагын зай болон замын бартаанаас хамааруулж</td></tr>
</table>

СУДАЛГААНЫ САН

| | | | |
|---|---|---|---|
| | | | олгох зохицуулалтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж, дагаж мөрдүүлнэ. |
| Онцгой байдлын нэмэгдэл | Эрүүл мэндийн тухай хууль 2011.05.05 https://www.legalinfo.mn/law/details/49 | 30.1.Олон улсын хөл хориот халдварт өвчний голомтод болон гамшигийн үед дайчилгаагаар ажилласан эрүүл мэндийн ажилтанд тухайн дайчилгааг зохион байгуулсан газар 1 сарын дотор ажилласан хугацааны цалин хөлсийг нь 3 дахин нэмэгдүүлж олгоно. | 30.5.Эрүүл мэндийн ажилтанд хууль тогтоомжид заасны дагуу цалин хөлсний нэмэгдэл, мөнгөн урамшуулал олгох бөгөөд тэдгээрийн төрөл, хэмжээ, олгох журмыг Засгийн газар батална. |
| Онцгой байдлын улмаас амь нас, хөдөлмөрийн чадвараа алдсаны нэмэгдэл | | 30.2.Эрүүл мэндийн ажилтан нь олон улсын хөл хориот халдварт өвчний голомтод ажиллаж халдвар авсны улмаас болон ажил үүргээ гүйцэтгэх үедээ амь насаа алдвал ар гэрт нь түүний 5 жилийн үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй мөнгөн тусламж олгох бөгөөд ажил үүрэг гүйцэтгэхтэй нь холбогдуулан бие махбодод нь гэмтэл учруулсан буюу эрүүл мэндийг нь бусад хэлбэрээр хохироосноос хөдөлмөрийн чадвараа түр алдсан, тахир дутуу болсон тохиолдолд тэтгэвэр, тэтгэмж, авч байсан цалингийн зөрүүг хөдөлмөрийн чадвар түр алдсан, тахир дутуугийн тэтгэмж авч байсан нийт хугацаанд олгоно. | |
| Хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэл | Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын Хавсралт 8. Хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настанд тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа төрийн үйлчилгээний зарим албан хаагчид хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэл олгох журам https://www.legalinfo.mn/annex/details/11891?lawid=13946 | 3. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эмч, сувилагч, туслах сувилагч, асрагч, хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч, хэл засалч, сэтгэл засалчид тухайн ажил, албан тушаал эрхлэх хугацаанд нь албан тушаалын сарын үндсэн цалингийн 20 хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдлийг сар бүр олгоно.<br>4. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний төрөлжсөн асрамжийн газарт ажиллаж байгаа асрагчид тухайн ажил, албан тушаал эрхлэх хугацаанд нь албан тушаалын сарын үндсэн цалингийн 20 хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдлийг сар бүр олгоно. | 5. Хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдлийг тухайн байгууллага жил бүрийнхээ төсөвт тусгаж олгоно. |
| Хөдөлмөрийн хүнд нөхцөлийн нэмэгдэл | Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол. Хавсралт 7. Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэл олгох журам https://www.legalinfo.mn/annex/details/9076?lawid=13946 | 2. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан "Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт"-д багтсан эрүүл мэндийн ажилтан, эх барих-эмэгтэйчүүдийн эмч, эх баригч, хүүхэд, нярайн эмч болон сувилагчид тухайн ажил, албан тушаал эрхлэх хугацаанд нь албан тушаалын сарын үндсэн цалингийн 10 хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдлийг сар бүр олгоно.<br>3. Сүрьеэгийн эмнэлэг, тасаг, амбултор, тандалт судалгааны нэгжид ажиллаж байгаа дарга/эрхлэгч, хүний их эмч, шүдний их эмч, эм зүйч, нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн, сувилагч, лабораторын болон рентген туяаны техникч, ариутгагч, асрагч/үйлчлэгчид албан тушаалын үндсэн цалингийн 30 хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдлийг тухайн албан тушаалыг эрхлэх хугацаанд сар бүр олгоно. | 4. Хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдлийг тухайн байгууллага жил бүрийнхээ төсөвт тусгаж олгоно. |
| Илүү цагийн нэмэгдэл | Засгийн газрын тогтоол 2018 оны 382 дугаар тогтоол. Хавсралт 2. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид | 1.4.1. Нарийн төвөгтэй ажилбар болон анхаарал төвлөрөл шаардах ажил гүйцэтгэдэг эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний зарим албан хаагчийг шөнийн цагаар (орон нутгийн цагаар 22 цагаас 06 цаг хүртэлх хугацаанд) ажиллуулсан тохиолдолд мэргэжлийн алдаа гаргах, үйлчлүүлэгчийн амь нас, эрүүл мэндэд үүсэх эрсдлээс сэргийлж, түүнийг нөхөн амруулна. Зайлшгүй шаардлагатай тохиолдолд шөнийн цагаар ажилласан төрийн албан хаагчтай зөвшилцсөний үндсэн дээр түүнийг үргэлжлүүлэн ажиллуулж, энэ журмын дагуу нэмэгдэл хөлсийг тодорхойлно.<br>2.2. Илүү цагаар болон долоо хоногийн амралтын өдөр ажилласан төрийн албан хаагчийг нөхөн амруулаагүй бол илүү цагийн хөлсийг тодорхойлохдоо сарын | 2.5. Нэмэгдэл хөлс олгох зохицуулалтыг байгууллагын дотоод журамд тусган зохицуулж болно. |

UIH.MN

<table>
<tr><td></td><td>нэмэгдэл хөлс олгох журам https://www.legalinfo.mn/annex/details/9071?lawid=13946</td><td>цалин хөлсний хэмжээг тухайн сарын ажиллавал зохих цагт хуваах, нэг цагт ногдох цалин хөлсийг тооцож гаргана. Нэг цагийн цалин хөлсийг илүү ажилласан цагаар үржүүлж гарсан цагийг 1.5 (1.5 ба түүнээс дээш байхыг хамтын гэрээ, хөдөлмөрийн гэрээнд тусгаж зохицуулна) дахин нэмэгдүүлж, илүү цагийн хөлсний хэмжээг тодорхойлно.<br>2.3. Нийтээр амрах баярын өдөр ажилласан төрийн албан хаагчийг нөхөн амруулаагүй бол дээрх зарчмын дагуу нэг цагт ногдох цалин хөлсийг нийтээр амрах баярын өдөр ажилласан цагаар үржүүлж, түүнийг 2.0 дахин нэмэгдүүлэх замаар нэмэгдэл хөлсийг тодорхойлно.<br>2.4. Шөнийн цагаар ажилласан төрийн албан хаагчийг нөхөн амруулаагүй бол нэмэгдүүлсэн цалин хөлс олгох зохицуулалтыг хамтын ба хөдөлмөрийн гэрээнд тусгаж, дээрх зарчмын дагуу нэмэгдэл хөлсийг тодорхойлно.</td><td></td></tr>
<tr><td colspan="4">7. МӨНГӨН УРАМШУУЛАЛ</td></tr>
<tr><td>Урамшуул-лыг дэмжих</td><td>Эрүүл мэндийн тухай хууль 2011.05.05 https://www.legalinfo.mn/law/details/49</td><td>29.4.Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага нь эмнэлгийн мэргэжилтэнд урамшуулал олгох, нийгмийн баталгааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.</td><td>29.4.Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага</td></tr>
<tr><td>Урамшуул-лын зардал</td><td>Эрүүл мэндийн даатгалын тухай хууль 2015.01.29 (Шинэчилсэн найруулга) https://www.legalinfo.mn/law/details/10922</td><td>20.1.3. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, үр дүнг харгалзан даатгалын гэрээтэй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагад олгох урамшууллын зардал орно гэж заасан.</td><td>16.1.13. Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагад энэ хуулийн 20.1.3-т заасан урамшуулал олгох журмыг батлах;</td></tr>
<tr><td>Урамшуул лыг зохион байгуулах</td><td>Эрүүл мэндийн тухай хууль 2011.05.05.https://www.legalinfo.mn/law/details/49</td><td>11.1.5. эрүүл мэндийг хамгаалах, дэмжих чиглэлээр идэвх, санаачилгатай ажиллаж байгаа хамт олон, аж ахуйн нэгж, байгууллагыг <u>урамшуулах</u>, сурталчлах ажлыг зохион байгуулах;</td><td>11 дүгээр зүйл.Бүх шатны Засаг даргын бүрэн эрх</td></tr>
<tr><td>Нэг удаагийн мөнгөн тэтгэмж</td><td>Эрүүл мэндийн тухай хууль 2011.05.05 https://www.legalinfo.mn/law/details/49</td><td>29.2.Төрийн өмчийн эрүүл мэндийн болон бусад салбарын байгууллагад 25 ба түүнээс дээш жил, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд болон анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх тусгай эмнэлэгт 10 ба түүнээс дээш жил ажилласан эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн бусад ажилтанд тэтгэвэрт гарахад нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг үндсэн цалингийн дунджаас нь тооцож олгох бөгөөд нэг удаагийн тэтгэмж тооцох цалингийн дундаж хэмжээ, тэтгэмж олгох шалгуур нөхцөлийг Төрийн албаны тухай хуульд заасан журмыг баримтлан тогтооно.</td><td>29.3.Энэ хуулийн 29.2, 29.5-д заасан нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгоход шаардагдах зардлыг тухайн байгууллага төсөвтөө тусгасан байна.</td></tr>
<tr><td>Тасралт-гүй ажилла-сны мөнгөн тэтгэмж</td><td>Эрүүл мэндийн тухай хууль 2011.05.05 https://www.legalinfo.mn/law/details/49</td><td>29.5.Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд болон анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх тусгай эмнэлэгт тасралтгүй ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтэн, эмнэлгийн бусад мэргэжилтэнд гурван жил тутамд нэг удаа зургаан сарын, аймаг дахь төрийн болон орон нутгийн өмчит эрүүл мэндийн байгууллагад тасралтгүй ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтэн, эмнэлгийн бусад мэргэжилтэнд таван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг тухайн байгууллагаас нь олгоно. /Энэ хэсэгт 2019.01.18-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/</td><td>29.5.тухайн байгууллага</td></tr>
<tr><td>Үр дүн, гүйцэтгэ-лийн урамшуу-лал</td><td>Засгийн газрын тогтоол 2019 оны 5 дугаар тогтоол, Хавсралт 3, Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам</td><td>3.1. Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтанд ажлын үр дүн, гүйцэтгэлийг нь үндэслэн мөнгөн урамшуулал олгоно. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага энэ журмын дагуу мөнгөн урамшуулал олгож болно.<br>3.2. Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлийг үндэслэн үндсэн цалингийн 10-20 хувиар сар бүр тооцож, улирал тутам олгоно. (Энэ дэд заалтад Засгийн газрын 2019 оны 395 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон)<br>3.7. Ажлын үр дүнгийн үнэлгээнээс хамааран дараах хувь хэмжээгээр сар бүр мөнгөн урамшуулал тооцно:
<table>
<tr><td>Бүх шалгуурын биелэлтийн хувь</td><td>Ажлын үр дүнгийн үнэлгээ</td><td>Албан тушаалын үндсэн цалингаас урамшил тооцох хувь (сард)</td></tr>
<tr><td>90-100</td><td>Бүрэн хангалттай</td><td>11-20 хувь</td></tr>
<tr><td>71-89</td><td>хангалттай</td><td>10 хувь хүртэл</td></tr>
</table></td><td>3.3. Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага нь эрүүл мэндийн ажилтанд мөнгөн урамшуулал олгохдоо энэ журмын 3.4-т заасан шалгуур үзүүлэлтийг баримтлан ажлын үр дүн, гүйцэтгэлийг дүгнэж, тухайн жилийн төсөвт</td></tr>
</table>

| | | | |
|---|---|---|---|
| | | | уг урамшуулалд зориулан батлагдсан хөрөнгийн дунд багтаан энэ журмын 3.10, 3.12-т заасан шийдвэрийг үндэслэн олгоно. |
| **8. МӨНГӨН БУС УРАМШУУЛАЛ** | | | |
| Эрүүл мэндийн үзлэг, шинжил-гээ | Эрүүл мэндийн тухай хууль 2011.05.05 https://www.legalinfo.mn/law/details/49 | 29.6.Эрүүл мэндийн ажилтныг жилд нэг удаа эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд төлбөргүй хамруулна. | 29.3. Шаардагдах зардлыг тухайн байгууллага төсөвтөө тусгасан байна. |
| Нэмэлт амралт | | 29.7.Эрүүл мэндийн ажилтанд ажилласан 5 жил тутамд нь Хөдөлмөрийн тухай хуулиар тогтоосон ээлжийн амралтын үндсэн болон нэмэгдэл амралт дээр нь 1 өдрийн нэмэгдэл амралт олгоно. | |
| Сургалт | | 29.8.Сум, тосгоны эрүүл мэндийн төв, багийн эмчийн салбар, анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх тусгай эмнэлэгт 5 ба түүнээс дээш жил ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтнийг мэргэжил дээшлүүлэх сургалтад 5 жил тутамд улсын зардлаар хамруулна. | |

**Эрүүл мэндийн ажиллагсдын цалингийн дундаж (2016-2020 он)**







*Эх сурвалж: ЭМЯ. 2021*

Их эмчийн үндсэн цалин 2016 онд 598400 байсан бол 2020 онд 847269, сувилагчийн үндсэн цалин 478700 байсан бол 712200, эрүүл мэндийн бусад үйлчилгээний ажилтны цалин 824402 байна. Гэвч энэхүү бага хэмжээний нэмэгдэл нь төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2016 онд 2146 төгрөг байсан бол 2020 онд 2850 болсноос үзвэл энэ хугацаанд үүссэн цалингийн нэмэгдэл бодит нэмэгдэл болж чадаагүйг харуулж байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**Эрүүл мэндийн ажиллагсдын дундаж цалингийн хэмжээ (2016-2020 он)**

| Он | Эрх зүйн акт | Албан тушаал | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Их эмч | | Сувилагч | | Үйлчлэх бусад /ТҮ-1-ТҮ-3/ | |
| | | Үндсэн цалин | Сарын дундаж цалин /нэмэгдэл, нэмэгдэл хөлстэй хамт/ | Үндсэн цалин | Сарын дундаж цалин /нэмэгдэл, нэмэгдэл хөлстэй хамт/ | Үндсэн цалин | Сарын дундаж цалин /нэмэгдэл, нэмэгдэл хөлстэй хамт/ |
| 2016 он | 2015 оны 75 дугаар тогтоол | 598,400 | 837,760 | 478,700 | 669,200 | | |
| 2018 он | 2018 оны 264 дүгээр тогтоол | 646,300 | 904,820 | 527,600 | 738,640 | | |
| | 2018 оны 263 дугаар тогтоол | 646,300 | 904,820 | 610,700 | 854,980 | | |
| 2019 он | 2019 оны 24 дүгээр тогтоол | 698,000 | 977,200 | 659,300 | 923,020 | | |
| 2020 он | 2019 оны 472 дугаар тогтоол | 847,269 | 1,313,267 | 712,200 | 1,103,910 | 531,872 | 824,402 |

Цалингийн бүрэлдэхүүн:

- Үндсэн цалин ТҮЭМ- эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаал ба ТҮ-Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн сүлжээгээр тогтоогдож байна.
- Нэмэгдэл цалинд мэргэшлийн зэргийн нэмэгдэл, ажилласан жилийн нэмэгдэл, орон нутгийн нэмэгдэл, ур чадварын нэмэгдэл, Эрдмийн зэрэг цолны нэмэгдэл, Дуудлагын нэмэгдэл, онцгой байдлын нэмэгдэл, Онцгой байдлын улмаас амь нас, хөдөлмөрийн чадвараа алдсаны нэмэгдэл, хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй ажиллах үеийн хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэл, хөдөлмөрийн хүнд нөхцөлийн нэмэгдэл, илүү цагийн нэмэгдэл орж байгаа нь цалин хөлсөнд нөлөөлөх хүчин зүйлсийн ихэнхийг тусгаж чадсан нь харагдаж байна.[95]

Манай улсын цалин хөлсний системийн хувьд нэгжийн үнэлгээнд суурилсан нормативт цалингийн систем буюу тогтмол цалингийн систем зонхилж байна. Харин 2021 оноос гүйцэтгэлд суурилсан цалингийн тогтолцоог аажмаар нэвтрүүлж эхэлсэн. Энэ онд эрүүл мэндийн байгууллагууд гүйцэтгэлд суурилсан санхүүжилтэд шилжсэнтэй холбоотойгоор эрүүл мэндийн албан хаагчдад ажлын гүйцэтгэлээс хамааран цалингийн нэмэгдэл урамшуулал олгох эрх тухайн байгууллагад нээлттэй болсон. Төлбөртэй тусламж үйлчилгээний орлогын тодорхой хувийг эмч, эмнэлгийн албан хаагчдад олгож байна. Хэдэн хувийн цалингийн нэмэгдэл олгохыг үйлдвэрчний эвлэлтэй байгуулсан хамтарсан гэрээнд зааж өгсөн байдаг.[96]

Үр дүнд суурилсан төсөвлөлт (ҮДСТ)-ийг эрүүл мэндийн анхан шатны тусламжид болон эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлдэг эмнэлгийн тусламж, үйлчилгээнд хэрэгжүүлж байна. Улсын төсвөөс санхүүжүүлдэг эмнэлгийн тусламж, үйлчилгээнд ҮДСТ-ийг хэрэгжүүлэх Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 1 дүгээр

[95] https://www.careerprofiles.info/salary-factors.html
https://www.salary.com/articles/eight-factors-that-can-affect-your-pay/
[96] ЭМЯ-ны эрүүл мэндийн салбарын эдийн засгийн бодлого, хэрэгжилтийн газрын мэдээлэл, 2021

UIHMN СУДАЛГААНЫ САН

сарын 22-ны өдрийн 03 дугаар тогтоолоор хэрэгжүүлж байна. Үүнд ЭМД-ын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн жагсаалт, төлбөрийн хэмжээ, ЭМДС-аас зардлын төлбөрийг нь хариуцах тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх төлбөрийн арга, ЭМДС-аас санхүүжүүлэх журам, төлбөрийг нь төр хариуцан амбултороор эмчлэх өвчин, эмгэг ба түүнд хэрэглэх эмийн жагсаалтыг баталсан.[97]

Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх судалгаанд[98] эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг бүрдүүлэх, хөгжүүлэх, улс орны чухал онцгой салбар гэдэг утгаар нь салбарт нөөцийг хуваарилахдаа микро удирдлагын хандлагыг халж стратегийн хувьд нөөцийг тогтвортой байлгах арга зам руу шилжих шаардлагатай гэж онцолжээ. Мөн эрүүл мэндийн байгууллагуудын төлбөрийн механизм, эрүүл мэндийн ажилчдын цалин хөлсний тогтолцооны заагийг арилгаж гүйцэтгэлийг сайжруулах нэгдмэл сонирхлыг аль аль түвшинд бий болгох хэрэгтэй байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

97 https://www.legalinfo.mn/law/details/16076
98 ttps://mohs.gov.mn/uploads/userfiles/files/TA%209386_Technical%20Report_1_MON_LAST%2016022019.pdf

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ


**АНУ**

- Patient protection and affordable care act https://www.hhs.gov/sites/default/files/ppacacon.pdf
- US health system https://www.commonwealthfund.org/international-health-policy-center/countries/united-states
- National health expenditure data https://www.cms.gov/Research-Statistics-Data-and-Systems/Statistics-Trends-and-Reports/NationalHealthExpendData/NHE-Fact-Sheet
- https://www.census.gov/library/stories/2021/04/who-are-our-health-care-workers.html
- GS-schedule https://www.federaljobs.net/salarybase.htm#Physicians_Comparibility_Allowan
- 5 U.S. Code 5948-physicians comparability allowances https://www.law.cornell.edu/uscode/text/5/5948
- Nurse salary https://www.federaljobs.net/Occupations/gs-0600-nursing-jobs.htm https://www.ziprecruiter.com/Jobs/Federal-Government-Nursing

**Шинэ Зеланд**

- New Zealand public health and disability act https://www.health.govt.nz/new-zealand-health-system/overview-health-system/statutory-framework
- Overview of New Zealand health and disability system https://www.health.govt.nz/new-zealand-health-system/new-zealand-health-strategy-future-direction/turning-strategy-action
- Health system funding https://www.health.govt.nz/new-zealand-health-system/overview-health-system/funding
- https://www.health.govt.nz/about-ministry/what-we-do/budget-2020-vote-health
- New Zealand GDP data https://www.stats.govt.nz/information-releases/gross-domestic-product-march-2021-quarter
- Health budget 2021 https://www2.deloitte.com/nz/en/pages/2021-government-budget/articles/health.html
- Budget at a glance 2021 https://www.treasury.govt.nz/sites/default/files/2021-05/b21-at-a-glance.pdf
- Care and support workers pay equity settlement https://www.health.govt.nz/new-zealand-health-system/pay-equity-settlements/care-and-support-workers-pay-equity-settlement
- Salary expenditure on health and disability workers https://www.health.govt.nz/system/files/documents/publications/cost-value-employment-health-disability-sector-25nov2020.pdf
- Comparison of salaries of Medical Specialists https://www.asms.org.nz/wp-content/uploads/2019/11/BERL-Report-Final-November.pdf
- District Health Boards collective agreement https://careers.adhb.govt.nz/assets/Documents/MECAs/NZNO-Nursing-and-Midwifery-Multi-Employer-Agreement.pdf

**Израил улс**

- Health Insurance and the healthcare system of Israel explained https://www.internations.org/go/moving-to-israel/healthcare
- International health care system profile-Israel, The commonwealth fund, 2020
- https://www.commonwealthfund.org/international-health-policy-center/countries/israel
- Isreal economic indicators
- https://www.theglobaleconomy.com/Israel/
- Israel-Health system review, 2015
- https://www.euro.who.int/__data/assets/pdf_file/0009/302967/Israel-HiT.pdf
- Israel Policy brief, OECD, 2016

- https://www.oecd.org/policy-briefs/israel-securing-adequate-resources-for-health-system.pdf
- The Israel healthcare system, Israeli Medical Association, 2020
- https://www.ima.org.il/userfiles/image/TheIsraeliHealthcareSystem2020.pdf
- Israel:health system review, LSE research online
- http://eprints.lse.ac.uk/67099/1/Rosen_Waitzberg_%20Merkur_Israel%20Health.pdf

**БНСУ**

- South Korea economic indicators https://www.theglobaleconomy.com/Israel/
- Advancing Universal health coverage: What developing countries can learn from the Korean experience?, World Bank, 2018


UIH.MN СУДАЛГААНЫ САН

- https://documents1.worldbank.org/curated/en/418791516185685994/pdf/Advancing-universal-health-coverage-what-developing-countries-can-learn-from-the-Korean-experience.pdf
- Number of licensed medical personnel and employed health care providers
- https://www.mohw.go.kr/eng/hs/hs0104.jsp?PAR_MENU_ID=1006&MENU_ID=100604
- An analysis of the health financing system of the Republic of Korea, WHO, 2009
- https://www.who.int/health_financing/documents/hsfr_e_09-korea.pdf?ua=1

**Япон Улс**

- International Health Care System
- https://www.commonwealthfund.org/international-health-policy-center/countries/japan
- Health Insurance Act http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail_main?re=&vm=02&id=3266
- National Health In Insurance Law
- https://www.ilo.org/dyn/travail/docs/2064/National%20Health%20Insurance%20Law%201938.pdf
- Reform of the health care system in Japan
- Long-Term Care Insurance Act http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?id=94&vm=2&re=02
- Japan https://p4h.world/en/universal-object-country/japan
- International health care system profiles https://www.commonwealthfund.org/international-health-policy-center/countries/japan 8.
- Labour Standards Law https://www.ilo.org/dyn/natlex/docs/WEBTEXT/27776/64846/E95JPN01.htm
- National public Service Act http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail_main?re=&vm=02&id=2713
- Minimum Wage Act http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?id=2420&vm=2&re=02
- National Personnel Authority https://www.jinji.go.jp/en/
- Remuneratio of Japanese National Public Employees https://www.oecd.org/gov/pem/48668483.pdf
- Average salary in Japan
- http://www.salaryexplorer.com/salary-survey.php?loc=107&loctype=1

**Перу Улс**

- Peru’s Legal Framework for the Rights to Health care https://www.socialprotection-toolbox.org/practice/perus-legal-framework-rights-health-care
- Constitute https://www.constituteproject.org/constitution/Peru_2009?lang=en
- Peru Health Insurance https://www.pacificprime.com/country/americas/peru-health-insurance-pacific-prime-internationa/
- what are the Employment Laws https://www.bizlatinhub.com/what-are-the-employment-laws-in-peru/
  Salario Minimo https://www.who.int/alliancehpsr/projects/alliancehpsr_healthworkersalaries_bitran_finalreport.pdf
- Medical doctor salary https://www.salaryexpert.com/salary/job/medical-doctor/peru/lima

**Казахстан**

- https://strategy2050.kz/upload/iblock/c10/gosudarstvennaya_programma_razvitiya_zdravookhraneniya_respubliki_kazakhstan_na_2020_2025_gody.pdf
- Государственная программа развития здравоохранения Республики Казахстан на 2020 - 2025 годы
- https://adilet.zan.kz/rus/docs/V2000021711 - Об утверждении типовой системы оплаты труда работников государственных предприятий на праве хозяйственного ведения в области здравоохранения
- https://med.mcfr.kz/article/1059-oplata-meditsinskogo-truda-normativnoe-regulirovanie-pravila-oplaty-i-primer-rascheta - Система оплаты труда медицинских работников в 2021 году: примеры расчета
- https://med.mcfr.kz/article/863516?btx=15768937#1 - Как дифференфированно оплачивать труд медработников: критериев и расчетов И.Д.МУРАТОВА


UIH.MN СУДАЛГААНЫ САН

**Монгол Улс**

-https://www.1212.mn/BookLibraryDownload.ashx?url=eruul_mend_2019.pdf&ln=Mn
-Ажилчдын сарын дундаж цалингийн статистикийн мэдээ, 2021. Үндэсний Статистикийн хороо
-https://www.careerprofiles.info/salary-factors.html
-https://www.salary.com/articles/eight-factors-that-can-affect-your-pay/
-Эрүүл мэндийн яамны эрүүл мэндийн салбарын эдийн засгийн бодлого, хэрэгжилтийн газрын мэдээлэл, 2021
-https://www.legalinfo.mn/law/details/16076
-https://www.1212.mn/BookLibraryDownload.ashx?url=eruul_mend_2019.pdf&ln=Mn
-https://www.adb.org/sites/default/files/publication/352706/health-fs-mongolian.pdf
-https://www.legalinfo.mn/law/details/5690

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

# МОНГОЛ УЛСЫН СЭТГЭЛ СУДЛАЛЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, МЭРГЭЖИЛТЭН БЭЛТГЭХ ТОГТОЛЦОО БА ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

*Э.Энхтүвшин, П.Уранчимэг,*
*С.Золжаргал, Б.Туул*

## ГАРЧИГ

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

НЭГ. МОНГОЛ УЛСЫН СЭТГЭЛ СУДЛАЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

ХОЁР. СЭТГЭЛ СУДЛААЧИД МЭРГЭЖЛЭЭРЭЭ АЖИЛЛАХ БОЛОМЖ НӨХЦӨЛ, АЖЛЫН БАЙРНЫ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

ГУРАВ. СЭТГЭЛ СУДЛАЛЫН БОЛОВСРОЛ ОЛГОХ ТОГТОЛЦОО, МЭРГЭЖЛИЙН ХҮНИЙ НӨӨЦ БҮРДҮҮЛЭЛТ

ДӨРӨВ. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

ХАВСРАЛТ

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

| | |
|---|---|
| ЯУ | Япон Улс |
| ФУ | Филиппин Улс |
| БННУ | Бүгд Найрамдах Намиби Улс |
| БНУ | Бүгд Найрамдах Улс |
| ННФ | Нээлттэй нийгэм форум |
| ТХБ | Тогтвортой хөгжлийн боловсрол |
| МХ | Мэргэжлийн холбоо |
| БШУЯ | Боловсрол, шинжлэх ухааны яам |
| ХНХЯ | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

## УДИРТГАЛ

Судалгааны захиалгын дагуу “Монгол Улсын сэтгэл судлалын салбарын өнөөгийн байдал, мэргэжилтэн бэлтгэх тогтолцоо ба гадаадын зарим орны туршлага, эрх зүйн зохицуулалт” сэдэвт судалгааны ажлыг Парламентын судалгааны хүрээлэнд гүйцэтгэв.

Сэдвийн хүрээнд Монгол Улсын сэтгэл судлалын өнөөгийн байдал, тулгамдсан асуудлууд, сэтгэл судлалын мэргэжилтэн бэлтгэх тогтолцоо, хэрэгцээ шаардлага, хүний нөөц бүрдүүлэлт, сэтгэл судлаачид мэргэжлээрээ ажиллах боломж нөхцөл болон гадаадын зарим орны туршлага, эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлахыг зорилоо.

Судалгааны мэдээллийг интернэтийн нээлттэй эх сурвалжууд болон БШУЯ, ХНХЯ, Нээлттэй нийгэм форум, Боловсролын хүрээлэн, Стандарт хэмжил зүйн газар, зарим их, дээд сургуулиудаас авсан мэдээлэлд тулгуурлан гүйцэтгэв.

Ингэхдээ зарим мэдээллийг утсаар болон биечлэн лавлах, ярилцлага хийх замаар тодруулсан болно.

Мэдээлэл цуглуулах явцад сэтгэл судлалын талаар ном, товхимол, гарын авлага, судалгааны материалууд хомс байсан бөгөөд тэр дундаа гадаад орнуудын туршлагыг судалсан байдал хангалтгүй, үндсэндээ судлагдаагүй сэдэв болох нь ажиглагдав.

Иймд гадаад орнуудын туршлага, эрх зүйн зохицуулалтыг судлахдаа бие даасан хуультай дараах 3 орныг сонгон судалсан болно. Үүнд:

1) Филиппин Улс;
2) Япон Улс;
3) Бүгд Найрамдах Намиби Улс.

Судалгааны багийн зүгээс богино хугацаанд аль болохоор боломжтой хэмжээнд мэдээлэл, материал цуглуулж, олдсон мэдээллийн түвшинд боловсруулалт хийсэн болно.

## СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

### *1. Монгол Улсын сэтгэл судлалын өнөөгийн байдал*

Өнөө үед сэтгэл судлал бол хүн судлалын хамгийн эрчимтэй, хурдтай хөгжиж байгаа салбарт тооцогдох бөгөөд оюун ухаан, зан үйлийг судалдаг томоохон шинжлэх ухааны салбар юм.

Гэхдээ сэтгэл судлал нь зөвхөн хүнийг судалдаг гэж үзвэл учир дутагдалтай. Хүний анатоми-физиологи, сурган хүмүүжүүлэх зүй гэх мэт олон шинжлэх ухааныг хамруулан судалдаг байна.

"Сэтгэл судлал" гэдэг үг нь өөрөө грек хэлний *psyche* гэсэн үгнээс гаралтай ба шууд утгаараа "амьсгал, сүнс, сэтгэл" гэсэн утгатай байдаг байна.[99]

Сэтгэл судлалын түүхийн туршид хүний оюун ухаан, зан үйлийг тайлбарлах янз бүрийн онол, үзэл санаанууд гарч байсан бөгөөд үүнийг дагаад сэтгэлгээний сургуулиуд ч бий болсон байна [100] (Структурализм: Бүтэц, үзэл нь хамгийн эртний сэтгэлгээний сургууль, Функционализм: Хүний ухамсар, зан үйлийн зорилгод анхаарлаа төвлөрүүлсэн сэтгэлгээний сургууль, Психоанализ: Ухамсаргүй оюун ухаан хүний зан төлөвт хэрхэн нөлөөлж байгааг голчлон үздэг сургууль гэх мэт)

[99] http://npost.mn/a/173473
[100] https://www.verywellmind.com/psychology-4014660

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Хүн сэтгэл судлалын талаар илүү баялаг, гүн гүнзгий ойлголттой болох нь хүмүүст өөрсдийн үйлдлүүдийг ойлгох, мөн бусад хүмүүсийг илүү сайн ойлгоход тусалдаг гэж эртний Грекийн агуу сэтгэгч Аристотель хэлсэн байдаг[101] ба энэ ч үүднээсээ сэтгэл судлал нь хүний сэтгэлгээ, сэтгэл хөдлөл, зан чанар, төлөв байдал, хөгжил зэргийг судалдаг тул өргөн цар хүрээтэй байдаг байна.

Дэлхий дахинд сэтгэл судлалын шинжлэх ухаан нь улс орон бүрт харилцан адилгүй хөгжиж байна. Дэлхийн нийт хүн амын 4 тэрбум нь Азид амьдардаг бөгөөд Ази тивд сэтгэл судлалаар Хятад Улс тэргүүлж, Япон, Солонгос гэх мэт орнууд удаалдаг байна.[102]

Харин Монгол Улсын хувьд сэтгэл судлалын шинжлэх ухааны салбар нь бусад хөгжингүй улс оронтой харьцуулахад өнөөг хүртэл хөгжиж буй төдий байсаар байна.[103]

Судалгаанаас үзэхэд, манай улсад өнөөгийн сэтгэл судлалын салбарын хууль эрх зүйн орчин хангалтгүй, тусдаа бие даасан хуульгүй нь судалгааны явцад харагдаж байна. Гадаадын зарим улс орнуудад (Япон, Филлиппин, Солонгос, Англи гэх мэт) сэтгэл судлалын салбарын эрх зүйн зохицуулалтыг тусгайлан бие даасан хуулиар зохицуулж, мэргэжлийн ёс зүйн асуудлыг нь дүрмээр зохицуулдаг бөгөөд сэтгэл судлал нь шинжлэх ухааны чухал салбарт тооцогддог тул сэтгэл судлаачдын үйл ажиллагааны эрх зүйн орчныг тодорхой болгож, практик сэтгэл судлал, мэргэжлийн холбоодын үйл ажиллагаа, сэтгэл судлаачдын бүртгэл, лиценз олголт, хариуцлага, гишүүдийн хураамж зэрэг олон асуудлуудыг нарийвчлан зохицуулсан байдаг байна.

Мөн судалгаанаас үзэхэд, манай улсын хувьд сэтгэл зүйн өвчлөлтэй хүмүүсийн тоо улам нэмэгдэж байгаа бөгөөд Ази, Номхон далайн орнуудаас сэтгэл гутралын түвшингээр 7-рт, архинд донтох, сэтгэл түгших, архаг ядаргаа зэрэг эмгэгээрээ 3-рт эрэмбэлэгдсэн байна. Эрүүл мэндийн яам, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвөөс гаргасан тайланд сэтгэц, зан үйлийн эмгэгийн тохиолдол 2000-2016 оны хооронд (16-хан жилийн дотор) 30 хувиар нэмэгдсэн нь дэлхийн дунджаас 3 дахин хурдтай өссөн байгааг дурдсан байна.[104]

Энэхүү сэтгэл зүйн өвчлөлүүд нь ч дэлхий дахинд тулгарч байгаа асуудлуудын нэг мөн бөгөөд эрүүл мэнд, боловсролын салбарын хүрээнд энэ асуудалд ихээхэн анхаарал хандуулж, мэргэшсэн боловсон хүчин бэлтгэх (өсвөр насны хүүхдүүдийн сэтгэл судлал, гэр бүлийн сэтгэл судлал, нийгмийн сэтгэл судлал, сурган хүмүүжүүлэх сэтгэл судлал зэрэг) мэргэжилтнүүдийг давтан сургах, мэргэшүүлэх хэрэгцээ шаардлага өндөр байна. Учир нь дэлхий дахинд өсөн нэмэгдэж буй сэтгэл зүйн өвчлөлийн асуудал дэлхий нийтийн анхаарлыг татаж байгаа бөгөөд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас энэ асуудалд онцгойлон анхаарах шаардлагатай байгаа тухай дурдсан байна.[105]

Нөгөөтэйгүүр дэлхий дахинд сэтгэл зүйн өвчлөл өсөн нэмэгдсэнтэй холбоотойгоор үүнийг дагаад сэтгэл зүйн үйлчилгээний эрэлт хэрэгцээ нэмэгдэж, өнөөдөр сэтгэл судлалын мэргэжил дэлхийн хамгийн эрэлттэй 10 мэргэжлийн нэгэнд тооцогдож байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[101] Сэтгэл зүйд өөрөө суралцах нь. 58 дахь тал. УБ хот, 2005 он Д.Доржжав
[102] Сэтгэл судлалын хөгжлийн түүх. Хоёрдугаар дэвтэр УБ. 2008 он. Б.Оюунчимэг.
[103] Сэтгэл зүйд өөрөө суралцах нь. 47 дахь тал. УБ хот, 2005 он Д.Доржжав
[104] НХХЯ, 2003-2016; СЭМҮТ-ийн статистик тайлан, 2014-2016
[105] WHO and Fountain House (2015). Ecxess mortality in persons with severe mental disorders

### *2. Сэтгэл судлалын салбарын хүний нөөц, боловсон хүчин бэлтгэх тогтолцоо, хэрэгцээ шаардлага*

Судалгаанаас үзэхэд, манай улсын хувьд ч гэсэн энэ мэргэжлээр суралцах хүсэлтэй хүмүүсийн тоо сүүлийн жилүүдэд нэмэгдсэн бөгөөд[106] сэтгэл судлаачдын эрэлт хэрэгцээ ирэх 10 жилийн хугацаанд бүх ажил мэргэжлийн дунджаас ойролцоогоор 4 хувиар өсөх төлөвтэй гэжээ.[107]

Гэхдээ ажил эрхлэлтийн өсөлт нь мэргэшсэн (сэтгэл судлалын багш, хүүхдийн сэтгэл судлаач, мэдрэлийн сэтгэл судлаач гэх мэт) байдлаасаа хамаарч өөр өөр байна. Учир нь сургууль, эмнэлэг, сэтгэцийн эрүүл мэндийн төв, нийгмийн үйлчилгээний агентлагуудад сэтгэл зүйн үйлчилгээ авах эрэлт их байгаа учраас дээрх чиглэлээр сэтгэл судлаачдын ажил эрхлэлт нэмэгдэх магадлалтай байна.

Монгол Улс дахь сэтгэл судлаачдын хөдөлмөр эрхлэлтийн судалгаанаас үзэхэд[108] сэтгэл судлаач мэргэжлээр 435 хүн төгссөнөөс 50-иас дээш хувь нь эрүүл мэндийн байгууллага, их, дээд сургууль болон шинжлэх ухааны (жишээлбэл, Анагаах ухааны их сургууль эсхүл эмнэлэг) салбарт ажиллаж байна. Бусад нь шүүх, прокурор, цагдаа, батлан хамгаалах, хил хамгаалах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага зэрэг цөөн хэдхэн байгууллагад мэргэжлийн сэтгэл зүйчид ажиллаж байна. (Дэлгэрэнгүйг 3 дахь хэсгээс харна уу)

Сэтгэл судлалын мэргэжлээр олон салбарт ажиллах боломж байдаг бөгөөд гагцхүү тухайн хүний мэргэшсэн байдлаас шалтгаалдаг байна.

Гадаад орнуудын жишгээс үзэхэд, сэтгэл судлалын мэргэжлээр бакалаврын боловсрол эзэмшсэний дараа дахин тухайн чиглэлээр сургалтанд сууж, мэргэшлийн шалгалт өгч, тусгай зөвшөөрөл буюу лиценз (Англи, Япон) авдаг бол зарим улсад зөвхөн докторын зэрэг (АНУ) хамгаалсан хүн л сэтгэл судлалын мэргэжлээр ажилладаг байна.[109]

Харин манай улсын хувьд сэтгэл судлалын дээд боловсролыг их, дээд сургуульд 4 жилийн хугацаатай суралцаж эзэмшдэг бөгөөд улмаар мэргэжлээрээ ажиллах боломж зарим улс орнуудыг бодвол нээлттэй, өөрөөр хэлбэл ямар нэгэн тусгай зөвшөөрөл, мэргэжлийн гэрчилгээ шаардахгүйгээр төгсөөд шууд ажиллах боломжтой байдаг байна.

Сэтгэл зүйн мэргэжил нь ажил эрхлэлт, гэр бүлийн амьдрал болон сэтгэцийн аливаа тулгамдсан асуудалд, жишээ нь сэтгэлийн дарамт, сэтгэл гутрал, боловсрол гэх мэт хүний амьдралын өдөр тутмын олон талт үйл ажиллагаанд хэрэглэгддэг тул чухал мэргэжил юм. Тиймээс нийгэмд энэ бүх мэдлэг, мэдээллийг түгээх, шаардлагатай үед мэргэжлийн туслалцаа үзүүлдэг мэргэжлийн боловсон хүчнийг зайлшгүй бэлтгэх шаардлагатай.

Судалгаанаас үзэхэд Монгол Улсад анх “Сэтгэл судлал”-ын мэргэжлийн ангийг МУБИС-д 1991-1992 оны хичээлийн жилд шинээр нээж, 1995 онд анхны төгсөлтөө хийсэн түүхтэй байна. Үүнээс хойш одоогийн байдлаар 9 их, дээд сургуулиудад сэтгэл судлалын чиглэлээр мэргэжилтнүүдийг бэлтгэж байна. Тэдгээрээс 1911 оюутан сэтгэл судлал мэргэжлээр төгссөнөөс 19.3 хувь буюу 446 нь мэргэжлээрээ ажиллаж байна.[110]

[106] https://www.meds.gov.mn/statistics-industry?category_id=11403
[107] Ерөнхий боловсролын сургуульд сэтгэл зүйч ажиллуулах асуудлаар санал боловсруулах ажлын хэсгийн тайлан УБ хот 2021 он.
[108] МУИС-ын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгааны тайлан УБ хот. 2020 он
[109] https://link.springer.com/article/10.1007/s12124-020-09545-0
[110] https://www.meds.gov.mn/statistics-industry?category_id=11403

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Эдгээр статистик мэдээллүүдээс харахад, хэдийгээр энэ мэргэжлээр суралцах элсэгчдийн тоо сүүлийн жилүүдэд нэмэгдэж байгаа хэдий ч бусад мэргэжилтэй харьцуулахад элсэлт харьцангуй цөөн, мэргэжлээрээ төгсөж буй төгсөгч ч цөөхөн байна. (Дэлгэрэнгүйг 3 дахь хэсгээс харна уу)

Иймээс Монгол Улсад сэтгэл судлалын шинжлэх ухааны салбарыг хөгжүүлэхэд гадаадын сайн туршлагуудыг нэвтрүүлэхээс гадна шаардлагатай эрх зүйн орчныг бүрдүүлэн, чадвартай мэргэшсэн боловсон хүчнийг бэлтгэх, хүний нөөцийг бүрдүүлэх шаардлагатай бөгөөд энэ салбарыг бодлогоор дэмжих хэрэгцээ шаардлага байна.

***3. Гадаадын зарим орны туршлага, эрх зүйн зохицуулалт***

Судалгаанд авагдсан орнуудын нийтлэг жишгийг авч үзвэл “сэтгэл зүйч”- гэж сэтгэл судлалын бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй, сэтгэл зүйчээр ажиллах тусгай зөвшөөрөл авсан байх, тодорхой хугацаанд хуримтлуулсан мэргэшсэн боловсон хүчин байхыг шаарддаг байна.

Сэтгэл зүйч нь ганцаарчилсан болон бүлгийн зөвлөгөө өгөх, сэтгэл зүйн сургалт явуулах, үнэлгээ хийх, үйлчлүүлэгчтэй нягт уялдаа холбоотой хамтран ажиллах гэх мэт олон чиглэлийн үйлчилгээг үзүүлдэг.

Сэтгэл судлалын шинжлэх ухаан нь салбар дундын асуудлыг хамарсан шинжлэх ухааны ихээхэн чухал салбарт тооцогддог тул үйл ажиллагаануудыг нь бие даасан хуулиар нарийвчлан зохицуулсан туршлага дэлхийн орнуудад байна. Тухайлбал, Зарим улсад (Филиппин Улс) утсаар болон цахимаар зөвлөгөө өгдөг “Дуудлагын төв” маягийн тогтолцоо байдаг бол Япон Улсад практикийн сэтгэл зүйчид ерөнхий боловсролын сургуулиудад цагаар очиж ажиллан зөвлөгөө өгдөг, сэтгэл зүйн алба ажиллуулдаг тогтолцоо ч байна.

Монгол Улсын хувьд энэ салбарын эрх зүйн зохицуулалт, тогтолцоог бусад орнуудын жишигт нийцүүлэхийн тулд өөрийн орны нөөц боломж, онцлогт тохирсон зөв систем, сайн тогтолцоог бүрдүүлэх Үндэсний хөтөлбөр боловсруулж үе шаттай хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага байж болох юм.

Сэтгэл судлалын салбарын тогтолцоонд мэргэжлийн холбоод чухал үүрэгтэй оролцдог нь судалгаанаас харагдаж байна. Тухайлбал, сэтгэл судлаачдын мэргэшсэн сургалтыг тогтмол зохион байгуулах, тусгай зөвшөөрөл олгох, цуцлах, хяналт тавихтай холбоотой практик үйл ажиллагаа, мэргэшсэн хяналтыг салбарын өөрөө өөрийгөө зохицуулах байгууллага буюу мэргэжлийн холбоод гүйцэтгэдэг, эдгээр холбоод тодорхой хэмжээний эрх, үүрэгтэйгээр салбарын үйл ажиллагаанд оролцдог жишиг дэлхийн практикт байна.

Судалгааны явцад Филиппин Улсын Сэтгэл судлалын тухай хууль, Япон Улсын Мэргэжлийн сэтгэл судлаачийн тухай хуулийн албан бус орчуулга хийж хавсаргав.

/Мэдээллийн дэлгэрэнгүйг судалгааны хэсгээс үзнэ үү/

UIH.MN СУДАЛГААНЫ САН

## НЭГ. МОНГОЛ УЛСЫН СЭТГЭЛ СУДЛАЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Орчин үед сэтгэл судлал нь асар олон тооны салбар ухааныг өөртөө багтаасан мэдлэгийн өргөн хүрээтэй салбар болон хөгжиж байна. Тэдгээрээс мөн маш олон салбар (өсвөр насны хүүхдүүдийн сэтгэл судлал, гэр бүлийн сэтгэл судлал, нийгмийн сэтгэл судлал, сурган хүмүүжүүлэх сэтгэл судлал зэрэг) шинжлэх ухаан, бие даасан мэдлэгийн салбар болж, өөр бусад шинжлэх ухаануудтай илүү нягт уялдаатай хөгжих болсон нь анхаарал татаж буй.

Америкийн эрдэмтэн Роналд 2008 оны судалгаандаа дэлхийд сэтгэл судлалын шинжлэх ухаан улс оронд харилцан адилгүй хөгжиж буй тухай дурдсан байдаг.[111]

Сэтгэл судлалын чиглэлээр олон улсын хэмжээнд нийт судалгаа, эрдэм шинжилгээний өгүүллийн 75% нь Америкчуудад зориулсан ба мөн тэднээс авсан судалгаа байдаг, 25% нь Европ, үлдсэн 5% нь Азийн орнуудад ногдох аж. Дэлхийн нийт хүн амын 4 тэрбум нь Азид амьдардаг. Азид сэтгэл судлалын тэргүүлэгч нь Хятад улс бөгөөд дараа нь Япон, Солонгос гэх мэт орнууд ордог байна.

Нэрт судлаач, профессор Д.Санжжав: Монгол Улсын хувьд сэтгэл судлал тодорхой цагийн эрхээр үүсч хөгжсөөр ирсэн ч өнөөг хүртэл сэтгэлгээний хүрээнээс хальж, бүрэн төгс “хэрэглэгдэж” чадахгүй байсаар байна[112] гэжээ. Өөрөөр хэлбэл, сэтгэл судлалын шинжлэх ухааны хөгжил зогсонги байдалтай байна гэж хэлэхэд хилсдэхгүй юм.

Анхлан манай улсад 1969-1970 онд Улсын багшийн дээд сургуульд сэтгэл судлаач, профессор Д.Санжжавын санаачилгаар “сэтгэл судлал”-ын анхны хичээлийг зааж байсан нь сэтгэл судлаач мэргэжилтэн бэлтгэх эх үндсийг тавьсан гэж үздэг.[113] Үүнээс хойш 1991 оноос эхлэн их, дээд сургуулиудад оюутнуудыг бэлтгэж сэтгэл судлалын мэргэжлээр төгсгөх болсон бөгөөд улмаар “***сэтгэл судлаач***” эсхүл “***сэтгэл зүйч***” гэж нэрлэх болжээ.

Уг нэршлийн хүрээнд сэтгэл судлалын эрх зүйн зохицуулалтыг манай улсад хэрхэн зохицуулсан талаар сонирхон Монгол Улсын хуулийн нэгдсэн портал сайт болох www.legalinfo.mn хайлт хийж үзэхэд, илэрц бага олдсон бөгөөд “сэтгэл зүйч” гэсэн үгээр хайлт хийхэд (2021 оны 10 дугаар сарын 12-ны байдлаар) нийтдээ 485 илэрц гарсан юм. Эдгээр нь тодорхой хэдэн хуулиудад байгаагаас гадна янз бүрийн түвшний тогтоол, шийдвэрүүдэд орсон илэрцүүд байсан. Зөвхөн хууль, журманд туссан болон дараагийн дэд сэдвийн хүрээнд ашиглах үүднээс гол зохицуулалтуудыг түүвэрлэн авлаа. Ихэнх нь батлан хамгаалах, хил хамгаалах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагууд, хүний эрхийг хамгаалах чиглэлийн хууль тогтоомжуудад туссан байна. (Хүснэгт 1)

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[111] Сэтгэл судлалын хөгжлийн түүх. Хоёрдугаар дэвтэр УБ. 2008 он. Б.Оюунчимэг.
[112] Сэтгэл судлал УБ хот. 1991 он. 21дэх тал. Д.Санжжав
[113] Сэтгэл судлал УБ хот. 1991 он. Д.Санжжав

**Хүснэгт 1.Сэтгэл судлалын талаарх одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжид туссан заалтууд**

| Хуулийн нэр | Хуулийн зүйл, заалт |
|---|---|
| **Бага, дунд боловсролын тухай хууль** | 13.6.Ерөнхий боловсролын тусгай сургуульд энэ хуулийн 12.6-д заасан ажилтнаас гадна хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сэргээн засах, чийрэгжүүлэх, эрүүл мэндийн анхан шатны тусламж үзүүлэх чиглэлээр мэргэшсэн эмч, сувилагч, туслах багш, сэргээн засалч, **сэтгэл зүйч** ажиллана.<br>13.10.Ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тооноос хамаарч тусгай мэргэжлийн багш, туслах багш, **сэтгэл зүйч**, сувилагч, сэргээн засалч, нийгмийн ажилтан ажиллуулж болно. |
| **Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль** | 3.1.17.“эмнэл зүйн **сэтгэл зүйч**” гэж эмнэл зүйн сэтгэл зүйгээр төрөлжсөн мэргэшил эзэмшсэн сэтгэцийн эмчийг;<br>3.1.19.“**сэтгэл зүйч**” гэж их, дээд сургуулийг сэтгэл зүйн мэргэжлээр төгссөн мэргэжилтнийг;<br>5.1.3.хэвтүүлэн эмчлэх болон эмнэл зүйн, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг сэтгэцийн эмнэлэг, аймаг, дүүргийн эмнэлэгт бий болгох, сургууль, хамт олны түвшинд **сэтгэл зүйч**, нийгмийн ажилтны баг бүрдүүлж ажиллуулах; |
| **Хүүхэд хамгааллын тухай хууль** | 6.3-д “Сургалтын байгууллагад суралцаж байгаа хүүхэд бүрийг тухайн орчинд бие махбодийн шийтгэл, сэтгэл зүйн болон үе тэнгийнхний дарамт, үл хайхрах байдал, гэмт хэрэг, зөрчил, хорт зуршилд өртөхгүй байх нөхцөлийг бүрдүүлэхийн тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ” гэж заагаад үүнийг нарийвчлан 6.3.1-д “сургалтын байгууллагын багш, ажилтан хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга эзэмших”, 6.3.2-т “сургалтын байгууллагын багш, ажилтан суралцагчдын эрсдэлт нөхцөлд байгаа эсэхийг үнэлэх, судлах, зөвлөгөө өгөх”, 6.3.3-д “сургалтын байгууллагын багш, ажилтан суралцагчдын хоорондын нөхөрсөг бус харилцаа, маргаан, зөрчлийг эвлэрүүлэх, зохицуулах, гэр бүлд нь мэдэгдэх зэргээр урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах”, 6.3.4-т “хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд хохирол учруулж болохуйц үйл ажиллагаа, арга хэмжээнд хүүхдийг оролцуулахгүй байх”, 6.3.5-д “хүүхдийг согтуурах, мансуурах, донтох байдалд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг авах” гэж заасан заалтуудыг хэрэгжүүлэхэд багш ажлын ачааллын хувьд ч, мэргэжил ур чадварын хувьд ч хүчин мөхөсдөх бөгөөд үүнийг сургуулийн **сэтгэл зүйч**ээр мэргэшсэн мэргэжилтэн л хэрэгжүүлж чадна. |
| **Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль** | 17.2.1.гэрч, хохирогчийг хамгаалалтад авсан үеэс эхлэн шаардлагатай тохиолдолд **сэтгэл зүйч**ийг байлцуулах;<br>17.2.4.шүүх хуралдааны танхимд гэрч, хохирогчтой **сэтгэл зүйч**ийг хамт байлцуулах;<br>17.3.Энэ хуулийн 23.4-т заасан **сэтгэл зүйч**ийн баг хамгаалалтад байгаа гэрч, хохирогчид үзүүлэх сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.<br>22.2.Энэ хуулийн 23.4-т заасан **сэтгэл зүйч**ийн баг нь шаардлагатай тохиолдолд гэрч, хохирогчийн сэтгэл зүйн байдлыг тодорхойлох зорилгоор энэ хуулийн 22.1.6-д заасан сэтгэл зүйн сорилыг авч, хамгаалалтын хэлбэрийг сонгох зөвлөмж гаргана.<br>23.4.Энэ хуулийн 23.2-т заасан тусгай албаны дэргэд мэргэжлийн хууль зүйн зөвлөгөө өгөх болон **сэтгэл зүйч**ийн баг ажиллана. |
| **Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр** | 3.1.1.4. хөгжлийн бэрхшээлтэй хүний эрэлт хэрэгцээг үндэслэн аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төвүүдэд ахуй засалч, хөдөлгөөн засалч, **сэтгэл зүйч**ийг ажиллуулах асуудлыг судлах; |

UILMN СУДАЛГААНЫ САН

| | |
|---|---|
| **/Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн 321 дугаар тогтоол/** | 3.1.1.6. сэргээн засах эмч, мэргэжилтэн, хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч, хэл засалч болон эмнэл зүйн **сэтгэл зүйч**, хиймэл эрхтэн, туслах хэрэгслэл хийдэг техникч зэрэг мэргэжилтнийг үе шаттайгаар гадаад, дотоодод сургах;<br>3.1.3.6. аймаг, дүүргийн эрүүл мэндийн байгууллага нь нарийн мэргэжлийн эмч, **сэтгэл зүйч,** ахуйн болон хөдөлгөөн засалчдаас бүрдсэн мэргэжлийн багийг бүрдүүлэн харьяа нутаг дэвсгэртээ оршин суугаа хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг тогтоох оношилгоо хийж дүгнэлтээ “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол нийгмийн хамгааллын салбар комисс”-т хүргүүлэх;<br>3.2.3.2. тусгай хэрэгцээт боловсролын багш, хэл засалч, хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч, дохионы хэлмэрч-орчуулагч, **сэтгэл зүйч**ийг бакалавр, магистр, докторын түвшинд гадаад, дотоодод шинээр бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтад хамруулах; |
| **Боловсролын байгууллагын сургалтын орчин, дотуур байранд хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх журам /Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн А/239 тоот тушаалын хавсралтаар/** | 3.2.3.Багш, сургуулийн эмч, нийгмийн ажилтан**, сэтгэл зүйч** нь хүүхдийн бэртэл гэмтэл, өвчлөл, сэтгэл санааны байдал, айдас, хичээл таслалт, сургууль завсардалт зэрэг хүүхдийн бие махбод, сэтгэл санаа, зан үйлд гарч байгаа сөрөг нөлөөллийн шалтгааныг тогтоох, хүчирхийллээс үүдэлтэй эсэхийг тандан судална.<br>3.3.1.Суралцагчдад сэтгэл санааны хямрал, гутрал, тогтворгүй байдлыг даван туулахад чиглэсэн үйлчилгээг нийгмийн ажилтан, хүүхдийн сэтгэл зүйн чиглэлээр мэргэшсэн **сэтгэл зүйч** үзүүлнэ. |
| **Сэтгэцийн эмгэгтэй хүний эмчилгээ, үйлчилгээ, түүнд хяналт тавих журам /Эрүүл мэндийн сайдын 2014 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 180 дугаар тушаал/** | 2.5.Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгээс илгээх бичгээр ирсэн үйлчлүүлэгчид онош тодруулах эмгэг **сэтгэл судлалын** шинжилгээ хийнэ.<br>3.2.3.Анагаахын **сэтгэл судлалын**<br>3.2.4.Эмнэл зүйн **сэтгэл судлалын** |

Дээрх хууль тогтоомжуудыг үзэхэд, сэтгэл зүйчид ажиллах боломжтой салбар, сэтгэл зүйчийн талаарх ерөнхий ойлголтыг тодорхойлж өгсөн бөгөөд сэтгэл зүйчийн эрх, үүрэг, мэргэжлийн холбоод, тэдгээрт тавигдах шаардлага зэрэг эрх зүйн зохицуулалтуудыг нарийн тусгаж өгөөгүй нь өнөөгийн сэтгэл судлалын салбарын хууль, эрх зүйн зохицуулалт учир дутагдалтайгаас гадна бие даасан зохицуулалтгүй байгаа нь харагдаж байна.

Гэтэл гадаадын зарим улс орнуудад сэтгэл судлаачийн эрх зүйн байдлыг тусгайлан хуулиар зохицуулж, мэргэжлийн ёс зүйн асуудлыг нь дүрмээр зохицуулж өгсөн байдаг. (Дэлгэрэнгүйг судалгааны 4 дэх хэсгээс үзнэ үү.)

Учир нь сэтгэл судлаач бол хүнтэй ажилладаг, хүний сэтгэл санааны өөрчлөлт, гэр бүлээс эхлээд нийгэм дэх хүмүүсийн найрсаг хамтын амьдралын төлөө ажилладаг, хүмүүсийн сэтгэцийн эрүүл мэндийн манаанд зогсдог учраас маш нарийн бэлтгэгдэж, тодорхой хэмжээний мэдлэг, чадвар, туршлага хуримтлуулж байж зөвлөн туслах, улмаар сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэхэд мэргэшиж, үйл ажиллагаа нь нарийн зохицуулагдсан байх шаардлагатай мэргэжилтэн юм.

Олон улсын байгууллагууд тухайлбал, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Дэлхийн банк болон гадаадын их сургуулиудын түүвэр судалгааны дүгнэлтүүдээс Монгол Улсын

UIH.MN СУДАЛГААНЫ САН

хүн амын сэтгэцийн өвчлөл ямар нөхцөл байдалд байгааг авч үзэхэд, Ази, Номхон далайн орнуудаас сэтгэл гутралын түвшингээр 7-рт, архинд донтох, сэтгэл түгших, архаг ядаргаа зэрэг эмгэгээрээ 3-рт эрэмбэлэгддэг байна. Эрүүл мэндийн яам, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвөөс гаргасан тайланд сэтгэц, зан үйлийн эмгэгийн тохиолдол 2000 онд 10 мянган хүн тутамд 77.4 хувьтай байсан бол 2016 онд 109.5 болж нэмэгдсэн. Ердөө 16-хан жилийн дотор 30 хувиар нэмэгдсэн нь дэлхийн дунджаас 3 дахин хурдтай өссөн[114] байгааг харж болно.

Ийнхүү орчин үед сэтгэл зүйн тулгамдсан асуудалтай хүмүүсийн тоо өдрөөс өдөрт нэмэгдсээр байгаа бөгөөд үүнд сэтгэл судлалын шинжлэх ухааны салбарынхан анхаарал хандуулж, мэргэшүүлэх зайлшгүй шаардлагатай. Учир нь өнөөгийн сэтгэл зүйн өвчлөл сэтгэл судлалын шинжлэх ухааны салбарт тулгамдаж байгаа томоохон асуудлуудын нэг мөн бөгөөд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас ч энэ асуудалд онцгойлон анхаарах зайлшгүй хэрэгцээ шаардлагатайг дурдсан байдаг.

**Сэтгэл судлал бол хэний ч ойлгохгүй байгаа зүйлсийг хүн бүхний ойлгох хэл дээр тайлбарладаг шинжлэх ухаан гэж үздэг байна.[115]** Энэ ч үүднээс сэтгэл судлалын шинжлэх ухаан бусад шинжлэх ухааны суурь үндэс гэх ба томоохон шинжлэх ухаанд тооцогддог байна.

Гэвч манай улсын хувьд хууль тогтоомжийн зохицуулалт нь хэт ерөнхий, хүний нөөц боловсон хүчин, төсөв мөнгө хомс, удирдлага зохион байгуулалтын нэгдсэн тогтолцоо байхгүй зэрэг олон шийдвэрлээгүй тулгамдсан асуудлуудаас болж сэтгэл судлалын шинжлэх ухааны салбарын хөгжил өнөөг хүртэл зогсонги байдалтай байна.

Иймд цаашид уг шинжлэх ухааны салбарт бие даасан хууль, эрх зүйн орчинг бүрдүүлж өнөөгийн сэтгэл судлалын хөгжилд анхаарах цаг нь болжээ.

**Дүгнэлт:**

- Монгол Улсад сэтгэл судлалын шинжлэх ухаан нь хөгжиж буй төдий байна.
- Хууль эрх зүйн орчин хангалтгүй байна.
- Сэтгэл зүйн өвчлөл улам нэмэгдсээр байна.
- Удирдлага зохион байгуулалтын нэгдсэн тогтолцоо байхгүй, бодлого тодорхойгүй байна.

## ХОЁР. СЭТГЭЛ СУДЛААЧИД МЭРГЭЖЛЭЭРЭЭ АЖИЛЛАХ БОЛОМЖ НӨХЦӨЛ, АЖЛЫН БАЙРНЫ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын тооцооллоор 2030 он гэхэд дэлхий нийтийн хамгийн том асуудал бол эдийн засаг, байгаль орчны асуудал бус “сэтгэл гутрал”-аас үүдэлтэй асуудал болсон байна гэж үзсэн.[116]

Сэтгэцийн эмгэгтэй хүмүүс ердийн хүнээс 20 жилээр бага насалдгийг Дэлхийн эрүүл мэндийн байгууллага мөн нотолсон байна.[117] Иймээс сэтгэл зүйн үйлчилгээний эрэлт хэрэгцээ дэлхий даяар өсөн нэмэгдэж сэтгэл судлалын мэргэжил дэлхийн хамгийн эрэлттэй 10 мэргэжлийн тоонд орсон байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[114] НХХЯ, 2003-2016; СЭМҮТ-ийн статистик тайлан, 2014-2016
[115] Аристотелийн гүн ухааны сургаал
[116] Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн А/126 тоот тушаалаар байгуулагдсан Ерөнхий боловсролын сургуульд сэтгэл зүйч ажиллуулах асуудлаар санал боловсруулах ажлын хэсгийн тайлан. 2 дахь таль. 2021 он. УБ хот
[117] WHO and Fountain House (2015). Excess mortality in persons with severe mental disorders.

Манай улсад ч гэсэн энэ хэрэгцээ шаардлагыг мэдэрч сэтгэл судлалаар суралцах хүсэлтэй оюутнуудын тоо сүүлийн жилүүдэд нэмэгдэж байна. Зөвхөн МУИС-д сэтгэл судлалаар элсэгчдийн тоо гэхэд л 2015 оноос хойш хоёр дахин нэмэгджээ.[118]

Харамсалтай нь манай улсад шүүх, прокурор, цагдаа, батлан хамгаалах, хил хамгаалах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага зэрэг цөөн байгууллагуудад мэргэжлийн сэтгэл зүйчийн орон тоогоор ажиллаж байна. Гэхдээ хууль тогтоогчид энэ мэргэжлийн чухлыг ойлгож холбогдох хууль тогтоомжуудад сэтгэл зүйч ажиллах заалтыг тусгадаг ч гэсэн холбогдох газруудад орон тоо, төсөв мөнгийг нь шийдэхгүй байгаагаас хууль тогтоомжууд хэрэгжихгүй, төгссөн мэргэжилтнүүд ажилгүйчүүдийн эгнээнд шилжиж байна. (Дэлгэрэнгүй судалгааны 3 дахь сэдвээс харна уу)

Жишээ нь: 2002 онд Бага, дунд боловсролын тухай хуульд Ерөнхий боловсролын сургуульд сэтгэл зүйч ажиллуулахаар заасан ч энэ нь өнөөдөр хүртэл бодит ажил болоогүй байна. Мөн УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын “Хүний хөгжил” гэсэн хоёрдугаар бүлгийн 2.1.22-т “Сурагч болон багшид сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх, суралцагчдад мэргэжлээ сонгох, ирээдүйгээ төлөвлөхөд нь зөвлөн туслах чиг үүрэгтэй сэтгэл зүйч мэргэжилтнийг **сургууль бүрд** ажиллуулна”, 2.1.23-д “Сэтгэл зүйч болон хүний хөгжлийн чиглэлээр хос мэргэжилтэн бэлтгэнэ” гэж заасан.

Гэтэл Монгол Улсын хэмжээнд 2020 оны байдлаар ерөнхий боловсролын 839 сургуульд нийт 76 сэтгэл зүйч үндсэн орон тоогоор ажиллаж байна. Үүнээс 85.5 хувь буюу 65 нь мэргэжлийн сэтгэл зүйч, 14.4 хувь буюу 11 нь мэргэжлийн бус хүмүүс ажиллаж байна.[119]

Дээрх хуулийн зохицуулалтыг харахад ерөнхий боловсролын сургууль бүрд сэтгэл зүйч байх ёстой бөгөөд өнөөдөр 763 сургууль мэргэжлийн сэтгэл зүйчгүй байна.

Уг жишээнд дурдсан хууль, тогтоомжоос харахад ерөнхий боловсролын сургуульд сэтгэл зүйч ажиллах эрх зүйн орчин бүрэн бүрдсэн гэлтэй.

Манай улсад сэтгэл судлаачдын хөдөлмөр эрхлэлтийг салбараар нь ангилвал ажил олгогчид дараах байдалтай байна.[120]

| № | Хөдөлмөр эрхэлж буй салбар | Хувь |
|---|---|---|
| 1 | Эмнэлэг - төрийн, орон нутгийн, хувийн | 38% |
| 2 | Бага, дунд сургууль - төрийн, орон нутгийн, хувийн | 20% |
| 3 | Амбулторын эрүүл мэндийн үйлчилгээ | 18% |
| 4 | Шүүх, цагдаа, онцгой байдал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх зэрэг | 10% |
| 4 | Хувиараа хөдөлмөр эрхлэгчид | 8% |
| 5 | Бусад | 6% |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Сэтгэл судлаачид ихэвчлэн эрүүл мэндийн байгууллага, их, дээд сургууль болон шинжлэх ухааны (жишээлбэл, анагаах ухааны сургууль эсхүл эмнэлэг) салбарт ажиллаж

[118] МУИС-ын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгааны тайлан УБ хот. 2020 он
[119] https://www.meds.gov.mn/post/70624
[120] 1911 төгсөгч төгссөн байгаагаас 17.3 хувь буюу 331 нь мэргэжлээрээ ажиллаж байна гэсэн статистик мэдээлэл байдаг

байна. Мөн зарим нь шүүх, прокурор, цагдаа, батлан хамгаалах, хил хамгаалах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага зэрэг бусад салбарт ажилладаг байна.

Зарим хүмүүсийн үзэж байгаагаар сэтгэл судлалын салбарт боломж хомс байдаг гэж бодож болох ч хөдөлмөр эрхлэлтийн хувьд хангалттай боломжууд байдаг. Сэтгэл судлал бол ажлын байрны хувьд тийм ч бага боломж олгодог салбар биш юм. Тухайлбал:

- Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх төвд сэтгэл судлаач;
- ЕБС-д сэтгэл судлаач;
- Шүүх, прокурор болон цагдаа, онцгой байдал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх зэрэг хүчний байгууллагад сэтгэл судлаач;
- Гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудлаар ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагад сэтгэл судлаач;
- Улсын хэмжээний болон дүүргийн нэгдсэн эмнэлэгт сэтгэл судлаач;
- Хүүхдийн халамж асрамжийн төвд сэтгэл судлаач;
- Тусгай хэрэгцээт хүүхдүүдэд боловсрол олгох төвд сэтгэл судлаач;
- Хүмүүнлэгийн болон олон улсын байгууллагад сэтгэл судлаач;
- Судалгаа шинжилгээний байгууллагад судлаач;
- Хувь хүний хөгжлийн зөвлөх (ментор);
- Их, дээд сургуулийн сэтгэл судлалын багш.

Дээрх салбаруудыг үзэхэд, сэтгэл судлалын мэргэжлээр олон салбарт ажиллах боломж бий бөгөөд гагцхүү мэргэшсэн байдал нь ажлын байрны төлөв байдалд (Хүүхдийн сэтгэл судлал, шүүгчийн сэтгэл судлал, нийгмийн сэтгэл судлал гэх мэт) нөлөөлөхөөр байгаа юм.

Манай улсын хувьд сэтгэл судлалын боловсролыг их, дээд сургуульд 4 жилийн хугацаагаар суралцаж эзэмшдэг бөгөөд улмаар мэргэжлээрээ ажиллахад зарим улс орныг бодвол тусгай зөвшөөрөл шаардахгүйгээр шууд ажиллах боломжтой байдаг.

Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.19-д “**сэтгэл зүйч**” гэж их, дээд сургуулийг сэтгэл зүйн мэргэжлээр төгссөн мэргэжилтнийг хэлнэ гэж тодорхойлжээ.

Харин тухайн мэргэжлээр багшлах, эрүүл мэндийн болон хүчний байгууллагад ажиллах (цагдаа, онцгой байдал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх зэрэг) бол богино хугацааны мэргэшсэн сургалтанд суудаг байна.

Дэлхийн зарим улс оронд сэтгэл судлалын мэргэжлээр бакалаврын боловсрол эзэмшсэний дараа дахин тухайн нарийвчилсан чиглэлээр сургалтанд сууж, мэргэшлийн шалгалт өгч, тусгай зөвшөөрөл буюу лиценз (Англи, Япон) авснаар ажиллах эрхтэй болдог бол зарим улсад зөвхөн докторын зэрэг (АНУ) хамгаалсан хүн сэтгэл судлалын мэргэжлээр ажиллах боломжтой болдог байна.[121]

Энэ нь нэг талаасаа сэтгэл судлалын мэргэжлээр ажиллахад шалгуур өндөртэй гэдэг ч нөгөө талаасаа мэргэжлийн чадварлаг мэргэжилтэн бэлтгэгддэг байна.

АНУ-ын Хөдөлмөрийн Статистикийн Товчооны (BLS) мэдээлснээр дэлхийн улс оронд сэтгэл судлалын мэргэжлийн эрэлт хэрэгцээ ихсэх хандлага их байна гэж мэдээлжээ. Тухайлбал: АНУ-д сэтгэл судлаачдын ажил эрхлэлт 2014-2024 оны хооронд 19 хувиар, сэтгэцийн эмч нарын ажил эрхлэлт 15 хувиар, нийгмийн ажилтнууд 12 хувиар тус тус

[121] https://link.springer.com/article/10.1007/s12124-020-09545-0

UIH.MN СУДАЛГААНЫ САН

өсөх төлөвтэй байна. Энэ нь дунджаар 7 хувийн өсөлттэй байх бусад ажил мэргэжилтэй харьцуулахад харьцангуй хурдтай өсөхөөр төлөвтэй байна.[122]

Манай улсын хувьд Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн А/126 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн тайланд дурдсанаар сэтгэл судлаачдын эрэлт хэрэгцээ ирэх 10 жилд ойролцоогоор 4 хувиар өсөх төлөвтэй байна.[123] Харин ажил эрхлэлтийн өсөлт нь нарийн мэргэшлээс (сэтгэл судлалын багш, хүүхдийн сэтгэл судлаач, мэдрэлийн сэтгэл судлаач гэх мэт) хамаарч өөр өөр байхаар байна. Учир нь сургууль, эмнэлэг, сэтгэцийн эрүүл мэндийн төв, нийгмийн үйлчилгээний агентлагуудад сэтгэл зүйн үйлчилгээ авах эрэлт их байгаа тул эмнэлзүйн зөвлөгөө өгөх, сургуулийн сэтгэл судлаачдын ажил эрхлэлт нэмэгдэх магадлалтай байна. Хүмүүс тулгарсан сэтгэл зүйн асуудлаа ойлгох, түүнд гарц олохын тулд сэтгэл зүйчид ихээр хандах тусам клиник болон зөвлөгөө өгөх сэтгэл судлаачдын эрэлт нэмэгдэх шалтгаан болж байж болох юм.

Мэдээж энэ чиглэлийн ажлын байр өсөлттэй байх тусам сэтгэл судлалын мэргэжлийн эрэлт хэрэгцээ их байхаар байна.

## ГУРАВ. СЭТГЭЛ СУДЛАЛЫН БОЛОВСРОЛ ОЛГОХ ТОГТОЛЦОО, МЭРГЭЖЛИЙН ХҮНИЙ НӨӨЦ БҮРДҮҮЛЭЛТ

Дэлхий нийтэд сэтгэл зүйн өвчлөл нэмэгдэж байгаа энэ цаг үед сэтгэл судлалын мэргэжил ихээхэн чухал мэргэжилд тооцогдох нь гарцаагүй. Энэ ч үүднээс сүүлийн жилүүдэд дэлхийн улс орнууд сэтгэл судлалын (сэтгэл зүйч) боловсрол олгох тал дээр онцгойлон анхаарч, **чадвартай** боловсон хүчнийг бэлтгэсээр байна.

Манай улсын хувьд 1991 оноос эхлэн Монгол Улсын Боловсролын Их сургуульд сэтгэл судлалын мэргэжилтэн бэлтгэсэн бөгөөд тэр үеэс хойш хэд хэдэн их, дээд сургуулиудад мэргэжилтэн бэлтгэж эхэлжээ.

Одоогийн байдлаар улсын хэмжээнд 85 их, дээд сургууль, коллеж байгаагийн 9 сургууль нь сэтгэл судлалын мэргэжилтэн бэлтгэн төгсгөж байна.[124] (Хүснэгт 2)

**Хүснэгт 2.Сэтгэл судлалын хөтөлбөрийг хэрэгжүүлж буй сургуулийн мэдээлэл**

| № | Сургуулийн нэр | Сэтгэл судлаач бэлдэж эхэлсэн он | Тодорхой мэргэшүүлж буй чиглэл |
|---|---|---|---|
| 1 | Монгол Улсын Их сургууль | 1992 | Нийгмийн сэтгэл судлал, сурган хүмүүжүүлэх ба хөгжлийн сэтгэл судлал |
| 2 | Монгол Улсын Боловсролын Их сургууль | 1991 | Сэтгэл судлаач |
| 3 | Хүмүүнлэгийн Ухааны их сургууль | 2007 | Ерөнхий |
| 4 | Улаанбаатар Эрдэм Их Сургууль | 2010 | Хүүхдийн сэтгэл судал |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[122] https://www.apa.org/monitor/2017/11/trends-popular
[123] Ерөнхий боловсролын сургуульд сэтгэл зүйч ажиллуулах асуудлаар санал боловсруулах ажлын хэсгийн тайлан УБ хот 2021 он.
[124] https://www.meds.gov.mn/statistics-industry?category_id=11403

| | | | |
|---|---|---|---|
| 5 | Отгонтэнгэр Их сургууль | 2017 | Сэтгэл судлаач |
| 6 | Шинжлэх Ухаан Технологийн их сургууль | | |
| 7 | Дотоод Хэргийн Их сургууль | 2002 | Сэтгэл зүйн бэлтгэлийн офицер |
| 8 | Нийгэм Сэтгэл судлалын дээд сургууль | 1994 | |
| 9 | Олон Улсын Улаанбаатар Их сургууль | 2020 | гэр бүл, хүүхдийн сэтгэл зүйч |
| | | | |

Судалгааны баг нь дээрх сургуулиудтай холбогдож тухайн мэргэжлээр нийт төгссөн төгсөгчдийн тоон мэдээллээс гадна ажил эрхлэлтийн байдлыг тодруулахд сэтгэл судлалын мэргэжлээр 1911 төгсөгч төгссөн байгаагаас 19.3 хувь буюу 446 нь мэргэжлээрээ ажиллаж байна. (Хүснэгт 3)

**Хүснэгт 3.Сургуулиудын сэтгэл судлалын хөтөлбөрөөр нийт төгссөн төгсөгчдийн мэдээлэл**

| № | Сургуулийн нэр | Нийт төгсөгчийн тоо | Мэргэжлээр ажил эрхэлж байгаа төгсөгчийн тоо |
|---|---|---|---|
| 1 | Монгол Улсын Их сургууль | 678 (600/Баклавр/ ,78/Магистр/) | 280 |
| 2 | Монгол Улсын Боловсролын Их сургууль | 888 | 80 |
| 3 | Хүмүүнлэгийн Ухааны их сургууль | 300 | Судалгаа хийгээгүй байсан |
| 4 | Улаанбаатар Эрдэм Их Сургууль | 77 | 35 |
| 5 | Отгонтэнгэр Их сургууль | 2021.06 сард анхны төгсөлт | 5 |
| 6 | Шинжлэх Ухаан Технологийн их сургууль | | Мэдээллийг авах боломжгүй байсан |
| 7 | Дотоод Хэргийн Их сургууль | 274 | 30 |
| 8 | Нийгэм Сэтгэл судлалын дээд сургууль | 372 | 16 |
| 9 | Олон Улсын Улаанбаатар Их сургууль | | Мэдээллийг авах боломжгүй байсан |
| Нийт | | 1911 | 446 |

Мөн Боловсрол, шинжлэх ухааны яамнаас гаргасан “хичээлийн жилийн статистик мэдээ”-ний сүүлийн хоёр жилийн хугацааны статистик тоо баримтыг үзэхэд сэтгэл судлалын хөтөлбөр хэрэгжүүлж буй нийт их, дээд сургуульд сэтгэл судлалын мэргэжлээр жилд дунджаар 435-457 оюутан шинээр элсэж байна.[125]

[125] https://www.meds.gov.mn/statistics-industry?category_id=11403

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Харин нийт элсэгчдийн 50 хувь буюу 178-210 оюутан сэтгэл судлалын мэргэжлээрээ төгсдөг байна. (Хүснэгт 4, 5)

**Хүснэгт 4.Нийт сэтгэл судлалын мэргэжилд шинээр элсэгчдийн статистик мэдээлэл**

| № | Элссэн он | Нийт суралцагсад | Эр | Эм | Боловсролын түвшин | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Баклавар | Магистр | Доктор |
| 1 | 2019 | 435 | 90 | 345 | 341 | 92 | 2 |
| 2 | 2020 | 457 | 95 | 362 | 363 | 92 | 2 |

**Хүснэгт 5.Нийт сэтгэл судлалаар төгссөн төгсөгчдийн статистик мэдээлэл**

| № | Төгссөн он | Нийт суралцагсад | Эр | Эм | Боловсролын түвшин | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Баклавар | Магистр | Доктор |
| 1 | 2019 | 178 | 34 | 133 | 167 | 10 | 1 |
| 2 | 2020 | 210 | 48 | 162 | 197 | 10 | 3 |

Дээрх статистик мэдээллүүдээс үзэхэд, сэтгэл судлалын мэргэжлийг **бусад мэргэжилтэй** харьцуулахад харьцангуй цөөхөн оюутан сонгож байгаагаас гадна энэхүү мэргэжлээрээ төгсөж буй төгсөгч цөөхөн байна. Голдуу их, дээд сургууль төгсөгчдийн хувьд нийгэм-эдийн засаг, хууль эрх зүй, анагаах ухаан, бүх төрлийн инженерийн чиглэлээр суралцаж төгсөх нь бусад мэргэжилтэй харьцуулахад илүү байна.

Түүнчлэн сэтгэл судлалын мэргэжлээр төгссөн мэргэжилтнүүд тухайн мэргэжлээрээ ажиллаж байгаа нь цөөхөн байх бөгөөд ихэнх нь хувийн хэвшилд хүний нөөцийн менежер, маркетингийн болон санхүүгийн чиглэлийн ажилтан эрхэлж байгаа бол зарим хэсэг нь мэргэжлээрээ сэтгэл зүйн зөвлөгөө өгдөг Төрийн бус байгууллага, компани байгуулан ажиллаж байна[126]

Сэтгэл судлалын боловсрол бол нийгмийг эрүүлжүүлэх үйлсэд ихээхэн хувь нэмэр оруулдаг чухал салбар юм. Дэлхийн улс орны эрүүл мэндэд сайнаар нөлөөлөх хандлагад сэтгэл судлаач мэргэжил хүчтэй байр суурь эзэлсээр байна.

Тиймээс улс орнуудад орчин үеийн сэтгэл судлалаар **чадвартай боловсон** хүчин бэлтгэх хандлага улам нэмэгдэж байх бөгөөд сэтгэл зүйн онол, практикт илүү ихээр сургах замаар сэтгэл судлалын боловсрол олгох тал дээр анхаарч байна.

Манай улсын хувьд ч гэсэн энэ хандлага руу шилжих шаардлага зүй ёсоор тулгарч байгаа бөгөөд их, дээд сургуульд сэтгэл судлалын мэргэжлээр **чадвартай боловсон хүчин бэлтгэх** тал дээр онцгойлон анхаарах шаардлага бий.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[126] Сэтгэл судлалын хөтөлбөрийг хэрэгжүүлж буй сургуулиудтай холбогдон тодруулж авсан

## ДӨРӨВ. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

### 4.1. Филиппин Улс

Сэтгэл судлаачид бол сэтгэцийн өвчлөлд хүрэхэд ойрхон болсон хүмүүст сэтгэл зүйн зөвлөгөө өгөх бөгөөд тэдэнд тодорхой сэтгэл зүйн асуудлууд, тэр дундаа хүн хоорондын харилцаа болон шийдвэр гаргахад тулгарсан хүндрэл бэрхшээл, стресс, сэтгэл санааны хямрал, гутрал, биеийн болон сэтгэл зүйн хүчирхийлэлд өртсөн, салалт, үхэл хагацал гэх мэт сэтгэл санаанд нь сөргөөр нөлөөлсөн асуудалтай хүмүүст тодорхой сэтгэл зүйн техник, сэтгэл заслын аргуудаас хэрэглэн үйлчлүүлэгчийн асуудлыг шийдвэрлэхэд нь тусалдаг.

Филиппиний сэтгэл судлалын хөтөлбөрийн талаар[127]

Филиппинд сэтгэл судлалын бакалаврын хөтөлбөрийг 20 жилийн өмнө 44 сургууль явуулдаг байсан бол одоо 170 орчим их дээд сургууль болж өргөжсөн байна. Сэтгэл судлалыг анх Филиппинд 1926 онд философийн ухаанаас тусад нь салбар болгон хөгжүүлж эхэлжээ. Түүнээс хойш Филиппиний Боловсролын их сургуулийн дэргэд Сэтгэл судлалын тэнхим байгуулагджээ. Филиппиний сэтгэл судлалын бакалаврын хөтөлбөр нь 4 жил байдаг. Сэтгэл судлалд өргөн хэрэглэгддэг онцлох чиглэлүүд нь: байгууллагын сэтгэл зүй, клиник сэтгэл судлал, зөвлөгөө нийгмийн сэтгэл судлал, боловсролын сэтгэл судлал, хүүхдийн сэтгэл судлал зэрэг ордог байна.

Сэтгэл судлалын бакалаврын зэрэг олгох сургалтын ихэнх хувийг хувийн их дээд сургуулиуд санал болгодог байна. Филиппинд дөрвөн төрлийн боловсролын байгууллага байдаг. Үүнд:

1. Хувийн сектор шашны бүлэглэлийн удирддаг их дээд сургууль, коллеж юм. Атенео Де Манила их сургууль, Де Ла Салле их сургууль, Филиппиний Адвентист их сургууль гэх мэт;
2. Корпораци эсхүл сангийн удирддаг их дээд сургууль, коллеж юм. Мануэль Л.Кезоны их сургууль, Алс Дорнодын их сургууль гэх мэт;
3. Улсын их дээд сургуулиуд коллежууд бол засгийн газраас санхүүждэг байгууллага юм. Филиппиний их сургууль, Боловсролын их сургууль, Өмнөд Лузополитехникийн коллеж гэх мэт;
4. Орон нутгийн их дээд сургууль, коллеж бол тухайн сургууль байрладаг орон нутгийн засаг захиргаанаас санхүүждэг байгууллага юм. Памантасан ба Лунгсод Майнила, Урданета олон нийтийн коллеж зэрэг.

**Эрх зүйн орчин**

Филиппин Улсын сэтгэл судлалын тухай хуулийг 2009 онд 9 бүлэг 41 зүйлтэй баталсан. Ингэснээр сэтгэл судлалын мэргэжлийг хөгжүүлэхэд шинэ үе шат эхэлж, сэтгэл судлаачаар ажиллах таатай нөхцөл бүрдсэн юм. Хуулийн зорилго нь олон нийтийг мэргэжлийн бус сэтгэл судлаачид хандахаас болгоомжлох, сэтгэл судлаачдыг албан ёсны бүртгэлд хамруулах, лицензийн шалгалтыг зохион байгуулж дэлхийн хэмжээнд өрсөлдөх чадвартай шударга, үнэнч сэтгэл судлаачдыг бэлтгэхэд оршино.

Хуулийн 4 дүгээр бүлэгт Сэтгэл судлалын мэргэжлийн зохицуулах хорооны удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн болон эрх үүргийг заасан байна. Үүнд:

Тус хорооны Удирдах зөвлөлд сэтгэл судлалын холбоо болон итгэмжлэгдсэн үндэсний байгууллагаас зөвлөлийн даргад хоёр, гишүүдэд тус бүр гурван нэр дэвшигчийг дэвшүүлнэ.

[127] https://onlinelibrary.wiley.com/doi/full/10.1080/00207590444000465

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Удирдах зөвлөлийн дарга болон гишүүд дараах шаардлагыг хангасан байна.

- Филиппин улсын иргэн, байнгын оршин суугч байх;
- Гучин таван нас хүрсэн байх;
- Өндөр ёс зүйтэй байх;
- Филиппиний их сургууль болон бусад сургуульд сэтгэл судлалын чиглэлээр докторын зэрэг хамгаалсан, Дээд боловсролын комиссоос хүлээн зөвшөөрөгдсөн байх;
- Албан ёсны зөвшөөрөгдсөн байгууллага, клиник төвд сэтгэл судлалын чиглэлээр дор хаяж 10 жил ажилласан, эсхүл сэтгэл судлалын чиглэлээр багадаа 5 жил багшилсан туршлагатай байх;
- Сэтгэл судлалын хүчин төгөлдөр мэргэжлийн үнэмлэхтэй, лицензтэй сэтгэл судлаач байх;
- Сэтгэл судлалын их дээд сургууль, коллеж бусад байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан, шууд болон шууд бусаар санхүүгийн ашиг сонирхолгүй байх;
- Ёс суртахууны аливаа гэмт хэрэгт холбогдоогүй байх.

Эрх, үүрэг

- энэхүү хуулийн заалтыг хэрэгжүүлэх, шаардлагатай дүрэм, журам, тогтоол, удирдамжийг батлах, шинэчлэх, түгээн дэлгэрүүлэх;
- Филиппин дэх сэтгэл судлаачдын бүртгэл, лиценз, практикт хяналт тавих;
- энэхүү хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан тангараг өргөх;
- сэтгэл судлаачийн бүртгэлийн гэрчилгээ, мэргэжлийн үнэмлэх олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, сэргээх;
- Зөвлөлийн албан ёсны тамга тэмдгийг батлах;
- Филиппин дэх сэтгэл судлал, психометрийн практикт нөлөөлж буй нөхцөл байдалд хяналт тавьж, мэргэжлийн ёс зүй, техникийн стандартыг сайжруулах, хадгалахад хууль ёсны арга хэмжээг авах;
- байгууллага, холбоо болон сэтгэл судлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хүмүүсийн бүртгэлийн гэрчилгээ, хүчин төгөлдөр мэргэжлийн үнэмлэхтэй сэтгэл судлаач мөн эсэхийг шалгах, хяналт тавих;
- Сэтгэл судлаачийн мэргэжлийн тасралтгүй боловсролын талаарх удирдамж боловсруулж хэрэгжүүлэх;
- Сэтгэл судлалын сургалт хөтөлбөрийг санал болгодог боловсролын байгууллагуудтай бодлого, стандарт, сургалтын хөтөлбөрийн дагуу хамтран ажиллах;
- Тусгай зөвшөөрлийн шалгалтын хөтөлбөрийг дээд боловсролын комисстой зөвлөлдсөний үндсэн дээр бэлтгэх, батлах, өөрчлөлт оруулах;
- Хууль ёсны дагуу шилжүүлсэн болон энэ хуулийн зорилгыг хэрэгжүүлэхэд шаардлагатай гэж үзсэн бусад чиг үүргийг гүйцэтгэх.

Мөн тус хуулийн 5 дугаар бүлэгт сэтгэл судлаач болон туслах сэтгэл судлаачид нь тусгай зөвшөөрлийн шалгалтад хамрагдах, ур чадварын шалгуур үзүүлэлтүүд, тавигдах шаардлага болон шалгалтын сэдвүүдийг тусгасан байна. Сэтгэл судлалын чиглэлээр дадлага хийхээр бүртгүүлсэн хүмүүс хорооноос тогтоосон шаардлагын дагуу сэтгэл судлаачийн мэргэжлийн шалгалтад хамрагдах ёстой.

Сэтгэл судлаачаар бүртгүүлэх, лиценз авахаар шалгалт өгөх хүмүүс Удирдах зөвлөлд холбогдох баримт бичгийг ирүүлэх ба дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Филиппин улсын иргэн, байнгын оршин суугч эсхүл гадаад улсын иргэн бол Филиппин улсад мэргэжлийн чиглэлээр албан ёсоор үйл ажиллагаа эрхэлдэг байх;
- Дээд боловсролын комиссоос хүлээн зөвшөөрөгдсөн магадлан итгэмжлэгдсэн Филиппин эсхүл гадаадын их сургуульд сэтгэл судлалын чиглэлээр магистрын зэрэг эзэмшсэн байх;
- тусгай зөвшөөрөлтэй сэтгэл судлаач эсхүл туслах сэтгэл судлаачаар багадаа 200 цагийн клиникийн дадлага туршлагатай байх;
- Ёс суртахуунтай холбоотой гэмт хэрэгт холбогдоогүй байх.

Туслах сэтгэл судлаачийн тусгай зөвшөөрлийн шалгалтад хамрагдах өргөдөл гаргагч нь дараах шаардлагыг хангасан тохиолдолд хүсэлт гаргаж болно.

- Филиппин улсын иргэн, байнгын оршин суугч эсхүл гадаад улсын иргэн бол Филиппин улсад сэтгэл судлалын чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг байх;
- Дээд боловсролын комиссоос хүлээн зөвшөөрөгдсөн магадлан итгэмжлэгдсэн Филиппин эсхүл гадаадын их дээд сургуульд сэтгэл судлалын чиглэлээр бакалаврын зэрэг эзэмшсэн, шалгалтад хамрагдсан сэдвүүдэд хангалттай оноо авсан байх;
- Ёс суртахуунтай холбоотой гэмт хэрэгт холбогдоогүй байх.

Сэтгэл судлаачдын лицензийн шалгалтад дараах сэдвүүдийг хамруулна.

- Хувь хүнийг тодорхойлох онолууд;
- Хэвийн бус сэтгэл судлал;
- Сэтгэлзүйн үнэлгээ;
- Сэтгэлзүйн зөвлөгөө ба сэтгэл засал.

Энэхүү хуульд зааснаар сэтгэл судлаачийн шаардлагатай ур чадвар, мэдлэг боловсролтой хүнийг шалгалтгүйгээр бүртгэж болно. Өргөдөл гаргагч нь дараах бичиг баримтыг хороонд баталгаажуулна. Үүнд:

- Сэтгэл судлалын чиглэлээр докторын зэрэг хамгаалсан, гурван жил ажилласан туршлагатай байх;
- Сэтгэл судлалын магистрын зэрэг хамгаалсан, сэтгэл судлалын чиглэлээр хамгийн багадаа 5 жил ажилласан туршлагатай байх;
- Төрийн болон хувийн байгууллагад сэтгэл судлаачаар ажилладаг сэтгэл судлалын бакалавр зэрэгтэй, сэтгэл судлаачаар багадаа 10 жилийн ажлын туршлагатай байх.

Шалгалтын үнэлгээ

- Сэтгэл судлаачийн лицензийн шалгалтад нийт (75%) ба түүнээс дээш оноогоор шалгалтад тэнцсэн гэж үзнэ. Гэхдээ нэр дэвшигч шалгалтын бүх сэдвээр хамгийн багадаа (60%)-ийн үнэлгээг авах ёстой. Хэрэв нийт үнэлгээ 75% гэсэн хэдий ч сэдвийн шалгалтаар 60%-аас доош үнэлгээ авсан бол 2 жилийн хугацаанд тухайн сэдвийн шалгалтыг дахин өгөх эрхтэй.

Үнэлгээний тайлан

- Мэргэжлийн зохицуулах хороо нь шалгалт авсанаас хойш хуанлийн 10 хоногийн дотор сэдэв бүрийн үнэлгээний талаар албан ёсны тайланг гаргана.

Филиппин Улсад сэтгэл судлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй дараах байгууллагууд байна. Үүнд:

ЦИХ.МН СУДАЛГААНЫ САН

1. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв (National Center for Mental Health)[128],
2. Филиппиний сэтгэцийн эрүүл мэндийн холбоо (Philippine Mental Health Association)[129],
3. Филиппиний мэргэжлийн зохицуулах хороо (Philippine professional regulation commission)[130],
4. Филиппиний сэтгэл судлалын холбоо (The Psychological Association of the Philippines).[131]

Эдгээрээс сэтгэл судлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Филиппиний сэтгэл судлалын холбоо болон Филиппиний мэргэжлийн зохицуулах хорооны талаар товч дурдвал:

**1. Филиппиний сэтгэл судлалын холбоо[132]**

1962 онд байгуулагдсан Филиппиний Сэтгэл судлалын холбоо (PAP) нь сэтгэл судлалын судалгаа, дадлага туршлагын ур чадварыг сурталчлах, хүн ба нийгмийн хөгжилд чиглэсэн үйл ажиллагаа явуулж буй байгууллага юм. Тус холбоо сэтгэл судлалын салбарыг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулан 4 зорилго тавин ажиллаж байна. Үүнд:

1. Сэтгэл судлалыг шинжлэх ухааны салбар болгон хөгжүүлэх, сургах, заах, судлах ажлыг ахиулах;
2. Сэтгэл судлалын практикийг бие даасан, шинжлэх ухааны чиг баримжаатай, ёс суртахууны хувьд ухамсартай мэргэжил болгон хөгжүүлэх;
3. Хүний сайн сайхны төлөө;
4. Бусад эрдэмтэн судлаач нартай хамтран ажиллаж, анхаарал хандуулж буй асуудлыг ойлгох, шийдвэрлэхэд туслах.

Тус холбоонд Филиппин Улсын мэргэжлийн зохицуулах комиссоос магадлан итгэмжлэгдсэн мэргэшсэн сэтгэл судлаачид ажилладаг.

Филиппиний сэтгэл судлалын холбоо сэтгэл судлалын 7 чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Үүнд:

- үнэлгээний сэтгэл судлал;
- клиник сэтгэл судлал;
- сэтгэл судлалын зөвлөгөө;
- хөгжлийн сэтгэл судлал;
- боловсролын сэтгэл зүй;
- байгууллагын сэтгэл судлал;
- нийгмийн сэтгэл судлал.

Эдгээрээс гадна сэтгэцийн эрүүл мэнд ба сэтгэлзүйн үйлчилгээ, лесбиян гей бисексуал ба трансжендерүүдийн сэтгэл судлалын тусгай сонирхлын бүлгүүд мөн ажилладаг байна.

**2. Филиппиний мэргэжлийн зохицуулах хороо[133]**

Тус хороо нь магадлан итгэмжлэгдсэн мэргэжлийн байгууллагууд, их дээд сургууль төгсөгчид, академи бусад төрийн байгууллагуудад мэргэжлээрээ ажиллах болон түр зөвшөөрөл хүссэн дотоодын болон гадаадын мэргэжилтнүүд үйлчилдэг байгууллага юм.

Мэргэжлийн зохицуулах хороо нь мэргэжлийн дадлагын стандартаар мэргэжлийн ур чадварыг тодорхойлох, мэргэшсэн лицензийн эрх олгох, лицензийн шалгалт зохион

[128] http://www.ncmh.gov.ph/
[129] https://pmha.org.ph/
[130] https://www.prc.gov.ph/psychology
[131] https://www.pap.ph/
[132] https://www.pap.ph/
[133] https://www.prc.gov.ph/

байгуулах, сэтгэл судлаачийн бүртгэлийн гэрчилгээ олгох, мэргэжлийн үнэмлэх олг мэргэжлийн эрхийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, сэргээх зэрэг үйл ажиллагааг эрхл явуулна.

**4.2. Япон Улс**

Япон Улсад сэтгэл судлалын шинжлэх ухаан нь Эдо (1603 - 1868 он) үеийн сүүлчийн хагасаас Мэйжигийн эриний (1868 оноос эхэлсэн) эхэн үе хүртэл нэвтэрч, барууны шинжлэх ухаанд гүнзгий нэвтэрсэн гүн ухаантан Кацүнагаритай салшгүй холбоотой хөгжжээ[134]. Энэ үеэс сэтгэл судлал гэдэг үг хэрэглэгдэж, Мэйжигийн үеийн төлөөлөгч, сэтгэл судлаач Южиро Мотора нь Америкийн их сургуульд эрдмийн зэрэг хамгаалсан анхны япон эрдэмтэн болж байсан байна. Сэтгэл судлалын эрдэмтэн нар Америк болон Германы шинжлэх ухааныг судлаж ирсээр Кюүшюүгийн Их сургууль болох Эзэн хааны Их сургуульд дайны дараах Японы сэтгэл судлалын үндэс суурийг тавьжээ. Дайны дараа Япон Улс нь Америкийн эрхшээлд аргагүйн эрхэнд амьдрахаас өөр аргагүй байдалд хүрсэн нь ард иргэдийн сэтгэл зүйд маш нөлөөлж байв. Сэтгэл судлал нь зан үйлийн шинжлэх ухаанд суурилдаг тул оюун ухааныг эмчлэх зорилготойгоор дорно дахины өвөрмөц сэтгэл зүйг хөгжүүлэх боломжтойг тухайн үед японы эрдэмтэд харж байсан байна.

Өнөө үеийн Япон Улсын сэтгэл судлал нь өндөр хөгжилтэй орнуудын адил хөгжиж ирсэн ч хэт хөгжлийн улмаас нийгмийн үл үзэгдэх дарамт ихтэй, энэ ч үүднээсээ сэтгэл санааны хувьд ядарсан насанд хүрэгчид мөн хүүхдүүд их байна. Иймээс сэтгэл судлалаар мэргэших сонирхолтой залуучууд ихсэж тэднийг сургах их сургууль, мэргэшүүлэх холбоодын ажил идэвхжиж байна.

Их сургуулиудын хувьд сэтгэл судлалын тэнхимтэй байх ба уламжлалт сэтгэл судлалын хичээлүүдээс гадна шинээр гэмт хэргийн сэтгэл судлалын тухай шүүхийн сэтгэл судлал, эрүүгийн шинжлэх ухаан, мөрдөн байцаалтын ажиллагаа, эрүүгийн клиник гэсэн чиглэлтэйгээр оюутнуудаа бэлтгэж байна.[135] Нэмж дурдахад эмнэл зүйн сэтгэл судлал буюу хөгжлийн бэрхшээлтэй хүний сэтгэл судлал, хүүхэд хөгжил, хүн хоорондын харилцаа гэсэн нийгмийн төрлүүдээр давхар сургадаг байна. Төгссөн сэтгэл судлаачид нь анагаах ухааны салбар, боловсролын салбар, халамжийн салбар, аж үйлдвэрийн салбарт ажиллах боломжоор бүрэн хангагддаг байна.

**Эрх зүйн орчин**

Япон Улс нь 2007 оны 9 сарын 16-ны өдөр Мэргэшсэн сэтгэл судлаачийн хуулиа[136] (公認心理師法) баталсан. 2019 оны 6 сарын 14-ний өдөр хамгийн сүүлд нэмэлт өөрчлөлт орсон. Уг хууль нь 5 бүлэг 50 зүйлтэй.

Хууль нь мэргэшсэн олон нийтийн сэтгэл зүйчдийн мэргэшлийн түвшинг тогтоох, тэдний ажил үүргийн зохистой байдлыг хангах, хүмүүсийн сэтгэцийн эрүүл мэндийг сахин хамгаалах, дэмжихэд хувь нэмрээ оруулах зорилготой.

Мэргэшсэн олон нийтийн сэтгэл зүйчийн эрх зүйн зохицуулалт, эрх үүрэг, хариуцлага, үйл ажиллагаагаа явуулах хүрээ болон мэргэшсэн сэтгэл зүйч болох шалгалтыг хаанаас хэн ямар зохион байгуулалттайгаар бүртгэж, шалгалтыг авах тухай энэ хуулиар зохицуулсан.

[134]http://shinrigaku2008.web.fc2.com/index/sinnrigaku2.html
[135]https://www.uhe.ac.jp/undergraduate/psychology/?utm_source=google&utm_medium=cpc&gclid=Cj0KCQjw8eOLBhC1ARIsAOzx5cGFh-sNpVkcLvVfFjEPNmtBrNj1ISAQ2-9nEsd9RnWIR8B9385xvLkaAmUKEALw_wcB
[136] https://hourei.net/law/427AC0000000068

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Япон Улсад сэтгэл судлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг дараах байгууллагууд байна. Үүнд:

1. Япон Улсын Сэтгэл судлалын холбоо (The Japanese Psychological Association)
2. Япон Улсын Сэтгэл судлалын нийгэмлэгүүдийн холбоо (Japanese Union of Psychological Associations)

**1. Япон Улсын Сэтгэл судлалын холбоо (The Japanese Psychological Association)**

Япон Улсын Сэтгэл судлалын холбоо[137] нь 1927 оны 4-р сарын 7-нд байгуулагдсан , сэтгэл судлалын хөгжлийг дэмжих зорилгоор байгуулагдсан бөгөөд улсын хэмжээнд сэтгэл судлалын хамгийн анхны холбоо юм. Сэтгэл судлалын үндсэн салбараас эхлээд хэрэглээний чиглэл хүртэл төрөл бүрийн чиглэлээр мэргэшсэн гишүүдтэй бөгөөд Японы сэтгэл судлалын хөгжилд тууштай хувь нэмэр оруулсан. Энэ нь сайн дурын байгууллага байсан ч 1994 оны 9 -р сарын 20 -ны өдөр Боловсролын яамнаас үүсгэн байгуулагдсан холбоо болгон батлагдсан. 2011 оны 4-р сарын 1-ээс эхлэн Засгийн газрын хэрэг эрхлэх газраас баталгаажуулсны дараа олон нийтийн эрх ашгийг нэгтгэсэн холбоо болсон.

Тус холбоо нь Байнгын хороо болон тусгай хороодтой. Байнгын хороонд Олон улсын хороо, Олон нийттэй харилцах хороо, Ёс зүйн хороо гэх мэт 12 хороо байдаг бол, тусгай хороо нь Газар хөдлөлтийн дараах сэргээн босголтыг дэмжих тусгай хороо, Жендэрийн тэгш байдлыг дэмжих хороо, Мэргэшлийн системийг тохируулах хороо байна.

Одоогоор Японы сэтгэл судлалын холбоо нь 8000 орчим гишүүнтэй бөгөөд ерөнхийлөгч Такаюки Сакагами удирдаж байна. Гишүүд нь холбооны дараах Ёс зүйн дүрмийг[138] сайтар ухамсарлан дагаж баримтална. Үүнд:

**1. Хариуцлагын ухамсар, өөрийгөө сайжруулах**

Мэргэжлийн хүмүүсийн хувьд сэтгэлзүйн судалгаа, боловсрол, практик үйл ажиллагаа нь хувь хүн болон нийгэмд нөлөөлж болохыг энэ холбооны гишүүд мэдэж байх ёстой. Нийгэмд хувь нэмэр оруулахын тулд холбооны гишүүд нэр төр, өөрийгөө сайжруулахыг байнга хичээж, чанар, мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх ёстой. Үүний тулд хамгийн сүүлийн үеийн тусгай мэдлэг, ур чадвар эзэмших, холбогдох янз бүрийн мэдээлэл олж авах, ёс суртахууны үзэл санаа, холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг Япон болон хилийн чанадад сурч мэдэх, залуу үеэ идэвхтэй сургах, олон нийтийг соён гэгээрүүлэхэд хүчин чармайлт гаргах ёстой.

**2. Хууль тогтоомжийг дагаж мөрдөх, эрх, халамжийг хүндэтгэх**

Энэ холбооны гишүүд иргэн хүний хувьд хууль тогтоомж, дүрэм журмыг дагаж мөрдөөд зогсохгүй мэргэжлийн мэргэжилтнүүдийн хувьд харьяалагддаг байгууллага, байгууллагын дүрэм журам, судалгаа, хамтын ажиллагааны хамт олны ёс зүй, ёс заншлыг дагаж мөрдөх болон соёлын үнэт зүйлсийг мөн хүндэтгэх ёстой. Түүнчлэн хувь хүмүүсийн нэр төр, амьтдын сайн сайхан байдлыг дутуу үнэлж болохгүй. Хамтарсан судалгаа, боловсрол, практик үйл ажиллагаанд оролцож буй хамт олон, оюутнууд болон бусад хүмүүсийн эрх, ашиг сонирхолд хэт халдахаас болгоомжлох хэрэгтэй. Нэмж дурдахад хамт ажиллагсад, оюутнууд, холбогдох хүмүүсийн хүний эрх, сайн сайхны төлөө анхаарал хандуулах хэрэгтэй. Ялангуяа амьтан ашиглах судалгаа, боловсрол, практик үйл ажиллагааны талаар холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу зохих

137 https://psych.or.jp/
138 https://psych.or.jp/about/

ёсоор үржүүлж, хадгалж, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, амьтны сайн сайхан байдлыг сайжруулахыг хичээх ёстой. Түүнчлэн зэрлэг амьтдадтай ажиллахдаа байгаль, нутгийн иргэд, экосистемд үзүүлэх нөлөөллийг хамгаалах талаар анхаарах ёстой.

**3. Тайлбар ба зөвшөөрөл**

Сэтгэл судлалтай холбоотой үйл ажиллагаа явуулахдаа энэ холбооны гишүүд хамтран ажиллагсаддаа энэ үйл ажиллагааг бүрэн тайлбарлаж, зөвшөөрлийг нь авах ёстой. Хэрэв хамтран ажиллагчдаас хангалттай ойлголт, зөвшөөрөл (мэдээлэлтэй зөвшөөрөл) авахад хэцүү байвал хамтран ажиллагчийн төлөөлөгч (ойрын хамаатан садан гэх мэт)-ийн дүгнэлт, зөвшөөрлийг авах ёстой. Нэмж дурдахад хамтран ажиллагсад нь үйл ажиллагааны үеэр ч хамтын ажиллагаагаа (оролцоогоо) чөлөөтэй зогсоож, цуцалж болно гэдгээ урьдчилан тайлбарлах ёстой.

**4. Нууцлал**

Энэ холбооны гишүүд хувийн нууцлалыг зөрчсөн судалгаа, боловсрол, практик үйл ажиллагаанд тэдний зөвшөөрөлгүйгээр оролцох ёсгүй. Үүнээс гадна хамтран ажиллагчдад сэтгэлзүйн болон бие махбодийн хохирол учруулах ёсгүй. Хэрэв хамтран ажиллагсадтайгаа холбоотой эрх мэдэлтэй бол та үүнийг хувийн ашиг сонирхлын үүднээс ашиглах ёсгүй. Түүнчлэн, судалгаа, боловсрол, практик үйл ажиллагаанаас олж авсан мэдээллийг бусдад задруулахгүйн тулд хатуу хадгалж, удирдан зохион байгуулах ёстой бөгөөд үүний зэрэгцээ зориулалтаас нь өөр зорилгоор ашиглах ёсгүй.

**5. Хэвлэн нийтлэхтэй холбоотой үүрэг хариуцлага**

Энэ холбооны гишүүд судалгаа, боловсрол, практик үйл ажиллагааны үр дүнд олж авсан мэдээллээ задруулахдаа хамтран ажиллагсдынхаа зөвшөөрлийг урьдчилан авах ёстой бөгөөд үүнтэй зэрэгцэн хамтран ажиллагчдыг тэдний зөвшөөрөлгүйгээр тодорхойлохоос болгоомжлох хэрэгтэй. Хамтарсан судалгаа хийх тохиолдолд хамтарсан судлаачийн зөвшөөрлийг авч, нийтлэх үед хамтарсан судлаачийн эрх үүргийг бүрэн харгалзан үзэх ёстой.

**2. Япон Улсын Сэтгэл судлалын нийгэмлэгүүдийн холбоо (Japanese Union of Psychological Associations)**

Японы Улсын Сэтгэл судлалын нийгэмлэгүүдийн холбоо[139] нь сэтгэл судлал, түүнтэй холбогдох салбаруудын эв нэгдэлтэй хөгжлийг дэмжин, сэтгэл судлалын нийгэмлэгүүдийн өвөрмөц үйл ажиллагааг хүндэтгэн харилцах, харьяа нийгэмлэгүүдийн хамтын ажиллагааг бэхжүүлэх замаар олон улсын хамтын ажиллагааг цогц байдлаар хөгжүүлэх зорилгоор 1999 онд байгуулагдсан. Олон салбарт хувь нэмэр оруулах зорилготой нийгмийн асуудлуудыг тогтвортой төлөвлөж, шийдвэрлэх арга замыг санал болгож байгуулагдсан холбоо бөгөөд, 2021 оны 3-р сарын байдлаар 56 гишүүнчлэл бүхий байгууллагуудтай байна.

Тодорхой үйл ажиллагааны хувьд жилд хоёр удаа эрдэм шинжилгээний байгууллага бүрийн төлөөллөөс бүрдсэн ажилчдын нэгдсэн хурлыг хийдэг бөгөөд энэ хугацаанд 2-3 сар тутамд нэг удаа удирдах зөвлөлийн хурал хийдэг. Сэтгэл судлалын холбооны байнгын хороодтой хамтран ажилахын сацуу гишүүнчлэлтэй 56 байгууллагатай шийдвэрлэх шаардлагатай олон асуудлыг шийдвэрлэх, тогтоосон арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажилладаг. 2009 оноос хойш Мэргэшсэн сэтгэл

139 https://jupa.jp/

UHMIN СУДАЛГААНЫ САН

судлаачийн тухай хууль[140] (Certified Psychologist Law)-ийн төслийг сурталчлах гурван байгууллагыг байгуулсан. Үүнээс гадна 2008 оноос хойш мэргэшсэн сэтгэл судлалын тестийг боловсруулж байна. Сэтгэл судлалын нийгэмлэгүүдийн холбоо нь үйл ажиллагааныхаа дотоод зохицуулалтыг хороодод хувиарласан бөгөөд дараах хороод байна.

- ✓ Ерөнхий хэргийн хороо
- ✓ Санхүүгийн хороо
- ✓ Мэргэшлийн хороо
- ✓ Олон Улсын хороо
- ✓ Олон нийттэй харилцах хороо
- ✓ Нийтийн төлөвлөлтийн хороо
- ✓ Ёс зүйн хороо.

Уг холбооны ерөнхийлөгчөөр Японы Сэтгэл судлалын холбооны ерөнхийлөгч Такаюки Сакагами нь хоёр жилийн хугацаагаар сонгогдон ажиллаж байгаа ба холбооны хороодын дарга нар болон Удирдах зөвлөл нь мэргэшлийн 56[141] гишүүнчлэл бүхий байгууллагатай хамтран ажиллаж байна. Тухайлбал:

1. Үйлдвэр ба Байгууллагын сэтгэл судлалын нийгэмлэг;
2. Японы EMDR Нийгэмлэг; (Ege Movement Desensitization and Reprocessing)
3. Японы Зургийн сэтгэл судлалын нийгэмлэг; (Learning Disabilities)
4. Японы LD нийгэмлэг;
5. Японы Хэрэглээний Боловсролын Сэтгэл Судлалын Нийгэмлэг;
6. Японы Хэрэглээний Сэтгэл Судлалын Нийгэм;
7. Японы Зөвлөх Нийгэмлэг гэх мэт.

Японы Сэтгэл судлалын холбоо, Сэтгэл судлалын нийгэмлэгүүдийн холбоо нь мэргэшсэн сэтгэл судлаачдыг дэмжих, тэднийг хөгжүүлэх, олон улстай холбох, дадлага туршлагыг нэмэх тал дээр хангалттай ажилласаар ирсэн. Мэргэшсэн судлаачийг дүрэм журмын дагуу хууль зүйн үндэслэлээр сонгон шалгаруулах, бүртгэл гэрчилгээг бүртгэж нийтэд мэдээлэх нь тус холбоодын ажил үүргийн чиглэлд байна. Гэхдээ мэргэшсэн сэтгэл судлаачийн шалгалтыг өгөх сэтгэл судлаач нь, тус холбоодын гишүүн байх шаардлагагүй байдаг байна.

### 4.3. Бүгд Найрамдах Намиби Улс

Бүгд Найрамдах Намиби Улс (Republic of Namibia) нь 1884-1915 онд Холбооны бүгд найрамдах Герман Улсын, 1915-1989 онд Өмнөд Африкийн бүгд найрамдах Улсын колончлолд байсан бөгөөд 1990 оны 3 дугаар сарын 21-ний өдөр тусгаар тогтносон байна.

Тус улсад сэтгэл судлалын шинжлэх ухаан хожуу үүсэж хөгжиж байгаа бөгөөд сэтгэл судлалын шинжлэх ухааны хөгжлийн түвшин доогуурт жагсдаг байна.

Намибийн Их Сургууль[142] (University of Namibia-UNAM) нь сэтгэл судлалын бакалавр, магистр, докторын зэргийн сургалт явуулдаг цорын ганц байгууллага юм.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[140] https://hourei.net/law/427AC0000000068
[141] https://jupa.jp/category2/
[142] University of Namibia. https://www.unam.edu.na/search?search=psychology

Дараах чиглэлээр мэргэжил олгодог байна.

- Сэтгэл судлал;
- Клиник сэтгэл судлал;
- Байгууллагын сэтгэл судлал;
- Үйлдвэрлэлийн сэтгэл судлал;
- Эмнэл зүй/зөвлөгөө өгөх сэтгэл судлал.

“Намибийн Их Сургууль нь клиник сэтгэл судлал, үйлдвэрлэлийн сэтгэл судлалын чиглэлээр магистрын зэрэг олгодог боловч орон тоо хязгаарлагдмал байдаг тул элсэх өрсөлдөөн маш их байдаг. Мөн тус сургууль сэтгэл судлалын чиглэлээр докторын зэрэг олгодог боловч удирдагч багш, шүүмжлэгчээр ажиллах профессор дутагдалтай байна” гэж Намибийн сэтгэл судлалын холбооны гишүүн Hambeleleni Ndjaleka өөрийн “Намиби дахь сэтгэл судлалын байдал”[143] эрдэм шинжилгээний өгүүлэлдээ дурдсан байна.

Одоогоор тус улсад нийгмийн эрүүл мэндийн салбарт бэлтгэгдсэн, мэргэшсэн мэргэжилтнүүд дутагдалтай байсаар байна.

**Эрх зүйн орчин**

Намиби Улс 2004 оны 6 дугаар сарын 26-ны өдөр *Нийгмийн ажил, сэтгэл судлалын тухай*[144] (Social Work and Psychology Act, №151, 2004) хуулиа баталж, 10 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн байна.

Намиби Улсын *Нийгмийн ажил, сэтгэл судлалын тухай* хууль нь 6 бүлэг, 63 зүйлтэй байна. Хуулиар Намиби Улсын Нийгмийн ажил, сэтгэл судлалын зөвлөлийг байгуулах, түүний чиг үүрэг, бүрэн эрхийн тухай; баримтлах дүрэм журмын тухай; сэтгэл судлалын мэргэжил, боловсрол олгох тухай; бүртгэлийн асуудлуудыг зохицуулдаг байна. Тухайлбал:

- Нийгмийн ажилтны болон сэтгэл судлалын чиглэлээр мэргэшсэн мэргэжлийн зөвлөл байгуулах, дүрмийг батлуулах;
- Зөвлөлийн эрх, чиг үүргийг тодорхойлох;
- Нийгмийн ажилтны болон сэтгэл судлалын мэргэжлээр ажиллаж буй хүмүүс болон тэдгээр мэргэжлүүдтэй холбоотой өөр мэргэжлээр ажиллаж байгаа хүмүүсийн бүртгэлийг зохицуулах;
- Нийгмийн ажилтны болон сэтгэл судлалын мэргэжлээр мэргэшсэн хүмүүсийн боловсрол, сургалтын төлбөр, сургалт, мэргэшлийг тодорхойлох;
- Холбогдох байгууллагад бүртгүүлэхгүйгээр нийгмийн ажилтны болон сэтгэл судлалын мэргэжлээр ажиллахыг хориглох;
- Ажилласан тохиолдолд хариуцлага тооцох зэрэг болно.

Намиби Улсад сэтгэл судлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг дараах байгууллагууд байна. Үүнд:

1. Нийгмийн ажил, сэтгэл судлалын зөвлөл
2. Сэтгэл судлалын холбоо

### *1. Нийгмийн ажил, сэтгэл судлалын зөвлөл*

Намиби Улсын Нийгмийн ажил, сэтгэл судлалын зөвлөл (цаашид Зөвлөл гэх) нь 2004 оны 6 дугаар сарын Нийгмийн ажил, сэтгэл судлалын тухай хуулийн дагуу байгуулагдсан. Тус зөвлөл нь туслах нийгмийн ажилтан, сэтгэл судлаач, сэтгэлзүйн зөвлөх, клиник

[143] The state of psychology in Namibia. https://www.apa.org/international/pi/2017/06/psychology-namibia
[144] Social Work and Psychology Act. №3426. 2004. https://www.namiblii.o[144]rg/akn/na/act/2004/6/eng@2018-09-06

UIH.MN СУДАЛГААНЫ САН

сэтгэл судлаач, боловсролын сэтгэл судлаач, сэтгэлзүйн дадлагажигч, дадлагажигч боловсролын сэтгэл судлаач, оюутны нийгмийн ажилтан, оюутны сэтгэлзүйн зөвлөх, оюутан сэтгэл судлаачид зэрэг мэргэжилтнүүдийн үйл ажиллагааг зохицуулдаг.

Зөвлөл нь Нийгмийн ажил, сэтгэл судлалын тухай хуулийн дагуу мэргэжилтний бүртгэл, мэргэжилтний боловсрол, давтан сурах үйл ажиллагаа, сургалтад нөлөөлж буй асуудал зэрэгт хяналт тавих эрх мэдлийг хэрэгжүүлдэг.

Мөн Зөвлөлийн бас нэг чухал үүрэг бол мэргэжлийн бус зан авирын талаар гаргасан гомдол, эсхүл мэргэжлээрээ ажиллах чадвар сул, эргэлзээтэй байгаа хүнтэй хариуцлага тооцох асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдэнэ.

Зөвлөлийн гишүүнийг 5 жилийн хугацаатай томилох бөгөөд хугацаа нь дуусахаас өмнө дахин томилуулахаар нэр дэвшүүлж болно.

Зөвлөл нь дараах хороодтой байна.

1. Гүйцэтгэх хороо (executive committee)
2. Мэргэжлийн ёс зүйн хороо (professional conduct committee)
3. Давж заалдах хороо (appeal committee)
4. Боловсролын хороо (education committee)
5. Урьдчилан мөрдөн байцаах хороо (preliminary investigation committee)

**2. *Сэтгэл судлалын холбоо*[145] (Psychological association of Namibia-PAN)**

Намибийн сэтгэл судлалын холбоо нь Эрүүл Мэндийн Мэргэжлийн Зөвлөл[146] (Health Professions Councils of Namibia-HPCNA)-д багтдаг бөгөөд Намиби Улс дахь клиник сэтгэл судлаач, боловсролын сэтгэл судлаач, сэтгэлзүйн зөвлөхүүдийн цорын ганц мэргэжлийн холбоо юм. Анх 1987 онд сэтгэл судлалыг шинжлэх ухаан, мэргэжил, эрүүл мэнд, хүний сайн сайхан байдлыг дэмжих хэрэгсэл болгон хөгжүүлэх зорилготойгоор байгуулагдсан байна.

*Холбооны зорилго нь*:

- Мэргэжлийн болон ёс суртахууны хэм хэмжээг сурталчлах, дэлгэрүүлэх, мөн шинжлэх ухаанаар дамжуулан сэтгэл судлал, сэтгэл судлаач, сэтгэл зүйчдийн нэр хүндийг дээшлүүлэх;
- Сэтгэл судлалыг цаашид хөгжүүлэх, сурталчлахын тулд гадаад харилцаа холбоогоо нэмэгдүүлэх, бэхжүүлэх;
- Сэтгэл судлалыг цаашид хөгжүүлэх, сурталчлахын тулд бусад салбарын мэргэжилтнүүдтэй харилцах харилцаа, холбоогоо нэмэгдүүлэх, бэхжүүлэх;
- Сэтгэл судлал, олон нийтийн сайн сайхны төлөө, сэтгэлзүйн үйлчилгээний хүртээмж, ашиглалтыг нэмэгдүүлэх;
- Олон нийтийн сайн сайхны төлөө сэтгэлзүйн зөвлөгөө үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх;
- Гишүүдийн эрх ашгийг хамгаалах, холбооны нөөцийг үр ашигтай удирдах, төлөөллийг өсгөх замаар холбооны ач холбогдлыг нэмэгдүүлж, хөгжүүлэхэд чиглэгдэнэ.

Сэтгэл судлалын холбоо нь үйл ажиллагаагаа дүрмээр[147] зохицуулдаг бөгөөд 2013 онд баталсан байна. Дүрэм 13 зүйлтэй.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[145] Psychological association of Namibia-PAN. http://www.psychologynamibia.org/
[146] Health Professions Councils of Namibia-HPCNA. https://www.hpcna.com/index.php
[147] PAN constitution. http://www.psychologynamibia.org/pan-constitution/

## ХАВСРАЛТ

**Албан бус орчуулга**

***Филиппиний сэтгэл судлалын тухай хууль***[148]

### I. Бүлэг

**1-р зүйл.** *Гарчиг*

### II.Бүлэг

**2-р зүйл.** *Хуулийн зорилго*

Тус хуулийн зорилго нь олон нийтийг мэргэжлийн бус сэтгэл судлаачид хандахаас болгоомжлох, сэтгэл судлаачдыг албан ёсны бүртгэлд хамруулах, лицензийн шалгалтыг зохион байгуулах, зохицуулалтын арга хэмжээ авах, сурталчлах замаар үйлчилгээний стандарт бий болгох, дэлхийн хэмжээнд өрсөлдөх чадвартай шударга, үнэнч сэтгэл судлаачдыг бэлтгэхэд оршино.

### III.Бүлэг Нэр томьёоны тодорхойлолт

**3-р зүйл.** *Нэр томьёоны тодорхойлолт*

а) "Сэтгэл судлал" бол хүний зан төлвийн шинжлэх ухааны судалгаа юм. Энэ нь хүний зан үйлийн биологийн, танин мэдэхүйн, сэтгэл хөдлөлийн, хөгжлийн, нийгэм, соёлын болон хувь хүний ялгааг хэмжиж судлах шинжлэх ухааны аргуудыг ашиглах хэлбэр юм.

б) "Сэтгэл судлаачийн үйлчилгээ үзүүлэх" Хүнийг оновчтой тодорхойлох, сэтгэлзүйн тулгамдсан асуудалд туслах зорилгоор хувь хүн, бүлгийн зан байдлыг тайлбарлах, ойлгох, урьдчилан таамаглах, нөлөөлөхөд чиглэсэн сэтгэлзүйн үйлчилгээ юм. Сэтгэлзүйн үйлчилгээ үзүүлэхэд дараах зүйлс орно:

- сэтгэлзүйн оролцоо: сэтгэлзүйн зөвлөгөө, сэтгэлзүйн эмчилгээ, сэтгэлзүйн дэмжлэг, сэтгэлзүйн мэдээлэл, үйл явц, хувь хүн, гэр бүл, бүлэг, байгууллагын сэтгэлзүйн үйл ажиллагааг сайжруулах сэтгэлзүйн зарчмуудыг хэрэгжүүлэхтэй холбоотой бусад оролцоо;
- сэтгэлзүйн үнэлгээ: сэтгэлзүйн хямралыг үнэлэх зорилгоор бие даасан тест, ярилцлага болон бусад сэтгэлзүйн үнэлгээний арга хэрэгслээр дамжуулан сэтгэл асуудлыг нэгтгэх, үнэлэх;
- сэтгэлзүйн хөтөлбөрүүд: хувь хүн ба бүлгийн сэтгэлзүйн эмчилгээг боловсруулах, төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах, үнэлэх.

в) "Сэтгэл судлаач" гэж энэхүү хуульд заасны дагуу Мэргэжлийн зохицуулах хорооноос баталгаажуулсан мэргэжлийн сэтгэл судлаачийн бүртгэлийн гэрчилгээ, мэргэжлийн ажиллах лиценз авч зохих журмын дагуу бүртгүүлсэн иргэнийг хэлнэ.

г) " Туслах сэтгэл судлаач" гэж энэ хуулийн дагуу Мэргэжлийн зохицуулах хорооноос баталгаажуулсан хүчин төгөлдөр бүртгэлийн гэрчилгээ, мэргэжлийн үнэмлэхтэй иргэнийг хэлнэ.

### IV. Бүлэг Сэтгэл судлалын мэргэжлийн зохицуулах хороо

**4-р зүйл.** *Сэтгэл судлалын мэргэжлийн зохицуулах хорооны бүрэлдэхүүн*

Тус хорооны Удирдах зөвлөлд сэтгэл судлалын холбоо болон итгэмжлэгдсэн үндэсний байгууллагаас зөвлөлийн даргад хоёр, гишүүдэд тус бүр гурван нэр дэвшигчийг дэвшүүлнэ.

[148] https://lawphil.net/statutes/repacts/ra2010/ra_10029_2010.html

**5-р зүйл.** *Сэтгэл судлалын мэргэжлийн зохицуулах зөвлөлийн дарга, гишүүд*

Удирдах зөвлөлийн дарга болон гишүүд томилогдсон бүрэн эрхийнхээ хугацаанд дараах шаардлагыг хангасан байна.

- Филиппин улсын иргэн, байнгын оршин суугч байх;
- Гучин таван нас хүрсэн байх;
- Өндөр ёс зүйтэй байх;
- Филиппиний их сургууль болон бусад сургуульд сэтгэл судлалын чиглэлээр докторын зэрэг хамгаалсан, Дээд боловсролын комиссоос хүлээн зөвшөөрөгдсөн байх;
- Албан ёсны зөвшөөрөгдсөн байгууллага, клиник төвд сэтгэл судлалын чиглэлээр дор хаяж 10 жил ажилласан, эсхүл сэтгэл судлалын чиглэлээр багадаа 5 жил багшилсан туршлагатай байх;
- Сэтгэл судлалын хүчин төгөлдөр мэргэжлийн үнэмлэхтэй, лицензтэй сэтгэл судлаач байх;
- Сэтгэл судлалын их дээд сургууль, коллеж бусад байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан, шууд болон шууд бусаар санхүүгийн ашиг сонирхолгүй байх;
- Ёс суртахууны аливаа гэмт хэрэгт холбогдоогүй байх.

**6-р зүйл.** *Бүрэн эрхийн хугацаа*

Удирдах зөвлөлийн гишүүдийг 3 жилийн хугацаатай томилох ба улируулан 1 удаа дахин 3 жилийн хугацаагаар сунгаж болно. Шалгуур хангасан гишүүд тангараг өргөж баталгаажуулна.

**7-р зүйл.** *Эрх, үүрэг*

- энэхүү хуулийн заалтыг хэрэгжүүлэх, шаардлагатай дүрэм, журам, тогтоол, удирдамжийг шалгах, шинэчлэл, түгээн дэлгэрүүлэх;
- Филиппин дэх сэтгэл судлаачдын бүртгэл, лиценз, практикт хяналт тавих;
- энэхүү хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан тангараг өргөх;
- сэтгэл судлаачийн бүртгэлийн гэрчилгээ, мэргэжлийн үнэмлэх олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, сэргээх;
- Зөвлөлийн албан ёсны тамга тэмдгийг батлах;
- Филиппин дэх сэтгэл судлал, психометрийн практикт нөлөөлж буй нөхцөл байдалд хяналт тавьж, мэргэжлийн ёс зүй, техникийн стандартыг сайжруулах, хадгалахад хууль ёсны зохистой арга хэмжээг авах;
- байгууллага, холбоо болон сэтгэл судлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хүмүүс нь бүртгэлийн гэрчилгээ, хүчин төгөлдөр мэргэжлийн үнэмлэхтэй сэтгэл судлаач мөн эсэх, магадлан итгэмжлэлтэй эсэхийг шалгах, хяналт тавих;
- Сэтгэл зүйч, сэтгэл судлаачийн мэргэжлийн тасралтгүй боловсролын талаарх удирдамжийг боловсруулж хэрэгжүүлэх;
- Сэтгэл судлалын сургалт хөтөлбөрийг санал болгодог боловсролын байгууллагуудтай тогтоосон бодлого, стандарт, сургалтын хөтөлбөрийн дагуу хамтран ажиллах;
- Тусгай зөвшөөрлийн шалгалтын хөтөлбөрийг дээд боловсролын комисстой зөвлөлдсөний үндсэн дээр бэлтгэх, батлах, гаргах, өөрчлөлт оруулах;
- Хууль ёсны дагуу шилжүүлсэн эсхүл энэ хуулийн зорилгыг хэрэгжүүлэхэд шаардлагатай гэж үзсэн бусад чиг үүргийг гүйцэтгэх.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**8-р зүйл.** *Нөхөн олговор ба тэтгэмж*

Удирдах зөвлөлийн дарга, гишүүдэд Комиссын дүрэм, Тэтгэлгийн ерөнхий хуульд заасанаар тэтгэмжийг адил хэмжээгээр олгоно.

**9-р зүйл.** *Сэтгэл судлалын мэргэжлийн зохицуулах хорооны гишүүдийг чөлөөлөх, түдгэлзүүлэх*

Зөвлөлийн гишүүд хорооны дүрэм журмыг дагаж мөрдөөгүй, үүргээ үл тоомсорлох, мэргэжлийн чадваргүй байдал, сэтгэл судлалын мэргэжилтний хувьд зохисгүй ёс суртахууны доголдолтой үйлдэл, нэр төр унагасан үйлдэл, аливаа гэмт хэрэгт холбогдох ял шийтгэл, лицензийн шалгалт болон бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой хуурамч мэдээлэл ашиглах зэрэг шалтгаанаар албан тушаалаас нь түдгэлзүүлж эсхүл огцруулж болно.

**10-р зүйл.** *Удирдах зөвлөлд захиргааны хяналт тавих*

Удирдах зөвлөл нь сэтгэл судлалын мэргэжлийн хорооны захиргааны хяналтад байна. Удирдах зөвлөлийн хийсэн бүх бүртгэл, түүний дотор тусгай зөвшөөрлийн шалгалт, удирдах зөвлөлөөс гаргасан захиргааны болон бусад баримт бичгийг хорооны захиргаанд тайлагнана.

## V.Бүлэг Лицензийн шалгалт

**11-р зүйл.** *Шаардлагатай шалгалтууд*

Сэтгэл судлалын чиглэлээр дадлага хийхээр бүртгүүлсэн бүх хүмүүс хорооноос тогтоосон шаардлагыг дагаж сэтгэл судлаачийн мэргэжлийн шалгалтад хамрагдах ёстой.

**12-р зүйл.** *Сэтгэл судлаачдын тусгай зөвшөөрлийн шалгалтад хамрагдах хүсэлтэй хүмүүсийн ур чадвар*

Сэтгэл судлаачаар бүртгүүлэх, лиценз авахаар шалгалт өгөх оролцогчид Удирдах зөвлөлд холбогдох баримт бичгийг ирүүлэх ба дараах шаардлагыг хангасан байна.

- Филиппин улсын иргэн, байнгын оршин суугч эсхүл гадаад улсын иргэн бол Филиппин улсад мэргэжлийн чиглэлээр үйл ажиллагаа үзүүлдэг байх;
- Дээд боловсролын комиссоос хүлээн зөвшөөрөгдсөн магадлан итгэмжлэгдсэн Филиппин эсхүл гадаадын их сургуульд сэтгэл судлалын чиглэлээр магистрын зэрэг эзэмшсэн байх;
- тусгай зөвшөөрөлтэй сэтгэл зүйч эсхүл туслах сэтгэл зүйчээр хамгийн багадаа 200 цагийн клиникийн дадлага туршлагатай байх;
- зан төлөвийн сайн шинж чанартай байх;
- Ёс суртахуунтай холбоотой гэмт хэрэгт холбогдоогүй байх.

**13-р зүйл.** *Туслах сэтгэл судлаачийн тусгай зөвшөөрлийн шалгалтад хамрагдах хүсэлтэй хүмүүсийн ур чадвар*

Өргөдөл гаргагч нь дараах шаардлагыг хангасан нотлох баримт бичгийг хангасан тохиолдолд тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргаж болно.

- Филиппин улсын иргэн, байнгын оршин суугч эсхүл гадаад улсын бол Филиппин улсад мэргэжлийн чиглэлээр үйл ажиллагаа үзүүлдэг байх;
- Дээд боловсролын комиссоос хүлээн зөвшөөрөгдсөн магадлан итгэмжлэгдсэн Филиппин эсхүл гадаадын их сургуульд сэтгэл судлалын чиглэлээр бакалаврын зэрэг эзэмшсэн, шалгалтад хамрагдсан сэдвүүдэд хангалттай оноо авсан байх;
- Ёс суртахуунтай холбоотой гэмт хэрэгт холбогдоогүй байх.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**14-р зүйл.** *Сэтгэл судлаачдын шалгалт*

Сэтгэл судлаачдын лицензийн шалгалтад дараах сэдвүүдийг хамруулна.

- Хувь хүнийг тодорхойлох онолууд;
- Хэвийн бус сэтгэл судлал;
- Сэтгэлзүйн үнэлгээ;
- Сэтгэлзүйн зөвлөгөө ба сэтгэл засал.

**15-р зүйл.** *Туслах сэтгэл судлаачдад зориулсан шалгалт*

Туслах сэтгэл судлаачдад зориулсан лицензийн шалгалтад дараах сэдвүүдийг хамруулна.

- Хувь хүний тухай онолууд;
- Хэвийн бус сэтгэл судлал;
- Үйлдвэрлэлийн сэтгэл судлал;
- Сэтгэлзүйн үнэлгээ.

**16-р зүйл.** *Сэтгэл судлаачийн шалгалт өгөхгүй бүртгүүлэх нөхцөл*

Энэхүү хуулийн заалтын дагуу сэтгэл судлаачийн шаардлагатай ур чадвар, мэдлэг боловсролтой хүнийг шалгалтгүйгээр бүртгэж болно. Өргөдөл гаргагч нь дараах бичиг баримтыг хороонд баталгаажуулна. Үүнд:

- Сэтгэл судлалын чиглэлээр докторын зэрэг хамгаалсан, гурван жил ажилласан туршлагатай байх;
- Сэтгэл судлалын магистрын зэрэг хамгаалсан, сэтгэл судлалын чиглэлээр хамгийн багадаа 5 жил ажилласан туршлагатай байх;
- Төрийн болон хувийн байгууллагад сэтгэл судлаачаар ажилладаг сэтгэл судлалын бакалавр зэрэгтэй, сэтгэл судлаачаар багадаа 10 жилийн ажлын туршлагатай, мэргэжлийн боловсролоо дээшлүүлсэн судлаачид.

**17-р зүйл.** *Туслах сэтгэл судлаачийн шалгалт өгөхгүйгээр бүртгүүлэх*

Энэхүү хуулийн дагуу сэтгэл судлаач нь шаардлагатай ур чадвар, мэдлэг боловсролтой хүнийг шалгалтгүйгээр бүртгэж болно. Сэтгэл судлалын чиглэлээр бакалавр зэрэгтэй хамгийн багадаа хоёр жил ажилласан туршлагатай байна.

**18-р зүйл.** *Шалгалтын үнэлгээ*

Сэтгэл судлаачийн лицензийн шалгалтад нийт (75%) ба түүнээс дээш оноогоор шалгалтад тэнцсэн гэж үзнэ. Гэхдээ нэр дэвшигч шалгалтын бүх сэдвээр хамгийн багадаа (60%)-ийн үнэлгээг авах ёстой. Хэрэв нийт үнэлгээ 75% гэсэн хэдий ч сэдвийн шалгалтаар 60%-аас доош үнэлгээ авсан бол 2 жилийн хугацаанд тухайн сэдвийн шалгалтыг дахин өгөх эрхтэй.

ИНМН СУДАЛГААНЫ САН

**19-р зүйл.** *Үнэлгээний тайлан*

Мэргэжлийн зохицуулах хороо нь шалгалт авсанаас хойш хуанлийн 10 хоногийн дотор сэдэв бүрийн үнэлгээний талаар албан ёсны тайланг гаргана.

## VI.Бүлэг Бүртгэл

**20-р зүйл.** *Тангараг*

Шалгалтад тэнцсэн болон шалгалт өгөхгүйгээр бүртгүүлэх эрх бүхий хүмүүс тангараг өргөнө.

**21-р зүйл.** *Бүртгэлийн гэрчилгээ, мэргэжлийн үнэмлэх олгох*

Мэргэжилийн зохицуулах хорооноос тогтоосон хураамж төлж хууль ёсны шаардлагыг ханган шалгалтад хамрагдсан хүмүүст бүртгэлийн гэрчилгээ, мэргэжлийн үнэмлэх олгоно. Бүртгэлийн гэрчилгээнд хорооны дарга, удирдах зөвлөлийн гишүүдийн гарын үсэг байна. Энэхүү бүртгэлийн гэрчилгээний хүчинтэй байх хугацаа нь 3 жил бөгөөд хугацаа дуусмагц сэтгэл судлаач нь тасралтгүй ажиллаж буй нотолгоог үндэслэн сунгаж болно.

**22-р зүйл.** *Бүртгэлийн мэдээлэл*

Сэтгэл судлаач нь иргэдэд үйлчилгээ үзүүлсэн баримт бичиг тус бүр дээр гарын үсэг зурж, мэргэжлийн үнэмлэхийн дугаар болон хүчинтэй хугацааг зааж өгөх ёстой.

**23-р зүйл.** *Бүртгэлийн гэрчилгээ, мэргэжлийн үнэмлэх олгохоос татгалзах*

Удирдах зөвлөл нь ёс суртахууны асуудалтай холбоотой гэмт хэрэгт холбогдсон болон шүүхээр тогтоогдсон хэн нэгэнд бүртгэлийн гэрчилгээ, мэргэжлийн үнэмлэх олгохоос татгалзана. Бүртгэлийн гэрчилгээ олгохоос татгалзсан тохиолдолд удирдах зөвлөл нь өргөдөл гаргагчид татгалзсан шалтгаанаа бичгээр мэдэгдэж Зөвлөлийн тэмдэглэлд тусгах ёстой.

**24-р зүйл.** *Гадаад улсын иргэний үйлчлэл*

Гадаад улсын иргэн сэтгэл судлалын лицензийн шалгалтад хамрагдах боломжгүй байна.

- Гэхдээ Филиппин улсад бүртгэлийн гэрчилгээ/мэргэжлийн үнэмлэх олгохгүйгээр/ сэтгэл судлалын чиглэлээр дадлага хийлгэхийг зөвшөөрдөг;
- Филиппиний иргэдэд сэтгэл судлал, туслах сэтгэл судлаачаар ажиллах боломжийг олгодог.

**25-р зүйл.** *Тусгай/түр зөвшөөрөл/-өөр дадлага хийх*

Тусгай/түр зөвшөөрөл/Зөвлөлөөс баталж, зохих хураамж төлсөн тохиолдолд дараах хүмүүст олгож болно.

- Тухайн улсдаа хүлээн зөвшөөрөгдсөн шилдэг мэргэжилтэн, Лицензтэй сэтгэл судлаач олон улсын сэтгэл зүйн мэргэжилтэн байх;
- Тусгай эмнэлэг, төв, клиникийн өвчтөнүүдэд үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлэх гадаадын улс, муж улсын тусгай зөвшөөрөлтэй сэтгэл судлаачид;
- Сэтгэл судлал, туслах сэтгэл судлаачийн сургалт, хөтөлбөр санал болгодог их дээд сургууль, коллежид сэтгэл судлалын хичээл заадаг эсхүл сэтгэл судлаач солилцооны профессороор ажилладаг.

**26-р зүйл.** *Бүртгэлийн гэрчилгээ, мэргэжлийн үнэмлэх тусгай/түр зөвшөөрөл/-ийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох*

Зөвлөл нь энэ хуулийн 33 дугаар зүйлд заасан үндэслэлээр мэдэгдэл, сонсголын дараа бүртгэлийн гэрчилгээ, мэргэжлийн үнэмлэхийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, олгосон тусгай/түр зөвшөөрөл/ хүчингүй болгох эрхтэй. Үүнд:

- Бүртгэлийн гэрчилгээ, мэргэжлийн үнэмлэх, тусгай/түр зөвшөөрөл/ залилан мэхлэх замаар олж авах;
- Бүртгэлийн гэрчилгээ, мэргэжлийн үнэмлэх, тусгай/түр зөвшөөрл/-ийг ашиглан мэргэжилгүй хүнд сурталчлах;
- Цаашид Удирдах зөвлөлөөс нийтэлсэн энэхүү хуулийн заалт, түүнийг хэрэгжүүлэх дүрэм, журам, ёс зүйн дүрэм, мэргэжлийн стандартын аль нэг заалтыг зөрчсөн;

UIH.MN СУДАЛГААНЫ САН

- Үйлчлүүлэгч болон өвчтөндөө ур чадвар, аюулгүй байдал, сэтгэлзүйн үйлчилгээ хангалтгүй үзүүлэх, бие мах бодийн болон сэтгэцийн чадваргүй байдал нотлогдвол;
- Сэтгэл зүйчийн үүргээ гүйцэтгэхдээ мэргэжлийн ёс зүйгүй үйлдэл, хайхрамжгүй байдал гаргах.

**27-р зүйл.** *Гэрчилгээ, мэргэжлийн үнэмлэхийг сэргээх*

Бүртгэлийн гэрчилгээ нь хүчингүй болгосон сэтгэл судлаач нь хүчингүй болгосноос хойш хоёр жилийн дараа дахин сэргээх хүсэлтээ Удирдах зөвлөлд бичгээр гаргана. Зөвлөлөөс тогтоосон шаардлагыг хянан хэлэлцэнэ. Бүртгэлийн гэрчилгээ, мэргэжлийн үнэмлэх, тусгай/түр зөвшөөрөл/-ийг сэргээхээс мөн татгалзаж болно.

**28-р зүйл.** *Шүүхэд гомдол гаргах*

Зөвлөлийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй бол шийдвэрийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор шүүхэд гомдол гаргаж болно.

**29-р зүйл.** *Хариуцагчийн эрх*

Хариуцагч сэтгэл судлаач нь аливаа хэргийн үе шатанд гэрчээр оролцох эрхтэй.

## VII.Бүлэг Мэргэжлийн харилцаа

**30-р зүйл.** *Сэтгэл судлаачийн давуу эрх*

Сэтгэл судлаач нь үйлчлүүлэгч, өвчтөний зөвшөөрөлгүйгээр тухайн үйлчлүүлэгчид сэтгэлзүйн үйлчилгээ үзүүлэх явцад олж авсан аливаа мэдээллийг задруулахгүй байх болно. Харин шаардлагатай тохиолдолд холбогдох бүх бүртгэлд тэмдэглэгдэх бөгөөд тусгай зөвшөөрөлтэй сэтгэл судлаач, сэтгэл судлаачийн нарийн бичгийн дарга, бичиг хэргийн ажилтан зэрэгт нээлттэй байх болно. Энэхүү заалтыг зөрчин олж авсан аливаа нотлох баримт, мэдээллийг хууль бус, буруу зүйлд ашиглах боломжгүй болно.

**31-р зүйл.** *Мэргэжилтнийг нэгтгэх*

Цаашид хүлээн зөвшөөрөгдсөн магадлан итгэмжлэгдсэн, бүртгэгдсэн, лицензтэй сэтгэл судлаачийг нэг үндэсний байгууллага дор нэгтгэх болно. Зөвлөл, Комисс д зохих ёсоор бүртгүүлж, зөвшөөрөл авсан сэтгэл судлаач нь тогтоосон хураамж төлсний дараа тухайн байгууллагын гишүүн болж, давуу эрх эдлэх боломж нээгдэнэ.

**32-р зүйл.** *Сэтгэл судлаачийн ёс зүйн дүрэм*

Мэргэжлийн зохицуулах хороо нь сэтгэл судлаачдын магадлан итгэмжлэгдсэн мэргэжлийн байгууллагаас гаргасан сэтгэл судлаачийн ёс зүйн дүрмийг баталж, нийтлүүлнэ.

## VIII.Бүлэг Хориглосон үйлдэл, торгууль

**33-р зүйл.** *Хориотой үйлдэл*

- Бүртгэлийн гэрчилгээ, хүчин төгөлдөр бус мэргэжлийн үнэмлэх, Зөвлөлөөс олгосон тусгай/түр зөвшөөрөлгүй/ этгээд сэтгэл судлалын мэргэжлийн ажил хийх, өөрийгөө мэргэжилийн сэтгэл судлаачаар төлөөлөхгүй байх;
- Бүртгэлийн гэрчилгээ, мэргэжлийн үнэмлэх болон тусгай/түр зөвшөөрөл/-ийг ямар ч зорилгоор өөр хүнд ашиглуулахгүй байх, ингэснээр мэргэшсэн бус хүн сэтгэлзүйн үйлчилгээ үзүүлэхээс сэргийлэх;
- Бүртгэлийн гэрчилгээ болон мэргэжлийн үнэмлэх, бусдын тусгай/түр зөвшөөрөл/-ийг өөрийн өмчлөлдөө ашиглах;

UIH.MN СУДАЛГААНЫ САН

- Бүртгэлийн гэрчилгээ, мэргэжлийн үнэмлэх, тусгай/түр зөвшөөрөл/ авах тухай Зөвлөлд худал, буруу, төөрөгдүүлсэн мэдээлэл өгөх;
- Аливаа байгууллага, түншлэл, холбоо, удирдах зөвлөлөөс зөвшөөрөл авалгүйгээр сэтгэлзүйн болон психометрийн оффис, төв, клиник ажиллуулахгүй, сэтгэл судлаачийн үүргээр үйлчилгээ үзүүлэхгүй байх;
- Энэхүү хуулийн аливаа заалтыг зөрчсөн тохиолдолд зохих шийтгэлийг оногдуулна.

**34-р зүйл.** *Торгууль.*

Энэхүү хуулийн аливаа зүйл заалтыг зөрчсөн этгээдийг 6 сараас 3 жил хүртэлх хугацаагаар хорих эсхүл 10.000-100.000 песогийн торгууль ногдуулна.

**35-р зүйл.** *Зөрчлийг мэдэгдэх*

Удирдах зөвлөл нь энэхүү хуулийг зөрчсөн сэтгэл судлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хувь хүн, байгууллага, холбоо, түншлэл, аж ахуйн нэгжид холбогдох арга хэмжээ авч болно.

**36-р зүйл.** *Хууль сахиулах.*

Энэхүү хуулийн зүйл заалтыг дагаж мөрдөөгүй, зөрчсөн аливаа этгээдийг мөрдөн шалгаж, мөрдөн байцаах ажиллагаа явуулах ажлыг хууль сахиулах байгууллага хариуцна.

## IX.Бүлэг Бусад

**37-р зүйл.** *Санхүүжилтийн нөхцөл*

Мэргэжлийн зохицуулах хорооны дарга цаашид энэхүү хуулийг шуурхай хэрэгжүүлэх ажлыг Ерөнхий Тэтгэлгийн тухай хуульд заасны дагуу хөтөлбөрт нэн даруй оруулах болно.

**38-р зүйл.** *Дүрэм, журмыг хэрэгжүүлэх*

Удирдах зөвлөл байгуулагдсанаас хойш 90 хоногийн дотор энэ хуулийн заалтыг хэрэгжүүлэхийн тулд хорооны зөвшөөрөлтэйгөөр шаардлагатай хэрэгжүүлэх дүрэм, журмыг нийтэлнэ.

**39-р зүйл.** *Салгах заалт*

Хэрэв энэ хуулийн аль нэгэн заалт Үндсэн хууль зөрчсөн гэж үзвэл, тухайн заалт хүчин төгөлдөр бус гэж тооцогдвол бусад үлдсэн бүлэг заалтууд нь хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ.

**40-р зүйл.** Зүйл заалтыг *хүчингүй болгох*

Энэхүү хуулийн заалттай зөрчилдсөн бүх хууль, тогтоол, дүрэм, журмыг хүчингүй болгож, зохих ёсоор өөрчилсөн болно.

**41-р зүйл .** *Хүчин төгөлдөр болох*

Энэхүү хууль нь албан ёсны сонинд нийтлэгдсэнээс хойш арван тав хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

## ЯПОНЫ МЭРГЭШСЭН СЭТГЭЛ СУДЛААЧИЙН ХУУЛЬ[149]

*2007 оны 9-р сарын 16 өдөр батлагдаж*
*2015 оны 6 сарын 14 ний өдөр нэмэлт өөрчлөлт орсон*

Хуулийн агуулга:


1-р бүлэг Ерөнхий заалт (1-3 зүйл)
2-р бүлэг Шалгалт (4-27 зүйл)
3-р бүлэг Бүртгэл (28-39 зүйл)
4-р бүлэг Үүрэг гэх мэт (40 дүгээр зүйл 45 дугаар зүйл)
5-р бүлэг Торгууль (46-р зүйл 50-р зүйл)
Нэмэлт заалтууд


### 1-р бүлэг. Ерөнхий дүрэм

**1 дүгээр зүйл. (Зорилго)**

Энэхүү хуулийн зорилго нь мэргэшсэн олон нийтийн сэтгэл судлаачдын мэргэшлийг бий болгох, тэдний ажил үүргийн зохистой байдлыг хангах, хүмүүсийн сэтгэцийн эрүүл мэндийг сахин хамгаалах, дэмжихэд хувь нэмэр оруулах явдал юм.

**2 дугаар зүйл. (Тодорхойлолт)**

Энэхүү хуульд хэрэглэсэн "мэргэшсэн олон нийтийн сэтгэл зүйч" гэсэн нэр томьёо нь 28-р зүйлд бүртгэгдсэн, эрүүл мэндийн чиглэлээр сэтгэл судлалын талаар тусгай мэдлэгтэй байхын тулд мэргэшсэн олон нийтийн сэтгэл судлаачийн нэрийг ашигладаг "мэргэшсэн олон нийтийн сэтгэл зүйч" гэсэн утгатай. Халамж, боловсрол болон бусад салбарууд. Мөн дараах зүйлийг хийдэг хүн технологийн тусламжтайгаар ажилладаг.

(I) Сэтгэлзүйн дэмжлэг авах шаардлагатай байгаа хүний сэтгэлзүйн байдлыг ажиглаж, үр дүнг шинжлэх.
(II) Сэтгэлзүйн зөвлөгөөний хариуд сэтгэлзүйн дэмжлэг авах шаардлагатай хүмүүст зөвлөгөө, удирдамж болон бусад туслалцаа үзүүлэх.
(III) Сэтгэцийн эрүүл мэндийн талаарх мэдлэгийг түгээх боловсрол, мэдээлэл өгөх.

**3 дугаар зүйл**

Дараах зүйлсийн аль нэгэнд орсон хүн олон нийтийн сэтгэл судлаач байж болохгүй.

(I) Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яамны тушаал, Эрүүл мэнд, хөдөлмөр, хамгааллын яамны тушаалаар бие бялдар, оюун санааны байдлаас шалтгаалан мэргэшсэн олон нийтийн сэтгэл судлаачийн үүргийг зохих ёсоор гүйцэтгэж чадахгүй хүмүүс гэж заасан хүмүүс (эмгэг).
(II) Ажлын хажуугаар ба түүнээс дээш хугацаагаар хорих ял сонсч, ялаа эдлэж дууссан.
(III) Засгийн газрын тогтоолоор тогтоосон энэхүү хууль болон Эрүүл мэнд, эмнэлгийн тусламж, халамж, боловсролын тухай хуулийн бусад заалтын дагуу торгууль ногдуулж, гүйцэтгэлийг дуусгах буюу гүйцэтгэхээ болино. Хоёр жил өнгөрөөгүй хүмүүс
(IV) 32 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн (ii) зүйлийн 2 дахь хэсгийн заалтуудын дагуу бүртгэлээ цуцалсан, цуцалсан өдрөөс хойш хоёр жил өнгөрөөгүй хүн.
(Хуулийн 37 дугаар зүйл, Хэсэгчилсэн нэмэлт өөрчлөлт)

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[149] https://hourei.net/law/427AC0000000068

## 2-р бүлэг. Шалгалт

**4 дүгээр зүйл. (Мэргэшлийн шаардлага)**

Нийтийн сэтгэл судлалын мэргэшсэн шалгалт (цаашид "шалгалт" гэх)-нд тэнцсэн хүн олон нийтийн мэргэшсэн сэтгэл судлаач болох эрхтэй.

**5 дугаар зүйл. (Туршилт)**

Мэргэшсэн олон нийтийн сэтгэл судлаачийн хувьд шаардлагатай мэдлэг, ур чадварын шалгалтыг явуулна.

**6 дугаар зүйл. (Туршилтын хэрэгжилт)**

Шалгалтыг Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн сайд, Эрүүл мэнд, хөдөлмөр, хамгааллын сайд нар жилд нэгээс доошгүй удаа явуулна.

**7 дугаар зүйл. (Шалгалтын мэргэшил)**

Шалгалтыг зөвхөн дараах зүйлсийн аль нэгэнд орсон хүн л авах боломжтой.

(I) Сургуулийн боловсролын тухай хууль (1947 оны 26-р хууль)-ийг үндэслэн их дээд сургуулиудад мэргэшсэн олон нийтийн сэтгэл судлаач болох шаардлагатай сэтгэл судлал болон бусад хичээлүүд (бага коллежийг эс тооцвол; цаашид мөн адил хамаарна), Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны тушаалаар тогтоосон бөгөөд Боловсрол, соёлын яамны тушаалаар заасан курсуудыг дүүргэж, хууль тогтоомжид үндэслэн төгссөн сургуулийн сэтгэл судлал болон бусад чиглэлээр мэргэшсэн олон нийтийн сэтгэл судлаач болох, Спорт, шинжлэх ухаан, технологи, Эрүүл мэнд, хөдөлмөр, халамжийн яамны тушаал, Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яамны тушаал, дээрх тушаалаар заасан бусад хичээлийг гүйцэтгэсэн хүмүүс.

(II) Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яам, Эрүүл мэнд, хөдөлмөр, халамжийн яамны тушаалд заасан их сургуулиудад мэргэшсэн олон нийтийн сэтгэл судлаач болоход шаардлагатай хичээлүүдийг дүүргэсэн хүмүүс. Сургуулийн боловсролын тухай хуулийг үндэслэн Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яамны тушаалыг төгссөн бусад хүмүүс. Эрүүл мэнд, хөдөлмөр, хамгааллын яамны тушаалаар тодорхойлсон хүн Захирамжид заасан байгууламжид Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яам, Эрүүл мэнд, хөдөлмөр, халамжийн яамны тушаалд заасан хугацаанд 2-р зүйлийн 1-ээс 3-р зүйлд жагсаасан болно. Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яам, Эрүүл мэнд, хөдөлмөр, халамжийн яамны тушаал.

(III) Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн сайд, Эрүүл мэнд, хөдөлмөр, халамжийн сайдын өмнөх хоёр зүйлд жагсаасан мэдлэг, ур чадварын түвшингээр баталгаажсан хүмүүс.

**8 дугаар зүйл. (Туршилтын хүчин төгөлдөр бус байдал гэх мэт.)**

Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн сайд, Эрүүл мэнд, хөдөлмөр, халамжийн сайд нар шалгалттай холбоотой зөрчил гаргасан тохиолдолд шалгалтыг түр зогсоох, эсхүл шалгалтыг хүчингүй болгоно.

Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн сайд, Эрүүл мэнд, хөдөлмөр, халамжийн сайд нар өмнөх догол мөрийн заалтын дагуу шийтгүүлсэн хүнийг тодорхой хугацаанд шалгалт өгөхийг зөвшөөрөхгүй.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**9 дүгээр зүйл. (Шалгалтын төлбөр)**

Шалгалт өгөх гэж буй хүн бодит зардлыг харгалзан Засгийн газрын тогтоолоор тогтоосон хэмжээгээр Засгийн газарт шалгалтын хураамж төлөх ёстой.

Өмнөх догол мөрөнд заасан шалгалтын төлбөрийг төлсөн хүн шалгалтанд хамрагдаагүй байсан ч буцаан олгогдохгүй.

**10 дугаар зүйл. (Туршилтын байгууллагын тодорхойлолт)**

Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яамны захирамж, энэхүү тушаалын дагуу Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн сайд, Эрүүл мэнд, хөдөлмөр, халамжийн сайд, Эрүүл мэнд, хөдөлмөр, халамжийн яамнаас шалгалтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг (цаашид "шалгалтын ажил" гэх) томилсон хүмүүсийг (цаашид "томилогдсон шалгалтын байгууллага" гэх) томилно.

Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яамны тушаал, Эрүүл мэнд, Хөдөлмөр, халамжийн яамны Захирамжид заасны дагуу шалгалтын ажил хийх гэж буй хүний хүсэлтээр томилогдсон шалгалтын байгууллагын нэрийг гаргана.

Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн сайд, Эрүүл мэнд, хөдөлмөр, халамжийн сайд нар, өргөдөл нь дараах шаардлагыг хангаж байгаа гэж үзэхгүй бол томилогдсон шалгалтын байгууллагыг томилохгүй.

(I) Байгууллагын ажилтнууд, тоног төхөөрөмж, шалгалтын ажлыг хэрэгжүүлэх арга болон бусад асуудлаар хийсэн шалгалтын ажлыг хэрэгжүүлэх төлөвлөгөө нь шалгалтын ажлыг зохих ёсоор, найдвартай хэрэгжүүлэхэд тохиромжтой.

(II) Өргөдөл гаргагч нь өмнөх зүйлд заасан шалгалтын ажлыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг зохих ёсоор, найдвартай хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн болон техникийн үндэслэлтэй байна.

Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн сайд, Эрүүл мэнд, хөдөлмөр, халамж үйлчилгээний сайд өргөдөл дараах зүйлийн аль нэгэнд хамаарах тохиолдолд шалгалтын байгууллагыг томилохгүй.

(I) Өргөдөл гаргагч нь ерөнхий хувь нийлүүлсэн нийгэмлэг эсвэл ерөнхий хувьцаат сангаас өөр.

(II) Өргөдөл гаргагчийн хийсэн шалгалтын ажлаас өөр ажлын улмаас шалгалтын ажил шударга явагдахгүй байх эрсдэлтэй.

(III) Өргөдөл гаргагч нь 22 дугаар зүйлд заасны дагуу нэрээ цуцалсан бөгөөд хүчингүй болсноос хойш хоёр жил өнгөрөөгүй хүн.

(IV) Өргөдөл гаргагчийн дунд дараах зүйлсийн аль нэгэнд багтсан хүн байдаг.

(V) Энэ хуулийг зөрчиж хорих ял сонсч, түүний гүйцэтгэлийг дуусгасан буюу хоёр жил гаруй гүйцэтгээгүй хүн.

(VII) Дараагийн зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу тушаалаар ажлаас халагдсан, ажлаас халагдсан өдрөөс хойш хоёр жил өнгөрөөгүй хүн.

**11 дүгээр зүйл. (Томилогдсон шалгалтын байгууллагын ажилтнуудыг томилох, чөлөөлөх)**

Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн сайд, Эрүүл мэнд, хөдөлмөр, халамжийн сайдын зөвшөөрөлгүйгээр томилогдсон шалгалтын байгууллагын томилогдсон албан тушаалтныг томилох, чөлөөлөх нь хүчин төгөлдөр болохгүй.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн сайд, Эрүүл мэнд, хөдөлмөр, халамжийн сайд нар энэ хуулийг зөрчсөн (энэ хуульд үндэслэсэн тушаал, захирамжийг оруулаад) эсвэл шалгалтыг зөрчсөн үйлдэл хийх. 13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан асуудлын журам:

Хэрэв шалгалтын ажилтай холбогдуулан зохисгүй үйлдэл үйлдвэл, томилогдсон шалгалтын байгууллагад албан тушаалтныг ажлаас халах тушаал өгч болно.

**12 дугаар зүйл. (Бизнес төлөвлөгөөг батлах гэх мэт)**

Томилогдсон шалгалтын байгууллага нь бизнес төлөвлөгөө, орлого, зарлагын төсвийг бизнесийн жил бүрийн хувьд, мөн ажлын жил эхлэхээс өмнө (тухайн өдрийг харьяалагдах бизнесийн жилд, тодорхойлолтыг хүлээн авсны дараа) боловсруулдаг. Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн сайд, Эрүүл мэнд, хөдөлмөр, халамжийн сайд  өөрчлөхийг хүсвэл мөн адил хамаарна.

Томилогдсон шалгалтын байгууллага нь тухайн жилийн бизнесийн тайлан, санхүүгийн тайланг гаргаж, хугацаа дууссанаас хойш гурван сарын дотор Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн сайд, Эрүүл мэнд, хөдөлмөр, халамжийн сайдад хүргүүлэх ёстой.

**13 дугаар зүйл. (Шалгалтын албаны дүрэм)**

Томилогдсон шалг алтынбайгууллага нь шалгалтын ажлыг хэрэгжүүлэх журмыг (цаашид энэ бүлэгт "шалгалтын ажлын дүрэм" гэх) бий болгож, Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн сайд, Эрүүл мэндийн сайдаас зөвшөөрөл авах ёстой.

Шалгалтын ажлын дүрэмд тусгах асуудлыг Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яам, Эрүүл мэнд, хөдөлмөр, халамжийн яамны тушаалаар тусгана.

Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн сайд, Эрүүл мэнд, хөдөлмөр, халамжийн сайд нар 1-р зүйлд батлагдсан шалгалтын ажлын журам нь шалгалтын ажлыг зохих ёсоор, найдвартай хэрэгжүүлэхэд тохиромжгүй гэж үзвэл тэдгээрийг өөрчлөх ёстой.

**14 дүгээр зүйл. (Мэргэшсэн олон нийтийн сэтгэл судлаачийн шалгалтын хороо)**

Шалгалтын ажил хийхдээ томилогдсон шалгалтын байгууллага нь шаардлагатай мэдлэг эзэмшсэн эсэхийг тодорхойлохтой холбоотой асуудлаар мэргэшсэн олон нийтийн сэтгэл судлаачийн шалгалтын хорооны гишүүн (цаашид энэ бүлэгт "шалгалтын комиссын гишүүн" гэх) байна.

Томилогдсон шалгалтын байгууллага шалгалтын комиссын гишүүнийг томилох гэж байгаа бол түүнийг Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яамны тушаал, Хөдөлмөр, халамжийн яамны тушаалд заасан шаардлагыг хангасан хүмүүсээс томилох ёстой.

Томилогдсон шалгалтын байгууллага шалгалтын комиссын гишүүнийг томилохдоо энэ тухай тушаалын заалтын дагуу Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн сайд, Эрүүл мэнд, хөдөлмөр, халамжийн сайдад мэдэгдэнэ. Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яам, Эрүүл мэнд, хөдөлмөр, халамжийн яамны тушаал. Шалгалтын комисст өөрчлөлт орсон тохиолдолд мөн адил хамаарна.

11 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтууд нь шалгалтын хорооны гишүүдийг ажлаас чөлөөлөхөд mutatis mutandis хамаарна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**15 дугаар зүйл. (Дүрэм журам хэрэглэх гэх мэт)**

Томилогдсон шалгалтын байгууллага, шалгалтын ажил хийхдээ 8 дугаар зүйлийн 1, 9-р зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан "Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн сайд, Эрүүл мэнд, хөдөлмөр, халамжийн сайд" 8-р зүйлийн 1-д), 9-р зүйлийн 1 дэх хэсэгт "томилогдсон шалгалтын байгууллага" гэсэн утгатай.

9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу өмнөх томилогдсон шалгалтын байгууллагад төлсөн шалгалтын хураамжийг тухайн шалгалтын байгууллагын орлого болно.

**16 дугаар зүйл. (Нууцыг хадгалах үүрэг гэх мэт)**

Томилогдсон шалгалтын байгууллагын ажилтнууд эсвэл ажилчид (шалгалтын комиссын гишүүдийг оролцуулаад, дараагийн догол мөрөнд мөн адил хамаарна) эсвэл эдгээр албан тушаалтнууд шалгалтын ажлын талаар олж мэдсэн аливаа нууцыг задруулахгүй.

Шалгалтын ажил эрхэлдэг шалгалтын байгууллагын ажилтнууд эсвэл ажилтнуудыг Эрүүгийн хууль (1890 оны 45-р хууль) болон бусад шийтгэлийн талаар хуулиар олон нийтийн ажил эрхэлдэг ажилтнууд гэж үзнэ.

**17 дугаар зүйл. (Нягтлан бодох бүртгэл гэх мэт)**

Томилогдсон шалгалтын байгууллага нь Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яам, Эрүүл мэнд, хөдөлмөр, халамжийн яамны захирамжийн дагуу шалгалтын талаарх номыг хадгална. Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яам, Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн халамжийн яамны тушаалаар заасантай ажил.

**18 дугаар зүйл. (Хяналтын тушаал)**

Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн сайд, Эрүүл мэнд, хөдөлмөр, халамжийн сайд нар энэхүү хуулийг хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзвэл шалгалтын ажилд хяналт шалгалтыг томилогдсон шалгалтын байгууллагад өгч болно.

**19 дүгээр зүйл. (тайлан)**

Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн сайд, Эрүүл мэнд, хөдөлмөр, халамжийн сайд нар энэхүү хуулийг хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзвэл тогтоосон хяналт шалгалтыг, шалгалтын байгууллагад заасан журмын дагуу шаардлагатай хэмжээгээр өгөх ёстой. Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яамны тушаал, Эрүүл мэнд, хөдөлмөр, халамжийн яамны захирамж., Мэдээлэх боломжтой.

**20 дугаар зүйл. (Газар дээрх үзлэг)**

Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн сайд, Эрүүл мэнд, хөдөлмөр, халамжийн сайд нар энэхүү хуулийг хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзвэл шаардлагатай хэмжээгээр томилогдсон шалгалтын байгууллагын ажилтнуудыг шалгалтын байгууллагад оруулна. Томилогдсон шалгалтын байгууллагын оффис, шалгалтын байгууллагын байр юм..Та тэдэнд ном, бичиг баримт болон бусад шаардлагатай эд хөрөнгийг шалгах, эсвэл холбогдох хүмүүсээс асуулт асуухыг хүсч болно.

Өмнөх догол мөрийн заалтын дагуу газар дээр нь хяналт шалгалт хийж буй ажилтнууд өөрсдийн биеийн байцаалтыг баталгаажуулсан гэрчилгээ авч, холбогдох хүний хүсэлтээр өгөх ёстой.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

(1) дэх хэсэгт заасан эрх мэдлийг эрүүгийн мөрдөн байцаалтад өгсөн гэж ойлгож болохгүй.

**21 дүгээр зүйл. (Шалгалтын ажлыг цуцлах)**

Томилогдсон шалгалтын байгууллага нь Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн сайд, Эрүүл мэнд, хөдөлмөр, халамжийн сайдын зөвшөөрөлгүйгээр шалгалтын ажлыг бүхэлд нь буюу хэсэгчлэн зогсоох буюу хүчингүй болгохгүй.

**22 дугаар зүйл. (Тэмдэглэгээг хүчингүй болгох гэх мэт.)**

Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн сайд, Эрүүл мэнд, хөдөлмөр, халамжийн сайд нар томилогдсон шалгалтын байгууллага нь 10 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн аль нэг зүйлд (3-р зүйлийг оруулаагүй) хамаарах тохиолдолд томилгоог хүчингүй болгоно.

Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн сайд, Эрүүл мэнд, хөдөлмөр, халамжийн сайд нар дараах зүйлсийн аль нэгэнд хамаарах тохиолдолд томилолтыг цуцлах эсвэл туршилтыг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн зогсоохыг үүрэг болгоно. Тодорхой хугацаанд ажиллах.Захиалга өгөх боломжтой.

(I) 10 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн зүйл бүрийн шаардлагыг хангахаа больсон нь тогтоогдвол.
(II) 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу (14 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт mutatis mutandis-ийг хэрэглэсэн тохиолдлуудыг оруулаад), 13 дугаар зүйлийн 3 дахь хэсэг эсвэл 18 дугаар зүйлд заасан журмыг зөрчсөн тохиолдолд.
(III) 12 дугаар зүйл, 14 дүгээр зүйл, 1-3 дахь заалтууд эсвэл өмнөх зүйлийн заалтыг зөрчсөн тохиолдолд.
(IV) Шалгалтын ажлыг 13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан батлагдсан шалгалтын ажлын дүрмийг дагаж мөрдөхгүйгээр хийх үед.
(V) Дараагийн зүйлийн 1 дэх хэсэгт заасан нөхцөлийг зөрчсөн тохиолдолд.

**23 дугаар зүйл. (Тэмдэглэгээ гэх мэт нөхцөлүүд)**

10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 13 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 21 дүгээр зүйлийн заалтын дагуу томилох, батлах, зөвшөөрөх зорилгоор үүнийг нөхцөлт болгож өөрчилж болно.

Өмнөх догол мөрөнд заасан нөхцөлүүд нь томилгоо, зөвшөөрөл, зөвшөөрөлтэй холбоотой асуудлыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хамгийн бага хэмжээгээр хязгаарлагдах бөгөөд томилолт, зөвшөөрлийг хүлээн авсан этгээдэд үндэслэлгүй үүрэг хариуцлага хүлээлгэж болохгүй.

**24 дүгээр зүйл. (Томилогдсон шалгалтын байгууллагаар хийлгэсэн эсэхийг шалгах хүсэлт гэх мэт)**

Томилогдсон шалгалтын байгууллагаар хийлгэсэн шалгалтын ажилд захирамж гаргаагүй, орхигдуулсан, сэтгэл хангалуун бус байгаа хүн Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн сайд, Эрүүл мэнд, хөдөлмөр, халамжийн сайдад шалгалт өгөх хүсэлт гаргаж болно. Энэ тохиолдолд Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн сайд, Эрүүл мэнд, хөдөлмөр, хамгааллын сайд нар Захиргааны зөрчлийн шалгалтын тухай хууль (2006 оны 68 дугаар хууль), 25 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт, болон 46 дугаар зүйл, 1. 2 дахь хэсэг, 47 дугаар зүйл, 49 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн заалтыг хэрэглэхтэй холбогдуулан шалгана.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**25 дугаар зүйл. (Шалгалтын ажлыг Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн сайд, Эрүүл мэнд, хөдөлмөр, халамжийн сайдын хэрэгжүүлсэн гэх мэт)**

Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн сайд, Эрүүл мэнд, хөдөлмөр, халамжийн сайд нар шалгалтын байгууллага гэж томилогдсон тохиолдолд шалгалтын ажил явуулахгүй.

Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн сайд, Эрүүл мэнд, хөдөлмөр, халамжийн сайдыг 22 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу томилсон, томилогдсон шалгалтын байгууллага нь шалгалтын ажлыг бүхэлд нь буюу хэсэгчлэн түр зогсоох тохиолдолд томилно. 21 дүгээр зүйлд заасны дагуу зөвшөөрөлтэйгээр томилогдсон шалгалтын байгууллагад шалгалтын ажлыг бүхэлд нь буюу хэсэгчлэн зогсоохыг тушаах, эсвэл бүхэлд нь буюу хэсэгчлэн хийх нь хэцүү болоход шаардлагатай гэдэг, жишээ нь байгалийн гамшиг болон бусад шалтгаанаар хийсэн шалгалтын ажил.Энэ тохиолдолд шалгалтын ажлыг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн өөрөө хийх ёстой.

**26 дугаар зүйл. (Олон нийтэд зарлах)**

Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн сайд, Эрүүл мэнд, хөдөлмөр, халамжийн сайд дараах тохиолдолд албан ёсны мэдээллийн товхимолд энэ тухай нийтэд мэдээлнэ.

(I) 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтын дагуу томилгоо хийх үед.
(II) 21 дүгээр зүйлийн заалтын дагуу зөвшөөрөл олгосон тохиолдолд.
(III) 22 дугаар зүйлд заасны дагуу томилгоог хүчингүй болгосон эсвэл шалгалтын ажлыг бүхэлд нь буюу хэсэгчлэн зогсоох тушаал гаргасан тохиолдолд.
(IV) Өмнөх зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу шалгалтын ажлыг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн хийхээр шийдсэн эсвэл шалгалтыг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн хийхгүй байхаар шийдсэн тохиолдолд. түүний гүйцэтгэсэн ажил.

**27 дугаар зүйл. (Туршилтын дэлгэрэнгүй мэдээлэл гэх мэт)**

Энэ бүлэгт зааснаас гадна шалгалт, томилогдсон шалгалтын байгууллага болон энэ бүлгийн заалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой бусад шаардлагатай асуудлыг Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яамны тушаалаар тодорхойлно. болон Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны тушаал.

## 3-р бүлэг. Бүртгэл

**28 дугаар зүйл. (Бүртгүүлэх)**

Нийтийн мэргэшсэн сэтгэл зүйч мэргэжилтэй хүн мэргэшсэн олон нийтийн сэтгэл судлаач болохын тулд БСШУЯ-ны тушаалаар заасан нэр, төрсөн он сар өдөр болон бусад асуудлыг бүртгүүлэх ёстой. Спорт, шинжлэх ухаан, технологи, Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны олон нийтийн сэтгэл судлаачийн мэргэшсэн бүртгэлд бүртгүүлсэн болно.

**29 дүгээр зүйл. (Мэргэшсэн олон нийтийн сэтгэл судлаачийн бүртгэл)**

Нийтийн сэтгэл судлалын мэргэшсэн бүртгэлийн бүртгэлийг Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яам, Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам тус тус бэлтгэнэ.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**30 дугаар зүйл. (Мэргэшсэн олон нийтийн сэтгэл судлаачийн бүртгэлийн гэрчилгээ)**

Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн сайд, Эрүүл мэнд, хөдөлмөр, халамжийн сайд нар олон нийтийн сэтгэл судлалын мэргэшсэн сэтгэл судлаачаар бүртгүүлсэн бол олон нийтийн сэтгэл судлаачийн бүртгэлийн гэрчилгээ (цаашид энэ бүлэгт "бүртгэл" гэх болно) 28 дугаар зүйлд заасан асуудлыг өргөдөл гаргагчид мэдэгдсэн болно. "Баталгаа") гаргана.

**31 дүгээр зүйл. (Бүртгэгдсэн эд зүйлсийг өөрчлөх тухай мэдэгдэл гэх мэт)**

Мэргэшсэн олон нийтийн сэтгэл зүйч нь бүртгэгдсэн асуудалд өөрчлөлт орсон тохиолдолд Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн сайд, Эрүүл мэнд, хөдөлмөр, хамгааллын сайдад цаг алдалгүй мэдэгдэнэ.

Мэргэшсэн олон нийтийн сэтгэл судлаач өмнөх догол мөрийн дагуу мэдэгдэл хийхдээ бүртгэлийн гэрчилгээний хамт мэдэгдлийг ирүүлж, залруулгыг хүлээн авах ёстой.

**32 дугаар зүйл. (Бүртгэлийг цуцлах гэх мэт.)**

Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн сайд, Эрүүл мэнд, хөдөлмөр, халамжийн сайд нь мэргэшсэн олон нийтийн сэтгэл зүйч дараах зүйлсийн аль нэгэнд хамаарах тохиолдолд бүртгэлийг хүчингүй болгоно.

(I) 3 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг эс тооцвол).

(II) Бүртгэлийг хуурамч эсвэл залилан хийсэн баримтад үндэслэн хүлээн авах үед,

Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн сайд, Эрүүл мэнд, хөдөлмөр, халамжийн сайд нар бүртгэлийг хүчингүй болгох, эсхүл мэргэшсэн сэтгэл зүйч 40 дүгээр зүйлийн 41, 42 дугаар зүйлийн 42 дахь заалтыг зөрчсөн тохиолдолд хугацааг тогтооно. Та мэргэшсэн олон нийтийн сэтгэл судлаачийн нэрийг захиалж, энэ нэрээр сэтгэл судлаач гэдэг үгийн хэрэглээг түдгэлзүүлэх боломжтой.

**33 дугаар зүйл. (Бүртгэлийг цуцлах)**

Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн сайд, Эрүүл мэнд, хөдөлмөр, халамжийн сайд нар мэргэшсэн олон нийтийн сэтгэл судлаачийн бүртгэл хүчингүй болсон тохиолдолд бүртгэлийг хүчингүй болгоно.

**34 дүгээр зүйл. (Мэдээлэл өгөх)**

Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн сайд, Эрүүл мэнд, хөдөлмөр, халамжийн сайд нар мэргэшсэн олон нийтийн сэтгэл зүйчдийг бүртгэх талаар харилцан шаардлагатай мэдээллийг өгнө.

**35 дугаар зүйл. (Өөрчлөлтийн бүртгэлийн хураамж гэх мэт)**

Бүртгэлийн гэрчилгээнд заасан зүйлийг өөрчлөх хүсэлтэй хүн, бүртгэлийн гэрчилгээний дахин олголтыг авах гэж байгаа хүн бодит зардлыг харгалзан Засгийн газрын тогтоолоор тогтоосон төлбөрийг төлөх ёстой.

**36 дугаар зүйл. (Заасан бүртгэлийн байгууллагын томилгоо гэх мэт)**

Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яамны захирамжийн дагуу Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн сайд, Эрүүл мэнд, хөдөлмөр, халамжийн сайдыг томилно. Эрүүл мэнд, хөдөлмөр, халамжийн үйлчилгээний яам нь сэтгэл судлалын мэргэжлийн эмч нарын бүртгэлийг томилогдсон хүмүүс (цаашид

UIH.MN СУДАЛГААНЫ САН

"томилогдсон бүртгэлийн байгууллага" гэх) хэрэгжүүлэхтэй холбоотой. Тэднийг оффисын ажил (цаашид "бүртгэлийн албаны ажил" гэх) хийлгэж болно).

Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яамны тушаал, тус яамны захирамжийн дагуу бүртгэлийн ажил хийх гэж байгаа хүний хүсэлтээр томилогдсон бүртгэлийн байгууллагыг томилно.

**37 дугаар зүйл. (Заасан бүртгэлийн байгууллага байгуулах гэх мэт)**

29 дүгээр зүйлд заасан бүртгэлийн байгууллага бүртгэлийн ажлыг явуулахдаа 29 дүгээр зүйл, 30 дугаар зүйл, 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 33 дугаар зүйл, 35 дугаар зүйлийн 29 дүгээр зүйлд заасан заалтыг хэрэгжүүлэх тухай "Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухааны яаманд болон Технологи, Эрүүл мэнд, Хөдөлмөр, Халамжийн Яам нь тус тус "бүртгүүлсэн байгууллагад" гэсэн утгатай, 30 дугаар зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 33 дахь заалт. 35 дугаар зүйлд "Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, Технологи, Эрүүл мэнд, хөдөлмөр, халамжийн сайд", 35-р зүйлд заасан "бүртгэгдсэн бүртгэлийн байгууллага" болно.

Тодорхойлсон бүртгэгч бүртгүүлэхдээ мэргэшсэн олон нийтийн сэтгэл зүйчээр бүртгүүлэхээр төлөвлөж буй хүн бодит зардлыг харгалзан Засгийн газрын тогтоолоор тогтоосон бүртгэгчид төлбөр төлөх ёстой.

35 дугаар зүйл, өмнөх догол мөрийн дагуу томилогдсон бүртгэгчид төлсөн төлбөрийг 1-р зүйлийн заалтаар сольж хэрэглэсэн нь томилогдсон бүртгэгчийн орлого болно.

**38 дугаар зүйл. (Холбогдох)**

10 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг, 11-13 дугаар зүйл, 16-26 дугаар зүйлийн заалтыг mutatis mutandis томилогдсон бүртгэгчдэд хэрэглэнэ. Энэ тохиолдолд эдгээр заалтуудын "шалгалтын асуудал" нь "бүртгэлийн асуудал", "шалгалтын хэргийн журам" нь "бүртгэлийн асуудлын журам", 10 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "өмнөх догол мөр дэх өргөдөл" гэсэн утгатай байна. Мөн, 16 дугаар зүйлд, 4-р зүйл, 2-р зүйлийн "өргөдөл" гэдэг нь "36-р зүйлийн 2 дахь хэсэгт заасан өргөдөл", 16-р зүйлийн 1 дэх хэсэгт "ажилтнууд (шалгалтын хорооны гишүүдийг оролцуулаад)" гэсэн утгатай. "Дараагийн догол мөрөнд мөн адил хамаарна." "ажилтан" бөгөөд үүнд "11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг (14 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг)-ийн 22 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь хэсгийн mutatis mutandis -ийг хэрэглэсэн" тохиолдлыг оруулсан болно.), 1-р зүйлийн 3 дахь хэсэг буюу өмнөх зүйлийн "мөн зүйлийн 3 дахь хэсэгт" буюу өмнөх зүйлийн "гэсэн утгыг илэрхийлнэ., 23 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 26 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн" 10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг "-ийг" гэж уншина. 36 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

**39 дүгээр зүйл. (Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яамны тушаал (Эрүүл мэнд, хөдөлмөр, халамжийн яамны тушаал)**

Энэ бүлэгт зааснаас гадна мэргэшсэн олон нийтийн сэтгэл зүйч, бүртгэгдсэн бүртгэлийн байгууллагуудын бүртгэл, энэ бүлгийн заалтыг дагаж мөрдөхтэй холбоотой бусад шаардлагатай асуудлыг Боловсрол, соёлын яамны тушаалаар тодорхойлно. Спорт, шинжлэх ухаан, технологи, Эрүүл мэнд, хөдөлмөр, халамжийн яамны тушаал.

**4-р бүлэг. Үүрэг гэх мэт.**

**40 дүгээр зүйл. (Зээлийн алдагдлыг хориглох)**

Мэргэшсэн олон нийтийн сэтгэл зүйч нь мэргэшсэн олон нийтийн сэтгэл судлаачийн нэр хүндэд халдсан үйлдэл хийх ёсгүй.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**41 дүгээр зүйл. (Нууцыг хадгалах үүрэг)**

Мэргэшсэн олон нийтийн сэтгэл зүйч уг ажлын талаар хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр олж мэдсэн хүний нууцыг задруулж болохгүй. Энэ нь түүнийг олон нийтийн сэтгэл судлаач байхаа больсон ч гэсэн мөн адил хамаарна.

**42 дугаар зүйл. (Хамтын ажиллагаа гэх мэт)**

Мэргэшсэн олон нийтийн сэтгэл судлаач нь хүнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, халамж, боловсрол гэх мэт цогц, зохистой үйлчилгээ үзүүлж, нягт хамтран ажиллана.

Мэргэшсэн олон нийтийн сэтгэл судлаач, хэрэв дэмжлэг үзүүлэх ажлыг хариуцсан эмч байвал үүргээ гүйцэтгэхдээ сэтгэлзүйн дэмжлэг авах шаардлагатай хүнээс зааварчилгаа авна.

**43 дугаар зүйл. (Мэргэжил дээшлүүлэх үүрэг)**

Мэргэшсэн олон нийтийн сэтгэл судлаачид хүмүүсийн сэтгэцийн эрүүл мэндийг хүрээлэн буй орчны өөрчлөлтөөс шалтгаалан ажлын агуулгын өөрчлөлтөд дасан зохицохын тулд 2 дугаар зүйлд тусгагдсан үйлдлүүдийн талаарх мэдлэг, ур чадвараа дээшлүүлэхийг хичээнэ.

**44 дүгээр зүйл. (Нэр ашиглахыг хязгаарласан)**

Мэргэшсэн олон нийтийн сэтгэл зүйч биш хүн "мэргэшсэн олон нийтийн сэтгэл зүйч" нэрийг ашиглах ёсгүй.

Өмнөх догол мөрөнд зааснаас гадна олон нийтийн сэтгэл судлаачаар мэргэшээгүй хүн өөрийн нэр дээр "сэтгэл зүйч" гэсэн тэмдэгтийг ашиглах ёсгүй.

**45 дугаар зүйл. (Шилжилтийн арга хэмжээ гэх мэт)**

Энэ хуулийн заалтыг үндэслэн тушаал гаргах, өөрчлөх, цуцлах тохиолдолд шилжилтийн шаардлагатай арга хэмжээ (тушаал гаргах, өөрчлөх, цуцлахтай холбогдуулан шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр) (Үүнтэй холбоотой шилжилтийн арга хэмжээг багтаасан болно. Жишээ нь торгууль) тогтоож болно.

Энэ хуульд зааснаас гадна Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яамны тушаал, Эрүүл мэнд, хөдөлмөр, Халамжийн яамны тушаал.

**5-р Бүлэг. Торгууль**

**46 дугаар зүйл**

41 дүгээр зүйлийн заалтыг зөрчсөн этгээдийг 1 жилээс илүүгүй хугацаагаар ажил хийлгэх эсхүл 300,000 иенээс хэтрэхгүй торгууль ногдуулна.

Өмнөх хэсэгт дурдсан гэмт хэргийг гомдолгүйгээр гаргаж болохгүй.

**47 дугаар зүйл.**

16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн этгээдийг (38 дугаар зүйлд mutatis mutandis-ийг хэрэглэсэн тохиолдлыг оруулбал) 1 жилээс илүүгүй хугацаагаар ажил хийлгэх эсвэл 300,000 иенээс ихгүй мөнгөн торгууль ногдуулна.

**48 дугаар зүйл**

22 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу шалгалтын ажил эсвэл бүртгэлийн ажлыг зогсоох тухай тушаал (38 дугаар зүйлд mutatis mutandis-ийг хэрэглэсэн тохиолдлуудыг

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

оруулаад) зөрчсөн тохиолдолд зөрчил гаргадаг байгууллага эсвэл томилогдсон бүртгэлийн байгууллагыг 1 жилээс илүүгүй хугацаагаар ажил хийлгэх эсвэл 300,000 иенээс хэтрэхгүй торгууль ногдуулна.

**49 дүгээр зүйл**

Дараах зүйлсийн аль нэгэнд орсон этгээдийг 300,000 иенээс хэтрэхгүй торгууль ногдуулна.

(I) 32 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу мэргэшсэн олон нийтийн сэтгэл судлаачийн нэр, "сэтгэл зүйч" гэсэн нэрийг нэрээр нь ашиглахыг түдгэлзүүлэх тушаал авсан бөгөөд тухайн хугацаанд мэргэшсэн олон нийтийн сэтгэл зүйч.

(II) 44 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг буюу 2 дахь хэсгийн заалтыг зөрчсөн этгээд.

**50 дугаар зүйл**

Дараах зүйлсийн аль нэг нь хамааралтай бол зөрчил гаргасан шалгалтын байгууллага, бүртгэлийн байгууллагын ажилтан, ажилтанд 200,000 иенээс хэтрэхгүй торгууль ногдуулна.

(I) 17 дугаар зүйлийн заалтыг зөрчиж (38 дугаар зүйлд mutatis mutandis-ийг хэрэглэсэн тохиолдлуудыг оруулаад) номыг хадгалахгүй, номыг оруулаагүй, эсвэл хуурамчаар оруулсан.

(II) Тэрээр 19 дүгээр зүйлийн заалтын дагуу тайлан гаргаж өгөөгүй бол (38 дугаар зүйлд заасны дагуу үүнийг mutatis mutandis хэрэглэсэн тохиолдлуудыг оруулаад) эсвэл хуурамч тайлан гаргавал.

(III) 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу (38 дугаар зүйлд заасны дагуу mutatis mutandis-ийг хэрэглэсэн тохиолдлыг оруулаад) орохоос татгалзах, саад учруулах, орохоос зайлсхийх, эсхүл хариуд нь худал мэдүүлэг өгөхгүй байх асуулт. Мэдэгдэл гаргахдаа.

(IV) Шалгалтын ажил эсвэл бүртгэлийн ажлыг 21 дүгээр зүйлийн зөвшөөрөлгүйгээр бүхэлд нь цуцалсан тохиолдолд (38 дугаар зүйлд mutatis mutandis хэрэглэсэн тохиолдлыг оруулаад).

**Нэмэлт заалтууд**

**1 дүгээр зүйл. (Хүчинтэй хугацаа)**

Энэхүү хууль нь нийтэд мэдээлсэн өдрөөс хойш хоёр жилээс хэтрэхгүй хугацаанд Засгийн газрын тогтоолоор тогтоосон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. Гэсэн хэдий ч 10-14 дүгээр зүйл, 16 дугаар зүйл, 18-23 дугаар зүйл, 25-27 дугаар зүйл, 47 дугаар зүйлийн 48, 50 дугаар зүйлийн (1-р зүйлийг эс тооцвол) заалтууд томилогдсон шалгалтын байгууллага) болон Нэмэлт заалтын 8-11-р зүйлийн заалтуудыг нийтлэгдсэн өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Засгийн газрын тушаалаар тогтоосон өдрөөс эхлэн зургадугаар сараас хэтрэхгүй хугацаанд хүчин төгөлдөр болно.

(Засгийн газрын 2009 оны 242 тоот тушаалаар тексттэй холбоотой хэсгийг 2009 оны 9-р сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө)

(Засгийн газрын 2008 оны 55 тоот тушаал, энэ заалттай холбоотой хэсгийг 2008 оны 3-р сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө)

UIH.MN
ТҮЛХҮҮ ДАНЫН САН

**2 дугаар зүйл. (Шалгалтын тусгай шаардлага)**

Дараах зүйлийн аль нэгэнд орсон хүн 7 дугаар зүйлийн заалтыг үл харгалзан шалгалт өгч болно.

(I) Энэхүү хууль хэрэгжиж эхлэх өдрөөс өмнө сургуулийн боловсролын тухай хуулийг үндэслэн төгсөх курст суралцаж төгссөн хүн (цаашид энэ заалтын "нэмэлт заалт"-ын 6 дугаар зүйлд заасан "гүйцэтгэх хугацаа" гэх), мөн сэтгэл судлалын болон бусад асуудлаар төгсөлтийн дараах сургуулиас албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн. Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яамны тушаал, Эрүүл мэнд, хөдөлмөр, халамжийн яамны тушаалаар заасан хичээлүүдийг төгссөн хүмүүс сэтгэл судлаач болох шаардлагатай.

(II) Сургуулийн боловсролын тухай хуулийг дагаж мөрдөх хугацаанаас өмнө төгссөн сургуульд элсэж, Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яамны тушаал, Эрүүл мэндийн яамны тушаалаар заасан хичээлийг дүүргэсэн хүмүүс, Хөдөлмөр, халамж нь хууль сахиулах өдрөөс хойш сэтгэл судлалын чиглэлээр мэргэшсэн олон нийтийн сэтгэл судлаач болоход шаардлагатай сэдвүүдийн хувьд курс төгссөн хүмүүс

(III) Сургуулийн боловсролын тухай хуулийг дагаж мөрдөх хугацаанаас өмнө их дээд сургуульд элсэн орж, Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яам, Эрүүл мэнд, хөдөлмөр халамжийн яамны тушаалаар заасан хичээлүүдийг төгссөн хүмүүс. Сэтгэл зүй болон бусад чиглэлээр мэргэшсэн олон нийтийн сэтгэл судлаач болоход шаардлагатай сэдвүүдийн хувьд Боловсрол, Соёл, Спорт, Шинжлэх ухаан, Технологийн Яам, Эрүүл мэнд, Хөдөлмөр, Халамжийн Яамны Захирамжид тусгасан хүмүүс.

(IV) Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яам, Эрүүл мэнд, хөдөлмөрийн яамны тушаалаар заасан хичээлийг төгссөн хүмүүс сургуулийн боловсролын тухай хуулийг үндэслэн их дээд сургуульд элссэн хүмүүс. Сэтгэл судлал болон бусад чиглэлээр мэргэшсэн олон нийтийн сэтгэл судлаач болоход шаардлагатай сэдвүүдийн хувьд Боловсрол, Соёл, Спорт, Шинжлэх ухаан, Технологийн Яам, Эрүүл мэнд, Хөдөлмөр, халамжийн яамны Захирамжид заасантай тэнцэх хүн. Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яамны тушаал, Эрүүл мэнд, хөдөлмөр, халамжийн яамны захирамжид заасан хугацаа 2 -р зүйлийн 1-ээс 3-р зүйлд заасан үйл ажиллагаа эрхэлдэг хүмүүс.

Энэхүү хуулийг хэрэгжүүлэх үед 2-р зүйлийн 1-ээс 3-р зүйлд заасан үйлдэл хийсэн хүн болон Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яамны тушаалаар заасан бусад хүмүүс. Ийм хүмүүстэй дүйцэхүйц Эрүүл мэнд, Хөдөлмөр, халамжийн яамны захирамж. Дараах зүйлсийн аль нэгэнд хамрагдсан хүмүүс 7 дугаар зүйлийн заалтыг үл харгалзан энэхүү хууль хэрэгжсэнээс хойш таван жилийн хугацаанд шалгалтанд хамрагдах боломжтой.

(I) Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн сайд, Эрүүл мэнд, хөдөлмөр, халамжийн сайдын томилсон семинарын курс дууссан хүмүүс.

(II) Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яам, захирамжид заасан байгууламжид 2-р зүйлийн 1-ээс 3-р зүйлд заасан үйлдлүүдийг таван жил ба түүнээс дээш хугацаагаар бизнес эрхэлж байсан хүн. Мөн Эрүүл мэнд, хөдөлмөр, халамжийн яамны.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Өмнөх догол мөрөнд заасан хүмүүсийн шалгалтыг Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яамны дүрэм, Эрүүл мэнд, хөдөлмөр, халамжийн яамны тушаалын дагуу зарим хичээлээс чөлөөлж болно.

**3 дугаар зүйл. (Шалгалтанд хамрагдах эрхийн талаар авч үзэх болно)**

Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яамны тушаал, Эрүүл мэнд, хөдөлмөр, халамжийн яамны захирамжийг Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн сайд, Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд тогтооно. 7-р зүйлийн 2 дахь хэсгийн шалгалтанд хамрагдах эрхийн талаар, мөн зүйлийн 3 дахь хэсгийн баталгаажуулалтыг хийх бөгөөд ингэснээр 2, 3-р зүйлд жагсаасан хүмүүс сэтгэл судлал, бусад хичээлтэй холбоотой тусгай мэдлэг, ур чадвартай болно. Тухайн зүйлийн 1 дэх хэсэгт заасантай ижил түвшинд эмнэлзүйн сэтгэл зүй, хугацаа болон бусад шаардлагатай тооцоог хийх болно.

**4-р зүйл. (Нэр ашиглахыг хязгаарлахтай холбоотой шилжилтийн арга хэмжээ)**

Энэ хуулийг хэрэгжүүлэх үед мэргэшсэн олон нийтийн сэтгэл судлаачийн нэрийг үнэхээр ашиглаж байгаа хүмүүсийн хувьд эсвэл нэрээр нь сэтгэл судлаачийн дүрийг ашиглаж байгаа хүмүүсийн хувьд 44 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 2 дахь хэсэгт зааснаас хойш зургаан сарын хугацаанд хамаарахгүй.

**5 дугаар зүйл. (шалгалт)**

Засгийн газар энэхүү хуулийг хэрэгжүүлснээс хойш таван жилийн дараа энэхүү хуулийн заалтуудын хэрэгжилтийг шалгаж, үр дүнд үндэслэн шаардлагатай арга хэмжээг авна.

**6-р зүйл. (Туршилтын хэрэгжилтийн талаарх тусгай заалтууд)**

6-р зүйлийн заалтыг үл харгалзан туршилтыг гүйцэтгэх огнооны харьяалагдах жилд хийж болохгүй.

Нэмэлт заалтууд (6-р сарын 14-ний өдрийн 37-р хууль, Рэйвагийн 1-р жил)

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ


- Хуулийн сэтгэл судлал ба сэтгэл зүйн зөвлөгөө by Мөнхцэцэг Д, УБ 2020.
- Бие хүний сэтгэл судлал: орчин үеийн онол болон оношилгоо, сэтгэц заслын аргууд by Баасандорж Э, УБ, 2020.
- Сэтгэл судлал, сурган хүмүүжүүлэх зүйн орос - монгол нэр томьёоны толь
- Сэтгэл судлал, УБ,1967,
- Сурагчдын ёс суртахууны хүмүүжлийн сэтгэл зүйн үндэс, УБ,1973.
- “Сэтгэл судлалын үндэс сурах бичиг” УБ. 2020 Д.Цогзолмаа, Н.Ариунтуяа, А.Нарангэрэл
- “Мэргэжлийн чиг хандлагын сэтгэц оношилгоо”. УБ.2014 Д.Цогзолмаа.
- СЭМҮТ, Сэтгэл зүйн оношилгооны баг. Роршах. УБ.,2019
- Сэтгэц оношилгоо УБ.2017 Г.Сарантуяа. /Д.Цогзолмаа. 6-р бүлэг/
- Сэтгэл судлалын үндэс. Сурах бичиг, УБ,2015 Ж.Даваа, Л.Уранцэцэг, Г.Сарантуяа, Д.Цогзолмаа нар.
- https://onlinelibrary.wiley.com/doi/full/10.1080/00207590444000465
- http://www.ncmh.gov.ph/
- https://pmha.org.ph/
- https://www.prc.gov.ph/psychology
- https://www.pap.ph/
- https://www.pap.ph/
- https://www.prc.gov.ph/
- https://lawphil.net/statutes/repacts/ra2010/ra_10029_2010.html


UIH.MN
СУДАЛГААНЫ САН

# ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ ТОГТОЛЦОО БА ПАРЛАМЕНТЫН ОРОЛЦООНЫ ТАЛААРХ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

*Ц.Норовдондог (Ph.D), Д.Жигвваагүнсэл,*
*Д.Амаржаргал (Ph.D), Б.Батцэцэг*

**АГУУЛГА**

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Нэг. Хүний эрхийн боловсрол, түүний ач холбогдол
- Хүний эрхийн боловсрол ба бодлогын баримт бичгүүд
- Хүний эрхийн боловсрол гэж юу вэ?
- Хүний эрхийн боловсролын ач холбогдол

Хоёр. Хүний эрхийн боловсрол олгох тогтолцоо ба хөтөлбөр
- Хүний эрхийн боловсрол олгох тогтолцоо
- Хүний эрхийн боловсролын хөтөлбөр

Гурав.Парламентын хүний эрхийн боловсрол олгох тогтолцоо, арга хэлбэр, бусад орнуудын туршлага
- Хүний эрхийн боловсрол олгоход парламентын оролцоо
- Бусад орнуудын парламентаас хүний эрхийн боловсролыг хэрхэн олгож буй талаарх туршлага (Австрали, Их Британи, БНСУ)

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

## ТОВЧИЛСОН ҮГ

| | |
|---|---|
| НҮБ | Нэгдсэн Үндэстний Байгууллага |
| ХЭК | Хүүхдийн эрхийн конвенц |
| ХЭҮК | Хүний эрхийн үндэсний комисс |
| ХЭТТ | Хүний эрхийн түгээмэл тунхаглал |
| ХЭХҮХ | Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр |
| ХЭБ | Хүний эрхийн байгууллага |
| ХЭБДХ | Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөр |
| ХЭБСТТ | Хүний эрхийн боловсрол, сургалтын тухай тунхаглал |
| ЭЯГБХУТК | Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц |
| ЭЗНСЭТОУП | Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

## УДИРТГАЛ

Судалгааны сэдвийн хүрээнд хүний эрхийн боловсрол гэж юу вэ, түүний ач холбогдол, хүний эрхийн боловсрол олгодог нийтлэг тогтолцоо, арга хэлбэрүүд болон бусад орнуудын парламентаас хүний эрхийн боловсрол хэрхэн олгож буй талаарх туршлагыг судлав. Нийтлэг асуудлын хүрээнд, олон улсын хүний эрхийн боловсрол олгохтой холбоотой баримт бичгүүд, НҮБ-ын хүний эрхийн боловсролын гарын авлага, зөвлөмж зэрэг олон улсад дагаж мөрддөг баримт бичиг, гарын авлагуудыг судалсан бол бусад орны туршлагын хүрээнд, судалгаанд авагдсан орнуудын хууль эрх зүйн орчин, практик туршлагыг холбогдох мэдээллийн эх сурвалжуудын хүрээнд судалсан болно.

**Судалгааны бүтэц:** Судалгаа нь 3 хэсгээс бүрдэнэ. *Нэгдүгээр хэсэгт*, хүний эрхийн боловсролын талаарх үндсэн ойлголт, ач холбогдол, олон улсын баримт бичгүүдийн талаарх мэдээлэл, *Хоёрдугаар хэсэгт*, хүний эрхийн боловсрол олгох тогтолцоо, арга хэлбэр, хэрэгжүүлэх арга замын талаарх мэдээлэл, *Гуравдугаар хэсэгт* хүний эрхийн боловсрол олгоход парламентаас хэрхэн оролцдог талаарх туршлагыг Австрали, БНСУ, Их Британи зэрэг орнуудын жишээн дээр авч үзсэн болно.

***Түлхүүр үг**: Хүний эрхийн боловсрол, Парламентын хүний эрхийн боловсролын хөтөлбөр, Хүний эрхийн боловсролд парламентын оролцоо, НҮБ-ын хүний эрхийн боловсролын хөтөлбөр, тунхаглал, баримт бичгүүд*

***Keywords:** Human Rights Education, Parliamentary Human Rights Education Program, Parliamentary Participation in Human Rights Education, UN global human rights education program*

## СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Хүний эрх нь бүх улс үндэстэн, ард түмний хувьд нийтлэг үнэт зүйлс, зайлшгүй дагаж мөрдөх хэм хэмжээ мөн тул улс үндэстнүүд хүний эрхийг хамгаалах үндсэн зарчим, түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалтыг хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээний акт, үндэсний хөгжлийн бодлого, хөтөлбөртөө тусган хэрэгжүүлж, холбогдох хууль тогтоомж, олон улсын гэрээ, конвенцоор хамгаалсан байдаг. Эдгээр эрх зүйн хэм хэмжээ, хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, цаашид төгөлдөржүүлэх үндсэн нөхцөл нь хүн өөрөө эрхээ сайн мэдэж, хэрэгжүүлэх явдал буюу хүний эрхийн боловсролыг дээшлүүлэх тухай асуудал юм.

Хүний эрхийг хүлээн зөвшөөрөх, хүндэтгэх, хангах, хамгаалах, хөхиүлэн дэмжих үүргийг төр, засгийн газрууд хүлээдэг болохыг олон улсын хүний эрхийн гэрээнүүдэд өргөнөөр тусгаж, эрх хэмжээг нь тодорхойлж өгсөн байдаг бол хүний эрхийн боловсрол нь уг үүрэг хариуцлагыг хангах үндсэн хэрэгсэл болдог байна.

Хүний эрхийн боловсрол нь хүний эрхэм чанар ба үнэт зүйлс, аливаад хандах хандлагыг төлөвшүүлдэг, зан үйлийг сайнаар өөрчилж, нийгмийн шударга ёсыг бэхжүүлдэг, хүмүүс, аливаа үндэстэн хоорондын эв санааны нэгдлийг бий болгодог, мэдлэг олгож, задлан шинжлэх ур чадварыг хөгжүүлдэг, суралцагчдын оролцоог хангасан боловсролыг олгодог гэх зэрэг олон талын ач холбогдолтой юм.

1994 оны 12-р сард хуралдсан НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулганаас НҮБ-аас анх удаа Хүний эрхийн боловсролын 10 жилийг (1995-2005) тунхаглан зарласан бөгөөд хүний эрхийн боловсрол бол нийгмийн бүхий л түвшинд тэгш эрхийг хангаан баталгаажуулах чухал арга хэрэгсэл тул хүний эрхийн боловсрол олгоход төрийн болон

төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, иргэний нийгмийн бүх байгууллага, хувь хүмүүс бүгд оролцох шаардлагатайг онцлон тэмдэглэсэн.[150]

Энэ хугацаанд НҮБ-аас *албан ёсны сургуулийн тогтолцоо, түгээмэл болон насанд хүрэгчдийн боловсролоор дамжуулан* хүний эрхийн талаарх мэдээллийг хүн бүрт хүртээмжтэй байлгахыг бүх гишүүн орнуудаас шаардаж, дэмжиж иржээ.

Үүний дараа 2004 онд хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагааг нэгдсэн удирдамж, чиглэлээр хангах зорилгоор НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Парисын зарчим, хүний эрхийг хангах бусад олон улсын баримт бичиг, гэрээ, конвенцуудад тулгуурлан НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулганаас хүний эрхийн боловсрол олгох стратеги, төлөвлөгөөг агуулсан олон улсад дагаж мөрдөх *Дэлхийн Хүний эрхийн боловсролын хөтөлбөр* (2004 оноос хойш), *Хүний эрхийн боловсрол, сургалтын тунхаглал* (2011) зэрэг баримт бичгүүдийг батлан хэрэгжүүлж байна.[151] Эдгээр хөтөлбөр, тунхаглал, түүнийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө нь дэлхийн улс орнуудад хүний эрхийн боловсролыг үе шаттайгаар олгох, зорилтот бүлгүүдийн эрхийг хамгаалах, тэдэнд хүний эрхийн талаарх мэдлэг ойлголт өгөх, тэгш боломжийг хангах бодлогын гарын авлага, нэгдсэн удирдамж, чиглэл болон ашиглагдаж байна.

*Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөр нь* 2004 оноос эхлэн 4 үе шаттайгаар хэрэгжиж байгаа бөгөөд хөтөлбөрийн үе шат бүхэнд хэрэгжүүлэх бодлого, зорилтуудыг нэгдсэн журмаар гаргаж дэлхийн улс орнуудад хэрэгжүүлэхийг уриалж ирсэн. 2005-2009 онд хэрэгжүүлсэн хөтөлбөрийн 1-р үе шатны төлөвлөгөөнд хүний эрхийн боловсролын агуулгыг бага болон дунд боловсролын тогтолцоонд тусгах, 2010-2014 оны хөтөлбөрийн 2-р шатны төлөвлөгөөнд дээд боловсролын тогтолцоо, төрийн албан хаагчид, хууль сахиулах байгууллага, цэрэг, цагдаагийн ажилтнуудын сургалтын хөтөлбөрт тусгах, сургагч багш нарыг бэлтгэх, 2015-2019 оны 3-р шатны төлөвлөгөөнд хэвлэл мэдээллийн салбарын мэргэжилтнүүд, сэтгүүлчдэд зориулсан хүний эрхийн боловсролын асуудлыг онцлон тусгасан бол 2020 оноос эхлэн хэрэгжиж байгаа хөтөлбөрийн 4-р шатны төлөвлөгөөнд хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагаанд залуучуудыг татан оролцуулах, оролцооны олон талт аргуудад тулгуурласан аргаар хүний эрхийн боловсрол олгох, мөн түүнчлэн хүний эрхийн боловсрол олгох хөтөлбөрийг “Тогтвортой хөгжлийн зорилго-2030” бодлогын баримт бичгийн 4.7-д тусгасан зорилтыг хэрэгжүүлэхэд чиглүүлэх шаардлагатай байгааг онцолсон.

Хүний эрхийн дэлхийн хөтөлбөрийн үе шат бүхэнд дэвшүүлсэн зорилго, онцлон анхаарах сэдвүүд өөр өөр байгаа бөгөөд 2020-2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн гол сэдвүүд нь **тэгш байдал, хүний эрх, үл ялгаварлал, харилцан бие биенээ хүндлэх, хүртээмжтэй байх хандлагыг төлөвшүүлэхэд** чиглэгдэж байна.

Энэхүү 4-р шатны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссын ажлын албанаас боловсруулж байгаа бөгөөд энэ хүрээнд дараах ажлууд хийгдсэн байна. Үүнд:

- “Хүний эрхийн боловсролын хүч” олон улсын нээлттэй портал сайтыг 2018 онд нээн ажиллуулж байна. Уг нээлттэй эх сурвалжаас хүний эрхийн боловсролыг виртуал хэлбэрээр олгох гарын авлага, материал, баримтат кино болон төлөвлөгөөг хэрэгжүүлэх, идэвхжүүлэхтэй холбоотой заавар зөвлөмж, холбогдох мэдээллийг авч ашиглах боломжтой болсон. (https://www.power-humanrights-education.org)

150 http://hrlibrary.umn.edu/edumat/hreduseries/hrhandbook/part1B.html
151 https://www.ohchr.org/en/issues/education/training/compilation/pages/listofcontents.aspx

UIH.MN СУДАЛГААНЫ САН

- Хүний эрхийн байгууллагуудаас хүний эрхийн боловсролын үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэнд мониторинг хийх шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулан баталсан.
- Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөрийн 4-р үе шатыг хэрэгжүүлэх төрийн болон төрийн бус байгууллагуудын эвсэл буюу “HRE-2020 санаачилга” олон улсын байгууллага байгуулагдаж хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилготой ажиллаж байна.[152]

Хүний эрхийн үндэсний байгууллагууд дээрх хөтөлбөр, тунхаглалыг хариуцан хэрэгжүүлэх үүрэг хүлээх бөгөөд энэ үүрэг хариуцлагынхаа хүрээнд төрийн болон хувийн, олон нийтийн байгууллагуудтай хамтран ажилладаг.

Судалгаанд авагдсан орнуудаас, Их Британийн үндэсний хэмжээний хүний эрхийн байгууллагууд болох Тэгш эрх ба хүний эрхийн комисс, Шотландын хүний эрхийн комисс, Умард Ирландын хүний эрхийн комисс, БНСУ-ын Хүний эрхийн үндэсний комисс, Австралийн Хүний эрхийн үндэсний комисс, Хүний эрхийн боловсролын үндэсний хороо, Хүний эрхийн боловсролын зөвлөл зэрэг байгууллагууд хүний эрхийг хамгаалах, түүнийг сурталчлах үндсэн үүргийг хэрэгжүүлэх бөгөөд хүний эрхийн боловсролыг олон нийтэд олгох, хувь хүний эрхийг хамгаалах, хүний эрх хамгаалагдаж буй эсэхэд хяналт тавих зэрэг үүргийг хэрэгжүүлж, төрийн байгууллагуудаас хүний эрхийг дээдэлсэн үйлчилгээ үзүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажилладаг байна.

Хүний эрхийн байгууллагууд нь хүний эрхийн боловсролыг бүх нийтэд олгох зорилтын хүрээнд хүний эрхийн боловсролын агуулгыг ерөнхий боловсролын сургууль болон их дээд сургуулийн хичээлийн хөтөлбөрт тусгах, сургагч багш нарыг бэлтгэх, төрийн албан хаагчдын хүний эрхийн боловсролыг дээшлүүлэх, мэдлэг олгох хөтөлбөрт сургалт явуулах, хэвлэл мэдээлэл, сэтгүүл зүйн салбараар дамжуулан хүний эрхийн боловсролыг сурталчлах зэрэг ажлуудыг нийтлэг (Австрали, Их Британи, БНСУ) байдлаар зохион байгуулдаг байна.

*Хүний эрхийн боловсрол олгох хэлбэр нь* албан болон албан бус боловсрол, албан бус насан туршийн боловсролын хэлбэртэй байх бөгөөд аргын хувьд сургалтын, мэдээллийн, нөлөөллийн, чиглүүлэх зэрэг олон талт аргуудыг ашигладаг байна. Албан боловсролыг Засгийн газраас хэрэгжүүлж, Хүний эрхийн комисс нь түүнд хөндлөнгийн хяналт тавьдаг байна. (Австрали)

*Хүний эрхийн боловсрол олгох хөтөлбөрийн агуулгын хувьд*, тухайн улсын хүний эрхийн хөгжлийн түвшин, улс төрийн орчин, үндэсний онцлог, соёлын ялгаатай байдал, эрх зүйн тогтолцоо зэрэг олон хүчин зүйлсээс шалтгаалан ижил, эсхүл нэгдсэн стандарт агуулгатай байх боломжгүй хэдий ч ерөнхийдөө хүний суурь үнэт зүйлсийг төлөвшүүлэх, хүний эрхийг хамгаалах стратегид тулгуурласан байх ёстой. Түүнчлэн хүний эрхийн боловсролын агуулгад тэгш боломж, үл ялгаварлах асуудлуудыг зайлшгүй тусгасан байх ёстой гэж үздэг[153] байна.

UIL.MN СУДАЛГААНЫ САН

[152] http://www.hre2020.org/node/46
[153] http://www.mn-nhrc.org/files/setguul_2005_03.pdf

Судалгаанд авагдсан орнуудын хүний эрхийн боловсрол олгох тогтолцоог тоймлон авч үзвэл:

Хүснэгт 1.

| № | Улсын нэр | Боловсрол олгодог хэлбэр | Боловсрол олгож буй байдал |
|---|---|---|---|
| 1 | **Австрали** | - бага, дунд боловсролоор<br>- их дээд сургуулиар<br>- албан бус сургалтаар | Албан боловсролыг Засгийн газраас бүх шатны боловсролын байгууллагаар дамжуулан олгох ба албан бус боловсролыг Хүний эрхийн комиссоос олгодог. Ингэхдээ хүний эрхийн төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран бизнес эрхлэгч, төрийн албан хаагч, олон нийтийн зорилтот бүлгүүдэд өөр өөрсдийн ажлын байр, үйл ажиллагааны явцад хүний эрхийг хэрхэн хангах, хамгаалах талаар мэдлэг, боловсрол олгох сургалтыг тогтмол явуулдаг байна. |
| 2 | **Их Британи** | - бага, дунд боловсролоор<br>- их дээд сургуулиар<br>- албан бус сургалтаар | Хүний эрхийн боловсролыг бүх шатны сургалтын үндэсний хөтөлбөрт тусгаж албан боловсролоор олгодог ба “Иргэний боловсрол” хичээлээр олгодог. Түүнчлэн нийт хүн амын дундах хүний эрхийн талаарх мэдлэг дээшлүүлэх сургалт, төрийн албан хаагчдын анхан шатны сургалт, мэргэжил дээшлүүлэх зэрэг сургалтуудыг явуулдаг. Ингэснээр төрийн үйлчилгээнд хүний эрхийг дээдлэх чухал ач холбогдолтой гэж үздэг. |
| 3 | **БНСУ** | - бага, дунд боловсролоор<br>- их дээд сургуулиар<br>- албан бус сургалтаар | Иргэний болон ёс суртахууны боловсролоор дамжуулж ерөнхий боловсролын сургуулийн хөтөлбөрт хүний эрхийн боловсролыг тусгадаг. Хүний эрхийн иргэний нийгмийн байгууллага, сургалтын институтээс сургагч багш бэлтгэх урт, богино хугацааны дунд болон ахисан түвшний сургалтуудыг зохион байгуулах ба сургагч багш нарт хүний эрхийн тухай ойлголт, ялгаварлан гадуурхалт, захиргаа ба хүний эрх, хүний эрхийн тогтолцоо, хүний эрх, эрх чөлөө зэрэг өргөн сэдвээр хичээлүүд ордог. |

*__Хүний эрхийн боловсролд парламентын оролцооны хувьд,__* парламентаас хүний эрхийн боловсрол олгох үүргийг шууд хэрэгжүүлдэггүй хэдий ч хууль тогтоох, хянан шалгах, төлөөлөл хэрэгжүүлэх бүрэн эрхийнхээ хүрээнд хүний эрхийг хангах эрх зүйн орчныг бүрдүүлэх, парламентын байнгын болон хамтарсан хороодоор дамжуулан хүний эрхийн хэрэгжилтэнд хяналт тавих зэргээр оролцдог. Түүнчлэн парламентаас хүний эрхийн боловсролын үндэсний хөтөлбөр батлах, хэрэгжилтэнд хяналт тавих, төлөөллийн чиг үүргийнхээ хүрээнд иргэд сонгогчид, хүүхэд залууст чиглэсэн сургалт, мэдээлэл, танин мэдэхүйн мэдлэг олгох үйл ажиллагааг парламентын боловсрол олгох хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлдэг туршлага байна.

Судалгаанд авагдсан орнуудын туршлагаас үзвэл, *__Их Британийн__* Парламентын Хүний эрхийн хамтарсан хороо нь хүний эрхийн боловсрол олгох, сурталчилгаа хийх зэрэг ажилд шууд оролцдоггүй. Учир нь парламентын хууль тогтоомжинд хяналт тавих, дүгнэлт гаргах зэрэг үндсэн үүрэгт нөлөөлж болзошгүй гэж үздэг. *__Австралийн__* парламентын хувьд, Хүний эрхийн комиссын хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагааны тайланг хэлэлцэн тухайн асуудлаар тогтоол гаргах байдлаар оролцдог бол *__БНСУ-д__* Хүний эрхийн комиссын бүрэлдэхүүнд Үндэсний Ассамблейн гишүүд (11 комиссарын 4 нь) ордог бөгөөд Комиссын даргыг Үндэсний Ассамблейгаар хэлэлцэн Ерөнхийлөгч нь баталдаг байна.

Парламентаас хүний эрхийн боловсрол олгох оролцооны чухал хэлбэр бол Парламентын боловсрол олгох хөтөлбөр юм. Судалгаанд авагдсан орнуудын туршлагаас үзэхэд, эдгээр орнууд нь парламентын боловсролын хөтөлбөртөө хүний эрхийн асуудлыг тусгасан байх ба агуулгын хувьд тухайн оронд тулгамдсан хүний эрхийн асуудлыг тусгасан нийтлэг туршлага харагдаж байна.

*Хүснэгт 2. Хүний эрхийн боловсролд парламентын оролцоо*

| **№** | **Улсын нэр** | **Парламентын оролцоо** |
|---|---|---|
| *1* | *Австрали* | - Хүний эрхийн комиссын хүний эрхийн боловсролын талаарх тайланг парламентаар хэлэлцэж тогтоол гаргадаг.<br>- Парламент нь бүх шатны боловсролын хууль тогтоомжийг батлахдаа хүний эрхийн боловсролын эрх зүйн орчныг бүрдүүлэх, хяналт тавих чиг үүрэгтэй.<br>- Парламентын боловсролын газраас хэрэгжүүлдэг Парламентын боловсролын хөтөлбөрт хүний эрх тус бүрээр тусгайлан сэдэв гаргаж оруулсан. |
| *2* | *Их Британи* | - Хүний эрхийн хэрэгжилтэнд Парламентын Хүний эрхийн хамтарсан хороо хяналт тавьдаг.<br>- Парламентаас хууль тогтоомжийн төсөл хүний эрхэд нийцэж буй эсэхэд дүгнэлт гаргаж, хэрэгжилтэнд хяналт тавина.<br>- Парламентын боловсрол олгох хөтөлбөрт сонгох эрх, эмэгтэйчүүдийн сонгох эрх, тэгш болон ялгаатай байдал зэрэг сэдвүүдийг тусгасан. |
| *3* | *БНСУ* | - Хүний эрхийн комиссын бүрэлдэхүүнд Үндэсний Ассамблейн гишүүд ордог.<br>- Парламентын боловсрол олгох хөтөлбөрт "Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хөгжлийн бэрхшээлээр ялгаварлан гадуурхахаас сэргийлэх зэрэг асуудлыг тусгасан. |

*(Дэлгэрэнгүй мэдээллийг судалгааны хэсгээс үзнэ үү)*

## СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

### Нэг. ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ, ТҮҮНИЙ АЧ ХОЛБОГДОЛ

Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглалд[154] хүний эрхийг "яс үндэс, оршин сууж буй газар, хүйс, үндэсний болон угсаатны угсаа гарал, арьсны өнгө, шашин, хэл, аливаа бусад байдлаас үл хамааран бүхий л хүмүүний угаас салшгүй хэсэг" гэжээ. Эдгээр эрх нь биднийг ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэл, шударга бус харьцаа хандлагаас хамгаалж, суурь эрх чөлөөг хангадаг байна. Хүний эрх нь боолчлол, хүний наймаанаас ангид байх, амьд байх, хувийн халдашгүй байдал гэхчлэн өргөн хүрээг хамарсан ойлголт юм.

Өнөө цагт хүний эрх нь бүх улс үндэстэн, ард түмний хувьд нийтлэг үнэт зүйлс, зайлшгүй даган мөрдөх хэм хэмжээ болон хүлээн зөвшөөрөгдсөн тул улс үндэстнүүд хүний эрхийн мөн чанар, үндсэн агуулгыг хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ, үндэсний хөгжлийн бодлого, хөтөлбөртөө тусган хэрэгжүүлж, хүний эрхийг хууль тогтоомж, олон улсын гэрээ конвенцоор хамгаалж, хүний эрхийн боловсролоор дамжуулан төлөвшүүлдэг байна.

[154] Хүний эрхийн түгээмэл тунхаглал 1946, https://www.legalinfo.mn/law/details/1271

### *1.1 Хүний эрхийн боловсрол ба бодлогын баримт бичгүүд*

Төр, засгийн газрууд нь хүний эрхийг хүлээн зөвшөөрөх, хүндэтгэх, хангах, хамгаалах, хөхиүлэн дэмжих үүрэг хүлээдэг болохыг олон улсын хүний эрхийн гэрээнүүдэд өргөнөөр тусгаж, эрх хэмжээг нь тодорхойлж өгсөн байдаг. Хүний эрхийн боловсрол нь уг үүрэг хариуцлагыг хангах үндсэн хэрэгсэл юм.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын оршилд “...*хүн бүр, нийгмийн нэгж байгууллага бүхэн эл Тунхаглалыг байнга бодолцон, суралцаж боловсрох замаар хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн сахихад дөхөм үзүүлэхийг эрмэлзэх ёстой*...” хэмээн заасан. Мөн тунхаглалын 26 дугаар зүйлд “... *Боловсрол нь бие хүнийг өв тэгш хөгжүүлэх, хүний эрх, үндсэн эрх чөлөөг улам бүр хүндэтгэдэг болоход чиглэх ёстой. Боловсрол нь аливаа улс түмэн, янз бүрийн арьстан хийгээд шашны бүлгүүд бие биеэ харилцан ойлгох, хүлцэн тэвчих, эвсэн найрамдах, мөн түүнчлэн НҮБ-аас энх тайвныг сахиулах талаар явуулж буй үйл ажиллагаанд дөхөм үзүүлэх ёстой*”[155] хэмээн тодорхойлжээ.

Хүний эрхийн боловсрол нь хүний эрхийг хөхиүлэн дэмжих, сахин хамгаалах мэдлэг, чадвар, хандлага болон зан үйлийг төлөвшүүлэх үйл явц бөгөөд үүнд чухал түлхэц өгсөн арга хэмжээ бол НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1995-2004 оныг Хүний эрхийн боловсролын 10 жил болгон зарласан явдал юм. Энэхүү 10 жилийн үр дүнг хэлэлцээд мөн Ассамблейгаас “Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөр” (2004), “Хүний эрхийн боловсрол, сургалтын тухай тунхаглал (2011) зэрэг бодлогын баримт бичгүүдийг баталсан байна. “Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөр” нь хүний эрхийн боловсролын суурь зарчим, арга зүйн талаар нийтлэг ойлголтод хүрэх, үйл ажиллагааны нэгдсэн хөтөлбөр, чиглэлийг тодорхойлох зорилготой бөгөөд эхний үе[156] (2005-2009) нь сургуулийн тогтолцоонд түлхүү анхаарсан бол Хөтөлбөрийн 2 дахь үе (2010-2014) нь өмнөх таван жилийн ололт дээрээ тулгуурлан ирээдүйн иргэд, удирдагчдыг сургах, тухайлбал, дээд боловсролын байгууллагууд болон хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах үүрэг хүлээсэн төрийн албан хаагчид, хууль сахиулагчид, цэргийн албан хаагчдад чиглэж, 3 дахь үе (2015-2019) хэвлэл, мэдээлэл, сэтгүүл зүйн салбарынханд хүний эрхийн боловсролыг сурталчлахад тус тус чиглэсэн байна. Улмаар 2018 оны 9-р сарын 27-ны өдөр НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссоос Дэлхийн хүний эрхийн боловсролын хөтөлбөр (World programme for Human Rights, WHREP)-ийн 4-р үе шат (2020-2024)-ыг залуучуудын оролцоог хангах, тэдний хүний эрхийн боловсролд чиглэгдэж байгааг зарласан. Энэ хүрээнд хүний эрхийн боловсрол, сургалтын агуулгыг тэгш байдал, хүний эрх, үл ялгаварлал болон оролцоонд тулгуурласан, энх тайван нийгмийг бүтээхийн тулд харилцан бие биенээ хүндлэх, хүртээмжтэй байх сэдвийн дор оролцооны олон талт арга хэлбэрүүдийг ашиглан явуулахыг зөвлөсөн.

Энэхүү төлөвлөгөө нь Засгийн газрууд болон бусад байгууллагууд бодлого, төлөвлөлт хийх үйл явц, төлөвлөгөөг хэрхэн хэрэгжүүлэх асуудлаарх практик удирдамж болдог байна.

Харин “Хүний эрхийн боловсрол, сургалтын тухай тунхаглал”-аар өмнө батлагдсан хүний эрхийн гэрээнд туссан зарчим, хэм хэмжээг дахин баталгаажуулахын хамт бүхий л эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхэд хүний эрхийн боловсрол чухал ач холбогдолтой болохыг тодорхойлон тусгасан байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[155] Хүний эрхийн боловсрол: Хүний эрхийн байгууллагуудын гарын авлага, 2013 он
[156] http://daccess-dds-ny.un.org/doc/UNDOC/GEN/N05/253/74/PDF/N0525374.pdf?OpenElemen

Дээрх баримт бичгүүдийг НҮБ-аас хүний эрхийн боловсролыг хөхиүлэн дэмжих зорилгоор батлан гаргасан ба Хүний эрхийн түгээмэл тунхаглал, холбогдох бодлогын баримт бичиг, гэрээнд зааснаар хүний эрхийн боловсрол нь дараах зарчмууд дээр тулгуурладаг. Тухайлбал,

a) Хүний эрх, эрх чөлөөг хамгаалахад чиглэсэн, олон улсын, бүс нутгийн, үндэсний түвшний хүний эрхийн түгээмэл хэм хэмжээ, зарчмуудыг хүлээн зөвшөөрөх, хэрэгжүүлэх болон мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх;
b) Чөлөөт, ардчилсан, олон ургальч, тэгш хамруулсан нийгмийн үүрэг хариуцлага бүхий хувь хүний хөгжлийг дэмжих, бусдын эрхийг хүндэтгэхийн хамт өөрийн эрх, үүргээ ухамсарлан ойлгодог хүний эрхийн түгээмэл соёлыг бүрдүүлэх;
c) Тэгш байдал, хүлцэн тэвчил, ялгаварлан гадуурхахгүй байхыг эрхэмлэн, хүний бүхий л эрхийг бодитой хэрэгжүүлэхэд эрмэлзэх;
d) Аливаа ялгаварлан гадуурхалтгүйгээр хүн бүр өөрийн эрх, эрх чөлөөний тухай суралцаж, боловсрох тэгш боломжийг бүрдүүлэх;
e) Арьсны үзэл, хэвшмэл ойлголт, дорд үзэх, сөрөг хандлага зэрэг бүх хэлбэрээр ялгаварлан гадуурхах, алагчлах байдалтай тэмцэх, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэнэ.

*1.2.Хүний эрхийн боловсрол гэж юу вэ?*

Хүний эрхийн боловсролыг олон янзаар тодорхойлсон байдаг ч эдгээр нь бүгдээрээ мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, оролцоог хангах, чадавхжуулах, ажил хэрэг болгох сэдлийг төрүүлэхэд чиглэдэг байна. Тухайлбал:[157]

- **Хүний эрхийн Дээд Комиссарын Газар** (ХЭДКГ): Хүний эрхийн боловсрол нь хүн бүр эрхээ эдэлж, бусдын эрхийг хүндэтгэхэд чиглэсэн үнэлэмж, хандлага, итгэл үнэмшлийн цогц юм. Энэ нь хүний эрхийг орон бүрт бодит үйл хэрэг болгох нийтлэг үүрэг хариуцлагыг хөгжүүлдэг.
- **НҮБ-ын Хүний эрхийн боловсрол, сургалтын тухай тунхаглал:** Хүний эрхийн боловсрол гэдэгт хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэх, бүх нийтээр хүндэтгэх байдлыг дэмжихэд чиглэсэн боловсрол, сургалт, мэдээлэл, суралцахуйн бүхий л үйл ажиллагааг ойлгоно. Мөн энэ нь хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэхүйц мэдлэг ойлголт, чадвартай болж, өөрийн зан үйл, хандлагаа төлөвшүүлэх, улмаар хүний эрхийн түгээмэл соёл бүрдүүлэхэд хүн бүр хувь нэмрээ оруулахад чиглэдэг.
- **Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөр** (2012–2014): Хүний эрхийн боловсрол гэдэгт хүний эрхийн түгээмэл соёл бүрдүүлэхэд чиглэсэн боловсрол, сургалт, мэдээллийн үйл ажиллагааг ойлгоно. Үр дүнтэй хүний эрхийн боловсрол нь хүний эрх болон түүнийг хамгаалах тогтолцооны тухай мэдлэг олгоод зогсохгүй, өдөр тутмын амьдралдаа хүний эрхийг хэрэгжүүлэх, хамгаалах, хөхиүлэн дэмжих чадвар хандлагыг хөгжүүлдэг. Мөн хүний эрхийн боловсрол нь нийгмийн бүх гишүүдийн хүний эрхийн нөхцөл байдлыг дээшлүүлэх хандлага, зан үйлийг дэмждэг.
- **Хүний эрхийн төв, Миннесотагийн их сургууль**: Хүний эрхийн боловсрол гэдэг нь хүний эрхийн олон улсын хэм хэмжээг үндэс суурь болгон хүн бүр эрхээ мэдэх, баталгаажуулахын төлөө зохих мэдлэг, чадвар, үнэлэмжид суралцах үйл явц мөн. Үүний хамт хүний эрхийн боловсролыг гэгээрүүлэх чиг хандлагаар дараах байдлаар тодорхойлсон байдаг. Зохих цогц чадамж, боломжуудыг дэмжин

[157] Хүний эрхийн боловсрол: Хүний эрхийн байгууллагуудын гарын авлага, 2013 он

хөгжүүлснээр хүний эрхийн боловсрол нь хүн байхын утга учрыг тодорхойлдог. Иймд боловсрол нь улс төрийн, эдийн засгийн, нийгэм соёлын бүх үйл ажиллагаанд нийгмийн бүрэн эрхт гишүүний хувьд оролцох боломжийг хүн бүрт бүрдүүлэх гэгээрлийн үйл явц юм.

- **Эмнести Интернэшнл ТББ**: Хүний эрхийн боловсрол нь хувь хүмүүс, бүлэг, нийгэмд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрхийн зарчимтай уялдсан мэдлэг, ур чадвар, хандлагад нөлөөлөх, эрх мэдэлжүүлэх зорилго бүхий сайтар боловсруулсан оролцооны туршлага юм.
- **Хүний эрхийн боловсролын Нийгэмлэгийн гүйцэтгэх захирал, Фелисса Тиббитс**: Хүний эрхийн боловсрол бол Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал, бусад гэрээгээр баталгаажуулсан хүний эрхийг олон нийтэд хүргэх, хөхиүлэн дэмжих олон улсын хөдөлгөөнөөс гадна хүний зөрчигдсөн эрхийг сэргээх явц юм.
- Харин НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1948 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталсан **Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 26-р зүйлийн 2 дахь хэсэгт** “...Боловсрол нь бие хүний өв тэгш хүмүүжүүлэх, хүний эрх, үндсэн эрх чөлөөг улам бүр хүндэтгэдэг болгоход чиглэх ёстой. Боловсрол нь аливаа улс түмэн, янз бүрийн арьстан хийгээд шашны бүлгүүд бие биенээ ойлгох, хүлцэн тэвчих, эвсэн найрамдах, мөн түүнчлэн НҮБ-ын энх тайвныг сахин хамгаалах талаар явуулж буй үйл ажиллагаанд дөхөм үзүүлэх ёстой...” гэж заасан нь хүний эрхийн боловсролын сонгодог тодорхойлолт юм.

*1.3. Хүний эрхийн боловсролын ач холбогдол*[158]

Хүний эрх, эрх чөлөөг хоосон уриа, тунхаг бус харин хүн бүрийн бодитойгоор эдэлж чаддаг хэрэглээ болгохын тулд иргэд өөрсдөө хүний эрхийн боловсролтой байх явдал туйлын чухал юм. Хүний эрхийн боловсрол нь оролцогчдод үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, бүлэг, хамт олныг төлөөлөх, шийдвэр гаргах, үндэслэл нотолгоо дэвшүүлэх, бусдыг сонсох, санал нийлэхгүй ч бусдын санал бодлыг хүндэтгэх, ялгаатай соёлыг хүлээн зөвшөөрөх, хамтран ажиллах, хүлээцтэй байх зэрэг иргэний ардчилсан нийгмийн үнэт чадваруудыг төлөвшүүлэхэд үнэлж баршгүй хувь нэмэр оруулдаг.

Хүний эрхийн ойлгон таниулахад чиглэсэн боловсрол нь хүмүүс хүний эрхийн ач холбогдлыг мэдрэх, хүний эрхийн үнэт зүйлсийг мэдэж авах, өөрийн амьдарч буй арга замтайгаа уялдуулахад туслахаас гадна хүмүүсийн өмнө сурсан ур чадвараар дамжуулан хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах хариуцлагын мэдрэмжийг өөрт нь төрүүлж, хэрхэн тохирох арга хэмжээг авахыг тэдэнд зааж өгдөг ажээ.

Хүний эрхийн боловсролын ач холбогдлыг дараах байдлаар тодорхойлж болно.

1. хүндэтгэн дээдлэх үнэт зүйлс, аливаад хандах хандлагад өөрчлөлт авчирдаг;
2. зан үйлд ч өөрчлөлт гардаг;
3. нийгэм дэх шударга ёсыг бэхжүүлдэг;
4. ямарваа нэгэн асуудалд, эсвэл үндэстнүүдийн хоорондын эв санааны нэгдлийг бий болгодог;
5. мэдлэг олгож, задлан шинжлэх ур чадварыг хөгжүүлдэг;
6. суралцагчдын оролцоог хангасан боловсролыг олгодог гм.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[158] СТ-21/411 Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон хүний эрх ба хүний эрхийн боловсрол

## Хоёр. ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ ТОГТОЛЦОО БА ХӨТӨЛБӨР

Хүний эрхийн боловсрол нь хүний эрхийг хэрэгжүүлэх чухал хэрэгсэл бөгөөд энэ нь бүхий л нас, түвшин бүрд хамаарах сургалт, судалгаа, боловсролын бүх хэлбэрийг хамарсан үйл явц юм. Хүний эрхийн боловсрол нь төрийн, хувийн, албан, албан бус зэрэг олон орчинд хэрэгжинэ. Тухайлбал,

- **Албан боловсрол (**Formal education) нь сургуулийн өмнөх боловсролоос эхлэн бага, дунд, дээд боловсролын түвшинд хөтөлбөрт суурилсан ерөнхий эрдмийн, техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтаар хэрэгждэг.
- **Албан бус боловсрол** (Non-formal education) нь албан боловсролын тогтолцоонд хамаарахгүй боловч зохион байгуулалт бүхий боловсролын үйл ажиллагааг ойлгоно. Өөрөөр хэлбэл, тодорхой зорилтот бүлэгт сургалтын тусгайлсан хөтөлбөрийн дагуу сургалт зохион байгуулах явдал юм. Үүнд, ажлын байрны сургалтын хөтөлбөр, насанд хүрэгчдийн болон орон нутгийнханд чиглэсэн хөтөлбөр, хүний эрхийн нөлөөлөл ба иргэдийг чадавхжуулах зэрэг сургалтууд орж болно.
- **Албан бус насан туршийн боловсрол** (Informal education) нь хувь хүн өөрийн дадлага туршлага, суралцахуйн нөлөө, хүрээлэн буй орчны зүйлсээс өөрт шаардлагатай мэдлэг, чадвар, үнэт зүйлс, хандлагад суралцах тодорхой зохион байгуулалтгүй, насан туршийн үйл явцыг хэлнэ.[159]

1993 онд Вена хотноо хуралдсан НҮБ-ын Хүний эрхийн Бага хурлаар хүний эрхийг хангах, хамгаалах явдалд ахиц гаргахад хүний эрхийн боловсролыг бүх нийтэд олгох нь зайлшгүй болохыг хүлээн зөвшөөрсөн байна. Бүх нийтэд хүний эрхийн боловсролыг олгохын тулд сургуулийн өмнөх боловсролоос эхлэн дээд боловсрол хүртэл буюу боловсролын бүх түвшинд хүний эрхийн агуулгыг суралцагчдын хэрэгцээ, шаардлага, нас, сэтгэхүйн онцлогт нийцүүлж тусгах, багш нарыг бэлтгэх сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, энэ чиглэлийн албан бус сургалтыг эрчимжүүлэх ажлыг улс орнуудын Засгийн газар хэрэгжүүлэх үүрэгтэй гэдгийг тэмдэглэжээ.

НҮБ-ын Хүний эрхийн боловсрол, сургалтын тухай тунхаглалд: [160] “*Хүний эрхийн боловсрол, сургалт нь хүний бүхий л эрх, суурь эрх чөлөөг түгээмэл байдлаар хүндэтгэх, мөрдөхөд чиглэсэн төдийгүй хүмүүсийн мэдлэг, ур чадвар, ойлголтоор дамжуулан, өөрийн гэсэн хандлага, зан үйлээр хүний эрхийн зөрчил, зүй бус үйлдлээс урьдчилан сэргийлэх, хүний эрхийн түгээмэл соёлыг бий болгох, хөхиүлэн дэмжихэд хувь нэмэр оруулах хүртэл тэднийг эрх мэдэлжүүлэх боловсролын, сургалтын, мэдээллийн, мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, сурах бүх үйл ажиллагаанаас бүрдэнэ*...гэжээ. Мөн тунхаглалд хүний бүх эрх, суурь эрх чөлөөг хөхиүлэн дэмжихийн тулд мэдээлэл, харилцаа холбооны шинэ технологиудыг мэдээллийн хэрэгслийн адил онцлон, ашиглах, урлагийн төрлүүдийг хүний эрхийн салбарын сургалт болон мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх арга хэрэгслээр ашиглахыг дэмжинэ хэмээн заасан байдаг.

Хүний эрхийн үндэсний байгууллагууд нь тухайн сургалтын зорилго, нөхцөл байдал, оролцогчдын ялгаатай байдлаас хамааран хамгийн зохистой хүний эрхийн боловсролын хандлагыг сонгон тодорхойлох үүрэг хүлээдэг. Эдүгээ хүний эрхийн боловсрол олгоход

[159] Хүний эрхийн боловсрол: Хүний эрхийн байгууллагуудын гарын авлага, 2013 он
[160]https://www.ohchr.org/EN/Issues/Education/Training/Compilation/Pages/UnitedNationsDeclarationonHumanRightsEducationandTraining(2011).aspx

UHRMN СУДАЛГААНЫ САН

олон талт аргын хандлагыг өргөн хэрэглэж байгаа ба энэ нь **мэдээлэл хуваалцах, сургалт, чиглүүлэх, харилцааны менежмент, хүний эрхийн төлөө нөлөөллийн ажил, олон нийтийн хөгжил** гэсэн 6 үндсэн арга зүйг агуулдаг байна. Тухайлбал, олон нийттэй харилцах, мэдээлэл харилцаанд “мэдээлэл хуваалцах”, “нөлөөллийн үйл ажиллагаа”-г, бодлогын шинжилгээ, эрх зүйн нөлөөлөлд “нөлөөлөл”, “чиглүүлэх”, “мэдээлэл хуваалцах” зэрэг аргыг ашиглаж болно. Мөн “харилцааны менежмент” нь энэхүү байгууллагын бүх чиг үүргийн хувьд хэрэглэгдэнэ.

*<u>Хүний эрхийн дэлхийн боловсролын хөтөлбөр</u>*

Хүний эрхийн боловсролын талаар олон улсын гэрээ, конвенц болон баримт бичигт цөөнгүй тусгасан байдаг бөгөөд Хүний эрхийн боловсролыг олгох үйл ажиллагаанд **Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөр** (ХЭБДХ)-ийг чиглэл болгодог ба 2005 оноос хойш тус хөтөлбөрийн дагуу бүх салбарт хүний эрхийн боловсролыг тусгах бодит арга хэмжээ авахыг уриалсан байна.[161] Уг хөтөлбөр нь хүний эрхийн боловсролын суурь зарчим, арга зүйн талаар нийтлэг ойлголтод хүрэх, үйл ажиллагааны нэгдсэн хөтөлбөр, чиглэлийг тодорхойлох зорилготой. Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөрийн:

- *нэгдүгээр шат* (2005-2009) нь бага болон дунд боловсролын тогтолцоонд, *хоёрдугаар шат* (2010–2014) нь дээд боловсрол дахь хүний эрхийн боловсрол буюу багш, сургагч, төрийн албан хаагч, хууль сахиулах болон цэргийн албан хаагчид руу чиглэсэн бол,
- *гуравдугаар* шатны (2015-2019) төлөвлөгөөнд урьдчилан харах үе шатыг бэхжүүлэх, хэвлэл мэдээллийн салбарын мэргэжилтнүүд, сэтгүүлчдэд зориулсан хүний эрхийн сургалтыг онцолсон байдаг.
- *дөрөвдүгээр үе шатны* (2020-2024) төлөвлөгөөг 2018 оны 9-р сарын 27-ны өдөр НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссоос Дэлхийн хүний эрхийн боловсролын хөтөлбөр(World programme for Human Rights, WHREP)-ийн 4-р үе шат (2020-2024)-ыг залуучуудын боловсролд чиглэгдэж байгааг зарласан. Сэдвийн хувьд тэгш байдал, хүний эрх, үл ялгаварлал харилцан бие биенээ хүндлэх, хүртээмжтэй байх агуулгыг хамарч оролцооны болон олон талт сургалтын хэлбэрүүдийг ашиглан явуулахыг зөвлөсөн.

Түүнчлэн Хүний эрхийн боловсролын дэлхийн 4-р шатны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилго-2030 (ялангуяа ТХЗ-ын 4.7-р зорилго)-д нийцүүлэн зөвлөлдөх процессын дагуу боловсруулж, Хүний эрхийн дээд комиссын 42-р чуулганаар хэлэлцүүлэн батлуулахыг ХЭДК (OHCHR)-ийн Ажлын албанд даалгасан.

Уг хөтөлбөр нь хэд хэдэн үе шаттайгаар хэрэгжиж байгаа бөгөөд 4-р шатны зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд улс орнууд өмнөх үе шатанд авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдээ үргэлжлүүлэн авч хэрэгжүүлэхээс гадна 4-р шатанд төлөвлөсөн арга хэмжээнүүдийг мөн хэрэгжүүлэх шаардлагатай болно. ХЭДК-оос уг хөтөлбөрийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна. Үүнд:

- *<u>Хүний эрхийн боловсролын “Хүний эрхийн боловсролын хүч” нээлттэй мэдээллийн сайтыг нээн ажиллуулж байна.</u>* 2018 оны 9-р сарын 18-ны өдөр Хүний эрхийн тунхаглал батлагдсаны 70 жилийн ойн үеэр Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөрийг сурталчлан таниулах, хамтын ажиллагааг

[161] Хууль зүйн сургууль дахь хүний эрхийн боловсролын төлөв байдал 2014 он. 6 дахь тал

хөгжүүлэх зорилго бүхий олон улсын нээлттэй эх сурвалж буюу вэб сайтын нээлтийн ажиллагаа болсон. Уг вэб хуудаснаас хүний эрхийн боловсролыг виртуал хэлбэрээр олгох гарын авлага, материал, баримтат кино болон төлөвлөгөөг хэрэгжүүлэх, идэвхжүүлэхтэй холбоотой заавар зөвлөмж, холбогдох мэдээллийг авч ашиглах боломжтой болсон. (https://www.power-humanrights-education.org)

- *Хүний эрхийн байгууллагуудаас хүний эрхийн боловсролын үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэнд мониторинг хийх шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулсан*. Данийн Хүний эрхийн институтээс ХЭДК-ийн техникийн тусламжтайгаар хүний эрхийн боловсролд мониторинг хийх шалгуур үзүүлэлтийг боловсруулан ХЭК-ийн 39-р чуулганд танилцуулсан. Уг шалгуур үзүүлэлтүүдийг ТХЗ-ын 4.7.1-д тусгасан зорилтуудтай нийцүүлэн боловсруулсан бөгөөд цаашид Хүний эрхий боловсролын дэлхийн хөтөлбөрийг үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой гэж үзэж байна.
- *ХЭДК-ийн 39-р чуулганаас хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагаанд залуу хүмүүсийг татан оролцуулах нь чухал болохыг онцлон тэмдэглэсэн*. Хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагаа нь бүх насны хүмүүсийн үүрэг боловч залуу хүмүүст сургагч багш хийх, нөлөөллийн ажиллагаа явуулах боломж олгох нь зөвхөн тэдний хандлага, ур чадвар, үүрэг хариуцлагыг сайжруулаад зогсохгүй, хүний эрхийг хамгаалах чиглэлд тэдний идэвхтэй үйл ажиллагаа, дэмжлэгийг авах том боломж юм. Албан болон албан бус сургалтын аль ч хэлбэр байсан залуу хүмүүс илүү энх тайванч, хариуцлагатай нийгмийг бүтээхэд манлайлах үүрэг рольтой байх болно. Түүнчлэн ХЭБДХ-ийн 4-р үе шатыг хэрэгжүүлэхэд дэлхийн улс орнуудын төр, засгийн газрууд идэвхтэй дэмжлэг үзүүлж хамтран ажиллах нь чухал гэдгийг онцолсон. HRE-2020 санаачилга нь Хүний эрхийн боловсролын нээлттэй мэдээллийн вэб сайтыг дэмжин хөгжүүлж байгаа бөгөөд уг сайтад дэлхийн бүх улс орнууд хандаж мэдээллээ хуваалцах боломжтой гэдгийг онцолсон.[162]

ХЭБДХ-т хүний эрхийн боловсролын үйл ажиллагааны зарчмыг ийнхүү тодорхойлжээ.[163]

а) Иргэний, улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын эрх болон хөгжих эрх зэрэг хүний эрхийн харилцан хамааралтай, салшгүй, хуваагдашгүй, түгээмэл зарчмыг хөхиүлэн дэмжих;

б) Ялгаатай байдлыг хүндэтгэх хандлагыг дэмжих, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төр болон бусад үзэл санаа, үндэстний, цөөнхийн аль эсхүл нийгмийн гарал, биеийн эсхүл оюуны санааны байдал, бэлгийн баримжаа болон бусад асуудлаар нь ялгаварлах явдлыг эсэргүүцэх;

в) Цаг үеийн болон тулгамдаж буй хүний эрхийн асуудал (ядуурал, зөрчил тэмцэл, ялгаварлан гадуурхалт гэх мэт)-уудад дүн шинжилгээ хийхийг уриалах, түүнчлэн хүний эрхийн стандартад нийцүүлж улс төр, нийгэм, эдийн засаг, технологи болон экологийн салбарын хурдацтай өөрчлөгдөж буй хөгжилд дүн шинжилгээ хийх явдлыг хөхиүлэн дэмжих;

г) Олон нийт болон хувь хүмүүс хүний эрхийн хэрэгцээгээ тодорхойлж, түүнийгээ үр дүнтэй шаардах явдлыг бэхжүүлэх;

162 http://www.hre2020.org/node/46
163 http://daccess-dds-ny.un.org/doc/UNDOC/GEN/N05/253/74/PDF/N0525374.pdf?OpenElement

UIH.MN СУДАЛГААНЫ САН

д) Хуулиар олгосон бүрэн эрхийн хүрээнд хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах үүрэг хүлээгчид, ялангуяа төрийн албан хаагчдад энэхүү үүргээ биелүүлэх чадавхыг олгох;
е) Хүний эрхийн зарчмыг соёлын ялгаатай түвшинг харгалзан бий болгох, улс бүрийн түүх, нийгмийн хөгжлийг анхаарч үзэх;
ё) Хүний эрхийг хамгаалах орон нутгийн, бүсийн, олон улсын хүний эрхийн гэрээ, конвенц болон хүний эрхийн механизмыг ашиглах мэдлэг чадварыг сайжруулах;
ж) Хүний эрхийг хөгжүүлэхэд шаардагдах оролцооны арга зүйг сургалтад ашиглах;
з) Оролцоог дэмжиж, хүний эрхийг хангаж, хүний зан чанарыг бүрэн дүүрэн хөгжүүлэх явдлыг уриалсан, сэтгэл хөдлөл болон дарамтаас ангид заах арга болон сурах орчныг сайжруулах;
к) Суралцагчидтай абстракт хэм хэмжээнээс авахуулаад өдөр тутмын амьдрал, нийгэм, эдийн засаг, соёлын болон улс төрийн бодит нөхцөл байдалтай холбох замаар тэдэнтэй хүний эрхийн талаар харилцан ярилцаж ойлгуулах.

Дээрх зарчмын хүрээнд дэлхийн улс орнууд хүний эрхийн боловсролын сургалтыг явуулдаг ч гадаад улс орнуудын хүний эрхийн сургалт ямар агуулгатай байдаг тухайд нэгдсэн хариулт өгөх боломжгүй юм. Учир нь хүний эрхийн хичээлийн агуулга нь тухайн улсын хүний эрхийн хөгжил, улс төрийн орчин, үндэсний болон соёлын онцлог, эрх зүйн тогтолцоо зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалдаг байна.

Ерөнхийдөө Хүний эрхийн боловсролын агуулга нь хүмүүсийн суурь үнэт зүйлсийг төлөвшүүлэх, эрхийг нь хамгаалах стратегийг боловсруулахад чиглэгдэх ёстой. Түүнчлэн хүний эрхийн боловсролын агуулгад тэгш боломж, ялгаварлан гадуурхалтын асуудлууд зайлшгүй багтах ёстой гэж үздэг[164] байна.

Хүний эрхийн сайн боловсролын хөтөлбөр нь дараах үндсэн шинжүүдийг өөртөө агуулна. Үүнд:

- тэргүүлэх чиглэлд багтсан, судлагдсан, үнэлэгдсэн хүний эрхийн асуудлуудад чиглэх;
- Хүний эрхийн үндэсний байгууллагуудын стратегийн төлөвлөлт, тэргүүлэх чиглэлд чухал хувь нэмэр оруулж чадах, шийдвэрлэх үр нөлөө гаргахуйц асуудлыг сонгох;
- Албан болон албан бус боловсролын аль аль тогтолцоонд анхаарлаа хандуулах;
- хүний эрхийн сургалтын хөтөлбөр, хэрэглэгдэхүүн нь сонсогчдод зориулагдсан, сайтар судлагдсан, мөн зохих байдлаар хянан магадлагдсан байх;
- Албан болон албан бус боловсролын арга зүй, хэрэглэгдэхүүнд дотоод хяналт, зөвлөгөө хийх;
- Хүний эрхийн ***үндэсний хөтөлбөр***, хүний эрхийн ***боловсролын үндэсний хөтөлбөр*** боловсруулах зэргээр албан болон албан бус түншлэлийн хүрээнд хамтран ажиллах;
- Эрх эдлэгч, үүрэг хүлээгч, нөлөөлөгч нарт чиглэх;
- Иж бүрэн хяналт, шинжилгээ үнэлгээний тогтолцоо бүрдүүлэх зэрэг болно..

Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөр (2010–2014)-т хүний эрхийн үндэсний байгууллагууд нь хүний эрхийн боловсролын үндэсний хөтөлбөрийг тодорхойлох, төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх явцад төрийн байгууллагуудтай хамтран ажиллах үндсэн байгууллага болохыг зааж өгсөн байдаг. Мөн хүний эрхийн боловсролын үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийх, түүний ахиц дэвшлийн талаар хүний

[164] http://www.mn-nhrc.org/files/setguul_2005_03.pdf

UIH.MN СУДАЛГААНЫ САН

эрхийн гэрээний тайлагналтын тогтолцоогоор дамжуулан НҮБ-д тайлан илгээх үүрэгтэй. Хүний эрхийн үндэсний байгууллагууд нь чанартай хүний эрхийн боловсролын хөтөлбөр олгохдоо төлөвлөгөө, стратеги, зохих нөөц бүхий байх, чадварлаг сургагч багш нар, зохистой хүний эрхийн боловсролын нөөц хэрэглэгдэхүүнтэй байхыг чухалчилдаг байна.

## Гурав. ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХОД ПАРЛАМЕНТЫН ОРОЛЦОО

Парламентууд нь хүний эрхийг баталгаажуулахад сурталчлан дэмжих (*хүний эрхийн таатай хууль, эрх зүйн орчныг бүрэлдүүлэх болон хүний эрхийн боловсролын үйл ажиллагаагаар*), хамгаалах (*хүний эрхийг зөрчихийг хориглосон, хамгаалалтын идэвхтэй механизмыг бий болгож, зөрчигдсөн тохиолдолд үр дүнтэй засаж залруулах хууль тогтоомжуудыг гаргах зэргээр*), хэрэгжүүлэх (*хүний эрхэд суурилсан хөгжлийн хөтөлбөрүүдийн эх сурвалжийг бий болгон хуваарилах замаар*) гэх зэрэг олон арга замаар хувь нэмрээ оруулах боломжтой. Эдгээрийг дээр дурдсан, хууль батлах, хянах ба төлөөллийн үүрэг, үйл ажиллагаагаараа хийдэг.

Улс орнуудын холбогдох төрийн эрх мэдлийн байгууллага нь хүний эрхийн боловсрол, сургалтыг хөхиүлэн дэмжих, баталгаажуулах үндсэн үүрэг хүлээх ба дангаар болон олон улсын тусламж, хамтын ажиллагаагаар дамжуулан өөрийн боломжит эх сурвалжийг бүрэн ашиглах замаар хуулийн болон захиргааны арга хэмжээ авах, бодлого батлах зэрэг хүний эрхийн боловсрол сургалтыг хэрэгжүүлэх явдлыг баталгаажуулах алхмуудыг хийхийг НҮБ-ын Хүний эрхийн боловсрол, сургалтын тунхаглалд заасан байдаг.

Энэ ч үүднээс улс орнуудын хүний эрхийн байгууллагууд болон төрийн болон хувийн, олон нийтийн байгууллагууд нь өөрсдийн эрх үүргийн хүрээнд хүний эрхийг хөхиүлэн дэмжих, боловсрол олгох үйл ажиллагааг явуулдаг.

Судалгаанд хамрагдсан улс орнуудын парламент нь үндсэн чиг үүргийнхээ хүрээнд хүний эрхийн боловсролыг олгох үйл ажиллагааг дэмжих, баталгаажуулах хууль эрх зүйн орчныг бий болгох, хүний эрхийн хэрэгжилтэд хяналт тавих, хүний эрхийн боловсролыг сурталчлах, иргэдийн дуу хоолойг сонсох, парламентын боловсролоор дамжуулан иргэд, олон нийт, хүүхэд, залуучуудад хүний эрхийн мэдлэг, ойлголтыг түгээхэд оролцдог туршлага байна.

*<u>Парламент хүний эрхийн боловсролыг хэрхэн олгодог талаарх бусад улс орны туршлага</u>*

### 1. ИХ БРИТАНИ

Их Британийн үндэсний хэмжээний хүний эрхийн байгууллагуудад Тэгш эрх ба хүний эрхийн комисс, Шотландын хүний эрхийн комисс, Умард Ирландын хүний эрхийн комисс ордог. Эдгээр байгууллагууд нь хүний эрхийг хамгаалах, түүнийг сурталчлах үндсэн үүрэгтэй ба хүний эрхийн боловсролыг олон нийтэд олгох, хувь хүний эрхийг хамгаалах, хүний эрх хамгаалагдаж буй эсэхэд хяналт тавьж, төрийн байгууллагууд хүний эрхийг дээдэлсэн үйлчилгээ үзүүлэхэд дэмжиж ажилладаг.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**Хүний эрхийн боловсрол олгодог байгууллагууд**

<u>Тэгш эрх ба хүний эрхийн комисс (Equality and Human Rights Commission)</u>: Энэхүү комисс нь 2006 оны тэгш байдлын тухай хуулийн 9-р хэсэгт заасан хүний эрхийн ач холбогдлыг сурталчлах үүрэгтэй бөгөөд Англи ба Уэльс дэх бие даасан олон нийтийн байгууллага юм.[165]

[165] https://www.equalityhumanrights.com/en

Шотландын хүний эрхийн комисс (Scottish Human Rights Commission): Энэ байгууллага нь хүний эрхийн хуульд үндэслэн хууль ба бодлогод өөрчлөлт оруулахыг санал болгодог ба боловсрол, сургалт, эрдэм шинжилгээний ажил эрхлэх замаар хүний эрхийг дэмжих үүрэгтэй ажилладаг.

Умард Ирландын Хүний эрхийн комисс: Уг комисс нь Умард Ирландын хүний эрхийг хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, түүний хэрэгжилт, үр нөлөөнд хяналт тавьдаг. Мөн хүний эрхийг хамгаалахад шаардлагатай хууль тогтоомжийн болон бусад арга хэмжээ авах талаар Умард Ирландын Төрийн нарийн бичгийн дарга болон Ассамблейд зөвлөмж өгдөг. Түүнээс гадна тухайн бүс нутагт хүний эрхийн ач холбогдлын талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, энэ талаар боловсрол, эрдэм шинжилгээний үйл ажиллагаа явуулах үүрэгтэй.[166]

Британийн Хүний эрхийн институт (BIHR-The British Institute of Human Rights): Уг байгууллага нь 45 жилийн турш Их Британи даяар хүний эрхийг хэрэгжүүлэхийн төлөө ажиллаж ирсэн бие даасан үндэсний байгууллага юм. BIHR нь олон нийтийн болон сайн дурын салбарын байгууллагуудтай хамтран хүний эрхийн боловсролыг доорх чиглэлээр олгодог.[167]

- Хүний эрхийг олон нийтийн хуулийн боловсролоор дамжуулан олгох;
- шүүхээс гадуур хүний эрхийг нийгмийн эерэг өөрчлөлтөд ашиглах, байгууллагын соёл, бодлогыг өөрчлөх, хувь хүнийг чадавхжуулахад ашиглах;
- хүний эрхийг хамгаалах чиглэлээр судалгаа, бодлого, компанит ажил явуулж хууль ёсны хамгаалалтыг баталгаажуулах.

Олон нийтийн эрх зүйн боловсролын байгууллагууд: Боловсролын тогтолцооноос гадуур олон нийтийн эрх зүйн мэдлэгийг сайжруулах зорилгоор бий болсон олон нийтийн эрх зүйн боловсрол, мэдээллийн байгууллагууд (public legal education) нь хүний эрхийн боловсрол олгоход чухал үүрэг гүйцэтгэнэ.[168]

**Хүний эрхийн боловсролын агуулга**

Хүний эрхийн боловсролыг хөгжүүлэхийн тулд эхлээд хувь хүн бүр өөрийн эрхийг мэдэж байх ёстой, хоёрдугаарт хууль дээдлэх тухай үндсэн ойлголттой байх шаардлагатай. Энэхүү мэдлэг нь хүний эрхийн соёл цэцэглэн хөгжих урьдчилсан нөхцөл гэж Их Британийн боловсролын тогтолцоонд оруулсан байдаг. Сургуулиудад хүний эрхийн боловсролыг үндэсний сургалтын хөтөлбөрт багтаасан байдаг ба “Иргэний боловсрол” (citizenship education) хичээлээр олгодог. Сургуулиудад хүний эрхийн боловсрол олгохоос гадна нийт хүн амын дунд хүний эрхийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх, төрийн албан хаагчдын анхан шатны сургалт, мэргэжил дээшлүүлэх сургалтуудад хүний эрхийн талаарх сургалтыг тусгасан байдаг. Ингэснээр төрийн үйлчилгээг хүргэх арга хэлбэрийг хөгжүүлэн, хүний эрхийг дээдлэх арга зам болж чадна гэж үздэг.

Британийн Хүний эрхийн институтээс олгодог хүний эрхийн боловсролд Европын Комиссоос баталсан Хүний эрхийн актын дагуу дараах 16 ойлголтыг багтаадаг. Үүнд:

- Амьдрах эрх
- Эрүү шүүлт тулган эсхүл хэрцгийгээр, хүний ёсноос гадуур буюу нэр төрийг нь доромжлон харьцуулах, шийтгүүлэхгүй байх эрх

[166] https://publications.parliament.uk/pa/jt201719/jtselect/jtrights/669/669.pdf
[167] https://www.bihr.org.uk
[168] https://publications.parliament.uk/pa/jt201719/jtselect/jtrights/669/669.pdf

- Боолчлох болон бусдын эрхшээлд орохгүй байх эрх
- Эрх чөлөөтэй байх эрх
- Шударгаар шүүлгүүлэх эрх
- Тухайн үед хуулийн дагуу гэмт хэрэгт эс тооцож байсан аливаа үйлдэлд үндэслэж, гэмт хэрэгт яллан шийтгүүлэхгүй байх эрх
- Хувийн болон гэр бүлийн амьдрал, орон байрны халдашгүй байдал, захидал харилцааныхаа нууцад халдаахгүй байх эрх
- Өөрийн үзэл бодолтой байх, шашинтай байх эрх
- Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх
- Чөлөөтэй хуран цуглах, эвлэлдэн нэгдэх эрх
- Гэрлэх, өрх тусгаарлах эрх
- Энд дурдсан эрхийг эдэлснийхээ төлөө ялгаварлан гадуурхагдахгүй байх эрх
- Өмч эзэмших эрх
- Боловсрол эзэмших эрх
- Сонгох эрх
- Цаазаар авах ялыг устгах




UIH.MN СУДАЛГААНЫ САН

*Зураг.Британийн хүний эрхийн институтийн хүний эрхийн боловсролын агуулга*

Харин Тэгш эрх ба хүний эрхийн комиссоос олон нийтэд олгодог хүний эрхийн боловсролд дараах агуулга багтсан байна.[169] Тухайлбал,

[169] https://www.equalityhumanrights.com/en/equality-act/know-your-rights

- 2010 оны Тэгш эрхийн хуулийн талаарх мэдлэг
- Насаар ялгаварлан гадуурхах
- Хөгжлийн бэрхшээлээр ялгаварлан гадуурхах
- Хүйсээр ялгаварлан гадуурхах
- Гэрлэлтээр ялгаварлан гадуурхах
- Жирэмслэлт ба амаржсанаар ялгаварлан гадуурхах
- Арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах
- Шашин болон итгэл үнэмшлээр ялгаварлан гадуурхах
- Хүйсээр ялгаварлан гадуурхах
- Бэлгийн чиг хандлагаар ялгаварлан гадуурхах

**Хүний эрхийн боловсролд парламентын оролцоо**

Парламентаас Хүний эрхийн хамтарсан хороо (Human rights joint committee) байгуулагддаг. Уг хороо нь Төлөөлөгчдийн танхим болон Лордуудын танхимаас томилогдсон арван хоёр гишүүнээс бүрддэг ба Их Британи дахь хүний эрхтэй холбоотой асуудалд хяналт тавьдаг. Хорооны ажил нь Засгийн газрын хууль тогтоомж бүрийг хүний эрхэд нийцэж байгаа эсэхийг нягтлан шалгах үүрэгтэй ба үүнд, 1998 оны Хүний эрхийн тухай хуулиар баталгаажсан Европын хүний эрхийн конвенц (ECHR), Их Британийн олон улсын гэрээнд багтсан хүний эрхийн хуулийг баримталдаг.[170]

Хүний эрхийн хамтарсан хороо нь хүний эрхийн боловсрол болон сурталчилгааны ажилд шууд оролцдоггүй ба Хүний эрхийн комисст энэ үүргийг хүлээлгэдэг. Учир нь Хүний эрхийн хамтарсан хороо нь хууль тогтоомжид хяналт тавьж, дүгнэлт гаргах үндсэн үүргээ гүйцэтгэхэд нөлөөлж болзошгүй байдаг. Харин Хүний эрхийн комиссын санал болгож буй хууль тогтоомжид дүгнэлт хийж тайланг комисст хүргүүлж болно.[171]

Мөн парламентад суудалтай намуудын хүний эрхийн бүлэг (PHRG-All-Party Parliamentary Human Rights Group) гэж байх ба энэ нь парламентын намуудын нэгдсэн бүлэг (APPG- All-Party Parliamentary Group)-ийн нэг хэсэг юм. Уг бүлгийн гишүүд нь нам харгалзахгүй хамтын ажиллагааны зарчмаар ажиллах бөгөөд үндэсний болон олон улсын хүрээнд хүний эрхийг хангах, ялангуяа шийдвэр гаргагчид болон иргэдийн хооронд маргаан мэтгэлцээн үүсгэж буй иргэний болон улс төрийн эрхийн зөрчилтэй асуудлуудын талаарх мэдлэг, ойлголт өгөх, ийм төрлийн шийдвэрүүдийг засаж залруулах, хууль тогтоомжид өөрчлөлт оруулах лобби ажиллагаа явуулах зорилготой.

Намуудын хамтарсан хүний эрхийн бүлэг нь шийдвэр гаргагчдад зориулсан зөвлөмж гаргах, тэдний гаргасан шийдвэртэй холбоотойгоор хүний эрхийн зөрчилд хариуцлага тооцох, хүний эрхийн зөрчлийг таслан зогсоох, арилгах, олон улсын хүний эрхийн ойлголтыг хүндэтгэн сурталчлах зорилгын дор парламентын бүрэн эрхийг хэрэгжүүлдэг. Ингэснээр тус бүлэг нь улс төрийн хувьд төвийг сахисан, хүний эрхэд суурилсан өргөн хүрээний зөвшилцлийг бий болгодог.

Түүнчлэн уг бүлэг нь Их Британийн улс төрчдийн хүний эрхийг хамгаалах үйл ажиллагааг дэмжих замаар хүний эрх нь зөрчигдсөн хохирогчдыг хамгаалахаас гадна олон улсын форумд хүний эрхийн асуудлыг өргөн хүрээнд хөндөж тавихыг Их Британийн Засгийн газарт уриалан ажилладаг. Мөн Их Британийн улс төрчдийн олон улсын хүний эрхийн

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[170] https://committees.parliament.uk/committee/93/human-rights-joint-committee/role/
[171] The parliamentary committee as promoter of human rights: The UK's Joint Committee on Human Rights. Commonwealth Human Rights Initiative 2007. https://www.humanrightsinitiative.org/publications/hradvocacy/parliamentary_committee_aspromoter_of_hr.pdf

талаарх мэдлэг, мэдээллийг хангалттай хэмжээнд хүргэж, гадаад бодлогын хэлэлцүүлэгтээ хүний эрхийн асуудлыг чухалчлан авч үзэх хандлагыг бий болгодог байна.[172]

**Парламентын боловсрол олгох хөтөлбөрт хүний эрхийн боловсролыг багтаасан эсэх**

Их Британи Улсын парламентын Нийтийн танхим нь стратеги төлөвлөгөөндөө үндэслэн жил бүрийн ажлын төлөвлөгөөндөө парламентын боловсролын асуудлыг багтаасаар ирсэн байна. Парламентын боловсролыг Парламентын боловсролын төвөөр, парламентын ажлын албаны цахим хуудсаар, Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрөөр, орон нутаг дахь парламентын сургалт, мэдээллийн төвүүдээр болон мэдээ, мэдээллийн хэрэгслүүдээр дамжуулан олгодог.[173]

Иргэд олон нийт, хүүхэд багачуудад парламентын боловсролыг олгож, үйл ажиллагааг нь танилцуулахдаа:

- Иргэншил болон Британийн үнэт зүйлс;
- **Сонгууль, сонгох эрх**;
- **Эмэгтэйчүүдийн сонгох эрх**;
- Парламент болон Засгийн газар;
- Нийтийн танхим болон гишүүд;
- Лордуудын танхим;
- Хэлэлцүүлэг;
- Дүрэм журам болон хууль тогтоомж;
- **Тэгш болон ялгаатай** байдал зэрэг сэдвүүдэд төвлөрдөг байна.

Үүнээс сонгууль, сонгох эрх, эмэгтэйчүүдийн сонгох эрх, тэгш болон ялгаатай байдал нь хүний эрхийн боловсролын ойлголтуудад хамаарна.

Эдгээр сэдвүүдийн хүрээнд мэдээллийн контентуудыг цахим болон хэвлэмэл хэлбэрээр бэлтгэн сурагч, оюутнууд хийгээд сургагч багш нарт үнэ төлбөргүй түгээх боломжтой төдийгүй хөдөө, орон нутгийн багш, сурган хүмүүжүүлэгчид парламентын цахим хуудсаар дамжуулан эдгээр хичээлийн хэрэглэгдэхүүнийг татан авах буюу хэвлэмэл байдлаар захиалан авч, хичээлдээ хэрэглэх боломжтой юм. Ерөнхий боловсролын болон их, дээд сургуулийн багш, сурган хүмүүжүүлэгчид, боловсролын салбарын мэргэжилтнүүд нь парламентын боловсрол олгох тусгай багш нар бэлтгэх үнэ төлбөргүй сургалтанд хамрагдаж, өөрийн заадаг хичээлээ улам баяжуулан заах боломжтой. Түүнчлэн энэхүү сургалт нь насанд хүрэгчдэд мөн нээлттэй байдаг.

Парламентын боловсрол олгох хөтөлбөрийг дараах насны ангиллаар хэрэгжүүлдэг:

- сургуулийн өмнөх нас;
- 5-7 нас;
- 7-11 нас;
- 11-14 нас;
- 14-16 нас;
- 16-аас дээш нас;
- Насанд хүрэгчид;
- Залуучуудын бүлэг болон иргэний нийгмийн байгууллагууд.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[172] http://appg-humanrights.org.uk
[173] Парламентын боловсрол олгож буй гадаадын зарим орны туршлага СТ-20/204

Сургалтын хөтөлбөрийн материал дээрх насны ангиллуудаар ойлгомжтой, хүртээмжтэй байх тал дээр түлхүү анхаарч тодорхой сэдвүүдийн хүрээнд янз бүрийн хэлбэрээр хүргэдэг байна. Үүнд: танилцуулга, ном товхимол, видео хичээл, зайн сургалт, парламентын байраар зочлон үйл ажиллагаатай нь танилцах болон тусгай бэлтгэгдсэн багш нараар сургуулийн анги танхимдаа хичээл заалгах зэрэг үйлчилгээнүүдийг авах боломжтой байна. Хүүхдүүдэд ойлгомжтой, сонирхолтой болгох үүднээс биет болон цахим тоглоом, хүүхэлдэйн кино зохион бүтээсэн байна.[174]

Парламентын орон нутаг дахь сургалтын төвүүд нь (Parliament’s Outreach Officers) тус улсын бүс нутаг болгонд парламентын үйл ажиллагааг сурталчилж ажилладаг байна. Иргэд, олон нийт, нийгмийн бүлгүүдэд парламентын үйл ажиллагаа болон хүний эрхийн тодорхой асуудлаар мэдээллийг өгч, тэдэнд санал хүсэлт, тулгарч буй асуудлаа хэрхэн шийдвэрлүүлэх, хэрхэн өөрсдийн дуу хоолойг парламентад хүргэх талаар сургалт, мэдээллийг хүргэдэг байна. Нийгмийн бүлгүүд, олон тооны байгууллагатай хамтран ажилладаг хэдий ч залуучууд, эмэгтэйчүүдийн байгууллага, Ази, Африк гаралтай иргэд, үндэсний цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон урт хугацаанд ажилгүй байгаа иргэдийг түлхүү анхаарч үйл ажиллагаагаа тэдэнд чиглүүлэн ажилладаг байна.

Парламентын боловсрол, иргэдийн оролцооны алба нь “Парламентын нэрэмжит 7 хоног” (UK Parliament week) хүүхэд залуус, олон нийтийг хамарсан, иргэдийн парламентын боловсролыг нэмэгдүүлэх, хууль тогтоох үйл ажиллагаанд иргэдийн оролцоог дээшлүүлэх, идэвхийг нэмэгдүүлэх үндсэн зорилготой олон төрлийн сонирхолтой уралдаан тэмцээнийг орон даяар 7 хоногийн турш зарлан, зохион байгуулдаг байна. Энэхүү арга хэмжээг анх 2011 онд Их Британийн Парламентаас санаачлан жил бүр зохион байгуулж ирсэн бөгөөд жил бүр тодорхой асуудал, сэдвийг хөнддөг. Тухайлбал, 2017 онд “Эмэгтэйчүүдийн санал өгөх эрх”-ийн талаар парламентын нэрэмжит долоо хоногийг зохион байгуулсан байна.

Британийн Залуучуудын Холбоо нь хүүхэд, залуучуудын улс төрийн боловсрол, нийгмийн идэвхийг нэмэгдүүлэх, ирээдүйд нийгмийн хариуцлагатай, оролцоотой иргэнийг бэлтгэх, шийдвэр гаргах түвшинд залуусын дуу хоолойг хүргэх зорилгоор 11-18 насныхнаас бүрдсэн “Өсвөрийн парламент”-ыг ажиллуулдаг.[175]

Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрөөр дамжуулан парламентын боловсролын хүрээнд хүний эрхийн боловсрол олгож буй туршлага

Тус улсад Ерөнхий боловсролын сургуулийн хөтөлбөрийн Иргэний боловсрол (Citizenship education) хичээлээр дамжуулан сурагчдад парламентын боловсролыг олгодог бөгөөд сурагчдын нас, сэтгэхүйн онцлогт тохируулж бага ангиас нь “*чи хэн бэ, чиний эргэн тойрон, хүрээлэн буй орчин чамаас ямар хамааралтай байдаг вэ”* гэсэн энгийн ойлголтыг өгч үүнийгээ дунд ангиудад гүнзгийрүүлэн нийгэмд өөрийн үзэл бодолтой, өөртөө итгэлтэй хувь хүн болон төлөвшихөд түлхүү анхаарч, өөрийн амьдарч буй хүрээлэл, гадаад ертөнц хоёрын харилцан хамаарал, нийгмийн шударга байдал, ёс зүй гэж юу болох, чиний үзэл бодол, чиний сонголт зөвхөн орон нутгийн төдийгүй, цаашлаад өөрийн улсын, бүр энэ дэлхийн амьдралд ямар нөлөөтэй болох тухай мэдлэг мэдээлэл, ойлголтыг өгдөг байна.[176]

[174] https://learning.parliament.uk/resources/
[175] https://www.byc.org.uk/uk/uk-youth-parliament
[176] https://assets.publishing.service.gov.uk/government/uploads/system/uploads/attachment_data/file/402173/Programme_of_Study_KS1_and_2.pdf

Ахлах ангид тус хичээлээр нийгэмд идэвхтэй, оролцоотой иргэн бэлтгэхэд шаардагдах ойлголт, мэдлэг, ур чадварыг олгоход чиглэж, ардчилал, төр засаг, хууль тогтоох үйл ажиллагааны талаарх мэдлэгийг сонирхолтой байдлаар хүргэхийг зорьдог байна. Ирээдүйд нийгэмд хариуцлагатай иргэн болж төлөвших, мөнгө төгрөгөө зөв зүйтэй зарцуулах, санхүүгийн зөв шийдвэр гаргаж байх, хүний эрх ба нийгмийн хариуцлага зэрэг ойлголтыг энэхүү хичээлээр заадаг байна. Ахлах ангийн нийт сурагчдад Иргэний боловсрол хичээлээр хүний эрхийн боловсролыг багтаасан дараах мэдлэг, чадварыг эзэмшүүлэх зорилготой:

- Их Британийн төрийн тогтолцоо, ардчилсан засаглалд иргэд хэрхэн идэвхтэй оролцох талаар;
- Нийгэмд хууль тогтоомж, шүүхийн тогтолцооны гүйцэтгэх үүрэг болон хууль боловсруулах, батлах үйл явц, түүний хэрэгжилтийн талаар;
- **Хүний эрх ба нийгмийн хариуцлага; Олон талт байдал, хүртээмж; Тэгш эрх ба нийгмийн шударга ёс; Ардчилал ба идэвхтэй оролцооны талаар;**
- Цаашид олон нийтийн болон бусад нийгэмд тустай, хариуцлагатай үйл ажиллагаанд оролцох идэвх, сонирхлыг төрүүлэх, хөгжүүлэх, хэвшүүлэх талаар;
- Асуудалд олон талаас нь нухацтай хандах, улс төрийн сэдвээр хэлэлцүүлэг өрнүүлэх, өдөр тутмын мөнгө санхүүгийн асуудлаа зөв зүйтэй зохицуулах зэрэг болно.[177]

## 2. БНСУ

### Хүний эрхийн боловсрол олгодог байгууллагууд

Хүний эрхийн үндэсний комисс (National Human Right Commission) БНСУ-д 2001 онд Хүний эрхийн үндэсний комисс байгуулагдсан ба уг байгууллага нь тус улсын дагаж мөрддөг олон улсын хүний эрхийн конвенц, гэрээнүүдэд тусгагдсаны дагуу хүний нэр төр, үнэ цэнэ, эрх чөлөөг дээдэлж, хүний эрхийг баталгаажуулах үүрэгтэй.[178]

Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 1-р зүйлд хүний нэр төр, үнэ цэнийг хамгаалж, ардчиллын үндсэн зарчмыг баримтлахад хүний эрхийн үндэсний комиссыг байгуулж, хүний халдашгүй дархан эрхийг хамгаалах үйлсэд зориулна гэж заасан. Мөн үндсэн чиг үүрэгт нь олон нийтэд хүний эрхийн боловсрол олгох талаар орсон байдаг ба энэ талаар Засгийн газар, иргэний нийгмийн байгууллагууд, НҮБ-ын хүний эрхийн байгууллагуудтай хамтран ажилладаг.

Хүний эрхийн сургалтын институт (Human Rights Training Institute) Хүний эрхийн сургалтын институт нь хүний эрхийн талаар заадаг сургагч багш нарыг бэлдэхээс гадна иргэн бүрийг хүний эрхийн боловсрол эзэмшихэд шаардагдах орон зайг хангадаг байгуулллага юм. Тус институтийн сургалтын хөтөлбөрт Хүний эрхийн үндэсний комисст тулгарч байгаа өнөөгийн сэдвүүдийн дагуу мэдлэг, ойлголтыг шингээж өгснөөр хүний эрхийн чанартай боловсрол олгох, хүний эрхийн таатай соёлыг төлөвшүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Кибер хүний эрхийн сургалтын төв (Cyber Human Rights Training Center) Хүний эрхийн боловсролын эрэлт хэрэгцээ тасралтгүй нэмэгдэж байгаатай холбогдуулан Хүний эрхийн үндэсний комиссоос уг сургалтын төвийг байгуулж, зайны сургалтын системийг бий

[177] https://www.gov.uk/government/publications/national-curriculum-in-england-citizenship-programmes-of-study
[178] https://www.humanrights.go.kr/site/main/index002

болгосон. Үүгээр багш хөгжүүлэх хөтөлбөр явуулж хүний эрхийн багш нарыг бэлдэхээс гадна олон нийтэд зориулсан хөтөлбөр хэрэгжүүлдэг. 2020 онд КОВИД-19 цар тахлын улмаас бүлгийн сургалтыг бүрэн цахим хэлбэрт шилжүүлж, өмнө нь биеэр ирж суудаг байсан сургалтуудыг хоёроос дээш хоногийн тусгай сургалтын хөтөлбөрөөр сольсон байна.

**Хүний эрхийн боловсролын агуулга**

Кибер хүний эрхийн сургалтын төвөөс явуулдаг хүний эрхийн боловсролын талаар олон нийтэд олгодог түгээмэл контентод дараах агуулга багтдаг.

- "Хүний эрхийг ойлгох нь" сэдвийн хүрээнд хүний эрхийн талаарх үндсэн ойлголт олгох;
- "Хүйсээр ялгаварлан гадуурхахаас урьдчилан сэргийлэх" сэдвийн хүрээнд хүйсээр ялгаварлан гадуурхалт, бэлгийн мөлжлөг, бэлгийн дарамтын талаар цогц ойлголт өгч, эдгээр үйлдлийг таслан зогсоох;
- "Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ялгаварлан гадуурхахаас урьдчилан сэргийлэх" сэдвийн хүрээнд хөгжлийн бэрхшээл ба хүний эрхийн мэдлэгийг дээшлүүлэх замаар хөгжлийн бэрхшээлтэй холбоотой ялгаварлан гадуурхахаас урьдчилан сэргийлэх;
- "Захиргаа ба хүний эрх" сэдвийн хүрээнд захиргааны бодлогыг хэрэгжүүлэх явцад хүний эрхтэй холбоотой гарч болзошгүй нөхцөл байдал, шийдвэрийг хэлэлцдэг.[179]

Харин хүний эрхийн сургалтын институтээс явуулдаг хүний эрхийн сургагч багш хөгжүүлэх хөтөлбөр анхан шатны нэг ба хоёрдугаар үе, дунд, гүнзгий гэсэн 4 үе шаттай бөгөөд 12 хоног үргэлжилдэг. Түүнээс гадна бүлгээр ордог дөрвөн сарын курс бүхий 101 удаагийн урт хугацааны, гүнзгийрүүлсэн сургалт байх ба үүнд, хүний эрх, эрх чөлөөний эрх, нийгмийн эрх, тэгш эрх, олон улсын хүний эрхийн тогтолцоо, хүний эрхийн үндэсний байгууллагуудын тухай хичээлүүд ордог. Дунд болон ахисан түвшний хөтөлбөрүүдэд оролцогчид багшлах арга зүйгээ шалгуулснаар багшлах эрхтэй болдог.[180]

**Хүний эрхийн боловсролд парламентын оролцоо**

Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн 19 ба 26-р зүйлд тус комисс нь хүний эрхийн ойлголтыг олон нийтэд таниулж, хүний эрхийн боловсролын үйл ажиллагаа явуулж, хүний эрхийн талаар сурталчилна гэж заасан. Хүний эрхийн үндэсний комисс нь 11 комиссараас бүрдэх ба Комиссаруудын 4 нь Үндэсний Ассамблейн гишүүн байх ба 4-ийг нь БНСУ-ын Ерөнхийлөгч томилж, 3-ыг нь Дээд шүүхийн ерөнхий шүүгчийн санал болгосноор БНСУ-ын Ерөнхийлөгч баталдаг. Комиссарын бүрэн эрхийн хугацаа 3 жил байх бөгөөд нэг удаа дахин сонгогдох боломжтой. Гишүүд хүйсийн тэнцвэртэй байдлыг хадгалж нэг хүйсийн гишүүд 60 хувиас хэтрэхгүй байх ёстой. Хүний эрхийн үндэсний комиссын даргыг Үндэсний Ассамблейгаар хэлэлцэж Ерөнхийлөгч баталдаг байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**Парламентын боловсролын хөтөлбөрт хүний эрхийн боловсролыг багтаасан эсэх**

БНСУ-ын Үндэсний Ассамблейн Тамгын газрын харьяанд байдаг Сургалтын Институт нь хууль, эрх зүйн сургалтыг явуулдаг ба тус институт нь төрийн албан хаагчид болон орон

[179] https://www.humanrights.go.kr/site/program/board/basicboard/view?currentpage=4&menuid=002002001&pagesize=10&searchcategory=education&boardtypeid=7003&boardid=7400732

[180] https://www.humanrights.go.kr/site/program/board/basicboard/view?menuid=002003003001&pagesize=10&boardtypeid=7017&boardid=7607209

нутгийн зөвлөл, иргэдийн зөвлөлд эрх зүйн боловсрол олгох сургалт явуулдаг байна. Тус институт нь Үндэсний Ассамблейн Тамгын газрын Захиргааны асуудал хариуцсан нарийн бичгийн даргын удирдлагад ажилладаг.[181]

Үндэсний Ассамблейн сургалтын хэлтсээс зохион байгуулдаг цахим сургалтын хөтөлбөр дараах ерөнхий агуулгатай байдаг.[182]

- Мэргэшүүлэх боловсрол;
- Хууль тогтоомжийн тухай хууль, төсвийн төсөл батлах үйл явцын тухай ойлголт, үндсэн хууль, захиргааны эрх зүй гэх мэт сургалтууд;
- Мэдээлэл зүйн боловсрол;
- Бусад (хувь хүний хөгжлийн чадвар эзэмшүүлэх сургалтууд);
- Хууль, эрх зүйн заавал эзэмших боловсрол;
- **Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хөгжлийн бэрхшээлээр ялгаварлан гадуурхахаас сэргийлэх сургалт**.[183]

Үүнээс хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хөгжлийн бэрхшээлээр ялгаварлан гадуурхахаас сэргийлэх сэдвүүд нь хүний эрхийн боловсролын ойлголтод хамаарна.

Үндэсний Ассамблейн Сургалтын Институт нь өөрийн бие даасан цахим хуудастай ба төрийн албан хаагчид, холбогдох байгууллагын ажилчид болон энгийн иргэд хөтөлбөрийн дагуу цахимаар бүртгүүлэн хамрагдах боломжтой байдаг.

Солонгосын Хүний эрхийн үндэсний комисс нь хүний эрхийн тухай олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх хүний эрхийн боловсрол, сургалт зохион байгуулах дараах чиглэлийн үйл ажиллагаа явуулах ба Үндэсний ассамблейн гишүүдийг үүнд татан оролцуулж болдог:[184]

- Бага, дунд, их сургууль болон бусад боловсролын хөтөлбөрт хүний эрхийн зарчмуудыг нэгтгэн хэрэгжүүлэх талаар санаачлан ажиллах;
- Төрийн албаны шалгалт зэрэг сонгон шалгаруулалт, үнэлгээнд хүний эрхийг чухал шалгуур болгох талаар үйл ажиллагаа санаачлан хэрэгжүүлэх;
- Соёлын бүтээл, ном хэвлэлээр дамжуулан нийгэмд хүний эрхийн соёл бүрдүүлэх;
- Хүний эрхийн тухай мэдээллээр хангах хүний эрхийн номын сан ажиллуулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлдэг.

Комисс мөн дараах үйл ажиллагааг санал болгодог. Үүнд:

- Прокурор, хорих байгууллага, цагдаагийн албан хаагчдад хүний эрхийн боловсрол олгох;
- Хүний эрхийн судалгааны сургууль, төвийг ажиллуулах;
- Хүний эрхийн боловсролын төвийг ажиллуулах;
- Хүний эрхийн тухай кино, хүүхэлдэйн киног боловсруулах, түгээх зэрэг болно.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[181] Парламентын боловсрол олгож буй гадаадын зарим орны туршлага СТ-20/204
[182] https://training.assembly.go.kr:448/ecms/view/defHtmlContentsView.do
[183] https://training.assembly.go.kr:448/ecms/view/defHtmlContentsView.do
[184] Хүний эрхийн үндэсний байгууллагуудын гарын авлага. Asia Pacific Forum. 2013 https://apf-prod.s3.amazonaws.com/media/resource_file/Human_Rights_Education_Manual_for_NHRIs_Mongolian.pdf?AWSAccessKeyId=AKIA57J6V557ISASX34R&Signature=5MOva2zqjVoTKdzOSmz5jbXldVk%3D&Expires=1633403469

***Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрөөр дамжуулан хүний эрхийн боловсрол олгож буй туршлага***

Тус улсын Боловсролын Яам, Хүний эрхийн үндэсний комисс, Сургуулийн хөтөлбөр ба үнэлгээний хүрээлэн болон бусад төрийн бус байгууллагуудын зүгээс хамтран хүний эрхийн боловсролыг ерөнхий боловсролын сургуулиудад зохион байгуулдаг.[185]

Хүний эрхийн боловсролын талаарх ойлголтыг 3-6-р ангиас эхлэн өгдөг ба хүний амь, амьдралыг хүндэтгэх, эцэг эх, ахмад настнаа хүндэтгэх, шударга ёс, ардчилал, энх тайван, халамж, хариуцлага гэх мэт сэдвүүдийн хүрээнд заадаг. Мөн шинэчилсэн сургалтын хөтөлбөрт санал өгөх эрх, хүрээлэн буй орчныг хамгаалж, экологийн тэнцвэртэй орчинд амьдрах эрх, ардчилал, олон нийтийн ажилд оролцох эрх чөлөө, иргэний үүрэг зэрэг ойлголтыг багтаасан байна.

Ёс суртахууны боловсролыг 7-10-р ангид ордог. Үүнд хүний эрхийн талаарх дараах сэдвүүдийг тусгасан байдаг. Үүнд хувь хүний онцлогийг хүндэтгэх, аз жаргалтай байх эрх, хувь хүний хөгжил, эцэг эхээ хүндэтгэх, гэр бүл, ах дүүсээ хайрлах, нийгмийн хариуцлага, шударга байдал, тэгш байдал, ардчилал, хувь хүний үзэл, либерализм, сайн дурын ажил олон нийтийн ашиг сонирхол, нийгмийн үүрэг гэх мэт орно. Гэхдээ ёс суртахууны боловсрол нь хүний нэр төр, өмчлөл гэх мэт хүний эрхийн ойлголтыг системтэйгээр хөгжүүлдэггүй дутагдалтай талтай байна. Ёс суртахууны боловсрол нь Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Хүүхдийн эрхийн тухай олон улсын конвенц, Хүний эрхийн олон улсын хуулийн төслийг шууд заадаггүй ч эдгээр баримт бичгүүд дээр суурилан үндэсний сургалтын хөтөлбөрт оруулахыг зорьдог.

## 3. АВСТРАЛИ

Австрали Улс нь НҮБ-ыг үүсгэн байгуулагч гишүүн орон бөгөөд 1945 онд НҮБ-ын дүрмийг хэлэлцэхэд чухал үүрэг гүйцэтгэж, мөн Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг боловсруулахад оролцсон 8 улсын нэг нь билээ. 1948 онд Австрали Улсаас НҮБ-д суугаа төлөөлөгчдийн тэргүүн доктор Х.В.Эватт Ерөнхий Ассамблейн Ерөнхийлөгч болж уг тунхаглалыг батлах ажлыг удирдан ажиллаж байсан юм. Австрали Улс нь хүний эрхийн олон улсын гол баримт бичгүүдийн ихэнхийг соёрхон баталсан. Хүний эрхийн үндсэн долоон гэрээ болох Иргэний болон улс төрийн эрх, Эдийн засаг, нийгэм соёлын эрх, хүүхдийн эрх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц болон эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц, арьс өнгөөр ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц, эрүүдэн шүүхийн эсрэг конвенцэд нэгдэн орсон.

**Хүний эрхийн боловсрол олгоход парламентын оролцоо**

Австрали Улсын Засгийн газар нь хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөрт нийцүүлэн бага, дунд, ахлах болон их дээд, мэргэжлийн сургуулийн сургалтын хөтөлбөр буюу албан боловсролын хөтөлбөрийг боловсруулан баталдаг. Парламент нь бүх шатны боловсролын хууль тогтоомжийг батлахдаа хүний эрхийн боловсролын эрх зүйн орчныг бүрдүүлэх, хяналт тавих чиг үүрэгтэй.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[185] https://www.hurights.or.jp/archives/human_rights_education_in_asian_schools/section2/2000/03/korea-improving-human-rights-education-in-schools.html

***1. Парламентын Хүний эрхийн хамтарсан хороо*** (Parliamentary Joint Committee on Human Rights)[186]

2011 онд Хүний эрхийн тухай хуулийн дагуу Парламентын Хүний эрхийн хамтарсан хороог байгуулсан бөгөөд хорооны үндсэн чиг үүрэг нь тус улсын хуулийн төсөл, хууль тогтоомж нь нэгдэж орсон хүний эрхийн үндсэн 7 гэрээнд нийцэж байгаа эсэхийг судалж, тайлан дүгнэлтээ Парламентын хоёр танхимд танилцуулдаг. Хорооны тайлан дүгнэлтийг хорооны цахим хуудсанд нийтэлдэг.

***2. Парламентын боловсролын газар*** (Parliamentary Education Office)[187]

Парламентын боловсролын газар нь Сенатын танхимын Клеркийн удирдлагад харьяалагдах бөгөөд Парламентын боловсрол олгох чиг үүрэгтэй байгууллага юм. Боловсролын газар нь бүх насныханд зориулсан PEO[188] хөтөлбөр төлөвлөгөөтэй сургалт зохион байгуулдаг. Хөтөлбөрийн агуулга нь:

- Ардчилал
- Хууль тогтоомжийн талаарх мэдлэг олгох
- Парламентын чиг үүрэг
- Засгийн газрын чиг үүргийн талаар мэдлэг олгоно.

Сургуулийн Мини Парламентын хөтөлбөрийн (School Parliament)[189] хүрээн дэх сургалтыг иргэний боловсролын мэргэжлийн багш нар, Парламентын хуралдаан зохион байгуулах хэлтсийн ажилчид зохион байгуулдаг. Сургалтын үйл ажиллагааг:

- Сургуулийн орчинд мини Парламент зохион байгуулах;
- Парламентын ордонтой танилцах аялал;
- Цахим хэлэлцүүлэг хийх;
- Парламентын боловсролын цахим хичээлд хамрагдах;
- Ангийн хэлэлцүүлэг хийх;
- Иргэний боловсрол, иргэний сургалтыг зохион байгуулах хэлбэрээр сургалтыг олгодог байна. Энэхүү сургалтыг олгосноор үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эвлэлдэн нэгдэх, шашин шүтэх, эс шүтэх, эрх тэгш байдал болон сонгох сонгогдох эрх зэрэг хүний эрх, эрх чөлөөний талаар давхар хүний эрхийн боловсролыг олгодог байна.

***3. Хүний эрхийн комисс*** (Australian Human Rights Commission)[190]

Австралийн Холбооны Парламент нь 1986 онд Хүний эрхийн комиссын тухай хууль (Australian Human Rights Commission Act 1986)[191]-ийн дагуу тус улсын Хүний эрхийн комиссыг байгуулсан юм. Комисс нь хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагааг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэгтэй бөгөөд тус комиссын хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагааны талаарх тайланг үндэслэн Парламент тухайн асуудлаар хууль тогтоомжийг сайжруулах замаар хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагаанд оролцдог. Хүний эрхийн комисс нь албан бус боловсрол олгох чиг үүргийг

---

[186] Parliamentary Joint Committee on Human Rights https://www.aph.gov.au/Parliamentary_Business/Committees/Joint/Human_Rights
[187] Parliamentary Education Office https://peo.gov.au/
[188] PEO- Parliament Education Office
[189] School Parliament https://www.parliament.act.gov.au/visit-and-learn/resources/general/school-parliament#Assembly%20education%20and%20engagement%20program
[190] Australian Human Rights Commission https://humanrights.gov.au/about
[191] Australian Human Rights Commission Act 1986 https://compliance.une.edu.au/directory/summary.php?legislation=633

хэрэгжүүлж, албан боловсролын хүрээнд хүний эрхийн боловсрол олгож буй Засгийн газрын ажилд хөндлөнгийн хяналт тавьдаг. Хүний эрхийн комисс нь хүний эрхийн талаарх боловсролыг олгохдоо:

*Сургуулийн өмнөх боловсролд хүний эрхийн боловсрол*-Австралийн хүүхдийн байгууллага (Early Childhood Australia) тай хамтран бага насны хүүхдийн эрхийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд цахим ном, хөдөлгөөнт дүрсжүүлсэн дуу, зурагт хуудас, сурган хүмүүжүүлэгчийн гарын авлага зэргээр ханган ажилладаг.

*Ажил олгогчдод*-Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх: Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ажлын чадавхыг бэхжүүлэх хөтөлбөр боловсруулан сургагч багшийн гарын авлага, суралцагсдын гарын авлагаар ханган ажилладаг.

***4.Хүний эрхийн боловсролын зөвлөл*** *[192] (Australian Council for Human Rights education)[193]* нь хүний эрхийн боловсролыг түгээхээр багш, эрдэмтэн, судлаачид, олон нийтийн гишүүдээс бүрдсэн бие даасан байгууллага юм. Зөвлөл нь Холбооны болон мужийн Засгийн газар, тэдгээрийн боловсролын асуудал хариуцсан газар, хэлтэс, хүний эрхийн үндэсний комисс, хороодтой хүний эрхийн боловсролын тодорхой хөтөлбөрийг сурталчлах чиглэлээр хамтран ажилладаг.

**Хүний эрхийн боловсрол олгох хөтөлбөрүүд**[194]

Австрали Улс нь дотооддоо Хүний эрхийн боловсролын талаарх үндэсний хөтөлбөрийг батлаагүй бөгөөд дэлхийн хөтөлбөрийг шууд эх сурвалж болгон хэрэгжүүлж байна. Харин Засгийн газар нь албан боловсролын хүрээнд сургалтын хөтөлбөр боловсруулахдаа Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөрт нийцүүлэн баталдаг ажээ.

**1. Дунд сургууль дахь хүний эрхийн боловсрол**

Бага, дунд сургуулийн хичээлийн хөтөлбөрт бусдыг хүндэтгэх, гэр бүлийн хүчирхийллийн талаарх ойлголт мэдлэг олгох хичээлийг оруулж, хүн хүнээ хайрлах, хүндэтгэх, хүйсийн эрх тэгш байдлын талаар зааж сургахаас гадна багш нараасаа үлгэр дуурайл авах, гэр бүлийн харилцаа, оролцоог сайжруулах замаар ирээдүйд гарч болох гэр бүлийн хүчирхийллээс сэргийлэхийг зорьж байна. Засгийн газар нь энэ хөтөлбөрөө Үндэсний хүүхдийн комиссар (National Children’s Commissioners) [195] -тай хамтран хэрэгжүүлдэг. Ахлах сургуулийн сурагчдад газар зүй, түүх, нийгэм, англи хэл, иргэний боловсрол, эрх зүй судлал, хүмүүнлэгийн ухааны хичээлийн хөтөлбөрөөр дамжуулан хүний эрхийн боловсрол олгодог байна.

**2. Дээд сургууль дахь хүний эрхийн боловсрол**

Австралийн үнэт зүйл болох оюутнуудад хүний эрхийн талаар мэдлэг олгох, бусдын эрхийг хүндлэх, нийгмийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, хүмүүсийн эрхийг хүндэтгэх, өөрсдийн зан төлөв, хандлагыг өөрчлөх, хүний бүх эрхийн талаар цогц боловсрол олгох тал дээр маш их анхаардаг. Хичээлийн хөтөлбөрт тусгахаас гадна эерэг үйл ажиллагааны стратеги боловсруулах, эмзэг бүлгийн хүмүүсийг дэмжих, орон нутгийн оюутнуудад тэтгэлэг олгох, элсэлтийн тусгай шалгалт авах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн суралцах орчин нөхцөлийг бүрдүүлэх гэх мэт бусад үйл ажиллагаагаар ч хүний

[192] *Australian Counsil for Human Rights education* https://humanrights.gov.au/
[193] Australian Counsil for Human Rights education https://humanrightseducationaustralia.com/about-achre/
[194] Human rights education and training https://humanrights.gov.au/our-work/education/human-rights-education-and-training
[195] National Children’s Commissioners https://www.dss.gov.au/our-responsibilities/families-and-children/publications-articles/national-children-s-commissioner

UIH.MN СУДАЛГААНЫ САН

эрхийн боловсрол олгоход анхаарч ажилладаг. Мөн их дээд сургуулийн багш нарын дунд эрх тэгш байдлыг хангах зорилгоор эмэгтэйчүүдийн ажиллах нөхцөлийг бүрдүүлдэг. Хүний эрхийн судалгаа, сургалтын хувьд хууль зүйн сургуулиуд нь хүний эрхийн боловсролын төвүүдтэй байдаг. Зарим нь хүний эрхийн боловсролын хичээлийг хүмүүнлэгийн ухааны хичээлийн нэг хэсэг болгон заадаг. Жишээ нь: Куртин их сургуулийн Хүний эрхийн боловсролын төв[196], эсхүл Сиднейн их сургуулийн Энхтайван, зөрчилдөөн судлалын төв гэх мэт болно.

**3. Төрийн албан хаагчдын хүний эрхийн боловсрол**

Австралийн Төрийн албаны зөвлөл (Australian Public Service Commission)[197] нь жилд 3 удаа уулзалт, семинар зохион байгуулж, төрийн албан хаагчдад хүний эрхийн албан болон албан бус боловсрол олгох үйл ажиллагааг Хүний эрхийн Үндэсний Комисс болон Хүний эрхийн боловсролын Үндэсний хороотой хамтран хэрэгжүүлдэг бөгөөд үүнийг Засгийн газар санхүүжүүлдэг.

**4. Мэргэжлийн боловсрол, сургалтын салбарт хүний эрхийн боловсрол олгох**

Австрали Улсын хэмжээнд Техникийн болон нэмэлт боловсрол (Technical and Further Education) олгох сургалтаар дамжуулан хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагааг зохион байгуулдаг.

**5. Бизнес эрхлэгчдийн хүний эрхийн боловсрол**

Бизнес эрхлэгчид болон ажил олгогчдод ажлын байрны олон талт байдлыг дэмжих, ялгаварлан гадуурхалтын эсрэг хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхэд туслах зорилготой онлайн төв ажиллуулдаг.
Онлайн төвийн чиг үүрэг:

- Ажлын байран дахь ялгаварлан гадуурхлаас сэргийлэхийн тулд туршлага солилцох, холбогдох хууль тогтоомжийг сурталчлах;
- Аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хүний эрхийн баримт бичгийг мөрдүүлэх;
- Жендэрийн тэгш байдлыг хангах, хөгжлийн бэрхшээлтэй, ахмад настай хүмүүсийг ажилд авах, ажлын байраар хангах, ажлын байрны соёлыг түгээх тал дээр хяналт тавин зөвлөгөө, дэмжлэг үзүүлдэг.

Хүний эрхийн үндэсний комиссын хяналт, удирдлаган дор хүний эрхийн боловсрол олгох онлайн төвийн үйл ажиллагаа явагдддаг.

***6. Хүний эрхийн боловсрол олгох төрийн бус байгууллагууд***

Хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд нь хүний эрхийн боловсрол олгох сайн хөтөлбөрүүдтэй байдаг. Жишээ нь: Орогнол хүсэгчдийн бүртгэлийн төв болон цагаачдын байгууллагууд, хуулийн нийгэмлэгүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн, хүйсийн болон бэлгийн өөр чиг баримжаатай хүмүүсийн эрхийг хамгаалсан, аливаа ялгаварлан гадуурхалттай тэмцсэн зэрэг төрийн бус байгуулагууд, мөн ажлын нөхцөл байдалд хяналт тавих үйлдвэрчний эвлэл нь өөр өөрсдийн үйл ажиллагааны хамрах хүрээ, зорилтот бүлэгтээ хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагааг тогтмол явуулдаг байна.

[196] Human Rights Education in Western Australia https://humanrightseducationaustralia.com/across-the-country-western-australia/
[197] Australian Public Service Commission https://www.apsc.gov.au/

UIH.MN СЭШИЙН АНХЫСАН

**Дэлхийн хүний эрхийн боловсролын хөтөлбөрийн Дөрөвдүгээр үе шатны хүрээнд Австрали Улсын авч хэрэгжүүлэх арга хэмжээ:**[198]

Тогтвортой хөгжлийн зорилтын 8.7 зорилтын хүрээнд Австралийн Хүний эрхийн комисс нь дэлхийн нийтийн анхааралд байгаа орчин үеийн боолчлолд анхаарлаа хандуулж ялангуяа хөдөө аж ахуй, барилга, үйлдвэр, бизнесийн салбар болон хувийн ажил олгогч нарын дунд хөдөлмөрийн боолчлол их байгаад хүний эрх зөрчигдөж байгаа явдлыг таслан зогсоохыг зөвлөж байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

[198] Australian human rights commission submission to office of the high commissioner for human rights (ohchr) https://www.ohchr.org/documents/issues/education/training/fourthphase/targetsectorsnhris/australian_human_rights_commission.pdf

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ


Австрали

- Australian Human Rights Commission Act 1986 https://compliance.une.edu.au/directory/summary.php?legislation=633
- Human rights education and training https://humanrights.gov.au/our-work/education/human-rights-education-and-training
- National Children’s Commissioners https://www.dss.gov.au/our-responsibilities/families-and-children/publications-articles/national-children-s-commissioner
- Human Rights Education in Western Australia https://humanrightseducationaustralia.com/across-the-country-western-australia/
- Australian Public Service Commission https://www.apsc.gov.au/
- Australian Counsil for Human Rights education https://humanrightseducationaustralia.com/about-achre/

БНСУ

- National Human Rights Commision of Korea https://www.humanrights.go.kr/site/main/index002
- Cyber Human Rights Education https://www.humanrights.go.kr/site/program/board/basicboard/view?currentpage=4&menuid=002002001&pagesize=10&searchcategory=education&boardtypeid=7003&boardid=7400732
- NHRCK Annual Report 2020 https://www.humanrights.go.kr/site/program/board/basicboard/view?menuid=002003003001&pagesize=10&boardtypeid=7017&boardid=7607209
- Training at assembly https://training.assembly.go.kr:448/ecms/view/defHtmlContentsView.do

Их Британи

- Equality and Human Rights Commission https://www.equalityhumanrights.com/en
- House of Commons, House of Lords, Joint Committee on Human Rights. Enforcing human rights. Tenth Report of Session 2017–19. https://publications.parliament.uk/pa/jt201719/jtselect/jtrights/669/669.pdf
- The British Institute of Human Rights. https://www.bihr.org.uk
- Equality and Human Rights Commission https://www.equalityhumanrights.com/en/equality-act/know-your-rights
- Joint Committee on Human Rights https://committees.parliament.uk/committee/93/human-rights-joint-committee/role/
- The parliamentary committee as promoter of human rights: The UK’s Joint Committee on Human Rights. Commonwealth Human Rights Initiative 2007. https://www.humanrightsinitiative.org/publications/hradvocacy/parliamentary_committee_as_promoter_of_hr.pdf

Бусад

- СТ-21/411 Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон хүний эрх ба хүний эрхийн боловсрол
- СТ-20/204Парламентын боловсрол олгож буй гадаадын зарим орны туршлага
- Хүний эрхийн боловсрол: Хүний эрхийн байгууллагуудын гарын авлага, 2013 он
- Parliaments and human rights


UIH.MN СУДАЛГААНЫ САН

# ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЁС ЗҮЙН КОДЕКС БА СУРГУУЛИЙН ОРЧИН ДАХЬ ХҮЧИРХИЙЛЭЛ, ДЭЭРЭЛХЭЛТИЙН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААРХ БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА

*Ц.Норовдондог (Ph.D), Д.Аюуш,*
*Д.Амаржаргал (Ph.D), Б.Батцэцэг,*
*О.Нарантуяа, Д.Жигваагүнсэл Р.Оргилмаа*

**ГАРЧИГ**

УДИРТГАЛ

ХУРААНГУЙ

БҮЛЭГ I. СУРГУУЛИЙН ОРЧИН ДАХЬ ХҮЧИРХИЙЛЭЛ, ДЭЭРЭЛХЭЛТИЙН ЭСРЭГ ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГУУДААС БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО, НИЙТЛЭГ ЗӨВЛӨМЖ

1.1 ДЭЛХИЙН НИЙТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

1.2 БУСАД ОРНЫ СУРГУУЛИЙН ОРЧИН ДАХЬ ХҮЧИРХИЙЛЭЛ, ДЭЭРЭЛХЭЛТИЙН ЭСРЭГ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

БҮЛЭГ II. СУРГУУЛИЙН ОРЧИН ДАХЬ ХҮҮХЭД ХАМГААЛАЛ, ЁС ЗҮЙН ЗӨРЧЛИЙН ЭСРЭГ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААРХ БУСАД ОРНУУДЫН ПРАКТИК ТУРШЛАГА

2.1 ХҮҮХДИЙГ ДЭЭРЭЛХЭЛТЭЭС ХАМГААЛАХ ТУХАЙ НҮБ-ЫН ЕРӨНХИЙ АССАМБЛЕЙН ЗӨВЛӨМЖ

2.2 БУСАД ОРНУУДЫН СУРГУУЛИЙН ОРЧИН ДАХЬ ХҮЧИРХИЙЛЭЛ, ДЭЭРЭЛХЭЛТИЙН ЭСРЭГ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ПРАКТИК ТУРШЛАГА

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

## УДИРТГАЛ

Судалгааны захиалгын дагуу "Ерөнхий боловсролын сургуулийн ёс зүйн кодекс ба сургуулийн орчин дахь хүчирхийлэл, дээрэлхэлтийн эсрэг хариу арга хэмжээний талаарх бусад орнуудын туршлага" сэдэвт судалгааны ажлыг Парламентын судалгааны хүрээлэнгийн Нийгмийн судалгааны сектор гүйцэтгэв.

***Судалгааны зорилго:*** ЕБС-ийн ёс зүйн кодекс болон сургуулийн орчин дахь хүчирхийлэл, дээрэлхэлтийн эсрэг эрх зүйн орчин, бусад орнуудын практик туршлагыг харьцуулан судлах.

***Судалгааны хүрээ:*** Судалгаанд дэлхийн бусад орны сургуулийн орчны хүчирхийлэл, дээрэлхэлтийн байдал, олон улсад баримталж буй бодлого, эрх зүйн зохицуулалтын зөвлөмж болон олон улсын сургалтын чанарын үнэлгээний PISA байгууллагын үнэлгээгээр эхний байранд ордог БНСУ, Япон, Сингапур, Финланд Улс, Тайванийн ЕБС-ийн ёс зүйн кодекс болон үе тэнгийнхний дээрэлхэлтийн эсрэг эрх зүйн орчин, хэрэгжүүлж буй арга хэмжээний практик туршлагыг харьцуулан судлав.

***Судалгааны бүтэц:*** Судалгааны мэдээллийг дараах 2 бүлэг асуудлын хүрээнд боловсруулсан:

- Бүлэг I. Сургуулийн орчин дахь хүчирхийлэл, дээрэлхэлтийн эсрэг олон улсын байгууллагуудаас баримталж буй бодлого, нийтлэг зөвлөмж
- Бүлэг II. Сургуулийн орчин дахь хүүхдийн хүчирхийлэл дээрэлхэлт болон ЕБС-ийн ёс зүйн асуудлыг зохицуулж буй хууль, эрх зүйн орчин, холбогдох дүрэм журмын талаарх бусад орнуудын туршлага
- Бүлэг II. Сургуулийн орчин дахь хүүхэд хамгаалал, ёс зүйн зөрчлийн эсрэг хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх бусад орнуудын практик туршлага

## СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

2019 оны 11 дүгээр сард хуралдсан ЮНЕСКО-ийн 40 дүгээр чуулганаар жил бүрийн 11 дүгээр сарын 05-ны өдрийг "Сургуулийн орчин дахь хүчирхийлэл, дээрэлхэлт, цахим дарамтыг устгах олон улсын өдөр" болгон тэмдэглэхээр шийдвэрлэсэн юм. Энэ хүрээнд олон сая хүүхэд, залуусын сурч боловсрох суурь эрхэд сөрөг нөлөө үзүүлж буй сургуулийн орчин дахь хүчирхийлэл, дээрэлхэлт, үе тэнгийнхний дарамт шахалт, цахим дарамтанд дэлхий нийтээрээ анхаарал хандуулж, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлээр үйл ажиллагаагаа эрчимжүүлж эхлээд байна.

Дэлхий дахинаа жил бүр 246 сая сурагч сургуулийн орчинд дээрэлхүүлснээс үүдэн сурлагын амжилт нь буурч, сургууль завсардаж, мөн бие махбодын болон сэтгэл санааны хохирол амсаж байна. Түүнчлэн, КОВИД-19 цар тахлын үеэр сургуулийг түр хаах арга хэмжээ авсны улмаас зохистой бүтэц, хяналт байхгүй нөхцөлд хүүхэд, залуусын цахим хэрэглээ эрс нэмэгдсэн нь цахим дарамтад өртөх эрсдлийг нэмэгдүүлжээ.

Үе тэнгийнхний дээрэлхэлт нь далд хэлбэрээр, давтагдан даамжирч улмаар хүүхдийг амиа хорлоход хүргэдэг учраас хүүхэд, эцэг эхчүүд, багш нар болон олон нийтийн оролцоо, хамтын ажиллагаа маш чухал гэж үздэг. Хүчирхийлэл бол хувь хүний төрөлхийн шинж чанар гэхээс илүүтэй гэр бүл, найз нөхөд, сургуулийн орчин, нийгмийн

UIH.MN СУДАЛГААНЫ САН

хүчин зүйлсийн нөлөөгөөр бий болж төлөвшдөг хандлага, зан үйл юм. Хэвшмэл зан үйлийг өөрчилж болох ба сөрөг зан үйлийг ч мөн хэвшихээс урьдчилан сэргийлэх боломжтои. Хүчирхийлэл үйлдэхэд нөлөөлдөг хүчин зүйлсийн эсрэг хэдий чинээ үр нөлөөтэй арга хэмжээ авч хэрэгжүүлнэ төдий чинээ тухайн зан үйлийг өөрчилж, улмаар хүчирхийлэл гарахаас урьдчилан сэргийлж болно. Сургуулийн орчинд гарч буй үе тэнгийнхний хүчирхийлэлд хариу арга хэмжээ авахгүй байгаа нь хүчирхийлэл сургуулийн орчинд төдийгүй цахим орчинд газар авах шалтгаан болж байна.

Олон улсад сургуулийн орчин дахь дээрэлхэлт, хүчирхийллийн асуудлыг Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Хүүхдийн эрхийн конвенц болон олон улсын гэрээ, конвенцын хэрэгжилтийн талаарх улс орнуудын тайланг хэлэлцэж гаргасан зөвлөмжийн хүрээнд зохицуулдаг ба улс орнууд үндэсний хууль тогтоомжийг батлах, сайжруулах, хэрэгжилтийг үр нөлөөтэй хангах арга хэмжээ авч ажиллаж байна.

Түүнчлэн Тогтвортой хөгжлийн зорилго 2030 нь хүүхдийн эсрэг хүчирхийллийг олон талт асуудал болгон авч үзэж, хэд хэдэн зорилго, зорилтын хүрээнд тодорхой амлалтуудыг тусгасан. Тухайлбал, ТХЗ 4-ийн хүрээнд хүний эрхийн талаарх мэдлэг, ур чадварын ач холбогдлыг онцлон тэмдэглэж, энх тайван, хүчирхийлэлгүй соёлыг сурталчлах (зорилт 4.7);түүнчлэн хүүхэд, хүйс, хөгжлийн бэрхшээлтэй холбоотой эмзэг байгууламж, аюулгүй, хүчирхийлэлгүй, хүртээмжтэй, үр дүнтэй сургалтын орчинг хүн бүрээр хангах (зорилт 4.а); энх тайван, хүртээмжтэй нийгмийг дэмжих тухай SDG 16-ын хүрээнд 2030 он хүртэлх мөрийн хөтөлбөрт хүүхдийн хүчирхийлэл, мөлжлөг, хүний наймаа болон бүх төрлийн хүчирхийлэл, эрүү шүүлтийг таслан зогсоох (зорилт 16.2) гэх мэт тодорхой зорилтууд тусгагдсан.

Судалгаанд хамрагдсан орнуудын туршлагаас үзэхэд, сургуулийн орчин дахь дээрэлхэлт, хүчирхийллийн асуудлыг тусгай хуулиар, эсхүл ерөнхий болон бусад хууль тогтоомжийн хүрээнд зохицуулж байна. Ерөнхий боловсролын сургуулийн ёс зүйн кодекс буюу загвар дүрмийн тухайд нийтээр дагаж мөрдөх стандарт дүрэм байхгүй байгаа бөгөөд улс орон бүр олон улсын байгууллагуудаас гаргасан зөвлөмж,бусад орнуудын сайн туршлага болон өөрийн орны нөхцөл байдалдаа тохируулан эрх зүйн орчин, тогтолцоогоо бүрдүүлж байна. ЕБС-д ёс зүйн асуудлаа ихэвчлэн сургуулийн дүрмээр зохицуулж байгаа бөгөөд сургуулийн орчин дахь хүчирхийлэл, дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх, хамгаалах чиглэлээр тусгайлсан цогц хөтөлбөр хэрэгжүүлж байгаа нь судалгаанаас харагдаж байна. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд сургуулийн орчин дахь дээрэлхэлт болон хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох, хор хохирлыг арилгах, хариуцлага хүлээлгэх, хүүхэд хамгаалах арга хэмжээний тогтолцоо, зохион байгуулалтын дэд бүтцийг бий болгоод зогсохгүй багш сурган хүмүүжүүлэгчид, эцэг эх зэрэг холбогдох субъектүүд, нийгмийн гишүүдэд шаардлагатай ур чадварыг эзэмшүүлэх, соён гэгээрүүлэх ажлыг системтэйгээр зохион байгуулж байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Олон улсын туршлагаас үзэхэд, БНСУ, Филиппин, Австри, Швед, Шинэ Зеланд, Австрали, Япон, Финланд зэрэг орнуудад сургуулийн орчин дахь хүүхдийн хүчирхийлэл, дээрэлхэлтийн асуудлыг тусгайлсан хууль, хөтөлбөрийн хүрээнд авч үзэж систем, тогтолцоог бүрдүүлж байгаа бол АНУ, Их британи, Ирланд, Нидерланд, Малави зэрэг орнуудад тусгайлан нэрлэсэн хууль гаргаагүй ч гэлээ сургуулийн орччин дахь дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалтын эсрэг холбогдох эрх зүйн актууд, хүний эрх, тэгш байдлын тухай хууль зэрэг өргөн хүрээтэй хууль тогтоомжоор зохицуулж систем, тогтолцоо, арга хэрэгслүүдээ маш сайн төлөвлөн нутагшуулж байгаа нь харагдаж байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

2017 онд БНСУ-ын Сөүл хотноо болсон сургуулийн хүчирхийлэл болон дээрэлхэлтийн олон улсын симпозиумаар сургуулийн орчин дахь хүчирхийлэл, дээрэлхэлтийн дэлхийн төлөв байдлын тайланг авч хэлэлцээд сургуулийн орчин дахь хүчирхийлэл, дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээний хүрээнд дараах асуудлыг бодлого, эрх зүйн орчинг бүрдүүлэхдээ харгалзан үзэхийг зөвлөсөн байна. Үүнд:

- **Манлайлал:** Сургуулийн орчин дахь хүүхэд, өсвөр үеийнхнийг хүчирхийлэл, дээрэлхэлтээс хамгаалсан үндэсний хууль тогтоомж, бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх, сургуулийн хүчирхийлэл, дээрэлхэлтийн асуудлыг шийдвэрлэх хангалттай нөөцийг хуваарилах;
- **Сургуулийн орчин:** Аюулгүй, хүртээмжтэй сургалтын орчныг бүрдүүлэх, сургуулийн хүчирхэг менежмент, мөн сургуулийн бодлого, ёс зүйн дүрмийг боловсруулж мөрдүүлэх, тэдгээрийг зөрчсөн ажилтнуудад хариуцлага тооцох;
- **Чадавх:** Багш нар болон бусад ажилтнуудад хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, сургуулийн хүчирхийлэл, дээрэлхэх үйлдлүүдэд хариу арга хэмжээ авах арга барилыг эзэмших мэдлэг, ур чадвар олгох сургалт явуулах, дэмжлэг үзүүлэх; хүүхэд, өсвөр үеийнхний чадварыг хөгжүүлэх, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх мэдлэг, хандлага, ур чадварыг хөгжүүлэх;
- **Хамтын ажиллагаа:** Сургуулийн хүчирхийлэл, дээрэлхэлтийн сөрөг нөлөөллийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх, үндэсний болон орон нутгийн түвшинд бусад салбартай хамтран ажиллах, багш нарын үйлдвэрчний эвлэлтэй хамтран ажиллах, гэр бүл, олон нийттэй ажиллах, хүүхэд, өсвөр үеийнхний идэвхтэй оролцоог дэмжих;
- **Үйлчилгээ ба дэмжлэг:** Хүртээмжтэй, мэдэрмжтэй, хүүхдэд чиглэсэн нууц мэдээлэл өгөх механизмаар хангах, зөвлөгөө дэмжлэг үзүүлэх боломжтой байх, эрүүл мэндийн болон бусад чиглэлийн үйлчилгээ, туслалцаа үзүүлэх;
- **Баталгаа, нотолгоо**: Иж бүрэн мэдээлэл цуглуулах тогтолцоо бүрдүүлэх, ахиц дэвшил, үр нөлөөг хянахын тулд нарийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, хөтөлбөр, интервенцийн дизайнд мэдээлэл, судалгаа хийх.

***Судалгаанд хамрагдсан орнуудын туршлагыг тоймлон танилцуулбал:***

**БНСУ** Олон Улсын сургалтын чанарын үнэлгээний PISA байгууллагын үнэлгээгээр тогтмол дээгүүр байр эзэлдэг буюу ЕБС-ийн сургалтын чанар сайтай улсын нэг боловч сургуулийн орчин дахь дээрэлхэлт, гадуурхалт, хүчирхийллийн нөхцөл байдал нь анхаарал татсаар байгаа юм. Иймд 2005 онд ***“Сургуулийн орчин дахь хүчирхийллийн эсрэг хариу арга хэмжээ авах, түүнээс урьдчилан сэргийлэх тухай хууль”***-ийг батлан гаргажээ.

Энэ хуулийн хүрээнд сургуулийн орчин дахь хүчирхийлэл, дээрэлхэлт, гадуурхалтыг илрүүлэх, шалтгаан нөхцөлийг тогтоох, хохирогч сурагчийг хамгаалах, зөрчил гаргасан сурагчид хариу арга хэмжээ авах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зэрэг цогц ажлыг зохион байгуулах хороо, газар, хэлтсийн чиг үүрэг, уялдаа холбоог тодорхой болгож, үе тэнгийнхний санал асуулгын механизмыг бүрдүүлсэн.

Түүнчлэн, тус улсын ***“Насанд хүрээгүйчүүдийн тухай хууль”***-иар 13 ба түүнээс доош насныханд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй гэж зохицуулсан байдаг бөгөөд сургуулийн орчин дахь хүчирхийллээс урьдчилан сэргийлэх 2020-2024 оны хөтөлбөрийн хүрээнд эрүүгийн хариуцлага хүлээх насны доод хязгаар 14 байсныг 13 болгохоор төлөвлөжээ.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**Япон Улс *“Дээрэлхэлтээс сэргийлэх тухай хууль”-***ийг 2013 онд баталсан ба Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яамнаас дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг дэмжих үндэсний бодлогыг боловсруулж, холбогдох байгууллагуудтай хамтран ажилладаг. Дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх үндэсний бодлого нь дараах цогц арга хэмжээнүүдээс бүрдэнэ:

- Дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний үндсэн чиглэл, авах арга хэмжээ;
- Дээрэлхэлттэй холбоотой ноцтой нөхцөл байдал үүссэн үед үзүүлэх хариу арга хэмжээ;
- Дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой онцлог ойлголт.

Мөн ***Кибер аюулгүй байдлын стратеги ба насанд хүрээгүй хүмүүсийн интернэтийн аюулгүй орчныг бүрдүүлэх тухай*** хуульд олон нийтийн сүлжээгээр хүүхдэд хор хохирол учруулах аливаа үйлдлээс урьдчилан сэргийлэх асуудлыг зохицуулсан байна.

**Финланд Улс** сургуулийн орчин дахь үе тэнгийнхний дээрэлхэлт харьцангүй багатай хэдий ч энэ нь анхаарал татсан асуудал хэвээр байна. ***“Суурь боловсролын тухай хууль”-***иар хүүхэд аюулгүй, таатай орчинд сурч боловсрох эрхтэй бөгөөд үүнд боловсрол олгогч эрх бүхий субъект болох сургууль, орон нутгийн захиргаа хяналт тавьж, төлөвлөгөө гарган ажиллахаар зохицуулсан байна. Гэвч дээрэлхэлтийн асуудлыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэхэд энэхүү хууль эрх зүйн зохицуулалт нь төдийлөн хангалтгүй бөгөөд сургууль, эцэг, эх, багш, сурагчдын зүгээс дээрэлхэлтийн талаарх мэдлэг, харилцаа, хандлага, түүнд тавих хяналт, авах арга хэмжээний системтэй, тасралтгүй, цогц үйл ажиллагаа чухал гэж үздэг байна. Тиймээс Боловсролын яамнаас 2006 онд үндэсний хэмжээний ***“Дээрэлхэлтийн эсрэг хөтөлбөр”*** (KiVa) боловсруулах ажлыг эхлүүлж, 2009 оноос албан ёсоор хэрэгжүүлж эхэлсэн нь эдүгээ Финланд Улсад төдийгүй европын бусад улс орнуудад амжилттай хэрэгжиж байна. Энэ нь сургуулийн орчин дахь ёс зүйн нийтлэг хэм хэмжээ, баримтлах дүрэм журмыг тогтоох, ёс зүйн зөрчлийг бууруулахад чухал ач холбогдол, үр дүнтэй хөтөлбөр болжээ.

**Сингапур Улс** сургуулийн орчин дахь хүчирхийлэл, дээрэлхэлтээс хамгаалах асуудлыг зохицуулсан *тусгайлсан хууль байхгүй* байна. Дээрэлхэлтээс үүдсэн хор хохирлын төрөл зүйлээс нь хамааран (тухайлбал, бие махбодын болон сэтгэл санааны гэмтэл учруулсан, эд хөрөнгийн хохирол үзүүлсэн зэрэгт) холбогдох хуулиар зохицуулж байна. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт хүүхдийн хүчирхийллийн эсрэг хичээлийг багтаан, улс орон даяар хүүхдийн хүчирхийллийн эсрэг аянуудыг хэрэгжүүлдэг. Тухайлбал, Сингапурын Хүүхдийн Нийгэмлэг (Singapore Children’s Society)-ээс “***Дээрэлхэлтээс ангид хөтөлбөр***” (Bully-Free programme)-ийг орон даяар хэрэгжүүлдэг ажээ. Түүнчлэн ***“Хүүхэд хамгаалах Үндэсний Стандарт”*** (National Standards for Protection of Children)-ыг боловсруулан, холбогдох байгууллагуудын үүрэг оролцоо, эцэг эх, асран хамгаалагч, багш сурган хүмүүжүүлэгчдийн гүйцэтгэх үүрэг хариуцлагыг тодорхойлсон байна. Боловсролын яамнаас *сургуулийн дүрэм боловсруулахад баримтлах гарын авлагыг боловсруулан, сургуулиудад удирдамж болгодог* бөгөөд тус гарын авлагад сахилга батын жижиг зөрчлөөс авахуулаад том хэмжээний зөрчлүүдийг жагсаасан байдаг байна. Сургууль бүр энэхүү гарын авлага, удирдамжид тулгуурлан, өөрийн сургуулийн онцлогт нийцүүлэн ***“Сургуулийн дүрэм***”-ийг боловсруулах бөгөөд дүрэмд зөрчил, түүний эсрэг хэрэгжүүлэх арга хэмжээ зэргийг багтаасан байна. Хэрэв сурагчийн үйлдсэн зөрчил нь сургуулийн дүрмээс давсан

тохиолдолд холбогдох хуулиар зохицуулна. Дээрэлхэлт, түүнтэй хэрхэн тэмцэх, дээрэлхүүлж буй хүүхдийг олж таних, түүнд туслах зэрэг багш, сурган хүмүүжүүлэгчдийн эзэмшвэл зохих дадлуудыг Боловсролын яамнаас болон тухайн сургуулиас, Сингапурын Хүүхдийн Нийгэмлэгээс зохион байгуулдаг сургалтуудаар багш, сурган хүмүүжүүлэгчдэд тодорхой давтамжтайгаар олгодог байна. Сургуулийн орчин дахь дээрэлхэх зөрчлийг арилгахад эцэг эх, гэр бүлийнхний төдийгүй хамт суралцаж буй сурагч хүүхдүүдийн тусламж дэмжлэг, хамтын ажиллагааг нэн чухалд тооцдог ажээ.

**Тайвань** нь ЕБС-ийн орчин дахь хүүхэд хамгаалал, ёс зүйн зөрчлийн асуудлыг ***“Хүйсийн тэгш боловсролын тухай хууль”*** (Gender Equity Education Act) болон ***“Хүүхэд, залуучуудын эрх ашгийг хамгаалах тухай хууль”*** (The Protection of Children and Youths Welfare and Rights Act)-ийн хүрээнд шийдвэрлэж байна.

Хүйсийн тэгш боловсролын тухай хуульд жендэрийн тэгш байдлыг хангах, жендэрийн ялгаварлан гадуурхалтыг арилгах, хүний нэр төрийг хамгаалах, жендэрийн тэгш байдлыг хангасан боловсролын нөөц, орчныг бүрдүүлэх зорилготой байна.

Хүүхэд, залуучуудын эрх ашгийг хамгаалах тухай хууль хүүхэд өсвөр үеийнхний бие, оюун санааны эрүүл мэндийг дэмжих, тэдний ашиг сонирхлыг хамгаалах, сайн сайхан байдлыг хөгжүүлэх зорилготой байна. Энэ хуульд хүүхэд, залуучууд гэж 12-18 настай, насанд хүрээгүй хүмүүсийг хамааруулж байна. Мөн эцэг эх, асран хамгаалагч нь хүүхэд, залуучуудын хамгаалал, хүмүүжлийн асуудлыг хариуцах ба эрх бүхий байгууллага болон хүүхэд хамгааллын байгууллагууд тус хуульд заасан арга хэмжээг авч ажиллахаар заажээ.

Харин нэгдсэн байдлаар ЕБС-ийн ёс зүйн загвар дүрэм байхгүй бөгөөд сургуулиуд хууль, тогтоомжийн ерөнхий зохицуулалтын хүрээнд ёс зүйн дүрмээ дотооддоо батлан мөрддөг байна.

***Түлхүүр үг:*** *сургуулийн орчин дахь хүчирхийлэл, дээрэлхэлт, цахим дээрэлхэлт, хохирогч сурагч, дээрэлхүү сурагч*

***Keywords:*** *school violence, bullying, cyber-bullying, victim student, aggressor student*

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

## СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

## БҮЛЭГ I. СУРГУУЛИЙН ОРЧИН ДАХЬ ХҮЧИРХИЙЛЭЛ, ДЭЭРЭЛХЭЛТИЙН ЭСРЭГ ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГУУДААС БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО, НИЙТЛЭГ ЗӨВЛӨМЖ

### 1.1 ДЭЛХИЙН НИЙТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Дэлхийн бүх улс оронд хүүхдийн хүчирхийлэл, дээрэлхэлтийн асуудал хурцаар тавигдаж, анхаарал хандуулах шаардлагатай асуудлуудын нэг болж байна.

Сургуулийн хүчирхийлэл, тухайлбал, бие махбодын, сэтгэл зүйн болон бэлгийн хүчирхийлэл, дээрэлхэлт бүх улс оронд тохиолдож байна. Үндсэн шалтгаанууд нь жендэр, нийгмийн хэм хэмжээ, орлогын тэгш бус байдал, гадуурхалт, зөрчил зэрэг өргөн хүрээний бүтцийн болон нөхцөл байдлын хүчин зүйлсээс шалтгаалдаг байна. Жил бүр 246 сая хүүхэд, өсвөр насныхан ямар нэг хэлбэрээр сургуулийн хүчирхийлэлд өртдөг гэсэн тоон мэдээлэл байдаг. Сургуулийн хүчирхийллийн хамгийн түгээмэл хэлбэр нь дээрэлхэлт байдаг байна. Сургуулийн орчин дахь хүчирхийлэл, дээрэлхэлт нь хүүхдийн сурч боловсрох, эрүүл байх эрхийг зөрчдөг бөгөөд энэ нь урт хугацаанд насанд хүрэгчдийн амьдралд нөлөөлдөг.

Сургуулийн хүчирхийлэлд бие махбодын хүчирхийлэл түүний дотор бие махбодын шийтгэл багтдаг. Тухайлбал,

- Сэтгэл зүйн хүчирхийлэл, хэл амаар доромжлох;
- Бэлгийн хүчирхийлэл, хүчиндэх, дарамтлах;
- Дээрэлхэлт, кибер дээрэлхэлт.

Дээрэлхэх нь зан үйлийн шинжтэй бөгөөд хохирогч, дээрэлхэгч хажууд байгаа хүмүүст сөрөг нөлөө үзүүлдэг. Дээрэлхэх гэдэг нь “сургуулийн насны хүүхдүүдийн дундах хүч чадлын тэнцвэргүй байдлыг бодитойгоор илэрхийлсэн хүсээгүй, түрэмгий зан үйл” юм. Энэ зан үйл нь цаг хугацааны явцад давтагддаг, эсхүл давтагдах магадлалтай байдаг. Дээрэлхэх зан үйл нь цохих, өшиглөх, эд хөрөнгийг сүйтгэх зэрэг бие махбодын шинжтэй шоолох, доромжлох, заналхийлэх, цуурхал тараах, бүлгээс гадуурхах зэрэг үг хэллэг болон харилцааны шинжтэй үйлдлүүдээр илэрдэг. Дээрэлхэх, цахим дээрэлхэлт нь хүүхэд, өсвөр үеийнхний санаа зовоосон гол асуудал болж байна.

Сургуулийн хүчирхийлэл, дээрэлхэлтийг бусад сурагчид, багш нар болон сургуулийн ажилтнууд үйлддэг. Үе тэнгийнхний үйлдсэн хүчирхийлэл, боловсролын байгууллага, эсвэл тэдний төлөөлөгчдийн үйлдсэн хүчирхийллийг хооронд нь ялгах нь чухал бөгөөд энэ нь хүчирхийллийн нөлөөлөл болон хариу арга хэмжээнд нөлөөлдөг байна.

Сургуулийн хүчирхийлэл, дээрэлхэлтийн ихэнх нь жендэртэй холбоотой байдаг. Жендэрт суурилсан хүчирхийлэл нь бие махбод, бэлгийн болон сэтгэл зүйн гэмтэл, эсвэл хүйсээр ялгаварлан гадуурхалтад үндэслэн хэн нэгний эсрэг хор хөнөөл (harm) учруулах ба жендэрийн үүргийн хүлээлт, хэвшмэл ойлголт болон хүйстэй холбоотой эрх мэдлийн ялгавартай байдал гардаг байна. Амьдралын түвшин, хэл, соёлын цөөнх, иргэншил, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд зэрэг хамгийн эмзэг бүлгийн хүүхэд, өсвөр насныхан сургуулийн хүчирхийлэл, дээрэлхэлтэд өртөх эрсдэлтэй байдаг байна. Хүйсийн хувьд хүчирхийлэл, дээрэлхэлтэд өртөх байдал адил боловч эзлэх хувь харилцан адилгүй байдаг байна. Тухайлбал, Охид бэлгийн хүчирхийлэлд, хөвгүүд сургуульд байхдаа охидыг бодвол бие махбодын шийтгэлд өртөх магадлал өндөр

UIH.MN ТЭНХИМ ДАНЫ САН

байдаг байна. Доорх зурагнаас эрэгтэй, эмэгтэй сурагчдын дээрэлхэлтэд өртөж буй байдлыг талаар үзнэ үү.




*Эх сурвалж:Behind the numbers: Ending school violence and bullying, 2017*

НҮБ-ын Хүүхдийн сангийн 2016 оны тайланд (U-Report/SRSG-VAC) 18 орны 100.000 залуусын дунд хийсэн судалгаагаар дээрэлхэлтийн шалтгаан хүйсээр (25%), бэлгийн чиг баримжаагаар (25%), үндэс угсаа, үндэсний гарал үүслээр (25%), бусад (25%) гэж ангилсан байна.

Хүчирхийлэл, дээрэлхэлт нь анги дотор болон гадна, сургууль орчимд, сургууль орох болон буцах замд, мөн цахим орчинд гарч болно.



UIH.MN СУДАЛГААНЫ САН

БНСУ-ын Боловсролын яамны 2015 оны тайланд сургуулийн хүчирхийлэл, дээрэлхэлтийн гэмт хэргийн 75.5 хувь нь сургууль дотор, 24 хувь нь сургуулиас гаруур гардаг байна.

АНУ-ын Кибер дээрэлхэлтийн судалгааны төвийн 2012 онд хийсэн судалгаагаар ахлах сургуулийн 20 мянган сурагч, ялангуяа эмзэг бүлгийн сурагчдын дунд сургуулийн дээрэлхэлт болон цахим дээрэлхэлт давхцаж байгааг тогтоосон байна.

Хүчирхийлэл, дээрэлхэлтийн талаар хэнд ч хэлэхгүй байх, мэдээлэхгүй байх шалтгаан нь насанд хүрэгчид, ялангуяа багш нарт итгэх итгэлгүй байх, хариу үйлдэл үзүүлэх, хэлмэгдүүлэхээс эмээх, гэм буруугаа мэдрэх, ичгүүртэй эсхүл эргэлзэх, тэднийг нухацтай авч үзэхгүй байх вий гэсэн санаа зовох, эсхүл хаанаас тусламж хүсэхээ мэдэхгүй байх зэрэг орно. 2016 онд НҮБ-ын U-Report/SRSG-VAC-аас хийсэн санал асуулгаар дээрэлхэлтэд өртсөн хүүхдийн

30% нь насанд хүрсэн хүнд, 30 гаруй хувь нь найз, ах эгчдээ, 10 хүрэхгүй хувь нь багшдаа хэлсэн бол, үлдсэн 30 хувь нь хэнд ч хэлээгүй байна. Тайланд дурдсанаар дээрэлхэлтийн золиос болсон хүүхэд, өсвөр насныхан хариу арга хэмжээ авахаас айсан эсвэл цахимаар дээрэлхсэн тохиолдолд нэр хүндээ алдахаас айдаг учраас эцэг эх, багш нар болон бусад насанд хүрэгчдэд эдгээр тохиолдлын талаар мэдээлэх дургүй байдаг байна.

2017 онд БНСУ-ын Сөүл хотноо болсон сургуулийн хүчирхийлэл болон дээрэлхэлтийн олон улсын симпозиумаар сургуулийн хүчирхийлэл, дээрэлхэлтийн дэлхийн төлөв байдлын тайланг танилцуулсан байна. Тайланд сургуулийн хүчирхийлэл, дээрэлхэлтийн хариу арга хэмжээг боловсролын салбар нь бусад салбар болон бусад оролцогч талуудтай хамтран хүүхэд, залуучуудыг хүчирхийллээс хамгаалах, бүх сурагчдад аюулгүй, хүртээмжтэй суралцах орчныг бүрдүүлэх үүрэгтэй гэжээ. Сургууль бол хүчирхийлэлд хандах хандлагыг өөрчилж, хүчирхийлэлгүй зан төлөвт суралцах боломжтой газар юм. Сургалтын орчин болон боловсролын агуулга нь хүний эрх, жендэрийн тэгш байдал, хүндэтгэл, эв нэгдлийн үнэт зүйлсийн талаарх ойлголтыг бий болгож, харилцаа холбоо тогтоох, хэлэлцээр хийх, асуудлыг тайван замаар шийдвэрлэх чадварыг бий болгож чадна.

Сургуулийн хүчирхийлэл, дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь сургуулийн хүчирхийлэл, дээрэлхэлтийг бууруулахад хувь нэмэр оруулаад зогсохгүй хичээл таслалтыг бууруулах, сурлагын амжилтыг сайжруулах, хүүхдийн нийгмийн ур чадвар, сайн сайхан байдлыг сайжруулахад боловсролын салбарын үр дүнтэй, цогц арга хэмжээг хэрэгжүүлэх нь зүйтэй юм. Энэхүү цогц арга хэмжээнд дараах элементүүдийг багтаасан байна. Үүнд:

- **Манлайлал:** Сургуулийн орчин дахь хүүхэд, өсвөр үеийнхнийг хүчирхийлэл, дээрэлхэлтээс хамгаалсан үндэсний хууль тогтоомж, бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх, сургуулийн хүчирхийлэл, дээрэлхэлтийн асуудлыг шийдвэрлэх хангалттай нөөцийг хуваарилах;
- **Сургуулийн орчин:** Аюулгүй, хүртээмжтэй сургалтын орчныг бүрдүүлэх, сургуулийн хүчирхэг менежмент, мөн сургуулийн бодлого, ёс зүйн дүрмийг боловсруулж мөрдүүлэх, тэдгээрийг зөрчсөн ажилтнуудад хариуцлага тооцох;
- **Чадавх:** Багш нар болон бусад ажилтнуудыг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, сургуулийн хүчирхийлэл, дээрэлхэх үйлдлүүдэд хариу арга хэмжээ авах сургалтын хөтөлбөрийн арга барилыг ашиглах мэдлэг, ур чадварыг

баталгаажуулах сургалт явуулах, дэмжлэг үзүүлэх; хүүхэд, өсвөр үеийнхний чадварыг хөгжүүлэх, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зохих мэдлэг, хандлага, ур чадварыг хөгжүүлэх;

- **Хамтын ажиллагаа:** Сургуулийн хүчирхийлэл, дээрэлхэлтийн сөрөг нөлөөллийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх, үндэсний болон орон нутгийн түвшинд бусад салбартай хамтран ажиллах, багш нарын үйлдвэрчний эвлэлтэй хамтран ажиллах, гэр бүл, олон нийттэй ажиллах, хүүхэд, өсвөр үеийнхний идэвхтэй оролцоо;
- **Үйлчилгээ ба дэмжлэг:** Хүртээмжтэй, хүүхдэд мэдрэмтгий, нууц мэдээлэл өгөх механизмаар хангах, зөвлөгөө дэмжлэг үзүүлэх боломжтой байх, эрүүл мэнд болон бусад үйлчилгээний туслалцаа хүсэх;
- **Баталгаа, нотолгоо**: Иж бүрэн мэдээлэл цуглуулах ажлыг хэрэгжүүлэх, ахиц дэвшил, үр нөлөөг хянахын тулд нарийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, хөтөлбөр, интервенцийн дизайнд мэдээлэл, судалгаа хийх.

Дээрх тайланд дурдсан хүчирхийлэл, дээрэлхэлтээс хамгаалах, урьдчилан сэргийлэх асуудлыг хууль тогтоомжоор хэрхэн зохицуулж байгааг авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

- Тусгай хууль тогтоомжоор зохицуулсан
- Ерөнхий болон бусад хууль тогтоомжоор зохицуулсан байна.

**1.Тусгай хууль тогтоомжоор** гэдэг нь сургуулийн орчин дахь хүчирхийлэл, дээрэлхэлтээс хамгаалсан тусгайлсан хууль тогтоомж батлан хэрэгжүүлж байгааг хэлэх бөгөөд энэ хүрээнд зарим улс орнууд хүчин чармайлт гаргаж байна. Тухайлбал;

***БНСУ-д*** 2005 онд Сургуулийн орчин дахь хүчирхийллийн эсрэг хариу арга хэмжээ авах, түүнээс урьдчилан сэргийлэх тухай хуулийг баталсан. Зорилго нь "Хохирогч сурагчдыг хамгаалах, түрэмгийлэгч сурагчдыг удирдан чиглүүлэх, сургах, хохирогч сурагчид болон түрэмгийлэгч сурагчдын хооронд эвлэрүүлэн зуучлах замаар сурагчийн хүний эрхийг хамгаалах, сурагчдыг нийгэмд зөв хүн болгон төлөвшүүлэх" явдал юм.

***Филиппинд*** Дээрэлхэлтийн эсрэг хууль (Anti-Bullying Act) нь бүх бага, дунд сургуулиас дээрэлхэх гэмт хэргийг шийдвэрлэх бодлого боловсруулж, холбогдох механизм, тайлагнах тогтолцоог бий болгож, зөрчлийн хариуцлагыг тодорхойлсон.

***Австралид*** 2003 онд сургуулийн орчинд дээрэлхэх, хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хандлагыг сурталчлах зорилгоор Үндэсний аюулгүй сургуулиудын ерөнхий бүтэц (the National Safe Schools Framework)-ийг боловсруулсан бөгөөд 2004 онд Сургуульд дэмжлэг үзүүлэх хууль (Schools Assistance Act)-аар хуульчилсан байна.

***Финландад*** Суурь боловсролын хууль (Basic Education Act)-ийн 29 дүгээр зүйлд сурагч бүр сургуулийн аюулгүй орчинд байх эрхтэй гэж заасан байдаг. Энэ хуулийн дагуу боловсролын байгууллагууд сурагчдыг сургууль дээрээ хүчирхийлэл, дээрэлхэлтэд өртөхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй.

***Шведэд*** 2009 онд баталсан Ялгаварлан гадуурхахын эсрэг хууль (Discrimination Act) болон 2010 онд баталсан Боловсролын тухай хууль (Education Act)-аар сургуулиудад ялгаварлан гадуурхах, дээрэлхэлтийн аливаа хэлбэрийг хориглодог бөгөөд Боловсролын хуулийн дагуу сургуулиуд дээрэлхэх гэмт хэргийн бүх тохиолдлыг шалгаж, мэдээлэх, түүнээс урьдчилан сэргийлэх, шийдвэрлэх төлөвлөгөөг жил бүр боловсруулах үүрэгтэй байдаг. Мөн хуульд дээрэлхсэн гэмт хэргийн талаар мэдээлсэн

хүмүүсийг хэлмэгдүүлэхийг хориглож, сургууль дүрэм, журмыг мөрдөөгүй тохиолдолд хохирлыг барагдуулах эрхтэй. Түүнчлэн кибер дээрэлхэлттэй холбоотой асуудлыг онцгойлон хууль тогтоомжоор зохицуулж буй улс орнууд ч байна. Тухайлбал,

***Филиппинд*** Дээрэлхэлтийн эсрэг акт (Anti-Bullying Act)-д кибер дээрэлхэлтийн талаар тусгайлан зохицуулсан. АНУ-ын Калифорниа муж 2011 онд гар утас болон бусад интернэтийн үйлчилгээг ашиглан нийгмийн сүлжээний сайтууд дээр дээрэлхэх талаарх биллийг баталсан. Энэ нь сургуулиудад кибер дээрэлхэлтийг зогсоох боломжийг олгож байна. Австралид 2015 онд кибер хүчирхийлэлтэй тэмцэх Хүүхдийн онлайн аюулгүй байдлыг сайжруулах акт (Enhancing Online Safety for Children Act)-ыг баталсан бөгөөд энэхүү хуулиар гомдол гаргах системийг бий болгож, нийгмийн сүлжээнээс аюултай мэдээллийг устгах зэрэг хүчин чармайлтыг удирдан чиглүүлэх зорилготой Хүүхдийн цахим аюулгүй байдлын комиссарыг байгуулсан.

***Шинэ Зеландад*** 2015 онд Хор хөнөөлтэй дижитал харилцааны акт (Harmful Digital Communications Act)-ыг баталсан бөгөөд энэ нь хор хөнөөлтэй харилцаа холбоог таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, хохирогчид үзүүлэх нөлөөллийг бууруулах, гомдлыг хурдан шийдвэрлэх, онлайн материалыг устгах системийг ий болгох зорилготой.

**2. Ерөнхий хууль тогтоомжоор** гэдэг нь зарим улс оронд тусгайлсан хууль тогтоомж байдаггүй ч сургуулийн дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалтын эсрэг, хүний эрх, тэгш байдлын тухай хууль зэрэг өргөн хүрээтэй холбогдох хуулиар зохицуулж байна. Тухайлбал,

***Их Британид*** 2006 оны Боловсрол ба хяналт шалгалтын акт, 2010 оны сургуулийн бие даасан сургуулийн стандарт журам, 2010 оны Тэгш байдлын акт, 1989 оны Хүүхдийн акт, 1997 оны Хүчирхийллийн акт, 1988 оны Ёс бус харилцааны акт (Malicious Communications Act), 2003 оны Харилцаа холбооны акт болон 1986 оны Нийтийн хэв журмын актуудаар зохицуулдаг. Эдгээр актуудын дагуу сургуулиуд дээрэлхэлтийн эсрэг үр дүнтэй стратеги хэрэгжүүлэх, сурагчдыг дээрэлхэлтээс хамгаалах үүрэг хүлээдэг.

***Ирландад*** Тэгш байдлын акт, Хөдөлмөр эрхлэлтийн тэгш байдлын акт, Хөдөлмөрийн эрүүл, аюулгүй байдал болон халамжийн акт, Боловсрол (нийгмийн халамж)-ын акт, Боловсролын актын дагуу хүүхэд, өсвөр үеийнхнийг дээрэлхэлтээс хамгаалдаг.

***АНУ-ын*** хувьд холбооны түвшинд дээрэлхэлтийн эсрэг хууль байхгүй ч Америкийн сургуулиудыг сайжруулах акт (The Improving America Schools Act), Аюулгүй, мансууруулах бодисгүй сургууль болон олон нийтийн акт (Safe And Drug-Free Schools And Communities Act)-аар ерөнхийд нь зохицуулдаг бөгөөд сургуулийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх, хүүхдийг хамгаалах зорилгоор муж бүр хууль тогтоомж болон боловсролын дүрмийг батлан хэрэгжүүлдэг.

Хүчирхийлэл, дээрэлхэлтэд өртсөн хүүхдийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, дэмжлэг туслалцаа үзүүлэх асуудал ч чухал юм. Үр дүнтэй, хүртээмжтэй, нууцыг хадгалсан, нас, хүйсийн мэдрэмжтэй мэдээлэх механизм, тэднийг цаашид эрсдэлд оруулахгүй арга хэмжээ авах зэрэг нь хохирогч болон түүний хажууд байгаа хүмүүсийн хувьд маш чухал байдаг. Мэдээллийн механизм нь хүүхэд, өсвөр үеийнхэнд зориулсан эх сурвалж болохоос гадна зөвлөгөө, тусламж шаардлагатай хүмүүст чиглүүлэх хүүхэд хамгааллын үндэсний тогтолцооны нэг бүрэлдэхүүн хэсэг байх ёстой. Тухайлбал, тусламжийн утас, чат өрөө болон “аз жаргал, уйтгар гунигийн хайрцаг”, багш зэргээс гадна охидын клуб зэрэг бэлгийн хүчирхийллийн талаар санаа зовниж, мэдээлэх аюулгүй газар болгон ашиглаж байна. Эдгээр механизм нь бүх хүүхэд, өсвөр насныханд хүртээмжтэй байх

UIH.MN СУДАЛГААНЫ САН

ёстой бөгөөд зарим нь сургуулийн хүчирхийлэл, дээрэлхэлтийн талаар мэдээлэхэд тулгарч болох саад бэрхшээлийг харгалзан үзэх ёстой. Зарим сайн туршлагаас дурдвал, Канадын Онтарио мужид сургууль бүр аюулгүй, хүлээн зөвшөөрөгдсөн сургуулийн багтай байх, дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх, хөндлөнгөөс оролцох талаарх үйл ажиллагааны иж бүрэн төлөвлөгөөтэй байхыг шаарддаг. ***Нидерландад*** 18-аас доош насны хүүхдүүдэд зориулсан нэрээ нууцалсан тусламжийн утас байдаг. Мөн вэбсайтаар дамжуулан бэлтгэгдсэн сайн дурын ажилтантай 30 минут хүртэл хугацаанд харилцан чатлах боломжтой байдаг.

***Малавид*** “Айдасгүйгээр суралц” төслийн хүрээнд хүүхэд, өсвөр үеийнхний сургуулийн орчин дахь хүчирхийлэл, хүчирхийллийн талаар мэдээлэхийг сайжруулах зорилгоор “аз жаргал, уйтгар гуниг” хайрцгийг нэвтрүүлсэн бөгөөд хайрцгийг нэвтрүүлсний дараа хайрцагт дээрэлхэлт, бие махбодын шийтгэл, хоол унд өгөхгүй байх, багш нарын гэрт ажиллах зэрэг асуудлыг онцолсон байжээ. Хайрцгийн талаар оролцогчид өндөр үнэлгээ өгсөн бөгөөд багш, сурагчид хайрцгийг хүүхэд хамгаалал, тайлангах үр дүнтэй арга хэмжээ гэж үзсэн байна.

## ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧИГ

Сургуулийн хүчирхийлэл, дээрэлхэлтийг арилгах арга хэмжээ нь бусад олон улсын конвенц, амлалтын чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд олон улсын гэрээ, конвенцод нийцүүлэн дотоодын хууль тогтоомжоор зохицуулж байна.

## ХҮНИЙ ЭРХИЙН ТҮГЭЭМЭЛ ТУНХАГЛАЛ

НҮБ-ын Эдийн засаг, Нийгмийн Зөвлөл 1946 оны анхдугаар хурлаараа НҮБ-ын Хүний эрхийн Комиссыг байгуулж Комиссын анх удаа Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын төслийг боловсруулсан бөгөөд тунхаглалыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблей 1948 оны 12 дугаар сарын 10-нд Франц Улсын нийслэл Парис хотноо батлан гаргажээ. Хүний эрхийн түгээмэл тунхаглал нийт 30 зүйлээс бүрдэх бөгөөд Тунхаглал нь хэдийгээр заавал биелүүлэгдэх шинжгүй, санал зөвлөмжийн шинжтэй ч хүний эрхийг хамгаалах механизмын үүсэл хөгжилд гол үүрэг гүйцэтгэж, хүний эрхийг хамгаалах тогтолцоо бүрэлдэх үндэс суурийг тавьсан байна. Энэхүү Хүний эрхийн түгээмэл тунхаглалд Хүн бүр арьсны өнгө, үндэс, хүйс, хэл, шашин шүтлэг, нийгмийн гарал, эд хөрөнгө, язгуур угсаа болон бусад байдлыг үл харгалзан адил тэгш эрхтэй байхыг тунхаглан баталгаажуулж хүн төрөлхтөн нийтээрээ хүлээн зөвшөөрсөн хүний эрхийн тухай анхны баримт бичиг юм. Өнөөдөр хүний эрхийн түгээмэл тунхаглалыг дэлхийн 375 хэлээр орчуулж, Хүний эрхийн түгээмэл тунхаглалд үндэслэн, түүнээс салбарласан хүний эрхтэй холбоотой гэрээ, конвенц, хууль, эрх зүйн баримт бичгүүд гарсаар байна. Энэхүү тунхаглалд хүүхэд онцгой халамж, туслалцаа авах эрхтэй, Хүн бүр сурч боловсрох эрхтэй. Анхан шатны болон ерөнхий боловсролыг үнэ төлбөргүйгээр заавал эзэмшүүлэх ёстой, Боловсрол нь бие хүнийг өв тэгш хөгжүүлэх, хүний эрх, үндсэн эрх чөлөөг улам бүр хүндэтгэдэг болоход чиглэх ёстой. Боловсрол нь аливаа улс түмэн, янз бүрийн арьстан хийгээд шашны бүлгүүд бие биеэ харилцан ойлгох, хүлцэн тэвчих, эвсэн найрамдах, мөн түүнчлэн НҮБ-аас энх тайвныг сахиулах талаар явуулж буй үйл ажиллагаанд дөхөм үзүүлэх ёстой гэж тунхагласан байдаг.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын хэрэгжилтийг хангахад улс орнуудын авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар 4 жил тутам хүний эрхийн төлөв байдлын тайланг НҮБ хүлээн авч хэлэлцдэг.

### ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦ

Хүүхдийн эрхийн тухай конвенц[199] буюу хүүхдийн эрхийг хамгаалах олон улсын гэрээ нь 1990 онд батлагдсан бөгөөд үүнийг оролцогч бүх улс орнууд хэрэгжүүлэх үүрэгтэй. Конвенц нь хүүхэд бүрийг ЭРХ ЭДЛЭГЧ, харин насанд хүрсэн хүн бүрийг ҮҮРЭГ ХҮЛЭЭГЧ хэмээн тодотгож, хүүхдийн эрхийг хамгаалах үүрэгтэй. Хүүхдийн эрхийг хангах, хамгаалах гэдэг нь тэдний хуульд заасан эрхийг эдлүүлж, түүнийг зөрчихгүй байх, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн тохиолдолд тусламж үйлчилгээ үзүүлэх, нөхөн сэргээх, хэвийн орчинд ороход туслах нь асран хамгаалагч, гэр бүл, төрийн байгууллагын үүрэг юм. Хүүхдийн эрхийн тухай хуульд хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, бие махбодын шийтгэл, сэтгэл санааны дарамт, үл хайхрах байдал болон мөлжлөгийн аливаа хэлбэрээс нийгмийн бүх орчинд хамгаалагдах эрхтэй гэж заажээ.

### ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО-2030

Тогтвортой хөгжлийн зорилго 2030 нь хүүхдийн эсрэг хүчирхийллийг олон талт асуудал болгон авч үзэж, хэд хэдэн зорилго, зорилтын хүрээнд тодорхой амлалтуудыг тусгасан. Тухайлбал, ТХЗ 4-ийн хүрээнд хүний эрхийн талаарх мэдлэг, ур чадварын ач холбогдлыг онцлон тэмдэглэж, энх тайван, хүчирхийлэлгүй соёлыг сурталчлах (зорилт 4.7), түүнчлэн хүүхэд, хүйс, хөгжлийн бэрхшээлтэй холбоотой эмзэг байгууламж, аюулгүй, хүчирхийлэлгүй, хүртээмжтэй, үр дүнтэй сургалтын орчинг хүн бүрээр хангах (зорилт 4.a).

Түүнчлэн энх тайван, хүртээмжтэй нийгмийг дэмжих тухай SDG 16-ын хүрээнд 2030 он хүртэлх мөрийн хөтөлбөрт хүүхдийн хүчирхийлэл, мөлжлөг, хүний наймаа болон бүх төрлийн хүчирхийлэл, эрүү шүүлтийг таслан зогсоох тодорхой зорилт тусгагдсан (зорилт 16.2). Сургуулийн орчин дахь хүчирхийлэл, дээрэлхэлтийг арилгах арга хэмжээ нь бусад олон улсын конвенц, амлалтын чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд Хүүхдийн эрхийн тухай конвенц нь хүүхдийг хүчирхийллээс хамгаалах, хүүхдийг хамгаалахыг улс орнуудад үүрэг болгодог.

Тогтвортой хөгжлийн зорилго 2030-ын зорилт 4-т чанартай боловсролын дэмжих буюу бүх нийтэд хүртээмжтэй, чанартай боловсролыг баталгаажуулж, насан туршийн боловсролыг дэмжих, зорилт 5 жендэрийн тэгш байдал буюу жендэрийн тэгш байдалд хүрч, бүх эмэгтэйчүүд, охидыг чадавхжуулах болон зорилт 3-эрүүл мэндийг дэмжих буюу бүх насны бүх хүмүүсийн эрүүл амьдралыг баталгаажуулж, сайн сайхан байдлыг дэмжих зорилтуудын хүрээнд дэлхийн улс орнууд сургуулийн хүчирхийлэл, дээрэлхэлтээс сурагчдыг хамгаалах, урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх үүргийг хүлээсэн байдаг.

## 1.2 БУСАД ОРНУУДЫН СУРГУУЛИЙН ОРЧИН ДАХЬ ХҮЧИРХИЙЛЭЛ, ДЭЭРЭЛХЭЛТИЙН ЭСРЭГ БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

### БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС

БНСУ нь 51.5 сая хүн амтай бөгөөд 24-35 насны хүмүүсийн 70 хувь нь дээд боловсролтой байгаа нь тус улсын сүүлийн үеийн ерөнхий боловсролын чанарын түвшнийг харуулж байна.[200] Мөн сурагчдын мэдлэгийн чанарыг стандартчилсан тестээр хэмждэг бөгөөд олон улсын сургалтын чанарын үнэлгээ (PISA)-ээр байнга өндөр үнэлгээтэй орны тоонд ордог юм. 2020

[199] МУ-ын ОУ-ын гэрээ, Хүүхдийн эрхийн тухай конвенц http://www.legalinfo.mn/law/details/1276?lawid=1276

[200] WENR https://wenr.wes.org/2018/10/education-in-south-korea

UIH.MN СУДАЛГААНЫ САН

онд Боловсролын яамнаас бага, дунд, ахлах ангийн 130,000 гаруй сурагчийг хамруулан үе тэнгийнхэндээ дээрэлхүүлж байсан эсэх талаар судалгаа хийхэд бага анги 2.1%, дунд анги 0.8%, ахлах анги 0.3% нь үе тэнгийнхэндээ дээрэлхүүлж байсан гэсэн үр дүн гарчээ. Дээрэлхэлтийн түгээмэл хэлбэрт хэл амаар доромжлох 39%, бүлэглэн дээрэлхэх 19.5%, мөрдөж мөшгөх 10.6%, цахим дээрэлхэлт 8.2%, бие махбодын хүчирхийлэл 7.7%, бэлгийн хүчирхийлэл 5.7%-тай байна.

**I. Хууль эрх зүйн орчин**

2005 онд "Сургуулийн орчин дахь хүчирхийллийн эсрэг хариу арга хэмжээ авах, түүнээс урьдчилан сэргийлэх тухай хууль" (Act on the Prevention of and Counter-measures Against Violence in School)[201]-ийг баталсан байна.

*Хуулийн зорилго*:

Хүчирхийлэл, заналхийлэл, дээрэлхэлтэд өртсөн сурагчдыг хамгаалах, танхайрах дээрэлхэх үйлдэл хийсэн сурагчдыг хүмүүжүүлэх, хохирогч болон танхайрсан хүүхдүүдийг эвлэрүүлэх, зөрчлийг шийдвэрлэх замаар сурагчдын эрх ашгийг хамгаалах, сургууль дахь хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, нийгэмд зөв хүн болгон төлөвшүүлэхэд оршино.

*Тодорхойлолт:*

Орчин "*сургуулийн орчин дахь хүчирхийлэл*" гэдэг нь сургуулийн гадна болон дотор сурагчдын эсрэг заналхийлэх, хулгайлах, гүтгэх, доромжлох, бие махбод, сэтгэл санаа болон эд хөрөнгөд хохирол учруулах, мөнгө нэхэх, дарамтлах, дээрэлхэх, эсхүл хувь хүний мэдээллийг цахим орчинд тараах, бэлгийн хүчирхийлэл үзүүлэх үйлдлүүдийг хэлнэ.

*(bullying) буюу "дээрэлхэлт"* гэдэг нь сургуулийн гадна болон дотор хоёр ба түүнээс дээш сурагч бүлэглэн нэг, эсхүл хэсэг бүлэг сурагчийн бие махбод, сэтгэл санаанд дарамт үзүүлэх, хохирол учруулах үйлдлийг байнга хийхийг хэлнэ.

*"цахим дээрэлхэлт"* гэдэг нь интернэт зэрэг мэдээлэл, харилцаа холбооны хэрэгсэл ашиглан сурагчдын бие махбод, сэтгэл санаанд дарамт үзүүлэх, хохирол учруулах зорилгоор хувийн мэдээллийг нь байнга задруулахыг хэлнэ.

"*хохирогч сурагч*" гэдэг нь сургуулийн дотор болон гадна орчин дахь дээрэлхэлт, гадуурхалтын улмаас бие махбод, сэтгэл санааны хохирол амссан сурагчийг хэлнэ.

*"дээрэлхүү сурагч" (aggressor student)* гэдэг нь сургуулийн орчинд бусад сурагчийг дээрэлхсэн, гадуурхсан, хүчирхийлсэн болон түүнд хамтран оролцсон, хөгжөөн дэмжсэн сурагчдыг хэлнэ.

*Төрийн болон орон нутгийн засаг захиргааны хариуцлага (Responsibilities of State and Local Governments):*

- Сургуулийн орчин дахь хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, уг үйлдлийг таслан зогсоох, устгах арга замыг эрэлхийлсэн судалгаа хийх, соён гэгээрүүлэх байгууллагын тогтолцоог бүрдүүлэх;
- Төрийн болон орон нутгийн засаг захиргаанаас хүүхэд хамгааллын байгууллага болон төрийн бус байгууллагуудын сургуулийн орчин дахь хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогч сурагчдыг хамгаалах, хүчирхийлэл үйлдсэн сурагчийг хүмүүжүүлэх зорилгоор авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг дэмжин хамтран ажиллах;
- хүүхэд хамгааллын байгууллага болон төрийн бус байгууллагаас гаргасан санал зөвлөмжийг төрийн бодлогод тусгах талаар анхаарч ажиллах;
- санхүүгийн дэмжлэг үзүүлэх.

[201] Act on the Prevention of and Countermeasures Against Violence in School https://law.go.kr/LSW/lsInfoP.do?lsiSeq=199081&viewCls=engLsInfoR&urlMode=engLsInfoR#0000

*Мастер төлөвлөгөө* (*Master Plan*) нь энэ хуулийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд сургуулийн орчин дахь хүчирхийллийн эсрэг хариу арга хэмжээ авах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах бодлого чиглэлийг тодорхойлдог бөгөөд сургуулийн орчин дахь хүчирхийлэлтэй тэмцэх хороогоор дамжуулан санал авснаар Боловсролын сайд 5 жилийн хугацаагаар баталдаг бодлогын баримт бичиг юм.

Мастер төлөвлөгөөнд**:**

- Сургуулийн орчин дахь хүчирхийллийг арилгах судалгаа, шинжилгээ хийх;
- Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээ зохион байгуулах;
- Хохирогч сурагчдын эмчилгээ, эргэн нийгэмшүүлэхэд туслах үйл ажиллагаа явуулах;
- Сургуулийн орчин дахь хүчирхийллийн эсрэг хэрэгжүүлэх орон нутгийн захиргааны болон боловсролын байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах;
- Сургууль бүрд мэргэжлийн зөвлөхүүд ажиллуулах, түүнд захиргааны болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх;
- Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирсон хүүхдүүдийг эмчлэх, эргэн нийгэмшүүлэх, зөрчил гаргасан хүүхдүүдийг хүмүүжүүлэх, зөвлөгөө авах талаар мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах, санхүүгийн дэмжлэг үзүүлэх;
- Сургуулийн орчин дахь хүчирхийллээс урьдчилан сэргийлэх бүх талын арга хэмжээний чиглэлийг төлөвлөгөөнд тусгаж боловсруулна.

*Сургуулийн орчин дахь хүчирхийлэлтэй тэмцэх хороо* (*The Committee for Countermeasures against School Violence*)

Энэ хороо нь Ерөнхий сайдын удирдлага доор дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

- Сургуулийн орчин дахь хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хариу арга хэмжээ авах мастер төлөвлөгөөг боловсруулах;
- Хэрэгжүүлсэн арга хэмжээ, ажлын үр нөлөөг үнэлэх;
- Холбогдох захиргааны байгууллага болон орон нутгийн засаг захиргаанд гаргасан сургуулийн орчин дахь хүчирхийллийн талаарх санал, хүсэлт, бусад асуудлыг хэлэлцэх.

Тус хороо нь дарга, дэд дарга, 18 гишүүнтэй байх бөгөөд хорооны үйл ажиллагааны журам, ажлын зохион байгуулалт, үйл ажиллагаанд шаардлагатай бусад асуудлуудыг Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоодог байна.

Хорооны гишүүд:

- Стратеги, сангийн сайд, Боловсролын сайд, Шинжлэх ухаан, мэдээлэл технологийн сайд, Хууль зүйн сайд, Дотоод хэргийн болон Аюулгүй байдлын сайд, Соёл, спорт, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд, Гэр бүл, жендэрийн эрх тэгш байдлын сайд, Солонгосын Харилцаа холбооны комиссын дарга, Солонгосын Үндэсний цагдаагийн газрын Ерөнхий комиссар;
- Сургуулийн орчин дахь хүчирхийлэлтэй тэмцэх хорооноос санал болгосон;
- Холбогдох төрийн захиргааны төв байгууллагын III зэргийн албан тушаалтан;
- Сэтгэл зүйн чиглэлээр мэргэшсэн эрдэм шинжилгээний байгууллагын туслах профессор болон түүнээс дээш зэрэг цолтой;
- Шүүгч, прокурор, өмгөөлөгч;
- Хүүхэд хамгааллын байгууллагад 5-аас доошгүй жил ажилласан;
- Мэргэжлийн үнэмлэхтэй эмч;
- Сургуулийн удирдах зөвлөл болон хүүхэд хамгааллын талаар туршлагатай эцэг, эх гэх мэт хүмүүсээс тус хорооны гишүүдийг бүрдүүлнэ.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

*<u>Сургуулийн орчин дахь хүчирхийлэлтэй тэмцэх бүс нутгийн хороод</u> (Regional Committees for Countermeasures against School Violence)*

Сургуулийн орчин дахь хүчирхийлэлтэй тэмцэх хорооноос бүс нутгийн хороодыг дарга 11 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулдаг. Хотын захирагч, засаг дарга болон боловсролын газрын дарга нар хорооны үйл ажиллагаатай холбоотойгоор дэд хороог байгуулж болно. Хорооны чиг үүрэг:

- мастер төлөвлөгөөний дагуу жил бүр сургуулийн орчин дахь хүчирхийллээс хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа зохион байгуулах;
- тухайн бүс нутгийн сургууль болон цагдаагийн газраас гаргасан сургуулийн орчин дахь хүчирхийллийн дүн мэдээг авч дүн шинжилгээ хийх;
- зөвлөгөө, мэдээлэл өгөх байгууллага ажиллуулан тухайн байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах.

Мөн сургуулийн орчин дахь хүчирхийллийн эсрэг сургууль бүрийн авч хэрэгжүүлэх төлөвлөгөө бусад байгууллагын хамтын ажиллагааны уялдаа холбоо, дэмжлэгийг зохицуулах зохицуулах хороог байгуулж болно.

*<u>Боловсролын газар</u> (Offices of Education)* – Боловсролын газраас хотын сургууль бүрд сургуулийн орчин дахь хүчирхийллийн эсрэг нэгжийг байгуулж хамтран ажиллаж түүний үйл ажиллагаанд хяналт тавина. Тус газар нь:

- сургууль бүрийн сургуулийн орчин дахь хүчирхийллийн эсрэг арга хэмжээний төлөвлөгөөг хянаж, хэрэгжилтэд хяналт тавих;
- сургуулийн орчин дахь хүчирхийллийн талаар мөрдөн байцаах ажил зохион байгуулж, авч хэрэгжүүлж байгаа болон урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт судалгаа хийж олон нийтэд мэдээлэх;
- уг асуудлыг таслан зогсоох, илрүүлэх, зөвөлгөө мэдээлэл өгөх тусгай байгууллага байгуулж үйл ажиллагааг хянах;
- холбогдох байгууллагатай хамтран ажиллах чиг үүрэгтэй байна.

Боловсролын газрын дэд дарга нар мөрдөн байцаалтын ажиллагаа явуулах, зөвлөгөө өгөх дараах эрх үүрэгтэй байна.

- сургуулийн орчинд хүчирхийлэлд өртсөн сурагчдад зөвлөгөө өгөх;
- дээрэлхэлт, хүчирхийлэл үйлдсэн сурагчдыг мөрдөн байцаах;
- шаардлагатай тохиолдолд хүчирхийлэл үйлдсэн сурагчийн эцэг эхийг шалгах;
- сургуулийн орчин дахь хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг удирдан чиглүүлэх;
- сургуулийн орчин дахь элдэв бүлэглэл тэдний үйл ажиллагааг олж илрүүлэх, таслан зогсоох, илрүүлэхийн тулд хувийн байгууллага, албан газрыг нэгжих мөрдөн байцаалтыг цагдаагийн ерөнхий газар болон харьяа дүүргийн цагдаагийн газартай хамтран явуулах эрхтэй байна.

*<u>Сургуулийн орчин дахь хүчирхийлэлтэй тэмцэх бие даасан хороо</u>*

*(The Autonomous Committees for Countermeasures against School Violence)*

Тус бие даасан хороо нь сургууль бүрд байх бөгөөд эсхүл хоёр сургууль хамтарч хамтарсан хороотой байж болно. Ерөнхийлөгчийн зарлигаар томилогдсон дарга болон эцэг эхийн хурлаар шууд сонгогдсон эцэг эхчүүд мөн хохирогч сурагчийн эцэг эхээс бүрдсэн 10 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Хорооны чиг үүрэг:

- сургуулийн орчин дахь хүчирхийллийн эсрэг авах арга хэмжээг боловсруулах;
- хүчирхийллийг олж тогтоох;
- хохирогч сурагчийг хамгаалах;
- дээрэлхүү сурагчийг удирдан чиглүүлэх, тохирсон шийтгэлийг өгөх;
- мэргэжлийн зөвлөх ажиллуулах;
- хэрэгт холбогдсон болон хохирогч сурагчид авсан арга хэмжээний талаар тайлагнах;
- хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр боловсруулах үр дүнг тайлагнах;
- холбогдох байгууллага болон цагдаагийн байгууллагатай хамтран ажиллана.

Хорооны хурал улиралд нэгээс доошгүй хуралдах боловч дараах тохиолдолд яаралтай хурал зарлаж болно.

- Хорооны ¼-өөс гишүүдээс доошгүй хүсэлт гаргасан;
- Сургуулийн захирлын хүсэлтээр;
- Хохирогч болон түүний эцэг эхийн хүсэлтээр;
- Тус хороонд хүчирхийллийн мэдээлэл ирсэн тохиолдолд;
- Түрэмгийлэл үйлдсэн сурагчид заналхийлэл ирсэн тохиолдолд яаралтай хуралдана.

Сургуулийн захирал мэргэжлийн зөвлөх ажиллуулах тусгай кабинет байгуулж, сургуулийн дэд дарга, мэргэжлийн зөвлөх, эрүүл мэнд хичээлийн багш, багш гэсэн бүрэлдэхүүнтэйгээр тусгай нэгжийг байгуулан ажиллана. Тус нэгж нь сургуулийн орчинд хүчирхийлэл гарсан даруйд таслан зогсоох арга хэмжээг аван бие даасан хороонд мэдэгдэнэ. Мөн тус нэгж улирал бүр сургуулийн орчин дахь хүчирхийллээс урьдчилан сэргийлэх боловсролын (хүчирхийлэл гэж юу вэ, хэр өргөн тархсан байна вэ, түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх, хүчирхийлэлд өртсөн тохиолдолд яах вэ гэх мэт) агуулгыг багтаасан сургалтын хөтөлбөр боловсруулж сурагчид болон эцэг эхчүүдэд мэдлэг олгодог байна. Сургуулийн цахим сайтаар дамжуулан нийтэд мэдээлнэ.

*Хохирогч сурагчийг хамгаалах арга хэмжээ* *(Protection of Victim Students)*

- Сургуулийн орчин дахь хүчирхийлэлтэй тэмцэх хороо болон тусгай нэгжийн зөвлөх эсхүл гадны мэргэжилтнүүдийн сэтгэл зүйн зөвлөгөө өгөх;
- Түр хамгаалалтад авах;
- Нөхөн сэргээх эмчилгээ хийлгэх;
- Ангийг солих;
- Хохирогч сурагч болон асран хамгаалагчийн санал бодлоо илэрхийлэх боломжийг бүрдүүлэх;
- Хохирогчид шаардлагатай бүх арга хэмжээ болон нөхөн төлбөр олгох зэрэг арга хэмжээ авна.

*Түрэмгийлэл үйлдсэн сурагчид авах арга хэмжээ* *(Countermeasures against Aggressor Students)*

- Хохирогчоос албан ёсоор бичгээр уучлалт гуйх;
- Хүчирхийллийн талаар мэдээлсэн гэрчид заналхийлэл хийхгүй байх;
- Тусгай сургалтад хамрагдуулах;
- Сэтгэл зүйн эмчилгээ хийх;
- Нийгэмд тустай ажил хийлгэх;
- Сургуулийн ирцийг түдгэлзүүлэх;
- Мэдүүлэг өгөх боломжийг бүрдүүлэх;
- Ангийг солих;
- Өөр сургуульд шилжүүлэх, шилжсэн тохиолдолд хохирогчийн сургуульд дахин нэвтрэхийг хориглох;
- Сургуулиас хасах зэрэг арга хэмжээ авна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

*Бусад арга хэмжээ*

- Муж болон орон нутгийн захиргаа сургуулийн орчин дахь хүчирхийллийн талаарх мэдээлэл хүлээн авах яаралтай утас (117) ажиллуулах;
- Орон нутгийн засаг захиргаа эсхүл сургуулийн зүгээс сургуулийн орчин дахь хүчирхийллээс сэргийлэх эргүүл ажиллуулах;
- Хүчирхийллийг цаг алдалгүй илрүүлэх хяналтын систем (камер, байршил тогтоогч гэх мэт) ашиглах;
- Цагдаагийн газраас тусгайлан сургуулийн орчин дахь хүчирхийллийг таслан зогсоох цагдаагийн ажилтан томилж болно.

*Торгуулийн заалт*

- Хэрэв сургуулийн орчин дахь хүчирхийлэлтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх ажил үүргийн дагуу олж авсан нууц мэдээллийг задруулбал нэг жил хүртэл хорих эсхүл 10 сая воноор торгоно;
- Сургуулийн орчин дахь хүчирхийлэлтэй тэмцэх бие даасан хорооноос гаргасан шийдвэрийг түрэмгийлэл үйлдсэн сурагчийн асран хамгаалагч нь дагаж мөрдөж хэрэгжүүлээгүй тохиолдолд 3 сая воны торгууль ногдуулна.

**II. ЕБС-ийн ёс зүйн дүрэм, журам[202]**

Боловсролын яамнаас баталсан хөтөлбөр төлөвлөгөө, сурах бичгийн дагуу ерөнхий боловсролын сургуулийн 1-12 дугаар ангид долоо хоногт 2 цаг ёс зүйн боловсрол олгох хичээл ордог. Хөтөлбөрийг тоймловол;

*Бага сургууль* – ёс зүйн боловсрол олгох эхний шат буюу “өөртэйгөө харилцах харилцаа”-ны хүрээнд ангийн багш нь хувь хүн, гэр бүл, хөрш, иргэний харьяалал, үндэстэн, эв нэгдэл зэрэг сэдвийн хүрээнд ёс зүйн боловсрол олгоно.

*Дунд сургууль* – ёс зүйн боловсрол олгох хоёр дахь шат буюу “бусадтай харилцах харилцааг бий болгох”-ын хүрээнд мэргэшсэн лицензтэй багш ёс суртахуун, амьдралын үнэ цэнэ, гэр бүлийн үнэ цэнэ, эх орон, ардчилсан солонгосын хуваагдал, үндэсний эв нэгдэл сэдвийн хүрээнд ёс зүйн боловсрол олгоно.

*Ахлах сургууль* – ёс зүйн боловсрол олгох сүүлийн шат буюу “харилцааг бий болгох”-ын хүрээнд мэргэшсэн лицензтэй багш хувь хүний амьдралын ёс зүй, нийгмийн ёс зүй, Солонгос Улсын үнэт зүйл, уламжлал ёс заншил, хөгжил цэцэглэлтийн талаар ёс зүйн боловсрол олгодог байна.

**ЯПОН УЛС**

**I. Хууль эрх зүйн орчин**

2013 оны 9 сарын 18-нд Дээрэлхэлтээс сэргийлэх тухай хууль (Act for the promotion of measures to prevent bullying)-ийг баталсан бөгөөд тус хууль 6 бүлэг 35 зүйлтэй байна.[203]

I бүлэг.Ерөнхий зүйл

II бүлэг.Дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх үндсэн бодлого

III бүлэг.Үндсэн санаачилга

IV бүлэг.Дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэхэд авах арга хэмжээ

V бүлэг.Ноцтой нөхцөл байдал үүссэн үед авах арга хэмжээ

VI бүлэг.Бусад зүйл

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[202] The Status and Perspective of Moral Education in Korea https://sspace.snu.ac.kr/bitstream/10371/72457/1/01.pdf
[203] Act for the promotion of measures to prevent bullying https://www.mext.go.jp/en/policy/education/elsec/title02/detail02/1373868.html

Нэмэлт зүйл

*Хуулийн зорилго*

Дээрэлхэлт нь хохирогч хүүхдийн боловсрол эзэмших эрхийг ноцтой зөрчиж, тэдний оюун санаа, бие бялдрын өсөлт, хөгжил, амь насанд ноцтой эрсдэл учруулж болзошгүй байдаг тул энэ хууль нь дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний үндсэн зарчмууд болох урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, арга хэмжээ авах ойлголтыг хамаарна. Хүүхдийн хувийн нэр төрийг хамгаалах зорилгоор дээрэлхэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндсэн бодлогыг боловсруулж, дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг цогц, үр дүнтэй сурталчлахад энэ хуулийн зорилго оршино.

*Нэр томьёо*

"Дээрэлхэлт" гэдэг нь ижил сургуульд сурдаг, эсхүл ямар нэг хувийн харилцаатай өөр сургуулийн хүүхэд хохирогч хүүхдэд сэтгэл санааны болон бие махбодын нөлөө үзүүлэх (интэрнэтээр үйлдсэн үйлдлүүд мөн орно) үйлдлийг хэлнэ.

"Сургууль" гэдэгт бага сургууль, бүрэн дунд сургууль, албан журмын боловсрол олгодог сургууль, тусгай хэрэгцээт боловсролын сургуулийг заана.

*Үндсэн зарчим*

Дээрэлхэх нь бүх хүүхдэд хамаатай асуудал тул дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг сургууль дотор болон гадна авах хэрэгтэй ба хүүхэд сурах болон бусад үйл ажиллагаанд санаа зоволтгүй оролцох боломжийг бүрдүүлэх ёстой.

Дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хүүхдийн сэтгэцийн болон бие махбодод үзүүлэх нөлөөг илрүүлэх, хэмжих үйл ажиллагааг оруулж ойлгоно.

Дээрэлхэлтийн хохирогч болсон хүүхдүүдийн амь нас, оюун ухаан, бие махбодыг хамгаалах нь онцгой чухал гэдгийг хүлээн зөвшөөрч, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь үндэсний, орон нутгийн, засгийн газар, сургууль, гэр бүлийн орчинд дээрэлхэлттэй холбоотой бүхий л асуудлыг шийдэхэд чиглэх ёстой. Мөн хүүхэд дээрэлхэх үйлдэл гаргах ёсгүй.

*Талуудын үүрэг*

Дээрэлхэлтийн эсрэг үндсэн зарчмын дагуу засгийн газар үндэсний хэмжээнд урьдчилан сэргийлэх арга хэмжээг цогцоор нь авч хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.

Орон нутгийн засаг захиргаа нь үндсэн зарчмын дагуу дээрэлхэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг засгийн газартай хамтран хэрэгжүүлж, тухайн орон нутгийн нөхцөл байдалд нийцүүлэн санаачилгатай ажиллах үүрэгтэй.

Сургуулийн захиргаа нь үндсэн зарчмын дагуу сургуулийн орчинд дээрэлхэх явдлаас урьдчилан сэргийлэхэд шаардлагатай арга хэмжээг авах үүрэгтэй.

Сургуулийн багш, бусад ажилтнууд үндсэн зарчмын дагуу хүүхдийн асран хамгаалагчидтай хамтран ажиллаж, дээрэлхэхээс урьдчилан сэргийлэх, түүнийг эрт үед илрүүлэхийн тулд бүхий л хүчин чармайлтыг гаргах үүрэгтэй. Тухайн орон нутгийн оршин суугчид, холбогдох талуудтай хамтран хүүхдийг дээрэлхсэн гэж сэжиглэгдсэн тохиолдолд зохих ёсоор, шуурхай хариу арга хэмжээ авах үүрэгтэй.

*Асран хамгаалагч*

Асран хамгаалагч нь хүүхдээ хүмүүжүүлэх үндсэн үүрэгтэй бөгөөд өөрийн халамжид байгаа хүүхдийг дээрэлхэх үйлдэл гаргуулахгүй байх ухамсрыг төлөвшүүлэх, чиглүүлэх үүрэгтэй.

Өөрийн халамжид байгаа хүүхэд дээрэлхүүлснийг олж мэдсэн тохиолдолд асран хамгаалагч нь хүүхдийг зохих ёсоор хамгаалах үүрэгтэй.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Асран хамгаалагч нь үндэсний болон орон нутгийн засаг захиргаа, сургуулийн захиргаа, багш нарын санаачилсан дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх ажилд хамтран ажиллахыг хичээх ёстой.

Гэрийн боловсрол олгож байгаа тохиолдолд дээрэлхэлтийн эсрэг үндсэн зарчмыг мөрдсөн хэвээр байх ба үүнд сургуулийн хүлээсэн үүргийг хөнгөвчлөгдсөн гэж ойлгож болохгүй.

*Дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх үндсэн бодлого*

Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яамны сайд дээрэлхэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг холбогдох захиргааны байгууллагатай хамтран цогц, үр дүнтэй хэрэгжүүлэхэд чиглэсэн үндсэн бодлогыг боловсруулна.

Дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх үндэсний бодлогод дараах зүйлийг тусгасан байх ёстой.

- дээрэлхэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний үндсэн чиглэл
- дээрэлхэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний дэлгэрэнгүй мэдээлэл
- дээрэлхэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаарх бусад чухал асуудал.

Орон нутгийн засаг захиргаа нь тухайн орон нутгийн нөхцөл байдалтай уялдуулан харьяалагдах нутаг дэвсгэртээ дээрэлхэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг иж бүрэн, үр дүнтэй авахын тулд үндэсний бодлогод нийцүүлэн орон нутгийн бодлогыг боловсруулна.

Сургууль өөрийн нөхцөл байдалд тохируулан, дээрэлхэхээс урьдчилан сэргийлэх үндэсний болон орон нутгийн бодлогыг харгалзан сургууль дээрээ дээрэлхэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний үндсэн бодлогыг боловсруулах ёстой.

*Дээрэлхэлтийн эсрэг зөвлөл*

Дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой байгууллагууд болох орон нутгийн засаг захиргаа, сургууль, холбогдох боловсролын зөвлөл, хүүхдийн төв, хууль зүйн товчоо, цагдаагийн газар зэргээс төлөөлөл бүхий дээрэлхэлтийн эсрэг зөвлөлийг байгуулж болно.

Уг зөвлөлийг байгуулахдаа хотын харилцааны зөвлөл болон боловсролын зөвлөл гэх мэт холбогдох байгууллагуудын хамтын ажиллагааг хангана.

Дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх бүс нутгийн арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай гэж үзвэл боловсролын зөвлөлийн дэргэд харьяа байгууллагыг байгуулж болно.

*Дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх үндсэн санаачилга*

Сургуулийн захиргаа нь хүүхдийн мэдрэмж, ёс суртахууны зөв мэдрэмжийг төлөвшүүлэх, халуун дулаан хүмүүжлийг бий болгох үндэс суурийг бий болгох үзэл баримтлалд тулгуурлан боловсролын бүхий л үйл ажиллагааг явуулах ёстой.

Сургуулийн захиргаа нь сайн дураар дээрэлхэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулж буй хүүхэд, тэдний асран хамгаалагч, багш, бусад ажилчдын санаачилгад дэмжлэг үзүүлэх.

Сургуулийн захиргаа нь дээрэлхэх явдлыг эрт илрүүлэхийн тулд сурагчдын дунд тогтмол судалгаа явуулах ёстой.

Үндэсний болон орон нутгийн засаг захиргаа нь дээрэлхэлтийн дараах зөвлөгөө өгөх тогтолцоог хөгжүүлэхэд шаардлагатай санаачилгыг хэрэгжүүлэх ёстой. Энэ нь сургуулийн захиргаа нь сурагчид ба тэдний асран хамгаалагч, багш нар болон бусад ажилтнууд дээрэлхэлтийн талаар зөвлөгөө авах тогтолцоо юм.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

*Интернэтээр дээрэлхэлтийн эсрэг арга хэмжээг сурталчлах*

Интернэтэд буй мэдээлэл нь хувирах чадвар өндөр, илгээгч нь нэрээ нууцалж чаддаг тул эрсдэл өндөр. Тиймээс үүнд чиглэсэн шаардлагатай сурталчилгааны үйл ажиллагааг явуулах ёстой.

Үндэсний хэмжээнд болон орон нутгийн засаг захиргаа нь интернэтээр дээрэлхэлтэнд өртөж буй хүүхдэд тусламж үзүүлэх холбогдох байгууллагад дэмжлэг үзүүлж, хариу арга хэмжээ авах тогтолцоог хөгжүүлэхийг хичээх ёстой.

Интернэтээр дээрэлхүүлсэн хохирогч хүүхэд ба түүний асран хамгаалагч нь холбогдох мэдээллийг устгахыг шаардах, учруулсан хохирлын хариуцлагыг нэхэх, илгээгчийн мэдээллийг задруулахыг шаардах эрхтэй ба шаардлагатай бол хууль зүйн товчоонд энэ талаар хүсэлт гаргаж болно.

*Дээрэлхэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой судалгааг дэмжих*

Улсын болон орон нутгийн засаг захиргаа нь дээрэлхэхээс урьдчилан сэргийлэх, түүнийг эрт үед илрүүлэх, хохирогч хүүхэд болон тэдний асран хамгаалагчид дэмжлэг үзүүлэх талаар санал асуулга, судалгаа хийхийг дэмжин сурталчлах ёстой. Мөн энэ талаар асран хамгаалагчдад зөвлөгөө өгөх, зохих арга хэмжээг авах, дээрэлхэхээс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай бусад асуудал, дээрэлхэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилтийн байдал зэргийг судалж үр дүнг олон нийтэд түгээх ёстой.

Улсын хэмжээний болон орон нутгийн засаг захиргаа нь хохирогч хүүхдүүдэд үзүүлэх сэтгэц, бие махбодод үзүүлэх нөлөөг арилгах тал дээр зөвлөгөө өгөх, энэ талаар олон нийтэд сурталчлах, эсхүл бусад аргаар таниулах үйл ажиллагааг явуулах ёстой.

*Дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэхэд авах арга хэмжээ*

Сургууль нь дээрэлхэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор сургуулийн багш, ажилчдаас гадна сэтгэл зүйн чиглэлээр мэргэшсэн мэдлэгтэй боловсон хүчин, бусад холбогдох хүмүүсийг бэлдсэн байх ёстой.

Хүүхэд өөрөө эсхүл сургуулийн багш, бусад ажилтан, хүүхдэд зөвлөгөө өгдөг хүмүүс, асран хамгаалагч зэрэг нь хүүхдийн дээрэлхэлтийн талаар зөвлөгөө авсан тохиолдолд тухайн хүүхдийг дээрэлхсэн гэж сэжиглэсэн сургуульд мэдэгдэх буюу бусад тохирох арга хэмжээг авна. Сургууль уг мэдээллийг хүлээн авсан тохиолдолд нэн даруй хэргийг шалгаж дээрэлхэлт явагдсан эсэхийг тодорхойлно.  Хэрэв дээрэлхэлт явагдсан нь тодорхой болбол хохирогч хүүхэд ба түүний асран хамгаалагчдад байнга дэмжлэг үзүүлж, чиглүүлэх багш ажилтнууд байх ёстой. Энэ нь дээрэлхэх явдлыг таслан зогсоох, дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх зорилготой ба энэ тал дээр сэтгэл зүйн чиглэлийн мэргэжилтэнтэй хамтран ажиллаж болно.

Хэрэв сургуулийн захиргаа шаардлагатай гэж үзвэл хохирогч хүүхдийг тайван боловсрол эзэмших эрхийг нь хамгаалж, дээрэлхсэн хүүхдийг хохирогч хүүхдийн байгаа ангиас өөр газарт суралцуулах хүртэл арга хэмжээ авна.

Сургуулийн багш, ажилтнууд дээрэлхэлтийг илрүүлж, шаардлагатай арга хэмжээ авах тохиолдолд дээрэлхэгч ба хохирогч хүүхдийн асран хамгаалагчдад уг мэдээллийг хуваалцах ёстой. Ингэснээр асран хамгаалагчдын хооронд маргаан үүсэхээс сэргийлнэ.

Сургуулийн захиргаа дээрэлхсэн хэргийг эрүүгийн шинжтэй гэж үзвэл  эрх бүхий цагдаагийн газартай хамтран хариу арга хэмжээ авна. Хүүхдийн амь нас, эд хөрөнгө эрсдэлд орсон тохиолдолд сургуулийн захиргаа эрх бүхий цагдаагийн хэлтэст нэн даруй мэдэгдэх үүрэгтэй. Орон нутгийн захиргаа дээрэлхэлттэй холбоотой мэдээг хүлээн авсны дараа холбогдох сургуульд шаардлагатай арга хэмжээ авахад нь дэмжлэг үзүүлэх, сургуулийг удирдан

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

чиглүүлэх, мэдээлсэн хэргийн талаар сургуулийн захиргаа бие даан мөрдөн байцаалт явуулах боломжоор хангах ёстой. Сургуулийн захирал эсхүл багш дээрэлхэх үйлдэл гаргасан сурагчид хүмүүжлийн хувьд шаардлагатай гэж үзвэл зохих сахилгын арга хэмжээг авах эрхтэй. Шаардлагатай тохиолдолд хохирогч хүүхдийг тайван боловсрол эзэмшүүлэх үүднээс дээрэлхсэн хүүхдийг сургуульд ирэхийг түдгэлзүүлэх хүртэлх арга хэмжээг хотын боловсролын зөвлөлөөс гаргаж болно.

Хохирогч хүүхэд ба дээрэлхсэн хүүхэд нэг сургуульд харьяалагддаггүй байсан ч орон нутгийн засаг захиргаа нь хохирогч хүүхэд болон түүний асран хамгаалагчдад дэмжлэг үзүүлэх, зөвлөгөө өгөх хамтын ажиллагааны тогтолцоог хөгжүүлэх ёстой.

*Ноцтой нөхцөл байдалд үзүүлэх хариу арга хэмжээ*

Сургуулийн захиргаа нь дараах тохиолдолд үүссэн ноцтой нөхцөл байдлын талаар асуулгын хуудас болон бусад аргыг ашиглан мөрдөн байцаах ажиллагаа явуулна.

- Хүүхдийн амь нас, сэтгэц, бие махбод, эд хөрөнгөд дээрэлхэх гэмт хэргийн улмаас ноцтой хохирол учруулсан
- Дээрэлхсэний улмаас хүүхэд багагүй хугацаагаар хичээл таслахаас өөр аргагүйд хүрсэн

Сургуулийн захиргаа үүссэн ноцтой нөхцөл байдлын талаар мөрдөн байцаалтын явцад шаардлагатай мэдээллийг өгөх, дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

*Улсын их дээд сургуульд дээрэлхэх явдал гарсан үед авах арга хэмжээ*

Улсын их дээд сургуульд дээрэлхэлтийн улмаас ноцтой нөхцөл байдал үүссэн бол их сургуулиудын корпорац Боловсролын сайдад мэдээлнэ. Мөрдөн байцаалтын дүнд дээрэлхэх ноцтой гэмт хэрэг тогтоогдвол хариу арга хэмжээ авна. Мөн Боловсролын яам нь үндэсний их сургуулийн корпорацтай хамтран ижил төстэй нөхцөл байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авна.

*Дунд боловсролын сургуульд дээрэлхэх явдал гарсан үед авах арга хэмжээ*

Дунд сургуульд ноцтой нөхцөл байдал үүсвэл тухайн орон нутгийн боловсролын зөвлөлөөр дамжуулан орон нутгийн захирагчид мэдээлэх ёстой. Уг мэдэгдлийг хүлээн авсны дараа харьяа байгууллагаар дамжуулан мөрдөн байцаалтын ажиллагаа явуулна. Мөн үүссэн ноцтой нөхцөл байдалд тохирох хариу арга хэмжээг авах, ижил төстэй нөхцөл байдал үүсэхээс урьдчилан сэргийлнэ.

Мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсны дараа орон нутгийн засаг захиргааны тэргүүн түүний үр дүнг нутгийн удирдлагын чуулганд мэдээлэх ёстой. Хийсэн шалгалтын үр дүнд үндэслэн орон нутгийн засаг захиргааны тэргүүн, холбогдох боловсролын зөвлөл нь ноцтой нөхцөл байдалд тохирсон шаардлагатай арга хэмжээг авах ёстой.

*Хувийн сургуульд дээрэлхэх явдал гарсан үед авах арга хэмжээ*

Хувийн сургуульд дээрэлхэх хэрэг гарвал боловсролын нэгдсэн байгууллагаас мужийн захирагчид мэдэгдэнэ. Уг хэргийн талаарх тайланг хүлээн авсны дараа мужийн захирагч тайланд хамаарах ноцтой нөхцөл байдалд хариу арга хэмжээ авах, эсвэл холбогдох ноцтой нөхцөл байдалтай ижил төстэй нөхцөл байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авна.

*Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн сайд ба мужийн боловсролын зөвлөлөөс гаргах удирдамж, зөвлөгөө, тусламж*

Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн сайд ба мужийн боловсролын зөвлөлийн зүгээс дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээ авахад муж, хотын түвшинд удирдамж, зөвлөгөө, туслалцаа үзүүлж болно.

*Бусад зүйлс*

Сургууль дээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээг дүгнэхдээ дээрэлхэх гэмт хэргийг эрт илрүүлэх, дахин давтагдахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн хүчин чармайлтыг нь зөв үнэлж, дээрэлхэх явдлыг нуун дарагдуулахгүй, эрт илрүүлж байсан эсэхийг тодорхойлно.

Дээрэлхэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг энэ хууль хэрэгжиж эхэлснээс хойш гурван жилийн дотор хуулийн хэрэгжилтийн байдлыг үнэлж, цаашид сайжруулах шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Сургуулийн орчинд дээрэлхүүлсний улмаас сэтгэлийн түгшүүрт автаж, багагүй хугацаанд хичээлдээ явах боломжгүй болсон хүүхдэд суралцахад нь дэмжлэг үзүүлэх тал дээр засгийн газар хянаж, дэмжлэг үзүүлэх ёстой.

**II. Бусад хуулийн зохицуулалт**

***Кибер аюулгүй байдлын стратеги 2021***

2021 оны 3-р сарын байдлаар Үндэсний цагдан сэргийлэхийн газраас явуулсан судалгаагаар 18-аас доош насны 1819 хүүхэд 2020 онд нийгмийн сүлжээтэй холбоотой гэмт хэргийн хохирогч болсон болохыг тогтоожээ. Хохирогчдын бараг 90 хувь нь бага, ахлах сургуулийн сурагчид байсан бөгөөд үүний 35,3 хувийг твиттер ашиглагч эзэлж байна. Хэдийгээр 2019 оны мөн үетэй харьцуулахад 12,6%-аар буурсан боловч 2013 оноос хойш сүүлийн 5 жилд 4.6 хувиар өссөн үзүүлэлттэй байжээ.[204]

2021 оны 9 сард Кибер аюулгүй байдлын 3 дахь стратеги төлөвлөгөөг батлан гаргасан байна. Үндсэн зарчим нь мэдээллийн чөлөөт урсгалын баталгаа, хуулийн засаглал, нээлттэй байдал, бие даасан байдал, олон талт хамтын ажиллагаатай байна гэж тусгажээ. Ирэх 3 жилд хэрэгжүүлэх стратегийн зорилго, чиглэл:

*1. Нийгэм эдийн засгийн тогтвортой хөгжлийг нэмэгдүүлэх:*

- Дижитал аюулгүй байдлын мэдлэгийг дээшлүүлэх;

*2. Аюулгүй байдал, дижитал нийгмийг ухамсарлах:*

- Нийгэм болон хувь хүнийг хамгаалах кибер аюулгүй байдлын орчныг бүрдүүлэх;
- Кибер халдлагад хариу өгөх бэлэн байдлыг хангах;

*3. Японы үндэсний аюулгүй байдлыг хангах:*

- Чөлөөт, шударга, аюулгүй цахим орон зайг хангах;
- Кибер аюулгүй байдлын хамгаалалт, урьдчилан сэргийлэх чадварыг бэхжүүлэх;
- Олон улсын хамтын ажиллагааны оролцоог дээшлүүлэх;
- Хүний нөөцийг бүрдүүлэх, хөгжүүлэх зорилгоор баталсан байна.

Интернэт орчинд үйл ажиллагаа явуулдаг GREE, CyberAgent, DeNA, Facebook Japan, Mixi, LINE, Twitter Japan зэрэг операторууд нэгдэн “Өсвөр үеийнхний интернет ашиглалтын орчныг сайжруулах зөвлөл”-ийг олон нийтийн сүлжээгээр дамжуулж хүүхдийг гэмтээх аливаа үйлдлээс урьдчилан сэргийлэх явдлыг сурталчлах зорилгоор 2017 онд байгуулсан. Зөвлөл нь хүүхдийн аюулгүй интернэт орчныг бүрдүүлэхээр мэдээлэл солилцох, судалгаа, боловсрол,

[204] Кибер гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын туршлага ба эрх зүйн орчин СТ-21/230

UIH.MN СУДАЛГААНЫ САН

соён гэгээрүүлэх үйл ажиллагаа явуулдаг. Тус зөвлөл нь цагдаагийн ерөнхий газартай хамтран ажилладаг байна. Цахим орчин дахь хүүхэд, залуучуудыг хамгаалах асуудлыг “Насанд хүрээгүй хүмүүсийн  интернэтийн аюулгүй орчныг бүрдүүлэх тухай хууль”, Насанд хүрээгүй хүмүүсийн аюулгүй интернэт хэрэглээг бий болгох үндсэн төлөвлөгөөг үндэслэн Дотоод хэргийн яам, Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан технологийн яам, холбогдох агентлагууд, Үндэсний цагдаагийн газар бусад төрийн болон хувийн байгууллагууд хамаарах бөгөөд тэдгээр нь интернэтийн аюулгүй хэрэглээний талаар сурталчлах ажлыг тогтмол зохион байгуулдаг.

***Насанд хүрээгүй хүмүүсийн интернетийн аюулгүй орчныг бүрдүүлэх тухай хууль(Act on Development of an Environment that Provides Safe and Secure Internet Use for Young People)[205]***

Тус хуулийг 2008 онд баталсан бөгөөд энэхүү хуулиар насанд хүрээгүй буюу 18 наснаас доош насны хүмүүст интернэтийг зохистой ашиглах чадварыг эзэмшүүлэх, шүүлтүүрийн тархалтыг дэмжих замаар насанд хүрээгүй хүмүүсийн хортой агуулга бүхий мэдээллийг үзэх боломжийг багасгах, иргэдэд интернэтийн зохистой хэрэглээг зохицуулах үүргийг ногдуулж, түүнийг төр засгаас дэмжих бодлогыг баримталсан. Мөн холбогдох засаг захиргаа, интернэттэй холбоотой бизнес эрхлэгчид, эцэг эхчүүд, асран хамгаалагчдад хүүхдийг хор хөнөөлтэй мэдээллээс хамгаалах арга хэмжээ авах (интернэтийн зохистой хэрэглээний талаар сурталчлах, боловсрол олгох, хүүхдийн хэрэглэж буй цахим төхөөрөмжид шүүлтүүр хэрэглэж буй эсэхэд хяналт тавих гм) үүрэг хариуцлагыг ногдуулах болсон байна.

Насанд хүрээгүй хүүхдийн асран хамгаалагч хортой мэдээллийг шүүгч үйлчилгээг ашиглахгүй гэсэн хүсэлт гаргаснаас бусад тохиолдолд цахим төхөөрөмж үйлдвэрлэгч, үйлчилгээ эрхлэгчдээс шүүгч програмыг ашиглахад хялбар байдлаар суурилуулж тухайн бүтээгдэхүүнийг борлуулах, үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй. Энэхүү үүргээ биелүүлээгүй тохиолдолд заавал биелүүлэхийг шаардах эрхтэй.

Хуульд зааснаар цахим орчин дахь хүүхдийн эрхийг хамгаалах бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг “Цахим орчинд насанд хүрээгүй хүмүүст аюулгүй мэдээллийн орчныг бүрдүүлэх хороо” хариуцахаар заасан байна.

Энэхүү хуулийн гол зорилго нь хүүхдэд сөргөөр нөлөөлөх мэдээллээс урьдчилан сэргийлэх, шүүгч програм хангамжийг өргөн нэвтрүүлэх боломжийг бий болгох, ингэснээр хүүхдүүдийг цахим гэмт хэргийн золиос болохоос урьдчилан сэргийлэх ач холбогдолтой юм.

**ФИНЛАНД УЛС**

Финланд улс нь сургуулийн орчин дахь хүүхдийн хүчирхийлэл, дээрэлхэлтийн түвшингээрээ харьцангуй багатай орны тоонд ордог. Түүнчлэн Олон улсын сургалтын чанарын үнэлгээний PISA байгууллагын үнэлгээгээр эхний 5-рт орж байна. Энэ нь тус орны сургалтын тогтолцоо, чанар, аюулгүй байдал, сурах таатай нөхцөл боломжоор сайн хангагдсан болохыг илэрхийлж байна.

Гэсэн хэдий ч хүүхэд залуучуудын 15 орчим хувь нь сургуульд байхдаа дээрэлхэлт, хүчирхийллийн янз бүрийн хэлбэрт өртдөг гэсэн ерөнхий статистик мэдээ байдаг. Тиймээс Финланд улс сургуулийн орчин дахь дээрэлхэлтийг сэтгэл эмзэглүүлсэн асуудал гэж үзсэн хэвээр байгаа ажээ.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[205] Act on Development of an Environment that Provides Safe and Secure Internet Use for Young People https://www8.cao.go.jp/youth/youth-harm/law/pdf/for_english.pdf

## I. Сургуулийн орчин дахь хүүхдийн хүчирхийлэл, дээрэлхэлтийн өнөөгийн нөхцөл байдал

Финландын Боловсролын үндэсний цөм хөтөлбөр (2014)-ийн зорилгод сурагчид үргэлж өөрийгөө болон бусдыг хүндэтгэн талархах ёсыг эрхэмлэсэн байдаг. Гэсэн хэдий ч ерөнхий боловсролын сургуулийн бүх ангиудад хүүхдүүд нэгнийгээ дээрэлхэх явдал гарсаар байна.

2019 оны “Сургуулийн эрүүл орчныг дэмжих судалгаа” (the 2019 School Health Promotion Study (THL))-ны[206] дүнгээс үзэхэд 4 ба 5 дугаар ангийн хүүхдүүдийн 7.2% нь долоо хоног тутамд дээрэлхэлтэд өртсөн байжээ. Харин 8 ба 9 дүгээр ангийн хүүхдүүдийн хувьд 5.5%-тай байсан байна. Нөгөө талд 4 ба 5 дугаар ангийн хүүхдүүдийн 2% нь бусдыг дээрэлхэхэд оролцсон бол 8 ба 9 дүгээр ангийн сурагчдын 3% нь долоо хоног тутам бусдыг дээрэлхэхэд оролцсон гэж мэдэгдсэн байна. Мөн судалгаагаар Финландад 2010 оноос хойш бусдад дээрэлхүүлсэн болон дээрэлхсэн сурагч, оюутнуудын тоо буурсан үзүүлэлтэй гарчээ.

Анхаарал татсан нэг асуудал бол хүүхэд, залуучууд дээрэлхэлт, хүчирхийлэл, дарамтлалд өртсөн тухайгаа насанд хүрэгчдэд хэлдэггүй явдал юм. 2019 оны “Сургуулийн эрүүл орчныг дэмжих судалгаа” (the 2019 School Health Promotion Study (THL))-ны дүнгээс үзэхэд 4 болон 5 дугаар ангийн сурагчдын 51.5%, 8 болон 9 дүгээр ангийн сурагчдын 43% нь сургуулийнхаа хэн нэгэн насанд хүрсэн хүнтэй энэ асуудлаар ярилцах боломжтой гэж үзсэн байдаг байна.[207]

Финландын сургуулийн орчин дахь дээрэлхэлтийн хамгийн түгээмэл хэлбэрүүд нь хэл амаар доромжилж дээрэлхэх, олон нийтийн өмнө гутаан доромжлох, зохион байгуулалттайгаар гадуурхах, хорлонтой цуу яриа тараах зэрэг байна. Биед халдан дээрэлхэх явдал бага сургуулийн орчинд дунд сургуулийн бага ангиудынхаас илүүтэй түгээмэл байна. Онлайн буюу цахим орчны дээрэлхэлтийн тухайд бол уламжлалт дээрэлхэлтийн хэлбэрүүдээс харьцангуй бага үзүүлэлтэй гарчээ. Цахимаар дээрэлхүүлдэг бараг бүх сурагчид дээрэлхэлтийн бусад хэлбэрт өртөж байсан байна.

Бэлгийн болон хүйсийн суурьтай дарамтыг дээрэлхэлтийн нэгэн хэлбэрийн илрэл гэж үздэг. Гэхдээ 2019 оны “Сургуулийн эрүүл орчныг дэмжих судалгаа” (the 2019 School Health Promotion Study (THL))-ны дүнгээс үзэхэд бэлгийн дарамт нь сургуулийн орчноос илүүтэй утас, цахим орчин гэх зэрэг олон нийтийн сүлжээнд түгээмэл байдаг байна. Уг судалгаагаар 8 ба 9 дүгээр ангийн сурагчдын 4% нь сургууль дээрээ бэлгийн дарамтад өртөж байжээ. Финландын Боловсролын Үндэсний Агентлагаас 2018 онд сургууль, боловсролын байгууллагууд дээрх бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох тухай гарын авлагыг боловсруулан гаргасан. Үүнд, боловсролын байгууллагуудад зориулсан зааварчилгаа, сургуулийн захирлууд, багш нар, сургуулийн бусад ажилтнууд, сурагч, оюутнууд ба асран хамгаалагч нарыг хүртэл хамруулсан байна.

Багш нар ч гэсэн сурагч, оюутнуудтайгаа зохисгүй харьцах асуудал байх талтай. Финландын боловсролын үнэлгээний төвөөс гаргасан үнэлгээгээр (Julin & Rumpu 2018) суурь боловсролын сургуулийн 3 дугаар ангийн сурагчдын 3% орчим хувь, 8 дугаар ангийн сурагчдын 16.2% нь багш нарын дээрэлхэлт, дарамтлалтанд удаа дараа өртөж байсан гэсэн үр дүн гарчээ. (Julin & Rumpu 2018.)

## II. Сургуулийн орчин дахь хүүхдийн хүчирхийлэл, дээрэлхэлтэй холбогдох хуулийн зохицуулалтууд

Дээрэлхэлтийг тодорхойлбол энэ нь дахин давтагдах шинжтэй үйлдэл бөгөөд дээрэлхэж байгаа болон дээрэлхүүлж байгаа хоёрын хоорондох тэнцвэргүй байдал юм. Дээрэлхэлт нь байнга давтагддаг шинжээрээ аливаа бусад халдлага түрэмгийллээс ялгаатай ажээ.

[206] https://scandinavianlaw.se/pdf/61-11.pdf
[207] Мөн тэнд

ҮИХ.MN СУДАЛГААНЫ САН

Дээрэлхэлт гэх энэхүү маш өвөрмөц сэтгэл зүй, олон төрлийн таагүй үйлдлээс бүрдсэн байнга давтагдах үйлдлээс асар их хор хохирол үүдэн гарч байна. Гэтэл дээрэлхэлт гэдэг нь өнөөдөр хууль, эрх зүйн үүднээс төдий л сайн тодорхойлогдоогүй байсаар байгаа юм.

*а)* ***Боловсролын хуулийн зохицуулалт***

Финландад суурь боловсролыг 7-17 насанд, ахлах сургуулийн боловсролыг 18-19 насанд олгодог байна. Суурь боловсролын үйл ажиллагааг зохицуулж буй **Суурь боловсролын хууль** (Basic education act 628/1998)[208]-д сургуулийн орчин дахь хүүхдийн аюулгүй суралцах нөхцөл, сургалтын таатай орчныг бүрдүүлэх талаар дараах байдлаар зохицуулсан байна. Тухайлбал,

**29-р зүйл. Аюулгүй орчинд суралцах эрх**

1. Боловсролд хамрагдаж буй сурагч аюулгүй орчинд суралцах эрхтэй.
2. Боловсролын байгууллага нь сурагчдыг хүчирхийлэл, дээрэлхэх, дарамтлахаас хамгаалах төлөвлөгөөг сургалтын хөтөлбөртэйгөө уялдуулан гаргаж, төлөвлөгөөний биелэлт, хэрэгжилтэд хяналт тавина. Боловсролын үндэсний зөвлөл нь төлөвлөгөө боловсруулахтай холбоотой журмыг гаргаж, сургалтын цөм хөтөлбөртэй нь нийцүүлнэ.
3. Боловсролын байгууллага нь сургуулийн дотоод дэг журам, суралцагчдын сэтгэл ханамж, суралцах таатай нөхцөлийг бүрдүүлэх, сургуулийн хамт олны аюулгүй байдлыг хангах зорилгоор бусад журмын зохицуулалтыг боловсруулан батална.
4. Гуравдугаар дэд хэсэгт дурдсан сургуулийн дүрэм болон бусад журмын зохицуулалтууд нь сургуулийн аюулгүй байдал, сэтгэл ханамжийг хангахад шаардлагатай бүх практик нөхцөл бүрэлдүүлж, зохистой зан үйлийг тогтооно. Сургуулийн эд хөрөнгөтэй харьцах, сургуулийн байр болон сургуулийн орчинд хэрхэн явах, суух зэрэгтэй холбоотой журмыг ч мөн боловсруулан баталж болно.

Мөн Финландын Засгийн газраас Суурь боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан зохицуулалтуудыг хангаагүй тохиолдолд аль ч сургуулийн тусгай зөвшөөрлийг нь цуцлах боломжтой.

Харин **Ерөнхий бүрэн дунд боловсролын тухай хууль** (Act on General Upper Secondary Education (714/2018)) [209] -д ерөнхий боловсролын ахлах сургуулийн сурагчдын үүрэг, хариуцлагыг зохицуулсан ба тус хуулийн 30 дугаар зүйлд суралцагч нь бусдыг дээрэлхэх, дарамтлах, хамт олны таагүй байдал үүсгэхгүйгээр биеэ зөв боловсон авч явах, мөн бусдын дээрэлхэх, бусад сурагчдйн эрүүл, аюулгүй орчныг эрсдэлд оруулах үйлдлээс зайлсхийх үүрэгтэй гэж заасан байна. Хуулийн 40 дүгээр зүйлд суралцагчид нь эрүүл, аюулгүй сургалтын орчинд суралцах эрхтэй ба боловсролын байгууллага нь сурагчдыг дээрэлхэх, хүчирхийлэл, дарамтаас хамгаалах ёстой бөгөөд үүнийг хэрэгжүүлэхийн тулд Боловсролын цөм хөтөлбөртэй уялдуулан төлөвлөгөө боловсруулж, дүрэм журам, зааварчилгааг гарган мөрдүүлэх үүрэгтэй байна.

**Дээрэлхэлтийг таслан зогсоох арга хэмжээний талаарх зохицуулалт**[210]

Суурь болон дунд боловсролын тухай хуулиудад зааснаар Финландад бусдыг дээрэлхсэн хүүхдийг ихэнхдээ донгодох, дээд тал нь хоёр цаг саатуулах эсхүл бичгээр сануулга өгөх арга хэмжээг авна. Энэ үндсэн дээр тухайн сурагчид хамгийн ихдээ гурван сарын хугацаатай сануулга өгч болно. Аюулгүй байдлын хувьд нэлээн эрсдэлтэй нөхцөлд хичээл тасалдуулсан сурагчийг тухайн ангиас эсхүл тухайн ангийн хичээлийн өөр бусад танхимаас хөөн гаргах, эсхүл бүр сургуулийн үйл ажиллагааг орхин явахыг тушааж болно. Мөн тухайн сурагчийг тэр

[208] Суурь боловсролын тухай хууль 628/1998 https://www.finlex.fi/en/laki/kaannokset/1998/en19980628.pdf
[209] https://www.finlex.fi/fi/laki/kaannokset/2018/en20180714.pdf
[210] https://www.finlex.fi/en/laki/kaannokset/1998/en19980628.pdf

UIH.MN СУДАЛГААНЫ САН

өдрийн бүх хичээлд суухыг хориглож болно.[211] Үүнээс гадна, гомдолтой холбоотой бичиг баримтуудад дээрэлхсэн болон дээрэлхүүлсэн сурагчдын аль аль нь сурагчдыг хамгаалах үйлчилгээнд хамрагдах эрхтэй болохыг заасан байдаг. Мөн дээрэлхэлт зогссоны дараа ч тэд сургуулийн эмч эсхүл сэтгэл зүйчид үнэ төлбөргүй үзүүлэн тусламж авах эрхтэй.

Финландын Суурь боловсролын тухай хуульд дээрэлхэлтийн тохиолдлуудад хэрэглэж болох заалтууд байдаг ч практик амьдрал дээр түүнийг төдийлөн хэрэглэдэггүй байна. Тухайлбал: “Боловсролын үйл ажиллагааг зохицуулахтай холбоотой тодорхой шалтгаанаар орон нутгийн захиргаа нь боловсрол эзэмших газрыг нь хичээл заах хэлийг нь өөрчлөлгүйгээр сольж болно” (6.2 §) гэж заасан байдаг. Үүнээс үзэхэд сурагчийг сургууль дотор нь өөр ангид шилжүүлэх нь хууль ёсны арга хэмжээ байдаг байна. Энэ нь дээрэлхэлтэд өртсөн сурагчийн хувьд үр дүнтэй арга зам гэж судлаачид үздэг байна.

Мөн сургууль руу явах замд гарсан дээрэлхэлтийн тохиолдлуудад таслан зогсоох арга хэмжээг авах үүргийн талаар тус хуульд одоогоор сургуулийн багш ажилтнууд сургууль дээр гарсан аливаа дээрэлхэлтийн талаар дээрэлхэгч болон хохирогчийн эцэг эх буюу асран хамгаалагчдад нь мэдэгдэх ёстой гэж дурдсанаас хэтрэхгүй байна. Энэ нь Финландын сургуулиуд нь сургууль дээр болсон асуудалд сахилга батын арга хэмжээ авч болох ч сургууль руу явах замд тохиолдсон дээрэлхэлтийн хэрэгт тус арга хэмжээг авч болохгүй гэсэн үг юм. Иймээс хичээлийн цагаас гадуур болсон дээрэлхэлтийн талаар өөр бусад алба, захиргаадад хандах ёстой болдог байна.

***б) Бусад хуулийн зохицуулалтын талаар***[212]

Олон улсын түвшинд авч үзвэл Финланд нь сургуулийн орчин дахь дээрэлхэлтийн үзүүлэлтээр муу биш боловч дээрэлхэлт нь тулгамдсан асуудал хэвээр байсаар байна гэж судлаачид тэмдэглэсэн байна.

Финландын Vaasa их сургуулийн профессор Нина Мэнтиля сургуулийн орчин дахь дээрэлхэлтийг таслан зогсоож шийдвэрлэх хууль эрх зүйн боломжийг судалсан байна. Тэрээр сургуулийн сурагчдын ихэнх нь 15-аас доош насныхан бөгөөд тэдгээрт биеэ зөв авч явахад нь насанд хүрэгчдийн хараа хяналт зайлшгүй шаардлагатай. Тиймээс дээрэлхэлтийн ихэнх тохиолдлоос урьдчилан сэргийлж, таслан зогсоох үр дүнтэй системийг бий болгон, хэрэгжүүлэх нь насанд хүрэгчдийн үүрэг юм хэмээн тодорхойлсон байна. Иймд сургуулийн түвшинд сурагчдын аюулгүй сурч боловсрох орчныг бий болгох талаар үр дүнтэй сайн ажиллах хэрэгтэй гэсэн байна.

Финландын нутгийн захиргаад нь (боловсрол олгогч) боловсролын үйл ажиллагаанд чухал үүрэгтэй оролцдог. Бүс нутгийн төрийн удирдлагын агентлагууд боловсролын салбарын хүрээнд сурагчдын эрхийг хамгаалж, хуулийн зохицуулалтуудаар хангах хэдий ч эцэг эхчүүд эсхүл хүүхэд өөрөө бичгээр гомдол гаргаснаар асуудлыг авч үздэг. Гомдол гаргагчийн зүгээс сургуулийн багш ажилтнууд эсхүл нийтийн эрх ашгийг хамгаалахаар томилогдсон хотын зарим эрх мэдэлтнүүдийг хууль бусаар шийдвэрлэсэн, эсхүл үүрэг хариуцлагаа биелүүлээгүй гэж үзвэл Финландын парламентын омбудсмэн ба Засгийн газрын Шүүхийн канцлерын аль аль нь өргөдөл гомдлын дагуу шалгах ажлыг хийж болно. Финландад насанд хүрээгүй хүмүүсийн дээрэлхэлтэд Иргэний эрхийн зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээлгэх боломжтой байдаг.

- Иргэний эрхийн зөрчлийн хариуцлага

Суурь болон дунд боловсролын тухай хуулиудад сургуулийн захиргааг иргэний эрхийн зөрчлийн хариуцлагатай холбосон ямар нэгэн зохицуулалт байдаггүй ч **Финландын Үндсэн**

[211] Суурь боловсролын тухай хууль, 36 дугаар зүйл (Basic Education act, 36§)
[212] https://scandinavianlaw.se/pdf/61-11.pdf

**хууль** (731/1999) ба **Иргэний эрхийн зөрчлийн тухай хууль** (412/1974)-д төрийн албан хаагчдын иргэний эрхийг зөрчсөн хариуцлага хүлээлгэх зохицуулалт бий. Финландын практикт, иргэний эрхийн зөрчлийн хариуцлагыг дам байдлаар боловсролын үйл ажиллагааг зохион байгуулагчид ногдуулна. Хэн нэгэн багш эсхүл захирал дангаараа хуулийн иймхариуцлага хүлээдэггүй.

Нөхөн төлбөр нэхэмжилж болох хохиролд тухайн хохирогч гэмтсэн (бие болоод ёс суртахууны хувьд), эд хөрөнгө сүйдсэн, ба бусад эдийн засгийн алдагдлууд орно. Дээрэлхэлттэй холбон авч үзвэл, ийм хохирлын жишээнд, дээрэлхэлтийн улмаас шалгалтаа муу дүнтэй өгч суурь боловсролоос дээд шатанд дэвшин суралцах боломжоо алдсан хохирлыг дурдаж болно. Иргэний эрхийг зөрчсөн хариуцлага нь тухайн нэг дээрэлхэлтэд өртсөн хүүхдэд учирсан үндсэн хохирол, хор нөлөө нь тогтоогдон батлагдсан тохиолдолд ногдуулж болох хариуцлага юм.

- Эрүүгийн хариуцлага

Финландад эрүүгийн хариуцлага хүлээх нас нь 15-аас эхэлдэг тул ихэнх сурагчдад үйлдсэн хэрэгт нь эрүүгийн хариуцлага ногдуулах боломжгүй байдаг. Гэвч энэ нь бусдыг дээрэлхсэн хүүхэд хариуцлага хүлээхгүй гэсэн үг биш юм. Тиймээс хариуцлага багш нар, захирал эсхүл орон нутгийн захиргаа руу шилжиж байна. Хотын түвшний боловсролын алба, сургуулийн захирал ба ихэнх багш нар нь төрийн албан хаагчид байдаг ба, тэднийг дээрэлхэлт болон эрүүгийн хариуцлагатай холбогдуулан (*албан үүргээ биелүүлээгүй, эсхүл цалгардуулсан гэх зэргээр*) шийтгэх боломжтой байдаг.

Финландын Эрүүгийн хуулийн 40 дүгээр бүлгийн 9-р хэсэгт зааснаар төрийн албан тушаалтан нь албан үүргээ гүйцэтгэхдээ баримтлах дүрэм журмыг мөрдөөгүйн улмаас гэмт хэрэг үйлдсэн, түүнээс үүдэн гарсан хор уршиг, үр дагавар нь их бол торгох эсвэл нэг жилээс дээш хугацаагаар хорих ял ногдуулна. Мөн албан үүргээ санаатай болон хайхрамжгүйгээс биелүүлээгүй, цалгардуулсан бол ажлаас нь огцруулах, торгох шийтгэл ногдуулахаар заажээ.

Финландын Захиргааны хуульд шүүхийн мөрдөн шалгах ажлын зарчмыг тухайн нэг хэргийг шаардлагатай бүх талаас нь шалгаж тогтоох үүрэгтэй гэж заасан байна. Жишээлэхэд, дээрэлхэлтэд өртсөн хохирогч дээрэлхүүлсэн тухайгаа үгүйсгэж болох ба энэ тохиолдолд орон нутгийн захиргаа тухайн асуудлыг хохирогчийн тусламжгүйгээр (*Финландын сургуулиуд нэргүй асуулгын аргыг хэрэглэж хэн нь хохирогч, хэн нь дээрэлхэгч болохыг тогтоодог*) шалган тогтоох үүрэг хүлээнэ.

Финландын ялгаварлан гадуурхалт болон түүнд авах арга хэмжээний талаарх сүүлийн үеийн дэвшил нь Европын Холбооны хууль тогтоомжид суурилж байна.

Финландын сургуулийн орчин дахь дээрэлхэлтийн эрх зүйн зохицуулалтыг тоймлон авч үзвэл, “Боловсролын хуулийн зохицуулалтуудад хүүхдийн ашиг сонирхлын талаар огт дурдагдаагүй, зөвхөн “хамтын гэрээ”-г хүчин төгөлдөр гэж үзэж байна. Гэтэл хамтын гэрээний талаар ихэнх шийдвэр гаргагчид сайн мэдэхгүй бөгөөд практик амьдрал дээрх хууль зүйн үр дагавар багатай зүйл тул асуудлыг шийдвэрлэх хамгийн сайн арга зам биш юм. Мөн Эрүүгийн хууль нь дээрэлхэлтэд өртсөн хохирогч хүүхдүүдийг хамгаалах чадамжгүй байна. Эрүүгийн хуулийн талаас, Финландын сургуулийн захиргаа болон боловсрол олгогч (өөрөөр хэлбэл, орон нутгийн захиргаа)-ийн хоорондох үүрэг хариуцлагын хуваарилалт маш тодорхойгүй байдаг нь хэргийг шийдвэрлэхэд ихээхэн бэрхшээлтэй болгодог. Иргэний эрхийн зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээлгэх, хохирлыг нөхөн барагдуулах системийг боловсронгуй болгох нь илүү бодитой шийдэл юм. Дээрэлхэлттэй холбоотой хууль тогтоомж ихэвчлэн өргөдөл гомдол барагдуулах албаныхны тайлбарт бичигдсэн байдаг ба гэмт үйлдлээс урьдчилан сэргийлэх талаар ямар нэгэн зохицуулалт байхгүй байгаа зэрэг нь практик нөхцөл байдалд хууль эрх зүйн зохицуулалт сургуулийн орчин дахь дээрэлхэлтийг таслан зогсооход

хангалтгүй байна” гэж дүгнэхэд хүргэсэн байна.[213] Сургуулийн орчин дахь дээрэлхэлтийн асуудлыг хууль тогтоомжийн өөрчлөлтөөр (өөрөөр хэлбэл, сургуулиудыг дээрэлхэлтийн эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөгөө боловсруулах үүрэгтэй болгох) эсвэл сургуулийн ажилтнуудыг дээрэлхэлттэй таарсан даруйдаа таслан зогсоож байх үүрэгтэй болгосноор бүрэн шийдвэрлэгдэхгүй болох нь практикаас тодорхой болсон учир дээрэлхэлтийг бууруулахад хүүхэд, анги танхим, бүхэл сургуулийн түвшинд системтэй, тасралтгүй хүчин чармайлт гаргаж ажиллах нь дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэхэд илүү үр дүнтэй гэж үзэн Финландын Боловсролын яамнаас тусгай хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх болжээ.

**СИНГАПУР**

Сингапур Улсад хүүхдийн эрх, эрх чөлөө, хүүхэд хамгаалал, хүүхдийг хүчирхийллээс сэргийлэх асуудлыг НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Конвенц (The UN Convention on the Rights of the Child), Боловсролын хууль (Education Act), Хүүхэд, өсвөр насныхны тухай хууль (Children and Young Person’s Act), Дарамт, хүчирхийллээс хамгаалах тухай хууль (Protection from Harrassment Act), Эрүүгийн хууль (Penal Code) болон холбогдох бусад хууль, дүрэм, журмуудаар зохицуулж байна. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт хүүхдийн хүчирхийллийн эсрэг хичээл хөтөлбөрүүдийг багтаан, улс орон даяар хүүхдийн хүчирхийллийн эсрэг аянуудыг хэрэгжүүлэн ажилладаг байна. Түүнчлэн Хүүхэд хамгаалах Үндэсний Стандарт (National Standards for Protection of Children)-ыг боловсруулан хүүхдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүчирхийллийг таслан зогсоох, хүчирхийллээс үүдэн гарах хор хохирлыг арилгах, үүнд төрийн болон төрийн бус, олон нийтийн байгууллагуудын үүрэг оролцоо, эцэг эх, асран хамгаалагч, багш сурган хүмүүжүүлэгчдийн гүйцэтгэх үүрэг хариуцлагыг тодорхойлсон байна. Сингапурын Хүүхдийн Нийгэмлэг (Singapore Children’s Society)-ээс “Дээрэлхэлтээс ангид хөтөлбөр” (Bully-Free programme)-ийг улс орон даяар хэрэгжүүлдэг ажээ.

**I. Өнөөгийн байдал, туршлага**

2012 оноос хойш бага болон дунд сургуулиудад бүртгэгдсэн зөрчлийн тоо тогтмол буурсаар ирсэн бөгөөд 2020 оны судалгаагаар бага сургуулийн сурагчдын 1000 хүүхэд тутамд 2 зөрчил, дунд сургуулийн 1000 хүүхэд тутамд 5 зөрчил бүртгэгдсэн байна.[214] Дээрэлхэх зөрчлийн тоо тогтмол буурсаар ирсэн үзүүлэлттэй байгаа ч нүднээс далд, цахимаар үйлдэгдэх, хохирогч дээрэлхүүлснээ нуун дарагдуулах байдал нь дээрэлхэлттэй тэмцэхэд илүү ярвигтай болгож байна.

Боловсролын яамнаас бага, дунд, их, дээд буюу нийт сургууль, сурган хүмүүжүүлэх байгууллагын удирдлага, багш, сурган хүмүүжүүлэгчид, ажилтнууд, эцэг эх, сурагч оюутнуудад сургуулийн орчныг дээрэлхэлт, гадуурхалтаас ангид байлгах, түүнээс урьдчилан сэргийлэх, дээрэлхэлт, түүний хор хохирол, түүний эсрэг авах хариу арга хэмжээ зэргийг сурталчлан таниулах зорилгоор сургуулийн дүрэм боловсруулахад баримтлах гарын авлагыг боловсруулан, сургуулиудад удирдамж болгодог байна. Тус гарын авлагад сахилга батын жижиг зөрчлөөс авахуулаад том хэмжээний зөрчлүүдийг (Minor and Major offences) жагсаасан байдаг байна. Сургууль тус бүр энэхүү гарын авлага, удирдамжид тулгуурлан, өөрийн сургуулийн онцлогт нийцүүлэн “Сургуулийн дүрэм”-ээ боловсруулах бөгөөд дүрэмд зөрчил, түүний эсрэг хэрэгжүүлэх арга хэмжээ зэргийг багтаасан байна. Хэрэв сурагчийн үйлдсэн зөрчил нь сургуулийн дүрмээс давсан тохиолдолд холбогдох хуулиар зохицуулна.

Боловсролын яамнаас сургууль, сурган хүмүүжүүлэх байгууллагын үйл ажиллагааг дэмжих үүднээс 3 чиглэлд анхаарч ажиллахаар шийдвэрлэжээ. Үүнд:

[213] https://scandinavianlaw.se/pdf/61-11.pdf
[214] https://www.moe.gov.sg/news/parliamentary-replies/20210104-bullying-cases-in-schools

UIH.MN СУДАЛГААНЫ САН

- Шинэчлэн боловсруулсан Зан төлөв, иргэний боловсролын хичээлээр сурагчдыг сургуулийн орчинд төдийгүй цахимаар нэг нэгэнтэйгээ эелдэг, бусад хүмүүстэй, эелдэг дөлгөөн харилцах, халамж анхаарал тавьж сурахад анхаарна.
- Сургуулийн сурагчдад үе тэнгийнхнээ дэмжих соёлыг бий болгоно. Ингэснээр дээрэлхэлт нь буруу зүйл болохыг ойлгуулж, дээрэлхүүлж хохирсон хүүхдүүдэд хэрхэн тусалж дэмжих талаар энэ хүрээнд зааж сургана.
- Боловсролын яамнаас сургуулийн анги танхимд эерэг хандлагыг төлөвшүүлэх, дээрэлхэх зөрчлийг судлах, шийдвэрлэх, эцэг эх, олон нийттэй хамтран өсвөр насныхныг сурган хүмүүжүүлэхэд сургууль, боловсролын байгууллагын чадавхыг нэмэгдүүлнэ.

Сургуулийн удирдлага, багш сурган хүмүүжүүлэгчид, ажилтнууд бүгд сургуулийн орчинд сахилга бат сахиулах үйл ажилагаанд хяналт тавьж ажиллах бөгөөд хичээл сургалтаар дамжуулан дээрэлхэлтийн талаар мэдлэг, мэдээлэл олгох, урьдчилан сэргийлэх, дээрэлхэх, хүчирхийлэх аливаа хэргийг олж илрүүлэх, таслан зогсоох олон төрлийн үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байна. Зан төлөв, иргэний боловсрол (Character and Citizenship Education) хичээлээр сурагчид нэг нэгнээ хүндлэх, өрөвдөх хайрлахын ач холбогдлыг заалгадаг. Аюулгүй цахим орчин (Cyber Wellness) хичээлээр цахим орчинд өөрийгөө хэрхэн хамгаалах арга хэрэгслүүд болон цахим дээрэлхэлт, цахим хүчирхийллийн талаар интернет үйлчилгээ үзүүлэгчид мэдээлэх нь зүйтэй зэрэг дээрэлхэлтийн эсрэг хариу арга хэмжээнд суралцдаг байна. Түүнчлэн хүүхдүүдийг дээрэлхэлт, хүчирхийллийн хажуугаар дуугай өнгөрөхгүй, нэг нэгэндээ анхаарал хандуулах, аливаа зөрчлийг эсэргүүцэх, зөрчлийн талаар мэдээлж байхыг сургадаг ажээ. Сурагчдад сургуулийн дүрэм, сахилга батын талаар тогтмол, тодорхой танилцуулга хийгддэг байна. Багш, сурган хүмүүжүүлэгч нь хүүхэдтэй өдөр бүр харилцаж, ажилладагийн хувьд тухайн сурагчид дээрэлхэлтээс үүдэн гарч буй өөрчлөлтийг анзаарч илрүүлэх нь зүйтэй байна. Ингэхийн тулд Үндэсний Боловсролын Хүрээлэн (National Institute of Education)-ээс бэлтгэгдэн гарч буй багш нарын нэн тэргүүнд эзэмшсэн байх шаардлагатай ур чадварт анги танхимд эерэг нааштай зан төлвийг төлөвшүүлэх, ангийн сурагчдыг зөв зүйтэй зохион байгуулах ордог байна. Боловсролын яамнаас болон сургуулиас, Сингапурын Хүүхдийн Нийгэмлэгээс зохион байгуулдаг энэ төрлийн сургалтуудад багш нарыг давтан хамруулдаг байна. Хүүхдүүд нэгнийгээ дээрэлхсэн талаар мэдээлсэн тохиолдолд тухайн асуудлаар бэлтгэгдсэн сургуулийн ажилтан нь дээрэлхүүлсэн сурагчид зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэхийн сацуу дээрэлхсэн сурагчид тохирох сахилгын шийтгэлийн талаар сургуулийн удирдлагуудтай хэлэлцэж, шийдвэрлэдэг. Сурагчид болсон явдлаас сургамж авч, дээрэлхсэн болон дээрэлхүүлсэн сурагчдыг эвлэрүүлэх, зөрчил гаргагч этгээдийг хүмүүжүүлэх, хохирсон хүүхэдтэй харилцах харилцааг хэвийн болгох сургалт, хүмүүжлийн тохирсон үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байна. Хохирогч хүүхдүүдэд зөвлөгөө өгөх, халамж дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг мөн хэрэгжүүлдэг ажээ. Сургуулийн орчинд дээрэлхэх зөрчлийг арилгахад гэр бүлүүдийн тусламж дэмжлэг, хамтын ажиллагаа нэн чухал байна. Эцэг эхчүүдэд мөн адил зан төлвийн зөв зүйтэй хандлага суулгахыг зорьж, хүүхэдтэйгээ ижил үнэт зүйлээ тодорхойлоход нь дэмжлэг үзүүлдэг. Ингэснээр дээрэлхэлт, хүчирхийллийн хор хохирлыг бага дээр нь арилгах, эцэг эх, сургуулийн удирдлага, холбогдох бусад хүмүүстэй хамтран хохирогч хүүхэд болон зөрчил гаргаж буй хүүхдийг аль алиныг нь аврах боломжтой байна. Хүүхэд болон иргэд, олон нийт гомдол гаргах, тодорхой асуудал шийдүүлэх шаардлагатай тохиолдолд төрийн байгууллага болгоны утсыг мэдэж байх шаардлагагүй бөгөөд засгийн газрын бүх агентлагууд нэгдсэн системд холбогдсон байдаг тул хүүхэд төрийн ямар ч байгууллагад ямар ч асуудлаар гомдол мэдүүлсэн тохиолдолд тухайн асуудлыг хариуцсан байгууллага, холбогдох ажилтанд уламжлан, асуудлыг шийдвэрлэдэг ажээ. Мөн хүүхдийн эрхийг хамгаалах төрийн бус, олон нийтийн, сайн дурын байгууллагууд хүүхдийн гомдлыг хүлээн авах, хүүхдэд тулгарсан аливаа асуудлыг шийдвэрлэх зорилгоор тусламжийн

UIH.MN СУДАЛГААНЫ САН

утсыг ажиллуулах бөгөөд эдгээр утас, холбогдох чатуудыг сургууль дээр болон олон нийтэд ил, тодоор хэвлэн байршуулдаг байна.

**II. Сургуулийн орчин дахь дээрэлхэлтийн талаарх хуулийн зохицуулалт**

Сургуулийн орчинд үйлдэгдсэн гэмт үйлдэл-дээрэлхэлтийг зохицуулсан тусгайлсан хууль байхгүй хэдий ч дээрэлхэлтээс үүдсэн хор хохирлыг төрөл зүйлээс нь хамааран (тухайлбал, бие махбодын болон сэтгэл санааны гэмтэл учруулсан, эд хөрөнгийн хохирол үзүүлсэн зэрэгт) холбогдох хуулиар зохицуулж байна. Гэхдээ 12-оос доош насны хүүхдийн хувьд өөрийн үйлдсэн гэмт үйлдлийн хор хохирлыг бүрэн гүйцэд ухаарахгүй гэж үзэн гэмт хэрэгт тооцохгүй бөгөөд хуулиар шийтгэхгүй. Харин өсвөр насныхны хувьд буюу 16-21 настай бол гэмт хэргийн хүнд, хөнгөн зэргээс хамааран нийгэмд тустай хөдөлмөр эрхлүүлэхээс эхлээд тэнсэн харгалзах шийтгэл оноох, хорих ялаар шийтгэх хүртэл шийтгэл ногдуулдаг байна.

**Боловсролын хуулийн зохицуулалт**[215]

Тус хуулиар сургуулийн орчинд үйлдэгдэж буй дээрэлхэлт, хүчирхийллийн талаар тодорхой зохицуулалт байхгүй хэдий ч сургуулийн удирдлагын зүгээс сурагч, оюутнуудын сахилга батыг хэн, хэрхэн хариуцан сахиулах талаар дараах байдлаар зохицуулжээ.

*XIII хэсэг. Дүрэм журам, зөрчил, мэдэгдэл, нөхөн төлбөр*

*Дүрэм журам*

61.(1) Сайд нь сургуулийн үйл ажиллагааг үр дүнтэй байлгахтай холбоотой бүхий л асуудлаар болон тус хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой дүрэм, журмуудыг боловсруулан мөрдүүлж ажиллана. Үүнд:

(б) сургууль дээр сахилга бат, дэг журмыг мөрдүүлэх арга зам, аргачлалын талаар.

**Боловсролын (Сургуулийн) журам (Education (Schools) regulations)**[216]

*XIII хэсэг. Сахилга бат*

*Сахилга батыг хариуцан сахиулах ажилтан (Principal)*

83. Ерөнхий боловсролын бага болон дунд сургуулийн захирал нь тухайн сургуулийнхаа сурагчдын сургуулийн орчинд болон сургуулиас гадуур биеэ авч яваа байдал, сахилга батыг хариуцна.

*Сургуулийн хяналтын ажилтан (Supervisor)*

84. Ерөнхий боловсролын сургуулийн Хяналтын ажилтан нь Захирлын хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн аливаа дэг журам сахиулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

**Сурагчид эмх замбараагүй байдал гарган, хорлон сүйтгэх үйл ажиллагаанд оролцсон тохиолдолд сургуулиас чөлөөлөх тухай**

87. Сурагчид хууль бус, сахилгын алдаа гаргах, сургуулийн дүрэм, журмыг баримтлахаас татгалзах зэрэг тохиолдлуудад биеэр эдлүүлэх шийтгэл (corporal punishment) (зөвхөн эрэгтэй сурагчдад) ногдуулах болон сургуулиас хөөх хүртэл арга хэмжээ авна.

**Хүүхэд, өсвөр насныхны тухай хуулийн зохицуулалт**[217]

Тус хуулиар бага болон өсвөр насны хүүхдийг аливаа гэмт үйлдэлд өртөх, гэмт үйлдлийн золиос болохоос сэргийлэх, хамгаалах, анхаарал халамж тавих, шаардлагатай тохиолдолд эмчлэх, түүнчлэн санаатай болон санамсаргүйгээр гэмт үйлдэлд холбогдсон, эцэг эхийн хараа

[215] https://sso.agc.gov.sg/Act/EA1957?WholeDoc=1
[216] https://sso.agc.gov.sg/SL/EA1957-RG1?DocDate=20130731&ValidDate=20130731&WholeDoc=1
[217] https://sso.agc.gov.sg/Act/CYPA1993

UIH.MN СУДАЛГААНЫ САН

хяналтаас гадуурх хүүхэд, өсвөр насны хүүхдийг засан хүмүүжүүлэх, шаардлагатай тохиолдолд эмчлэх зэрэг үйл ажиллагааг зохицуулна. Энэ хуулиар гэр бүл, эцэг эхийн зүгээс хүлээх үүрэг хариуцлага болон төрийн байгууллагын зүгээс хүлээх үүрэг хариуцлагыг тодорхой заасан байна. 1949 онд тус хууль батлагдсанаас хойш хэд хэдэн удаагийн нэмэлт өөрчлөлт хийгдсэн бөгөөд 2001 онд гадуурхагдсан, үл ойшоогдсон, хүчирхийлэлд өртсөн, ядууралд өртсөн болон асрах газар, хоргодох байранд байрлаж буй хүүхдүүд, өсвөр настнуудад тавих анхаарал, халамжийг нэмэгдүүлэх талаар нэмэлтийг оруулсан байна. Мөн сэтгэл санааны болон сэтгэл зүйн дарамт үзүүлэх, дээрэлхэх, доромжлох нь хүчирхийллийн хэлбэр болохыг тодорхой заан, 2001 онд оруулсан нэмэлт өөрчлөлт нь 3 үндсэн зорилгод чиглэсэн байна:

- Хүчирхийлэлд өртсөн, гадуурхагдсан, үл ойшоогдсон хүүхдийн эрх ашгийг хамгаалах;
- Гэмт хэрэг, гэмт үйлдэл үйлдсэн өсвөр насныхныг засан хүмүүжүүлэх, эргээд тэднийг эрүүл, аюулгүй, хэвийн амьдралд оруулах, нийгэмшүүлэх үйл ажиллагааг сайжруулах;
- Гэр бүлүүдэд эцэг эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, олон нийтийн дэмжлэгийг нэмэгдүүлэх зэрэг болно.

**ТАЙВАНЬ (БНХАУ)**

Тайвань нь 23 сая гаруй хүн амтай бөгөөд хэдийгээр Тайванийг БНХАУ нь өөрийн муж гэж үздэг[218] хэдий ч 1996 оноос хойш ардчилсан зарчмаар буюу сонгуулийн үр дүнгээр Засгийн газраа байгуулж ирсэн де-факто тусгаар тогтносон улс юм.

**I.Боловсролын бодлого, эрх зүйн зохицуулалт**

Тайванийн боловсролын системд бага сургуульд 6 жил, дунд сургуульд 3 жил, ахлах сургуульд 3 жил, бакалаврын хөтөлбөрт 4 жил, магистр болон докторын зэрэгт 2-7 жил, нийт 20 хүртэл жил суралцах боломжтой. Үүнээс бага болон дунд боловсролыг заавал эзэмших боловсролд хамруулдаг байна.

Тайванийн боловсролын бодлогын асуудлыг Боловсролын яам[219] нь хариуцдаг. Тус яам нь боловсролын яамны тухай хууль[220] (Organization Act of the Ministry of Education)-ийн дагуу үйл ажиллагаа явуулдаг.

Тайваньд боловсролын салбарын хууль эрх зүйн орчинг Үндсэн хууль, Боловсролын суурь хууль, Бага, дунд сургуулийн тухай хууль, Заавал эзэмших боловсролын тухай хууль, Ахлах сургуулийн боловсролын тухай хууль, Нэмэлт боловсролын тухай хууль, Техникийн болон мэргэжлийн боловсролын тухай хууль, Багшийн боловсролын тухай хууль, Тусгай боловсролын тухай хууль, Уугуул иргэдийн боловсролын тухай хууль, Хүйсийн тэгш боловсролын тухай хууль, Нийгмийн боловсролын тухай хууль, Байгалийн боловсролын тухай хууль, Урлагийн боловсролын тухай хууль, Гэр бүлийн боловсролын тухай хууль, Цагдаагийн боловсролын тухай хууль, Хүүхдийн хүмүүжлийн сургууль байгуулах, боловсролын хэрэгжилтийг хангах тухай хууль, Ахлах сургуульд хамтын боловсролыг хэрэгжүүлэх, сурагчдын эрхийг хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжууд бүрдүүлж байна.

**II.ЕБС-ын тогтолцоо, зохион байгуулалт**

Тайвань нь ЕБС-ийн асуудлыг Боловсролын суурь хууль, Бага, дунд сургуулийн тухай хууль, Заавал эзэмших боловсролын тухай хууль, Ахлах сургуулийн боловсролын тухай хууль зэрэг хуулиар тус тус зохицуулж байна. Үүнд:

[218] https://wenr.wes.org/2016/06/education-in-taiwan Тайваний боловсрол, WES судалгааны сэтгүүл, 2016.06.07
[219] https://english.moe.gov.tw/mp-1.html Тайваний боловсролын яам
[220] https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=H0000001 Боловсролын яамны тухай хууль, сүүлд өөрчлөлт орсон, 2021.05.26

UILI.MN СУДАЛГААНЫ САН

*Боловсролын суурь хууль (Educational Fundamental Act)*[221]

Энэ хууль нь 17 зүйлтэй бөгөөд 1999 оны 06 сарын 23-нд батлагдаж, хамгийн сүүлд 2013 оны 12 сарын 11-нд нэмэлт, өөрчлөлт оржээ. Тус хуулиар хүмүүсийн сурч боловсрох эрх, суурь боловсролыг эзэмшүүлэх зохион байгуулалт, тогтолцоо зэргийг тусгаж өгчээ.

*Бага, дунд сургуулийн тухай хууль (Primary and Junior High School Act)*[222]

Энэ хууль нь 22 зүйлтэй бөгөөд 1979 оны 05 сарын 23 нд батлагдаж, хамгийн сүүлд 2016 оны 06 сарын 01-нд нэмэлт, өөрчлөлт оржээ. Тус хууль БНХАУ-ын Үндсэн хуулийн 158 дугаар зүйлд заасан бага, дунд сургулуийн боловсрол нь иргэдийн ёс суртахуун, танин мэдэхүй, бие бялдар, нийгэм, гоо зүйн хөгжилд чиглэх зорилгыг биелүүлэх зорилготой байна. Бага боловсрол нь 6 жил, дунд боловсрол нь 3 жил байдаг бөгөөд энэ боловсролын заавал эзэмшүүлэх боловсролд хамааруулдаг байна.

*Заавал эзэмших боловсролын тухай хууль (Compulsory Education Act)*[223]

Энэ хууль нь 17 зүйлтэй бөгөөд 1944 оны 07 сарын 18 нд батлагдаж, хамгийн сүүлд 2019 оны 04 сарын 17-нд нэмэлт, өөрчлөлт оржээ. Тус хууль "Бага, дунд сургуулийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2-т заасан буюу сургуулийн насны иргэд (6-15 насны иргэн)-д заавал боловсрол олгох асуудлыг зохицуулж өгчээ.

*Ахлах сургуулийн боловсролын тухай хууль (Senior High School Education Act)*[224]

Энэ хууль нь 67 зүйлтэй бөгөөд 2013 оны 07 сарын 10 нд батлагдаж, хамгийн сүүлд 2021 оны 05 сарын 26-нд нэмэлт, өөрчлөлт оржээ. Тус хууль нь бага, дунд сургуулийн 9 жилийн боловсролын үргэлжлэл буюу ахлах сургуулийн боловсролын асуудлыг шийдвэрлэх бөгөөд сурагчдын оюун ухаан, бие бялдрын чадавхыг хөгжүүлэх, эрдмийн судалгаа, мэргэжлийн ур чадварын үндэс, суурийг тавих, чанартай иргэнийг төлөвшүүлэхэд чиглэдэг байна.

**III.ЕБС-ийн хүүхэд хамгаалал, ёс зүйн дүрэм, журам**

Тайвань нь ЕБС-ийн хүүхэд хамгаалал, ёс зүйн зөрчил, дүрэм, журмын асуудлыг Хүйсийн тэгш боловсролын тухай хууль болон Хүүхэд залуучуудын эрх ашгийг хамгаалах тухай хуулийн хүрээнд шийдвэрлэж байна. Харин нэгдсэн байдлаар ЕБС-ийн ёс зүйн загвар дүрэм одоохондоо байхгүй бөгөөд сургуулиуд хууль, тогтоомжийн хүрээнд өөрдсийн ёс зүйн дүрмийг батлан мөрдүүлдэг байна. Жишээ болгож Мельбурн дахь Тайванийн сургуулийн Хүүхдийн аюулгүй байдлын ёс зүйн дүрмийг судалгаанд авч үзэв.

**Хүйсийн тэгш боловсролын тухай хууль (Gender Equity Education Act)**[225]

Энэ хууль нь 38 зүйлтэй бөгөөд 2004 оны 06 сарын 23-нд батлагдаж, хамгийн сүүлд 2018 оны 12 сарын 28-нд нэмэлт, өөрчлөлт оржээ. Тус хууль нь жендэрийн тэгш байдлыг хангах, жендэрийн ялгаварлан гадуурхалтыг арилгах, хүний нэр төрийг хамгаалах, жендэрийн тэгш байдлыг хангасан боловсролын нөөц, орчныг бүрдүүлэх зорилготой байна. Хуульд сургуулийн орчин дахь бэлгийн хүчирхийлэл, бэлгийн дарамт, урьдчилан сэргийлэх болон хариуцлагын асуудлыг дараах байдлаар зохицуулжээ. Үүнд:

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[221] https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=H0020045 Боловсролын суурь хууль, сүүлд өөрчлөлт орсон, 2013.12.11
[222] https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=H0070001 Бага, дунд сургуулийн тухай хууль, сүүлд өөрчлөлт орсон, 2016.06.01
[223] https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=H0070002 Заавал эзэмших боловсролын тухай хууль, сүүлд өөрчлөлт орсон, 2019.04.17
[224] https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=H0060043 Ахлах сургуулийн боловсролын тухай хууль, сүүлд өөрчлөлт орсон, 2021.05.26
[225] https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=H0080067 Хүйсийн тэгш боловсролын тухай хууль, сүүлд өөрчлөлт орсон, 2018.12.28

*4 дүгээр бүлэг. Сургуулийн орчин дахь бэлгийн хүчирхийлэл ба бэлгийн дарамт, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх /20-27 дугаар зүйл/*

Эрх бүхий төв байгууллага нь сургуулийн орчин дахь бэлгийн хүчирхийлэл, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, зохицуулах журмыг боловсруулах, мөн эдгээр журамд сургуулийн орчны аюулгүй байдлын төлөвлөгөө, сургуулийн орчин доторх болон сургуулийн орчноос гадуурх зааварчилгаа, хүмүүс хоорондын харилцааны заавар, сургуулийн орчин дахь бэлгийн хүчирхийлэл, бэлгийн дарамт, бэлгийн дарамттай холбоотой аливаа тохиолдлыг шийдвэрлэх механизм, журам, түүнээс урьдчилан сэргийлэх аргуудыг тусгажээ.

*6 дугаар бүлэг. Эрүүгийн хариуцлага /36 дугаар зүйл/*

Аливаа төрлийн бэлгийн дарамт, хүчирхийллийг мэдээлээгүй багш, сургуулийн удирдлага, сургуулийн ажилтныг 30.000-150.000 Тайвань доллараар, мөн дээрх гэмт хэрэг гарах нөхцөл байдлыг бий болгосон, нуун дарагдуулсан тохиолдолд тухайн байгууллагыг 10.000-150.000 Тайвань доллароор тус тус торгодог байна.

**Хүүхэд, залуучуудын эрх ашгийг хамгаалах тухай хууль (The Protection of Children and Youths Welfare and Rights Act)[226]**

Энэ хууль 2003 оны 05 сарын 28 нд батлагдсан 118 зүйлтэй бөгөөд хамгийн сүүлд 2021оны 01 сарын 20-нд нэмэлт, өөрчлөлт оржээ. Тус хууль хүүхэд өсвөр үеийнхний бие, оюун санааны эрүүл мэндийг дэмжих, тэдний ашиг сонирхлыг хамгаалах, сайн сайхан байдлыг хөгжүүлэх зорилготой байна. Энэ хуульд хүүхэд, залуучууд гэж 12-18 настай, насанд хүрээгүй хүмүүсийг хамааруулж байна. Мөн эцэг эх, асран хамгаалагч нь хүүхэд, залуучуудын хамгаалал, хүмүүжлийн асуудлыг хариуцах бол эрх бүхий байгууллага болон хүүхэд хамгааллын байгууллагууд тус хуульд заасан арга хэмжээг авч ажиллахаар заажээ.

*3 дугаар бүлэг. Нийгмийн халамжийн арга хэмжээ /23-42 дугаар зүйл/*

Энэ бүлэгт төр захиргааны төв байгууллага хүүхэд залуучуудыг хамгаалах нэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлж, хувийн салбартай хэрхэн хамтарч ажиллах талаар тусгаж өгчээ.

- Хөгжлийн хоцрогдолтой хүүхдүүдийг эрт мэдээлэх тогтолцоо ба эрт үеийн тусламж үйлчилгээ;
- Хүүхэд харах үйлчилгээ;
- Хүүхэд, залуучууд, тэдний гэр бүлд зөвлөх үйлчилгээ;
- Хүүхэд залуучууд, тэдний эцэг эхчүүдэд эцэг эхийн боловсрол олгох үйлчилгээ;
- Амьжиргааны боломжгүй сургуульд сурч буй хүүхдүүдийг дэмжих үйлчилгээ;
- Ховор өвчтэй хүүхэд, хүнд өвчтэй хүүхэд, хөгжлийн хоцрогдолтой хүүхдийн эмчилгээний зардлыг төлөх үйлчилгээ;
- Сургууль завсардсан, тэнэмэл хүүхдүүдийг асрах үйлчилгээ;
- Сургуулиас гадуурх орчинд хүүхдийг харах үйлчилгээ;
- Хүүхэд, залуучуудын аюулгүй байдал, ослын гэмтлээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, мэдээлэл өгөх, сургах үйлчилгээ;
- Хүүхэд залуучууд, тэдний гэр бүлд халамжийн бусад үйлчилгээ… гэх мэт үйлчилгээг үзүүлдэг байна.

*4 дүгээр бүлэг. Хамгаалалтын арга хэмжээ /43-74 дүгээр зүйл/*

Энэ бүлэгт хүүхэд, залуучуудын хийж болохгүй зүйлсийг болон хүүхэд, залуучуудад хийж болохгүй зүйлсийг жагсаан оруулжээ.

[226] https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=D0050001 Хүүхэд, залуучуудын эрх ашгийг хамгаалах тухай хууль, сүүлд өөрчлөлт орсон, 2021.01.20

UIH.MN СУДАЛГААНЫ САН

*5 дугаар бүлэг. Халамжийн байгууллагууд /75-85 дугаар зүйл/*

Халамжийн байгууллагуудыг ...

1. Хүүхэд асрах төв
2. Эрт илрүүлэх байгууллагууд
3. Дээд боловсролын байгууллагууд
4. Сэтгэл зүйн болон гэр бүлийн зөвлөгөө өгөх байгууллага
5. Хүүхэд, залуучуудын халамжийн бусад байгууллагууд ... зэргээр ангилдаг байна.

Эдгээр байгууллагын цар хүрээ, бүтэц, орон тоо, зохион байгуулалтыг энэ чиглэлийг хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас тогтоож өгдөг байна.

*6 дугаар бүлэг. Хариуцлага, шийтгэл /86-109 дүгээр зүйл/*

Зөрчсөн үйл ажиллагаа, төрлөөсөө шалтгаалаад мөнгөн торгууль оногдуулдаг байна.

## БҮЛЭГ II. СУРГУУЛИЙН ОРЧИН ДАХЬ ХҮҮХЭД ХАМГААЛАЛ, ЁС ЗҮЙН ЗӨРЧЛИЙН ЭСРЭГ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААРХ БУСАД ОРНУУДЫН ПРАКТИК ТУРШЛАГА

Олон улсын болон судалгаанд хамрагдсан улс орнуудын хувьд сургуулийн орчин дахь хүчирхийлэл, дээрэлхэлтийн эсрэг практикт хэрэгжүүлж буй хариу арга хэмжээ болон аргачилсан зөвлөмжийг энэ бүлэгт нэгтгэн тусгалаа.

### 2.1 ХҮҮХДИЙГ ДЭЭРЭЛХЭЛТЭЭС ХАМГААЛАХ ТУХАЙ НҮБ-ЫН ЕРӨНХИЙ АССАМБЛЕЙН 2016, 2018 ОНЫ ТАЙЛАНГИЙН ЗӨВЛӨМЖ:

- Хүүхдийн эрхийг хамгаалах, сургуулийн хүчирхийлэл, дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах бодлогыг дэмжих хууль тогтоомжийг батлах;
- Үнэн зөв, найдвартай, ангилсан мэдээллийн хүртээмжийг сайжруулж, үндэслэлтэй судалгаанд тулгуурласан нотолгоонд суурилсан санаачилгыг хэрэгжүүлэх;
- Сургуулийн хүчирхийлэл, дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авахад багш нарыг сургаж, дэмжих;
- Сурагчид, багш нар, сургуулийн бусад ажилтнууд, эцэг эх, орон нутгийн засаг захиргаа зэрэг өргөн хүрээний олон нийтийг татан оролцуулж бүх сургуульд хандлагыг сурталчлах;
- Хүүхдэд үг хэлэх, дэмжлэг туслалцаа хайх боломжийг олгохын тулд тэдэнд мэдээллийн болон туслалцаа үзүүлэх;
- Сургуулийн хүчирхийлэл, дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үйлсэд хүүхдүүдийн утга учиртай оролцоог дэмжих;
- Арьсны өнгө, үндэс угсаа, хөгжлийн бэрхшээл, хүйс, бэлгийн чиг баримжаа зэргээс шалтгаалан онцгой эмзэг бүлгийн хүүхдүүдэд давуу эрх олгох;
- Хүүхдэд ээлтэй, жендэрийн мэдрэмжтэй мэдээлэл, гомдол, зөвлөгөө өгөх механизм, сэргээн засах арга барилыг бий болгох.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

## 2.2 БУСАД ОРНУУДЫН СУРГУУЛИИН ОРЧИН ДАХЬ ХҮЧИРХИИЛЭЛ, ДЭЭРЭЛХЭЛТИИН ЭСРЭГ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ПРАКТИК ТУРШЛАГА

### БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС

**Сургуулийн орчин дахь хүчирхийлэл, дээрэлхэлтийн эсрэг авч буй арга хэмжээ, туршлага**

*Эрүүл мэндийн яам*

- Сургуулийн орчин дахь хүчирхийллийн хохирогчдыг эмчлэх;
- Хохирогчийг хамгаалах байгууллага ажиллуулах;
- Сургуулийн орчин дахь хүчирхийллээс урьдчилан сэргийлэх тусгай хөтөлбөр боловсруулахад хамтран ажиллах

*Гэр бүл, жендерийн эрх тэгш байдлын яам*

- Хохирогчид зөвлөгөө өгөх;
- Хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх;
- Хохирогчид сэтгэл заслын эмчилгээ үзүүлэх төвүүдийг хариуцан ажилладаг.

*Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны харьяа Хүүхэд хамгааллын Үндэсний газар (National Center for the Rights of the Child)* [227]

- Хүүхдийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх тал дээр салбар хоорондын уялдааг бий болгох;
- Хүчирхийллийн эсрэг хөтөлбөр боловсруулах, хэрэгжилтийг үнэлэх;
- Хүүхдийн хүчирхийллийн талаарх нэгдсэн мэдээллийн санг удирдах, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн, тайланг нийтэд мэдээлэх;
- Хүчирхийлэл хайхрамжгүй байдлын эсрэг арга хэмжээг олон нийтэд сурталчлах;
- Хүүхэд хамгааллын шуурхай утас 102 ажиллуулах;
- Хүүхэд хамгааллын олон аргаар хүүхдийн эрхийг дэмжин нягт хамтран ажиллаж байна.

**WEE төсөл (We, Education, Emotion)**[228]

2008 онд Боловсролын яамнаас сургуулийн орчинд дээрэлхэлт түүний сөрөг үр дагаврыг таслан зогсоох зорилгоор WEE төслийг оношилгоо, зөвлөгөө, эмчилгээ гэсэн 3 үе шаттайгаар авч хэрэгжүүлэхээр санаачлан ажиллаж байна.




*Оношилгоо*-анхан шатны нэгж болох анги бүлэгт сургуулийн хүчирхийлэлд өртсөн, цахим орчинд донтсон, сахилгын шийтгэл хүлээсэн сурагчдыг илрүүлж ганцаарчилсан зөвлөгөө өгөх, бүлгийн зөвлөгөө өгөх, сэтгэл зүйн эмчилгээний төрөл бүрийн хөтөлбөрийг хэрэгжүүлдэг байна.

*Зөвлөгөө*- орон нутгийн боловсролын газрууд нэгдэж тусгай зөвлөгөө өгөх төвд мэргэжлийн сэтгэл зүйч, шинжээч зөвлөх, эмнэлгийн ажилтан, нийгмийн халамжийн ажилтнуудаас бүрдсэн

[227] National Center for the Rights of the Child http://korea1391.go.kr/new/page/eng/welcoming.php
[228] Wee project file:///Users/uurtsaikh/Desktop/9._Analyzing_the_effectiveness_of_the_Korean_National_anti-bullying_program(Cho).pdf

багийг ажиллуулан хохирсон сурагчдад зөвлөгөө өгөх, сургуулийн хүчирхийлэл үйлдсэн сурагчтай уулзаж нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулдаг.

*Эмчилгээ*-мэргэжлийн байгууллагуудтай хамтран урт хугацааны сэтгэл зүйн эмчилгээ болон шаардлагатай эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлдэг.

**Солонгосын үе тэнгийнхний санал асуулга (Korean-Peer Nomination Inventory)[229]**

Энэхүү санал асуулгыг Солонгос Улсад сургуулийн орчин дахь дээрэлхэлтийг илрүүлэхэд ашигладаг. Уг санал асуулга нь хүүхдүүдийн нийгэмд дасан зохицох чадваргүй байдлыг шалгах ажлын нэг хэсэг болдог бөгөөд үе тэнгийнхний дунд ил болон далд хэлбэрийн гадуурхалтыг илрүүлэх зорилгоор үе тэнгийнхний санал асуулгад суурилсан байна. Хүүхдүүд санал асуулгыг бөглөхдөө сэдэв тус бүр дэх зан төрхийн тодорхойлолтод нийцэх ижил хүйсийн сурагчдын нэрсийг дурдах боломжтойн зэрэгцээ сэдэв тус бүр дээр хэд хэдэн сурагчийн нэрийг дурдахыг зөвшөөрдөг. Үе тэнгийнхний санал асуулгын дундаж оноо нь өгөгдсөн категорт нэр дурдагдсан сурагчдыг илрүүлэх төдийгүй гадуурхалтын өнгө аясыг тодорхойлдог.

**Бид ч бас нэгдэж байна хөдөлгөөн (Me too)**

Me too хөдөлгөөн нь олон нийтийн мэдээллийн хэрэгслээр санал асуулга явуулах хэлбэрээр сургуулийн орчинд үе тэнгийнхэндээ дээрэлхүүлсэн болон сургуулийн хүчирхийллийн талаар мэдээллийг ил тод болгох хөдөлгөөн зохион байгуулсан. Уг хөдөлгөөнийг өрнүүлсээр урлаг спортын олон одуудын өсвөр насандаа үйлдсэн үе тэнгийнхнийгээ дээрэлхэх явдлууд ил болсон.

## ЯПОН УЛС

**Дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний үндсэн чиглэл, авах арга хэмжээ**

*<u>Дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх засгийн газрын үндсэн чиглэл</u>*

- Дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх үндэсний бодлогын удирдамж боловсруулах;
- Дээрэлхэлтийн эсрэг хуулийн хэрэгжилтийг шалгах (Дээрэлхэлтийн эсрэг зөвлөлийг байгуулах);
- Дээрэлхэлттэй холбоотой ноцтой нөхцөл байдлын үед хяналт, шалгалт явуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор мэргэжлийн холбоодтой хамтран ажиллах нөхцөл бүрдүүлэх;
- Дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх зорилготойгоор хүүхдийн оюун санааг төлөвшүүлэх, бие даасан үйл ажиллагааг дэмжих, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хариуцан явуулах боловсон хүчнийг бэлдэх, тэдний чанарыг сайжруулах, судалгаа явуулах, энэ талаар олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх, мэдээлэл түгээх;
- Эрт илрүүлэх зорилгоор боловсролын системд энэ талаар зөвлөгөө өгөх байдлыг сайжруулах, орон нутгийн иргэд, гэр бүлийн хамтын ажиллагааг дэмжих;
- Дээрэлхэлтээс сэргийлэх арга хэмжээг салбар бүрийн хүний нөөцийг ашиглах замаар дэмжлэг үзүүлэх, интернэт ашиглан дээрэлхэх явдалд хариу үйлдэл үзүүлэх;
- Багш нарт хүүхдүүдтэй тулж ажиллах хангалттай цаг гаргах боломжтой тогтолцоог хөгжүүлэх.

*<u>Орон нутгийн хэмжээнд дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх үндсэн чиглэл</u>*

- Орон нутгийн хэмжээнд дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх үндсэн бодлогыг боловсруулах;

[229] Korean-Peer Nomination Inventory https://jamanetwork.com/journals/jamapediatrics/fullarticle/485789



UIH.MN СУДАЛГААНЫ САН

- Бүс нутгийн нөхцөл байдалтай уялдуулан, холбогдох гишүүдээс бүрдсэн дээрэлхэлтийн эсрэг авах арга хэмжээний зөвлөл байгуулах;
- Бүс нутгийн нөхцөл байдалд тохируулан дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх бодлогыг хэрэгжүүлэх салбар байгууллагыг боловсролыг тогтолцоонд суулгах;
- Ийм салбар байгууллагын шударга, төвийг сахисан байдлыг хангах;
- Энэ талаар тусгай мэдлэг, туршлагатай гуравдагч этгээдийн оролцоог хангах;
- Орон нутаг дахь багш нарыг үнэлэхдээ дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх оролдлогыг тооцож үнэлэх.

*Сургуулийн хэмжээнд дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх үндсэн чиглэл*

- Сургуулийн хэмжээнд дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх үндэсний санаачилгад нийцүүлэн хэрэгжүүлэх арга хэмжээг нарийвчлан боловсруулах;
- Сургуульд дээрэлхэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, зохион байгуулалттай хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг тогтмол хариуцан гүйцэтгэдэг байгууллагыг бий болгож ажиллуулах;
- Уг байгууллагад зохих мэргэжилтнүүдийн (хуульч, эмч, цагдаа гэх мэт) оролцоотойгоор дээрэлхэлттэй холбоотой хэргийг шийдвэрлэх;
- Сурагчдад тохиолдож буй дээрэлхэх гэмт хэргээс болж илэрч буй шинж тэмдгийг илрүүлж, сэжиглэн зөвлөгөө өгөх үүргийг зөвхөн багш, сургуулийн ажилчдад тохолгүй зохих арга хэмжээг хариуцагч байгууллагатай хамтран зохион байгуулалттайгаар авах;
- Сургуульд дээрэлхэлтийн эсрэг арга хэмжээг авахдаа 1.Дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх; 2. Эрт илрүүлэх; 3. Дээрэлхэхийн эсрэг арга хэмжээ авах гэсэн гурван үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

**Дээрэлхэлттэй холбоотой ноцтой нөхцөл байдал үүссэн үед үзүүлэх хариу арга хэмжээ**

- Сургуулийн захиргаа болон холбогдох байгууллага дээрэлхэлттэй холбоотой ноцтой нөхцөл байдал үүссэн үед мөрдөн байцаах үйл ажиллагааг хариуцна.
- Амиа хорлохыг завдах гэх мэт сурагчийн амь нас, сэтгэц, бие махбод, эд хөрөнгөд дээрэлхэх гэмт хэргийн улмаас ноцтой хохирол учруулсан гэх сэжигтэй тохиолдолд мөрдөн байцаана.
- Жилд 30-аас дээш хоног хичээлдээ ирээгүй, дээрэлхэлтээс болж хичээлдээ ирээгүй гэсэн сэжигтэй бол мөрдөн байцаалтыг яаралтай эхлүүлэх;
- Сурагч өөрөө болон түүний асран хамгаалагчаас дээрэлхэлтээс болж ноцтой нөхцөл байдал үүссэн гэсэн гомдол гарсан тохиолдолд сургуулийн захиргаа энэ талаар мэдээлж, мөрдөн байцаах ажиллагааг эхлүүлэх ёстой.

*Дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой онцлог ойлголт*

- Хүүхдийг бэлгийн ба хүйсийн чиг баримжаагаар нь дээрэлхэхээс урьдчилан сэргийлэхийн тулд сургуулийн багш, ажилтнуудад зөв ойлголтыг бий болгож, энэ талаар сургуулиас авах арга хэмжээг сурталчлах ёстой.
- Зүүн Японы их газар хөдлөлтийн улмаас хохирол амссан сурагчдын сэтгэц, бие махбодод үзүүлэх нөлөөлөл, танил бус орчинд үүсэх сэтгэлийн түгшүүрийг сургуулийн багш, ажилчид бүрэн ойлгож, тэдэнд зохих тусламж, үйлчилгээг үзүүлэх, мөн тийм сурагчдыг дээрэлхэх явдлаас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тал дээр анхаарч, ажиллах ёстой.
- Сургууль бүрд тусгай хэрэгцээт сурагчдын онцлогт тохирсон дэмжлэгийг тогтмол үзүүлж, асран хамгаалагчидтай хамтран ажиллах замаар дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах ёстой.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

- Багш, ажилчид хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголтоо гүнзгийрүүлж, боловсролыг дэмжих төлөвлөгөөний дагуу хувь хүний хэрэгцээ, онцлогт тохируулан шаардлагатай дэмжлэгийг үзүүлэх шаардлагатай.
- Хилийн чанадаас буцаж ирсэн, гадаадын харьяат, Японы иргэн бус асран хамгаалагчтай, гадаад улстай холбоотой хүүхдүүд, сурагчид хэл, соёлын ялгаатай байдлаас шалтгаалан сургуульд сурахад хүндрэлтэй байдгийн дээр тийм ялгаатай байдлаас болж дээрэлхэх явдал үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор тийм хүүхдийг анхааралтай ажиглаж, бүх талаар шаардлагатай дэмжлэгийг санал болгох хэрэгтэй.

**ФИНЛАНД УЛС**

**Сургуулийн орчин дахь хүүхэд хамгаалал, дээрэлхэлтийн эсрэг авч буй арга хэмжээ, туршлага**

Финляндын Боловсролын хуулиудад заасны дагуу боловсрол олгогч байгууллагууд нь сурагчдын аюулгүй орчин нөхцөлд суралцах эрхийг хангах үүднээс өөрийн сургалтын хөтөлбөртэй уялдуулан сурагчдыг хүчирхийлэл, дээрэлхэлт, дарамтлалтаас хамгаалах төлөвлөгөөг гарган, түүнийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах үүрэгтэй. Тэрхүү төлөвлөгөө нь хот тус бүрт харилцан адилгүй ялгаатай байхыг зөвшөөрөх болович Финляндын бүх суурь боловсролын сургуулийн 90% гаруй хувь нь KiVa Сургуулийн дээрэлхэлтийн эсрэг хөтөлбөрийг хэрэгжүүлдэг байна.

**KiVa дээрэлхэхийн эсрэг хөтөлбөр**[230]

Финляндын Боловсролын яам нь 2006 онд Турку их сургуультай суурь боловсролын сургуулиудад (Финляндын боловсролын системд 1-9 ангийг суурь боловсрол гэж үзнэ) зориулсан дээрэлхэхийн эсрэг хөтөлбөрийг боловсруулах, тус хөтөлбөрийн эхэн үеийн үнэлгээг гаргах гурван жилийн гэрээг байгуулжээ. Хөтөлбөрийг боловсруулахдаа анхнаас нь улс орон даяар хэрэгжүүлэх алсын хараатай зорилт тавьж, өргөн хүрээнд боловсруулахыг зорьсон байна.

Тус хөтөлбөрийг Турку их сургуулийн Сэтгэл судлалын тэнхим, Суралцахуйн судалгааны төвүүд хамтран боловсруулжээ. Төсөлд сэтгэл судлал, боловсрол, социологи, статистик зэрэг хэд хэдэн салбарын мэргэжилтнүүд оролцон ажиллажээ.[231] Хөтөлбөр нь Финляндын ерөнхий боловсролын сургуулиудад 2009 оноос албан ёсоор хэрэгжиж эхэлсэн бөгөөд 2017 он гэхэд Финляндын ерөнхий боловсролын сургуулиудын 50 гаруй хувь нь (1400 сургууль, түүний дотор 300000 орчим сурагч) хөтөлбөрт хамрагдсан байна. Одоогоор дотоодын боловсролын байгууллагуудын 90 гаруй хувь, гадаад улс орнуудад тухайлбал, Европын 10 гаруй оронд албан ёсоор амжилттай хэрэгжиж байна. Мөн хөтөлбөр нь англи, герман, франц, япон зэрэг хэд хэдэн хэлээр орчуулагджээ.

KiVa хөтөлбөрийн гол зорилго нь үе тэнгийнхний дээрэлхэх гэмт үйлдлээс урьдчилан сэргийлэхэд сургуулиудад туслах, сургуулийн ажилтнуудыг үүнд оролцож таслан зогсоох үр дүнтэй стратегиар хангах, улмаар сургуулийн аюулгүй, суралцах таатай орчныг нэмэгдүүлэхэд оршиж байгаа юм.

Хөтөлбөрийн агуулга нь бүхэлдээ анги хамт олны дунд биеэ хэрхэн авч явах, бусадтай хэрхэн харилцах, зан харилцаа, бусдыг хүндэтгэх, ёс суртахууны асуудлыг хамардаг бөгөөд үүнийг 1, 4, 7-р ангиудад насны онцлогт нь тохируулан дахин давтан тогтмол хичээлээр заадаг байна. Мөн дээрэлхэх явдалтай тулгарвал үүнийг хэрхэн даван туулах, шийдвэрлэх арга замын

[230] https://eucpn.org/document/kiva-koulu-kiva-anti-bullying-program
[231] GP_ECPA_2009_FI_KiVaKoulu-3.pdf

UIH.MN СУДАЛГААНЫ САН

талаар тусгайлан анхаарч үздэг. Харин дээрэлхэлтийн ноцтой тохиолдлуудыг таслан зогсоох арга хэмжээг тухайн сургуульд ажилладаг гурван насанд хүрэгчдээс бүрдсэн сургуулийн KiVa багийнхан авч хэрэгжүүлэг байна.

Хөтөлбөр нь хичээлээс гадна дээрэлхэлтийн хохирогч болон дээрэлхсэн хүүхдүүдтэй фокус ярилцлага хийх, сургалт зохион байгуулах, хөтөлбөрийн сургагч багш бэлтгэх, тэдэнд зориулсан гарын авлага, хичээлийн удирдамж боловсруулах, эцэг, эх, багш сурагчдад зориулсан товхимол гаргах, хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх онлайн сургалт зохион байгуулах, KiVa эрдэм шинжилгээний хурлыг жилд хоёр удаа зохион байгуулах, хэрэгжилтийг улам бүр сайжруулах зөвлөмж саналыг хүргүүлэх, хэрэгжилтэд тогтмол хяналт тавих зэрэг ажлуудыг хэрэгжүүлдэг байна. Үүнээс гадна жил бүр KiVa хөтөлбөрийг хэрэгжүүлэгч оны шилдэг сургуулийг шалгаруулдаг болжээ.

Хөтөлбөрийг боловсруулсан Турку сургуулийн багийнхан KiVa хөтөлбөр нь онол, практикийн суурь сайтай тул Финландаас өөр бусад газруудад ч хэрэглэх боломжтой юм гэж дүгнэжээ.[232]

Мөн Хууль зүйн яамны дэмжлэгээр байгуулагдсан Гэмт хэргийн хохирогчийг дэмжих төв нь веб сайтдаа сургуулийн дээрэлхэлтэнд өртсөн хүүхдүүд, тэдний эцэг эх, төрөл садан, ойр дотны хүмүүс, хэн бүхэнд тусламж, зөвлөгөө мэдээлэл өгөх зорилгоор RIKU чат онлайн үйлчилгээ нэвтрүүлсэн. Чат нь ажлын өдрүүдэд 9-15 цаг, Даваа гаригт 17:00-19:00 цагийн хооронд нээлттэй байдаг.[233]

**СИНГАПУР УЛС**

**Дээрэлхэлтээс ангид хөтөлбөр[234]**

Сингапурын Хүүхдийн Нийгэмлэгээс *“Дээрэлхэлтээс ангид хөтөлбөр*”-ийг улс орон даяар хэрэгжүүлдэг байна. Хөтөлбөрийн гол зорилго нь хүүхэд, багачуудад дээрэлхэлт гэж юу болох, түүнээс хэрхэн сэргийлэх, дээрэлхэлтийн эсрэг хүүхэд багачууд, эцэг эх, сургууль хамтдаа хэрхэн тэмцэх талаарх мэдээллийг сургуулийн өмнөх насныхан, бага, дунд, ахлах сургуулийн сурагчид, эцэг эхчүүд, багш сурган хүмүүжүүлэгчдийг хамруулан, товч тодорхой, сонирхолтой байдлаар хүргэдэг ажээ. Хөтөлбөр нь олон тооны дэд хөтөлбөрүүдээс бүрдэх бөгөөд цахим болон танхимын уулзалт ярилцлага, сургуулийн орчинд болон сургуулиас гадуур зэрэг төрөл бүрийн арга хэмжээгээр зохион байгуулагддаг байна. Үүнд:

- Цахим уулзалт ярилцлагууд;
- Эцэг эхчүүдэд зориулсан Ctrl+Alt+Delete Цахим дээрэлхэлт;
- Дээрэлхэлтэнд “Баяртай гэж хэлцгээе”;
- “Delete” Цахим хүчирхийллийг устгая;
- “Дээрэлхэлтээс ангид байцгаая” хүүхэд багачуудын уулзалт аялал;
- Багш нарын сургалт зэрэг хөтөлбөрүүд багтдаг байна.

Эдгээр хөтөлбөрийн хүрээнд Хүүхдийн нийгэмлэгээс эрхлэн гаргадаг “Buzz” сэтгүүлээр дээрэлхэлтийн эсрэг мэдээллийг хүүхэд багачуудад зориулан товч, ойлгомжтой байдлаар цахим болон цаасан хэлбэрээр хэвлэн түгээдэг ажээ.[235]

***Сургуулийн дүрэм***

Сургууль бүр Боловсролын яамнаас батлан гаргасан удирдамжийн дагуу өөрийн сургуулийн онцлогт тохируулан дотооддоо мөрдөх дүрмээ боловсруулна. Сахилга баттай, үр дүнтэй сургуулийн орчинг бүрдүүлэх нь сурагчдад үнэт зүйлээ мэдэж авах болон асуудал шийдвэрлэх

[232] http://www.kivaprogram.net/
[233] https://www.riku.fi/en/guides-and-instructions/what-to-do-in-school-bullying-situations/
[234] https://bullyfree.sg/programmes/
[235] https://bullyfree.sg/wp-content/uploads/2019/03/TF_mar2019_v4_compressed.pdf

UIH.MN СУДАЛГААНЫ САН

бэрхшээлийг даван туулах нийгмийн болон сэтгэл зүйн ур чадварыг суралцахад туслана. Ингэхийн тулд:

- Сургууль болон гэр бүлд хүүхэд багачуудад аюулгүй, халамжтай, дэмжлэг үзүүлэх орчныг бий болгох;
- Багш, сурган хүмүүжүүлэгчид нийгмийн болон сургуулийн үнэт зүйлсийг сурагч, оюутнуудад зааж сургах, сайн зан чанарыг эзэмших, түүнийгээ бататгах боломж, нөхцөлийг нь сурагчдад бүрдүүлж өгөх, өөрийн зан чанараа удирдахад нь зааж чиглүүлэх;
- Сурагчид харилцан бие биендээ тусалж дэмжин, эерэг нөлөө үзүүлж байх;
- Эцэг эх, олон нийт болон бусад оролцогч талууд сурагчдын сурч боловсроход тусалж дэмжин, сургуулиудтай хамтарч ажиллах шаардлагатай байна.

Дүрмийг Сургуулийн дүрэм (School rules), Сахилгын дүрэм (Discipline policy), Ёс зүйн дүрэм (Code of Conduct) гэж янз бүрээр нэрлэж байна. Дүрэмд дараах асуудлуудыг багтаана. Үүнд:

Сурагчийн эрх, үүрэг:
- Улс, үндэстнээ болон сургуулиа хүндэтгэх;
- Багш, ажилтнуудыг хүндэтгэх;
- Цаг баримтлах, ирц бүрэн байх;
- Сургууль дотор, анги танхимд биеэ зөв боловсон авч явах;
- Сургуулийн дүрэмт хувцас өмсөх;
- Сахилгын зөрчил гаргахгүй байх зэрэг болно.

Үүнээс сурагчийн эрх, үүрэг, түүнчлэн сахилгын зөрчил-дээрэлхэлт, түүний эсрэг авах арга хэмжээний талаар хэрхэн зохицуулсныг тодруулан авч үзье.

*Сурагчийн эрх:*

- Сурагчтай шударга, хүндэтгэлтэй харьцана.
- Бие махбод, сэтгэл санааны болон сэтгэл зүйн аливаа хүчирхийллээс ангид, аюулгүй, тайван орчинд сурч боловсрох эрхтэй.
- Хувь хүнийхээ хувьд үнэлэгдэж, өөрийн өвөрмөц суралцах хэв маягаа таниулж, суралцах боломжоо нэмэгдүүлэх эрхтэй.
- Сургуулиас зохион байгуулж буй аливаа арга хэмжээнд оролцох эрхтэй.
- Нийгмээс хүлээн зөвшөөрсөн зан үйлийн хүрээнд өөрийгөө илэрхийлэх эрхтэй.
- Багшаас хичээл номондоо нэмэлт тусламж хүсэх эрхтэй.

*Сурагчийн үүрэг:*

- Нийгмийн хариуцлагатай зан үйлийг харуулах үүрэгтэй.
- Бусдын эрхийг хүндэтгэх үүрэгтэй.
- Мэдрэмжтэй байж, бусдын итгэл үнэмшил, ёс заншлыг хүндэтгэх үүрэгтэй.
- Сургуулиа хүндэтгэх, хувийн болон бусдын эд зүйлсийг хямгадах, хамгаалах үүрэгтэй.
- Цаг баримтлах, сургуулиас зохион байгуулж буй үйл ажиллагаанд тогтмол оролцох үүрэгтэй.

Зарим сургуулийн дүрэмд зөрчлийг ноцтой болон жижиг сахилгын зөрчлүүд гэж ялгасан байх бөгөөд дээрэлхэлт нь сахилгын ноцтой зөрчилд тооцогдож байна. Дээрэлхэлт болон бусад ноцтой зөрчлийн эсрэг сургуулиас авах арга хэмжээ нь:

1. Зөрчил гаргасан этгээдийн эцэг, эхэд нэн даруй мэдэгдэх;
2. Зөвлөх багш зөвлөгөө өгөх;
3. Сургуулийн Сахилгын хорооноос авах арга хэмжээний талаар эцэг эхчүүдэд мэдэгдэх;
4. Цаашид дахин зөрчил гаргуулахгүйн тулд эцэг эхтэй хамтран ажиллах;
5. Мэргэжлийн байгууллагаас тусламж, зөвлөгөө авах зэрэг үйл ажиллагаа багтаж байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**ТАЙВАНЬ**

Тайвань нь ЕБС-ийн ёс зүйн нийтлэг загвар дүрэм одоохондоо байхгүй бөгөөд сургуулиуд хууль, тогтоомжийн хүрээнд өөрдсийн ёс зүйн дүрмийг батлан мөрдүүлдэг байна. Жишээ болгож Мельбурн дахь Тайванийн сургуулийн Хүүхдийн аюулгүй байдлын ёс зүйн дүрмийг судалгаанд авч үзэв.

Мельбурн дахь Тайваний сургуулийн Хүүхдийн аюулгүй байдлын ёс зүйн дүрэм нь (Child Safety Code of Conduct)[236] сургуулийн бүх ажилтнууд, сурагчдын аюулгүй байдал, үйл ажиллагаа, сайн сайхан байдлыг дэмжих зорилготой. Үүнд:

- Сургуулийн эрсдэлийн удирдлагын стратегийг үргэлж дагаж мөрдөх;
- Хүүхдийн хүчирхийллийг үл тэвчих;
- Сурагчийн аюулгүй байдлыг үргэлж хамгаалах бүх арга хэмжээг цаг тухайд авч хэрэгжүүлэх;
- Сурагчийн санаа зовнилыг сонсож, хариу өгөх; /ялангуяа тэд өөрсдөдөө болон өөр сурагчийн аюулгүй байдлын талаар санаа зовж байгаа бол/
- Бүх сурагчийн соёлын олон нийтийн оролцоо, чадавхыг дэмжих;
- Бүх төрлийн ялгаварлан гадуурхалтыг үл тэвчих;
- Хүүхдийн хүчирхийллийн талаарх аливаа гомдлыг сургуулийн удирдлагын багт шуурхай мэдээлэхийн зэрэгцээ аливаа гомдлыг муж бүрийн цагдаа, хүүхэд хамгааллын агентлагт мэдээлсэн эсэхийг баталгаажуулах;
- Хүүхдийн аюулгүй байдлын талаарх аливаа асуудлыг сургуулийн удирдлагын багт мэдээлэх;
- Хүүхдийн хүчирхийлэлд өртсөн гэх мэдээлэл гарвал сурагч аюулгүй байгаа эсэхийг аль болох хурдан шалгах;
- Сурагчдын дунд үүсээд байгаа асуудлууд дээр анхаарал хандуулах;
- Үүрэг хариуцлагаа үнэнч шударгаар хамгийн сайнаараа гүйцэтгэх;
- Үйл ажиллагааны болон ажилтнуудтай холбоотой сургуулийн бүх бодлого, журмыг дагаж мөрдөх;
- Хүн бүртэй дарамт шахалтгүйгээр хүндэтгэлтэй, эелдэг харьцах;
- Хүүхэд залуучууд, гэр бүл, ажилчид, сайн дурынхны хувийн нууцыг чандлан хамгаалах;
- Холбогдох дүрэм, журам, байгууллагын бодлого, хүүхэд хамгааллын болон холбогдох хууль, тогтоомжийг мөрдөж ажиллах.
- Хэрэв сурагч хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй, өртсөн тохиолдолд 1900 утсанд мэдэгддэг байна.

**Ажилтнууд болон сайн дурын ажилтнуудад дараах зүйлсийг хориглоно:**

- Сурагчидтай аливаа "онцгой" харилцааг үүсгэх;
- Сурагчдын бие махбодтой холбоотой зан үйл үзүүлэх;
- Сурагчдыг хүчирхийлэлд өртөх эрсдэлд оруулах;
- Сурагчдыг насанд хүрэгчдийн шинж чанартай нээлттэй хэлэлцүүлэгт оролцуулах;
- Сурагчдын дэргэд зохисгүй үг хэллэг хэрэглэх;
- Сурагчдын дэргэд соёл, арьс өнгө, бэлгийн харилцааны талаарх хувийн үзэл бодлоо илэрхийлэх;
- Аливаа сурагчийг ялгаварлан гадуурхах;
- Сурагчид эсхүл тэдний гэр бүлтэй онлайнаар харилцах;
- Сэжигтэй эсхүл нийтэд ил болсон хүүхдийн хүчирхийллийг үл тоомсорлох.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[236] https://www.taiwaneseschool.com.au/child-safety-code-of-conduct Мельбурн дахь Тайваний сургуулийн Хүүхдийн аюулгүй байдлын ёс зүйн дүрэм. 2021

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ


- School violence and bullying: global status report-2017 https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000246970
- Behind the numbers: Ending school violence and bullying-2019 https://www.unicef.org/media/66496/file/Behind-the-Numbers.pdf
- Олон улсын дээрэлхлээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг https://ibpaworld.org/about/our-mission/
- Тогтвортой хөгжлийн зорилго 2030 https://sdg.1212.mn/
- WENR https://wenr.wes.org/2018/10/education-in-south-korea
- Child Welfare Act https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=39028&type=part&key=38
- Elementary And Secondary Education Act https://elaw.klri.re.kr/kor_service/lawView.do?lang=ENG&hse
- The Status and Perspective of Moral Education in Korea https://s-space.snu.ac.kr/bitstream/10371/72457/1/01.pdf q=52609
- National Center for the Rights of the Child http://korea1391.go.kr/new/page/eng/welcoming.php
- Wee project file:///Users/uurtsaikh/Desktop/9._Analyzing_the_effectiveness_of_the_Korean_National_anti-bullying_program(Cho).pdf
- Korean-Peer Nomination Inventory https://jamanetwork.com/journals/jamapediatrics/fullarticle/485789
- Basic policies for the prevention of bullying https://www.mext.go.jp/en/policy/education/elsec/title02/detail02/__icsFiles/afieldfile/2020/06/22/20200622-mxt_kouhou02-01.pdf
- Кибер гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын туршлага ба эрх зүйн орчин СТ-21/230
- Act on Development of an Environment that Provides Safe and Secure Internet Use for Young People https://www8.cao.go.jp/youth/youth-harm/law/pdf/for_english.pdf
- Act for the promotion of measures to prevent bullying https://www.mext.go.jp/en/policy/education/elsec/title02/detail02/1373868.html
- Basic Education Act https://www.finlex.fi/en/laki/kaannokset/1998/en19980628.pdf
- Bullying at School in Finlandhttps://scandinavianlaw.se/pdf/61-11.pdf
- School Bullying hurts and may make life difficult still as an an adulthttps://www.riku.fi/en/various-crimes/school-bullying/
- What to do in school bullying situationshttps://www.riku.fi/en/guides-and-instructions/what-to-do-in-school-bullying-situations/
- KIVA programhttps://www.kivaprogram.net/
- Education Act https://sso.agc.gov.sg/Act/EA1957?WholeDoc=1
- Children and Young Persons Act https://www.msf.gov.sg/policies/Children-and-Youth/Pages/Protection-under-Children-and-Young-Persons-Act.aspx
- Protection from Harrassment Act https://sso.agc.gov.sg/Act/PHA2014?ProvIds=pr3-
- National Standards for protection of children file:///Users/munkhtungalag/Downloads/national_standards_for_the_protection_of_children.pdf
- Anti-bullying and anti-cyberbullying policies in schools https://www.moe.gov.sg/news/parliamentary-replies/20210201-anti-bullying-and-anti-cyberbullying-policies-in-schools
- Discipline https://www.moe.gov.sg/programmes/discipline
- Protection of children in Singapore https://www.childrensociety.org.sg/resources/ck/files/child_protection.pdf
- United Nations Study on Violence against Children https://www.ohchr.org/Documents/HRBodies/CRC/StudyViolenceChildren/Responses/Singapore.pdf
- Ragging and Bullying: Their Penalties and What Victims Can Do (Young offenders) https://singaporelegaladvice.com/law-articles/ragging-bullying-penalties-victims/
- Сургуулийн дүрмийн жишээ https://clementipri.moe.edu.sg/about-us/school-information/school-rules, https://www.yuvabharathi.sg/docs/static/discipline_policy.pdf


UIH.MN СУДАЛГААНЫ САН

- Мельбурн дахь Тайваний сургуулийн Хүүхдийн аюулгүй байдлын ёс зүйн дүрэм. 2021https://www.taiwaneseschool.com.au/child-safety-code-of-conduct
- Тайваний боловсрол, WES судалгааны сэтгүүл, 2016.06.07https://wenr.wes.org/2016/06/education-in-taiwan
- Тайванийн боловсролын яам https://english.moe.gov.tw/cp-126-17722-3fb83-1.html
- Заавал эзэмших боловсролын тухай хууль, сүүлд өөрчлөлт орсон, 2019.04.17https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=H0070002
- Ахлах сургуулийн боловсролын тухай хууль, сүүлд өөрчлөлт орсон, 2021.05.26 https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=H0060043
- Нэмэлт боловсролын тухай хууль, сүүлд өөрчлөлт орсон, 2017.06.14 https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=H0080002
- Техникийн болон мэргэжлийн боловсролын тухай хууль, сүүлд өөрчлөлт орсон, 2019.12.31 https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=H0040028
- Багшийн боловсролын тухай хууль, сүүлд өөрчлөлт орсон, 2019.12.11 https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=H0050001
- Тусгай боловсролын тухай хууль, сүүлд өөрчлөлт орсон, 2019.04.24 https://law.moj.gov.tw/Eng/LawClass/LawAll.aspx?PCode=H0080027
- Уугуул иргэдийн боловсролын тухай хууль, сүүлд өөрчлөлт орсон, 2021.01.20 https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=H0020037
- Хүйсийн тэгш боловсролын тухай хууль, сүүлд өөрчлөлт орсон, 2018.12.28 https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=H0080067
- Нийгмийн боловсролын тухай хууль, сүүлд өөрчлөлт орсон, 2015.05.06 https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawHistory.aspx?pcode=H0080001
- Байгалийн боловсролын тухай хууль, сүүлд өөрчлөлт орсон, 2017.11.29 https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=O0120001
- Урлагийн боловсролын тухай хууль, сүүлд өөрчлөлт орсон, 2015.12.30 https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=H0170037
- Гэр бүлийн боловсролын тухай хууль, сүүлд өөрчлөлт орсон, 2019.05.08 https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=H0080050
- Цагдаагийн боловсролын тухай хууль, сүүлд өөрчлөлт орсон, 2002.06.05 https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=D0080007
- Хүүхдийн хүмүүжлийн сургууль байгуулах, боловсролын хэрэгжилтийг хангах тухай хууль, сүүлд өөрчлөлт орсон, 2010.05.19 https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=I0040043
- Ахлах сургуульд хамтын боловсролыг хэрэгжүүлэх, сурагчдын эрхийг хамгаалах тухай хууль, сүүлд өөрчлөлт орсон, 2021.06.16 https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=H0060042
- Хүүхэд, залуучуудын эрх ашгийг хамгаалах тухай хууль, сүүлд өөрчлөлт орсон, 2021.01.20 https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=D0050001
- Мельбурн дахь Тайваний сургуулийн Хүүхдийн аюулгүй байдлын ёс зүйн дүрэм. 2021 https://www.taiwaneseschool.com.au/child-safety-code-of-conduct


UIH.MN
СУДАЛГААНЫ САН

# НИЙГМИЙН ДААТГАЛ ТӨЛӨЛТӨД ЭРЭГТЭЙ, ЭМЭГТЭЙ ХҮМҮҮСИЙН ХАМРАГДАЛТ: МОНГОЛ УЛСЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

*Ц.Норовдондог (Ph.D), О.Нарантуяа*

**АГУУЛГА**

УДИРТГАЛ

ХУРААНГУЙ

ДЭЛГЭРЭНГҮЙ

1.НИЙГМИЙН ДААТГАЛ ТӨЛӨЛТӨД ЭРЭГТЭЙ, ЭМЭГТЭЙ ХҮМҮҮСИЙН ХАМРАГДАЛТ

2.ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ ТӨЛӨЛТӨД ЭРЭГТЭЙ, ЭМЭГТЭЙ ХҮМҮҮСИЙН ХАМРАГДАЛТ

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

## УДИРТГАЛ

Судалгааны захиалгын дагуу “Нийгмийн даатгал төлөлтөд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хамрагдалт: Монгол Улсын нөхцөл байдал” сэдэвт мэдээлэл, лавлагааг Парламентын судалгааны хүрээлэнгээс гаргав.

Мэдээлэл, лавлагааг дараах асуудлуудын хүрээнд гаргав. Үүнд:

- Нийгмийн даатгал төлөлтөд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хамрагдалт, нас, хүйсийн байдлын харьцуулалт;
- Эрүүл мэндийн даатгал төлөлтөд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хамрагдалт, нас, хүйсийн байдлын харьцуулалт.

Мэдээлэл, лавлагааг Нийгмийн даатгалын ерөнхий газар, Үндэсний Статистикийн хорооноос гаргасан сүүлийн 5 жилийн статистик мэдээллийг ашиглан харьцуулан гаргав. Түүнчлэн холбогдох хууль, эрх зүйн актууд, судалгааны мэдээллийг ашигласан болно.

## СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Монгол Улсад 2020 оны байдлаар нийгмийн даатгалд 1,013,190 даатгуулагч даатгуулсны 826,064 (81.5%) нь албан журмын, 187,126 (18.5%) нь сайн дурын даатгуулагчид байна. 2020 онд нийгмийн даатгалд хамрагдсан даатгуулагчдын тоо 2016 онтой харьцуулахад 18 орчим хувиар өссөн бөгөөд 2016-2020 оны хооронд жилд дунджаар 2.9 хувиар өсчээ. 2020 онд албан журмын даатгуулагчдын төлсөн шимтгэлийн хэмжээ 522.9 тэрбум төгрөг болж өмнөх онтой харьцуулахад 7.5 хувиар буурсан бол сайн дурын даатгуулагчдын төлсөн шимтгэлийн хэмжээ 99.1 тэрбум төгрөг болж өмнөх онтой харьцуулахад 12 хувиар өссөн байна. Ерөнхийдөө 2016-2020 оны хооронд сайн дурын даатгуулагчдын төлсөн шимтгэлийн хэмжээ тасралтгүй нэмэгджээ.

Нийгмийн даатгалд хамрагдсан даатгуулагчдыг насны байдлаар авч үзвэл, сүүлийн 3 жилд 65-аас дээш насныхан хамгийн бага байгаа буюу нийт даатгуулагчдын 0.7 хувийг, 25-39 насныхан хамгийн их буюу нийт даатгуулагчдын 49 хувийг эзэлж байна.

Хүйсийн байдлаар авч үзвэл, нийт даатгуулагчдын 51%-ийг (517,316) эмэгтэй, 49%-ийг (495,874) эрэгтэй даатгуулагчид эзэлж байна.

2020 оны байдлаар эрүүл мэндийн даатгалд 973,737 даатгуулагч байна. Эрүүл мэндийн даатгалд хамрагдалт 2016-2020 онд өссөн дүнтэй байгаа бөгөөд хүйсийн хувьд төдийлөн зөрүүгүй байх бөгөөд нийт даатгуулагчдын 49.8 хувийг эрэгтэй даатгуулагч, 50.2 хувийг эмэгтэй даатгуулагч эзэлж байна.

## СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ

### 1.НИЙГМИЙН ДААТГАЛ ТӨЛӨЛТӨД ЭРЭГТЭЙ, ЭМЭГТЭЙ ХҮМҮҮСИЙН ХАМРАГДАЛТ

Монгол Улсын нийгмийн даатгалын тогтолцоо нь даатгуулагч ажилтан болон ажил олгогчийн төлсөн шимтгэл дээр суурилдаг. Нийгмийн даатгал нь тэтгэврийн даатгал, тэтгэмжийн даатгал, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгал, ажилгүйдлийн даатгал, эрүүл мэндийн даатгал гэсэн бүрэлдэхүүн хэсгүүдтэй байна.

Монгол Улсын нийгмийн даатгалын шимтгэл, эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлттэй холбоотой харьцуулсан мэдээллийг Нийгмийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн сүүлийн 5 жилийн статистик мэдээлэлд үндэслэн гаргав.

Манай улсын нийгмийн даатгалын сангийн орлого 2016-2019 оны хооронд тогтвортой өссөөр 2019 онд 2.4 их наяд төгрөг болжээ. Харин 2020 онд дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас нийгмийн даатгалын сангийн нийт орлого 1.8 их наяд төгрөг болж буурсан байна.

2020 онд албан журмын даатгуулагчдын төлсөн шимтгэлийн хэмжээ 522.9 тэрбум төгрөг болж өмнөх онтой харьцуулахад 7.5 хувиар буурсан бол сайн дурын даатгуулагчдын төлсөн шимтгэлийн хэмжээ 99.1 тэрбум төгрөг болж өмнөх онтой харьцуулахад 12 хувиар өссөн байна. Ерөнхийдөө 2016-2020 оны хооронд сайн дурын даатгуулагчдын төлсөн шимтгэлийн хэмжээ тасралтгүй өссөн дүнтэй байна. (Хүснэгт №1)

*Хүснэгт №1.Нийгмийн даатгалын сангийн орлого, сая төгрөг*

| | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 |
|---|---|---|---|---|---|
| **Нийт орлого, үүнээс** | **1,809,912.1** | **2,114,259.8** | **2,090,066.9** | **2,485,005.7** | **1,878,187.3** |
| **Албан журмын даатгуулагчийн төлсөн** | 464,851.9 | 534,893.4 | 541,431.7 | 701,185.9 | 522,943.5 |
| **Сайн дурын даатгуулагчийн төлсөн** | 52,259.6 | 62,410.0 | 69,186.7 | 88,431.9 | 99,120.3 |

Нийгмийн даатгалын сангийн орлогын бүтцийг үзвэл, 2019 оны байдлаар нийт орлогын 40.1 хувийг ажил олгогчийн төлсөн НДШ, 31.9 хувийг даатгуулагчийн төлсөн НДШ, 24.4 хувийг улсын төсвөөс олгосон хөрөнгө, 3.6 хувийг бусад эх үүсвэрээс тус тус бүрдүүлсэн байна. (График-1) Түүнчлэн нийгмийн даатгалын сангийн зарлагын 98.8 хувийг тэтгэвэр, тэтгэмжийн зардал[237] эзэлж байна.

*График №1. Нийгмийн даатгалын сангийн орлогын бүтэц, 2019 он*




Нийгмийн даатгалын тухай хуульд заасны дагуу албан журмын болон сайн дурын нийгмийн даатгалын шимтгэл төлж буй этгээдийг даатгуулагч гэх бөгөөд даатгуулагч гэж хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.

[237] Нийгмийн хамгааллын статистик 2019, ҮСХ, УБ., 2020 он, 15 дахь тал

**2020 оны байдлаар нийгмийн даатгалд 1,013,190 даатгуулагч даатгуулсны** 826,064 (81.5%) нь албан журмын, 187,126 (18.5%) нь сайн дурын даатгуулагчид байна. 2020 онд нийгмийн даатгалд хамрагдсан даатгуулагчдын тоо 2016 онтой харьцуулахад 18 орчим хувиар өссөн бөгөөд 2016-2020 оны хооронд жилд дунджаар 2.9 хувиар өсчээ.(График №2)

*График №2. Нийгмийн даатгалд хамрагдсан даатгуулагчийн тоо*




Хүйсээр нь аваад үзвэл, нийт даатгуулагчдын 51%-ийг (517,316) эмэгтэй, 49%-ийг (495,874) эрэгтэй даатгуулагчид эзэлж байна.

Түүнчлэн албан журмын даатгуулагчдын 48% (400,276) нь эмэгтэй, 52% (425,788) нь эрэгтэй даатгуулагчид байгаа бол сайн дурын даатгуулагчдын 62.5% (117,040) нь эмэгтэй, 37.5% (70,086) нь эрэгтэй даатгуулагчид байна. (График №3)

*График №3. Нийгмийн даатгалд даатгуулагчийн хүйсийн байдал*




UIH.MN СУДАЛГААНЫ САН

**Албан журмын даатгал**д даатгуулсан эрэгтэй даатгуулагчдын тоо 2016-2020 онд дунджаар 4 хувиар өсчээ.

25-44 насныхан нийт даатгуулагчдын дийлэнхийг буюу дунджаар 57%-ийг эзэлж байгаа бол 15-19, 60-аас дээш насныхан нийт даатгуулагчдын хамгийн бага буюу 8.8 хувийг эзэлж байна.

Эмэгтэй даатгуулагчдын хувьд 25-44 насныхан нийт эмэгтэй даатгуулагчдын 59 хувийг эзэлж байна. Харин 15-19 болон 60-аас дээш насны даатгуулагчид нийт эмэгтэй даатгуулагчдын 6 хувийг эзэлж байна.

Статистик мэдээллээс дүгнэхэд, албан журмын даатгалд даатгуулагчдын хамгийн өндөр оролцоотой нь 25-44 насныхан байна. Харин 15-19 болон 60-аас дээш насны даатгуулагчид хамгийн бага оролцоотой байна. Гэхдээ 15-19 насны эрэгтэйчүүд нь эмэгтэйчүүдтэй харьцуулахад албан журмын даатгалд хамрагдалт нь 60 орчим хувиар өндөр байгаа нь эрэгтэйчүүд насны хувьд эрт хөдөлмөр эрхэлдэг гэж дүгнэж болохоор байна. Харин 45-55 насны эмэгтэйчүүдийн хувьд албан журмын даатгалд хамрагдалт эрэгтэйчүүдээс 4.6 орчим хувиар өндөр байна.

*Хүснэгт №2. Албан журмын даатгалд хамрагдсан даатгуулагчид, нас, хүйсээр*

| Он | 2016 | | 2017 | | 2018 | | 2019 | | 2020 | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Нас/Хүйс | Эр | Эм | Эр | Эм | Эр | Эм | Эр | Эм | Эр | Эм |
| **Бүгд** | **356532** | **343639** | **375908** | **358,582** | **403340** | **378,907** | **427989** | **397,197** | **425788** | **400,276** |
| 15-19 | 13397 | 0 | 14809 | 0 | 13448 | 6,251 | 14187 | 7,263 | 12963 | 4,986 |
| 20-24 | 61 | 25 | 186 | 137 | 50134 | 38,659 | 52935 | 40,308 | 51444 | 38,038 |
| 25-29 | 16512 | 6033 | 24875 | 11765 | 74663 | 69,038 | 73602 | 67,600 | 69144 | 63,772 |
| 30-34 | 50621 | 41897 | 57807 | 51244 | 71332 | 70,815 | 78152 | 76,119 | 80346 | 78,042 |
| 35-39 | 73322 | 71480 | 75486 | 73625 | 49701 | 53,059 | 55034 | 56,828 | 58104 | 60,152 |
| 40-44 | 53368 | 56717 | 54558 | 57647 | 40485 | 47,852 | 43563 | 49,257 | 45242 | 50,449 |
| 45-49 | 41369 | 47420 | 42276 | 48144 | 33036 | 40,978 | 36038 | 43,375 | 37152 | 44,978 |
| 50-54 | 34866 | 43612 | 35286 | 43856 | 27112 | 31,768 | 28382 | 33,126 | 29421 | 34,577 |
| 55-59 | 28791 | 37098 | 28754 | 36446 | 19143 | 14,411 | 21095 | 16,212 | 21478 | 17,089 |
| 60-64 | 24009 | 26868 | 23474 | 24498 | 6275 | 4,233 | 7317 | 5,058 | 8306 | 5,806 |
| 65-аас дээш | 14213 | 9122 | 12797 | 7862 | 3522 | 1,843 | 3772 | 2,051 | 3891 | 2,346 |
| Тодорхойгүй | 6003 | 3367 | 5600 | 3358 | 14,489 | - | 13,912 | - | 8,297 | 41 |

**Сайн дурын даатгал**д хамрагдсан эрэгтэй даатгуулагчдын хувьд 35-54 насныхан нийт даатгуулагчдын дийлэнхийг буюу дунджаар 60.5%-ийг эзэлж байгаа бол 15-24, 65-аас дээш насныхан нийт даатгуулагчдын хамгийн бага буюу 6.4 хувийг эзэлж байна.

Эмэгтэй даатгуулагчдын хувьд 35-54 насныхан хамгийн өндөр оролцоотой буюу нийт эмэгтэй даатгуулагчдын 65.4 хувийг эзэлж байна. Харин 15-24 болон 65-аас дээш насны даатгуулагчид нийт эмэгтэй даатгуулагчдын хамгийн цөөн буюу 3.2 хувийг эзэлж байна. (Хүснэгт-3)

Статистик мэдээллээс дүгнэхэд сайн дурын даатгалд даатгуулагчдын хамгийн өндөр оролцоотой нь 35-54 насныхан байна. Харин 15-24 болон 65-аас дээш насны даатгуулагчид хамгийн бага оролцоотой байна. Хүснэгтээс харахад, сайн дурын даатгуулагчдын 62.5% (117,040) нь эмэгтэй, 37.5% (70,086) нь эрэгтэй даатгуулагчид байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

*Хүснэгт №3. Сайн дурын даатгалд хамрагдсан даатгуулагчид, нас, хүйсээр*

| Он | 2016 | | 2017 | | 2018 | | 2019 | | 2020 | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Нас/хүйс | Эр | Эм | Эр | Эм | Эр | Эм | Эр | Эм | Эр | Эм |
| **Бүгд** | **80326** | **123647** | **60824** | **109,902** | **60770** | **108,963** | **58965** | **103,333** | **70086** | **117,040** |
| 15-19 | 763 | 0 | 525 | 0 | 853 | 739 | 815 | 603 | 740 | 602 |
| 20-24 | 1 | 0 | 19 | 18 | 3860 | 5,736 | 3393 | 4,822 | 3660 | 5,311 |
| 25-29 | 1661 | 1421 | 2117 | 2233 | 6277 | 13,157 | 5458 | 10,707 | 5775 | 11,696 |
| 30-34 | 6065 | 9521 | 5185 | 9731 | 7848 | 16,883 | 7274 | 15,530 | 8105 | 17,752 |
| 35-39 | 9853 | 18178 | 7384 | 16285 | 8872 | 17,334 | 8313 | 16,475 | 10023 | 19,621 |
| 40-44 | 12057 | 19882 | 8752 | 17335 | 9940 | 18,256 | 9465 | 17,606 | 11444 | 20,777 |
| 45-49 | 13674 | 21441 | 10022 | 18249 | 9217 | 18,368 | 9541 | 18,721 | 1,992 | 21,999 |
| 50-54 | 13617 | 20907 | 10122 | 18422 | 7494 | 15,939 | 8101 | 16,046 | 10665 | 16,350 |
| 55-59 | 10783 | 19781 | 8169 | 18141 | 5280 | 2,520 | 5480 | 2,788 | 6251 | 2,891 |
| 60-64 | 7659 | 12108 | 5912 | 9341 | 656 | 27 | 716 | 30 | 1,009 | 35 |
| 65-аас дээш | 4109 | 382 | 2588 | 138 | 8 | 3 | 5 | 5 | 8 | 6 |
| Тодорхойгүй | 84 | 26 | 31 | 9 | 465 | 1 | 404 | - | 414 | - |

Нийгмийн даатгалд хамрагдсан даатгуулагчдыг насны байдлаар авч үзвэл, сүүлийн 3 жилийн байдлаар 65-аас дээш насныхан хамгийн бага буюу нийт даатгуулагчдын 0.7 хувийг дунджаар эзэлж байна. Харин хамгийн идэвхтэй даатгуулагчид 25-39 насныхан байгаа бөгөөд нийт даатгуулагчдын 49 хувийг эзэлж байна. (Хүснэгт №4)

Хүснэгтээс харахад сүүлийн 3 жилийн хугацаанд нийгмийн даатгалд даатгуулагчдын хамрах хүрээ насны ангиллын байдлаараа нэлээд өөрчлөгдсөн байна. 2016-2017 онд 15-24 насны даатгуулагчид дунджаар нийт даатгуулагчдын 1.6 хувийг эзэлж байсан бол 60-аас дээш насны даатгуулагчид дунджаар нийт даатгуулагчдын 10 хувийг эзэлж байсан.

Харин сүүлийн 3 жилд буюу 2018-2020 онд 15-24 насны даатгуулагчдын тоо өсч дунджаар нийт даатгуулагчдын 8 хувийг, 60-аас дээш насны даатгуулагчдын тоо буурч нийт даатгуулагчдын 2 хувийг тус тус эзэлж байна.

*Хүснэгт №4. Нийгмийн даатгалд даатгуулагчдын тоо*

| Он | 2016 | | 2017 | | 2018 | | 2019 | | 2020 | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Нас | Албан журам | Сайн дурын | Албан журам | Сайн дурын | Албан журам | Сайн дурын | Албан журам | Сайн дурын | Албан журам | Сайн дурын |
| **Бүгд** | **700171** | **203973** | **734,490** | **170,728** | **782,247** | **169,733** | **825,186** | **162,298** | **826,064** | **187,126** |
| 15-19 | 13397 | 763 | 14809 | 525 | 19,699 | 1,592 | 21,450 | 1,418 | 17,949 | 1,342 |
| 20-24 | 86 | 1 | 323 | 37 | 88,793 | 9,596 | 93,243 | 8,215 | 89,482 | 8,971 |
| 25-29 | 22545 | 3082 | 36640 | 4350 | 143,701 | 19,434 | 141,202 | 16,165 | 132,916 | 17,471 |
| 30-34 | 92518 | 15586 | 109051 | 14916 | 142,147 | 24,731 | 154,271 | 22,804 | 158,388 | 25,857 |
| 35-39 | 144802 | 28031 | 149111 | 23669 | 102,760 | 26,206 | 111,862 | 24,788 | 118,256 | 29,644 |
| 40-44 | 110085 | 31939 | 112205 | 26087 | 88,337 | 28,196 | 92,820 | 27,071 | 95,691 | 32,221 |
| 45-49 | 88789 | 35115 | 90420 | 28271 | 74,014 | 27,585 | 79,413 | 28,262 | 82,130 | 33,991 |
| 50-54 | 78478 | 34524 | 79142 | 28544 | 58,880 | 23,433 | 61,508 | 24,147 | 63,998 | 27,015 |
| 55-59 | 65889 | 30564 | 65200 | 26310 | 33,554 | 7,800 | 37,307 | 8,268 | 38,567 | 9,142 |
| 60-64 | 50877 | 19767 | 47972 | 15253 | 10,508 | 683 | 12,375 | 746 | 14,112 | 1,044 |
| 65-аас дээш | 23335 | 4491 | 20659 | 2726 | 5,365 | 11 | 5,823 | 10 | 6,237 | 14 |
| Тодорхойгүй | 9370 | 110 | 8958 | 40 | 14,489 | 466 | 13,912 | 404 | 8,338 | 414 |

## 2.ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ ТӨЛӨЛТӨД ЭРЭГТЭЙ, ЭМЭГТЭЙ ХҮМҮҮСИЙН ХАМРАГДАЛТ

Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд зааснаар эрүүл мэндийн даатгал гэж төр, иргэн, хуулийн этгээдээс хуульд заасан журмын дагуу эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлж, эрүүл мэндийн даатгалын санг урьдчилан бүрдүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг ойлгоно. Эрүүл мэндийн даатгал нь дараах хоёр төрөлтэй. Үүнд:

- албан журмын даатгал
- сайн дурын нэмэлт даатгал.

Монгол Улсын хувьд эрүүл мэндийн албан журмын даатгалд бүх иргэд заавал даатгуулдаг. Гадаадын иргэн, харьяалалгүй хүний хувьд Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол эрүүл мэндийн албан журмын даатгалд заавал даатгуулна.

Сайн дурын нэмэлт даатгал гэж эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцад ороогүй тусламж, үйлчилгээ авахын тулд эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус өмчийн даатгалын байгууллагад сайн дураар даатгуулахыг ойлгоно.

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

- даатгуулагчийн төлсөн эрүүл мэндийн даатгалын шимтгэл
- ажил олгогчийн төлсөн эрүүл мэндийн даатгалын шимтгэл
- төр даатгалыг нь хариуцан иргэдэд улсын төсвөөс төлсөн шимтгэл
- бусад

Даатгуулагч эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг дараах хувь хэмжээгээр төлнө. Үүнд:

- нийгмийн даатгалд албан журмаар даатгуулж буй даатгуулагч-хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 4-өөс доошгүй хувиар жил бүр;
- хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчин, оюутан суралцагч, 0-18 насны хүүхэд- нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1-ээс доошгүй хувиар жил бүр;
- гадаадын иргэн, харьяалалгүй хүн, тэтгэврээс өөр тогтмол мөнгөн орлогогүй иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа шаардлагатай иргэн, хүүхдээ 2 нас хүртэл нь өсгөж байгаа эх /эцэг/, хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч, ял эдэлж байгаа ялтан- нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 2-оос доошгүй хувиар жил бүр.

**2020 оны байдлаар эрүүл мэндийн даатгалд 973,737 даатгуулагч** байна. (Хүснэгт №5) Даатгуулагч гэж эрүүл мэндийн санд шимтгэл тогтмол урьдчилан төлж, эрүүл мэндийн улмаас учирч болзошгүй санхүүгийн эрсдэлээ уг даатгалын сангаас хуваалцах эрх бүхий иргэнийг хэлэх бөгөөд статистик мэдээллээс үзэхэд эрүүл мэндийн даатгалд хамрагдалт 2016-2020 онд өссөн дүнтэй байгаа бөгөөд хүйсийн хувьд төдийлөн зөрүү байхгүй байна.

*Хүснэгт №5. Эрүүл мэндийн даатгалд даатгуулсан даатгуулагчдын тоо*

| Он | 2016 | | 2017 | | 2018 | | 2019 | | 2020 | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Хүйс** | эр | эм | Эр | Эм | Эр | Эм | Эр | Эм | Эр | Эм |
| **Нийт даатгуулагч** | **987,834** | | **1,001,713** | | **1,096,237** | | **1,037,549** | | **973,737** | |
| | 474023 | 504811 | 493891 | 507822 | 545876 | 550361 | 523520 | 514029 | 492567 | 481170 |

Эрүүл мэндийн даатгалд хамрагдаж буй нийт даатгуулагчид аж ахуй нэгж, байгууллагад ажиллаж цалин, орлогоосоо эрүүл мэндийн даатгалын шимтгэл тогтмол төлдөг даатгуулагч нийт даатгуулагчийн 47,5 хувийг эзэлж байна. (Хүснэгт №6) Аж ахуй нэгж, байгууллагад ажиллаж хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоосоо тогтмол шимтгэл төлдөг даатгуулагчид бүх төрийн байгууллага, аж ахуй нэгжид ажиллаж буй даатгуулагч хамаарна.

*Хүснэгт №6. ААНБ-д ажиллагч*

| Он | 2016 | | 2017 | | 2018 | | 2019 | | 2020 | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Хүйс** | эр | эм | Эр | Эм | Эр | Эм | Эр | Эм | Эр | Эм |
| **Нийт даатгуулагч** | **603,671** | | **670,583** | | **711,510** | | **737,712** | | **730,606** | |
| | 313025 | 290646 | 349132 | 321451 | 377938 | 333572 | 393888 | 343824 | 389194 | 341412 |

Статистик мэдээллээс үзэхэд, эрүүл мэндийн даатгалд хамрагдсан даатгуулагчдыг хүйсийн байдлаар авч үзвэл нийт даатгуулагчдын 49.8 хувийг эрэгтэй даатгуулагч, 50.2 хувийг эмэгтэй даатгуулагч эзэлж байна. (Хүснэгт №7)

*Хүснэгт №7. Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан даатгуулагчийн тоо*

| | 2016 | | 2017 | | 2018 | | 2019 | | 2020 | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Эр | Эм | Эр | Эм | Эр | Эм | Эр | Эм | Эр | Эм |
| **Бүгд** | **483023** | **504811** | **493891** | **507822** | **545876** | **550361** | **523520** | **514029** | **492567** | **481170** |
| 15-19 | 14,644 | 0 | 16,115 | 0 | 15,880 | 13,990 | 13,311 | 12,226 | 9,421 | 8,450 |
| 20-24 | 41 | 30 | 194 | 161 | 75,459 | 75,733 | 65,730 | 62,444 | 59,746 | 55,431 |
| 25-29 | 26,859 | 30,211 | 32,587 | 35,525 | 92,332 | 90,327 | 84,623 | 79,009 | 76,907 | 69,522 |
| 30-34 | 57,389 | 59,470 | 72706 | 73,546 | 89,596 | 92,152 | 91,132 | 89,146 | 89,831 | 84,924 |
| 35-39 | 87,204 | 89,470 | 89,391 | 90,908 | 69,249 | 76,779 | 70,132 | 73,940 | 69,743 | 72,257 |
| 40-44 | 73,053 | 79,315 | 69,782 | 76393 | 60,282 | 73,652 | 59,560 | 70,536 | 57,999 | 68,046 |
| 45-49 | 60,504 | 69,823 | 59,894 | 69687 | 50,807 | 66,165 | 50,928 | 65,950 | 49,469 | 64,713 |
| 50-54 | 54,431 | 68,534 | 53,512 | 67416 | 41,919 | 49,898 | 40,339 | 48,977 | 39492 | 47,244 |
| 55-59 | 45,207 | 60,206 | 44,077 | 58103 | 29,441 | 10,589 | 27,956 | 10,763 | 26,470 | 9,759 |
| 60-64 | 38,100 | 39,862 | 35,900 | 32557 | 4,728 | 811 | 4,358 | 796 | 4,188 | 652 |
| 65-аас дээш | 22,167 | 6,786 | 18,216 | 2822 | 505 | 252 | 482 | 242 | 318 | 172 |
| Тодорхойгүй | 3,424 | 1,104 | 1517 | 704 | 15,678 | 13 | 14,969 | - | 8,983 | - |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан эрэгтэй даатгуулагчдаас 25-39 насныхан нийт даатгуулагчдын дийлэнхийг буюу дунджаар 48%-ийг эзэлж байгаа бол 15-19, 60-аас дээш насныхан нийт даатгуулагчдын хамгийн бага буюу 2.8%-ийг эзэлж байна. (Хүснэгт №8)

Эмэгтэй даатгуулагчдын хувьд 25-44 насныхан нийт эмэгтэй даатгуулагчдын дийлэнхийг буюу дунджаар 61.2%-ийг эзэлж байна. Харин хамгийн бага буюу 15-19, 60-аас дээш насныхан нийт эмэгтэй даатгуулагчдын 1.9%-ийг эзэлж байна. (Хүснэгт №9)

*Хүснэгт №8. Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан эрэгтэй даатгуулагчдын тоо*

| | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 |
|---|---|---|---|---|---|
| **Бүгд** | **483,023** | **493891** | **545876** | **523520** | **492567** |
| **15-19** | 14,644 | 16,115 | 15,880 | 13,311 | 9,421 |
| **20-24** | 41 | 194 | 75,459 | 65,730 | 59,746 |
| **25-29** | 26,859 | 32,587 | 92,332 | 84,623 | 76,907 |
| **30-34** | 57,389 | 72706 | 89,596 | 91,132 | 89,831 |
| **35-39** | 87,204 | 89,391 | 69,249 | 70,132 | 69,743 |
| **40-44** | 73,053 | 69,782 | 60,282 | 59,560 | 57,999 |
| **45-49** | 60,504 | 59,894 | 50,807 | 50,928 | 49,469 |
| **50-54** | 54,431 | 53,512 | 41,919 | 40,339 | 9492 |
| **55-59** | 45,207 | 44,077 | 29,441 | 27,956 | 26,470 |
| **60-64** | 38,100 | 35,900 | 4,728 | 4,358 | 4,188 |
| **65-аас дээш** | 28,953 | 21038 | 757 | 724 | 490 |
| **Тодорхойгүй** | 4,528 | 2221 | 15,691 | 14,969 | 8,983 |

*Хүснэгт №9. Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан эмэгтэй даатгуулагчдын тоо*

| | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 |
|---|---|---|---|---|---|
| **Бүгд** | **504811** | **507822** | **550361** | **514029** | **481170** |
| **15-19** | 0 | 0 | 13,990 | 12,226 | 8,450 |
| **20-24** | 30 | 161 | 75,733 | 62,444 | 55,431 |
| **25-29** | 30,211 | 35,525 | 90,327 | 79,009 | 69,522 |
| **30-34** | 59,470 | 73,546 | 92,152 | 89,146 | 84,924 |
| **35-39** | 89,470 | 90,908 | 76,779 | 73,940 | 72,257 |
| **40-44** | 79,315 | 76393 | 73,652 | 70,536 | 68,046 |
| **45-49** | 69,823 | 69687 | 66,165 | 65,950 | 64,713 |
| **50-54** | 68,534 | 67416 | 49,898 | 48,977 | 47,244 |
| **55-59** | 60,206 | 58103 | 10,589 | 10,763 | 9,759 |
| **60-64** | 39,862 | 32557 | 811 | 796 | 652 |
| **65-аас дээш** | 6,786 | 2822 | 252 | 242 | 172 |
| **Тодорхойгүй** | 1,104 | 704 | 13 | - | - |

UHMN СУДАЛГААНЫ САН

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

*Хууль тогтоомж*

- Нийгмийн даатгалын тухай хууль, 1994 он
- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, 1994 он
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, 2015 он

*Ном, гарын авлага*

- Нийгмийн даатгал, халамж 2017, ҮСХ https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Social_insurance_and_welfare_2017.pdf&ln=Mn
- Нийгмийн хамгааллын статистик-2019, ҮСХ, 2020 он https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Social_Protection_intro_2019.pdf&ln=Mn

*Бусад*

- Нийгмийн даатгалын ерөнхий газрын статистик мэдээлэл

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

# ЖИРЭМСЭН БОЛОН АМАРЖСАН ЭХИЙН ТЭТГЭМЖ, ХҮҮХЭД АСРАХ ЧӨЛӨӨНИЙ ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

*Ц.Норовдондог (Ph.D), Д.Аюуш,*
*Д.Амаржаргал (Ph.D), Б.Батцэцэг,*
*Д.Жигваагүнсэл, Р.Оргилмаа, О.Нарантуяа*

## АГУУЛГА

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ

НЭГ. ЖИРЭМСЭН БОЛОН АМАРЖСАН ЭХЭД ТЭТГЭМЖ ОЛГОХТОЙ ХОЛБООТОЙ ОЛОН УЛСЫН БАРИМТ БИЧИГ, ЗӨВЛӨМЖҮҮД

ХОЁР. БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА

ГЕРМАН УЛС

ФИНЛАНД УЛС

ТАЙВАНЬ (БНХАУ)

МОНГОЛ УЛС

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

## УДИРТГАЛ

УИХ-ын гишүүнээс ирүүлсэн захиалгын дагуу “Жирэмсэн болон амаржсан эхийн тэтгэмж хүүхэд асрах чөлөөний талаарх гадаадын зарим орны туршлага” сэдэвт харьцуулсан судалгааны ажлыг парламентын судалгааны хүрээлэнд гүйцэтгэв.

*Судалгааны хамрах хүрээ:* Захиалагчаас ирүүлсэн хүсэлтийн дагуу судлах асуудлын хүрээг дараах байдлаар тодорхойлов. Үүнд:

- Хүүхэд төрүүлсэн эхэд  тэтгэмж олгохтой холбоотой олон улсын баримт бичиг, зөвлөмжүүд;
- Бусад орнуудын туршлага. Үүнд:
    - Тэтгэмж олгох бодлого, тогтолцоо
    - Тэтгэмж олгох хугацаа
    - Тэтгэмж олгоход тавигдах шаардлага, нөхцөл болзол

Олон улсын баримт бичиг, зөвлөмжүүдийг судлах хүрээнд, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц, Нийгмийн хамгааллын тухай конвенц, Эхчүүдийг хамгаалах тухай конвенц, ОУХБ-ын Нийгмийн хамгааллын суурь түвшний тухай зөвлөмж, ОУХБ-аас гаргасан Албан бус эдийн засагт ажиллагсдыг жирэмсний болон амаржсаны тэтгэмжид хамруулах зөвлөмж гэх мэт олон улсад дагаж мөрддөг баримт бичиг, зөвлөмжүүдийг авч үзсэн бөгөөд Хүүхэдтэй болсон эх эцэгт цалинтай чөлөө олгохтой холбоотой бодлогын судалгааны тоймыг мөн багтаасан.

Бусад орнуудын туршлагын хүрээнд, Герман, Финланд, Норвеги, Тайвань (БНХАУ), Монгол зэрэг орнуудын холбогдох хууль эрх зүйн орчин, бодлого, тогтолцооны асуудлуудыг харьцуулан судалсан болно. Улс орны сонголтыг хийхдээ жирэмсэн болон амаржсан эхийг хамгаалах тогтолцоо сайн хөгжсөн Скандинавын орнуудаас Финланд, Норвеги, эцэг эхийн тэтгэмж ба чөлөө олгох харьцангуй сайн хуультай Герман, Зүүн Азийн орнуудаас Тайванийг оруулсан болно.

*Түлхүүр үгс: жирэмсэн ба амаржсан эхийн тэтгэмж, хүүхэд асрах тэтгэмж, төрсний дараах эцэг эхийн чөлөө.*

*Keywords: Maternity leave; maternity benefits; parental leave; benefit for a new mother.*

## СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Судалгаанаас үзэхэд, бусад орнуудын гэр бүлийн талаар төрөөс баримтлах бодлогын нэг чухал хэсэг нь жирэмсэн эмэгтэйчүүд, амаржсан эх, нялхсыг хамгаалах, тэтгэмж тусламж олгох, хүүхэдтэй гэр бүлд хөнгөлөлт, чөлөө олгох зэрэг нийгмийн халамжийн дараах арга хэмжээнүүд байна.[238] Үүнд:

- Эхчүүдийн жирэмсэн үе болон төрөх үеийн эмнэлгийн үйлчилгээ;
- Жирэмсний болон амаржсаны дараах тэтгэмжтэй амралт, чөлөө;
- Нялх болон бага насны хүүхдийн эрүүл мэндийн хяналт;
- Хүүхэд асрах, хүмүүжүүлэх амралт, чөлөө (эцэг, эхийн);
- Хүүхдэд олгох тэтгэмж;
- Татварын хөнгөлөлт;
- Орон сууцны нөхцөл сайжруулахад зориулсан бага хүүтэй зээл ба субсиди  болон бусад төрлийн дэмжлэгүүд  багтаж байна.

[238] Амаржсан эхчүүдэд үзүүлдэг нийгмийн халамж, үйлчилгээний талаарх гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалт, туршлага, Судалгааны эмхэтгэл XVII боть, Р.Хатанбаатар, А.Пагма, Ө.Мөнхтунгалаг

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Судалгааны сэдвийн хүрээнд амаржсан ээжид хүүхэд харсны тэтгэмж олгох бодлого, эрх зүйн орчин, ямар шаардлага, нөхцөлөөр ямар хугацаанд олгодог гэх мэтийн асуудлуудыг харьцуулан судлав.

**Олон улсын баримт бичиг, зөвлөмжийн тухайд**: Хүний эрх, нийгмийн хамгааллын талаарх олон улсын гэрээ хэлэлцээр, баримт бичгүүдэд эхчүүдийн хүүхэд асрах, тэтгэмж чөлөө авах эрхийг баталгаажуулсан байдаг. Амаржсан эхэд хүүхэд харсны тэтгэмж олгохтой холбоотой зарим томоохон олон улсын конвенц, зөвлөмжүүдийг тоймлон дурдвал:

- Хүний эрхийн түгээмэл тунхаглал;
- Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц;
- Нийгмийн хамгааллын тухай 1952 оны 102 дугаар конвенц;
- Эхчүүдийг хамгаалах тухай 2000  оны 183 дугаар конвенц (1952 оны 103 дугаар конвенц);
- ОУХБ-ын Нийгмийн хамгааллын суурь түвшний тухай 2012 оны 202 дугаар зөвлөмж;
- ОУХБ-ын Албан бус эдийн засагт ажиллагсдыг жирэмсний болон амаржсаны тэтгэмжид хамруулах тухай 2015 оны 204 дугаар зөвлөмж гэх мэт.

<u>Жирэмсний болон амаржсаны дараах тэтгэмж:</u> Эхчүүдийг хамгаалах тухай 103 дугаар конвенцод Монгол Улс нэгдээд байгаа бөгөөд энэхүү конвенцын 3-р зүйлд жирэмсний болон хүүхэд төрүүлсний дараа чөлөө олгох талаар, 4-р зүйлд жирэмсэн болон хүүхэд төрүүлсэн эхэд мөнгөн болон эмнэлгийн үйлчилгээний тэтгэмж олгох талаар, 5-р зүйлд хүүхдээ хөхүүлэх зорилгоор ажлаас завсарлах эрхийн талаар, 6-р зүйлд жирэмсний болон хүүхэд төрүүлсний чөлөөнд буй эмэгтэйг халах тухай шийдвэр гаргахыг хууль бус гэж үзэх талаар тус тус заасан байна.

Энэхүү конвенц нь эхчүүдийг хамгаалах талаар хамгийн сүүлд батлагдсан конвенц бөгөөд гишүүн орнууд өөрийн орны хууль тогтоомжийн хүрээнд мөнгөн тэтгэмжийг нийгмийн даатгал, улсын төсөв болон бусад эх үүсвэрээс санхүүжүүлэн албан журмаар олгохыг зөвлөсөн. Мөн жирэмсэн болон амаржсан эхэд олгох тэтгэмж нь эхийн өөрийн болон хүүхдийн эрүүл мэндийг хамгаалахуйц зохистой түвшинд байх, амьжиргааны түвшинг баталгаатай хангахуйц байх, цалингийн гуравны хоёроос багагүй байх нөхцөлийг заасан. Энэ конвенцын жирэмсний болон амаржсаны тэтгэмжтэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг судалгааны хэсгээс үзнэ үү.

<u>Албан бус эдийн засгийн салбарт ажилладаг эхчүүдийг жирэмсний болон амаржсаны тэтгэмжид хамруулах талаар</u> 2016 онд Олон Улсын Хөдөлмөрийн байгууллга (ILO)-аас 204 дүгээр зөвлөмж гаргасан. Дэлхий даяар хөдөлмөр эрхэлж байгаа нийт эмэгтэйчүүдийн 28 хувь нь л жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах боломжтой байгаа бөгөөд үүний гол шалтгаан нь тэтгэмжид хамрагдаж чадахгүй байгаа эхчүүдийн дийлэнх нь албан бус секторт ажиллаж байгаагаас үүдэлтэй байна хэмээн дурджээ.

Уг зөвлөмжид эхчүүдийг хамгаалах хөтөлбөрт албан бус секторт ажилладаг эхчүүд хамрагдахгүй байгааг онцгойлон анхаарч “нийгмийн хамгаалал, түүний дотор эхчүүдийн хамгааллын хамрах хүрээг аажмаар өргөжүүлж, албан бус салбарт ажилладаг эхчүүдийг бүрэн хамруулах асуудлыг хуульчлах, хэрэгжилтийг хангах арга хэмжээ авах”-ыг гишүүн орнууддаа зөвлөсөн байна. Улс орнуудын засгийн газруудад жендэрийн эрх тэгш байдлыг дэмжих, албан эдийн засагт шилжүүлэх боломжийг бүрдүүлэх үүднээс хүүхэд асрах болон бусад үйлчилгээг бий болгох, хүртээмжийг  нэмэгдүүлэх нь зүйтэй гэж уг зөвлөмжийн 21 дэх хэсэгт дурджээ.

Эх эцэгт хүүхэд асрах цалинтай чөлөө олгох асуудлыг судлах олон улсын бодлогын судалгааны сүлжээ (The International Network on Leave Policies and Research) байгууллага байдаг бөгөөд уг байгууллагаас хийсэн судалгаанаас үзэхэд дэлхийн олон улс оронд жирэмсний болон амаржсаны чөлөөг олгохдоо орлогын хэмжээтэй дүйцүүлэн тэтгэмжийн дээд хязгаарыг тогтоодог байна.

Судалгаанд авагдсан орнуудын туршлагаас үзвэл (хүснэгт 1), ихэнх улс оронд жирэмсний болон амаржсаны чөлөө, тэтгэмжийн асуудлыг бие даасан хууль, хөдөлмөрийн хууль, даатгалын тухай хууль, бусад холбогдох эрх зүйн баримт бичгүүдээр зохицуулсан байна.

**Герман** улсын хувьд жирэмсний чөлөө, тэтгэмж, ажил эрхлэлтийн асуудлыг “Амаржсан эхийг хамгаалах тухай” хуулиар зохицуулдаг. Жирэмсний болон амаржсаны чөлөө нь 14 долоо хоног байх ба үүний 6 долоо хоног нь төрөхийн өмнөх, 8 долоо хоног нь төрсний дараах чөлөө байдаг. Төрөхийн өмнөх чөлөөний хугацаанд эх хүсвэл цалинтай ажил хийж болдог бол төрсний дараах 8 долоо хоногт чөлөөгөө заавал эдлэх ёстой. Жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг цалинтай ажил эрхэлдэг эхчүүдэд төрөхийн өмнөх орлогын 100-иар тооцож олгодог бол ажилгүй болон хувиараа хөдөлмөр эрхлэгч, бага орлоготой, ажилгүйдлийн тэтгэмж авдаг эхчүүдэд дүйцүүлэн олгох, эсвэл НДС-аас 210 еврогийн тэтгэмж олгодог байна.

Амаржсаны дараа 8 долоо хоногийн чөлөөний хугацаа дуусмагц эх, эцгүүд нь хүүхдээ 3 нас хүртэл нь асрах чөлөөг авах эрхтэй. Үүнийг эцэг, эхийн аль аль нь авч болох ба хамтдаа ч авах боломжтой. Хүүхэд асрах чөлөөний хугацаанд өрхийн орлогоос хамаарч 300-1800 еврогийн тэтгэмж авдаг. Мөн хүүхдийн тоо, орлогын хэмжээ зэргийг харгалзан энэ хугацаанд хүүхэд асаргааны нэмэлт тэтгэмжүүд, гэр бүлийн бонус хөнгөлөлтүүд (үүнд: *ажлын цагийг багасгах, чөлөөний хугацааг сунгах, нэмэлт тэтгэмж*) олгох, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй, ганц бие эцэг, эсвэл эхэд тусгай нэмэлт тэтгэмж олгох, уян хатан нөхцөлийг тавих зэрэг өргөн боломжуудыг олгодог байна. Эдгээр зохицуулалт нь Холбооны улсын хэмжээнд нийтлэг мөрдөгдөх боловч Бавари, Саксони зэрэг мужуудад зарим онцлог зохицуулалттай байдаг. Тухайлбал, Хүүхэд асаргааны чөлөөтэй байх хугацаанд хорогдуулсан цагаар ажиллах, эцэг эх нь 18 нас хүрээгүй байхдаа хүүхэд төрүүлсэн бол уг чөлөөг өвөө эмээд нь олгох, хүүхдийн тооноос хамааруулан хүүхэд асаргааны нэмэлт тэтгэмжүүдийг олгодог гэх мэт туршлагууд байна.

**Финланд** улсад төрөлт харьцангуй буурсан учраас 1948 оноос хойш төрөлт болон гэр бүлийг дэмжих бодлого, хөтөлбөрүүд хэрэгжүүлж эхэлсэн. Энэхүү бодлого нь эхчүүдэд хүүхдээ тээж төрүүлэх, өсгөн бойжуулах аюулгүй, таатай орчин нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдэж байгаа бөгөөд хүүхэд өсгөж буй гэр бүлд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, тусламж үйлчилгээ үзүүлэх, гэр бүлийн чөлөө олгох гэсэн гурван гол дэмжлэгийг үзүүлэх замаар хэрэгжиж иржээ. Тус улсад хүүхэд асрах чөлөөг “Хөдөлмөрийн гэрээний тухай” хуулийн дагуу ажил олгогчоос олгодог байна. Нийгмийн даатгалын байгууллагаас хүүхдийн мөнгө, эрүүл мэндийн даатгал, ажилгүйдлийн тэтгэмж, гэр бүлийн тэтгэмжийг олгодог. Тус байгууллага нь татварын сан, даатгалын шимтгэлээр санхүүждэг. Хүүхэд асрах тэтгэмж нь хүүхдээ гэртээ асарсны тэтгэмж, хувийн өдөр өнжүүлэхийн тэтгэмж, асаргааны уян хатан тэтгэмж, асаргааны хэсэгчилсэн тэтгэмж гэх мэт хэлбэртэй байна. Хүүхэд асарсны тэтгэмжид цалингийн нэгэн адилаар 25%-ийн татвар ногдуулна.

**Норвеги** улсын нийгмийн халамжийн тогтолцоо нь нэлээд өгөөмөрт тооцогддог. Шаардлагатай тохиолдолд жирэмсний хугацаандаа эмэгтэйчүүд 12 долоо хоног хүртэл цалинтай чөлөө авах эрхтэй. Төрсний дараа эхийн эрүүл мэндийг хамгаалах үүднээс 6

UIH.MN СУДАЛГААНЫ САН

долоо хоногийн чөлөөг зайлшгүй биеэр эдлэхийг шаарддаг. Эцэг, эх хамтдаа хүүхдээ 3 нас хүртэл асрах эрхтэй байна. Тэтгэмжийн хэмжээнээс хамааруулан төрөхийн өмнөх 3 долоо хоногийн чөлөөг оролцуулан 49 долоо хоног орлогын 100%-тай тэнцэх тэтгэмж олгох буюу эсхүл 59 долоо хоног орлогын 80%-тай тэнцэх хэмжээний тэтгэмж олгодог байна.

Эх, эцгийн хүүхдээ асрах хугацааны чөлөөг эх, эцгийн хүсэлтийг харгалзан уян хатан олгох бөгөөд онцгой тохиолдолд чөлөөгөө бие биендээ шилжүүлэх боломжтой. Эцэг эхийн хүүхэд асрах чөлөөг эдлэх эрх бүхий ганц бие эх, эцэгт хүүхэд асрах эрхийг шууд олгоно. Хүүхэд асрах тэтгэмжтэй чөлөө дууссаны дараа ч эцэг, эхчүүд хүүхдээ асрах нэг жилийн цалингүй чөлөө авах эрхтэй байна.

Тус улсад сургуулийн өмнөх боловсролын хүрээнд улсын цэцэрлэг үнэ төлбөргүй үйлчилдэг. Хэрэв 1-2 насны хүүхдээ цэцэрлэгт хамруулалгүй өөрсдөө асрах сонирхолтой бол тухайн эцэг, эх хүүхэд асрах тэтгэмжид 1 жилийн хугацаагаар хамрагдах эрхтэй.

Нэмэлт асаргаа шаардлагатай хүүхэд буюу хүүхэд өвдсөн тохиолдолд 12-оос доош насны 1-2 хүүхэдтэй ажилтнууд жилд нэг удаа ажлын 10 хоногийн, 2-оос дээш хүүхэдтэй бол жилд нэг удаа ажлын 15 хоногийн, ганц бие эцэг, эх жилд нэг удаа 20-30 хоногийн цалинтай чөлөө тус тус авах эрхтэй байна. Хүнд болон ужиг өвчтэй хүүхдээ асрах шаардлагатай эцэг, эхчүүд хүүхдээ 18 нас хүртэл жил бүр дээрх чөлөөг уртасгасан хугацаагаар авах эрхтэй. Эцэг, эхчүүд хүүхдээ 10 нас хүртэл хагас цагаар ажил эрхлэх боломжтой байдаг байна.

**Монгол** Улсын хувьд жирэмсний болон амаржсаны чөлөө нь 120 хоног байна. Чөлөөний хугацаанд олгох тэтгэмжийг ажил эрхэлдэг буюу заавал даатгуулагч эхэд 12 сарын хөдөлмөрийн хөлс, орлогын дунджаас 100 хувиар тооцож, харин сайн дурын даатгуулагч эхийн хувьд шимтгэл төлсөн сүүлийн 12 сарын хөдөлмөрийн хөлс, орлогын дунджаас 70 хувиар тооцон мөн тэтгэмжийн даатгалын сангаас 4 сарын хугацаанд тус тус олгоно. Нийгмийн даатгалын сангаас жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрх үүсээгүй эх жирэмсний 5 сартайгаас эхлэн 12 сарын хугацаанд сар тутам тэтгэмж авах эрхтэй. Хүүхэд асрах чөлөөг эх, эцэг өөрөө хүсвэл хүүхдээ 3 нас хүртэл нь авах эрхтэй. Мөн жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эхийн ажлын цагийг хорогдуулах, хөдөлмөрийн нөхцөлийг хөнгөлөх зэрэг зохицуулалт байна.

(Дэлгэрэнгүй мэдээллийг судалгааны хэсгээс үзнэ үү)

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**Хүснэгт 1. Судалгаанд авагдсан орнуудын мэдээллийн харьцуулалт**

| Улсын нэр | Эрх зүйн зохицуулалт | Тэтгэмж олгох бодлого, тогтолцоо | Тэтгэмж олгох хугацаа | Шаардлага шалгуур үзүүлэлт |
|---|---|---|---|---|
| **Герман** | Германд хүүхэд төрүүлсэн эхэд олгох чөлөө, тэтгэмжтэй холбоотой асуудлыг дараах хуулиар зохицуулж байна. Үүнд:<br>-Амаржсан эхийг хамгаалах тухай хууль (Maternity Protection Act)<br>-Эцэг, эхийн тэтгэмж ба чөлөөний тухай хууль (Parental Allowance and Parental Leave Act)<br>-Үндэсний даатгалын журам (National Insurance Regulation)<br>-Тэгш байдлын тухай ерөнхий хууль (General Act on Equal Treatment) | Амаржсан эхийг хамгаалах тухай хуулиар ажил эрхэлдэг эхчүүдийн жирэмсний болон амаржсаны тэтгэмж, чөлөө, ажил эрхлэлтийн асуудлыг зохицуулдаг ба 2018 онд уг хуулинд өөрчлөлт орж, хамрах хүрээг өргөжүүлж дадлагажигч, оюутнууд, хувиараа хөдөлмөр эрхэлдэг эмэгтэйчүүдийг энэ хуулийн зохицуулалтад хамруулсан. | *Төрсний дараах тэтгэмж:*<br>14 долоо хоног байна: төрөхийн өмнө 6 долоо хоног, төрсний дараа 8 долоо хоног байна. Үүнд, төрсний дараах 8 долоо хоногийн чөлөө нь заавал олгох ёстой чөлөө юм.<br>*Эцэг эхийн тэтгэмж:* **Үндсэн болон нэмэлт** гэсэн 2 төрлийн тэтгэмжийг олгодог. Энэ нь 12-14 сар байна.<br>*Хүүхэд асрах тэтгэмж:* Хүүхэд асрах чөлөөг 0-3 нас хүртэл өгнө. | Герман улсад оршин суух эсхүл ажил эрхлэх гэрээний шаардлагуудыг хангасан дараах эмэгтэйчүүд энэхүү тэтгэмжинд хамрагдана:<br>- Бүх эмэгтэй ажил эрхлэгчид. Үүнд хагас цагаар ажиллагсад болон албан журмын нийгмийн даатгалын хэмжээнд хүрэхээргүй (сард €450-аас бага орлого олдог) орлоготой эмэгтэйчүүд хамаарна.<br>- Оюутан, сурагчид<br>- Эмэгтэй сайн дурын ажилтнууд (нийгмийн эсхүл экологийн сайн дурын)<br>- Хувиараа хөдөлмөр эрхлэгч эмэгтэйчүүд<br>- Орогнол хүсэгчид<br>Оюутан, сурагч, сайн дурын ажил эрхэлдэг эмэгтэйчүүд, хувиараа хөдөлмөр эрхлэгчид ба орогнол хүсэгчид нь (гэр бүлийн эсхүл хувийн даатгалаар хамгаалагдсан тохиолдолд) жирэмсний болон төрсний чөлөөний хамгийн бага тэтгэмжийг авна. |
| **Финланд** | Жирэмсний тэтгэмж, жирэмсний амралт, эцэг эхийн чөлөө, эцэг эхийн тэтгэмж, хүүхэд асарсны тэтгэмжийг олгохдоо<br>-Хөдөлмөрийн тухай хууль (Employment & Labour Laws)[239]<br>-Нийгмийн халамжийн тухай хууль (Social | Нийгмийн даатгалын байгууллагаас (The Social Insurance Institution of Finland)[244] нь хүүхдийн мөнгө, эрүүл мэндийн даатгал, ажилгүйдлийн тэтгэмж, гэр бүлийн тэтгэмжийг олгодог. Тус байгууллага нь татварын сан, даатгалын шимтгэлээр санхүүждэг. Тэтгэмжийн төрлийн хувьд:<br>-Жирэмсний тэтгэмж<br>-Төрсний дараах тэтгэмж | *Төрсний дараах тэтгэмж:*<br>ажлын 54 өдрийн чөлөө олгох бөгөөд төрөхөөс өмнө хамгийн багадаа 180 хоног нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байх шаардлагатай.<br>*Эцэг эхийн тэтгэмж:* ажлын 158 өдрийн цалинтай чөлөө байх бөгөөд эцэг эхийн аль нь ч авч болно.<br>*Хүүхэд асрах тэтгэмж:* энэ үед | Төрсний дараах тэтгэмж нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, ажилгүй болон оюутан эцэг эхчүүдэд бүгдэд нь хамаарах бөгөөд төрөхөөс өмнө хамгийн багадаа 180 хоног нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байх шаардлагатай. |

[239]Employment and Labour Laws https://iclg.com/practice-areas/employment-and-labour-laws-and-regulations/finland
[244] The Social Insurance Institution of Finland https://www.kela.fi/web/en/organization

| | | | | |
|---|---|---|---|---|
| | Welfare Act)[240],<br>-Хүүхдийн халамжийн тухай хууль (Child Welfare Act)[241],<br>-Хүүхэд асрах тэтгэмжийн тухай хууль (Child Home Care and Private Day Care Allowance)[242],<br>-Жирэмсний тэтгэмжийн тухай хууль (Maternity Benefit Act)[243] | -Эцэг эхийн тэтгэмж<br>-Хүүхэд асрах тэтгэмж... гэж байдаг байна. | хүүхэд ойролцоогоор 9 сар хүрсэн байдаг бөгөөд хүүхдээ өөрөө харах эсхүл улсын, хувийн цэцэрлэгээр харуулж болно. Хүүхэд асрах чөлөөг 0-3 нас хүртэл өгнө. | |
| **Норвеги** | Норвеги улсад хүүхэд төрүүлсэн эх болон эцэгт хүүхдээ асарсны чөлөөг:<br>-Хөдөлмөрийн орчны тухай хууль (Work Environment Act 2005)<br>Тэтгэмжийг:<br>-Үндэсний даатгалын тухай хууль (National Insurance Act)-аар зохицуулж байна. | Хүүхэд асрах чөлөө, тэтгэмжийг "Эцэг эхийн чөлөө, тэтгэмж" (Parental leave, benefit) гэж нэрлэдэг байна. Хөдөлмөрийн орчны тухай хуульд зааснаар хүүхэд асарсны чөлөөг Хөдөлмөрийн яам (Ministry of Labour), хүүхэд асарсны тэтгэмжийг Хүүхэд, гэр бүлийн яам (Ministry of Children and Families) тус тус хариуцан олгодог ажээ. | <u>*Төрсний дараах тэтгэмж:*</u> ажлын 6 долоо хоног (42 хоног) байдаг бөгөөд шаардлагатай бол 12 долоо хоног хүртэл цалинтай чөлөө авах эрхтэй.<br><u>*Эцэг эхийн тэтгэмж:*</u> эхэд 6 долоо хоног ажлаас чөлөө өгдөг бол эцэгт 2 долоо хоногийн чөлөө олгодог.<br><u>*Хүүхэд асрах тэтгэмж:*</u> Эцэг эх хоёулаа нийт 12 сарын хүүхэд асрах чөлөө авах эрхтэй.<br>Хүүхэд асрах чөлөөг 2 хүртэлх жил эдлэх эрхтэй. | -Төрөхөөс өмнөх сүүлийн 10 сарын 6 сард нь ажил эрхлэн, өмнөх жилдээ наад зах нь үндэсний даатгалын үндсэн тэтгэмжийн талаас багагүй хэмжээний хөлс авч байсан бүх эмэгтэйчүүд тэтгэмж авах эрхтэй.<br>-Хувиараа хөдөлмөр эрхлэгчид тэтгэмжид хамрагдах эрхтэй.<br>-Хөдөлмөр эрхлээгүй эмэгтэйчүүд хүүхэд бүрд зориулсан нэг удаагийн тэтгэмж авах эрхтэй. Хөдөлмөр эрхлээгүй эмэгтэйчүүд хүүхэд өргөж авсан тохиолдолд мөн нэг удаагийн тэтгэмжид хамрагдах эрхтэй. |
| **Тайвань (БНХАУ)** | Тайваньд төрсний дараах тэтгэмжийн асуудлыг:<br>-Хөдөлмөрийн стандартын тухай хууль (Labor Standards Act) | Тайваньд төрсний дараах тэтгэмжийн асуудлыг Хөдөлмөрийн яамны харьяа Хөдөлмөрийн даатгалын товчоо (Bureau of Labor Insurance)[245] хариуцдаг бөгөөд энэ байгууллага нь нийгмийн | <u>Жирэмсний амралт</u>- жирэмсний өмнө болон хойно хугацаанд 8 долоо хоног амралт авах эрхтэй. Зулбасан тохиолдолд, 3 сар өнгөрсөн бол 4 долоо хоног, 2-3 сар өнгөрсөн бол 1 долоо хоног, | 6 сараас доошгүй ажилласан, даатгалд хамрагдсан ажилтнуудад жирэмсний дараах тэтгэмж олгох эрх үүсдэг. Даатгуулагч нь төрөх, дутуу төрөх тохиолдолд жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг сүүлийн 6 сарын сарын цалингийн дунджаар тооцож, |

[240] Social Welfare Act https://www.finlex.fi/fi/laki/kaannokset/1982/en19820710_20140491.pdf
[241] Child Welfare Act https://www.finlex.fi/en/laki/kaannokset/2007/en20070417_20131292.pdf
[242] Child Home Care and Private Day Care Allowance https://www.finlex.fi/fi/laki/alkup/1996/19961128
[243] Maternity Benefit Act https://clc.gov.in/clc/ыsites/default/files/MATERNITY%20BENEFIT%20ACT.pdf
[245] https://www.bli.gov.tw/En/

| | | | | |
|---|---|---|---|---|
| | -Хөдөлмөр эрхлэлтийн жендэрийн тэгш байдлын туха хууль (Act of Gender Equality in Employment)<br>-Хөдөлмөр эрхлэлтийн даатгалын тухай хууль (Employment Insurance Act)<br>-Эцэг эхэд хүүхэд асарсны цалингүй чөлөө олгох журам (Regulations for Implementing Unpaid Parental Leave for Raising Children) зэрэг актуудаар зохицуулж байна. | хамгаалал болон даатгалын бүхий л үйл ажиллагааг хариуцдаг байна. | 2 сар хүрэхгүй хугацаа өнгөрсөн бол 5 хоног амрах эрхтэй.<br><u>Хүүхэд асрах чөлөө</u>- 6 сараас дээш ажилласан эхнэр, нөхөр 3-аас доош насны хүүхэдтэй бол 2 жилийн хугацаанаас хэтрэхгүй хүүхэд асрах чөлөө авч болно. 2-оос дээш хүүхэдтэй бол нэг дор тооцох бөгөөд хамгийн бага хүүхдийн 2 жилээр хязгаарлагдана.<br><u>Эцэг эхийн амралтын тэтгэмж</u>-хүүхэд асрах чөлөө авахаас өмнө даатгуулагчийн цалингийн 60 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг сар бүр авна. | 60 хоногийн цалинтай тэнцэх хэмжээний мөнгийг авна. Олон хүүхэд төрүүлсэн тохиолдолд төлбөрийг хувь тэнцүүлэн нэмэгдүүлнэ.<br>Мөн Хөдөлмөр эрхлэлтийн жендэрийн тэгш байдлын тухай хууль (Act of Gender Equality in Employment)-ийн 16.5 дахь хэсэгт заасны дагуу гаргасан Хүүхэд өсгөсний эцэг эхийн цалингүй чөлөө олгох журам (Regulations for Implementing Unpaid Parental Leave for Raising Children)–ын дагуу шаардлагаар тэтгэмж, чөлөө олгож байна. |
| **Монгол Улс** | Монгол Улсын хувьд жирэмсний болон амаржсаны тэтгэмжтэй холбоотой харилцааг дараах хууль тогтоомжоор зохицуулж байна:<br>1. Нийгмийн даатгалын тухай хууль (1994 он)<br>2. Нийгмийн халамжийн тухай хууль (2012 он)<br>3. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль (1994 он)<br>4. Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хууль (2017 он)<br>5. Хөдөлмөрийн тухай хууль (1999 он) | Жирэмсэн болон амаржсан эхэд олгох тэтгэмжийг нийгмийн даатгалын сан, нийгмийн халамжийн сангаас санхүүжүүлдэг. Жирэмсэн эмэгтэй болон эмэгтэйчүүдийг хүүхэд төрүүлэхийг дэмжих, тэдний эрхийг хамгаалах зорилгоор Хөдөлмөрийн тухай хуулиар жирэмсний чөлөөтэй байх хугацаанд түүний ажил, албан тушаалыг хадгалах, мөн өөрөө зөвшөөрөөгүй бол илүү цагаар ажиллуулахыг хориглосон байна.<br>Мөн хүүхдээ асарсны тэтгэмжийг зөвхөн эхэд олгодог байсныг Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн гэж үзсэн тул 2021 оны 5 дугаар сараас эхлэн 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа болон дөрөв хүртэлх насны ихэр хүүхэдтэй эх, эцэг, гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эцэгт тэтгэмжийг олгохоор шийдвэрлэсэн. | 1. <u>Жирэмсний болон амаржсаны тэтгэмж</u><br>Тэтгэмжийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн 12 сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас 100 хувиар тооцож 4 сарын хугацаанд;<br>Ихэр хүүхэд төрүүлсэн эхэд тэтгэмжийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн 12 сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас 100 хувиар тооцож 4 сар 20 хоногийн хугацаанд.<br>2. <u>Жирэмсэн эхийн тэтгэмж</u><br>Жирэмсний 5 сартайгаас төрөх хүртэл хугацаанд (40.000 төгрөг)<br><u>3. 0-3 насны хүүхдээ асарч байгаа эх, эсхүл эцэг (</u>50.000 төгрөг)<br>3.<u>Ихэр хүүхдийн тэтгэмж</u> ихэр хүүхэдтэй бол тус бүрт 1,0 сая төгрөгийг 1 удаа тус тус олгоно. | Нийгмийн даатгалын сангаас олгох жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг:<br>1.Тэтгэмжийн даатгалын шимтгэлийг жирэмсний чөлөө авахаас өмнө 12 сараас доошгүй хугацаанд, үүнээс сүүлийн 6 сард нь уг шимтгэлийг тасралтгүй төлсөн даатгуулагч эх;<br>2.тэтгэмжийн даатгалын шимтгэл төлөх хугацааг хангасан даатгуулагч эх, хүүхдээ 196-аас доошгүй хоног тээгээд дутуу төрүүлсэн буюу үр хөндүүлсэн, жирэмслэлтийг эмнэлгийн аргаар тасалсан, мөн 196 хоног тээгээгүй боловч амьдрах чадвартай хүүхэд төрүүлсэн бол;<br>3.Хөдөлмөр эрхэлж байгаад хууль тогтоомжид заасны дагуу хүүхдээ асрах чөлөөтэй байх хугацаанд дахин хүүхэд төрүүлсэн эх тус тус тэтгэмж авах эрхтэй. |

## СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ

## НЭГ. ЖИРЭМСЭН БОЛОН АМАРЖСАН ЭХЭД ТЭТГЭМЖ ОЛГОХТОЙ ХОЛБООТОЙ ОЛОН УЛСЫН БАРИМТ БИЧИГ, ЗӨВЛӨМЖҮҮД

Хүний эрхийн талаарх олон улсын гэрээ, конвенцуудаар эхчүүдийн эрхийг баталгаажуулсан байдаг.[246] Тухайлбал, Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 25 дугаар зүйлд "Эх, нялхас онцгой асрамж, туслалцаа авах эрхтэй", Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 10-ын 10.2 дугаар зүйлд "Эхчүүдийг хүүхэд төрүүлэхийн өмнөх болон дараах тодорхой хугацаанд онцгойлон хамгаална. Ажил хийж байгаад хүүхэд төрүүлсэн эхчүүдэд энэ хугацаанд цалинтай чөлөө, нийгмийн хамгааллын зохих тэтгэмжийг олгох ёстой" гэж заасан бол Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын удиртгал хэсгийн 11-ийн 11.2 дугаар зүйлд эхчүүд хамгаалагдах, түүний дотор ялгаварлан гадуурхагдахгүй байх, цалинтай чөлөө авах эрх, хүүхдээ асрах боломжоор хангагдах эрхийг хүний чухал эрх хэмээн онцолсон байна. Мөн нийгмийн хамгааллын тухай 1952 оны 102 дугаар конвенц ба Эхчүүдийг хамгаалах тухай 2000 оны 183 дугаар конвенцод гишүүн орнууд үндэснийхээ түвшинд эхчүүдийн зохистой хамгаалах тогтолцоог бүрдүүлэхэд баримтлах олон талт бодлогын хүрээг тодорхойлсон байдаг. Энэхүү конвенц нь хөдөлмөр эрхэлж байгаа нийт эмэгтэйчүүд болон албан бус секторт ажилладаг эмэгтэйчүүдэд ялгаваргүй үйлчилнэ. Ингэхдээ үндэсний хууль тогтоомжийн дагуу эхчүүдэд мөнгөн тэтгэмж олгохдоо нийгмийн даатгал, улсын төсөв, эсвэл бусад аргаар санхүүжүүлэн албан журмаар олгох нь зүйтэй хэмээн зөвлөсөн.

Эхчүүдийг хамгаалах тухай 2000 оны 183 дугаар конвенцийн хэрэгжилтийн талаарх ОУХБ-аас гаргасан судалгааны тайланд тэмдэглэснээр, судалгаанд хамрагдсан 185 орны хоёроос бусад нь жирэмсний болон амаржсаны чөлөөтэй хугацаанд тэтгэмж буюу цалин олгодог, мэдээллээ өгсөн 155 орны 80 гаруй хувь нь эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхахыг хориглосон тодорхой зохицуулалт бий болгосон, 43 орон "жирэмсэн", эсвэл "жирэмсэн буюу амаржсан" гэсэн үндэслэлээр ялгаварлан гадуурхахыг хориглосон байна. Конвенцын гол заалтуудыг хэрэгжүүлж байгаа орнуудын тоо нэмэгдэж байгаа хэдий ч эхчүүдийг хамгаалах хөтөлбөрт хамрагдахгүй байгаа эхчүүд ч байсаар байна.

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагаас (ОУХБ) гаргасан Нийгмийн хамгааллын суурь түвшний тухай 2012 оны 202 дугаар зөвлөмжид улс орнууд нийгмийн хамгааллын суурь түвшинг нийгмийн хамгааллын цогц тогтолцооныхоо нэгэн хэсэг болгож бүрдүүлэхээр заасан. Нийгмийн хамгааллын эдгээр суурь баталгаанд наад зах нь нэн шаардлагатай эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, түүний дотор эхэд үзүүлэх тусламж үйлчилгээ, бүх эмэгтэйчүүд жирэмслэх буюу амаржих үедээ амьжиргааны доод түвшнийг хангахуйц суурь орлогоор хангагдах зэрэг баталгаа орно. Энэ нь "нэр төртэй амьдрах боломж бүрдүүлэх" ёстой гэж 8 дахь хэсэгт заасны дагуу эхчүүдийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зардал гаргаснаас санхүүгийн хүндрэлд орох, ядууралд өртөхөөс сэргийлэх ач холбогдолтой заалт юм.

**Эхчүүдийг хамгаалах тухай Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ILO)-ын конвенц**

Дэлхийн 195 орны ихэнх улсад жирэмсний ба амаржсаны тэтгэмжийг хуульчилсан байдаг бөгөөд зарим нь 19-р зууны сүүлчээр батлагдсан байдаг бол цөөн хэдэн улс энэ харилцааг зохицуулсан тусгайлсан хуульгүй байна. Энэ асуудлаар Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ОУХБ) анх 1919 онд эхчүүдийг хамгаалах 3-р конвенцыг баталсан. Түүнээс хойш ОУХБ-аас ажлын байранд эхчүүдийг хамгаалах асуудалд онцгой анхаарал хандуулж 1952 оны 103-р конвенц, 2000 оны 183-р конвенцыг баталсаны дээр, 1952 оны 95-р зөвлөмж, 2000 оны

[246] Албан бус эдийн засагт ажиллагчдыг жирэмсний болон амаржсаны тэтгэмжид хамруулах нь, Олон улсын хөдөлмөрийн товчоо. 2016. https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---asia/---ro-bangkok/---ilo-beijing/documents/publication/wcms_544098.pdf

191-р зөвлөмжийг дагалдуулан гаргасан. ОУХБ-ын бусад олон конвенцууд эхчүүдийг хамгаалах асуудлыг шууд болон шууд бусаар хөндсөн байдаг. Тухайлбал гэр бүлийн хариуцлагын тухай конвенц (No156, 1981), Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай конвенц (No155, 1981), Гэрийн ажил эрхэлдэг хүмүүсийн тухай конвенц (No 189, 2011) гэх мэт орно.[247]

Үүнээс Монгол Улсад эхчүүдийг хамгаалах тухай ОУХБ-ын 103 дугаар конвенцыг одоогоор батлаад байна.[248] Энэхүү конвенцын 3-р зүйлд жирэмсний болон хүүхэд төрүүлсний чөлөө олгох талаар, 4-р зүйлд жирэмсний болон хүүхэд төрүүлсний чөлөөнд байгаа эмэгтэйд мөнгөн болон эмнэлгийн үйлчилгээний тэтгэмж олгох талаар, 5-р зүйлд хүүхдээ хөхүүлэх зорилгоор ажлаас завсарлах эрхийн талаар, 6-р зүйлд жирэмсний болон хүүхэд төрүүлсний чөлөөнд буй эмэгтэйг халах тухай шийдвэр гаргах нь хууль бус байх талаар заасан байна.

Харин 183-р конвенц нь эхчүүдийг хамгаалах талаар гарсан хамгийн сүүлийн конвенц ба тухайн улсын хууль тогтоомжийн дагуу мөнгөн тэтгэмжийг албан журмаар олгох бөгөөд нийгмийн даатгал, улсын төсөв, эсвэл бусад эх үүсвэрээс санхүүжүүлэн олгохыг зөвлөсөн. Мөн жирэмсний болон амаржсаны чөлөөтэй байгаа эхэд олгох тэтгэмж нь эхийн өөрийнх нь болон хүүхдийнх нь эрүүл мэндэд зохистой нөхцөлийг бүрдүүлэх, амьжиргааны түвшинг нь алдагдуулахааргүй байх ёстой бөгөөд цалингийн гуравны хоёроос багагүй байна гэж заасан байна.

Энэхүү конвенцод жирэмсэн эх, хөхүүл эх нь өөрийн болон үр хүүхдийнхээ эрүүл мэндэд хортой гэж үзсэн ажлыг хийх үүрэг хүлээхгүй байх, жирэмслэлт болон төрөлтөөс үүдэлтэй ялгаварлан гадуурхалтаас хамгаалах зохицуулалт бүхий хууль батлахыг улс орнуудаас шаарддаг. Жирэмслэлт, төрөлт, хүүхэд асран сувилахтай холбоотойгоор ажилтны жирэмсний амралтаа авч байх хооронд эсвэл ажилдаа буцаж ирсний дараа ажил олгогч ажлаас халахыг хориглоно. Ажилдаа буцаж орсон эмэгтэйчүүдийг өмнөхтэй нь ижил албан тушаалд эсвэл ижил хэмжээгээр цалинжуулах албан тушаалд томилох ёстой. Түүнчлэн хүүхдээ хөхүүлэхийн тулд эмэгтэй хүн өдөр бүр нэг эсвэл хэд хэдэн удаа завсарлах эрхтэй байх, эсхүл ажлын цагийг богиносгох шаардлагатай гэж заасан байна.[249]

<u>Эхчүүдийг хамгаалах тухай конвенцын жирэмсний болон амаржсаны тэтгэмжтэй холбоотой онцлох заалтууд, 2000 (No.183)</u>

- Нийт 14, үүнээс долоо хоногоос доошгүй хугацаанд жирэмсний болон амаржсаны амралт эдлэх эрхтэй байна. (эсвэл 191 дүгээр зөвлөмжид заасны дагуу 18)
- Жирэмсний болон төрсний дараах амралтын хугацаанд олгох мөнгөн тэтгэмж нь эмэгтэйчүүд өөрсдөө болон хүүхдээ эрүүл саруул, зохистой түвшинд амьдрахад хүрэлцэхүйц хэмжээнд байна.
- Тэтгэмж нь тухайн эмэгтэйн өмнө авч байсан цалин хөлсний гуравны хоёроос багагүй (буюу түүнтэй дүйцэхүйц) (эсвэл 191 дүгээр зөвлөмжид заасны дагуу цалин хөлсийг бүрэн нөхөхүйц) хэмжээтэй байна.
- Тэтгэмжийг зөвхөн ажил олгогчид хариуцуулаад орхилгүй албан журмын нийгмийн даатгал, эсвэл улсын төсвөөс олгодог байх.
- Үндэсний хууль тогтоомжийн дагуу цалин орлогоос хамааралтай тэтгэмж авах эрх үүсэхгүй байгаа эмэгтэйчүүдэд нийгмийн халамжийн сангаас зохих тэтгэмж олгох.
- Эх, хүүхдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээ, түүний дотор жирэмсэн үе, төрөх үе, төрсний дараах үеийн эмнэлгийн тусламж үзүүлэх, шаардлагатай бол хэвтүүлэн эмчлэх.

[247] https://www.gifa.org/wp-content/uploads/2017/01/Intro-Maternity-Protection-Legislation-Worldwide-1.pdf
[248]Монгол улсын олон улсын гэрээ. Эхчүүдийг хамгаалах тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 103 дугаар конвенц (хянаж өөрчилсөн) https://www.legalinfo.mn/law/details/1192
[249]https://www.ilo.org/global/standards/subjects-covered-by-international-labour-standards/maternity-protection/lang--en/index.htm

**Эх эцэгт хүүхэд асрах цалинтай чөлөө олгох бодлогын судалгааны тойм**

Олон улсад хүүхдээ асрах эх эцэгт чөлөө олгох асуудлаар бодлогын судалгаа хийдэг Олон Улсын нэгдсэн сүлжээ (The International Network on Leave Policies and Research) байдаг ба Вений Их Сургуулийн санаачилгаар 2004 онд байгуулагдаж, үүнд одоогоор дэлхийн 47 орны энэ асуудлаар мэргэшсэн 60 гаруй мэргэжилтнүүд нэгдээд байна. Уг байгууллагын гишүүд эх, эцгүүдэд олгох халамж тэтгэмж, хөдөлмөр эрхлэлт, жендэрийн асуудлаар харилцан санал бодлоо солилцон, хамтран ажилладаг. Гишүүд жил бүр семинар зохион байгуулахаас гадна бодлогын тойм гаргадаг. Энэхүү тойм нь дэлхийн өнцөг булан бүрт хэрэгжиж буй эх эцэгт тэтгэмж, чөлөө олгох бодлогын шинэчлэлд хувь нэмрээ оруулдаг бөгөөд 2021 оны тоймд нийт 47 орны бодлогын тойм багтсан байна.[250]

Уг тойм судалгаанд дурдсанаар, олон улс орнууд жирэмсний болон амаржсаны чөлөө олгохдоо орлогын хэмжээнд дүйцүүлж тэтгэмжийн дээд хязгаарыг тогтоодог байна. Харин жирэмсний болон амаржсантай холбогдуулан хууль ёсны цалинтай чөлөө авах эрхгүй орнуудын нэг нь АНУ бөгөөд зөвхөн 50 ба түүнээс дээш ажилтантай компанид ажилладаг эхчүүдэд чөлөө олгодог бөгөөд 2021 онд бүх ажилчдад 12 долоо хоногийн гэр бүлийн цалинтай чөлөө олгох нэмэлт өөрчлөлтийг санаачилсан байна.[251] Харин Австрали, Исланд, Шинэ Зеланд, Норвеги, Португал, Швед улсуудад эмэгтэйчүүдийг төрөх үед болон төрсний дараа цалинтай чөлөө олгодог ба "эцэг эхийн чөлөө" гэсэн ерөнхий нэршилтэй байдаг тул хүүхдийн эцэг нь ч мөн адил эхийг орлон авах боломжтой байдаг.

Улс орнуудад төрсний дараах жирэмсний амралтын хугацаа хэдэн долоо хоногоос 12 сар хүртэл үргэлжилдэг. Зарим улс оронд ихэр төрөлт, хүндрэлтэй төрөлт, эмнэлгийн заалттай төрөлт тохиолдсон бол эхэд илүү олон хоногоор цалинтай чөлөө олгох зохицуулалттай байна.

Болгар, Чили, Хорват, Чех, Израил, Польш, Серби, Их Британи зэрэг орнуудад уян хатан чөлөө олгох бодлого баримталдаг ба эхчүүд амралтын хугацаанаасаа тодорхой хэмжээгээр эцэгт шилжүүлэх боломжтой байдаг. Харин Бүгд Найрамдах Словак улсад зөвхөн амаржсаны тэтгэмжийг эцгүүдэд шилжүүлэх боломжтой.

Дэлхийн улс орнуудад эхэд чөлөө олгох бодлогын 2 янзын чиг хандлага байна.

1. Хамгийн өргөн тархсан хандлага нь ‘Жирэмсний амралт’ гэх уламжлалт ойлголт бөгөөд энэ нь зөвхөн эмэгтэйчүүдэд зориулагдсан жирэмслэлтийн явц, төрөлтийн эхний саруудтай холбоотой эрүүл мэнд, халамжийн арга хэмжээ юм. Энэхүү хандлагаар бол эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү хугацаанд чөлөө авах эрхтэй байдаг.
2. Сүүлийн үед шинээр гарч ирж байгаа хандлага бол эмэгтэйчүүд төрсний дараа өөрийн биеэр амрахаас гадна ямар нэгэн зайлшгүй шалтгаан нэрлэхгүйгээр амралтын хоногоо хэсэгчлэн эцэгт нь шилжүүлэх боломжтой чөлөө юм. Тухайлбал, Исландад 12 сарын цалинтай чөлөөг олгодог ба эцэг эхэд тус бүр зургаан сар ногддог. Үүнээс эцэг эх нь зургаан долоо хоногийг өөр хоорондоо шилжүүлэх боломжтой байдаг. Исландын энэ загвараар эмэгтэйг төрсний дараа хоёр долоо хоног заавал чөлөө олгох ба төрөхийн хүндрэлтэй байсан бол энэ чөлөөг сунгах боломжтой. Үүнтэй адил хандлагатай бусад оронд Шинэ Зеланд, Норвеги, Португал, Швед орж байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[250] Koslowski, A., Blum, S., Dobrotić, I., Kaufman, G. and Moss, P. (2021) *International Review of Leave Policies and Research 2021*. Available at: http://www.leavenetwork.org/lp_and_r_reports/
[251] https://www.cnbc.com/2021/04/28/paid-leave-of-up-to-4000-a-month-for-12-weeks-part-of-biden-proposal.html

**Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ILO)-аас гаргасан албан бус эдийн засагт ажиллагсдыг жирэмсний болон амаржсаны тэтгэмжид хамруулах зөвлөмж**

2016 онд ОУХБ-аас албан бус эдийн засгийн салбарт ажилладаг эмэгтэйчүүдийг жирэмсний болон амаржсаны тэтгэмжид хамруулах талаар зөвлөмж гаргасан[252] ба учир нь дэлхий дахинаа хөдөлмөр эрхэлж байгаа нийт эмэгтэйчүүдийн 28 хувь нь л жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах боломжтой байгаа бөгөөд тэтгэмжид хамрагдаж чадахгүй байгаа эхчүүдийн дийлэнх нь албан бус эдийн засгийн секторт хамаарч байна гэжээ.

Эхчүүдийн хамгааллын тухай 183 дугаар конвенц, түүнийг дагалдан гарсан 191 дүгээр зөвлөмж, Нийгмийн хамгааллын суурь түвшний тухай 202 дугаар зөвлөмж, Албан бус хэвшлээс албан эдийн засагт шилжих тухай 204 дүгээр зөвлөмж зэрэг ОУХБ-ын удирдамжид эхчүүдийн хамгааллыг өргөжүүлж албан бус эдийн засгийн салбарт ажиллагсдыг хамруулах талаар тусгасан байдаг.

ОУХБ-ын албан бус хэвшлээс албан эдийн засагт шилжих тухай 204 дүгээр зөвлөмжид эхчүүдийг хамгааллын хөтөлбөрт албан бус эдийн засагт ажилладаг эхчүүд хамрагдахгүй байгааг онцгойлон анхаарч “нийгмийн хамгаалал, түүний дотор эхчүүдийн хамгааллын хамрах хүрээг аажмаар өргөжүүлж, албан бус эдийн засагт ажилладаг эхчүүдийг бүрэн хамруулах асуудлыг хуульчлах, хэрэгжилтийг хангах арга хэмжээ авах”-ыг гишүүн орнууддаа зөвлөсөн байна. Улс орнуудын засгийн газрыг жендэрийн эрх тэгш байдлыг дэмжих, албан эдийн засагт шилжих боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн хүүхэд асрах болон бусад үйлчилгээг бий болгож, хүртээмжийг нь нэмэгдүүлэх нь зүйтэй гэж уг зөвлөмжийн 21 дэх хэсэгт оруулжээ.

Ажил олгогчид жирэмсний болон амаржсаны тэтгэмж, амралтын зардлыг бүрэн болон хэсэгчлэн хариуцдагтай холбоотой хэд хэдэн асуудлууд үүсдэг. Тухайлбал, хууль тогтоомж нь хэрэгждэггүй, ажил олгогчийн хүлээсэн үүрэг хариуцлагын хэрэгжилтэд үр дүнтэй хяналт тавьж чаддаггүй орнуудад ажил олгогчдод эхчүүдийг хамгаалах асуудлыг бүрэн буюу хэсэгчлэн хариуцуулж орхих нь тун эрсдэлтэй. Эмэгтэйчүүдийг ажилд авах, тогтвортой ажиллуулах, дэмжих сонирхлыг нь бууруулж болзошгүй учраас эхчүүдийн хамгааллыг дан ганц ажил олгогчдод хариуцуулах нь буруу гэдгийг ОУХБ-ын 183 дугаар конвенцод тодорхой дурдсан байна.

Үүнээс гадна доорх зөвлөмжүүдэд албан бус эдийн засагт ажиллаж буй эхчүүдийн жирэмсний болон амаржсаны тэтгэмжийн талаар тусгасан байна.

<u>Нийгмийн хамгааллын суурь түвшний тухай зөвлөмж, 2012 (No.202)</u>

- Эрүүл мэндийн нэн шаардлагатай тусламж, үйлчилгээ, түүний дотор эхэд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээг бүх нийтэд хүргэх.
- Өвчлөх, ажилгүй болох, жирэмслэх, хүүхэд төрүүлэх, хөдөлмөрийн чадвараа алдах зэрэг шалтгаанаар хангалттай орлого олох боломжгүй байгаа хөдөлмөрийн насны хүмүүсийг амьжиргааны доод түвшинг хангахуйц хэмжээний орлогын суурь баталгаатай болгох.

<u>Албан бус хэвшлээс албан эдийн засагт шилжих тухай зөвлөмж, 2015 (No.204)</u>

- Нийгмийн болон эхчүүдийн хамгаалал, хөдөлмөрийн зохистой нөхцөл, цалингийн доод хэмжээний зохицуулалтад албан бус эдийн засагт ажилладаг эхчүүдийг аажим хамруулан хуульчлах, хэрэгжилтийг нь хангах;
- Үндэсний нийгмийн хамгааллын суурь түвшинг тогтоох, нийгмийн даатгалыг өргөжүүлж

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[252] Албан бус эдийн засагт ажиллагчдыг жирэмсний болон амаржсаны тэтгэмжид хамруулах нь, Олон улсын хөдөлмөрийн товчоо. 2016. https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---asia/---ro-bangkok/---ilo-beijing/documents/publication/wcms_544098.pdf

албан бус эдийн засагт ажилладаг хүмүүсийг хамруулахдаа тэдний болон гэр бүлийнхнийх нь хэрэгцээ, шимтгэл төлөх чадавхыг харгалзан үзэх;
- Бизнес болон хөдөлмөр эрхлэлтэд жендэрийн эрх тэгш байдлыг хангах, албан эдийн засагт шилжих нөхцөлийг бүрдүүлэхийн тулд боломжийн үнэ өртөгтэй, чанартай хүүхэд асрах болон бусад үйлчилгээг бий болгох, хүртээмжийг нь нэмэгдүүлэхийг дэмжих.

Албан бус эдийн засагт ажилладаг эмэгтэйчүүдийг нийгмийн хамгааллд амжилттай хамруулсан туршлагаас үзэхэд хууль тогтоомж, хөтөлбөрийн дизайныг боловсруулах, хэрэгжүүлэхдээ эхчүүдийн онцлог хэрэгцээ, нөхцөл байдлыг зайлшгүй харгалзан үзсэн байна. Үүнд хуулиар албан ёсоор хүлээн зөвшөөрөгдөөгүй категорын ажилчид, тухайлбал, гэрийн үйлчлэгч гэх мэт хүмүүсийг тодорхойлж тусгах, хөдөлмөр, нийгмийн хамгаалалд хамруулах зэргээр албан эдийн засагт шилжүүлэх нь зүйтэй гэжээ.

**Жирэмсэн ба амаржсан эхийн тэтгэмжийн талаар бодлого боловсруулахад анхаарах асуудлууд**

2016 онд ОУХБ-аас гаргасан эмэгтэйчүүдийг жирэмсний болон амаржсаны тэтгэмжид хамруулах талаар зөвлөмжид[253] эхчүүдийн орлогын наад захын баталгааг хангахын тулд хоол хүнс, орон байр, эрүүл мэндийн үйлчилгээ, тээвэр, хувцас, хүүхдээ асрах болон бусад олон төрлийн хэрэгцээг нь харгалзах ёстой гэжээ. Мөнгөн тэтгэмж нь зөвхөн хүнсний хэрэгцээнээс гадна хүнсний бус зайлшгүй хэрэгцээг хангахуйц хэмжээнд байх нөхцөлд л хүнсний аюулгүй байдал, хоол тэжээлийн талаар дэвшүүлсэн зорилтууд хэрэгжих боломжтойг олон судалгаа харуулсан[254]. Өөрөөр хэлбэл, ядуу болон хоол хүнсний дутагдалтай эмэгтэйчүүдэд зориулсан мөнгөн тэтгэмж нь дан ганц тэдний хоол тэжээлийг сайжруулах бус төрөхийн өмнөх болон дараах үед тухайн эх, хүүхдийн орлогын баталгааг хангахуйц байх ёстой гэсэн үг юм.

Тиймээс тэтгэмжийг хүнсний бус зайлшгүй хэрэгцээг хангах төдий бус эмэгтэйчүүд амаржих хүртлээ, эсвэл амаржаад төд удалгүй орлогогүйгээс болж эргээд ажилдаа орохоос өөр аргагүй болох дарамтаас чөлөөлөхүйц хэмжээнд тогтоох нь зүйтэй.

Үүний зэрэгцээ мөнгөн тэтгэмжийн хөтөлбөр хэрэгжүүлэхдээ цалинтай ажил, гэрийн цалин хөлсгүй ажил, асаргааны үүргийн хуваарилалтад жендэрийн мэдрэмжтэй хандах шаардлагатай. Нөхцөлт мөнгөн тэтгэмжийн хөтөлбөрүүдийн үндсэн шалгуурт эмэгтэйчүүдийг хүүхдийнхээ эрүүл мэнд, боловсролыг хариуцсан ганц асран халамжлагч гэж үздэг хэвээр байна. Хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээлийн байдлыг зөвхөн төрсний дараа биш илүү урт хугацаанд авч үзэх шаардлагатай. Нөхцөлт мөнгөн тэтгэмжийн хөтөлбөрөөр эх, эцэг хоёулаа гэр бүлээ тэжээгч, халамжлагч гэдгийг хүлээн зөвшөөрч, цалинтай болон цалин хөлсгүй ажил, асран халамжлах үүрэг хариуцлагын уламжлалт хуваарилалтыг эргэн харж, дахин хуваарилахыг дэмжсэн нөхцөл тавих, үйлчилгээ үзүүлэх, мэдлэг ойлголтыг нь сайжруулахыг зорих нь зүйтэй. Хөтөлбөрийг нөхцөлт болгосноор эмэгтэйчүүдийн эрхийг хязгаарлаж, ихэвчлэн маш бага хэмжээтэй олгогддог мөнгөн тэтгэмж авахын тулд илүү дарамт үүрч, нэмэлт зардал төлөх нөхцөлд хүргэж болохгүй. Тэтгэмж хөөцөлдөх нь зардал чирэгдэлтэй байдгаас үүдэн эмэгтэйчүүд сүүлдээ тэтгэмж авч чадахгүйд хүрч болзошгүй юм.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[253] Албан бус эдийн засагт ажиллагчдыг жирэмсний болон амаржсаны тэтгэмжид хамруулах нь, Олон улсын хөдөлмөрийн товчоо. 2016. https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---asia/---ro-bangkok/---ilo-beijing/documents/publication/wcms_544098.pdf

[254]Деверюкс, С., 2015: Нийгмийн хамгааллд болон хоол хүнсээр хангагдах эрхийг хэрэгжүүлэх нь. Нийгмийн хамгааллын суурь түвшний хүнсний аюулгүй байдал, бүх нийтээр зохистой хоол хүнсээр хангагдах эрхийг хэрэгжүүлэхэд оруулах хувь нэмэр (Женев: ОУХБ).

Албан бус эдийн засагт ажилладаг эмэгтэйчүүдийг тэтгэмжид хамруулах стратегийг хэрэгжүүлэхэд анхаарах зүйлс:

- Ажил олгогч дангаараа хариуцдаг тогтолцооноос татгалзаж, жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг үндэснийхээ нийгмийн даатгалын тогтолцоонд хамааруулахыг зорих нь зүйтэй. Нийгмийн даатгал болон халамжийн хөтөлбөрүүдийг хослуулан хэрэгжүүлбэл шимтгэл төлөх боломж хязгаарлагдмал ажилчдыг жирэмсний болон амаржсаны тэтгэмжид хамруулахад тус дөхөм болно.
- Өмнө хамрагдахгүй байсан категорын ажилчдыг хамруулах боломжийг зөвхөн хууль эрх зүйн орчны хувьд нээгээд зогсохгүй практикт тулгарч буй саад бэрхшээлийг шийдвэрлэх шаардлагатай.
- Албан бус эдийн засагт ажиллагчид ихэнх тохиолдолд тогтмол бус, бага орлоготойг харгалзан шимтгэл төлөх чадавхад нь тохирсон зохицуулалтыг нийгмийн даатгалын системд суулгах хэрэгтэй. Мөн тэдний эрүүл мэндийн үйлчилгээ, орон байр, хоол тэжээл, тээвэр, хувцас, хүүхдээ асрах буюу бусад олон төрлийн хэрэгцээг нь хангахуйц байх ёстой. Шимтгэлийн хэмжээ болон шимтгэл хураах арга нь уян хатан байж, даатгуулсан ажилтан, ажил олгогчийн хэрэгцээ шаардлага, онцлогт нийцсэн байх хэрэгтэй.
- Эмэгтэйчүүдийн нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэхийн тулд журмыг хялбаршуулж, төвлөрсөн бус, явуулын үйлчилгээ, цаасгүй бүртгэл зэргийг нэвтрүүлэх нь зүйтэй. Хямд төсөр өртөгтэй, хүртээмжтэй шинэ технологи нэвтрүүлэх нь хамрагдалтыг өргөжүүлэхэд чухал үүрэгтэй.
- Хүүхдээ эмнэлгийн үзлэг болон сургуульд хамруулах нөхцөл тавьдаг мөнгөн тэтгэмжийн хөтөлбөрүүдийн хувьд эцэг, эхийн аль аль нь өрх гэрийнхээ тэжээгч, асран халамжлагч гэдгийг хүлээн зөвшөөрөх шаардлагатайгаас гадна тэтгэмж авагчдад ямар нэгэн дарамт учруулж, нэмэлт зардал гаргуулахгүй байвал зохино.
- Амаржсан эхийн хэрэгцээнд нийцсэн бодлого, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэхдээ шийдвэр гаргахад тэдний төлөөллийг оролцуулдаг, дуу хоолойг нь сонсдог байх хэрэгтэй.
- Үндэсний хэмжээний кампанит ажлыг өрнүүлэх нь амаржсан эхийн хэрэгцээ шаардлагыг таниулах, мөн тэдний нийгмийн даатгалд хамруулах эрэлтийг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

## ХОЁР. БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА

### ГЕРМАН УЛС[255]

Герман Улс нь эхчүүдийг гэртээ хүүхдээ асрах ёстой гэж үздэг уламжлалтай боловч жендэрийн ялгаатай байдалд гүүр болохуйц менежментийг маш амжилттай хийж буй улс юм. 2000-аад оны дунд үеэс эхлэн амаржсан эмэгтэйчүүд эргээд ажил хөдөлмөр эрхлэхийг урамшуулан дэмжсэн хуулиуд батлагдсанаар дээрх тогтсон уламжлалт үзэл бодол өөрчлөгдсөн байна.

***Тэтгэмж олгох бодлого, тогтолцоо***

Германд хүүхэд төрүүлсэн эхэд олгох тэтгэмж, чөлөөтэй холбоотой асуудлыг дараах хуулиар зохицуулж байна. Үүнд:

- Амаржсан эхийг хамгаалах тухай хууль (Maternity Protection Act)
- Эцэг, эхийн тэтгэмж ба чөлөөний тухай хууль (Parental Allowance and Parental Leave Act)
- Үндэсний даатгалын журам (National Insurance Regulation)
- Тэгш байдлын тухай ерөнхий хууль (General Act on Equal Treatment)

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[255]https://ub-deposit.fernuni-hagen.de/servlets/MCRFileNodeServlet/mir_derivate_00002197/Koslowski_et_al_Leave_Policies_2021.pdf

*Амаржсан эхийг хамгаалах тухай хуулиар* жирэмсэн эхийн төрөхийн өмнөх болон төрсний дараах чөлөө, амралт, тэтгэмж, ажил эрхлэлт зэрэг харилцааг нарийвчлан зохицуулдаг бол *Эцэг, эхийн тэтгэмж ба чөлөөний тухай хуулиар* хүүхэд төрсний дараа хүүхэд асрах чөлөө болон тэтгэмж олгох, ажил эрхлэлттэй холбоотой асуудлыг тус тус зохицуулдаг байна.

**2020 оны 4 дүгээр сараас хойших бодлогын өөрчлөлтүүд**

Эцэг эхийн чөлөөний тухай хуульд дараах өөрчлөлтийг оруулж, 2021 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болсон байна. Үүнд:

- Эцэг эхийн чөлөөний тэтгэмж авах гэр бүлийн жилийн орлогын дээд хэмжээ €500,000 байсныг €300,000 болгож бууруулсан;
- Эцэг эхийн чөлөөтэй үедээ ажиллаж болох цагийг долоо хоногт 30 цаг байсныг 32 цаг болгож нэмэгдүүлсэн;
- Дутуу төрсөн хүүхэдтэй эцэг эхчүүдэд гурав хүртэлх сарын нэмэлт чөлөө олгож байхаар болсон (төрөх ёстой хугацаанаасаа 6 долоо хоногийн өмнө төрсөн хүүхдүүдэд 1 сар, 8 долоо хоногийн өмнө төрсөн хүүхдүүдэд 2 сар, 12 долоо хоногийн өмнө төрсөн хүүхдүүдэд 12 долоо хоногийн чөлөөг тус тус олгохоор болсон);
- Нэмэлт тэтгэмж (ElterngeldPlus)-ийн шалгуур хангах хугацааг хүүхэд төрснөөс хойш 46 сар байсныг 32 сар болгож бууруулсан.

***<u>Жирэмсэн болон амаржсан эхийн чөлөө, тэтгэмж, ажил эрхлэлттэй холбоотой зохицуулалт</u>***

Германд "Амаржсан эхийг хамгаалах тухай" хуулиар зөвхөн ажил эрхэлдэг эхчүүдийн жирэмсний болон амаржсаны тэтгэмж, чөлөө, ажил эрхлэлтийн асуудлыг зохицуулдаг байсан бол 2018 онд хуулинд өөрчлөлт орж, хамрах хүрээг өргөжүүлж дадлагажигч, оюутнууд, хувиараа хөдөлмөр эрхэлдэг эмэгтэйчүүдийг энэ хуулийн зохицуулалтад нэмж хамруулсан.

***Жирэмсний болон амаржсаны чөлөөний хугацаа (төрөхийн өмнө ба хойно)***

- Жирэмсний чөлөөний хугацаа 14 долоо хоног байна: төрөхийн өмнө 6 долоо хоног, төрсний дараа 8 долоо хоног байх ба үүнийг заавал олгоно.
- Жирэмсний 12 долоо хоногтойгоос эхлэн жирэмсний болон амаржсаны чөлөөтэй байх хугацаанд эхчүүдийг ажлаас халах, ажлын байрны аливаа осол эрсдэлд өртөх, мөн орогнол хүсэгчдийн хувьд албадан гаргах явдлаас тус тус хамгаална.
- Ихэр төрөлт, үр зулбах, хүүхэд эрхтэн согог төрөх тохиолдлуудад чөлөөний хугацааг төрсний дараа 12 долоо хоног хүртэл сунгана. Гэхдээ үр зулбасан тохиолдолд төрөхийн дараах чөлөөг олгохгүй.

***Тэтгэмж болон санхүүжилт***

- Жирэмсний чөлөөний хугацаанд өмнө нь авч байсан цалин орлогыг нь (төрөхийн өмнөх гурван сарын орлогын дунджаар) ямар нэгэн дээд хязгаарлалтгүйгээр 100 хувь олгоно.
- Жирэмсний болон төрсний чөлөөний тэтгэмжийг (Mutterschaftsgeld) эрүүл мэндийн даатгал (өдрийн €13)[256] болон ажил олгогчоос төлнө. Хэрвээ эхэд олгох төрөхийн өмнөх орлогын дундаж болон эрүүл мэндийн даатгалын төлбөрийн хооронд зөрүү гарвал зөрүүг ажил олгогчоос төлнө. Тэтгэмжийн зөрүүг тухайн эхэд ажил олгогч шууд төлөх бөгөөд холбогдох эрүүл мэндийн даатгалын байгууллагаас уг нөхөн төлбөрийг гаргуулж авахаар өргөдлөө гаргана.

[256] 2006 оноос хойш ажил олгогчид нь эхчүүдийн эрүүл мэндийн даатгалд зориулж түүний нийт цалингийн ойролцоогоор 0,2 хувийн хэмжээтэй тэнцэх (эрүүл мэндийн даатгалаас тогтоосон тодорхой хувийг) хувийг төлдөг болсон байна (**Umlageverfahren 2**).

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

- Сарын орлого нь €390-аас бага эхчүүдийн тэтгэмжийг дан ганц эрүүл мэндийн даатгалаас өмнөх орлоготой нь дүйцүүлэн олгоно.
- Ажилгүйдлийн тэтгэмж авдаг эхчүүд ч мөн адил жирэмсний болон төрсний чөлөөний тэтгэмжинд хамрагдах ба эрүүл мэндийн даатгалаас ажилгүйдлийн тэтгэмжтэй дүйцэх хэмжээгээр авах боломжтой.
- Хувиараа хөдөлмөр эрхлэгч болон ажилгүй эмэгтэйчүүд хэрвээ нийтийн эрүүл мэндийн даатгал төлдөггүй бол жирэмсний болон төрсний чөлөөний тэтгэмжинд хамрагдахгүй. Гэхдээ тэд улсын нийгмийн хамгаалал (даатгалаас)-аас сарын €210 хүртэлх хэмжээний тэтгэмж авах өргөдлийг гаргах боломжтой.

Эмэгтэйчүүд хүүхдээ төрүүлэх хүртлээ өөрөө зөвшөөрвөл, мөн эрүүл мэндийн асуудалгүй бол цалинтай ажил хийх, эсхүл сурч боловсрох үйл ажиллагаагаа үргэлжлүүлж болно. Гэхдээ эрүүл мэндийг хамгаалах зайлшгүй шаардлагад үндэслэн төрсний дараах чөлөөний хугацаанд цалинтай ажил хийхийг үндсэндээ зөвшөөрдөггүй. Зөвхөн ураг нь зулбасан эмэгтэйчүүд л өөрөө шийдсэн бөгөөд эрүүл мэндийн ямар нэгэн асуудалгүй бол 2 долоо хоногийн дараа ажлаа үргэлжлүүлэн хийж болно.

***Тавигдах шаардлага***

Герман улсад оршин суух эсхүл ажил эрхлэх гэрээний шаардлагуудыг хангасан дараах эмэгтэйчүүд энэхүү тэтгэмжинд хамрагдана:

- Бүх эмэгтэй ажил эрхлэгчид. Үүнд хагас цагаар ажиллагсад болон албан журмын нийгмийн даатгалд хамрагдахааргүй (сард €450-аас бага орлого олдог) орлоготой эмэгтэйчүүд хамаарна.
- Оюутан, сурагчид
- Эмэгтэй сайн дурын ажилтнууд (нийгмийн эсхүл экологийн сайн дурын)
- Хувиараа хөдөлмөр эрхлэгч эмэгтэйчүүд
- Орогнол хүсэгчид

Оюутан, сурагч, сайн дурын ажил эрхэлдэг эмэгтэйчүүд, хувиараа хөдөлмөр эрхлэгчид ба орогнол хүсэгчид нь (гэр бүлийн эсхүл хувийн даатгалаар хамгаалагдсан тохиолдолд) жирэмсний болон төрсний чөлөөний хамгийн бага тэтгэмж буюу ихдээ €210 авна.

Зарим тодорхой нөхцөлд (тухайлбал, эцэг, эх нас барах эсхүл ужиг өвдсөн) шинэ төрсөн хүүхэдтэй хамт амьдарч асран хамгаалж буй өөр бусад асран хамгаалагчид нь уг тэтгэмжийг авч болно.

***<u>Эцэг эхийн чөлөө, тэтгэмж ба ажил эрхлэлтийн талаарх зохицуулалт</u>***

Энэхүү асуудлыг “Эцэг эхийн чөлөө ба тэтгэмжийн тухай” хуулиар зохицуулсан байдаг. Германд ажил эрхлэгчид шинээр төрсөн болон үрчлэн авсан хүүхдээ асрах чөлөөг хүүхдийг 3 нас хүртэл буюу 3 хүртэлх жилийн хугацаатайгаар авах эрхтэй бөгөөд үүнийг эцэг эхийн чөлөө гэж нэрлэнэ. Энэхүү чөлөөг эцэг эх хоёул хамт нэгэн зэрэг авах, эсхүл тус тусдаа авах боломжтой.

Мөн түүнчлэн эцэг эхийн чөлөөтэй байх хугацаандаа эцэг, эхчүүд долоо хоногт 30 хүртэлх цагаар ажиллах боломжтой. Үүнээс гадна 2015 оны 7 дугаар сарын 01-нээс хойш төрсөн хүүхдүүдийн эцэг эхчүүд “Эцэг эхийн нэмэлт тэтгэлэг” (Parental Allowance Plus) авах боломжтой болжээ. Энэ нь 24 хүртэлх сарын хугацаатай, эсхүл эцэг эх хоёул хамтдаа нэгэн зэрэг эцэг эхийн чөлөөг авсан бол 28 сар хүртэлх хугацаатай олгодог тэтгэлэг юм.

Эцэг эхийн чөлөөний 12 сарын (хэрвээ эцэг эх хоёул зэрэг чөлөө авсан бол 14 сарын) хугацаанд, ажилтны сарын дундаж орлогын 67% буюу 300 Еврогоос багагүй, 1,800 Евро хүртэлх хэмжээний тэтгэмжийг төрөөс олгоно. Хэрвээ ажилтнууд 3-аас доош насны 2

хүүхэдтэй, эсхүл 6-аас доош насны 3 ба түүнээс олон хүүхэдтэй бол тэтгэмжийн хэмжээг 10% өсгөнө (хамгийн багадаа 75 Евро).

***Чөлөөний хугацаа***

- Хүүхэд төрснөөс хойш 3 хүртэлх жилийн чөлөө олгох ба үүнээс 24 сарыг нь хүүхдийг 8 нас хүртэлх хугацааны дотор эцэг, эхийн аль аль нь авч болно. Энэ нь хувь хүний эрх бөгөөд бусдад шилжүүлэх боломжгүй. Эцэг, эхийн ажлын байраа хадгалах эрхийг энэ хугацаанд баталгаажуулан хамгаалсан байдаг.

***Тэтгэмж ба санхүүжилт***

- Хэрвээ тухайн эх, эсхүл эцэг бүтэн, эсхүл хагас цагаар чөлөө авсан бол түүнд орлогоос нь хамааруулан тэтгэмж тогтоон олгоно. Эцэг, эхчүүд Basiselterngeld, ElterngeldPlus хэмээх хоёр төрлийн тэтгэмжээс сонгож (эсхүл дараалуулан хослуулж) болно.

| ***Үндсэн тэтгэмж /Basiselterngeld/*** | ***Нэмэлт тэтгэмж /ElterngeldPlus/*** |
|---|---|
| o Хэрвээ эцэг, эх хүүхдээ асрах чөлөө авсан бол өмнө нь олж байсан орлогын зохих хувийг нөхөн олгоно.<br>o Төрөхөөс өмнө ажил эрхэлж байгаагүй эцэг эхчүүд сард багадаа €300 тэтгэмж авна.<br>o Хүүхэд төрснөөс хойш 12 (нэмэлт хоёр) сарын хугацаанд тэтгэмж олгоно.<br>o Орлого нөхөх хувь: өмнөх жилийн цэвэр орлогын[257] 65 хувийг[258], хамгийн багадаа сард €300, хамгийн ихдээ сард €1,800 олгоно.<br>o Тэтгэмж авах уян хатан нөхцөл: эцэг эхчүүд хагас цагаар (долоо хоногт 30 цаг хүртэлх хугацаагаар)[259] ажиллаж болно.<br>o Хүүхэд төрсний дараах албан журмын 8 долоо хоногийн хугацаанд олгосон төрсний чөлөөний тэтгэмжийг хасч тооцвол ажил эрхэлдэг эхчүүдэд олгох энэхүү тэтгэмжийн хугацаа 10 (ганц бие эхчүүдийн хувьд 12) сар байна. | o Хэрвээ эцэг эхчүүд хүүхдээ асрах зорилгоор ажил эрхлэх цагаа багасгасан бол тэдний орлогын алдагдсан хувь хэмжээг нөхнө.<br>o Хугацаа: 24 (нэмэлт 4) сарын хугацаанд олгох ба хүүхэд төрсний дараах эхний хоёр жилийн дотор олгоно.<br>o Хамтын бонус (***Partnerschaftsbonus***): хэрвээ эцэг эх хоёул хамгийн багадаа дараалсан 4 сарын туршид долоо хоногт 25-30[260] цаг буюу хагас цагаар ажилласан бол 4 сарын хугацаанд бонус тэтгэмж олгоно.<br>o Орлогыг нөхөн олгох хувь хэмжээ: хагас цагаар ажилласнаар алдсан орлогыг нөхөх үүднээс өнгөрсөн жилийн цэвэр орлогын 65 хувьтай тэнцэхүйц тэтгэмж олгоно. Elterngeld тэтгэмжийн 50 хувь, тухайлбал энэ нь €150-аас €900 хооронд байна.<br>o Хүүхэд төрсний дараах албан журмын 8 долоо хоногийн хугацаанд олгосон төрсний чөлөөний тэтгэмжийг хасч, бодит хугацааг тооцож үзэхэд ажил эрхэлдэг эхчүүдэд олгох энэхүү тэтгэмжийн хугацаа 22 сар байна. |

Эцэг эхийн чөлөөний эрхийг хувь хүний эрх гэж үздэг бөгөөд эцэг эх хоёулаа энэхүү чөлөөний тэтгэмжийг нэгэн зэрэг авч болно.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[257] Цэвэр орлого гэдэг нь тухайн хүний өмнөх нийт орлогоос тогтсон нийгмийн даатгалын хувийг хасч тооцсоныг хэлнэ.
[258] Өмнөх цэвэр орлого нь сард €1,000-аас €1,240 хооронд байсан эцэг, эхчүүд 67 хувьтай тэнцэх хэмжээний тэтгэмж, харин сарын орлого нь €1,240 буюу түүнээс дээш байсан бол 65 хувьтай тэнцэх тэтгэмж гэхчлэн сард хамгийн ихдээ €1,800 хүртэлх хэмжээний эцэг эхийн (Elterngeld) тэтгэмж авна. Тэгвэл сарын цэвэр орлого нь €1,000 бага эцэг, эхчүүдийн хувьд өсгөж бодсон хэмжээгээр тэтгэмж авна: Сарын цэвэр орлогын €1,000 -аас дутаж буй €2 тутамд өсгөж бодохоор, тэдний эцэг, эхийн тэтгэмж 0,1 хувиар өснө. Сарын цэвэр орлого €1,240-өөс дээш эцэг эхчүүдийн орлогын нөхөх хувийг бууруулж тооцно: энэхүү хэмжээнээс давж гарсан €2 тутамд бууруулахаар тэдний тэтгэмж 0,1 хувиар буурах ба хамгийн багадаа 65 хувьтай тэнцэхүйц байхаар тооцогдоно. Чөлөөтэй байгаа боловч тэрхүү чөлөөтэй хугацаандаа хагас цагаар ажиллаж буй эцэг эхчүүдийн орлогын нөхөх тэтгэмжийн хувь хэмжээ нь төрөхийн өмнөх жилийн цэвэр орлого ба төрсний дараах одоогийн орлогын хоорондох зөрүүний 65 хувь байна.)
[259] 2021 оны 9 дүгээр сарын 01-нээс эхлэн долоо хоногт 32 цаг болгож нэмсэн.
[260] 2021 оны 9 дүгээр сарын 01-нээс эхлэн долоо хоногт хагас цагаар ажиллах зөвшөөрөгдсөн цаг 24-32 болж өөрчлөгдсөн.

Нэгээс дээш бага насны хүүхэдтэй эцэг эхчүүдэд нэмэгдэл тэтгэмж (***Geschwisterbonus***) олгоно: 3 хүртэлх насны хоёр хүүхэдтэй, эсхүл 6 хүртэлх насны 3 ба түүнээс дээш олон хүүхэдтэй, эсхүл 2 хүүхдийнх нь нэг нь хөгжлийн бэрхшээлтэй бөгөөд 14 хүртэлх насны бол эцэг, эхийн тэтгэмж 10 хувиар өснө. Үндсэн тэтгэмж (Basiselterngeld)-ийн хувьд хүүхэд тус бүрт багадаа €75 эсхүл нэмэлт тэтгэмж (ElterngeldPlus***)*** €37,50 байна.

Ихэр хүүхэд төрүүлсэн эцэг, эхчүүдийн хувьд нэгээс дээших хүүхэд тус бүрт сарын €300 (Basiselterngeld) эсхүл €150 (ElterngeldPlus)-ийн нэмэгдэл тэтгэмж олгоно.

Үндсэн тэтгэмж ба нэмэлт тэтгэмжийг Холбооны Засгийн газар ерөнхий татвараас /төсвөөс/ санхүүжүүлнэ.

Эцэг эхчүүд (хэрвээ тэд хүүхдээ асрагч бол) нь хүүхэд асрах чөлөөг авч эдлээгүй байсан ч тухайн хугацаанд нь тэтгэврийн кредит тооцно (эцэг эхчүүд өөрсдөө тэтгэврийнхээ кредитийг хэрхэн хувааж авахаа шийднэ). 1992 оны 01 дүгээр сарын 01-нээс хойш төрсөн хүүхэд тус бүрт хүүхэд асарсны 3 жилийг тэтгэврийн системд хүлээн зөвшөөрч ажилласан жилд тооцдог. Баруун Германд хүлээн зөвшөөрөгдсөн хүүхэд асрах хугацааны жил тутамд сарын тэтгэврийг €33,05-аар өсгөх, харин Зүүн Германд €31,89-р өсгөх зохицуулалттай байна. Өнөөгийн байдлаар хүүхэд асрах хугацааны тэтгэврийн кредитийг Германы тэтгэврийн системд даатгалын орлогоос олгож байна.

***Уян хатан хэрэглээ***

- Эцэг эхчүүд нь дээрх тэтгэмжийг хослуулсан маягаар чөлөө, тэтгэмжийг сонгох боломжтой.
- Үндсэн болон нэмэлт тэтгэмж авагчид нь долоо хоногт 30 хүртэлх (2021 оны 9 дүгээр сарын 01-нээс эхлэн 32 хүртэлх) цагийн ажил хийх боломжтой. Энэ тохиолдолд тэд зөвхөн алдсан орлогыг нөхөх эцэг эхийн тэтгэмжийг авна: Өөрөөр хэлбэл, хэрвээ эцэг эсхүл эх чөлөө авахын өмнө долоо хоногт, жишээлэхэд 40 цаг ажилладаг байсан гэж бодвол чөлөө авснаар ажлаа үргэлжлүүлэн хийх боловч долоо хоногт 30 цаг ажилласан гэж үзвэл, ийнхүү ажилласан ажлын орлогоосоо гадна өмнө олж байсан орлогын зөрүүний 65 хувийг (доогуур орлоготой бол 67-100 хувь) авах юм.
- Эцэг эх хоёул нэгэн зэрэг чөлөө авах эрхтэй тул тэд эцэг эхийн чөлөөгөө хамгийн ихдээ гурван удаа (үүнээс олон удаа авах нь ажил олгогч зөвшөөрөх эсэхээс шалтгаална) таслан авахаар хуваарилж болно. Гэхдээ хүүхэд нэгэнт 14-өөс дээш сартай болж эцэг эх нь хоёул эцэг эхийн чөлөөний тэтгэмжээ аваад дууссан бол чөлөө авч болох хугацаа[261] хараахан дуусаагүй байсан ч эцэг эхийн чөлөөг шинээр дахин авах боломжгүй.

***<u>Эцэг эхийн чөлөө, тэтгэмжийн бодлогын бүс нутаг болон орон нутаг дахь ялгаа</u>***

Эцэг эхийн чөлөөний тухай хууль бол холбооны түвшний хууль юм. Гэхдээ хоёр муж улсад (Бавари, Саксон) гачигдлыг судлан тогтоож үндэслэл бүхий байна гэж үзвэл (means-tested) төрөөс эцэг эхийн тусгайлсан тэтгэмжийг (*Landeserziehungseld*) олгодог. Энэ тэтгэмжийг гурван жил хүртэлх хугацаагаар олгож болох ба хүүхэд бүрт сарын €150-€300 тэтгэмж олгоно.

***Тавигдах шаардлага***

Эцэг эхийн чөлөө (*Elternzeit*): хүүхдээ төрөх үед ажил орлоготой байсан бүх эцэг эхчүүд. Эцэг эхийн чөлөөтэй байх үедээ эцэг эхчүүд долоо хоногт 30-(2021 оны 9 дүгээр сарын 01-нээс 32)-аас илүү цагаар ажил хийхгүй.

UILMN СУДАЛГААНЫ САН

[261] Ковид-19 цар тахлын үеийн “стратегийн дэд бүтэц”-д хамаарах ажил эрхэлдэг (тухайлбал, “системийн чухал албан тушаалын ажил эрхэлдэг) эцэг эхчүүд нь 2020 оны 3 дугаар сарын 01-нээс 12 дугаар сарын 31-ний хооронд авахыг хүсч байсан Эцэг эхийн чөлөөний тэтгэмжийн саруудаа хямрал өнгөрөх хүртэл хойшлуулах эрхтэй. Дараа нь хүүхэд нь 14-өөс дээш сартай болсон ч үндсэн Эцэг эхийн тэтгэмжээ авч болно.

- Эцэг эхийн тэтгэмж *(Basiselterngeld/ElterngeldPlus)*:
  - Долоо хоногт 30-(2021 оны 9 дүгээр сарын 01-нээс 32)-аас илүү цагаар ажиллаагүй бүх эцэг эхчүүд
  - Эцэг эхчүүд нь хүүхэдтэйгээ хамт амьдардаг байх (үүнд салсан боловч өмч хөрөнгө нэгтэй эцэг эхчүүдийг бас хамруулна)
  - Эцэг эх өвдсөн, тахир дутуу болсон эсхүл нас барсан бол хүүхдийг асарч буй бусад хүмүүс
  - Үрчилсэн ба өргөж авсан эцэг эх
  - Хувиараа хөдөлмөр эрхлэгч эцэг эх
  - Ижил хүйстэн хосууд
  - Цэвэр орлого нь €500-тай тэнцэх эсхүл түүнээс доош эцэг эхчүүд, эсхүл €250-тай тэнцэх эсхүл түүнээс доош орлоготой ганц бие эцэг эсхүл эх
  - Герман улсад (Европын холбооны хууль тогтоомжийн дагуу) ажилладаг эсхүл амьдардаг Европын Холбоо, Европын эдийн засгийн бүс, Швейцар улсын иргэд
  - Байнгын оршин суух зөвшөөрөлтэй эсхүл Герман улсад ажил хөдөлмөр эрхлэх гэрээтэй бусад орны иргэд. Орогнол хүсэгчид нь Герман улсад багадаа 3 жил амьдарсан бол хамрагдах боломжтой болно.

***Хүүхдийн, эсхүл гэр бүлийн шалтгаанаас чөлөөг эхээс нь өөр хүнд төлөөлүүлэн олгох***

- Хэрвээ хүүхэд нь, тодорхой хэлбэл ач хүүхдийнх нь эцэг эх 18 насанд хүрээгүй эсхүл эцэг эсхүл эх нь сургууль, мэргэжлийн сургалтад суралцдаг, хараахан төгсөөгүй байгаа бол өвөө эмээ нь эцэг эхийн чөлөөг авах эрхтэй.
- 2021 оны 9 дүгээр сарын 01-нээс эхлэн төрөх өдрөөсөө адаглаад 6 долоо хоногийн өмнө төрвөл эцэг эхэд нь Эцэг эхийн тэтгэмжийн нэмэгдэл нэг сар олгогдоно. Хэрвээ хүүхэд 8 долоо хоногоос өмнө төрвөл нэмэлт 2 сарын тэтгэмж олгоно. Хэрвээ 12 долоо хоногийн өмнө төрвөл 3 сарын нэмэлт, 16 долоо хоногийн өмнө төрвөл нэмэлт 4 сарын тэтгэмж олгодог байна.

***Хүүхэд асаргааны чөлөө ба тэтгэмж***

Герман улсын Бавари, Саксон мужуудын хуулиар хүүхэд төрснөөс хойш 13 дахь сараас эхлэн 3 нас хүртэлх хугацаанд асаргааны мөнгөн тэтгэлэг (*Landeserziehungsgeld/Familiengeld*) олгодог. Энэ тэтгэмжийг бусад нийгмийн халамжийн тэтгэмжүүд дээр нэмж олгоно. Бавари мужид, эцэг эхчүүдэд эхний болон хоёр дахь хүүхдийн асаргаанд зориулан сар бүр €250-ийг, гурав дахь болон түүнээс дээших хүүхдүүдийн асаргаанд сарын €300 евроны тэтгэмж олгоно. Энэхүү тэтгэмжийг улсаас санхүүждэг хүүхэд асаргааны газарт хандалгүйгээр нярайг чанартай сайн асарч, эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамруулж байх нөхцөлтэйгөөр эцэг эхчүүдэд олгодог байна.

***Ковид-19 цар тахлын үеийн жирэмсний болон хүүхэд асрах чөлөөтэй холбоотой арга хэмжээний зохицуулалт***

2020 оны 3 дугаар сараас цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан жирэмсний болон хүүхэд асрах чөлөө, ажил эрхлэлт, тэтгэмжийн асуудлаар холбогдох хуулиудад нэмэлт өөрчлөлтүүд орсон байна. Тухайлбал,

1. Стратегийн, дэд бүтцийн чухал салбарт ажилладаг эцэг эхчүүдийн чөлөөний тэтгэмж авах хүсэлт гаргах хугацааг хойшлуулсан. Өөрөөр хэлбэл, хүүхдийг 14 сар болсноос хойш хугацаанд ч тэтгэмж авах хүсэлтээ гаргаж болно гэсэн үг. Гэхдээ 2021 оны 6-р сард багтаан гаргана.
2. Хэрэв Ковид 19 цар тахлын улмаас орлого буурсан тохиолдолд гэр бүл, хамтран амьдрагчийн бонус тэтгэмж авна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

3. Орлогын алдагдалтай сарuudыг (бага цагаар ажилласан) эцэг эхийн тэтгэмжийг тооцох орлогод хамруулахгүй. Өөрөөр хэлбэл, орлого буураагүй саруудын дунджаар тооцож олгоно гэсэн үг.

Цар тахлын улмаас хүүхэд асаргааны төвүүд хаагдаж хүүхдээ гэрээр асрах шаардлагатай болсон тохиолдолд орлого нөхөх тэтгэмжид хамруулна. 12 хүртэл насны хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй 12-оос дээш насны хүүхдээ асрах тохиолдолд орлого нөхөх тэтгэмжийг ажил олгогчоос олгох бөгөөд дараа нь Холбооны Засгийн газраас буцаан авдаг байна. Эцэг эх хоёулаа ажил эрхэлдэг бол хүн тус бүр хамгийн ихдээ 10 долоо хоногийн хугацаанд, хэрэв ганц бие эцэг, эх бол 20 долоо хоногийн хугацаанд энэхүү тэтгэмжийг авч болохоор зохицуулжээ.

## ФИНЛАНД УЛС

Финланд улс амьдралын чанарын индексээр дэлхийд Наймдугаарт, хүүхэд өсгөж хүмүүжүүлэхэд хамгийн таатай орнуудын Зургаадугаарт эрэмбэлэгдэж, харин 1000 төрөлтөд 3.4 гэсэн үзүүлэлтээр нялхсын эндэгдэл багатай улсын Тавд жагсаж байна. Тус улс нь 5.5 сая хүн амтай бөгөөд 1,467,653 гэр бүл бүртгэлтэй байна.

1948 оноос хэрэгжүүлж эхэлсэн гэр бүлийг дэмжих бодлого нь үр хүүхэд тээж төрүүлэх, өсгөх таатай, аюулгүй орчин нөхцөлийг бүрдүүлэх, гэр бүл бүрд хүүхдээ өсгөхөд шаардлагатай санхүүгийн дэмжлэг, тусламж үйлчилгээ үзүүлэх, чөлөө олгох гэсэн гурван гол дэмжлэгийн хүрээнд хэрэгжиж иржээ.

### *Тэтгэмж олгох бодлого, тогтолцоо*

Нийгмийн даатгалын байгууллагаас (The Social Insurance Institution of Finland)[262] нь хүүхдийн мөнгө, эрүүл мэндийн даатгал, ажилгүйдлийн тэтгэмж, гэр бүлийн тэтгэмжийг олгодог. Тус байгууллага нь татварын сан, даатгалын шимтгэлээр санхүүждэг.

*Хууль эрх зүйн зохицуулалт*

Жирэмсний тэтгэмж, жирэмсний амралт, эцэг эхийн чөлөө, эцэг эхийн тэтгэмж, хүүхэд асарсны тэтгэмжийг олгох харилцааг Хөдөлмөрийн тухай хууль (Employment & Labour Laws)[263], Нийгмийн халамжийн тухай хууль (Social Welfare Act)[264], Хүүхдийн халамжийн тухай хууль (Child Welfare Act)[265], Хүүхэд асрах тэтгэмжийн тухай хууль (Child Home Care and Private Day Care Allowance)[266], Жирэмсний тэтгэмжийн тухай хууль (Maternity Benefit Act)[267] болон холбогдох хууль тогтоомжоор зохицуулж байна.

*Тэтгэмжийн төрөл*

Жирэмсэн болон амаржсан эхэд жирэмсний тэтгэмж, төрсний дараах тэтгэмж, эцэг эхийн тэтгэмж, хүүхдийн мөнгө, хүүхэд асарсны тэтгэмжийг олгодог.

### *1. Жирэмсний тэтгэмж*

Жирэмсний чөлөөг төрөх сүүлийн хугацаанаас ажлын 30-50 өдрийн өмнө хугацаагаа өөрөө сонгож авах боломжтой байдаг. Жирэмсний чөлөөний үед ажлын 105 өдрийн цалинтай тэнцэх хэмжээний жирэмсний тэтгэмж авдаг. Хэрэв ажлын хортой нөхцөлд ажилладаг бол жирэмсэн болсон нь батлагдсан өдрөөс эхлэн жирэмсний чөлөө авах эрхтэй бөгөөд жирэмсний тусгай тэтгэмж авна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[262] The Social Insurance Institution of Finland https://www.kela.fi/web/en/organization
[263] Employment and Labour Laws https://iclg.com/practice-areas/employment-and-labour-laws-and-regulations/finland
[264] Social Welfare Act https://www.finlex.fi/fi/laki/kaannokset/1982/en19820710_20140491.pdf
[265] Child Welfare Act https://www.finlex.fi/en/laki/kaannokset/2007/en20070417_20131292.pdf
[266] Child Home Care and Private Day Care Allowance https://www.finlex.fi/fi/laki/alkup/1996/19961128
[267] Maternity Benefit Act https://clc.gov.in/clc/ыsites/default/files/MATERNITY%20BENEFIT%20ACT.pdf

### *2. Төрсний дараах тэтгэмж*

Төрсний дараа ажлын 54 өдрийн чөлөө, тэтгэмж олгох бөгөөд нэг хүүхдийн 18 хүртэлх ажлын өдрөөр тооцон эцэг эх хоёрт хоёуланд нь чөлөө олгоно. Гэхдээ төрөхөөс өмнө хамгийн багадаа 180 хоног нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байх шаардлагатай.

### *3. Эцэг эхийн тэтгэмж*

Жирэмсний чөлөөний дараа эцэг эхийн чөлөөний хугацаа эхлэх бөгөөд эцэг эхийн аль нэг нь авч болно. Эл тэтгэмж нь ажлын 158 өдрийн цалинтай тэнцэх хэмжээтэй байна. Эцэг эхчүүд мөн хагас цагаар ажиллах, хагас өдөр нь хүүхдээ асрах  боломжтой байдаг. Жирэмсний тэтгэмж, төрсний дараах тэтгэмж, эцэг эхийн тэтгэмжийн хэмжээг тогтоохдоо жилийн орлогод үндэслэн тооцоолдог. Жилийн орлогод цалин хөлс, даатгалын сангаас  авдаг  ажилгүйдлийн нөхөн олговор, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн орлого, орлогын бууралтад зориулан улсаас авч буй тодорхой нөхөн төлбөр зэргүүд орно.




Хэрэв хөдөлмөр эрхэлдэггүй бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг ажлын өдрийн 29,05 еврогоор тооцон олгодог.

| Жилийн орлого (евро)<br>(Нийт орлогоос суутгалыг хасна) | Тэтгэмж (евро)<br>(татвараас өмнө) |
|---|---|
| 0-11,452 | 29,05 |
| 15000 | 35,00 |
| 17,500 | 40,83 |
| 20,000 | 46,67 |
| 30,000 | 70,00 |
| 40,000 | 92,48 |
| 50,000 | 105,81 |
| 60,000 | 119,14 |

Хэрэв тэтгэмжийг хамгийн бага хэмжээгээр авдаг бол 20%, цалинтай ажил эрхэлж жирэмсний тэтгэмж, эцэг эхийн тэтгэмж зэрэг авдаг бол 40%-ийн татвар ногдуулна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

### *4. Хүүхэд асрах тэтгэмж*

Эцэг эхийн тэтгэмж авч дуусахад хүүхэд ойролцоогоор 9 сар хүрсэн байдаг. Үүнээс цааш хүүхэд асрах тэтгэмжийг авч эхэлдэг. Хүүхдээ гэртээ өөрөө харах эсхүл улсын, хувийн цэцэрлэгээр харуулж болно. Хүүхэд асрах чөлөөг Хөдөлмөрийн гэрээний тухай хууль (Employment Contracts Act)[268] үндэслэн ажил олгогчоос олгодог. Хүүхэд асрах тэтгэмж нь:

[268] Employment Contracts Act https://www.finlex.fi/en/laki/kaannokset/2001/en20010055.pdf

1. Хүүхдээ гэртээ асарсны тэтгэмж
2. Хувийн өдөр өнжүүлэхийн тэтгэмж
3. Асаргааны уян хатан тэтгэмж
4. Асаргааны хэсэгчилсэн тэтгэмж байна.

**4.1 Хүүхдээ гэртээ асарсны тэтгэмж**

Сургуулийн өмнөх боловсрол олгох ясли, цэцэрлэгт огт хамрагдаагүй 0-3 насны хүүхдээ гэртээ харж байгаа эцэг эх, албан ёсны асран хамгаалагч(эмээ, өвөө), эцэг эхийн хамтран амьдрагч, хөлсөлж авсан асрагч нар уг тэтгэмжийг авах эрхтэй. Мөн 3-аас дээш насны хүүхэд үрчилж авсан эцэг эхчүүд тэтгэмж авч болно. Хүүхэд үрчилж авсан эцэг эхэд эцэг эхийн тэтгэмж олгож эхэлснээс хойш хоёр жил хамгийн ихдээ хүүхэд сургуульд орох хүртэл уг тэтгэмжийг олгодог. Хүүхдээ гэртээ асарсны тэтгэмж нь асаргааны тэтгэмж, асаргааны нэмэлт тэтгэмж, хотын нэмэлт тэтгэмж зэргээс бүрдэнэ.

*Асаргааны тэтгэмж*

Асаргааны тэтгэмжийг тэтгэмж авах боломжтой хүүхэд бүрд тусад нь олгодог. Гэр бүлийн орлогод тооцогдохгүй.

- 3-аас доош насны нэг хүүхдэд сард 342.95 евро
- 3 хүртэлх насны нэмэлт хүүхэд бүрд сард 102.67 евро
- 3-аас дээш насны боловч сургуулийн нас хүрээгүй хүүхэд бүрд сард 65.97 еврогийн тэтгэмж олгодог.

*Асаргааны нэмэгдэл тэтгэмж*

Асаргааны нэмэгдэл тэтгэмж нь ам бүлийн тоо болон өрхийн нийт орлогоос хамаардаг учраас гэр бүлийн нийт орлогод хамаарна. Гэр бүлийн сарын орлого нь ам бүлийн тоогоор тогтоосон орлогын хязгаарласан хэмжээнээс хэтрэхгүй бол уг тэтгэмжийг бүрэн олгоно. Нэмэлт тэтгэмжийн дээд хэмжээ сард нэг хүүхдэд 183.53 евро байна. Орлогын хэмжээ хэтэрсэн тохиолдолд доорх хүснэгтийн дагуу харгалзах хувь хэмжээгээр асрамжийн нэмэлт төлбөрийг хасаж тооцно.

| Ам бүлийн тоо* | Нийт орлого (нэмэлт тэтгэмж авна) | Суутгал (%) | Нийт орлогын хязгаарласан хэмжээ (нэмэлт тэтгэмж авахгүй) |
|---|---|---|---|
| 2 | Сар бүр1,160.00 евро | 11.5% | Сар бүр 2,755.87 евро |
| 3 | Сар бүр 1,430.00 евро | 9.4% | Сар бүр 3,382.40 евро |
| 4 ба түүнээс дээш | Сар бүр 1,700.00 евро | 7.9% | Сар бүр 4,023.11 евро |

** Гэр бүлийн тоо 4 хүн: 2 том хүн, сургуулийн насны 2 хүртэлх хүүхэд. Эцэг эхийн тэтгэмж төлсөн хүүхэд эсвэл сургуульд сурч байгаа хүүхдийг гэр бүлийн хүмүүсийн тоонд оруулаагүй болно.*

*Хотын нэмэлт тэтгэмж*

Хотын нэмэлт тэтгэмжийн хэмжээ, хамрагдах шалгуур нь тухайн хотоос хамаарч өөр өөр байдаг бөгөөд бүх хотын захиргаа нэмэгдэл өгдөггүй.

*Тэтгэмжийг дараах тохиолдолд олгохыг зогсоодог:*

- Хүүхэд 3 нас хүрсэн;
- Хүүхэд улсын өдөр өнжүүлэх төвд хамрагдаж эхэлсэн;
- Хамгийн бага хүүхэд 3-аас доош настай ч гэсэн сургуульд сурч эхэлсэн (энэ тохиолдолд тэтгэмж хамгийн сүүлд 7-р сарын 31-нд дуусна);
- Гэр бүлээрээ гадаад улс руу нүүсэн тохиолдолд тэтгэмж олгохыг зогсоодог байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Хүүхэд гэртээ асарсны тэтгэмжид цалингийн нэгэн адил 25%-ийн татвар ногдуулдаг.

### 4.2 Хувийн өдөр өнжүүлэхийн тэтгэмж

Албан ёсны эрхтэй өдөр өнжүүлэх төвд эсхүл сургуулийн өмнөх боловсролын мэргэжилтнээр хүүхэд асруулж байгаа тохиолдолд уг тэтгэмжийг авна. Уг тэтгэмж нь асаргааны, асаргааны нэмэлт тэтгэмжээс бүрдэнэ.

*Асаргааны тэтгэмж*

Хувийн өдөр өнжүүлэхийн тэтгэмж нь гэр бүлийн орлогод нөлөөлдөггүй. Нэг хүүхдийн 174,59 еврогийн тэтгэмж үзүүлдэг.

*Асаргааны нэмэлт тэтгэмж*

Уг тэтгэмж нь ам бүлийн тоо, өрхийн орлогоос хамаардаг. Сар болгон нэг хүүхдэд 146,82 еврогийн тэтгэмж олгодог. Эцэг эхийн орлого нь заасан орлогын хэмжээнээс хэтрэхгүй бол сургуулийн өмнөх насны бүх хүүхдэд асаргааны нэмэлт тэтгэмж олгоно.

| Ам бүлийн тоо* | Нийт орлого (нэмэлт тэтгэмж авна) | Суутгал (%) | Нийт орлогын хязгаарласан хэмжээ (нэмэлт тэтгэмж авахгүй) |
|---|---|---|---|
| 2 | 1,160,000 | 11.5% | Сарын 2,436,66 евро |
| 3 | 1,430,000 | 9.4% | Сарын 2,991,87 евро |
| 4 ба түүнээс дээш | 1,700.00 | 7.9% | Сарын 3,558,42 евро |

** Гэр бүлийн тоо 4 хүн: 2 том хүн, сургуулийн насны 2 хүртэлх хүүхэд. Эцэг эхийн тэтгэмж төлсөн хүүхэд эсвэл сургуульд сурч байгаа хүүхдийг гэр бүлийн хүмүүсийн тоонд оруулаагүй болно.*

### 4.3 Асаргааны уян хатан тэтгэмж

Уг тэтгэмжийг:

- Долоо хоногт 30 ба түүнээс бага цагаар ажиллаж үлдсэн хугацаанд 3-аас доош насны хүүхдээ хардаг эцэг эх, албан ёсны асран хамгаалагч (энэ нь үрчилж авсан болон ижил хүйстэн эцэг эхчүүд мөн хамаарна);
- Эцэг эх нь хоёулаа хүүхдээ өөр өөр цагт асрах боломжтой хөдөлмөр эрхэлдэг (жишээлбэл, эцэг эхийн нэг нь Даваа, нөгөө нь Баасан гаригт, эсхүл эцэг эхийн нэг нь өглөө, нөгөө нь үдээс хойш);
- Хүүхэдтэйгээ хамт амьдардаггүй эцэг эх;
- Төрийн болон хувийн хэвшлийн ажил олгогчтой хөдөлмөрийн гэрээ байгуулсан эцэг эх;
- Тэтгэврийн даатгалтай хувиараа хөдөлмөр эрхлэгч эцэг эхчүүдэд олгоно.

*Тэтгэмжийн хэмжээ*

- Тэтгэмж авагч долоо хоногт 22.5 цагаас илүүгүй ажлын цагаар эсхүл бүтэн ажлын цагийн 60%-аас хэтрэхгүй ажилласан тохиолдолд сар бүр 244.47 еврогийн тэтгэмж (Энэ нь жишээлбэл, долоо хоногт 3 өдөр эсвэл өдөрт ойролцоогоор 4.5 цаг)
- Долоо хоногт 22.5 цагаас илүү ажилласан ч 30 цаг хүрээгүй, 60%-иас илүү ердийн цагийн 80%-аас бага бол сар бүр 162.98 еврогийн (Энэ нь жишээлбэл, долоо хоногт 4 өдөр эсвэл өдөрт 6 цаг орчим) тэтгэмж олгоно.

*Тэтгэмжийг дараах тохиолдолд:*

- Жирэмсний тэтгэмж, жирэмсний тусгай тэтгэмж, төрсний дараах тэтгэмж, эцэг эхийн тэтгэмж авдаг;
- Хүүхдээ гэртээ асарсны тэтгэмж авдаг;

UIH.MN СУДАЛГААНЫ САН

- Гэр бүлд нэгээс илүү хүүхдийн асаргааны тэтгэмж авдаг;
- 4 долоо хоногоос дээш хугацаагаар өвчний чөлөөтэй байсан хүмүүст тэтгэмжийг олгодоггүй.

Тэтгэмжээс гадна цалин хөлс эсхүл татвар ногдох бусад орлогыг авдаг бол 40%-иар татвар ногдуулна.

**4.4 Хэсэгчилсэн асаргааны тэтгэмж**

Сургуулийн 1,2-р ангийн хүүхэдтэй, долоо хоногт 30-аас илүүгүй цагаар ажиллаж буй эцэг эхчүүдэд Хөдөлмөрийн гэрээний тухай хуулийг үндэслэн ажил олгогчоос хэсэгчилсэн тэтгэмж олгодог. Гэр бүлд хэдэн хүүхэд байхаас үл хамааран тодорхой цаг хугацаанд зөвхөн нэг хүүхдэд нь сард 98,21 еврогийн тэтгэмж олгодог.

*Тэтгэмжийг дараах тохиолдолд:*

- Эцэг эх хоёулаа хөдөлмөр эрхэлдэггүй;
- 4 долоо хоногоос дээш хугацаагаар өвчний чөлөө авсан;
- Хүүхэд асарсны тэтгэмж, эцэг эхийн тэтгэмж авдаг;
- Ажил хайж байгаа эцэг эх;
- Оюутан;
- Ээлжийн амралттай байгаа эцэг эхчүүдэд олгодоггүй.

Хэсэгчилсэн асаргааны тэтгэмж нь татвар ногдох орлогод хамаардаг. Цалин хөлс болон татвар ногдох бусад орлого дээр нэмэгдэж буй тэтгэмжийн хувь хэмжээгээр татвар ногдуулна.

**НОРВЕГИ УЛС**

Норвеги улсад хүүхэд төрүүлсэн эх болон эцэгт хүүхдээ асарсны чөлөөг Хөдөлмөрийн орчны тухай хууль (Work Environment Act 2005), тэтгэмжийг Үндэсний даатгалын тухай хууль (National Insurance Act) болон холбогдох бусад хууль, тогтоомжоор зохицуулан олгож байна. Хүүхэд асрах чөлөө, тэтгэмжийг "Эцэг эхийн чөлөө, тэтгэмж" (Parental leave, benefit) гэж нэрлэдэг байна. Хөдөлмөрийн орчны тухай хуульд заасанаар хүүхэд асарсны чөлөөг Хөдөлмөрийн яам (Ministry of Labour), хүүхэд асарсны тэтгэмжийг Хүүхэд, гэр бүлийн яам (Ministry of Children and Families) тус тус хариуцан олгодог ажээ.

Тус улсад хүүхэдтэй болсон эх, эцгүүд тэтгэмжийн хэмжээнээс хамаараад төрөхийн өмнөх 3 долоо хоногийн чөлөөг оролцуулан 49 долоо хоног орлогын 100%-тай тэнцэх тэтгэмж эсхүл 59 долоо хоног орлогын 80%-тай тэнцэх тэтгэмж бүхий чөлөө авах эрхтэй. Төрсний дараах чөлөөний 15 эсхүл 19 долоо хоног нь эхэд ногдох чөлөө буюу эхийн квот, 15 эсхүл 19 долоо хоног нь эцэгт ногдох чөлөө буюу эцгийн квот байна. Үлдсэн 16 эсхүл 18 долоо хоног нь эцэг, эхийн аль нэг нь үргэлжлүүлэн авч болох чөлөө юм. Тэтгэмжийн дээд хэмжээ нь Үндэсний даатгалын үндсэн тэтгэмжийн хэмжээг 6 дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй байхаар хуулиар зохицуулсан байна.

***Эцэг эхийн хүүхэд асрах чөлөө, тэтгэмжийн Эхэд хамаарах хэсэг (Mother’s quota)***

Ажил олгогч өөр ажилд шилжүүлэн ажиллуулах боломжгүй тохиолдолд хими, биологи, физикийн хүнд хортой нөхцөлийн улмаас ажлаа зогсоох шаардлагатай жирэмсэн эмэгтэйчүүдэд 12 долоо хоног хүртэл чөлөө олгох боломжтой. Чөлөөний хугацаан дахь тэтгэмжийг өвчний тэтгэмжтэй ижил дүнгээр тооцон олгоно.

**Чөлөөний хугацаа**

Тэтгэмжийн дүнгээс хамааран 18 буюу 22 долоо хоногийн чөлөө авах эрхтэй. Үүнд, Төрөхөөс өмнө 3 долоо хоног, төрсний дараа 15 буюу 19 долоо хоног. Үүнээс төрсний дараах 6 долоо

UIH.MN СУДАЛГААНЫ САН

хоногийн чөлөөг эрүүл мэндийн хэвийн байдалдаа эргэн орох үүднээс зайлшгүй биеэр эдлэх шаардлагатай байдаг.

**Тэтгэмж болон санхүүжилт**

Үндэсний даатгалын үндсэн тэтгэмжийн (үндсэн тэтгэмж сард 8867 Норвеги крон буюу 1033$ ам доллар)[269] хэмжээг 6 дахин нэмэгдүүлснээс хэтрүүлэхгүй тэтгэмж буюу 18 долоо хоног орлогын 100%-тай тэнцэх тэтгэмж эсхүл 22 долоо хоног орлогын 80%-тай тэнцэх тэтгэмжийг ерөнхий татварын орлогоос санхүүжүүлдэг байна. Сургуулийн насанд хүрээгүй хүүхдээ асрах зорилгоор түр хугацаагаар ажил эрхлэхгүй байгаа эцэг, эхэд мөн тэтгэмж олгоно.

**Чөлөөг өөрт тохируулан авах боломж**

Төрснөөс хойш зайлшгүй авах шаарлагатай 6 долоо хоногийн чөлөөний дараа ажил, чөлөөг хослуулан Хагас цагаар ажиллаж (Part-time work), Хагас цагийн чөлөө (Part-time leave) авах болон илүү богиносгосон цагаар ажиллах боломжтой.

*Тавигдах шаардлага*

- Төрөхөөс өмнөх сүүлийн 10 сарын 6 сард нь ажил эрхлэн, өмнөх жилдээ наад зах нь үндэсний даатгалын үндсэн тэтгэмжийн талаас багагүй хэмжээний хөлс авч байсан бүх эмэгтэйчүүд тэтгэмж авах эрхтэй.
- Хувиараа хөдөлмөр эрхлэгчид тэтгэмжид хамрагдах эрхтэй.
- Хөдөлмөр эрхлээгүй эмэгтэйчүүд хүүхэд бүрд зориулсан нэг удаагийн тэтгэмж авах эрхтэй. Хөдөлмөр эрхлээгүй эмэгтэйчүүд хүүхэд өргөж авсан тохиолдолд мөн нэг удаагийн тэтгэмжид хамрагдах эрхтэй.

*Чөлөө, тэтгэмжийн бусад нөхцөлүүд*

- Төрсний дараа эх болон хүүхэд эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа тохиолдолд чөлөөний тэтгэмжийг хойшлуулна.

Ихэр хүүхэд төрүүлсэн болон олон хүүхэд өргөж авсан тохиолдолд Эцэг, эхийн хүүхэд асрах чөлөөний хугацаа уртсана. Ихэр хүүхэдтэй болсон эцэг, эх нь 66/80 долоо хоног, харин гурван ихэр хүүхэдтэй болсон бол 95/115 долоо хоногийн чөлөө, тэтгэмжийг авах эрхтэй.

***<u>Эцэг эхийн хүүхэд асрах чөлөө, тэтгэмжийн Эцэгт хамаарах хэсэг (Paternity leave)</u>***

*Чөлөөний хугацаа*

Хүүхэд төрсний дараах 2 долоо хоногийн чөлөө “Аавын өдрүүд” (daddy days) болон хүүхэд асрах чөлөөний Эцэгт хамаарах 15 эсхүл 19 долоо хоногийн чөлөөг авах эрхтэй.

*Тэтгэмж болон санхүүжилт*

“Аавын өдрүүд”-д засгийн газраас тэтгэмж тооцон олгодоггүй. Хүүхэд асрах урт хугацааны тэтгэмж нь ажил олгогчтой байгуулсан болон хамтын гэрээнээс хамаарах бөгөөд ихэнх ажил эрхэлдэг аавууд ийм гэрээнд хамрагддаг байна.

Чөлөөний нөхцөлийг өөрчлөх

- Эцэг, эх хамт амьдардаггүй тохиолдолд хүүхдээ асрахад нь эхэд туслах хэн нэгэн Эцгийн хүүхэд асрах чөлөөг шилжүүлэн авах эрхтэй.
- Хүүхдээ асрах эцгийн чөлөөг шаардлагатай тохиолдолд хугацааг нь өөрчлөн, төрөхийн өмнөх болон дараа, түүнчлэн нэг дор бус шаардлагатай үедээ хуваан авах боломжтой.
- Хүүхэд өргөж авсан эцэг мөн хүүхэд асрах эцгийн чөлөөг авах боломжтой.

[269] https://www.nav.no/no/nav-og-samfunn/kontakt-nav/utbetalinger/grunnbelopet-i-folketrygden

UIH.MN СУДАЛГААНЫ САН

*Тавигдах шаардлага*

Хөдөлмөр эрхэлдэг бүх аавууд хүүхэд асрах чөлөө авах боломжтой. Гэвч тэтгэмжийг гэрээний үндсэн дээр ажил олгогч төлнө.

***<u>Хүүхэд асрах эцэг эхийн чөлөө, тэтгэмж (Parental leave)</u>***

**Чөлөөний хугацаа (Төрөхийн өмнөх болон дараа)**

Тэтгэмжийн хэмжээнээс хамаараад, төрөхийн өмнөх 3 долоо хоногийн чөлөөг оролцуулан 49 долоо хоног орлогын 100%-тай тэнцэх тэтгэмж эсхүл 59 долоо хоног орлогын 80%-тай тэнцэх тэтгэмж бүхий чөлөөг авна. Тэтгэмжийн хэмжээнээс хамаараад төрсний дараах чөлөөний 15 эсхүл 19 долоо хоног нь эхэд ногдох чөлөө буюу эхийн квот, 15 эсхүл 19 долоо хоног нь эцэгт ногдох чөлөө буюу эцгийн квот байна. Үлдсэн 16 эсхүл 18 долоо хоног нь эцэг, эхийн аль нэг нь үргэлжлүүлэн авч болох чөлөө (family entitlement) юм.

**Тэтгэмж болон санхүүжилт**

- Үндэсний даатгалын үндсэн тэтгэмжийн (үндсэн тэтгэмж сард 8867 Норвеги крон буюу 1033$ ам доллар) хэмжээг 6 дахин нэмэгдүүлснээс хэтрүүлэхгүй тэтгэмж буюу 49 долоо хоног орлогын 100%-тай тэнцэх тэтгэмж эсхүл 59 долоо хоног орлогын 80%-тай тэнцэх тэтгэмжийг ерөнхий татварын орлогоос санхүүжүүлдэг байна. Хэрэв ажилтнууд хамтын гэрээнд хамрагдсан бол ажил олгогчид нь цалин болон тэтгэмжийн зөрүүг төлнө.
- Хөдөлмөр эрхэлдэггүй эмэгтэйчүүд 90300 Норвеги крон буюу 10561$ ам долларын тэтгэмж хүүхдийн тоогоор авдаг байна.
- Дээрх тэтгэмжүүдийг ерөнхий татварын орлогоос санхүүжүүлдэг.

**Чөлөөний нөхцөлийг өөрчлөх**

- Хүүхэд асрах чөлөөг (Эхийн болон эцгийн) урт хугацаанд орлогын 80%-ийн тэтгэмжтэй болон богино хугацаанд орлогын 100%-ийн тэтгэмжтэй авах боломжтой.
- Зайлшгүй авах шаардлагатай 6 долоо хоногийн дараа эх нь бүтэн цагийн ажилд орсон бол хүүхэд төрснөөс хойших 3 жилийн хугацаанд чөлөө, тэтгэмжийг өөрт тохиромжтой байдлаар авах боломжтой.
- Эхний 6 долоо хоногийн чөлөөний дараа эцэг, эхийн нэг нь болон хоёулаа нийт чөлөөний хугацаагаа нэгтгэн эсхүл хэсэгчлэн хагас цагаар (part-time) ажил эрхлэх боломжтой. Эцэг, эх хоёулаа, нэгэн зэрэг хүүхэд асрах тэтгэмжтэй чөлөөний хугацаандаа хагас цагийн ажил эрхлэх боломжтой. Тухайн тохиолдолд ажил олгогчтой гэрээ байгуулсан байх шаардлагатай.
- Хүүхэд асрах чөлөөний эцгийн болон эхийн квотыг (тус бүр 15/19 долоо хоног) нэг нэгэндээ шилжүүлэх боломжгүй. Онцгой тохиолдол буюу эцэг, эхийн хэн нэгэн нь өвдсөн бөгөөд хүүхдээ асрах боломжгүй, түүнчлэн эцэг, эх нь хамт амьдардаггүй тохиолдолд хүүхэд асрах чөлөөний эрхээ нэг нэгэндээ шилжүүлэх боломжтой байна.
- Хүүхэд асрах чөлөөний эцгийн квотыг ихэр хүүхэд төрүүлсэн болон хүүхэд өргөж авснаас бусад тохиолдолд хүүхэд төрсний дараах 6 долоо хоногийн дотор авах боломжгүй. Үүнээс хойш хүүхдийн 3 нас хүртэлх хугацаанд хэдийд нь ч өөрт ногдох хүүхэд асрах чөлөөгөө авах боломжтой. Мөн дээр дурдсаны дагуу чөлөөний хугацаандаа ажил олгогчтой зөвшилцсөний үндсэн дээр хагас цагаар ажил эрхлэх болон шаардлагатай тохиолдолд чөлөөгөө бүхэлд нь эсхүл хэсэгчлэн авах боломжтой. Ийм тохиолдолд ажил эрхлэгчтэй зөвшилцөх шаардлагатай.
- Эцэг, эхийн аль нэг нь үргэлжлүүлэн авах чөлөөг мөн 3 жилийн хугацаанд бүхэлд нь, хагас цагаар, хэсэгчлэн авах боломжтой.

UILMN СУДАЛГААНЫ САН

- Хуулиар эхийн заавал авах чөлөөний хугацаанаас бусад үед эцэг, эх хоёул нэгэн зэрэг хүүхэд асрах чөлөөгөө авах боломжтой. Гэхдээ нэгэн зэрэг чөлөө авах нь хүүхэд асрах чөлөөний хугацааг богиносгоно.

*Тавигдах шаардлага*

- Эцэг эхийн аль алин нь хүүхэд төрөхийн өмнөх 10 сарын 6 сард нь хөдөлмөр эрхлэн, хамгийн багадаа өмнөх жилийн үндэсний даатгалын үндсэн тэтгэмжийн тал хувиар цалинжсан байх шаардлагатай.
- Хувиараа хөдөлмөр эрхлэгч нь бусад байгууллагад хөдөлмөр эрхлэгчидтэй адил чөлөө, тэтгэмж авах эрхтэй.

*Чөлөө, тэтгэмжийн бусад нөхцөлүүд*

- Эцэг эхийн хүүхэд асрах чөлөөний хугацаанд хүүхэд эндсэн тохиолдолд 6 сарын хугацааны тэтгэмжийг олгоно.
- Эцэг эхийн хүүхэд асрах чөлөөг эдлэх эрх бүхий ганц бие эхэд, эцгийн хүүхэд асрах эрхийг шууд олгоно. Эцэг, эх зөвшилцөөд тус улсад оршин суух зөвшөөрөлгүй эцэгт хүүхэд асрах эцгийн чөлөө авах хүсэлт гаргаж болно.

**Хүүхэд асрах нэмэлт чөлөө (Childcare leave)**

- Хүүхэд асрах тэтгэмжтэй чөлөө дууссаны дараа эцэг, эхийн хэн нь ч хүүхдээ асрах нэг жилийн цалингүй чөлөө авах эрхтэй.
- Улсаас санхүүжүүлдэг Бага насны хүүхдийн боловсрол болон асаргаа (Early Childhood Educatuion and Care-ECEC service) буюу цэцэрлэгийн үйлчилгээнд 1-2 насны хүүхдээ хамруулдаггүй эцэг, эхчүүд Хүүхэд асрах тэтгэмжид[270] хамрагдах эрхтэй. Хүүхэд асрах тэтгэмж сард 7500 Норвеги крон буюу 880$ ам доллар байна. Улсын санхүүжилттэй цэцэрлэгт хагас цагаар хүмүүждэг хүүхдэд хорогдуулсан хэмжээгээр уг тэтгэмжийг олгоно.

**Хүүхэд өргөж авахад олгох чөлөө, тэтгэмж (Adoption leave and pay)**

Хүүхэд өргөж авсан эцэг, эхэд төрөхөөс өмнө эхчүүдэд олгодог 3 долоо хоногийн чөлөөнөөс бусад чөлөө, тэтгэмж ижил олгогдоно. Гадаадаас хүүхэд өргөж авсан эцэг, эхчүүд чөлөө авах хугацаагаа өөрсдөө сонгож болно. Хүүхэд асрах эцэг, эхийн чөлөөнд тавигдах шаардлагыг хангахгүй байгаа эцэг эхчүүд 90300 Норвеги крон буюу 10561$ ам долларын тэтгэмж авах боломжтой.

**Хүүхдэд нэмэлт асрамж шаардлагатай тохиолдолд олгох чөлөө (Time off for the care of dependents)**

- 12-оос доош настай 1-2 хүүхэдтэй ажилтнууд хүүхэд нь өвдсөн тохиолдолд жилд нэг удаа ажлын 10 хоногийн, 2-оос дээш хүүхэдтэй бол жилд нэг удаа ажлын 15 хоногийн цалинтай чөлөө тус тус авах боломжтой. Ганц бие эцэг болон эхчүүд тэтгэмжээсээ хамааран жилд нэг удаа 20 эсхүл 30 хоногийн чөлөө авах боломжтой байна. Хүнд болон ужиг өвчтэй хүүхдээ асрах шаардлагатай эцэг, эхчүүд хүүхдээ 18 нас хүртэл жил бүр дээрх чөлөөнөөс уртасгасан хугацаагаар чөлөө авах эрхтэй.
- Ажил олгогч чөлөөний хугацаан дахь тэтгэмжийг өвчтэй байх үеийн тэтгэмжтэй адилаар, орлогын 100 хувиар тооцон олгоно.
- Эцэг, эхчүүд хүүхдээ 10 нас хүртэл хагас цагаар ажил эрхлэх боломжтой байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[270] Cash for care benefit https://www.nav.no/en/home/relatert-informasjon/cash-for-care-benefits-for-the-parents-of-toddlers

***<u>Хөдөлмөрийн орчны тухай хууль</u>***[271]

**Бүлэг 12. Ажилтан ажлаас чөлөө авах эрхийн тухай**

**12-1 дүгээр зүйл. Төрөхийн өмнөх үзлэг**

Хэрэв төрөхийн өмнөх үзлэгт ажлын бус цагаар хамрагдах боломжгүй тохиолдолд жирэмсэн ажилтан цалинтай чөлөө авч үзлэгт хамрагдах боломжтой.

**12-2 дугаар зүйл. Жирэмсний хугацаанд чөлөө авах**

Жирэмсэн ажилтан жирэмсний хугацаанд 12 долоо хоног хүртэл чөлөө авах боломжтой. Энэ чөлөөг хүүхэд төрсний дараа нөхөн авах боломжгүй.

**12-3 дугаар зүйл. Хүүхэд асрах чөлөө**

(1) Хүүхэд төрсний дараа хүүхдээ асрахад туслах зорилгоор эцэг нь 2 долоо хоногийн чөлөө авах эрхтэй. Хэрэв төрсөн хүүхдийн эцэг, эх хамт амьдардаггүй тохиолдолд хүүхэд төрүүлсэн эхэд туслах хүн ажлаасаа чөлөө авах эрхтэй.

(2) Хүүхэд үрчилж авсан болон асран хамгаалахаар шийдвэрлэсэн эцэг, эх хүүхэд асрах 2 долоо хоногийн чөлөө авах эрхтэй. Энэ нь нөхөр болон эхнэрийн дагавар хүүхдийг асрах эсхүл хүүхэд 15-аас дээш настай бол хэрэгжихгүй.

**12-4 дүгээр зүйл. Хүүхэд төрүүлсэн эхэд олгох чөлөө**

Хүүхэд төрүүлсэн эх эрүүл мэндийн хэвийн байдалдаа орох үүднээс эхний 6 долоо хоног ажлаас чөлөөлөгдөх шаардлагатай бөгөөд хэрэв эмнэлгийн магадлагаагаар тухайн эхийг ажлаа үргэлжлүүлэн хийх нь өөрт нь сайн нөлөөтэй гэж үзсэн тохиолдолд ажилдаа эргэн орж болно.

**12-5 дугаар зүйл. Эх, эцгийн хүүхдээ асрах чөлөө**

(1) Хүүхэд төрүүлсэн эх, эцэг нь энэ зүйл болон 12-2, 12-4 дүгээр зүйлд тус тус заасан хугацааг тооцон хоёулаа нийт 12 сарын хүүхэд асрах чөлөө авах эрхтэй. Хүүхэд асарсны тэтгэмжийг Үндэсний даатгалын газраас олгох эсэхийг үл хамааран эх, эцэг нь хүүхэд асрах чөлөө авах эрхтэй.

(2) Нэгдүгээр хэсэгт заасан хүүхэд асрах чөлөөний хугацаан дээр нэмээд эх, эцгийн аль нь ч төрөлт бүрд 12 сар хүртэлх чөлөө авах эрхтэй. Энэхүү чөлөөг нэгдүгээр хэсэгт заасан хүүхэд асрах чөлөөнөөс шууд үргэлжлүүлэн авах шаардлагатай. 12-6 дугаар зүйлд заасны дагуу хэсэгчлэн чөлөө авсан ажилтан энэ хэсэгт заасны дагуу чөлөө авах эрхгүй.

(3) Эцэг эх хоёр нь хүүхдээ хамт асардаггүй тохиолдолд нэгдүгээр хэсэгт заасан хүүхэд асрах чөлөөг тухайн хүүхдийг асарч буй этгээд эдлэх боломжтой. Хүүхдээ асрах хариуцлагыг дангаараа үүрдэг ажилтан хоёрдугаар хэсэгт заасан чөлөөг 2 хүртэлх жил эдлэх эрхтэй.

(4) Хүүхэд үрчилж авсан болон асран хамгаалахаар шийдвэрлэсэн эцэг, эх энэ зүйлд заасны дагуу хүүхэд асрах чөлөө авах эрхтэй. Хэн нэгэн нас барсан тохиолдолд хүүхдийг нь асран хамгаалахаар шийдвэрлэсэн ажилтанд энэ зүйл мөн хамаарна. Нөхөр болон эхнэрийн дагавар хүүхдийг асрах эсхүл хүүхэд 15-аас дээш настай бол энэ зүйлд заасан хүүхэд асрах чөлөө авах эрхгүй.

ПАРЛАМЕНТ СУДАЛГААНЫ САН

**12-6 дугаар зүйл. Хүүхэд асрах чөлөөг хэсэгчлэн авах**

(1) Ажилтан 12-2, 12-4, 12-5 дугаар зүйлүүдэд тус тус заасан хүүхэд асрах чөлөөг хэсэгчлэн авах боломжтой.

[271] https://www.arbeidstilsynet.no/globalassets/regelverkspdfer/working-environment-act

(2) Ажил олгогч болон ажилтны хооронд байгуулсан гэрээний үндсэн дээр, тухайн байгууллагад ноцтой хүндрэл гарахгүй тохиолдолд ажилтнуудад хүүхэд асрах чөлөөг хэсэгчлэн олгох боломжтой. Онцгой тохиолдолд хэсэгчлэн авах чөлөөний гэрээг өөрчлөх мөн цуцлах боломжтой.

(3) Хүүхэд асрах хэсэгчилсэн чөлөөг 3 жилийн хугацаанд авах эрхтэй.

**12-7 дугаар зүйл. Ажил олгогчид мэдэгдэх**

Ажилтан 12-2 дугаар зүйлээс 12-6 дугаар зүйлд заасан чөлөөг авах тохиолдолд ажил олгогчид урьдчилан мэдэгдэх үүрэгтэй. 2 долоо хоногоос илүү хугацаанд чөлөө авах шаардлагатай тохиолдолд нэг долоо хоногийн өмнө, 12 долоо хоногоос илүү хугацаанд чөлөө авах шаардлагатай тохиолдолд 4 долоо хоногоос багагүй хугацааны өмнө, 1 жилээс дээш хугацаагаар чөлөө авах тохиолдолд 12 долоо хоногоос багагүй хугацааны өмнө урьдчилан мэдэгдэх үүрэгтэй. Хэрэв ажилтан урьдчилан мэдэгдэх үүргээ мэдээгүйн улмаас хугацаа хэтэрсэн бол энэ нь ажилтанд шаардлагатай чөлөөг олгохгүй байх нөхцөл болохгүй.

**12-8 дугаар зүйл. Хөхүүл эхэд чөлөө олгох**

(1) Хөхүүл эх нь хүүхдээ хөхүүлэхэд шаардагдах хугацааны чөлөө хүсэх эрхтэй. Хөхүүл эхэд өдөртөө 2 удаа доод тал нь хагас цагийн цалинтай чөлөө олгох буюу ажлын цагийг өдөрт 1 цагаар хорогдуулж болно.

## ТАЙВАНЬ (БНХАУ)

Тайвань нь төрөлтийн түвшин харьцангуй буурч буй оронд тооцогддог (төрөлтийн түвшин 227 орноос хамгийн сүүлд жагсчээ). Тайванийн Засгийн газраас үүнийг өөрчлөхийн тулд холбогдох арга хэмжээг авч эцэг эхийн амралт, төрсний дараах тэтгэмж, жирэмсний хяналтанд байх хугацаатай холбоотой хууль, дүрэм, журмуудад нэмэлт өөрчлөлт оруулсан. Эдгээр өөрчлөлтүүд 2021.07.01-ээс хүчин төгөлдөр үйлчилж байна.[272]

**Төрсний дараах тэтгэж олгох бодлого, эрх зүйн зохицуулалт**

Тайваньд төрсний дараах тэтгэмжийн асуудлыг Хөдөлмөрийн яамны харьяа Хөдөлмөрийн даатгалын товчоо (Bureau of Labor Insurance)[273] хариуцдаг бөгөөд энэ байгууллага нь нийгмийн хамгаалал болон даатгалын бүхий л үйл ажиллагааг хариуцдаг байна. Хууль, эрх зүйн хүрээнд дараах хууль, дүрэм үйлчилж байна. Үүнд:

- Хөдөлмөрийн стандартын тухай хууль (Labor Standards Act)[274]
- Хөдөлмөр эрхлэлтийн жендэрийн тэгш байдлын тухай хууль (Act of Gender Equality in Employment)[275]
- Хөдөлмөр эрхлэлтийн даатгалын тухай хууль (Employment Insurance Act)[276]
- Хүүхэд өсгөхөд эцэг эхэд цалингүй чөлөө олгох журам (Regulations for Implementing Unpaid Parental Leave for Raising Children)[277]
- Засгийн газар болон харьяа агентлагийн ажилтнуудад зориулсан тусгай чөлөө олгох журам (Regulations on Special Leave for Employees of the Executive Yuan and Subordinated Agencies)[278]

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[272] Taiwan enhances parental leave policies » Winkler Partners - Attorneys at Law of Taiwan and Foreign Legal Affairs
[273] https://www.bli.gov.tw/En/
[274] Labor Standards Act - Article Content - Laws & Regulations Database of The Republic of China (moj.gov.tw)
[275] Act of Gender Equality in Employment - Article Content - Laws & Regulations Database of The Republic of China (moj.gov.tw)
[276] Employment Insurance Act - Article Content - Laws & Regulations Database of The Republic of China (moj.gov.tw)
[277] Regulations for Implementing Unpaid Parental Leave for Raising Children - Article Content - Laws & Regulations Database of The Republic of China (moj.gov.tw)
[278] Regulations on Special Leave for Employees of the Executive Yuan and Subordinated Agencies - Article Content - Laws & Regulations Database of The Republic of China (moj.gov.tw)

**Хөдөлмөрийн стандартын тухай хууль (Labor Standards Act)**[279]

Энэ хууль нь 12 бүлэгтэй бөгөөд 1984 оны 07 дугаар сарын 30-нд батлагдаж, сүүлд 2020 оны 6 дугаар сарын 10-нд нэмэлт, өөрчлөлт орсон.

Тус хуулийн 6 дугаар бүлгийн 50-р заалтад *“Эмэгтэй ажилтанд төрөхөөс өмнө болон төрсний дараах 8 долоо хоногийн хугацаатай жирэмсний амралт олгоно. Жирэмсний эхний 3 сарын дараа зулбасан тохиолдолд тухайн эмэгтэйд дөрвөн долоо хоногийн хугацаатай жирэмсний амралт олгоно.*

*Хэрэв өмнөх хэсэгт дурдсан эмэгтэй ажилтан зургаан сараас дээш хугацаагаар ажилласан бол жирэмсний амралтын хугацаанд тогтмол цалин хөлс олгож, харин ажилласан хугацаа нь зургаан сараас бага бол хөдөлмөрийн хөлсний талыг нь олгоно*” гэсэн заалт орсон байдаг.

**Хөдөлмөр эрхлэлтийн жендэрийн тэгш байдлын тухай хууль (Act of Gender Equality in Employment)**[280]

Энэ хууль нь 7 бүлэгтэй бөгөөд 2002 оны 01 дүгээр сарын 16-нд батлагдаж, 2016 оны 5 дугаар сарын 18-нд нэмэлт, өөрчлөлт орсон. Тус хуулийн 4 дүгээр бүлгийн 15-р заалтад *“хөдөлмөрийн стандартын тухай хуулийн 50-р заалтаас гадна ажилтны жирэмсний хугацаанд ажил олгогч нь жирэмсний үзлэгт хамрагдахад 5 хоногийн чөлөө олгох, ажилтны нөхөр нь хөдөлмөр эрхэлж байгаа бол ажил олгогч нь 5 хоногийн чөлөө олгох, жирэмсний үзлэг, эцгийн амралтын үед цалинтай чөлөө олгоно* ”, 16-р заалтад “*6 сар ажилласны дараа ажилчид хүүхдээ гурван нас хүрэхээс өмнө цалингүй чөлөө авах хүсэлт гаргаж болно. Энэ амралтын хугацаа нь хүүхдүүд 3 нас хүрэх хүртэл 2 жилээс хэтрэхгүй байж болно*” 17-р заалтад *“эцэг, эхийн хүүхдээ харах чөлөөний хугацаанд болон дараа нь ажлын байрыг хадгална”* зэрэг заалтууд орсон байдаг. Мөн энэ хуулиар хүүхэд үрчилж авсны дараах, ажлын цагийн хуваарийг өөрчлөх, хүүхдээ хөхөөр хоолох, хүүхэд харах үйлчилгээ зэрэг асуудлуудын талаар зохицуулалтуудыг тусгаж өгчээ.

**Хүүхэд өсгөж буй эцэг эхэд цалингүй чөлөө олгох журам (**<u>Regulations for Implementing Unpaid Parental Leave for Raising Children</u>**)**[281]

Энэ журмыг Хөдөлмөрийн яамнаас 2002 оны 3 дугаар сарын 6-нд баталж, сүүлд 2021 оны 6 дугаар сарын 4-нд нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Тус журмыг Хөдөлмөр эрхлэлтийн жендэрийн тэгш байдлын тухай хууль (Act of Gender Equality in Employment)-ийн 16.5 дахь хэсэгт заасны дагуу гаргасан бөгөөд 9 зүйлтэй байна. Үүнд:

1 дүгээр зүйл

Эдгээр зохицуулалтыг Хөдөлмөр эрхлэлтийн жендэрийн тэгш байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу гаргасан болно.

2 дугаар зүйл

Ажилтан хүүхдээ өсгөн хүмүүжүүлэхийн тулд эцэг эхийн амралтын хүсэлт гаргахдаа 10 хоногийн өмнө ажил олгогчдоо бичгээр өргөдөл гаргана.

Өргөдөлд дараах зүйлийг тусгана. Үүнд:

1. Нэр, албан тушаалын нэр.
2. Эцэг эхийн цалингүй амралтын хугацааны эхлэх, дуусах огноо.
3. Хүүхдийн төрсөн он сар, хүүхдийн нас.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[279] Labor Standards Act - Article Content - Laws & Regulations Database of The Republic of China (moj.gov.tw)
[280] Act of Gender Equality in Employment - Article Content - Laws & Regulations Database of The Republic of China (moj.gov.tw)
[281] Regulations for Implementing Unpaid Parental Leave for Raising Children - Article Content - Laws & Regulations Database of The Republic of China (moj.gov.tw)

4. Хүүхэд асрах чөлөө авах хугацаанд оршин суугаа газрын хаяг, холбоо барих утасны дугаар.

5. Нийгмийн даатгалын анхны хөтөлбөрт тасралтгүй хамрагдах эсэх.

6. Эхнэр нөхрийн ажил эрхлэлтийн байдлыг нотлох баримт бичгийг гаргаж өгөх.

Хүүхэд өсгөн хүмүүжүүлэх эцэг эхийн цалингүй амралтын үргэлжлэх хугацаа нь зарчмын хувьд зургаан сараас бага байж болохгүй. Хэрэв ажилтан зургаан сараас бага хугацаанд чөлөө авах шаардлагатай бол 30-аас доошгүй хоног үргэлжилсэн чөлөө олгох өргөдлөө ажил олгогчдоо дээд тал нь хоёр удаа өгч болно.

3 дугаар зүйл

Хүүхэд харах чөлөөтэй байх хугацаанд амралтаа авсан ажилтан ажил олгогчтойгоо зөвшилцөж ажилд орох хугацаагаа хойшлуулж болно.

4 дүгээр зүйл

Хүүхэд харах чөлөөтэй байх хугацаанд, ажил олгогч, ажилтны зүгээс өөр зохицуулалт хийгээгүй бол амралттай байгаа ажилтны ахмадын насыг тооцохгүй.

5 дугаар зүйл

Хүүхэд харах чөлөөтэй байх хугацаанд хэрэв хөдөлмөрийн гэрээг цуцлах гэж байгаа бол холбогдох хууль тогтоомж, захиргааны журмын дагуу ажлаа цуцлах ёстой.

6 дугаар зүйл

Хүүхэд харах чөлөөтэй байх хугацаанд ажил олгогч нь ажилчны хийж байсан өмнөх ажлыг гүйцэтгэхийн тулд ажилчин авч болно.

7 дугаар зүйл

Хүүхэд харах чөлөөтэй байх хугацаанд ажил олгогч өөр хүнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах ёсгүй.

8 дугаар зүйл

Хүүхэд харах чөлөөтэй байх хугацаанд ажил олгогч нь амралттай байгаа ажилтантайгаа холбоо барьж, түүнд хамаарах боловсролын сургалтын хөтөлбөрийн талаар түүнд мэдэгдэх ёстой ба энэ нь албан ёсны үүрэг, хариуцлага юм.

9 дүгээр зүйл

Эдгээр журам нь нийтэд мэдээлсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

Эдгээр журмын 2021 оны 6-р сарын 4-ний өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан заалтууд 2021 оны 7-р сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

**Засгийн газар болон харьяа агентлагуудын ажилтнуудад зориулсан тусгай чөлөө олгох журам (Regulations on Special Leave for Employees of the Executive Yuan and Subordinated Agencies)[282]**

Энэ журмыг Засгийн газрын боловсон хүчний ерөнхий газраас 2001 оны 7 дугаар сарын 31-нд баталж, сүүлд 2020 оны 7 дугаар сарын 15-нд нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Тус журмыг Төрийн албан хаагчийн албаны тухай хууль (Civil Servant Association Act)[283]-ийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасны дагуу гаргасан. Тус журмын 3-р зүйлийн 3.3-3.5 дахь заалтад төрсний өмнөх болон дараах амралт, үр зулбалт, эхнэр болон нөхрийн амралтын хугацаа зэргийг нарийвчлан зааж өгчээ.

**Хөдөлмөр эрхлэлтийн даатгалын тухай хууль (Employment Insurance Act)[284]**

Энэ хууль нь 8 бүлэгтэй бөгөөд 2002 оны 5 дугаар сарын 15-нд батлагдаж, сүүлд 2015 оны 02 дугаар сарын 4-нд нэмэлт, өөрчлөлт орсон. Тус хуулийн 4 дүгээр бүлгийн 19-р зүйлийн

[282] Regulations on Special Leave for Employees of the Executive Yuan and Subordinated Agencies - Article Content - Laws & Regulations Database of The Republic of China (moj.gov.tw)

[283] https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=S0010008

[284] Employment Insurance Act - Article Content - Laws & Regulations Database of The Republic of China (moj.gov.tw) щ

19.2-т эцэг эхийн амралтын тэтгэмжийн талаар зохицуулсан бөгөөд тэтгэмжийг хүүхэд харах амралтын өмнөх 6 сарын цалингийн 60 хувьтай тэнцүүгээр тооцдог байна. Мөн даатгуулагч нэгэн зэрэг 2-оос дээш хүүхэд төрүүлсэн болон хүүхэд үрчилж авсан тохиолдлуудыг зохицуулж өгчээ.

**Тэтгэмж олгох төрөл, хугацаа**

Жирэмсний амралт- жирэмсний өмнө болон хойших хугацаанд 8 долоо хоног амралт авах эрхтэй. Зулбасан тохиолдолд, 3 сар өнгөрсөн бол 4 долоо хоног, 2-3 сар өнгөрсөн бол 1 долоо хоног, 2 сар хүрэхгүй хугацаа өнгөрсөн бол 5 хоног амрах эрхтэй.

Цалин- 6 сараас дээш хугацаанд ажилласан бол жирэмсний амралтын үеэр тогтмол цалин өгдөг. Энэ нь ердийн цалингийн 50 хувиар тооцож олгоно.

Цалинтай чөлөө- нөхөр хөдөлмөр эрхэлж буй тохиолдолд ажил олгогчоос эхнэрээ жирэмсний үзлэгт үзүүлэх зорилгоор 5 хоногийн цалинтай чөлөө олгох эрхтэй.

Хүүхэд асрах чөлөө- 6 сараас дээш ажилласан эхнэр, нөхөр 3-аас доош насны хүүхэдтэй бол 2 жилийн хугацаанаас хэтрэхгүй хүүхэд асрах чөлөө авч болно. 2-оос дээш хүүхэдтэй бол нэг дор тооцох бөгөөд хамгийн бага хүүхдийн 2 жилээр хязгаарлагдана.

Эцэг эхийн амралтын тэтгэмж- хүүхэд асрах чөлөө авахаас өмнө даатгуулагчийн цалингийн 60 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг сар бүр авна. Энэ тэтгэмжийг эцэг, эхийн аль нэг нь дээд тал нь 6 сар авах боломжтой. Хүүхдийн эцэг эхээр хоёулангаар харуулах боломжийг олгож эцэг эх дараалан хүүхэд харах амралтын тэтгэмж авах хүсэлтийг дараалан гаргаж болно. Энэ нь нийт 12 сар байна.

**Тэтгэмж олгох шаардлага, шалгуур**

6 сараас доошгүй ажилласан, даатгалд хамрагдсан ажилтнуудад жирэмсний дараах тэтгэмж олгох эрх үүсдэг. Даатгуулагч нь төрөх, дутуу төрөх тохиолдолд жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг сүүлийн 6 сарын цалингийн дунджаар тооцож, 60 хоногийн цалинтай тэнцэх хэмжээний мөнгийг авна. Олон тооны хүүхэд төрүүлсэн тохиолдолд төлбөрийг хувь тэнцүүлэн нэмэгдүүлнэ.

Нийгмийн даатгалын холбогдох хөтөлбөрийн дагуу жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрхтэй даатгуулагчид үндэсний жирэмсний тэтгэмж авах эрхтэй. Цэргийн, иргэний болон боловсролын ажилтнуудын хувьд зөвхөн нэг төрлийн жирэмсний тэтгэмж, тэтгэмжийг сонгох ёстой. Харин тариачдын эрүүл мэндийн даатгалд хамрагдах хүмүүс энэ дүрэм мөрдөгдөхгүй.

**Бүрдүүлэх бичиг баримт[285]**

1. Хөдөлмөрийн даатгалын жирэмсний тэтгэмжийн анкет, төлбөрийн баримт.
2. Хүүхдийн төрсний гэрчилгээний эх хувь.
   Амьгүй төрөлтийн тухайд улсын эрүүл мэндийн даатгалд хамрагдсан эмнэлгийн байгууллагаас олгосон амьгүй төрсөн тухай баримтын хуулбар, тусгай зөвшөөрөлтэй эмч, эх баригчийг (амьгүй төрсөн он сар өдөр, шалтгаан, сүүлчийн сарын тэмдэг ирсэн он сар өдрийг зааж) ирүүлнэ.
3. Даатгалын хугацаанд жирэмсэн болсон, жирэмсний улмаас даатгал дуусгавар болсноос хойш нэг жилийн дотор гадаадад хүүхэд төрүүлэх, дутуу төрөх тохиолдолд даатгуулагч зохих дэмжлэг үзүүлэх ёстой.
4. Хэрэв төрсний гэрчилгээ эсвэл холбогдох дагалдах бичиг баримтыг БНХАУ-ын төрийн байгууллагаас бусад байгууллага олгосон бол дараах байгууллагууд нотариатаар гэрчлүүлнэ. Даатгуулагчийн паспортын хуулбарыг мөн хавсаргана.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[285] Bureau of Labor Insurace Website-Employee-How to Apply for Insurance Benefit Payment?-Labor Insurance Benefit Payment-Maternity Benefits Payment (bli.gov.tw)

a. Гадаадын төрсний гэрчилгээг ЭСЯ, ЭСЯ-ны төлөөлөгчийн газар, холбоо, Гадаад хэргийн яамнаас (дипломат агентлагууд) эрх олгосон бусад байгууллагаар баталгаажуулсан байх ёстой; Хэрэв гадаад төрсний гэрчилгээг Тайваньд суугаа гадаадын элчин сайдын яам, эрх бүхий байгууллагууд олгосон бол үүнийг Гадаад хэргийн яамаар баталгаажуулсан байх ёстой.
b. Хэрэв гэрчилгээг Хятадын эх газрын нутаг дэвсгэрт бөглөсөн бол засгийн газар эсвэл төлөөлж буй байгууллагуудаар баталгаажуулсан байх ёстой. (Straits Exchange Foundation)
c. Хэрэв гэрчилгээг Хонг Конг эсвэл Макаод бөглөж, олгосон бол түүнийг засгийн газар эсвэл Хонконг, Макао дахь байгууллагууд баталгаажуулсан байх ёстой.
d. Гадаад хэл дээр бичигдсэн баримт бичиг дээр дурдсан агентлагууд эсвэл Тайвань дахь нотариатын гэрчилгээний дагуу хятад хэл дээрх орчуулгыг хийсэн байх ёстой.

*Жич:*

1. *Жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах тухай нэхэмжлэлийг тэтгэмж төлөгдөж эхэлсэн өдрөөс хойш таван жилийн дотор гаргаагүй тохиолдолд хэрэгсэхгүй болгоно.*
2. *Даатгалын гэрээний нөхцөлийг хангасан даатгуулагч жирэмсний улмаас төрсний болон дутуу төрсний тэтгэмж авах эрхтэй. Даатгуулагч өөрөө өргөдөл гаргаж болно.*
3. *Даатгуулагч нь зулбах, ургийн гажиг жирэмслэлт, умайн гадуур жирэмслэлтийн үед жирэмсний тэтгэмж авах өргөдөл гаргахгүй байж болно.*

**МОНГОЛ УЛС**

Монгол Улсын хувьд жирэмсний болон амаржсаны чөлөөг Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулдаг. Хуульд зааснаар эхэд жирэмсний болон амаржсаны 120 хоногийн амралт олгоно. Хүүхдээ 196, түүнээс дээш хоног тээгээд дутуу төрүүлсэн болон үр хөндүүлсэн, жирэмслэлтийг эмнэлгийн аргаар тасалсан, 196 хоног тээгээгүй боловч амьдрах чадвартай хүүхэд төрүүлсэн эмэгтэйчүүд мөн үүнд хамрагдана. Энэ нь төрөхийн өмнө 60 хоног, төрсний дараа 60 хоног байна. Харин жирэмсний болон амаржсаны тэтгэмжийн асуудлыг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиар зохицуулдаг. Тус хуульд зааснаар жирэмсэн болон амаржсан эхэд хэд хэдэн төрлийн тэтгэмжийг олгож байна. Тухайлбал,

- Жирэмсний болон амаржсаны тэтгэмж;
- Жирэмсэн эхийн тэтгэмж;
- 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эх, эцэг;
- дөрөв хүртэлх насны ихэр хүүхэдтэй эх, эцэг, гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт олгох тэтгэмж.

Дээрх тэтгэмжүүд нь нийгмийн даатгалын сан, нийгмийн халамжийн сангаас санхүүжинэ. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд зааснаар нийгмийн даатгалын сан нь тэтгэврийн болон тэтгэмжийн даатгалын сангаас бүрдэх бөгөөд тэтгэмжийн даатгалын сангаас олгож буй 3 төрлийн тэтгэмжийн нэг нь жирэмсний болон амаржсаны тэтгэмж юм. Тэтгэмж нь хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдах, жирэмсний, амаржсаны чөлөө эдлэх, ажилгүй болох тохиолдолд даатгуулагч өөрт нь, даатгуулагч нас барсан тохиолдолд гэр бүлд нь хуульд заасан болзол, нөхцөлийн дагуу нийгмийн даатгалын сангаас тодорхой хугацаанд буюу нэг удаа олгох мөнгөн олговор юм.

Жирэмсний болон амаржсан тэтгэмжийг нийгмийн даатгалын сангаас санхүүжүүлэх бөгөөд даатгуулагчийн төлсөн шимтгэлээс сүүлийн 12 сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос дунджаас 100 хувиар тооцож төрөхийн өмнөх 2 сар, төрсний дараах 2 сард олгодог.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Жирэмсэн эхийн тэтгэмж нь төрөхийн өмнө (40.000 төгрөг) болон төрсний дараа (50.000 төгрөг) гэж ялгамжтай тогтоосон байх бөгөөд нийгмийн халамжийн сангаас 100 хувь санхүүжүүлдэг. Мөн 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа болон дөрөв хүртэлх насны ихэр хүүхэдтэй эх, эцэг, гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт мөн нийгмийн халамжийн сангаас олгож байна.

Хүүхдээ асарсны тэтгэмжийг зөвхөн эхэд олгодог байсныг Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн гэж үзсэн тул 2021 оны 5 дугаар сараас эхлэн 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа болон дөрөв хүртэлх насны ихэр хүүхэдтэй эх, эцэг, гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эцэгт тэтгэмжийг олгохоор шийдвэрлэсэн.

**<u>Хууль, эрх зүйн зохицуулалт</u>**

Монгол Улсын хувьд жирэмсний болон амаржсаны тэтгэмжтэй холбоотой харилцааг дараах хууль тогтоомжоор зохицуулж байна. Тухайлбал,

1. Нийгмийн даатгалын тухай хууль (1994 он)
2. Нийгмийн халамжийн тухай хууль (2012 он)
3. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль (1994 он)
4. Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хууль (2017 он)
5. Хөдөлмөрийн тухай хууль (1999 он)

**Нийгмийн даатгалын тухай хуульд** зааснаар нийгмийн даатгалын шимтгэлийг албан журмын болон сайн дурын даатгалын үндсэн дээр төлөх бөгөөд жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг нийгмийн даатгалын сангаас авна.

**Нийгмийн халамжийн тухай хууль** нь жирэмсэн болон амаржсаны дараа нийгмийн халамжийн сангаас олгогдох тэтгэмжтэй холбоотой харилцааг энэхүү хуулиар зохицуулах бөгөөд нийгмийн халамжийн сан бүрдүүлэх, уг сангийн хөрөнгийг зарцуулах, нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх, нийгмийн халамжийн байгууллагын тогтолцоо, чиг үүрэгтэй холбоотой харилцааг зохицуулсан.

**Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн** зургадугаар бүлгийг 1999 онд шинээр нэмсэн бөгөөд энэхүү бүлэгт жирэмсний болон амаржсаны тэтгэмжтэй холбоотой харилцааг зохицуулсан. Хуулийн $19^1$ дүгээр зүйлд зааснаар жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг дараах даатгуулагч авах эрхтэй. Үүнд:

1. Тэтгэмжийн даатгалын шимтгэлийг жирэмсний чөлөө авахаас өмнө 12 сараас доошгүй хугацаанд, үүнээс сүүлийн 6 сард нь уг шимтгэлийг тасралтгүй төлсөн даатгуулагч эх;
2. Тэтгэмжийн даатгалын шимтгэл төлөх хугацааг хангасан даатгуулагч эх, хүүхдээ 196-аас доошгүй хоног тээгээд дутуу төрүүлсэн буюу үр хөндүүлсэн, жирэмслэлтийг эмнэлгийн аргаар тасалсан, мөн 196 хоног тээгээгүй боловч амьдрах чадвартай хүүхэд төрүүлсэн бол;
3. Хөдөлмөр эрхэлж байгаад хууль тогтоомжид заасны дагуу хүүхдээ асрах чөлөөтэй байх хугацаанд дахин хүүхэд төрүүлсэн эх тус тус тэтгэмж авах эрхтэй.

*<u>Тэтгэмжийн хэмжээ, хугацаа:</u>* Тэтгэмж авах эрх үүссэн эхэд тэтгэмжийг дараах байдлаар олгоно. Үүнд:

- тэтгэмжийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн 12 сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас 100 хувиар тооцож 4 сарын хугацаанд;
- ихэр хүүхэд төрүүлсэн эхэд тэтгэмжийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн 12 сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас 100 хувиар тооцож 4 сар 20 хоногийн хугацаанд.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулиар** жирэмсэн эх, 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эх, эцэг, дөрөв хүртэлх насны ихэр хүүхэдтэй эх, эцэг, гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгохтой холбогдсон харилцааг зохицуулах бөгөөд энэ тэтгэвэр, тэтгэмжийг нийгмийн халамжийн сангаас олгоно. Энэхүү хуульд зааснаар олгох жирэмсэн эхийн тэтгэмжийг жирэмсний 5 сартайгаас төрөх хүртэл хугацаанд Засгийн газраас тогтоосон хэмжээгээр сар бүр 40.000 төгрөгийн тэтгэмжийг олгох бөгөөд тэтгэмжид зарцуулах хөрөнгийг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

Жирэмсэн эхийн тэтгэмж авч байсан иргэн хүүхэд төрөнгүүт 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж авах хүсэлт гаргах бөгөөд хүүхдийн тооноос үл хамааран 0-3 насны хүүхдээ асарч байгаа эх, эсхүл эцэгт Засгийн газраас тогтоосон хэмжээгээр буюу 50.000 төгрөгийг сар бүр олгоно.

Хэрэв ихэр хүүхэд төрүүлсэн бол ихэр хүүхдийн тэтгэмж авах бөгөөд Засгийн газраас тогтоосон хэмжээгээр буюу ихэр хүүхэдтэй бол тус бүрд 1,0 сая төгрөг, 3 болон түүнээс дээш ихэр хүүхэдтэй бол хүүхэд тус бүрд 3,0 сая төгрөгийн тэтгэмжийг 1 удаа олгоно.

**Хөдөлмөрийн тухай хуульд** зааснаар ажил олгогч нь жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эхийг ажлаас халахыг хориглох бөгөөд жирэмсэн эмэгтэй, найм хүртэлх насны хүүхэдтэй эх, 16 хүртэлх насны хүүхэдтэй ганц бие эхийг өөрөө зөвшөөрөөгүй тохиолдолд шөнийн буюу илүү цагаар, түүнчлэн албан томилолтоор ажиллуулахыг хориглодог.

Мөн Хөдөлмөрийн хуулийн 35 дугаар зүйлд зааснаар жирэмсний болон амаржсаны амралттай болон хүүхэд асрах чөлөөтэй байгаа үед ажил, албан тушаалыг хэвээр хадгалахаар заасан.

**Жирэмсний болон амаржсаны тэтгэмж авсан эхчүүдийн талаарх статистик мэдээлэл**

2020 оны статистик мэдээллээр нийгмийн даатгалын сангаас жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг 65.5 мянган эх авсан байна (Хавсралт 1). Жирэмсний болон амаржсаны тэтгэмж авсан даатгуулагчдын тоо 2016-2020 онд тогтмол өсөлттэй байсан бөгөөд өсөлтийн дундаж хувь нь 2.7 байна (Хүснэгт №1). Үүнээс албан журмын даатгалд даатгуулагч эхийн тоо мөн тогтмол өсөлттэй байсан бөгөөд дундаж өсөлт 3% байна (Хүснэгт №2). Харин сайн дурын даатгуулагч эхийн хувьд тогтмол хэмжээнд байсан бөгөөд өсөлтийн хувь 1,4 байна (Хүснэгт №3).

Нийгмийн даатгалд даатгуулсан эмэгтэй даатгуулагчдаас жирэмсний болон амаржсаны тэтгэмж авч буй эхийн тоо 12-13 хувьтай байна.

*Хүснэгт №1. Жирэмсний болон амаржсаны тэтгэмж авсан даатгуулагчдын тоо*

| Он | НД-д даатгуулсан нийт эмэгтэй даатгуулагч | Тэтгэмж авсан эх | Эзлэх хувь |
|---|---|---|---|
| **2016** | 467286 | 58,132 | 12,4% |
| **2017** | 468484 | 57,769 | 12,3% |
| **2018** | 487870 | 61,507 | 12,6% |
| **2019** | 500530 | 63,384 | 12,6% |
| **2020** | 517316 | 64,575 | 12,4% |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

*Хүснэгт №2. Албан журмын даатгуулагч эхийн тоо*

| Он | НД-д даатгуулсан нийт эмэгтэй даатгуулагч | Тэтгэмж авсан эх | Эзлэх хувь |
|---|---|---|---|
| **2016** | 343,639 | 46424 | 13,5% |
| **2017** | 358,582 | 45104 | 12,5% |
| **2018** | 378,907 | 48295 | 12,7% |
| **2019** | 397,197 | 50658 | 12,7% |
| **2020** | 400,276 | 52215 | 13,0% |

*Хүснэгт №3. Сайн дурын даатгуулагч эхийн тоо*

| Он | НД-д даатгуулсан нийт эмэгтэй даатгуулагч | Тэтгэмж авсан эх | Эзлэх хувь |
|---|---|---|---|
| **2016** | 123,647 | 11,708 | 9,4% |
| **2017** | 109,902 | 12,665 | 11,5% |
| **2018** | 108,963 | 13,212 | 12,1% |
| **2019** | 103,333 | 12,726 | 12,3% |
| **2020** | 117,040 | 12,360 | 10,5% |

Жирэмсний болон амаржсаны тэтгэмж авсан даатгуулагчдын насны байдлыг авч үзвэл, 25-39 насны эмэгтэйчүүд нийт тэтгэмж авсан эхийн 88,6%-ийг эзэлж байна. Харин 15-19, 45-аас дээш насны эхчүүд хамгийн бага буюу нийт тэтгэмж авсан эхийн 4,1%-ийг эзэлж байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**Хавсралт-1.Жирэмсний болон амаржсаны тэтгэмж авсан даатгуулагчдын тоо, олгосон тэтгэмж**

| Насны бүлэг | 2016 | | | | 2017 | | | | 2018 | | | | 2019 | | | | 2020 | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Хүний тоо | Олгосон тэтгэмжийн хэмжээ, сая.төг | үүнээс албан журмын даатгуулагч эх | | Хүний тоо | Олгосон тэтгэмжийн хэмжээ, сая.төг | үүнээс албан журмын даатгуулагч эх | | Хүний тоо | Олгосон тэтгэмжийн хэмжээ, сая.төг | үүнээс албан журмын даатгуулагч эх | | Хүний тоо | Олгосон тэтгэмжийн хэмжээ, сая.төг | үүнээс албан журмын даатгуулагч эх | | Хүний тоо | Олгосон тэтгэмжийн хэмжээ, сая.төг | үүнээс албан журмын даатгуулагч эх | |
| | | | Хүний тоо | Олгосон тэтгэмжийн хэмжээ, сая.төг | | | Хүний тоо | Олгосон тэтгэмжийн хэмжээ, сая.төг | | | Хүний тоо | Олгосон тэтгэмжийн хэмжээ, сая.төг | | | Хүний тоо | Олгосон тэтгэмжийн хэмжээ, сая.төг | | | Хүний тоо | Олгосон тэтгэмжийн хэмжээ, сая.төг |
| **Бүгд** | **58,132** | **68,371.9** | **46424** | **63,879.2** | **57,769** | **70,564.4** | **45104** | **65,281** | **61,507** | **79,914.1** | **48295** | **74,210.17** | **63,384** | **90,226.9** | **50,658.0** | **86,253.0** | **64,575** | **109,900.3** | **52215** | **99,570.74** |
| 15-19 | 35 | 39.4 | 25 | 36.70 | 39 | 38.24 | 27 | 35 | 50 | 62.8 | 35 | 55.4 | 56 | 74.6 | 48.0 | 73.2 | 62 | 105.7 | 52 | 97.9 |
| 20-24 | 4629 | 4,385.8 | 3582 | 3,994.84 | 4194 | 4,190.61 | 3133 | 3,756 | 4,730 | 5,030.6 | 3578 | 4,538.4 | 5,141 | 6,356.4 | 4,134.0 | 6,004.1 | 5,007 | 7,412.0 | 4101 | 6,644.6 |
| 25-29 | 21760 | 25,256.2 | 17964 | 23,699.56 | 20806 | 25,121.57 | 16936 | 23,396 | 20,456 | 25,504.6 | 16601 | 23,822.2 | 19,455 | 26,537.6 | 16,000.0 | 25,419.3 | 18,578 | 29,769.0 | 15547 | 27,241.8 |
| 30-34 | 17749 | 21,743.5 | 14187 | 20,382.69 | 18391 | 23,338.76 | 14487 | 21,739 | 20,730 | 28,108.9 | 16434 | 26,201.6 | 21,819 | 31,770.7 | 17,528.0 | 30,478.4 | 22,718 | 39,927.3 | 18384 | 36,180.9 |
| 35-39 | 10753 | 12,946.2 | 8247 | 12,049.27 | 11006 | 13,755.11 | 8176 | 12,644 | 11,800 | 16,108.4 | 8899 | 14,921.6 | 13,086 | 19,620.4 | 10,054.0 | 18,694.9 | 14,092 | 25,138.3 | 11008 | 22,696.7 |
| 40-44 | 3026 | 3,772.6 | 2285 | 3,510.91 | 3145 | 3,852.22 | 2198 | 3,468 | 3,546 | 4,836.4 | 2612 | 4,436.6 | 3,629 | 5,577.0 | 2,744.0 | 5,303.3 | 3,870 | 7,047.3 | 2933 | 6,299.2 |
| 45-49 | 167 | 207.0 | 123 | 187.02 | 180 | 252.09 | 139 | 227 | 184 | 232.7 | 127 | 205.3 | 193 | 282.3 | 145.0 | 271.1 | 238 | 465.6 | 182 | 388.9 |
| 50-54 | 6 | 11.1 | 4 | 7.96 | 5 | 8.75 | 5 | 9 | 2 | 0.6 | 0 | - | 3 | 7.0 | 2.0 | 6.4 | 6 | 22.9 | 4 | 8.7 |
| 55-59 | 0 | - | 0 | - | 0 | - | 0 | - | - | - | 0 | - | - | - | 1.0 | 1.4 | - | - | 0 | - |
| 60-64 | 1 | - | 1 | - | 0 | - | 0 | - | - | - | 0 | - | - | - | - | - | - | - | 0 | - |
| 65-69 | 0 | - | 0 | - | 0 | - | 0 | - | 1 | 1.4 | 1 | 1.4 | - | - | - | - | - | - | 0 | - |
| 70-74 | 0 | - | 0 | - | 0 | - | 0 | - | - | - | 0 | - | - | - | - | - | - | - | 0 | - |
| 75-аас дээш | 6 | 10.2 | 6 | 10.20 | 3 | 7.05 | 3 | 7 | 8 | 27.6 | 8 | 27.7 | 2 | 0.9 | 2.0 | 0.9 | 4 | 12.2 | 4 | 12.2 |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ


**Олон улсын баримт бичгийн хэсэг**

- Maternity Protection Legislation Worldwide. Elaine Petitat-Côté. https://www.gifa.org/wp-content/uploads/2017/01/Intro-Maternity-Protection-Legislation-Worldwide-1.pdf
- Монгол Улсын олон улсын гэрээ. Эхчүүдийг хамгаалах тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 103 дугаар конвенц (хянаж өөрчилсөн) https://www.legalinfo.mn/law/details/1192
- International Labour Standards on Maternity protection International Labour Organization.
- https://www.ilo.org/global/standards/subjects-covered-by-international-labour-standards/maternity-protection/lang--en/index.htm
- Албан бус эдийн засагт ажиллагчдыг жирэмсний болон амаржсаны тэтгэмжид хамруулах нь, International Labour Organization. 2016. https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---asia/---ro-bangkok/---ilo-beijing/documents/publication/wcms_544098.pdf
- Koslowski, A., Blum, S., Dobrotić, I., Kaufman, G. and Moss, P. (2021) *International Review of Leave Policies and Research 2021*. http://www.leavenetwork.org/lp_and_r_reports/
- Деверюкс, С., 2015: Нийгмийн хамгаалалд болон хоол хүнсээр хангагдах эрхийг хэрэгжүүлэх нь. Нийгмийн хамгааллын суурь түвшний хүнсний аюулгүй байдал, бүх нийтээр зохистой хоол хүнсээр хангагдах эрхийг хэрэгжүүлэхэд оруулах хувь нэмэр (Женев: ОУХБ).

**Герман улс**

- https://www.bmfsfj.de/resource/blob/139908/72ce4ea769417a058aa68d9151dd6fd3/elterngeld-elterngeldplus-englisch-data.pdf
- https://www.globalpeoplestrategist.com/4-countries-with-the-best-parental-leave-laws/
- https://www.make-it-in-germany.com/en/living-in-germany/family-life/parental-leave-benefit
- https://www.global-regulation.com/translation/germany/385266/the-parental-allowance-and-parental-leave-act.html
- https://ub-deposit.fernuni-hagen.de/servlets/MCRFileNodeServlet/mir_derivate_00002197/Koslowski_et_al_Leave_Policies_2021.pdf

**Финланд улс**

- Family leave reform
- https://stm.fi/en/-/draft-government-proposal-for-family-leave-reform-completed
- Employment and Labour Laws https://iclg.com/practice-areas/employment-and-labour-laws-and-regulations/finland
- Social Welfare Act https://www.finlex.fi/fi/laki/kaannokset/1982/en19820710_20140491.pdf
- Child Welfare Act https://www.finlex.fi/en/laki/kaannokset/2007/en20070417_20131292.pdf
- Child Home Care and Private Day Care Allowance https://www.finlex.fi/fi/laki/alkup/1996/19961128
- Maternity Benefit Act https://clc.gov.in/clc/sites/default/files/MATERNITY%20BENEFIT%20ACT.pdf
- Employment Contracts Act https://www.finlex.fi/en/laki/kaannokset/2001/en20010055.pdf

**Норвеги улс**

- Working Environment Act https://www.arbeidstilsynet.no/globalassets/regelverkspdfer/working-environment-act
- Norwegian Labour and Welfare Administration https://familie.nav.no/om-foreldrepenger
- 17th International Review of Leave Policies and Related Research 2021 https://ub-deposit.fernuni hagen.de/servlets/MCRFileNodeServlet/mir_derivate_00002197/Koslowski_et_al_Leave_Policies_2021.pdf


UIH.MN СУДАЛГААНЫ САН

- Family related benefits https://familie.nav.no/om-foreldrepenger#hvem-kan-fa-foreldrepenger https://www.nav.no/en/home/benefits-and-services/family-related-benefits
- Cash for care benefit https://www.nav.no/en/home/relatert-informasjon/cash-for-care-benefits-
- for-the-parents-of-toddlers

**Тайвань (БНХАУ)**

- Taiwan enhances parental leave policies » Winkler Partners - Attorneys at Law of Taiwan and Foreign Legal Affairs
- https://www.bli.gov.tw/En/
- Labor Standards Act - Article Content - Laws & Regulations Database of The Republic of China (moj.gov.tw)
- Act of Gender Equality in Employment - Article Content - Laws & Regulations Database of The Republic of China (moj.gov.tw)
- Employment Insurance Act - Article Content - Laws & Regulations Database of The Republic of China (moj.gov.tw)
- Regulations for Implementing Unpaid Parental Leave for Raising Children - Article Content - Laws & Regulations Database of The Republic of China (moj.gov.tw)
- Regulations on Special Leave for Employees of the Executive Yuan and Subordinated Agencies - Article Content - Laws & Regulations Database of The Republic of China (moj.gov.tw)
- Labor Standards Act - Article Content - Laws & Regulations Database of The Republic of China (moj.gov.tw)
- https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=S0010008
- Bureau of Labor Insurace Website-Employee-How to Apply for Insurance Benefit Payment?-Labor Insurance Benefit Payment-Maternity Benefits Payment (bli.gov.tw)

Монгол Улс

- Нийгмийн даатгалын тухай хууль (1994 он) https://www.legalinfo.mn/law/details/390
- Нийгмийн халамжийн тухай хууль (2012 он) https://www.legalinfo.mn/law/details/393
- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль (1994 он) https://www.legalinfo.mn/law/details/383
- Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хууль (2017 он) https://www.legalinfo.mn/law/details/12756
- Хөдөлмөрийн тухай хууль (1999 он) https://www.legalinfo.mn/law/details/565
- Нийгмийн даатгал, халамж 2017, ҮСХ https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Social_insurance_and_welfare_2017.pdf&ln=Mn
- Нийгмийн хамгааллын статистик-2019, ҮСХ, 2020 он https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Social_Protection_intro_2019.pdf&ln=Mn
- Нийгмийн даатгалын ерөнхий газрын статистик мэдээлэл


UIH.MN
СУДАЛГААНЫ САН

# ТЭТГЭВРИЙН ХУРИМТЛАЛЫН ТОГТОЛЦООНЫ ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

*Ц.Норовдондог (Ph.D), Р.Нургүл, Ц.Ариунаа,*
*И.Жаргалзаяабямба, П.Уранчимэг*

## АГУУЛГА

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ

Нэг. ТЭТГЭВРИЙН ТОГТОЛЦОО

Хоёр. ТЭТГЭВРИЙН ХУРИМТЛАЛЫН ТОГТОЛЦООТОЙ ОРНУУДЫН ТУРШЛАГА

1. БҮГД НАЙРАМДАХ СИНГАПУР УЛС
2. БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН УЛС
3. НОРВЕГИЙН ХААНТ УЛС
4. БҮГД НАЙРАМДАХ ЧИЛИ УЛС
5. НИДЕРЛАНДЫН ХААНТ УЛС

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

## Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1.Тэтгэврийн хуваарилалтын болон хуримтлалын тогтолцооны сул ба давуу тал
Хүснэгт 2. Хуримтлалын данс
Хүснэгт 3. Хуримтлалын шимтгэлийн хувь хэмжээ, дансны хуваарилалт
Хүснэгт 4. MediSave дансны шимтгэл
Хүснэгт 5. Хуримтлалын дансны хүү
Хүснэгт 6. Нэмэлт хүү
Хүснэгт 7. Тэтгэврийн дансанд шилжүүлэх хуримтлал
Хүснэгт 8. CPF LIFE хөтөлбөрт хамрагдах нөхцөл /Стандарт тэтгэвэр/
Хүснэгт 9. Өв залгамжлах эрх үүсэх нөхцөл
Хүснэгт 10. Silver Support Scheme хөтөлбөрт хамрагдах иргэнд олгох дэмжлэг
Хүснэгт 11. Workfare Income
Хүснэгт 12. Workfare Income Supplement Scheme хөтөлбөрт хамрагдсан иргэнд үзүүлэх санхүүгийн дэмжлэг
Хүснэгт 13. Тэтгэвэр авах нөхцөл, хэлбэр, хэмжээ
Хүснэгт 14. Чили Улсын сан
Хүснэгт 15. Нидерландын тэтгэврийн шимтгэлийн хувь хэмжээ

## Зургийн жагсаалт

Зураг 1. Хуваарилалтын тогтолцооны тэтгэвэр олголт
Зураг 2. Хуримтлалын тогтолцооны тэтгэвэр олголт
Зураг 3. Хуримтлалын дансанд шимтгэл төлөх
Зураг 4. Хуримтлалын төвлөрсөн сангийн засаглал
Зураг 5. Тэтгэврийн хуримтлалыг хөрөнгө оруулалтад оруулах
Зураг 6. CPF LIFE хөтөлбөрөөс олгох тэтгэврийн төрөл
Зураг 7. Энгийн дансны хуримтлалын зарцуулалт
Зураг 8. Төрийн тэтгэврийн хуримтлалын тогтолцооны бүтэц
Зураг 9.ТХНС-ийн засаглал
Зураг 10.ХОМБ-аар дамжуулан тэтгэврийн хуримтлалаа хөрөнгө оруулалтад оруулах
Зураг 11. Норвегийн баялгийн сан, тэтгэврийн сан
Зураг 12. Норвегийн Засгийн газрын тэтгэврийн сан
Зураг 13. Норвегийн тэтгэврийн сангийн хөрөнгө оруулалтын бүтэц
Зураг 14. Тэтгэврийн тогтолцоо
Зураг 15. Тэтгэвэр болон баялгийн сан
Зураг 16. Нидерланд улсын тэтгэврийн тогтолцоо
Зураг 17. Тэтгэврийн гурвалжин

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

## УДИРТГАЛ

Судалгааны захиалгын дагуу “Тэтгэврийн хуримтлалын тогтолцооны талаарх гадаадын зарим орны туршлага” сэдэвт судалгааны ажлыг Парламентын судалгааны хүрээлэнд гүйцэтгэв.

**Судалгааны зорилго:** УИХ-ын гишүүний захиалгын дагуу тэтгэврийн хуримтлалын тогтолцоо бүхий орнуудын туршлагыг харьцуулан судлах.

**Судалгааны хамрах хүрээ:** Судалгаанд Нидерланд, Сингапур, Казахстан, Норвеги, Чили зэрэг тэтгэврийн хуримтлалын тогтолцоотой орнуудыг сонгон авч тэтгэврийн хуримтлалын сан бүрдүүлэлт, сангийн удирдлага, сангийн зарцуулалттай холбоотой асуудлуудыг дэлгэрүүлэн судлав. Мөн судалгааны эхний бүлэгт тэтгэврийн тогтолцооны талаарх ерөнхий мэдээллийн хүрээнд тэтгэврийн хуримтлалын тогтолцооны онцлогийн талаарх мэдээллийг дэлгэрүүлэн авч үзсэн болно.

**Судалгааны арга зүй:** Судалгааны явцад холбогдох мэдээллийг гадаад хэлнээс хөрвүүлэх, судалгааны захиалга болон удирдамжид заасан сэдэв, чиглэлийн дагуу мэдээллийг харьцуулан судлах, нэгтгэн дүгнэх зэрэг арга зүйг ашиглав.

***Keyword**:* *pension system, funded pension system*

***Түлхүүр үг:*** *тэтгэврийн тогтолцоо, тэтгэврийн хуримтлалын тогтолцоо*

## СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Аливаа улс орон тэтгэврийн тогтолцоогоо бүрдүүлэхдээ тухайн орны эдийн засаг, нийгэм, улс төрийн нөхцөл байдлыг анхааран үзэж ирээдүйгээ харсан зөв тогтолцоог бүрдүүлэх нь чухал гэж үздэг байна. Дэлхийд тэтгэврийн тогтолцооны хуваарилалтын болон хуримтлалын гэсэн 2 сонгодог хэлбэр байдаг. Тэтгэврийн хуваарилалтын (Pay-as-you-go буюу PAYG) болон тэтгэврийн хуримтлалын (Fully funded) тогтолцооны аль аль нь давуу болон сул талтай тул тогтолцооны сонголтыг хийхдээ үр ашиг, эрсдэлийг сайтар тооцох шаардлагатай хэмээн судлаачид зөвлөдөг.[286]

*<u>Тэтгэврийн хуваарилалтын тогтолцооны үед</u>* одоогийн ажил эрхлэгчид нь одоогийн тэтгэврийг санхүүжүүлдэг бөгөөд ирээдүйд тэтгэвэрт гарах үедээ ирээдүйн ажил эрхлэгчдийн санхүүжилтэд найдах хэрэгтэй болдог. Өөрөөр хэлбэл, хүн амын өсөлтөөр бий болсон илүү олон ажил эрхлэгчид, эдийн засгийн өсөлтөөр бий болсон илүү өндөр цалингаас шимтгэл төлж энэхүү тогтолцоог санхүүжүүлж байдагт энэхүү тогтолцооны эдийн засгийн механизм оршино. Тиймээс тэтгэврийн хуваарилалтын тогтолцоо нь хүн ам зүйн болон эдийн засгийн өсөлтийн бодлоготой шууд холбоотой.

Тэтгэврийн хуваарилалтын тогтолцооны үед тэтгэврийг дараах 2 аргаар тогтоодог.

- Тогтсон хэмжээгээр тэтгэвэр тогтоох (Defined benefits буюу DB) – Тэтгэвэр нь цалин болон шимтгэл төлсөн хугацаанаас хамааран тогтоогддог.
- Нэрийн дансаар тогтоох (Notional Defined Contributions буюу NDC) – Төлсөн шимтгэл нь нэрийн дансанд хөтлөгдөх бөгөөд тухайн нэрийн дансанд хүүгийн бичилт хийнэ. Тэтгэвэрт гарах үед нь энэ дансанд хуримтлагдсан бичилтээс тэтгэвэр тооцогдоно.

*<u>Тэтгэврийн хуримтлалын тогтолцооны үед</u>* тэтгэврийн санхүүжилт нь тэтгэврийн шимтгэл болон хуримтлагдсан хөрөнгийг санхүүгийн зах зээлд байршуулж олсон ашгаас бүрддэг. Тиймээс энэ тогтолцоо нь санхүүгийн зах зээлийн нөхцөл байдалтай шууд холбоотой.

[286] https://journals.openedition.org/estetica/5747

Тэтгэврийн хуримтлалын тогтолцооны үед тэтгэврийг хуримтлалаас тооцож тогтоох (Defined Contributions буюу DC) аргачлалыг ашиглана. Өөрөөр хэлбэл, ажил эрхлэгч тэтгэвэрт гарахад нийт хуримтлагдсан мөнгөнөөс хамааран авах тэтгэвэр нь тогтоогдоно. Тэтгэврийн хуримтлалын тогтолцооны үед тодорхой хугацааны туршид хуримтлал бий болсны дараа тэтгэврийн хуваарилалт хийгддэг учраас энэ тогтолцоог шууд нэвтрүүлэх боломжгүй байдаг.

Тэтгэврийн тогтолцоонд туйлын зөв тогтолцоо гэж байхгүй бөгөөд аль ч тогтолцоо нь өөрийн давуу, сул талтай байдаг учраас практикт хуваарилалтын болон хуримтлалын тогтолцоог хослуулан хэрэглэх нь элбэг байдаг байна. Тухайлбал, Герман, Франц, Итали, Америк зэрэг орнууд нь анх зөвхөн хуримтлалын тогтолцоог нэвтрүүлсэн боловч Америк Их хямралын дараа Герман, Франц, Итали Дэлхийн II дайны дараах гиперинфляцын үед хуваарилалтын тогтолцоог нэвтрүүлсэн байна. Дэлхийн II дайны дараах эдийн засаг болон хүн амын өсөлтийн тааламжтай нөхцөлд барууны олон улс хуваарилалтын тогтолцоог амжилттай нэвтрүүлсэн нь тухайн улс орнуудын нийгэм-эдийн засагт ихээхэн эерэг нөлөө үзүүлсэн байдаг. Гэвч хүн амын насжилт болон санхүүгийн их хямралын дараах эдийн засгийн сул өсөлт нь хуримтлалын тогтолцоог хөгжүүлэх шаардлагыг бий болгож, улс орнууд тэтгэврийн тогтолцоондоо шинэчлэл хийх бодлого баримтлах болсон.

Тэтгэврийн хуваарилалтын болон хуримтлалын тогтолцооны давуу болон сул талыг авч үзвэл:

*<u>Тэтгэврийн хуваарилалтын тогтолцооны үед</u>* тэтгэвэр авагч урьдчилан тогтоосон хувь хэмжээгээр тэтгэвэр тогтоолгох давуу талтай байдаг бол нийгэм, эдийн засаг, хүн ам зүйн бодлогоос өндөр хамааралтай байдаг тул төрөөс тэтгэврийн шимтгэлийн хувь хэмжээ болон тэтгэвэрт гарах насыг нэмэгдүүлэх эрсдэлтэй тулгарч байдаг.

*<u>Тэтгэврийн хуримтлалын тогтолцооны үед</u>* тухайн хүний хуримтлуулсан шимтгэлээс хамааруулан тэтгэвэр тогтоох тул хүн амзүйн болон төсөв, эдийн засгийн бусад нөхцөл байдлууд нөлөөлөхгүй байх давуу талтай боловч хэрэв тухайн хүн хангалттай хуримтлал үүсгэж чадахгүй бол хуримтлуулсан шимтгэлээс хамааран бага тэтгэвэр тогтоолгох эрсдэлтэй. Түүнчлэн хуримтлалын сан нь эдийн засагт тодорхой хэмжээний хуримтлалыг бий болгож хөрөнгө оруулалтын эх үүсвэр болон ашиглагдсанаар эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх боловч нөгөө талдаа эдийн засгийн хямрал, санхүүгийн зах зээлийн эрсдэлээс өндөр хамааралтай учраас эрсдэлтэйд тооцогдоно.

**Судалгаанд авагдсан орнуудын туршлагыг тоймлон авч үзвэл:**

*<u>Тэтгэврийн тогтолцооны хувьд</u>* судалгаанд авагдсан 5 орон бүгд хуримтлалын тогтолцоог хэрэгжүүлж байгаа бөгөөд зарим нь бүрэн хуримтлалын тогтолцоотой, зарим нь хуваарилалтын болон хуримтлалын хосолсон тогтолцоотой байна. Тухайлбал, Сингапур Улс тэтгэврийн бүрэн хуримтлалын тогтолцоотой. Чили Улс 1981 онд тэтгэврийн шинэчлэл хийснээр хуваарилалтын тогтолцооноос хуримтлалын тогтолцоонд шилжсэн боловч одоогоор хүн амын нэг хэсэг нь хуучин тогтолцоондоо хамрагдаж хуваарилалтын зарчмаар тэтгэвэр авч байна. Цаашдаа хуучин тогтолцоогоо дуусгаж хуримтлалын тогтолцоонд бүрэн шилжих төлөвлөгөөтэй байна.

Нидерланд, Казахстан, Норвеги зэрэг улсууд хуваарилалт болон хуримтлалын тогтолцоог хослуулан хэрэглэдэг. Казахстан Улсын хувьд 1998 онд тэтгэврийн шинэчлэл хийж тэтгэврийн хуримтлалын тогтолцоог нэвтрүүлсэн. Одоогоор шинэ, хуучин 2 системийг хослуулан хэрэглэж байгаа бөгөөд цаашдаа шинэ системдээ бүрэн шилжих төлөвлөгөөтэй байна. (1998 оноос өмнө ажил эрхэлж эхэлсэн иргэд тэтгэврийн хуучин системд, 1998 оноос ажил эрхэлж эхэлсэн иргэд шинэ систем хамрагдана)

UIH.MN СУДАЛГААНЫ САН

*Тэтгэвэр авах эрх үүсдэг нас улс орон бүрд өөр байна*. Сингапурт 65, Нидерландад 66, Норвегит 62 нас байх бөгөөд хүйс харгалзахгүй. Норвегит иргэн өөрөө хүсвэл 75 нас хүртэл ажиллаж болно. Үлдсэн хоёр орны хувьд хүйсээр ялгаатай байна. Казахстанд эрэгтэй 63, эмэгтэй 60 нас (эмэгтэй насыг мөн 63 болгох зорилгоор жил бүр 6 сараар нэмэгдүүлж байна), Чилид эрэгтэй 65, эмэгтэй 60 нас байна.

*Улс орнууд тэтгэврийн хуримтлалын тогтолцоог тэтгэврийн хуримтлалын сан байгуулах замаар хэрэгжүүлж байна*. Тэтгэврийн хуримтлалын тогтолцоо төрийн, хувийн гэсэн 2 хэлбэртэй байхаас гадна заавал хамрагдах, сайн дураар хамрагдах хэлбэртэй байж болдог.

Зарим орны хувьд заавал хамрагдах хуримтлалын тэтгэврийг төрөөс хэрэгжүүлдэг бол зарим оронд хувийн сектор хэрэгжүүлж байна.

Судалгаанд авагдсан орнуудаас Сингапур, Казахстан улсууд нь төрийн хуримтлалын тэтгэврийн тогтолцоог хэрэгжүүлдэг бөгөөд хуримтлалын нэгдсэн сантай. Иргэд албан журмаар заавал хамрагдах зохицуулалттай боловч Казахстан Улсын хувьд одоогоор тэтгэврийн шинэ, хуучин 2 системийг хослуулан хэрэглэж байгаа тул хуучин системд хамрагдсан хүмүүс хуримтлалын нэгдсэн сангийн тэтгэвэрт хамрагдахгүй, зөвхөн тус сангаас санал болгодог сайн дурын санд хамрагдах боломжтой. 1998 оноос хойш ажил эрхэлж байгаа хүмүүс албан журмын хуримтлалд хамрагдана. Эдгээр орнуудын аль аль нь хуримтлалын нэгдсэн сангаас заавал хамрагдах хуримтлалын тэтгэврээс гадна сайн дурын хуримтлалын тэтгэврийн үйлчилгээг санал болгодог.

Нидерланд, Норвеги, Чили зэрэг орнуудад хуримтлалын нэгдсэн сан байхгүй бөгөөд заавал хамрагдах хувийн тэтгэврийн хуримтлалын тогтолцоотой байна. Норвеги Улсын хувьд зөвхөн хувийн секторын компани, албан байгууллагууд л тэтгэврийн хуримтлалын сан үүсгэх бөгөөд заавал даатгуулах хэлбэртэй байна. Судалгаанд авагдсан орнуудын тэтгэврийн хуримтлалын сангууд нь улс болгонд өөр өөр нэршилтэй байна. Тухайлбал:

- Сингапур Улсад Хуримтлалын төвлөрсөн сан (Central Provident Fund) гэж нэрлэх ба хуримтлалын төрийн сангийн тогтолцоотой.
- Казахстан Улсад Тэтгэврийн хуримтлалын нэгдсэн сан (Unified Accumulative Pension Fund) гэж нэрлэх ба хуримтлалын төрийн сангийн тогтолцоотой.
- Нидерланд Улсад хуримтлалын нэгдсэн сан байхгүй, тэтгэврийн хуримтлалын тогтолцоог эдийн засгийн салбарууд, мэргэжлийн салбарууд, эсвэл томоохон компаниуд тус тусдаа өөр дээрээ тэтгэврийн хуримтлалын сан үүсгэх замаар хэрэгжүүлдэг.
- Норвеги Улсад мөн адил хуримтлалын нэгдсэн сан байхгүй. Албан байгууллага, компани тус бүр тэтгэврийн хуримтлалын сан үүсгэдэг бөгөөд зөвхөн хувийн секторын байгууллагууд тэтгэврийн хуримтлал үүсгэх эрхтэй байна.
- Чили Улсад хуримтлалын нэгдсэн сан байхгүй, хувийн тэтгэврийн хуримтлалын тогтолцоотой ба хуримтлалын тэтгэврийг зөвхөн хувийн сектор хариуцан хэрэгжүүлнэ. Бие даасан Тэтгэврийн сангийн менежментийн компаниуд тэтгэврийн хуримтлалын сангуудыг үүсгэн удирддаг.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

*Хүснэгтэд судалгаанд авагдсан 5 орны тэтгэврийн хуримтлалын сангийн удирдлага, сангийн орлогын эх үүсвэр, зарцуулалтын талаарх мэдээллийг тоймлон харуулав.*

| | **Хуримтлалын сангийн удирдлага** | **Сангийн Орлого** | **Сангийн зарцуулалт** |
|---|---|---|---|
| Сингапур | Сангийн дээд удирдлагыг Удирдах зөвлөл, өдөр тутмын үйл ажиллагааг Гүйцэтгэх захирал болон гүйцэтгэх удирдлагууд хэрэгжүүлнэ. Сангийн дотоод хяналтыг Удирдах зөвлөлийн Аудитын хороо хийдэг.<br>Санд жилд дор хаяж нэг удаа аудитын хяналт шалгалт явуулах бөгөөд Ерөнхий Аудитор эсвэл, Ерөнхий аудитортой зөвшилцсөний үндсэн дээр Хөдөлмөрийн сайдын томилсон хараат бус аудитор хэрэгжүүлнэ. | • Хуримтлалын шимтгэлийн орлого;<br>• Засгийн газрын тусгайлан гаргасан үнэт цаасны хүүгийн орлого<br>• Хөрөнгө оруулалтын орлого | • Өндөр насны тэтгэвэр;<br>• Орон сууц худалдан авах;<br>• Эрүүл мэндийн үйлчилгээний төлбөр;<br>• Сургалтын зээл;<br>• Хөрөнгө оруулалт хийх;<br>• Өвлүүлэх |
| Казахстан | Сангийн дээд удирдлагыг Үндэсний сангийн зөвлөл хэрэгжүүлдэг. Харин өдөр тутмын үйл ажиллагааг Гүйцэтгэх удирдлага хэрэгжүүлэх ба Төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавьж ажиллана. Хөрөнгийн удирдлагыг Казахстаны Үндэсний банк хариуцдаг. Сангийн дэргэд сангийн үйл ажиллагаанд хяналт тавих, зөвлөх үүрэгтэй Олон нийтийн зөвлөл ажилладаг. Энэ нь тэтгэврийн тогтолцооны бүх оролцогчдыг хамарсан бие даасан бүтэц юм. Сангийн дотоод хяналтыг Төлөөлөн удирдах зөвлөл, Аудитын хороо, Дотоод аудитын газар хэрэгжүүлнэ. Жилд дор хаяж нэг удаа аудитын хяналт шалгалт явуулна. Аудитыг бие даасан хараат бус аудитор гүйцэтгэнэ. | • Тэтгэврийн шимтгэлийн орлого;<br>• Хүү, хөрөнгө оруулалтын орлого | • Өндөр насны тэтгэвэр;<br>• Зорилтот хэрэгцээнд ашиглах (орон байрны нөхцөл сайжруулах, эмчилгээний зардал, гадаад улсад байнга оршин суухаар явах).<br>• Амь даатгалын компанид шилжүүлэх;<br>• Хөрөнгө оруулалт хийх;<br>• Өвлүүлэх |
| Норвеги | Тэтгэврийн хуримтлалын сангаа тухайн ажил олгогч байгууллага өөрөө удирдана эсвэл, мэргэжлийн байгууллагаар удирдуулна. Энэ нь тухайн байгууллагын санал болгож буй тэтгэврийн хөтөлбөрөөс хамаардаг. | • Хуримтлалын шимтгэлийн орлого<br>• Тэтгэврийн татварын орлого | • Өндөр насны тэтгэвэр |
| Чили | Тэтгэврийн сангийн менежментийн компаниуд хуримтлалын сангийнхаа үйл ажиллагаа өөрсдөө удирдан зохион байгуулдаг. Эдгээр компаниудад төрөөс тавих хяналтыг Тэтгэврийн сангийн менежментийн компаниудыг хянах газар (Superintendency of Pension Fund Administrators - SAFP) хэрэгжүүлнэ. | • Хуримтлалын шимтгэлийн орлого<br>• Хөрөнгө оруулалтын орлого<br>• Сангаас олгох тэтгэвэр тэтгэврийн доод хэмжээнд хүрэхгүй тохиолдолд төрөөс олгох нөхөн олговор | • Өндөр насны тэтгэвэр |
| Нидерланд | Хуримтлагдсан хөрөнгийг тэтгэврийн сан болон даатгалын байгууллагууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр удирдан зохион байгуулдаг. Тэтгэврийн сан болон даатгалын байгууллагуудад Нидерландын банк, Санхүүгийн зах зээлийн газар зэрэг хоёр байгууллага хяналт тавьдаг байна. | • цалингийн орлогоос төлөх шимтгэл<br>• хөрөнгө оруулалтын орлого<br>• хувь хүний тэтгэврийн шимтгэлийн орлого<br>• татварын орлого<br>• хуримтлалын шимтгэлийн орлого | • өндөр насны тэтгэвэр<br>• хөрөнгө оруулалт хийх<br>• тэтгэвэр өвлүүлэх |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

## СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ

## Нэг. ТЭТГЭВРИЙН ТОГТОЛЦОО[287]

Бүх нийтийг хамарсан тэтгэврийн тогтолцоог Германы канцлер Отто фон Бисмарк 1889 онд нэвтрүүлснээс хойш дэлхийд хамгийн өргөн түгсэн хөдөлмөр, нийгмийн хамгааллын тогтолцоо болж чадсан. Тэтгэврийн тогтолцоо нь эдийн засагт бий болсон баялгийн тодорхой хэсгийг өндөр настан ахмадуудад хуваарилах тогтолцоо бөгөөд үүнийг албан журмын хуримтлал, даатгалын хэлбэрээр хэрэгжүүлдэг.

Тэтгэврийн тогтолцоо нь баялгийн тэгш хуваарилалтыг бий болгох, ажил эрхлэгчдэд албан журмын тэтгэврийн хуримтлал үүсгэх боломжийг бүрдүүлэх, ахмад настнуудын амьжиргааны эх үүсвэрийг бий болгох замаар ядуурлыг бууруулах зэрэг нийгэм-эдийн засгийн асуудлуудыг шийдвэрлэж байдаг.

Улс орнууд тэтгэврийн тогтолцоог бий болгохдоо тэтгэврийн тогтолцоог хэрхэн санхүүжүүлэх вэ, тэтгэвэр авагчдын тэтгэврийг хэрхэн тогтоох вэ, тэтгэвэр авах насыг хэрхэн тооцох вэ гэсэн 3 хүчин зүйлсийг анхаарч үздэг.

Тэтгэврийн тогтолцооны 2 сонгодог хэлбэр байдаг.

1. Тэтгэврийн хуваарилалтын тогтолцоо (Pay-as-you-go буюу PAYG)
2. Тэтгэврийн хуримтлалын тогтолцоо (Fully funded)

### Тэтгэврийн хуваарилалтын тогтолцоо

Тэтгэврийн хуваарилалтын тогтолцооны үед одоо ажиллаж буй ажил эрхлэгч нь шимтгэл төлөх бөгөөд энэ шимтгэлийг тэтгэвэр хэлбэрээр одоогийн тэтгэвэр авагчдад хуваарилдаг. Тиймээс ч тэтгэврийн хуримтлал үүсгэдэггүй.

**Зураг 1. Хуваарилалтын тогтолцооны тэтгэвэр олголт**




UIH.MN СУДАЛГААНЫ САН

Одоогийн ажил эрхлэгчид нь одоогийн тэтгэврийг санхүүжүүлдэг ба ирээдүйд тэтгэвэрт гарах үедээ ирээдүйн ажил эрхлэгчдийн санхүүжилтэд найдах хэрэгтэй болдог.

Хүн амын өсөлтөөр бий болсон илүү олон ажилчид, эдийн засгийн өсөлтөөр бий болсон илүү өндөр цалингаас шимтгэл төлөн тэтгэврийн хуваарилалтын тогтолцоог санхүүжүүлж байдаг нь энэ тогтолцооны эдийн засгийн үндэслэл болдог. Тиймээс тэтгэврийн хуваарилалтын тогтолцоо нь хүн ам зүй болон эдийн засгийн өсөлттэй шууд холбоотой.

[287] https://journals.openedition.org/estetica/5747#tocto1n2

Тэтгэврийн хуваарилалтын тогтолцооны үед тэтгэврийг дараах 2 аргаар тогтоодог.

- Тогтоосон хэмжээгээр тэтгэвэр тогтоох (Defined benefits буюу DB) – Тэтгэвэр нь цалин болон шимтгэл төлсөн хугацаанаас хамааран тогтоогддог.
- Нэрийн дансаар тогтоох (Notional Defined Contributions буюу NDC) – Төлсөн шимтгэл нь нэрийн дансанд хөтлөгдөх бөгөөд тухайн нэрийн дансанд хүүгийн бичилт хийнэ. Тэтгэвэрт гарах үед нь энэ дансанд хуримтлагдсан бичилтээс тэтгэвэр тооцогдоно. Өөрөөр хэлбэл, бодит хуримтлалгүй хуримтлалын тогтолцоотой ижил юм.

Тэтгэврийн хуваарилалтын тогтолцоо нь одоогийн шимтгэлээр одоогийн тэтгэврийг санхүүжүүлэх боломжтой учраас шууд нэвтрүүлэх боломжтой байдаг.

**Тэтгэврийн хуримтлалын тогтолцоо**

Тэтгэврийн хуримтлалын тогтолцоонд ажил эрхлэгч нь шимтгэл төлөх бөгөөд энэ шимтгэл нь тусгай санд хуримтлал болон хуримтлагдана. Энэ хуримтлалыг санхүүгийн зах зээлд байршуулах ба олсон ашгийн хэмжээгээр хуримтлал нь өсөж байдаг. Тэтгэвэрт гарах үед энэ хуримтлагдсан хөрөнгөөс тэтгэвэр авдаг.

**Зураг 2. Хуримтлалын тогтолцооны тэтгэвэр олголт**




Тэтгэвэр авагч нь ажиллах хугацаандаа төлсөн шимтгэл болон санхүүгийн зах зээлд байршуулснаас олсон ашгаар хуримтлуулсан мөнгөөр тэтгэврээ санхүүжүүлнэ. Тиймээс тухайн иргэний тэтгэвэр зөвхөн өөрөөс нь хамаарч байдаг. Тэтгэврийн хуримтлал нь тухайн тэтгэвэр авагчийн хөрөнгө учир, бүхэлд нь зарцуулах, барьцаалах, өвлүүлэх эрхтэй байдаг.

Тэтгэврийн хуримтлалын тогтолцооны санхүүжилт нь тэтгэврийн шимтгэл болон хуримтлагдсан хөрөнгийг санхүүгийн зах зээлд байршуулснаас олсон ашгаас бүрддэг. Тиймээс энэ тогтолцоо нь санхүүгийн зах зээлийн нөхцөл байдалтай шууд холбоотой.

Тэтгэврийн хуримтлалын тогтолцооны үед тэтгэврийг хуримтлалаас тогтоох (Defined Contributions буюу DC) аргачлалаар тогтооно. Өөрөөр хэлбэл, ажил эрхлэгч тэтгэвэрт гарах үед нийт хуримтлагдсан мөнгөнөөс хамааран авах тэтгэвэр тогтоогдоно.

Тэтгэврийн хуримтлалын тогтолцооны үед тодорхой хугацааны туршид хуримтлал бий болсны дараа тэтгэврийн хуваарилалт хийгддэг. Тиймээс хуваарилалтын тогтолцоог шууд нэвтрүүлэх боломжтой бол энэ тогтолцоог шууд нэвтрүүлэх боломжгүй байдаг.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**Хүснэгт 1.Тэтгэврийн хуваарилалтын болон хуримтлалын тогтолцооны сул ба давуу тал**

| | Давуу тал | Сул тал |
|---|---|---|
| **Хуваарилалтын тогтолцоо** | - Урьдчилан тогтоосон хэмжээгээр тэтгэвэр олгоно<br>- Санхүүгийн нөхцөлөөс хамааралгүй | - Хүн ам зүйн үзүүлэлтээс өндөр хамааралтай.<br>- Хүн амын насжилтаас хамаарч тэтгэвэр авагчид нэмэгдэх тусам төсвийн ачааллыг бууруулах үүднээс шимтгэл нэмэх болон тэтгэвэрт гаргах насыг өсгөх шаардлагатай болдог. |
| **Хуримтлалын тогтолцоо** | - Хүн ам зүйн үзүүлэлтээс хамааралгүй.<br>- Улсын төсөвт нөлөөлөхгүй.<br>- Эдийн засагт хуримтлал бий болдог.<br>- Хуримтлал нь хөрөнгө оруулалтын эх үүсвэр болж эдийн засагт эерэг нөлөө үзүүлдэг.<br>- Санхүүгийн хувьд тогтвортой байдаг. | -Хуримтлуулсан хөрөнгөөс шалтгаалан маш бага тэтгэвэр тогтоолгох.<br>- Санхүүгийн зах зээлээс олох ашгаас ихээхэн хамааралтай.<br>- Эдийн засгийн тэнцвэргүй байдал болон санхүүгийн зах зээлийн хөдөлгөөнд мэдрэмтгий |

Улс орнууд тэтгэврийн тогтолцоогоо бүрдүүлэхдээ тухайн улсын эдийн засаг, нийгэм, улс төрийн нөхцөл байдлыг анхааран үзэж ирээдүйгээ харсан тогтолцоог бүрдүүлэх нь чухал бөгөөд хуваарилалтын эсвэл, хуримтлалын тогтолцооны аль нэгийг нь сонгохдоо үр ашиг, эрсдэлийг сайтар тооцох шаардлагатай гэж үздэг.

Тэтгэврийн тогтолцоонд туйлын зөв тогтолцоо гэж байдаггүй. Аль ч тогтолцоо нь өөрийн сул ба давуу талтай. Тиймээс практикт хуваарилалтын болон хуримтлалын тогтолцоог хослуулан хэрэглэх нь элбэг байдаг. Тухайлбал, Герман, Франц, Итали, Америк нь анх зөвхөн хуримтлалын тогтолцоог нэвтрүүлсэн боловч Америк Их хямралын дараа, Герман, Франц, Итали Дэлхийн II дайны дараах гипер инфляцын үед хуваарилалтын тогтолцоог нэвтрүүлсэн байна.

Дэлхийн II дайны дараах эдийн засаг болон хүн амын өсөлтийн тааламжтай нөхцөлд Барууны олон улс хуваарилалтын тогтолцоог амжилттай нэвтрүүлж хэрэгжүүлснээр нийгэм-эдийн засагт их хэмжээний эерэг нөлөө үзүүлсэн. Гэвч хүн амын хөгшрөлт болон Санхүүгийн их хямралын дараах эдийн засгийн сул өсөлт нь хуримтлалын тогтолцоог хөгжүүлэх шаардлага бий болгож, улс орнууд тэтгэврийн тогтолцоондоо шинэчлэл хийх бодлого хэрэгжүүлэх болсон.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

## Хоёр. ТЭТГЭВРИЙН ХУРИМТЛАЛЫН ТОГТОЛЦООТОЙ ОРНУУДЫН ТУРШЛАГА

### 1. БҮГД НАЙРАМДАХ СИНГАПУР УЛС

#### 1.1 Тэтгэврийн тогтолцоо

Сингапур Улсын тэтгэврийн систем нь азийн хамгийн анхны тэтгэврийн системийн нэг бөгөөд азидаа хамгийн сайн тэтгэврийн систем гэж үнэлэгддэг. Дэлхийн хүн амын 63-аас дээш хувийг бүрдүүлдэг 37 орны тэтгэврийн тогтолцоог харьцуулан судалдаг Monash Centre for Financial Studies болон Global Consultant Mercer хамтран гаргасан Mercer Global Pension Index-т тус улсын тэтгэврийн тогтолцоо нь долоо удаа азийн хамгийн шилдэг тэтгэврийн тогтолцоогоор шалгарсан байна.

Сингапур Улсын үндэсний философи болон нийгмийн бодлого нь төрийн идэвхтэй дэмжлэгтэйгээр хувь хүн бие дааж өөрийн амьдралаа цогцлоох гэсэн байдаг. Тиймээс ч тэтгэврийн систем нь нийгмийн баялгийг дахин хуваарилах бус харин хувь хүмүүс өөрсдөө хуримтлал бий болгон тэтгэвэрт гарах үедээ тогтмол орлоготой байхад чиглэгдсэн байдаг.

Тэтгэврийн систем нь бүхэлдээ хуримтлалын тогтолцоотой. Тэтгэврийн системийн гол тулгуур нь Хуримтлалын төвлөрсөн сан (Central Provident Fund) байна. Үүнээс гадна зарим нийтийн албан хаагчдад зориулсан Төрийн тэтгэврийн хөтөлбөр (Government Pension Scheme), цэргийн албан хаагчдад зориулсан Ажилтан-Хуримтлал хөтөлбөр (Savings and Employees scheme) зэрэг хөтөлбөрүүдийг төрөөс хэрэгжүүлдэг.

Улсын тэтгэврийн хөтөлбөрөөс гадна Хуримтлалын төвлөрсөн сангаас санал болгодог Supplementary Retirement Scheme гэсэн сайн дурын хувийн тэтгэврийн даатгалын үйлчилгээ нь Сингапурын тэтгэврийн тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг болдог.

#### 1.2 Хуримтлалын төвлөрсөн сан (Central Provident Fund- CPF)[288]

Сингапурын Хуримтлалын төвлөрсөн сан (ХТС) 1955 онд байгуулсан бөгөөд ажил олгогч, ажилтан тус бүрээс цалингийн 5%-иар тооцон шимтгэл суутган авч ажилчдад тэтгэврийн хуримтлал үүсгэх боломжийг бүрдүүлсэн.

Нийгмийн хөгжил дэвшил, эдийн засгийн өсөлт, хүн амын амьжиргааны түвшин дээшлэхтэй холбогдон шинээр нийгмийн хэрэгцээ бий болж, энэхүү хэрэгцээг хангах үүднээс ХТС-ийн үйл ажиллагаа ч хувьсан өргөжих болсон.

1968 онд тэтгэврийн хуримтлалаараа ипотекийн зээлийн төлбөрөө төлөх боломжийг бүрдүүлж өгсөн.

1977 онд хуримтлалын дансыг “Энгийн” болон “Тусгай” данс гэж 2 хуваан, цалингийн 1%-ийн шимтгэлийг “Тусгай данс”-нд хуримтлуулах болсон. Ингэснээр хуримтлал эзэмшигч тусгай дансан дахь хуримтлалаараа хөрөнгө оруулалт хийн илүү их өгөөж олох боломж олгожээ.

1984 онд иргэдийн эрүүл мэндийн зардлыг төлөх үүднээс MediSave буюу эрүүл мэндийн данс нээж цалингийн 6%-ийг энэ дансанд хуримтлуулах болсон бол 1990 онд MediShield хөтөлбөрийг хэрэгжүүлсэн.

1986 онд Энгийн дансны хуримтлалаас тодорхой хэсгийг хөрөнгө оруулалт хийх CPFIS (CPF Investment Scheme) хөтөлбөрийг хэрэгжүүлсэн.

Эхэн үедээ хуримтлал эзэмшигч ХТС дахь хуримтлалаа бөөнд авах эрхтэй байсан. Гэтэл хүн амын нас уртсах тусам өндөр настнуудын тэтгэврийн хуримтлал хүрэхгүй байх асуудал тулгарсан. Тиймээс 1987 онд Minimum Sum Scheme буюу сар бүр тэтгэвэр авах хөтөлбөр бий

[288] https://www.enpf.kz/ru/pension-system/world/singapore.php
https://www.cpf.gov.sg/Members/AboutUs/about-us-info/cpf-overview

UIH.MN СУДАЛГААНЫ САН

болгосон. Анхандаа Minimum Sum Scheme хүрээнд 20 жилийн турш тэтгэвэр авдаг байсан бол одоо CPF LIFE хөтөлбөрийн хүрээнд насан туршдаа тэтгэвэр авах боломжтой болсон.

Иргэдээ хөгшрөх үед амьжиргаагаа хангах орлоготой байлгах үүднээс байгуулагдсан ХТС нь тэтгэврийн хуримтлалын сан төдийгүй тус улсын нийгмийн хамгааллын цогц систем болж чадсан.

Нийгмийн хамгааллын тогтолцоо болохын хувьд ХТС-гийн үндсэн зорилго нь Сингапур Улсын иргэдийг тэтгэврийн дараах баталгаат амьдралтай болгох явдал юм. Тэтгэврийн дараах баталгаат амьдрал нь дор дурдсан 3 хүчин зүйлсээс хамаарна.

- баталгаат тэтгэвэр;
- өөрийн гэсэн орон байртай байх;
- эрүүл мэндийн үйлчилгээг авах боломжтой байх.

ХТС нь үйл ажиллагаатайгаа уялдуулан 4 даатгалын санг удирддаг.

1. Орон сууцны даатгалын сан (Home Protection Fund)
2. MediShield даатгалын сан (MediShield Life Fund)
3. Насан туршийн орлого даатгалын сан (Lifelong Income Fund)
4. Халамжийн тэтгэмжийн сан (CareShield and ElderShield Insurance Fund)

*Өнөөдөр ХТС нь 4,1 сая иргэдийг хамруулсан, жилд 40.9 тэрбум сингапур долларын*[289] *хуримтлалын орлоготой, нийт 462.1 тэрбум сингапур долларын хөрөнгөтэй хуримтлалын сан болж өргөжжээ.*

***Хуримтлалын төвлөрсөн сангийн зорилго, үйл ажиллагаа***

ХТС-ийн үйл ажиллагаа нь Хуримтлалын төвлөрсөн сангийн тухай хуулиар зохицуулагддаг.

*Алсын хараа.* Сингапурын иргэдийг тэтгэврийн дараах баталгаат амьдралтай байх боломжийг хангах найдвартай, итгэл даах нийгмийн хамгааллын байгууллага болох.

*Зорилго.* Насан туршийн орлого, эрүүл мэндийн санхүүжилт, орон сууцны санхүүжилтээр хангах замаар Сингапурын иргэдийг тэтгэврийн дараах баталгаат амьдралтай болгоход оршино.

ХТС нь албан журмын хуримтлал бөгөөд гурван үндсэн зарчимтай байна.

- Хувь хүний хариуцлага — *Хөдөлмөр эрхэлж тэтгэврийн хуримтлалаа үүсгэ*
- Өмчлөх эрх — *Та хуримтлалаа өмчлөх эрхтэй.*
- Насан туршийн орлого — *Таныг насан туршийн орлоготой болгоно.*

ХТС-аас дараах хөтөлбөрүүдийг санал болгодог.

- Тэтгэврийн хуримтлал;
- Орон сууцтай болоход дэмжлэг үзүүлэх;
- Эрүүл мэндийн үйлчилгээг авах боломжоор хангах;
- Хуримтлалаараа хөрөнгө оруулалт хийх боломж;
- Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг тэтгэвэрт хамруулах;
- Боловсролын төлбөр төлөх;
- CPF Nomintaion буюу өвлүүлэх эрх;
- Dependants’ Protection Scheme буюу сайн дурын тэжээгчээ алдсны даатгал;
- Бусад

ХТС-гийн хуримтлалд Сингапур Улсын иргэн болон тус улсад байнга оршин суугч хамрагдана. Сангийн үндсэн үйл ажиллагаа нь тэтгэврийн хуримтлал бий болгоход чиглэдэг. Мөн түүнчлэн

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[289] 2021 оны 10-р сарын 4-ний өдрийн Монголбанкны ханшаар 1 сингапур доллар 2,098.34 төг байна.

эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах, орон байртай болох, гэр бүл хамгаалал болон хөрөнгөө өсгөх боломжоор хангахад чиглэгдэнэ.

Ажилтан болон ажил олгогч нь ХТС-д сар бүр хуримтлал хийнэ. ХТС-д төлсөн хуримтлалын шимтгэл **Энгийн данс** (Ordinary Account), **Тусгай данс** (Special Account), **Эрүүл мэндийн данс** (MediSave Account) гэсэн гурван дансанд хуваарилагдана. Мөн түүнчлэн 55 нас хүрсэн бол Тэтгэврийн данс автоматаар нээгдэх бөгөөд энэ нь өндөр насны тэтгэвэр олгоход зарцуулагдана.

**Хүснэгт 2. Хуримтлалын данс**

| Данс | Зориулалт |
|---|---|
| **Энгийн данс** | Орон сууц, даатгал, боловсрол, хөрөнгө оруулалт |
| **Тусгай данс** | Хөрөнгө оруулалт |
| **MediSave данс** | Эмчилгээний төлбөр болон зөвшөөрөгдсөн эрүүл мэндийн даатгал |
| **Тэтгэврийн данс** | Тэтгэвэр олгох |

**Зураг 3. Хуримтлалын дансанд шимтгэл төлөх**




***Хуримтлалын төвлөрсөн сангийн засаглал***

ХТС-г удирдах дээд байгууллага нь Удирдах зөвлөл байна. Удирдах зөвлөл дараах чиг үүргийг гүйцэтгэнэ.

- Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг хянах;
- Жилийн төсөв, санхүүгийн тайланг хянаж, батлах;
- Үйл ажиллагааны гүйцэтгэлийг хянах;
- Эрсдэлийн удирдлагыг сайжруулах, хянах;
- Үйл ажиллагааны талаар Гүйцэтгэх удирдлагад зөвлөх.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**Зураг 4. Хуримтлалын төвлөрсөн сангийн засаглал**




Удирдах зөвлөл нь дарга, дэд дарга, гүйцэтгэх захирал, Засгийн газар, ажилтан, ажил олгогчийг төлөөлж тус бүр 2 гишүүн, хараат бус 6 хүртэл гишүүд нийт 15 гишүүнтэй. Удирдах зөвлөлийн гишүүдийг Хөдөлмөрийн сайд Ерөнхийлөгчтэй зөвшилцөн 2 жилийн хугацаатай томилно.

Удирдах зөвлөл нь Аудитын хороо, Хөрөнгө оруулалтын хороо, Даатгалын хороо, Эрсдлийн удирдлагын хороо, Боловсон хүчний хороо гэсэн 5 хороотой.

*<u>Гүйцэтгэх удирдлага</u>*

ХТС-ийн өдөр тутмын үйл ажиллагааг Гүйцэтгэх захирал болон түүний удирдлага дор ажилладаг Гүйцэтгэх удирдлагууд хэрэгжүүлнэ. Сан 17 газар, нэгжтэй үйл ажиллагаагаа явуулж байна .

*<u>Сангийн хяналт</u>*

ХТС-ийн дотоод хяналтыг Удирдах зөвлөлийн Аудитын хороо хэрэгжүүлнэ. Дотоод аудитын газар нь Аудитын хороонд үйл ажиллагаагаа тайлагнана.

ХТС-д жилд дор хаяж нэг удаа аудитын хяналт шалгалт явуулна. Аудитын Хяналт шалгалтыг Ерөнхий Аудитор эсвэл, Ерөнхий аудитортой зөвшилцсөний үндсэн дээр Хөдөлмөрийн сайдын томилсон хараат бус аудитор хэрэгжүүлнэ.

Аудитор нь дараах чиглэлээр хяналт шалгалт хийнэ.

- Санхүүгийн тайланд үнэлэлт өгөх;
- Эрсдэлийн үнэлгээ хийх;
- Үйл ажиллагаанд гарсан материаллаг хохирол, дутагдлыг илрүүлэх

Аудиторын тайланг Удирдах зөвлөл, Аудитын хороонд хэлэлцэж Ерөнхий Аудиторын Газар хүргүүлнэ.

***Хуримтлалын төвлөрсөн сангийн орлого***

Сан нь дараах 3 төрлийн орлогоос бүрдэнэ.

1. Хуримтлалын шимтгэлийн орлого
2. Засгийн газрын тусгай үнэт цаасны хүүгийн орлого
3. Хөрөнгө оруулалтын орлого

UIH.MN СУДАЛГААНЫ САН

*<u>1. Хуримтлалын шимтгэл</u>.*

Сангийн гол эх үүсвэр нь тэтгэврийн шимтгэл байна. Дараах 2 төрлийн тэтгэврийн шимтгэлээр ХТС-гийн хуримтлалын эх үүсвэрийг бүрдүүлж байна.

- ажилтнаас төлөх хуримтлалын шимтгэл
- ажил олгогчоос төлөх хуримтлалын шимтгэл

Хуримтлалын шимтгэлийн хувь хэмжээг тухайн ажилтны наснаас хамаарч тогтооно. Шимтгэл нь Энгийн данс, Тусгай данс, MediSave дансанд хуваарилагдан орно.

**Хүснэгт 3. Хуримтлалын шимтгэлийн хувь хэмжээ, дансны хуваарилалт**

| Ажилтны нас | Хуримтлалын хувь хэмжээ | | | Дансны хуваарилалт | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Ажил олгогч | Ажилтан | Нийт | Энгийн | Тусгай | MediSave |
| **35-аас доош** | 17% | 20% | 37% | 23% | 6% | 8% |
| **35-45 нас** | 17% | 20% | 37% | 21% | 7% | 9% |
| **45-50 нас** | 17% | 20% | 37% | 19% | 8% | 10% |
| **50-55 нас** | 17% | 20% | 37% | 15% | 11.5% | 10.5% |
| **55-60 нас** | 13% | 13% | 26% | 12% | 3.5% | 10.5% |
| **60-65 нас** | 9% | 7.5% | 16.5% | 3.5% | 2.5% | 10.5% |
| **65-аас дээш** | 7.5% | 5% | 12.5% | 1% | 1% | 10.5% |

Хуримтлалын шимтгэл тооцох цалинг үндсэн цалин (Ordinary Wage) болон нэмэлт цалин, урамшуулал (Additional Wage) гэж ангилна.

**Шимтгэл тооцох цалингийн дээд хэмжээ**

| | |
|---|---|
| **Үндсэн цалин** | Сарын 6000 сингапур доллар |
| **Нэмэлт цалин, урамшуулал** | Жилийн 102000 сингапур доллар |

Хувиараа хөдөлмөр эрхлэгч ХТС-д хуримтлал хийж болох бөгөөд заавал төлөх **MediSave дансны** шимтгэл болон **сайн дурын хуримтлалын** шимтгэл гэсэн 2 хэлбэртэй.

MediSave дансанд хуримтлуулах шимтгэл нь цэвэр орлого болон наснаас хамаарч 4%-10.5% байна.

**Хүснэгт 4. MediSave дансны шимтгэл**

| Цэвэр орлого (синга.доллар) | Хувиараа хөдөлмөр эрхлэгчийн нас | | | |
|---|---|---|---|---|
| | 35-аас бага | 35-45 нас | 45-50 нас | 50-аас дээш |
| **6000-12000** | 4,0% | 4.5% | 5.0% | 5.25% |
| **12000-18000** | 4%-8% | 4.5%-9% | 5%-10% | 5.25%-10.5% |
| **18000 дээш** | 8% | 9% | 10% | 10.5% |

*2020 онд 251000 хувиараа хөдөлмөр эрхлэгчид 801.9 сая сингапур долларын хуримтлалын шимтгэл төлснөөс 627.8 сая сингапур долларын хуримтлалын шимтгэлийг MediSave дансанд хуримтлуулжээ. 2020 оны байдлаар Хуримтлалын төвлөрсөн сангийн хуримтлалын шимтгэлийн орлого 40.9 тэрбум сингапур доллар болсон байна.*

*<u>2. Засгийн газрын тусгай үнэт цаасны хүүгийн орлого</u>*

Сингапурын Засгийн газраас хуримтлалын дансанд бодогдох хүүгийн зардлыг нөхөх зорилгоор тусгай үнэт цаас гаргах бөгөөд ХТС-д хуримтлагдсан хуримтлалыг энэ үнэт цаасанд байршуулдаг. Засгийн газрын тусгай үнэт цаас нь хувьсах хүүтэй байх бөгөөд Энгийн, Тусгай, MediSave болон Тэтгэврийн дансанд бодогдох хүүтэй тэнцүү байна.

ХТС нь данс эзэмшигчдийн дансан дахь хуримтлалд хүү олгодог.

**Хүснэгт 5. Хуримтлалын дансны хүү**

| Данс | Дансанд бодох хүү | Баталгаат хүү (жилийн) |
|---|---|---|
| **Энгийн данс** | Банкуудын 3 сарын хүүгийн дундаж | 2.5% |
| **Тусгай данс** | 10 жилийн ЗГ-ын ҮЦ-ны хүүний 12 сарын дундаж + 1% | 4% |
| **MediSave данс** | 10 жилийн ЗГ-ын ҮЦ-ны хүүний 12 сарын дундаж + 1% | 4% |
| **Тэтгэврийн данс** | Хөрөнгө оруулалтын багцын дундаж өгөөж эсвэл,<br>10 жилийн ЗГ-ын ҮЦ-ны хүүний 12 сарын дундаж + 1% | 4% |

Энгийн, Тусгай, MediSave дансны хүүг улирал бүр, тэтгэврийн дансны хүүг жил бүр шинэчлэн тогтооно. Мөн түүнчлэн бага хуримтлалтай иргэдийг дэмжихийн тулд нэмэлт хүү бодож олгодог.

**Хүснэгт 6. Нэмэлт хүү**

| Нас | Нэмэлт хүү | Нөхцөл |
|---|---|---|
| **55 наснаас доош** | 1% | Эхний 60000 хуримтлалд |
| **55 наснаас дээш** | 2% | Эхний 30000 хүртэлх |
| | 1% | Дараагийн 30000 хуримтлалд |

Хуримтлалын дансанд нийтдээ дээд тал нь 6% хүртэл хүү бодогдоно.

2020 онд 2.5%, 3.5%, 4%, 5%, 6%-ийн хүүтэй Засгийн газрын тусгай үнэт цааснаас олсон хүүгийн орлого нь 16.8 тэрбум сингапур доллар болжээ.

*<u>3. Хөрөнгө оруулалтын орлого</u>*

ХТС-гийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг Удирдах зөвлөлийн Хөрөнгө оруулалтын хороо хариуцаж ажилладаг. Хөрөнгө оруулалтын хороо нь ХТС-гийн хөрөнгө оруулалтын бодлого болон хөрөнгө оруулалтын багцын хуваарилалтын стратегийг тодорхойлдог. Хөрөнгө оруулалтын хороо нь дор дурдсан чиглэлээр шийдвэр гаргах эрхтэй.

- Хөрөнгө оруулалтын удирдлагын стратеги
- Хөрөнгө оруулалтын бүтэц
- Хөрөнгө оруулалтын зөвлөхийг томилох
- Кастодиан банкийг сонгох
- Хөрөнгө оруулалтын менежментийн удирдлагыг сонгох
- Эрсдэлийн удирдлага
- Активын хуваарилалт болон үр дүнгийн тайлан

ХТС-гийн хөрөнгө оруулалт нь дам байдлаар хийгдэнэ. Өөрөөр хэлбэл, ХТС-ийн хөрөнгө нь бүрэн баталгаажсан Засгийн газрын тусгай бондод байрших бөгөөд цааш нь энэ хөрөнгийг Төрийн хөрөнгө оруулалтын корпорац удирдаж хөрөнгө оруулалт хийнэ.

**Зураг 5. Тэтгэврийн хуримтлалыг хөрөнгө оруулалтад оруулах**




Төрийн хөрөнгө оруулалтын корпорац хөрөнгө оруулалтаас олсон ашгаа Засгийн газрын бондоор дамжуулан ХТС-д шилжүүлнэ. Хэрэв хөрөнгө оруулалтын өгөөж нь ХТС-гийн дансанд олгох баталгаат хүүгийн хэмжээнээс бага бол Засгийн газраас баталгаат хүүтэй тэнцүү хэмжээгээр хүү олгоно.

***Хуримтлалын төвлөрсөн сангийн зарцуулалт***

Сангаас дараах зориулалтаар зарцуулалт хийж болно.

1. Өндөр насны тэтгэвэр;
2. Орон сууц худалдан авах;
3. Эрүүл мэндийн үйлчилгээний төлбөр;
4. Сургалтын зээл.

*1. Өндөр насны тэтгэвэр*

ХТС-д хуримтлалтай иргэн 55 нас хүрэх үед автоматаар Тэтгэврийн данс нээгдэж, Энгийн болон Тусгай дансны хуримтлал нь Тэтгэврийн дансанд шилжинэ. ХТС-д хуримтлалтай иргэн 65 нас хүрснээр Тэтгэврийн дансан дахь хуримтлалын хэмжээнээс хамаарч сар бүр тэтгэвэр авах эрхтэй болно.
55 настай иргэний Тэтгэврийн дансны хуримтлал 3 төрөлтэй.

- Суурь тэтгэврийн хуримтлал (Basic Retirement Sum)
- Бүрэн тэтгэврийн хуримтлал (Full Retirement Sum)
- Ахиу тэтгэврийн хуримтлал (Enhanced Retirement Sum)

**Хүснэгт 7. Тэтгэврийн дансанд шилжүүлэх хуримтлал**

| Тэтгэврийн хуримтлал | Тэтгэврийн дансан дахь хуримтлал (сингапур доллар) | Сарын тэтгэвэр (сингапур доллар) |
|---|---|---|
| **Суурь хуримтлал** | 93000 | 770 – 830 |
| **Бүрэн хуримтлал** | 186000 | 1430-1530 |
| **Ахиу хуримтлал** | 279000 | 2080- 2230 |

Тухайн иргэний Энгийн болон Тусгай дансны үлдэгдэл дээр дурдсан тэтгвэрийн хуримтлалын төрөлд хүрэхгүй бол Тэтгэврийн дансандаа нэмж мөнгө шилжүүлж болно.

Хэрэв 55 нас хүрсэн хуримтлал эзэмшигчийн Энгийн болон Тусгай дансны үлдэгдэл Бүрэн тэтгэврийн хуримтлалаас илүү гарвал 5000 сингапур долларыг хуримтлалаасаа авч болно. Харин 65 нас хүрсэн бол Тэтгэврийн дансныхаа хуримтлалын 20% хүртэлх мөнгөн дүнг авч болно.

Хэрэв 55 нас хүрсэн иргэн хувийн тэтгэврийн даатгалд хамрагдсан бөгөөд насан туршийн тэтгэвэр авах эрхтэй бол Тэтгэврийн дансанд хуримтлалаа байршуулахгүй байж болно.

CPF LIFE хөтөлбөр

Тэтгэвэр авагчдыг насан туршийн тэтгэврээр хангахын тулд ХТС-аас CPF LIFE хөтөлбөрийг хэрэгжүүлсэн.

Тэтгэврийн дансандаа 60000 сингапур долларын хуримтлал бүхий 65 нас хүрсэн иргэн CPF LIFE хөтөлбөрт автоматаар хамрагдаж насан туршийн тэтгэвэр авах боломжтой. Хэрэв 65 насандаа хамрагдаж чадаагүй бол 70 нас хүрэхэд Тэтгэврийн дансны хуримтлалын хэмжээнээс үл хамааран CPF LIFE хөтөлбөрт автоматаар хамруулна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**Хүснэгт 8. CPF LIFE хөтөлбөрт хамрагдах нөхцөл /Стандарт тэтгэвэр/**

| Сарын тэтгэврийн хэмжээ | CPF LIFE хөтөлбөрт хамрагдахын тулд Тэтгэврийн дансанд байх шаардлагатай хуримтлалын хэмжээ (сингапур доллар) | |
|---|---|---|
| | 65 нас | 55 нас |
| **$350 - $370** | $60,000 | $35,500 |
| **$540 - $570** | $97,300 | $60,000 |
| **$770 - $830** | $145,200 | $93,000 |
| **$960 - $1,030** | $184,400 | $120,000 |
| **$1,430 - $1,530** | $280,200 | $186,000 |
| **$1,520 - $1,640** | $300,600 | $200,000 |
| **$2,080 - $2,230** | $415,300 | $279,000 |

CPF LIFE хөтөлбөрт хамрагдсан иргэд Суурь тэтгэвэр, Стандарт тэтгэвэр, Өсөн нэмэгдэх тэтгэвэр гэсэн 3 төрлийн тэтгэврээс сонголт хийх боломжтой.

**Зураг 6. CPF LIFE хөтөлбөрөөс олгох тэтгэврийн төрөл**




*2020 оны байдлаар CPF LIFE хөтөлбөрт 178,000 иргэн хамрагдаж, 76,000 иргэн 2.6 тэрбум сингапур долларын тэтгэврийг сар бүр авч байна. 2020 онд 8.55 тэрбум сингапур долларыг тэтгэвэр олголт хэлбэрээр ХТС-аас зарцуулсан.*

*2. Орон сууц худалдан авах*

ХТС нь хуримтал бүхий иргэдэд орон сууц худалдан авахад дэмжлэг болох үүднээс Housing Scheme хөтөлбөрийн хүрээнд хуримтлалаа ашиглах боломж олгодог. Дараах 2 нөхцөлд орон сууц худалдан авахад хуримтлалаа ашиглаж болно.

- Төрийн орон сууцны хөтөлбөрийн байр (Housing and Development Board)
- Хувийн орон сууц худалдан авах эсвэл, барих

Орон сууц худалдан авахдаа зөвхөн Энгийн дансны хуримтлалыг ашиглаж болно. Энгийн данснаас зарцуулж болох хуримтлалын дүнг тодорхой аргачлалаар тооцоолж гаргана.

**Зураг 7. Энгийн дансны хуримтлалын зарцуулалт**




UIH.MN СУДАЛГААНЫ САН

*2020 оны байдлаар 17.3 тэрбум сингапур долларыг орон сууцны дэмжлэгт зарцуулсан бөгөөд үүнээс 741000 иргэний 10.5 тэрбум сингапур долларыг Төрийн орон сууцны санхүүжилтийн хөтөлбөрт, 231000 иргэний 6.8 тэрбум сингапур долларыг хувийн орон сууц худалдан авахад зарцуулжээ.*

Home Protection Scheme буюу Ипотекийн даатгал

Home Protection Scheme буюу Ипотекийн даатгал нь хуримтлал эзэмшигч нас барах эсвэл, хөдөлмөрийн чадвараа алдах үед Төрийн орон сууцны хөтөлбөрийн түрээсийг төлөх боломж олгодог ХТС-аас хэрэгжүүлж буй даатгалын хөтөлбөр юм. Хэрэв иргэн Төрийн орон сууцны хөтөлбөрт хамрагдаж сарын түрээсээ ХТС дахь хуримтлалын данснаасаа төлдөг бол Home Protection Scheme буюу Ипотекийн даатгалд заавал хамрагдах ёстой.

*2020 оны байдлаар нийт 580000 иргэний 95.2 тэрбум сингапур долларын орон сууцыг Home Protection Scheme буюу Ипотекийн даатгалд хамруулжээ.*

*<u>3. Эрүүл мэндийн үйлчилгээний төлбөр</u>*

MediSave хуримтлалын дансан дахь хуримтлалаа ашиглан тухайн данс эзэмшигч нь дараах 4 төрлийн зардлыг санхүүжүүлж болно.

- Эрүүл мэндийн зардал
- Эрүүл мэндийн даатгалын багц худалдан авах
- ElderShield хөтөлбөр буюу өндөр насны асрамжийн даатгал
- CareShield life хөтөлбөр буюу хөгжлийн бэрхшээлтэй иргэний халамжийн даатгал

Эрүүл мэндийн зардал

ХТС-гийн MediSave хуримтлалын дансан дахь хуримтлалаа тухайн данс эзэмшигч өөрийн болон гэр бүлийн гишүүд, асран хамгаалж буй хүний эрүүл мэндийн зардлыг төлөхөд ашиглана.

Эмчилгээ хийлгэж буй эмнэлэг нь B2 болон C түвшний олон нийтийн эмнэлгийн бүх зардлыг төлөх боломжтой. Харин бусад төрлийн эмнэлэгт эрүүл мэндийн үйлчилгээ авах бол зарим хэсгийг нь MediSave хуримтлалаас төлдөг.

Хэрэв MediSave хуримтлалын дансан дахь хуримтлал нь эрүүл мэндийн төлбөрийг төлөхөд хүрэлцэхгүй бол гэр бүлийн гишүүдийн MediSave хуримтлалын дансан дахь хуримтлалыг ашиглаж болно.

*2020 оны байдлаар ХТС-аас 1.01 тэрбум сингапур долларыг эрүүл мэндийн зардалд зарцуулсан байна.*

Эрүүл мэндийн даатгалын багц худалдан авах

Данс эзэмшигч нь Эрүүл мэндийн дансныхаа хуримтлалаар эрүүл мэндийн даатгалын багц худалдан авч болно. Сингапур Улсын иргэн 2 төрлийн Эрүүл мэндийн даатгалын багцад хамрагдах боломжтой.

- ХТС хариуцдаг MediShield Life эрүүл мэндийн даатгалын багц. MediShield Life B2 болон C түвшний олон нийтийн эмнэлэгт эрүүл мэндийн үйлчилгээ авахад хэрэглэгдэнэ. MediShield Life багцын даатгалын хураамжийг MediSave хуримтлалын данснаасаа төлж болно.
- Хэрэв A болон B1 түвшний олон нийтийн эмнэлэг болон бусад эмнэлэгт эрүүл мэндийн үйлчилгээ авахыг хүсвэл эрүүл мэндийн “Integrated Shield Plan”-ыг хувийн даатгалын компаниас худалдан авч болно. “Integrated Shield Plan” багцын даатгалын хураамжийг MediSave хуримтлалын данснаасаа зөвшөөрөгдсөн хэмжээгээр төлөх боломжтой. Илүү гарсан хэсгийг иргэн өөрөө төлнө.

UILMN СУДАЛГААНЫ САН

*2020 онд ХТС-аас 701000 хүсэлтийн Эрүүл мэндийн даатгалын багцын худалдан авахад 1.4 тэрбум сингапур долларыг зарцуулжээ. Мөн хувийн эрүүл мэндийн даатгалын багцанд 0.9 тэрбум сингапур доллар зарцуулжээ.*

ElderShield хөтөлбөр буюу өндөр насны асрамжийн даатгал

MediSave хуримтлалтай иргэд 40-65 нас хүртлээ ElderShield хөтөлбөрт автоматаар хамрагдана. ElderShield хөтөлбөр нь өндөр настан байнгын асрамжид байх тохиолдолд үүнтэй холбогдох зардлыг санхүүжүүлэх зорилготой. ElderShield даатгалд хамрагдсанаар өндөр настан 72 сар буюу 6 жилийн хугацаанд сарын 400 сингапур долларын тэтгэмж авна. ElderShield даатгалын хураамжийг MediSave данснаас төлнө.

CareShield life хөтөлбөр буюу хөгжлийн бэрхшээлтэй иргэний халамжийн даатгал

MediSave хуримтлалтай 30 нас хүрсэн иргэд CareShield life хөтөлбөрт автоматаар хамрагдана. CareShield life хөтөлбөр нь хөгжлийн бэрхшээлтэй болсон иргэдэд халамжийн тэтгэмж хэлбэрээр орлогын эх үүсвэр бий болгох зорилготой. CareShield life даатгал нь дараах боломжуудыг олгоно.

- Хөгжлийн бэрхшээлтэй бол насан туршийн тэтгэмж олгоно.
- Сар бүр 600 сингапур долларын тэтгэмж авах бөгөөд энэ нь ирээдүйд амьжиргааны түвшнээс хамааран нэмэгдэнэ.
- Хэрэв даатгалын шимтгэлээ төлөх боломжгүй болсон тохиолдолд Төрөөс шимтгэлийг хариуцдаг.
- Даатгалын шимтгэл нь MediSave данснаас төлөгдөнө.

*2020 оны байдлаар ХТС-аас CareShield life болон ElderShield даатгалын хураамжид 0.6 тэрбум сингапур долларыг зарцуулжээ.*

*3. Сургалтын зээл*

ХТС-д хуримтлалтай иргэн өөрийн, эхнэр/нөхрийн, үр хүүхдийнхээ сургалтын төлбөрт зориулж Энгийн дансан дахь хуримтлалаасаа зээл авах боломжтой. Зөвхөн зөвшөөрөгдсөн сургуулийн төлбөрийг төлөх бөгөөд сургуулиа төгссөнөөс 1 жилийн дараа Энгийн данснаас авсан зээлийн үндсэн төлбөр болон хүүг буцаан төлөх ёстой.

*2020 оны байдлаар ХТС-аас сургалтын зээлийн хэлбэрээр 56.6 сая сингапур долларын санхүүжилт гаргажээ.*

***Хуримтлалын төвлөрсөн сан дахь хуримтлалаараа хөрөнгө оруулалт хийх***

Хуримтлал эзэмшигчийг хуримтлалаа өсгөх боломжоор хангахын тулд ХТС-гаас тусгай хөтөлбөр санал болгодог.

ХТС дахь хуримтлалаар 2 төрлийн хөрөнгө оруулалт хийж болно.

1. CPF Investment Scheme (CPFIS) хөрөнгө оруулалтын хөтөлбөр
2. Special Discounted Shares (SDS) Scheme хөтөлбөр

1. CPF Investment Scheme (CPFIS) хөрөнгө оруулалтын хөтөлбөр

CPF Investment Scheme (CPFIS) хөрөнгө оруулалтын хөтөлбөр нь хуримтлал эзэмшигч Энгийн болон Тусгай дансны хуримтлалаа хөрөнгө оруулалт хийн тэтгэврийн хуримтлалаа нэмэгдүүлэх боломж олгох хөтөлбөр юм.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | CPFIS-т хамрагдах нөхцөл (сингапур доллар) | Хөрөнгө оруулалт хийх боломжтой дүн (сингапур доллар) |
|---|---|---|
| **Энгийн данс** | Хамгийн багадаа 20000 хуримтлалтай байх | 20000-оос давсан дүн |
| **Тусгай данс** | Хамгийн багадаа 40000 хуримтлалтай байх | Бүх дүн |

Энгийн дансны хуримтлалаасаа оруулах хөрөнгө оруулалтын 35% хүртэл хувьцаанд, 10% хүртэл алтанд хөрөнгө оруулж болно.

*2020 оны байдлаар 960,000 иргэн 17.0 тэрбум сингапур долларын хөрөнгө оруулалтын Энгийн дансны хуримтлалыг ашиглаж хийсэн. Мөн 283,000 иргэн 5.5 тэрбум сингапур долларын хөрөнгө оруулалтын Тусгай дансны хуримтлалыг ашиглаж хийсэн.*

<u>2. Special Discounted Shares (SDS) Scheme хөтөлбөр</u>

Special Discounted Shares (SDS) Scheme хөтөлбөр буюу хямдруулсан үнэ бүхий хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр нь Сингапурын иргэдийг хувьцаагаар дамжуулан баялаг эзэмших боломжоор хангах зорилго бүхий хөтөлбөр юм.

Одоогийн байдлаар ХТС-д хуримтлалын данстай иргэд төрийн өмчит нөлттэй хувьцаат компани болох SingTel харилцаа холбооны хувьцааг эзэмшиж байна.

***Өв залгамжлал***

ХТС-д данс эзэмшигч нь өөрийн хуримтлалыг өвлүүлж болно. Данс эзэмшигч нь өөрийн хуримтлалыг авах этгээдийг CPF Nomintaion үйлчилгээний хүрээнд өвлөгчөөр бүртгүүлнэ. Ингэснээр тухайн данс эзэмшигч нас барсан эсвэл, чадамжгүй болсон тохиолдолд тухайн бүртгүүлсэн өвлөгчид хуримтлалын эрх нь шууд шилжинэ.

**Хүснэгт 9. Өв залгамжлах эрх үүсэх нөхцөл**

| CPF Nomintaion өвлөх эрхтэй | CPF Nomintaion өвлөх эрхгүй |
|---|---|
| • **Энгийн, Тусгай, MediSave болон Тэтгэврийн дансан дахь хуримтлал**<br>• **CPF LIFE хөтөлбөрийн дансны хуримтлал**<br>• **Singtel (Сингапурын харилцаа холбооны компани) компанийн хямдруулсан хувьцаа** | • ХТС-ийн хуримтлалаар худалдан авсан үл хөдлөх хөрөнгө<br>• Dependants’ Protection Scheme хөтөлбөрийн хүрээнд олгодог тэжээгчээ алдсны даатгал<br>• CPF Investment Scheme хүрээнд хийсэн хөрөнгө оруулалт |

*2020 оны байдлаар хуримтлал эзэмшигч нас барсны улмаас 1.2 тэрбум сингапур долларыг ХТС-аас зарцуулжээ.*

***Төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг***

Тэтгэврийн хуримтлалын дансандаа хангалттай хэмжээний хуримтлал үүсгэж чадаагүй, эсвэл бага орлоготой иргэдэд Төрөөс дэмжлэг татаас олгодог.

ХТС-аас хэрэгжүүлдэг дараах хөтөлбөрт төрөөс татаас олгож байна.

1. Matched Retirement Savings Scheme буюу бага тэтгэврийн хуримтлалыг дэмжих
2. Silver Support Scheme буюу бага орлоготой иргэдийг дэмжих
3. Workfare Income Supplement Scheme буюу ажил эрхлэлтийг дэмжих
4. CareShield life буюу хөтөлбөр буюу хөгжлийн бэрхшээлтэй иргэний халамжийн даатгал

<u>1. Matched Retirement Savings Scheme буюу бага тэтгэврийн хуримтлалыг дэмжих</u>

Matched Retirement Savings Scheme хөтөлбөр нь Тэтгэврийн дансны хуримтлал Суурь тэтгэврийн хуримтлалыг (93000 сингапур доллар) хангаж чадахгүй байгаа иргэдэд зориулсан

UIH.MN СУДАЛГААНЫ САН

татаас юм. Дор дурдсан нөхцөлийг хангасан иргэд Matched Retirement Savings Scheme хөтөлбөрт хамрагдана.

- Сингапур Улсын иргэн байх;
- 55 – 70 настай байх;
- Тэтгэврийн дансны хуримтлал нь Сууръ тэтгэврийн хуримтлалаас бага буюу 93000 сингапур доллароос бага байх;
- Сарын орлого нь 4000 сингапур доллароос бага байх;
- Орон сууцны жилийн үнэ цэнэ нь 13000 сингапур доллароос хэтрэхгүй;
- 1-ээс илүү орон сууц, үл хөдлөх хөрөнгө эзэмшдэг байх.

Нөхцөл хангасан иргэдэд Сингапурын Засгийн газраас 5 жилийн хугацаанд жилийн 600 сингапур долларын хуримтлалыг Тэтгэврийн дансанд нь шилжүүлэх бөгөөд нийтдээ 3000 сингапур долларын санхүүгийн дэмжлэг үзүүлдэг.

2. Silver Support Scheme буюу бага орлоготой иргэдийг дэмжих

Ажиллах хугацаандаа бага орлоготой байснаас шалтгаалж Тэтгэврийн хуримтлалын дансандаа хангалттай хэмжээний хуримтлал үүсгэж чадаагүй иргэдэд энэ хөтөлбөр чиглэгддэг Дор дурдсан нөхцөлийг хангасан 65 нас хүрсэн Сингапур Улсын иргэн энэ хөтөлбөрт хамрагдана.

- Бага орлоготой буюу 55 нас хүртлээ ХТС-д хуримтлуулсан нийт хуримтлал нь 140000 сингапур доллароос бага байх. Хэрэв хувиараа хөдөлмөр эрхлэгч бол 45-55 насны хооронд олсон жилийн цэвэр орлого нь 27600 сингапур доллароос бага байх.
- Төрийн орон сууцны хөтөлбөрийн байранд амьдардаг бөгөөд байр нь 1-5 өрөөтэй байх.
- Нэг хүнд ногдох сарын өрхийн орлого нь 1800 сингапур доллароос хэтрэхгүй байх.

Нөхцөл хангасан өндөр настнууд улирал бүр дор дурдсан хэмжээгээр тэтгэмж авна.

**Хүснэгт 10. Silver Support Scheme хөтөлбөрт хамрагдах иргэнд олгох дэмжлэг**

| Төрийн орон сууцны хөтөлбөрийн байрны өрөө | Улиралын тэтгэмж (сингапур доллар) | |
|---|---|---|
| | Өрхийн орлого 1300 бага | Өрхийн орлого 1301 - 1800 |
| **1 болон 2 өрөөтэй** | 900 | 450 |
| **3 өрөөтэй** | 720 | 360 |
| **4 өрөөтэй** | 540 | 270 |
| **5 өрөөтэй** | 360 | 180 |

4. Workfare Income Supplement Scheme буюу ажил эрхлэлтийг дэмжих

Сингапур Улсын Засгийн газраас иргэдийг ажил эрхлэн орлого олж ХТС-д хуримтлал үүсгэхийг дэмжих үүднээс Workfare Income Supplement Scheme буюу ажил эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. Хөтөлбөрт ажил эрхэлж буй иргэд хамрагдах бөгөөд дор дурдсан нөхцөлийг хангасан байна.

**Хүснэгт 11. Workfare Income Supplement Scheme хөтөлбөрт хамрагдах, хамрагдахгүй нөхцөл**

| Хөтөлбөрт хамрагдах нөхцөл | Хөтөлбөрт хамрагдахгүй байх нөхцөл |
|---|---|
| • **Сингапур Улсын иргэн**<br>• **35 ба түүнээс дээш настай байх**<br>• **Сарын нийт цалингийн орлого нь 2300 сингапур доллароос бага байх** | • Орон сууцны жилийн үнэ цэнэ нь 13000 сингапур доллароос их байх<br>• Өөрөө эсвэл, эхнэр/нөхрийн хамт 2 ба түүнээс дээш орон сууц, үл хөдлөх хөрөнгө эзэмшдэг<br>• Эхнэр/нөхрийн өмнөх жилийн орлого 70000 сингапур доллароос их. |

Нөхцөл хангасан иргэн дор дурдсан хэмжээгээр жил бүр санхүүгийн дэмжлэг авна.

**Хүснэгт 12. Workfare Income Supplement Scheme хөтөлбөрт хамрагдсан иргэнд үзүүлэх санхүүгийн дэмжлэг**

| Нас | Жилийн тэтгэмжийн дээд хэмжээ |
|---|---|
| **35 - 44 нас** | 1,700 сингапур доллар |
| **45 - 54 нас** | 2,500 сингапур доллар |
| **55 – 59 нас** | 3,300 сингапур доллар |
| **60-аас дээш нас** | 4,000 сингапур доллар |

CareShield life буюу хөгжлийн бэрхшээлтэй иргэний халамжийн даатгал

Хэрэв иргэн CareShield life буюу хөгжлийн бэрхшээлтэй иргэний халамжийн даатгалын шимтгэлийг төлөх боломжгүй болсон тохиолдолд Засгийн газрын татаасаар халамжийн даатгалын шимтгэлийг нь төлдөг.

*2020 онд Засгийн газраас 57,6 сая сингапур долларын татаасыг халамжийн даатгалын шимтгэлийг төлөхөд зарцуулжээ.*

## 2. БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН УЛС[290]

### 2.1. Тэтгэврийн тогтолцоо

Казахстаны тэтгэврийн тогтолцоо улсын тэтгэвэр, хуримтлалын тэтгэвэр, сайн дурын тэтгэврээс бүрдэнэ. Улсын тэтгэврийг төсвөөс хуваарилалтын зарчмаар олгоно. Хуримтлалын тэтгэврийг Казахстан Улсын Тэтгэврийн хуримтлалын нэгдсэн санд шимтгэл төлж тэтгэврийн хуримтлалтай болсон иргэд авах эрхтэй (иргэд энэ 2 тэтгэвэрт заавал хамрагдана). Сайн дурын тэтгэвэрт иргэн бүр хамрагдаж болно. Иргэд Тэтгэврийн төрийн хуримтлалын нэгдсэн сангаас үзүүлдэг сайн дурын тэтгэвэрт хамрагдаж болохоос гадна энэ төрлийн үйлчилгээг санал болгодог хувийн байгууллагуудын сайн дурын тэтгэвэрт хамрагдах боломжтой.

Казахстан Улс 1998 он хүртэл социалист нийгмийн эв санааны зарчимд үндэслэсэн тэтгэврийн хуваарилалтын тогтолцоо хэрэглэж ирсэн бөгөөд 1998 оноос тэтгэврийн тогтолцоондоо шинэчлэл хийсэн байна. Тусгаар тогтнож, социалист нийгмээс зах зээлийн нийгэмд шилжсэнтэй холбогдон одоо тэтгэврийн шинэ, хуучин 2 системийг хослуулан хэрэглэж байна.

**1. Үндсэн тогтолцоо буюу 1998 оноос хойш ажил эрхэлж эхэлсэн иргэдэд зориулсан тэтгэврийн систем.**

Казахстан Улсын тэтгэврийн үндсэн тогтолцоог 1998 оноос нэвтрүүлсэн. Үндсэн тогтолцоо нь тэтгэврийн хуваарилалтын болон хуримтлалын тогтолцоог хослуулан хэрэглэдэг. Албан журмын болон сайн дурын гэсэн 2 хэлбэртэй.

Албан журмын тэтгэвэр нь төрийн тэтгэврийн тогтолцоо бөгөөд хуваарилалтын, хуримтлалын гэсэн 2 хэсэгтэй байна.

Сайн дурын тэтгэвэр нь хуримтлалын хэлбэртэй төрийн эсвэл хувийн байж болно.

*Тэтгэвэрт гарах нөхцөл.* Тэтгэвэрт гарах нас эрэгтэй 63 нас, эмэгтэй 60 байна. Насан туршийн хөгжлийн бэрхшээлийн I, II группад хамрагдсан иргэд тэтгэвэрт гарч болно.

*Тэтгэвэр тогтоох.* Тэтгэвэр 2 хэсгээс бүрдэнэ.

- Хуваарилалтын тогтолцоогоор олгох **суурь тэтгэвэр.** 2018 оны 7-р сарын 1 болон түүнээс хойш ажил эрхэлсэн иргэд хамрагдана. Тэтгэврийг ажилласан хугацаанаас хамаарч дараах

[290] https://www.enpf.kz/ru/

UIH.MN СУДАЛГААНЫ САН

аргачлалаар амьжиргааны доод түвшний орлогоос (2021 оны байдлаар 34302 тенге[291]) хувь тэнцүүлэн тооцно. Үүнд:

- 0-10 хүртэл ажилласан жилд амьжиргааны доод түвшний орлогын 54%-тай тэнцэх хэмжээгээр;
- 10-аас дээш ажилласан жил тутамд 2%-иар нэмэгдүүлэн тогтооно.

Суурь тэтгэврийн дээд хэмжээ нь (33 ба түүнээс дээш жил ажилласан тохиолдолд) амьжиргааны түвшний доод орлоготой тэнцүү буюу 2021 оны байдлаар 34302 тенге байна. Харин суурь тэтгэврийн доод хэмжээ нь 2021 оны байдлаар 18524 тенге байна. Суурь тэтгэвэр олголтыг төсвөөс санхүүжүүлнэ.

- Хуримтлалын тогтолцоогоор олгох **хуримтлалын тэтгэвэр** нь төрийн хуримтлалын сангаас эсвэл, хувийн тэтгэврийн сангаас олгох хуримтлалын тэтгэвэр байна. Тэтгэвэрт гарах хүртлээ хуримтлуулсан тэтгэврийн хуримтлалаас анниутетээр тооцож сар бүр олгоно.

**2. Нэмэлт тогтолцоо буюу 1998 оноос өмнө ажил эрхэлж эхэлсэн иргэдэд зориулсан тэтгэврийн систем.**

1998 оны 1-р сарын 1 хүртэл дор хаяж 6 сарын хугацаанд ажил эрхэлсэн иргэд хамрагдана.

*Тэтгэвэрт гарах нөхцөл.* Тэтгэвэрт гарах ажилласан хугацааны нөхцөл эрэгтэй 25 жил, эмэгтэй 20 жил байна.

*Тэтгэвэр тогтоох.* Тэтгэврийн хэмжээг 1995 оны 01-р сарын 01-нээс дурын дараалсан 3 жилийн сарын дундаж орлогын 60%-тай тэнцүүлэн тогтоох бөгөөд тэтгэврийн доод хэмжээнээс[292] багагүй байна. Тэтгэвэрт гарах нөхцөлийг бүрэн хангаагүй бол (ажилласан жил хүрээгүй бол) тэтгэврийн хэмжээг ажилласан жилтэй хувь тэнцүүлэн тогтооно.

Тэтгэвэр тогтоох орлогын дээд хэмжээ сарын тооцооллын индексийг [293] 46 дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй.[294]

2023 оны 1-р сараас эхэлж энэ системд хамрагдсан ажилтны ажил олгогчоос 5%-ийн шимтгэл авах төлөвлөгөөтэй байна.

Энэ тогтолцоонд тэтгэврийг төсвөөс санхүүжүүлдэг.

2038 он гэхэд энэ систем дуусаж тэтгэврийн Үндсэн тогтолцоондоо бүрэн шилжих төлөвлөгөөтэй байна.

### 2.2. Тэтгэврийн хуримтлалын тогтолцоо - Тэтгэврийн хуримтлалын нэгдсэн сан (ТХНС)[295]

Казахстан Улсын тэтгэврийн хуримтлалын тогтолцоо нь төрийн болон хувийн гэсэн 2 хэлбэртэй.

Төрийн тэтгэврийн хуримтлалын тогтолцоо буюу Казахстан Улсын “Тэтгэврийн хуримтлалын нэгдсэн сан” нь тус улсын тэтгэврийн хуримтлалын тогтолцоог үндсэндээ бүрдүүлдэг. 2013 оны 8-р сарын 22-нд хуучны Төрийн тэтгэврийн хуримтлалын нэгдсэн сангийн суурин дээр байгуулагдсан. Тус сан нь хувьцаат компани бөгөөд түүнийг үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч нь Казахстан Улсын Засгийн газар байна. Засгийн газрыг Сангийн яамны харьяа

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[291] Тенге – Казахстан Улсын мөнгөн тэмдэгт, 2021 оны 10-р сарын 4-ний өдрийн Монголбанкны ханшаар 1 тенге 6.69 төг байна.
[292] 2021 оны байдлаар 43272 тенгетэй тэнцүү байна.
[293] Казахстан Улсын хууль тогтоомжийн дагуу тэтгэвэр, тэтгэмж, төлбөр тооцоо, торгууль, татвар болон бусад төлбөрийг тооцоход ашигладаг тооцооны нэгж. 2021 оны байдлаар 2917 тенгетэй тэнцүү байна.
[294] 2021 оны байдлаар 134182 тенгетэй тэнцүү байна.
[295] https://www.enpf.kz/ru/about/summary/index.php

Төрийн өмч, хувьчлалын хороо төлөөлдөг. Харин сангийн хөрөнгийн удирдлагыг Казахстаны Үндэсний банк (Төв банк) хариуцан ажилладаг.

ТХНС нь 3 сангаас бүрдэнэ.

- Заавал төлөх тэтгэврийн хуримтлалын сан
- Заавал төлөх мэргэжлийн тэтгэврийн хуримтлалын сан
- Сайн дурын тэтгэврийн хуримтлалын сан

ТХНС нь нийтдээ 11,5 сая нэрийн данстай бөгөөд үүнээс Заавал төлөх тэтгэврийн хуримтлалын сан 10981,0 мянган данс, Сайн дурын тэтгэврийн хуримтлалын сан нь 57,6 мянган данс, Заавал төлөх мэргэжлийн тэтгэврийн хуримтлалын сан нь 528,3 мянган данс байна.

*2020 оны эцсээр ТХНС-д 15,2 их наяд гаруй тенге хуримтлагдсан бөгөөд Заавал төлөх тэтгэврийн хуримтлалын санд 12,8 их наяд тенге, Сайн дурын тэтгэврийн хуримтлалын санд 2,2 их наяд тенге, Заавал төлөх мэргэжлийн тэтгэврийн хуримтлалын сан нь 0,3 их наяд тенге хуримтлагдсан байна.*

***Төрийн тэтгэврийн хуримтлалын тогтолцооны бүтэц***

Төрийн тэтгэврийн хуримтлалын тогтолцоонд Үндэсний сангийн зөвлөл, Засгийн газар, Үндэсний Банк, Тэтгэврийн Хуримтлалын Нэгдсэн Сан, Хөрөнгө оруулалтын менежменийн байгууллага, Санхүүгийн зах зээлийн зохицуулах агентлаг зэрэг нь өөрийн чиг үүргийн хүрээнд оролцдог.

**Зураг 8. Төрийн тэтгэврийн хуримтлалын тогтолцооны бүтэц**




<u>*Үндэсний сангийн зөвлөл.*</u> Казахстан Улсын бүх үндэсний сангуудын дээд удирдлагыг энэхүү зөвлөл хэрэгжүүлдэг. Энэ нь ТХНС-д мөн адил хамааралтай. Зөвлөл дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

- Казахстан Улсын Ерөнхийлөгч – Зөвлөлийн тэргүүн;
- Ерөнхий сайд;
- Парламентын дээд, доод танхимын тэргүүнүүд;
- Казахстан Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга;
- Үндэсний банкны дарга;
- Аудитын хорооны дарга;
- Сангийн сайд;
- Үндэсний эдийн засгийн сайд зэрэг болно.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Зөвлөлийн чиг үүрэг:

- ТХНС-ийн хөрөнгийн үр ашигтай удирдлагыг бий болгох талаар бодлого боловсруулах;
- ТХНС болон сангийн байршуулсан хөрөнгө оруулалтад хяналт тавьж, үнэлэлт өгөх;
- ТХНС-ийн үйл ажиллагааны жилийн тайланд үнэлгээ өгөх.

*Казахстан Улсын Засгийн газар*. ТХНС-ийн үйл ажиллагаа, хийж буй хөрөнгө оруулалтыг хянаж үнэлгээ өгнө. Сангийн хөрөнгийг хөрөнгө оруулалт хэлбэрээр байршуулж болох санхүүгийн хэрэгслүүдийн жагсаалтыг тогтооно.

*Казахстаны Үндэсний Банк (Төв банк).* ТХНС-тай холбоотой хөрөнгө оруулалтын менежент болон төлбөр тооцооны банкны үйл ажиллагааг хэрэгжүүлдэг.

Үндэсний Банк дараах чиг үүрэгтэй байна.

- ТХНС-ийн тэтгэврийн хөрөнгийн удирдлага, хяналтыг хэрэгжүүлэх;
- Хөрөнгө оруулалтын декларац батлах;
- Хөрөнгө оруулалтын стратеги боловсруулах;
- Хөрөнгө оруулалт хийх тухай шийдвэр гаргах;
- Кастодиан банкны үүрэг гүйцэтгэх.

*Тэтгэврийн Хуримтлалын Нэгдсэн Сан (ТХНС)*. Сан шимтгэл төлөгчийн хөрөнгийг төвлөрүүлэх, хөрөнгө оруулалтын менежментийн байгууллагаар дамжуулан хөрөнгө оруулалт хийх боломж олгох, тэтгэвэр олголтыг зохион байгуулах зэрэг үйл ажиллагааг явуулна.

ТХНС-ийн чиг үүрэг:

- Хөрөнгө оруулалтын менежментийн байгууллагатай (ХОМБ) үйл ажиллагааны гэрээ байгуулж ажиллах;
- Шимтгэл төлөгчийн хуримтлалыг ХОМБ-д шилжүүлэхтэй холбогдох хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх, архивлах;
- ХОМБ-д тэтгэврийн хуримтлалаа шилжүүлэх тухай шимтгэл төлөгчийн хүсэлтийг хүлээн авснаас хойш хуанлийн 30 хоногт багтаан Үндэсний банканд мэдээллэх.

*Хөрөнгө оруулалтын менежменийн байгууллага (ХОМБ)*. ХОМБ нь тэтгэврийн шимтгэл төлөгчийн хүсэлтээр тэтгэврийн хуримтлалын хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэн шимтгэл төлөгчийн хөрөнгийг арвижуулах зорилготой бөгөөд дараах чиг үүргийг гүйцэтгэдэг.

- Хөрөнгө оруулалтын декларацыг боловсруулж батлах;
- Тэтгэврийн хуримтлалын хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийх талаар шийдвэр гаргах;
- Хөрөнгө оруулалтын өгөөжийн доод хэмжээг хангаж ажиллах баталгаа гаргах;
- Шимтгэл төлөгчийн хүсэлтээр түүний тэтгэврийн хуримтлалыг жилд нэг удаа өөр ХОМБ-д шилжүүлэх;
- Хэрэв шимтгэл төлөгч хүсэлт гаргавал ХОМБ-ын удирдлагад 2-оос доошгүй жил байсан тэтгэврийн хуримтлалыг Үндэсний банканд буцаан шилжүүлэх;
- ХОМБ шимтгэл төлөгчийн тэтгэврийн хуримтлалыг тэтгэврийн насанд хүрэхээс 10 хоногийн өмнө Үндэсний банканд шилжүүлэх;
- ХОМБ-ын үйл ажиллагааг зохицуулах дээд байгууллагын шаардлагыг хангаж ажиллах.

*Санхүүгийн зах зээлийн зохицуулах агентлаг.* Агентлаг нь ХОМБ-ын үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын багцад хяналт тавьж ажиллах бөгөөд дараах чиг үүрэгтэй байна.

- ХОМБ-д тавигдах шаардлагуудыг боловсруулж батлах;
- Тэтгэврийн хуримтлалыг хөрөнгө оруулалт хэлбэрээр байршуулж болох санхүүгийн хэрэгслүүдийн жагсаалтыг гаргах;
- Тэтгэврийн хуримтлалын хөрөнгийг удирдах эрх бүхий ХОМБ-уудын бүртгэл, мэдээллийг цахим хуудсандаа байршуулах.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

***Тэтгэврийн хуримтлалын нэгдсэн сангийн (ТХНС) зорилго, үйл ажиллагаа.***

Сангийн зорилго нь тэтгэврийн үйлчилгээний чанарыг дээшлүүлж тэтгэврийн шимтгэл төлөгчдөд тэтгэврийн хуримтлал үүсгэх зуршлыг бий болгох, тэтгэврийн хуримтлалаа төлөвлөх, бүртгэл хөтлөхөд зохион байгуулалтын дэмжлэг туслалцаа үзүүлэхэд оршино.

ТХНС нь дараах стратеги зорилго, зорилтуудыг дэвшүүлсэн байна.[296]

1. Шилдэг туршлага стандартад нийцсэн чанартай үйлчилгээ үзүүлэх
   - Тэтгэврийн үйлчилгээний тэгш хүртээмжийг хангах;
   - Тэтгэврийн үйлчилгээний тогтоогдсон стандартыг дагаж мөрдөх;
   - Удирдлагын тогтолцооны стандартад нийцүүлж, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын нэгдсэн системийг улам хөгжүүлэн сайжруулж Сангийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах.
2. Тэтгэврийн хуримтлал бий болгож, тэтгэвэр төлөвлөх соёлыг нэвтрүүлэх, хөгжүүлэх
   - Тэтгэврийн талаарх иргэдийн санхүүгийн болон хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх;
   - ТХНС-д эерэг дүр төрхийг бий болгох замаар иргэдийн хуримтлалын тэтгэврийн тогтолцоонд итгэх итгэлийг бэхжүүлэх;
   - Тэтгэврийн хуримтлалын төлөвлөлт хийх соёлыг төлөвшүүлэх;
   - Сайн дурын тэтгэврийн хуримтлалыг хөгжүүлэх.
3. Тэтгэврийн хуримтлалын тогтолцооны хөгжилтэй холбогдох Казахстан Улсын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх
   - ТХНС-ийн тэтгэвэр олголтийн үзүүлэлт, механизмыг сайжруулах;
   - Ажил олгогчийн заавал төлөх шимтгэлээр санхүүжих нөхцөлт хуримтлалыг нэвтрүүлэх;
   - “ЭЗХАХБ-ын (OECD) гишүүн орнуудын ажилчдын тэтгэврийн тухай хэлэлцээр”-ийн хүрээнд ТХНС нь эрх бүхий байгууллага болохын хувьд үйл ажиллагааг явуулах зэрэг болно.

ТХНС-аас дор дурдсан үйлчилгээг иргэдэд үзүүлдэг.

1. Тэтгэврийн гэрээ байгуулан хуримтлалын тэтгэврийн данс нээх. Дараах шимтгэлүүдийг төвлөрүүлэн хуримтлал үүсгэнэ. Үүнд:
   - Заавал төлөх тэтгэврийн шимтгэл;
   - Заавал төлөх мэргэжлийн тэтгэврийн шимтгэл;
   - сайн дурын тэтгэврийн шимтгэл орно.

2. Тэтгэврийн хуримтлалаас зарцуулалт хийх үйл ажиллагааг зохион байгуулах. Дараах хүчин зүйлсийг харгалзан үзнэ.
   - Тэтгэвэр олголтын хуваарь;
   - сайн дурын хуримтлалын данстай эсэх;
   - Казахстан Улсаас өөр газар байнгын оршин суухаар явсан эсэх;
   - тэтгэвэр авагч нас барсан эсэх (оршуулга, өв залгамжлал);
   - орон байрны нөхцөл сайжруулах болон (эсвэл) эмчилгээний төлбөрт ашиглах хүсэлт гаргасан эсэх зэрэг болно.

3. Тэтгэврийн аннуитетийн гэрээний дагуу тэтгэврийн хуримтлалыг ТХНС-аас даатгалын байгууллагад шилжүүлэх.
4. Шимтгэл төлөгчийг түүний хувийн тэтгэврийн хуримтлалын дансны тухай мэдээллээр хангах.
5. Тэтгэврийн хуримтлалын данс эзэмшигчийн бүртгэл, мэдээллийг өөрчлөх.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[296]Корпоративная стратегия развития акционерного общества «Единый накопительный пенсионный фонд» на 2017-2021 годы, https://www.enpf.kz/upload/medialibrary/0d1/0d139b3753dd328c2325d6aaf21c2285.pdf

6. Тэтгэврийн хуримтлалын тогтолцооны үйл ажиллагаа болон тэтгэврийн хөрөнгийн хөрөнгө оруулалтын менежментийн асуудлаар үнэгүй зөвлөгөө өгөх.
7. Шимтгэл төлөгчийн сонголтын дагуу тэтгэврийн хөрөнгийг хөрөнгө оруулалтын менежментийн байгууллагад (ХОМБ) шилжүүлэх.

***Тэтгэврийн хуримтлалын нэгдсэн сангийн засаглал***

ТХНС-ийн үйл ажиллагаа тэгш байдал, ил тод байх, үйл ажиллагаагаа тайлагнадаг байх, мэргэжлийн байх, хариуцлагатай байх, ур чадвартай байх зарчмуудад суурилна. Түүнчлэн хөрөнгө оруулагч, шимтгэл төлөгч болон олон нийтийн эрх ашгийг дээдэлнэ. Сан хувьцаат нийгэмлэгийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд цорын ганц хувьцаа эзэмшигч нь Засгийн газар байна (Сангийн яамны харьяа Төрийн өмч, хувьчлалын хороо төлөөлдөг).

**Зураг 9.ТХНС-ийн засаглал**




ТХНС-ийн үйл ажиллагааг Гүйцэтгэх удирдлага хэрэгжүүлэх бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавьж ажиллана. Сангийн дэргэд олон нийтийн хяналт тавьж, сангийн үйл ажиллагаанд зөвлөх үүрэгтэй Олон нийтийн зөвлөл ажиллана.

<u>Төлөөлөн удирдах зөвлөл</u>
Энэ нь 6 гишүүнтэй бөгөөд дараах чиг үүргийг гүйцэтгэнэ.

- Хувь нийлүүлэгч болон шимтгэл төлөгчдийн эрх ашгийг хангах;
- Сангийн үйл ажиллагааний хэм хэмжээг тогтоох;
- Сангийн үйл ажиллагаанд хяналт тавих;
- Сангийн үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх.

Төлөөлөн удирдах зөвлөл нь 3 хороотой.

- Стратеги төлөвлөлтийн хороо;
- Аудитын хороо;
- Боловсон хүчин, нийгмийн асуудал, шагнал урамшууллын хороо.

<u>Олон нийтийн зөвлөл</u>
ТХНС-д зөвлөх үүрэгтэй бөгөөд тэтгэврийн тогтолцооны бүх оролцогчдыг хамарсан бие даасан бүтэц юм. Нийт 15 гишүүнтэй ба дор дурдсан нийгмийн төлөөллүүдийг оролцуулдаг.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

- Бие даасан хараат бус экспертүүд (7 гишүүн);
- Олон нийтийн байгууллагын төлөөлөл (1 гишүүн);
- Хэвлэл, мэдээллийн төлөөлөл (3 гишүүн);
- Шимтгэл төлөгчдийн төлөөлөл (1 гишүүн).

Олон нийтийн зөвлөл нь дараах үндсэн чиг үүрэгтэй.

- ТХНС-ийн үйл ажиллагааны талаарх нийгэм, олон нийтийн үзэл санааг илэрхийлэх;
- ТХНС-ийн үйл ажиллагаанд тулгарч буй асуудлыг илрүүлж, шийдвэрлүүлэх замаар ТХНС-д итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх;
- ТХНС-ийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, ТХНС-д тавих олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх.

<u>Гүйцэтгэх удирдлага</u>

ТХНС-ийн өдөр тутмын үйл ажилллагааг Гүйцэтгэх захирлаар удирдуулсан Гүйцэтгэх удирдлага гүйцэтгэнэ. Захирлуудын зөвлөл нь 6 гишүүнтэй.

ТХНС нь нийтдээ 17 газар хэлтэс, 18 салбар нэгжтэй үйл ажиллагаа явуулж байна.

<u>Сангийн хяналт</u>

Сангийн дотоод хяналтыг Төлөөлөн удирдах зөвлөл, Аудитын хороо, Дотоод аудитын газар хэрэгжүүлнэ.

Санд жилд дор хаяж нэг удаа аудитын хяналт шалгалт явуулна. Аудитыг бие даасан хараат бус аудитор гүйцэтгэдэг. Аудитор нь дараах чиглэлээр хяналт шалгалт хийнэ.

- Санхүүгийн тайланд үнэлэлт өгөх;
- Эрсдэлийн үнэлгээ хийх;
- Үйл ажиллагаанд гарсан материаллаг хохирол, дутагдлыг илрүүлэх.

***Тэтгэврийн хуримтлалын нэгдсэн сангийн орлого***

Сангийн орлого нь 2 эх үүсвэрээс бүрдэнэ.

1. Тэтгэврийн шимтгэл
2. Хүү, хөрөнгө оруулалтын орлого

*<u>1. Тэтгэврийн шимтгэл.</u>* Сангийн гол эх үүсвэр нь тэтгэврийн шимтгэл байна. Дараах 3 төрлийн тэтгэврийн шимтгэлээр ТХНС-ийн хуримтлалын эх үүсвэрийг бүрдүүлнэ.

- Заавал төлөх тэтгэврийн шимтгэл – 10%
  Үүнийг ажилтан төлөх бөгөөд ажилтны сарын цалингийн орлогоос тооцно. (шимтгэл тооцох цалингийн хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг [297] 50 дахин нэмэгдүүлснээс ихгүй байхаар тогтоосон)
- Заавал төлөх мэргэжлийн тэтгэврийн шимтгэл – 5%
  Үүнийг ажил олгогч төлөх бөгөөд ажилтны сарын орлогоос тооцно.
- Сайн дурын тэтгэврийн шимтгэл – хувь хүн олсон орлогоосоо өөрөө төлнө, эсвэл шимтгэл төлөгчийн нэрийн өмнөөс бусад хувь хүн болон хуулийн этгээд төлж болно.

Хуримтлалын тэтгэврийн хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор 2019 оноос хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг (өөрийгөө ажлаар хангагч) ТХНС-ийн албан журмын хуримтлалд хамруулах болсон. Үүнд:

- Тогтмол үйл ажиллагаа явуулдаг хувиараа бизнес эрхлэгч
  Энэ төрлийн хувиараа бизнес эрхлэгчдээс сар бүр нэгдсэн байдлаар нэг л төрлийн татвар хураамж авах бөгөөд үүнийг “**нэгдсэн төлбөр**” гэж нэрлэдэг. Нэгдсэн төлбөрийн 30%-ийг ТХНС-д тухайн хувиараа бизнес эрхлэгчийн дансанд хуримтлуулна. (Нэгдсэн төлбөрийн 10%-ХХОАТатвар, 20%-Нийгмийн даатгалын шимтгэлд, 40%-Эрүүл мэндийн даатгалд хуваарилагдана.)

[297] 2021 оны байдлаар 42500 тенгетэй тэнцүү байна.

- Тогтмол бус үйл ажиллагаа явуулдаг хувиараа бизнес эрхлэгч
  Энэ төрлийн хувиараа бизнес эрхлэгчдийн гэрээт хөдөлмөрийн хөлсний 10%-иар шимтгэл тооцож ТХНС-д шилжүүлэх бөгөөд тухайн хувиараа бизнес эрхлэгчийн дансанд хуримтлагдана. Тухайн гэрээг байгуулж, хөдөлмөрийн хөлс олгож буй байгууллага шимтгэлийг суутган тооцож ТХНС-д шилжүүлнэ. Хэрэв тухайн этгээд нь суутган тооцох эрхгүй бол шимтгэл төлөгч өөрөө хуримтлалын шимтгэлээ төлнө.

Хувиараа бизнес эрхлэгчээс сард төлөх нэгдсэн төлбөрийн нийт дүн улсын болон бүсийн хэмжээний хотууд, нийслэлд сарын тооцооллын индекстэй[298], бусад хэсэгт сарын тооцооллын индексийн хагастай тэнцүү байна.

*2020 оны байдлаар ТХНС-ын шимтгэлийн орлого нь 1,1 их наяд тенге болсон байна.*

*2. Хүү, хөрөнгө оруулалтын орлого.* ТХНС-ийн орлогын 2 дахь хэсэг хүү, хөрөнгө оруулалтын орлого байдаг. Энэ нь 2 хэсгээс бүрдэнэ.

- Хүүгийн орлого – Тухайн шимтгэл төлөгчийн ХОМБ-ын удирдлагад шилжүүлээгүй (хөрөнгө оруулалтад оруулахаар) тэтгэврийн хөрөнгийн үлдэгдэлд инфляцаас хамааруулан хүү тооцож олгоно.
- Хөрөнгө оруулалтын орлого – Казахстаны Үндэсний Банк хөрөнгө оруулалтын удирдлагыг хэрэгжүүлэх замаар Тэтгэврийн хуримтлалын сангийн хөрөнгийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулж, олсон орлогоор Тэтгэврийн хуримтлалын сангийн хөрөнгийг өсгөдөг. Хөрөнгө оруулалт хийх боломжтой зөвшөөрөгдсөн санхүүгийн хэрэгслийн жагсаалтыг Казахстаны Үндэсний Банк тогтооно.
  2021 оноос эхлэн ТХНС-д тэтгэврийн хуримтлалтай иргэд өөрийн хуримтлалыг ХОМБ-аар дамжуулан санхүүгийн хэрэгслүүдэд хөрөнгө оруулах эрхтэй болсноор хөрөнгө оруулалтын орлогын 2 дахь эх үүсвэр бий болсон байна.

*ТХНС-ын хөрөнгө оруулалтын орлого нь 2020 онд 1,22 их наяд тенге буюу 9.5%-ийн өгөөжтэй байна. Харин 2013 оны 9 сараас 2021 оны 1 сар хүртэл хуримтлагдсан нийт хөрөнгө оруулалтын орлого нь 5,0 их наяд тенге болсон байна.*

***Тэтгэврийн хуримтлалын нэгдсэн сангийн зарцуулалт***

ТХНС-аас дараах тохиолдолд зарцуулалт хийнэ.

1. Өндөр насны тэтгэвэр;
2. Зорилтот хэрэгцээнд ашиглах;
3. Амь даатгалын компанид шилжүүлэх.

*1. Өндөр насны тэтгэвэр*

Дор дурдсан нөхцөлийг хангасан шимтгэл төлөгч тэтгэвэр авах хүсэлт гаргаж болно.

**Хүснэгт 13. Тэтгэвэр авах нөхцөл, хэлбэр, хэмжээ**

| | **Заавал хамрагдах тэтгэвэр** | **Сайн дурын тэтгэвэр** |
|---|---|---|
| **Тэтгэвэр авах нөхцөл** | • эрэгтэй 63 нас, эмэгтэй 60 нас (2021 оны байдлаар)<br>• Насан туршийн хөгжлийн бэрхшээлийн I , II группт хамрагдсан иргэд | • 50 нас хүрсэн байх;<br>• Насан туршийн хөгжлийн бэрхшээлийн I, II группт хамрагдсан иргэд;<br>• ТХНС-д 5-аас доошгүй жил хуримтлуулсан сайн дурын тэтгэврийн шимтгэлийн дүн болон хөрөнгө оруулалтын орлоготой байх. |
| **Тэтгэвэр авах хэлбэр** | **Нэг удаа бөөнд нь авах:**<br>тэтгэврийн хуримтлалын дүн хөдөлмөрийн | • Нэг удаа бөөнд нь авах<br>• Сар бүр авах |

[298] 2021 оны байдлаар 2917 тенгетэй тэнцүү байна.

| | | |
|---|---|---|
| | хөлсний доод хэмжээг 12 дахин нэмэгдүүлснээс бага тохиолдолд.<br>**Сар бүр авах**:<br>тэтгэврийн хуримтлалын дүн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12 дахин нэмэгдүүлснээс их тохиолдолд. | • Жилд 1 удаа авах |
| **Тэтгэврийн хэмжээ** | Тэтгэвэрт гарсан эхний жил нийт хуримтлалын 6,5%-иар тооцсон дүнг 12-т хуваах сар бүр авах тэтгэврийг гаргана. Эхний жилээс хойших жилд өмнөх жилийн тэтгэврийн хэмжээг 5%-иар нэмэгдүүлэн сар бүр авах тэтгэврийг тогтооно.<br>Тэтгэврийн доод хэмжээ нь амьжиргааны доод түвшний орлогын 70%-аас багагүй байна. | Гэрээнд заасны дагуу |

*ТХНС-аас 2020 онд тэтгэвэр хэлбэрээр 193,4 тэрбум тенге зарлагадсан байна.*

*Зорилтот хэрэгцээнд ашиглах.*

ТХНС-ийн заавал хамрагдах тэтгэврийн хуримтлалын данстай шимтгэл төлөгч хүсэлт гаргасан тохиолдолд дараах зорилгоор тэтгэврийн хуримтлалын данснаас зарцуулалт хийх боломжтой.

- орон сууцны нөхцөлөө сайжруулах зорилгоор;
- зөвшөөрөгдсөн эрүүл мэндийн зардлаа төлөх;
- шимтгэл төлөгч нас барсан тохиолдолд өв залгамжлагчид олгох нэг удаагийн төлбөр;
- гадаад улсад байнга оршин суухаар явах болсон нөхцөл зэрэг орно.

Зорилтот хэрэгцээнд ашиглах зорилгоор тэтгэврийн хуримтлалын данснаасаа зарцуулалт хийхдээ дор дурдсан нөхцөл хангасан байна.

- дансны хуримтлалын хэмжээ нь зөвшөөрөгдөх түвшинд хүрсэн байх;
- орлуулалтын коэфциентээр тооцсон тэтгэврийн хэмжээ нь сарын дундаж орлогын 40%-иас багагүй байх. Энэ тохиолдолд зарцуулалтын хэмжээ нь нийт хуримтлалын 50%-иас хэтрэхгүй байх;
- Даатгалын компанитай байгуулсан гэрээгээр тэтгэврийн аннуитет авах эрхтэй. Энэ тохиолдолд зарцуулалтын хэмжээ нь ТХНС-ийн хуримтлалын дансны үлдэгдлээс хэтрэхгүй байх.

Харин сайн дурын тэтгэвэрт хамрагдагсад зорилтот хэрэгцээнд ашиглах зорилгоор зарцуулалт хийх эрхгүй байна.

Шимтгэл төлөгч нас барсан тохиолдолд өв залгамжлагчид олгох нэг удаагийн төлбөрийн дээд хэмжээ нь сарын тооцооллын индексийн 52,4 дахин өсгөсөн дүн буюу 152851 тенгегээс хэтрэхгүй.

***2021 оны 9 сарын байдлаар орон сууцны нөхцөлөө сайжруулах зорилгоор1786,2 тэрбум тенге, эрүүл мэндийн зардлаа төлөх зорилгоор 29,5 тэрбум тенге, шимтгэл төлөгч нас барсан тохиолдолд өв залгамжлагчид олгох нэг удаагийн төлбөрт 42,2 тэрбум тенге, гадаад улсад байнга оршин суухаар явсан шимтгэл төлөгчид зориулж 25,1 тэрбум тенгений зарцуулалт хийсэн байна.***

*Амь даатгалын компанид шилжүүлэх.*

ТХНС-д шимтгэл төлөгч нь тэтгэврийн хуримтлалаа амь даатгалын компанид шилжүүлж болно. Дор дурдсан нөхцөлийг хангах шаардлагатай.

- Амь даатгалд хамрагдаагүй шимтгэл төлөгч
  - Хэрэв тэтгэврийн аннуитет авах эрх үүссэн бол эрэгтэй 55 нас, эмэгтэй 52 нас хүрсэн тохиолдолд Заавал төлөх тэтгэврийн хуримтлалын сангаас тэтгэврийн хуримтлалаа шилжүүлж болно.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Харин Заавал төлөх мэргэжлийн тэтгэврийн хуримтлалын сангаас 60 сар шимтгэл төлсөн 50 нас хүрсэн шимтгэл төлөгч тэтгэврийн хуримтлалаа шилжүүлж болно.

- Хэрэв тэтгэврийн аннуитет авах эрх үүсээгүй бол 45 нас хүрсэн тохиолдолд Заавал төлөх тэтгэврийн хуримтлалын сангаас тэтгэврийн хуримтлалаа шилжүүлж болно. Харин Заавал төлөх мэргэжлийн тэтгэврийн хуримтлалын сангаас 60 сар шимтгэл төлсөн 40 нас хүрсэн шимтгэл төлөгч тэтгэврийн хуримтлалаа шилжүүлж болно.

- Амь даатгалаар тэтгэврийн аннуитет авч буй шимтгэл төлөгч эрэгтэй 55 нас, эмэгтэй 52 нас хүрсэн тохиолдолд Заавал төлөх тэтгэврийн хуримтлалын сангаас тэтгэврийн хуримтлалаа шилжүүлж болно. Харин Заавал төлөх мэргэжлийн тэтгэврийн хуримтлалын сангаас 60 сар шимтгэл төлсөн 50 нас хүрсэн шимтгэл төлөгч тэтгэврийн хуримтлалаа шилжүүлж болно.

Амь даатгалын компанид шилжүүлэх хуримтлалын хамгийн бага хэмжээ нь эрэгтэй 6,7 сая тенге, эмэгтэй 9,0 сая тенге байна. Хэрэв Заавал төлөх тэтгэврийн хуримтлалын сан болон Заавал төлөх мэргэжлийн тэтгэврийн хуримтлалын сангийн хуримтлал нь хүрэлцэхгүй бол Сайн дурын тэтгэврийн хуримтлалын сангаас шилжүүлж болно.

Амь даатгалаас төлөх тэтгэврийн аннуитет нь амьжиргааны доод түвшний орлогын 70%-иас багагүй байна.

*2020 оны байдлаар ТХНС-аас 44,0 тэрбум тенгетэй тэнцэх хуримтлалыг амь даатгалын компанид шилжүүлсэн байна.*

***Тэтгэврийн хуримтлалаараа хөрөнгө оруулалт хийх***

2021 оноос эхлэн Тэтгэврийн хуримтлалын нэгдсэн санд тэтгэврийн хуримтлалтай иргэд өөрийн хуримтлалыг ХОМБ-аар дамжуулан санхүүгийн хэрэгслүүдэд хөрөнгө оруулах замаар ирээдүйн тэтгэврийн хуримтлалаа өсгөх боломжийг нээж өгсөн.

**Зураг 10.ХОМБ-аар дамжуулан тэтгэврийн хуримтлалаа хөрөнгө оруулалтад оруулах**




UIH.MN СУДАЛГААНЫ САН

ХОМБ-ыг тухайн шимтгэл төлөгчийн хүсэлтээр сонгоно.

Тэтгэврийн хуримтлалыг шилжүүлэх ХОМБ нь дараах шаардлагыг хангасан байна.

- Санхүүгийн зах зээлийг зохицуулах агентлагаас тогтоосон нөхцөл, шаардлагыг хангасан байх. Үүнд:
    - Өөрийн хөрөнгийн хэмжээ 3 тэрбум тенге;
    - Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагааг хамгийн багадаа 36 сар эрхэлсэн байх;

  - ХОМБ-ын менежмент хийж буй хөрөнгө оруулалтын багцын хэмжээ нь 5 тэрбум тенгегээс багагүй байх;
  - Сүүлийн 2 жил менежмент хийсэн хөрөнгө оруулалтын багц нь алдагдал хүлээгээгүй байх;
  - Бусад шаардлагууд.
- Хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээ үзүүлэх гэрээг ТХНС-тай байгуулсан байх.
- ТХНС болон Кастодиан банктай гурвалсан гэрээ байгуулсан байх.

Шимтгэл төлөгч дор дурдсан нөхцөлийг хангасан бол ХОМБ-д шилжүүлэг хийж болно.
- ТХНС дахь хуримтлалын хэмжээ нь байх ёстой хамгийн бага тэтгэврийн хуримтлалын хэмжээнээс их байх. Хөрөнгө оруулах боломжтой хуримтлалын дүн нь байх ёстой хамгийн бага тэтгэврийн хэмжээнээс илүү гарсан хэсэг байна.
- Эсвэл, даатгалын компаниас насан турш тэтгэврийн анниутет авах эрхтэй байх. ТХНС дахь хуримтлалын хэмжээгээр хөрөнгө оруулах эрхтэй.

ХОМБ-аар дамжуулан хийж болох хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийн жагсаалт, хөрөнгө оруулалт хийх нөхцөлийг Санхүүгийн зах зээлийг зохицуулах агентлаг батлах бөгөөд ХОМБ нь хөрөнгө оруулалтаас олох хамгийн бага өгөөжийн баталгаа гаргадаг.

Хөрөнгө оруулалт хийж болох санхүүгийн хэрэгслүүд:
- Казахстан Улсын Засгийн газрын үнэт цаас;
- Казахстан Улсын орон нутгаас гаргасан үнэт цаас;
- Төв банк 100% эзэмшдэг хуулийн этгээд болон “Казахстан Улсын Хөгжлийн банк”, “Самрук-Казна” сан, “Байтерек” холдингийн гаргасан өрийн бичиг;
- “BB-” болон түүнээс дээш рейтингтэй II зэргийн арилжааны банкин дахь хадгаламж;
- “A-“ болон түүнээс дээш рейтингтэй гадаадын арилжааны банкин дахь хадгаламж;
- “BB” болон түүнээс дээш рейтингтэй олон улсын санхүүгийн байгууллагын өрийн бичиг;
- “BB+” болон түүнээс дээш рейтингтэй гадаад улсын Засгийн газрын үнэт цаас;
- “BB” болон түүнээс дээш рейтингтэй компанийн гаргасан үнэт цаас;
- Хөрөнгө оруулалтын сан;
- Үнэт металл;
- Зөвшөөрөгдсөн санхүүгийн активуудын опцион, форвард, фьючерс, своп арилжаа зэрэг болно.

ХОМБ-ын үйлчилгээний комисс авах эрхтэй ба энэ нь хөрөнгө оруулалтаас олсон орлогын 7.5%-иас хэтрэхгүй.

***Тэтгэврийн хуримтлалын нэгдсэн сан дахь хөрөнгийг өвлөх***

ТХНС-д шимтгэл төлөгч нас барсан тохиолдолд түүний хуримтлалыг өв залгамжлагч өвлөж авах эрхтэй. ТХНС-аас өв залгамжлагчид дараах мөнгөн дүнг олгоно.

1. Оршуулгын зардал
   Шимтгэл төлөгч нас барсан тохиолдолд өв залгамлагчид олгох оршуулгын зардлын дээд хэмжээ нь сарын тооцооны индексийг 52,4 дахин өсгөсөн дүн буюу 152851 тенгегээс хэтрэхгүй байна.
2. ТХНС дахь хуримтлал
   Өв залгамжлагч нь хуульд заасны дагуу холбогдох бичиг баримтыг бүрдүүлэн өгч, хуульд заасан хэмжээгээр ТХНС дахь хуримтлалыг өвлөж авна.

***Тэтгэврийн хуримтлалын нэгдсэн сангийн хөрөнгийн баталгаа***

Тэтгэврийн шимтгэл төлөгчийн тэтгэврийн хуримтлалд төрөөс дараах баталгааг гаргана.
- Заавал төлөх тэтгэврийн хуримтлалын сан болон Заавал төлөх мэргэжлийн тэтгэврийн хуримтлалын санд байршиж буй хуримтлалын дүнд
- Инфляцаас хамааруулж тооцсон хүүд баталгаа гаргана.

Төрийн баталгаанд ХОМБ-д шилжүүлсэн хөрөнгө хамаарахгүй.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

## 3. НОРВЕГИЙН ХААНТ УЛС

### 3.1 Норвегийн тэтгэврийн тогтолцоо[299]

Дэлхийн хүн амын 63-аас дээш хувийг бүрдүүлдэг 37 орны тэтгэврийн тогтолцоог харьцуулан судалдаг Monash Centre for Financial Studies болон Global Consultant Mercer хамтран гаргасан 2019 оны “Mercer Global Pension Index”-т Норвеги Улс зургаадугаар байрт орсон байна.

Норвеги Улс бүх нийтийн тэтгэврийн системийг 1937 онд нэвтрүүлсэн бөгөөд 1967 онд нийгмийн хамгааллын системийн нэг бүрэлдэхүүн хэсэг болсон.

Норвегийн тэтгэврийн систем нь заавал болон сайн дурын гэсэн 2 хэлбэртэй бөгөөд хуваарилалтын болон хуримтлалын системийг хослуулан хэрэглэдэг.

Заавал даатгах албан журмын тэтгэврийн даатгал нь 2 хэсэгтэй.

- Өндөр настны тэтгэврийн хөтөлбөр (Statutory old age pension scheme)
- Байгууллагын тэтгэврийн хөтөлбөр (Public sector Occupational pension scheme болон Private sector Occupational pension scheme)

***Хуваарилалтын тэтгэврийн систем***

Норвегийн тэтгэврийн хуваарилалтын систем нь заавал даатгах тэтгэврийн даатгал байх бөгөөд дараах 2 төрөлтэй.

- Өндөр настны тэтгэврийн хөтөлбөр (Statutory old age pension scheme)
- Төрийн албан хаагчдад зориулсан байгууллагын тэтгэврийн хөтөлбөр (Public sector Occupational pension scheme)

Өндөр настны тэтгэврийн хөтөлбөр нь төрөөс хэрэгжүүлдэг гол тэтгэврийн систем бөгөөд Нийгмийн хамгааллын системийн нэг бүрэлдэхүүн хэсэг болдог. Норвеги Улсын ажилтан бүр энэ тэтгэврийн даатгалд заавал хамрагдах ёстой .

Тэтгэвэр олголт нь хуваарилалтын системээр явагдах бөгөөд дор дурдсан 3 төрлийн шимтгэлээр санхүүжинэ.

- Ажилтан бүр 8.2%-ийн нийгмийн даатгалын шимтгэл төлөх ба үүнээс 3.1% нь тэтгэврийн санд хуваарилагдана.
- Ажил олгогч бүс нутгаас хамаарч 14.1% хүртэл төлнө.
- Хувиараа ажил эрхлэгч 11.4% төлнө.

2019 оны байдлаар Өндөр настны тэтгэврийн хөтөлбөрийн 2/3 нь шимтгэлийн орлогоор 1/3 нь төсвөөс санхүүжигдсэн байна.

Тэтгэвэрт гарах нас нь уян хатан бөгөөд 62-75 насандаа тэтгэвэрт гарч болно.

Өндөр настны тэтгэврийн хөтөлбөрийг Норвегийн Үндэсний Даатгалын Байгууллага буюу Norwegian National Insurance Administration(NAV) хариуцаж ажилладаг.

Төрийн албан хаагчдад зориулсан байгууллагын тэтгэврийн хөтөлбөр нь төрөөс хэрэгжүүлдэг нэмэлт албан журмын тэтгэврийн хөтөлбөр болдог. Хөтөлбөрийг Норвегийн Төрийн албаны тэтгэврийн сангаар дамжуулан хэрэгжүүлдэг. Төрийн албан хаагч энэ тэтгэвэрт заавал хамрагдана.

Тэтгэвэр олголт нь хуваарилалтын системээр явагдах бөгөөд дор дурдсан 2 төрлийн шимтгэлээр санхүүжинэ.

- Ажилтан бүр 2% шимтгэл төлнө.
- Ажил олгогч 8-12% шимтгэл төлнө.

[299] https://www.oecd.org/els/public-pensions/PAG2019-country-profile-Norway.pdf

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Харин орон нутгийн өөрөө удирдах байгууллагын ажилтнуудад зориулсан албан журмын байгууллагын тэтгэврийн хөтөлбөр нь хуримтлалын тэтгэврийн систем байдаг.

***Тэтгэврийн хуримтлалын систем***

Норвеги Улсын тэтгэврийн хуримтлалын систем нь дараах 2 төрөлтэй.

- Хувийн секторын байгууллагын тэтгэврийн хөтөлбөр
- Сайн дурын хувийн тэтгэврийн даатгал

Хувийн секторын байгууллагын тэтгэврийн хөтөлбөр нь заавал даатгуулах албан журмын тэтгэврийн даатгал байна. Дор хаяж 2 ажилтантай хувийн секторын хуулийн этгээд энэ тэтгэврийн хөтөлбөрт хамрагдана.

Тэтгэврийн нэгдсэн сан байдаггүй бөгөөд албан байгууллага тус бүр тэтгэврийн хуримтлалын сан үүсгэнэ.

Тэтгэврийн сан нь ажил олгогчоос төлөх шимтгэлээс бүрэлдэх бөгөөд шимтгэлийн хувь хэмжээ нь дор дурдсан нөхцөлийг хангасан байна.

- Хамгийн бага шимтгэлийн хувь хэмжээ нь 2%
- 7.1G хүртэлх цалингаас төлөх шимтгэлийн дээд хувь хэмжээ нь 7%
- 7.1G – 12G хүртэлх цалингаас төлөх шимтгэлийн дээд хувь хэмжээ нь 18.1%

Ажилтан нь сайн дурын үндсэн дээр шимтгэл төлж болно.

Санг тухайн ажил олгогч байгууллага эсвэл, мэргэжлийн байгууллага удирдана. Санг удирдахтай холбоотой зардлыг ажил олгогч гаргадаг. Тэтгэвэрт гарах насыг гэрээгээр зохицуулна.

Норвеги Улсын тэтгэврийн тогтолцоо нь[300]

- Улсын тэтгэвэр буюу Үндэсний нийгмийн даатгалын систем. Улсын тэтгэврийн тогтолцоо буюу Үндэсний даатгалын систем (folketrygden) нь тэтгэврийн хуваарилалтын тогтолцоотой бөгөөд тэтгэврийг улсын төсвөөс санхүүжүүлнэ. Энэ системийн удирдлагыг Хөдөлмөр, нийгэм хамгааллын захиргаа[301] (NAV) хариуцан ажилладаг.
- Байгууллагын (ажил олгогчийн) тэтгэврийн хөтөлбөр болон хамтын тэтгэврийн хөтөлбөр. Хамтын гэрээний үндсэн албан журмын Байгууллагын тэтгэврийн хөтөлбөр болон хамтын тэтгэврийн хөтөлбөр нь тэтгэврийн системийн бүрэлдэхүүн хэсэг болдог. Ажилтан уг хөтөлбөрт заавал хамрагдана. Энэ хөтөлбөрийн хүрээнд төрийн албан хаагчид хамрагдах Public sector Occupational pension scheme болон хувийн секторт ажиллагсад хамрагдах Private sector Occupational pension scheme гэсэн 2 тусдаа хөтөлбөрийг хэрэгжүүдэг.
- Сайн дурын хуримтлалын тэтгэвэр. Энэ нь банк, даатгалын компанитай хувиараа гэрээ байгуулах замаар хэрэгжүүлэх сайн дурын хуримтлал байна.

Улсын тэтгэвэр нь орлогын тэтгэвэр (income pension), орлого олдоггүй болон бага орлоготой иргэдэд зориулсан баталгаат тэтгэвэр (guarantee pension)-ээс бүрдэнэ.

Түүнчлэн улсын тэтгэврийн зэрэгцээ 2006 оноос албан журмын Байгууллагын тэтгэврийн хөтөлбөрийг нэвтрүүлсэн байна.

Иргэд заавал хамрагдах улсын тэтгэвэр, байгууллагын тэтгэврийн хөтөлбөрөөс гадна сайн дурын Хувийн сайн дурын тэтгэвэр (Voluntary private pension) тэтгэвэрт хамрагдах боломжтой.

Норвеги Улс дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ 6.6 хувийг тэтгэвэрт зарцуулдаг байна.

[300] https://www.enpf.kz/ru/pension-system/world/norway.php
[301] https://www.nav.no/en/home

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**Улсын тэтгэвэр**

*Тэтгэвэр тогтоолгох нөхцөл*

Норвегит 16-66 насандаа гурван жилээс доошгүй хугацаагаар оршин суусан иргэдэд шинэ системээр баталгаат тэтгэвэр авах эрх үүсдэг. Бүрэн баталгаат тэтгэврийг дөчин жил амьдарсны дараа олгодог.

*Орлогын тэтгэвэр*

Тэтгэврийн орлого нь 13-75 насны иргэдийн хөдөлмөрийн хөлс эсвэл, бусад төрлийн орлогоос шимтгэл авах замаар хуримтлагддаг. Жил бүр иргэн орлогынхоо 18.1%-тай тэнцэх хэмжээ хүртэл шимтгэлээ нэмэгдүүлэн төлж болдог бөгөөд цалингийн өсөлтийг харгалзан тэтгэврийн эрхийг жил бүр нэмэгдүүлдэг байна.

2018 онд дундаж тэтгэвэр 95.800 NOK[302] байсан. ЭЗХАХБ-аас гаргасан тооцоололд үндэслэн Норвегит 2018 онд бүтэн цагаар ажилласан хүний дундаж цалин 596.477 NOK байжээ. Тиймээс тэтгэврийн дээд хэмжээ нь дундаж цалингийн 114 орчим хувьтай тэнцэж байна.

2011 оноос эхлэн 62-75 насны иргэдийн нөхцөл байдлыг харгалзан уян хатан тэтгэвэр (flexible retirement) тогтоолгох ажлыг бүх нийтийн тэтгэврийн тогтолцоонд нэвтрүүлсэн. Ажил, тэтгэврийг орлогын шалгалгүйгээр 62 наснаас эхлэн бүрэн буюу хэсэгчлэн хослуулах боломжтой. 2011 оноос эхлэн өндөр насны тэтгэвэр авагчдын тэтгэврийн дундаж наслалтын зохицуулалтыг хийж эхэлсэн.

*Баталгаат тэтгэвэр*

Баталгаат тэтгэврийг тэтгэврийн доод хэмжээгээр олгодог бөгөөд орлогын тэтгэврийн 80%-тай тэнцдэг. Тэтгэвэр авагчийн баталгаат тэтгэвэр нь 2018 онд дунджаар 192.383 NOK байсан бөгөөд энэ нь дундаж орлогын 32 орчим хувьтай тэнцэж байна. Баталгаат тэтгэврийг цалинтай уялдуулан индексжүүлэх боловч дундаж наслалтын нөлөөллийг харгалзан 67 жил болгосон байна. Статистикийн урт хугацааны төсөөлөлд Норвеги иргэдийн дундаж наслалт 67 болж, жилд 0.5%-иар нэмэгдэж байна.

*Нэмэлт схем Defined contribution scheme*

2006 оноос эхлэн тогтоосон тэтгэврийн шимтгэлийн хөтөлбөрийн дагуу ажил олгогч ажилтны өмнөөс түүний орлогын 2-оос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний шимтгэл төлдөг болсон. Хэрэв ажил олгогчоос үүний оронд өөр хөтөлбөр санал болгосон тохиолдолд шимтгэлийн хэмжээ дээрхтэй ижил байх ёстой. Шимтгэлийн хэмжээ нь улсын тэтгэврийн суурь хэмжээ[303] ба түүнийг 12 дахин нэмэгдүүлсэн хэмжээний хооронд байхаар тооцогдоно.

Тэтгэврийн шинэчлэлийн хүрээнд 2011 оноос эхлэн 62 наснаас эхлэн тэтгэвэр тогтоолгох уян хатан тэтгэмжийг тогтоосон байна. Тэтгэмжийг дор хаяж 77 нас хүртлээ насан туршийн аниутетээр авах боломжтой.

*Тэтгэвэр тогтоох Variant careers (public scheme)*

*Эрт тэтгэвэрт гарах*

Нийт ажилчдын гуравны хоёр орчим нь ажил олгогчтой гэрээ байгуулсны үндсэн дээр эрт тэтгэвэрт гарах Contractual Early Retirement Schemes (AFP) схемд хамрагдаж болно. 1989 онд нэвтрүүлсэн энэ схем нь 62 наснаас тэтгэвэрт гарах боломжийг олгодог.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[302] NOK – Норвегийн мөнгөн тэмдэгт
[303] 2021 оны байдлаар 106 399 НОК байна. https://www.skatteetaten.no/en/rates/national-insurance-scheme-basic-amount/

2011 оноос эхлэн хэрэгжүүлсэн хувийн хэвшлийн AFP схем нь өндөр насны тэтгэврийн тогтолцоонд насан туршийн нэмэгдэл болдог.

Нэмэгдэл тэтгэврийн хэмжээ нь бүрэн тэтгэврийн доод хэмжээний 4.2 хувьтай тэнцэх бөгөөд 62 нас хүртлээ хуримтлуулж болно. Нэмэлтийг тооцохдоо тасралтгүй байх зарчим болон дундаж наслалтад үндэслэдэг бөгөөд 62-70 насны хооронд авах боломжтой.

Хувийн хэвшлийн AFP-ийн тэтгэвэрт хамрагдахын тулд тодорхой нөхцөлийг хангах хэрэгтэй байдаг. Нэгдүгээрт, ажилтан 62 нас хүрсэн байх ба сүүлийн есөн жилийн долоон жилийн хугацаанд хувийн AFP схемд хамрагдах ёстой. Хоёрдугаарт, ажиллахаа болих хүртлээ ажилтан сүүлийн гурван жил тасралтгүй ажилласан байх ёстой. Гуравдугаарт, тэтгэвэрт гарах үеийн жилийн орлого нь хамгийн багадаа улсын тэтгэврийн суурь хэмжээтэй тэнцүү байх ёстой

*Хожуу тэтгэвэрт гарах*

Иргэд 67 нас хүрснээр тэтгэвэрт гарах эрх үүсэх боловч өөрөө хүсвэл тэтгэвэр авангаа үргэлжлүүлэн ажиллаж болно.

*Хувь хүний орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэл*

Тэтгэврээс татвар авах: Тэтгэврийн орлогод хөдөлмөрийн орлогоос бага татвар ногдуулдаг. Татварын тусгай дүрмээр тэтгэврийн доод хэмжээгээр тэтгэвэр авагчдыг орлогын албан татвараас чөлөөлдөг.

Татварын тогтолцоог тэтгэврийн шинэчлэлд нийцүүлэх зорилгоор тэтгэврийн орлогын албан татварын дүрмийг 2011 оноос эхлэн өөрчилсөн. Гол зорилго нь хөдөлмөрийн орлогын ахиу татварын хэмжээг бууруулах, ингэснээр тэтгэвэр тогтоолгосон ч хөдөлмөр эрхлэхийг дэмжихэд оршино.

Хожуу ба эрт тэтгэвэрт гарсан тэтгэвэр авагчид: Эдгээр тэтгэвэр авагчид тэтгэврийн орлогоос хамааран татварын тусгай хөнгөлөлт эдэлдэг. Татварын хөнгөлөлтийн дээд хэмжээ нь 2018 онд 29.950 NOK байсан.

*Норвегийн Төрийн албаны тэтгэврийн сан*

Төрийн албан хаагчдад зориулсан Public sector Occupational pension scheme тэтгэврийн хөтөлбөрийг Норвегийн Төрийн албаны тэтгэврийн сангаар дамжуулан хэрэгжүүлнэ. Уг сан Хөдөлмөр, нийгэм хамгааллын яамны харьяанд ажилладаг.

Норвегийн Төрийн албаны тэтгэврийн сангийн хөрөнгийг өндөр насны тэтгэвэр, орон сууц худалдан авахад, мэргэжлээс шалтгаалсан ослын даатгалд, амь насны даатгалд зарцуулж болдог онцлогтой.

Орон сууцны зээл нь санд хамрагдсан иргэдийг дэмжих зорилготой зах зээлийн хамгийн бага хүүтэй зээл юм. Норвегийн Төрийн албаны тэтгэврийн санд хамрагдсан иргэн 2.3 сая NOK, харин гэр бүлийн 2 гишүүн санд хамрагддаг бол 4.6 сая хүртэлх NOK-ийн зээл авах боломжтой. Зээлийг орон сууц худалдан авах, дахин санхүүжүүлэх, орон сууцаа засварлах, үл хөдлөх хөрөнгийн төлбөр тооцоонд ашиглах боломжтой байдаг.[304]

Ажилтан мэргэжлээс шалтгаалсан гэмтэл болон өвчнөөр өвчилсөн тохиолдолд нөхөн төлбөр авах хууль ёсны эрхийг мэргэжлээс шалтгаалсан ослын даатгал олгодог. Бүх ажил олгогчид ажилчдаа мэргэжлээс шалтгаалсан ослын даатгалд хамруулах ёстой. Норвегийн Төрийн албаны тэтгэврийн сан нь засгийн газрын нэрийн өмнөөс энэхүү схемийг удирддаг. Мэргэжлээс шалтгаалах гэмтлийн талаар Норвегийн Хөдөлмөр, халамжийн алба (NAV) болон Норвегийн

[304] https://www.spk.no/en/housing-loan/

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Төрийн албаны тэтгэврийн санд мэдэгдэх бөгөөд хэрэв гэмтлийн улмаас нас барсан бол эхнэр/нөхөр/ хамтран амьдрагч, хүүхэд нь гэрээний дагуу нөхөн төлбөр авдаг.[305]

Амь насны даатгал нь Норвегийн Төрийн тэтгэврийн сангийн нэг хэсэг биш ч төрийн албан хаагчдын дийлэнх нь мөн төрийн албанд түр болон хагас цагаар ажилладаг хүмүүст энэ даатгалд хамрагддаг байна. Энэ даатгалд хамрагдсан иргэн нас барсан тохиолдолд түүний төрөл төрөгсөд нь даатгуулагчийн нас барсан шалтгаанаас үл хамааран нэг удаагийн төлбөр авдаг байна.[306]

*Норвегийн тэтгэврийн тогтолцооны давуу тал*[307]

- Норвегийн тэтгэврийн зах зээл дээрх хувийн тэтгэврийн 75 орчим хувийг даатгалын гэрээгээр санхүүжүүлдэг бөгөөд шилдэг таван даатгалын компани зах зээлийн 94 орчим хувийг хянадаг.
- Улсын тэтгэврийн тогтолцоо нь ажил эрхэлж буй болон хувиараа хөдөлмөр эрхэлдэг бүх хүнийг хамруулсан хавтгайрсан суурь тэтгэвэр ба орлоготой холбоотой нэмэгдэл дээр үндэслэн тэтгэврийн хангалттай түвшинг хангаж өгдөг.
- Ажилчдын шимтгэл нь орлогын 7.8 хувийг эзэлж байгаа бол ажил олгогч нь 14.1 хувийг төлдөг.
- Ихэнх Европын орнуудаас ялгаатай нь орлогын дээд хязгаарыг дагаж мөрдөөгүй тул нийт орлогыг тооцдог.

*Тэтгэврийн тогтолцооны сул тал*

- Норвегийн бүх иргэн Норвегийн үндэсний даатгалын тухай хуулийн дагуу 67 наснаас эхлэн улсын тэтгэвэр авах эрхтэй байдаг. Энэ нь дундаж тэтгэвэр тогтоолгох наснаас өндөр байна.
- Эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс өндөр тэтгэвэр авдаг. Энэ нь цалингийн тэгш бус байдал, эмэгтэйчүүд давамгайлсан ажил мэргэжилд доогуур цалин өгдөгтэй холбоотой.

### 3.2 Норвеги Улсын баялгийн сан

Норвегийн Хаант Улс (цаашид Норвеги Улс гэх) байгалийн баялгийг хэний өмч байх талаар үндсэн хуульдаа тусгаагүй ч “Газрын тостой холбогдох үйл ажиллагааг зохицуулах” хуульдаа (Act 29 November 1996 No. 72 relating to petroleum activities[308]) “Норвегийн төр нь газрын тосны нөөцийг эзэмших ба нөөцийг ашиглах онцгой эрхтэй” гэж заажээ. Үндсэн хуулийнхаа 112 дугаар зүйлд “Байгалийн нөөцөө хойч үеийн эрхийг баталгаажуулсан, урт хугацааны бодлогод суурилан ашиглах болно”[309] гэж тусгасан байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

305 https://www.spk.no/en/insurance/occupational-injury-insurance/
306 https://www.spk.no/en/insurance/group-life-insurance/
307 ‘’Монгол Улсын тэтгэврийн үндэсний тогтолцооны жишиг загвар боловсруулах нь’’ судалгааны ажлын тайлан. Залуу судлаачдыг дэмжих сан ТББ 2021 он
308 Газрын тостой холбогдох үйл ажиллагааг зохицуулах хууль. https://www.npd.no/en/regulations/acts/act-29-november-1996-no2.-72-relating-to-petroleum-activities/
309 Норвегийн Үндсэн хууль. https://lovdata.no/dokument/NLE/lov/1814-05-17?q=grunnloven

**Зураг 11. Норвегийн баялгийн сан, тэтгэврийн сан**




*Эх сурвалж: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяагийн илтгэл 2021.04.06*

Байгалийн баялгийн орлогыг “Засгийн газрын тэтгэврийн сан-Глобал”-д оруулдаг. Энэ сан нь Засгийн газрын тэтгэврийн сан нэртэй боловч хөрөнгө оруулалтын сан юм. Норвеги Улсын баялгийн сангууд нь хоёр өөр чиг үүрэг бүхий хөрөнгө оруулалтын сангаас бүрддэг.

Эхнийх нь Засгийн газрын тэтгэврийн сан-Глобал бөгөөд үүнийг **Газрын тосны сан** гэж нэрлэдэг. Норвегийн төсөвт төвлөрсөн газрын тосны салбарын илүүдэл орлогыг хөрөнгө оруулалт хийх, нефтийн орлогын зах дээл дахь тогтворгүй байдлаас хамгаалах зорилготой.[310] Засгийн газрын тэтгэврийн сангийн тухай хууль (Government Pension Fund Act[311]) 2020 онд батлагдсан.

Газрын тосны сан нь дэлхийн хамгийн том бие даасан баялгийн сан болсон ба түүний зах зээлийн үнэлгээ нь 2021 оны байдлаар 1.3 их наяд ам.доллар хүрсэн. Энэхүү сан нь зөвхөн гадаадын зах зээлд хөрөнгө оруулалт хийдэг ба өмчийн, үл хөдлөх, тогтмол орлогын зэрэг чиглэлийн хөрөнгөөс бүрдэнэ.

Норвегийн хоёр дахь сан бол **Засгийн газрын тэтгэврийн сан- Норвеги** юм. 1967 онд үндэсний даатгалын сангийн хэлбэрээр байгуулагдсан ба Газрын тосны сангаас тусдаа удирдлагатай бөгөөд дотоодын болон Скандинавын зах зээлд хөрөнгө оруулалт хийхэд чиглэгдсэн. Ослогийн хөрөнгийн биржээр дамжуулан Норвеги дахь компаниудын томоохон хувьцаа эзэмшигч юм.[312]

Засгийн газрын тэтгэврийн сан нь газрын тосны орлогын тодорхой хэсгийг хуримтлуулан ирээдүйн тэтгэврийн зардлын зарим хэсгийг төлөх гол хэрэгсэл. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын /ЭЗХАХБ/ гишүүн орон болох Норвеги Улсын тэтгэврийн зардал ирээдүйд өсөх хандлагатай байгааг тооцон ирээдүйн зардлыг санхүүжүүлэх нөөцийг эртнээс хуримтлуулах арга замыг хайж, хөрөнгө оруулалтын орлогоосоо ирээдүйд өсөн нэмэгдэх тэтгэврийн зардлын тодорхой хувийг санхүүжүүлэх, өөрөөр хэлбэл, газрын тосны орлогын зарцуулалтын талаар урт хугацааны менежментийн бодлого хэрэгжүүлж ирээдүй хойч үеийнхэнд ирэх тэтгэврийн зардлын хүнд ачаа дарамтыг бууруулах, үе дамжсан хөрөнгө бий болгох, одоо болон хойч үедээ газрын тосны орлого, үр шимийг хүртэх боломж олгохыг зорьж байна.

[310]Норджес банк, Хөрөнгө оруулалтын менежмент. (2021 он). Сангийн тухай. https://www.nbim.no/en/the-fund/about-the-fund/

[311] https://www.regjeringen.no/contentassets/9d68c55c272c41e99f0bf45d24397d8c/government-pension-fund-act-01.01.2020.pdf

[312] https://www.investopedia.com/terms/g/government-pension-fund-norway.asp

**Зураг 12. Норвегийн Засгийн газрын тэтгэврийн сан**




*Эх сурвалж: Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газрын цахим хуудас*
https://cabinet.gov.mn/wp-content/uploads/uul-uurhai.pdf

*Засгийн газрын тэтгэврийн сангийн тогтолцоо, сангийн удирдлага*

Засгийн газрын тэтгэврийн сангийн хөрөнгийн удирдлагын тухай зохицуулалтыг Парламентаас баталсан Засгийн газрын тэтгэврийн сангийн тухай хууль (Government Pension Fund Act[313] no. 123 of 21 December 2005) болон нэмэлт зохицуулалт бүхий дүрэм журмаар зохицуулна.

Засгийн газрын тэтгэврийн сангийн тухай хуулийн 1-р зүйлд: ***“Засгийн газрын тэтгэврийн сан нь Үндэсний даатгалын тогтолцоон дахь тэтгэврийн зардал болон газрын тосны орлогыг захиран зарцуулахтай холбоотой урт хугацааны асуудлыг шийдвэрлэхэд Засгийн газрын хуримтлалаас санхүүжилт хийхэд дэмжлэг үзүүлнэ”*** гэж заасан.

Мөн хуулийн 2-р зүйлд: “Засгийн газрын тэтгэврийн санг Сангийн яам удирдана. Норвегийн тэтгэврийн сан нь Засгийн газрын тэтгэврийн сан-Глобал, Засгийн газрын тэтгэврийн сан-Норвеги гэсэн хоёр сангаас бүрдэнэ. Засгийн газрын тэтгэврийн сан-Глобалын хөрөнгийг Norges Bank-ны дансанд, Засгийн газрын тэтгэврийн сан-Норвегийн хөрөнгийг Folketrygdfondet-ийн дансанд тус тус байршуулна” гэж заасан.

Энэ сангийн орлого нь Засгийн газрын нэгдсэн төсвөөс шилжүүлсэн газрын тосны үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ, газрын тосны үйл ажиллагаатай холбоотой санхүүгийн гүйлгээний цэвэр үр дүн болон Сангийн хөрөнгийн үр өгөөжөөс бүрддэг.

*Сангийн хөрөнгө оруулалтын менежмент*

Засгийн газрын тэтгэврийн сангийн хөрөнгө оруулалтын стратеги нь сангийн хөрөнгийн олон улсын худалдан авах чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого юм.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

313 https://resourcegovernance.org

**Зураг 13. Норвегийн тэтгэврийн сангийн хөрөнгө оруулалтын бүтэц**

**Засгийн газрын тэтгэврийн сан-Глобал**




**Засгийн газрын тэтгэврийн сан-Норвеги**




Засгийн газрын тэтгэрийн сан-Глобалын капитал нь бүхэлдээ гадаад валютаар гадаадын орнуудад хийгдсэн хөрөнгө оруулалт юм. Сангийн хөрөнгө оруулалт нь хувьцаа, тогтмол орлого, үл хөдлөх хөрөнгө гэсэн хэд хэдэн тодорхой хөрөнгийн ангилалд тархсан байдаг. Глобал ба Норвегийн гэсэн хоёр тэтгэврийн сангийн ялгаатай тал нь Засгийн газрын тэтгэврийн сан-Норвеги нь жижиг хөрөнгийн зах зээл дэх харьцангуй том хөрөнгө оруулагч байдаг бол Глобал тэтгэврийн сан нь ОУ-ын зах зээл дэх харьцагуй жижиг хөрөнгө оруулагч болдог.[314]

**Засгийн газрын тэтгэврийн сан-НОРВЕГИ**

Энэ сан нь хуулийн дагуу 1967 онд байгуулагдсан бөгөөд 2006 онд Газрын тосны сангийн нэгэн адил нэрийг нь сольсон. Сангийн хөрөнгө нь 2020 оны байдлаар 292 тэрбум NOK.

Засгийн газрын тэтгэврийн сан-НОРВЕГИ-д зөвхөн дотоодын хувьцаанд хөрөнгө оруулахыг зөвшөөрдөг. Иймд тус сан нь Норвегийн олон том компаниудын гол хувьцаа эзэмшигч нь байдаг.

**Хүснэгт 14. Норвеги Улсын баялгийн сан**

| | Агуулга | Засгийн газрын Тэтгэврийн сан-Глобал (GPFG[315]) | Засгийн газрын Тэтгэврийн сан- Норвеги (GPFN[316]) |
|---|---|---|---|
| 1. | Байгуулагдсан он | 1990 он | 1967 он |
| 2. | Зорилго | • Эдийн засгийг газрын тосны үнийн уналтаас хамгаалах<br>• Ирээдүй хойч үеийнхэндээ газрын тосны баялгаас үр шимийг нь хүртээх<br>• Эдийн засгийн бодит өсөлтийг хангах | • Эрсдэлийн түвшинг хязгаарлах<br>• Санхүүгийн өгөөжийг нэмэгдүүлэх |
| 3. | Сангийн удирдлага | Норвегийн Сангийн яам тус санг удирдаж, Төвбанкны хөрөнгө оруулалтын удирдлага нь менежментийг нь хийдэг. | Норвегийн Сангийн яам тус санг удирддаг. Сангийн үйл ажиллагааны менежментийг Folketrygdfondet хийдэг. |

UIH.MN

[314] Гадаадын зарим орны тэтгэврийн сангийн тогтолцоо, сангийн нөөц хөрөнгийн удирдлага, хөрөнгө оруулалтад ашиглах боломжийн талаарх туршлага, эрх зүйн зохицуулалт. СТ-16/219
Эх үүсвэр нь уул уурхайн орлогоос бүрддэг баялгийн сангуудын зарчим, үйл ажиллагаа. СТ-09/215
[315]Норвегийн Засгийн газрын цахим хуудас https://www.regjeringen.no/en/topics/the-economy/the-government-pension-fund/government-pension-fund-global-gpfg/id697027/
[316] Мөн тэнд

| | | | |
|---|---|---|---|
| 4. | Сангийн хадгаламж | • Газрын тосны нийт орлого, АМНАТ, улсын шууд санхүүжилтийн хүүгийн орлого, ногдол ашиг<br>• Статойл, газрын тосны үндэсний компанийн болон бусад салбар дах ЗГ-ын эзэмшлийн компаниудын хувьцааны борлуулалтын цэвэр орлого<br>• Сангийн хөрөнгө оруулалтын өгөөж | |
| 5. | Сангийн зарцуулалт | • Хөгжлийн зорилгоор эдийн засагт эргэлтэд оруулан, сангийн үр шимийг хүртэх (сангийн хөрөнгийн 3-4 хувь)<br>• Зөвхөн Парламентын шийдвэрээр төсөвт шилжүүлэх ба үүгээр газрын тосны бус салбарын алдагдлыг нөхөх | |
| 6. | Сангийн хөрөнгө оруулалт | Зөвхөн гадаад зах зээлд<br>• 60-80 хувь үнэт цаас<br>• 20-40 хувь тотмол орлого<br>• 0-7 хувь үл хөдлөх хөрөнгө<br>• 0-2 хувь сэргээгдэх эрчим хүч | • 40 хувь тогтмол орлого<br>• 60 хувь хувьцаа |
| 7. | Сангийн хориглох зүйлс | Сангийн хууль, тогтоомж болон Сантьягогийг зарчимд зааснаас бусад | Энэ сангийн хөрөнгийг зөвхөн дотоодын хувьцаанд хөрөнгө оруулахыг зөвшөөрдөг. |

**4. БҮГД НАЙРАМДАХ ЧИЛИ УЛС**

Чили Улс нь 1981 онд нийгмийн даатгалын хувийн дансны системийг нэвтрүүлснээр Тэтгэврийн хуваарилалтын системийг Тэтгэврийн хуримтлалын системээр сольсон анхны улс болсон юм.

Тэтгэврийн систем нь бүхэлдээ албан журмын хувийн хуримтлалын системд тулгуурласан байдаг. Чили Улсын тэтгэврийн системд хүн бүр хувийн данс эзэмших бөгөөд дансандаа шимтгэлээ төлж хуримлал бий болгодог. Тэтгэврийн нэгдсэн хуримтлалын сан байдаггүй, харин бие даасан Тэтгэврийн сангийн менежментийн компаниуд нь тэтгэврийн үйлчилгээг санал болгон хуримтлалын сан үүсгэж, энэхүү санг удирдан ажилладаг.

Тэтгэврийн сангийн менежментийн компаниуд нь зөвхөн тэтгэврийн эсвэл, нийгмийн хамгааллын даатгалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг тусгайлсан мэргэжлийн байгууллагууд байдаг. Энэхүү компаниуд нь шимтгэл төлөгчөөс төлдөг заавал төлөх нийгмийн даатгалын шимтгэл хураан авч, хуримтлалын сан үүсгэн, хөрөнгө оруулах замаар тэтгэврийн хуримтлалын санг арвижуулах үүрэгтэй. Тэтгэврийн сангийн менежментийн компаниуд нь энэ үйлчилгээг үзүүлснийхээ төлөө шимтгэл төлөгчийн хуримтлалаас комисс авдаг. Шимтгэл төлөгч нь Тэтгэврийн сангийн менежментийн компанийг өөрөө сонгох эрхтэй.

Тэтгэврийн санд төлөх шимтгэлийн хувь хэмжээ нь 10% байдаг бөгөөд шимтгэл тооцох цалингийн дээд хэмжээ нь 60UF[317] байна. Шимтгэл төлөгч хүсвэл сайн дурын үндсэн дээр нэмж төлж болно. Тэтгэвэрт гарах нас нь эрэгтэй 65 нас, эмэгтэй 60 нас байна.

Тэтгэврийн системд төр онцгой үүрэгтэй оролцдог. Төрийн үүрэг:

- Тэтгэврийн систем, сангийн хөрөнгийн баталгаа гаргах
- Тэтгэврийн сангийн менежментийн компаниудын үйл ажиллагааг хянах үүрэгтэй.

[317] “Unidad de Fomento” (UF) нь Чили Улсад ашигладаг тооцооны нэгж. https://si3.bcentral.cl/estadisticas/Principal1/metodologias/EC/IND_DIA/ficha_tecnica_UF_EN.pdf

UIH.MN СУДАЛГААНЫ САН

1. Тэтгэврийн систем, сангийн хөрөнгийн баталгаа гаргах. Төр дараах баталгааг гаргадаг.

- Тэтгэврийн доод хэмжээний баталгаа гаргах. Өөрөөр хэлбэл, шимтгэл төлөгч 20 жилийн турш шимтгэл төлсөн бөгөөд хуримтлалын сангаас авах тэтгэвэр нь тэтгэврийн доод хэмжээнд хүрэхгүй бол зөрүүг төр хариуцаж санхүүжүүлдэг.
- Тэтгэврийн хуримтлалын өгөөжийн баталгаа. Хэрэв Тэтгэврийн сангийн менежментийн компани Тэтгэврийн хуримтлалын санг хөрөнгө оруулж олсон орлогын сүүлийн 36 сарын өгөөж нь нийт Тэтгэврийн хуримтлалын сангийн өгөөжийн дунджаас бага бол зөрүүг төр хариуцаж санхүүжүүлдэг. Энэ тохиолдолд тухайн Тэтгэврийн сангийн менежментийн компанийг татан буулгах үйл ажиллагааг төр хариуцаж явуулна.
- Тэтгэврийн хуримтлалын баталгаа. Хэрэв Тэтгэврийн сангийн менежментийн компани нь төлбөрийн чадваргүй болсон, дампуурсан тохиолдолд хохирлыг төр хариуцдаг.

2. Тэтгэврийн сангийн менежментийн компаниудын үйл ажиллагааг хянах. Тэтгэврийн хуримтлалын бүрэн бүтэн байдлыг хангахын тулд төрөөс Тэтгэврийн сангийн менежментийн компаниудын үйл ажиллагаанд хяналт тавьдаг. Тэтгэврийн сангийн менежментийн компаниудыг хянах газар (Superintendency of Pension Fund Administrators - SAFP) төрийн хяналтыг хэрэгжүүлнэ. Тэтгэврийн сангийн менежментийн компаниудыг хянах газрын даргыг Ерөнхийлөгч томилдог. Тэтгэврийн сангийн менежментийн компаниудыг хянах газар нь дараах эрх, үүрэгтэй.

- Тэтгэврийн сангийн менежментийн компанийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, олгохоос татгалзах;
- Тэтгэврийн сангийн менежментийн компаниудад хуулийн, үйл ажиллагааны, санхүүгийн хяналт тавих;
- Тэтгэврийн сангийн менежментийн компаниудын дүрмийн сан, заавал байлгах нөөц шаардлага хангаж байгаа эсэхэд хяналт тавих;
- Тэтгэврийн системийг сайжруулах зорилгоор хууль, журамд өөрчлөлт оруулах талаар санал гаргах;
- Хүчин төгөлдөр хуульд нийцүүлэн дүрэм, журам батлах;
- Зөрчлийн арга хэмжээ авч торгууль ногдуулах, Тэтгэврийн сангийн менежментийн компанийг хуульд заасны дагуу татан буулгах үйл ажиллагааг зохион байгуулах;
- Ажилгүйдлийн сангийн менежментийн компаниудын үйл ажиллагааг хянах, хариуцлагын арга хэмжээ авах.

**Тэтгэврийн системийн бүтэц[318]**

Чили Улс нь 1981 онд төрийн тэтгэврийн системээс хувийн тэтгэврийн сантай, хуримтлалын системд шилжсэн анхны улс юм.

Чилийн тэтгэврийн тогтолцооны шинэчлэл нь Засгийн газар хууль баталснаар эхэлсэн бөгөөд иргэдийн хувийн тэтгэврийн сан хэлбэрээр олж авсан, сонгох эрхэнд суурилсан тэтгэврийн шинэ тогтолцоог бүрдүүлжээ.

Шинэчлэлийн зорилго нь хувийн сонгох эрхэнд суурилсан тогтолцоог бий болгож, бүх Чиличуудын ашиг сонирхлын нэгдмэл байдлыг хангах явдал байв.

Энэхүү шинэчлэлийн үр дүнд төрийн тэтгэврийн систем (PAYG DB)-ээс хувийн хуримтлалын тэтгэврийн систем руу шилжсэн.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[318] Структура пенсионной системы Чили. https://www.enpf.kz/upload/medialibrary/fc2/fc25f1948e1e13860d2568b086e6df75.pdf

**Зураг 14. Тэтгэврийн тогтолцоо**




**Төрийн тэтгэврийн систем**

*Төрийн тэтгэвэр:* Энэ нь 1981 оноос хойш хэрэгжиж буй шинээр нэвтрүүлсэн хуримтлалын системд (накопительная система) хамрагдаагүй, цалингийн хуучин систем буюу хуваарилалтын зарчмаар (PAYG) тэтгэвэр авах хүмүүс хамрагдана. Цаашдаа хуучин PAYG системийг дуусгаж шинэ тогтолцоондоо бүрэн шилжих төлөвлөгөөтэй байна.

*Үндсэн тэтгэвэр:* Тэтгэврийн системд шимтгэл төлөөгүй, тэтгэвэр авах эрхгүй 65 нас хүрсэн хүмүүст улсын төсвөөс олгодог. Үүнд хувь хүмүүсийн орлогын түвшин, тухайн улсад хэдэн жил амьдарсан байх гэсэн шаардлагыг хангасан байх ёстой (өндөр орлоготой бүлэгт харьяалагддаггүй; тус улсад доод тал нь 20 жил амьдарсан, үүнээс өргөдөл гаргахаас 5-аас доошгүй жилийн өмнө тус улсын иргэншилтэй болсон байх). Тэтгэврийн доод хэмжээг инфляцын түвшинг харгалзан жил бүр тогтоож индексжүүлнэ.

*Үндсэн тэтгэврийн нэмэлт төлбөр:* Тэтгэврийн системд шимтгэл төлсөн боловч тэтгэврийн доод хэмжээнээс доогуур тэтгэвэр тогтоолгосон 65-аас дээш насны хүмүүст олгох ёстой (ингэснээр тэтгэврийн доод хэмжээг нэмэгдүүлэх үүрэг гүйцэтгэдэг). Мөн орлогын түвшин болон тухайн улсад хэдэн жил амьдарсан зэрэг тавигдах шаардлагууд байдаг. Цэргийн албан хаагчид болон хууль сахиулах байгууллагын ажилтнуудын хувьд тэтгэврийн тусдаа хөтөлбөртэй байдаг.

**Заавал хамрагдах хувийн хуримталын тэтгэврийн систем.** Хувийн тэтгэврийн санг удирддаг тэтгэврийн хуримтлалын систем (бүрэн санхүүжүүлсэн DC). 1983 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш ажилд орсон хүмүүс (хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг үе шаттайгаар хамруулсан), мөн хуримтлалын системд хуучин PAYG системээс сайн дураар шилжсэн иргэд хамрагдана.

**Сайн дураар хамрагдах хувийн тэтгэврийн систем.** Хувийн тэтгэврийн сан болон бусад санхүүгийн байгууллагуудын (арилжааны банкууд, даатгалын компаниуд гэх мэт) санал болгодог сайн дурын тэтгэврийн сан.

**Тэтгэврийн систем** нь гурван бүрэлдэхүүн хэсэгтэй.[319]

1. дахин хуваарилах;
2. заавал оролцох;
3. сайн дурын.

[319] Chile. https://www.oecd.org/els/public-pensions/PAG2019-country-profile-Chile.pdf

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**Тэтгэвэрт гарах нөхцөл, шаардлага.** Тэтгэвэрт гарах нас эрэгтэй 65 нас, эмэгтэй 60 нас байдаг. Хувь хүмүүс тэтгэвэрт гарахын тулд заавал ажлаасаа гарах шаардлагагүй байдаг.

*Хамтын үндсэн тэтгэвэр* (Basic solidarity pension-PBS) нь тэтгэвэр авах боломжгүй иргэдэд олгох эрх юм. Хамтын үндсэн тэтгэврийг 65 наснаас эхлэн хүн амын хамгийн ядуу 60% хүртэл олгох ёстой. Уг тэтгэврийг Чилид 20-иос доошгүй жил оршин суусан байх, мөн өргөдөл гаргахаас өмнөх таван жилийн доод тал нь дөрвөн жилд нь оршин суусан байх ёстой байна.

Тэтгэвэр багатай хүмүүст зориулагдсан *Хамтын тэтгэврийн төлбөр* (Solidarity Pension Payment-APS) нэртэй халамжийн нэмэлт тэтгэвэр байдаг. Тэтгэвэр авагчдын тогтоолгосон тэтгэврийн хэмжээ нь тогтоосон хэмжээнээс доогуур байвал энэ тэтгэмжийг авахаар хүсэлт гаргаж болно. Энэхүү тэтгэмж авах болзол нь Хамтын үндсэн тэтгэвэр авах болзолтой ижил байна.

**Тэтгэмжийн тооцоо.** Хувь хүний орлогын албан татвар нь нийт орлогын 10 хувь байна. Албан татварыг уг хувь дээр нэмж тооцдог.

**Төлөвлөсөн болон нэмэлт.** Хамтын үндсэн тэтгэвэр (PBS)-ийн хэмжээг инфляцийн түвшинтэй уялдуулан жил бүр шинэчлэн тогтоодог.

Хамтын тэтгэврийн төлбөр (APS) нь PBS ба PBS-ийн PMAS[320]-ийн харьцааг тэтгэврийн дүнгээр үржүүлсэн зөрүүгээр тооцсон нэмэлт юм.

PBS нь тэтгэврийн доод хэмжээ байдаг бол PMAS нь тогтмол хэмжээ бөгөөд инфляцийн түвшинг харгалзан жил бүр шинэчлэн тогтоодог.

**Тэтгэврийн доод хэмжээ.** Өндөр насны тэтгэврийн доод хэмжээ нь хамгийн багадаа 20 жил шимтгэл төлсөн байх ёстой бөгөөд нийт орлого нь өндөр насны тэтгэврийн доод хэмжээнээс бага байна.

Өндөр насны тэтгэврийн сарын доод хэмжээ нь 70-аас доош настай бол CLP[321]132258.72; 70-75 насныхан CLP144614.74; 75-аас дээш настай бол CLP154299.05 байна.

Энэхүү тэтгэврийг аажмаар халж, 2023 он гэхэд ахмад настны хамтын тэтгэврийн төлбөр (APS)-өөр сольж байна.

**Тэтгэврийн боломжууд**

*Эрт тэтгэвэрт гарах.* Тодорхой босго хэмжээнээс дээш тэтгэврийг санхүүжүүлэхэд тэтгэврийн дансанд хуримтлагдсан хөрөнгө хангалттай байгаа тохиолдолд дор дурьсан нөхцөлийн дагуу аль ч насанд тэтгэвэрт гарахыг зөвшөөрдөг.

1. Тэтгэмж нь PMAS-ийн 80%-иас багагүй байх ёстой.
2. Тэтгэвэрт гарахаас өмнөх арван жилийн дундаж орлогын 70%-тай тэнцэх хэмжээний тэтгэвэр авах боломжтой байх.

Тэтгэвэрт гарах ердийн насыг тодорхой мэргэжлээр хүнд нөхцөлд ажилласан таван жил тутамд нэг эсхүл, хоёр жилээр бууруулж болно. Тэтгэвэрт гарах насны хамгийн дээд насны хэмжээг арван жилээр бууруулна.

*Хожуу тэтгэвэрт гарах*. Тэтгэврийн насыг тэтгэвэрт гарах наснаас хойш хойшлуулах боломжтой.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[320] The PMAS is a fixed amount, also adjusted every year to account for inflation.
[321] Чилийн мөнгөн тэмдэгт – Чилийн песо

**Ковид-19 цар тахлын үед тэтгэврийн сангийн хуримтлал.**[322] 2020 оны 7 дугаар сарын 24-ний өдөр Ковид-19 цар тахлын улмаас үүссэн санхүүгийн асуудлаа иргэд шийдвэрлэхийн тулд тэтгэврийн сангийн хуримтлалын 10 хүртэлх хувийг авах боломжтой болох тухай хуульд гарын үсэг зурсан.

2020 оны 12 дугаар сарын 3-ны өдөр Коронавирусын цар тахлын улмаас үүссэн эдийн засгийн хямралыг даван туулахад туслах зорилгоор тэтгэврийн сангийн хуримтлалаа (10 хувь хүртэл) буцааж авах боломжийг иргэдэд олгох тухай хуульд гарын үсэг зурсан.

**Баялгийн сангууд**

Бүгд Найрамдах Чили Улс төсвийн хариуцлагын эрх зүйн орчинг бий болгох асуудлыг одоогоос 20 жилийн өмнөөс эхэлж явуулсан гэж үздэг бөгөөд 2006 онд “Төсвийн хариуцлагын тухай” (Fiscal Responsibility Law, №20.218)[323] 4 бүлэг, 24 зүйлтэй хуулийг батлан мөрдүүлжээ. Энэ хуулиар үндсэний мөнгөн хуримтлалын тогтолцоог анх “Эх орны баялгийн сангууд” гэсэн агуулгаар хуульчилсан байна.

Чили Улс нь Төсвийн хариуцлагын тухай хуулиар байгуулагдсан 2 төрлийн баялгийн сантай байна. Үүнд:

- Тэтгэврийн нөөцийн сан (Pension Reserve Fund)
- Эдийн засаг, нийгмийг тогтворжуулах сан (Economic and Social Stabilization Fund) юм.

Үндэсний баялгийн сангууд нь Чилийн төсвийн бодлогыг хэрэгжүүлэх үндсэн хэрэгсэл бөгөөд макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, Чиличүүдэд хамгийн сайн төрийн үйлчилгээг үзүүлэх, нийгэм хамгааллыг хөгжүүлэх зорилготой.

*Нэг.Эдийн засаг, нийгмийг тогтворжуулах сан (ЭЗНТС) .*[324] ЭЗНТС нь татан буугдсан Зэсийн нөхөн олговрын санг орлох зорилгоор Сангийн яамны шийдвэрийн дагуу албан ёсоор 2007 оны эхээр байгуулагдсан. Тус сангаас төсвийн алдагдлыг нөхөх болон улсын өрийг барагдуулах санхүүжилтийг гаргана. Энэ нь тогтворжуулалтын сан бөгөөд мөчлөг сөрөх хэрэгсэл юм. Өөрөөр хэлбэл, зэсийн үнийн бууралтаас хамаарах төсвийн алдагдлыг санхүүжүүлэх, мөн шаардлагатай үед улсын өрийг төлөх боломж бүрдүүлнэ.

*Хоёр.Тэтгэврийн нөөцийн сан (ТНС)*[325]. 2006 оны сүүлээр байгуулагдсан бөгөөд ядуу иргэдэд дэмжлэг үзүүлэх зорилготой. Сангаас төсвийн тэтгэвэр, тэтгэмжид (өндөр насны тэтгэвэр, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэмж) зарцуулах зардлыг санхүүжүүлнэ. Тус сан нь ирээдүйд тэтгэврийн тооцоологүй зардлыг санхүүжүүлэх нэмэлт эх үүсвэр болдог.

Төсвийн хариуцлагын тухай хуулийн дагуу ТНС-ийн хөрөнгө жил бүр өмнөх оны ДНБ-ний 0.2%-тай тэнцэх хэмжээгээр нэмэгддэг. Хэрэв төсвийн бодит илүүдэл ДНБ-ний 0.2%-иас хэтэрсэн бол сан нь уг илүүдэлтэй тэнцэх хэмжээний шимтгэл авдаг бөгөөд дээд хэмжээ нь ДНБ-ний 0.5% хүртэл байна. Ийнхүү хуримтлалын дүрмийн дагуу улс оронд тулгарч буй төсвийн нөхцөл байдлаас үл хамааран жил бүр санд нөөц хуваарилагддаг.

***Хөрөнгө оруулалтын бодлого***. Сан дараах 2 багцад хуваагддаг. Үүнд:

1. Богино хугацааны хөрөнгө оруулалтын багц. 2020-2021 онуудад татан төвлөрүүлэх нөөцийг энэ багцад нөөцлөн хадгална.
2. Урт хугацааны хөрөнгө оруулалтын багц. Энэ нь Сангийн урт хугацааны хөрөнгө оруулалтын хэсэг байна (илүү их эрсдэлд орж болзошгүй хэсэг).

[322] Структура пенсионной системы Чили.
https://www.enpf.kz/upload/medialibrary/fc2/fc25f1948e1e13860d2568b086e6df75.pdf
[323] Fiscal Responsibility Law, https://www.bcn.cl/leychile/navegar?idLey=20128
[324] *https://hacienda.cl/english/work-areas/international-finance/sovereign-wealth-funds/pension-reserve-fund*
[325] https://hacienda.cl/english/work-areas/international-finance/sovereign-wealth-funds/pension-reserve-fund

UIH.MN СУДАЛГААНЫ САН

*<u>Урт хугацааны хөрөнгө оруулалтын багц.</u>* Хөрөнгө оруулалтын гол зорилго нь төсвийн тэтгэврийн зарим үүргийн санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгоход оршино. Үүний тулд арван жилийн хугацаанд жилд Чилийн инфляцын түвшингээс дор хаяж 2%-ийн песогийн (латин америкийн мөнгөний нэгж) хүлээгдэж буй өгөөжийг авах тодорхой зорилтыг тодорхойлсон (хамгийн багадаа 60%-ийн магадлалтай). Мөн эрсдэлийн байж болох хэмжээг тогтоосон бөгөөд энэ нь сангийн песогоор илэрхийлэгдсэн бодит өгөөж 12%-иас бага байх магадлал тухайн жилд 5%-аас хэтрэхгүй байхаар заажээ. Санхүүжүүлэх үүргийн хэмжээ, боломжийг харгалзан хөрөнгө оруулалтын хугацааны хязгаарыг дунд, урт хугацааны гэж үздэг.

Стратегийн хөрөнгийн хуваарилалт. Хувьцаанд 31%, Soverein ба Засгийн газрын бондод 34%, корпорацын бондод 13%, өндөр хүүтэй бондод 8%, АНУ-ын агентлагийн моргежийн зээлийн баталгаажсан үнэт цаасанд (MBS) 6%, инфляцаар индексжүүлсэн Soverein бондод 8% байршсан байна. Урт хугацааны багцын хувьд Soverein ба засгийн газрын бондын багц, инфляцаар индексжүүлсэн Soverein бондын багцыг Чилийн Төв банк шууд удирддаг. Үнэт цаас, Корпорацын бонд, Өндөр хүүтэй бонд, АНУ-ын Агентлаг MBS-ийн багцыг Чилийн Төв Банкнаас сонгон шалгаруулалтын журмаар сонгогдсон гадны менежерүүд удирддаг.

*<u>Богино хугацааны хөрөнгө оруулалтын багц.</u>* Хөрөнгө оруулалтын гол зорилго нь хөрвөх чадвар өндөртэй хэрэгсэлд хөрөнгө оруулах замаар эрсдэлийн хатуу стандартын хүрээнд оруулсан хөрөнгийн эх үүсвэрийн үнэ цэнийг хадгалахад оршино. Стратегийн хөрөнгийн хуваарилалт: Багцын бүрдэл нь АНУ-ын сангийн вексельд 93%, АНУ-ын урт хугацааны сангийн вексельд 7% байршсан байна. Багцыг бүхэлд нь Төв банк удирддаг.

**Зураг 15. Тэтгэвэр болон баялгийн сан[326]**




UIH.MN СУДАЛГААНЫ САН

[326] Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хуримтлалын нэгдсэн сангийн танилцуулга. 2021.

**Хүснэгт 14. Чили Улсын сан**

| № | | ***Эдийн засаг, нийгмийг тогтворжуулах сан*** | ***Тэтгэврийн нөөц сан*** |
|---|---|---|---|
| 1 | Байгуулагдсан он | 2006 он | 2007 он |
| 2 | Зорилго | Зэсийн орлого гэнэтийн буурах үед төсвийн алдагдлыг даван туулахад туслах | Тэтгэврийн болон нийгмийн халамжийн зардлыг санхүүжүүлэхэд туслах |
| 3 | Сангийн удирдлага | Сангийн яам | Сангийн яам |
| 4 | Сангийн хадгаламж | - Уул уурхайн орлого<br>- Төсвийн төлөвлөгөөт орлогоос давсан илүүдэл<br>- Хөрөнгө оруулалтын өгөөж | - Жил бүр өмнөх оны ДНБ-ний 0.2-0.5 хувь<br>- Сангийн сайдын шийдвэрээр хадгаламжийг Эдийн засаг нийгмийг тогтворжуулах сангаас санхүүжүүлэх |
| 5 | Сангийн зарцуулалт | - Төсвийн алдагдлыг нөхөх<br>- Улсын өрийг төлөх<br>- Тодорхой хувиар тэтгэврийн сангийн зузаатгал хийх | - Зөвхөн тэтгэвэр, нийгмийн халамжийн өр төлбөрийг төлөх |
| 6 | Сангийн хөрөнгө оруулалт | ***Зөвхөн гадаад зах зээлд***<br>• Мөнгөний зах зээлийн хэрэгслүүд 35% (Банкны хадгаламж 15.5%, АНУ-н ЗГ-н богино хугацаат өрийн бичиг 19.5%)<br>• Бонд 56.5%<br>• Инфляцтай уясан бонд 3.5%<br>• Энгийн хувьцаа 5%<br>***Валют багц бүрдүүлэлт нь:***<br>• Ам.доллар 41%<br>• Евро 25.78%<br>• Японы Иен 20.5%<br>• Швейцарын франк 7.78% | ***Зөвхөн гадаад зах зээлд:***<br>1. Урт хугацааны хөрөнгө оруулалтын багц:<br>- Хувьцаа 31%<br>- Засгийн газрын бонд 34%<br>- Компанийн бонд 13%<br>- Өндөр өгөөжтэй бонд 8%<br>- АНУ-ын институционал моргейжийн зээлээр баталгаажсан үнэт цаас 6%<br>- Инфляцтай уясан бонд 8%<br>2. Богино хугацааны хөрөнгө оруулалтын багц:<br>- АНУ-ын ЗГ-ын богино хугацаат өрийн бичиг 93%,<br>- АНУ-ын бонд 7% |
| 7 | Сангийн хориглох зүйлс | Сангийн мөрддөг хуулиуд болон Сантьягогийн зарчимд зааснаас бусад | Сангийн мөрддөг хуулиуд болон Сантьягогийн зарчимд зааснаас бусад |

## 5. НИДЕРЛАНДЫН ХААНТ УЛС

### *Тэтгэврийн тогтолцоо*

Monash Centre for Financial Studies болон Global Consultant Mercer хамтран 2019 онд дэлхийн улс орнуудын тэтгэврийн тогтолцоог үнэлж гаргасан “Mercer Global Pension Index”-т Нидерланд Улс тэргүүлжээ.

Нидерландын тэтгэврийн тогтолцоо үндсэн 3 бүтэцтэй. Үүнд:

1. Улсын тэтгэвэр (Өндөр насны тэтгэврийн ерөнхий хуулийн дагуу)
2. Хөдөлмөр эрхлэлтийн хувийн тэтгэвэр (мэргэжлийн тэтгэвэр);
3. Хувь хүний сайн дурын тэтгэвэр зэрэг болно.[327]

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[327] Хамгийн шилдэг тэтгэврийн систем Нидерландынх (shuud.mn)

**Зураг 16. Нидерланд улсын тэтгэврийн тогтолцоо**




*Эх сурвалж: Нидерланд Улсын тэтгэврийн тогтолцоо*

**1.Улсын тэтгэвэр**: Энэ тэтгэврийг улсын төсөв болон цалингаас төлсөн татвараар санхүүжүүлж олгодог. Энэхүү тэтгэвэр нь Нидерландын өндөр насны тэтгэврийн хуулиар зохицуулагдана. Хуулиар тогтоосон тэтгэвэрт гарах наснаас эхлэн сард ганц бие иргэн 1250 евро, гэр бүлийн хосууд 1700 евро авдаг байна.[328] Тэтгэврийн хэмжээ нь цалин буюу ажиллах үедээ улсын төсөвт төлсөн татварын хэмжээнээс хамаардаггүй. Тэтгэврээс орлогын албан татвар болон үндэсний нийгмийн даатгалын шимтгэл (НДШ) тооцдог бөгөөд бүх орлогоосоо татвар төлөх шаардлагагүй байдаг тул бусад орлого дээрээ татварын хөнгөлөлт эдлээгүй бол тэтгэвэр авахдаа хөнгөлөлтөө хасуулах боломжтой байдаг. Эрүүл мэндийн даатгалын шимтгэлд 5.45 %-ийг төлдөг. Эдгээр шимтгэл, татварыг хассаны дараа гар дээр авах цэвэр тэтгэврийн дүн олгогддог байна.[329] Нидерланд Улсад 50-аас багагүй жил амьдарсан 65-аас дээш насны бүх иргэн тэтгэвэр авах эрхтэй. Нидерландад ажиллаж амьдарч байсан жил бүртээ 2%-ийн тэтгэврийн хуримтлалыг бий болгодог байна. Тэтгэвэрт гарахдаа 15-65 насандаа Нидерландад амьдарсан бол улсын бүрэн тэтгэвэр авах эрх үүснэ.

Улсын тэтгэврийг ажил хөдөлмөр эрхлээгүй ч Нидерландын нутаг дэвсгэр дээр амьдарч байсан иргэдэд 2%-иар олгодог бөгөөд заавал голланд хүн байх албагүй. Улсын тэтгэврийг нийгмийн даатгалын банк (SVB)-аар дамжуулан олгодог.

Улсын тэтгэврийн хувь хэмжээг дараах нөхцөлүүдийг харгалзан тогтооно:

- Ганцаараа амьдардаг хүмүүс - хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 70%;
- Гэрлэсэн эсвэл хамтран амьдрагч - хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 %;
- Хэрэв тэтгэврийн насанд хүрсэн хамтрагчтай бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 100% хүртэл авна.

Голландад тэтгэврийн насыг аажмаар нэмэгдүүлж байгаа бөгөөд 2020 оноос эхлэн тэтгэврийн насыг 66, 2021 оноос 67 нас гурван сар болгож байна.

**2.Хөдөлмөр эрхлэлтийн хувийн тэтгэвэр:** Нидерландын тэтгэврийн хоёр дахь тулгуур нь хуримтлалд суурилсан хөдөлмөр эрхлэлтийн хамтын тэтгэврийн тогтолцоо юм. Тэтгэврийн сан болон даатгалын компаниуд энэхүү санг удирдана. Тэтгэврийн тухай хуулиар зохицуулагддаг тул заавал даатгалын хэлбэртэй байна. Ажил олгогчид ажилтантайгаа тохирсон хувь хэмжээгээр тухайн ажилтны нэр дээр тэтгэврийн данс нээж, сар бүр хуримтлал үүсгэнэ. Талууд ихэвчлэн тэнцүү хэмжээний шимтгэл төлөх бөгөөд хэмжээ нь тухайн хүний цалингаас хамаарч, цалингийн 10 %-иас хэтэрдэггүй. Байгууллагын зүгээс мөнгө оруулдаг ч

[328] https://www.tus.mn/wp-content/uploads/2020/11/Nederland-Tsuvral-20201117.pdf
[329] Social insurance bank Netherlands", 2020

UIH.MN СУДАЛГААНЫ САН

ажилтан тэтгэвэрт гарах үедээ тухайн хуримтлалаа ганцаараа захиран зарцуулах эрхтэй болдог. Арилжааны банкны хугацаатай хадгаламжийн үйлчилгээтэй адилхан тэтгэврийн сангийн өсөлт, өгөөж өндөр байдаг. Мөн улсын тэтгэврээс ялгаатай нь тухайн хүн нас барахад мөнгөө үр хүүхэд, гэр бүлийнхэндээ үлдээх боломжтой. Эдгээр сангууд тухайлсан компанитай холбоотой хэдий ч санхүүгийн хувьд тусдаа, бие даасан ашгийн бус байгууллага хэлбэрээр үйл ажиллагаа явуулах ёстой гэж хуульчилсан байдаг. Компанид санхүүгийн эрсдэл үүссэн тохиолдолд тэтгэврийн сан бие даасан байдлаар орших тул тухайн компанийн санхүүгийн эрсдлийг үүрэхгүй.

Харин хувиараа хөдөлмөр эрхэлдэг буюу ажилладаг салбар нь хамтын тэтгэврийн сан үүсгэх боломжгүй иргэд тэтгэврийн хуримтлалаа өөрсдөө удирдана. Гэхдээ хөрөнгө оруулалт хийх, даатгуулах, хувьцаа эсвэл үл хөдлөх хөрөнгө авах, мөн үүнтэй холбоотой татварын хөнгөлөлт эдлэх зэрэг **тэтгэврийн хөрөнгө оруулалтын багцуудаас** заавал сонгох ёстой байдаг. Тэтгэвэрт гарсан иргэд хуулийн дагуу цалингийнхаа 70 хүртэлх хувиар тэтгэвэрт тогтоолгож боломжийн орлоготой амьдрах нөхцөл бүрддэг. Нидерландын ажилчдын 90 гаруй хувь нь хөдөлмөр эрхлэлтийн хувийн тэтгэврийн санд харьяалагддаг. Хувийн тэтгэврийн санд зөвхөн ажил эрхэлж буй хүмүүс л хамрагдах боломжтой. Нидерланд Улсад хувь хүн улсын тэтгэвэртээ цалингийн 4.9 хувийг, тэтгэврийн хуримтлалдаа 16%-ийг хийдэг. Үүнийг ажил олгогчоос урамшуулж, цалингийн 20.9%-тай тэнцэх мөнгийг ажилтныхаа хуримтлалд хийдэг.[330]

Нидерландын ихэнх тэтгэврийн хуримтлалыг тэтгэврийн сангууд удирддаг. Тэтгэврийн сан нь дараах гурван төрөлтэй байна.

- эдийн засаг, барилга, жижиглэнгийн худалдаа гэх мэт салбарыг хамарсан Засгийн газрын харьяа тэтгэврийн сангууд;
- компани буюу корпорацын ажилчдад зориулагдсан корпорацийн тэтгэврийн сан;
- хувиараа хөдөлмөр эрхлэгч, бие даасан мэргэжилтнүүдэд зориулсан тэтгэврийн сан;

Нидерландын хувийн тэтгэврийн сангууд ашгийн бус бөгөөд компаний бүрэлдэхүүн хэсэг биш бие даасан хуулийн этгээд гэж тооцогддог байна.[331]

Хувийн тэтгэврийн сангаас иргэнд бий болох давуу талууд:

- Ажил олгогч мөн шимтгэл төлөх тул хувь хүнд илүү их хуримтлал үүсгэх боломж бий болдог.
- Хувийн тэтгэвэрт төлсөн дүнг татвараас чөлөөлдөг тул татварын зардлыг бууруулдаг.
- Хөрөнгө оруулалтыг зөв удирдсан тохиолдолд их хэмжээний өгөөж хүртэх боломжтой.
- Санхүүгийн эрсдэл үүссэн тохиолдолд тэтгэврийн сантай шууд харилцах боломжтой.

Ажил олгогчдын хувьд бий болох давуу талууд:

- Хувийн тэтгэврийн сангаар дамжуулан мэргэшсэн боловсон хүчнийг тогтоон барих боломжтой.
- Шимтгэл төлөх үүрэг хүлээснийхээ хэрээр татварын тодорхой хөнгөлөлт эдэлдэг. Мөн төлсөн хэмжээгээр татварыг бууруулах систем үйлчилдэг.

**3. Хувь хүний сайн дурын тэтгэвэр:** Тэтгэврийн хуримтлалын 3 дахь тулгуур нь хувь хүний сайн дурын тэтгэвэр буюу голчлон хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон хамтын тэтгэврийн тогтолцоогүй салбаруудад ашигладаг хэлбэр байна. Хувь хүний тэтгэврийн хуримтлал нь хувь

[330] https://medium.com/@ganzorigganbat/%D1%82%D1%8D%D1%82%D0%B3%D1%8D%D0%B2%D1%80%D0%B8%D0%B9%D0%BD-%D1%82%D1%83%D1%85%D0%B9-d7873feb8e92
[331] http://repository.ufe.edu.mn:8080/xmlui/bitstream/handle/8524/2022/FA16b043

UIH.MN СУДАЛГААНЫ САН

хүн өөрийн хүсэлтээр орлогоосоо хамаарч сайн дураараа тэтгэврийн данс нээлгэх үйлчилгээг арилжааны банк болон даатгалын байгууллагууд санал болгодог. Иргэд тэтгэврийн бүтээгдэхүүн, амьдралын даатгал, хувьцаа, үл хөдлөх хөрөнгө, түүнтэй холбоотой татварын хөнгөлөлт зэрэг хөрөнгө оруулалтыг багцыг бие даан, сайн дураараа худалдаж авч өөрөө хөрөнгө оруулалтаа удирдах боломжтой. Иргэд татварын хөнгөлөлтийг ашиглан нэмэлт хуримтлал үүсгэх боломжийг ийнхүү бүрдүүлдэг.

***Тэтгэврийн сангийн удирдлага***

Нидерландын тэтгэврийн санд заавал дагаж мөрдөх хяналтын тогтолцоо нь эрсдэлд суурилсан төлбөрийн чадварын шаардлагыг бий болгосон.

Financial Assessment Framework (Financieel Toetsingskader) нь тэтгэврийн сангийн өр төлбөрийг үнэлэх дүрмийг боловсруулан баталж шаардлага хангаагүй тэтгэврийн тогтолцоонд хориг арга хэмжээ авах, торгууль ногдуулах арга хэмжээ авдаг. Ажил олгогчийн шимтгэлийг сангийн актуар буюу даатгагч тодорхойлно. Тогтмол шимтгэлд (DC) ажилчид нийт дүнгийн гуравны нэг орчим хувийг төлдөг бол гуравны хоёр нь ажил олгогчоос төлөгддөг байна[332].

Дараах 7 төрлийн тэтгэврийн сан байна.[333] Үүнд:

1. Үйлдвэрийн салбарын албан журмын тэтгэврийн сан; (2019 онд 45 сан)
2. Үйлдвэрийн салбарын сайн дурын тэтгэврийн сан; (2019 онд 7 сан)
3. Хөдөлмөр эрхлэлтийн тэтгэврийн сан; (2019 онд 9 сан)
4. Компанийн тэтгэврийн сан; (2019 онд 164 сан)
5. Тэтгэвэр ба амьдралын даатгалын сан; (2019 онд ойролцоогоор 7 том сан)
6. Premium pension institution; (2019 онд 7 сан)
7. Ерөнхий тэтгэврийн сангууд; (2019 онд 6 сан)

Нидерландын Тэтгэврийн тухай хууль ('Pensioenwet')-д заасан журмын дагуу ажил олгогч, ажилтан тэтгэврийн гэрээг байгуулах ба тэтгэврийн нөхцөл, гэрээг дагаж мөрдөх нөхцөлүүдийг тусгадаг. Түүнчлэн Голландын Засгийн газар болон холбогдох талуудын эрх, үүргийг ч мөн гэрээнд тодорхой тусгана. Ажилтан, ажил олгогч, тэтгэврийн үйлчилгээ үзүүлэгч хооронд гурвалсан харилцаа үүсэх ба энэхүү харилцаа нь тэтгэвэр бол хөдөлмөрийн нөхцөлийн нэг хэсэг гэдэг зарчимд суурилна. Үүнд:

- Ажил олгогч ба ажилтны хооронд байгуулах тэтгэврийн гэрээний харилцаа;
- Ажил олгогч болон тэтгэврийн даатгалын үйлчилгээ үзүүлэгч хооронд байгуулсан гэрээний үндсэн дээр үүсэх захиргаа гэрээний харилцаа;
- Дээрх захиргаа гэрээний үндсэн дээр үүсэх тэтгэврийн даатгалын үйлчилгээ үзүүлэгч болон ажилтан хоорондын харилцаа.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

332 Гадны орнуудын хувийн тэтгэврийн тогтолцоо – Нидерланд – Тэтгэврийн Ууган Сан (tus.mn)
333 KWPS - Pensions in the Netherlands.pdf

**Зураг 17. Тэтгэврийн гурвалжин**




*Эх сурвалж: KWPS - Pensions in the Netherlands.pdf*

**Хүснэгт 15. Нидерландын тэтгэврийн шимтгэлийн хувь хэмжээ**

| 21-67 насны ангилал | 4 хувийн хөнгөлтийн хувь дээр үндэслэсэн тэтгэврийн суурь (хувиар-%) | 3 хувийн хөнгөлөлтийн хувь дээр үндэслэсэн тэтгэврийн суурь (дундаж цалингийн 1,875%-ийн хуримтлал - хувиар-%) |
|---|---|---|
| **21-25** | 4.4 | 7.7 |
| **25-30** | 5.4 | 8.9 |
| **30-35** | 6.6 | 10.4 |
| **35-40** | 8.0 | 12.0 |
| **40-45** | 9.8 | 14.0 |
| **45-50** | 11.8 | 16.3 |
| **50-55** | 14.6 | 19.0 |
| **55-60** | 18.0 | 22.3 |
| **60-65** | 22.4 | 26.5 |
| **65-67** | 26.8 | 30.6 |

*Эх сурвалж: KWPS - Pensions in the Netherlands.pdf*

Тэтгэврийн сангийн засаглалын тухай хууль (Pension Fund Governance Act)- нь 2014 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн байна.

***Нидерландын тэтгэврийн тогтолцоонд тавих хяналт***

Нидерланд Улсад тэтгэврийн сан болон даатгалын байгууллагуудыг хянадаг хоёр байгууллага нь Нидерландын банк (Nederlandsche Bank), Санхүүгийн зах зээлийн газар (Dutch Authority for the Financial Markets) юм[334]. Тэтгэврийн тухай хууль (Pensions Act) болон Санхүүгийн хяналтын тухай хууль (Financial Supervision Act)-ийн дагуу Нидерландын банк нь тэтгэвэр авагчдын санхүү болон удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавьдаг. Санхүүгийн зах зээлийн газар нь дээрх хуульд заасны дагуу тэтгэвэр авагч, оролцогч талуудад тодорхой мэдээлэл өгөх үүрэгтэй. Энэхүү газар нь тэтгэвэр авагчид шаардлага хангаж байгаа эсэх, үүргээ хэрхэн биелүүлж байгааг хянадаг ба шаардлагатай тохиолдолд хөрөнгө оруулалтын талаар зөвлөгөө өгдөг байна.

***Тэтгэвэр өвлүүлэх***

Тус улсад тэтгэвэр авагч тухайн хүн нас барахад “Үндэсний амьд үлдсэн хүний тэтгэмжийн тухай хууль” (National Survivor Benefits Act)-ийн дагуу үр хүүхэд, гэр бүл, хамтран амьдрагчид тэтгэврийн тодорхой хэсгийг өвлүүлэн үлдээдэг байна. Энэ нь хамтрагч буюу эцэг эх нь нас барсан тохиолдолд санхүүгийн үр дагавараас урьдчилан сэргийлэх үндэсний даатгалын тогтолцоо юм. Нас барсан өдрөө даатгуулсан тохиолдолд тэтгэмж авах эрх үүснэ. Энэ хуулийн дагуу Нидерландад ажиллаж, орлогын албан татвар төлдөг, амьдардаг болон амьдардаггүй

[334] https://www-pensioenfederatie-nl.translate.goog/website/the-dutch-pension-system-highlights-and-characteristics?_x_tr_sl=mn&_x_tr_tl=en&_x_tr_hl=mn&_x_tr_pto=nui

бүх иргэдийг оролцуулан даатгалд хамруулдаг байна. Хамтрагч нь  дараах тохиолдолд тэтгэмж авах эрх үүснэ. Үүнд:

- 1950-иад оноос өмнө төрсөн бол;
- 18-аас доош насны хүүхэдтэй, эсхүл жирэмсэн бол;
- Хөдөлмөрийн чадвараа 45 хувь алдсан бол.

Эцэг эхээ алдсан хүүхдийн мөнгийг асран хамгаалагчид, өнчин хүүхдийн тэтгэмжийг өөрт нь тус тус олгоно. Энэ хуульд гэрлэсэн болон хамтран амьдарч буй хосууд ижил эрхтэй байна. Хамтрагчид төлөх тэтгэмжийн хэмжээ нь тэдний орлогоос хамаарна. Тэтгэмж авахдаа тооцсон хөдөлмөрийн орлогын хэмжээ нь нийт хөдөлмөрийн орлогын доод хэмжээний 50%, түүнийг хассаны гуравны нэгийг нэмж тооцно. Хэрэв орлого нь сард тогтоосон дээд хэмжээнээс  өндөр байвал  дээрх хуулийн дагуу тэтгэмж авах эрх үүсэхгүй. Энэ  орлогын түвшин 1950 оноос өмнө төрсөн иргэдэд хамаатай байна.[335]

***Нидерландын тэтгэврийн тогтолцооны онцлог  шинж:***

- Нидерландын хуулиар тогтоосон тэтгэврийн тогтолцоо нь өндөр настнуудыг эдийн засгийн эрдсэл, ядуурлаас сэргийлэхээс гадна, нэмэлт орлого бий болгох боломжийг хувийн тэтгэврээр бүрдүүлсэн, хамгийн бага эрсдэлтэй улс болж чадсан.
- 2019 оны тэтгэврийн шинэчлэл нь  тэтгэвэр тогтоох насны өсөлтийг удаашруулсан. Тэтгэвэр тогтоолгох насыг 66 насыг 2020, 2021 онд өөрчлөөгүй, 2024 онд 67 нас болгон аажмаар нэмэгдүүлэх ба 2025 онд тэтгэвэр тогтоолгох насыг бага хурдаар  нэмэгдүүлэх чиглэлийг баримтлана.
- 2009-2019 оны хооронд санхүүгийн хямралын улмаас мэргэжлээс шалтгаалах тэтгэвэр авагчид орлогогүй болсон байна. Хөдөлмөр эрхлэлтийн хувийн  тэтгэврийн тогтолцоо нь хөрөнгө оруулалтын алдагдал, бага хүүтэй  холбоотой  тэтгэмжийг  царцаах, заримдаа бууруулах  арга хэмжээ авч байсан.
- Тэтгэврийн шинэчлэл нь Голландын Засгийн газар, нийгмийн түншүүдийн тэргүүлэх чиглэл хэвээр байна. 2008 оны санхүүгийн хямрал, түүхэндээ бага хүүтэй байсан тул тэтгэврийн эрхийг 10 жил царцаах, танах  зэргээр тэтгэврийн тогтолцооны хуулийн систем алдагдаж  байсан. 2019 оны 6 дугаар сараас эхлэн тэтгэврийн гэрээний зарчимд үр дүнтэй  шинэчлэл хийсэн алхам болсон гэж үздэг.[336]

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

[335] https://www.cbs.nl/en-gb/news/2010/20/fewer-and-fewer-survivor-benefits/national-survivor-benefits-act--anw--
[336] https://data.consilium.europa.eu/doc/document/ST-9145-2021-ADD-2/en/pdf

**АШИГЛАСАН МАТЕРИАЛ**


**Нидерланд**

- https://www.oecd.org/daf/fin/private-pensions/Pension-Funds-in-Figures-2020.pdf
- https://lead.style/n/JrUmuJAooIoYTsl7qqh6http://documents.worldbank.org/curated/en/750651468286290848/pdf/685260ESW0MONG0port0No-685260MN0Mon.pdf
- https://business.gov.nl/regulation/pension/?gclid=CjwKCAjwtfqKBhBoEiwAZuesiKodHG3dgmhr10dMxPrQloSRZUWZTd5OSlWAzFjha6OowcFRnBxDfBoC3ZwQAvD_BwE
- https://www.oecd.org/pensions/Pension-Funds-in-Figures-2020.pdf
- https://ec-europa-eu.translate.goog/employment_social/soc-prot/missoc98/english/01/nl.htm?_x_tr_sl=en&_x_tr_tl=mn&_x_tr_hl=mn&_x_tr_pto=nui
- https://www-expatica-com.nl/living/gov-law-admin/social-security-in-the-netherlands-100578/?_x_tr_sl=en&_x_tr_tl=mn&_x_tr_hl=mn&_x_tr_pto=nui
- Гадны орнуудын хувийн тэтгэврийн тогтолцоо – Нидерланд – Тэтгэврийн Ууган Сан (tus.mn)
- https://kwps.com/usr-uploads/files/brochures/KWPS%20-%20Pensions%20in%20the%20Netherlands.pdf
- http://repository.ufe.edu.mn:8080/xmlui/bitstream/handle/8524/2022/FA16b043%20B.Oyundelger%20diflom.pdf?sequence=1&isAllowed=y
- https://www.pensioenfederatie.nl/website/the-dutch-pension-system-highlights-and-characteristics
- https://www.tus.mn/wp-content/uploads/2020/11/Nederland-Tsuvral-20201117.pdf
- https://medium.com/@ganzorigganbat/%D1%82%D1%8D%D1%82%D0%B3%D1%8D%D0%B2%D1%80%D0%B8%D0%B9%D0%BD-%D1%82%D1%83%D1%85%D0%B9-d7873feb8e92
- https://www-pensioenfederatie-nl.translate.goog/website/pension-fund-governance?_x_tr_sl=mn&_x_tr_tl=en&_x_tr_hl=mn&_x_tr_pto=nui
- https://www.cbs.nl/en-gb/news/2010/20/fewer-and-fewer-survivor-benefits/national-survivor-benefits-act--anw--
- https://data.consilium.europa.eu/doc/document/ST-9145-2021-ADD-2/en/pdf

**Сингапур**

- https://www.enpf.kz/ru/pension-system/world/singapore.php
- https://www.cpf.gov.sg/Members/AboutUs/about-us-info/cpf-overview

**Казахстан**

- https://www.enpf.kz/ru/

**Норвеги**

- Гадаадын зарим орны уул уурхайн баялгийн сангийн зохицуулалт, туршлага СТ- 15/429
- Эх үүсвэр нь уул уурхайн орлогоос бүрддэг баялгийн сангуудын зарчим, үйл ажиллагаа СТ-09/215
- Гадаадын зарим орны тэтгэврийн сангийн тогтолцоо, сангийн нөөц хөрөнгийн удирдлага, хөрөнгө оруулалтад ашиглах боломжийн талаарх туршлага, эрх зүйн зохицуулалт СТ- 16/219
- Хууль зүйн үндэсний хүрээлэн Уурхайгаас олох эх үүсвэр бүхий тусгай сангийн эрх зүйн зохицуулалт” бодлогын судалгаа 2013 http://nli.gov.mn/pdf/uul_uurhain_orlogo_buhii.pdf
- Дэлхийн банк “Уур уурхай ба оюун ухаан” эдийн засгийн хөгжлийн загварын тойм судалгаа, 2020 оны 9 дүгээр сар http://documents1.worldbank.org/curated/en/732411600370860178/pdf/Mines-and-Minds-Leveraging-Natural-Wealth-to-Invest-in-People-and-Institutions.pdf
- Сангийн яам Баялаг ба боломжийг удирдах нь: уул уурхайн орлого, баялгийн сан https://app.greensoft.mn/uploads/users/1277/files/P-1%20Zorigtbat.pdf
- Азийн хөгжлийн банк – Монгол Улсын эрдэс баялгийн орлогын менежментийг сайжруулах нь ,2019 он https://www.adb.org/sites/default/files/publication/520536/management-natural-resource-revenues-mongolia.pdf
- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам “Баялгийн сан,баялгийн үр ашгийг иргэдэд хүртээх” дэд сайд Д.Загджав 2019 https://cabinet.gov.mn/wp-content/uploads/uul-uurhai.pdf


UIH.MN СУДАЛГААНЫ САН

- Mongolian mining journal Монгол баялгийг удирдах хуулийн нууц төсөл http://www.mongolianminingjournal.com/a/71261
- Инвестопедиа. (2020 он). *Норвегийн засгийн газрын тэтгэврийн сан.* https://www.investopedia.com/terms/g/government-pension-fund-norway.asp
- Норджес банк, Хөрөнгө оруулалтын менежмент. (2021 он). *Сангийн тухай.* https://www.nbim.no/en/the-fund/about-the-fund/
- Байгалийн нөөцийн засаглалын хүрээлэн., Колумбын их сургуулийн Тогтвортой хөрөнгө оруулалтын Колумбын төв. (2013 он). *Норвегийн Засгийн газрын тэтгэврийн сан глобал.* https://resourcegovernance.org/sites/default/files/NRF_Norway_July2013.pdf
- Норджес банк, Хөрөнгө оруулалтын менежмент. (2021 он). *Хөрөнгө оруулалтын стратеги.*https://www.nbim.no/en/the-fund/how-we-invest/investment-strategy/
- Харвардын Их Сургуулийн Харвард Кеннедийн сургуулийн Шинжлэх ухаан ба олон улсын харилцааны Белфер төв. (2015 он). *Үндэснийн Их Сургуулийн Харвард Кеннедийн сургуулийн Шинжлэх ухаан ба олон улсын харилцааны Белфер төв.* https://www.belfercenter.org/sites/default/files/legacy/files/FundProfiles.pdf
- Засгийн газрын тэтгэврийн сан-Government Pension Fund of Norway http://en.wikipedia.org/wiki/The_Government_Pension_Fund_of_Norway

**Чили**

- Fiscal Responsibility Law, https://www.bcn.cl/leychile/navegar?idLey=20128
- Ministerio de Hacienda, https://hacienda.cl
- Natural Resource Funds, Chile, The Pension Reserve Fund and the Economic and Social Stabilization Fund, http://ccsi.columbia.edu/files/2014/04/nrf_Chile_August2013_RWI_VCC.pdf
- https://www.investopedia.com/terms/p/passiveinvesting.asp
- Судалгааны эмхтгэл.3 боть, **"**Эх үүсвэр нь уул уурхайн орлогоос бүрддэг баялгийн сангуудын зарчим, үйл ажиллагаа" харьцуулсан судалгаа
- Судалгааны эмхтгэл. 22 боть, "Гадаадын зарим орны уул уурхайн баялгийн сангийн зохицуулалт, туршлага" харьцуулсан судалгаа.
- Судалгааны эмхтгэл. 23 боть, "Гадаадын зарим орны тэтгэврийн сангийн тогтолцоо, сангийн нөөц хөрөнгийн удирдлага, хөрөнгө оруулалтад ашиглах боломжийн талаарх туршлага, эрх зүйн зохицуулалт" харьцуулсан судалгаа.
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хуримтлалын нэгдсэн сангийн танилцуулга. 2021.
- Хууль зүйн үндэсний хүрээлэн. Бодлогын судалгаа. 2013. Уул уурхайгаас олох эх үүсвэр бүхий тусгай сангийн эрх зүйн зохицуулалт. https://nli.gov.mn/pdf/uul_uurhain_orlogo_buhii.pdf
- Нэг хүнд ногдох ДНБ ба сангийн хуримтлалын тухай. http://www.iltod.gov.mn/?p=382.


UIH.MN
СУДАЛГААНЫ САН

# НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

*Г.Алтан-оч (Ph.D)*

## АГУУЛГА

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ

Нэг. АНУ

1. Техас муж улсын Нийтийн мэдээллийн тухай хууль
2. АНУ-ын Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль

Хоёр. ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН СОРИЛТУУД

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

ХАВСРАЛТ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

## УДИРТГАЛ

Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэний мэдээлэл авах эрхийг хангах зорилгоор Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг Улсын Их Хурлаас 2011 оны 6 дугаар сарын 16-ны өдөр баталсан.

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиар төрийн байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөцийн мэдээллийг ил тод байлгах асуудлыг, Шилэн дансны тухай хуулиар төрийн байгууллагуудын төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах, тэдгээртэй холбоотой мэдээллийг ил тод, нээлттэй байх харилцааг зохицуулдаг байна.

Өмнөх парламентын бүрэн эрхийн хугацаанд хэлэлцэж амжаагүй үлдсэн, дахин өргөн мэдүүлж буй Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хуулийн нэрийг Нийтийн мэдээллийн тухай гэж өөрчлөн боловсруулсан байна.

Судалгаанд Герман, Казахстан, Эстони, АНУ, Техас муж улсын эрх зүйн орчны талаар судалж, мөн ХБНГУ-ын жишээн дээр тухайн хуулийн хэрэгжилтийн сорилтууд, тулгарч буй хүндрэл бэрхшээлийн талаар судаллаа.

***<u>Түлхүүр үг:</u>*** *нийтийн мэдээлэл, мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрх, мэдээллийн эрх чөлөө, төрийн мэдээлэл, мэдээлэлд хандах эрх, public information*

## СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Энэхүү судалгаанд Герман, Казахстан, Эстони, АНУ зэрэг улсуудын туршлагыг судлав. Судалгаанд эдгээр улсуудын ижил төрлийн хуулийг авч үзсэн бөгөөд тухайн хуулийн зохицуулах харилцаа, бүтэц, хамрах хүрээний талаар судалсан болно. Хуулийн оноосон нэр нь “Мэдээллийн эрх чөлөө”, “Мэдээлэл авах эрх”, “Нийтийн (төрийн) мэдээлэл” зэрэг олон янз байна. Дээрх улсуудын туршлагыг тоймлон авч үзвэл:

<u>*Хуулийн зохицуулах харилцаа*</u>.

**ХБНГУ-ын Мэдээллийн эрх чөлөөний (Төрийн мэдээлэлд хандахыг зохицуулах) тухай** хуулиар иргэнд Холбооны Улсын яам, төрийн байгууллага болон Холбооны Улсын бусад байгууллагуудын албан ёсны мэдээлэлд хандах эрх олгож, мэдээлэл авах харилцааг зохицуулдаг байна.

**Казахстан Улсын Мэдээлэл авах эрхийн тухай** хууль нь хүн бүр хуулиар хориглоогүй аливаа хэлбэрээр мэдээллийг чөлөөтэй авах, түгээх зэрэг Үндсэн хуулиар олгосон эрхээ хэрэгжүүлэхэд холбогдох харилцааг зохицуулдаг.

**Эстони Улсын Нийтийн мэдээллийн тухай** хуулиар ардчилсан нийгмийн засаглал болон нээлттэй нийгмийн зарчмыг үндэс сууриа болгон төрийн мэдээлэл олон нийтэд нээлттэй байх боломжийг хангах, хүн бүр олон нийтэд нээлттэй мэдээллийг ашиглах, түүнчлэн олон нийтийг мэдээллээр хангах үүргийн хэрэгжилтийг хянах боломж бүрдүүлэх харилцааг зохицуулдаг байна.

**АНУ-ын Нийтийн мэдээллийн/Мэдээллийн эрх чөлөөний тухай** хууль нь иргэн төрийн мэдээлэлтэй танилцах буюу түүнийг хуулбарлан авах харилцааг зохицуулдаг байна. Мөн төрийн байгууллага нь мэдээллийг нийтэд ил тод болгохоос татгалзаж болох зарим хязгаарлалтын талаар тусгажээ.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

*Зохицуулалтын хамрах хүрээ*

**Герман.** Мэдээллийн эрх чөлөө нь зөвхөн эцэслэн батлагдсан бичиг баримтад хамаатай бөгөөд төлөвлөлтийн шатанд байгаа бичиг баримтын төсөлд хандах эрх олгохгүй. Мөн хувийн болон байгууллагын мэдээлэл уг эрхэд багтахгүй. Мэдээлэл авахаар хүсэлт гаргагчийн уг мэдээлэлтэй холбогдох ашиг сонирхол нь тухайн хүний хувийн нууц хамгаалалтын ашиг сонирхлоос давсан, эсхүл хувь хүн өөрөө зөвшөөрсөн бол хувийн мэдээлэлд хандах эрх олгоно. Гэхдээ хувийн хэрэг болон хувийн хэргийн систем доторх агуулгад хандаж мэдээлэл авах эрхгүй байна. (*Мэдээллийн эрх чөлөө нь Үндсэн хуульд тусгасан “үгээ хэлэх эрх чөлөөтэй” холбоогүй бөгөөд “мэдээлэлд хандах”, “ил тод байдал”, “акттай танилцах” зэрэг утгаар хэрэглэгдэнэ.)*

**Казахстан.** Хуулиар нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад мэдээллийг авахтай холбогдох харилцааг зохицуулна. Захиргаа, Иргэн, Эрүүгийн хэргийн хуульд заасан хувь хүн болон хуулийн этгээдийн гаргасан өргөдөл, Архивын хуульд заасан хүсэлт хянан үзэх журам, мөн Хэвлэл мэдээллийн хуульд заасан хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл түгээх журам зэрэгт хамааралгүй байна.

**Эстони.** Хууль нь мэдээллийг авах, дахин хэрэглэх нөхцөл, журам, арга; мэдээлэл өгөхөөс татгалзах; зарим хязгаарлагдмал мэдээллийг авах журам; мэдээллийн санг бүрдүүлэх, удирдан зохион байгуулах, хянах; мэдээллийн хүртээмж, түүнд төрөөс тавих хяналт зэрэг асуудлыг хамаарна. Төрийн нууцын зэрэглэлтэй буюу гадаадын мэдээлэл, хуулиар хязгаарласан засаг захиргааны архивын мэдээ, баримт, мэдээллийг судалж дүн шинжилгээ хийх, нэмэлт мэдээлэл цуглуулах, баримтжуулах тохиолдол, олон улсын гэрээ, эсхүл тусгай хуулиар зохицуулсан хязгаарлагдмал болон тусгай нөхцөл бүхий мэдээлэлд хамааралгүй болно.

**АНУ.** Хуулийн дагуу төрийн байгууллага нь шаардсан мэдээллийг гаргаж өгөх ерөнхий зарчимтай байдаг байна. Гэхдээ төрийн байгууллага нь уг хуулийн хүрээнд тухайн мэдээллийг ил тод болгох асуудлыг тодруулах шаардлагатай гэж үзвэл Ерөнхий прокурорын газарт хандах ба түүний зөвшөөрлийг үндэслэн хүсэлт гаргагчид мэдээллийг гаргаж өгөх буюу татгалзах эсэхийг шийддэг байна. Төрийн байгууллага нь бүх хүсэлтийг адил тэгш авч үзэх, мөн шаардсан мэдээллийг түргэн шуурхай гаргаж өгөх үүрэг хүлээдэг байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

## СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

### Нэг. АНУ

### 1. Техас муж улсын Нийтийн мэдээллийн тухай хууль

АНУ-ын Техас муж улсад Нийтийн мэдээллийн тухай хуулиар[337] иргэн засгийн газрын (төрийн) бичлэгтэй (мэдээлэлтэй) танилцах[338] буюу хуулбарлан авах харилцааг зохицуулдаг байна. Мөн төрийн байгууллага нь зарим тохиолдолд төрийн мэдээллийг нийтэд ил тод болгохоос татгалзаж болох талаар тусгасан байна. Нийтийн мэдээллийн хууль нь Муж улсын Засгийн газрын тухай хууль дотроо бүлэг байдалтай багтсан байна.

Уг хуулийн дагуу төрийн байгууллага нь шаардсан мэдээллийг гаргаж өгөх ерөнхий зарчим баримталдаг байна. Гэхдээ төрийн байгууллага нь уг хуулийн хүрээнд тухайн мэдээллийг ил болгох эсэхийг тодруулах шаардлагатай гэж үзвэл Мужийн Ерөнхий прокурорын газрын дэргэдэх Нээлттэй мэдээллийн хэлтэс[339] (НМХ)-т хандаж мэдээлэл авах хүсэлт, холбогдох мэдээллийг аль алийг нь хянуулж нягталдаг байна. НМХ нь хүсэлт гаргагчид холбогдох мэдээллийг гаргаж өгөх буюу татгалзах талаар тухайн төрийн байгууллагад зөвшөөрөл олгодог.

Төрийн байгууллага нь бүх хүсэлтийг адил тэгш авч үзэх үүрэг хүлээдэг байна. Мөн төрийн байгууллага нь журмын дагуу Ерөнхий прокурорын газарт (ЕПГ) хүсэлтийг уламжилсан талаар хүсэлт гаргагчид мэдэгдэх үүрэгтэй байна. Төрийн байгууллага нь түүнчлэн шаардсан мэдээллийг түргэн шуурхай гаргаж өгөх үүрэгтэй байна. Хэрэв төрийн байгууллага нь уг хуулийн дагуу хэрэгжилтийг хангахгүй бол ЕПГ хүсэлт гаргагчид тусалж, дэмжлэг үзүүлнэ.

Журмаар хүлээгдэж буй хүсэлтийн талаар аливаа сонирхогч тал санал, мэдэгдэл гаргаж болно. Санал, мэдэгдлийг АНУ-ын шуудан, буухиа шуудан буюу НМХ-ийн цахим баримтын системээр дамжуулан НМХ-т бичгээр гаргана.

Зарим нийтийн мэдээлэл нууцын зэрэглэлтэй байдаг байна. Хэрэв мэдээлэл нууцад хамаарах бол уг хуулийн дагуу төрийн байгууллага нь хүссэн мэдээллийг гаргаж өгөхгүй байх ерөнхий зарчимтай. Зарим тохиолдолд төрийн байгууллага нь нууцад хамаарахгүй мэдээллийг ч гаргаж өгөхөөс татгалзах эрхтэй байна.

***Хуулийн бүтэц[340]***

Техасын Нийтийн мэдээллийн тухай хууль

Засгийн газрын тухай хуулийн 552 дугаар бүлэг. Нийтийн мэдээлэл

Дэд бүлэг A. Нийтлэг зүйл

Дэд бүлэг B. Нийтийн мэдээлэлд хандах эрх

Дэд бүлэг C. Ил тод болгохоос татгалзах мэдээлэл

Дэд бүлэг D. Нийтийн мэдээллийн ажилтан

Дэд бүлэг E. Хандалтад холбогдох журам

Дэд бүлэг F. Нийтийн мэдээллийг хуулбарлах төлбөр

Дэд бүлэг G. Ерөнхий прокурорын шийдвэр

Дэд бүлэг H. Иргэний эрх зүйг сахиулах

UIH.MN СУДАЛГААНЫ САН

---

[337] Нийтийн мэдээллийн тухай хуулийн танилцуулга-Overview of the Public Information Act-*англиар* https://www.texasattorneygeneral.gov/open-government/members-public/overview-public-information-act

[338] inspect

[339] Open Records Division (ORD)

[340] Нийтийн мэдээллийн тухай хуулийн гарын авлага 2020-PUBLIC INFORMATION ACT Handbook 2020 https://www.texasattorneygeneral.gov/sites/default/files/files/divisions/open-government/publicinfo_hb.pdf

Дэд бүлэг I. Эрүүгийн гэмт хэрэг

Дэд бүлэг J. Гэрээний мэдээлэлд холбогдох зохицуулалт

Энэ хуулиас гадна Техасын Захиргааны тухай хуулийн 1 дүгээр ботийн 63 дугаар бүлэг. Ерөнхий прокурорын нийтэд зарлах[341] журмыг мөн мөрдүүлнэ.

**2. АНУ-ын Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль**

Холбооны Улсын Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль (МЭЧТХ)[342] нь Нэгдсэн Улсын 5 дахь хуулийн 552 дугаар бүлэг буюу Засгийн газрын бүтэц, зохион байгуулалт болон албан хаагчийн тухай (5 U.S.C. § 552) хуулийн бүтцэд багтсан холбооны хууль юм. Хуулийн бусад хоч нэр[343] гэвэл “Нийтийн мэдээллийн тухай хууль 1966”[344], “Нийтийн мэдээллийн хүртээмжийн тухай хууль”[345] зэрэг болно. Уг холбооны хууль нь Нэгдсэн Улсын Засгийн газраас өмнө нь нийтлээгүй болон түүний хяналтанд байгаа мэдээлэл, баримтыг хүсэлт гаргасны үндсэн дээр бүрэн эсвэл хэсэгчлэн ил тод болгох харилцааг зохицуулдаг байна. Хуулиар төрийн байгууллагын ил тод болговол зохих бичлэгийг (мэдээллийг) тодорхойлж, ил тод болгох ажилбарын (процедурын) албан журмыг тоймлож, мөн Үндсэн хуулиас хэлтрүүлэх[346] 9 зүйлийг тодорхойлсон байна. Уг хуулийн зорилго нь Нэгдсэн Улсын төрийн байгууллагуудын үйл ажиллагааг илүү ил тод болгосноор АНУ-ын иргэд Засгийн газрын үйл ажиллагаан дахь асуудал, алдаа дутагдлыг илүү хялбар илрүүлж, улмаар парламент, төрийн албан хаагчид болон улсын ерөнхийлөгчийн сонорт хүргэж, шийдвэр гаргахад шахалт үзүүлэхэд оршино.

Уг АНУ-ын Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулиас гадна муж улс бүр өөрийн мэдээллийн эрх чөлөөний хуультай байдаг байна.

Хуулийн хамрах хүрээ нь зөвхөн гүйцэтгэх засаглалын төрийн байгууллагаар хязгаарлагдана. Эдгээр байгууллагууд нь баримт бичгийг нийтэд ил тод болгох үүрэг хүлээдэг байна. Хэрэв ямар нэгэн байдлаар өргөдөл, гомдлын ажилбарт саад тотгор учруулбал торгууль шийтгэл хүлээдэг байна. Түүнээс гадна төрийн байгууллага мэдээлэл гаргаж өгөхгүй бол шүүхэд хандаж гаргуулах боломж бас бий. Гэвч гүйцэтгэх байгууллагаас ил тод болгохгүй байх үндэсний батлан хамгаалах буюу гадаад бодлогын хүрээнд нууцалбал зохих, “худалдааны нууц”, “хүний хувийн нууц” зэрэг 9 хэлтрүүлэлт бий. Эдгээр 9 хэлтрүүлэлт нь эмзэг болон хувь хүний эрх чөлөөтэй холбогдох баримт мэдээлэл байдаг байна. Үүнд:

1. (а) үндэсний батлан хамгаалах болон гадаад бодлогын ашиг сонирхлын үүднээс нууц байхаар гүйцэтгэх тушаалаар батлагдаж тусгайлан зөвшөөрсөн болон (б) гүйцэтгэх тушаалаар тодорхойлсон;
2. Төрийн байгууллагын дотоод ажилтны журам, практиктай дагнан холбогдох;
3. Үндсэн хуулиар ил тод болгохоос тусгайлан хэлтрүүлсэн;
4. Худалдааны нууц, хувь хүнээс олж авсан, давуу эрхтэй буюу нууцын зэрэгтэй арилжааны буюу санхүүгийн мэдээлэл;
5. Гуравдагч этгээдэд үл хамаарах байгууллага хоорондын буюу байгууллагын дотоод санамж бичиг буюу захидал;
6. Хүний хувийн буюу эрүүл мэндийн файл, үндсэн хуулиар тогтоосон хувийн нууцтай холбогдох ижил төстэй файл;
7. Хууль сахиулах зорилгоор хийсэн бичлэг буюу мэдээлэл

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[341] promulgation
[342] Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль-Freedom of Information Act (FOIA) https://en.wikipedia.org/wiki/Freedom_of_Information_Act_(United_States)
[343] nickname
[344] Public Information Act of 1966
[345] Public Information Availability
[346] exemptions

8. Санхүүгийн байгууллагын зохицуулах буюу хянан шалгах чиг үүргийн хүрээнд хийсэн хяналт шалгалт, үйл ажиллагаа буюу нөхцөл байдлын тайланг агуулсан буюу түүнтэй холбогдох;
9. Геологийн болон гео физикийн мэдээлэл болон өгөгдөл, худаг, булаг шанд бүхий газрын зураг

Шууданг өөрчлөн зохион байгуулах тухай 1970 оны хуулиар арилжааны зориулалттай мэдээлэл, худалдааны нууцыг USPS (Нэгдсэн Улсын Шуудангийн Алба) нь нийтэд ил тод болгохыг хориглосон байдаг байна.***Тус хуулийн түүхээс...***

- 1966 онд 89 дүгээр конгресс анх баталсан.
- 1974 онд Хүний хувийн нууцын хуулийн нэмэлт, өөрчлөлт
- 1976 онд Засгийн газрын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт (7 хэлтрүүлэлт)
- 1982 онд МЭЧТХ-д ерөнхийлөгч Рейганы гүйцэтгэх тушаал (зарлиг)-аар хийсэн хязгаарлалт
- 1986 онд хар тамхитай тэмцэх тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт
- 1995-99 онд ерөнхийлөгч Клинтений зарлигаар хийсэн өргөтгөл
- 1996 онд Мэдээллийн цахим өрх чөлөөний тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт
- 2001 онд МЭЧТХ-д ерөнхийлөгч Жорж В. Бушийн гүйцэтгэх тушаал (зарлиг)-аар хийсэн хязгаарлалт
- 2002 онд Тагнуулын байгууллагын эрх зүйн тухай хууль
- 2007 онд Нээлттэй засгийн газрын тухай хууль
- 2009 онд Гүйцэтгэх тушаалаар (зарлигаар) хийсэн үндэсний аюулгүй байдалтай холбогдох мэдээллийн нэмэлт, өөрчлөлт
- 2010 онд Wall Street шинэчлэлийн хүрээнд хийсэн МЭЧТХ-ийн нэмэлт, өөрчлөлт

***Хуулийн бүтэц:***

МЭЧТХ-ийг сайжруулсан тухай 2016 оны хууль.[347]

552 дугаар зүйл. Нийтийн мэдээлэл; төрийн байгууллагын дотоод журам, санал мэдэгдэл, шийдвэр, бичлэг болон эмхэтгэл

(а) төрийн байгууллагын нийтэд ил тод байлгах мэдээллийн жагсаалт;

(б) ил тод болгохоос хэлтрүүлэх зүйлийн жагсаалт;

(в) хүсэлт гаргасны үндсэн дээр хандах боломжтой бичлэгүүд;

(г) гаргаж өгөхөөс татгалзах мэдээлэл буюу бичлэгийн нийтийн хандалтыг хязгаарлахыг хориглох хэлтрүүлэлтийн жагсаалт;

(д) төрийн байгууллага нь жил бүрийн 2-р сарын 01-нээс өмнө АНУ-ын Ерөнхий прокурор болон Төрийн мэдээллийн албаны гүйцэтгэх захирал нарт тайлагнах;

(е) төрийн байгууллагын дарга олон нийт шалгахад зориулан цахим хэлбэрээр мэдээллийг бэлдэж, хандах боломж олгох;

(ё) Үндэсний архив болон бичлэгийн захиргааны дэргэд Төрийн мэдээллийн албыг байгуулах. Албаны дарга нь Төрийн мэдээллийн албаны гүйцэтгэх захирал байх;

(ж) Төрийн хянан шалгах алба нь захиргааны байгууллагуудад аудитын шалгалт хийж, тайлан гаргах;

(з) төрийн байгууллага бүр МЭЧТХ-ийн Захиралтай байна. Захирал нь удирдах дээд түвшний албан тушаалтан (туслах нарийн бичгийн дарга болон түүнтэй адил) байх;

(и) МЭЧТХ-ийн захирлуудын зөвлөл нэртэй гүйцэтгэх байгуулах;

[347] Full Text of the FOIA Improvement Act of 2016 (Public Law No. 114-185) https://www.foia.gov/foia-statute.html

UIH.MN СУДАЛГААНЫ САН

(й) МЭЧТХ-ийн Олон нийтийн төлөөлөгч нь МЭЧТХ-ийн захиралд тайлагнах;

(к) Удирдлага, төсвийн албаны захирал нь Ерөнхий прокурортой зөвшилцсөний үндсэн дээр нэг вэбсайтаас бүх төрийн байгууллага руу хандах боломж бүхий онлайн санал хүсэлтийн порталын үйл ажиллагааг хариуцан ажиллуулах;

## Хоёр. ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН СОРИЛТУУД

Германы “Төрийн мэдээлэлд хандахыг зохицуулах тухай хууль” буюу мэдээллийн эрх чөлөөний хуулийн жишээн дээр уг хуулийн амьдралд хэрэгжсэн байдал, тулгарч буй хүндрэл бэрхшээлийн талаар судалсныг тоймлон хүргэе.[348]

*Мэдээллийн эрх чөлөөний хууль 2006 оноос хойш хэрэгжиж байна*

Германы иргэн бүр учир шалтгаанаа илэрхийлэхгүйгээр төрийн мэдээлэлд хандаж, авах эрхээр хангагдсан байдаг аж. Хүчин төгөлдөр мөрдөгдөөд 15 жил болж буй мэдээллийн эрх чөлөөний хууль (МЭЧХ) үүнд үйлчилдэг байна. Хэрэв төрийн байгууллага мэдээллийг гаргаж өгөхөөс цааргалбал шүүхийн тусламжтай хэрэгжүүлэх боломж бүрдэнэ.

“AlgorithmWatch” судалгаа, лоббигийн төрийн бус байгууллагын програм хангамжийн ажилтан Ё.Филтэрийн үзэж байгаагаар, Мэдээлэл чөлөөтэй (нээлттэй) байх ёстой. Хэнд ч хохирол учруулахгүй мэдээлэл нийтэд ил тод байснаар энэ ертөнц илүү сайхан болно. Энэ хууль байдаг талаар маш олон хүн мэддэггүй. Тиймээс хуулийг мэдэх болон ашиглах талаар олон нийтэд сурталчлах ажлыг сайн хийх хэрэгтэй байна.

Уг хууль нь Холбооны Улсын түвшинд 2006 оноос хойш хэрэгжиж байна. Зарим муж улсад тухайлбал, анхны мэдээллийн эрх чөлөөний хуультай болсон муж улс бол Бранденбург. Энд БНАГУ-ын үеийн Аюулаас хамгаалах байгууллагын холбогдолтой архивын баримт бичигтэй танилцах эрхийг Үндсэн хуулиндаа тусгаж өгсөн.

*Германд албаны нууц уламжлал болсон*

Өгөгдөл хамгаалалт, мэдээллийн эрх чөлөөний төрийн төлөөлөгч (парламент дахь албан тушаал)-өөр 2003-2013 онд ажилласан П.Шаар “Иргэний нийгмийн зүгээс энэ нь анх гарсан. 1980-аад онд нийтийн захиргааны албанд акттай танилцах эрхийг хөхиүлэн дэмжиж эхэлсэн. Үүнд 70-аад оны америкийн туршлага шууд нөлөөлсөн. Тэгээд герман маягийн мэдээллийн эрх чөлөөний хуультай болъё гэдэг хүсэл зоригоо олон хүн илэрхийлэх болсон.

Улаан-ногоон хамтарсан засгийн газар байгуулах тухай 1998 оны гэрээнд мэдээллийн эрх чөлөөний хуультай болохоор тусгагдсан боловч олон жилийн дараа хоёр дахь улаан-ногоон эвслийн бүрэн эрхийн хугацаанд хэрэгжсэн юм.

Ингэж цаг хугацаа их алдсаны шалтгаан нь Германд он удаан жил уламжлал болон тогтсон “албаны нууц” хэмээх ойлголт байлаа. Төрийн мэдээллийг авах гэсэн хэн нэгэн яагаад, ямар зорилгоор мэдээлэл авах гэж буй хүсэлтээ маш дэлгэрэнгүй илэрхийлэх үүрэгтэй байсан байна. Тэгвэл мэдээллийн эрх чөлөөний хуулиар байдал эсрэгээрээ эргэж, иргэн, төр хоёрын хоорондын харилцаа бүр мөсөн өөрчлөгдсөн.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

*Иргэд акттай танилцах хүсэлтээ гаргана*

Энэхүү эсрэгцлийн үр дүнд иргэн бүр учир шалтгаанаа хэлэлгүйгээр холбооны төрийн захиргаа болон улс, орон нутгийн засаг захиргааны байгууллагад акттай танилцах хүсэлт гаргах эрхтэй болсон. П.Шаарын хэлснээр, энэ хуулийг мэдэж, ашиглаж байгаа байдал бусад

[348] П.Фийбиг “Хэрхэн канцлерын зочны жагсаалтанд хүрэх вэ”-P.Fiebig “Wie man an die Gästeliste des Kanzleramts kommt”-*германаар* https://www.deutschlandfunk.de/15-jahre-informationsfreiheitsgesetz-wie-man-an-die.724.de.html?dram:article_id=495773

улстай, ялангуяа өнө удаан жил уламжлал болон хэвшсэн Скандинавын орнуудтай харьцуулахад муу байна.

Мөн захиргаанд ажиллаж байгаа оролцогч талууд өөрөөр сэтгэх хэрэгтэй байна: олон зуун жил тогтсон байгууллагын соёл, иргэнд нээлттэй биш хандах хандлага, мэдээллийг нууцлах байдлын уламжлал арилаагүй байна. Тиймээс ч акттай танилцах эрхээ шүүхийн шийдвэрийн дагуу их хүчин чармайлт гаргасны үндсэн дээр хэрэгжүүлж байгаа тохиолдол элбэг байна.

*МЭЧХ-ийг хэрэглэснээр ил тод байдал бий болно*

Ё.Филтэр хэлсэнчлэн, хэрэв би асуумж тавиагүйсэн бол энэ бүхэн элсэнд шингээд алга болох байсан. Ийнхүү МЭЧХ-ийг хэрэглэснээр ил тод байдал бий болох боломжтойг асуумж тойрсон элдэв түүх бэлхнээ харуулж байна.

*Юуг “албан мэдээлэл” гэж үзэх вэ?*

Хууль хэрэгжиж эхэлсэн эхэн үед ойлголтуудыг цэгцлэх явдал чухал байлаа. Жишээ нь, өгч болох “албан мэдээлэл” гэж чухам юу вэ? Төрийн канцлерын цагийн хуваарийн цаглавар “албан мэдээлэл” мөн үү? Уригдсан зочны жагсаалт хамаарах эсэх? Ер нь хэн мэдээлэл гаргаж өгөх вэ? Холбооны төрийн прокурорын газар МЭЧХ-ийн хувьд “төрийн захиргааны төв байгууллага” мөн эсэх? Мөн гэдгийг нь Захиргааны хэргийн шүүх болон хожим нь Захиргааны хэргийн дээд шүүхээс тогтоосон.

Ё.Акерманн төрсөн өдрийн цайллагандаа урьсан хүмүүсийн жагсаалтыг (үүнд нь канцлер багтсан байсан) ил тод болгох шаардлагатай болсон. Гэтэл канцлерын цагийн хуваарийн цаглавар “албан мэдээлэл” мөн боловч аюулгүй байдлын үүднээс нууц байх ёстой байна.

*Төрийн байгууллага актыг дэлгэхээс үндэслэлтэйгээр татгалзана*

Сүүлийн үед Берлиний Захиргааны хэргийн шүүх дээр хэлэлцэж байгаа асуудлын агуулга өөрчлөгдөөд байна. Захиргаа хэзээ актыг дэлгэхээс татгалзаж болох эсэх асуудал улам ихээр орж ирэх боллоо.

Зарчмын хувьд мэдээллийг гаргаж өгөх, эсвэл бүр олгож болохгүй тухай шийдвэр гаргах ямар шалтгаан байгааг тогтоох асуудал шүүхүүдийн буюу дээрх шүүхийн хэлэлцдэг хоёр дахь том асуудал болоод байна.

МЭЧХ-д тиймээс жишээлбэл, нийтийн хариуцлагад татахаас тусгайлан хамгаалах, төрийн байгууллагын шийдвэр гаргах явц, хувь хүнтэй холбоотой өгөгдлийг хамгаалах болон байгууллагын нууцыг хамгаалах талаар туссан байдаг байна.

*“Төрөөс асуу” тавцан: Асуумж тавьж, нийтэлнэ*

FragDenStaat (Төрөөс асуу) санаачлагыг 2011 оноос хойш хэрэгжүүлж байна. Үүсгэн байгуулагч А.Сэмсротын тайлбарласнаар, Интернэт хуудсаар дамжуулан янз бүрийн төрийн байгууллагад хандан мэдээллийн асуумж тавьж болох юм: “Дээрх онлайн-тавцангийн анхны зорилго бол Германы бүх төрийн байгууллагад хурдан шуурхай асуумж илгээж, эдгээр асуумж нь гол нь бүх хүнд ил тод нээлттэй байх явдал юм. Учир нь миний асуухыг хүссэн зүйлийг хэн нэгэн өмнө нь асуусан байвал би шинээр асуумж илгээх шаардлагагүй болно.”

Жилээс жилд асуумж илгээх иргэдийн тоо нэмэгдэж одоогийн байдлаар 18 000 гаруй асуумжийг уг тавцан бүртгэж аваад байна. “Асуумжийг судлаад үзэхэд, ямар үнэтэй, манай дэргэд юу бариад байна, шинэ зам, шинэ усан сангаас авахуулаад Европын холбооны комисс буюу Дотоод хэргийн яамнаас гаргасан төлөвлөгөө болон магадлан авах хүртэл үнэндээ бүх зүйл багтсан байна. Ихэнх нь хувийн шинжтэй асуудал байдаг боловч улс төрийн ач холбогдол бүхий том сэдвээр ч хүмүүс илүү мэдээлэлтэй байхыг зүгээр хүсдэг байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

*Иргэдэд илүү ойртохын тулд ил тод байдал чухал*

Нутгийн захиргаа нь яамтай харьцуулбал, иргэндээ хамгийн ойр захиргаа юм. Германы Нутгийн тойргийн парламентын (Иргэдийн төлөөлөгчдийн хурлын) гишүүн К.Ритгэн “Нутгийн захиргаа итгэл дээр тогтдог, итгэлийг ил тод байдал бий болгодог. Хэрэв иргэд маань нутгийн хариуцлагыг ухамсарладаг байхыг бид хүсэж байгаа бол иргэд чухам юуны тухай яригдаж байгааг мэддэг байхыг бид зорих болно.”

МЭЧХ нь иргэн бүрд чухал эрх олгосноос гадна ийм замаар мэдээлэл олж авдаг сэтгүүлчид мөн адил боломж олгосон байна. Берлиний сэтгүүлч Ё.Мюллэр-Нойхоф МЭЧХ-ийн дагуу жишээ нь төрийн яамдуудад тогтмол асуумж тавьж, шаардлагатай бол акттай танилцах асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргадаг байна.

*Сэтгүүлчдэд мэдээлэл авах илүү эрх шаардлагатай*

Өнөөгийн шийдвэрт нөлөөлж болохуйц өнгөрсөн онуудын тэмдэглэлийг гаргаж өгөхгүй байгаад сэтгүүлчид бухимдалтай байдаг байна. Иймд сэтгүүлчдийн мэдээлэл авах эрхийг нэмэгдүүлж, илүү сайжруулах шаардлагатай гэж тэд үзэж байна.

Шпайэр дахь Германы Нийтийн захиргааны Судалгааны хүрээлэн нь МЭЧХ-ийн ирээдүй хэрхэх талаар задлан шинжилж байдаг билээ. Төр болон улсуудын санхүүжилт бүхий тус байгууллага нь төр болон захиргааны бүтэц, явцыг судалдаг юм.

*Өгөгдлийг хэрэглэгчид ойлгомжтой байхаар бэлтгэх*

Хүрээлэнгийн захирал Я.Зийков төрийн мэдээлэлд хандах байдал ирээдүйд эрс өөрчлөгдөнө гэж үзэж байна. Захиргаа нь зөвхөн өргөдөлд үндэслэн өгөгдөл гаргаж өгдөг бус харин маш идэвхтэйгээр мэдээллийг холбогдох тавцанд бэлтгэн гаргадаг болно. Хамбург болон Райнланд-Пфальц улсуудад аль хэдийн ил тод байдлын хууль гараад, гэхдээ одоогоор зарим салбарт төрийн байгууллагуудын үүрэг болгоод байна. Берлинд Депутатын танхим холбогдох хуулийг гаргахаар хэлэлцэж байна.

Нээлттэй засгийн газар, нээлттэй өгөгдөл хэмээх хэллэгүүд төрийн мэдээлэлд хандах ирээдүйг тодорхойлох боллоо. Профессор Зийков “Энэ бол квантын үсрэлт. Гэхдээ мөн л урьдын адил “сагалт”[349]-ыг хориглох зарчмыг баримтлан бэлтгэн гаргаж байгаа өгөгдлийг хэрхэн ангилахаас мэдээж хамаарна. Холбогдох хайлтын алгоритм бүхий мэргэжлийн ангилал энд маш чухал юм.” гэж хэлжээ.

Ингэхдээ хэрэглэгчийн нүдээр харах нь чухал юм. Одоогоор тус хүрээлэн Төрийн дотоод хэргийн яамны захиалгаар бүх түвшний захиргааны өгөгдөл, мэдээлэлд хандах боломж бүхий Govdata-Portal буюу Төрийн өгөгдлийн тавцангийн үнэлгээг хийж байна.

Иргэдийн хариултыг хэвлэн нийтлэх ажил өнөөг хүртэл сайн дурын үндсэн дээр хийгдэж байна. Учир нь одоогоор техникийн нөхцөл боломж бүрэн бүрдээгүй байна.

*Бавари, Нидерсаксон, Саксон улсуудад МЭЧХ байхгүй*

Цахим актыг төрийн түвшинд бүрэн нэвтрүүлэхэд их хол байна. Улсын түвшинд ч байдал ялгаатай, орон нутгийн түвшинд бүр илүү ялгаатай байна. Бавари, Нидерсаксон, Саксон гэсэн 3 улсад МЭЧХ байхгүй байна.

Тиймээс Өгөгдөл хамгааллын төрийн төлөөлөгч асан П.Шаар “Хэрэв ил тод байдал, төрийн мэдээлэлтэй харьцах зэрэг сэдвүүд жишээ нь, сонгууль гэх мэт улс төрийн хэлэлцүүлгийн асуудал болж байвал би баярлах болно.” хэмээн хэлж, мэдээллийн эрх чөлөөний талаар өчигдрөөс илүү чангаар мэтгэлцэхийн ерөөл дэвшүүлсэн ажээ.

[349] Хог сагаар дүүргэх [ГА]

UIH.MN СУДАЛГААНЫ САН

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ


- Олон нийтийн мэдээллийн тухай хууль (*Public Information Act1*) https://www.riigiteataja.ee/en/eli/514112013001/consolide
- Мэдээлэл авах эрхийн тухай хууль (*О доступе к информации*) http://adilet.zan.kz/rus/docs/Z1500000401
- Захиргааны зөрчлийн тухай хууль (*Об административных правонарушениях*) http://adilet.zan.kz/kaz/docs/K1400000235
- Төрийн өмчийн тухай хууль (*О государственном имуществе*), 1 дүгээр зүйл http://adilet.zan.kz/rus/docs/Z110000041
- Холбооны Улсын Мэдээлэл хандалтын зохицуулалтын тухай хууль (Мэдээллийн эрх чөлөөний хууль)-Gesetz zur Regelung des Zugangs zu Informationen des Bundes https://www.gesetze-im-internet.de/ifg/
- Freedom of Information Around the World 2006: A Global Survey of Access to Government Information Laws, David Banisar https://www.researchgate.net/publication/228245794_Freedom_of_Information_Around_the_World_2006_A_Global_Survey_of_Access_to_Government_Information_Laws
- Нийтийн мэдээллийн тухай хуулийн танилцуулга-Overview of the Public Information Act-*англиар* https://www.texasattorneygeneral.gov/open-government/members-public/overview-public-information-act
- Нийтийн мэдээллийн тухай хуулийн гарын авлага 2020-PUBLIC INFORMATION ACT Handbook 2020 https://www.texasattorneygeneral.gov/sites/default/files/files/divisions/open-government/publicinfo_hb.pdf
- Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль-Freedom of Information Act (FOIA)-*англиар* https://en.wikipedia.org/wiki/Freedom_of_Information_Act_(United_States)
- Мэдээллийн эрх чөлөөний тухай сайжруулсан хууль 2016-Full Text of the FOIA Improvement Act of 2016 (Public Law No. 114-185) https://www.foia.gov/foia-statute.html
- П.Фийбиг “Хэрхэн канцлерын зочны жагсаалтад хүрэх вэ”-P.Fiebig “Wie man an die Gästeliste des Kanzleramts kommt”-*германаар* https://www.deutschlandfunk.de/15-jahre-informationsfreiheitsgesetz-wie-man-an-die.724.de.html?dram:article_id=495773


UIH.MN
СУДАЛГААНЫ САН

# ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ ХАМГААЛАХ ТАЛААРХ ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

*С.Золжаргал*

## АГУУЛГА

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ

Нэг. ОЛОН УЛСЫН БАРИМТ БИЧИГ

1.1.НҮБ-ын баримт бичиг

1.2.Европын Холбооны дүрэм

1.3.Ази, номхон далайн бүсийн Хүний хувийн мэдээллийн зохицуулалтын хүрээ

1.4.Тусгаар улсуудын хамтын нөхөрлийн гишүүн орнуудын баримт бичиг

Хоёр. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

2.1.Япон Улс

2.2.Америкийн Нэгдсэн Улс

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН

3.1.Бодлогын баримт бичиг

3.2.Хувь хүний нууц

3.3.Хувь хүний нууц ба хувийн мэдээлэл

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

## УДИРТГАЛ

УИХ-ын гишүүний захиалгаар “Хүний хувийн мэдээллийг хамгаалах талаарх Олон улсын эрх зүйн зохицуулалт” харьцуулсан судалгааны ажлыг хийж гүйцэтгэв.

Монгол Улсын Хувь хүний нууцын тухай хууль нь 1995 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр батлагдаж, хувь хүний нууцыг хамгаалахтай холбоотой харилцааг зохицуулж байна. Уг хууль нь үйлчилж эхэлснээс хойш Үндсэн хуулийн цэцийн дүгнэлттэй холбоотой өөрчлөлт орсноос бусад нэмэлт, өөрчлөлт ороогүй юм. Хувийн мэдээллийг хамгаалах талаар нийтлэг үйлчлэх ерөнхий зохицуулалт байхгүй ба хүний хувийн мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах нь нэг талаасаа тухайн мэдээллийн эзэн болох хувь хүний эрхийг хамгаалах асуудал боловч, нөгөө талаасаа бизнес эрхлэгчдийн эдийн засгийн ашиг сонирхлыг харгалзан үзэх учраас эрх зүйн зохицуулалт зайлшгүй шаардлагатайг харуулж байна.

Иймд энэхүү судалгааны хүрээнд дээрх Монгол Улсын эрх зүйн зохицуулалтын онцлог болон Япон, АНУ-д хэрхэн хувийн мэдээллийг хамгаалах талаар эрх зүйн актад тусгасныг судаллаа.

## СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Хувь хүн хувийн нууцтай байх, түүнийгээ хуулиар хамгаалуулах нь Монгол Улсын Үндсэн хуульд тусгагдсан халдашгүй чөлөөтэй байх эрхийн баталгаа билээ. Техник технологийн хөгжил, цахим орчны хэрэгцээ, шаардлага эрчимтэй хөгжиж буй өнөө үед хувийн мэдээлэл, хувь хүн нууцаа хамгаалуулах энэхүү эрхийг улам бүр шаардах болсон байна. Ихэнх улс орон уг харилцааг зохицуулахдаа өөрийн орны онцлогт тохирсон Өгөгдөл хамгаалах хууль, Хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль зэрэг багц хуулиудыг баталж мөрдүүлдэг. Тэдгээр эрх зүйн зохицуулалтын онцлогоос үзэхэд, хуулиар хамгаалагдах хувийн мэдээллийн цар хүрээг тогтоож, мэдээллийн урсгалд хяналт тавьж, хувийн мэдээллийн эрх зүйн орчинг хамгаалахаар зохицуулжээ. Мөн мэдээллийн эзэн, мэдээлэл дамжуулагч, боловсруулагч-нарын эрх, үүрэг болон хувийн мэдээллийг зөв зохистойгоор цуглуулах, боловсруулах, дамжуулах зэргийг нарийвчлан тодорхойлжээ.

Судалгаанд олон улсад жишиг болсон Европын холбооны “Өгөгдөл хамгаалах ерөнхий дүрэм” [350] (General Data Protection Regulation-GDPR)-д хувийн өгөгдлийг цуглуулах, боловсруулах, ашиглах зорилгын уялдаа холбоо болон, хувийн өгөгдлийг цуглуулж, ашиглахад баримтлах шударга, хууль ёсны, ил тод байх зэрэг зарчмыг тогтоож, хувийн өгөгдөлд тавигдах шалгуурыг тодорхойлсон.

Хувийн мэдээллийг хамгаалах талаар гадаадын зарим орны онцлог заалт байх ба жишээ нь БНСУ-ын Хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль тогтоомжоор хүний хувийн мэдээллийг цуглуулах, ашиглах, дамжуулах, устгахад баримтлах стандартыг тогтоосон. Дүрсэн мэдээлэл цуглуулах төхөөрөмжийг зөвхөн эрүүгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор нийтийн эзэмшлийн талбайд байрлуулж болохыг зөвшөөрсөн. Сингапурын Хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн зохицуулалт нь бизнесийн үйл ажиллагааны чиглэлийг тодорхой заасан. Тухайн бизнесийн байгууллага хувь хүнд мэдэгдсэнээр зөвшөөрөл авсанд тооцож гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх зорилгоор бусад гэрээлэгчдэд дамжуулахыг зөвшөөрсөн байдаг байна. Эстони Улсын хувьд Хувийн мэдээллийг хамгаалах хуульдаа сэтгүүл зүйн зорилгоор мэдээллийн эзний зөвшөөрөлгүйгээр хэвлэл мэдээллийн хэрэгслээр задруулж болохоор зохицуулсан байна. Энэ нь нийтийн ашиг сонирхол, түүнчлэн сэтгүүлчийн ёс зүйн зарчимд нийцсэн бол зөвшөөрөгдөнө. Хувийн мэдээллийг задруулах нь мэдээллийн эзэнд хохирол учруулах ёсгүй. Эрдэм шинжилгээ, уран сайхны болон уран зохиолын нийтлэлд зориулж хувийн мэдээллийг, мэдээллийн эзний зөвшөөрөлгүйгээр боловсруулж болно. Энэ нь

[350] Европын холбооны “Өгөгдөл хамгаалах ерөнхий дүрэм”” https://gdpr-info.eu/

UIH.MN СУДАЛГААНЫ САН

өгөгдөл эзэмшигчид хохирол учруулахгүй бол зөвшөөрөгдөнө. Мөн уг хуульд олон нийтийн байгууллагад хувийн мэдээллийг боловсруулах талаар зохицуулалт тусгагдсан байх бөгөөд мэдээллийн эзний зөвшөөрлөөр ирээдүйд задруулах аудио болон дүрс бичлэгийг олон нийтийн газар хийхдээ эзэнд нь мэдэгдэх үүрэгтэй. Мэдэгдэх үүрэг нь олон нийтийн арга хэмжээнд хамаарахгүй байхаар заажээ.

*Япон Улс “Хувийн мэдээлэл хамгаалах тухай” хуулийг[351] (個人情報の保護に関する法律,2003 年) 2003 оны 5 дугаар сарын 30-нд баталж, 2020 оны 6 дугаар сард шинэчлэн найруулсан байна. Уг хуулийн онцлог зохицуулалт нь Хувийн мэдээллийг хамгаалах комисс байгуулсан ба энэхүү байгууллага нь хувийн мэдээллийг хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллана. Хувийн мэдээллийг устгах, задруулах талаарх асуудлыг өргөн хүрээнд хуульчилсан. Хувь хүний нууцын мэдээллээс бусад хувийн мэдээллийг мэдэгдэл өгөх замаар гуравдагч этгээдэд шилжүүлсэн нь зөвшөөрөл авсанд тооцогдоно. Мөн нэгэнт зөвшөөрөлтэй хүлээн авсан хувийн мэдээллийг гуравдагч этгээдэд шилжүүлэх асуудлыг нарийвчлан зохицуулсан. Хувийн мэдээлэл хамгаалах хувийн байгууллагыг магадлан итгэмжлэх асуудлыг зохицуулж мөн нууц нэрээр илэрхийлэгдсэн мэдээлэлтэй холбоотой харилцааг зохицуулж өгчээ.*

*АНУ нь Нууцлалын тухай хуулийг[352] (Privacy Act) 1974 онд баталсан. Уг хуулиар холбооны байгууллагуудын бүртгэлийн системд хадгалагдаж буй хувь хүмүүсийн талаарх мэдээллийг цуглуулах, хадгалах, ашиглах, задруулах тухай зохицуулалтыг зааж өгсөн.*

2018 онд хамгийн олон хүн амтай Калифорниа муж нь Хэрэглэгчийн нууцлалын тухай хууль[353] (CCPA - California Consumer Privacy Act)-ийг баталсан. Тус муж нь Google, Facebook зэрэг мэдээллийн технологийн томоохон компаниудтай. Нууцлалын тухай хууль нь төр болон төрийн агентлагуудын харилцааны зохицуулалтыг тодорхойлж өгсөн бол мужийн Хэрэглэгчийн нууцлалын тухай хууль нь бизнесийн байгууллага, хэрэглэгчдийн хоорондын харилцааг зохицуулдаг.

Монгол Улсын “Хувь хүний нууцын тухай” хуульд хувь хүний нууцыг хамгаалах, зөвшөөрөлгүйгээр задруулахыг хориглосон зүйл заалт хэт ерөнхий агуулгатай байх бөгөөд хувь хүний мэдээллийг цуглуулах, бүртгэх, хадгалах, хамгаалах, дамжуулах, ашиглах, өөрчлөх, устгах зэрэг мэдээлэл боловсруулалтын үйл ажиллагаа явуулахад хувь хүн болон хувь хүний мэдээллийг хамгаалахтай холбоотой үүсэж буй харилцааг зохицуулаагүй байна.

Мэдээлэл харилцаа холбооны технологи хөгжихийн хэрээр мэдээлэл хүлээн авах, цуглуулах төрөл, хэлбэр улам өсөн нэмэгдэж, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд хүний хувийн мэдээллийг цахим хэлбэрээр цуглуулах, боловсруулах, хадгалах, дамжуулах үйл ажиллагааг бий болгосноор хүний хувийн мэдээлэл нь эдийн засгийн эргэлтэд орж, баялаг бүтээх нэг боломж болж байгаа сайн талтай хэдий ч нөгөө талаар хувийн мэдээлэл алдагдах, буруугаар ашиглагдах, мэдээллийг зөвшөөрөлгүйгээр ашиглаж, боловсруулах замаар хувь хүний эрх, эрх чөлөөнд халдах эрсдлийг дагуулж байна.

***Түлхүүр үг***: *Хүний хувийн мэдээлэл, Хувийн мэдээллийн хадгалалт, Боловсруулалт, Хамгаалалт, Аюулгүй байдал, Хувийн нууц, Хувийн өгөгдөл мэдээлэл*

UIH.MN СУДАЛГААНЫ САН

351 https://elaws.e-gov.go.jp/
352 *Privacy Act of 1974 - https://www.justice.gov/opcl/privacy-act-1974*
353 https://oag.ca.gov/privacy/ccpa

## СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ

### Нэг. ОЛОН УЛСЫН БАРИМТ БИЧИГ

Олон Улсад Хүний хувийн мэдээлэл хамгаалах талаарх баримт бичигт “Хувийн мэдээлэл” гэдгийг хэрхэн тодорхойлсныг авч үзвэл: Европын холбооны “Өгөгдөл хамгаалах ерөнхий дүрэм”-ийн 4.1-т “*хувийн мэдээлэл”* гэдэг нь тухайн хувь хүнийг тодорхойлох боломжтой, тодорхойлж болохуйц аливаа мэдээллийг хэлнэ. Үүнд: хүний нэр, хувь хүн гэдгийг шууд буюу шууд бусаар тодорхойлох дугаар, байршлын мэдээлэл, цахим тодорхойлогч, эсхүл бие махбод, физиологи, генетик, оюун санаа, эдийн засаг, соёл болон нийгмийн нөхцөл байдалтай холбоотой мэдээлэл ба хувийн эмзэг мэдээлэл нь үндэс угсаа, улс төрийн үзэл бодол, шашин шүтлэг, генетик болон биометрийн мэдээлэл орно” хэмээн заасан байна.

Хүний хувийн өгөгдөл, мэдээлэл нь халдашгүй байдал, хамгаалагдах эрх зүйн үндэслэлтэй байх ба Англи хэлний “right to privacy” буюу дангаарших (хувийн орон зай, шийдвэр, мэдээлэл халдашгүй байх)[354] эрхтэй салшгүй хамааралтай бөгөөд АНУ зэрэг цөөнгүй улсууд хувийн мэдээллээ хамгаалуулах нь дангаарших эрхийн бүрдэл хэсэг гэж үздэг. Олон улсын болон үндэсний эрх зүйн тогтолцоонд хүний хувийн өгөгдөл, мэдээллийг хамгаалах талаар зохицуулсан хэм хэмжээ цөөнгүй.

Харин дэлхийд сайн жишигт тооцогдож буй Эстони Улсын Өгөгдөл хамгаалах тухай хуульд *“хувийн эмзэг өгөгдөл мэдээлэл”*-д дараах мэдээллүүд хамаарна гэж заасан. Үүнд:

1) Хуулинд заасан журмын дагуу хууль ёсны гишүүн байхтай холбоотой өгөгдөл мэдээллийг үл оролцуулан улс төрийн үзэл бодол, шашин шүтлэг, гүн ухааны талаарх итгэл үнэмшлийг харуулсан өгөгдөл мэдээлэл;
2) Гарал, үүсэл үндэстэн ястанг харуулсан өгөгдөл мэдээлэл;
3) Эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлийн байдлыг харуулсан өгөгдөл мэдээлэл;
4) Генетикийн мэдээллийг харуулсан өгөгдөл мэдээлэл;
5) Бэлгийн амьдралыг харуулсан өгөгдөл мэдээлэл;
6) Үйлдвэрчний эвлэлийн гишүүнчлэлтэй холбоотой өгөгдөл мэдээлэл;
7) Гэмт хэргийг шүүн таслах ажиллагааны үеэр эсвэл нийтийн шүүх хурлаас өмнө хэргийг мөрдөн шалгах явцад цугласан мэдээ мэдээлэл, эсвэл хэрэгтэй холбоотой шүүхийн шийдвэрийн өмнө цуглуулсан баримт мэдээлэл, хэрэв шаардлагатай бол олон нийтийн ёс журмыг хамгаалахын тулд эсвэл гэр бүл хувийн амьдралтай холбоотой хэн нэгэн, эсвэл бага насны хүүхэд, хохирогч, гэрч, шүүгч гэх мэт хүмүүсийн эрх ашиг хөндөгдсөн үед цуглуулагдсан мэдээ мэдээлэл орно.

*Олон улсын голлох эрх зүйн зохицуулалтаас:*

- Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 12 дугаар зүйл;[355]
- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 17 дугаар зүйл;[356]

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[354] Нэр томьёоны талаарх саналыг хавсралтаар тайлбарлав.
[355] Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн оролцох, орон байрны халдашгүй байдал, захидал харилцааны нь нууц болон нэр төр, алдар хүндэд нь халдах ёсгүй. Тийм оролцоо халдлагын эсрэг хэн ч бай хуулиар хамгаалуулах эрхтэй.
[356] 1. Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн буюу хууль бусаар оролцох, орон байранд нь буюу захидал харилцааных нь нууцад дур мэдэн буюу хууль бусаар халдах, эсхүл нэр төр, алдар хүндэд нь хууль бусаар халдахыг хориглоно.
2. Хүн бүр тийм оролцоо, халдлагаас хуулиар хамгаалуулах эрхтэй.

- Хүүхдийн эрхийн тухай конвенцын 16 дугаар зүйл;[357]
- Компьютержүүлсэн хувийн өгөгдлийн файлуудын зохицуулалтын талаарх НҮБ-ын зааварчилгаа (1990);
- Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын зааварчилгаа (1981). Нууцлал болон хувийн өгөгдлийн хил дамнасан урсгалын талаарх.

*Бүсийн онцлох зохицуулалтаас:*

- Өгөгдөл хамгаалах ерөнхий дүрэм (Европын холбоо 2016)-GDPR;
- Европын хүний эрхийн конвенцын 8-р зүйл;[358]
- Исламын улсуудын хүний эрхийн Кайрогийн тунхаглалын 18-р зүйл;
- Арабын хүний эрхийн дүрмийн 16, 21 дүгээр зүйл;
- Африкийн хүний болон иргэний эрхийн тунхаглалын комисс
- Африкийн хүүхдийн эрх, сайн сайхны дүрмийн 19 дүгээр зүйл;
- Зүүн өмнөд Азийн улсуудын хүний эрхийн тунхаглалын 21 дүгээр зүйл;
- Ази Номхон далайн privacy-н хамтын зохицуулалт.

### 1.1.НҮБ-ын баримт бичиг

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 17.1 дэх хэсэгт “Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн буюу хууль бусаар оролцох, орон байранд нь буюу захидал харилцааных нь нууцад дур мэдэн буюу хууль бусаар халдах, эсхүл нэр төр, алдар хүндэд нь хууль бусаар халдахыг хориглоно.” гэж, 17.2 дахь хэсэгт “Хүн бүр тийм оролцоо, халдлагаас хуулиар хамгаалуулах эрхтэй.” хэмээн заасан байдаг.

Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 12 дугаар зүйлд “Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн оролцох, орон байрны халдашгүй байдал, захидал харилцааны нууц болон нэр төр, алдар хүндэд нь халдах ёсгүй. Тийм оролцоо халдлагын эсрэг хэн ч бай хуулиар хамгаалуулах эрхтэй” гэж тус тус заасан.

Дээрх хоёр тодорхойлолт нь хоорондоо ижил хэдий ч, зарим чухал ялгаа бий. Хүний эрхийн түгээмэл тунхаглалаар зөвхөн хувийн нууцын халдашгүй байдалд хөндлөнгөөс дур мэдэн нөлөөлж оролцохыг хориглосон хэдий ч, “*хууль бусаар”* гэдэг нь байхгүй юм. Бодит байдалд, хууль бус хөндлөнгийн оролцоо нь ямагт дур зоргын болохыг нь тодруулдаг учраас энэхүү хязгаарлалт нь ач холбогдолтой юм. Мөн Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактаар нэр төр, алдар хүндэд зөвхөн хууль бусаар халдахаас хамгаалсан бол, Хүний эрхийн түгээмэл тунхаглалд бүхий л төрлийн халдлагаас хамгаалагдах тухай заасан байна.

Мөн НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1990 оны 12 сарын 14-ний өдрийн 45/95 тоот Шийдвэрээр баталсан “Компьютерт хадгалагдаж буй хувийн өгөгдлийг зохицуулах удирдамж”-ийг баталж, үндэсний хууль тогтоомжоор баталгаажуулах өгөгдөл хамгаалахтай холбоотой үндсэн зарчмуудыг нэгтгэн дараах байдлаар тогтоосон байна.

UIH.MN ЭМХЭТГЭЛ САН

[357] 1. Нэг ч хүүхдийн хувийн болон гэр бүлийн амьдрал, орон байрны халдашгүй байдал болон захидал харилцааны нууцад хөндлөнгөөс, хууль бусаар буюу дур мэдэн оролцох, эсхүл түүний нэр төр, алдар хүндэд хууль бусаар халдаж болохгүй.
2. Хүүхэд хөндлөнгийн ийм оролцоо, халдлагаас хуулиар хамгаалуулах эрхтэй.

[358] Хүн бүр өөрийн хувийн болон гэр бүлийн амьдрал, орон гэр болон захидал харилцааг хүндэтгүүлэх эрхтэй.

Үүнд:

- *<u>Хууль ёсны болон шударга ёсны зарчим:</u>* Өгөгдөл цуглуулах үйл ажиллагаа нь шударга, хууль ёсны дагуу байх ёстой бөгөөд НҮБ-ын Үндсэн дүрмийн зорилго, зарчимд харшлах ёсгүй.
- *<u>Үнэн зөв байх зарчим:</u>* Өгөгдөл хянагчид өгөгдлийг үнэн зөв, харилцан хамааралтай байгаа эсэхийг шалгаж, хянах үүрэгтэй бөгөөд алдаа гаргахаас зайлсхийх ёстой.
- *<u>Тодорхой зорилгоор ашиглах зарчим:</u>* Өгөгдөл цуглуулах үйл ажиллагаа нь хууль ёсны дагуу байх ёстой бөгөөд хувийн өгөгдлийг зөвхөн тусгайлсан зорилгоор цуглуулж, боловсруулах, өгөгдлийн эзний зөвшөөрөлгүйгээр өгөгдлийг бусад этгээдэд ашиглуулахгүй байх, өгөгдөл нь зөвхөн тухайн зорилгод шаардлагатай хугацаагаар хадгалагдах ёстой.
- *<u>Нэвтрэх боломжтой байх зарчим:</u>* Өгөгдлийн эзэн нь тухайн өгөгдлийг ойлгомжтой хэлбэрээр хэрхэн цуглуулах, боловсруулах, нэвтрэхийг мэдэх эрхтэй байх ёстой.
- *<u>Ялгаварлан гадуурхахгүй байх зарчим:</u>* Эдгээр зарчмыг бодитоор хэрэгжүүлэхийн тулд ялгаварлан гадуурхах аливаа онцгой тохиолдол гэж байх ёсгүй.
- *<u>Аюулгүй байдлын зарчим:</u>* Зөвшөөрөгдөөгүй этгээд өгөгдөлд хандах, өгөгдлийг урвуулан ашиглах ёсгүй.

### 1.2.Европын Холбооны дүрэм

2016 оны 5 дугаар сарын 24-ний өдөр батлагдаж, 2018 оны 5 дугаар сарын 25-ны өдрөөс хэрэгжиж эхэлсэн Европын холбооны “Өгөгдөл хамгаалах ерөнхий дүрэм”[359](General Data_Protection Regulation - GDPR) хамгийн өргөн хүрээг зохицуулсан бөгөөд дэлхий нийтэд сайн жишиг хэмээн хүлээн зөвшөөрөгдөж байна.

“Өгөгдөл хамгаалах ерөнхий дүрэм” нь 11 бүлэг, 99 зүйлээс бүрдэнэ. Энэ дүрмээр хувийн өгөгдлийг цуглуулах, боловсруулах, ашиглах зорилгын уялдаа, нийцлийг тодорхойлж, хувийн өгөгдлийг цуглуулж, ашиглахад баримтлах шударга, хууль ёсны, ил тод байх зэрэг зарчмыг тогтоож, хувийн өгөгдөлд тавигдах шалгуурыг тодорхойлжээ.

Уг “Өгөгдөл хамгаалах ерөнхий дүрэм”-ийн (Цаашид GDPR гэх) онцлог зүйлээс дурдвал:

- Дүрмийн 3 дугаар зүйлд дүрмийн үйлчлэх цар хүрээ, чухам ямар этгээдүүдийн эрхийг хамгаалах тухай тодорхойлсон байдаг. Европын Холбооны Хувийн Мэдээллийг Хамгаалах Зөвлөлөөс гаргасан зөвлөмжид GDPR-ийн үйлчлэх цар хүрээг ерөнхий тодорхойлсон нь хууль тогтоогчийн дээрх хэм хэмжээг аль болох өргөн хүрээнд тайлбарлан хэрэглэх боломж олгох гэсэн хүсэл зоригийн илэрхийлэл юм[360] гэсэн байна. GDPR-ийн 3.1 болон 3.2 дугаар зүйлийн дараах шалгууруудын аль нэгийг хангасан тохиолдолд GDPR-ийн үйлчлэх хүрээнд багтана гэж үзнэ:

1. үйл ажиллагаа явуулж буй газрын шалгуур буюу *establishment test*;
2. ямар этгээдэд чиглэсэн үйл ажиллагаа явуулж буй шалгуур буюу *targeting test.*

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[359] Европын холбооны “Өгөгдөл хамгаалах ерөнхий дүрэм”” https://gdpr-info.eu/
[360] Guidelines 3/2018 on the territorial scope of the GDPR (Article 3), The European Data Protection Board, 4 дэх талhttps://edpb.europa.eu/sites/edpb/files/files/file1/edpb_guidelines_3_2018_territorial_scope_after_public_consultation_en_0.pdf

Европын Холбооны нутаг дэвсгэрт хувийн мэдээлэл боловсруулах ажиллагаа хийгдэх эсэхээс үл хамааран тухайн хувийн мэдээлэл боловсруулагч болон хариуцагч нь Европын Холбоонд явуулж буй тогтвортой үйл ажиллагааны зохион байгуулалттай нь холбоотойгоор хувийн мэдээллийг боловсруулах ажиллагаа хийгдэж байгаа тохиолдолд үйл ажиллагаа явуулж буй газрын шалгуурыг хангана гэж үзнэ. Гэвч тухайн хувийн мэдээлэл боловсруулагч болон хариуцагч нь зайлшгүй Европын Холбооны аль нэг улсад бүртгэгдсэн, үүсгэн байгуулагдсан байхыг шаардахгүй. Харин дээрх шалгуурыг хангаж буй эсэхийг тодорхойлохдоо тухайн хувийн мэдээлэл хариуцагч болон боловсруулагчид ямар нэгэн байдлаар Европын Холбоонд тогтвортой үйл ажиллагаа явуулах зохион байгуулалтын хэлбэр байгаа эсэх, мөн хувийн мэдээлэл боловсруулах ажиллагаа нь уг зохион байгуулалтын хэлбэртэй нь уялдаа холбоотой эсэхийг тодруулна. Түүнчлэн, хувийн мэдээлэл хариуцагч нь Европын Холбооны нутагт үйл ажиллагаа явуулдаг бол хувийн мэдээллийг боловсруулах ажиллагаа хаана явагдаж байгаагаас үл хамааран GDPR үйлчилнэ. Харин ямар этгээдэд чиглэсэн үйл ажиллагаа явуулж буй шалгуур нь Европын Холбоонд байрладаггүй хувийн мэдээлэл боловсруулагч болон хариуцагч нарт GDPR үйлчлэх нөхцөлийг тодорхойлсон байдаг. GDPR-ийн 3.2-т заасны дагуу Европын Холбоонд байрладаггүй хувийн мэдээлэл боловсруулагч болон хариуцагч нар нь Европын Холбоонд байгаа хувийн мэдээллийн эзний мэдээллийг доорх үйл ажиллагаатай холбоотойгоор цуглуулсан бол GDPR нь тэдгээрт үйлчилнэ. Үүнд:

1. хувь хүнээс төлбөр авах шаардлагатай эсэхээс үл хамааран хувь хүмүүст бараа, үйлчилгээ үзүүлдэг; эсхүл
2. Европын Холбооны нутаг дэвсгэр дээр тухайн хувь хүмүүсийн үйлдлийн шинж чанарыг хянах зорилготой үйл ажиллагаа

- Дүрмийн 5-р зүйлд хувийн мэдээллийг цуглуулах, хадгалах, ашиглахад баримтлах үндсэн зарчмуудыг дараах байдлаар тогтоосон байна:

- өгөгдлийг хуулийн дагуу, шударгаар, мэдээллийн эзэнд нээлттэй байдлаар боловсруулах;
- өгөгдлийг хууль ёсны, тодорхой зорилгоор боловсруулах;
- өгөгдөл нь боловсруулж буй зорилгод шууд хамааралтай, хүрээ хязгаартай байх;
- өгөгдөл нь хаана шаардлагатай байгаа, ямар хугацаанд хадгалах нь тодорхой байх;
- өгөгдлийн эзний зөвшөөрлийн дагуу хувийн өгөгдөл боловсруулах зорилгод шаардагдах хугацаагаар хадгалах;
- хувийн өгөгдлийн аюулгүй байдлыг зохих ёсоор хангаж боловсруулах зэрэг болно.

Түүнчлэн хувийн өгөгдлийг хадгалах хугацааны хязгаарыг тогтоож аюулгүй байдлыг хангах технологид тавигдах шаардлагыг тодорхойлсон.

Хувийн өгөгдлийг боловсруулахад өгөгдлийн эзэн хяналт тавихаас гадна түүнд хяналт тавих эрх бүхий байгууллага, албан тушаалтны эрх зүйн байдлыг дүрмээр тогтоосон байна. Энэхүү хяналт тавих төрийн байгууллага нь бие даасан, хараат бус байх бөгөөд дүрэмд тухайн байгууллагыг байгуулах дарга, гишүүдийг сонгох, бүрэн эрх болон үйл ажиллагаа явуулах хугацааг тогтоох, гадны нөлөөгүй бие даан шийдвэр гаргах зэрэг асуудлыг тусгайлан зохицуулсан. Энэхүү хяналтын байгууллага иргэдийн гомдлыг хүлээн авч шийдвэрлэх бөгөөд цуглуулсан хууль бус, эсхүл буруу мэдээллийг устгуулах эрх мэдэлтэй байдаг байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

- GDPR-т тусгасан бас нэгэн онцлог зохицуулалт нь *right to be forgotten* буюу мартагдах эрх юм. GDPR-ийн 17 дугаар зүйлд заасны дагуу доорх тохиолдолд хувийн мэдээллийн эзэн нь өөрийн хувийн мэдээллийг устгуулахаар шаардах эрхтэй бөгөөд хувийн мэдээлэл хариуцагч нь тухайн мэдээллийг устгах үүрэгтэй болно:

1. хувь хүн өөрийн өгсөн зөвшөөрлийг цуцалсан;
2. тухайн хувийн мэдээллийг цуглуулсан, эсхүл боловсруулах болсон зорилго, шалтгааныг биелүүлэхэд тухайн хувийн мэдээлэл шаардлагагүй болсон;
3. хувийн мэдээллийг зөвшөөрөгдсөн хууль ёсны ашиг сонирхлынхоо хүрээнд боловсруулж байсан боловч хувийн мэдээллийн эзэн зөвшөөрөл өгөхөөс татгалзсан, уг татгалзлыг үгүйсгэх хариу хууль ёсны ашиг сонирхол байхгүй байвал;
4. хууль зөрчиж хувийн мэдээллийг боловсруулсан;
5. холбогдох хуулийн дагуу хувийн мэдээллийг устгах үүрэгтэй болсон;
6. хүүхдийн хувийн мэдээллийг харилцах үйлчилгээний хүрээнд цуглуулсан бол.

### 1.3. Ази, номхон далайн бүсийн Хүний хувийн мэдээллийн зохицуулалтын хүрээ

2004 онд Ази номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагаас ерөнхий мэдээлэл хамгаалах болон хил дамнасан мэдээлэл хамгаалалтын тогтолцооны загвар (APEC privacy framework) боловсруулсныг 21 гишүүн улс нь бүгд сайн дураар хүлээн зөвшөөрч ашиглахаар болжээ. (Greenleaf, Graham (2009). "Five years of the APEC Privacy Framework: Failure or promise?". Computer Law & Security Report. 25: 28–43.) Уг зохицуулалтаар нууцлал хамгаалах дараах 9 зарчмыг стандартын доод шалгуур болгон тогтоожээ:

1. Хохирол учрахаас урьдчилан сэргийлэх зарчим;
2. Мэдэгдэх зарчим;
3. Мэдээлэл цуглуулахад хязгаар тогтоох зарчим;
4. Хувийн мэдээллийн ашиглалтыг зохицуулах зарчим;
5. Сонгох зарчим;
6. Хувийн мэдээллийн нэгдмэл (халдашгүй) байдал;
7. Мэдээлэл хамгаалах;
8. Хувийн мэдээллээ авах, өөрчлөх эрхийн зарчим;
9. Бүртгэл, хариуцлагын зарчим.

### 1.4.Тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн гишүүн орнуудын баримт бичиг

Тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн гишүүн орнуудын 2018 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн Парламент хоорондын ассамблейн 48 дахь чуулганы 48-9 тоот тогтоолоор баталсан “Хүний хувийн мэдээллийн тухай” загвар хуульд [361] “***тодорхой хүний талаарх хувийн мэдээлэл*** гэдэг нь тухайн хүнийг шууд болон шууд бусаар тодорхойлох, эсхүл тодорхойлж чадахуйц аливаа мэдээлэл болно. Хувийн мэдээлэл гэдэгт тухайн хүний овог, нэр, гадаад төрх байдал, түүх намтрын болон таних өгөгдөл, хувийн шинж чанар, гэр бүл, нийгмийн байдал, боловсрол, мэргэжил, ажлын болон санхүүгийн байдал, эрүүл мэндийн байдал болон бусад мэдээлэл багтахаар тодорхойлсон байна.

[361] https://cis-legislation.com/document.fwx?rgn=116757

UIH.MN СУДАЛГААНЫ САН

## Хоёр. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

Монгол Улсын Үндсэн хуулийн 13 дугаар зүйлд мэдээлэл хамгаалах талаар суурь агуулгыг тусгасны адил Алжир[362], Бутан[363], Болив[364], Бразил[365], Камбож[366], Хятад[367] зэрэг дэлхийн 180 гаруй улсын Үндсэн хуулинд дангаарших эрхийн талаар янз бүрээр тусгагдсан байна.

Тухайлбал, Энэтхэгийн Үндсэн хуулийн 21-р зүйл[368] АНУ-н Үндсэн хуулийн 1, 4-р нэмэлт өөрчлөлтөд[369] ч мөн тусгалаа олжээ.

Ерөнхийдөө, иргэнлэг буюу нийтлэг эрх зүйн тогтолцоо, бүсийн ялгаанаас шалтгаалан хувийн мэдээлэл хамгаалах дараах тогтолцоо үйлчилж байна:

- Үндсэн хуулийн тайлбар, шүүхийн прецедент давамгайлсан (Жишээ нь: АНУ);
- Бүсийн хамтын зохицуулалтад тулгуурласан – (Жишээ нь: Европын холбоо);
- Үндэсний органик хуулийн зохицуулалтад тулгуурласан – (Жишээ нь: Эстони).

Зарим орны онцлог зохицуулалтаас дурдвал:

БНСУ-ын Хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль тогтоомжоор хүний хувийн мэдээллийг цуглуулах, ашиглах, дамжуулах, устгахад баримтлах иж бүрэн стандартыг тогтоосон. Дүрсэн мэдээлэл цуглуулах төхөөрөмжийг зөвхөн эрүүгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор нийтийн эзэмшлийн талбайд байрлуулж болохыг зөвшөөрсөн.

Сингапурын Хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн зохицуулалт нь бизнесийн үйл ажиллагааг дэмжих чиглэлийг баримталдаг. Тухайн бизнесийн байгууллага хувь хүнд мэдэгдсэнээр зөвшөөрөл авсанд тооцож гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх зорилгоор бусад гэрээлэгчдэд дамжуулахыг зөвшөөрсөн байдаг байна.

Эстони Улсын Хувийн мэдээллийг хамгаалах хуульд сэтгүүл зүйн зорилгоор мэдээллийн эзний зөвшөөрөлгүйгээр хэвлэл мэдээллийн хэрэгслээр задруулж болохоор зохицуулсан байна. Энэ нь нийтийн ашиг сонирхол, түүнчлэн сэтгүүлчийн ёс зүйн зарчимд нийцсэн бол зөвшөөрөгдөнө. Хувийн мэдээллийг задруулах нь мэдээллийн эзэнд хохирол учруулах ёсгүй. Эрдэм шинжилгээ, уран сайхны болон уран зохиолын нийтлэлд зориулж хувийн мэдээллийг, мэдээллийн эзний зөвшөөрөлгүйгээр боловсруулж болно. Энэ нь өгөгдөл эзэмшигчид хохирол учруулахгүй бол зөвшөөрөгдөнө. Мөн уг хуульд олон нийтийн байгууллагад хувийн мэдээллийг

[362] Үндсэн хуулийн (2020) §47-д “Хүн бүр нэр төр, хувийн амьдралаа хамгаалуулах эрхтэй”.
[363] Үндсэн хуулийн (2008) §7.19-д “Хэний ч хувийн амьдрал, орон байр, ... нэр төрд хууль бусаар халдаж болохгүй”
[364] Үндсэн хуулийн (2009) §21.2-т “Боливын иргэд дараах эрхтэй: Эрхэм чанар, дангааршил, ... нэр төр.
[365] Үндсэн хуулийн (1988 онд батлагдаж 2017 онд шинэчлэн найруулсан) §5-д “...хууль шүүхийн өмнө тэгш байж ... эрх эдэлнэ: 10. ... хувийн амьдралтай байх, нэр төртэй байх ...”
[366] Үндсэн хуулийн (1993 онд батлагдаж 2008 онд шинэчлэн найруулсан) §40-д “... орон байр, шуудан, телеграм, утас зэрэг ... дангаарших эрхтэй.
[367] Үндсэн хуулийн (1982) §40-д “БНХАУ-н иргэний харилцаа холбооны халдашгүй байдал, эрх чөлөөг хуулиар хамгаална”
[368] “Хуульд заасанаас бусдаар хүний хувийн амьдрал, эрх чөлөөнд халдахыг хориглоно”. БНЭУ-д Үндсэн хуулийн уг заалтын агуулгыг тайлбарлан шийдвэрлэсэн хэд хэдэн чухал хэрэг маргаан бий. Тухайлбал, Smt. Maneka Gandhi v. Union of India & Anr.,(1978); Govind vs State Of Madhya Pradesh & Anr (1975); Naz Foundation v. Govt. of NCT of Delhi (2009).
[369] АНУ дангаарших эрхийн хөгжилд багагүй нөлөө үзүүлсэн. Үндсэн хуулийн эдгээр заалтаас гадна Griswold v. Connecticut, 381 U.S. 479 (1965); Katz v. United States, 389 U.S. 347 (1967) зэрэг олон алдартай хэргүүдэд хийсэн Дээд шүүхийн тайлбар нь хүний мэдээлэл, шийдвэр халдашгүй байх талаар үзэл санаанд өөрсдийн хувь нэмрийг оруулжээ. Флорида, Хавай, Монтана, Луизана зэрэг олон мужууд нь мөн дангааршлын талаар өөрсдийн Үндсэн хуулинд тусгасан байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

боловсруулах талаар зохицуулалт тусгагдсан байх бөгөөд мэдээллийн эзний зөвшөөрлөөр ирээдүйд задруулах аудио болон дүрс бичлэгийг олон нийтийн газар хийхдээ эзэнд нь мэдэгдэх үүрэгтэй. Мэдэгдэх үүрэг нь олон нийтийн арга хэмжээнд хамаарахгүй байхаар заажээ.

### 2.1.Япон Улс

Япон Улс “Хувийн мэдээлэл хамгаалах тухай” хуулийг[370] 2003 оны 5 дугаар сарын 30-нд баталж, 2020 оны 6 дугаар сард шинэчлэн найруулсан. Энэ хууль нь 7 бүлэг, 88 зүйлтэй. Уг хуулиар хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах бие даасан байгууллагын эрх хэмжээг тодорхойлж, эмзэг өгөгдлөөс бусад хувийн мэдээллийг мэдэгдэл өгөх замаар гуравдагч этгээдэд шилжүүлсэн нь зөвшөөрөл авсанд тооцогдоно. Нэгэнт зөвшөөрөлтэй хүлээн авсан хувийн мэдээллийг гуравдагч этгээдэд шилжүүлэх асуудлыг нарийвчлан зохицуулсан байна.

*Хуулийн зохицуулалтын ерөнхий агуулга*

Уг хууль нь мэдээлэл харилцаа холбооны дэвшилтэт нийгэм хөгжихийн хэрээр хувийн мэдээллийн хэрэглээ эрс өргөжиж байгааг харгалзан энэхүү мэдээлэл нь хувийн мэдээлэлтэй зөв харьцах, төрөөс баримтлах үндсэн зарчим, бодлогыг бий болгох, хамгаалахтай холбоотой юм. Хувийн мэдээллийг зохистой, үр дүнтэй ашиглахын үндсэн асуудлуудыг тодорхойлж, улсын болон орон нутгийн засаг захиргааны үүрэг хариуцлагыг тодорхой болгож, хувийн мэдээллийг зохицуулж буй аж ахуйн нэгжийн дагаж мөрдөх үүргийг нарийвчлан зохицуулж байгаа болно.

*Хувь хүний мэдээлэл хамгаалах тусгай зохицуулалт*

Энэ хуулийн дагуу Хувийн мэдээллийг хамгаалах комисс байгуулагдсан ба энэхүү байгууллага нь хувийн мэдээллийг хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллана. Хувийн мэдээллийг устгах, задруулах талаарх асуудлыг өргөн хүрээнд хуульчилсан. Хувь хүний нууцын мэдээллээс бусад хувийн мэдээллийг мэдэгдэл өгөх замаар гуравдагч этгээдэд шилжүүлсэн нь зөвшөөрөл авсанд тооцогдоно. Мөн нэгэнт зөвшөөрөлтэй хүлээн авсан хувийн мэдээллийг гуравдагч этгээдэд шилжүүлэх асуудлыг нарийвчлан зохицуулсан. Хувийн мэдээлэл хамгаалах хувийн байгууллагыг магадлан итгэмжлэх асуудлыг зохицуулж мөн нууц нэрээр илэрхийлэгдсэн өгөгдөлтэй холбоотой харилцааг зохицуулж өгчээ.

*Хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийн бүтэц*[371]

*1 дүгээр бүлэг. Ерөнхий зарчим (1-3 дугаар зүйл)*

Хувийн мэдээлэл гэж мэдээлэлд багтсан нэр, төрсөн он сар өдөр болон бусад тодорхойлолт (баримт бичиг, зураг, цахилгаан соронзон бичлэг) байхыг заахаас гадна "хувийн таних код" гэдэг нь тодорхой хувь хүний биеийн онцлог шинж чанарыг компьютерт танихаар хөрвүүлсэн тэмдэгт, тоо болон бусад кодууд нь тухайн хүнийг таних боломжтой болон хувь хүмүүст үзүүлсэн үйлчилгээ, хувь хүнд олгосон карт эсвэл бусад баримт бичигт бичсэн, цахилгаан соронзон хэрэгслээр тэмдэглэсэн тэмдэгт, тоо байхыг тодорхойлсон.

Түүнчлэн хувийн нууцад арьс өнгө, шашин шүтлэг, өвчний түүх, гэмт хэргийн түүх, ялгаварлан гадуурхагдаж байсан түүх зэрэг хувь хүний сул мэдээлэл мөн багтахыг зааж,

[370] https://elaws.e-gov.go.jp/
[371] https://elaws.e-gov.go.jp/document?lawid=415AC0000000057

хувийн мэдээллийн сан, хувийн мэдээлэлтэй харьцах этгээд гуравдагч талтай мэдээллийг хэрхэн солилцох, нэрээ нууцалсан мэдээлэл мөн хүний мэдээллийг хувь хүнийг хүндэтгэх зарчмын дагуу анхаарах ёстойг зааж багтаасан.

*2 дугаар бүлэг. Улсын болон орон нутгийн засаг захиргааны үүрэг (4-6 дугаар зүйл)*

Төрөөс тухайн хуулийн зорилт зорилгын дагуу хувийн мэдээлэлтэй зохистой харьцахад шаардлагатай нөхцөлөөр хангах талаар боловсруулах, олон улсын байгууллагуудтай харилцах бусад үүргүүдийг заасан.

*3 дугаар бүлэг. Хувийн мэдээллийг хамгаалахтай холбоотой арга хэмжээ*

Төрөөс хувийн мэдээллийн талаарх мэдээлэл сурталчилгаагаар хангах, хамгаалах мөн бусад хувийн мэдээлэлтэй харьцах байгууллагуудтай хэрхэн харилцаж, энэ нь Засгийн газар түүнчлэн Ерөнхий сайдын ажлын хүрээнд хэрхэн танилцуулагдаж, хувийн мэдээллийг хамгаалах тухай заасан.

Хэсэг 1. Хувийн мэдээллийг хамгаалах үндсэн бодлого (7 дугаар зүйл)
Хэсэг 2. Улсын бодлого (8-10 дугаар зүйл)
Хэсэг 3. Орон нутгийн засаг захиргааны арга хэмжээ (11-13 дугаар зүйл)
Хэсэг 4. Улсын болон нутгийн захиргааны хамтын ажиллагаа (14 дүгээр зүйл)

*4 дүгээр бүлэг. Хувийн мэдээлэлтэй харьцах бизнес эрхлэгчдийн үүрэг хариуцлага*

Хувийн мэдээлэлтэй харьцах бизнесийн байгууллагуудын өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, тэдэнд мэдээлэл өгөх, мэдээлэлтэй харьцах зөвшөөрлийг хувь хүний мэдээллийг хамгаалах комиссоос хэрхэн олгох тухай заасан.

Хэсэг 1. Хувийн мэдээлэлтэй харьцах бизнес эрхлэгчдийн үүрэг (15-35 дугаар зүйл)
Хэсэг 2. Нэрээ нууцалсан мэдээлэл боловсруулж буй аж ахуйн нэгжийн үүрэг (36-39 дүгээр зүйл)
Хэсэг 3. Хяналт шалгалт (40-46 дугаар зүйл)
Хэсэг 4. Хувийн мэдээллийг хамгаалах хувийн хэвшлийн байгууллагын сурталчилгаа (47-58 дугаар зүйл)

*5 дугаар бүлэг. Хувийн мэдээллийг хамгаалах комисс (59-74 дүгээр зүйл)*

Хувийн мэдээлэл хамгаалах комисс нь Ерөнхий сайдын харьяанд байх бөгөөд хуулийн зорилт зорилгыг хангуулах ажлыг хэрэгжүүлж, мэдээлэлтэй харьцах, бизнес эрхлэгчдэд хяналт тавих, хамтран ажиллах, заавар зөвлөгөө өгөх, олон нийттэй харьцах, соён гэгээрүүлэх, шаардлагатай судалгаа хийнэ. Мөн комиссын дарга, гишүүдийн бүрэн эрх, бүрэн эрхийн хугацаа, орон тоо, тэдэнд тавигдах мэдлэг, ур чадварын шаардлага, хурлын тов, хариуцлага тооцох, комиссын гишүүний байх хугацаанд хориглох ажил, албан тушаалыг тус тус заасан.

*6 дугаар бүлэг. Дүрэм журам (75-81 дугаар зүйл)*

Хувийн мэдээлэлтэй харьцдаг аж ахуйн нэгжүүдийн зорилгыг бүхэлд нь буюу хэсэгчлэн тогтоож, тэдэнтэй харьцах, гомдлыг шийдэх, гадаадын хууль сахиулах байгууллагуудтай хэрхэн харьцах тухай заасан.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

*7 дугаар бүлэг. Эрүүгийн хариуцлага (82-88 зүйл*)

Эрүүгийн хариуцлага нь тодорхой хугацаагаар ажил хийлгэх, мөнгөн торгууль ногдуулах тухай заасан. Мөн Япон улсаас гадна үйлдэгдсэн эрүүгийн хариуцлага ч багтана.

Тус хуулийн онцлог зохицуулалт нь Хувийн мэдээллийг хамгаалах комисстой байх заалт оруулж ирсэн. Хуулийн зохицуулалтаас дурдвал:

**Хувийн мэдээллийг хамгаалах комисс (5 дугаар бүлэг)** нь (цаашид "хороо" гэх)-ийг Засгийн газрын хэрэг эрхлэх газрыг байгуулах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн заалтыг үндэслэн байгуулна. Хороо нь Ерөнхий сайдын харьяанд байна.

Үндсэн үүргээ биелүүлэхийн тулд дараах ажлыг хариуцна.

- Үндсэн бодлогыг боловсруулах, сурталчлахтай холбоотой асуудлыг хариуцах;
- Хувийн мэдээлэл, нэрээ нууцалсан хувийн мэдээллийн боловсруулалт хийхтэй холбоотой гомдлын талаарх шаардлагатай зохицуулалт, тэдгээрийг боловсруулдаг аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллах;
- Хувийн мэдээллийг хамгаалах эрх бүхий байгууллагуудтай холбоотой асуудлыг хариуцах;
- Хувийн мэдээллийг хамгаалах тодорхой үнэлгээтэй холбоотой асуудлыг хариуцах;
- Хувийн мэдээллийг хамгаалах, зохистой, үр дүнтэй ашиглах талаар олон нийттэй харилцах, соён гэгээрүүлэхтэй холбоотой асуудлыг хариуцах;
- Захиргааны ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай мөрдөн байцаалт, судалгааны талаарх асуудлыг хариуцах;
- Захиргааны ажилтай холбоотой олон улсын хамтын ажиллагааны асуудлыг хариуцах;
- Хороонд харьяалагдах ёстой хууль зүйн үйлчилгээг үзүүлэх.

Хороо нь дарга, найман гишүүнтэй, дөрөв нь орон тооны бус байж болно. Хорооны дарга, гишүүдийг Ерөнхий сайд хоёр танхимын зөвшөөрлөөр ёс зүйн өндөр ёс суртахуунтай хүмүүсийг томилно.
Дарга, гишүүдэд хувийн мэдээллийг хамгаалах чиглэлээр эрдэм шинжилгээний ажлын туршлагатай, хэрэглэгчдийг хамгаалах талаар хангалттай мэдлэг, туршлагатай, мэдээлэл боловсруулах технологийн чиглэлээр ажиллаж туршлагажсан хүмүүс багтдаг. Дарга, гишүүдийн бүрэн эрхийн хугацаа таван жил байна. Хорооны дарга, гишүүд, шинжээч зөвлөхүүд, ажилтнууд ажил үүргээ гүйцэтгэж байхдаа олж мэдсэн нууцыг задруулж, хууль бусаар ашиглах ёсгүй. Энэ нь ажлаасаа гарсан ч гэсэн мөн адил хамаарна.

### 2.2. Америкийн Нэгдсэн Улс

АНУ нь Нууцлалын тухай хууль[372] (Privacy Act)-ийг 1974 онд баталсан. Уг хуулиар холбооны байгууллагуудын бүртгэлийн системд хадгалагдаж буй хувь хүмүүсийн талаарх мэдээллийг цуглуулах, хадгалах, ашиглах, задруулах тухай зохицуулалтыг зааж өгсөн.

[372] *Privacy Act of 1974 - https://www.justice.gov/opcl/privacy-act-1974*

Энэ хуулиар компьютержсэн мэдээллийн бааз үүсгэж ашиглаж байгаа нь хувь хүний нууцлалын эрхэнд хэрхэн нөлөөлж буйтай холбогдуулан дараах дөрвөн хувийн мэдээллээр нууцлалыг хамгаалах хуулийн зохицуулалтыг тусгажээ.[373] Үүнд:

1. хувь хүний талаар хадгалагдсан аливаа бүртгэлийг тухайн хүнд үзүүлэхийг төрийн байгууллагуудаас шаардах;
2. хүний хувийн мэдээллийг цуглуулах болон боловсруулахдаа төрийн байгууллагууд нь “Мэдээллийн шударга практик” буюу тодорхой захирамж, зөвлөмжийг дагаж мөрдөх;
3. тодорхой чиглэлийн агентлагууд тухайн хүний мэдээллийг бусад хүмүүс болон агентлагуудтай хэрхэн хуваалцах талаар хязгаарлалт тавих;
4. хууль зөрчсөн тохиолдолд хувь хүмүүс нь Засгийн газрыг шүүхэд өгөх боломжтой байх.

Төрийн үйлчилгээний байгууллагууд, цэргийн алба, бие даасан зохицуулах агентлагууд, Засгийн газрын хяналттай корпорацууд бүгд энэ хуульд хамрагдана.

2018 онд хамгийн олон хүн амтай Калифорниа муж нь Хэрэглэгчийн нууцлалын тухай хууль[374] (CCPA-California Consumer Privacy Act)-ийг баталсан. Тус муж нь Google, Facebook зэрэг мэдээлэл технологийн томоохон компаниудтай.

Хэрэглэгчийн нууцлалын тухай хууль нь бизнес эрхлэгчдийн цуглуулсан хувийн мэдээллийг хянах боломжийг олгодог бөгөөд Хэрэглэгчийн нууцлалын тухай хуулийг хэрхэн хэрэгжүүлэх талаар зааварчилгаа өгдөг. Уг хуулиар Калифорнийн хэрэглэгчдэд хувийн мэдээлэлтэй холбоотой дараах эрхийг баталгаажуулсан. Үүнд:

- бизнес эрхлэгчдээс хувийн мэдээлэл, түүнийг хэрхэн ашиглаж, задруулдаг талаар мэдэх эрх;
- хувийн мэдээлэл цуглуулагчаас, цуглуулсан хувийн мэдээллийг устгах хүсэлт гаргах эрх;
- хувийн мэдээллээ борлуулахаас татгалзах эрх;
- мэдээлэл цуглуулагч нь эрхээ хэрэгжүүлсэн шалтгаанаар хэрэглэгчдийг ялгаварлан гадуурхахгүй байх.

Одоогийн байдлаар бусад мужууд мөн хүний хувийн мэдээллийг хамгаалах хуулиудыг батлахаар идэвхтэй байгаа юм.

1973 онд АНУ-ын Эрүүл мэнд, боловсрол, халамжийн газраас (HEW) гаргасан Бүртгэл, компьютер, иргэдийн эрх гэсэн тайланд дараах асуудлуудыг хуульчлах зөвлөмж гаргаж автоматжуулсан мэдээллийн баазыг хариуцдаг байгууллага хувийн хэвшлийн байгууллагуудаас доорх зүйлийг хийхийг шаардсан байдаг. Үүнд:

1. тухайн өгөгдлийг хамгаалах хамгаалалт гаргах;
2. ямар мэдээллийн санд ямар төрлийн мэдээлэл хадгалж байгааг жил бүр олон нийтэд тайлагнах;
3. хүний “өгөгдлийн субъект”-д зайлшгүй багтах эрхийн жагсаалтыг гаргах.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[373] https://www.govinfo.gov/content/pkg/USCODE-2018-title5/pdf/USCODE-2018-title5-partI-chap5-subchapII-sec552a.pdf
[374] https://oag.ca.gov/privacy/ccpa

*Хуулийн зохицуулалтын ерөнхий агуулга*

Нууцлалын тухай хуульд Засгийн газрын байгууллага бүртгэлийн системд авагдсан мэдээллийг задруулахыг хязгаарласан.

Хууль сахиулах байгууллага нь мэдээллийн сангийнхаа хэвийн байдал, шинж чанарыг Холбооны бүртгэлд нийтэлж, тогтмол хэрэглээ, өгөгдөл хадгалах бодлого, систем хариуцсан албан тушаалтны холбоо барих мэдээллийг оруулна. Шүүхийн шийдвэр эсвэл зарлан дуудах хуудаснаас болж бүртгэлээ ил болгосон тохиолдолд хувь хүнд мэдэгдэх ёстой.

Мөн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хамгаалах талаар зохих журам, хамгаалалтын механизмыг бий болгох шаардлагатай байдаг байна.

Хувь хүний мэдээлэл хамгаалах тусгай зохицуулалт

Нууцлалын тухай хуулийн заалтыг зөрчсөн тохиолдолд иргэний болон эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан байдаг.[375]

Иргэний хариуцлага: Хэрэв агентлагийг хувь хүн өөрийн бүртгэлд нэвтэрч ажил мэргэжил, зан чанар, бусад бүртгэлд хамааралгүй мэдээлэлд нэвтэрснийг эс хүлээн зөвшөөрвөл тухайн иргэн иргэний шүүхэд нэхэмжлэл гаргаж, бүртгэлийг хийлгэх боломжтой. Хэрэв шүүх агентлагийг Нууцлалын тухай хуулийн заалтыг “санаатай буюу санамсаргүйгээр” зөрчсөн гэдгийг тогтоовол, зөрчлийн улмаас учирсан бодит хохирлыг тухайн хүнд төлөх, мөн өмгөөллийн хөлсийг гаргуулахаар тогтооно. Гэхдээ ямар ч тохиолдолд хохирлоо нөхөн төлүүлэх хувь хүн 1,000 ам.доллараас багагүй нөхөн төлбөр авдаг байна.

Эрүүгийн хариуцлага: Хувь хүнтэй холбоотой аливаа мэдэгдлийг санаатайгаар гаргаж өгөх хүсэлт гаргасан эсвэл олж авсан хүн, мөн эрх бүхий албан тушаалтан өөрийн ажлын байрны давуу талаа ашиглан хувийн мэдээллийг бусдад задруулах, задруулахыг зөвшөөрсөн хууль бус үйлдэл үйлдсэн нь тогтоогдвол 5,000 хүртэл ам.долларын торгууль ногдуулж болно.

Монгол Улсын Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төслийн зарим зүйл заалтыг АНУ-ын Нууцлалын тухай хуультай харьцуулсан нь:

| ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ ХАМГААЛАХ ТУХАЙ (төсөл) | The Privacy Act |
|---|---|
| **4 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт**<br><br>4.1.1.“хүний хувийн мэдээлэл” гэж хүний эмзэг мэдээлэл болон хүний эцэг, эхийн нэр, өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр, төрсөн газар, оршин суугаа газрын хаяг, байршил, иргэний бүртгэлийн дугаар, боловсрол, гишүүнчлэл, цахим тодорхойлогч, хүнийг шууд болон шууд бусаар тодорхойлох, эсхүл тодорхойлох боломжтой бусад мэдээллийг;<br><br>4.1.2.“хүний эмзэг мэдээлэл” гэж хүний үндэс, угсаа, шашин шүтлэг, итгэл үнэмшил, эрүүл | (4) " бүртгэл " гэсэн нэр томьёо нь хувь хүний боловсрол, санхүүгийн гүйлгээ, өвчний түүх, гэмт хэрэг, ажил эрхлэлт, тухайн хүний нэр, бүртгэлийн дугаар, тэмдэг болон бусад тухайн хүний тодорхойлох хурууны хээ, дуу хоолой, зураг зэрэг бусад мэдээллийг багтаасан, тухайн байгууллагад хадгалагдаж буй хувь хүний талаарх аливаа мэдээллийн цуглуулга, хэрэгсэл, бүлэглэлийг хэлнэ. |

ПАРЛАМЕНТ СУДАЛГААНЫ САН

[375]https://www.govinfo.gov/content/pkg/USCODE-2018-title5/pdf/USCODE-2018-title5-partI-chap5-subchapII-sec552a.pdf

| | |
|---|---|
| мэнд, хөрөнгө, захидал харилцаа, генетик болон биометрик мэдээлэл, цахим гарын үсэг, ял эдэлж байгаа болон ял эдэлсэн эсэх, бэлгийн чиг хандлага, бэлгийн харьцааны талаарх мэдээллийг; | |
| **6 дугаар зүйл. Төрийн байгууллага мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах**<br><br>6.1.Төрийн байгууллага дараах тохиолдолд мэдээлэл цуглуулж, боловсруулна:<br>6.1.1.мэдээллийн эзний зөвшөөрлөөр;<br>6.1.2.хуульд заасан үндэслэлээр;<br>6.1.3.хуульд заасан тохиолдолд хөдөлмөрийн харилцааны явцад мэдээлэл хариуцагч эрхээ эдлэх, үүргээ биелүүлэх;<br>6.1.4.гэрээ байгуулах, байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангах;<br>6.1.5.Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх;<br>6.1.6.мэдээллийн эзний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөөгүй тохиолдолд хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх.<br><br>6.2.Төрийн байгууллага дараах тохиолдолд мэдээллийг ашиглана:<br>6.2.1.мэдээллийн эзний зөвшөөрлөөр;<br>6.2.2.хуульд заасан үндэслэлээр;<br>6.2.3.мэдээллийн эзний амь нас, бие махбодь, эрх, эрх чөлөө, эд хөрөнгөд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх, түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;<br>6.2.4.бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх;<br>6.2.5.хүнийг тодорхойлох боломжгүй болгож түүх, эрдэм шинжилгээ, урлаг, утга зохиолын бүтээл туурвих, статистикийн мэдээлэл бэлтгэх.<br>6.3.Төрийн байгууллага хүнийг тодорхойлох боломжгүй болгож мэдээллийн эзний мэдээллийг нээлттэй өгөгдөл болгохдоо Нийтийн мэдээллийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан журмыг баримтална.<br><br>**7 дугаар зүйл. Хүн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах**<br><br>7.1.Төрийн байгууллагаас бусад хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага, хүн дараах тохиолдолд мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглана:<br>7.1.1.энэ хуулийн 6.1.1, 6.1.2, 6.1.3, 6.1.4-т заасан үндэслэлээр;<br>7.1.2.хуульд заасны дагуу нийтэд ил болгосон;<br>7.1.3.хүнийг тодорхойлох боломжгүй болгож түүх, эрдэм шинжилгээ, урлаг, утга зохиолын бүтээл туурвих, статистикийн мэдээлэл бэлтгэх. | **Мэдээллийг ил болгох нөхцөл**<br><br>Дараах нөхцөлдөхөөс бусад тохиолдолд Мэдээллийн системд орсон аливаа бүртгэлийг ямар ч байгууллага, хэн нэгэн, эсвэл өөр байгууллагад бичгээр гаргасан хүсэлт, эсхүл тухайн мэдээллийн эзэн болох хүний бичгээр өгсөн хүсэлт эсхүл бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр бусад байгууллагад задруулж болохгүй:<br><br>(1) ажил үүргээ гүйцэтгэж байхдаа бүртгэл хөтлөх шаардлагатай байгаа бүртгэл хөтлөх байгууллагын ажилтнууд болон ажилтнуудад;<br>(2) энэ гарчгийн 552 -р хэсэгт заасан;<br>(3) энэ хэсгийн (a) (7) дэд хэсэгт тодорхойлсон бөгөөд энэ хэсгийн (e) (4) (D) дэд хэсэгт тайлбарласан ердийн хэрэглээнд зориулагдсан;<br>(4) 13-р зүйлийн заалтын дагуу тооллого, судалгаа, холбогдох үйл ажиллагааг төлөвлөх, явуулах зорилгоор тооллогын товчоонд;<br>(5) уг бүртгэлийг зөвхөн статистикийн судалгаа эсвэл тайланд ашиглаж тухайн эх сурвалжаас хувь хүнийг тодорхойлох боломжгүй хэлбэрээр ашиглана гэдгээ урьдчилан бичгээр баталгаажуулан агентлагт;<br>(6) Архив, Бүртгэлийн Үндэсний Захиргаанд АНУ-ын Засгийн газар үргэлжлүүлэн хадгалж үлдэх, эсвэл АНУ-ын Архивын ажилтан эсвэл Архивын ажилтан түүхэн болон бусад үнэ цэнийг агуулсан мэдээлэл мөн эсэхийг үнэлэх зорилгоор;<br>(7) өөр байгууллагад, эсхүл АНУ-ын хяналтад байгаа, хяналтад байгаа засгийн газрын харьяаллын байгууллагад иргэний болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаа явуулахыг хуулиар зөвшөөрсөн, мөн агентлагийн дарга тухайн холбогдох мэдээллийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд авах гэж байгаагаа тодорхойлон бичгээр тухайн мэдээллийг хадгалагч байгууллагаас хүссэн тохиолдолд;<br>(8) тухайн хүний эрүүл мэнд, аюулгүй байдалд нөлөөлөх ноцтой нөхцөл байдлыг баталж харуулсан хүнд;<br>(9) Конгрессын Танхимд, эсхүл харьяаллын асуудлын хүрээнд түүний аль ч хороо, дэд хороо, Конгрессын хамтарсан хороо, ийм хамтарсан хорооны дэд хороонд; |

| | |
|---|---|
| | (10) Засгийн газрын Хариуцлагын албаны үүргийг гүйцэтгэж байх үед Ерөнхий хянагч эсвэл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчдөд;<br>(11) эрх бүхий харьяаллын шүүхийн шийдвэрийн дагуу; эсвэл<br>(12) хэрэглэгчийг мэдээлэх байгууллагад. |
| **16 дугаар зүйл. Мэдээллийн эзний эрх**<br><br>16.1.Мэдээллийн эзэн дараах эрхтэй:<br>--<br>16.1.8.өөрт хамааралтай мэдээллийн хуулбарыг мэдээлэл хариуцагчаас цаасан, эсхүл цахим хэлбэрээр гаргуулан авах; | **Бүртгэл хайх, авах**<br><br>Бүртгэлийн систем хөтлөх агентлаг бүр:<br>(1) Хувь хүний хүсэлтээр түүний бүртгэл эсвэл системд байгаа өөртэй нь холбоотой мэдээллийг олж авахыг хүсвэл түүнийг болон түүний хүсэлтээр дагалдан явах хүний хамтаар бүртгэлтэй танилцах, өөрийн хүссэн хэлбэрээр хуулбарлан авахыг зөвшөөрнө. Бүртгэлтэй танилцахад дагалдах хүнтэй байх бол бичгээр дагалдах хүнтэй хамт бүртгэлтэй танилцах талаар бичгээр мэдэгдэл бичиж өгөхийг тухайн байгууллага хүсэж болно.<br>(2) Хувь хүн өөртэй нь холбоотой мэдээллийг засварлах хүсэлт тавихыг зөвшөөрөх.<br>(3) Тухайн хүсэлтийг татгалзвал гомдол гаргах эрхийг баталгаажуулах |
| 29.5.Мэдээллийг энэ хуульд заасны дагуу олж мэдсэн этгээд бусдад задруулахыг хориглоно. | **Шуудангийн жагсаалт**<br><br>Хувь хүний нэр, хаягийг хуулиар тусгайлан зөвшөөрөөгүй бол агентлаг худалдах, түрээслэх эрхгүй. |

## Гурав. МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН

### 3.1. Бодлогын баримт бичиг

Хүний хувийн мэдээлэл хамгаалах зохицуулалт нь эрх зүйн шинэтгэлийн болон бусад бодлогын баримт бичигт дараах байдлаар тусгасан байна.

*а) Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрт:*[376]

- 5.Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийг Монгол Улсын Хөгжлийн болон **Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг иш үндэс болгон** жил бүрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлд тусгах замаар тодорхой үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 7.Монгол Улсын **тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хангах эрх зүйн үндсийг бататгана.** Ингэхдээ Монгол Улс нь төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байж, нутаг дэвсгэр нь зөвхөн засаг захиргааны нэгжид хуваагдах, **засгийн бүх эрх ард түмний мэдэлд байж** ард түмэн шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдлэх зарчмуудыг хангах механизмыг төгөлдөржүүлнэ.
- 18. 2/хүн бүр эрх зүйн этгээд байна гэсэн Үндсэн хуулийн зарчмыг хууль тогтоох үйл ажиллагаанд удирдлага болгох;
- 18. 3/Монгол Улсын иргэний үндсэн эрх, эрх чөлөөг Үндсэн хуулийн агуулга, үзэл

[376] Монгол Улсын Их Хурлын 1998 оны 18 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

санаанд нийцүүлэн хуульчлан бататгаж, хүний эрхийг зөвхөн хуульд заасан үндэслэлээр хязгаарлах;

*б) “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд:*[377]

- *I үе шат (2021-2030):* **Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан**, үр дүнтэй цахим засаглалын бодлогын болон **хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, төлөвшүүлэх үе.**
- Зорилт 5.3.Хүний хөгжлийг дэмжсэн, үр дүн, үр нөлөөтэй цахим засаглалыг төлөвшүүлнэ.
- 5.3.1.Мэдээллийн аюулгүй байдлын, цахим гарын үсгийн, мэдээллийн сангийн**, хувь хүний мэдээллийн аюулгүй байдлын** зэрэг **цахим засаглалыг хөгжүүлэхэд шаардагдах хууль тогтоомжийг боловсруулж батлуулан,** түүнтэй нийцүүлэн холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулна.
- Зорилт 7.5.Төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг баталгаажуулж, өрсөлдөх чадварыг бий болгоно.

*в) Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд:*[378]

- **Мэдээллийн салбарт үндэсний ашиг сонирхлыг хамгаалах**, **төр**, **иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан,** хүртээмжтэй **байдлыг баталгаажуулах нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэс мөн**.
- 3.6.1.1.**Үндэсний аюулгүй байдлыг хангах**, улс орны хөгжлийг дэмжих, үндэсний үнэт зүйлийг хэвшүүлэх, **нийгмийн оюун санааг төлөвшүүлэхэд мэдээлэл, мэдээллийн аюулгүй байдал нэн чухал ач холбогдолтой**.
- 3.6.1.2.**Нийгмийн сэтгэл зүй, тогтвортой байдал, хувь хүний ухамсар, ёс зүйд хөндлөнгөөс нөлөөлөх оролдлогыг хязгаарлана. Дайсагнал, ялгаварлан гадуурхах үзэл, үзэн ядалтыг сурталчилсан, дэмжсэн сурталчилгаа, мэдээллийг таслан зогсоох, саармагжуулах чадавхыг бий болгож**, үл зөвшөөрөх сэтгэхүйг нийгэмд төлөвшүүлнэ.
- 3.6.2.3.**Хуулиар зөвшөөрсөн, өөрөө зөвшөөрснөөс бусад тохиолдолд хувь хүний тухай мэдээллийг цуглуулах, хадгалах, ашиглах, бусдад шилжүүлэхийг хориглоно**.

### 3.2. Хувь хүний нууц

Монгол Улсын Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтад “... Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална”, мөн зүйлийн 17 дахь заалтад “... Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална” гэж заасан. Энэ зохицуулалтаас үзвэл, хувь хүн нууцтай байх, түүнийгээ хуулиар хамгаалуулах шаардлагатайг үндсэн хуульд ийнхүү тусгасан.

Дээрх зохицуулалтад үндэслэн 1995 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр “Хувь хүний нууцын тухай” хууль батлагдаж, мөн оныхоо 7 дугаар сарын 01-ний өдрөөс даган мөрдөгдөж эхэлсэн бөгөөд тус хууль нь хувь хүний нууцыг хамгаалахтай холбогдох харилцааг зохицуулж буй суурь эрх зүйн зохицуулалт юм.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

---

[377] Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт
[378] Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралт

Тус хуульд “***Хувь хүний нууц*** гэж Монгол Улсын болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн нууцалсан бөгөөд задруулбал тухайн хүний хууль ёсны ашиг сонирхол, нэр төр, алдар хүндэд илтэд хохирол учруулж болзошгүй мэдээ, баримт бичиг, биет зүйлийг хэлнэ” хэмээн тодорхойлсон бөгөөд хувь хүний нууцыг дараах 5 төрөлтэй байхаар хуульчилсан. Үүнд:

1. *Захидал харилцааны нууц:* Захидал, цахилгаан, илгээмж, өргөдөл зэрэг шуудан холбооны хэрэгслээр бусад хүн, байгууллагатай солилцож буй мэдээ, баримт бичиг, биет зүйл
2. *Эрүүл мэндийн нууц:* Тухайн хувь хүний бие эрхтний гажиг, нийтэд аюултай онцлог зарим халдварт өвчнөөс бусад өвчнөөр өвчилсөн тухай мэдээлэл
3. *Хөрөнгийн нууц:* Зөвхөн эд хөрөнгө, оюуны өмч, эрхийн эзэн, эсхүл түүний итгэмжлэгдсэн хүмүүс мэдэх, түүнчлэн эрх бүхий байгууллага албан тушаалтны албан үүргийнхээ дагуу олж мэдсэн мэдээ, баримт бичиг, тоо, гэрээ хэлцэл, биет зүйл
4. *Гэр бүлийн нууц:* Бусдад задруулбал тухайн хувь хүн, түүний гэр бүлийн гишүүдийн нэр төр, алдар хүнд, ашиг сонирхолд харшлах мэдээлэл
5. *Хуулиар тогтоосон бусад нууц:* Хувь хүн өөрийн архив, хадгаламж, тэмдэглэл, битүүмжлэл болон тэдгээрт хамаарах дүрс, дуу бичлэгийг нууцалж болно.

Дээрх зохицуулалтаас үзэхэд хувь хүний нууц нь:

- Хуульд заасан байх,
- Задруулсан тохиолдолд тухайн хүний нэр төр, алдар хүндэд илтэд хохирол учруулж болзошгүй байх,
- Мэдээ, баримт бичиг, биет зүйл байх шаардлагатай байна.

Харин хувийн нууцад хамаарах мэдээллийн хэлбэрийн хувьд мэдээ, баримт бичиг, биет зүйл байна гэж тодорхойлсон. Эдгээрээс баримт бичиг, биет зүйлс нь бодитой оршиж, өөрөөр хэлбэл гарт баригдахуйц юмс байх бол “мэдээ” гэсэн ойлголтыг хэрхэн тодорхойлж болохоос хамаарч эдгээрээс бусад мэдээлэл (бодитоор хөрвүүлээгүй цахим систем дээрх хадгалагдсан зураг, бичлэг гэх мэт) хувийн нууцад хамаарах эсэхийг тодорхойлж болохоор байна.

Дээрх хуулийн зохицуулалтаас харахад Монгол Улс хувь хүний мэдээллийн зарим хэсгийг хувь хүний нууц гэж хуулиар тогтоосон байх бөгөөд төр болон хувийн байгууллагууд хувь хүний мэдээллийг цуглуулж байгаа харилцааг “Хувь хүний нууцын тухай” хуулиар зохицуулах боломжгүй байна.

### 3.3. Хувь хүний нууц ба хувийн мэдээлэл

Мэдээлэл харилцаа холбооны технологи хөгжихийн хэрээр мэдээлэл хүлээн авах, цуглуулах төрөл, хэлбэр улам өсөн нэмэгдэж, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд хувь хүний мэдээллийг цахим хэлбэрээр цуглуулах, боловсруулах, хадгалах, дамжуулах үйл ажиллагааг бий болгосноор хувь хүний мэдээлэл нь эдийн засгийн эргэлтэд орж, баялаг бүтээх нэг боломж болж байгаа сайн талтай хэдий ч нөгөө талаар хувь хүний мэдээлэл алдагдах, буруугаар ашиглагдах, мэдээллийг зөвшөөрөлгүйгээр ашиглаж, боловсруулах замаар хувь хүний эрх, эрх чөлөөнд халдах эрсдлийг дагуулж байдаг.

Одоогийн байдлаар Монгол Улсын “Хувь хүний нууцын тухай” хуульд хувь хүний нууцыг хамгаалах, зөвшөөрөлгүйгээр задруулахыг хориглосон зүйл заалт хэт ерөнхий

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

агуулгатай байх бөгөөд хувь хүний мэдээллийг цуглуулах, бүртгэх, хадгалах, хамгаалах, дамжуулах, ашиглах, өөрчлөх, устгах зэрэг мэдээлэл боловсруулалтын үйл ажиллагаа явуулахад хувь хүн болон хувь хүний мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглах талаар нарийвчилсан заалт байхгүй байна.

Харин тусгай харилцааг зохицуулсан 2011 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан “Сонгуулийн автоматжуулсан системийн тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь хэсэгт “сонгогчийн хувийн мэдээлэл’’ гэж тухайн иргэнийг гэрчлэх талаар хуульд заасан албан ёсны баримт бичигт туссан мэдээлэл, гэрэл зураг, биеийн давхцахгүй өгөгдөл (гарын хурууны хээ)-ийг хэлнэ гээд сонгогч тус мэдээллээ авах эрхтэйгээр зохицуулжээ. Гэвч уг хууль нь зөвхөн сонгууль зохион байгуулах үед ашиглагдах тул уг тодорхойлолтыг ерөнхийлөн хэрэглэх боломжгүй юм.

Мөн 2018 оны 6 дугаар сарын 21-ний өдөр батлагдсан Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 3.1.6-д “*иргэний үнэмлэхний санах ой* гэж энэ хуульд заасны дагуу иргэний хувийн мэдээллийг агуулсан, мэдээлэл нь бичигдэх, уншигдах, өөрчлөгдөх боломжтой цахим санах ойг хэлнэ” гээд иргэний улсын бүртгэл хийхэд энэхүү мэдээллийг ашиглаж болохоор зохицуулжээ.

“Үндэсний аюулгүй байдлын тухай” хуулийн 3 дугаар зүйлийн 3.4-т зааснаар мэдээллийн аюулгүй байдал нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг байхаар хуульчилсан. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчныг сайжруулах төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг хангасан мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоог дараах бодлогын баримт бичигт тусгасан байна. Үүнд: Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.6 дахь хэсэгт “Мэдээллийн салбарт үндэсний ашиг сонирхлыг хамгаалах, төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг баталгаажуулах нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэс мөн” гэж заасан. Мөн үзэл баримтлалын 3.6.3.1-т “Мэдээлэл түүний бүрдэл хэсэгт хууль бусаар хандах, халдах, задрахаас хамгаалагдсанаар нууцлал хангагдана” гэж, 3.6.3.7-д “Үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд хувийн болон гэр бүлийн нууц, захидал харилцаа, мэдээллийн нууц, нэр төрөө хамгаалах эрх, эрх чөлөөнд халдахыг хориглоно’’ гэж, 3.6.2.3-т “Хуулиар зөвшөөрсөн, өөрөө зөвшөөрснөөс бусад тохиолдолд хувь хүний тухай мэдээллийг цуглуулах, хадгалах, ашиглах, бусдад шилжүүлэхийг хориглоно’’ гэж тус тус тусгасан байна.

Өргөн мэдүүлээд байгаа “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай” хуулийн төсөл нь үндэсний бие даасан хуулиар тухайн харилцааг нэгтгэн зохицуулахыг эрмэлзсэн бөгөөд хууль тогтоомжийн хувьд Үндсэн хууль, Иргэний хууль, Хувь хүний нууцын тухай хууль, Нийтийн мэдээллийн тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль зэрэгт үндэслэхээр дарааллыг тодорхойлсон байна.[379]

Монгол Улсын хувьд, Аюулгүй байдлын уламжлалт бус сорилтуудын нэг нь хүмүүсийн зан төлөв, шашны болон улс төрийн итгэл үнэмшил, айдас, хүсэл зориг зэрэг хувийн болон эмзэг мэдээллийг цуглуулж түүнийгээ нийгмийн сэтгэл зүйд нөлөөлөх, улс төрийн ухуулга сурталчилгаа хийх зэргээр ашиглах явдал мөн. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын[380] §3.6-д “***Мэдээллийн салбарт*** *үндэсний ашиг сонирхлыг*

[379] Хуулийн төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг.
[380] Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралт

*хамгаалах*, төр, ***иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан,*** *хүртээмжтэй* ***байдлыг баталгаажуулах нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэс мөн***.” гэж заасан.[381]

**ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХҮРЭЭНД АНХААРАХ ЗОХИЦУУЛАЛТ:**

- Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн үйлчлэх хүрээг тодорхой болгох;
  Хүний хувийн мэдээлэл хамгаалах хуулийн төслийн 3.3.1-т зааснаар хувийн мэдээллийг “хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг зөрчихгүйгээр” гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагчид цуглуулах, боловсруулах, ашиглах тохиолдолд тус хууль үйлчлэхгүй байхаар заасан нь хүний халдашгүй байх эрхийг бүрэн хамгаалаагүй байна. Хувь хүн өөрийн хүссэн хувийн мэдээллээ гэр бүлдээ хуваалцсанаас бусад хувийн мэдээллийг нь мэдэгдэлгүйгээр аливаа хэлбэрээр цуглуулах, боловсруулах, ашиглах нь түүний хувийн орон зайд халдаж хувийн халдашгүй байдлыг нь зөрчсөн үйлдэл болно. Түүнчлэн хувийн нууцтай байх эрх зөрчигдөхөөр байна.
- Хүүхдийн хувийн мэдээллийг хамгаалахтай холбоотой харилцааг зохицуулах;
  Хуулийн төслийн 4.1.7 дахь хэсэгт “мэдээллийн эзэн” гэж 4.1.1-д заасан мэдээллээр тодорхойлогдож байгаа хүн, мөн төслийн 8.5-д заасан иргэний мэдээллийг цуглуулахад түүний хууль ёсны төлөөлөгчөөс зөвшөөрөл авна гэж зааснаас өөрөөр 18 насанд хүрээгүй хүн буюу хүүхдийн хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглахтай холбоотой харилцааг зохицуулаагүй байна. Тодорхой насанд хүрсэн хүүхэд өөрийн мэдээллийг хамгаалах, бусад этгээд цуглуулах, боловсруулах, ашиглахад үзэл бодлоо илэрхийлж, хууль ёсны төлөөлөгчтэй санал солилцох, эрхээ хамгаалуулах шаардлага гаргах эрхтэй.
- Мэдээллийн эзний хүсэлтээр мэдээллийг устгах нөхцөлийг тусгаж, хувь хүний халдашгүй байдлыг хамгаалах;
  Хуулийн төслийн 15 дугаар зүйлд мэдээллийг устгах 4 нөхцөлийг тодорхойлсон. Үүнд:

- Мэдээллийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу цуглуулж, боловсруулж, ашиглаагүй бол мэдээллийн эзний хүсэлтээр;
- Хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрээр мэдээллийг устгахаар мэдээлэл хариуцагчид үүрэг хүлээлгэсэн;
- Хуульд заасны дагуу цуглуулснаас бусад мэдээллийг анх цуглуулсан зорилгод хүрсэн, эсхүл гэрээнд заасан;
- Хуульд заасан бусад.

Хүний хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах явцад хувийн халдашгүй байх эрх зөрчигдөж болзошгүй тул мэдээллийн эзнээс зайлшгүй зөвшөөрөл авах шаардлага үүсдэг. Мэдээллийн эзэн өөрийн хувийн халдашгүй байдлыг хамгаалах үүднээс мэдээллийг устгуулах эрхтэй байх шаардлагатай. Иймд “мартагдах эрх”-ийг хэрэгжүүлэх боломжийг тусгах шаардлагатай.

- Мэдээлэл хариуцагчаас мэдээлэл боловсруулагчтай гэрээ байгуулан хамтран ажиллах тохиолдолд мэдээллийн эзнээс мэдээллийг дамжуулах зөвшөөрөл авах.
  Хуулийн төслийн 19, 22 дугаар зүйлүүдэд мэдээлэл хариуцагч нь мэдээлэл боловсруулагчтай байгуулсан гэрээний дагуу хүний хувийн мэдээллийг

[381] Энэ өгүүллийн гуравдугаар хэсгээс дэлгэрүүлж үзнэ үү.

шилжүүлэхдээ мэдээллийн эзнээс зөвшөөрөл авах талаар зохицуулаагүй нь хүний хувийн мэдээллийг ямар шатаар цуглуулж буй нь тодорхой бус, мэдээллийг цуглуулах, боловсруулахтай холбоотой үүссэн эрхийн зөрчил нь мэдэгдэхгүйн улмаас эрхээ хамгаалуулах арга хэмжээг авах боломж хязгаарлагдмал байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ


*Нэг. Бодлогын баримт бичиг*

- *Монгол Улсын Үндсэн хууль,1992 он. www.Legalinfo.mn - Хуулийн нэгдсэн портал сайт*
- *Хувь хүний нууцын тухай хууль, 1995 он. www.Legalinfo.mn - Хуулийн нэгдсэн портал сайт*
- *Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, 2001 он. www.Legalinfo.mn - Хуулийн нэгдсэн портал сайт*
- *Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал,1946 он.*
- *Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын акт, 1966 он.*
- *НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас баталсан 45/95 тоот шийдвэр, 1990 он.*
- *Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын Их хурлын 48 дугаар тогтоол, 2010 он.*
- Хувь хүний нууц, Холбогдох мэдээллийг хамгаалах харилцааг зохицуулж буй эрх зүйн орчин болон практикийн судалгаа (Судалгааны тайлан) 2020он. Номин энд Адвокатс ХХН.
- Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн хэрэгцээ, шаардлагын урьдчилан тандан судалгааны тайлан 2020 он. “Монгол өмгөөлөгч” хууль зүйн фирм.
- Докторант М.Хатанзориг багшийн илтгэл. Шихихутуг Их Сургууль

*Хоёр. Цахим эх сурвалж*

- Европын холбооны “Өгөгдөл хамгаалах ерөнхий дүрэм”” https://gdpr-info.eu/
- Тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн гишүүн орнуудын “Хувь хүний мэдээллийн тухай” загвар хууль https://cis-legislation.com/document.fwx?rgn=116757
- *Япон Улс “Хувийн мэдээлэл хамгаалах тухай” хууль https://elaws.e-gov.go.jp/*
- *АНУ-ын Нууцлалын тухай хууль https://www.justice.gov/opcl/privacy-act-1974*
- АНУ-ын хувь хүний мэдээлэл хамгаалах тусгай зохицуулалт https://www.govinfo.gov/content/pkg/USCODE-2018-title5/pdf/USCODE-2018-title5-partI-chap5-subchapII-sec552a.pdf
- АНУ, Калифорни муж “Хэрэглэгчийн нууцлалын тухай хууль” https://oag.ca.gov/privacy/ccpa
- АНУ-ын Нууцлалын тухай хууль https://www.govinfo.gov/content/pkg/USCODE-2018-title5/pdf/USCODE-2018-title5-partI-chap5-subchapII-sec552a.pdf


UIH.MN
СУДАЛГААНЫ САН

# ЦАХИМ ГАРЫН ҮСГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ОЛОН УЛСЫН ЧИГ ХАНДЛАГА: МОНГОЛ УЛС БОЛОН ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

*Г.Уянга*

## АГУУЛГА

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ

1. Цахим гарын үсгийн тухай ойлголт

2. Цахим гарын үсгийн эрх зүйн зохицуулалт

    2.1 eDIAS загвар хууль

    2.2 Тоон гарын үсгийн UNCITRAL загвар хууль

3. Монгол Улсын цахим гарын үсгийн хэрэглээний өнөөгийн байдал

4. Улс орнуудын цахим гарын үсгийн эрх зүйн зохицуулалт

    4.1 Канад

    4.2 Литва

    4.3 Эстони

    4.4 Тайвань

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

## УДИРТГАЛ

Судалгааны захиалгын дагуу “Цахим гарын үсгийн эрх зүйн орчны, олон улсын чиг хандлага” сэдвийн хүрээнд цахим гарын үсгийн талаарх ерөнхий ойлголт, практик хэрэглээ, эрх зүйн зохицуулалтын талаарх олон улсын жишиг, загвар хуулиуд, бусад орнуудын туршлагыг Монгол Улсын эрх зүйн зохицуулалттай харьцуулан судалсан болно.

Цахим гарын үсгийн тухай хууль нь 2011 онд батлагдсан, 3 удаагийн нэмэлт, өөрчлөлтөөр нийт 3 зүйл, заалтад өөрчлөлт орсон. Энэ хуулиар цахим болон тоон гарын үсэг хэрэглэх эрх зүйн үндсийг тогтоож, тоон гарын үсгийн нийтийн түлхүүрийн дэд бүтцийг бий болгохтой холбоотой харилцааг зохицуулж байна. Өөрөөр хэлбэл, нийтийн түлхүүр ашиглан мэдээллийг шифрлэн хувиргаж, түүнд хамааралтай хувийн түлхүүрээр мэдээллийг задлах, эсрэгээр мэдээллийг хувийн түлхүүрээр шифрлэсэн бол зөвхөн түүнд хамааралтай нийтийн түлхүүрээр задлах зарчмаар ажиллах нийтийн түлхүүрийн дэд бүтцийг байгуулж, иргэн, хуулийн этгээдийг цахим хэлбэрээр таньж, баталгаажуулах нөхцөлийг бүрдүүлсэн.

Энэ хуулийг батласнаас хойш 9 жилийн хугацаанд иргэн, хуулийн этгээдэд нийт 38 407 тоон гарын үсэг олгогдсон байгаа нь практикт тус хуулийн хэрэгжилт туйлын хангалтгүй байгааг бодитойгоор харуулж байна. Өөрөөр хэлбэл, эдгээр олгосон тоон гарын үсгийн ихэнх нь аж ахуйн нэгж, байгууллагад олгогдож, иргэн бүрийг тоон гарын үсэгтэй болгох ажил ихээхэн удаашралтай байгаа юм.

Иймд Цахим гарын үсгийн тухай хуулийн зохицуулалтыг олон улсын жишигт нийцүүлэн сайжруулах, практикт үүсээд байгаа хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэх, тухайлбал төрийн албан хаагч албан үүргээ хэрэгжүүлэхдээ тоон гарын үсэг хэрэглэх, гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн тоон гарын үсэг, хуулийн этгээд цахим тамга хэрэглэх, гадаадын тоон гарын үсгийг хүлээн зөвшөөрөх замаар цахим орчинд тоон гарын үсгийг ашиглан үйл ажиллагаа явуулах боломжийг сайжруулж, түүний хэрэглээг нэмэгдүүлэхийг мэдээллийн технологийн өнөөгийн үсрэнгүй хөгжил шаардаж байна.

Судалгаанд Европын холбоо, НҮБ-ын загвар хуулиуд, болон гадаадын зарим орнуудын эрх зүйн зохицуулалт, Монгол Улсын цахим гарын үсгийн хэрэгжилт, өнөөгийн байдлыг тусгалаа.

***Түлхүүр үг:*** *Цахим гарын үсэг, Тоон гарын үсэг, Дижитал гарын үсэг, Нийтийн түлхүүрийн дэд бүтэц*

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

## СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Цахим гарын үсэг гэдэг нь цахим баримтад гарын үсэг зурсан этгээдийг тодорхойлох зорилготой цахим баримт бичигт хавсаргасан буюу нэгтгэсэн үг, үсэг, тоо, тэмдэгт, дүрсийг агуулсан цахим өгөгдлийг хэлнэ. Харин тоон гарын үсэг нь цахим баримт бичгийг хуурамчаар үйлдэх, өөрчлөхөөс хамгаалах зорилгоор гарын үсгийн хувийн түлхүүр ашиглан мэдээллийг криптограф хувиргалтад оруулж үүсгэсэн, уг баримт бичгийн бүрдэл болох цахим гарын үсгийн төрөл юм. Тоон гарын үсгээр баталгаажсан аливаа өгөгдөл нь хадгалагдаж, эсвэл дамжиж буйгаас үл шалтгаалан ямар ч орчинд бүрэн хамгаалагддаг байна. Тоон гарын үсэг нь ихэвчлэн Нийтийн түлхүүрийн дэд бүтэц /*Public Key Infrastructure (PKI)*/ хэмээх технологи дээр суурилсан байдаг. Нийтийн түлхүүрийн дэд бүтэц нь тоон гарын үсгийн цаана байдаг технологи бөгөөд мэдээллийг шифрлэн нууцалж, тоон аргаар цахим баримт бичигт гарын үсэг зурах боломжийг хэрэглэгчид бүрдүүлж өгөхөөс гадна хэрэглэгчийн хэн болохыг давхар баталгаажуулдаг байна.

Цахим гарын үсгийн эрх зүйн зохицуулалт болон олон улсад ашиглагдаж буй загваруудыг харьцуулан судалбал, Европын холбооноос баталсан “Цахим танилт болон итгэмжлэгдсэн үйлчилгээний журам” (eDIAS) болон НҮБ-ын UNCITRAL загварын хууль гэсэн үндсэн хоёр загварыг ашиглаж байна.

Европын холбооны улс орнууд Европын холбооноос баталсан “Цахим танилт болон итгэмжлэгдсэн үйлчилгээний журам” (eDIAS)-ыг дагаж мөрддөг. Зарим улс орнууд НҮБ-ээс баталсан UNCITRAL загварын хуульд нийцүүлэн өөрийн орны эрх зүйн орчинг бүрдүүлсэн байна. Харин Монгол Улсын хувьд “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод цахим засаглалыг хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлийг тусгаж, НҮБ-ын UNCITRAL загварын дагуу Цахим гарын үсгийн тухай хуулийг 2011 онд баталсан байна.

Сонгон судалсан улс орнууд болох Канад Улс нь НҮБ-ын UNCITRAL загвар хуулийн дагуу цахим гарын үсгийн тухай зохицуулалтыг Хувийн мэдээллийг хамгаалах, цахим баримт бичгийн тухай хуулиар зохицуулж байна. Энэ хууль нь хувийн хэвшлийн байгууллагууд бизнес эрхлэх явцад хувийн мэдээллээ хэрхэн цуглуулах, ашиглах, задруулах асуудлыг зохицуулдаг бөгөөд хуулийн 2-р бүлэгт холбооны түвшинд цаасан дээр үндэслэсэн баримт бичгийн гарын үсэг цахим гарын үсэгтэй адил болохыг мөн тогтоосон байдаг. Уг бүлэгт цахим гарын үсгийг “цахим баримт бичигт оруулсан, хавсаргасан эсвэл түүнтэй холбоотой тоон хэлбэрээр нэг буюу хэд хэдэн үсэг, тэмдэгт, тоо эсвэл бусад тэмдгээс бүрдсэн гарын үсэг” гэж тодорхойлжээ. Үндсэндээ цахим гарын үсэг нь үүнийг ямар ч хэлбэрээр цахим хэлбэрээр төлөөлүүлж болно гэсэн үг юм.

Мөн Канад Улсын хувьд муж бүр өөр, өөр зохицуулалттай байх бөгөөд гэрээслэл, гэр бүл цуцлалт, шүүх, үл хөдлөх хөрөнгө, вексель гэх мэт дараах зүйлүүдэд гараар гарын үсэг зурах шаардлагатай гэж үздэг байна.

Харин Эстони, Литва болон Тайвань улсууд нь цахим болон тоон гарын үсгийн тухай хуулиар цахим гарын үсгийн эрх зүйн орчинг бүрдүүлж байна. Литва болон Эстони улсуудад байнгын оршин суудаг бүх гадаадын иргэд албан ёсны ID үнэмлэх карттай байх ёстой ба өөрийн гар утсыг ашиглан баримт бичигт цахимаар гарын үсэг зурах боломжтой Мөн эдгээр улсууд нь Европын холбооноос баталсан “Цахим танилт болон Итгэмжлэгдсэн үйлчилгээний журам” (eDIAS)-ыг хэрэгжүүлдэг. Эстони Улс нь Европын холбооноос баталсан журмыг жишиг болгон дагаж мөрдөхөөс гадна 2000 онд баталсан Тоон гарын үсгийн тухай хуулиар тоон гарын үсэгтэй холбоотой харилцааг зохицуулж,

UIH.MN СУДАЛГААНЫ САН

хуулийн этгээд бүртгүүлэх, банк, санхүү, сонгууль, татварын бүртгэл хийлгэх зэрэг гарын үсэг шаардах аливаа үйлчилгээг төрийн байгууллагаас цахим хэлбэрээр авахад болон бусад үйлчилгээнд 2021 оны байдлаар 900 сая гаруй тоон гарын үсгийг хэрэглээнд гаргасан байна. Ингэхдээ тоон гарын үсгийг иргэний үнэмлэхний санах ой болон гар утасны сим картанд байршуулсан байна.

## СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ

### 1. Цахим гарын үсгийн тухай ойлголт

Цахим гарын үсэг (*electronic signature*) нь цахимаар дамжуулж байгаа баримтыг хууль ёсны гэж хүлээн зөвшөөрч буйг баталгаажуулах цахим дүрслэл юм. Энэ нь гараар буюу бичгээр үйлдсэн гарын үсгийн адил хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

Тоон гарын үсэг (*digital signature*) гэж цахим баримт бичгийг хуурамчаар үйлдэх, өөрчлөхөөс хамгаалах зорилгоор гарын үсгийн хувийн түлхүүр ашиглан мэдээллийг криптограф хувиргалтад оруулж үүсгэсэн, уг баримт бичгийн бүрдэл болох цахим гарын үсгийн төрөл юм. Тоон гарын үсэгт нийтийн түлхүүрийн шифрлэлт ашиглагддаг ба цахим гарын үсгээс ялгаатай нь тоон гарын үсэг нь тодорхой стандарт, баталгаажуулалтын хатуу чанд журмыг баримтлан хийгддэг.

Тоон гарын үсгийн хувьд цахим гарын үсгийг ашиглах үйл явцтай харьцуулахад төвөгтэй бөгөөд илүү хийсвэр, цахим орчинд явагддаг. Энэ нь тухайн компьютерт хадгалагдаж буй олон төрлийн мэдээ мэдээлэл, албан бичгийг үнэн зөв, баталгаатай дамжуулах процесст үндэслэн явагддаг байна.

Мэдээ мэдээллийг тодорхой сувгаар дамжуулахад 2 субъект оролцдог. Илгээгч тал нь уг мэдээллийг ойлгогдохгүй хэлбэрт хувиргаад мэдээллийн сувгаар дамжуулдаг. Үүнийг шифрлэлт гэх ба нэг ёсондоо мэдээллийг цоожилж байгаа юм. Харин уг цоожлогдсон мэдээг хүлээж авч буй тал нь цоожийг тайлан мэдээллийг олж авах үйлдлийг шифрийг тайлах гэж нэрлэдэг.

Мэдээлэл дамжуулах энэхүү үйл ажиллагааг явуулахын тулд нэг түлхүүрийн арга болон хос түлхүүрийн аргыг ашигладаг байна. Нэг түлхүүрийн арга нь илгээгч тал, хүлээн авагч тал хоорондоо урьдаас харилцан тохиролцсон тухайлсан нэг түлхүүрийг ашигладаг ба энэ нь нууцлал өндөртэй, тухайн мэдээлэл нь бүрэн хамгаалагдсан байдаг байна. Сул тал нь мэдээлэл дамжуулах суваг гадны цөөнгүй этгээд оролцож байдаг бөгөөд мэдээлэл алдагдах эрсдэлтэй байдаг.

Хос түлхүүрийн арга нь өөр хоорондоо тоон системийн хамааралтай хоёр түлхүүр оролцдог ба нэг нь мэдээ мэдээллийг цоожлоход нийтийн түлхүүр буюу “public key”, тухайн мэдээллийн цоожийг нь тайлахад хувийн түлхүүр буюу “private key”-г ашигладаг байна. Энэ тохиолдолд тухайн мэдээ мэдээллийг заавал аюулгүй байдал хангагдсан, нууцлалтай сувгаар илгээх шаардлагагүй, харилцагч талууд зөвхөн өөрсдийн нийтийн түлхүүрээ солилцох шаардлагатай болдог. (Зураг 1-ээс харна уу)

UIH.MN СУДАЛГААНЫ САН

*Зураг 1.*




Тоон гарын үсгийг дуурайлган үйлдэх боломжгүй. Учир нь тоон гарын үсгийн ажиллагаа нь хэш (*hash*) функц болон тэгш бус хэмт криптограф (*private/public key*) дээр тулгуурладаг байна. Хэш функц нь цахим баримтыг өөрийн аргаар уншиж шинжлээд түүнээс бичил мэдээлэл хувиргаж үүсгэх үүрэгтэй.

Цахим гарын үсгийн 3 тодорхой төрөл байдаг:[382]

- ***Хялбар цахим гарын үсэг*** (*Simple Electronic Signature*) гэдэг нь “Ямар нэгэн цахим мэдээлэлд хавсаргаж буй гарын үсэг зурагчийн гарын үсгээ зурахад ашигладаг цахим мэдээллийн хэлбэр юм. Цахим гарын үсгийн платформ нь гарын үсэг зурагчид компьютерийн хулгана юмуу үзэг ашиглан өөрийн гарын үсгээ тухайн бичиг баримтан дээр шууд зурах, эсвэл төрөл бүрийн үсгийн фонт болон стайлыг ашиглан компьютераар үүсгэсэн гарын үсгээ зурж болно. Хялбар гарын үсгийн бүтээгдэхүүн нь гарын үсэг зурагчийг мөн гэдгийг батлах гуравдагч этгээдийг оролцуулдаггүй байна.
- ***Дэвшилтэт цахим гарын үсэг*** (*Advanced Electronic Signature*). Дэвшилтэт цахим гарын үсэг (AES) нь цахим гарын үсгээс илүү нарийн, хамгаалалтын түвшин илүү сайжруулсан хувилбар юм. Энэ нь нийтийн түлхүүр /*Public Key Cryptograph (PKI)/* ашигласан, цахим бичиг баримтыг код ашиглан шифрлэдэг тоон гарын үсэг юм.

*Зураг 2.*



UIH.MN СУДАЛГААНЫ САН

[382] https://ec.europa.eu/cefdigital/wiki/display/CEFDIGITAL/What+is+the+legislation+-+esignature

AES буюу дэвшилтэт гарын үсэг бүтээхийн тулд нийтийн болон хувийн түлхүүр буюу хос түлхүүр үүсгэнэ. Ингэхийн тулд платформ бүтээгч нь математикийн алгоритмыг ашигладаг. Гарын үсэг зурагч нь hash гэж нэрлэдэг цахим бичиг баримтын компьютерээр үүсгэсэн хурууны хээг шифрлэхдээ хувийн түлхүүр (private key)-ээ ашиглана. Шифрлэсэн hash нь тоон гарын үсэг юм. Үүнийг хүлээн авагч руу цахим бичиг баримттай хамт илгээнэ. Хүлээн авагч нь гарын үсэг зурагчийн нийтийн түлхүүрийг дэвшилтэт гарын үсгийн кодыг тайлж, хувийн түлхүүрийг эзэмшиж байгаа хүн үүнийг үүсгэсэн гэдгийг баталгаажуулахад ашиглана. Хүлээн авагчид нь өөрсдийн цахим бичиг баримтын Hash-ийг үүсгэж тайлагдсан дэвшилтэт гарын үсэгтэй харьцуулна. Хэрэв тэд тохирч байвал энэхүү цахим гарын үсэг нь хүчинтэй бөгөөд хуурамчаар үйлдэх боломжгүй юм. Сул тал нь хуурамч бичиг баримт үүсгэн хос түлхүүрийг хуулбарлах, хулгайлах, эсвэл хийх эрсдэлтэй байдаг. Дэвшилтэт сертификатыг энэхүү эрсдэлийг шийдвэрлэхэд ашигладаг. Платформ бүтээгч буюу итгэмжлэгдсэн гуравдагч тал гарын үсэг зурагчийн нууц үгийг шалгасны үндсэн дээр хос түлхүүрийг үүсгэдэг байна. Итгэмжлэлийн үйлчилгээ үзүүлэгч нь гарын үсэг зурагчийн мэдээллийг баталгаажуулж, нийтийн түлхүүрийг агуулсан дэвшилтэт гарын үсэг бүхий сертификатыг олгодог. Энэхүү дэвшилтэт сертификатыг цахим бичиг баримтад хавсаргах бөгөөд энэ нь тоон гарын үсэг юм. Хүлээн авагч нь тоон гарын үсгийг хүчин төгөлдөр болгохын тулд гарын үсэг зурагчийн нийтийн түлхүүрийг ашиглаж баталгаажуулна. (*Creating and verifying a digital signature буюу дэвшилтэт гарын үсгийг бүтээх, баталгаажуулах хэсгийг зураг 2 харна уу).*

- ***Баталгаажсан цахим гарын үсэг*** *(Qualified Electronic Signature).* Энэ нь баталгаажсан цахим гарын үсэг бүтээх төхөөрөмж ашиглан хийгддэг тоон гарын үсэг юм. QES (Баталгаажсан цахим гарын үсэг) нь AES (Дэвшилтэт цахим гарын үсэг)-ийн шаардлагыг бүрэн хангасан байх ёстой ба гишүүн орнуудын итгэмжлэлийн жагсаалтад багтсан, баталгаажсан итгэмжлэлийн үйлчилгээ үзүүлэгчийн олгосон баталгаажсан сертификатаар дэмжигддэг. AES(Дэвшилтэт цахим гарын үсэг)-ийн нэгэн адил баталгаажсан итгэмжлэлийн үйлчилгээ үзүүлэгч нь гарын үсэг зурсан этгээдийн хэн болохыг баталгаажуулж "баталгаажсан гэрчилгээ" олгодог байна. Жишээлбэл, гэрээг бичгээр байгуулахыг хуулиар шаарддаг ХБНГУ-ын Иргэний хуулийн 126 дугаар зүйлд энэ шаардлагыг цахим хэлбэрээр, гэхдээ зөвхөн QES (Баталгаажсан цахим гарын үсэг)-ийн тусламжтайгаар гүйцэтгэх боломжтой гэж заасан байдаг.

**2. Цахим гарын үсгийн эрх зүйн зохицуулалт**

Нийтийн түлхүүрийн дэд бүтцийн технологи нь доорх стандарт, шаардлагуудад нийцсэн, хянаж болохуйц аюулгүй орчинг бүрдүүлсэн байх шаардлагатай. Үүнд:

- Secure Socket Layer (SSL) технологи нь цахим аюулгүй байдлын дэлхийн стандарт;
- EU Directive 2000, UNCITRAL&WTO зохицуулалтууд нь нийтийн түлхүүрийн дэд бүтэц болон SSL технологид хамааралтай;

Нийтийн түлхүүрийн дэд бүтцийн систем нь доорх бүтэц, бүрэлдэхүүн хэсгүүдээс бүрдэнэ:

- Гэрчилгээжүүлэх байгууллага /*certification authority*/. Энэ нь эцсийн хэрэглэгчид шифрлэсэн түлхүүр, тоон гэрчилгээ олгохоос гадна гэрчилгээ үүсгэх, хүчингүй болгох, хугацаа сунгах, шинэчлэх зэрэг гэрчилгээний циклийг зохицуулдаг итгэмжлэгдсэн гуравдагч этгээд юм.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

- Бүртгэлийн байгууллага /*registration authority*/. Хувь хүн, компани, төрийн байгууллагаас ирүүлсэн гэрчилгээний өргөдлийг хянах, батлах, татгалзах, хүчингүй болгох эрхтэй итгэмжлэгдсэн гуравдагч этгээд юм.
- Хүчингүй гэрчилгээний жагсаалт /*certificate revocation list*/
- Шаардлагатай бичиг баримтууд (аюулгүй байдлын төлөвлөгөө, бүртгэлийн мэдээ гэх мэт)
- Мэдээллийн сан

**2.1 eDIAS загвар журам**

Цахим гарын үсгийн аюулгүй байдал, хэрэглэл, бүртгэлийн байгууллага, мэдээллийн сангийн үйл ажиллагааны эрх зүйн баримт бичгүүдийг Олон улсад болон улс орнууд дотооддоо зохицуулдаг. Үүнээс хамгийн түгээмэл хэрэглэгддэг загвар нь Европын холбооноос гаргасан *eDIAS* болон НҮБ-ын UNCITRAL загвар хуулиуд байна.

Европын холбооноос 2016 онд “Цахим танилт болон итгэмжлэгдсэн үйлчилгээний журам” (*Electronic Identification and Trust Services Regulation eDIAS NO 910/2014*)-ийг шинэчлэн баталсан.[383] Өнөөдрийн байдлаар Австри, Бельги, Болгар, Хорват, Кипр, Чех, Дани, Эстони, Финланд, Франц, Герман, Грек, Унгар, Ирланд, Итали, Латви, Литва, Люксембург, Мальта, Нидерланд, Польш, Португал, Румын, Словак, Словени, Испани, Швед улсууд тоон гарын үсэг хэрэглэхдээ энэ журмыг дагаж мөрдөж байна. Энэхүү журмаар цахим гарын үсэг, цахим тамга, хугацааны тов, eDelivery (цахим хүргэлт) үйлчилгээ болон цахим хуудасны баталгаажуулалтын гэрчилгээг хил дамнуулан ашиглах хууль ёсны баталгааг хангасан болно.

Энэхүү Цахим танилт болон итгэмжлэгдсэн үйлчилгээний журам[384] нь доорх бүтэцтэй байна. Үүнд:

Бүлэг 1. Нийтлэг үндэслэл
Бүлэг 2. Цахим бүртгэл, танилт
Бүлэг 3. Итгэлцлийн үйлчилгээ
 Хэсэг 1. Нийтлэг үндэслэл
 Хэсэг 2. Хяналт
 Хэсэг 3. Баталгаажсан итгэлцлийн үйлчилгээ
 Хэсэг 4. Цахим гарын үсэг
 Хэсэг 5. Цахим тамга
 Хэсэг 6. Цахим цаг хугацааны тэмдэг
 Хэсэг 7. Цахим бүртгэгдсэн дамжуулалтын үйлчилгээ
 Хэсэг 8. Цахим хуудас бататгал
Бүлэг 4. Цахим баримт
Бүлэг 5. Эрх мэдлийн төлөөлөгчид ба хэрэгжүүлэх заалтууд
Бүлэг 6. Эцсийн заалт

*Платформ*

Хэдийгээр зарим үйлчилгээ үзүүлэгч нь цахим гарын үсгийн платформыг хувийн үүлэн технологид эсвэл нийтийн үүлэн үйлчилгээнд байршуулах сонголт өгдөг ч ихэвчлэн нийтийн үүлэн технологийг санал болгодог байна. Үйлчилгээ үзүүлэгчид энэхүү програм хангамжийг програм хангамжийн апликейшн болон үйлчлүүлэгчийн мэдээллийг

[383] https://ec.europa.eu/cefdigital/wiki/display/CEFDIGITAL/Introduction+to+e-signature
[384] https://www.eid.as/#article3

UIH.MN СУДАЛГААНЫ САН

хадгалах зэрэгт илгээлтийн загвар болгон ашигладаг. Үйлчлүүлэгч болон түүний итгэмжилсэн хэрэглэгч нь уг платформд 1-3 жилээр тохируулсан тодорхой хугацаанд веб хөтчөөр нэвтэрнэ. Програм хангамж ашигладаг загвар нь үйлчлүүлэгчид илүү таатай, ашиг тустай байдаг нь тодорхой бөгөөд ялангуяа хүчин чадлын цар хүрээ, бага өртөг, тогтмол бетта ажиллагаа (үйлчлүүлэгч нь тухайн платформын хамгийн сүүлийн үеийн хувилбарт нэмэлт төлбөр төлөхгүйгээр нэвтэрдэг) зэргийг онцолж болох юм. Гэхдээ үүлэн үйлчлүүлэгч нь мэдээлэл боловсруулах болон өгөгдөл хадгалах явцдаа хяналтаа сулруулах эрсдэлтэй байдаг. Дүрэм журмын, ялангуяа Мэдээлэл Хамгааллын Удирдамж (95/46/EC)–ын дагуу үйлчлүүлэгчийн үүргийг хэрэгжүүлэх нь зарим талаараа хүндрэлтэй байдаг байна.

*Гарын үсэг зурагчийн нотолгоо*

Гарын үсэг зурсан хүнийг баталгаажуулах үндсэн арга бол и-мэйл хаягийг ашиглах явдал юм. Хэрэв үйлчлүүлэгч илүү итгэлтэй байхыг хүсч байвал гарын үсэг зурагч бүрийн хувийн мэдээллийг баталгаажуулахын тулд SMS, нэг удаагийн нууц үг эсвэл мэдлэгт суурилсан баталгаажуулалт гэх мэт хоёр хүчин зүйлийн баталгаажуулалтыг сонгож болно. Их Британийн бизнес эрхлэгчид хоёр хүчин зүйлийн баталгаажуулалтыг сонгож байна. Энэ нь гарын үсэг зурах үйл явцыг арай илүү сунжруулдаг боловч AES эсвэл QES авахаас хамаагүй бага ачаалалтай бөгөөд хамаагүй хямд байдаг байна.

*Бусад компаний програмтай нэгтгэх*

Тэргүүлэх платформууд нь SalesForce, Microsoft, Google гэх мэт компаний програмуудтай урьдчилан нэгтгэсэн интеграцчилалтай байдаг байна. Тэд мөн хэрэглэгчид өөрсдийн хувийн бизнесийн системтэй цахим гарын үсгийг нэгтгэх боломжийг олгодог програмчлалын интерфэйсийг (API) санал болгодог. Энэ функц нь үйлчлүүлэгчдэд маш чухал боловч үйлчилгээ үзүүлэгчдийн стандартын хувьд баталгаа өгдөггүй.

Үйлчлүүлэгч нь платформыг бусад програмуудтай нэгтгэх техникийн тодорхойлолт байгаа эсэхийг шалгах ёстой бөгөөд уг интеграц нь тодорхойлолтынхоо дагуу ажиллана гэдэг баталгааг үйлчилгээ үзүүлэгчээс шаардах ёстой.

*Техникийн стандартын үнэлгээ*

Энэхүү журам нь технологийн хувьд төвийг сахисан байдаг. Энэ бол чухал зарчим юм. Технологи нь хөдөлгөөнгүй биш бөгөөд цахим болон тоон гарын үсгийг бий болгох, баталгаажуулах шинэ технологи гарч ирнэ гэдгийг Европын Холбооны комисс хүлээн зөвшөөрдөг. Тиймээс платформ нь тодорхой технологийг ашиглахыг Журамд заагаагүй байдаг байна.

Гэсэн хэдий ч тэргүүлэх үйлчилгээ үзүүлэгчид ETS, ISO, CEN зэрэг байгууллагуудын баталсан техникийн стандартыг дагаж мөрдөх ач холбогдлын талаар мэдэгдэл хийдэг. Эдгээр техникийн стандартууд нь платформыг сонгоход үйлчлүүлэгчид (мөн технологийн ахлах мэргэжилтэнд) нөлөөлдөг.

*Хариуцлагын хязгаарлалт*

Үйлчилгээ үзүүлэгчийн зүгээс үйлчлүүлэгчийн өгөгдлийг алдах, нууцыг задруулах нь гэрээг зөрчсөн гэж үздэг байна. Өгөгдөл хамгаалах тухай хуулийг зөрчсөн тохиолдолд үйлчилгээ үзүүлэгч нь үйлчлүүлэгчийн хохирлыг барагдуулахыг зөвшөөрөх нь ховор байдаг ба энэ тохиолдолд өгөгдлийн субъектэд торгууль эсвэл нөхөн төлбөр төлдөг. 1998 оны Өгөгдлийг өөрчлөх ерөнхий журам (679/2016/EU) (GDPR) нь Өгөгдлийг

хамгаалах тухай хуулийн дагуу одоогийн дээд тал нь 500,000 фунт стерлингийн торгууль ногдуулах хязгаарыг тогтоож өгсөн байна. *("Өгөгдөл хамгаалах ерөнхий дүрэм: "www.practicallaw.com/2-632-5285).*

## 2.2 Тоон гарын үсгийн UNCITRAL загвар хууль

Тоон гарын үсгийг өөрийн гараар бичсэн гарын үсэгтэй эн тэнцүү хүчин төгөлдөр болгохын тулд хуулиар зохицуулсан байх шаардлагатай. Ихэнх орнууд үүнтэй холбоотой хуулийг батлахдаа НҮБ-ын Тоон гарын үсгийн UNCITRAL загвар хуулийг баримталдаг. [385]

Уг загвар хуулийн харилцаанд онцолж заахыг зөвлөсөн зүйлс:[386]

- Энэ хууль нь тоон гарын үсгийг арилжааны ба бусад заасан нөхцөлд ашиглаж байгаа тохиолдолд үйлчилнэ.
- Энэ хууль нь хэрэглэгчдийг хамгаалах ямар ч хууль дүрмээс давж үйлчлэх ёсгүй.
- Уг загвар хуулийн хамрах хүрээ нь "ялгаварлан гадуурхахгүй байх", "төвийг сахисан” байх дүрмийг баримтална.
- Тоон гарын үсгийг хуульчлахдаа аль болох өргөн хүрээг хамарсан байхыг зөвлөдөг. Тиймээс хууль эрх зүйн орчинг гадаад болон дотоодын нөхцөлд адил үйлчилж байхаар заана. Олон улсын ба дотоодын гүйлгээний хүрээнд ашиглагдах тоон гарын үсгийн хэрэглээг тусад нь зохицуулбал хоёрдмол байдалд хүргэж болзошгүй ба ийм технологийг ашиглахад ихээхэн саад тотгор учруулах магадлалтай.
- Тоон гарын үсэг, сертификат, өгөгдлийн мессеж, гарын үсэг эзэмшигч, сертификатын үйлчилгээ үзүүлэгч, хамаарал бүхий этгээд[387] гэх мэт энэ хуульд тусгагдах нэр томьёоны тодорхойлолтыг оруулсан байна.
- Хуулийн үйлчлэх хүрээг хязгаарласан бусад хуулийг тодорхой заасан байна.
- Тоон гарын үсэг нь гагцхүү гарын үсэг эзэмшигчийн эрх мэдэлд байна. Бусдад итгэмжлэл хүлээлгэх тохиолдолд нууц хуваалцах схемийг [388] тодорхой болгосон байна.
- Тоон гарын үсгийг үүсгэж буй өгөгдлийн амьдрах хугацааг заасан байна.
- Гарын үсэг эзэмшигч, сертификатын үйлчилгээ үзүүлэгч, хамаарал бүхий этгээдийн үүрэг, хариуцлагыг тус бүр тодорхой заасан байна.
- Гадаадад хийгдсэн тоон гарын үсэг нь хуулийн хүрээнд эн тэнцүү хүчин төгөлдөр байна.
- Олон улсад хүлээн зөвшөөрөгдөх стандартыг технологийн, хуулийн, арилжааны хүрээнд мөрдсөн байна.

UNCITRAL Нарийн бичгийн дарга нарын газраас энэхүү загвар хуульд үндэслэн хууль боловсруулж буй улс орнуудад техникийн зөвлөгөө өгөх боломжтой байдаг байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[385] Global Guide to Electronic Signature Law: Country by country summaries of Law and enforceability, Adobe Systems Incorporated 2015.
[386] UNCITRAL Model Law on Electronic Signatures with Guide to Enactment 2001, UNITED NATIONS, New York, 2002
[387] Electronic signature, certificate, data message, signatory, certification service provider, relying party (Uncitral Model Law, Article 2)
[388] “shared-secret” scheme (Uncitral Model Law, Article 122)

### 3. Монгол Улсын цахим гарын үсгийн хэрэглээний өнөөгийн байдал

Монгол Улсад “Цахим гарын үсгийн тухай” хууль 2011 оны 12 сарын 15-ны өдөр анх батлагдаж, 2012 оны 01 сарын 16-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Цахим гарын үсгийн тухай хуулиар цахим болон тоон гарын үсгийг хэрэглэх эрх зүйн үндсийг тодорхойлж, тоон гарын үсгийн нийтийн түлхүүрийн дэд бүтцийг бий болгохтой холбогдсон харилцааг зохицуулж байна. Энэ хуулиар төрийн нууцад хамаарахаас бусад мэдээ, баримт бичгийг цахим хэлбэрт шилжүүлэх, дамжуулахтай холбогдсон харилцааг зохицуулсан.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсад тоон гарын үсгийн төхөөрөмжийн тусгай зөвшөөрлийн эрхтэй дараах 5 байгууллага байна. Үүнд:

- Monpass CA
- Tridum E-security
- VCM CA
- New Compass
- ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВ

Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын даргын тушаалаар 2015 оны 3 дугаар сарын 25-ны өдөр Монгол Улсад Цахим гарын үсгийн тухайг хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Нийтийн түлхүүрийн дэд бүтцийг ашиглах талаар төрөөс баримтлах бодлогын чиглэл”-ийг баталсан. Монгол Улс нь нийтийн түлхүүрийн шаталсан тогтолцоог мөрддөг ба Харилцаа Холбооны Зохицуулах Хорооны 2014 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн 45 дугаар тогтоолоор “Монгол Улсын цахим гарын үсгийн нийтийн түлхүүрийн дэд бүтцийн журмууд”-ыг баталсан.

Цахим гарын үсгийн тухай хууль батлагдсантай холбогдуулан дараах хууль, эрх зүйн актуудад нэмэлт, өөрчлөлт оруулах болон шинээр батлан мөрдүүлж байна.Үүнд:

1. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт;
2. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт;
3. Татварын ерөнхий хуульд өөрчлөлт;
4. Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт;
5. Иргэний бүртгэлийн тухай хуульд нэмэлт;
6. Банк, эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт;
7. Харилцаа, холбооны тухай хуульд нэмэлт;
8. Нийтээр тэмэдэглэх тэмдэглэлт, баярын өдрүүдийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт;
9. 2011 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дугаар 61. “Цахим гарын үсгийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоол;
10. 2011 оны 11 сарын 21-ний өдрийн дугаар 671. “Тоон гарын үсгийн технологийн дүрэм” Татварын ерөнхий газрын даргын тушаал;
11. Тоон гарын үсэг хэрэглэх гэрээ

Одоогоор тоон гарын үсгийг Нийслэлийн нутгийн захиргааны 981 байгууллага зөвхөн албан бичигт хүлээн зөвшөөрөн ажиллаж байна. Тоон гарын үсэгт суурилсан системүүдэд Цахим албан бичиг солилцооны eDoc, Smart Office[389] системүүд орж байна.

[389] https://smartoffice.mn/

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Одоогоор энэ системүүдийг зөвхөн Нийслэлийн хэмжээнд ашигладаг бөгөөд 1700 гаруй төрийн болон хувийн байгууллагуудыг хамардаг байна.

Тоон гарын үсгийн хэрэглээг сайжруулахад дараах нөхцөл байдлыг сайжруулах шаардлагатай гэж судлаачид үздэг.[390]

- Шүүх, прокурор, цагдаагийн байгууллагууд тоон гарын үсгийг хүлээн зөвшөөрөх.
- Төрийн бүхий л системд нэвтрэхэд тоон гарын үсэг шаардах.
- Төрийн байгууллага хоорондын мэдээлэл (төрийн нууцад хамаарахаас бусад) солилцоо зөвхөн тоон гарын үсгээр баталгаажсан байх.
- Төрийн байгууллагын системүүдэд тоон гарын үсгийн веб сервисүүдийг холбох.
- Тоон гарын үсгээр баталгаажсан гэрээ хэлцлийг хүлээн зөвшөөрөх.
- Цахим Нотариатын хүрээнд тоон гарын үсгээр баталгаажсан гэрээг цахимаар баталгаажуулах үйлчилгээг гаргах.
- Банк санхүүгийн салбарт тоон гарын үсгийг хүлээн зөвшөөрүүлэх.
- Тоон гарын үсгийг иргэний үнэмлэхтэй холбох.
- Цахим архивыг байгуулах, бүх архивын байгууллагууд тоон гарын үсгээр баталгаажсан баримтыг хүлээн зөвшөөрч цахимаар болон цаасан хэлбэрээр хадгалах журам гаргах.

## 4. Улс орнуудын цахим гарын үсгийн эрх зүйн зохицуулалт

Одоогоор дэлхийн улс орнууд цахим гарын үсгийн эрх зүйн орчинг бүрдүүлэхдээ ихэвчлэн Европын холбооноос баталсан “Цахим танилт болон Итгэмжлэгдсэн үйлчилгээний журам” (eDIAS) болон НҮБ-ын UNCITRAL загварын хуулиудыг тус тус өөрийн орны хууль эрх зүйн орчинд нийцүүлэн зохицуулсан байдалтай байна.

### 4.1 Канад

Канад Улс нь цахим гарын үсэгтэй холбоотой эрх зүйн харилцааг Хувийн мэдээллийг хамгаалах, цахим баримт бичгийн тухай /Personal information protection and electronic documents/[391] хуулиар зохицуулж байна. Энэ хуулийг анх 2000 онд баталсан бөгөөд 6 бүлэг, 72 зүйлтэй. 2001 оноос эхлэн хууль нь холбооны зохицуулалттай салбаруудад (агаарын тээврийн компани, банк, өргөн нэвтрүүлэг гэх мэт) үйлчилж эхэлсэн бөгөөд улмаар уг хуулийн хамрах хүрээг эрүүл мэндийн салбар, арилжааны банк зэрэг салбаруудад шат дараатайгаар өргөжүүлсэн байна.

Бүлэг 1. Хувийн хэвшил дэх хувийн мэдээллийг хамгаалах
    Хэсэг 1. Хувийн мэдээллийг хамгаалах
    Хэсэг 2. Гомдол гаргах
    Хэсэг 3. Аудит
    Хэсэг 4. Ерөнхий зүйл
    Хэсэг 5. Шилжилтийн нөхцөлүүд
Бүлэг 2. Цахим баримт бичиг
Бүлэг 3. Канадын нотолгооны хуулийн нэмэлт
Бүлэг 4. Баримт бичгийн хуулийн нэмэлт
Бүлэг 5. Хуулийн нэмэлт өөрчлөлт
Бүлэг 6. Хүчин төгөлдөр болох

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[390] https://advocate.mn/news/102/single/58
[391] https://laws-lois.justice.gc.ca/eng/acts/p-8.6/FullText.html

Хувийн мэдээллийг хамгаалах, цахим баримт бичгийн тухай хуулийн 2-р бүлэгт холбооны түвшинд цаасан дээр үндэслэсэн баримт бичгийн гарын үсэг цахим гарын үсэгтэй адил болохыг мөн тогтоосон байдаг. Уг бүлэгт цахим гарын үсгийг “цахим баримт бичигт оруулсан, хавсаргасан эсвэл түүнтэй холбоотой тоон хэлбэрээр нэг буюу хэд хэдэн үсэг, тэмдэгт, тоо эсвэл бусад тэмдгээс бүрдсэн гарын үсэг” гэж тодорхойлжээ. Үндсэндээ цахим гарын үсэг нь үүнийг ямар ч хэлбэрээр цахим хэлбэрээр төлөөлүүлж болно гэсэн үг юм.

Тус хуулийн 2-р бүлэгт “аюулгүй цахим гарын үсэг /secure electronic signature/” гэж нэрлэгддэг тодорхой ангиллын цахим гарын үсгийг ашиглахыг шаардах тохиолдол байдаг. Аюулгүй цахим гарын үсэг нь тэгш бус криптографид суурилсан цахим гарын үсгийн хэлбэр юм. Аюулгүй цахим гарын үсэг шаардагдах хэрэглээнд:

- Нотлох баримт эсвэл нотолгоо болгон ашигласан баримт бичиг (тус хуулийн 36-р зүйл)
- Лац, тамга (тус хуулийн 39-р зүйл)
- Цахим болгосон баримт бичиг хувь (тус хуулийн 42-р зүйл)
- Тангараг өргөсөн мэдэгдэл (тус хуулийн 44-р зүйл)
- Үнэнийг тунхагласан мэдэгдэл (тус хуулийн 45-р зүйл)
- Гэрчийн гарын үсэг (тус хуулийн 46-р зүйл)

Канад Улс нь Аюулгүй цахим гарын үсгийн журмыг 2005 онд баталсан[392]. (Secure Electronic Signature-SES)

Аюулгүй цахим гарын үсгийн шинж чанарыг хангасан технологи, үйл явцыг тодорхойлсон уг журам нь аюулгүй цахим гарын үсгийн хууль ёсны тодорхойлолтыг бүрэн хангаж өгдөг. Журмын шаардлагыг хангах чадвартай гэж хүлээн зөвшөөрөгдөх хүсэлтэй байгууллагуудыг Төрийн сангийн зөвлөлийн ерөнхийлөгч хангаж чадаж байгаа эсэхийг баталгаажуулах ёстой.

Энэхүү журамд аюулгүй цахим гарын үсэг үүсгэх чадвартай гэж хүлээн зөвшөөрөгдсөн гэрчилгээжүүлэх байгууллагуудыг Төрийн сангийн зөвлөлийн ажлын албаны вэбсайтад байршуулна гэж заасан байдаг.

Канадын Холбооны нийтийн түлхүүрийн /*Public Key Infrastructure (PKI)*/ гэрчилгээ авсан Засгийн газрын баталгаажуулалтын байгууллагууд л хүлээн зөвшөөрөгддөг.[393] Одоогоор доорх гэрчилгээжүүлэх эрх бүхий байгууллагууд тоон гарын үсгийг олгох чадамжтай.

Үүнд:

- ***гэрчилгээжүүлэх байгууллага*** (certification authority CA)
    - Канад Улсын нийтийн ажил, төрийн үйлчилгээний байгууллагууд (**Public Works and Government Services Canada)**
    - Канад Улсын орлогын агентлаг (**Canada Revenue Agency)**
    - Үндэсний батлан хамгаалах ба Канад Улсын зэвсэгт хүчин (**National Defence and the Canadian Armed Forces)**

Цахим гарын үсгийн зохицуулалтыг хүлээн зөвшөөрөх үйл явц нь дараах үе шатуудыг агуулна.

[392] https://laws-lois.justice.gc.ca/eng/regulations/SOR-2005-30/FullText.html
[393] https://www.canada.ca/en/government/system/digital-government/online-security-privacy/security-identity-management/secure-electronic-signature-regulations-recognition-process.html

UIH.MN СУДАЛГААНЫ САН

- Санаачилга: Гэрчилгээжүүлэх байгууллага (CA)-ыг Аюулгүй цахим гарын үсгийн журмын дагуу (SESRegs) хүлээн зөвшөөрч, хүлээн зөвшөөрөх бизнесийн шалтгааныг тогтоох - үүнд зарим санхүүгийн зохицуулалт багтаж болно.
- Шалгалт: Нэр дэвшигч (CA) нь өөрийн бодлого, үйл ажиллагаа нь шалгуурт нийцэж байгааг харуулах ёстой.
- Зохион байгуулалт: Гэрчилгээжүүлэх байгууллагын эзэн ба Төрийн сангийн зөвлөлийн ажлын алба нь харилцан хүлээн зөвшөөрөгдсөн зохицуулалтын нөхцөл, болзлыг хэлэлцэн тохиролцож, тус тусын үүрэг хариуцлага, хүлээлтийг тусгасан болно. Үүнд үе үе бие даасан аудит хийх, мэдэгдэлгүйгээр материаллаг өөрчлөлт хийхгүй байх, зөрчлийг арилгах хугацаа, маргааныг арбитраар шүүх гэх мэт ердийн заалтууд багтана.
- Үйлчилгээ: Зохицуулалт хийгдсэний дараа дагаж мөрдөх байдал, итгэлцлийн түвшинг цаг хугацааны явцад хадгалж үлдэхийг баталгаажуулдаг. Хүлээн зөвшөөрөлт бүрийг Зохицуулах үе шатанд байгуулсан гэрээгээр зохицуулна.

*Гэрчилгээжүүлэх байгууллага нь эзэмшигчийн хувийн мэдээллийг агуулсан тоон гарын үсгийн гэрчилгээг олгоно.* Тоон гарын үсгийн гэрчилгээ нь гэрчилгээний нэрлэсэн субъектийн нийтийн түлхүүрийн өмчлөлийг гэрчилдэг. Энэ нь бусад хүмүүст (найдвартай талууд) баталгаажуулсан нийтийн түлхүүрт тохирох хувийн түлхүүрийн талаарх гарын үсэг эсвэл мэдэгдэлд найдах боломжийг олгодог. *Гэрчилгээжүүлэх байгууллага* нь гэрчилгээний субъект (эзэмшигч) болон гэрчилгээнд найдаж буй талуудын аль алинд нь итгэмжлэгдсэн гуравдагч этгээдийн үүрэг гүйцэтгэдэг. Өөр нэг нийтлэг үйл ажиллагаа нь цахим гарын үсэг зурахад хэрэглэгдэх иргэний үнэмлэх олгох явдал юм.

- ***тоон гарын үсгийн гэрчилгээ*** гэж тоон гарын үсгийн гэрчилгээ гэдэг нь тухайн хүний тухайд цахим баримт бичиг гэсэн үг юм.
    - тоон гарын үсгийн гэрчилгээ олгосон гэрчилгээжүүлэгч байгууллагыг тодорхойлж, тухайн гэрчилгээжүүлэгч байгууллага тоон гарын үсэг зурсан байх;
    - тоон гарын үсгийн гэрчилгээ нь тухайн хүнийг тодорхойлдог, эсвэл танихад ашиглаж болно;
    - мөн тухайн хүний нийтийн түлхүүрийг агуулна. Нийтийн түлхүүр гэдэг нь тоон гарын үсгийн гэрчилгээнд агуулагдах өгөгдлийг хэлнэ.

*Технологи болон үйл явц*

Аюулгүй цахим гарын үсэг нь дараах дарааллын дагуу явагдана:

a) мессеж боловсруулалт үүсгэх өгөгдөлд хэш функцыг ашиглах;
b) мессежийн хэш утгыг шифрлэх хувийн түлхүүрийг ашиглах;
c) шифрлэгдсэн мессежийн боловсруулалтыг цахим баримт бичигт нэгтгэх,
d) цахим баримт бичиг болон шифрлэгдсэн мессежийн дамжуулалтыг аль алиных нь хамт дамжуулах.
    - тоон гарын үсгийн гэрчилгээ, эсвэл
    - тоон гарын үсгийн гэрчилгээнд нэвтрэх хэрэгсэл;

Цахим баримт бичиг, шифрлэгдсэн мессежийн боловсруулалт, тоон гарын үсгийн гэрчилгээ эсвэл тоон гарын үсгийн гэрчилгээнд нэвтрэх хэрэгслийг хүлээн авсны дараа:

UIH.MN СУДАЛГААНЫ САН

- тоон гарын үсгийн гэрчилгээнд агуулагдах нийтийн түлхүүрийг ашиглан шифрлэгдсэн мессежийн задралыг тайлах;
- хэш функцыг цахим баримт бичигт агуулагдсан өгөгдлийн шинэ мессеж боловсруулалт үүсгэх зорилгоор ашиглах;
- тоон гарын үсгийн гэрчилгээ хүчинтэй эсэхийг баталгаажуулах.

### 4.2 Литва[394]

Литва Улс нь Цахим гарын үсгийн тухай хуулийг (Law on electronic signature) 2000 онд батлан хэрэгжүүлж эхэлжээ. Энэ хууль нь улс орон даяар цахим гарын үсгийн дэд бүтцийг хэрэглэж, хэрэгжүүлэхэд шаардлагатай асуудлуудыг зохицуулсан байна. Хууль нь 5 бүлэг, 16 зүйлтэй ба дараах бүтэц, агуулгатай байна.

Бүлэг 1. Нийтлэг үндэслэл
Бүлэг 2. Гарын үсэг үүсгэлт, баталгаажуулалт, хүчин төгөлдөр, гарын үсэг хэрэглэгчдийн эрх, үүрэг
Бүлэг 3. Гэрчилгээжүүлэх үйлчилгээ ба үйлчилгээ үзүүлэгчид тавигдах шаардлага
Бүлэг 4. Цахим гарын үсгийн хяналт
Бүлэг 5. Эцсийн заалт

Энэхүү хууль нь цахим гарын үсэг, гарын үсэг хэрэглэгчийн эрх, үүрэг, баталгаажуулах, хүчин төгөлдөр байдлыг зохицуулах, гэрчилгээжүүлэх үйлчилгээ, тэдгээрийн үйлчилгээ үзүүлэгчийн шаардлага, цахим гарын үсгийн үйлчилгээ эрхлэх байгууллагын эрх, чиг үүргийг зохицуулна.

Хуулийн нийтлэг үндэслэлд тодорхойлсноор **цахим гарын үсэг** гэдэг нь эзэмшигч тухайн нэг бичиг баримттай өөрийгөө холбоотой болохыг баталгаажуулах, цахим гарын үсгийн үнэн зөвийг баталгаажуулах үүднээс үүсгэсэн дата юм.

*Цахим гарын үсгийн хэрэглээ*

Литва Улсын Цахим гарын үсгийн тухай хуулийн дагуу цахим гарын үсгийг бусад хуульд өөрөөр заагаагүй бол уг хуулиар заасан шаардлагатай нийцэж байвал гараар зурсан гарын үсэгтэй адил гэж үзнэ. Тиймээс улсын болон хувийн салбаруудын бичиг баримтын хөтлөлтөд тоон болон гараар бичсэн гарын үсгийг хуулийн дагуу адилд тооцно. Мөн хуульд цахим гарын үсгийг шүүхэд нотлох баримт болгон хүлээн зөвшөөрдөг байна.[395]

Литва Улсын Засгийн газраас 2007 оны 11-р сараас эхлэн цахим гарын үсэгтэй нийцсэн шинэ SIM картаар гар утас ашиглан баримт бичигт цахимаар гарын үсэг зурах боломжтой болсон байна. Гар утасны цахим гарын үсгийн давуу талыг ашиглахыг хүсч буй хүмүүс SIM картаа сольж, цахим үнэмлэхний /*eIdentity*/ гэрээнд гарын үсэг зурах шаардлагатай. Зөвхөн хэрэглэгчид мэддэг хоёр код нь утсан дээрх ID түлхүүрийг хууль бус хэрэглээнээс хамгаалдаг байна. Үүнээс хойш 2009 оны 01-р сараас цахим үнэмлэхний /*eID*/ баталгаажсан гэрчилгээ олгож эхэлсэн байна.

*Гэрчилгээжүүлэх үйлчилгээ*

Гэрчилгээжүүлэх үйлчилгээ үзүүлэгчид гарын үсэг ашиглахтай холбоотой дараах үйлчилгээ үзүүлнэ:

[394] https://www.uaipit.com/uploads/legislacion/files/0000004325_Law%20on%20Electronic%20Signature.pdf
[395] https://joinup.ec.europa.eu/sites/default/files/inline-files/eGovernment%20in%20Lithuania%20-%20February%202016%20-%2018_0%20-%20v2_00.pdf

УИХ.MN СУДАЛГААНЫ САН

- гэрчилгээ олгох, гарын үсгийг баталгаажуулах зорилгоор гарын үсэг хэрэглэгчдэд гэрчилгээний өгөгдөл өгөх;
- хоёрдогч шатны үйлчилгээ буюу гарын үсэг зурсан өгөгдлийн цагийн тамга үүсгэх, зөвлөгөө өгөх, гэрчилгээ авах хүний бүртгэл.

*Цахим гарын үсгийн хяналтын байгууллагын чиг үүрэг*

- гарын үсгийн тоног төхөөрөмжийн шаардлагыг боловсруулах;
- баталгаажсан гэрчилгээ олгох гэрчилгээжүүлэх үйлчилгээ эрхлэгчдэд тавигдах шаардлагыг боловсруулах;
- гарын үсгийг баталгаажуулах журмын шаардлагыг тогтоох;
- гэрчилгээжүүлэх үйлчилгээ эрхлэгчдэд сайн дураар магадлан итгэмжлэхэд тавигдах шаардлага, журмыг тогтоох;
- гэрчилгээжүүлэх үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудыг магадлан итгэмжлэх;
- баталгаажсан гэрчилгээ олгож, бүртгүүлж, жагсаалтыг нь "Албан ёсны сонин"-д нээлттэй нийтлэх;
- гэрчилгээжүүлэх үйлчилгээ үзүүлэгч байгууллагаас цуглуулсан баталгаажсан гэрчилгээний менежмент ба гарын үсэг хэрэглэгчдийн лавлагаатай холбогдсон мэдээллийг хэрхэн удирдаж байгааг хянах;
- баталгаажсан гэрчилгээ олгодог гэрчилгээжүүлэх үйлчилгээ эрхлэгчийн бүртгэлийг хүчингүй болгох;
- хоёрдогч баталгаажуулалтын үйлчилгээ үзүүлэх журмыг тогтоох;
- холбогдох цахим байгууллагуудтай холбоо тогтоох;
- олон улсад гарын үсэг зурахад хяналт тогтоох
- бусад чиг үүргийг гүйцэтгэх.

### 4.3 Эстони

Эстонийн парламент (Riigikogu) нь Тоон гарын үсгийн тухай хуулийг (Digital signature act)[396] 2000 онд батлан хэрэгжүүлж эхэлжээ. Энэ хууль нь улс орон даяар дижитал гарын үсгийн дэд бүтцийг хэрэглэж хэрэгжүүлэхэд шаардлагатай буй бүх асуудлыг зохицуулсан байна. Хууль нь 10 бүлэг, 47 зүйлтэй ба дараах бүтэц, агуулгатай байна.

Бүлэг 1. Нийтлэг үндэслэл
Бүлэг 2. Гэрчилгээ
Бүлэг 3. Гэрчилгээ олгох үйлчилгээ ба гэрчилгээ олгох үйлчилгээ үзүүлэгч
  Хэсэг 1. Гэрчилгээ ба гэрчилгээний шаардлага
  Хэсэг 2. Гэрчилгээ авах өргөдөл
  Хэсэг 3. Гэрчилгээний хүчинтэй хугацаа, сунгалт ба цуцлалт
Бүлэг 4. Цаг тамгалах үйлчилгээ ба цаг тамгалах үйлчилгээг үзүүлэгч
Бүлэг 5. Гэрчилгээний үйлчилгээ ба цаг тамгалах үйлчилгээний нөхцөлийг цуцлах нь
Бүлэг 6. Гэрчилгээний бүртгэл
Бүлэг 6.1. Аюулгүй гарын үсэг үүсгэх төхөөрөмжүүд
Бүлэг 7. Үйлчилгээ үзүүлэгчид болон даатгалын хөрөнгийн хариуцлага
Бүлэг 8. Гадаадын гэрчилгээний үйлчилгээгээр олгогдсон гэрчилгээ, тоон гарын үсэг, тоон тамга зэргийг хүлээн зөвшөөрөх тухай
Бүлэг 9. Гэрчилгээ олгох үйлчилгээ ба цаг тэмдэглэх үйлчилгээ үзүүлэгчдийн удирдлага

[396] https://www.riigiteataja.ee/en/eli/530102013080/consolide

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Бүлэг 10. Үндэслэл заалтуудыг хэрэгжүүлэх нь зэрэг болно.

Энэхүү хууль нь тоон гарын үсэг, тоон тамга хэрэглэх шаардлагатай нөхцөлүүдийг хангах, гэрчилгээ олгох үйлчилгээ ба цаг тамгалах үйлчилгээний нөхцөлүүдийг удирдах үйл явцыг зохицуулна.

Хуулийн нийтлэг үндэслэлд тодорхойлсноор **“Тоон гарын үсэг”** гэдэг нь эзэмшигч тухайн нэг бичиг баримттай өөрийгөө холбоотой болохыг илэрхийлэх үүднээс хэрэглэдэг техникийн систем болон байгууллагын арга хэлбэрийг ашиглан үүсгэсэн дата нэгж юм.

*Тоон гарын үсгийн тухай хэрэглээ*

Эстони Улсын Тоон гарын үсгийн тухай хуулийн дагуу тоон гарын үсгийг бусад хуульд өөрөөр заагаагүй бол уг хуулиар заасан шаардлагуудтай нийцэж байвал гараар зурсан гарын үсэгтэй адил гэж үзнэ. Тиймээс улсын болон хувийн салбаруудын бичиг баримтын хөтлөлтөд тоон болон гараар бичсэн гарын үсгийг хууль ёсоор адилд тооцно. Мөн хуульд төрийн байгууллагууд нь тоон гарын үсэг бүхий бичиг баримтуудыг хүлээн зөвшөөрнө гэж заажээ.

Тоон гарын үсгийн тухай хуульд заасан шаардлагын дагуу бол тоон гарын үсэг нь гарын үсэг зурагчийг өвөрмөцөөр таниулж байх ёстой. Ийм гарын үсэг бүхий дата мэдээллийг гарын үсэг зурсны дараагаар тухайн гарын үсгийг хүчингүй болгохоос нааш өөрчлөх боломжгүй байхаар албажуулах ёстой байдаг. Мөн гарын үсэг зурсан цагийг бас таниулна (цаг тамгалах эсхүл түүнтэй дүйцэхүйц цагийг үүсгэх програм ашиглах хэрэгтэй болно).

*Гэрчилгээ олгох үйлчилгээгээр хангагчид*

Тоон гарын үсгийн тухай хууль нь Эстони дахь Гэрчилгээ олгох үйлчилгээ үзүүлэх байгууллагуудын үйл ажиллагаа, тэдгээрт тавигдах шаардлагыг хуульд заасны дагуу зохицуулж удирдана. Гэрчилгээ олгох үйлчилгээний байгууллага нь;

1) Олон нийтийн хязгаарлагдмал хариуцлагатай компаниуд;

2) Дүрмийн сан нь 25,000 еврогоос давсан хувийн хязгаарлагдмал хариуцлагатай компаниуд;

3) Хуулийн этгээд;

4) Бүгд Найрамдах Улсын Засгийн газраас тогтоосон төрийн байгууллагууд байх ба Үндэсний гэрчилгээ олгох үйлчилгээгээр хангагчийн бүртгэлд бүртгэгдсэн, жил тутам байгууллагын болон системийн найдвартай байдлын тухайд хөндлөнгийн аудит шалгалтанд хамрагддаг байх ёстой. Гэрчилгээ олгох үйлчилгээгээр хангагч нь үйлчилгээ үзүүлэх явцад гарсан алдааг баталгаатай нөхөн төлөх залруулах үүднээс даатгалд хамрагдсан байх ёстой.

Тоон гарын үсгийн тухай хуулийн дагуу гэрчилгээ олгох үйлчилгээгээр хангагч нь зөвхөн үнэмлэх дээрх нэр ба регистрээр нотлогдох жинхэнэ нэрээр нь гэрчилгээ олгодог нь онцлог бөгөөд нууц нэрээр гэрчилгээ олгох асуудал одоогоор энэ хуульд тусгагдаагүй. Энэ талаар хууль хэлэлцэх үеэр хөндөгдөж байсан ч нэмэлт эрсдэл үүсгэх талтай гэж үзэж байжээ.

*Цаг тамгалах үйлчилгээгээр хангагчид*

Тоон гарын үсгийн тухай хууль нь мөн цаг-тамгалах үйлчилгээ үзүүлэгч нарын үйл ажиллагааг зохицуулна. Үйлчилгээ үзүүлэгчдэд тавигдах шаардлага нь үндсэндээ гэрчилгээний үйлчилгээнийхэнтэй адил байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Хуульд заасны дагуу цагийн тамга нь тодорхой мэдээлэл, өгөгдөл тодорхой агшинд оршиж байсныг нотлох дата нэгж юм. Хуульд цагийн тамгыг илүү нарийн дэлгэрэнгүй тодорхойлдоггүй боловч цагийн тамга бүхий мэдээллийг тухайн цагийн тамгыг хүчингүй болгохоос нааш ямарваа өөрчлөлт хийгдэх боломжгүйгээр үйлдэгдэх ёстой гэж заасан байна.

*Албан ёсны бичиг баримт*

Тоон гарын үсгийн тухай хуулиар нэг жилээс дээш оршин суух зөвшөөрөл бүхий иргэд мөн байнгын оршин суудаг бүх гадаадын иргэд албан ёсны ID Үнэмлэх карттай байх ёстой. Гэвч 1992-1996 онд 10 жилийн хугацаатай олгогдсон Эстони улсын иргэний паспорт 2002-2006 оны хооронд хугацаа нь дуусссан тул ихэнх хүмүүс зөвхөн үнэмлэх авах өргөдөл гаргасан, эсхүл үнэмлэхийг паспортын хамтаар авахаар ханджээ. 2006 оны сүүлч гэхэд 1 сая гаруй иргэнд үнэмлэх олгогдсон байна. Бүх бичиг баримт нь цахим мэдээлэл болон гэрчилгээ агуулсан чиптэй. Хэрэв үнэмлэхээ цахим хэрэглээтэй болгохыг хүсэхгүй бол гэрчилгээний хүчинтэй хугацааг түр түдгэлзүүлж болно. Ингэснээр тухайн үнэмлэхийг цахимаар хэрэглэх боломжгүй болох юм. Үнэмлэхний чипэнд агуулагдах гэрчилгээний хугацааг түдгэлзүүлэх, эсхүл цуцлах нь тухайн хүний нийтийн гэрчилгээний санд буй мэдээллийг арилгаж буй хэрэг юм.

*Үнэмлэх буюу карт дахь цахим мэдээлэл*

Иргэний үнэмлэх бүрт олон зүйл мэдээлэл агуулагдана. Фото зураг болон гараар зурсан гарын үсэг хоёроос бусад бүх мэдээлэл нь тус картанд цахим хэлбэрээр, өөрөөр хэлбэл, нийтээр уншиж болохуйц тусгай мэдээллийн файлын хэлбэрээр агуулагдана. Үүнээс гадна үнэмлэх картанд хоёр зүйл гэрчилгээ агуулагдах ба тэдгээрийн тус тусын хувийн түлхүүрүүд нь PIN кодтой байна. Гэрчилгээнүүд нь зөвхөн эзэмшигчийн нэр, регистрийг агуулна. Үүнээс гадна батлагаажуулалт ба и-мэйл хаяг нь доор нь байна.

*Гэрчилгээ*

Олгогдсон үнэмлэх бүр хоёр гэрчилгээг агуулна: нэг нь нэвтрэх баталгаажуулалтын нөгөө нь тоон гарын үсгийн гэх мэт. Мөн картанд тэдгээр гэрчилгээтэй холбогдох тус тус PIN кодоор хамгаалагдсан хоёр хувийн түлхүүр байна. Гэрчилгээнд ашиглалтын хязгаар байхгүй тул хувь хүмүүс, байгууллага хоорондын, эсхүл үнэмлэх эзэмшигч болон засгийн газар хоорондын гэхчлэн аливаа бүх хэлбэрийн харилцаа холбоонд ашиглагдана. Гэрчилгээнүүдэд карт эззэмшигчийн нэр, регистр агуулагдана. Гэрчилгээнүүд нь карт эзэмшигчийг бусад хэнтэй ч андуурахгүйгээр таниулна. Учир нь нэр давхцаж болох ч регистр давхцахгүй юм. Үүнээс гадна, нэвтрэх баталгаажуулалтын гэрчилгээнд карт эзэмшигчийн имэйл хаяг агуулагддаг байна.

**4.4 Тайвань**

Тайвань нь цахим гарын үсэгтэй холбоотой эрх зүйн харилцааг цахим гарын үсгийн тухай (Electronic Signatures Act 2001-11-14)[397] хуулиар зохицуулж байна. Энэхүү хууль нь UNCITRAL загварын хууль юм. Цахим гарын үсгийн тухай хууль нь нийт 17 зүйлтэй.

Уг хуулийн зорилго нь цахим ажил гүйлгээний хэрэглээг дэмжих, цахим гүйлгээний аюулгүй байдлыг хангах, цахим засаглал, цахим худалдааны хөгжлийг дэмжихэд оршино.

[397] https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=J0080037

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Энэхүү хууль нь цахим ажил гүйлгээний хэрэглээг дэмжих, цахим гүйлгээний аюулгүй байдлыг хангах, цахим засаглал, цахим худалдааны хөгжлийг дэмжих зорилгоор батлагдсан болно. Энэ хуульд заагаагүй бусад асуудлуудыг холбогдох бусад хуулийн заалтуудаар зохицуулна.

Цахим гарын үсэг гэдэг нь цахим бүртгэлд хавсаргах юм уу, холбогдох өгөгдөл буюу цахим бүртгэлд гарын үсэг зурсан этгээдийн таних тэмдэг, цахим бүртгэлийг баталгаажуулах зорилгоор бүтээсэн өгөгдлийг хэлнэ. “Тоон гарын үсэг” гэдэг нь гарын үсэг зурагчийн хувийн түлхүүрээр шифрлэгдсэн тоон өгөгдлийг математик алгоритм, эсвэл бусад арга хэрэгслүүдийг ашиглан бий болгосон, нийтийн түлхүүрээр баталгаажуулах боломжтой цахим гарын үсгийг хэлнэ.

*Гэрчилгээжүүлэх үйлчилгээ үзүүлэгч*

Олон нийтэд гэрчилгээ гаргаж өгөхийн өмнө, гэрчилгээжүүлэх үйлчилгээ үзүүлэгч нь гэрчилгээ гаргаж өгөх, гэрчилгээжүүлэх үйлчилгээтэй холбоотой үйл ажиллагааны талаар гэрчилгээжүүлэх мэдэгдлийг эрх бүхий байгууллагад гаргаж батлуулна. Батлуулсны дараа, гэрчилгээжүүлэлтийн үйлчилгээ үзүүлэгч батлагдсан гэрчилгээ олгох эрхийн тухай мэдэгдлийг вэбсайт дээрээ олон нийт лавлагаа авах боломжтой байдлаар нийтэлнэ. Энэхүү дүрмийг гэрчилгээжүүлэх мэдэгдэлд өөрчлөлт орсон тохиолдолд мөн мөрдөнө.

Гэрчилгээ олгох эрхийн мэдэгдэл нь дараах мэдээллийг багтаана:

- Баталгаажуулалтын үйлчилгээ эрхлэгчээс олгосон гэрчилгээний найдвартай байдал, гэрчилгээжүүлэх үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй чухал мэдээлэл;
- гэрчилгээ олгогч нь хүсэлт шаардахгүйгээр гэрчилгээг хүчингүй болгох үндэслэл;
- гэрчилгээний агуулгыг баталгаажуулахтай холбоотой мэдээллийг хадгалах;
- хувийн мэдээллийг хамгаалах арга, журам;
- эрх бүхий байгууллагаас өгсөн бусад чухал мэдээлэл.

Эрх бүхий байгууллага зөвшөөрөл олгосон гэрчилгээжүүлэх үйлчилгээ эрхлэгчдийн жагсаалтыг гаргана. Энэхүү хуулийг дагаж мөрдөж чадаагүй гэрчилгээжүүлэх үйлчилгээ үзүүлэгч нь тухайн эрх бүхий байгууллагын сонголтоор хамгийн багадаа 1 сая тайвань доллар, эсвэл 5 сая тайвань долларaас ихгүй мөнгөн дүнгээр торгуулна. Эрх бүхий байгууллага гэрчилгээжүүлэх үйлчилгээ үзүүлэгчээс тогтоосон хугацаанд зөрчил арилгахыг шаардаж болно. Тодорхой хугацааны дараа арилгаагүй тохиолдолд торгуулийг удаа дараа ногдуулж болно. Гэрчилгээ олгох үйлчилгээ үзүүлэгчийн шаардлагыг зөрчсөн тохиолдолд эрх бүхий байгууллага үйл ажиллагааг нь хэсэгчлэн буюу бүхэлд нь зогсоож болно.

Гэрчилгээжүүлэх үйлчилгээ үзүүлэгч үйлчилгээгээ зогсоохоос өмнө дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

- үйлчилгээг зогсоохоос өмнө багадаа 30 хоногийн өмнө эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ.
- цуцлах үед хүчинтэй хэвээр байгаа гэрчилгээтэй холбоотой аливаа үйлчилгээг өөр гэрчилгээжүүлэх үйлчилгээ эрхлэгчдэд шилжүүлэх үүрэг хүлээнэ.
- үйлчилгээ дуусгавар болох, хүчин төгөлдөр гэрчилгээг өөр гэрчилгээжүүлэх үйлчилгээ үзүүлэгчид олгох тухай мэдэгдлийг дуусгавар болохоос дор хаяж гучин хоногийн өмнө талуудад өгнө.
- гэрчилгээжүүлэх үйлчилгээ үзүүлэгч нь архив, бүртгэлээ оноогдсон гэрчилгээжүүлэх үйлчилгээ эрхлэгчид шилжүүлнэ.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Энэ зүйлийн нэг дэх хэсгийн хоёр дахь дэд хэсэгт заасны дагуу гэрчилгээжүүлэх үйлчилгээ үзүүлэгч уг үйлчилгээг авахыг хүсээгүй тохиолдолд эрх бүхий байгууллага гэрчилгээжүүлэх үйлчилгээ үзүүлэгчийг шууд томилж болно. Шаардлагатай тохиолдолд, эрх бүхий байгууллага тухайн үед хүчин төгөлдөр байгаа гэрчилгээг олон нийтэд зарлаж, цуцалж болно. Өмнөх заалт нь энэхүү хуулийн дагуу үйл ажиллагааг нь зогсоосон гэрчилгээжүүлэх үйлчилгээ үзүүлэгч нар мөн хамаарна.

Гэрчилгээжүүлэлтийн үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн үйл ажиллагаа болон гэрчилгээжүүлэхтэй холбоотой бусад үйл явцын улмаас талууд болон гэрчилгээнд найдаж буй иргэнд учирсан хохирлыг гэрчилгээжүүлэх үйлчилгээ үзүүлэгч хариуцлагатай ажилласан гэдгээ нотлохгүй бол хариуцлага хүлээнэ. Гэрчилгээжүүлэх үйлчилгээ үзүүлэгч гэрчилгээ ашиглах хязгаарлалтыг тодорхой зааж өгсөн тохиолдолд эсрэгээр ашигласнаас үүссэн хохирлыг хариуцахгүй.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**АШИГЛАСАН МАТЕРИАЛ**


- Тайвань улсын цахим гарын үсгийн тухай хууль https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=J0080037
- Шри Ланка улсын цахим гарын үсгийн тухай хууль https://www.casrilanka.com/casl/images/stories/EDBA/electronic%20transactions%20act%20no.%2019%20of%202006.pdf
- https://www.steptoe.com/images/content/2/4/v1/2416/4031.pdf
- Япон улсын цахим гарын үсгийн тухай хууль http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?id=109&vm=04&re=01
- https://www.fdic.gov/regulations/compliance/manual/10/X-3.1.pdf
- https://rightsignature.com/legality/electronic-signature-laws.html
- https://connective.eu/three-types-of-electronic-signatures/
- https://warwick.ac.uk/fac/soc/law/elj/jilt/2002_2/spyrelli/
- https://www.lexology.com/library/detail.aspx?g=4b4b0cfb-e0a5-4785-8d98-3fe799704782
- Digital Trade in MENA, 2020 https://openknowledge.worldbank.org/bitstream/handle/10986/33521/Digital-Trade-in-MENA-Regulatory-Readiness-Assessment.pdf?sequence=1&isAllowed=y
- Харилцаа холбоо, мэдээллийн технологийн нэр томьёоны толь бичиг https://www.cita.gov.mn/%D0%BD%D1%8D%D1%80-%D1%82%D0%BE%D0%BC%D1%8A%D1%91%D0%BE
- https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=uriserv:OJ.L_.2014.257.01.0073.01.ENG
- https://ec.europa.eu/cefdigital/wiki/display/CEFDIGITAL/Introduction+to+e-signature
- https://ec.europa.eu/cefdigital/wiki/display/CEFDIGITAL/What+is+the+legislation+-+esignature
- Welcome to e-Estonia https://ega.ee/wp-content/uploads/2016/09/eGA-esitlus-eEstonia_2016_PDF.pdf
- Монгол Улсын төрийн үйлчилгээг цахимжуулахтай холбоотой эрх зүйн өнөөгийн байдлын судалгаа Улаанбаатар хот 2014 он, Цахим эрх зүй хууль зүйн өгүүлэл ярилцлага Улаанбаатар хот 2010, https://unread.today/c/techworm-msign
- Харилцаа холбоо мэдээллийн технологийн газар. Төрийн үйлчилгээг цахимжуулах, нэгдсэн сүлжээ нэвтрүүлэх ажлын зорилт хэрэгжилт https://cabinet.gov.mn/wp-content/uploads/tsahimjuulah.pdf
- Цахим гарын үсэг ба түүний хэрэглээ, хууль ба бодит байдал. Ньюсоник ХХК 2021, Дамдинсүрэн Анхбаяр https://newsonic.mn/
- Тоон гарын үсэг олгогч байгууллагууд https://smartoffice.mn/
- Цахим гарын үсгийн тухай хууль https://www.legalinfo.mn/law/details/574
- https://unread.today/c/techworm-msign
- Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого. МУ-н Засгийн Газар 2019
- Цахим засаглал, бодлого болон тоон гарын үсэгтэй холбоотой эрх зүйн харьцуулсан судалгаа, ПСХ, 2021


UIH.MN
СУДАЛГААНЫ САН

# КИБЕР ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА БА ЭРХ ЗҮЙН ОРЧИН

*О.Билгүүтэй, Р.Оргилмаа, Б.Батцэцэг*

## АГУУЛГА

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

БҮЛЭГ I. КИБЕР ГЭМТ ХЭРГИЙН ТАЛААРХ ҮНДСЭН ОЙЛГОЛТ

1.1 КИБЕР ГЭМТ ХЭРЭГ, ХАЛДЛАГЫН ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

1.2 ХАЛДЛАГЫН АРГА ХЭЛБЭРҮҮД

БҮЛЭГ II. КИБЕР ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ОЛОН УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ НИЙТЛЭГ АСУУДЛУУД

2.1 КИБЕР ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ БУДАПЕШТИЙН КОНВЕНЦ

2.2 КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ОЛОН УЛСЫН СТАНДАРТ

2.3 ДЭЛХИЙН КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ИНДЕКС (GCI)

2.4 ОЛОН УЛСЫН КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОДЛОГО

2.4 ЦАХИМ ОРЧИН ДАХЬ ХҮНИЙ ЭРХИЙН ТҮГЭЭМЭЛ ТУНХАГЛАЛ

БҮЛЭГ III. МОНГОЛ УЛСЫН КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН

3.1 МОНГОЛ УЛС ДАХЬ КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДАЛ

БҮЛЭГ IV. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

4.1 АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС

4.2 БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС

4.3 МАЛАЙЗ УЛС

4.4 ЯПОН УЛС

4.5 ГЕРМАН УЛС

4.6 ИХ БРИТАНИ, УМАРД ИРЛАНДЫН НЭГДСЭН ХААНТ УЛС

ХАВСРАЛТ

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

## УДИРТГАЛ

Улсын Их Хурлын гишүүний захиалгаар “Кибер гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын туршлага ба эрх зүйн орчин” сэдэвт судалгааны ажлыг Парламентын судалгааны хүрээлэнд гүйцэтгэв.

***Судалгааны зорилго:*** Цахим орчинд үйлдэгдэж буй кибер гэмт хэргийн талаарх нийтлэг ойлголт, гэмт хэргийн төрөл, хэлбэр, цахим гэмт хэрэгтэй тэмцэх асуудлаарх олон улсын зөвлөмж, бусад орнуудын туршлага болон эрх зүйн орчныг харьцуулан судлах.

***Судалгааны хүрээ:*** Судалгаанд кибер аюулгүй байдал, цахим гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх бодлого, стратеги, эрх зүйн орчин сайтай өндөр хөгжилтэй орнууд болох АНУ, ИБУИНХУ, БНСУ, Малайз, Япон, Герман зэрэг 6 орныг сонгон авч бодлого, эрх зүйн орчны хүрээнд харьцуулан судлав. Эдгээр орнуудын цахим орчин дахь гэмт хэргийн нөхцөл байдал, цахим гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр баримталж буй бодлого, стратеги төлөвлөгөө болон институциональ тогтолцоо, эрх зүйн орчны асуудлуудыг авч үзсэн.

Түүнчлэн сэдвийн хүрээнд кибер аюулгүй байдлыг хангах, цахим гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр олон улсын холбогдох байгууллагуудаас гаргасан зөвлөмж, олон улсын гэрээ, конвенцууд болон уг асуудалтай холбоотой олон улсын нэр томьёоны тодорхойлолт, үндсэн ойлголтуудыг авч үзсэн болно.

***Судалгааны бүтэц:*** Судалгааны мэдээллийг дараах 4 бүлэг асуудлын хүрээнд ангилан боловсруулсан:

- Кибер гэмт хэрэг, халдлагын тухай ерөнхий ойлголт
- Кибер аюулгүй байдлын олон улсын зохицуулалт
- Монгол Улс дахь кибер аюулгүй байдал
- Гадаадын зарим орны туршлага

## СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Сүүлийн жилүүдэд цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэргийн нэр төрөл, арга, хэлбэр улам нарийсч, ийм төрлийн гэмт хэргийн гаралт ихсэж байна.

Иймд дэлхийн улс, орнууд кибер гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний бодлого стратегиа тодорхойлж, хүний нөөцөө бэлтгэх, хамгаалалтын дэд бүтэц бий болгох, байгууллага бүр дотооддоо бодлогын баримт бичиг, журам заавар батлан мөрдөх, эрсдлийн үнэлгээ хийх, аудит дээр суурилсан хамгаалалтын шийдлүүд гарган хэрэгжүүлэх, цахим гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний тогтолцоогоо бий болгох, эрх зүйн орчныг бүрдүүлэхээс гадна бүх нийтийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх гэх мэт арга хэмжээнүүдийг авах замаар энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэж байна.

<u>Судалгааны нэгдүгээр бүлэгт</u>, кибер гэмт хэрэг, кибер халдлагын тухай ерөнхий ойлголт, мэдээллийг оруулсан. Системийн сул талыг ашиглан хувь хүн, аж ахуйн нэгж, цаашлаад улсын нууцын зэрэглэлтэй мэдээлэл рүү нэвтэрч халдлага үйлдэх гэмт хэргүүд ихээр гарах болсон. Иймд цахим гэмт хэргийн нэр төрөл, халдлагын хэлбэр, халдлага үйлдэх арга замуудын талаар олон улсын хэмжээний зарим гол ойлголтууд болон нэр томьёоны тодорхойлолтыг энэ бүлэгт авч үзсэн болно.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Хоёрдугаар бүлэгт, олон улсад мөрдөж байгаа кибер аюулгүй байдлыг хангахтай холбоотой дараах стандарт, бодлогын зөвлөмж болон олон улсын гэрээ конвенцуудын талаарх мэдээллийг тусгасан.

- Олон улсад одоогоор кибер аюулгүй байдалтай холбоотой ISO/IEC 27032:2012 болон ISO 27001 стандартуудыг мөрдөж байна.
- Аливаа улс орны цахим халдлагаас өөрийгөө хамгаалах чадамжийг Олон улсын харилцаа холбооны байгууллагаас гаргасан “Кибер аюулгүй байдлын индекс”-ээр тодорхойлдог байна. Уг индексийг (1) эрх зүйн орчин (2) техникийн арга хэмжээ, (3) байгууллагын зохион байгуулалтын арга хэмжээ, (4) чадавх бэхжүүлэх арга хэмжээ, (5) хамтын ажиллагаа гэсэн үндсэн 5 чиглэлээр багцлан тодорхой шалгуур үзүүлэлтүүдээр гаргадаг.
- Олон улсын Програм хангамжийн холбоо (BSA)-ноос гаргасан зөвлөмжид кибер аюулгүй байдалтай холбоотой бодлого боловсруулахад дэлхийн улс орнуудын засгийн газруудаас баримтлах 6 тулгуур зарчмыг тодорхойлсон.
- 2001 онд “Кибер гэмт хэрэгтэй тэмцэх тухай Будапештийн конвенц” батлагдаж 2004 оноос эхлэн хэрэгжиж эхэлсэн бөгөөд энэхүү конвенцын зорилго, ач холбогдол, нэгдэн орсноор бий болох давуу талуудын талаарх мэдээллийг мөн энэ бүлэгт тоймлон оруулсан.

Гуравдугаар бүлэгт, Монгол Улс дахь кибер аюулгүй байдлын эрх зүйн орчин, кибер аюулгүй байдлыг хангахтай холбоотой үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон холбогдох хуулийн зохицуулалт, хэрэгжилтийг хариуцаж буй байгууллагуудын талаарх мэдээллийг тоймлон оруулсан.

Дөрөвдүгээр бүлэгт, Кибер аюулгүй байдлын индексээр дэлхийд тэргүүлдэг, цахим гэмт хэрэгтэй тэмцэх хууль, эрх зүйн зохицуулалт сайтай АНУ, ИБУИНХУ, БНСУ, Малайз, Япон, Герман зэрэг орнуудыг сонгон авч кибер гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хэрэгжүүлж буй бодлого стратеги болон холбогдох эрх зүйн зохицуулалтыг дэлгэрүүлэн судалсан болно.

***Судалгаанд авагдсан орнуудын туршлагыг тоймлон танилцуулбал:***

**АНУ:** Цахим гэмт хэрэгтэй тэмцэх “Үндэсний цахим стратеги”, “Богино хугацааны үндэсний аюулгүй байдлын стратегийн удирдамж”, “Үндэсний цахим аюулгүй байдлыг сайжруулах тухай” Ерөнхийлөгчийн зарлиг зэрэг хэд хэдэн бодлогын баримт бичгүүдийг батлан хэрэгжүүлж байна. Холбооны Засгийн газрын харьяа агентлагууд улс орны эдийн засгийн аюулгүй байдлыг хангах үүднээс томоохон дэд бүтцийн байгууламжууд, үйлдвэр үйлчилгээний газрууд, цаашлаад цахим сүлжээнд холбогдсон улсын болон хувийн байгууллагуудад Үндэсний стандарт технологийн хүрээлэнгээс батлан гаргасан нийтээр дагаж мөрдөх цахим аюулгүй байдлын нэгдсэн стандартыг дагаж мөрдөхийг шаарддаг. Түүнчлэн цахим аюулгүй байдлыг хамгаалах мэдлэг чадвартай хүний нөөцийг бүрдүүлэхэд анхаардаг.

АНУ-д одоогоор цахим орчны аюулгүй байдлын тухай 18 хуулийн төсөл Конгресст өргөн баригдаад байна.[398] Цахим гэмт хэргийн хохирогчдын ихэнх хувийг хүүхэд, өсвөр насныхан

[398] https://www.washingtonpost.com/politics/2021/10/18/cybersecurity-legislation-is-waiting-wings/

UIH.MN СУДАЛГААНЫ САН

эзэлдэг тул хүүхэд, залуусыг цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хамгаалах хууль цөөнгүй байна. Цахим харилцаанд оролцож буй талууд, ялангуяа интернэтээр үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын үүрэг, хариуцлагыг эдгээр хуулиудад тодорхой тусгаж өгчээ.

**ЯПОН УЛС**: 2021 оны 9 дүгээр сард Кибер аюулгүй байдлын 3 дахь стратеги төлөвлөгөөг нийгэм- эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, аюулгүй байдал-дижитал нийгмийг ухамсарлах, Япон Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах гэсэн 3 чиглэлээр хэрэгжүүлэхээр баталсан байна. Энэхүү төлөвлөгөө болон бусад бодлогын баримт бичгийн хүрээнд Японы Цагдаагийн ерөнхий газар, Кибер гэмт хэрэгтэй тэмцэх төв, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, холбогдох яамд болон интернэт орчинд үйл ажиллагаа явуулдаг хувийн хэвшлийн холбоо болох “Өсвөр үеийнхний интернэт ашиглалтыг сайжруулах зөвлөл” гэх мэтийн олон байгууллагууд хамтран ажилладаг.

Япон улсад кибер гэмт хэрэгтэй тэмцэх харилцааг Эрүүгийн хууль, Хүүхдийн биеийг үнэлэх, садар самуунд уруу татсан үйлдэлд хариуцлага ногдуулах болон хүүхэд хамгаалах тухай хууль, Насанд хүрээгүй хүмүүст интернэтийн аюулгүй орчныг бүрдүүлэх тухай хууль, Зөвшөөрөлгүйгээр цахим сүлжээнд нэвтрэхийг хориглох тухай хууль болон Кибер аюулгүй байдлын тухай хуулиар тус тус зохицуулж байна.

**ГЕРМАН УЛС:** “Кибер аюулгүй байдал-2021” стратеги төлөвлөгөөнд хамтын хариуцлагын хүрээнд цахим аюулгүй байдлыг бүрдүүлэх, төр, бизнес, шинжлэх ухаан, нийгмийн цахим халдашгүй байдлыг бэхжүүлэх, цахим хөгжлийн аюулгүй байдлыг хангах, хэмжигдэхүйц хийгээд ил тод болгох гэсэн 4 чиглэлийн дагуу холбогдох арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна.

Холбооны улсын Хууль зүйн яам, Гэр бүлийн яам, Цагдаагийн байгууллага, Эрүүгийн цагдаагийн газар зэрэг төрийн захиргааны байгууллагууд хамтран цахим гэмт хэргийн талаарх үйл ажиллагааг хянах, мэдээллийг индексжүүлэх, санал гомдол хүлээн авах, шийдвэрлэх, цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр, үйл ажиллагаанд хяналт тавьдаг. Кибер гэмт хэргээс хамгаалах харилцааг Эрүүгийн хууль, Нийгмийн сүлжээн дэх хуулийн хэрэгжилтийг хангах тухай хууль, Иргэний хууль болон Теле мэдээллийн хэрэгслийн тухай хууль зэрэг хуулиудаар тус тус зохицуулж байна.

**ИБУИНХУ:** Тус улсын Засгийн газраас цахим гэмт хэрэгтэй тэмцэх бодлогын баримт бичгийг 5 жилийн хугацаатай боловсруулан баталдаг бөгөөд 2016-2021 онд “Үндэсний цахим аюулгүй байдлын стратеги”-ийг хэрэгжүүлж, тус бодлогын баримт бичигт хэрэгжилтийн төлөвлөгөөг хавсарган баталсан. Уг стратеги нь цахим аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх, хөгжүүлэх гэсэн 3 цогц төлөвлөгөөнөөс бүрдэж байна. Найдвартай цахим харилцаа холбоог бий болгох, засгийн газар болон чухал шаардлагатай объектуудын цахим аюулгүй байдлыг хангах, гадаад, дотоодын террорист халдлагаас урьдчилан сэргийлэх, цахим аюулгүй байдлыг хангах байгууллага, нэгжүүдийн техник технологи болон хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх зэрэг ажлуудыг төлөвлөн хэрэгжүүлж байна.

Тус улсын хууль сахиулах байгууллагын цахим гэмт хэрэгтэй тэмцэх нэгжүүд нь зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хүрээнд өөр хоорондоо болон бүсийн хэмжээнд олон

https://www.csoonline.com/article/3626908/18-new-cybersecurity-bills-introduced-as-us-congressional-interest-heats-up.html

UIH.MN СУДАЛГААНЫ САН

улсын хууль сахиулах байгууллагууд, тухайлбал, Европол, Холбооны Мөрдөх Товчоо, АНУ-ын Тагнуулын Алба зэрэг байгууллагуудтай хамтран ажилладаг байна. Цахим гэмт хэрэгтэй холбоотой харилцааг олон тооны хууль, тогтоомжоор зохицуулдаг бөгөөд цахим орчны аюулгүй байдлыг хангахад төр, интернэтээр үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын үүрэг, хариуцлага, хяналтын асуудлуудыг нарийвчлан зохицуулсан байна.

**БНСУ:** 2019 онд Өмнөд Солонгос Улс кибер халдлага, гэмт хэргээс урьдчилан сэргийлсэн Кибер аюулгүй байдлын үндэсний стратегийг боловсруулжээ. Уг стратеги нь 6 зорилтот хөтөлбөртэй байна. Эдгээр зорилтот хөтөлбөрүүд нь үндэсний дэд бүтцийн аюулгүй байдлыг сайжруулах, кибер халдлагад шуурхай хариу арга хэмжээ авах, олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, кибер аюулгүй байдлын эрх зүйн орчныг сайжруулах зэрэг арга хэмжээнүүдийг багтаасан байна. БНСУ-д 2015 оноос эхлэн Ерөнхийлөгчид шууд харьяалагддаг Үндэсний аюулгүй байдлын зөвлөл (ҮАБЗ) нь кибер аюулгүй байдалтай холбоотой асуудлуудыг удирдан зохицуулж ирсэн байна.[399] Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн харьяанд байх Цахим аюулгүй байдлын үндэсний төв нь цахим гэмт хэрэг, халдлага аюулгүй байдалтай холбоотой асуудлуудыг хариуцан ажилладаг. Цахим аюулгүй байдлын үндэсний төв нь Шинжлэх ухаан, мэдээлэл, технологийн яам болон Үндэсний Батлан хамгаалах яамтай хамтран хувийн хэвшил болон төрийн байгууллагуудын цахим аюулгүй байдлыг хариуцаж хоорондоо нягт уялдаатай хамтран ажилладаг байна.

**МАЛАЙЗ УЛС:** Тус улсад 2020-2024 онд хэрэгжүүлэх кибер аюулгүй байдлын төлөвлөлт, хэрэгжилтийн бүх асуудлыг зохицуулах 5 чиглэл бүхий стратеги боловсруулсан байна. Энэхүү кибер аюулгүй байдлын стратеги[400] (Malaysia Cyber Security Strategy)-т үр дүнтэй засаглал, эрх зүйн орчныг сайжруулах, инновац, технологи, судалгааны ажлуудыг түргэсгэх, олон нийтийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх, олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх зэрэг зорилтууд тусгагдсан байна. 1997 онд Компьютерийн гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуулийг (The Computer Crimes Act) баталсан ба 2011 оны 12-р сарын 1-нд дахин шинэчилсэн байна.

***Түлхүүр үг:*** *Кибер гэмт хэрэг, кибер халдлага, Кибер аюулгүй байдал, Мэдээллийн аюулгүй байдал, Кибер аюулгүй байдлын индекс, Будапештийн Кибер гэмт хэрэгтэй тэмцэх тухай конвенц*

***Keywords:*** *Cyber crime, Cyber attack, Cyber threat, Cybersecurity, Information security, Global cyber security index, Budapest cybersecurity convention*

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[399] From 2015 to 2018, the NSC designated the cybersecurity adviser to lead the cybersecurity efforts nation-wide, however, this position was merged with the cyber information convergence adviser under the same NSC

[400] Malaysia Cyber Security Strategy (2020-2024) https://asset.mkn.gov.my/wp-content/uploads/2020/10/MalaysiaCyberSecurityStrategy2020-2024.pdf

*Хүснэгт 1. Судалгаанд авагдсан орнуудын онцлох туршлага, эрх зүйн орчны талаарх мэдээллийг доорх хүснэгтээр хураангуйлан танилцуулав.*

| Улс | Цахим гэмт хэргийн нөхцөл байдал | Кибер гэмт хэрэгтэй тэмцэх стратегитай эсэх | Хэрэгжүүлэгч байгууллагууд | Эрх зүйн орчны лавлагаа |
|---|---|---|---|---|
| АНУ | Цахим гэмт хэргийн мэдээллийн сүлжээ (Cybertipline) нь 2020 оны байдлаар цахимаар үйлчилгээ эрхлэгчдээс хүүхдийг бэлгийн хүчирхийлэл, садар самуун үйлдэлд ашигласан талаарх 21.7 сая мэдээлэл хүлээн авсан байна.[401] (Дэлгэрэнгүйг судалгааны хэсгээс харах) | -2018 онд баталсан “Үндэсний цахим стратеги” (National Cyber Strategy)<br>-2021 онд баталсан “Богино хугацааны Үндэсний Аюулгүй байдлын Стратегийн Удирдамж” (Interim National Security Strategic Guidance)<br>-2021 онд гаргасан “Үндэсний Цахим Аюулгүй байдлыг сайжруулах тухай” (Executive Order on Improving the Nation’s Cybersecurity) Ерөнхийлөгчийн зарлиг | -Батлан Хамгаалах Яам (Department of Defense)-ны харьяа Үндэсний Аюулгүй байдлын Агентлаг (National Security Agency)<br>-Дотоодыг Аюулаас хамгаалах Яам (Department of Homeland Security)-ны харьяа Цахим Аюулгүй байдал, Дэд бүтцийн Аюулгүй байдлын Агентлаг (Cybersecurity and Infrastructure Security Agency)<br>-Дотоодыг Аюулаас хамгаалах Яамны харьяа АНУ-ын Тагнуулын газар (US Secret Service)<br>-Хууль зүйн яам (Department of Justice)-ны харьяа агентлаг<br>-Холбооны Мөрдөх Товчоо (Federal Bureau of Investigation) | -Компьютерт хууль бусаар нэвтрэхийг хориглох тухай хууль<br>-Холбооны Мэдээллийн Аюулгүй байдлын Менежментийн тухай хууль<br>-Цахим Харилцаа холбооны Нууцлалын тухай хууль<br>-Цахим Аюулгүй байдлын мэдээлэл солилцох тухай хууль<br>-Цахим ертөнцөд хүүхдийн нууцыг хамгаалах тухай хууль<br>-Интернэт орчинд хүүхдийг хамгаалах тухай хууль<br>-Хүүхэд хамгаалал, аюулгүй байдлын тухай хууль<br>-21-р зуунд хүүхдийг хамгаалах тухай хууль<br>-Домэйн нэр үнэн зөв байх тухай хууль[402]<br>-Цахим гэмт хэргийн мэдээллийн шинэчлэлийн тухай хууль<br>-Ялгаварлан гадуурхах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай |
| Герман Улс | 2020 онд Герман Улсад 108,474 кибер гэмт хэрэг бүртгэгдсэн нь 2019 оныхоос 7.9%-иар, 2015 оныхоос 2 дахин нэмэгдсэн байна. | Кибер аюулгүй байдлын стратеги- 2021 | -Холбооны Хууль зүйн яам,<br>-Гэр бүлийн яам,<br>-Цагдаагийн байгууллага,<br>-Эрүүгийн цагдаагийн газар хариуцахаас гадна Гэр бүлийн яамны харьяа Хүүхэд, залуучуудад хортой мэдээллийн хяналтын | -Эрүүгийн хууль<br>-Нийгмийн сүлжээн дэх хуулийн хэрэгжилтийг хангах тухай хууль<br>-Теле мэдээллийн тухай хууль<br>-Залуучуудыг хамгаалах тухай хууль |

[402] https://www.law.cornell.edu/uscode/text/34/subtitle-II/chapter-209

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | холбооны зөвлөл (BPJM), Цахим орчин дахь хүүхэд, залуучуудыг хамгаалах комисс (KJM) | |
| Япон Улс | 2021 оны 3-р сарын байдлаар Үндэсний цагдаагийн газраас явуулсан судалгаагаар 18-аас доош насны 1819 хүүхэд 2020 онд нийгмийн сүлжээтэй холбоотой гэмт хэргийн хохирогч болсон болохыг тогтоожээ. | 2021 оны 9 сард Кибер аюулгүй байдлын 3 дахь стратеги төлөвлөгөөг батлан гаргасан байна. | -Цагдаагийн ерөнхий газар,<br>-Ерөнхий газрын “Кибер гэмт хэрэгтэй тэмцэх төв” | -Эрүүгийн хууль,<br>-Интернэтийн аюулгүй орчныг бүрдүүлэх тухай хууль<br>-Зөвшөөрөлгүйгээр цахим сүлжээнд нэвтрэхийг хориглох тухай хууль<br>-Кибер аюулгүй байдлын тухай хууль |
| Солонгос | 2020 оны байдлаар БНСУ-ын цагдаагийн байгууллагад 234 мянга орчим цахим гэмт хэрэг бүртгэгдсэн ба энэ нь өмнөх оноос 54 мянга орчмоор нэмэгдсэн байна. | | -Үндэсний тагнуулын албаны дэргэдэх Цахим аюулгүй байдлын үндэсний төв<br>-Шинжлэх ухаан мэдээлэл технологийн яам (Ministry of Science and ICT)<br>-Үндэсний Батлан хамгаалах яам (Ministry of National Defense) | -Эрүүгийн хууль<br>-Сүлжээний тухай хууль<br>Харилцаа холбооны нууцыг хамгаалах тухай хууль<br>-Мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтцийг хамгаалах тухай<br>-Цахим засаглалын тухай хууль<br>-Үндэсний батлан хамгаалахын мэдээллийн дэд бүтцийг бий болгох, мэдээллийн нөөцийг удирдах тухай хууль<br>-Зээлийн мэдээллийн ашиглалт, хамгаалалтын тухай хууль (Credit information use and protection act),<br>-Байршлын мэдээллийг хамгаалах тухай хууль<br>-Үйлдвэрлэлийн технологийг хамгаалах тухай хууль<br>-Цахилгаан холбооны бизнесийн болон санхүүгийн луйврын тухай хууль |
| Малайз | Малайзын цагдаагийн байгууллагын мэдээлснээр 2019 онд кибер халдлага, гэмт хэргийн тоо 3,787 | Малайз Улсын кибер аюулгүй байдлын стратеги[404] (Malaysia Cyber Security Strategy) | Үндэсний кибер аюулгүй байдлын агентлаг (NACSA) | -Компьютерийн гэмт хэрэгтэй тэмцэх тухай хууль<br>-Зохиогчийн эрхийн тухай хууль (The copyright (amendment act),<br>-Тоон гарын үсгийн тухай хууль (The digital signature |

[404] Malaysia Cyber Security Strategy (2020-2024) https://asset.mkn.gov.my/wp-content/uploads/2020/10/MalaysiaCyberSecurityStrategy2020-2024.pdf

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | | | |
|---|---|---|---|---|
| | байсан бол 2020 онд 4,194 болж 10%-иар нэмэгдсэн байна. 2021 онд энэ тоо нэмэгдэх төлөвтэй байгаа аж[403]. | | | act),<br>-Телемедициний тухай хууль (The telemedicine act),<br>-Харилцаа холбоо ба мультимедиан тухай хууль (The communications and multimedia act),<br>-Цахим худалдааны тухай хууль( Electronic commerce act),<br>-Төрийн цахим үйл ажиллагааны тухай хууль (Electronic government activities act),<br>-Хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль (Personal data protection act), эрүүгийн хууль Penal code),<br>-Хуурамч мэдээллийн эсрэг хууль (The anti-fake news act) |
| ИБУИНХУ | Цахимаар хамгийн их үйлдэгдэж буй гэмт хэргийн төрлүүдэд дараах хэргүүд ордог байна:<br>Нууц үг ашиглах, хувийн мэдээлэл (phishing), сүлжээнд халдах (malicious software)<br>Мөнгө хулгайлах зорилгоор цахим хуудас руу халдах ингэхдээ тухайн цахим хуудасны сүлжээ болон серверийг хэт их ачааллах замаар үйлдэх (Distributed denial of service). | ИБУИНХУ нь 5 жил тутам “Үндэсний Цахим Аюулгүй байдлын Стратеги” (National Cyber Security Strategy)-ийг шинэчлэн боловсруулж, баталдаг. | -Үндэсний Гэмт хэрэгтэй тэмцэх Агентлаг (National Crime Agency)<br>-Цагдаагийн газар<br>-Бүсийн зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх нэгжүүд<br>-Үндэсний Цахим Аюулгүй байдлын Төв (National Cyber Security Centre) | -Компьютерийн зүй бус хэрэглээний тухай<br>-Харилцаа холбооны тухай хууль<br>-Хор нөлөөтэй харилцаа холбооны тухай хууль<br>-Дижитал Эдийн засгийн тухай хууль<br>-Айлган сүрдүүлэхээс хамгаалах тухай хууль<br>-Гэмт хэрэгтэнд хариуцлага тооцох ба нийтийн хэв журмыг сахиулах тухай хууль<br>-Боловсрол болон хяналт шалгалтын тухай<br>-Хүүхэд хамгааллын тухай хууль<br>-Бэлгийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль |

Дэлгэрэнгүй мэдээллийг судалгааны хэсгээс үзнэ үү.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[403] Малайз Улс Кибер гэмт хэргийн нөхцөл байдал The Star News https://www.thestar.com.my/news/nation/2021/06/28/cybercrime-increasing-as-more-people-rely-on-digital-tech-during-pandemic-says-pm

# СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

## БҮЛЭГ I. КИБЕР ГЭМТ ХЭРГИЙН ТАЛААРХ ҮНДСЭН ОЙЛГОЛТ

### 1.1 КИБЕР ГЭМТ ХЭРЭГ, ХАЛДЛАГЫН ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

Интернэтийн хэрэглээ эрс нэмэгдэж, зөвхөн компьютер төдийгүй төрөл бүрийн ухаалаг төхөөрөмж ашиглан сүлжээнд холбогддог болсон, өдөр тутмын амьдралын олон хэрэглээг ухаалаг төхөөрөмж, цахим сүлжээ ашиглан явуулдаг болсонтой зэрэгцэн технологийн ололт амжилтыг гэмт хэрэг үйлдэх зорилгоор ашиглах, үйлдэгдэж байгаа гэмт хэргийн төрөл, хэлбэр, арга, технологи илүү боловсронгуй болох хандлагатай байна.

Цахим орчин дахь гэмт хэргийн тухай ойлголтыг авч үзэхдээ юуны өмнө кибер орон зай, халдлагуудын хэлбэр, тодорхойлолтуудыг сайтар ойлгосон байх шаардлагатай.

**Кибер** /Cyber/ гэх нэршил нь кибернетик гэх үгтэй утга дүйх ба утгачлан тайлбарлавал нарийн тооцоолон бодох техник-технологийн туслалцаатайгаар мэдээллийг боловсруулах, үйл ажиллагааг удирдах буюу залуур зүй (удирдахуйн тогтолцоо) гэж ойлгогдоно. Европын холбооноос цахим орон зайг нийтэд нь кибер орчин хэмээн тодорхойлж байна.[405]

**Кибер гэмт хэрэг** гэдэгт кибер халдлага, фишинг, онлайн мөрдлөг, заналхийлэл, скиминг буюу картны гэмт хэрэг, онлайн залилан, садар самуун дүрс бичлэг тараах, интернэтэд суурилсан оюуны өмчийн эсрэг гэмт хэргүүдийг багтаан ойлгодог.[406] Өөрөөр хэлбэл, компьютер, мэдээллийн сүлжээ, интернэт ашиглан үйлдэгдсэн бүх төрлийн гэмт хэргийг хэлнэ.[407]

**Цахим хүчирхийлэл** гэдэг[408] нь хэн нэгэн этгээд цахим технологийг ашиглан бусад хүнийг дарамтлах, заналхийлэх, ичээх, эсвэл түрэмгийлэх явдал юм. Энэ нь гар утас, компьютер, таблет, тоглоомын систем гэх мэт төхөөрөмж ашиглан үйлдэгддэг.[409]

**Мэдээллийн аюулгүй байдал** гэдэг нь мэдээлэл болон мэдээллийн системд зөвшөөрөлгүй хандах, мэдээллийг ашиглах, ил болгох, өөрчлөх, хуулах, устгах, мэдээллийн системийн үйл ажиллагааг тасалдуулах, гаднаас хяналт хийхээс хамгаалахыг хэлнэ.[410]

**Кибер аюулгүй байдал гэдэг нь** кибер гэмт хэргээс систем, сүлжээ, өгөгдлийг хамгаалахад зориулагдсан технологи, үйл явц, арга хэмжээнээс бүрддэг.[411] Кибер аюулгүй байдал нь кибер халдлагын эрсдэлийг бууруулж, систем, сүлжээ, технологийг санаатайгаар ашигласаар байгаа хүмүүсээс аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүмүүсийг хамгаалахад чиглэгддэг. Кибер халдлагууд нь олон янзын хэлбэртэй байна. (жишээ нь програмын довтолгоонууд, malware, ransomware, фишинг гэх мэт).

[405] Б.Хишигдорж, Цахим мэдээллийн орчинд үйлдэгдэх гэмт хэргийн мөрдөн шинжлэхүйн онол арга зүйн үндэс сурах бичиг 2015
[406] https://searchsecurity.techtarget.com/definition/cybercrime
[407] Д.Сумъяацэрэн Монгол Улс дахь кибер гэмт хэргийн өнөөгийн байдал, 2016 https://www.slideserve.com/maina/4923860
[408] https://kidshealth.org/en/parents/cyberbullying.html
[409] https://www.verywellfamily.com/types-of-cyberbullying-460549
[410] Мэдээллийн аюулгүй байдлын газар
[411] Төрийн мэдээлэл холбооны газар

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Кибер халдлага нь ихэвчлэн хулгайгаар (төлбөрийн картын өгөгдөл, хэрэглэгчийн мэдээлэл, компаний нууцлал, оюуны өмчийн эрхийг зөрчих гэх мэт) сүлжээнд зөвшөөрөлгүй нэвтрэн хохирогч этгээдэд санхүүгийн болон нэр хүндийн хохирол учруулах зорилгоор хийгддэг ажиллагаа юм.

Кибер халдлагууд улам бүр боловсронгуй болсоор байгаа ба олон улсад аливаа улсын засгийн газрын мэдээллийн санд халдаж улс орны аюулгүй байдал, батлан хамгаалах, цэрэг, стратеги, улс төрийн салбарт чиглэсэн аюул занал учруулах явдал түгээмэл болж байна.

## 1.2 ХАЛДЛАГЫН АРГА ХЭЛБЭРҮҮД

Кибер гэмт хэрэгтний зүгээс халдлага үйлдэх хэд хэдэн арга хэлбэрүүд байдаг ба ерөнхийд нь дараах 3 хэлбэрээр ангилдаг байна.[412]

- Хувь хүний эсрэг чиглэсэн (вирус, залилан,фишинг, спэм г.м )
- Өмчийн эсрэг (бусдын эд хөрөнгийг сүйтгэх, хортой програм тараах г.м)
- Төрийн эсрэг (кибертерроризм, мэдээллийн дайн г.м )

<u>**Хувь хүн болон өмчийн эсрэг чиглэсэн**</u>: хортой програмыг компьютерт оруулах, эсхүл өгөгдлийг хулгайлах зэрэг олон арга замаар халдлага үйлддэг байна. Үүнд:

- **Social engineering**-Хувь хүний сул талыг ашиглан хортой холбоос дээр даруулах, эсвэл хууран мэхлэх замаар компьютерт нэвтрэх эрх олж авах арга;
- **Phishing /өгөөш хаях замаар хохирогчийг удирдах/**-Хуурамч аж ахуйн нэгж байгуулах, эсхүл тэднийг төлөөлөх замаар хэрэглэгчийн мэдээллийг олж авахыг оролдох үйлдэл;
- **Pharming /Интернэт залилан/-**Вэб сайтын мэдээллийн урсгалыг өөр зүгт чиглүүлэх, хуурамч вэбсайт үйлдэх зэргээр хувь хүний мэдээллийг хулгайлах халдлага;
- **Drive-by /жолоодох/**-Систем доторх тодорхой сул талуудыг ашиглаж халдах;
- **Man in the middle /зуучлагч/**-Талуудын харилцаанд хөндлөнгөөс оролцож үр дүнд нь хакер хоёр талыг хоёуланг нь удирдах, хохироох боломжтой болох арга.

**Malware** нь компьютерийн системийг тасалдуулах, гэмтээх, зөвшөөрөлгүй нэвтрэх зорилгоор тусгайлан бүтээсэн програм хангамж бөгөөд эдгээр нь дараах хэлбэртэй байдаг:

- **Ransomware** нь компьютерийн систем дээр хортой програмаар кибер халдлагыг эхлүүлсний дараа төлбөр шаарддаг хэлбэр юм. Энэ төрлийн хорт програм нь гэмт хэрэгтнүүдийн дунд түгээмэл болж, жил бүр сая сая байгууллагыг хохироож байна.
- **Viruses** (Вирус) нь нэг компьютерээс нөгөө компьютерт өөрөө өөрийгөө хуулбарлах боломжтой жижиг хэмжээний код юм.
- **Worms** (Өт) нь бусад компьютеруудад тархахын тулд өөрийгөө хуулбарладаг бие даасан хортой програм юм.
- **Trojans** (Троян) вирус нь нэг функц (жишээлбэл, вирус арилгах) мэт харагддаг Програм боловч яг үнэндээ үйлдэл хийх үед системийг гэмтээдэг байна.
- **Spyware/adware** төрөл бүрийн файл хавсаргадаг ба үүнийг нээх холбоос дээр дарах эсвэл хортой програмыг татаж авах үед системд нэвтэрч хохирол учруулдаг.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[412] Д.Сумъяацэрэн, Монгол Улс дахь кибер гэмт хэргийн өнөөгийн байдал, 2016 https://www.slideserve.com/maina/4923860

**<u>Төрийн эсрэг чиглэсэн</u>** дараах халдлагууд түгээмэл байдаг. Үүнд:

- **Cyber terrorism** нь террорист бүлэглэлүүдээс засгийн газрын үзэл суртлын болон улс төрийн хөтөлбөрт нэвтрэн орж тодорхой зорилгоор мэдээллийн технологийг ашигладаг хэлбэр юм. Сүлжээнүүд, компьютерийн систем, харилцаа холбооны дэд бүтцэд нэвтэрч халддаг.[413]
- **Cyber warfare** нь улс үндэстний сүлжээнд нэвтэрч, мэдээллийн технологийг доголдуулдаг. Cyber warfare довтолгоонууд нь үндсэн сүлжээг эвдэх ба тухайн сүлжээний хэвийн ажиллагааг тасалдуулах чухал өгөгдлийг боогдуулах замаар халдлага үйлддэг.[414]
- **Cyber espionage** нь эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр нууц мэдээллийг олж авах тагнах хэлбэр юм. Cyber espionage нь стратегийн, эдийн засгийн, улс төрийн, цэргийн давуу талыг олж авахад ашиглагддаг.[415]

### 1.3 ЦАХИМ ОРЧИН ДАХЬ ХҮЧИРХИЙЛЛИЙН ХЭЛБЭР

Цахим хүчирхийллийн хэлбэрийг Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооноос дараах байдлаар авч үзсэн байна. Үүнд:[416]

1. Хэн нэгэн рүү эелдэг бус доромжилсон эсвэл сүрдүүлсэн и-мэйл, чат, текст, мессеж илгээх;
2. Хэн нэгний цахим хаяг, бүртгэлд зөвшөөрөлгүй халдах, ашиглах;
3. Бусдын хувийн зураг, мэдээллийг хуулбарлан байршуулж, эвлүүлэг хийх, бичлэг хийх замаар бусдыг гүтгэх доромжлох;
4. Онлайн тоглоом тоглохдоо хэн нэгэнтэй бүдүүлэг, эелдэг бус харьцах;
5. Бусдын хувийн тааламжгүй зургийг цахим орчинд байршуулах, бусдад илгээх, хуваалцах;
6. Хэн нэгнийг элэглэн дууриасан, хуурч мэхэлсэн нийгмийн сүлжээний хуурамч хаяг үүсгэх, ашиглах;
7. Хэн нэгнийг анги сургууль, олон нийтийн нийгмийн сүлжээний групп, онлайн харилцаанд ямар нэг шалтгаангүйгээр оролцуулахгүй байх, блок хийх зэрэг байна.

Монгол Улсын нийт хүн амын 37.6 хувийг 0-18 хүртэлх насны хүүхэд эзэлж байна. Гэтэл цахим хүчирхийллийн золиос нь насанд хүрээгүй хүн буюу хүүхдүүд болох нь элбэг байна. Манай улсын нийт хүн амын 80.6 хувь нь интернэт хэрэглэгч[417], түүний дотор ухаалаг утастай хүүхдүүдийн 95 хувь нь интернэт хэрэглэдэг, мөн тэдний 92 хувь нь фэйсбүүк хаягтай байгаа[418] нь цахим орчин болон нийгмийн сүлжээнд агуулгын эрсдэл, харилцааны эрсдэл, үйлдлийн эрсдэл гарч болохоор байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

413 https://www.nato.int/cps/en/natohq/topics_140739.htm?
414 https://www.dcaf.ch/sites/default/files/publications/documents/OnCyberwarfare-Schreier.pdf
415 https://www.vmware.com/topics/glossary/content/cyber-espionage
416 Цахим орчин хүүхэд хамгаалал сэдэвт хэвлэмэл фостерын сан, Харилцаа холбооны зохицуулах хороо http://ekids.mn/Home/newsdetail?dataID=22012&fbclid=IwAR2YroLWF0HURKca5LdAYWTQH5Fr5kGOy5JwOxQlCEOer_x_7CNkqt_QixY
417 Харилцаа, холбоо, мэдээллийн технологийн газар https://dashboard.cita.gov.mn/
418 “Өсвөр үе ба цахим хэрэглээ” судалгаа, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, 2018 он https://bit.ly/2RlBGNE

# БҮЛЭГ II. КИБЕР ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ОЛОН УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ БА НИЙТЛЭГ АСУУДЛУУД

## 2.1 КИБЕР ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ БУДАПЕШТИЙН КОНВЕНЦ

Кибер аюулгүй байдлын олон талт хамтын ажиллагааны эрх зүйн үндэс нь Кибер гэмт хэргийн тухай Будапештийн конвенц[419] юм.

Цахим буюу Кибер гэмт хэргийн тухай Будапештийн конвенц нь үндэсний хэмжээний хууль тогтоомжуудыг уялдуулах, мөрдөн байцаах арга техникийг сайжруулах, улс хоорондын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх замаар интернэт болон компьютерийн гэмт хэрэг (кибер гэмт хэрэг)-ийг илрүүлэх, таслан зогсоох, шийдвэрлэх зорилготой олон улсын гэрээ юм.

Кибер гэмт хэрэг нь нийгмийн сүлжээ (social network), цахим орчинд үйлдэгддэг. Будапештийн Кибер гэмт хэрэгтэй тэмцэх тухай конвенц нь 2001 оны 11 дүгээр сарын 23-нд батлагдаж 2004 оны 7-р сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон бөгөөд гишүүн бус улс орнууд ч мөн гарын үсэг зурж нэгдэхэд нээлттэй гэрээ юм.[420] Конвенц нь интернэт орчинд болон компьютерийн бусад сүлжээгээр дамжуулан үйлдэгдсэн зөрчил, ялангуяа зохиогчийн эрх, компьютертэй холбоотой залилан, хүүхдийн садар самуун, сүлжээний аюулгүй байдлыг зөрчсөн гэмт хэрэг зэрэг компьютерийн сүлжээг ашиглан үйлдэгдсэн олон төрлийн зөрчил, гэмт хэргийг таслан зогсоох, нийгмийг кибер гэмт хэргээс хамгаалахад чиглэсэн хууль, эрх зүйн нийтлэг бодлогыг тодорхойлох, ялангуяа улс орнууд зохих хууль тогтоомжийг баталж, олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэхийг дэмжсэн конвенц юм.

Уг конвенцын 2 дугаар бүлгийн 1-10 дугаар заалтад дараах 4 төрлийн үндсэн халдлага, зөрчлийг тодорхойлсон байна.[421]

- Компьютерийн мэдээллийн системийн нууцлал, бүрэн бүтэн байдал, хүртээмжтэй байдлын эсрэг гэмт хэрэг;
- Компьютертэй холбоотой гэмт хэрэг, тухайлбал, залилан, хуурамч баримт бичиг үйлдэх;
- Агуулгатай холбоотой зөрчил-хүүхдийг садар самуунд уруу татах агуулга;
- Зохиогчийн эрхийн зөрчил.

Будапештийн конвенц нь цахим гэмт хэрэгт хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчинг бүрдүүлэхээс гадна олон улсын хамтын ажиллагааны үндсийг тодорхойлсон эрх зүйн баримт бичиг юм.[422]

Уг конвенцод нэгдэн орсноор тухайн улс орон конвенцыг дотоодын хууль тогтоомжийн чиглэл болгон ашиглаж болох ба дараах давуу талуудыг бий болгоно.

[419] Кибер гэмт хэргийн тухай конвенц, 2001.11.23 https://www.coe.int/en/web/conventions/full-list/-/conventions/rms/0900001680081561

[420] https://www.coe.int/en/web/conventions/full-list/-/conventions/treaty/185

[421] https://statesassembly.gov.je/scrutinyreviewresearches/2018/research%20-%20briefing%20paper%20on%20council%20of%20europe%20convention%20on%20cybercrime%20-%2031%20october%202018.pdf

[422] https://rm.coe.int/t-cy-2020-16-bc-benefits-rep-provisional/16809ef6ac#:~:text=The%20Budapest%20Convention%20requires%20States,cybercrime%20but%20any%20offence%20where

UIH.MN СУДАЛГААНЫ САН

- Олон улсын хамтын ажиллагааны эрх зүйн үндэс бүрдэнэ.
- Нэгдэн орсон талууд цаашид конвенцын хөгжилд нэмэлт санал, протокол оруулж болно.
- Конвенцод нэгдсэн орнууд энэхүү гэрээний дагуу байгуулагдсан цэгүүдтэй 24 цагийн холболттой байна.
- Талууд хувийн хэвшилтэй хамтын ажиллагаагаа хөгжүүлж туршлагажих боломжтой.
- Оролцогч талууд өөрийн хүсэл санаачилгаар чадавхыг бэхжүүлэхэд тэргүүлэх үүрэг рольтой төв болж болно.

Будапештийн конвенцтой уялдуулан дотоодын хууль эрх зүйн орчныг бий болгосноор олон улсын цахим гэмт хэрэгтэй тэмцэх шалгуурыг хангах нөхцөл бүрдэх юм. Энэхүү конвенц нь олон улсын хамтын ажиллагааг сайжруулахаас гадна олон улсад тавигдаж буй хууль эрх зүйн шаардлагыг хангахад тусалдаг. Конвенцын талаарх зарим мэдээллийг Хавсралт 3-аас үзнэ үү.

## 2.2 КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ОЛОН УЛСЫН СТАНДАРТ

Олон улсын стандартчиллын байгууллагаас (ISO) кибер аюулгүй байдлын ойлголт, шалгуур, боловсронгуй болгох зарчмуудыг багтаасан *ISO/IEC 27032:2012 Information technology буюу* Олон Улсын *Мэдээллийн технологийн* стандартыг 2012 оны 7 дугаар сард баталсан байна.[423] Уг стандартад кибер аюулгүй байдал, сүлжээний аюулгүй байдал, хэрэглээний аюулгүй байдал, интернэтийн аюулгүй байдал, дэд бүтцийн аюулгүй байдал гэх мэт нэр томьёонуудыг тодорхойлсон байна. Түүнчлэн ISO 27001 стандарт гэж байх ба энэ нь мэдээллийн аюулгүй байдлын менежментийн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарт юм. Энэхүү стандартыг хэрэгжүүлснээр мэдээллийг хамгаалах, мэдээллийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой арга хэмжээнүүдийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, талуудад баталгаа өгдөг байна.

## 2.3 ДЭЛХИЙН КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ИНДЕКС (GCI)

Америк, Англи, Герман тэргүүтэй өрнөдийн хөгжингүй орнууд кибер аюулгүй байдлаараа дэлхийд тэргүүлж байна. Цахим халдлагаас өөрийгөө хамгаалах чадамжийг Олон улсын харилцаа холбооны байгууллага *(International Telecommunication Union)*-аас гаргасан “Дэлхийн кибер аюулгүй байдлын индекс”-ээр (The Global Cybersecurity Index) тодорхойлдог. Уг индекс (GCI) нь дэлхийн улс орнуудын кибер аюулгүй байдлын түвшинг тодорхойлох итгэмжлэгдсэн лавлагаа болдог байна.[424]

Кибер аюулгүй байдал нь олон салбарын огтлолцолд оршдог тул улс орнуудын кибер аюулгүй байдлын хөгжлийн түвшинг дараах 5 үндсэн чиглэлээр үнэлдэг байна.

- Хууль эрх зүйн орчин (Legislative environment)
- Техникийн арга хэмжээ (Technical Measures)
- Байгууллагын арга хэмжээ (Organization Measures)
- Чадавх хөгжүүлэх арга хэмжээ (Capacity Building Measures)
- Хамтын ажиллагаа (Cooperation Measures)

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[423] https://www.iso.org/standard/44375.html
[424] https://www.itu.int/en/ITU-D/Cybersecurity/Pages/global-cybersecurity-index.aspx

Эдгээр үнэлгээний чиглэл тус бүрт тухайн орны кибер аюулгүй байдлын түвшинг үнэлэх тодорхой шалгуур үзүүлэлтүүд багтдаг байна. Үүнд:[425]

***Хууль эрх зүйн орчин***

- Кибер аюулгүй байдлын тухай хууль
- Кибер аюулгүй байдлыг зохицуулах арга хэмжээ
- Спам, халдлагыг хязгаарлах хууль эрх зүй

***Техникийн арга хэмжээ***

- CIRT-(Computer Incident Response Team) Компьютерийн гэмтлийн хариу арга хэмжээний баг
- CERT-(Computer Emergency Response Team) Компьютерийн түргэн тусламжийн баг
- CSIRT-(Computer Security Incident Response Team) Компьютерийн аюулгүй байдлыг хангах хариу арга хэмжээний баг
- Стандарт хэрэгжүүлэх стратеги
- Стандартчиллын байгууллага
- Спам халдлагыг арилгахад чиглэсэн техникийн механизм, чадавх
- Кибер аюулгүй байдлын зорилгод үүлэн технологи ашиглах
- Хүүхэд багачуудыг онлайнаар хамгаалах механизм

***Байгууллагын арга хэмжээ***

- Үндэсний кибер аюулгүй байдлын стратеги
- Кибер аюулгүй байдлын агентлаг
- Кибер аюулгүй байдлын хэмжигдэхүүн (Cybersecurity metrics)

***Чадавх бэхжүүлэх***

- Олон нийтийг мэдээллээр хангах
- Кибер аюулгүй байдлын мэргэжилтнийг гэрчилгээжүүлэх, магадлан итгэмжлэх тогтолцоо
- Кибер аюулгүй байдлын талаар мэргэжилтэн бэлтгэх
- Кибер аюулгүй байдлын боловсролын тухай мэргэжлийн багшийн сургалт
- Кибер аюулгүй байдлын эрдэм шинжилгээ, судалгааны хөтөлбөр (цахим дэд бүтцийг хамгаалах хөтөлбөр)
- Урамшууллын механизм

***Хамтын ажиллагаа***

- Хоёр тал хүлээн зөвшөөрсөн байх;
- Олон тал хүлээн зөвшөөрсөн байх;
- Олон улсын оролцогч талуудтай байх;
- Олон нийтийн болон хувийн хэвшлийн оролцогч талуудтай байх;
- Хамтрагч агентлагуудтай байх;
- Сайн туршлага, үйл ажиллагаатай байх.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

[425] https://www.secureworldexpo.com/industry-news/countries-dedicated-to-cybersecurity

Олон улсын харилцаа холбооны байгууллагаас дээрх 5 чиглэлээр шалгуур үзүүлэлтүүдийг үнэлж, индексийг тодорхойлсноор тухайн улс кибер халдлагаас урьдчилан сэргийлэх чадамжтай эсэхийг тодорхойлох ба бодлогын түвшинд дээрх шалгууруудыг тогтоохыг зөвлөмж болгодог байна.

## 2.4 ОЛОН УЛСЫН КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОДЛОГО

Сүүлийн жилүүдэд кибер аюулгүй байдлыг хангах бодлого, эрх зүйн орчныг бүрдүүлэхээр дэлхийн бүх засгийн газрууд хичээн ажиллаж байна. Жил бүр кибер гэмт хэрэг дэлхийн эдийн засгаас хэдэн зуун тэрбум долларыг залилж, бизнесийн үйл ажиллагааг тасалдуулж, инновацийг саатуулж, ажлын байрны өсөлтийг царцааж байна.[426]

*BSA |Олон Улсын Програм хангамжийн холбоо* (www.bsa.org) нь дэлхийн засгийн газрууд болон олон улсын зах зээл дээрх програм хангамжийн компаниудыг нэгтгэсэн олон улсын байгууллага юм. Уг байгууллага нь АНУ-ын Вашингтон хотод төвтэй бөгөөд дэлхийн 60 гаруй оронд үйл ажиллагаа явуулдаг. BSA нь хууль ёсны програм хангамжийг сурталчлах, технологийн шинэчлэлийг дэмжих төрийн бодлогыг сурталчлах, олон улсын кибер аюулгүй байдлын бодлогын хүрээнд цахим аюулгүй байдлын цогц шийдлүүдийг санал болгох үндсэн зорилготой.

BSA-ийн гаргасан Бодлогын хүрээ (Policy framework)-нд засгийн газраас кибер аюулгүй байдлын бодлого хэрэгжүүлэхдээ дараах үндсэн 6 зарчмыг баримтлахыг зөвлөж байна.

- Бодлогыг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн техникийн стандартад нийцүүлэх;
- Бодлого нь эрсдэлд суурилсан, үр дүнд чиглэсэн, төвийг сахисан технологитой байх;
- Бодлого нь зах зээлийн механизмд суурилсан байх;
- Бодлого нь инновацийг дэмжих уян хатан, дасан зохицох чадвартай байх;
- Төр, хувийн хэвшил хосолсон хамтын ажиллагаанд суурилах;
- Бодлого нь хувийн нууцыг хамгаалахад чиглэсэн байх.

**Үндэсний кибер аюулгүй байдлын үндсэн элементүүд (BSA):**

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ

- Кибер аюулгүй байдлын асуудал эрхэлсэн үндэсний байгууллагатай байх;
- Оролцогч талуудын үүрэг, хариуцлагыг тодорхой болгох;
- Байгууллага хоорондын уялдааг бий болгох;
- Үндэсний кибер аюулгүй байдлын стратеги боловсруулах;
- Кибер аюулгүй байдлын дэд бүтцийг бий болгох;
- Үндэсний кибер аюулгүй байдлын төлөвлөгөө, дэд бүтцийг байнга шинэчлэх;
- Салбарын нарийн төлөвлөгөө гаргах;
- Төр болон хувийн хэвшлийн хамтын ажиллагаа оролцоог дэмжсэн бүтэц бий болгох;
- Засгийн газар болон холбогдох байгууллагуудын хамтын ажиллагааны механизмыг бий болгох.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[426] BSA International Cybersecurity Policy Framwork 2018

КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ЗАСГИЙН ГАЗАР

- Үндэсний кибер аюулгүй байдлын яаралтай хариу арга хэмжээний баг бий болгох;
- Цаг тухайд мэдээлэл солилцох, түүнийг дэмжих;
- Халдлагын талаарх мэдээллийн дэд бүтэц бий болгох;
- Хувийн мэдээлэлд халдахад мэдэгдэх стандартыг тогтоох;
- Засгийн газрын үйл ажиллагаа ил тод, сул талуудаа засдаг байх.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХАНГАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

- Техник төхөөрөмж худалдан авахдаа төвийг сахих;
- Лицензтэй Програм хангамж ашиглах;
- Програм хангамжийг борлуулагчаар баталгаажуулсан эсэхийг шалгах;
- Үүлэн үйлчилгээний (Cloud service) аюулгүй байдлын давуу талыг ашиглах;
- Техник, төхөөрөмж худалдан авахдаа аюулгүй байдлыг хангах, шалгах;
- Мэдээллийн технологийн системийг ухаалаг, аюулгүй байдлаар удирдах.

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГАА

- Кибер аюулгүй байдлын технологи, төхөөрөмж хэрэгслийн судалгаа, хөгжүүлэлтийг дэмжих.

КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ХУВИЙН ХЭВШИЛ

- Кибер аюулгүй байдлын үр дүнд төвлөрөх;
- Эрсдэлд суурилсан, уян хатан бодлоготой байх;
- Дотоодын стандартаас гадна кибер аюулгүй байдлын дэд бүтцийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарттай уялдуулах;
- Тэнцвэртэй, ил тод, олон улсын туршлагад суурилсан байх;
- Эх код, бусад оюуны өмчийг нууцлах;
- Бүтээгдэхүүн сонгохдоо зах зээлд суурилсан шийдлүүдийг ашиглах;
- Олон улсын дата ашиглах.
- Шинээр гарч ирж буй технологийг идэвхжүүлэх бодлогын орчинтой байх

КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ИРГЭН

- Кибер аюулгүй байдлын талаар олон нийтэд сурталчлах;
- Хэрэглэгчийн сонголтыг бүртгэх, мэдээлэх хэрэгсэл бий болгох;
- Боловсролын бүх түвшинд цахим аюулгүй байдлын мэдлэгийг суулгах;
- Кибер аюулгүй байдлын талаар боловсрол олгох сургалт зохион байгуулах;
- Кибер аюулгүй байдлын мэргэжилтнүүдийг олон талаар дэмжих.

КИБЕР ГЭМТ ХЭРЭГ

- Кибер гэмт хэрэгтэй тэмцэх тухай Будапештийн конвенцод нийцсэн цогц хууль эрх зүйн орчныг бий болгох;
- Зөвхөн кибер халдлагад чиглэсэн тусгайлсан хууль эрх зүйн зохицуулалттай байх;
- Хууль сахиулах, хэрэгжүүлэгч байгууллагуудад техникийн сургалт, дэмжлэг үзүүлэх.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

ОЛОН УЛСЫН ОРОЛЦОО

1. Кибер аюулгүй байдлын хамтын ажиллагааны гадаад бодлогод нэгдэх;
2. Олон улсын хамтын ажиллагаанд хамрагдах;

3. Экспортын хяналтын бодлогыг кибер аюулгүй байдлын хууль ёсны үйл ажиллагаанаас тусад нь авч үзэх;
4. Өөрийн орны нутаг дэвсгэрийг олон улсын кибер халдлагад ашиглахаас урьдчилан сэргийлэх;
5. Хувийн мэдээллийг хамгаалах, хүний эрхийг хамгаалах.

## 2.5 ЦАХИМ ОРЧИН ДАХЬ ХҮНИЙ ЭРХИЙН ТҮГЭЭМЭЛ ТУНХАГЛАЛ

1948 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг баталсан. Тэгвэл өнөөдөр улам бүр даяаршиж байгаа цахим ертөнцөд тэдгээрийн харилцааг зохицуулах, тунхаглах шаардлага тулгарсан. Энэхүү тунхаглалын цахим орчин дахь хувилбар(төсөл)[427]-ыг Роберт Б.Геман хэмээх судлаач боловсруулжээ.

1. Хүн бүр хүний өөрийн санаа бодол, илэрхийллийг шууд ба шууд бусаар илэрхийлэх, түгээх, бусадтай хуваалцах зохих ёсны, тэгш боломжоор хангагдсан байна.
2. Хүн бүр энэхүү тунхаглалд заасан бүх эрх, эрх чөлөөг үндэс угсаа, арьсны өнгө, хүйс, хэл соёл, шашин шүтлэг, үзэл бодол, нийгмийн гарал үүсэл, хөрөнгө чинээ, нийгмийн байдал зэрэг дурын ялгаваргүйгээр тэгш эдэлнэ.
3. Хүн бүр өөрийн хувийн цахим орон зай, нэртэй байж нэр, онлайн хэлцлээ нууцлан хамгаалах эрхтэй.
4. Интернэтийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага, вэб сайтаас хүний хувийн мэдээллийг албадан гаргаж өгөхийг шаардаж болохгүй. Шаардлагатай үед зохих зөвшөөрлийн үндсэн дээр мэдээллийг гаргаж өгч болно.
5. Хэн ч урьдчилсан зөвшөөрөл авалгүйгээр сайн дураар нийтэд хандсан их хэмжээний цахим шуудан, сервер компьютерт ачаалал үүсгэх хавсралт файл, хөнөөлт Програм хангамжуудыг илгээх эрхгүй.
6. Хүн бүр интернэтээс мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Гагцхүү энэхүү эрхээ эдлэхдээ тухайн харилцаанд тогтоосон зан үйлийн хэм хэмжээг даган мөрдөнө.
7. Цахим ба бодит орон зайд цөөнхийн болон хэрэглэгчийг тусгайлан хамгаална. Газарзүйн харьяаллын гэрээ ёсоор ял оногдуулах тохиолдолд оршин байгаа газрын эрх зүйн тогтолцоооос үл хамааран хувь хүний суурь эрхийг хүндэтгэнэ.
8. Хүн бүр өөрийнх нь эрх, эрх чөлөө зөрчигдөх, хувийн мэдээллээ хортойгоор ашиглуулахын эсрэг хууль зүйн хамгаалалтад байх эрхтэй.
9. Агуулга, онлайн харилцаатай холбогдуулан хэнийг ч дур зоргоор хянаж, шалгахыг хориглоно.
10. Хүн бүр эрх, үүргээ тодорхойлуулах, түүний эсрэг ял тулгасан тохиолдолд ялын үндэслэлийг тогтоолгохоор хараат бус, шударга шүүхээр хууль ёсны, нээлттэй дэгээр шүүлгэх бүрэн эрхтэй.
11. Хүн бүр төрийн байгууллага, интернэтийн үйлчилгээ үзүүлэгчээр дамжуулан хуулиар тусгайлан нууцалснаас бусад мэдээлэлд хандах эрхтэй.
12. Хүн бүр өөрийн харилцаа холбоо, хэлцлээ хамгаалах технологийг сонгох эрхтэй ба энэ эрхийг хэрэгжүүлэхэд нь технологид харшлахыг хориглоно.
13. Хүн бүр өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй. Энэхүү эрх нь итгэл үнэмшил, сүсэг бишрэлээ төрөл бүрийн зан үйлээр илэрхийлэх эрхийг мөн агуулна.

[427] Цахим орчин дахь Хүний эрхийн түгээмэл тунхаглал, http://www.be-in.com/10/rightsdec.html

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Хэний ч үзэл бодлоо илэрхийлсэн зан үйлийн хэлбэрт нь ял, зэмлэл хүлээлгэхийг хориглоно.

14. Хүн бүр интернэтийн үйлчилгээ үзүүлэгчийг чөлөөтэй сонгох, түүнийгээ солих эрхтэй. Мөн үйлчилгээний төлбөртэй холбоотойгоор байрлал үл харгалзан “үнэгүй”, “нийтийн” үйлчилгээг сонгох эрхтэй.
15. Хэний ч хандалтын эрх буюу цахим шуудангийн бүртгэлийг үйлчилгээний гэнэтийн өөрчлөлт зэрэг зохисгүй шалтгаан, дур зоргоор хаах, устгахыг хориглоно.
16. Хүн бүр өөртэйгөө онлайнаар холбогдох этгээдээ чөлөөтэй сонгох эрхтэй. Хэнийг ч тодорхой бүлэгт хамруулах, вэб сайтад зочлуулахаар албадахыг хориглоно.
17. Хэн бүхний хувийн мэдээлэл, онлайн үйл ажиллагаа нь хувийн өмч бөгөөд түүнийг тухайн этгээд өөрөө хянана. Хүн бүр энэхүү өмчөө үнэлэх, ил тод болгох, бусадтай солилцох эсэхээ өөрөө шийдэх эрхтэй.
18. Хүн бүр ашиг сонирхол, үнэт зүйл, чиг үүргийн бүлгийг үүсгэх эрхтэй.
19. Хүн бүр шинэ технологийг эзэмших эрхтэй. Төрийн байгууллагаас бүх нийтэд хэрэглээний програм хангамжууд ба онлайн харилцааны сургалтуудыг явуулах үүрэгтэй. Амьдралын хүнд нөхцөлд байгаа хүмүүс, өндөр настангууд болон хэрэгцээт хүмүүст зориулсан сургалт тусгай хөтөлбөрүүдийг авч үзнэ. Сургалт нь хувь хүнд чиглэсэн, тэдний өөрийгөө хүндлэх хүндлэлийг бэхжүүлж, бие даасан байдлыг дэмжихэд чиглэнэ.
20. Эцэг, эхчүүд өөрийн үзэл бодлоор үр хүүхдийнхээ онлайн харилцааг удирдан чиглүүлэх эрх, үүрэгтэй. Энэ асуудлаар ямар ч байгууллага эцэг, эхийн сонголтыг үгүйсгэх эрхгүй.
21. Хүн бүр зохиогчийн эрхээр хамгаалагдах утга зохиол, урлагийн болон шинжлэх ухааны бүтээлээ бусадтай онлайнаар хуваалцах эрхтэй.
22. Хүн бүр энэхүү тунхаглалд заасан эрх, үүргийг хэрэгжүүлэн хувьдаа ашиг, орлоготой болох эрхтэй.
23. Хүн бүр өөрийн зан үйл, илэрхийллээ хариуцах, өөрийн байр суурьтай байх эрхтэй.
24. Энэхүү тунхаглалын зарчмуудыг аль нэг улс орон, бүлэглэл, бие хүний зүгээс энд тунхагласан эрх, эрх чөлөөг үгүйсгэхэд чиглэсэн аливаа үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх, агуулгыг мушгин өөрчлөх, өөрчлөн хэрэглэхийг хориглоно.

## БҮЛЭГ III. МОНГОЛ УЛСЫН КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН

### 3.1 МОНГОЛ УЛС ДАХЬ КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Монгол Улсын төр, засгаас харилцаа холбооны салбарыг хөгжүүлэх нь улс орны аюулгүй байдлыг хангахад чухал ач холбогдолтой гэдгийг онцгойлон анхаарч 1922 оноос эхлэн Дотоодыг хамгаалах газрын бүтцэд Шуудан, телефон, радио, щифр холбооны нэгжийг байгуулж ирсэн нь Мэдээллийн аюулгүй байдлын алба үүсэх эх суурь болсон. Техник технологи хурдтай хөгжиж буй өнөөгийн нийгэмд мэдээллийн аюулгүй байдлын асуудал хурцаар тавигдаж байна.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Тагнуулын байгууллагын тухай хуулийн 11.1.6, Харилцаа холбооны тухай хуулийн 20.3-т төрийн байгууллагуудыг кибер халдлагаас хамгаалах тогтолцоог бүрдүүлэхийг заасан бөгөөд энэ чиг үүргийг Мэдээллийн аюулгүй байдлын газар хэрэгжүүлэн ажиллаж байна.[428]

UIH.MN ТӨМӨЛӨГӨӨНЫ САН

[428] http://isd.gov.mn/

Тус байгууллага нь төрийн мэдээлэл, харилцаа холбооны аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хүрээнд:

1. Төрийн болон онц чухал мэдээллийн сүлжээ, харилцаа холбооны аюулгүй байдлыг хангах, цахим аюул, заналтай тэмцэх;
2. Кибер аюулгүй байдлын талаар баримтлах бодлогын баримт бичгийг боловсруулах;
3. Төрийн байгууллагуудад кибер аюулгүй байдал, мэдээллийн аюулгүй байдалтай холбоотой эрсдлийн үнэлгээ хийх;
4. Кибер аюулгүй байдлын талаар сургалт сурталчилгаа зохион байгуулах;
5. Төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын хэрэгцээнд ашиглагдах тусгай хэрэглээний шуудангийн үйлчилгээ үзүүлэх;
6. Төрийн болон төрийн захиргааны байгууллагуудын хооронд төрийн нууц мэдээ, мэдээлэл дамжуулах, солилцох үеийн нууцлал аюулгүй байдлыг хангах гэсэн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.

## 3.2 МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын Үзэл Баримтлалд мэдээллийн аюулгүй байдлын талаар баримтлах бодлогыг дараах байдлаар тодорхойлсон байдаг.

**Мэдээллийн аюулгүй байдал**

Мэдээллийн салбарт үндэсний ашиг сонирхлыг хамгаалах, төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг баталгаажуулах нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэс мөн.

3.6.1.Мэдээллийн салбарт үндэсний ашиг сонирхлыг хамгаалах

3.6.1.1.Үндэсний аюулгүй байдлыг хангах, улс орны хөгжлийг дэмжих, үндэсний үнэт зүйлийг хэвшүүлэх, нийгмийн оюун санааг төлөвшүүлэхэд мэдээлэл, мэдээллийн аюулгүй байдал нэн чухал ач холбогдолтой.

3.6.1.2.Нийгмийн сэтгэл зүй, тогтвортой байдал, хувь хүний ухамсар, ёс зүйд хөндлөнгөөс нөлөөлөх оролдлогыг хязгаарлана. Дайсагнал, ялгаварлан гадуурхах үзэл, үзэн ядалтыг сурталчилсан, дэмжсэн сурталчилгаа, мэдээллийг таслан зогсоох, саармагжуулах чадавхыг бий болгож, үл зөвшөөрөх сэтгэхүйг нийгэмд төлөвшүүлнэ.

3.6.1.3.Үндэсний мэдээллийн дэд бүтцэд халдах аюулаас хамгаалах, эдийн засаг, нийгмийн чадавхыг сулруулах оролдлоготой тэмцэх чадавхыг бий болгоно.

3.6.1.4.Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалттай хэвлэл мэдээллийн хэрэгсэл үндэсний аюулгүй байдалд харшилсан үйл ажиллагаа явуулбал үйл ажиллагаа явуулах эрхийг нь хязгаарлаж болно. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшил, харьяалал нь ил тод байх бөгөөд үйл ажиллагаа нь бодитой, тэнцвэртэй, хариуцлагатай байна. Мэдээллийн хэрэгслээр үндэсний үнэт зүйлийг түлхүү нийтлэх, сурталчлахыг дэмжиж, гадны шашин, соёл, төрийн бодлогыг сурталчилсан агуулгатай мэдээллийг зохистой түвшинд хязгаарлана.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

3.6.1.5.Мэдээллийн аюулгүй байдлын үндэсний хэмжээний бодлого, эрх зүйн зохицуулалт, стандарт, удирдлага, зохион байгуулалт, сургалтын тогтолцоог бий болгож нийгэм дэх ойлголт, мэдлэгийг төлөвшүүлнэ.

3.6.1.7.Төр, хувийн хэвшлийн байгууллагад мэдээллийн аюулгүй байдлын бодлого, дэг, эрсдэлийн удирдлага, дотоод аудит, үнэлгээний чадавхыг бий болгоно.

3.6.1.8.Мэдээллийн аюулгүй байдлын орчин үеийн дэвшилтэт, өртөг багатай шийдлийг зөвхөн эрсдэлийн үнэлгээний үндсэн дээр сонгон ашиглана. Төрийн байгууллага, онц чухал дэд бүтцийн объектын мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг өндөр түвшинд бэлтгэгдэж, итгэмжлэгдсэн үндэсний мэргэжилтнээр гүйцэтгүүлнэ.

3.6.1.9.Өрсөлдөх чадвартай мэдээлэл, харилцаа холбооны систем, техник хэрэгсэл, програм хангамжийн үндэсний үйлдвэрлэл болон мэдээллийн аюулгүй байдлын шийдэл боловсруулах ажиллагааг дэмжин хөгжүүлж технологийн хараат байдлыг бууруулна.

3.6.1.10.Мэдээлэл, харилцаа холбооны технологи, мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр үндэсний суурь болон хавсарга судалгаа, шинжилгээ, сургалтыг онцгойлон дэмжинэ.

3.6.1.11.Кибер орчин дахь гэмт явдалтай тэмцэх, аливаа гэмт хэргийг илрүүлэх, нотлоход тооцоолох хэрэгслийн криминалистик техникийн шинжилгээ ашиглах үндэсний чадавхыг бий болгоно.

3.6.1.12.Мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэдээллийн орчинд сөргөлдөх аюулаас сэргийлэх, кибер орчин дахь гэмт явдалтай тэмцэх чиглэлд олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлнэ.

**3.3 ТАГНУУЛЫН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬ**

**11 дүгээр зүйл.Тагнуулын ерөнхий газрын үүрэг**

11.1.Тагнуулын ерөнхий газар дараах үүрэг гүйцэтгэнэ:

11.1.6.Төрийн болон онц чухал мэдээллийн сүлжээ, харилцаа холбооны аюулгүй байдлыг хангах, цахим аюул, заналтай тэмцэх; */Энэ заалтад 2011 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт, 2015 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./*

**3.4 ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТУХАЙ ХУУЛЬ**

**20 дугаар зүйл.Тусгай хэрэглээний холбооны сүлжээ**

20.1.Монгол Улсын батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах, гамшгаас хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах, төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын хэрэгцээнд зориулан тусгай хэрэглээний холбооны сүлжээг байгуулан ажиллуулж болно. */Энэ хэсэгт 2019 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./*

20.2.Тусгай хэрэглээний холбооны сүлжээ төрийн хамгаалалтад байна.

20.3.Тусгай хэрэглээний холбооны сүлжээ байгуулах, ашиглах журмыг Засгийн газар тогтооно.

20.4.Тусгай хэрэглээний холбооны сүлжээнд цахилгаан холбооны суваг, тоног төхөөрөмжийг үйлчлэгчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ашиглана.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

20.5.Харилцаа холбооны сүлжээгээр дамжуулах тусгай хэрэглээний холбооны мэдээллийн нууцлалт, хамгаалалтыг энэ хуулийн 20.1-д заасан байгууллага хариуцна.

## БҮЛЭГ IV. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

### 4.1 АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС

***I. Цахим орчин дахь гэмт хэргийн нөхцөл байдал***

АНУ-д цахим гэмт хэрэгтэй тэмцэх ажил 1980-аад оноос эхэлсэн бөгөөд түүнд тавих хяналт, цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх алхмууд, цахим орчныг зохицуулах эрх зүйн зохицуулалтууд нь гэмт хэргийн гаралт, төрлөөс хамааран боловсронгуй болсоор байна. 2020 оны байдлаар Интернэт гэмт хэргийн талаар гомдол хүлээн авах төвд бүртгэгдсэн цахим гэмт хэргийн төрөлд хувь хүний кредит картны дугаар, картны нууц дугаарыг мэхлэн авах (phishing) болон үүнтэй ижил төрлийн залилангийн хэргүүд хамгийн их бүртгэгдсэн байна.[429] Цахим аюулгүй байдлыг хангах, ард иргэд, улс орны аюулгүй байдлыг хамгаалах, цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, цахим гэмт хэрэгтэй тэмцэх асуудлыг Холбооны Засгийн газрын харьяа агентлагууд, хувийн хэвшил болон олон нийтийн байгууллагууд нэгдэн, хамтран хэрэгжүүлж байна.

***II. Цахим орчин дахь гэмт хэргийн стратеги төлөвлөгөө***

Цахим орчин нь ард иргэдийн өдөр тутмын амьдралд төдийгүй эдийн засаг, батлан хамгаалах зэрэг улс орны амин чухал салбаруудын аюулгүй байдалтай салшгүй холбоотой. Техник технологийн дэвшлийг дагаад цахим халдлага, гэмт хэрэг улам нарийсч, давтамж нь нэмэгдсээр байгаа тул үүнтэй тэмцэх зорилгоор бодлогын баримт бичгүүдийг боловсруулан хэрэгжүүлж байна.

- 2018 онд Ерөнхийлөгч Доналд Трамп **“Үндэсний цахим стратеги”** (National Cyber Strategy)-ийг шинэчлэн баталсан.[430] Стратеги нь дөрвөн үндсэн хэсгээс бүрдэж байна.

**Нэгдүгээр хэсэг:** Эх орон, ард түмэн, Америк амьдралын хэв маягийг хамгаалах (Америкчуудын амар тайван амьдралыг хамгаалах)

- Холбооны засгийн газрын сүлжээ ба мэдээллийн аюулгүй байдлыг хангах;
- Улс орны чухал дэд бүтцүүдийн аюулгүй байдлыг хангах;
- Цахим гэмт хэрэгтэй тэмцэн, гэмт хэргийг мэдээлэх ажлыг сайжруулах;
- (Цахим тандалт, компьютерээр үйлдэгдэж буй гэмт хэргийн талаарх хуулийг шинэчлэх).

**Хоёрдугаар хэсэг:** Америкийн хөгжил цэцэглэлтийг дэмжих

- Хурдтай, хүчтэй, уян хатан, дижитал эдийн засгийг хөгжүүлэх;
- АНУ-ын иргэдийн авьяас чадвар, шинэлэг санааг дэмжин хөгжүүлэх, хамгаалах;
- Цахим аюулгүй байдлыг хамгаалах шилдэг ажиллах хүчнийг бий болгох.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[429] https://www.statista.com/statistics/184083/commonly-reported-types-of-cyber-crime/
[430] https://trumpwhitehouse.archives.gov/wp-content/uploads/2018/09/National-Cyber-Strategy.pdf

**Гуравдугаар хэсэг:** Өөрсдийн хүч чадлаар амар амгалан байдлаа хадгалах

- Хариуцлагатай төрийн ажил хэргээр дамжуулан цахим орчны тогтвортой байдлыг бэхжүүлэх;
- Цахим орчин дахь хүлээн зөвшөөрөгдөхгүй үйлдлийг илрүүлэх, таслан зогсоох.

**Дөрөвдүгээр хэсэг:** АНУ-ын нөлөөг нэмэгдүүлэх

- Нээлттэй, харилцан ашиглах боломжтой, найдвартай, аюулгүй интернэтийг дэмжих;
- Олон улсын кибер чадавхыг бий болгох зэрэг ажлуудыг төлөвлөн, хэрэгжүүлж эхлээд байна.

- 2021 оны Гуравдугаар сард Ерөнхийлөгч Жое Байден **“Богино хугацааны Үндэсний Аюулгүй байдлын Стратегийн Удирдамж”** (Interim National Security Strategic Guidance)-ийг батлан гаргасан байна.[431] Америк улс нь дэлхийн тэргүүлэх гүрний хувьд өөрийн улс үндэстний аюулгүй байдлыг сахин хамгаалахын зэрэгцээ дэлхий дахины аюулгүй байдлыг сахин хамгаалахад баримтлах бодлогыг тус удирдамжид тодорхойлсон байна. Үүнээс цахим аюулгүй байдлаа хамгаалахад шаардагдах дараах ажлуудыг үндэсний хэмжээнд хийхээр төлөвлөсөн байна: Үүнд,

  Шинжлэх ухаан, технологийн баазаа бэхжүүлснээр цахим аюулгүй байдлыг нэн тэргүүний зорилт болгож, цахим орон зайд өөрсдийн чадвар, бэлэн байдал, уян хатан байдлаа бэхжүүлнэ. Цахим аюулгүй байдлыг засгийн газрын бүхий л түвшинд чухлаар авч үзнэ. Нийт Америкчуудад аюулгүй, найдвартай онлайн орчныг бүрдүүлэх, эрсдэлийг даван гарах, хуваалцах үүднээс хувийн хэвшил, засгийн газрын бүх түвшний хамтын ажиллагааг дэмжин ажиллана. Улс орноо кибер халдлагаас үр дүнтэй хамгаалахын тулд дэд бүтцэд оруулсан хөрөнгө оруулалтаа өргөжүүлнэ. Гарал үүсэл харгалзахгүй бүх Америкчуудад боломж олгож, цахим ертөнц дэх авьяаслаг хүний нөөцийг бүрдүүлэх зэрэг ажлуудыг хийхээр төлөвлөсөн байна.
- 2021 оны Тавдугаар сард Ерөнхийлөгч Жое Байден дээрх удирдамж дээр үндэслэн **“Үндэсний Цахим Аюулгүй байдлыг сайжруулах тухай”** (Executive Order on Improving the Nation’s Cybersecurity) зарлигийг батлан гаргасан байна.[432] Тус зарлиг нь дээрх бодлогын баримт бичгүүд дээр үндэслэсэн бөгөөд цахим гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдалд үндэслэн яаралтай хэрэгжүүлэх үйл ажиллагааг 10 багц ажлын хүрээнд төлөвлөсөн байна. Төрийн болон хувийн байгууллагууд руу чиглэсэн цахим халдлагууд, түүнээс сэргийлэх, хамгаалахад шаардагдах нөөц бололцоо, хүчин чармайлтыг нэмэгдүүлэх шаардлагатай байгааг онцолжээ. Үндэсний Стандарт Технологийн Хүрээлэн (National Institute of Standards and Technology) болон Кибер аюулгүй байдлын хамрах хүрээний таван чиг үүргийг тодотгон, Холбооны Засгийн газрын харьяа агентлагууд кибер гэмт хэрэгтнүүд, кибер хорлон сүйтгэх ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, хариу арга хэмжээ авах зэрэгт хүчин

[431] https://www.whitehouse.gov/wp-content/uploads/2021/03/NSC-1v2.pdf
[432] https://www.whitehouse.gov/briefing-room/presidential-actions/2021/05/12/executive-order-on-improving-the-nations-cybersecurity/

чармайлтаа нэмэгдүүлэн, нэгдэн ажиллах шаардлагатай байгааг илэрхийлсэн байна. Зарлигт тодотгосноор, Холбооны бүх мэдээллийн систем нь кибер аюулгүй байдлын тодорхой шаардлагуудыг хангасан байх шаардлагатай гэжээ.

***III. Цахим гэмт хэрэгтэй тэмцэх байгууллагууд***

Цахим гэмт хэрэг нь дан ганц байгууллагын хариуцан хэрэгжүүлэх ажил биш бөгөөд Холбооны Засгийн газрын харьяа агентлагууд, хувийн байгууллагууд болон ашгийн бус олон нийтийн байгууллагууд, түүнчлэн олон улсын байгууллагуудын хамтын хүчин чармайлт шаарддаг байна.

**Холбооны Засгийн газрын харьяа агентлагууд**

- Батлан Хамгаалах Яам (Department of Defense)-ны харьяа Үндэсний Аюулгүй байдлын Агентлаг (National Security Agency) нь АНУ-ын харилцаа холбооны сүлжээ, мэдээллийн системийг хамгаалах, гадны улс орнуудаас ирэх цахим халдлагыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажилладаг.
- Дотоодыг Аюулаас хамгаалах Яам (Department of Homeland Security)-ны харьяа Цахим Аюулгүй байдал, Дэд бүтцийн Аюулгүй байдлын Агентлаг (Cybersecurity and Infrastructure Security Agency) нь 2018 онд байгуулагдсан бөгөөд засгийн газрын бүх түвшинд цахим аюулгүй байдлыг ханган, улс орон даяар цахим аюулгүй байдлын хөтөлбөрийг хэрэгжүүлж, холбооны цахим сүлжээ, цахилгаан станц, далан гэх мэт улс орны чухал дэд бүтцүүдийн аюулгүй, тогтвортой байдлыг хանган ажилладаг.
- Дотоодыг Аюулаас хамгаалах Яамны харьяа АНУ-ын Тагнуулын газар (US Secret Service) нь дотоодын болон олон улсын кибер гэмт хэрэгтнүүдийг илрүүлэх чиг үүрэг бүхий Цахим гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэстэй байна. Кибер тагнуулын хэлтэс нь үндэстэн дамнасан кибер гэмт хэрэгтнүүдийг баривчлахад онцгой үүрэгтэй ажилладаг байна. Үүний сацуу Тагнуулын газар нь хууль сахиулах ажилтнууд, прокурор, шүүгч нарт кибер гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор кибер сургалт явуулж, мэдээлэл өгдөг байна.
- Хууль зүйн яам (Department of Justice)-ны харьяа агентлаг Холбооны Мөрдөх Товчоо (Federal Bureau of Investigation) нь чиг үүргээрээ мөн цахим гэмт хэрэгтэй тэмцдэг. Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлын хүрээнд шинээр бүтээгдсэн орчин үеийн дэвшилтэт техник болон аналитик хэрэгслүүдийг үйл ажиллагаандаа ашигладаг байна.
    - Холбооны Мөрдөх Товчоо нь өөрийн 56 салбартаа тусгайлан бэлтгэсэн цахим гэмт хэрэгтэй тэмцэх тасгийг ажиллуулдаг байна. Тухайн тасаг нь үүргээ гүйцэтгэхдээ бусад агентлагийн алба, тасгуудтай хамтран ажиллана.
    - Томоохон гэмт хэргийг илрүүлэн, яаралтай хариу арга хэмжээ авах шаардлагатай тохиолдолд хэдхэн цагийн дотор улс орон даяар Кибер ажиллагааны шуурхай багийг бүрдүүлэн ажиллуулна.
    - Дэлхийн улс орнууд дахь АНУ-ын Элчин сайдын яамдад тухайн улсын болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах кибер гэмт хэрэгтэй тэмцэх төлөөлөгчийг томилон ажиллуулдаг.
    - Интернэт гэмт хэргийн талаар гомдол хүлээн авах төв (Internet Crime Complaint Center) нь олон нийтээс интернэт гэмт хэргийн талаарх гомдлыг

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

хүлээн авдаг. Гомдлыг хүлээн авснаар тус төвийн Иргэдийн хөрөнгийг буцаан авах, эргэн төлүүлэх баг нь кибер гэмт хэргийн хохирогчдод хэдэн зуун мянган долларыг эргүүлэн авахад тусалдаг байна.

- 7 хоногийн 24 цагаар тасралтгүй ажилладаг Кибер Хяналт (CyWatch)-ын төв нь улс орон даяар үйл ажиллагаа явуулж буй бусад салбаруудтай холбогдон, гарсан гэмт хэргийн талаар мэдээлэл өгөн, хяналт тавьж ажилладаг.
- Холбооны Мөрдөх Товчоо нь кибер гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаанд АНУ-ын Засгийн газрын туршлагатай мэргэжилтэн, шинжээчдээс бүрдсэн Үндэсний Батлан хамгаалах цахим холбоо (National Defence Cyber Alliance) болон хууль хэрэгжүүлэгчид, хувийн хэвшлийн төлөөллүүд, эрдэм шинжилгээний байгууллагуудаас бүрдсэн Үндэсний Кибер гэмт хэргийг илрүүлэх Сургалтын Холбоо (National Cyber Forensics and Training Alliance)-той хамтран ажилладаг байна.
- АНУ-ын засгийн газрын бусад агентлагууд болох тагнуул болон хууль хэрэгжүүлэгч 30 орчим агентлагаас бүрдсэн Үндэсний Кибер эрэн сурвалжлах хамтарсан баг (National Cyber Investigative Joint Task Force) 2008 онд байгуулагдан, үйл ажиллагаа явуулж буй бөгөөд Холбооны Мөрдөх товчоо тэргүүлдэг байна.

- Хууль зүйн яамны Хүүхдийг садар самуун, бэлгийн мөлжлөгөөс хамгаалах алба (Child Exploitation and Obscenity Section) нь 1987 онд байгуулагдсан бөгөөд садар самууныг сурталчлахаас урьдчилан сэргийлэх, энэ төрлийн гэмт хэргээс хүүхдийг хамгаалах үндсэн чиг үүрэгтэй бөгөөд 2002 онд Дэвшилтэт технологи ашиглан мөрдөн шалгах нэгж (High Technology Investigative Unit)-ийг дотооддоо байгуулан, орон даяар үйл ажиллагаа явуулдаг 94 салбар нэгжээр дамжуулан, цахимаар үйлдэгдэх энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлж, илрүүлж ажиллах болсон байна. Тус алба нь 2006 оноос Аюулгүй хүүхэд нас хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлжээ.[433]
- Үндэсний Стандарт Технологийн Хүрээлэн нь кибер аюулгүй байдлыг хамгаалахад баримтлах стандартыг боловсруулан, мөрдүүлж ажилладаг байна.

***IV. Хууль эрх зүйн орчин***

Тус улсад цахим гэмт хэргийг зохицуулсан бие даасан хууль байхгүй бөгөөд холбооны хууль болон мужийн хуулиудаар зохицуулж байна. Компьютерт хууль бусаар нэвтрэхийг хориглох тухай хууль (Computer Fraud and Abuse Act), Холбооны Мэдээллийн Аюулгүй байдлын Менежментийн тухай хууль (Federal Information Security Management Act), Цахим Харилцаа холбооны Нууцлалын тухай хууль (Electronic Communications Privacy Act), Цахим Аюулгүй байдлын мэдээлэл солилцох тухай хууль (Cybersecurity Information Sharing Act) болон холбогдох бусад хууль тогтоомжоор цахим орчин дахь харилцааг зохицуулж байна.

**Компютерт хууль бусаар нэвтрэхийг хориглох тухай хууль**[434]

Энэ хуулиар холбооны засгийн газар, банк болон интернэтэд холбогдсон бүх компьютерт

[433] https://www.justice.gov/criminal-ceos
[434] https://www.congress.gov/bill/99th-congress/house-bill/4718

UIHMN СУДАЛГААНЫ САН

хууль бусаар, зөвшөөрөлгүй нэвтрэх, халдах (hacking)-тай холбоотой асуудлыг зохицуулна. Компьютерт хууль бусаар нэвтрэн аюул учруулах, хохироох, тагнан турших зэрэг гэмт хэргүүд, түүнд ногдох ял шийтгэлийг энэ хуулиар зохицуулсан байна.

**Холбооны Мэдээллийн Аюулгүй байдлын Менежментийн тухай хууль**[435]

Энэ хуулиар Холбооны Засгийн газрын харьяа агентлаг бүр өөрийн дотоод үйл ажиллагаагаа хэрхэн явуулах болон хамтран ажилладаг байгууллагуудтайгаа хэрхэн харьцах, мэдээлэл түүчлэн агентлагийн хөрөнгийг хэрхэн гадны халдлагаас хамгаалах зэрэг цахим аюулгүй байдлын стандартыг боловсруулан, мөрдөж ажиллахыг шаарддаг байна.

**Цахим Харилцаа холбооны Нууцлалын тухай хууль**[436]

Тус хуулиар цахимаар мэдээ мэдээлэл дамжуулах, компьютерт хадгалагдсан мэдээлэл болон интернэт хэрэглэгчдийн хувийн нууцыг хэрхэн хамгаалах зэрэг үйлчилгээ үзүүлэгч байгууллага болон хэрэглэгчийн хооронд үүсэх харилцаа, хүлээх үүрэг хариуцлагыг зохицуулсан байна.

**Цахим Аюулгүй байдлын мэдээлэл солилцох тухай хууль**[437]

Тус хуулиар улсын болон хувийн байгууллага, компаниуд АНУ дахь цахим аюулгүй байдлыг сайжруулах, өөрийн үйл ажиллагааг цахим халдлагаас хамгаалах, урьдчилан сэргийлэх үүднээс цахим аюул, халдлагын талаарх мэдээллийг засгийн газарт мэдээлэх, хуваалцах, харилцан хүлээх үүрэг хариуцлагын талаар хуульчилсан байна.

АНУ-д цахим гэмт хэргийн төрөл болох цахим хүчирхийлэл (cyber violence), ихэвчлэн энэ төрлийн гэмт хэргийн золиос болдог хүүхэд хамгааллын асуудал анхаарлын төвд байсаар байна. Цахим хүчирхийлэл, түүний хэлбэр болох хүүхдэд хор хөнөөлтэй материал үзүүлэх, хүүхдийг садар самуунд уруу татах, хулгайлах, бэлгийн мөлжлөгийн золиос болгох зэрэг гэмт хэргүүдээс хүүхэд, өсвөр үеийнхнийг хамгаалах, урьдчилан сэргийлэх нэлээдгүй хууль тогтоомжийг баталсан байна. Үүнд, Цахим ертөнцөд хүүхдийн нууцыг хамгаалах тухай хууль (Children’s Online Privacy Protection Act), Интернэт орчинд хүүхдийг хамгаалах тухай хууль (Children’s Internet Protection Act), Хүүхэд хамгаалал, аюулгүй байдлын тухай хууль (Child Protection and Safety Act), 21-р зуунд хүүхдийг хамгаалах тухай хууль (Protecting Children in the 21$^{st}$ Century Act), Домэйн нэр үнэн зөв байх тухай хууль (Truth in Domain Names Act), Цахим гэмт хэргийн мэдээллийн шинэчлэлийн тухай хууль (Cybertipline Modernization Act) болон холбогдох бусад хууль тогтоомжоор цахим ертөнц дэх хүүхдийн эрхийг хамгаалдаг байна.

**Цахим ертөнцөд хүүхдийн нууцыг хамгаалах тухай хууль**[438]

Тус хуулиар 13-аас доош насны хүүхэд цахим хуудсанд хандаж байгаа тохиолдолд эцэг, эхийнх нь зөвшөөрөлгүйгээр хувийн мэдээллийг нь авахгүй байх талаар хуульчилсан байна. Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах үүрэг бүхий Холбооны Худалдааны Комисс нь тус хуулийг хэрэгжүүлэх журмыг баталсан бөгөөд 2012 онд шинэчлэн баталж, хууль зөрчсөн компаниудад зохих арга хэмжээг ногдуулсаар ирсэн байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

435 https://www.congress.gov/bill/107th-congress/house-bill/3844
436 https://www.sciencedirect.com/topics/computer-science/electronic-communications-privacy-act
437 https://www.congress.gov/bill/114th-congress/senate-bill/754/text
438 https://www.ftc.gov/news-events/media-resources/protecting-consumer-privacy-security/kids-privacy-coppa https://www.law.cornell.edu/uscode/text/15/chapter-91

**Интернэт орчинд хүүхдийг хамгаалах тухай хууль**[439]

Тус хуулиар хүүхдийг интернэтээр зохисгүй, садар самуун материал харах, үзэхээс сэргийлсэн зохицуулалтыг хийсэн байна. Сургууль, номын сангууд нь компьютертэ зохисгүй материалыг шүүх програмыг суулгах шаардлагатай бөгөөд интернэтийн аюулгүй байдлын бодлогыг баримтлан хэрэгжүүлдгээ баталгаажуулаагүй тохиолдолд E-rate хөтөлбөрөөс олгодог интернэтийн хөнгөлөлтийг эдлэх боломжгүй болох юм. Холбооны Харилцаа холбооны хороо нь (Federal Communication Commission) тус хуулийг хэрэгжүүлэх журмыг 2001 оны эхээр батлан, 2011 онд шинэчлэн баталсан байна.

**Хүүхэд хамгаалал, аюулгүй байдлын тухай хууль**[440]

Энэ хуулийг хүчирхийллийн золиос болсон Адам Валш хүүгийн нэрээр нэрлэсэн байна. Энэ хуулиар цахим хуудас хайх явцад санаатайгаар хүнийг төөрөгдүүлсэн нэр хаяг, зураг тавьж хүмүүс, насанд хүрээгүй хүүхдийг садар самуунд уруу татах, хүүхдэд зохисгүй, хортой контент үзүүлэхийг хориглосон байна.

Түүнчлэн энэ хуулиар улс орон даяар хүчингийн хэрэгт холбогдож байсан гэмт этгээдүүдийг бүртгэлжүүлэхийг үүрэг болгосон байна. Гэмт этгээдүүдийг гэмт хэргийн шинжээс хамааран 3 ангилалд (Tier 1, 2, 3) ангилах бөгөөд 2-хүнд, 3-онц хүнд хэрэг үйлдсэн этгээдүүдийн талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй байршуулахыг муж, орон нутгийн хууль сахиулагчдад үүрэг болгосон байна.

- 1-р ангиллын гэмт хэрэгтнүүд 15 жилийн турш, жил бүр оршин суугаа газрынхаа цагдаагийн газарт бүртгүүлнэ.
- 2-р ангиллын гэмт хэрэгтнүүд 25 жилийн турш, 6 сар тутам оршин суугаа газрынхаа цагдаагийн газарт бүртгүүлнэ.
- 3-р ангиллын гэмт хэрэгтнүүд насан туршдаа, 3 сар тутам оршин суугаа газрынхаа цагдаагийн газарт бүртгүүлнэ.

Бүртгэл хийлгээгүй тохиолдолд хууль зөрчсөнд тооцон, хариуцлага хүлээлгэнэ.

**21-р зуунд хүүхдийг хамгаалах тухай хууль**[441]

Энэ хуулиар хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах үүрэг бүхий Холбооны Худалдааны Комисст Хүүхдийн аюулгүй интернэт хэрэглээг дэмжих хөтөлбөр боловсруулан улс орон даяар хэрэгжүүлэхийг үүрэг болгосон байна. Тус хөтөлбөр нь төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын хэрэглэж буй интернэтийн аюулгүй байдлыг хангах арга хэрэгслүүдээс шилдэг туршлагыг шалгаруулан, урамшуулах, олон нийтэд түгээх, танилцуулах, ялангуяа интернэтийн аюулгүй болон зохистой хэрэглээ, цахим орчинд олон нийтийн сүлжээгээр үл таних хүнтэй хэрхэн харилцах, цахимаар доромжлох, дээрэлхэх үйлдлээс хэрхэн сэргийлэх, хариу өгөх талаар хүүхэд, өсвөр насныханд сургах, таниулах сургалтын хөтөлбөрүүдийг багтаасан байх шаардлагатай байна. Холбооны Худалдааны Комисс нь жил бүр Конгресст хуулиар хүлээсэн энэхүү үүргийнхээ хэрэгжилтийн тайланг танилцуулах шаардлагатай байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[439] https://www.fcc.gov/consumers/guides/childrens-internet-protection-act
[440] https://www.congress.gov/bill/108th-congress/senate-bill/800/text
[441] https://www.ftc.gov/enforcement/statutes/protecting-children-21st-century-act
https://www.law.cornell.edu/uscode/text/15/chapter-91A

**Домэйн нэр үнэн зөв байх тухай хууль**[442]

Тус хуулиар хүмүүст болон насанд хүрээгүй хүүхдэд интернэтээр зохисгүй материал үзүүлэх, садар самуунд уруу татах зорилгоор хуурамч домэйн нэр ашиглахыг хориглосон байна. Хэрэв санаатайгаар хуурамч домэйн нэр ашиглан, хүнийг төөрөгдүүлэн садар самуунд уруу татсан тохиолдолд мөнгөн торгууль ногдуулах буюу 2 жилээс ихгүй хугацаагаар хорих эсхүл мөнгөн торгууль ногдуулах болон хорих шийтгэл давхар ногдуулна. Хэрэв санаатайгаар хуурамч домэйн нэр ашиглан, хүүхдийг төөрөгдүүлэн садар самуунд уруу татсан тохиолдолд мөнгөн торгууль ногдуулах буюу 10 жилээс ихгүй хугацаагаар хорих эсхүл мөнгөн торгууль ногдуулах болон хорих шийтгэл давхар ногдуулна гэж заажээ.

**Цахим гэмт хэргийн мэдээллийн шинэчлэлийн тухай хууль**[443]

АНУ-д үйл ажиллагаа явуулж байгаа цахимаар үйлчилгээ эрхлэгчид нь хүүхдийг бэлгийн хүчирхийлэл, садар самуун үйлдэлд ашигласан материалын талаар мэдсэн тохиолдолд хууль сахиулагч байгууллагад нэн даруй мэдэгдэх үүрэгтэй байна.

Арьс өнгө, гарал үүсэл, нас хүйс, шашин шүтлэг, хөгжлийн бэрхшээл зэргээр нь ялгаварлан гадуурхаж, айлган сүрдүүлсэн (Cyber bullying, Cyber harassment) тохиолдолд **Ялгаварлан гадуурхах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай (Hate Crimes Prevention Act)**[444] хуулиар зохицуулдаг байна.

Нэгдсэн Улсын Код, Сэдэв 18 - Гэмт хэрэг болон Гэмт хэргийн үйл явц, Бүлэг 110А, Хэсэг 2261А-аар Мөшгих болон Цахимаар мөшгих (Cyber stalking) гэмт хэргийг зохицуулсан байна.[445]

### 4.2 БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС

***I. Цахим орчин дахь гэмт хэргийн нөхцөл байдал:***

2020 оны байдлаар БНСУ-ын цагдаагийн байгууллагад 234 мянга орчим цахим гэмт хэрэг бүртгэгдсэн ба энэ нь өмнөх оноос 54 мянга орчим хэргээр нэмэгдсэн байна. Цахим гэмт хэргийн хамгийн түгээмэл тохиолдлуудад интернэтийн залилан, санхүүгийн залилан, гэх мэт мэдээллийн сүлжээний гэмт хэрэгүүд бүртгэгдсэн байна.[446]

***II. Цахим аюулгүй байдлын засаглал***

Сүүлийн жилүүдэд Засгийн газар цахим халдлагын талаар ихээхэн анхаарал хандуулж бодлогын түвшинд авч үзсэн байна. Цахим засаглалын хувьд 3 агентаас бүрддэг.[447] Үүнд:

1. Үндэсний тагнуулын албаны дэргэдэх Цахим аюулгүй байдлын үндэсний төв (National Cybersecurity Center)
2. Шинжлэх ухаан мэдээлэл технологийн яам (Ministry of Science and ICT)
3. Үндэсний Батлан хамгаалах яам (Ministry of National Defense)

[442] https://www.law.cornell.edu/uscode/text/34/subtitle-II/chapter-209
[443] https://uscode.house.gov/view.xhtml?req=granuleid:USC-prelim-title18-section2258A&num=0&edition=prelim
[444] https://www.fbi.gov/investigate/civil-rights/federal-civil-rights-statutes
[445] https://www.law.cornell.edu/uscode/text/18/2261A#
[446]https://www.statista.com/statistics/1222208/south-korea-cyber-crime.
[447] https://carnegieendowment.org/2021/08/17/korean-policies-of-cybersecurity-and-data-resilience-pub-85164

UIH.MN СУДАЛГААНЫ САН

*Зураг 1. Цахим аюулгүй байдлын засаглалын схем*[448]




Source: NIS et. al., “White Paper on Information Security 2018” (in Korean), 2018, p. 52.

БНСУ-д 2015 оноос эхлэн Ерөнхийлөгчид шууд харьяалагддаг Үндэсний аюулгүй байдлын зөвлөл (ҮАБЗ) нь кибер аюулгүй байдалтай холбоотой асуудлуудыг зохицуулж ирсэн байна.[449] Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн доорх Цахим аюулгүй байдлын үндэсний төв нь цахим гэмт хэрэг, халдлага аюулгүй байдалтай холбоотой асуудлуудыг хариуцан ажилладаг байна. Цахим аюулгүй байдлын үндэсний төв нь Шинжлэх ухаан мэдээлэл технологийн яам болон Үндэсний Батлан хамгаалах яамтай хамтран хувийн хэвшил болон төрийн байгууллагуудын цахим аюулгүй байдлыг хариуцаж хоорондоо уялдаатай ажилладаг байна.

***III. Цахим орчин дахь гэмт хэргийн стратеги төлөвлөгөө***

Өмнөд Солонгос Улс төрөл бүрийн кибер халдлага гэмт хэргээс сэргийлэн 2019 онд Кибер аюулгүй байдлын үндэсний стратегийг боловсруулжээ. Уг стратеги нь 6 зорилттой байна. Үүнд:

1. Үндэсний дэд бүтцийн аюулгүй байдлыг нэмэгдүүлэх (Increase the Safety of National Core Infrastructure)

- Үндэсний мэдээлэл, харилцаа холбооны сүлжээний аюулгүй байдлыг бэхжүүлэх;
- Кибер аюулгүй байдлын орчны дэд бүтцийг сайжруулах;
- Шинэ үеийн кибер аюулгүй байдлын дэд бүтцийг хөгжүүлэх.

2. Кибер халдлагын хариу арга хэмжээ түүний хүчин чадлыг сайжруулах (Enhance Cyber Attack Response Capabilities)

- Кибер халдлагаас урьдчилан сэргийлэх;
- Том хэмжээний кибер халдлагын эсрэг бэлэн байдлыг бэхжүүлэх;
- Кибер халдлагын эсрэг цогц, идэвхтэй арга хэмжээ авах;
- Цахим гэмт хэрэгтэй тэмцэх чадварыг сайжруулах.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[448] NIS et al., “White Paper on Information Security 2004” (in Korean), 2004, p. 7.
[449] From 2015 to 2018, the NSC designated the cybersecurity adviser to lead the cybersecurity efforts nation-wide, however, this position was merged with the cyber information convergence adviser under the same NSC

3. Итгэлцэл, хамтын ажиллагаанд суурилсан засаглалыг бий болгох (Establish Governance Based on Trust and Cooperation)

- Төр, хувийн хэвшил, цэргийн хамтын ажиллагааны тогтолцоог сайжруулах;
- Улс даяар мэдээлэл солилцох системийг бий болгох;
- Кибер аюулгүй байдлын эрх зүйн үндсийг сайжруулах.

4. Кибер аюулгүй байдлын салбарын өсөлтийг дэмжих (Build Foundations for Cybersecurity Industry Growth)

- Кибер аюулгүй байдлын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;
- Кибер аюулгүй байдлын ажиллах хүч, технологийн өрсөлдөх чадварыг бэхжүүлэх;
- Кибер аюулгүй байдлын компаниудыг хөгжих орчныг бүрдүүлэх;
- Кибер аюулгүй байдлын зах зээлд шударга өрсөлдөөний зарчмыг бий болгох.

5. Кибер аюулгүй байдлын соёлыг бий болгох (Foster a Cybersecurity Culture)

- Кибер аюулгүй байдлын талаар мэдлэгийг дээшлүүлэх, кибер аюулгүй байдлын практикийг бэхжүүлэх;
- Үндсэн эрхийг кибер аюулгүй байдалтай тэнцвэржүүлэх.

6.Кибер аюулгүй байдлын чиглэлээр олон улсын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх (Lead International Cooperation in Cybersecurity)

- Хоёр талын болон олон талт хамтын ажиллагааны системийг сайжруулах;
- олон улсын хамтын ажиллагааг манлайлах.

***IV. Хууль эрх зүйн орчин***

БНСУ-ын Эрүүгийн хуульд цахим гэмт хэрэгтэй холбоотой дараах зохицуулалтууд байдаг. Үүнд:[450] Эрүүгийн хууль (Criminal Law)

- Зүйл 141. Олон нийтийн баримт бичиг, нийтийн хэрэгсэлд хохирол учруулах (The invalidity of Public Documents, etc. and Destruction of Public Goods) Төрийн албанд ашигладаг баримт бичиг, бусад хэрэгсэл, дуу бичлэг гэх мэт тусгай хэвлэл мэдээллийн хэрэгслийг гэмтээж, нуун дарагдуулсан, сүйтгэсэн этгээдийг 7 жил хүртэлх хорих ял эсвэл 10 сая хүртэлх воноор торгоно.
- Зүйл 227-2. Нийтийн дуу бичлэгийг хуурамчаар бэлтгэх буюу өөрчлөх (False Preparation or Alteration of Public Electromagnetic Records)
  Хэрэв үүнтэй холбоотой зөрчил үүсгэвэл 10 хүртэлх жилээр хорих шийтгэлтэй байна.
- Зүйл 316. Нууц задруулах (Violation of Secrecy) Битүүмжилсэн эсвэл нууцлалтай захидал, баримт бичиг, зургийг нээсэн этгээдийг 3 жил хүртэл хорих, эсхүл таван сая воноор торгууль ногдуулна.
- Зүйл 347-2. Компьютер ашиглах замаар залилан хийх (Fraud by The Use of Computer, etc.) Хэн нэгэн хөндлөнгийн этгээд компьютер ашиглан бусдын зөвшөөрөлгүй худал, зохисгүй мэдээлэл ашиглан ашиг хүртэх, хууль зөрчсөн тохиолдолд 10 хүртэлх жилээр хорих эсвэл 20 сая воноор торгоно.

[450] https://www.cybercrimelaw.net/Korea.html

UIH.MN СУДАЛГААНЫ САН

- Зүйл 366. Эд хөрөнгөд халдах, сүйтгэх (Destruction and Damage, etc. of Property) Бусдын эд хөрөнгөтэй холбоотой баримт бичиг, дуу бичлэг гэх мэт мэдээллийн хэрэгслийг устгах, гэмтээх, нуун дарагдуулах, тохиолдолд 3 жил хүртэлх хорих, эсвэл 7 сая хүртэлх воноор торгоно.

БНСУ 1980 оноос эхлэн Үндэсний мэдээллийн аюулгүй байдал болон нийгмийн сүлжээн дэх асуудлуудыг зохицуулах хуулийг боловсруулж эхэлсэн ба 1986 онд Харилцаа холбооны сүлжээг сайжруулах тухай хууль (Expansion and promotion of utilization of communications network act) анх баталж байжээ.[451] Одоогоор кибер аюулгүй байдалтай холбоотой асуудлыг хэд хэдэн хуулиар зохицуулж байна. Тухайлбал:[452]

- Сүлжээний тухай хууль (Network act)
- Харилцаа холбооны нууцыг хамгаалах тухай хууль (Protection of communication secret act)
- Мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтцийг хамгаалах тухай хууль (The act on protection of information and communication infrastructure)
- Цахим засаглалын тухай хууль (Electronic government act)
- Үндэсний батлан хамгаалахын мэдээллийн дэд бүтцийг бий болгох, мэдээллийн нөөцийг удирдах тухай хууль (Act on Establishment of infrastructure for information of national defence and management of information resources for national defence)
- Зээлийн мэдээллийн ашиглалт, хамгаалалтын тухай хууль (Credit information use and protection act)
- Байршлын мэдээллийг хамгаалах тухай хууль (Act on protection use of location information)
- Үйлдвэрлэлийн технологийг хамгаалах тухай хууль (Act on Prevention of Divulgence and protection of industrial technology)
- Цахилгаан холбооны бизнесийн болон санхүүгийн луйврын тухай хууль (Telecommunication business act and special act on financial fraud) зэрэг байна.

Үндэсний хэмжээнд кибер халдлагаас сэргийлэх зорилгоор “Кибер аюулгүй байдлын менежментийн зохицуулалтын (National cyber security management regulation) журам”-ыг Үндэсний Ассамблей баталсан байна. Уг журмаар Засгийн газрын байгууллагуудын (Үндэсний тагнуулын албаны Үндэсний аюулгүй байдлын төв, Хөх ордон дахь үндэсний аюулгүй байдлын алба) эрх үүрэг, оролцоог тодорхойлсон байна.[453] Кибер халдлагаас хамгаалах мэдээллийн дэд бүтцийн тухай хууль нь үндэсний аюулгүй байдалтай шууд холбогддог ба эрчим хүч, эрүүл мэнд, банк санхүүгийн цахим үйл ажиллагааг уг хуулиар зохицуулдаг байна. Солонгосын Засгийн газар 2002 онд Мэдээллийн дэд бүтцийг хамгаалах тухай хуулийг (Protecting critical information infrastrucutre act) баталсан байна. Уг хууль нь дараах бүтэцтэй байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[451] Introduction to Korean cyber security Law
[452] https://iclg.com/practice-areas/cybersecurity-laws-and-regulations/korea
[453] Ibid Page 28

**МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ДЭД БҮТЦИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ**

(The Act On Protection Of Information And Communication Infrastructure)

1 дүгээр зүйл. Зорилго

Энэхүү хуулийн зорилго нь харилцаа холбооны нууц, нууцыг хамгаалах, харилцаа холбооны эрх чөлөөг тогтоох, зохих журмын дагуу шийдвэр гаргах замаар харилцаа холбооны эрх чөлөөг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Нэр томьёоны тайлбар

3 дугаар зүйл. Харилцаа холбооны нууцыг хамгаалах

4 дүгээр зүйл. Хууль бус хяналт шалгалтаар олж авсан мэдээлэл хууль бусаар чагнах, цахилгаан холбооны агуулгыг нотлох баримт болгон ашиглахыг хориглох тухай

5 дугаар зүйл. Эрүүгийн байцаалтын мэдээллийг хязгаарлах зөвшөөрлийн шаадлага

6 дугаар зүйл. Эрүүгийн байцаалтын мэдээллийг хязгаарлах зөвшөөрлийн арга хэмжээ авах эрх олгох журам

7 дугаар зүйл. Үндэсний аюулгүй байдалд нийцүүлсэн харилцаа холбооны хяналт

8 дугаар зүйл. Онцгой байдлын үеийн харилцаа холбоог хязгаарлах арга хэмжээ

9 дүгээр зүйл. Харилцаа холбоонд хяналт тавих арга хэмжээний хэрэгжилт

10 дугаар зүйл. Чагнах төхөөрөмжийн зөвшөөрөл олгох журам

11 дүгээр зүйл. Нууцлалын үүрэг

12 дугаар зүйл. Харилцаа холбооны арга хэмжээгээр олж авсан материалыг ашиглахыг хязгаарлах тухай

13 дугаар зүйл. Эрүүгийн байцаан шийтгэх үйл ажиллагаанд мэдээлэл өгөх журам

14 дүгээр зүйл. Бусдын нууцыг задруулсан зөрчлийн тухай

15 дугаар зүйл. Үндэсний Ассамблейн хяналт

16 дугаар зүйл. Торгуулийн заалт

17 дугаар зүйл. Торгууль оногдуулах тухай

18 дугаар зүйл. Гэмт хэрэг үйлдэхийг завдах тухай

## 4.3 МАЛАЙЗ УЛС

### *I. Цахим орчин дахь гэмт хэргийн нөхцөл байдал*

Ковид-19 цар тахлын үед цахим технологийн хэрэглээ өсөж байгаа нь кибер гэмт хэргийн гаралтыг нэмэгдүүлж, Малайз Улсын аюулгүй байдалд нөлөөлж байна. Малайзын цагдаагийн байгууллагын мэдээлснээр 2019 онд кибер халдлага, гэмт хэргийн тоо 3,787 байсан бол 2020 он гэхэд эдгээр халдлагууд 4,194 болж, 10%-аар нэмэгдсэн байна. 2021 онд энэ тоо цаашид нэмэгдэх төлөвтэй байна.[454]

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[454] Малайз Улс Кибер гэмт хэргийн нөхцөл байдал The Star Hews https://www.thestar.com.my/news/nation/2021/06/28/cybercrime-increasing-as-more-people-rely-on-digital-tech-during-pandemic-says-pm

*Зураг 2. Малайз Улсын кибер гэмт хэргийн статистик*




## *II. Цахим орчин дахь гэмт хэргийн стратеги төлөвлөгөө*

***Малайз Улсын кибер аюулгүй байдлын стратеги нь*** [455] (Malaysia Cyber Security Strategy) 2020-2024 онд кибер аюулгүй байдлын төлөвлөлт, хэрэгжилтийг бүх талаар зохицуулах 5 чиглэлд хэрэгжихээр боловсруулагдсан байна.

1. Үр дүнтэй засаглал ба удирдлага (Effective Governance and Management)
2. Эрх зүйн хүрээ, гүйцэтгэлийг сайжруулах (Strengthening legislative framework and enforcement)
3. Дэлхийн түвшний инновац, технологи, судалгаа ба аж үйлдвэр (Catalysing World Class Innovation, Technology, R&D and Industry)
4. Чадавхыг дээшлүүлэх, мэдлэг, боловсролыг нэмэгдүүлэх (Enhancing Capacity and Capability Building, Awareness and Education)
5. Олон Улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх (Strengthening Global Collaboration)

Дээрх Малайз улсын кибер аюулгүй байдлын стратегит Засгийн газар, бизнес, нийгмийн (иргэд) янз бүрийн салбарт кибер аюулгүй байдлыг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагаануудын төлөвлөгөөг тодорхойлсон.

### *Үр дүнтэй засаглал ба удирдлага (Effective Governance and Management)*

***Стратеги 1.*** *Үндэсний кибер аюулгүй байдлын засаглал, экосистемийг сайжруулах;*
***Стратеги 2.*** *Байгууллагын менежмент ба бизнесийн үйл ажиллагааг сайжруулах (Засгийн газар, Үндэсний мэдээллийн дэд бүтэц ба Бизнес);*
***Стратеги 3.*** *Кибер аюулгүй байдлын ослын менежмент, кибер хамгаалалтыг идэвхжүүлэх.*

[455] Malaysia Cyber Security Strategy (2020-2024) https://asset.mkn.gov.my/wp-content/uploads/2020/10/MalaysiaCyberSecurityStrategy2020-2024.pdf

UIH.MN СУДАЛГААНЫ САН

***Эрх зүйн хүрээ, гүйцэтгэлийг сайжруулах (Strengthening legislative framework and enforcement)***

***Стратеги 4.*** *Кибер гэмт хэрэг, халдлагыг хязгаарлах бууруулах кибер аюулгүй байдлын хуулийг сайжруулах;*
***Стратеги 5.*** *Цахим гэмт хэрэгтэй тэмцэх чадавх, чадварыг сайжруулах.*

***Дэлхийн түвшний инновац, технологи, судалгаа ба аж үйлдвэр (Catalysing World Class Innovation, Technology, R&D and Industry)***

***Стратеги 6.*** *Үндэсний кибер аюулгүй байдлын судалгаа, шинжилгээний хөтөлбөрийг идэвхжүүлэх;*
***Стратеги 7.*** *Өрсөлдөх чадвартай дотоодын үйлдвэрлэл, технологийг дэмжих.*

***Чадавхыг дээшлүүлэх, мэдлэг, боловсролыг нэмэгдүүлэх (Enhancing Capacity and Capability Building, Awareness and Education)***

***Стратеги 8.*** *Үндэсний кибер аюулгүй байдлын чадавхыг бэхжүүлэх;*
***Стратеги 9.*** *Кибер аюулгүй байдлын талаарх мэдлэгийг дээшлүүлэх;*
***Стратеги 10.*** Боловсролоор дамжуулан кибер аюулгүй байдлын талаар мэдлэгийг нэмэгдүүлэх.

***Олон Улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх (Strengthening Global Collaboration)***

***Стратеги 11.*** *Кибер аюулгүй байдлын асуудлаарх олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх;*
***Стратеги 12.*** Олон улсын аюулгүй байдлыг сахин хамгаалахын тулд аюулгүй, тогтвортой, энх тайван кибер орон зайг дэмжих тухай амлалтаа зарлах.

***IV. Хууль эрх зүйн орчин***

Малайз Улс кибер аюулгүй байдалтай холбоотой дараах цогц хуулиудыг баталсан байна. (**Хавсралт 4)** Үүнд:

- Зохиогчийн эрхийн тухай хууль (The Copyright (AmendmentAct)
- Тоон гарын үсгийн тухай хууль (The Digital Signature Act)
- Телемедициний тухай хууль (The Telemedicine Act)
- Харилцаа холбоо ба мультимедиан тухай хууль (The Communications and Multimedia Act)
- Цахим худалдааны тухай хууль( Electronic Commerce Act)
- Төрийн цахим үйл ажиллагааны тухай хууль (Electronic Government Activities Act)
- Хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль (Personal Data Protection Act) Эрүүгийн хууль (Penal Code)
- Хуурамч мэдээллийн эсрэг хууль (The Anti-Fake News Act) гэх мэт.

Малайз Улс 1997 онд  Компьютерийн гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуулийг (The Computer Crimes Act) баталсан ба 2011 оны 12-р сарын 1-нд дахин шинэчилсэн байна. Уг хуулиар зохицуулж буй харилцаа:[456]

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[456] https://cyrilla.org/ar/entity/xqej2atn2lh?file=1568729651356shamgdeopv.pdf&page=5

## КОМПЬЮТЕРИЙН ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬ, 1997 ("CCA")

Бүлэг 1. **Зорилт**

Нэр томьёоны тайлбар

Бүлэг 2.

**Компьютерийн мэдээлэл рүү зөвшөөрөлгүй нэвтрэх**

- Бусдын компьютер болон компьютерийн мэдээлэл (дата)-д зөвшөөрөлгүй, санаатайгаар нэвтэрсэн гэм буруутай нь тогтоогдвол 50 мянган ринггитээс ихгүй торгууль ногдуулах буюу таван жилээс дээшгүй хугацаагаар хорих шийтгэл ногдуулна.

**Өөрөө болон бусад хүнээр халдлага үйлдэх,**

- Энэ хэсэгт заасны дагуу гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдэд 150 мянган ринггитээс ихгүй хэмжээний торгууль ногдуулах, эсхүл арван жилээс дээшгүй хугацаагаар хорих ялаар шийтгэнэ.

**Аливаа компьютерийн өгөгдөл агуулгыг зөвшөөрөлгүй өөрчлөх**

- Бусдын компьютерийн агуулгыг зөвшөөрөлгүй өөрчлөх үйлдэл хийсэн тохиолдолд 100-500 мянган ринггитээс дээшгүй торгууль ногдуулах, эсхүл долоогоос арван жилийн хорих ялаар шийтгэнэ.

**Зөвшөөрөлгүй харилцах**

- Компьютерт нэвтрэх дугаар, код, нууц үг эсвэл бусад хэрэгслийг шууд болон дам байдлаар мэдэгдсэн тохиолдолд 25 мянган ринггитээс дээшгүй торгууль ногдуулах, эсхүл гурван жил хорих ялаар шийтгэнэ.

Бүлэг 3.

Нэмэлт болон ерөнхий заалтууд[457]

**Халдлагын цар хүрээ**

- Энэхүү хуулийн заалтууд нь гэмт этгээдийн иргэншил болон оршин суух харьяаллаас үл хамааран Малайзын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр үйлчлэх бөгөөд хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хуулийн дагуу шийтгэдэг байна.

**Эрэн сурвалжлах, хураах, баривчлах бүрэн эрх**

- Энэ хуульд заасны дагуу гэмт хэрэг үйлдсэн болохыг нотлох баримтанд үндэслэх эсвэл шүүгчийн шийдвэр гарвал, байцаагчаас дээш цолтой (above the rank of Inspector) албан хаагч гэмт хэргийн газар хүчээр нэвтрэх, шаардлагатай бол саатуулах, тэнд байгаа нотлох баримтыг хайх, хураах эрхтэй байдаг.

**Мөрдлөгт саад учруулах**

- Уг хуульд заасны дагуу албан хаагчийн эрх, үүргийн дагуу мөрдлөг хийх явцад халдах, саад учруулах, байцаалтыг хойшлуулахыг хориглодог.

**Яллах**

- Уг хуулийн дагуу яллах ажиллагааг Улсын яллагчийн албан ёсны шийдвэрээс бусад тохиолдолд яллахгүй.

[457] https://www.nacsa.gov.my/legal.php

UIH.MN СУДАЛГААНЫ САН

## 4.4 ЯПОН УЛС

### *I. Цахим орчин дахь гэмт хэргийн нөхцөл байдал*[458]

2021 оны 3-р сарын байдлаар Үндэсний цагдаагийн газраас явуулсан судалгаагаар 18-аас доош насны 1819 хүүхэд 2020 онд нийгмийн сүлжээтэй холбоотой гэмт хэргийн хохирогч болсон болохыг тогтоожээ. Хохирогчдын бараг 90 хувь нь бага, ахлах сургуулийн сурагчид байсан бөгөөд үүний 35,3 хувийг твиттер ашиглагч эзэлж байна. Хэдийгээр 2019 оны мөн үетэй (2082) харьцуулахад 12,6%-аар буурсан боловч 2013 оноос хойш сүүлийн 5 жилд 4.6 хувиар өссөн үзүүлэлттэй байжээ. Гэмт хэргийн төрлийг ангиллаар нь авч үзвэл, хүүхдийг хамгаалах хууль, журмыг зөрчсөн 738, хүүхдийг садар самуунд уруу татсан 597, хүүхдийн биеэ үнэлэх явдал 311 байгаа бол хүнд гэмт хэргийн хувьд хулгайлах гэмт хэрэг өссөн үзүүлэлттэй гарчээ. Хохирогчдын нэвтрэх хэрэгслийн хувьд ухаалаг гар утас нь нийт интернэт хэрэглэгчдийн 90 орчим хувийг эзэлж байсан бол ашигладаг сүлжээний хувьд Твиттер дээр 642, Инстеграм дээр 221, Химабе дээр 160, Тик ток дээр 76, Коё Томо дээр 63 байсан байна. 2019 онд онлайн банкны луйврын улмаас 2.5 тэрбум гаруй иений хохирол учирсан байна. 2020 онд телевизийн реалити цуврал нэвтрүүлэгт оролцсон эмэгтэй мэргэжлийн бөх Хана Кимура амиа хорлосонтой холбоотойгоор цахим орчинд дээрэлхэх явдал нь улс оронд томоохон асуудал болжээ.

### *II. Цахим орчин дахь гэмт хэргийн стратеги төлөвлөгөө*

**Кибер аюулгүй байдлын стратеги (2021)**

2021 оны 9 сард Кибер аюулгүй байдлын 3 дахь стратеги төлөвлөгөөг батлан гаргасан байна. Үндсэн зарчимд мэдээллийн чөлөөт урсгалын баталгаа, хуулийн засаглал, нээлттэй байдал, бие даасан байдал, олон талт хамтын ажиллагаатай байна гэж тусгажээ. Ирэх 3 жилд хэрэгжүүлэх стратегийн зорилго, чиглэлээ:

*1. Нийгэм эдийн засгийн тогтвортой хөгжлийг нэмэгдүүлэх:*

- Дижитал аюулгүй байдлын мэдлэгийг дээшлүүлэх;
- Орон нутаг болон ЖДҮ эрхлэгчдийн дунд “Цахим аюулгүй байдал бүхий DX”-ийг сурталчлах;
- Сүлжээний найдвартай байдлыг хангах.

*2. Аюулгүй байдал, дижитал нийгмийг ухамсарлах:*

- Нийгэм болон хүмүүсийг хамгаалах кибер аюулгүй байдлын орчныг бүрдүүлэх;
- Нийгэм, эдийн засгийн дэд бүтцийг түшиглэсэн оролцогч талуудын хүчин чармайлтыг дэмжих;
- Кибер халдлагад хариу өгөх бэлэн байдлыг хангах.

*3. Японы үндэсний аюулгүй байдлыг хангах:*

- Чөлөөт, шударга, аюулгүй цахим орон зайг хангах;
- Кибер аюулгүй байдлын хамгаалалт, урьдчилан сэргийлэх чадварыг бэхжүүлэх;
- Олон улсын хамтын ажиллагааны оролцоог дээшлүүлэх;
- Хүний нөөцийг бүрдүүлэх, хөгжүүлэх зорилгоор баталсан байна.

[458] Cabinet Office https://www8.cao.go.jp/youth/kankyou/index.html

UIH.MN СУДАЛГААНЫ САН

### *III. Холбогдох байгууллагууд*

Цагдаагийн Ерөнхий газар нь Эрүүгийн хууль болон холбогдох хуулийн дагуу цахим гэмт хэргийг мөрдөн шалгаж, таслан зогсоох үүрэгтэй ажилладаг. Мөн Цагдаагийн Ерөнхий газрын “Кибер гэмт хэрэгтэй тэмцэх төв”-өөс муж бүрийн цагдаа нарт кибер гэмт хэргийн талаар мэдээлэл, заавар зөвлөгөө өгч ажилладаг. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь хүүхэд, залуучуудын хөгжил, дэмжлэгийн талаар төлөвлөлт, иж бүрэн зохицуулалт хийх үүрэг бүхий төрийн байгууллагын хувьд үндсэн цогц бодлогыг боловсруулсан бөгөөд энэхүү бодлогыг үндэслэн холбогдох яам, агентлагууд орон нутгийн засгийн газар болон бусад холбогдох төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг. Үүнээс гадна интернэт орчинд үйл ажиллагаа явуулдаг GREE, CyberAgent, DeNA, Facebook Japan, Mixi, LINE, Twitter Japan зэрэг операторууд нэгдэн “Өсвөр үеийнхний интернэт ашиглалтын орчныг сайжруулах зөвлөл”-ийг олон нийтийн сайтуудаас үүдэлтэй хүүхдийг гэмтээх аливаа үйлдлээс урьдчилан сэргийлэх хүчин чармайлтыг сурталчлах зорилгоор 2017 онд байгуулсан. Зөвлөл нь хүүхдийн аюулгүй интернэт орчныг бүрдүүлэхээр мэдээлэл солилцох, судалгаа, боловсрол, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа явуулдаг. Мөн Ignis, Cocone, Nanameue, Moi, Yudo, ITI, C studio, Social Town, Maleo зэрэг компаниуд хамтран оролцох болсон. Тус зөвлөл нь Цагдаагийн ерөнхий газартай хамтран ажилладаг байна. Цахим орчин дахь хүүхэд, залуучуудыг хамгаалах асуудлыг “Насанд хүрээгүй хүмүүсийн интернэтийн аюулгүй орчныг бүрдүүлэх тухай хууль”, Насанд хүрээгүй хүмүүсийн аюулгүй интернэт хэрэглээг бий болгох үндсэн төлөвлөгөөг үндэслэн Дотоод хэргийн яам, Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан технологийн яам, холбогдох агентлагууд, Үндэсний цагдаагийн газар бусад төрийн болон хувийн байгууллагууд хамаарах бөгөөд тэдгээр нь интернэтийн аюулгүй хэрэглээний талаар сурталчлах ажлыг тогтмол зохион байгуулдаг.

- **Кибер аюулгүй байдлын стратегийн төв штаб (National center of Incidient readiness and Strategy For Cybersecutity(NISC))[459]**

2014 онд Засгийн газрын дэргэд байгуулагдан тус штаб нь кибер аюулгүй байдлын стратегийг үр дүнтэй, цогцоор нь сурталчлах, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэгтэй.

- **Кибер гэмт хэрэгтэй тэмцэх төв (Japan Cybercrime Control Center)[460]**

2014 онд цахим гэмт хэргийн үндэс суурийг олж тогтоох, бууруулах, саармагжуулж дараагийн учирч болох аюул ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор төр болон хувийн хэвшилтэй хамтарсан ашгийн бус байгууллага болох Японы кибер гэмт хэрэгтэй тэмцэх төв байгуулагдсан. Үйл ажиллагааны чиглэл:

- Эдийн засаг, санхүүгийн кибер гэмт хэрэг;
- Зорилтот халдлага (мэдээлэл хулгайлах);
- Цахим худалдааны платформ дээр залилан мэхлэх үйл ажиллагаа;
- Хортой програмын шинжилгээ;
- Мэдээллийн аюулгүй байдал;
- Олон улсын хамтын ажиллагаа гэсэн чиглэлтэй байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[459] National center of Incidient readiness and Strategy For Cybersecutity https://www.nisc.go.jp/eng/index.html
[460] Japan Cybercrime Control Center https://www.jc3.or.jp/english/

Кибер орчин дахь аюул заналхийлэл, гэмт хэргийн талаарх мэдээлэл цуглуулж дүн шинжилгээ хийх, урьдчилан сэргийлэх сургалтын хөтөлбөр боловсруулах, цогцоор нь шийдвэрлэхийн тулд цагдаагийн ерөнхий газар, мэдээлэл технологийн байгууллага, банк санхүүгийн байгууллага, хувийн хэвшлийн компани болон олон улсын хамтын байгууллагатай нягт хамтран ажилладаг байна.

- **@Police[461] цахим мэдээллийн сайт**

Үндэсний цагдаагийн газрын кибер гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсээс кибер гэмт хэрэг, кибер халдлагаас урьдчилан сэргийлэх зорилгоор ажиллуулдаг цахим мэдээллийн сайт юм.

- **Кибер аюулгүй байдлын судалгааны төв (Cybersecurity Research Institute)[462]**

Мэдээлэл, харилцаа холбоо технологийн үндэсний хүрээлэнгийн харьяа Кибер аюулгүй байдлын судалгааны төв нь нийгэмд сүүлийн үеийн тулгамдаж байгаа кибер аюулгүй байдлын талаар судалгаа шинжилгээний ажил хийдэг.

***IV. Хууль эрх зүйн орчин***

- **Эрүүгийн хууль (Japan Penal Code)[463]**

Энэ хууль Япон Улсын нутаг дэвсгэр болон Япон Улсын хөлөг онгоц, онгоцонд гэмт хэрэг үйлдсэн хүн бүрд адил хамаарна.

*161(2) дугаар зүйл.* Эрх баригч болон төрийн албан хаагчдын бүртгэл, баримтыг ашиглан бичлэг хийн олон нийтэд тараасан тохиолдолд 10 жил хүртэлх хугацаагаар хорих эсхүл 1,000,000 иений торгууль ногдуулна.

*168 дугаар зүйл. Компьютерийн вирус болон буруу командын бүртгэл (Improper Command Records):*

*Improper Command Records* гэдэг нь (a) компьютерийг операторын эсрэг ажиллуулах, буруу команд өгөх цахилгаан соронзон бичлэгийг хэлнэ.

Компьютерийн вирус болон буруу командын бүртгэл үүсгэж бусдын компьютерт вирус болон зохисгүй бичлэг тараасан этгээд болон тараахыг завдсан этгээдэд 3 жил хорих ял эсхүл 500,000 иенээр торгоно.

*Hacking* ажиллагаанд буруу командын бүртгэлийг ашигласан тохиолдолд 3 жил хорих эсхүл 1,000,000 иений торгууль ногдуулна.

*Phishing* (a) хулгайлах, залилан мэхлэх, заналхийлэх зэрэг хууль бус аргаар ажил олгогчийн худалдааны нууцыг олж авах;

(b) худалдааны нууцыг ашиглах, бусдад задруулсан тохиолдолд 10 жилийн хорих ял шийтгэл эсхүл 20,000,000 иений торгууль ногдуулна.

*175(1) дүгээр зүйл. Электромагнет бичлэг агуулсан бүдүүлэг ичгүүргүй агуулгатай бичлэг үзүүлэх:*

UIH.MN СУДАЛГААНЫ САН

---

[461] @Police https://www.npa.go.jp/cyberpolice/english/index.html
[462] Cybersecurity Research Institute https://www.nict.go.jp/en/csri/
[463] Japan Penal Code http://www.isc.meiji.ac.jp/~sumwel_h/Codes/comp-crim.htm

Олон нийтэд ичгүүргүй бүдүүлэг баримт, зурмал зураг, электромагнет бичлэг бүхий эсхүл бусад агуулга бүхий мэдээлэл бичлэгээр хангасан эсхүл үзүүлсэн этгээдийг 2-оос илүүгүй жилээр хорих, эсхүл 2,500,000-аас ихгүй иенээр торгоно. Бүдүүлэг электромагнетик бичлэг эсхүл теле харилцаагаар дамжуулсан өөр бусдад бичлэг түгээсэн этгээдийг мөн адил шийтгэнэ.

Зүйл 3(1)-ийн *заалтаар учрах хохирлоос урьдчилан сэргийлэх тухай*

Танихгүй хүмүүст эсхүл хэд хэдэн хүмүүст хувийн бичлэгийг теле харилцааны шугамаар дамжуулж, улмаар гуравдагч этгээд тухайн дүрс бичлэг дэх хүнийг оноон таньсан тохиолдолд тухайн бичлэг дамжуулсан этгээдийг 3-аас илүүгүй жилээр хорих эсхүл 500,000-аас ихгүй иенээр торгож шийтгэнэ.

222 (1) дугаар зүйл. *Сүрдүүлэх*:

Бусдын амь нас, эрх чөлөө, нэр хүнд, эд хөрөнгөд заналхийлж сүрдүүлсэн этгээдийг 2-оос ихгүй жилээр хорих эсхүл 300,000-аас ихгүй иенээр торгоно.

*223 (1) дүгээр зүйл. Шахалт:*

Бусдын амь нас, эрх чөлөө, нэр хүнд, эд хөрөнгийг доромжлол, хэрцгийлэл хэрэглэж бусдаар үйл үйлдүүлэх, эсхүл бусдыг өөрийн зүй ёсны эрхээ эдлэхэд нь саад болох зэргээр заналхийлж сүрдүүлсэн этгээдийг 3-аас илүүгүй жилээр хорьж шийтгэнэ.

*230 (1) дүгээр зүйл. Гүтгэлэг:*

Олон нийтийн өмнө баримт дэлгэн мэдүүлж бусдыг гүтгэсэн этгээдийг, тухайн баримт үнэн, худлаас үл шалтгаалан, 3-аас илүүгүй жилээр хорих эсхүл ажил алба эрхлүүлэхгүй байх, эсхүл 500,000-аас ихгүй иенээр торгоно.

*231 дүгээр зүйл. Гутаан доромжлох:*

Бусдыг олны өмнө гутаан доромжилсон этгээдийг хэдий тэр нь ямарваа баримт нотолгоо болохгүй байсан ч хөдөлмөрлөх эрхийг хасаж, жижиг гэмт хэргийн нөхцөлөөр хорих эсхүл бага хэмжээний торгууль ногдуулна.

*233 дугаар зүйл. Бизнест саад учруулах:*

Буруу худал цуурхал тараах эсхүл залилан мэхлэх арга замаар бусдын бизнесийн нэр хүндийг сэвтүүлэх, эсхүл саад учруулсан бол 3-аас илүүгүй жилээр хорих эсхүл 500,000-аас ихгүй иенээр торгох шийтгэл ногдуулна.

*Эрүүгийн хуулийн нэмэлт өөрчлөлт*

234(2) дугаар зүйл. Компьютерийн програмыг санаатайгаар гэмтээж, операторын эсрэг ашиглах, бусдын бизнест хохирол учруулах, хуурамч мэдээлэл өгөх, зохисгүй Програм суулгасан тохиолдолд 5 жил хорих эсхүл 1,000,000 иений торгууль ногдуулна.

246(2) дугаар зүйл. Хуурамч мэдээллээр бичлэг хийх, эсхүл гуравдагч этгээдийн боловсруулсан бүртгэлээр санхүүгийн ашиг олсон тохиолдолд 10 хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэнэ.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

- **Хүүхдийн биеэ үнэлэх, хүүхдийн порно үйлдэлд хариуцлага ногдуулах болон хүүхдийг хамгаалах тухай хууль (Act on Punishment of Activities Relating to Child Prostitution and Child Pornography, and the Protection of Children)[464]**

Энэхүү хуулиар хүүхдийн эрхийг илтэд зөрчсөн садар самууныг сурталчилсан болон хүүхдийг садар самуун, биеэ үнэлэх, эрүүгийн хариуцлага ногдуулах, хүүхдийн эрхийг хамгаалах үндсэн зорилготой. Мөн хуулиар интернэтээр насанд хүрээгүй хүмүүсийн порно бичлэг тараасан, бичлэг үйлдсэн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг хуульчилсан. байна.

*7(6) дугаар зүйлтэй холбогдох хууль журам, шийтгэлийн тухай*

Насанд хүрээгүй хүмүүс буюу 18 нас хүрээгүй хүмүүс биеэ үнэлсэн бол 5-аас дээшгүй жил хорих ял оноох, эсхүл 5 саяас ихгүй иенээр торгох ял ногдуулна. Харин хүүхдийн порно бичлэгийг тараасан этгээдэд мөн адил ял ногдуулахаар заажээ.

- **Насанд хүрээгүй хүмүүсийн интернэтийн аюулгүй орчныг бүрдүүлэх тухай хууль(Act on Development of an Environment that Provides Safe and Secure Internet Use for Young People)[465]**

Тус хуулийг 2008 онд баталсан бөгөөд хуулиар насанд хүрээгүй буюу 18-аас доош насны хүмүүст интернэтийг зохистой ашиглах чадварыг эзэмшүүлэх, шүүлтүүрийн тархалтыг дэмжих замаар насанд хүрээгүй хүмүүсийн хортой агуулга бүхий мэдээллийг үзэх боломжийг багасгах, иргэдэд интернэтийн зохистой хэрэглээг зохицуулах үүргийг ногдуулж, түүнийг төр засгаас дэмжих бодлогыг баримталсан. Мөн холбогдох засаг захиргаа, интернэттэй холбоотой бизнес эрхлэгчид, эцэг эхчүүд, асран хамгаалагчдад хүүхдийг хор хөнөөлтэй мэдээллээс хамгаалах арга хэмжээ авах (интернэтийн зохистой хэрэглээний талаар сурталчлах, боловсрол олгох, хүүхдийн хэрэглэж буй цахим төхөөрөмжид шүүлтүүр хэрэглэж буй эсэхэд хяналт тавих гм) үүрэг хариуцлагыг ногдуулах болсон байна.

Насанд хүрээгүй хүүхдийн асран хамгаалагч хортой мэдээллийг шүүгч үйлчилгээг ашиглахгүй гэсэн хүсэлт гаргаснаас бусад тохиолдолд цахим төхөөрөмж үйлдвэрлэгч, үйлчилгээ эрхлэгчдээс шүүгч програмыг ашиглахад хялбар байдлаар суурилуулж тухайн бүтээгдэхүүнийг борлуулах, үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй. Энэхүү үүргээ биелүүлээгүй тохиолдолд заавал биелүүлэхийг шаардах эрхтэй.

Хуульд зааснаар цахим орчин дахь хүүхдийн эрхийг хамгаалах бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг “Цахим орчинд насанд хүрээгүй хүмүүст аюулгүй мэдээллийн орчныг бүрдүүлэх хороо” хариуцахаар заасан байна.

Энэ хуулийн гол зорилго нь хүүхдэд сөргөөр нөлөөлөх мэдээллээс урьдчилан сэргийлэх, шүүгч Програм хангамжийг өргөн нэвтрүүлэх боломжийг бий болгох, ингэснээр хүүхдүүдийг цахим гэмт хэргийн золиос болохоос урьдчилан сэргийлэх ач холбогдолтой юм.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[464] Act on Punishment of Activities Relating to Child Prostitution and Child Pornography, and the Protection of Children https://antislaverylaw.ac.uk/wp-content/uploads/2019/08/Japan-Child-Prostitution-and-Child-Pornography-Law.pdf

[465] Act on Development of an Environment that Provides Safe and Secure Internet Use for Young People https://www8.cao.go.jp/youth/youth-harm/law/pdf/for_english.pdf

- **Зөвшөөрөлгүйгээр комьютерт нэвтрэх тухай хууль (Act on Prohibition of Unauthorized Computer Access)[466]**

Хуулийн зорилго нь харилцаа холбооны хэрэгслээр дамжуулан компьютертой холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, компьютерт зөвшөөрөлгүй нэвтрэх үйлдлийг хориглох, түүнд авах арга хэмжээ болон оногдуулах шийтгэл зэргээр харилцаа холбооны дэг журмыг сахин биелүүлэхэд оршино.

3 дугаар зүйл. Бусдын компьютерт зөвшөөрөлгүй нэвтрэх заалтыг зөрчсөн тохиолдолд гурван жил хүртэлх хугацаагаар хорих;

4 дүгээр зүйл. Хэрэглэгчийн таних кодыг зөвшөөрөлгүй авсан тохиолдолд нэг жил хүртэлх хугацаагаар хорих, эсхүл 500,000 иенээр торгох;

5 дугаар зүйл. Хэрэглэгчийн таних кодыг админ, эсхүл гуравдагч этгээдэд дамжуулсан тохиолдолд 300,00 иенээр торгох;

6 дугаар зүйл. Хууль бусаар олж авсан хэрэглэгчийн таних кодыг хадгалах;

7 дугаар зүйл. Администраторын дүр эсгэх;

(a) Хуурамч администратораас хэрэглэгчийг таних кодоо оруулахыг хүссэн вэбсайт үүсгэх;

(b) Хуурамч администратораас хэрэглэгчийг таних кодоо оруулахыг хүссэн цахим шуудан илгээсэн тохиолдолд нэг жил хүртэлх хугацаагаар хорих эсхүл 500,000 иений торгууль ногдуулна.

Хакердах – 3 жил хүртэл хугацаагаар хорих эсхүл 1,000,000 иений торгууль ногдуулна.

- **Кибер аюулгүй байдлын тухай хууль(The Basic Act on Cybersecurity)[467]**

Мэдээллийн чөлөөт урсгалыг хангах, кибер аюулгүй байдлыг хамгаалах энэхүү хуулийн зорилго нь кибер аюулгүй байдлын бодлого:

- Үндэсний кибер аюулгүй байдлын зарчмуудыг тусгах;
- Засгийн газар, орон нутгийн засаг захиргаа болон бусад холбогдох олон нийтийн байгууллагын үүрэг хариуцлагыг тодорхой болгох;
- Кибер аюулгүй байдлын стратегийг боловсруулж кибер аюулгүй байдалтай холбоотой бодлогод зайлшгүй шаардлагатай зүйлийг тодорхойлох;
- Мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт сүлжээ нийгэмлэг байгуулах тухай үндсэн хууль (2000 оны 144 тоот хууль)-ийн хамт кибер аюулгүй байдлын стратегийн төв штаб байгуулснаар ард түмний аюулгүй байдал, аюулгүй нийгэмд амьдрах боломжтой нөхцөлийг бүрдүүлэх, олон улсын энх тайван, аюулгүй байдал, үндэсний аюулгүй байдлыг хамгаалахад хувь нэмэр оруулахад оршино.

18 дугаар зүйл. Засгийн газар кибер гэмт хэргийг таслан зогсоох, хохирлоос урьдчилан сэргийлэх үүрэгтэй.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

466 Act on Prohibition of Unauthorized Computer Access http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail_main?re=01&vm=02&id=2250
467 The Basic Act on Cybersecurity http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?printID=&re=02&vm=02&id=2760&lvm=01

## 4.5 ГЕРМАН УЛС

### *I. Цахим орчин дахь гэмт хэргийн нөхцөл байдал*[468]

2020 онд Герман Улсад 108,474 кибер гэмт хэрэг бүртгэгдсэн нь 2019 оныхоос 7.9%-иар, 2015 оныхоос 2 дахин нэмэгдсэн байна. Хүүхэд залуучуудыг цахим орчин дахь хүчирхийллээс хамгаалах үйл ажиллагаа, хяналтыг явуулдаг Jungendschutz.net цахим хуудсанд бүртгэгдсэн 7513 зөрчлийн ангиллыг авч үзэхэд хүүхдийг садар самуунд уруу татах гэмт хэрэг 41%-ийг эзэлж байгаа бол улс төрийн хэт туйлшралтай холбоотой цахим гэмт хэрэг, порнографтай холбоотой, хүүхэд залууст хор хөнөөлтэй мэдээлэл зэрэг нь бусад хувийг эзэлж байна. Эдгээр цахимаар үйлдэгдсэн гэмт хэргийн 86% нь гадаадын серверээс ирсэн бөгөөд агуулгын тал орчим хувь нь платформ дээр илэрчээ. Ялангуяа Facebook (14%), YouTube (10%), Twitter (6%), Instagram (5%), Tumblr (4%) нар ихээхэн хувийг эзэлж байжээ. Хор хөнөөлтэй мэдээллийг устгах амжилтын хувь нь дотоодын сервер дээр 100%, гадаадын серверүүдийн хувьд 92% байна. Хугацааны хувьд Германд дунджаар 4,8 хоногийн хугацаанд устгадаг бол гадаадын серверүүд 7,8 хоногт устгадаг байна.

Европын Холбооноос жил бүрийн 10 сарыг “Кибер аюулгүй байдлын сар” (CyberSecMonth)[469] болгон зарлаж иргэд болон байгууллагад кибер аюулгүй байдлыг сурталчлах, сайн туршлагыг нэвтрүүлэх, хуваалцах замаар онлайн аюулгүй байдлын хамгийн сүүлийн үеийн мэдээллээр хангадаг байна. 2021 онд Кибер анхны тусламж, Гэртээ хэрхэн кибер аюулгүй байдлыг хангах вэ гэсэн сэдэвтэй байна.

### *II. Цахим орчин дахь гэмт хэргийн стратеги төлөвлөгөө*

Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор Герман Улсын Засгийн газар болон Эрүүгийн цагдаагийн газар, иргэний нийгэм, хувийн секторууд ба олон улсын байгууллагуудын хамтын ажиллагааны хэлбэрээр маш өргөн цар хүрээтэй санал санаачилгуудыг гарган, дэмжих бодлогыг баримтлан ажилладаг. Энэ хүрээнд хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжилтэнд хяналт тавих, бодлого хөтөлбөр боловсруулах, хүүхэд залууст мэдлэг олгох, цахим орчныг ашиглах боловсролыг дээшлүүлэх, мэдээ мэдээллээр хангах, цахим гэмт хэрэг, хүчирхийллээс хамгаалах арга хэрэгслийг нэвтрүүлэх зэрэг өргөн хүрээний цогц арга хэмжээг авч ирсэн байна. Тухайлбал:

- ***Кибер аюулгүй байдлын стратеги 2021***[470]

  Холбооны Засгийн газрын тогтоолоор 2011, 2016 онд кибер аюулгүй байдлын стратеги төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж ирсэн. Энэ удаагийн 2021 оны стратеги төлөвлөгөөнд:

  1. Төрийн байгууллага, бизнес, нийгэм, шинжлэх ухааны хамтын хариуцлагаар цахим аюулгүй байдлыг бүрдүүлэх;
  2. Төр, бизнес, шинжлэх ухаан, нийгмийн цахим халдашгүй байдлыг бэхжүүлэх;
  3. Цахим хөгжлийн аюулгүй байдлыг хангах;
  4. Хэмжигдэхүйц хийгээд ил тод болгох гэсэн 4 чиглэлийн дагуу хэрэгжүүлнэ.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

---

468 Children on the Internet https://www.jugendschutz.net/fileadmin/download/pdf/Report_2019_Children_on_the_Internet.pdf
469 European Cybersecurity Month 2021 https://www.nixu.com/
470 CyberSecurity Strategy for Germany 2021 https://www.bundesregierung.de/breg-en/news/new-cyber-security-strategy-1958688

- ***Райнландын 10 зүйлт хөтөлбөр*** (Rhineland's 10 Point Program)- Интернэтийн зохистой хэрэглээний талаарх мэдлэгийг дээшлүүлж, суурь мэдлэгтэй болгох замаар хүүхэд, залуучуудыг аюултай цахим агуулгаас хамгаалах зорилготойгоор боловсруулж 2007 оноос хэрэгжүүлсэн. Энэхүү хөтөлбөр нь Европын Холбооноос санхүүждэг Киксейф (Kicksafe) зэрэг хөтөлбөрүүдтэй хамтран ажилладаг.
- ***Киксейф хөтөлбөр*** (Kicksafe)- Мөн хүүхэд, залуучуудын интернэт болон цахим хүчирхийллийн талаарх ухамсар, мэдлэгийг дээшлүүлэх зорилготойгоор 2009 оноос хэрэгжүүлж эхэлсэн. Хөтөлбөр нь хүүхэд, залуучуудыг өөрийн “хүүхэд залуучуудын” цахим хуудсаар дамжуулан нэгтгэж, шинээр тулгамдаж буй асуудлуудыг танилцуулдаг. Энэ хөтөлбөрийн хүрээнд жил бүрийн 2 дугаар сарын 5-ны өдрийг Европын “*Илүү аюулгүй интернэтийн өдөр*” болгон тэмдэглэдэг ба засгийн газрын болон хувийн хэвшлийн олон байгууллагуудтай хамтран ажиллаж, интернэт орчны аюулгүй байдал ба цахим хүчирхийллийн талаарх мэдээллүүдээр хангадаг. Европын Холбооны хэмжээнд улс орон тус бүрийн онцлог асуудлыг хөндөн үзэх үүднээс тусгайлсан цахим сүлжээнүүдийг бий болгон ажиллуулдаг байна.
- ***Freiwillige Selbstkontrolle Multimedia-Diensteanbieter (FSM)*** буюу Сайн дурын өөрийгөө зохицуулах мультимедиа үйлчилгээ үзүүлэгчдийн ассоциаци нь хүүхэд залуучуудыг аюултай цахим агуулгаас хамгаалах зорилгоор 1997 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд хууль бус болон аюултай цахим агуулгын талаарх мэдээг шинжлэн үздэг (Hotline)-ыг ажиллуулдаг. FSM нь 1999 онд INHOPE нэртэй интернэтийн хотлайн ажиллуулагчдын Олон улсын ассоциацийг бусадтай хамтран үүсгэн байгуулсан ба энд ихэвчлэн Европт байрлах 20 гаруй интернэтийн хотлайн нэгдэн орсон байна. INHOPE нь интернэтийн аюулгүй байдлыг ханган ажилладаг Hotline ажиллах орчныг нөхцөлдүүлж, хамтран ажилладаг.
- ***Интернэт ба Дижитал Нийгмийн лавлах***- Дижитал ур чадвар, боловсролыг дээшлүүлэх чиглэлээр зөвлөгөө өгч, гарын авлагаар ханган ажилладаг. Энд бас муж улсын түвшинд үйл ажиллагаа явуулдаг “Medienpass NRW” хөтөлбөр (хэвлэл мэдээллийн сувгийн паспорт) зэргийг дурдаж болно.

### *III. Холбогдох байгууллагууд*

Цахим болон нийгмийн сүлжээн дэх аливаа гэмт хэрэг, халдлагаас ард иргэдийг хамгаалах үйл ажиллагааг Холбооны Хууль зүйн яам, Гэр бүлийн яам, Цагдаагийн байгууллага, Эрүүгийн цагдаагийн газар хариуцахаас гадна Гэр бүлийн яамны харьяа Хүүхэд, залуучуудад хортой мэдээллийн хяналтын холбооны зөвлөл (BPJM), Цахим орчин дахь хүүхэд, залуучуудыг хамгаалах комисс (KJM) зэрэг байгууллагууд хариуцан ажилладаг. Эдгээр төрийн захиргааны байгууллагууд нь Хүүхэд, залуучуудыг хамгаалах хууль, Нийгмийн сүлжээн дэх хүүхэд, залуучуудын хамгааллын тухай муж хоорондын гэрээ зэрэг эрх зүйн орчны хүрээнд үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын үйл ажиллагааг хянах, мэдээллийг индексжүүлэх, гомдол хүлээн авах, шийдвэрлэх, хүүхдийн цахим хүчирхийллийн эсрэг хөтөлбөр, үйл ажиллагаа хэрэгжүүлэх зэргээр хяналт тавьдаг.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

- ***Эрүүгийн цагдаагийн газар (Bundeskriminalamt)[471]***

  Эрүүгийн цагдаагийн газар нь улс төрийн зорилготой гэмт хэрэг, терроризм, хар тамхитай холбоотой гэмт хэрэг, цахим гэмт хэргийг хариуцан ажилладаг. Эрүүгийн цагдаагийн газрын харьяа Кибер гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс нь дотроо гэмт хэргийн талаар мэдээлэл цуглуулах төв, үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх төв, судалгааны төв, хүүхэд, өсвөр үеийнхний гэмт хэрэгтэй тэмцэх төв гэсэн нэгжүүдтэй байна.

- ***Холбооны Гэр бүлийн яам (Federal Ministry for Family Affairs)[472]***

  Цахим болон нийгмийн сүлжээн дэх хүчирхийллийн аливаа гэмт хэрэг, халдлагаас хүүхэд, залуу үеийг хамгаалах үйл ажиллагааг Холбооны гэр бүлийн яам хариуцахаас гадна тус яамны харьяа Хүүхэд, залуучуудад хортой мэдээллийн хяналтын холбооны зөвлөл (BPJM)[473], Цахим орчин дахь хүүхэд, залуучуудыг хамгаалах комисс (KJM)[474] газар зэрэг байгууллагууд хариуцан ажилладаг. Эдгээр төрийн захиргааны байгууллагууд нь Хүүхэд, залуучуудыг хамгаалах хууль, Нийгмийн сүлжээн дэх хүүхэд, залуучуудын хамгааллын тухай муж хоорондын гэрээ зэрэг эрх зүйн орчны хүрээнд үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын үйл ажиллагааг хянах, мэдээллийг индексжүүлэх, гомдол хүлээн авах, шийдвэрлэх, хүүхдийн цахим хүчирхийллийн эсрэг хөтөлбөр, үйл ажиллагаа хэрэгжүүлэх зэргээр хяналт тавьдаг. Мөн эдгээр нь Холбооны хууль зүйн яам, Германы цагдаагийн байгууллага, төрийн болон хувийн, олон нийтийн байгууллагуудтай нягт хамтран ажилладаг байна.

- ***Цахим орчин дахь хүүхэд, залуучуудыг хамгаалах комисс (The Commission for the Protection of Minors in the Media)[475]***

  Интернэтийн нэвтрүүлгийг байнга хянах төв захиргаа нь агуулга нийтлэн түгээгч нарыг залуучуудыг хамгаалах хууль эрх зүйд нийцүүлэн ажиллах явдлыг баталгаажуулдаг төрийн хэвлэл мэдээллийн зохицуулагч байгууллага юм. Тус Комисс нь хууль журам зөрчигдсөн эсэхийг тодорхойлж, удирдан чиглүүлэх арга хэмжээний шийдвэрийг гаргана. Тухайн нэг агуулгыг хориглох эсхүл торгууль ногдуулах гэхчлэн зөрчлийн хүнд, хөнгөн хэлбэрийн хэмжээнээс хамааран харилцан адилгүй янз бүрийн хуулийн хариуцлагыг ногдуулна. Үүнд, тухайн нийтлэл, агуулга түгээгчийн харьяа мужийн хэвлэл мэдээллийн захиргаа нь зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэгтэй.

- ***Телефон зөвлөгөө, үйлчилгээний төв (Nummer gegen Kummer)[476]***

  Хүүхэд сэтгэлийн дарамтад орох үедээ залгаж тусламж авах боломжтой “Хүүхэд, залуучуудад туслах шугам (“Nummer gegen Kummer”) буюу Телефон зөвлөгөө, үйлчилгээний төвийн 116 111 утасны дугаарыг ажиллуулдаг. Энд өдөрт дунджаар хоёр дуудлага тутмын нэг нь цахим хүчирхийлэлтэй холбоотой байдаг байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[471]Bundeskriminalamt https://www.bka.de/EN/Home/home_node.html
[472] Federal Ministry for Family Affairs https://www.bmfsfj.de/bmfsfj/meta/en
[473] BPJM https://www.bzkj.de/bzkj/meta/en
[474] The Commission for the Protection of Minors in the Media https://www.kjm-online.de/en/
[475] The Commission for the Protection of Minors in the Media https://www.kjm-online.de/en/
[476] Nummer gegen Kummer https://www.nummergegenkummer.de/

- ***jugendschutz.net*** [477] цахим хуудас нь мужийн захиргааны зорилго, зорилтоо хэрэгжүүлэхэд нь дэмжин тусалдаг бөгөөд интернэт агуулгыг хянаж, Залуучуудыг хамгаалах хууль зөрчсөн үйлдлийг тогтоон таньж, Комисст дараагийн арга хэмжээг авхуулахаар уламжилна.
- ***Хүүхэд, залуучуудад хортой мэдээллийн хяналтын холбооны зөвлөл (The Federal Review Board for Media Harmful to Minors)*** [478] нь онлайн агуулгыг залуучуудад аюултай эсэхийг шийдэх үүрэг хүлээнэ. Зөвлөл нь бусад захиргааны байгууллагуудын албан хүсэлтээр үйл ажиллагаагаа явуулах ба "индекс жагсаалтад" URLs-уудыг оруулна. Үүнээс гадна Холбооны хянан шалгах зөвлөл нь интернэт орчинд хүүхэд, залуусыг найдвартай хамгаалахад учирч болзошгүй гэмт үйлдлүүдэд хариу арга хэмжээ авах албан ёсны эрх үүрэгтэй зөвлөл юм.

***IV. Хууль эрх зүйн орчин***

Тус улсын хууль эрх зүйд заасан цахим орчинд үйлдэгдэж байгаа гэмт хэргүүд нь Будапештийн конвенцтой тэр бүр шууд холбогддоггүй учраас Германд тэрхүү конвенцын бодит чадамжийг цахим гэмт хэргийг явцуу хүрээгээр авч үздэг гэж дүгнэжээ. Цахим орчин дахь гэмт хэргийг Эрүүгийн хууль болон Нийгмийн сүлжээн дэх хуулийн хэрэгжилтийг хангах тухай хууль, Теле мэдээллийн тухай хуулиар нийтлэг зохицуулдаг байна. Үүнээс гадна цахим сүлжээн дэх хүүхэд хамгааллын асуудлыг "Залуучуудыг хамгаалах тухай хууль" (JuSchG)[479] нь CD зэрэг биет мэдээллийг нийтэд түгээх асуудлыг зохицуулж, чухам алийг хүүхэд, залуучуудад хортой мэдээллийн жагсаалтад оруулахыг тодорхойлно. Мужийн түвшинд (Länder level) "Нийгмийн сүлжээн дэх хүүхэд, залуучуудын хамгааллын тухай муж хоорондын гэрээ"[480] (JMStV) нь интернэт болон өргөн нэвтрүүлэгт хэрэглэгддэг цорын ганц хууль эрх зүйн үндэс юм.

- **Германы Эрүүгийн хууль (Criminal Code)**[481]

Герман Улс бусад орнуудын нэгэн адилаар цахим орчин дахь гэмт хэргийг шийдвэрлэхэд Эрүүгийн хуулийн заалтуудыг хэрэглэж байна. Тухайлбал, Хууль бус суртал ухуулгын материал тараах буюу Үндсэн хуульд харшилсан байгууллагын тэмдэглэгээг ашиглах, төрийн эсрэг онц хүнд гэмт хэрэг үйлдэхийг дэмжих, хууран мэхлэх гэмт хэрэг үйлдэхийг завдах, олон нийтийг гэмт хэрэгт уриалах, мөн үзэн ядахыг өөгшүүлэх болон бусад гэмт үйлдлийн тохиолдлуудад дараах Эрүүгийн хуулийн зүйл заалтуудыг хэрэглэн шийдвэрлэнэ. Үүнд:

Эрүүгийн хуулийн 202 дугаар хэсэг (a) Нэвтрэхийг хориглосон хамгаалагдсан өгөгдөлд хууль бусаар нэвтэрсэн тохиолдолд 3 жил хүртэлх хугацаагаар хорих эсхүл торгууль ноогдуулна (b)Phishing хийсэн тохиолдолд 2 жил хүртэлх хугацаагаар хорих эсхүл торгууль ноогдуулна. 263 дугаар хэсэг (компьютерийн залилан)- 5 жил хүртэлх хугацаагаар хорих эсхүл торгууль ноогдуулна. 269 дүгээр хэсэг (техникийн бүртгэлийг хуурамчаар үйлдэх), 238 дугаар хэсэг (бусдыг хууль бусаар мөшгих), 240 дүгээр хэсэг (бусдыг заналхийлэх, хүч

[477] Jugendschutz.net _ https://www.jugendschutz.net/en/index.html
[478] The Federal Review Board for Media Harmful to Minors https://www.bzkj.de/bzkj/Service/english.html
[479] German Law Archive https://germanlawarchive.iuscomp.org/?p=724
[480] Interstate Treaty on the Protection of minors https://www.kjm-online.de/
[481] Criminal Code (Strafgesetzbuch, StGB) https://germanlawarchive.iuscomp.org/?p=752

UIH.MN СУДАЛГААНЫ САН

хэрэглэх хэлбэрээр үйл үйлдүүлэх, зовоох эсхүл эс үйлдүүлэх), 241 дүгээр хэсэг (гэмт хэрэг үйлдэхээр сүрдүүлэх), 176 дугаар зүйл (хүүхдийг хүчирхийлэх), 185 дугаар хэсэг (гутаан доромжлох), 186 дугаар хэсэг (гүтгэх), 187 дугаар хэсэг (санаатайгаар гүтгэх), 201 дүгээр хэсэг (үг ярианы хувийн нууцыг алдагдуулан зөрчих), 201а хэсэг (хувийн нууцыг зураг авч зөрчих) ба Үзүүлэх урлагийн бүтээл, фото зургийн зохиогчийн эрхтэй холбоотой хуулийн 33 дугаар хэсэг зэрэг багтана. Эрүүгийн хуулийн 238 дугаар хэсэгт (хууль бусаар мөшгих) теле харилцааны арга зам (1-р догол мөрийн 2 дугаарт) эсхүл хэн нэгний хувийн мэдээллийг ашиглах (1-р догол мөрний 3 дугаарт) зэргийг маш тодорхой заасан байдаг. Хүүхдийн хүчирхийллийг заасан 176 дугаар хэсэгт ч мөн адил теле харилцааны арга хэлбэрийг тодорхой хамруулан заасан (4-р догол мөрний 3 ба 4 дүгээрт).

- **Нийгмийн сүлжээн дэх хуулийн хэрэгжилтийг хангах тухай хууль (Network Enforcement Act)[482]**

2017 оны 6 дугаар сараас хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн “Нийгмийн сүлжээн дэх хуулийн хэрэгжилтийг хангах тухай хууль”[483] нь Эрүүгийн хуулийн хүчин төгөлдөр үйлчилж буй заалтуудыг нийгмийн сүлжээний онцгой орчинд хэрэгжүүлэх, нийгмийн сүлжээ эрхлэгчдэд гомдол хүлээн авч барагдуулах үр өгөөжтэй, ил тод менежментийг нэвтрүүлэх үүргийг хүлээлгэх, нийгмийн сүлжээ эрхлэгчид, төрийн захиргааны байгууллагуудын мэдэгдэл, шүүхийн зарлан дуудах, шүүхийн шийдвэр хүлээн авах, тэдгээртэй харилцах түншийг нэр заан томилох зэргийг зохицуулна.

Нийгмийн сүлжээнд хуулийн хэрэгжилтийг хангах тухай хууль нь нийгмийн сүлжээ эрхлэгчдэд зориулсан хууль бөгөөд 2 саяас илүү бүртгэлтэй хэрэглэгч бүхий нийгмийн цахим сүлжээ бүрийг санал гомдлыг үр дүнтэй барагдуулах менежменттэй байхыг шаарддаг ба тодорхой цаг, хүрээнд Эрүүгийн хуулийн тодорхой зүйл заалтуудыг зөрчсөн хууль бус агуулгыг мэдэгдсэн даруйд нь устгах эсхүл хаах үүргийг хүлээнэ. Харин хувиараа нийгмийн сүлжээ хэрэглэгчдэд үйлчлэхгүй.

Хуулиар нийгмийн сүлжээ эрхлэгчдэд шийдвэр гаргах тодорхой хугацааны хязгаарыг зааж өгсөн. Мөн нийгмийн сүлжээ эрхлэгчдээс хэрэглэгчдийн гомдлыг хүлээн авч барагдуулах хандалтын аливаа саадгүй, ойлгомжтой, ил тод аргачлалыг нэвтрүүлэхийг шаарддаг учраас үйлчилгээ эрхлэгчид тэдний платформ дээр Германы эрүүгийн хууль зөрчсөн байж болзошгүй агуулгын талаар мэдээлэл өгөхөд ашиглах ойлгомжтой, хялбар боломжийг хэрэглэгчдэд олгох ёстой. Нийгмийн сүлжээ эрхлэгчид эдгээр мэдээллийг хүлээн авмагц нэн даруй хуулиар тогтоосон хугацаанд багтаан боловсруулж гаргасан шийдвэрээ танилцуулах ёстой.

Хэрвээ нийгмийн сүлжээ эрхлэгчид хуулиар ногдуулсан үүрэг болох гомдол хүлээн авч барагдуулах менежментийг нэвтрүүлээгүй, хугацаа хэтрүүлсэн, эсвэл Германы эрүүгин хуулийн зохих заалтуудын дагуу агуулгыг устгах, хаах үүргээ үл тоомсорлосон бол 5 сая хүртэлх еврогийн мөнгөн торгууль төлөх, онц ноцтой тохиолдолд 50 сая хүртэлх еврогийн торгууль төлөх юм.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[482] Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх зааг хязгаар. Фрейдрих Эбертийн сан. 2018 он. http://library.fes.de/pdf-files/bueros/mongolei/14077.pdf

[483] Network Enforcement Act https://germanlawarchive.iuscomp.org/?p=1245

Нийгмийн сүлжээ эрхлэгчид хууль зүй, төрийн захиргааны байгууллагууд болон иргэдийн зүгээс агуулгын болон бусад асуудлаар хандаж байх байнгын түншийг нэр заан томилох үүргийг хүлээнэ. Тухайн түншид хандсан асуултад 48 цагийн дотор хариу өгөх ба хугацаа хэтрүүлсэн тохиолдолд мөнгөн торгууль ногдуулна.

Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, мөнгөн торгууль ногдуулах, нийгмийн сүлжээ эрхлэгчдийн талаар иргэдийн гаргасан гомдлыг Холбооны Хууль зүй, Хэрэглэгчдийн эрхийг хамгаалах яамны харьяа Холбооны хууль зүйн газар хариуцна.

Энэхүү хууль батлагдсантай холбоотойгоор **Теле мэдээллийн хэрэгслийн тухай хуульд** өөрчлөлт оруулж (интернэтийг зохицуулах суурь хууль) онц ноцтой тохиолдолд нийгмийн сүлжээ эрхлэгчдэд хууль зөрчсөн агуулгын зохиогчийн мэдээллийг ил болгох үүргийг ногдуулах эрхийг шүүхэд олгосон. Тухайлбал, доромжлуулсан иргэн зохиогчийг иргэний шүүхэд өгч болно. Ингэснээр доромжлолд өртсөн хүн нийгмийн сүлжээнд тухайн иргэнийг доромжилсон, гүтгэсэн агуулга нийтлүүлсний нь төлөө зохиогчоос хохирлын мөнгө төлүүлэх боломж бүрдсэн байна.

Мөн Нийгмийн сүлжээнд хуулийн хэрэгжилтийг хангах тухай хууль ёсоор нийгмийн сүлжээ эрхлэгч компаниуд хагас жил тутамд тайлан гаргах ёстой байдаг байна. Тус хуулийн үндсэн ач холбогдол нь зөвхөн иргэд болон байгууллагууд, төрийн захиргааны байгууллагуудын зүгээс мэдээлэл ирсэн тохиолдолд уг мэдээллийг үндэслэн тухайн агуулгын мөн чанар, түүнтэй холбоотойгоор тухайн агуулгыг устгах, хаах тухай шийдвэрийг эхлээд нийгмийн сүлжээ эрхлэгчид гаргадагт оршино. Тийм учраас энэ хууль нь нийгмийн цахим сүлжээнд эрүүл зөв орчныг бүрэлдүүлэх, цахим дарамт шахалт болон онлайн хүчирхийллийг зогсооход чухал хувь нэмэртэй байгаа ажээ. (*энэ хууль батлагдсанаар Фэйсбүүк компани гэхэд л Герман улсад өөрийн гэсэн 2 контент устгалын төвийг байгуулаад байгаа ба тэр нь 1200 ажилтантайгаар хяналт шалгалтын үйл ажиллагааг 24 цагаар явуулж байна. Хэрэв тус контент устгалын төв Герман Улсын нутаг дэвсгэр дээрх Фэйсбүүкийн хэрэглээ, контентод байнгын хараа хяналт тавих ба ямар нэгэн зөрчилтэй контент илэрвэл түүнийг нь 24 цагийн дотор устгах үүрэгтэй.*)

Хүүхэд, залуучуудад аюултай агуулга гэдэгт жишээлбэл насанд хүрэгчдийн порно эсхүл “Хүүхэд, залуучуудад хор хөнөөлтэй мэдээлэл” гэх жагсаалтад (индекс жагсаалт) орсон агуулгуудыг тооцох ба эдгээрийг зөвхөн насанд хүрэгчдэд л үзүүлж болно. Энэ агуулгад хүүхэд, залуучууд нэвтрэх явдлыг хаах үүднээс цахим сүлжээгээр хангагч нар шаардлага хангахуйц түвшний “нас тогтоох системийг” (age verification system)-ийг нэвтрүүлэн ашиглах ёстой. Мөн маш их бухимдал, айдсыг төрүүлэхүйц *хортой агуулгад* нэвтрэх хязгаарлалтыг үзэхэд мөн тодорхой хязгаарлалтыг хийх шаардлагыг цахим сүлжээ эрхлэгчдэд тавина. Үүний тулд KJM-ээс хүлээн зөвшөөрсөн нэвтрэх техникийн хамгаалалтын арга хэмжээнүүдийг (technical protection measures) авч хэрэгжүүлнэ. Мөн телевизороор хязгаарлалт тогтоосон зэрэглэлийн дагуу цацаж болно (жишээлэхэд,16 дугаар зэрэглэлийн агуулгыг 22 цагаас хойш үзүүлэх гэх мэт).

Зар сурталчилгаатай холбоотой тусгай журмууд бий: зар сурталчилгаа түгээгчид хүүхэд багачуудын гэнэн, туршлагагүй байдлыг ашиглан ямар нэг бүтээгдэхүүн, эсхүл үйлчилгээг худалдан авахыг шууд хандан сурталчилж болохгүй.



UIH.MN СУДАЛГААНЫ САН

Энэ мэтчилэн дээрх хуулийн олон салбар хүрээ нь цахим дарамт шахалт ба цахим хүчирхийллээс урьдчилан сэргийлэхтэй холбогдож байдаг. Эрүүгийн хууль болон эдгээр хуулиас гадна Иргэний хууль (нөхөн төлбөр, арилгах ба хориглох), Хөдөлмөрийн хууль (сануулах хуудас), Цагдаагийн хууль ба Үйлчилгээ үзүүлэгчдийн журам зэргийг багтаасан захиргааны хууль зэрэгт холбогдох зүйл заалтууд бий. Тухайлбал, **Иргэний хуулийн** хүчирхийлэл ба мөшгөх үйлдлээс урьдчилан сэргийлэх заалтууд нь шүүхэд цаашдын урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах үндэслэл болдог байна.

## 4.6 ИХ БРИТАНИ, УМАРД ИРЛАНДЫН НЭГДСЭН ХААНТ УЛС

### *I. Цахим орчин дахь гэмт хэргийн нөхцөл байдал*

ИБУИНХУ-д цахим гэмт хэрэг нь цар хүрээ нь нэмэгдэж, хувь хүмүүсийг эрүүл мэнд болон эдийн засгийн хувьд хохироох, аюул, эрсдэлд оруулахаас эхлээд улс орны нийгэм, эдийн засгийн чухал суурь дэд бүтэц, зайлшгүй шаардлагатай төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагааг тасалдуулах, доголдуулах, цаашлаад үндэсний аюулгүй байдалд заналхийлэх хэмжээний хэргүүд цахимаар үйлдэгдэж, тооцож баршгүй хохирол учруулдаг байна. Хувь хүн болон байгууллагууд нь аюулгүй байдлаа хангаагүйн улмаас цахим гэмт хэрэг үйлдэгсдийн өгөөш болсоор байна. Гэмт хэрэгтнүүд нууц үг, баримт мэдээлэл зэргийг хулгайлж гэмт хэрэгтээ ашиглахаас гадна банкны данснаас шууд мөнгө хулгайлах зэргийг цахимаар үйлдэж байна. Цахимаар хамгийн их үйлдэгдэж буй гэмт хэргийн төрлүүдэд:

- Нийгмийн сүлжээ болон цахим шуудангийн нууц үг ашиглан хакердах
- Хуурамч цахим шуудан ашиглан аюулгүй байдлын мэдээлэл, хувийн мэдээлэл авах (phishing)
- Хортой Програм хангамж-гэмт хэрэгтнүүд файлуудыг хулгайлж компьютерийн систем болон сүлжээнд халдах (malicious software)
- Мөнгө хулгайлах зорилгоор цахим хуудас руу халдах ингэхдээ тухайн цахим хуудасны сүлжээ болон серверийг хэт их ачааллах замаар үйлдэх (Distributed denial of service) зэрэг ордог байна.

### *II. Цахим орчин дахь гэмт хэргийн стратеги төлөвлөгөө*

Тус улс нь 5 жил тутам “Үндэсний Цахим Аюулгүй байдлын Стратеги” (National Cyber Security Strategy)-ийг шинэчлэн боловсруулж, баталдаг байна.[484] Тус стратеги нь ИБУИНХУ-ын цахим орчны аюулгүй байдлыг дотооддоо болон гадаад орчинд хамгаалахад Засгийн газраас авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө юм. 2016-2021 онд цахим орчны аюулгүй байдлыг хамгаалах Хэрэгжилтийн төлөвлөгөө нь (Implementation plan):

- **Хамгаалах**
    - Идэвхтэй цахим хамгаалалтыг бий болгох;
    - Илүү найдвартай интернэт холбоо харилцааг бий болгох;
    - Засгийн газрыг хамгаалах;

[484] https://assets.publishing.service.gov.uk/government/uploads/system/uploads/attachment_data/file/567242/national_cyber_security_strategy_2016.pdf

UIH.MN СУДАЛГААНЫ САН

    - Үндэсний чухал дэд бүтцийн байгууламжууд болон бусад тэргүүлэх салбаруудаа хамгаалах;
    - Олон нийтийн болон бизнес эрхлэгчдийн хандлагыг өөрчлөх;
    - Гэмт хэргийг шийдвэрлэх, цахим аюулын талаарх ойлголтыг нэмэгдүүлэх.
- **Урьдчилан сэргийлэх**
    - Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаан дахь цахим орчны үүрэг;
    - Цахим гэмт хэргийг бууруулах;
    - Бусад улс орны цахим гэмт хэрэгтнүүдтэй тэмцэх;
    - Терроризмоос урьдчилан сэргийлэх;
    - Цахим хариу арга хэмжээний чадавхыг нэмэгдүүлэх;
    - Криптографыг нэмэгдүүлэх.
- **Хөгжүүлэх**
    - Цахим аюулгүй байдлыг хамгаалах ур чадварыг бэхжүүлэх;
    - Цахим аюулгүй байдлын салбарыг өргөжүүлэх;
    - Цахим аюулгүй байдлын салбар дахь шинжлэх ухаан, технологийн дэвшлийг дэмжих зэрэг 3 цогц үйл ажиллагаанаас бүрдэж байна.

***III.Цахим гэмт хэрэгтэй тэмцэх байгууллагууд***

Үндэсний Гэмт хэрэгтэй тэмцэх агентлаг (National Crime Agency)[485] нь үндэсний хэмжээнд цахим болон бусад төрлийн гэмт хэрэгтэй тэмцдэг байна.

Цахим гэмт хэрэг нь дэлхий нийтийг хамарсан аюул болоод байгаа учир олон улсын байгууллагууд, улс орнууд хоорондын хамтын ажиллагаа зайлшгүй шаардлагатай байна. Тус улсын Үндэсний Гэмт хэрэгтэй тэмцэх агентлаг нь ИБУИНХУ-ын Цагдаагийн газар, бүсийн зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх нэгжүүд, олон улсын хууль сахиулах байгууллагууд, тухайлбал, Европын Холбооны Мөрдөх товчоо, АНУ-ын Тагнуулын алба зэрэгтэй мэдээ мэдээллээ хуваалцан хамтарч ажиллахын зэрэгцээ хувийн хэвшлийнхэнтэй техникийн туршлагаа хуваалцан, үр дүнтэйгээр хамтран ажилладаг байна.

Түүнчлэн иргэд, олон нийт, бизнес эрхлэгчдийг цахим халдлагаас урьдчилан сэргийлэх зорилгоор төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтарч ажилладаг. Үүнд: Үндэсний Цахим Аюулгүй байдлын төв (National Cyber Security Centre)[486], тус төвийн харьяа зөвлөгөө өгөх төв, Аюулгүй интернэт хэрэглээний талаар мэргэжилтний зөвлөгөө өгөх төв (Get Safe Online Free expert advice)[487] зэрэг олон байгууллагууд багтана.

Үндэсний гэмт хэрэгтэй тэмцэх агентлаг нь цахим орчинд гэмт хэрэг үйлдэгч өсвөр насныхан болон залуучуудыг цахим хэрэгтэн болохоос сэргийлж, тэдгээрийн цахим орчинд ажиллах ур чадварыг зөвөөр ашиглах, хаана ажиллах боломжтой талаар зөвлөгөө мэдээлэл өгөх зорилгоор тэдэнтэй болон эцэг эхтэй нь уулзаж ярилцах, гэмт хэргээс холдуулах шат дараатай арга хэмжээг авах Цахим сонголт (CyberChoices) аяныг зохион байгуулдаг байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[485] https://www.nationalcrimeagency.gov.uk/what-we-do/crime-threats/cyber-crime
[486] https://www.ncsc.gov.uk/
[487] https://www.getsafeonline.org/

*IV. Хууль эрх зүйн орчин*

**Компьютерийн зүй бус хэрэглээний тухай хууль** (Computer Misuse Act 1990)[488], **Харилцаа холбооны тухай хууль** (Communications Act 2003)[489], **Хор нөлөөтэй харилцаа холбооны тухай хууль** (Malicious Communications Act 1988)[490], **Дижитал Эдийн засгийн тухай хууль** (Digital Economy Act 2017)[491], **Айлган сүрдүүлэхээс хамгаалах тухай хууль** (Protection from Harassment Act 1997)[492], **Гэмт хэрэгтэнд хариуцлага тооцох ба нийтийн хэв журмыг сахиулах тухай хууль** (Criminal Justice and Public Order Act 1994)[493] болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулж байна.

Хэн нэгний нийгмийн сүлжээ болон цахим шуудангийн хаягны нууц үгийг хулгайлан дээрэлхэх, доромжлох гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд **Компьютерийн зүй бус хэрэглээний тухай** хуулиар шийдвэрлэнэ.

Бүдүүлгээр доромжилсон, зохисгүй, садар самуун болон сүрдүүлсэн, заналхийлсэн цахим зурвас илгээх нь **Харилцаа холбооны тухай** хуулийн 127-р хэсэгт заасны дагуу гэмт хэрэгт тооцогдоно.

Аливаа холбоо, харилцааны хэрэгсэл ашиглан хүнийг айлган сүрдүүлж, айдас түгшүүрт автуулах, сэтгэл санааны гутралд оруулах гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд **Хор нөлөөтэй харилцаа холбооны тухай** хуулиар шийдвэрлэдэг байна.

**Дижитал Эдийн засгийн тухай хууль** (Digital Economy Act 2017)-ийн 103-р хэсэгт зааснаар засгийн газар нь нийгмийн сүлжээний үйлчилгээ үзүүлэгчдэд зориулж, нийгмийн сүлжээгээр зүй бус, гэмт хэргийн шинжтэй дээрэлхсэн, доромжилсон, айлган сүрдүүлсэн утга агуулга бүхий материалыг нийтлэх, түгээхийг хориглох, холбогдох байгууллагад мэдэгдэх тухай гарын авлага боловсруулан, хэрэгжүүлж ажиллахыг хуульчилсан байна.

Мөшгих (stalking) болон цахимаар мөшгих (cyberstalking) хэргийг **Айлган сүрдүүлэхээс хамгаалах тухай** хуулийн 2А хэсгээр зохицуулна. Энэ хуулиар мөшгих гэмт хэргийн хохирогчийг хамгаалахаар заасан хэдий ч цахим халдлагын хохирогчийг давхар хамгаалдаг байна.

Тус хуулиар мөшгинө гэдэгт хэн нэгнээс салахгүй, байнгын хойноос нь даган, айдаст автуулах үйлдлийг хэлнэ гэжээ. Тодорхой хохирогчтой байнга, тогтмол холбоо барих, холбоо барих оролдлогууд тасралтгүй хийх үйлдлийг мөшгих гэнэ. Мөшгих болон цахимаар мөшгих гэмт хэрэг нь хохирогчийг байнга айлган сүрдүүлж, сэтгэл санаа болон бие махбодын хохирол учруулдаг тул хохирлын хэмжээ болон гэмт үйлдлээс хамааран 6 сараас 5 жил хүртэл хугацаанд хорих ялаар шийтгэхээр хуульчилсан байна.

Цахим гэмт хэргийн хохирогчдын дийлэнх хэсгийг хүүхэд, өсвөр насныхан эзэлж байна. Хүүхэд нь насанд хүрсэн гэмт хэрэгтнүүдийн золиос болохоос гадна үе тэнгийн хүүхдүүдийн доромжилсон, айлган сүрдүүлсэн зүй бус үйлдлийн золиос болдог байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[488] https://www.legislation.gov.uk/ukpga/1990/18/contents
[489] https://www.legislation.gov.uk/ukpga/2003/21/contents
[490] https://www.legislation.gov.uk/ukpga/1988/27
[491] https://www.legislation.gov.uk/ukpga/2017/30/contents/enacted
[492] https://www.legislation.gov.uk/ukpga/1997/40/contents
[493] https://www.legislation.gov.uk/ukpga/1994/33/contents

**Боловсрол болон хяналт шалгалтын тухай** хуулиар сургуулийн удирдлагад сургууль, сургалтын байгууллагын эргэн тойронд суралцагч хүүхдүүд болон багш сурган хүмүүжүүлэгчдэд эрүүл, аюулгүй орчин бүрдүүлж ажиллахыг үүрэг болгосон байна. Түүнчлэн энэ хуулиар бусад сурагчдыг дээрэлхэх, доромжлох, айлган сүрдүүлэх үйлдэл байнга үзүүлж буй сурагчдыг хүмүүжүүлэх, сахилга бат сахиулах тодорхой эрхийг (тухайлбал, үүрэн телефоны утсыг хураан авах зэрэг) багш, сурган хүмүүжүүлэгчдэд олгосон бөгөөд хүчирхийлэл үйлдэгч хүүхдүүд болон тэдгээрийн эцэг, эхчүүдэд хүчирхийлэл нь тэвчиж болшгүй гэмт үйлдэл болохыг ойлгуулж, үүнийг таслан зогсоохын тулд удаа дараа хүчирхийлэл үйлдэгч хүүхдийн эцэг, эхийг шүүхийн шийдвэрээр хүүхдээ хүмүүжүүлэх албадан сургалтанд хамруулах, цаашлаад 1000 хүртэлх фунт стерлингийн торгууль ногдуулах хүртэл арга хэмжээ авахаар хуульчилсан байна.

Хүүхдийг цахимаар садар самуунд уруу татах, хулгайлах, хүчирхийлэх, бэлгийн мөлжлөгийн золиос болохоос урьдчилан сэргийлэх зорилгоор төрийн болон төрийн бус байгууллагууд нэгдэн үйл ажиллагаагаа явуулдаг байна. Засгийн газар, хууль сахиулагчид, эрдэм шинжилгээний байгууллагууд, аж ахуйн нэгжүүд, болон эцэг эхчүүдийн төлөөллөөс бүрдсэн ИБУИНХУ-ын **Хүүхдийн цахим орчны аюулгүй байдлыг хангах зөвлөл** (UK Council for Child Internet Safety)[494] нь хүүхэд, залуусын цахим орчны аюулгүй байдлыг хангахын төлөө үйл ажиллагаа явуулдаг байна.

Үндэсний Гэмт хэрэгтэй тэмцэх агентлагийн харьяа **Хүүхдийн мөлжлөг ба Онлайн хамгааллын төв** (Child Exploitation and Online Protection Center)[495] нь хүүхэд багачуудыг гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлж, эцэг, эхчүүд, багш, сурган хүмүүжүүлэгчид болон хүүхдүүдэд зориулсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, таслан зогсоох төрөл бүрийн зөвлөгөө мэдээллийг багтаасан ThinkUKnow[496] цахим хуудсыг ажиллуулдаг.

**Хүүхдэд харгис хэрцгий хандахаас урьдчилан сэргийлэх үндэсний нийгэмлэг** (National Society for the Prevention of Cruelty to Children) нь хүүхдийн хүчирхийллийг таслан зогсоохын төлөө тэмцэгч, сайн дурын тэргүүлэгч байгууллага юм. Тус байгууллага нь хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдэд туслах, аюулд өртөж болзошгүй хүүхдүүдийг хамгаалах, хүчирхийлэл үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байна. Тус байгууллага нь 1883 онд үйл ажиллагаагаа эхлүүлж байжээ.

**Хүүхэд хамгааллын тухай хууль** (Protection of Children Act 1978)[497], **Бэлгийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль** (Sexual Offences Act 2003)[498] болон холбогдох бусад хуулиар хүүхдийг бэлгийн мөлжлөгийн золиос болохоос урьдчилан сэргийлэх, энэ төрлийн гэмт хэргийг таслан зогсоох, гэмт хэрэгтэнд хариуцлага ногдуулах зэрэг харилцааг зохицуулдаг байна. Эдгээр хуулиудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд засгийн газрын харьяа Боловсролын газар (Department for Education) нь “Хүүхдийн аюулгүй сурах орчныг бүрдүүлэх” удирдамжийг боловсруулан, сургалтын байгууллага болон эцэг, эхчүүдэд мөрдүүлэн ажиллаж байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[494] https://www.gov.uk/government/groups/uk-council-for-child-internet-safety-ukccis
[495] https://www.ceop.police.uk/Safety-Centre/
[496] https://www.thinkuknow.co.uk/
[497] https://www.legislation.gov.uk/ukpga/1978/37
[498] https://www.legislation.gov.uk/ukpga/2003/42/contents

## ХАВСРАЛТ

**Хавсралт 1. Кибер аюулгүй байдлын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй олон улсын байгууллагууд[499]**

| Байгууллагын нэр | Холбоос | Хамрах хүрээ |
|---|---|---|
| United Nations Internet Governance Forum | https://www.intgovforum.org/multilingual/ | Global |
| United States National Cyber security and Communications Integration Center (NCCIC) | https://www.cisa.gov/about-cisa | National, Global |
| Messaging and Anti Abuse Working Group (MAAWG) | www.maawg.org | Global |
| Anti-Abuse Working Group | www.ripe.net | Global |
| Forum for Incident Response Security Teams (FIRST) | www.firest.org | Global |
| Asia Pacific Computer Emergency Response Team (AP CERT) | www.apcert.org | Regional |
| Network Operators Groups (NOGs) | https://en.wikipedia.org/wiki/Internet_network_operators%27_group | Global |
| Asia Pacific Economic Cooperation (APEC) | www.apec.org | Regional |
| ICANN Security and Stability Working Group | www.icann.org | Global |
| Cooperative Cyber Defense and Center of Excellence (CCDCOE) | www.ccdcoe.org | Regional, Global |
| Council of Europe; Convention on Cybercrime | www.conventions.coe.int | Global |
| INTERPOL | Interpolnyc.com | Global |
| Internet Society (ISOC) | www.internetsociety.org | Global |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

[499] https://www.itic.org/dotAsset/c/c/cc91d83a-e8a9-40ac-8d75-0f544ba41a71.pdf

**Хавсралт 2. Будапештийн конвенцод нэгдэн орсон орнууд[500]**
(2020 оны 6 сарын байдлаар)

| Конвенцод нэгдэн орсон улсууд | |
|---|---|
| Andorra | Latvia |
| Argentina | Liechtenstein |
| Armenia | Lithuania |
| Australia | Luxembourg |
| Austria | Malta |
| Azerbaijan | Mauritius |
| Belgium | Republic of Moldova |
| Bosnia and Herzegovina | Monaco |
| Bulgaria | Montenegro |
| Cabo Verde | Morocco |
| Canada | Netherlands |
| Chile | North Macedonia |
| Colombia | Norway |
| Costa Rica | Panama |
| Croatia | Paraguay |
| Cyprus | Peru |
| Czech Republic | Philippines |
| Denmark | Poland |
| Dominican Republic | Portugal |
| Estonia | Romania |
| Finland | San Marino |
| France | Senegal |
| Georgia | Serbia Slovak |
| Germany | Republic Slovenia |
| Ghana | Spain |
| Greece | Sri Lanka |
| Hungary | Switzerland |
| Iceland | Tonga |
| Israel | Turkey |
| Italy | Ukraine |
| Japan | United Kingdom |
| | United States of America |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

[500] https://rm.coe.int/t-cy-2020-16-bc-benefits-rep-provisional/16809ef6ac#:~:text=The%20Budapest%20Convention%20requires%20States,cybercrime%20but%20any%20offence%20where

**Хавсралт 3. Будапештийн Кибер гэмт хэрэгтэй тэмцэх тухай конвенцын бүтэц**

| Бие даасан хууль | Нотлох баримт, мөрдөн байцаахтай холбоотой процедурын хууль | Олон улсын хамтын ажиллагаа |
|---|---|---|
| Art. 2 – Illegal access<br>Art. 3 – Illegal interception<br>Art. 4 – Data interference<br>Art. 5 – System interference<br>Art. 6 – Misuse of devices<br>Art. 7 – Computer-related forgery<br>Art. 8 – Computer-related fraud<br>Art. 9 – Child pornography<br>Art. 10 – IPR offences Art. 11 – Attempt, aiding, abetting<br>Art. 12 – Corporate liability | Art. 14 – Scope of procedural provisions<br>Art. 15 – Conditions and safeguards<br>Art. 16 – Expedited preservation<br>Art. 17 – Expedited preservation and partial disclosure of traffic data<br>Art. 18 – Production order<br>Art. 19 – Search and seizure Art. 20 – Real-time collection traffic data<br>Art. 21 – Interception of content data | Art. 23 – General principles<br>Art. 24 – Extradition<br>Art. 25 – General rules<br>Art. 26 – Spontaneous information<br>Art. 27 – MLA in absence of treaty<br>Art. 28 – Confidentiality Art. 29 – Expedited preservation<br>Art. 30 – Partial disclosure traffic data<br>Art. 31 – MLA accessing data<br>Art. 32 – Transborder access Art. 33 – MLA collection traffic data<br>Art. 34 – MLA interception content<br>Art. 35 – 24/7 point of contact |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

## Хавсралт 4. Малайз Улсын кибер гэмт хэрэг, кибер аюулгүй байдлын холбогдох хуулиуд



**АШИГЛАСАН МАТЕРИАЛ**


- Мэдээллийн аюулгүй байдлын газар http://www.isd.gov.mn/?lang=mn&cat=7
- Төрийн мэдээлэл холбооны газар https://www.cita.gov.mn/
- Эрх зүй мэдээллийн систем https://www.legalinfo.mn/
- https://www.nato.int/cps/en/natohq/topics_140739.htm
- https://www.dcaf.ch/sites/default/files/publications/documents/OnCyberwarfare-Schreier.pdf
- https://www.vmware.com/topics/glossary/content/cyber-espionage
- https://www.iso.org/standard/44375.html
- https://www.itu.int/en/ITU-D/Cybersecurity/Pages/global-cybersecurity-index.aspx
- https://www.secureworldexpo.com/industry-news/countries-dedicated-to-cybersecurity
- https://www.cyberdb.co/top-10-countries-best-prepared-cyber-attacks/
- https://www.cyberdb.co
- https://cyberdb1.wpengine.com/database/usa/
- https://www.cyberdb.co/top-10-countries-best-prepared-cyber-attacks/
- https://cyberdb1.wpengine.com/database/israel/
- https://www.broadcom.com/products/cyber-security
- BSA International Cybersecurity Policy Framwork 2018 https://www.coe.int/en/web/conventions/full-list/-/conventions/treaty/185
- https://statesassembly.gov.je/scrutinyreviewresearches/2018/research%20-%20briefing%20paper%20on%20council%20of%20europe%20convention%20on%20cybercrime%20-%2031%20october%202018.pdf
- https://rm.coe.int/t-cy-2020-16-bc-benefits-rep-provisional/16809ef6ac#:~:text=The%20Budapest%20Convention%20requires%20States,cybercrime%20but%20any%20offence%20where
- National center of Incidient readiness and Strategy For Cybersecutity https://www.nisc.go.jp/eng/index.html
- Japan Cybercrime Control Center https://www.jc3.or.jp/english/
- @Police https://www.npa.go.jp/cyberpolice/english/index.html
- Cybersecurity Research Institute https://www.nict.go.jp/en/csri/
- Act on Punishment of Activities Relating to Child Prostitution and Child Pornography, and the Protection of Children https://antislaverylaw.ac.uk/wp-content/uploads/2019/08/Japan-Child-Prostitution-and-Child-Pornography-Law.pdf
- Act on Development of an Environment that Provides Safe and Secure Internet Use for Young People https://www8.cao.go.jp/youth/youth-harm/law/pdf/for_english.pdf
- Japan Penal Code http://www.isc.meiji.ac.jp/~sumwel_h/Codes/comp-crim.htm
- Act on Prohibition of Unauthorized Computer Access http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail_main?re=01&vm=02&id=2250
- The Basic Act on Cybersecurity http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?printID=&re=02&vm=02&id=2760&lvm=01
- Children on the Internet https://www.jugendschutz.net/fileadmin/download/pdf/Report_2019_Children_on_the_Internet.pdf
- European Cybersecurity Month 2021 https://www.nixu.com/
- CyberSecurity Strategy for Germany 202 https://www.bundesregierung.de/breg-en/news/new-cyber-security-strategy-1958688
- Bundeskriminalamt https://www.bka.de/EN/Home/home_node.html
- Federal Ministry for Family Affairs https://www.bmfsfj.de/bmfsfj/meta/en
- BPJM https://www.bzkj.de/bzkj/meta/en


UIH.MN СУДАЛГААНЫ САН

- The Commission for the Protection of Minors in the Media https://www.kjm-online.de/en/
- The Commission for the Protection of Minors in the Media https://www.kjm-online.de/en/
- Nummer gegen Kummer https://www.nummergegenkummer.de/
- Jugendschutz.net https://www.jugendschutz.net/en/index.html https://www.jugendschutz.net/en/index.html
- The Federal Review Board for Media Harmful to Minors https://www.bzkj.de/bzkj/Service/english.html
- German Law Archive https://germanlawarchive.iuscomp.org/?p=724
- Interstate Treaty on the Protection of minors https://www.kjm-online.de/
- Criminal Code (Strafgesetzbuch, StGB) https://germanlawarchive.iuscomp.org/?p=752
- Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх зааг хязгаар. Фрейдрих Эбертийн сан. 2018 он.
- http://library.fes.de/pdf-files/bueros/mongolei/14077.pdf
- Network Enforcement Act https://germanlawarchive.iuscomp.org/?p=1245
- President Biden's Executive Order https://www.mondaq.com/unitedstates/security/1074554/what39s-in-president-biden39s-executive-order-on-improving-the-nation39s-cybersecurity
- https://www.everycrsreport.com/reports/97-1025.html#:~:text=The%20Computer%20Fraud%20and%20Abuse,computers%20connected%20to%20the%20Internet.
- Prosecuting Computer Crimes https://www.justice.gov/sites/default/files/criminal-ccips/legacy/2015/01/14/ccmanual.pdf
- United States Code http://uscode.house.gov/search.xhtml?edition=prelim&searchString=cybercrime&pageNumber=1&itemsPerPage=100&sortField=CODE_ORDER&action=search&q=Y3liZXJjcmltZQ%3D%3D%7C%3A%3A%3A%3A%3A%3A%3A%3Afalse%3A%7C%3A%3A%3A%3A%3A%3A%3A%3Afalse%3A%7Cfalse%7C%5B%3A%3A%3A%3A%3A%3A%3A%3Afalse%3A%5D%7C%5B%3A%5D
- Cybersecurity laws and Regulations https://iclg.com/practice-areas/cybersecurity-laws-and-regulations/usa
- Cybersecurity bills https://www.csoonline.com/article/3626908/18-new-cybersecurity-bills-introduced-as-us-congressional-interest-heats-up.html


UIH.MN
СУДАЛГААНЫ САН

# МОНГОЛ УЛСЫН НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАЛААРХ ОЛОН НИЙТИЙН ШҮҮМЖ БА ТУЛГАМДСАН АСУУДЛУУД

*(олон нийтийн санаа бодлыг тандах судалгаа)*

(2021.10.19-ний байдлаар)

*Парламентын судалгааны хүрээлэн*

## УДИРТГАЛ

Судалгааны захиалгын дагуу “Монгол Улсын нийгэм-эдийн засгийн нөхцөл байдлын талаарх олон нийтийн шүүмж ба тулгамдсан асуудлууд” сэдэвт олон нийтийн санаа бодлыг тандах судалгааг (2021.10.18-19-ний өдрүүдэд) Парламентын судалгааны хүрээлэнд гүйцэтгэв.

**Судалгааны зорилго:**

Сүүлийн үед олон нийтийн дунд ихээхэн шүүмж дагуулж байгаа нийгэм, эдийн засаг, улс төрийн хүрээний тулгамдсан асуудлуудыг тоймлон илрүүлж, бодлого, эрх зүйн орчны хүрээнд шийдвэрлэх шаардлагатай тулгамдсан асуудлуудыг тодорхойлохыг зорьсон.

**Судалгааны хамрах хүрээ:**

Тойм судалгааг нийгмийн сүлжээ, өдөр тутмын хэвлэл, цахим сайтууд, телевизийн ярилцлага, мэдээ мэдээлэл зэрэг олон нийтийн мэдээллийн эх сурвалжуудад тулгуурлан бэлтгэлээ.

**Судалгааны арга зүй:**

Тойм судалгааг гүйцэтгэхдээ тодорхой салбар, чиглэлүүдээр мэдээллийг түүвэрлэх, ангилах, бүлэглэх, эрэмбэлэх, мэдээллийн агуулгыг задлан шинжилж нэгтгэн дүгнэх контент анализын арга зүйг ашиглав.

**Судалгааны эх сурвалжууд:**

1. олон нийтийн сүлжээ (фэйсбүүк, твиттер);
2. өдөр тутмын цахим хуудас (өндөр хандалтай сайт);
3. телевизийн нийгэм, эдийн засаг, цаг үеийн нөхцөл байдлын талаар бэлтгэсэн нэвтрүүлгүүд;
4. өдөр тутмын сонингууд;
5. эксперт судлаачдын байр суурь зэрэг болно.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

## ҮР ДҮНГИЙН ТОЙМ

Мэдээллийн эх сурвалжуудаас сүүлийн үед олон нийтийн дунд маргаан мэтгэлцээн, шүүмж дагуулж байгаа асуудлуудыг тодорхой сэдэв, салбар, чиглэлүүдээр тоймлон түүвэрлэж хамгийн их давталттай, анхаарал татсан асуудлуудыг эрэмбэлэн хамаарах эрх бүхий субъектүүдээр нь ангилан авч үзвэл:

***Нэг. Хууль тогтоомжийн хэрэгжилт, Засгийн газрын шийдвэр, үйл ажиллагаа, зохион байгуулалттай холбоотой дараах асуудлууд хамгийн ихээр хөндөгдсөн байна. Үүнд:***

1.1 Үнийн өсөлт (нийлүүлэлтийн инфляц, бараа бүтээгдэхүүний хомстол, бүтээн байгуулалт царцсан, бодит үйлдвэрлэлийн салбарын уналт, барилгын материал, үйлдвэрлэлийн түүхий эдийн саатал, төсөв мөнгөний хомстол гэх мэт)
1.2 Ачаа тээвэрлэлт (хилийн гадна ачаа бараа саатсан, нүүрс тээвэрлэлт зогссон, тээврийн компани, жолооч нар хүнд байдалд орсон гэх мэт)
1.3 Шатахууны нийлүүлэлт (шатахууны нийлүүлэлт, нөөц бүрдүүлэлт, хомсдол)
1.4 Нүүрс тээвэр (төмөр замын цариг, нүүрсний экспорт буурсан, нүүрс тээвэрлэлт зогссон)
1.5 Сайжруулсан түлшний хангамж
1.6 Боловсролын байгууллагын үйл ажиллагаа

- Цахим хичээл/хичээл хоцрогдолт, үүнээс үүдэлтэй багш, хүүхдийн эрүүл мэнд, сэтгэл зүйн асуудал
- Сурах бичгийн агуулга, чанар, сургалтын хөтөлбөр,

1.7 Нийгмийн асуудал (цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж, өрхийн орлогын бууралт, ажилгүйдэл, ядуурал, ХБХ-ний асуудал, хавтгайрсан халамж)
Иргэдэд ээлгүй, стандартгүй дэд бүтэц (оновчгүй хөрөнгө оруулалт, зам, дэд бүтцийн бүтээн байгуулалт гэх мэт) зэргийг хамруулж үзсэн болно.
1.8 Эрүүл мэндийн салбарын асуудал (эмнэлгийн хүртээмж, эмчилгээ үйлчилгээ, эм тариа, эмнэлгийн хэрэгслийн дутагдал, салбарын менежмент гэх мэт)

Эдгээрээс хамгийн их давтамжтай хөндөгдөж байгаа нь Үнийн өсөлттэй холбоотой асуудлууд байгаа бөгөөд үнэ өсөж, инфляц нэмэгдэж байгаа шалтгааныг Засгийн газар нийлүүлэлтийг зохистой түвшинд хангаж чадахгүй байгаагаас бараа, бүтээгдэхүүний болон ачаа тээвэр, шатахууны нийлүүлэлтийн хомстол үүссэн, инфляцыг зөвхөн мөнгөний бодлогоор удирдах боломжгүй болсон гэх мэтийн санал шүүмжүүд байна.

**Хоёр. УОК, НОК-ын үйл ажиллагаа, зохион байгуулалттай холбоотой асуудлууд:**

2.1 Хөл хорио тэгш бус үйлчилж байгаа, энэ нь цар тахлын тархалтад нөлөөлж байна гэж үзэх хандлага (no double standard, 2 том тоглолт, арга хэмжээ,“Зайсан Хилл”, Цахим үндэстэн)
2.2 “Ковид-19” цар тахал: Засгийн газар, бүх шатны ЗДТГ, УОК болон НОК-ын уялдаагүй, эргэж буцсан үйл ажиллагаа)
2.3. Эрүүл мэндийн үйлчилгээ

- Эмнэлгийн нөхцөл (Сэтгүүлч Б.Ганчимэгийн ХӨСҮТ-ээс хийж буй пост, бичвэрүүд)
- Эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж (ковидын багц, шаардлагатай эм тариа, оношлуур, вакцин, хүчилтөрөгчийн аппарат гэх мэт)

UIH.MN СУДАЛГААНЫ САН

- Ковидын үед эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааны зохион байгуулалт (өрхийн эмнэлэг, 1,2,3-р шатлалын эмнэлгийн ковидын үеийн хамтын ажиллагаа, шуурхай бус байдал, нас баралт, хүндрэл гэх мэт)

**Гурав. Улсын төсөвт хамааралтай асуудлууд**

УИХ-аар 2022 оны Улсын төсвийг хэлэлцэж байгаатай холбогдуулан дараах асуудалд анхаарал хандуулж байна:

3.1 Төсвийн тэлэлт, үр ашиггүй зарцуулалт (8,0 их наядаар 2022 оны төсвийн зарлага өссөн, хөрөнгө оруулалтын бодлого оновчгүй)
3.2 Төсвийн хөрөнгө оруулалт

- Тендер будлиантуулах
- Том төслүүдийн хэрэгжилт (удааширсан, төсөвт өртөг нэмэгдсэн)
- Оновчгүй том төслүүд (дүүжин тээвэр)

3.3 Тойргийн мөнгө (2022 оны төсөвт гишүүн тус бүрт 4,0 тэрбум төгрөг тавьсан нь төсвийн алдагдлын 15% болж байна)
3.4 Цалин хөлс, тэтгэвэр тэтгэмжийг нэмэгдүүлэх (ялангуяа багш, эмч нарын цалинг нэмэгдүүлэх, халамжийг зорилтот бүлэгт чиглүүлэх, тэтгэвэр тэтгэмж нэмэгдүүлэх)

**Дөрөв. УИХ-ын үйл ажиллагаатай холбоотой асуудлууд**

- Хөрөнгө оруулалтын тухай хуулийг тойрсон маргаан олон нийтийн анхааралд байна. УИХ-ын гишүүн Х.Ганхуяг, Х.Булгантуяа, П.Анужин, Д.Өнөрболор нарын өргөн барьсан Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь нийгмийн сүлжээнд нэлээд хэл ам дагуулж байна. Харин уг хуулийн заалттай холбоотой асуудал нийгэмд шуугиан дэгдэнгүүт УИХ-ын гишүүн П.Анужин, Д.Өнөрболор нар нэрээ татаж байгааг өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслэлүүдээр ихээхэн хөндсөн байна.
- Цахим гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчинг бүрдүүлэх (банкнаас мөнгө алдагдах үед шуурхай таслан зогсоох эрх зүйн механизм хангалтгүй, криптовалютын сүлжээнээс иргэд хохирох эрсдэлээс хамгаалах эрх зүйн зохицуулалт гэх мэт)
- Казино байгуулах эрх зүйн орчин (аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх, хяналттайгаар нээх гэх мэт)
- 2022 оны төсвийн төсөлтэй холбоотой асуудлууд (төсвийн тэлэлт, хөрөнгө оруулалт)
- Ковидын дараах эдийн засгийг сэргээн босгох эрх зүйн орчинтой холбоотой асуудлууд
- Эрүүгийн хууль, хүний эрх, хэрэг хянах, шүүн таслах ажиллагааны эрх зүйн орчин
- Монгол банк болон арилжааны банкны үйл ажиллагаа, мөнгөний бодлого, зээл, санхүүжилтийн асуудал (төв банкны үнэт цаасны хүү, бодлогын хүүгийн бууралт зээл, санхүүжилтийн тэлэлтэд нөлөөлөхгүй байна, банкууд мөнгө хүүлж байна, эдийн засагт мөнгө дутагдаж байна гэх мэт)
- Шударга бус өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын үйл ажиллагаа
- НӨАТ-ын буцаан олголтын хувь хэмжээг нэмэгдүүлэх.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Түүнчлэн УИХ-ын харьяа байгууллагууд, Засгийн газрын харьяа байгууллагууд, тэдгээрийн үйл ажиллагаа, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой санал шүүмжүүд ихээр гарсан байна. Эдгээрийг товч тоймловол:

- банк санхүүгийн нөхцөл байдал, зээл, татвар, гэр бүлийн хүчирхийлэл, төрийн албан хаагчийн ёс зүй зан харилцаа, үйлчилгээний чанар, цахим үйлчилгээ нь хангалтгүй байгаа, Ерөнхийлөгчийн санаачилсан Тэрбум мод тарих хөдөлгөөн, Хүний эрхийн зөрчилтэй холбоотой мэдээлүүд гарсан байна
- Нөхөн сонгуулийн дүнтэй холбогдуулан 1992 оны шинэ Үндсэн хуулиар тогтоосон олон намын тогтолцоог Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр буцааж хумигдах нөхцөл байдал үүссэн, нэг намын дарангуйлал тогтох гэж байна, үүнийг дагаад сонгууль ардчилсан болж чадахгүй байна, сөрөг хүчин өрсөлдөх битгий хэл хяналтаа тавьж чадахгүй байна
- Иргэн Д.Монголхүү, Э.Одбаяр нарыг цагдаагийн байгууллагаас баривчилж хорьсон нь, цэргийн алба хаахаар явсан залуус зодуулах, улмаар амь насаа алдах, хууль шүүхийн байгууллагын чирэгдэл нь хүний эрх зөрчигдөж байна
- Шүүх засаглалд эрх зүйн шинэтгэл хийж байгаатай адилаар прокурор, мөрдөн байцаах байгууллагын үйл ажиллагааг мөн шинэчлэх шаардлагатай.
- Төрийн үйлчилгээ цахим хэлбэрт шилжиж байгаа ч төрийн байгууллагынхан янз бүрийн "цаас" нэхэж чирэгдүүлдэг асуудал хэвээр байна
- Аливаа томилгоог улс төрөөс ангид, мэргэжлийн болгох шаардлагатай
- Хүүхдийн төлөө гэх тодотголтой уг фонд нь хууль ёсны үйл ажиллагаа явуулж байгаад эргэлзэж байна
- Цар тахлын улмаас аялал жуулчлалын салбар (3) “тэг” зогсолт хийж, тур оператор, тур баазын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн орлого бүрэн тасалдсан
- Эрчим хүчний хангамжийн (2) найдвартай ажиллагаа доголдож, импортын шатахууны (8) хомсдол бий болж, сайжруулсан түлш-шахмал нүүрсний (2) нийлүүлэлт тасалдсан
- Үндсэн хуульд тусгагдсан хүний амьд явах эрхийн баталгаа болсон аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхийн тулд хот төлөвлөлт (6), нийтийн тээвэр (1), авто зам (1), газрын харилцаа, байгаль орчны (8) хууль, эрх зүйн орчныг харилцан уялдаатай, нэн яаралтай боловсронгуй болгох шаардлагатай.
- Үндэсний аюулгүй байдал (2), нэн ялангуяа эдийн засгийн аюулгүй байдал, гадаад харилцаа, хөрш орнуудтай харилцах асуудал, дипломатуудын томилгоо
- Хөрөнгө оруулагчдыг гадаад, дотоод гэж ялгавартай хандахгүй байх
- Хүнсний аюулгүй байдал, импортын хүнс
- Банкны цахим халдлага, нийгмийн сүлжээг ашиглан хүний эрхэд халдах гэмт хэрэг

Судалгаанд нийт иргэдийг ихээр бухимдуулж буй нийт 183 асуудлыг түүвэрлэн оруулж, шийдвэрлэх эрх бүхий субъектээр нь ангилж үзвэл УИХ-д хамааралтай 73, Засгийн газарт хамааралтай 127, Ерөнхийлөгчид хамааралтай 4, УОК, НОК-д хамааралтай 34, НЗДТГ-т хамаарах 9, Монголбанк-5, ШӨХТГ-2, ҮАБЗ-1, шүүх, хяналтын байгууллагад хамааралтай 4 мэдээлэл тус тус байна. Үүнээс дийлэнх нь буюу 70% нь Засгийн газарт хамааралтай асуудлууд байна.

*(Мэдээллийн дэлгэрэнгүйг хавсралтаас үзнэ үү.)*

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| Сэдэв | Тулгамдсан асуудал/ шүүмж | Эх сурвалж | Олон нийтийн санал | Асуудлын тодорхойлолт/ тайлбар | Хариуцан шийдвэрлэх субъект |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| **Төсөв** | Ч.Отгочулуу: 2022 оны төсөв УЛСЫНХ БИШ УЛС ТӨРЧДИЙН ТӨСӨВ болжээ | https://gogo.mn/r/4j27q | Соёлын сайдад их хэмжээний мөнгийг төсөвлөсөн. Судалгаагүй төсөв болсон Эдийн засагт яг юу болоод байгааг сайн ойлгоогүй байна. Хил гааль, боомт дээр маш их хүнрэл, түгжрэл үүссэн, Дарханы зам зэрэг асуудал их байна.<br>Архи, тамхины хэрэглээг дэмжсэн төсөв болсон. НӨАТ-ыг өсгөсөн, өр зээлийг өргөмжилсөн байна.<br>Ковидын хуулийг далимдуулж тендергүй төсөв зарцуулж байна. Хэнтий аймагт маш өндөр төсөв тавьсан. | Төсвийн алдагдалыг бууруулах, төсөв дэх улс төрийн нөлөөллийг бууруулах | УИХ/Засгийн газар |
| | Ч.Отгочулуу: ТӨСВИЙН БОЛОВСРУУЛАЛТАД СӨРӨГ ХҮЧИН ДУТАГДАЖ БАЙНА. Архи, ундаа, тамхины онцгой албан татварын орлогыг 500 тэрбум төгрөгөөр өсгөнө гэж тусгасан байгаа юм. Энэ нь монголчуудыг илүү их архи уу, тамхи тат гэж байгаагаас ялгаагүй. | https://eguur.mn/252762/ | Сангийн сайд бол төсвийг өөрөө хийнэ, төлөвлөнө, хэмжинэ, шалгуураа өөрөө тогтооно, түүндээ өөрөө дүн тавина, өөрөө тайлагнана. Уг нь Улсын их хурал хянадаг байсан ч ковидын хуулиар тэр үүргийг нь хязгаарлачихсан. Тэгэхээр Засгийн газар өөрсдөө дураараа дургиж байна. Бусад улсад хараат бус хөндлөнгийн шинжээчид төсвийг нягталдаг. Манайд тийм боломж байхгүй. | Төсвийн хариуцлагатай байдал, хяналт хангалтгүй | УИХ/Засгийн газар |
| | Гишүүн нэг бүрт 4’000’000’000₮. Нийт ₮304 тэрбум. Улсын дундаж төсвийн 3%. Төсвийн алдагдал 2’000’000’000’000₮ гэж үзвэл үүний 15%. Улайм цайм хуульчилсан авлига. Сөрөг хүчний гишүүд чихэр долоочихоогүй л бол нэг юм хэлээрэй. Ийм юмыг зөвшөөрч болохгүй. | https://twitter.com/Lodoisambuu/status/1449980830751723521 | Төсвийн алдагдалыг бууруулах, төсөв дэх улс төрийн нөлөөллийг бууруулах | Төсвийн алдагдалыг бууруулах, төсөв дэх улс төрийн нөлөөллийг бууруулах | УИХ/Засгийн газар |
| | Б.Отгонтөгс: Засгийн газар тойргийн хөрөнгө оруулалт нэрээр УИХ-ын гишүүдээ авлигадаж байна | http://itoim.mn/article/H1HZy/30047 | Төсвийн алдагдлыг бууруулах. УИХ-ын гишүүдийн тойрогт өгч буй 4 тэрбум төгрөгийг болиулах л хэрэгтэй. Иргэдийн дулаан амьдрах түлш, зудын асуудал хэцүү байна. Түлш, эрчим хүчний асуудлыг анхаарах. Гадаад өрийн асуудал. | Төсвийн алдагдалыг бууруулах, төсөв дэх улс төрийн нөлөөллийг бууруулах | УИХ/Засгийн газар |
| | Монгол Улс уул уурхайгаас их олз орж ирсэн 2009 оноос хойш төсвөө тэлэх бодлого явуулж, мөнгөний нийлүүлэлтийг байнга нэмэгдүүлж ирсэн билээ. Зөвхөн энэ үеэс хойш л гэхэд Монгол Улсын төсөв зургаа дахин нэмэгдсэн байна | http://eagle.mn/r/92310 | /2008 оны төсвийн тухай хуулиар нэгдсэн төсвийн нийт орлого 2,423.2 тэрбум төгрөг, нийт зарлага 2,560.1 тэрбум төгрөг байсан/. Сүүлийн хоёр жилд бүтээн байгуулалт руу их "мөнгө" хийснээ багасгавал ирэх жилийн төсөв энэ жилийнхээс бага байх ёстой. Учир нь ирэх хоёр жил сонгуульгүй. Иргэд бүсээ чангална, гэхдээ хариуцлагатай, алдагдалгүй төсөв баталъя | 2022 оны төсвийн зардал огцом нэмэгдсэн | УИХ/Засгийн газар |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | гэвэл "сонгуулийн" тодотголтой өмнөх хоёр жилийнхээсээ буурах нь гарцаагүй хэрэг. | | |
| Улаан бал 106 дугаар Төсвийн төсөл 18 их наяд болж өмнөх жилүүдийнхээс 8 их наядаар нэмэгдсэн тухай | https://www.youtube.com/watch?v=YtU2oKhaJaA | | 2022 оны төсвийн зардал огцом нэмэгдсэн | УИХ/Засгийн газар |
| Ажил нь зогссон, царцсан төслүүд төсвийн мөнгөнөөс шимигчилж байна. Үүний нэг нь нийтийн тээвэрт дүүжин тээврийг нэвтрүүлэх төсөл юм. Юу хийдэг нь тодорхойгүй тус орон нутгийн өмчит үйлдвэрийн газарт жилд 414 сая төгрөг зарцуулж байна. Дүүжин тээвэр нэвртүүлэх төслийн жилийн цалин 310 сая төгрөг. Баянхошууны тойрог орчимд 2020 оны 1 сард дүүжин тээвэр байгуулах төслийг анх эхлүүлнэ гэсэн боловч одоогоор нэгч тоосго, бүтээн байгуулалт эхлүүлээгүй байна. Энэ мэт зогссон төсөлд төсөв батлаж байгаад иргэд олон нийт бухимдалтай байна. | NTV Нийгэм мэдээний цаг | Төсвийн төлөвлөлт, зарцуулалтад иргэд бухимдаж байна. Дүүжин тээвэр гэх мэт ач холбогдолгүй төсөлд их хэмжээний мөнгө зарцуулж байгаа хэдий ч бүтээн байгуулалт огт хийгдээгүй. Ажил нь зогссон, царцсан, үр ашиггүй зарим төслүүд төсвийн мөнгөнөөс шимэгчилж байгааг зогсоох. | 2022 оны төсвийн төлөвлөлт, хөрөнгө оруулалтад анхаарах. Үр ашиггүй төслүүдийг төсвөөс санхүүжүүлдэгийг зогсоох. | Засгийн газар/ НЗДТГ |
| 2022 оны улсын төсөвт эдийн засагчид ямар үнэлгээ өгсөн бэ? Эдийн засагч Ж.Дэлгэрсайхан, Н.Энхбаяр, Г.Батзориг нар байр сууриа илэрхийлжээ. | Үндэсний шуудан 2021.10.15 | Хөрөнгө оруулалтын бодлого бүрхэг, хэт өөдрөг, инфляцийн өсөлтийг тооцоогүй. | 2022 оны төсөв хэт өөдрөг, хөрөнгө оруулалтын бодлого тодорхойгүй байна. | УИХ/Засгийн газар - 2022 оны төсвийн төлөвлөлт, хөрөнгө оруулалтыг нарийвчлах, хэт өөдрөг төсөв гэж үзсэн. |
| Эдийн засагч Н.Энхбаяр: Улсын тендер ч, төсвийн хуваарилалт ч хэдхэн том компаниудыг дэмждэг боллоо, хэт тэгш бус байна | http://itoim.mn/article/YwDBi/30083 Enkhbayar Namjildorj | -Тансаг хэрэглээний бараанд болон эрүүл мэндэд хортой, эдийн засагт үр өгөөжгүй архи, тамхинд өндөр татвар тавих хэрэгтэй. Дэлхийн улс орнуудад нэг хайрцаг тамхины үнэ Монголоос 3-4 дахин өндөр байна. -Дэд бүтцээ шийдээгүй байж 36 сая тонн нүүрс гаргана гээд төлөвлөж байгаа нь хэт өөрдөг, бодит бус төсөөлөл.<br>Төсвийн бодлого хэт өөдрөг бус, болгоомжтой төсөөлөх ёстой. Үүсч болох эрсдэлүүдийг тооцсон хувилбартай байх. Төсвийн зарлага талдаа тогтвортой бодлого алга. Татварын зохистой бодлого хэрэгтэй. Тансаг хэрэглээний бараанд илүү өндөр татвар тоггоож, эрүүл мэндэд хор хөнөөлтэй, эдийн засагт үр өгөөжгүй архи, тамхинд маш өндөр татвар тавих хэрэгтэй. Сангийн яамны оруулсан төсөл дээр татвар, орон тоо, хуваарилалт, хөрөнгө оруулалтыг | 2022 оны төсөв хэт өөдрөг, хөрөнгө оруулалтын бодлого тодорхойгүй байна. Төсвийн хуваарилалт ч тэгш бус, том компаниудыг дэмжиж байна. | УИХ |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | зөвхөн том компани биш, ЖДҮ-ийн асуудлыг бодож, төлөвлөж оруулах учиртай. Дэд бүтцийн асуудлаа шийдэх хэрэгтэй. Алдагдал үүсгэж байгаа шалтгаан бүрээр нь ярьж, засч сайжруулах ёстой. Төрийн өмчит компаниудын менежмент, төсөв баталж байгаа тогтолцоо зэргийг хамтад ярьж, цэгцлэх. Манай улсад тулгамдаж байгаа номер нэг асуудал болох ковидыг даван туулахын тулд үүсч болох эрсдэлүүдээ тодорхойлох. Эрүүл мэндийн бэлэн байдал, нөөцөө хэрхэн бэлдэх, дээр нь хилийн боомтууд дээр ямар дэглэм мөрдөх вэ гэдэг маш чухал асуудал. | | |
| | Монгол Улс "ковид-19" халдварт өвчний хөлд үрэгдэж байна. Татвар төлөгч аж ахуй нэгжүүд орлогогүй болж, иргэд бүсээ чангалж жиндүү өвөлжиж байна. Гэтэл төрд ажиллаж байгаа дарга нар, татвар төлөгчдийн мөнгөөр жийп автомашин хоёр дахин нугарсан үнээр худалдан авч унаж байгаа юм. Төрийн мөнгө хяналтгүй зарцуулагдаж байна. | https://zarig.mn/oo8 | | Төсвийн зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байна | УИХ |
| **Үнийн өсөлт/Инфляц** | Г.Батзориг: Нийлүүлэлтийн шинжтэй инфляцыг мөнгөний бодлогоор “эмчлэх” боломжгүй | http://itoim.mn/article/mNUgY/30082 https://ikon.mn/n/2csj | Гуравхан бүтээгдэхүүн инфляцын 50 хувийг эзэлж байна. Нэгт, хатуу түлш, хоёрт шатахуун, гуравт мах. Үүнийг нийлүүлэлтийн инфляц гэдэг. Энэ бол Засгийн газрын хариуцах ёстой инфляц буюу Засгийн газрын чадавхийн асуудал. Товчхондоо, нэг бол махны үнийг зах зээлийн зарчмаар нь явуул. Эс бөгөөс нөөцийн махаа бэлдсэн шиг бэлдээд логистикийн асуудлыг нь шийд гэсэн үг., эсхүл шатахууны үнийг төр угаасаа менежмент хийж чадахгүй юм байна. Тиймээс шатахууныг зөнд нь орхи. Битгий хамаагүй барьж байгаад үнийг нь өсгөөд зах зээл дээр худалдан авах чадварыг огцом бууруулж, хорлосон шийдвэр гарга гэсэн үг юм. | Монголбанк бодлогын хүүг 6 хувь хүргэн бууруулж репо санхүүжилтийг нэмэгдүүлсэн хэдий ч инфляц буурахгүй, эдийн засагт мөнгөний урсгал орж ирэхгүй байна. Засгийн газрын үйл ажиллагаатай холбоотой нөлөөллүүдийг арилгах | УИХ/Засгийн газар/Монголбанк |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | "2022 оны улсын төсөв батлахтай холбогдуулан барилгын салбарынхан Сангийн яамны гадна жагсаал зохион байгуулж байна. Барилгын салбарын төлөөлөл “Бид барилгаа барих ямар ч боломжгүй боллоо. Хил хаалттай, хэзээ нээгдэх нь тодорхойгүй байдалтай байна. Барилгын материалын үнэ өссөнтэй холбоотойгоор компаниуд багадаа 300 саяас нэг тэрбум төгрөгийн алдагдалд хүлээсэн. | http://eagle.mn/r/92951 http://eagle.mn/r/92849 | Барилгын материалын үнийн өсөлтийн зөрүүг 2022 оны төсөвт тусгаж өгөхийг хүсэж байна. Б.Жавхлан сайд энэ асуудлыг шийдэхгүй бол улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй 1100 гаруй барилга балгас болж үлдэх нь. Улмаар татвар төлөгчдийн мөнгө үнэгүйдэхэд хүрнэ. Засгийн газар хөрөнгө оруулалтын үр өгөөжийг дээшлүүлэхэд анхаарлаа хандуулахгүй байна. Бид ажил олгогчид. Гэсэн хэдий ч олон сая төгрөгийн өрөнд баригдаж ажилчдаа цалинжуулж чадахгүй байдалд хүрлээ. Энэ чигээрээ удвал барилгын компаниудын 70-80 хувь нь дампуурна”. | Барилгын салбарынхан 2022 оны төсөв барилгын материалын үнийн өсөлтийн зөрүүг тусгах, хил гаалийг яаралтай нээж салбарын хэвийн үйл ажиллагааг хангахыг шаардаж байна. | Засгийн газар- Хил, гааль, барилгын материалын үнийн өсөлт, дуусаагүй барилга, санхүүжилт, салбарын бусад асуудлуудыг шийдвэрлэж хөл дээр нь босгох |
| **Үнийн өсөлт** | 2020-2021 оны улсын төсвөөр барилга барьж буй компаниудын 70-80% нь дампуурахад бэлэн болчихоод байна | https://ikon.mn/n/2cuj | Энэ асуудлыг шийдэхгүй бол татвар төлөгчдийн мөнгө үнэгүйдэх гээд байна. Бидэнтэй Сангийн сайд Жавхлан та өөрийн биеэр уулзаж, тайлбар хийхийг хүсье. Барилгын материалын үнийн өсөлт түр зуурынх гэдгийг та ямар судалгаанд үндэслэн хэлсэн юм. Үнэхээр алдсан байвал үнийн өсөлтийн зөрүүг шийдэж, 2022 оны улсын төсөв батлагдахад хугацаа үлдсэн учраас засаж оруулах боломж байна. | Төсвийн хөрөнгөөр барилга барьж буй компаниуд санхүүгийн хүнд байдалд орсон | Засгийн газар |
| | Барилгын материалын үнэ өссөнөөс болж баригдаж буй бүтээн байгуулалтууд царцана | С1 ТВ - 2021.10.12-ны мэдээ | | Барилгын материалын үнэ өссөн | Засгийн газар |
| | Банк болоод зах зээлийн үнэлгээ хоорондоо зөрүүтэйгээс гадна үнийн хэт хөөсрөлтөөс болж иргэд орон сууцанд хамрагдаж чадахгүй байна. | С1 ТВ - 2021.10.12-ны мэдээ | | Орон сууцны үнийн хөөрөгдөлтийг зохицуулах. Банк болон зах зээлийн үнэлгээ хэт зөрүүтэй байна. Иргэд хохирч байна. | |
| | Иргэдийн худалдан авах чадвар улам муудаад байна. Дунд, дундаас дээш давхарга бий болгох биш ядуурал бүр ядуурлын эмзэг байдал руу орох магадлал маш өндөр болж байна | https://fb.watch/8IYuoPLbb-/ | Инфляци барих бодлого явуулж байгаа. Бараа бүтээгдэхүүний ханган нийлүүлэлтийг сайжруулах, макро тогтвортой байдлыг хангах. | Иргэдийн орлого,худалдан авах чадвар муудсан. Үнийн өсөлтийг мөнгөний бодлогоор барьж дийлэхгүй. Бараа бүтээгдэхүүний ханган нийлүүлэлтийг сайжруулах тал дээр Засгийн газар арга хэмжээ авах | Засгийн газар |
| | 4-р сард 38,872₮-өөр авч байсан бараа бүтээгдэхүүнийг 10-р сард 42,477₮-өөр худалдан авч байна | С1 ТВ - 2021.10.04-ний мэдээ | | Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ өссөн | Засгийн газар |
| | Цар тахлын үед махны үнэ 2000-2500 төгрөгөөр нэмэгджээ. | С1 ТВ - 2021.09.21-ний мэдээ | | Махны үнэ нэмэгдсэн | Засгийн газар |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Инфляц 10 хувьтай болно гэдэг, таны цалингийн 10 хувь нь хоосон цаас болсныг л илтгэж буй. Гар дээрх 100 мянган төгрөг тань худалдаа хийхэд 90 мянгатай дүйцэх л үнэ цэнтэй гэсэн үг. Гэтэл нөгөө талд хэрэглээний үнийн индекс 10 хувь хүрснээр өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ өнгөрөгч оны мөн үеэсээ даруй 10 хувиар нэмэгдсэнийг илтгэнэ. | https://eguur.mn/256458/ | | | |
| | Цар тахлын үеийн нийлүүлэлтийн “шок” эрчимжиж, боомтууд дахь саатал хүндэрч байна. Энэ нь жижиглэн худалдаанд нөлөөлж, бараа, бүтээгдэхүүний үнэ нэмэгдэх, компаниудын ашиг буурах зэрэг эрсдэл дагуулж байна. | http://bloombergtv.mn/боомтуудын-гацаа-хүндрэв/?cid=3 | | | Засгийн газар |
| **Гааль, хяналт** | Энэ оны эхний 9 сард гаалийн байгууллагад нийтдээ 776 удаагийн зөрчил, гэмт хэрэг бүртгэгдсэн байна. Монгол Улсын хилээр нэвтэрч байгаа зорчигч 15 сая төгрөгөөс дээш хэмжээний валютыг валютыг биедээ авч явж байгаа тохиолдолд гаалийн мэдүүлэгт заавал бичих үүрэгтэй. Иргэд энэ заалтыг мэдэхгүйгээс зөрчилд холбогдож, бэлэн мөнгөө хураалгах, торгуулах зөрчил буурахгүй байгааг гаалийн байгууллагаас анхааруууллаа. | http://eagle.mn/r/92457 | Энэ зөрчилд 2.1 тэрбум төгрөгийн татварыг нөхөн төлүүлж, 1.2 тэрбум төгрөгийн торгууль оногдуулжээ. Мөн 37.9 сая төгрөгийн барааг улсын орлого болгож, 56.8 сая төгрөгийн үнэ бүхий барааг бүтээгдэхүүнийг түр хураасан байна.<br>Мөн улсын хилээр 133.7 мянган юань буюу 58.9 сая төгрөгтэй тэнцэх валютыг хууль бусаар нэвтрүүлэхийг завдсаныг улсын орлого болгон, 8.8 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна. | Иргэд хуулиар хүлээсэн эрх, үүргээ мэдэхгүйгээс хохирч байна. Хууль сурталчлах, хэрэгжүүлэх, иргэдийн эрхийг хамгаалах асуудалд анхаарах | Засгийн газар-хуулийн хэрэгжилт, хяналт |
| **Ачаа тээвэр** | Чингэлэг тээвэр Хятад Улсад саатаж байгаа нь Монголын эдийн засагт сөргөөр нөлөөлж байна | https://www.facebook.com/tv9mongolia/ | | Хятадад саатсан чингэлэг тээврүүдийг гацаанаас гаргах шаардлагатай | Засгийн газар |
| | Эрээнээс ирж байгаа ачааны үнэ маш их нэмэгдсэн | С1 ТВ - Реакц "Хил гааль авилгад идэгдсэн үү" 2021.10.14 | | Ачаа тээврийн үнэ нэмэгдсэн | Засгийн газар |
| | Хятад Улсын Эрээн хотод ковид илэрч хилээ хааж зам тээврийн орох гарах хөдөлгөөнийг хаахаас гадна ачаа барааны татан авалтыг зогсоолоо. Хилээ хэзээ нээх нь тодорхойгүй байна. | https://www.facebook.com/tv9mongolia/ | | Хил хаагдсанаас бараа татан авалт зогссон | Засгийн газар |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Тяньжин боомтод гацсан чингэлэг ачааны асуудал | С1 ТВ - 2021.10.13 | | Хилийн чанадад гацсан барааг яаралтай татан авах | Засгийн газар |
| | С.Дэлгэр: Жинхэнэ авлигалчингууд чинь гаалийн ажилчид. Ялангуяа Замын-Үүдэд | С1 ТВ - 2021.10.06 | | Гаалийн ажилчид авилга авч байна. | Засгийн газар |
| | Т.Түмэнцэцэг: Эд нарын хэлээд байгаа шиг ачаа бараа хэвийн болсон зүйл ерөөсөө байхгүй. | С1 ТВ - 2021.10.07 | | Төрийн мэдээлэл үнэн зөв байх ёстой. Бодит байдал дээр ачаа барааны татан авалт жигдрээгүй, саатсан хэвээр байна. | Засгийн газар |
| | Эрээн хаагдсанаас хойш 100 айл дээр барилгын материалын үнэ 30-40% өслөө шдэ | @amaraaliberty | | | Засгийн газар |
| **Нүүрс тээвэр** | Нүүрс тээврийн жолооч нарын аж амьдрал сүүлийн 2 жил үнэхээр хүнд банкны мөнгө хүүлэгчидийн дарамтанд эд хөрөнгөө алдаж гэр бүл үр хүүхдүүдийн хамт тарчилж байгаа нь туйлийн үнэн. Төр засгийн бодлого 30 жил буруу явж ирсний гайгаас болж хичээж зүтгэж байгаа олон 100-н мянган хөдөлмөрч иргэд боолын хөлсөөр ажиллаж авсан цалингаа мөнгө хүүлэгчидэд дээрэмдүүлдэг тогтолцоог халах. | Жагар Бямбасүрэн | Дэлхийн жишигт нийцсэн банк санхүүгийн тогтолцоо бий болгох нь хамгийн чухал | Нүүрсний тээвэрт явж байгаа жолооч нарын аж амьдрал, цалин хөлс, нийгмийн асуудал маш хүнд байна. Төрөөс анхаарах<br><br>-Мөнгө хүүлэлтийн эсрэг эрх зүйн орчныг сайжруулах. ГА | УИХ/Монголбанк/Засгийн газар |
| | Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар тээвэрчдийн холбоотой хийсэн гэрээгээ зөрчиж, Тавантолгойгоос Чойр чиглэлийн улсын чанартай авто замыг хатуу хучилттай зам тавих хүртэл тээвэр хийлгэхгүй гэсэн 158 дугаартай тушаал аравдугаар сарын 6-ны өдөр гаргажээ. Монголын тээвэрчид банкны зээлээр, байгаа хөрөнгөө барьцаалж задгай тэвштэй тээврийн машин авсан ч тээвэрлэлт хийж чадахгүй 2-3 сараар цалин орлогогүй зогсож байна. | https://gogo.mn/r/v586y | | ЗТХЯ-ны сайд Л. Халтар буруу шийдвэр гаргасан. Тавантолгойн автозамын тээвэрлэлтийг зогсоосноос үүдэн тээвэрчдийн асуудал хүндэрч байна. Гэрээ зөрчигдсөн. | Засгийн газар |
| | Жолооч н.Баярхүү: Цагаан хаданд дуртай жолоочоо хил нэвтрүүлж, дургүйгээ буцаах нь түгээмэл боллоо | https://gogo.mn/r/0y65y | | Цагаан хаданд жолооч нарын эрх зөрчигдөж, дарамтанд байна. | Засгийн газар |
| | Зам тээврийн хөгжлийн сайдын тушаалыг эсэргүүцсэн тээвэрчид жагсаж байна | С1 ТВ - 2021.10.13-ны мэдээ | | ЗТХЯ-ны сайдын шийдвэрийг жолооч нар эсэргүүцэж байна | Засгийн газар |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Замын-Үүд сумын иргэд нүүрс тээвэрлэлтийг авто замаар тээвэрлэхийг эсэргүүцэж, Цагаан хадын замаар тээвэрлэхийг хүсэж байгаагаа илэрхийллээ. | http://eagle.mn/r/92710 | "Замын-Үүд суманд 30 мянган иргэн амьдардаг. Бид эрүүл, цэвэрхэн орчинд амьдрах эрхтэй. Иймээс суурьшлын бүсэд нүүрс авто замаар тээвэрлэхийг хатуу эсэргүүцэж байна. Замын-Үүд бол Монголын өмнөд бүсийн ганц нүүр царай. Энэ бүсэд нүүрс тээвэрлэвэл бид хоёр дахь Цагаан хад болно. Замын-Үүдэд нүүрс тээвэр татах дэд бүтэц байхгүй" гэсэн юм. "Тээвэрчид үнэ хөөрөгдөж байна гэсэн мэдээлэл буруу, ташаа болохыг мэдэгдэж байна. Бид гэрээний дагуу ажиллаж байгаа. Хэдийгээр Засгийн газраас ажлын хэсэг гарч ажилласан ч үр дүнд хүрсэнгүй. Нөхцөл байдал сайжирсангүй. Бодит байдал дээр боомтоор өдөрт 25 тээврийн машин орж байна. Харин нүүрс тээврийн 40-50 машин нэвтэрч байгаа. Үүнээс болж гацаа үүсэж байна. Ковидоос өмнө 200 гаруй машин явдаг байсан. Иймээс өдөрт нэвтрэх ачаа тээврийн машины тоог нэмэгдүүлж 100 болгохыг хүсэж байна. Мөн Шаргын овоон дээр нөхцөл байдал хүнд, хоол хүнс шаардлага хангахгүй байна. Дундын бүсэд гацаа их гарч байгаа учраас үүнийг болиулж өгөөч" гэлээ. | Замын үүд сумын иргэд суурьшлын бүс дагуу авто замаар нүүрс тээвэрлэхийг эсэргүүцэж байна. Ковидоос өмнө боомтоор 200 гаруй машин нэвтэрдэг байсан бол одоо өдөрт 25 машин л гарч байна. Иймээс өдөрт боомтоор нэвтрэх машины тоог нэмэдүүлж ядаж 100 болгох | Засгийн газар |
| | "Баянзам тээвэрчдийн холбоо"-ноос Гашуунсухайт боомтод үүсээд буй нөхцөл буюу шинжилгээний хариунууд зөрүүтэй гарч байгаагаас олон жолооч, компаниуд ихээхэн алдагдал хүлээж байгааг мэдэгдэв. | https://ikon.mn/n/2ci2 | Хилийн боомтын зөвлөлийн бүрэлдэхүүнийг солих хэрэгтэй гэж үзэж байна. Оронд нь тээврийн менежмент, халдвар хамгааллын зохион байгуулалтыг сайн хийдэг мэргэжлийн баг ажиллуулах хэрэгтэй | Гашуунсухайт боомтод шинжилгээний хариу буру гарсанаас олон жолооч, компаниуд хохирч байна. | Засгийн газар |
| | Салбартаа ч биш монголд халгаатай Л.Халтарын зохион байгуулалтгүй бодлогын үр дүнд энэ жил монголоос 42 сая тонн нүүрс гаргах ёстой байсан ч чадаагүй. | https://medee.mn/p/163557 | | ЗТЯ-ны сайдын буруу шийдвэрээс болж Монгол улс нүүрс экспортлохболомжоо алдаж байна. Шийдвэрийг эргэж харах | Засгийн газар |
| | Н.Ялагдашгүй: Нүүрс тээвэр зогссоноор 159 компани сул зогсож, 4000 орчим тээвэрчид ажилгүй болно. Улсын төсөвт ч асар хор хохиролтой | https://medee.mn/p/163604 | | Нүүрс тээвэр зогссоноос маш олон компани, тээвэрчид ажилгүй сул зогсч байна. | Засгийн газар |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **Эдийн засаг** | Бизнес эрхлэгчид дахин хөл хорио тогтоохгүй байхыг хүсчээ /2021.09.14/ | http://eagle.mn/r/91665 | Бизнесийн үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулахад тулгарч буй хүндрэл бэрхшээлүүдийг эрэмбэлэхэд: бэлэн мөнгөний (эргэлтийн хөрөнгийн) дутагдал, бизнес эрхлэх тодорхойгүй нөхцөл байдал, тээвэр ложистиктой холбогдох удаашрал, тасалдал хүндрэл учруулж байна. Судалгаанд оролцсон иргэдийн олонх нь бизнесээ сэргээж, хэвийн үргэлжлүүлэхэд дараах санхүүгийн дэмжлэг шаардлагатай байна гэж үзсэн байна. Үүнд: Санхүүгийн дэмжлэг (хөнгөлөлттэй зээл, барьцаагүй, урт хугацаат санхүүжилт) ААН-ийн албан татварыг хойшлуулах, хөнгөлөх Хориг цуцалсны дараа бизнесийг сэргээж хэвийн явуулахад нэгдсэн зохицуулалт хийх (Төрийн байгууллагын үйлчилгээний хүнд суртлыг бууруулах гэх мэт) Нөхцөл байдал хүнд болсон ч бизнесийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах (Хөл хорионд оруулахгүй байх) Тээвэр, ложистикийн нөхцөлийг сайжруулах Ач холбогдол, үр нөлөө багатай шаардлага, үнэлгээ, зөвшөөрлийн тоог багасгах, хялбаршуулах зэрэг дэмжлэг хэрэгтэй байна гэж бизнес эрхлэгчид үзжээ. | МҮХАҮТ-аас цар тахлын улмаас бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд гарч буй өөрчлөлт, тулгарч буй хүндрэл бэрхшээл, шаардлагатай дэмжлэгийг тодорхойлох зорилгоор явуулсан судалгаанд Улаанбаатар хот болон орон нутгийн нийт 1349 бизнес эрхлэгч оролцсон байна. Судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдээс: 61% нь ус, цахилгаан, дулааны төлбөр хөнгөлөх, чөлөөлөх дэмжлэг авсан 44% нь НДШ-ийн хөнгөлөлтөд 17% нь 3 хувийн зээлд хамрагдсан бол 24% нь ямар нэг дэмжлэг аваагүй байна. Цаашид бизнес эрхлэгчдэд цар тахлын хүндрэлийг даван туулах, нөлөөллийг бууруулах чиглэлээр төрөөс үзүүлэх дэмжлэг туслалцааг үргэлжлүүлэх, энэ чиглэлээр бодлогын шийдэл гаргах | УИХ/Засгийн газар - Олон улсын жишгээр цар тахалтай зэрэгцэн амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлэх |
| | Монгол Улсад ЖДҮ эрхлэгчид үйлдвэрлэл, үйлчилгээгээ өргөжүүлэхийн тулд нэн түрүүнд санхүүгийн эх үүсвэр дутагдалтай нүүр тулдаг | С1 ТВ - 2021.10.12-ны мэдээ | ЖДҮ эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх эх үүсвэр, хүртээмжийг нэмэгдүүлэх, хөнгөлөлттэй зээл олгох асуудлыг шийдвэрлэх | ЖДҮ эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх | УИХ/Засгийн газар |
| | ХААН банкин дахь иргэдийн данснаас мөнгө алдагдсан тохиолдол удаа дараа гарч, банкны зүгээс таслан зогсоох арга хэмжээ аваагүйгээс иргэд хохирч, хууль хяналтын байгууллагаар шалгуулах ажил удааширч байгаа талаар иргэдээс гомдол гарч байна. | https://gogo.mn/r/66wm0 | Арилжааны банкин дахь иргэдийн данснаас сэжигтэй гүйлгээ гарсан тохиолдолд харилцагчийг хохироохгүйн тулд иргэний мэдээллийн дагуу дансыг түр хаах, царцаах, хууль хяналтын байгууллагаас шуурхай шалгаж асуудлыг шийдвэрлэх эрх зүйн орчин бүрдүүлэх, банк болон хууль хяналтын байгууллага хоорондын хамтын ажиллагаа, ажлын уялдаа холбоог сайжруулах | Одоо хүчин төгөлдөр мөрдөж байгаа Банкны тухай хуулиар арилжааны банкууд иргэний хүсэлтээр харилцагчийн дансыг хаах эрхгүй, хууль хүчний байгууллагаас ийм төрлийн цахим гэмт хэргийг шийдвэрлэхдээ хойрго хандаж байгаагаас иргэд хохирч байгаа тул кибер аюулгүй байдлыг хангах, цахим гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчинг яаралтай бүрдүүлэх, банк-санхүүгийн салбарын хууль, журамд холбогдох өөрчлөлт оруулж | УИХ/ Монголбанк, СЗХ -Кибер аюулгүй байдлын эрх зүйн орчин бүрдүүлэх. Цахим гэмт хэрэгтэй тэмцэх хүрээнд Банкны хуульд өөрчлөлт оруулах, |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | харилцагчдыг цахим гэмт хэргээс хамгаалах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох, шуурхай шалган шийдвэрлэх чиглэлээр холбогдох байгууллагуудыг үүрэгжүүлэх | |
| | Эдийн засгаа сэргээхийн тулд заавал казино байгуулах шаардлагатай юу? | С1 ТВ - 2021.10.08-ны мэдээ | Олон улсын жишгээр, ж: Солонгос зөвхөн гадаад хүнд үйлчилдэг казино байгуулах боломжтой. ГА | | УИХ - эрх зүйн орчны асуудлыг шийдвэрлэх |
| | Иргэд койн худалдан авах замаар богино хугацаанд өндөр ашиг олох сонирхолтой байгаа нь эрсдэл дагуулж байна. Монголбанк, санхүүгийн зохицуулах хорооноос виртуаль хөрөнгө оруулалт нь албан ёсны хөрөнгө оруулалт, төлбөрийн хэрэгсэлд тооцогдохгүй, ирээдүйд эрсдэл үүсвэл хохирлыг төр хариуцахгүй гэдгийг мэдэгдсэн ч энэ төрлийн сүлжээ, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явагдсаар байна. Цаашид энэ төрлийн гүйлгээ, сүлжээнээс иргэд олноор хохирч болзошгүй байна. | https://gogo.mn/r/wv871?fbclid=IwAR07bhjb0H6U3uvQFQWd2hwzsIIOGrLKbRas5B3V_o9Ozx2VsmNjMDOr5jQ | | Монгол Улсад одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эрх зүйн орчны хүрээнд виртуаль хөрөнгийг албан ёсоор үнэт цаасны хөрөнгө оруулалтын хэрэгсэл, төлбөрийн хэрэгсэлд тооцоогүй, хориглосон агуулгатай хуулийн заалтууд үйлчилж байна. Эрх бүхий байгууллагуудаас зөвхөн сэрэмжлүүлэх мэдэгдэл хийснээр төрийн оролцоо хязгаарлагдаж байна. | УИХ/ Монголбанк, СЗХ - Эрх зүйн орчны хүрээнд асуудлыг шийдвэрлэх |
| | Зүв зүгээр байсан нарны замын бордюрыг техникийн хүчээр ховх татаж сольж байгааг харахад 1-р ээлжнийхэн нь олигтой идэш үлдээгээгүй юм байлгүй. Эрх мэдэлтнүүдэд ажил хийх сэтгэл байхгүй, зүгээр л мөнгө хийх шунал байгаагийн нэг жишээ энэ. Өмнө хийгдсэн бүтээн байгуулалтын ажлыг нураах, сайжруулах нэрийдлээр мөнгө угаадаг. | https://www.facebook.com/BuyangiinJagaa/ | | Замын сангийн хөрөнгийн зарцуулалтанд үнэлгээ хийх, үр ашиггүй хөрөнгө оруулалтыг таслан зогсоох. ГА | Засгийн газар |
| **Банк санхүү, зээл** | ₮10 их наядын хөтөлбөр эхэлж байх үед төв банкны үнэт цаасны үлдэгдэл ₮8.3 их наяд байв. Уг нь жилийн 3% хүүтэй зээл өгөхөд иргэд, ААН-үүд нь бизнес хийх ёстой. Гэтэл бизнес хийхгүй банкинд хийлээ, банкууд бүгдийг нь 6% хүүтэй төв банкинд байршуулаад байна. | https://www.facebook.com/Urantogtokh/videos/687631649293771 | | Төв банкны үнэт цаасны хүү өндөр байгаа учраас банкууд зээл гаргах сонирхолгүй мөнгөө Монголбанкинд байршуулаад байна. Төв банкны мөнгөний бодлогыг зөв болгох, банкны эх үүсвэрийг эдийн засагт чиглүүлэх арга хэмжээ авах. | УИХ/Монголбанк |
| **Цалин хөлс** | Гишүүдийн цалин 1,2 саяас 2,8 сая ₮ болтлоо нэмэгджээ | С1 ТВ - 2021.10.08-ны мэдээ (902 комменттой) | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Монголын багш нарын сарын дундаж цалин 770 мянган төгрөг бол энэ нь дэлхийн бусад улс орнуудын багш нарын цалингаас 3-5 дахин бага байна | С1 ТВ - 2021.10.05-ны мэдээ | | -Бага, дунд сургуулийн хүртээмжийг нэмэгдүүлж, анги дүүргэлтийн тоог бууруулсанаар багшийн ачааллыг бууруулах. ГА -Ахлах ангийг коллежтэй дүйцүүлэх, коллежийн хүртээмжийг нэмэгдүүлэх. ГА | Засгийн газар |
| | Багш нарын цалин бага, ажлын ачаалал их учир сурлага сайтай хүүхдүүд багш болохыг төдийлөн хүсдэггүй аж. Үүний улмаас багш нарын чадвар сул байгааг тус салбарынхан онцолдог. | http://eagle.mn/r/92462 | | -Бага ангийн багшийн цалинг эрс нэмэгдүүлэх замаар чадавхийг нэмэгдүүлэх. ГА | Засгийн газар |
| **Гадаад өр** | Улсын гадаад өр 33 тэрбум ам доллар хүрээд байна. Нарийн цариггүй, төмөр замаар нүүрсээ зөөж чадахгүй байгаагаас болсон. Өрийн тааз ДНБ 60 хувь гэж заасан. | https://www.youtube.com/watch?v=SV2RmX2He60 | | Улсын гадаад өр нэмэгдэхэд төмөр замын царигийн асуудал нөлөөлсөн. Нарийн цариггүй учраас нүүрсээ төмөр замаар зөөж чадахгүй байна. | |
| | ТӨХК-ууд 10,5 их наяд төгрөгийн өртэй байтал өнөөг хүртэл зохицуулалт хийсэнгүй | С1 ТВ - 2021.10.07-ны мэдээ | | | |
| **Өмч хувьчлал** | Циркийн өмч хувьлалын асуудал Циркийн хувьчлал буруу ядагдаж, зориулалтын бус ашиглалтаас үүдэн зөрчилдөж улстөрийн тэмцэл болон хувирсан | https://gogo.mn/r/24299 | Хүүхдүүдэд циркийг буцааж өг, эсхүл илүү сайжруулаад барьж өг. https://www.facebook.com/profile.php?id=100006253426563 | -Өмч хувьчлалыг мэнежментийн хувьчлалаар хийсэн эмнэлэг, боловсрол, соёлын байгууллагын гэрээг дүгнэж, үнэлэх. Шаардлагатай гэж үзвэл нийгэмчлэх, олон нийтийн эрх ашгийн үүднээс хариуцлага тооцох эрх зүйн орчин бүрдүүлэх, холбогдох арга хэмжээ авах-ГА | УИХ/ Засгийн газар |
| **Өмч хувьчлал** | Циркийн хууль бус өмч хувьчлалаас болж Монгол Улсад циркийн урлаг мөхсөн. | https://www.facebook.com/ | Нэгдэж тэмцэн, циркээ, циркийн урлагаа мөхөхөөс аваръя. | -Улсын циркийг зориулалтын дагуу ашиглах, циркийн урлагийг сэргээх. ГА | Засгийн газар-Соёлын яам |
| **Татвар** | Манай улсад Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль хэрэгжиж эхлээд 6 жил болсон байна. ААН, худалдааны үйлчилгээний газрууд иргэдийн төлбөр төлсөн баримтыг заавал олгох үүргийг хуулиар хүлээдэг. Гэвч зарим зах, худалдааны газруудын 40 орчим хувь нь төлбөрийн баримт олгохгүй зөрчил гарсаар байгаа юм байна. | МҮОНТ - Oct 13, 2021 - https://www.youtube.com/watch?v=u1fU-9DHxrs | Иргэд баримтаа авч хэвших | Зарим зах, худалдааны газрууд НӨАТ-ын баримт өгөхгүй хууль зөрчин иргэдийг хохироож байна. Холбогдох байгууллагууд хяналт тавьж, хууль хэрэгжүүлэх | Засгийн газар |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | НӨАТ-ын 10%-ийг төлчихөөд 2% буцаан авдаг нь шударга бус. | https://www.facebook.com/tsetseg.byambaa | | НӨАТ-ын буцаан олголтын хувийг нэмэгдүүлэх. 2% бага байна. | Засгийн газар |
| | Сангийн сайд Б.Жавхлан “НӨАТ-ын буцаан олголтыг болиулах нь зөв" гэсэн байр сууриа илэрхийлсэн нь иргэдийг ихээхэн шуугиулж байна. | https://ikon.mn/n/2crw | Б.Лхагважав: цар тахлын үед иргэдэд олгож байгаа НӨАТ-ын буцаан олголтыг 60-70 хувь болгож нэмэгдүүлэх ёстой. Зарим салбар руу 100 хувь ч буцааж болно. | Сангийн сайд Б. Жавхлан НӨАТ-ын буцаан олголтыг болиулна гэсэн нь иргэдийг бухимдуулж байна. | Засгийн газар |
| | Вьетнам засварын газруудаас татвар авдаггүй байсан | https://ikon.mn/n/2cog | НӨАТ-ын хэлтсийн дарга Д.Мөнхтуул: Татварын багц хууль болон бусад хууль, тогтоомжийн дагуу Монгол Улсад үйл ажиллагаа явуулж, орлого олж байгаа иргэн, аж ахуйн нэгжүүд албан татвар төлөх үүрэгтэй байдаг.Тэгэхээр манай улсад үйл ажиллагаа эрхэлж байгаа гадаадын иргэн ч хуулийн дагуу татвараа төлөх ёстой. Мөн гадны хөрөнгө оруулагчид, бизнес эрхлэгчид татварын албанд заавал бүртгүүлсний үндсэн дээр үйл ажиллагаа явуулах эрх үүсдэг. | Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын ХО-тай компани, иргэд,жижиг бизнес эрхлэгчид татвар төлж байгаа эсэхэд хяналт тавих | Засгийн газар |
| **Хөрөнгө оруулалт** | Хөрөнгө оруулалтын тухай хуульд 50 мянган долларын зүйл заалт шургуулж, ийм хэмжээний хөрөнгө оруулж, хоёр ажлын байр бий болгосон хүнд байнга оршин суух эрх олгуулахаар зүтгээд байгаа Булгантуяа, Ганхуяг хоёр гишүүнийг шүүмжлэв. | https://www.facebook.com/%D0%AD%D0%BC%D2%AF%D0%B6%D0%B8%D0%BD-553678738053852/ | 2 гишүүнийг УАБЗ шалгах хэрэгтэй байна. УХ-ийн 6.2 нь энэ яригдаад байгаа ХО-ын тухай хуулийн бэлтгэл байсан уу. Тийм л их дэмжмээр байгаа юм бол 50к доллар байтугай хөрөнгө оруулалт хийж байгаа үндэсний хөрөнгө оруулагчдаа яагаад татварын бодлогоор ч болсон дэмжихгүй байгаа юм бэ? | Х. Ганхуяг, Булгантуяа нарын гишүүдийн санаачилсан Хөрөнгө оруулалтын тухай хуулийн төсөлд гадаадын хөрөнгө оруулалтын босгыг бууруулсан нь олон нийтийн эсэргүүцэлтэй тулгарч байна. Гадаадын хөрөнгө оруулагчдад таатай нөхцөл бүрдүүлсэн хэрнээ дотоодын хөрөнгө оруулагчдаа дэмжихгүй байгаад иргэд шүүмжлэлтэй хандаж байна. | УИХ |
| **Шударга өрсөлдөөн** | Олуулаа нэгдэж монополь үүсгэж байна | http://eagle.mn/r/92912 | ШӨХТГ зах зээлд өрсөлдөгч олонтой ч хоорондоо үгсэн хуйвалддаг ийм мэтийн асуудалд хяналт тавьж ажиллах ёстой. Хуулийг цаг үед нь нийцүүлж өөрчлүүлэх асуудлыг ч хөндөж байх ёстой гэж бодно. Тиймээс дээр дурдсан шиг олноороо нийлж үнэ тогтоодог шударга бус өрсөлдөөнийг зохицуулахад онцгой анхаарч ажиллах хэрэгтэй. | ШӨХТГ зөв ажиллаж чадахгүй байна.<br>-Монополийн эсрэг эрх зүйн орчныг сайжруулах, хуулийг үр нөлөөтэй хэрэгжүүлэх. ГА | УИХ/Засгийн газар/ШӨХТГ |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **Аялал жуулчлал** | Цар тахлын үед аялал жуулчлалын салбар хүнд нөхцөл байдалд ороод байна. Энэ салбарт 1300 гаруй ААН байдаг. Сүүлийн 2 жилийн хугацаанд 88 мянга гаруй ажлын байраас 30-аад мянга нь өөр салбар луухөрвөн ажиллаж байна. Тэдгээрийн нэг нь "Mongolian guide tour" компани юм. 2006 онд байгуулагдсан тус компани нь 40 гаруй хүний орон тоотойгоор үйл ажиллагаа эрхлэж байсан. гэтэл сүүлийн 2 жил ажилтнуудын цалин хөлс, түрээсийн төлбөр зэргээс болж ганцхан хүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. | MONGOL TV - "Нүүдэл шийдэл" нэвтрүүлэг - Oct 5, 2021 - https://www.youtube.com/watch?v=bxUK83ddxVI | 1.Байгаль орчин болон аялал жуучлалын гэж яамыг салгах хэрэгтэй байна. 2.Тэгээд хамгийн түрүүнд хуулиа батлуулж авмаар байна. 3.Түүндээ аялал жуучлалын санг тусгамаар байна. 4.Цар тахлын үед төрийн шийдвэрийг гаргахдаа энгийн үеэс илүү хялбаршуулсан, илүү шуурхай гаргаж баймаар байна. 5.Онцгой байдлын комиссоос гарч байгаа шийдвэр байнга өөрчлөгдөж байгаа нь нөлөөлж байна. 6.Аялал жуучлалын чиглэлээр хилээ хэзээ, ямар шалгуураар, ямар орны иргэдэд нээх вэ гэдгийг одоо тодорхой гаргах хэрэгтэй байна (Жуучлах хүн төлөвлөгөө эртнээс гаргадагтай холбоотой). Үүнийг дагаад нислэг тодорхой байх хэрэгтэй байна, үзвэр үйлчилгээг бэлтгэсэн байх шаардлагатай байна. | Аялал жуулчлалын салбар хүнд байдалд байгаа тул эрх зүйн орчин, яамны бүтэц, ложистик, шийдвэр гаргалт, хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудлуудыг анхааралдаа авч шийдвэрлэх | УИХ/Засгийн газар |
| | Аялал жуулчлалын салбар 2021-2022 онд ₮4.13 их наядын орлого алдах магадлалтай | https://ikon.mn/n/2cf1 | Шийдвэрүүдээ эрт танилцуулж, халдварын нөхцөл байдлаа сайжруулж, зөв бодлого хэрэгжүүлж чадвал 2023 оноос аялал жуулчлалын захиалга өмнөх хоёр жилээс хоёр дахин ба түүнээс дээш хэмжээнд өсөх төлөвтэй байна гэж судлаачид үзжээ | 2023 оноос эхлэн жуулчдыг татах бодлого, төлөвлөлтийг одооноос эхлэн хийж эхлэх | Засгийн газар |
| | С.Номин-Эрдэнэ: Жуулчдыг татахад 'Андлалын хөшөө' биш, нүүдэлчин ахуй соёл гол нөлөөтэй | http://itoim.mn/article/2WSwX/30046 | Бидэнд жуулчдыг татахад "Андлалын хөшөө" маягийн барилга, хөшөө ямар ч шаардлагагүй. Бид дэлхий дээрх цорын ганц нүүдэлчин ард түмэн. Энэ уламжлалт соёл, ёс заншлаа түгээн дэлгэрүүлэх нь жуулчдын ирэх шалтгаан болох болно. Жуулчид жил болгон явдаг халуун орнууд руу явахаа больсон. Тэд шинэ адал явдал, шинэ зүйлсийг сонирхож байна. Иймд бид энэ давуу талаа ашиглан, дэлхийд таниулж жуулчдыг татах хэрэгтэй. | Монгол уламжлал, өв соёл, нүүдэлчин уламжлалыг аялал жуулчлалыг хөгжүүлэх гол хэрэгсэл болгон ашиглах. Үүнийг АЖ-ын бодлого, төлөвлөлтөнд тусгаж бүтээн байгуулалтын ажил хийх, шинэ адал явдал, шинэ зүйлсийг дэлхий сонирхож байна. | Засгийн газар |
| **Сайжруулсан түлш** | Сайжруулсан түлш олдохгүй байна. | C1 ТВ - 2021.09.30-ны мэдээ | Сайжруулсан түлшний нийлүүлэлт тасарсан | -Шахмал түлшний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх. ГА | НЗДТГ-"ТТ-Түлш" |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **Сайжруулсан түлш** | Шахмал түлшний хомсдол: Тодруулбал 1 цэгт өдөрт олгодог 5 тонн түлш нь хаанаа ч хүрэхгүй байгаа бөгөөд зарим шахмал түлш нь дууссан цэгүүдэд хэзээ ирэх нь тодорхойгүй байгааг иргэд хэлж байна.<br>Сайжруулсан шахмал түлшний борлуулах цэгийн зарим худалдаачид түлшний хомсдол үүсээгүй хүрэлцээтэй байгаа гэсэн хариулт өгч байгаа хэдий ч иргэд ирсэн даруйд нь оочирлож байж авдаг хүрэлцэхгүй дуусч байгаа талаар онцолж ярьж байлаа. | https://www.mass.mn/n/82189 | Сайжруулсан шахмал түлшний 500 цэг ажиллаж байна. Нийслэлийн хэмжээнд өнөөдрийн байдлаар, сайжруулсан шахмал түлшний нийт 500 борлуулах цэг ажиллаж байгаа тухай Нийслэлийн удирдах ажилтнуудын өнөөдрийн шуурхай зөвлөгөөний үеэр холбогдох албаныхан мэдээлэв. Тодруулбал, Сонгинохайрхан дүүрэгт 170, Баянзүрх дүүрэгт 127, Чингэлтэй дүүрэгт 102, Сүхбаатар дүүрэгт 38, Хан-Уул дүүрэгт 39, Баянгол дүүрэгт 24 борлуулалтын цэг ажиллаж байгаа юм. | -Шахмал түлшний тээвэр, логистикийг оновчтой болгон сайжруулах. ГА | НЗДТГ-"ТТ-Түлш" |
| | Шатахууны хомсдол үүсэхэд олон хүчин зүйлс нөлөөлж байна. | http://eagle.mn/r/92969 | - Нэгэнт зөвхөн 2 хөршөөс л шатахуун импортлохоос хойш энэ салбарыг буцаагаад нийгэмчилэх. ГА -Шатахуун импортын худалдааг төрийн монопольд шилжүүлэх. ГА | Шатахууны хомсдол, тасалдлыг зогсоох, найдвартай хангамжийн систем бий болгох | Засгийн газар |
| | Стандартад хүрэхгүй чанаргүй шатахуун оруулж ирж зардаг нь аль эрт л тодорхой болсон. Энэ Ашигт малтмал газрын тосны газар гэж авлигад нэвт идэгдсэн газрыг татан буулгавал таарна Ерөнхий сайдаа! | https://www.facebook.com/BuyangiinJagaa/ | Бараа үйлчилгээний чанар шалгадаг төрийн байгууллагууд, лабораторууд үнэн зөв ажлаа хийх. Нэгэнт А80 бензин хэрэглэдэг хуучин орос автомашин байгаа цагт октан багатай бензин оруулж ирсээр л байх болно. ГА | шатахууны чанар, лабораторын шинжилгээг сайжруулах | Засгийн газар |
| | Шатахууны чанарыг шалгах лаборатори энэ тэр эвдэрчихсэн гээд сар жил халгаахгүй нууна. Тэгээд асуудлыг яриад эхлэхээр шатахууны компаниудыг өмөөрч гарч ирж мэдэгдэл хийнэ. | https://www.facebook.com/BuyangiinJagaa/ | Би хэлдэг. Цаашдаа ч хэлнэ. Монгол Улс үйлдвэрлэгч орон болох ёстой. Ажлын байрууд нэмэгдэж залуучууд Солонгост биш эх орондоо, хайртай хүмүүсийнхээ хажууд хөдөлмөрлөх ёстой. Тэр нефтийн үйлдвэрээ хурдан ашиглалтанд оруулж бензинээр дээрэлхүүлэхээ больё. Нөгөө таван толгойн цахилгаан станц, 5-р цахилгаан станцаа ч одоо хөдөлгөөд цахилгаанаар дээрэлхүүлэхээ больё! | Үндэсний нефтийн үйлдвэртэй болох, шатахууны хамаарлаас гарах | Засгийн газар |
| | Улс төрчдийн хувийн сонирхлоор шатахууны хомсдол үүссэн байж болзошгүй | С1 ТВ - 2021.10.06 | | Нефтийн салбарт улс төрчдийн оролцоо бий эсэхийг тогтоож таслан зогсоох | Засгийн газар |
| | Мах худалдаж авсан тохиолдолд шатахууны талон олгож байна. | С1 ТВ - 2021.09.23 | | шатахууны хомсдлыг далимдуулж бартер хийсэн тохиолдлыг шалгаж буруу жишиг тогтохоос сэргийлэх | Засгийн газар |
| | Хөршүүдээ үл тоож АНУ-ыг зорьсон У.Хүрэлсүхийн айлчлалаас болж шатахуун тасарсан уу ? | С1 ТВ - 2021.09.22 (574 коммент) | | 2 хөрш орнтойгоо ухаалаг, зөв бодлогоор харьцах. Төрийн тэргүүнүүд анхаарах | УАБЗ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Монгол Улсын “5 ЕРӨНХИЙ САЙД” нефтийн үйлдвэрийн шав тавьсан ч нэг ч ашиглалтад ороогүй байна. | C1 ТВ - 2021.09.21 | 20 жилийн дараа нефтиэр ажилладаг автомашингүй болж, 100% цахилгаан болон ус төрөгчөөр хөдөлдөг болно. Иймд энэхүү технологийн хөгжлийг угтаж найдвартай, хангалттай цахилгаан эрчим хүчний эх үүсвэртэй болох шаардлагатай. ГА | -Ирээдүйд цахилгаан болон устөрөгчөөр ажилладаг машин бий болох тул ирээдүйг угтуулж авах арга хэмжээгээ төлөвлөх. -Цахилгаан эрчим хүчээр найдвартай хангах зорилгоор Атомын цахилгаан станц байгуулах, эрх зүйн орчныг бүрдүүлэх. ГА | УИХ, Засгийн газар |
| | Хараат байдлаас гарах уу, шатахуунаа аваад хараат хэвээрээ үлдэх үү | http://eagle.mn/r/92040 | | Үндэсний нефтийн үйлдвэртэй болох, шатахууны хамаарлаас гарах | Засгийн газар |
| **Эрчим хүч** | Эдийн засагч Д.Жаргалсайхан: Өнөөдөр Монгол Улсын эрчим хүчний нийлүүлэлт найдваргүй болж, эрчим хүчний дутагдалд оржээ. Гол шалтгаан нь хэрэглээ жил бүр нэмэгдсээр байхад дотоодын үйлдвэрлэлээ өсгөж чадахгүй, гадаадаас цахилгааныг өндөр үнээр худалдаж авсаар буй явдал. | https://news.mn/r/2485991/ | Эдийн засагч Д.Жаргалсайхан: Эхний ээлжинд дулаан цахилгааны үнээ бага багаар нэмж, аажмаар ядаж зардлаа нөхдөг болгохоос гадна зэрэгцээд эрчим хүч хэмнэх, дулаан алдагдлыг багасгах, эрчим хүчний алтернатив эх үүсвэр ашиглах зэргийг дэмжиж, урамшуулсан бодлого хэрэгжүүлэх цаг болжээ. Харин урт хугацаандаа цөмийн эрчим хүчний станц барих, ус төрөгчийн задралыг ашиглах зэргээр нүүрс хүчлийн хийг багасгасан эх үүсвэр ашиглахыг дэлхийн цаг агаарын дулаарал, манай улсын хүлээсэн үүрэг шаардах боллоо. | -АЦС байгуулах. ГА | УИХ |
| | Эрдэнэбүрэнгийн УЦС нь зөвхөн баруун аймгуудыг импортын эрчим хүчний хараат байдлаас гаргаад зогсохгүй Монгол Улсын хэмжээнд сэргээгдэх эрчим хүчний технологийг нэвтрүүлэх, ирээдүйд найдвартай эрчим хүчний үүсвэрээр хангагдах чухал ач холбогдолтой юм. Гэвч Монголд эрчим хүчний томоохон төсөл хэрэгжих болгонд түүнийг нураадаг, гацаадаг хүмүүс бий болсон. | https://news.mn/r/2485894/ | УЦС барих нь тухайн бүс нутагт шинжлэх ухаан, боловсрол, соёл, эрүүл мэндийн урт хугацааны хөгжлийг бий болгож, ажил эрхлэх боломжийг тасралтгүй нэмэгдүүлж, орон нутгийн иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд түлхэц болно. Ажил эрхлэлт, хүн амын өсөлт нь зах зээлийн биржийн цар хүрээг өргөжүүлэхээс гадна бараа бүтээгдэхүүний худалдааны эргэлт, ложистикийн урсгал, мэдээлэл солилцоо зэрэгт нөлөөлж, бүс нутгийн эдийн засгийг өргөжүүлэхэд нөлөөлж эдийн засгийн хөгжлийн хурдыг сайжруулна. Дээрх дүгнэлтээс Эрдэнэбүрэнгийн УЦС-ыг байгуулах нь чухал шаардлагатай юм. | -Сэргээгдэх эрчим хүчний бодлогыг хөхиүлэн дэмжиж, үнэ тарифын зохицуулалт хийж, татаац өгөх замаар өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх. ГА | УИХ |
| **Тэтгэвэр** | Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбооны ерөнхийлөгч Х.Амгаланбаатар 2022 оны төсвийг батлахтай холбогдуулан Хөдөлмөр нийгмийн гурван талт хэлэлцээрийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд хэд хэдэн асуудлыг тусгуулах шаардлагатай байна. | | Цалин, тэтгэвэр тэтгэмжийг 2022 онд үе шаттайгаар 20-оос доошгүй хувиар нэмэгдүүлэх эх үүсвэрийг улсын төсөвт суулгах; Төрийн болон орон нутгийн өмчит ААН-үүдийн нэмэгдүүлсэн цалин хөлсийг төсөвт тусгуулах; Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардлыг төсөвт тусган хэрэгжүүлэх; Төсвийн хэмнэлтийн тухай 43 дугаар тогтоолын холбогдох заалтыг эргэн харах, сөрөг үр дагаврыг арилгахыг шаардаж байна. | 2022 оны төсөвт цалин, тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэх, ХАБ-Эрүүл ахуйн зардал, цалингийн нэмэлтийг тусгах. Төсвийн хэмнэлтийн тухай 43-р тогтоолыг эргэж харах | УИХ/Засгийн газар |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **Нийгмийн халамж** | Хувьдаа байртай, 2-оос дээш машинтай 8000 гаруй иргэдийн асуудал | С1 ТВ - 2021.10.13 | | Цар тахлын нөлөөгөөр өрхийн орлого буурч байна | |
| | Хүн амын 80 хувь нь халамж авч, төсвийн 30 хувийг халамжид зарцуулж байна | С1 ТВ - 2021.09.14 | | Халамж хүрэх ёэндээ хүрэхгүй амьдралын боложтой хүмүүс халамж ихээр авч байгааг таслан зогсоох. Халамжийг зорилтот бүлэгт чиглүүлэх | Засгийн газар |
| | Сүүлийн 30 жилд үүссэн гажуудлыг тэтгэврийн реформоор л арилгаж чадна | Эдийн засагч Ө.Ганзориг https://dnn.mn/ | | -Тэтгэврийн сангийн зориулалтаар байгуулах баялгийн сангийн эрх зүйн орчныг бүрдүүлэх. ГА | УИХ |
| | Дөрвөн сайдын оролцоотой хөтөлбөр ба ажилгүй залуусыг сая төгрөгөөр халамжлах бодлого | http://itoim.mn/article/9cqC1/29918 | Засгийн газар төсвөө хэмнэнэ, халамжаа танана гэсэн хэрнээ нөгөө талд Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам халамжийн хүрээг улам тэлсээр байна. Мөн "Оролцоо" төслийн цаана яамдууд ажлаа булаацалдаж байгаа нь илт байна. Зөвхөн "Оролцоо" төсөлд гэхэд Боловсролын яам сургалтын агуулгаа гаргана, Соёлын яам хувцасны загвар гаргана, Батлан хамгаалахын яам загварын дагуу хувцас үйлдвэрлэнэ, ХНХ-ын яам нь бүртгэнэ, тэтгэлэг олгоно, хөдөлмөрт зуучилна нэрээр үргүй зардал гаргав. | ХНХЯ-нд хэрэгжиж байгаа залуусын " Оролцоо" төслийг иргэд халамжийг тэлсэн, олон яамд дамнасан, үрэлгэн төсөл хэмээн үзэж байна. | |
| **Ядуурал, амьжиргааны доройтол** | Цар тахлаас шалтгаалан өрхийн орлого 12-15 хувиар буурч байна. | С1 ТВ - 2021.10.18-ны 15.00 цагийн мэдээ | | Цар тахлын нөлөөгөөр өрхийн орлого буурч байна | УИХ/Засгийн газар |
| | Хоригдол эмэгтэйчүүдийн 45-48% залилангийн хэрэгт ял шийтгүүлсэн байна. Тэдний бараг 80% өрх толгойлсон эмэгтэйчүүд. Ихэнх нь мөнгө хүүлэгчээс авсан зээлийн хүүгээ дийлэхээ болиод залиланд тооцогдож ял авсан байдаг. Яагаад өрх толгойлочихов гэхээр дийлэнхийн ард зоддог нөхөр байна. | @erdecriminalist | | -Мөнгө хүүлэлтийн эсрэг эрх зүйн орчныг сайжруулах. ГА | УИХ |
| **Хүүхдийн мөнгө** | Эдийн засагч, судлаачид: Хүүхдийн мөнгийг ирээдүйн өв сантай холих нь зөв шийдэл биш | https://gogo.mn/r/en198 | Ирээдүйн өв сангийн менежмент нь төр өөрөө биш хөндлөнгийн хувийн компани хариуцах нь илүү үр дүнтэй, хөрөнгө оруулалт нь тархсан эдийн засаг үр ашиггүй байдаг байдал хэвээр байна. Хөрөнгө оруулалтаа хөгжил рүү чиглүүлэх нь оновчтой гэсэн санал дэвшүүллээ. | Ирээдүйн өв сангийн менежментийн асуудал | УИХ/Засгийн газар |
| **Нийгмийн халамж** | Хөгжлийн бэрхшээлтэй иргэд жил бүр группээ сунгуулахаас илүү олон жилээр сунгахыг шаардлаа | С1 ТВ - 2021.10.11-ний мэдээ | | Хөгжлийн бэрхшээлтэй,эдгэршгүй өвчтэй хүмүүсийн группыг жил болгон сунгадаг нь чирэгдэл , хүндрэл үүсгэж | Засгийн газар |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | байгаа тул олон жилээр сунгадаг болох | |
| | УНАЛТ ТАТАЛТЫН ОНОШТОЙ ИРГЭД СҮҮЛИЙН НЭГ САРЫГ ЭМГҮЙ ӨНГӨРӨӨЖ БАЙНА | С1 ТВ - 2021.09.30-ны мэдээ | | Тогтмол уудаг зарим эм тасарснаас иргэд хүнд байдалд байна. Жишээ нь, уналт таталтын эсрэг эм | Засгийн газар |
| | Монгол Улсад сонсголын бэрхшээлтэй иргэд дээд боловсрол эзэмших боломжгүй байна. | С1 ТВ - 2021.09.24 | | Сонсголын бэрхшээлтэй иргэд дээд боловсрол эзэмших боломж бүрдүүлэх | Засгийн газар |
| **Нийгэм/гэр бүл** | Жилд 16-17 мянган хос гэрлэлтээ батлуулдаг ч дөрвөн мянга нь салдаг аж. Үүний улмаас нэг жилийн дотор 10 мянган хүүхэд өнчирч, амьдын хагацал үзэж байна. | http://eagle.mn/r/92818 | Гэр бүл салалтын хамгийн том хохирогчийг хүүхэд, эмэгтэйчүүд гэж хардаг нийгмийн хэвшмэл ойлголт бий. Үрээ тэвэрч хоцроод, тэтгэж өсгөж буй олон мянган аавын эрх ашгийн хаана ч, хэн ч сөхдөггүй. Гурав хүртэлх настай хүүхдээ гэртээ асарч байгаа аавууд дөнгөж энэ оны долоодугаар сарын 01-нээс л хүүхэд асарсны тэтгэмж авах боломж бүрдсэн. Монгол Улсын хэмжээнд албан ёсны бүртгэлтэй 16419 өрх толгойлсон эцэг, судалгааны байгууллагын хийсэн тооцоогоор 20 гаруй мянган эцэг гурав хүртэлх насны хүүхдээ асарч байгаа гэсэн тоо байна. шүүхийн шийдвэрээр жилд 4000 орчим гэр бүл гэрлэлтээ цуцлуулж байгаа ч мянга хүрэхгүй нь л хүүхдийн тэтгэмж авдаг. Өөрөөр хэлбэл, хүүхдийн тэтгэмж өгөх шийдвэрийн 85 хувь нь хэрэгждэггүй байна. Үүнээс гадна эцэг, эх нь гэрлэлтээ батлуулахгүйгээр хамтран амьдарч байгаад салсан тохиолдолд хүүхдийн тэтгэмж авах боломж улам багасдаг талаар хуульчид онцолж байлаа. Түүнчлэн Гэр бүлийн тухай хуульд хүүхдийн тэтгэмжийн хэмжээг маш бага тогтоосон байдаг. Гэрлэлтээ цуцлуулсан тохиолдолд амьжиргааны доод түвшний 50 хувиар буюу 200 орчим мянган төгрөгийн тэтгэмж тогтоодог бол хүүхэд 11 наснаас дээш бол амьжиргааны түвшинтэй тэнцүү хэмжээний тэтгэмж тогтоодог заалттай. Энэ нь эцэг, эхийн орлогын түвшингээс үл хамаардаг байна. Энэ хэмжээний мөнгөөр ганц бие эцэг, эх хүүхдээ тэжээж, өсгөхөд бэрх юм. Эцэг, эхийн хариуцлагыг нэмэгдүүлэхгүй бол өнчин хүүхэд, өрх толгойлсон аав, ээжийн тоо буурахгүй. | Өрх толгойлсон аавуудын тоо жилээс жил өсөж байгаа асуудалд анхаарах. Гэр бүлийн хуулинд өөрчлөлт оруулах, хүүхдийн тэтгэмжийг нэмэгдүүлэх, заавал олгуулдаг байх, өрх толгойлсон аавуудыг ээжүүдтэй ижил хэмжээнд авч үзэж тэтгэмж дэмжлэг үзүүлэх, гэр бүл салалтыг багасгах, салалтаас үүдэлтэй хүүхдийн эрхийг хамгаалах | УИХ/Засгийн газар |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **Боловсрол** | Аудитын шалгалтаар "Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгох шаардагдах бодлого төлөвлөлт үр дүн муутай, сургалтын орчин хангалтгүй байна" гэсэн ерөнхий дүгнэлт гаргажээ. | | Төсвийн тухай хуулийн 6.1-д зааснаар төрийн байгууллага төсвийн зарцуулалтын ил тод байлгах ёстой. Мониторингоор ажиглагдсан нэгэн анхаарал татам зүйл нь боловсролын 2021 оны төсөв 2020 оныхоос хоёр дахин буурсан байна. Боловсролын сайдын багцаас өөр сайдын багц руу төсөв шилжүүлсэн нь сөргөөр нөлөөлсөн гэв. Мөн Боловсролын тухай хууль 2002 онд батлагдсан ба үүнээс хойш 16 удаа, Бага дунд боловсролын тухай хууль 13 удаа өөрчлөгджээ. Тиймээс хооронд нь уялдуулах шаардлагатай байгааг аудитор Д.Энхболд мэдээллээ. | Бүх нийтийн ЕБС-ийн бодлого төлөвлөлт, боловсролын салбарын төсвийн хүрэлцээ, хууль тогтоомжийн олон удаагийн өөрчлөлт зэргийг анхаарах | Засгийн газар |
| | Байгалийн ухаан, мэдээлэл зүйн сурах бичгүүд шинжлэх ухаан, технологийн өнөөгийн түвшнээс хоцрогджээ. Сурах бичгүүд мэдлэг олгоход чиглэж байгаа ч мэдлэгээ амьдралд хэрэглэх, дадал болгоход дутуу анхаарсан. Сурагчид бие даан ажиллаж, өөрөө мэдлэг бүтээх талд илт хоцрогдсон.<br>Байгалийн ухаан, мэдээлэл зүйн хичээлүүд шинжлэх ухаан, технологийн өнөөгийн хөгжлийн түвшнээс хоцорсон. Монгол уламжлал, зан заншил харьцангуй бага тусгасан. Сурах бичгийн сэдэв, дэд сэдвүүд болон түвшин хоорондын, хичээл хоорондын логик холбоо алдагдсан гэж дүгнэжээ. Энэ нь сурах бичиг зохиогчдыг зөв сонгоогүй, анги бүрийн сурах бичиг зохиогчид, редакторууд өөр өөр байгаагаас шалтгаалсан гэлээ. Түүнчлэн сурах бичиг зохиох, хэвлэх, түгээх ажил цаг хугацаанд баригддаг учир алдаа гаргах, туршихгүй хэрэглээнд нэвтрүүлэх үндэс болдог байна. | http://eagle.mn/r/92790 | Дүгнэлтээр: одоо ашиглаж байгаа 174 сурах бичигт дүн шинжилгээ хийсэн ажлын хэсэг дүгнэлт, зөвлөмжөө танилцууллаа. Дүгнэлт гаргахдаа сурах бичгийн агуулга, арга зүй, найруулга, зөв бичгийн дүрэм, логик холбоо, дизайн гэсэн үндсэн 4 хэсэгт төвлөрчээ.<br><br>УИХ-д өргөн барьсан Боловсролын ерөнхий хууль болон дагалдах хуулийн төслүүдэд сурах бичгийн ажлын хэсгийн зүгээс 20 орчим саналыг тусгуулжээ. | Сурах бичгийн агуулга шинжлэх ухааны дэвшлээс хоцрогдсон, шаардлагад нийцэхгүй байна. Ялангуяа байгалийн шинжлэх ухаан, мэдээлэл зүй | Засгийн газар |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Сурагчдын хоцрогдол арилж, сургалтын чанар сайжирсан уу? | http://eagle.mn/r/92528 | Цахим, танхим хосолсон хэлбэрээр хичээллэх нь 100 хувь танхимын сургалттай дүйцэхүйц үр дүнтэй байж чадахгүй байгааг багш нар хэлж байна. Бага ангийн сурагчдын хувьд эцэг, эх нь анхаарахгүй л бол цахим хичээл үр дүнтэй байж чадахгүй байна. Нэгдүгээр ангидаа уншиж, бичиж сурах ёстой ч хоёр жил цахимаар хичээллэсэн учир хүүхдүүдийн сурлагын чанар сул байна. Гэхдээ цахим, танхим хосолсон хэлбэрээр хичээллэх нь дандаа цахимаар хичээллэхээс арай дээр юм. Ядаж л хичээлээ бататгаад, хүүхдүүдтэйгээ тулж харилцах боломж бүрдэж байна” гэсэн юм. Дата л байхгүй бол хичээлдээ сууж чадахгүй байна. | Цахим сургалтанд хамрагдалт муу байгаа тул сургалтын чанарт сөргөөр нөлөөлж байна. Цаашид танхимын сургалт, хосолсон сургалтыг явуулах асуудлыг шийдэх. | засгийн газар |
| 2-3 насны хүүхдүүдийн суралцах, хөгжих эрх нь хязгаарлагдаж, төрсөн цагаасаа хойш дөрвөн ханаы дунд “түгжигдэж” байна. Түүнчлэн энэ насны хүүхэдтэй эцэг, эх хүүхдээ харахын тулд ажлаасаа чөлөө авах шаардлага тулгарч буй юм. | http://eagle.mn/r/92751 | "Эцэг, эхчүүд хоёр жил гаруй хугацаанд хүүхдээ харах, ажил хийх хэцүү сонголтон дунд амьдарлаа. харах хүнгүй, санхүүгийн боломж хомос ээж, аавууд хүүхдээ цоожтой хаалганы цаана үлдээж буй олон тохиолдол бий.Улмаар түлэгдэл зэрэг ахуйн хүрээний гэмтэл их гарч буйг ГССҮТ-ээс гаргасан сттатистикаас үзэхэд хөл хорио, цар тахлын жилүүдэд бага насны хүүхдийн ахуйн хүрээний гэмтэл, түлэгдэл, угаартах үзэгдэл нэмэгдсэн байна. 2020.04.01-нийг хүртэлх хугацаанд улсын хэмжээнд нийт 2,568 хүн угаарын хийнд хордож эмнэлгийн байгууллагаас тусламж үйлчилгээ авчээ. Үүнээс насанд хүрсэн хүн 1,435, хүүхэд 1,133 байна. Угаартаж эрүүл мэндээрээ хохирсон иргэдийн тал хувь нь хүүхдүүд байна | Хэнээр хүүхдээ харуулж, хэрхэн ажлаа амжуулах вэ гэх хүндхэн сонголттой эцэг, эхчүүд хоёр жил гаруй хугацаанд нүүр туллаа. Харах, хандах хүнгүй, ажилгүй гэртээ суух санхүүгийн боломж хомос ээж, аавууд хүүхдээ ах, эгчтэй нь үлдээгээд цоожтой хаалганы цаана үлдээж буй олон тохиолдол бий.Улмаар түлэгдэл зэрэг ахуйн хүрээний гэмтэл их гарч буйг ГССҮТ-ээс гаргасан статистикаас харж болохоор байна. Тодруулбал, хөл хорио, цар тахлын жилүүдэд бага насны хүүхдийн ахуйн хүрээний гэмтэл, түлэгдэл нэмэгдсэн байна. Түүнчлэн угаартах эрсдэл өндөр. 2020 оны дөрөвдүгээр сарын 1-нийг хүртэлх хугацаанд улсын хэмжээнд нийт 2,568 хүн угаарын хийнд хордож эмнэлгийн байгууллагаас тусламж үйлчилгээ авчээ. Үүнээс насанд хүрсэн хүн 1,435, хүүхэд 1,133 байна. Дээрх тоо мэдээллээс харахад, угаартаж эрүүл мэндээрээ хохирсон иргэдийн тал хувь нь хүүхдүүд байгаа юм. | засгийн газар |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Хөл хорио, цахим хичээлтэй холбоотойгоор сургуулийн насны хүүхдүүдийн хараа муудах эрсдэл нэмэгдэж байна | https://medee.mn/p/163644 | | Цахим сургалт хүүхдүүдийн эрүүл мэндэд нөлөөлж буй асуудалд үнэлгээ хийж зохистой арга хэмжээ авах. Хараа муудах, стрэсстэх, хөдөлгөөн хоригдох, гэх мэт олон асуудлууд үүсч байна. | засгийн газар |
| | Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид хичээлийн анги, танхимдаа согтууруулах ундаа уусан байж болзошгүй зураг цахим ертөнцөд түгсэн нь шүүмжлэл дагуулж байна. | https://eguur.mn/256906/ | | ЕБС-ийн сурагчдын хүмүүжил, сургуулийн орчныг эрүүл байлгах асуудалд анхаарах. Архи, тамхины хор нөлөө, биеэ зөв авч явах тал дээр анхаарах. Нийгмийн ажилтан, эрүүл мэндийн ажилтан, багш, сурган хүмүүжүүлэгчдийн хүүхэдтэй ажиллах арга барил, орчин, нөхцлийг сайжруулах | засгийн газар |
| | Манай сурах бичгийн агуулга дэлхийн боловсролын системээс нилээд хоцрогдчихсон юм байна. | Өдрийн сонин,2021-10-18 Дугаар 200, 11-р нүүр | Сурах бичгүүдийн хоорондох логик муу, сурах бичг дотроо сэдвүүдийн хоорондох логик холбоо байхгүй, дэд сэдвүүдийн хоорондох логик муу байна. | 2008 онд батлагдсан УБС - ийн хэвлэмэл сурах бичгийн стандарт нь өөрөө хоцрогдсон байна. | засгийн газар |
| **Эрүүл мэнд** | Эх нялхсын төвд ор хүрэлцэхгүй байна. Өвчтөн даргаар яриулаад орж ирсэн гээд ор нэхэж, эмч боломжгүй байдлаа хэлж. | https://www.facebook.com/%D0%AD%D0%BC%D2%AF%D0%B6%D0%B8%D0%BD-553678738053852/ | Өнөөдрийн Монголын бодит байдал. | Эмнэлгийн ор хүрэлэхгүй байгаа асуудлыг шийдвэрлэх | Засгийн газар/УОК |
| | Хүчилтөрөгчийн нөөц дуусч, эмнэлгүүдийн хагалгаа хойшлов уу? | https://news.mn/r/2486202/ | ЭМЯ-НЫ ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖИЙН ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН ДАРГА Б.БУЯНТОГТОХ:<br>-Хүчилтөрөгчийн хангамж тасраагүй ээ. Хамгийн гол нь цар тахлын өндөр эрсдэлтэй үед эмнэлгүүдийн төлөвлөгөөт хагалгааг хойшлуулахаас өөр аргагүй нөхцөл байдал үүсч байна. ДЭМБ-аас ийм үед амь тэнссэн үеийн тусламж үйлчилгээгээ түлхүү авахыг зөвлөж буй. Бид энэ чиглэлээр ажиллаж байна. Улсын хэмжээнд хүчилтөрөгчийн хэрэгцээт эмнэлгүүдийн дэргэд бэсрэг үйлдвэр байгуулсан. Цар тахлын халдварын ачаалалтай холбоотойгоор ганц нэг эмнэлэг дээр хүчилтөрөгчийн асуудал үүссэн. | Эмнэлгүүдэд төлөвлөгөөт хагалгаа хойшилсон, хүчилтөрөгчийн нөөц, шаардлагатай эм тариа дутагдах, тасрах зэрэг хүндрэлүүд гарч байна. | Засгийн газар/УОК |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **КОВИД-19 ба эдийн засаг** | Эдийн засаг О.Батчулуун Цар тахлын шок эдийн засгийн шок болов | https://gogo.mn/r/jno48 | Цар тахлыг 2, 3 жилээр харж хүчээ тэнцүү хуваарилж, төлөвлөгөөтэй асуудалд хандах ёстой. 1.Нүүрсний экспортоо нэмэхийн тулд ногоон бүс бий болгох, төмөр замаа дуусгах. 2. Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэх, мега төслүүдээ явуулах. 3. Өрийн удирдлагыг зөв хийх, төсвийн зарлагын үр ашигт байдалд анхаарах. 4.Эрдэс баялгийн биржийн систем нэвтрүүлэх, ил тод байдлыг бий болгох | Ковидын дараах эдийн засгийг сэргээх бодлогыг оновчтой хэрэгжүүлэх | УИХ/Засгийн газар |
| **КОВИД-19 ба "Зайсан Хилл"** | С. Амарсайхан “Зайсан Хилл”-д Камертоны тоглолт хийсэн | https://www.facebook.com/photo/?fbid=4628718440518253&set=a.210682768988531 | “Зайсан Хилл” Нийслэлийн Онцгой Комисстой хариуцлагын гэрээ байгуулаагүй, зөвшөөрөл аваагүй, мөн танхим дүүргэлт 50% хэтэрсэн, халдвар хамгааллын дэглэм сахих боломжгүй нөхцлийг бий болгосон тул зөрчлийн хэрэг үүсгэн шалгаж эхэлсэн https://tumen.mn/p/13881?fbclid=IwAR0NJn5OOUHXYIMajSh8RQjllCLUPhIgiY-s5ZxOV7Ke5QE6UEyka4019iA | Цар тахлын үеийн хууль журмыг зөрчин олон нийтийг хамарсан томоохон арга хэмжээ зохион байгуулж байгаа зөрчлүүд гарч, халдварын тархалтанд нөлөөлж байна гэж иргэд бухимдаж байна. Хуулийг тэгш мөрдүүлэх | УОК/НЗДТГ |
| | НМХГ-ын дарга Л.Эрдэнэчулуун: “Зайсан Хилл”-ийн тусгай зөвшөөрлийг цуцална | Өдрийн сонин 2021.10.18 | Л.Эрдэнэчулуун: Бид Хан-уул дүүргийн 11-р хороонд байрлах “Зайсан хилл”-д шалгалт явууллаа. Собт трэйд компани энэ барилгыг эзэмшдэг. Тэд дотогш нэвтэрч буй хүмүүсийн халууныг шалгаагүй, ажилчдынхаа халууныг шалгаж бүртгээгүй. Хоолны газар нь ариун цэврийн шаардлага хангаагүй. Хүн хоорондын зай баримтлаагүй байна. Иймд дээрх тоглолт үзсэн хүмүүс яаралтай шинжилгээ өгөхийг уриалж байна... | Зайсан хилл гэх мэт зарим компани халдвар хамгааллын дүрмийг зөрчин олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулж байгаад арга хэмжээ авах, Хууль тэгш сахиулах | УОК/НЗДТГ |
| | Өөрийн хувийн өмчид Камертоны тоглолт хийхийг зөвшөөрсөн УОК-ын дарга С.Амарсайханы хариуцлагагүй үйл ажиллагааг шүүмжлэв. | https://www.facebook.com/BuyangiinJagaa/ | 2 янз үйлчлээд байгаа хорио цээрийг асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байгааг дэмжив. | УОК-ын дарга хууль зөрчиж өөрийн эзэмшлийн обьектод Камертон хамтлагийн тоглолт зохион байгуулсан. Хууль тэгш сахиулах | Засгийн газар |
| | Ихо: Хайраа "Зайсан хилл" мөнгө их олоод сайхан байнаа тэ? Самар: Тхх, хайр нь чамайг цар тахлын үед ч мөнгөөр дутаахгүй гэж амласан шүү дээ. | https://twitter.com/SaruulhanA/status/1449290532362985476 | Хууль, журам тэгш үйлчилдэг байх. Хууль сахиулах | Зайсан хиллтэй холбоотой зөрчил Хууль тэгш сахиулах | Засгийн газар |
| | УОК-оос битүү зааланд ямар нэгэн арга хэмжээ зохион байгуулахыг хориглосон. Гэтэл "Камертон" хамтлаг 26 жилийн ойгоо Зайсан Хиллд хэдэн мянган хүн цуглуулан хийжээ. Тэдний энэ үйлдэлд иргэд ихээхэн бухимдаж, шүүмжилж байна. | https://zarig.mn/te2 | ХӨСҮТ-ийн дарга асан Л.Баттөр цахим хуудаснаа дараах байр суурийг илэрхийлэв. "За, КОВИД-гүй Монголоо зарлах уу даа. Юун мини концерт, задгай талбайн шоу. Юун дижитал Монгол боллоодоо. Ийм УОК, НОК ч байх гэждээ. Ийм болохоор ЭМ салбарынханд ямар ч буруу байхгүй шүү. | Ковидын хууль зөрчсөн. Зайсан хилл Хууль тэгш сахиулах | Засгийн газар |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Шог зураач С.Цогтбаярын зурсан зураг. Монгол Улсын Шадар сайд С.Амарсайханы хамаарал бүхий Зайсан хилл зааланд Камертон хамтлагын тоглолт Цар тахлын журам зөрчиж зохион байгуулагдсанд иргэд эгдүүцэв. | https://twitter.com/satso999/status/1449294966677639169/photo/1 | Хууль, журам тэгш үйлчилдэг байх. Хууль сахиулах | Зайсан хилл. Хууль тэгш сахиулах | Засгийн газар |
| **КОВИД-19 ба ХӨСҮТ** | Халдварт өвчин, цар тахалтай тэмцэж буй ХӨСҮТ-ийн дүр төрх аймшигтай байна. | https://www.facebook.com/Urantogtokh/photos/pcb.4400427196707619/4400425053374500/ | Цар тахлын эхний үед олон улсын байгуулагуудаас ирсэн мөнгөөр багахан засвар хийх ёстой байсан юм. Удирдлага байсан албан тушаалтанд хариуцлага тооц. | ХӨСҮТ эмнэлгийн орчин нөхцөл маш муу байна. Асуудлыг шийдвэрлэх | Засгийн газар/УОК |
| | ХӨСҮТ-ийн байранд олон жил засвар хийгээгүйгээс болж нурж унахад бэлэн байна. Ажилчид нь жилд бага хэмжээний мөнгө нийлүүлж засвар хийдэг байсан. | Ganchimeg Badamdorj | | ХӨСҮТ эмнэлгийн орчин нөхцөл маш муу байна. Асуудлыг шийдвэрлэх | Засгийн газар/УОК |
| | ХӨСҮТ-ийн "УЛААН БҮС" Сэхээний өрөө | М.Ганбаатар (facebook) | Энэ өрөөнүүд 1986 оноос хойш нэг ч засвар хийгдээгүй. 1 өрөөг нь л хэсэг иргэд сайн дураараа тохижуулж өгсөн гэнэ. Цэвэрлэх байгууламж бол бүр асуудалтай. Эмч нарын амрах өрөө ямар ч тохьгүй. Сүүлийн 2 жилд бага сага мөнгө шийдэж өгсөн нь хаанаа ч хүрээгүй гэнэ | Эмч, эмнэлгийн ажилтнуудын амрах өрөө, ажиллах нөхцөлийг сайжруулах шаардлагатай байна. ХӨСҮТ-ийн байр чанар, стандартын шаардлага хангахгүй байна. | Засгийн газар |
| **КОВИД-19** | “Ковид-19” халдварын хоногт батлагдах тохиолдлын тоо буурсан ч, эмнэлгүүдийн ачаалал 40 гаруй хувиар нэмэгджээ. Учир нь өвчтөнүүдийн 35 хувь нь хүнд, маш хүнд хүмүүс байгаа учраас нэг хүнд үзүүлэх тусламж үйлчилгээний үргэлжлэх хугацаа уртассан байна. | МҮОНТ - Oct 13, 2021 - https://www.youtube.com/watch?v=yKufHqSGiWo | | Эмнэлгүүдийн ачаалал хэрээс хэтэрсэн. Зохицуулах арга хэмжээ авах | Засгийн газар/УОК |
| | “NoDoubleStandart” өлсгөлөн суулт. МАН-ын 100 жилийн ой гэх мэт эрх баригчид хүн цуглуулж болдог, энгийн ард болдоггүй. | https://www.facebook.com/oyungerel.tsedevdamba/posts/4258826974215699 | | Улс төрийн нам олныг хамарсан арга хэмжэ эзохион байгуулсан | Засгийн газар |

| | | | | |
|---|---|---|---|---|
| “Nodoublestandart” иргэдийн хөдөлгөөнийхөн Ялалтын талбайд Засгийн газрыг огцрохыг шаардсан жагсаал хийсэн. | http://time.mn/qUY.html | Тэдний жагсаалын гол зорилго, шаардлага нь:<br>-Ковид-19-өөр нас барсан иргэдийн ар гэрийн өмнө хариуцлага хүлээх<br>- Ковид-19 халдварт төрөөс зарцуулж байгаа төсвийг олон нийтэд нээлттэй харуулах<br>-Удаа дараагийн хязгаарлалт тогтоохгүй байх гэсэн ийм шаардлагуудыг хүргүүлсэн. Гэхдээ хариу ирээгүй. Харин ч жагсаалыг зохион байгуулсан зарим нэг хөдөлгөөнийг тэргүүлэгчдийг баривчлан байцааж байгаа. Энэ үеэр Ардчилсан намаас “Одоо боллоо” гэх нэртэй тайван жагсаал зохион байгуулаад амжсан.<br>-Шатахууны зах зээлийн үнэ, импортыг бүрэн чөлөөлөх<br>-ОХУ, БНХАУ хоёр улсад байгаа Монгол Улсын Элчин сайд нарыг эгүүлэн татах<br>-Андлалын хөшөө, усан оргилуур гэх мэт хөрөнгө оруулалт нэрээр хийж буй луйврыг зогсоох<br>-Удаа дараа ёс зүйн зөрчил гаргасан албан тушаалтнуудад хариуцлага тооцох гэсэн шаардлагуудыг хүргүүлсэн ч мөн л хариу ирүүлээгүй. | ковидын төсвийн зарцуулалтыг ил болгох, шатахууны үнэ, хомсдол, үр ашиггүй хөрөгө оруулалт, төсвийн мөнгийг зүй бусаар зарцуулсан, ёс зүйн зөрчил гаргасан албан тушаалтнуудад хариуцлага тооцох, зарим элчин сайдуудыг эргүүлэн татах жагсагчдын шаардлага | Засгийн газар |
| Дэлгэцийн донтолт, цахим хичээлээс шалтгаалж хүүхдийн хараа муудах эрсдэл их байна | С1 ТВ 15.00 цагийн мэдээ | | | |
| Төлбөргүй, төлбөртэй ч шинжилгээ хийх оношлуур байхгүй | https://gogo.mn/r/xwgv6 | нэмэлт тунд итгэх олон нийтийн итгэлийг дээшлүүлэх, вакцин хийлгэх хүний тоог нэмэгдүүлэх, гуравдугаар тундаа хамрагдсан иргэд үйлчилгээний газруудад үйлчлүүлэх | ковидын оношлуур тасарсан | Засгийн газар/УОК |
| 30 хувь нь гуравдугаар тундаа хамрагдвал тахал бараг дууснa. | Өдрийн сонин. 2021.10.18 Дугаар 200. 3-р нүүр | дархлаа сэргээх нэмэлт тунд итгэх олон нийтийн итгэлийг дээшлүүлэх, вакцин хийлгэх хүний тоог нэмэгдүүлэх, хичээл сургууль ажлын байран дээр гуравдугаар тунд хамрагдсан байхыг шаардах Өнөөдөрийн байдлаар улсын хэмжээнд 2,8 сая тун вакцин байгаагаас 800 мянган тун нь 2021 оны 12 дугаар сарын 31-нд хугацаа нь дуусна | Засгийн газар дархлаажуулалтыг төгс болгох | Засгийн газар/УОК |
| "Хүүхдийн хариу эерэг" гарлаа гэсний дагуу үзлэг хийх гээд гэрт нь яваад ортол тэр айлд үсний найр болж байж. "Боль, тарцгаа" гээд цагдаа дуудалтай биш. Дуугүй л хүүхдийг нь үзээд гарсан гэнэ. Тэгэхээр зарим нь коронавирусээс хэт айхгүй, зарим нь хэтэрхий айгаад байна. | https://gogo.mn/r/xwgv6 | Өвдвөл яах вэ, хэнээс зөвлөгөө авах вэ, яаж эмчлүүлэх вэ, бусдад халдаахгүйн тулд хэрхэн хамгаалах вэ гээд энэ бүгдэд бэлдсэн байх хэрэгтэй. | ковидоор өвчилсөн хүмүүст эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх тогтолцоо ойлгомжгүй, иргэдийг зөнд нь хаясан байна. | засгийн газар/УОК |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Энэ оны эхний есөн сарын байдлаар 48 эх эндсэний 71 хувь нь Ковид-19-ийн хүндрэлээс шалтгаалжээ. | http://eagle.mn/r/92893 | | Эхийн эндэгдэл нэмэгдсэн. ковидоор ихэнхи нь эндэж байна. | засгийн газар |
| Т.Дүүрэн: 30 жилд анх удаа нүүр тулж байгаа энэ онцгой үеийг онцгой бодлогоор л давъя. Үгүй бол дүр эсгэсэн хууль гаргах шаардлага байхгүй | https://ikon.mn/opinion/2cqp | МҮХАҮТ-ын дарга Т.Дүүрэн Тэрбээр цар тахлын энэ хүнд үеийг онцгой бодлогоор тохируулга хийж чадвал Монгол Улсын эдийн засаг дөрвөн жилийн дотор ХОЁР ДАХИН тэлэх боломжтой гэдгийг онцолж байна. | Ковидын үед төрөөс онцгой бодлого хэрэгжүүлэх | УИХ/Засгийн газар |
| Вакцины бодлогоо тодорхой болгох хэрэгтэй байна. Хэн хариуцаад ямар вакциныг хэр хэмжээгээр хаанаас авахыг шийдэж байгаа процесс нь тодорхойгүй л байгаад байна. | https://www.facebook.com/Urantogtokh/videos/292144329198381 | Вакцины татан авалтыг хүн амын дундах вакцины үр нөлөөний судалгаан дээр үндэслэн явуулах хэрэгтэй байна. https://www.youtube.com/watch?v=TM4C3GHN1jw | вакцины бодлого тодорхойгүй байна.вакцины үр нөлөөний судалгаанд үндэслэн татан авалт хийх | Засгийн газар/УОК |
| Нийтийн тээвэрт коронавирусын халдвар тархах эрсдэл хамгийн өндөр байна | C1 ТВ - 2021.10.08 | | Хөл хорио тогтоохгүй байх, хувийн автомашины хөдөлгөөнийг дэмжих бодлого баримтлах. ГА | УОК/НЗДТГ |
| 0-18 насны 74 мянган хүүхэд коронавирусийн халдвар авчээ | C1 ТВ - 2021.10.06 | | ковидоор өвчилж байгаа хүүхдүүдийг анхаарах | Засгийн газар/УОК |
| 195 эмч өөрийн хүсэлтээр ажлаа өгчээ. | C1 ТВ - 2021.09.27 | | Эмч нар ажлаасаа ихээр гарч байна | Засгийн газар |
| Иргэд танилын хүрээгээр эмнэлэгт хэвтсэнээс зохиомол ачаалал бий болж хүнд өвчтөнүүд гэртээ нас барах эрсдэлтэй байна, | C1 ТВ - 2021.09.10 | | эмнэлгийн хүрэлцээгүй байдлаас үүдэн эмнэлэгт танил талаар хэвтэж байна. танилгүй иргэд гэртээ нас барах эрсдэлтэй бн | УОК |
| "Ангир нүдэн Мөндөөхэй хөдөлгөөн" ТББ-ын тэргүүн н.Цэрэнханд "КОВИД-19 цар тахлын үед эдийн засгийг эрчимжүүлэх тухай хуулийн төслийг бид бүхэлд нь эсэргүүцэж байгаа. Энэ хуулийн төслийн 2.3-т "Энэ хуулийн заалт бусад хуультай зөрчилдвөл энэ хуулийг хэрэглэнэ" хэмээн заажээ. Ингэснээр уул уурхайн хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгох, сунгахдаа орон нутгийн засаг захиргаа, иргэдийн санал асуулгыг авахгүй байх нөхцөл бүрдэж байна. Энэ нь Үндсэн хууль зөрчсөн үйлдэл юм. | https://ikon.mn/n/2clg | | "КОВИД-19 цар тахлын үед эдийн засгийг эрчимжүүлэх тухай хуулийн төслийг бид бүхэлд нь эсэргүүцэж байна | УИХ |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Цар тахлын нөлөөгөөр монголчууд эрүүл мэнд, сэтгэлзүйгээрээ маш их хохирч байна. Халдвар авч эдгэсэн ч суурь өвчтэй болж байна. Үүнээс болж маш их хямарч сэтгэл судлаач дээр иржр байна. | https://news.mn/r/2485919/ | | Ковидын дараах иргэдийн эрүүл мэнийн асуудлыг анхаарах. Сэтгэл засал, ужиг үлдцийг арилгах, сэргээн засах эмчилгээ, үйлчилгээ шаардлагатай | Засгийн газар |
| Засгийн газар эдийн засгийг механикаар дэмжиж хэчнээн мөнгө тараасан ч хүмүүсийн амьдралд хүрэлцэхгүй. Гэтэл Монголын хөдөлмөрийн зах зээл энэрэнгүй биш. Маш хатуу. Ажил хийж бүтээмж гарахгүй бол ажлаас халдаг. Цар тахлын улмаас маш их хүн эрүүл мэнд, ажлаа алдаж байна. | https://news.mn/r/2485919/ | дэлхий нийтээр ажиллах хүчийг тогтвортой хадгалахын тулд илүү энэрэнгүй уян хатан нөхцөл рүү шилжиж, эрүүл мэнд, сэтгэлзүйд нь анхаарч эхэлсэн байна. Тухайлбал, Ковид-19 халдвараар өвдсөн эсэхээс үл шалтгаалан эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамруулах, сэтгэлзүйн байдалд анхаардаг болсон байна. | Ковидын үед ажлын байрыг хадгалах, хөдөлмөрийн зах зээлд үүсч буй асуудлуудыг шийдвэрлэх, иргэнийг ажилтай байлагахад төрөөс анхаарах | Засгийн газар |
| Гуравдугаар тун ба Хүний эрх | http://eagle.mn/r/92482 | Хүний эрхийн тухай олон улсын хэд хэдэн баримт бичигт нийгмийн эрүүл мэнд, эсхүл бусад хууль ёсны зорилгын үүднээс тодорхой эрхийг хязгаарлахыг зөвшөөрдөг байна. Энэ тухай “Эмнести Интернэшнл” олон улсын хүний эрхийн байгууллага цахим хуудастаа мэдээлжээ. Тухайлбал, улс орнууд тодорхой нөхцөл байдалд зайлшгүй вакцинд хамрагдсан байхыг шаардаж болдог ба ингэхдээ хүн бүрийг вакцин хийлгэхийг албадахгүй боловч ажил хөдөлмөр, сургууль, эсхүл зорчих эрх чөлөө нь вакцинд хамрагдах шаардлагаас хамааралтай байж болно. Хамгийн гол нь энэ шаардлага хууль ёсны, зайлшгүй, тэнцвэртэй, ялгаварлан гадуурхахгүй байх зарчмуудыг хангах учиртай. Мөн бизнес эрхлэгчдийн хувьд нэмэлт тунд хамрагдсан байх шаардлага тавихын оронд хувийн хамгаалах хэрэгсэл, хүн хоорондын зай бариулах гэх мэт урьдчилан сэргийлэх аргыг мөрдөх боломжтой гэдгийг анхаарч, аль аль талдаа хүний эрхийн мэдрэмжтэй шийдвэр гаргаж ажиллая. | Хүний эрх ба вакцинжуулалт | Засгийн газар/УОК |
| Х.Дуламсүрэн: Ковидын халдвартай, хүндэвтэр хатгай оноштой ой зургаан сартай хоёр ихэр хүүхэдтэйгээ улаан бүсээс эмчилгээ хийлгэж чадалгүй нэг хоноод хөөгдөж гарсан | https://zarig.mn/tf1 | | Эмнэлгүүд ковидын халдвартай хүүхэд, том хүнд зохих ёсны дагуу тусламж үзүүлээгүй. 2 ихэр хүүхэдтэй ээжийн кейс | УОК |
| КОВИД-19 халдвараар эмнэлэгт хэвтэн эмчлүүлж буй хүмүүсийн орны эргэлт удаан байна. | https://zarig.mn/tcm | | Эмнэлгүүдийн орны хүрэлцээ | УОК |
| Засгийн газар, УОК, ЭМЯ-ны уялдаагүй эргэж буцсан | С1 ТВ - 2021.09.28ны мэдээ | | | Засгийн газар |

UHMN СУДАЛГААНЫ САН

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | шийдвэрийн балгийг иргэд үүрч байна | | | | |
| | Засгийн газар, УОК гаргасан шийдвэрээ өөрсдөө мөрдөхгүй байна | С1 ТВ - 2021.09.20-ны мэдээ | | Төрийн шийдвэр, эрх бүхий байгууллагуудын үйл ажиллагаа уялдаа холбоогүй байна. | Засгийн газар/УОК |
| **КОВИД-19 ба томилгоо** | Ковидын үеийн түр хуулийг далимдуулан 23 агентлагын даргыг сонгон шалгаруулалтгүй томилжээ. | С1 ТВ - 2021.09.27 | | Тухайн албан тушаалд мэргэжлийн, туршлагатай хүмүүсийг томилдог байх | УИХ/Засгийн газар |
| | Цар тахалтай тэмцэх ажилд зориулан баталсан хуулийг төрийн албанд чадвар, туршлагагүй этгээдийг даргаар томилоход ашиглаад жил гаруйн хугацаа өнгөрлөө. | http://eagle.mn/r/92585 | Энэхүү хуулийг анх 2020 он дуустал хэрэгжүүлэхээр баталсан ч цар тахлын нөхцөл байдал хүнд хэвээр байгааг шалтгаан болгон хоёр ч удаа сунгахдаа төрийн албанд сонгон шалгаруулалтгүйгээр томилгоо хийх заалтыг нь хасаагүй. | Төрийн албаны хамгийн дээд албан тушаал болох төрийн нарийн бичгийн даргаар төрийн албанд 16 жил ажилласан хүнийг томилох ёстой. Гэтэл цар тахлын хуулийг ашиглаж төрийн албанд мэргэжилтэн, хэлтсийн даргыг шургуулж эхэлсэн эрх баригчид төрийн нарийн бичгийн даргыг ч энэ зарчмаар томилж эхлэв. Зарим эх сурвалжийн мэдээлснээр цар тахлын хуулиар 23 агентлагийн дарга, зургаан яамны Төрийн нарийн бичгийн даргыг ямар ч сонгон шалгаруулалтгүйгээр томилоод байгаа аж. | УИХ/Засгийн газар |
| | Төрийн албанд ажиллах иргэдийг Төрийн албаны хуулийн зарчмыг зөрчин томилж байна. Короногийн хуулийн 3.1 3.2 заалтыг үндэслэж байна гэх боловч энэ хууль нь Монгол Улсын бусад хуулийг зөрчсөн хууль юм. | https://www.youtube.com/watch?v=YltDoNIHhpE | | Төрийн албанд ковидыг далимдуулан хууль зөрсөн томилгоонууд хийж байна. | УИХ/Засгийн газар |
| **"Үдийн хоол" хөтөлбөр** | “Үдийн хоол” хөтөлбөрийн үнэн төрх (хөтөлбөрийн талаарх бодит байдал) Үдийн хоолны өртөг нь нэмэгдсэн ч бахь байдгаараа. Хар цай, хатсан боорцог аяга шөлөөр л солигджээ. “Би лав цадсангүй”, “Хоол нэмж идмээр байна”, “Хоолоо нэмүүлмээр байдаг ч дахиж өгдөггүй” гэж хүүхдүүд гомдоллох ч багшийнхаа дэргэд хэлдэггүй.ҮДИЙН ХООЛНЫ 1500 | https://news.mn/r/2476866/ | -2-3 ээлжтэй сургуульд "үдийн хоол" хөтөлбөрийг зогсоох. ГА<br>-1 ээлжтэй сургуулиудыг стандартын дагуу "үдийн хоол"-оор хангах кейтерингийн төрөлжсөн компаний сүлжээ зохион байгуулах, хоолыг түгээлтээр сургуулиудад хүргэх. ГА | -"Үдийн хоол" хөтөлбөрт мониторинг хийж, эрх зүйн орчныг сайжруулах | УИХ/Засгийн газар |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | ТӨГРӨГ ХҮҮХДЭД БҮТЭН ОЧДОГГҮЙ | | | | |
| **Бэлгийн хүчирхийлэл** | Р.Булгамаа: Сүүлийн таван жил 1400 орчим охин бэлгийн хүчирхийлэлд өртсөн | http://eagle.mn/r/92721 | Сүүлийн таван жилийн байдлаар Монгол Улсад 1400 орчим охид бэлгийн хүчирхийлэлд өртсөн байна. Ийм ноцтой гэмт хэргийг таслан зогсоохыг ард иргэд, төр засаг, олон нийтээс хүсмээр байна. Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэгт холбогдуулан хууль хяналтын байгууллагаас зөвхөн гэмт хэрэгтэнд хорих ял оногдуулдаг, эсхүл хариуцлага хүлээлгэж байгаа нь үнэхээр харамсалтай байна.<br>Гэмт хэргийн хохирогч болсон хүүхдүүдийн сэтгэл санааны хохирлыг нь тооцон **нөхөн олговор олгодог зохицуулалт Монгол Улсад байдаггүй**. Хохирогч болсон хүүхдүүд өөрсдөө эмнэлэгт ханддаг. Энэ төрлийн гэмт хэрэг гарахад аль сургуулийн хэддүгээр ангийн, хэн гэдэг хүүхэд болох талаар мэдээллийг уралдан мэдээлдэг байдлаасаа татгалзах хэрэгтэй. Хүчирхийллийн гэмт хэрэг үйлдэгдэх орчин нь ахуйн шинжтэй болж байгаа нь анхаарал татаж байна. Тиймээс бэлгийн хүчирхийллийн хохирогч болсон охидын **гэмт хэрэг шийдэгдэж дуустал төрийн хамгаалалтад авдаг зохицуулалт манай улсад хэрэгтэй**. Хүүхдийн эрхийн хамгааллын чиглэлээр салбар дундын зохицуулалтыг сайжруулахад төрийн нэгдсэн бодлого зайлшгүй шаардлагатай байна | Гэмт хэргийн хохирогч болсон хүүхдүүдийн сэтгэл санааны хохирлыг нь тооцон нөхөн олговор олгодог, тухайн хэрэг шийдэгдэж дуустал төрийн хамгаалалтад авдаг байх эрх зүйн зохицуулалтыг бий болгох | УИХ/Засгийн газар |
| **Бэлгийн хүчирхийлэл** | Сүүлийн гурван жилийн хугацаанд 0-13 насны 527 хүүхэд бэлгийн хүчирхийллийн хохирч болжээ | С1 ТВ - 2021.10.11-ний мэдээ | | Хуулийн хариуцлагын хэмжээг чангатгах | УИХ/Засгийн газар |
| **Гэр бүлийн хүчирхийлэл** | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр ял шийтгэлийн бодлогуудыг чангатгана | http://gogo.mn/ | “Шүүх эрх мэдэл, хууль сахиулах алба хаагчдын үндэсний чуулган” Төрийн ордонд болж байна. Чуулганд Хууль, зүй дотоод хэргийн сайд Х.Нямбаатар "Эрх зүйн шинэтгэл: Шударга ёсыг бэхжүүлж, эдийн засгийн өсөлтийг дэмжинэ" сэдвээр илтгэл танилцууллаа. | Хуулийн хариуцлагын хэмжээг чангатгах | УИХ/Засгийн газар |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **Нийтийн тээвэр** | Нийтийн тээврийн хүрэлцээ өглөө, оройд нийтийн тээврийн үйлчилгээ хомсдолтой байна. Нийтийн тээвэр хүрэлцэхгүй, иргэд автобусандаа багтахгүй, автобус дүүрэн учраас буудлууд дээр зогсохгүй шууд явж байгаад иргэд бухимдалтай байна. Өдгөө нийслэл хотод хамгийн их тулгамдаж байгаа асуудал бол нийтийн тээврийн асуудал юм | https://mongoltv.mn/post/54177 | | Нийтийн тээврийн хүртээмжийг эрс нэмэгдүүлэх, цахилгаан болон гибрид тээврийн хэрэгслээр (гэхдээ троллейбус биш) бүрэн хангах бодлого баримтлах, эрх зүйн орчныг бүрдүүлэх. ГА | Засгийн газар, НЗДТГ |
| **Авто зам** | Дархан хотын түүхт 60 жилийн ой тохиож байгаа ч Дархан-УБ автозам засагдахгүй удаж байна. | https://www.facebook.com/Urantogtokh/photos/pcb.4400418690041803/4400416560042016/ | Одоо хүртэл тавьж чадахгүй байгаа буруу нь Засгийн газарт байгаа! Тэрнээс биш засаг дарга болон дарханы ард иргэд зам тавих эрх мэдэл нь байсан бол дууссан байгаа! | Дарханы замын бүтээн байгуулалтын ажилд учирсан болзошгүй авлигалын хэргийг шуурхай илрүүлж, концессын гэрээг шинэчлэн байгуулах. ГА | Засгийн газар |
| **Хот төлөвлөлт** | Манай улсад хүндээ ээлтэй дэд бүтэц хөгжөөгүйгээс иргэд хэд алхаад л асуудалтай тулгарч байна. Ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажил хөдөлмөр эрхлэх орчин, нөхцөл хомс байна. | МҮОНТ - Oct 13, 2021 - https://www.youtube.com/watch?v=Ojc7zyiUqQ8 | | ҮХНӨ--ийн хүрээнд хууль, эрх зүйн орчны мониторинг хийж, үнэлгээний дагуу эрх зүйн орчныг сайжруулах. ГА | УИХ/Засгийн газар |
| | Хот стандарттай, хүртээмжтэй байх ёстой ч хөгжлийн бэрхшээлтэй иргэддээ ээлгүй байсаар байна. | С1 ТВ - 2021.09.25 | | | |
| | Хот төлөвлөлт - Автомашинтай зорчиход хүндрэлтэй, явган зорчих аюултай, дугуйн зам хангалтгүй, тэргэнцэртэй иргэдэд бүр ч халтай хот | MONGOL TV - "Нүүдэл шийдэл" нэвтрүүлэг - Oct 5, 2021 - https://www.youtube.com/watch?v=JFzg-1NhZrQ | | -Хот төлөвлөлтийн эрх зүйн орчныг сайжруулах. ГА | УИХ, НЗДТГ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Баригдаад 3 дахь жилтэйгээ золгож байгаа “Олимп”-ын гүүрийн ажил: явган хүний замгүй дээрээс нь 2019 онд л 80 хувьтай явж байсан авто замууд яг хэвэндээ. Ер нь нийслэлээс тэргэнцэртэй иргэдийн ганцаараа аюулгүй, асуудалгүй хотдоо зорчдог байх тал дээр дорвитой ажил хийгдээгүй. Жуковийн хөшөөний ар талын дөрвөн га газарт дөрвөн блок, долоон хэсэгтэй 16 давхар орон сууц үйлчилгээний төв барихаар төлөвлөж байгаа. Гэхдээ үүнийг оршин суугчид эрүүл, аюулгүй амьдрах нөхцөлийг үгүй хийж байна хэмээн эсэргүүцсээр | http://time.mn/qNA.html | | ҮХНӨ--ийн хүрээнд хууль, эрх зүйн орчны мониторинг хийж, үнэлгээний дагуу эрх зүйн орчныг сайжруулах. ГА | УИХ/Засгийн газар |
| | "Хууль зөрчин олон улсын чанартай авто зам дагуу олгосон газрыг цуцалъя" Хот тойрсон газрууд үнэд орж, газрын наймаа цэцэглэж нийтийн эрх ашиг хохирч, хотын бүтээн байгуулалт төлөвлөлтгүй, замбараагүй хийгдэхэд хүрээд байна. | Өглөөний сонин. 2021.10.18 | -Хууль зөрчиж олгосон газруудыг цэгцэлж, стандарт бус газрын гэрчилгээг цуцлан, газрын наймааг таслан зогсоох талаар дорвитой арга хэмжээ авах шаардлагатай байна.<br><br>-Хотын дарга Д.Сумъяабазар Газрын луйварчдын гай балгийг таслан зогсооно гэж байсан. Харин Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ хоёр жилийн өмнө Улаанбаатар хотын утаа, автомашины түгжрэлүүд нэг талаасаа улстөрчид эрх мэдэлтнүүдийн өнгөрсөн жилүүдэд хууль бусаар замбараагүй олгосон газар олголттой холбоотой гэж үзэхээс өөр аргагүй гэж байсан. | -Хот төлөвлөлтийн эрх зүйн орчныг сайжруулах, хуультай болох. ГА | УИХ |
| **Хот төлөвлөлт** | "Хот төлөвлөлтийн оновчгүй бодлого иргэд, бизнес эрхлэгчдийг хохироож байна" УБ хотод орон сууцны барилгууд баригдсан ч ногоон байгууламж, хүүхдийн тоглоомын талбай, машины зогсоол зэрэг стандарт шаардлагыг хангахгүй төлөвлөгдөн хийгдэж байгаа нь иргэдийн аюулгүй, тав тухтай орчинд амьдрах эрхийг зөрчиж, иргэд, бизнес эрхлэгчид эрд хөрөнгөөр хохирч байна. | Өглөөний сонин. 2021.10.18 | Хотын төвөөр замбараагүй олгогдсон газрын асуудлыг хариуцлагажуулж, хот төлөвлөлтийг боловсронгуй болгох шаардлагатай байна. | -Хот төлөвлөлтийн эрх зүйн орчныг сайжруулах, хуультай болох. ГА | УИХ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **Цахим гэмт хэрэг** | Хүний эрх, нэр төрийг хэлмэгдүүлэхгүй байх. 1966 оны Иргэний болон улс төрийн эрхийн тухай пактад манай улс нэгдэн орсон. Төрийн гэхээсээ илүү нийгмийн зүгээс иргэдийг хэлмэгдүүлж байна. Хэвлэл мэдээллийн байгууллага, нийгмийн сүлжээгээр бусдыг хэлмэгдүүлж байна. | https://www.youtube.com/watch?v=PRRLYSEiGQE | | -Хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох. ГА | УИХ, Засгийн газар |
| **Үндэсний аюулгүй байдал** | Хөрөнгө оруулалтын тухай хууль ҮАБ-д ноцтойгоор харшилна. | https://www.facebook.com/%D0%AD%D0%BC%D2%AF%D0%B6%D0%B8%D0%BD%BD-553678738053852/ | | -ҮАБҮБ-д мониторинг хийх, хууль, эрх зүйн орчныг сайжруулах. ГА | УИХ |
| **Үндэсний аюулгүй байдал** | Өргөн нарийн царигт. Нарийн цариг нь дэлхийн стандарт. Урд хөрш нарийн царигтай. Автомашинаар нүүрс зөөж байгаль орчин сүйтгэж өндөр өртөгтэйгээр нүүрсээ зөөж байна. | https://www.youtube.com/watch?v=YtU2oKhaJaA | Салбар бүр нэг улсаас бүрэн буюу бараг 100 хувь хараат боловч бүхэлд нь харвал тэнцвэртэй л байна. Харин, тэнцвэрт байдлыг хангаж байгаа салбарт хөршүүдийн өрсөлдөөн үгсвэл /Жишээ нь, ОХУ бидэнд өргөн хэрэглээний бараа нийлүүлж, түүхий эд худалдаж авах,, эсхүл БНХАУ эрчим хүчний салбарт орж ирэх үед/ Монгол Улсын тусгаар тогтнолын баталгаа алдагдаж эхэлнэ гэж үздэг.<br><br>Нэгэнтээ ОХУ ингэж харж байгаа бол бид ГТБҮ-ийн бүтээн байгуулалтаа хурдлуулж, дараа, дараагийн Эрдэнэбүрэнг барьж байгуулан хамаарлаасаа нэн даруй гарахаар шуурхайлахаас өөр яах билээ. Газрын тостой, нүүрстэй, сэргээгдэх эрчим хүчний асар их нөөцтэй улс хэзээ нэгэн цагт зориглоод нөхцөл байдлаа өөрчлөх гэж оролдох нь зайлшгүй л байсан. | УИХ-аас 2010 онд баталсан Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримталын 3.1.1.4-т “ОХУ, БНХАУ-тай сайн хөршийн найрсаг харилцаа, өргөн хүрээтэй хамтын ажиллагааг хөгжүүлнэ. Ингэхдээ үндэсний эрх ашиг, харилцааны түүхэн уламжлалыг харгалзан бүс нутгийн энх тайван, тогтвортой байдлыг эрхэмлэж, бүхэлдээ тэнцвэртэй харилцахыг эрмэлзэнэ” гэж заажээ.<br><br>-Төмөр зэвсгийн эрин үе дуусаж био болон мэдээллийн дайны эрин үе эхэлсэн тул ҮАБҮБ-ийг шинэчлэн өргөн нарийн царигийн асуудлыг орхиж, нэмэлт зардал гарахгүй саадгүй тээвэрлэлтийн боломж олгох нарийн царигийн төмөр замын сүлжээ шинээр байгуулах. ГА | УИХ, Засгийн газар |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **Байгаль орчин** | Тусгай газар нутаг, орон нутгийн тусгай газрыг хамгаалахтай холбоотой зохицуулалтыг Газрын тухай хуулийн төсөлд орхидуулсан | МҮОНТ - "Хуулийн засаглал" ярилцлагын нэвтрүүлэг Oct 16, 2021: Хуульч Б.Мөнхтогтох - https://www.youtube.com/watch?v=Z28D96jY9co | Хуульд газрын үндсэн ангилалд "тусгай газар"-ыг тухайлан оруулах, орон нутгийн тусгай газрын талаар тусгах | -Нийтийн эдэлбэр газар гэсэн ойлголтыг хуулинд тусгах. ГА | УИХ |
| | Б.Мөнхтогтох: Газрын ерөнхий хуулийн төсөлд санаатай болон санаандгүй томоохон алдаа, дутагдлыг гаргасан байна. Хуульч, судлаач Б.Мөнхтогтох газрын багц хуулийн төсөлд шүүмжлэлтэй хандсан байна | Өнөөдөр, 2021.10.14 | Газрын нэгдмэл сангийн үндсэн ангиладд тусгай хамгаалалттай газар нутгйн зохицуулалтыг бүрэн орхигдуулсан, газар хамгаалал, нөхөн сэргээлтийн асуудлыг эдийн засгийн механизмтай уялдуулах шаардлагатай. | Одоогийн мөрдөгдөж байгаа хуулийн зохицуулалтын зарчмыг хэвээр үлдээх, орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн асуудлыг нэмж, одоогийн заалтыг боловсронгуй болгож хуулийн төсөлд тусгах, газрыг зохистой ашиглах, нөхөн сэргээх, учирч болзошгүй хохирлоос сэргийлэх төрийн бодлогыг хэрэгжүүлэх институцийн асуудлыг тусгах | УИХ |
| | Газрын тухай хуульд газрын харилцааг ашиглах талаар илүүтээ зохицуулсан, харин хамгаалах, нөхөн сэргээх талаар тусгаагүй | МҮОНТ - "Хуулийн засаглал" ярилцлагын нэвтрүүлэг Oct 16, 2021: Хуульч Б.Мөнхтогтох - https://www.youtube.com/watch?v=Z28D96jY9co | Газрын харилцааг байгаль орчны асуудлууд (экосистем)-тай уялдуулах, цогцоор нь зохицуулах шаардлагатай | -Байгаль орчны эрх зүйн орчныг сайжруулах. ГА | УИХ, Засгийн газар |
| | Газрын бодлого байхгүй байна | МҮОНТ - "Хуулийн засаглал" ярилцлагын нэвтрүүлэг Oct 16, 2021: Хуульч Б.Мөнхтогтох - https://www.youtube.com/watch?v=Z28D96jY9co | УИХ газрын бодлого тусгайлан гаргаж ирэх, тухайлбал, ямар газрыг бүсчлэн хөгжүүлэх гм | -Газрын харилцааны эрх зүйн орчныг сайжруулах. ГА | УИХ, Засгийн газар |
| | Тэрбум мод тарих бужигнааны цаана хууль бус үйлдэл гаарах вий | Өнөөдөр сонин,2021-10-18 Дугаар 202, А1, А3-р нүүр | | -Моджуулах чиглэлээр дагнасан агентлаг байгуулж, хариуцуулах. ГА | Ерөнхийлөгч, Засгийн газар |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Манай улс мод тарина гэж мэргэжлийн байгууллагуудаас холдуулаад, сайн дурын ажил болгоод, мэргэжлийн бус улсууд хавар, намар субботник хийгээд, баахан зарлага гардаг юм. | https://news.mn/r/2484248/ | Тэрбум мод тарих гэж байгаа бол мэргэжлийн ойн байгууллагууд, мод үржүүлгийн газруудад санхүүжилтийг нь өгөөд, алсын төлөвлөгөөг нь гаргуулаад ажиллавал үр дүнтэй ажил болно гэж бодож байна. | -Мэргэжлийн агентлаг байгуулж, хариуцуулах. ГА | Ерөнхийлөгч, Засгийн газар |
| | 1222 хүн цаг бусаар нас барсан үед үндэсний аюулгүй байдлын зөвлөл “МОД ТАРИХ” асуудлаар хуралдлаа. | С1 ТВ - 2021.10.01-ний мэдээ | | -Моджуулах чиглэлийн дагнасан агентлаг байгуулж, хариуцуулах. ГА | Ерөнхийлөгч, Засгийн газар |
| **Хүнсний аюулгүй байдал** | Ард иргэдийн хоолтой холбоотой өвчлөл жил ирэх тусам нэмэгдэж байгаагаас харахад, хүнсний аюулгүй байдлыг хангаж чадаж байгаа юм уу гэдгийг харж болно. | МҮОНТ - Нээлттэй хором: "Хүнсний аюулгүй байдал-хяналт..." хэлэлцүүлэг Oct 14, 2021: Хуульч Б.Мөнхтогтох - https://www.youtube.com/watch?v=_ZtQBfN6XSs | Иргэдийн амьдралын чанарыг сайжруулахын тулд өвчлөлийг бууруулах ёстой, өвчлөлийг хууруулахын тулд хүнсний аюулгүй байдлыг хангах ёстой. Үүнд хүнсний бохирдол, хүнсний хангамж, хүнсний шим тэжээлийн талаар ярина. Дэлхийн томоохон хотуудад энэ бүхнийг тээвэр ложистикийг төвөөрөө дамжуулан хянаж байдаг. Манайд энэ орон зайг ченжүүд хийж байна. Үүнийг боловсронгуй болгож шаардлагатай байна. | ҮХНӨ--ийн хүрээнд хууль, эрх зүйн орчны мониторинг хийж, үнэлгээний дагуу эрх зүйн орчныг сайжруулах. ГА | УИХ/Засгийн газар |
| | Дотооддоо төмс, хүнсний ногооны хэрэгцээгээ 100% хангах боломж байна. ургац хураалтын ажилд хүн хүч дутагдаж байна. | Өдрийн сонин - 2021.10.18, Дугаар 200 1, 19-р нүүр | Ургац хураалтад хугацаат цэргийн албан хаагчид, оюутнуудыг өргөнөөр татан оролцуулах, зоорийн хангамжийг нэмэгдүүлэх, халамж авдаг иргэн ургац хураалтад ажиллавал гүйцэтгэлээр цалин авдаг байх Гаднаас орж ирж байгаа хүнсний ногоонд тодорхой хязгаарлалт хийх Гурил, улаанбуудайг экспортод гаргах, экспортыг дэмжих | -3%-ийн зээл олгосон. Газар тариалан, ургац хураалтыг дэмжих чиглэлээр авсан арга хэмжээнүүдийг үргэлжлүүлэх -Импортын бодлогыг зөв явуулах, дотоод зах зээлээ хамгаалах -Экспортын бодлогоор үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих | Засгийн газар |
| **Оффшор данс** | Монголын хоёр улс төрч оффшорчдын жагсаалтад багтсан байна | С1 ТВ - 2021.10.5-ны мэдээ | | | УИХ/Засгийн газар |
| **Улс төрийн нам** | Хувьсгалын үр дүнд баталсан 1992 оны шинэ Үндсэн хуулийн нэг амин сүнс нь ОЛОН НАМЫН ТОГТОЛЦОО байсан юм. Цагаан дээр хараар бичсэн хуулийн энэ заалтын дагуу л олон намууд байгуулагдаж, одоо ч үйл ажиллагаагаа явуулж байна. Гэвч бодит амьдрал дээр хоёр нам л ээлжилж эрх мэдлийг гартаа атгаж ирсэн бол Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр олон намын тогтолцоо улам хумигдах нөхцөл байдал үүслээ. | http://eagle.mn/r/92251 | | Нам төрийн эрх "барьж" байгаа энэ тогтолцоог халж, ард түмэн нийгмийн бүлэг болох мэргэжлийн олон нийтийн байгууллагаар дамжуулан төрийн эрх барих тогтолцоо бий болгох. ГА | УИХ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Хүний эрх, хувийн өмчгүй коммунистууд гэж хөөрхий нэг хүний дарангуйлал үзэл бодолгүй цаазал гэвэл цаазлуулна, долоо гэвэл долооно!! Монголын коммунистууд хуучин МАХН одооны МАН дотор яг иим байгаа!!! | @DMunkherdene | | Улс төрийн намын тухай хуулийг шинэчлэх | УИХ |
| **Томилгоо** | Оюун-Эрдэнэ, Нямбаатар, Нямдорж, Сумьяабазар нарын огцруулая. | @Д.Мөнх-Эрдэнэ (facebook) | | | |
| | **Элчин, Консулын томилгоо улс төрийн ‘өр төлөх’ төлбөрийн хэрэгсэл болжээ** Монгол улсыг төлөөлж гадаад оронд суух элчин сайд, консулаар томилогдсон хүмүүст иргэд сэтгэл хангалуун бус байна. Эндээс харахад, манай улс цаашид гадаад харилцааны боловсон хүчин бэлдэх шаардлага байна уу гэх асуулт төрнө. Бид эндээс энэ мэтээр өнгөтэй өөдтэйгөө илгээж байгаа ч, тэнд дипломат албыг мэргэжлийн ажил, тухайн улс оронд тухайн улс орноос үзүүлж буй хандлага, ач холбогдол гэж хүлээж авдаг. | http://itoim.mn/article/2zm2X/29383 | Монгол Улсын гадаад харилцааны бодлого нь өөрчлөлтөд бэлтгэхгүй, эсрэгээрээ өр төлөхөд тамираа барж буйг Элчин сайд нар, Элчин зөвлөх, Консулуудын томилгооноос харж болно. Монгол төрийн алтан аргамж нь Ардын намын сонгуулийн өр төлөх төлбөрийн хэрэгсэл болсныг сүүлийн үеийн гадаад томилгоонууд илтгэнэ. | Монгол Улсаас гадаад оронд суух элчин сайд, консулын томилгоог улс төрөөс ангид, мэргэжлийн болгох | УИХ/Ерөнхийлөгч |
| | Эрүүгийн гэмт хэргүүдэд мөрдөгдөж буй Дангаагийн Ганбат УБТЗ-ын дарга болох уу? | Зууны мэдээ | Манайхан Монгол, оросын УБТЗ ХНН-ийн Замын даргаар хүнээ томилуулах гэж бүтэн найман сар үзэж байна. Гурван хүнийг нэр дэвшүүлсэн ч Оросын тал хүлээн зөвшөөрөөгүй. Харин заалснаас Дангаагийн Ганбат ЗТХ-ийн сайд асан нэр дэвшлээ. Түүнийг дэвшүүлж буй хүчин нилээд хүч хаяж буй болтой. | УБТЗ ХНН-ийн даргын томилгооны асуудал | Засгийн газар |
| **Хууль сахиулах байгууллагууд** | Шүүхийн араас прокурор, мөрдөн байцаах байгууллагын үйл ажиллагааг шинэчлэх ёстой | Өнөөдөр сонин | | -Эрх зүйн орчныг сайжруулах, прокурорын дэргэдэх мөрдөн байцаах албыг сэргээх. ГА | УИХ |
| **Хуулийн хэрэгжилт** | "Д.Мөнх-Эрдэнэ: Шүүх хурлаар гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдоогүй бол буцаах биш, хэрэгсэхгүй болгож цагаатгах л учиртай" Шүүхээс буцсан хэргүүдээс олон хэрэг хэрэгсэхгүй болж, хүний эрх ноцтой зөрчигдөж буй асуудлаар хуульчтай ярилцсан байна. | Өдрийн сонин 2021.10.14 #198, 7-р нүүр. | Олны анхаарлыг татсан томоохон хэрэгт оролцсон гэмт хэрэгтнүүд ял завших, хууль, шүүхийн шинэчлэлийг гацаах, саад болох нөхцөл байдлыг засахын тулд хууль шүүхийн байгууллагын хараат бус, бие даасан байдлыг хангах, шударга хуульчдыг бэлтгэх, сонгож ажиллуулах, хариуцлага тооцдог тогтолцоог бий болгох ажлыг түргэвчлэх шаардлагатай талаар өгүүлжээ. | Шүүхээс буцсан хэргүүдийг хэрэгсэхгүй болгох, ял завшуулах байдлыг засах, эрх зүйн орчны асуудал | УИХ/Шүүх |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Дабл стандарт. Хууль зөвхөн иргэнд үйлчилж байна. Даргад үйлчлэхгүй байгаа нь иргэдийг бухимдуулж байна.Үндсэн хуульд Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байна гэж заасан байдаг. Цахим үндэстэн арга хэмжээ КОВИД-ын хуулийг зөрчив. | https://www.youtube.com/watch?v=YltDoNIHhpE | | Хууль тэгш үйлчлэх. Цахим үндэстэн арга хэмжээ хийснээр Засгийн газар хууль зөрчсөн | УИХ/Засгийн газар |
| **Бодлого, эрх зүйн орчин** | Иргэн Ц.Чинбат долоо дахь хоногтоо төрийн ордны гадаа өлсгөлөн зарлаж байна. Тэрбээр дарангуйлал тогтоох зорилготой КОВИД-ын гэх хуулийг цуцлах, Үндсэн хуулиар олгогдсон эрхээ эдэлсэн иргэн Монголхүү, Одбаяр нарыг суллахыг шаардлаа. | https://www.facebook.com/erennews.mn/videos/591726175204045/ | | Ордны гадаа өлсгөлөн, суулт зарлаж буй иргэдийн шаардлага, хүсэлтийг судалж, хлбогдох арга хэмжээ авах | УИХ/Засгийнгазар |
| | "Казино шинэ зүйл биш, харин хууль нь хуучны ноорог" Монгол Улсад мөрийтэй тоглоомыг хуулиар хориглосон ч технологийн үсрэнгүй хөгжлийн энэ үед цар хүрээ нь улам тэлсээр байна. | Өглөөний сонин, 2021.10.18 | | Монгол Улс мөрийтэй тоглоомыг заавал хуульчлах албагүй ч мөнгө угаалт, хууль бус санхүүжилттэй холбогдох эрсдэл байна. Олон улсын байгууллагууд далд бизнесийг бүртгэлжүүлж, хууль ёсны хяналттай болгохыг зөвлөж байгаа тул энэ чиглэлийн хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлага тулгараад байна. | УИХ |
| | Эрх баригчид, УИХ-ын гишүүд өөрсдийнхөө бизнесийг дэмжиж, өөрсөддөө тааруулж хууль санаачлан батлуулдаг. Тухайлбал, Х.Ганхуяг гишүүн Хөрөнгө оруулалтын тухай хуулийн төслийг өргөн бариад байна | https://www.facebook.com/%D0%AD%D0%BC%D2%AF%D0%B6%D0%B8%D0%BD%BD-553678738053852/ | УИХ-ын гишүүд болон эрх баригчдын өр зээлийг нийтэд зарлаж байх. | Хөрөнгө оруулатын тухай хуулийн төслийг хянан үзэх | УИХ |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Д.Өнөрболор, П.Анужин нар “Хуулийн хулгай”-д өртөв үү, хууль санаачилсны мөнгөнд шунав уу? | http://eagle.mn/r/92683 | Өөр бусдын том эрх ашиг, лоббид л орчихоогүй бол өөрсдөө мэдэлгүйгээр “гарын үсэг” зурах нь хувийн явцуу эрх ашиг гэж харахаас өөр арга алга. Яагаад гэвэл, Монголд хууль санаачлах эрхтэй 78-хан субъект бий. УИХ-ын 76 гишүүн, Ерөнхийлөгч, Засгийн газар. 2015 оноос хэрэгжиж эхэлсэн, 2020 оны тавдугаар сарын 7-нд шинэчилсэн найруулсан Хууль тогтоомжийн тухай гэсэн 11 бүлэг 53 зүйлтэй хууль Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Энэ бол хуулийн төсөл боловсруулахаас хууль тогтоомжийг батлан гарах хүртэл бүхий л харилцааг зохицуулсан хууль. Энэ хуулийн дагуу л Хөрөнгө оруулалтын тухай хуулийн төсөл олон нийтэд танилцуулагдаж, санал авсан. Тэгээгүй бол УИХ-д орж ирээд хэлэлцүүлэгдэх боломжгүй. Тэгэхээр санаачилсан Д.Өнөрболор, П.Анужин нар өөрсдөө л гарын үсэг зурахдаа хуулийн төслийнхөө “агуулгыг тоогоогүй” байна гэсэн үг. Хэрэв тэдний гарын үсэг зурснаас өөр төслийг Х.Ганхуяг гишүүн УИХ-д өргөн барьсан бол нэг гишүүнийхээ бүрэн эрхэд, цаашилбал сонгогчдынх нь эрхэнд халдсан хэрэг болж тараах нь. Тиймээс л Д.Өнөрболор, П.Анужин нар “Хуулийн хулгай”-д өртөв үү, хувьдаа 250 саяыг халааслав уу? гэж асуугаад байгаа юм. | УИХ-ын гишүүд хуулийн төсөл боловсруулахын тулд судалгаа шинжилгээний ажил явуулна, судлаач хөлсөлнө, иргэдээр хэлэлцүүлнэ, туршлага судлана гэх зэргээр Д.Тогтохсүрэн гишүүний хэлснээр 250 сая төгрөгийг авдаг. Энэ мөнгөө авахын тулд ямар ч хамаагүй төсөлд гарын үсэг зурдаг гэж яригддаг. Тэгж байж ТББ-аараа дамжуулж 250 сая төгрөгөө захиран зарцуулах эрх нь УИХ-ын гишүүдэд үүсдэг гэсэн үг. Иймээс л хэний ч санаачилсан хамаагүй төсөл дээр гарын үсэг зурж, гагцхүү явцуу эрх ашгаа хангахын тулд “хууль санаачлагч” гэгдэж яваа хүн цөөнгүй бий болчихсон байж мэдэх нь.<br><br>-УИХ-ын тухай хуулийг сайжруулах, Парламентын судалгааны хүрээлэнгээс гадуур түүний оролцоогүй судалгааны ажил санхүүжүүлэхийг болиулах. ГА | УИХ |
| | УИХ-ын 4 гишүүний өргөн барьсан Хөрөнгө оруулалтын тухай хуулийн талаар Уг хуулийг өргөн барьсан 2 гишүүн нэрээ татсан байдалд дургүйцэж байгаа байдал (асуудлаа уншихгүй гарын үсэг зурж байна гэж бухимдах иргэд) | С1 ТВ - 10.14-ний өдрийн лайвын доорх коммент 1.2к (дийлэнх нь эсэргүүцсэн) | | УИХ-ын гишүүн хууль санаачлах, хуулийн төсөл боловсруулах, өргөн барих үйл ажиллагааг боловсронгуй болгох, журамлах, гишүүдийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх.<br><br>-УИХ-ын тухай хуулийг сайжруулах, Парламентын судалгааны хүрээлэнгээс гадуур түүний оролцоогүй судалгааны ажил санхүүжүүлэхийг болиулах. ГА | УИХ |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | "УИХ хэзээ үзэл бодлыг шоронгоос гаргах гэж байна вэ" Худал мэдээлэл тараах талаар зүйл анги Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах талаар УИХ-ын нэр бүхий гишүүдийн өргөн барьсан өөрчлөлтийн талаар шүүмжлэлтэй хандсан байна | Өглөөний сонин 2021.10.15 | Төр иргэдийн мэдэх эрхийг нгуйлагч шинж рүү орох эрсдэлтэй байна | -Нийтийн мэдээллийн тухай хуулийг баталсанаар иргэний мэдэх эрх хангагдана. ГА | УИХ |
| **Төрийн үйлчилгээ** | Цахим бус "цаасан" үндэстэн хэвээр байна. Төрийн үйлчилгээ цахим хэлбэрт шилжиж байгаа ч төрийн байгууллагынхан янз бүрийн "цаас" нэхэж чирэгдүүлдэг асуудал хэвээр буй талаар баримтуудаар өгүүлжээ. | Өнөөдөр 2021.10.14 | Цахим үндэстэн болох том зорилт хэрэгжилтийн шатандаа замхарч буйг цэгцлэх шаардлага байна. | Цахим үндэстэн хөтөлбөр хэрэгжихгүй байна | Засгийн газар |
| | Сумын төвүүдээ бүрэн интернэттэй болгож чадаагүй байж цахим үндэстэн болох тухай ярьж байна. | С1 ТВ - 2021.09.17 | | -Мэдээлэл-холбооны технологийн дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэх, үнэ тарифыг бууруулах. ГА | УИХ |
| | Төрийн албаны ажилчид үйлчилгээгээ үзүүлж чадахгүй, хүн доромжилдог, гомдол гаргахаар цагдаа дуудаж өгдөг. | https://www.facebook.com/Urantogtokh/videos/599253891271367 | Төрийн албаны ажилчдыг 2 удаа алдаа дутагдал гаргавал торгон шийтгэж,3 дахь дээрээс нь халах хэрэгтэй. | Төрийн үйлчилгээ,төрийн албан хаагчдын хариуцлага, сахилгабатыг сайжруулах | Засгийн газар |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **Сонгууль** | Д.Бумдарь: Монголд эрх баригч нам, сөрөг хүчин хоёрын дунд бодлогын өрсөлдөөн алга - Сонгуулийн дүн тоолох аргачлалыг хэрхэн боловсруулах, нэг сонгогчийн саналыг гээхгүй байлгахад хамгийн зохимжит хувилбар аль нь вэ гэдгийг ардчилсан сонгууль зохион байгуулдаг улс бүр тооцож байгаа. Олон улсад хамгийн зохимжит хувилбар хэмээн 50 хувь нь мажоритар, 50 хувь нь хувь тэнцүүлсэн /хосолмол/ байдлаар сонгуулиа зохион байгуулдаг системийг хэрэгжүүлж байна. Манай улс 2012 онд энэ тогтолцоог ашиглаж, 48, 28 гэж хослуулсан байдаг. Үүнээс ухарсан нь хамгийн том алдаа юм. Сонгуулийн тогтолцоог нутагшуулж өөрийн онцлогт тохируулах ёстой. Чөлөөт ардчилсан сонгуулийн гол зарчим нь иргэн болгоны дуу хоолой, өгсөн санал нь “амьтай” үлдэх ёстой юм. Өөрөөр хэлбэл, хамгийн байж болох хэмжээнд тултал сонгогчийн санал хүчинтэйгээр Парламентын танхимд орж ирэх юм. Сонгуулийн тогтолцооны зорилго үүнд чиглэсэн байх ёстой. Манайх тийм биш байгааг олон сонгуулийн үр дүнгээр ойлгож байгаа байх. Бид хосолмол сонгуулийн тогтолцоог буцаан авчрах хэрэгтэй, арга ядахад нийслэл дээр хэрэглэж баймаар байна. Сонгуулийн жил болгоноор сонгуулийнхаа тогтолцоо, аргачлалыг багахан өөрчилснөөр сайн үр дүн гарахгүй. | http://itoim.mn/article/LOONq/30002 | Сөрөг хүчин буюу бага суудал авсан намуудын хувьд ядаж УИХ, Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих ёстой юм. Үүнийг хийж чадахгүй бол сөрөг хүчин гэж байгаад хэрэггүй. Тухайлбал, “Ковид 19”-ийн тухай хууль шиг богино хугацаанд үр дүнг тооцох боломжтой бодлогын шийдвэрүүдэд сөрөг хүчин хяналт тавих хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, иргэдэд өдөр тутамд очоод байх боломжгүй төр засгийн үйл ажиллагаатай холбоотой, эрх ашиг хөндөхүйц мэдээллийг дамжуулж байх, түүнд байр сууриа илэрхийлэх, ил тод хэлэлцүүлэг өрнүүлж байх хэрэгтэй. Сөрөг хүчний хамгийн том ажил бол өөрсдөө ялж, мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэх боломж олдсон бол юугаараа давуу байх байсан бэ гэдгийг харуулж, илэрхийлж байх ёстой. Гэтэл Монгол Улсад **сөрөг хүчин, эрх баригч хоёрын дунд ийм бодлогын өрсөлдөөн байхгүй болчихлоо**. Нэг л бүхэллэг орчин байгаад байна. Үнэхээр сөрөг хүчин байна уу, үгүй юу, ер нь байх хэрэгтэй юу, үгүй юу гэдэг асуултыг сөрөг хүчнүүдэд тавимаар ч юм шиг. Ардчилалд зайлшгүй байх ёстой институци бол олон намын систем, чөлөөт сонгуулийн систем юм. Бид үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ Үндсэн хуулиараа баталгаажуулсан. Гэвч ардчиллын институциуд чанаргүй байна. Хамгийн гол нь чанартай ардчилал шүү дээ. Иймд байлгах хариуцлагыг сөрөг хүчнүүд үүрэх ёстой. | Сонгуулийн тогтолцоог боловсронгуй болгох (ингэхдээ хуулийн талаар иргэдээс санал авах, учир нь сонгогчидод яаж сонголтоо хийхийг нь сонгогдох гэж байгаа хүмүүс тодорхойлоод байна), түүнийг тогтвортой байлгах, Улс төрийн намын тухай хуулийг шинэчлэх | УИХ |
| | Төрөөс хулгай хийсэн хүн сонгуульд ялдаг биш шоронд л ордог болох ёстой Хэрсүү түмэн минь | @AOtgonbaatar twitter | | Улс төрийн намын тухай хуулийг шинэчлэх | УИХ |
| **Хүний эрх** | Цэргийн алба хаахаар явсан залуус зодуулах, улмаар амь насаа алдах тохиолдол гардаг. Үүнд хэрхэн анхаарч, ямар арга хэмжээ авч ажиллаж байна вэ? | https://ikon.mn/n/2cvc | М.Мөнхтулга: зодоонтой холбоотой асуудлууд 2021 оны хавар давтагдсан. Үүнд Батлан хамгаалахын сайд, Зэвсэгт хүчний жанжин штабын дарга тушаал заавраа гаргаад тодорхой ажлын хэсэг гарч ажилласан. Тийм асуудал | Цэрэг дэглэх, амь насыг нь хохироох үзэгдлийг таслан зогсоох, | Засгийн газар |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | дахин давтагдахгүй байх тал дээр бид анхаарч байна. | | |
| | ЦЕГ-ын дарга Ж.Болд генерал "1964 оны Эрүүгийн байцаан шийтгэх хууль манай орны хөрсөнд тохирсон" гэв! Энэ хуулиар яллагдсан Лоохууз, Тангадын Галсан гуай нарын тухай уншаарай. Өмгөөлөгчгүй ялладаг. Мөрдөн байцаагч зохиолоо бичдэг. Хүний эрхгүй. Жинхэнэ харгис хууль шүү дээ! | @oyunlt | | Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг боловсронгуй болгох, хүний эрхийн талаас | УИХ/Засгийн газар |
| | Урагшлах тухай бүгдээрээ зүтгэж байхад ухрах санаачилга яриад зогсож байдаг нээрээ. Юун 1964 он руугаа эргэж буцах вэ Мөрдөгч өөрөө эрүүгийн хэрэг үүсгэдэг, хаадаг, түтгэлзүүлдэг юм чинь прокурорын хяналтгүй болгож, хүний эрхийг нулимаж, жинхэнээсээ махны машин болгийшдээ | https://twitter.com/Enkhbayar_bat/status/1449529965909663745 | УИХ-ын гишүүн Б.Энхбаяр Ерөнхийлөгчийн ивээл дор байгууллагдсан Шүүх эрх мэдэл, хууль сахиулах алба хаагчдын үндэсний чуулганд ЦЕГ-ын даргын тавьсан илтгэлд эгдүүцэв. | Эрүүгийн хууль ба хүний эрх | Засгийн газар |
| | Өмгөөлөгч Ч.Мөнхсайхан: "Д.Монголхүү надад ямар ч ял тулгасан тэмцлээсээ буцахгүй" гэж байгаа | Өдрийн сонин 2021.10.18 | ...Шүүх хурлаар гомдол саналыг хүлээж авсангүй. Цагдан хорих асуудлыг тэр чигээр нь шийдсэн. Өнгөрсөн Баасан гарагт хэргийн материалыг танилцуулаад шүүхэд шилжүүлэх сналтай явсан. Тэгэхээр нөхцөл байдал бараг жирийн хулгайн хэргийг л хоёр, гурван сар шийдэгдэхгүй явдаг атал энэ маргаан 10-хан хоногийн дотор шийдэгдээд шүүхрүү явчихлаа... | | Засгийн газар/Шүүх |
| | Д.Монголхүү: Цагдаа нар хүч хэрэглэн, миний эгэмний ясыг хугалсан. | С1 ТВ - 2021.10.01-ний мэдээ | | Жагсагчдыг саатуулсан асуудал | Засгийн газар/Шүүх |
| | Д.Монголхүүг суллахыг шаардсан иргэд ХЗДХЯ-ны гадна хоножээ | С1 ТВ - 2021.10.07-ны мэдээ | | Жагсагчдыг саатуулсан асуудал | Засгийн газар/Шүүх |
| **Авлига** | Авлига, албан тушаалын хэрэгт холбогдсон хүмүүсийн 10 хувь нь улс төрийн албан тушаалтнууд бөгөөд хуулиар олгогдсон бүрэн эрхээ хувийн ашиг сонирхолдоо урвуулан ашиглаж, төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг гажуудуулан олон түмний итгэлийг хөсөрдүүлж байна. | https://medee.mn/p/163707 | Албан тушаалтнууд, ялангуяа төрийн өндөр албан тушаалтны халдашгүй дархан байдалтай холбоотой хуулийн зохицуулалтыг эргэн харах, авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд халдашгүй байдлын зохицуулалт үйлчлэхгүй байх хэмжээнд хүртэл холбогдох хуулиудад өөрчлөлт оруулах асуудал дээр хуулийн байгууллагууд санал дүгнэлтээ нэгтгэх, асуудлыг хөндмөөр байна. | Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих: Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль | УИХ/Засгийн газар: Хэргийн мөрдөлтийг цаг алдалгүй, тасралтгүй явуулахын тулд зарим ажиллагааг цахимаар явуулах эрх зүйн зохицуулалтыг бий болгох. |

UHMN СУДАЛГААН

| | | | | |
|---|---|---|---|---|
| Сүүлийн 4-5 жилд аймгийн засаг дарга нарын хөрөнгө орлого хэрхэн өсөв. | С1 ТВ - 2021.09.30-ны мэдээ | | Орон нутгийн удирдлага, албан тушаалтнуудын хөрөнгө орлогын эх үүсвэрийг судлах,авилгалтай холбоотой эсэх | АТГ |
| “Хүүхдийн төлөө фонд” хүүхдэд зориулсан хандив цуглуулах аянаар 2 тэрбум 225 сая төгрөг цугласан нь хаана байгаа нь тодорхойгүй байна. Тэр мөнгө тусгай сангийн дансанд одоо хүртэл ороогүй гэдгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа хэлж байв. | https://www.e-medee.com/?p=3954&fbclid=IwAR3egkydQs-EyP1cu4SEMH1sEFLcfTORHijm4OqPoPfKmhg9aULTEeMXkh4 | Энэ мөнгө угаах шинжтэй гэмт үйлдэлд оролцсон Соёлын сайд, дэд сайддаа улс төрийн хариуцлага тооцох нь зүй ёс. Энэ ТББ-д өгсөн хандивыг Засгийн газрын тусгай санд дайчлан авбал зохино. | Хүүхдийн төлөө фонд" хүүхдийн хандив нэрээр мөнгө цуглуулсан асуудал, зарцуулалтыг шалгах | УИХ/Засгийн газар |
| Хүүхдийн төлөө гэх тодотголтой уг фонд нь “хүүхдийн нэр барьж мөнгө угаах арга биш биз” гэх хардлага ч олон нийтийн дунд төрөх болов. | https://news.mn/r/2484694/ | | Хуульд зааснаар Хүүхдийн төлөө сангаас гурван чиглэлээр зарцуулалт хийнэ. Тодруулбал, хүүхдэд зориулсан бүтээн байгуулалт, олон улс, тив дэлхийн соёл урлаг, спортын уралдаан, наадамд амжилт гаргасан хүүхдүүдийг урамшуулах, олон улсын наадам, тэмцээнд оролцох бэлтгэл хангаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд дэмжлэг үзүүлнэ. | УИХ/Засгийн газар |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Олон нийтийн сүлжээ (фэйсбүүк, твиттер), нийгэм улс төрийн талаар идэвхтэй пост бичиж, уриалдаг page хуудас болон фейсбүүк хаяг:
   1. Н.Ганчимэг сэтгүүлч
   2. А.Отгонбаатар
   3. Д.Мөнх-Эрдэнэ
   4. Жагар
   5. Р.Эмүжин
   6. Комедиан Амараа
   7. Н.Энхбаяр (эдийн засагч)
   8. Б.Жаргалсайхан
   9. Цэцэг Бямбаа
   10. Элийрэгч Уянга
   11. Н.Урантогтох сэтгүүлч
   12. Сэтгүүл Б.Отгон.
2. Өдөр тутмын цахим хуудас (өндөр хандалтай сайт):
   1. http://bloombergtv.mn
   2. http://eagle.mn
   3. http://itoim.mn
   4. http://olloo.mn
   5. http://time.mn
   6. https://eguur.mn
   7. https://gogo.mn
   8. https://ikon.mn
   9. https://medee.mn
   10. https://news.mn
   11. https://www.trends.mn
   12. https://zarig.mn
3. Телевизийн нийгэм, эдийн засаг, цаг үеийн нөхцөл байдлын талаар бэлтгэсэн хэлэлцүүлэг, нэвтрүүлэгүүд:
   1. МҮОНТ – “Цаг үе, үзэл бодол”, "Хуулийн засаглал" нэвтрүүлэг;
   2. Монгол телевиз – Нүүдэл, шийдэл нэвтрүүлэг;
   3. ТВ-9 – “Монгол коммент” нэвтрүүлэг;
   4. НТВ – “Улаанбал” тойм нэвтрүүлэг;
   5. Ийгл ТВ – Зочны цаг.
4. Өдөр тутмын сонингууд:
   1. Өдрийн сонин;
   2. Зууны мэдээ;
   3. Өнөөдөр;
   4. Үндэсний шуудан;
5. Эксперт судлаачдын байр суурь (ТВ, сонинд өгсөн ярилцлага, нийтлэл):
   1. их, дээд сургуулийн багш нар;
   2. судлаачид.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН